

# **АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ**

(2014 он)

I боть

Хянасан: Д.Дуламсүрэн

Эмхтгэсэн: Д.Цэнд-Аюуш  
У.Номин-Эрдэнэ

Энэхүү эмхтгэлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн нэгжийн удирдлага, хамт олонд талархал илэрхийлье.

Энэхүү эмхтгэлд орсон шүүхийн шийдвэрүүдийг “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан” ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn))-аас түүвэрлэн авав.

Цаасны хэмжээ: А4  
Хэвлэлийн хуудас: 43.75  
Хэвлэсэн тоо: 1000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв

## УНШИГЧ ТАНАА

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоохоос гадна авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ойлгуулах, таниулах, соён гэгээрүүлэх ажил чухал байр суурь эзэлдэг.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар 2007 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар 10 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байв. Харин 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу авлигын 12 төрлийн гэмт хэргийг харьяалан шалгаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг болон түүний шийдвэрлэлтийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд тогтмол мэдээлэх, шийдвэрлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх тогтолцоо бүрдүүлэх зорилтыг тусгасан. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мөн ач холбогдолтой юм.

Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгаж, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн шийдвэрийг цувралаар олон нийтэд хүргэхээр энэ удаад 2014 онд

шийдвэрлэгдсэн албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрүүдийг эмхтгэн толилуулж байна.

Энэхүү эмхтгэлд Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгасан авлигын гэмт хэргийн 40 шийдвэр багтсан бөгөөд хууль хэрэглээний болон практик ач холбогдлыг харгалзан анхан шатны шүүхийн тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг багтааснаараа онцлог юм.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг ийнхүү эмхтгэн хэвлүүлснээр Эрүүгийн хуулийг нэг мөр, хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарт практик ач холбогдолтой бөгөөд багш, судлаач, оюутнуудын эрдэм шинжилгээ, сургалт судалгааны эргэлтэд оруулж, улмаар авлигын эсрэг эрх зүйн орчин, ялын бодлогыг сайжруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Эмхтгэлтэй холбоотой санал хүсэлтээ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст (hutulbur@iaac.mn цахим шуудан, утас 70112467) хандаж ирүүлэх боломжтой бөгөөд бид Таны саналыг таатай хүлээн авч хамтран ажиллах болно.

**Авлигатай тэмцэх газар**

## ГАРЧИГ

1.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 568 .....	5
2.	Сум дундын 26 дугаар шүүхийн цагаатгах тогтоол 07 .....	13
3.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн магадлал 48 .....	17
4.	Сум дундын 21 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 98 .....	22
5.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 797 .....	27
6.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 713 .....	44
7.	Сум дундын 5 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 35 .....	51
8.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 408 .....	55
9.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 496 .....	62
10.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 276 .....	72
11.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 1014 .....	78
12.	Сум дундын 28 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 76 .....	98
13.	Сум дундын 4 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 96 .....	104
14.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 355 .....	112
15.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 465 .....	124
16.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 281 .....	137
17.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 1263 .....	149
18.	Сум дундын 28 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 92 .....	164
19.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 211 .....	167
20.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 484 .....	214
21.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 358 .....	257
22.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн цагаатгах тогтоол 1169 .....	279
23.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 863 .....	283
24.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 907 .....	316
25.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн цагаатгах тогтоол 1189 .....	330
26.	Сум дундын 9 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 78 .....	337

**ШИЙТГЭХ ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 568

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС**

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн эрүүгийн шүүх хуралдааныг шүүгч Ц.Дайрийжав даргалж,

Хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга О.Даваажаргал хөтлөн,

Улсын яллагч С.Батгэрэл,

Шүүгдэгч Б.Д, түүний өмгөөлөгч Б.Ганпүрэв,

Шүүгдэгч Д.Н, түүний өмгөөлөгч Ц.Баасандорж нарыг оролцуулан, тус шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн хуралдаанаар Дүүргийн 2 дугаар прокурорын газраас

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан гэмт хэрэгт Б.Д-д холбогдуулан,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт Д.Н-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн 201401000005 дугаартай 4 хавтаст хэргийн шүүгдэгч,

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр ...аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, ..., дээд боловсролтой, хүнсний инженер мэргэжилтэй, Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт ...дүүргийн ...дугаар хороо .... тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, Б.Д /РД: ...../

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр ...аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, ..., дээд боловсролтой, багш мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл ..., нөхөр 2 хүүхдийн хамт ...дүүргийн ...дугаар хороо ... дүгээр хорооллын ...-ын ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, Д.Н /РД: ...../ нарт холбогдох хэргийг 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

3. Шүүгдэгч Б.Д нь 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэр “М” групп ХХК-ны байранд байрлах “А” ХХК-ны “Б” хүнсний дэлгүүрийн ажлын байр нь илтэд стандартын шаардлагад нийцээгүй байхад стандартад нийцсэн мэтээр ажлын байрны дүгнэлт

гаргаж өгөхөөр амлаж “А” ХХК-ны захирал Д.Н-ээс 475.000 төгрөгийн хээл хахууль авсан,

4. Шүүгдэгч Д.Н нь “А” ХХК-ны захирлаар ажиллаж байхдаа 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэр “М” групп ХХК-ны байранд байрлах “А” ХХК-ны хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлгэж, ажлын байрны дүгнэлт гаргуулах зорилгоор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчаар ажилладаг Б.Д-д 475.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Б.Д шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ:

Би Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст Хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчаар ажиллаж байхдаа “А” ХХК-ны захирал Д.Н-ээс бэлнээр 400.000 төгрөг авсан нь үнэн. 75.000 төгрөгийн тухайд бол Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын чиглэлийн ахлах байцаагч Ж.А ном зарж өгөөч гэсэн юм. Ж.А-ын номыг өөр аж ахуйн нэгжид зараад, мөнгийг нь Д.Н-ээр төлүүлж, Ж.А-ын данс руу 75000 төгрөг хийлгэсэн нь үнэн. Д.Н-д ном өгөөгүй. 3 шил архины асуудал бол манай ажлын эгч Ж.Ш манай охин хүнтэй сууж байгаа юм 3 шил архи хэрэгтэй байна гэхээр нь би Д.Н рүү яриад 3 шил архи аваад ир гэж хэлсэн нь үнэн. Д.Н мөнгө байхгүй гээд архи авчирч өгөөгүй. Хийсэн хэрэгтээ гэмшиж байна. Надад хөнгөн ял шийтгэл оногдуулж өгнө үү гэв.

Шүүгдэгч Д.Н шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би ажлын байрны дүгнэлт гаргуулах гэж Б.Д байцаагчид бэлнээр 400.000 төгрөг өгсөн. Б.Д байцаагч надад Ж.А гэх нэртэй Голомт банкны дансны дугаар өгч, 75000 төгрөг хийчих гэснийг би өөрөөсөө мөнгө гаргаж төлсөн, надад ном өгсөн зүйл байхгүй. Б.Д 3 шил гайгүй архи аваад ир гэж хэлэхэд нь надад мөнгө байхгүй байсан тул эгч Н.рүү уйлаад би энэ талаараа хэлсэн юм.

Би Б.Д-ээс 475.000 нэхэмжлэхгүй, буруу юм хийсэндээ гэмшиж байна гэв.

Шүүгдэгч нарын хувийн байдалтай холбоотой тэдгээрийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгасан хуудас /Н хх-ийн III-231, Б.Д III-232/,

Д.Н-ийн иргэний үнэмлэхийн лавлагаа / хх-ийн 1У-27 дугаар хуудас/, Б.Д-ийн иргэний үнэмлэхийн лавлагаа /хх-ийн 1У-38 хавтас 38 / болон бусад бичгийн баримтуудыг шинжлэн судлав.

Шүүгдэгч Б.Д нь 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэр “М” групп ХХК-ны байранд байрлах “А” ХХК-ны “Б” хүнсний дэлгүүрийн ажлын байр нь илтэд стандартын шаардлагад нийцээгүй байхад стандартад нийцсэн мэтээр ажлын байрны дүгнэлт гаргаж өгөхөөр амлаж “А” ХХК-ны захирал Д.Н-ээс 475.000 төгрөгийн хээл хахууль авсан,

Шүүгдэгч Д.Н нь “А” ХХК-ны захирлаар ажиллаж байхдаа 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэр, “М” групп ХХК-ны байранд байрлах “А” ХХК-ны хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлгэж ажлын байрны дүгнэлт гаргуулах зорилгоор Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагчаар ажилладаг Б.Д-д 475.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэргүүдийг тус тус үйлдсэн болох нь шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч нарын хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд, хавтаст хэрэгт авагдаж, шүүхийн хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн, шүүх шинжлэн судалсан

Шүүгдэгч Б.Д-ийн ...2013 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр “А” ХХК-аас Баянгол дүүрэг дэх МХХ-т улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн. Б.Д байцаагч миний бие, эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч М.М нарт хүсэлтийг шийдвэрлүүлэхээр, хамтарсан шалгалт хийхээр цохогдсон. Хүсэлтийн дагуу 11 дүгээр сарын 11-ний өдөр “А” ХХК-ийн захирал Д.Н-тэй очиж, тухайн ажлын байранд хамтарсан хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг МХЕГ-аас гаргасан Худалдаалах үйл ажиллагааг шалгах 1.11 кодтой хяналтын хуудсаар хийхэд, эрсдэл бага гарсан тул дүгнэлтийг олгохоор шийдвэрлэж, Баянгол дүүргийн МХХ дээрээ ирж М.М байцаагч

болон “А” ХХК-ийн захирал Д.Н-г байлцуулан, дүгнэлтийн төслийг бэлтгэсэн. Хяналтын хуудсаар бага эрсдэлтэй дүгнэгдсэн тохиолдолд улсын байцаагчийн дүгнэлтийг үйлддэг. 2 дугаарт нь худалдааны газар, түүний үйлчилгээ 5021:2007 стандартын шаардлага хангаж байсан учраас хяналтын хуудсыг миний бие М, компанийн захирал Д.Н нар хяналтын хуудас дээр ажлын байранд байх үед гарын үсэг зурж, тамга дарсан. Тэгээд хяналтын хуудсаараа бага эрсдэлтэй үнэлэгдсэн, стандартын шаардлага хангаж байсан учраас дүгнэлтийн төслийг үйлдсэн байгаа. Дүгнэлтийн төслийг үйлдээд тасгийн ахлах Ч.Б, Хэлтсийн ахлах Г.Ө, эрх зүйч О.Г нараар хянуулаад, хэлтсийн дарга Д.Г гараар хянуулахаар дүгнэлтийн төслийг оруулахад хэлтсийн дарга ажилтай байсан учраас маргааш хүртэл буюу 12-ныг хүртэл хойшлуулсан... Тэгтэл Д.Н захирал би хүлээж байя, би дүүрэг дээр гэрчилгээгээ авах гээд эгчтэйгээ ярьчихаад байна. Манай эгч хурдан наад дүгнэлтээ аваад ир гээд байна гэсэн. Ер нь манай дүгнэлтийг үндэслэж дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс гэрээ байгуулдаг юм. Дүүрэг дээр эгчтэйгээ ярьчихаад байна, хурдан дүгнэлтээ аваад ир, захирагчийн ажлын албанаас тусгай зөвшөөрлөө авах гээд хүнтэй ярьчихсан гээд намайг яаруулаад байсан... Тухайн үед манай НМХГ-ын чиглэлийн хэлтсийн байцаагч Ж.А над руу залгасан. МУИС-ийн нэг багштай хамтран худалдааны газрын тухай ном гаргасан. Тэрнээсээ надад 5 ширхгийг заруулах гээд өгсөн. Тэр 5 ширхэг номын нэг бүрийн үнэ нь 15.000 төгрөг, нийт 75.000 төгрөг байсныг нь над руу шилжүүлээч гээд над руу мессежээр Голомт банкны дансныхаа дугаарыг явуулсан...“А” ХХК-ийн дүгнэлт хянагдаж дууссан байсан учраас тэдний дүгнэлтийг хурдан гаргах гээд “А” ХХК-ийн захирлыг гуйгаад та банк ороод ирээчээ, тэр хооронд чинь таны дүгнэлтийг бланк дээр хэвлээд байж байя гэхэд “А” ХХК-ийн захирал зөвшөөрсөн. ...Манай үйлчлэгч Ж.Ш... би 5 охинтой хүн, эгчдээ 3 шил архины туслалцаа үзүүлээч... гэж надаас гуйсан... Тэгэхээр нь би Д.Н ...ирж дүгнэлтээ авах байсан учраас би түүн рүү утсаар яриад орж ирэхдээ дэлгүүрээр дайраад 3 шил архи аваад ирээч...гэтэл Д.Н захирал за гэж хэлчээд над руу 10 минутын дараа Д.Н захирал залгаад би мөнгөгүй явж байна. Нөгөө мөнгийг чинь бичиж өгсөн дансанд чинь тушаачихлаа 3 шил архийг чинь авч

орох боломж алга гэж хэлсэн. Тэгэхээр нь би...эрх зүйч дээрээ таны ажлын байрны дүгнэлтийг гаргаад үлдээчихье. Та ирээд авчхаарай гэж хэлсэн /хх-ийн II - 78-81/ гэсэн,

Шүүгдэгч Д.Н-ийн ...2013 оны 11 сарын эхээр 7 хоногт ажлын байрны дүгнэлт гаргуулахаар хандсан. Б.Д байцаагч томилогдоод М.М, Б.Д 2 байцаагч газар дээр нь очиж үзсэн. МХХ-т өргөдлөө өгсний дараа Б.Д байцаагч над руу залгаад, танай компанийн материал над дээр цохогдсон, ажил дээрээ хүрээд ир гэсэн. Газар дээр нь очиж шалгана гэсэн, би бичиг баримтаа бүрдүүлээд, материалтайгаа хамт өгчихсөн байсан бөгөөд би өргөдөл дээрээ өөрийн утасны дугаарыг бичсэн байсан...Тэгээд ажлын байран дээр байцаагч нарыг аваад очиход жин хэмжүүр, шилэн хөргөгч, хаяг байхгүй байна, ерөнхийдөө стандарт, шаардлага хангахгүй байна гэж Б.Д байцаагч хэлсэн. ...Б.Д байцаагчтай уулзахад дүгнэлт гаргах ямар ч боломж байхгүй, шаардлага хангахгүй байна, ийм ийм стандарт, шаардлага хангаагүй гэсэн бичгээ надад хуулбарлаж өгсөн. Би тусгай зөвшөөрөл гарчих юм бол явцын дунд кассын машин хөргөгч авчихна, хаяг хийгдэж байгаа, жин хэмжүүр тавина, хувцасны өрөөг явцын дунд энд хана босгоод хийчихнэ гэж гуйсан. Тэгтэл намайг та тэгвэл шаардлагаа хангачаад ир гэж хэлсэн. Ажил тарах үед нь ...өөрөөс чинь дүгнэлтээ авчихвал болох гээд байна, боломж бололцоо юу байна гэсэн. Тэгтэл Б.Д байцаагч ярья, маргааш ир гэж байснаа, чи яах гэж байгаа юм бэ, надаа юм өгөх гэж байгаа юмуу гэсэн, тэгэхээр нь би харин тиймээ яах уу гэтэл хэд юм бэ, тоог нь хэлчих гэж Б.Д байцаагч хэлсэн. Тэгэхээр нь би мөнгө өгөх ёстой юм байна гэж бодоод тэгвэл 100-г өгье гэж хэлтэл Б.Д байцаагч наадахыг чинь авснаас аваагүй нь дээр гэж хэлсэн. Тэгээд, одоо яв яв, маргааш болъё, ярьж байгаад ир гэсэн. Тэгээд нөхөр рүүгээ яриад, мөнгө өгөх гээд байгаа юмуу гэхээр нь 100.000 төгрөг гээд хэлсэн чинь тэгэж байна, гээд хэлчихсэн. Нөхөр ажил тарж байна гээд ирээд намайг авсан. Тэгээд Б.Д байцаагчтай хаана байна уулзъя гээд залгахад, хүрээд ир гээд 10-р хороололд очиж уулзсан. Бид нар 200.000 төгрөг өгье, бид нарт дүгнэлт нь маш их хэрэгтэй байна, явцын дунд шаардлагыг нь хангая. Анх удаа ийм юм ажиллуулж байна гээд учир байдлаа хэлсэн. 200.000 төгрөг өгье гэхэд өглөө яриарай гээд л буусан. Авахгүй гэж хэлээгүй. Тэр үед мөнгө

гаргаж ирсэн зүйл байхгүй. Маргааш ажил дээр нь очоод, өрөөнд нь ороогүй, коридорт уулзаад, яах вэ гэсэн чинь чи 75.000 төгрөг Голомт банкны дансанд хийгээд өгөөч гээд картын дугаар өгсөн. Тэр үед мөнгө надад өгөөгүй. Тэр мөнгийг нь би өөрөөсөө гаргаж шилжүүлсэн. Би Голомтоос гараад Б.Д-тэй яриад ажил дээр нь очсон. Тэгтэл дутуу юмаа аваад ороод ир гэсэн. Б.Д-д мөнгө шилжүүлсэн баримтаа авах уу гэтэл яах юм бэ гэсэн. Б.Д-ээс одоо яах гэрчилгээний хуулбар ирж байгаа гээд гуйсан, тэгтэл, чи юу бодож байна вэ гэхээр нь хаашдаа шаардлагаа биелүүлээгүй байсан учраас би урд нь хэлж байсан 200.000 төгрөгөө өгье л гэж хэлсэн. Тэгтэл Б.Д 400.000 төгрөг гэрчилгээнийхээ хуулбартай аваад ир л гэж шууд хэлсэн...гэрчилгээний хуулбараа аваад, 400.000 төгрөг бэлдээд, мэргэжлийн хяналт руу орсон. Тэр үед 12 цаг 20 минут орчим болж байсан, цайны цаг болчихсон, ямар ч хүнгүй Б.Д өрөөндөө ганцаараа сууж байхад нь гэрчилгээний хуулбараа мөнгөтэйгөө Б.Д-д өгсөн. Дан 20.000-ын дэвсгэрт байсан. ...Маргааш нь 16 цагийн үед Б.Д над руу залгаад, чи БГД-ийн Тамгын газар руу ярьж хэлсэн байна, дарга сая намайг дуудаж уулзлаа, чиний баримт бичиг дээр гарын үсэг зурсан, босоо удирдлагатай газар руу тамгын газраас ярьж байна, дарга намайг загнасан, чи одоо хаана явж байна гэхээр нь 25-ын энд явж байна гэхэд чи ирээд бичиг баримтаа ав гэсэн. Тэгэхээр нь би БГД рүү яриагүй, би зүгээр л эгчдээ хэлсэн гэхэд за за чи эргэж ирээд бичиг баримтаа ав, ирэхдээ 3 шил гайгүй архи авчраарай гэсэн. Тэгэхээр нь би юу гэнээ гэхэд гоулд юмуу экс архи аваад ирээрэй гэхээр нь би утсаа тасалсан. Энэ талаар нөхөр болон Н.Б эгчид хэлсэн. Нөхөр очиж дүгнэлтээ хуулийн зөвлөхөөс нь авсан. Маргааш нь Н.Ц гэх хүнд бүх үнэнээ ярьсан...М.М гэж байцаагч юу ч яриагүй, тэр хүн ажлын байран дээр ирээд нэг цаас гаргаж ирээд бөглөөд байсан, тэрэн дээрээ гарын үсэг зурчих гэсэн. Зураад өгсөн. Тэрэнтэй нь юу ч яриагүй, надаас мөнгө төгрөг нэхсэн асуудал байхгүй...Одоо тусгай зөвшөөрөл гарсан үйл ажиллагаа явуулж байгаа /хх-ийн 11-62-68/ гэсэн,

Гэрч П.Б-ын ...Манай эхнэр компани байгуулаад, хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаа явуулах зорилгоор ажлын байранд дүгнэлт гаргуулах шаардлагатай болсон...томилогдсон байцаагч нь эхнэр рүү залгаад ажлын байрыг чинь очиж үзнэ,

хувийн машинтай чинь явна шүү, такситай явахгүй гэж анх хэлсэн гэсэн. Тэр өдрөө хүний машин гуйж тэр байцаагчийг нь ажлын байран дээр аваачсан, түрээсээр авсан учир ундаа, ус өрсөн, үйл ажиллагаа нь эхлээгүй байсан учир шаардаж байгаа хөргөгч, хэмжүүр, кассын аппарат зэргийг аваагүй байсан бөгөөд шалгадаг хуудсан дээрх юмнууд нь байхгүй байсан...Тэгэхээр нь манай эхнэр 100.000 төгрөг гэхэд нь Б.Д наадахыг чинь авснаас аваагүй нь дээр гэж хэлсэн гэсэн. Тэгээд над руу залгаад яах вэ ингэж байна гээд болсон явдлын талаар ярьсан. Ажлаа тараад Б.Д-ийн байгаа газар нь очоод, машиндаа уулзаад түүнд бүх учир байдлаа тайлбарлаад, тусгай зөвшөөрөл байхгүй учраас яаж бүх юмаа бэлдэхэв дээ тусгай зөвшөөрөл гарсны дараа шаардлагатай зүйлсээ авна шүү дээ гэж хэлээд түүнд 200.000 төгрөг санал болготол Б.Д багадаж байна гэл үү, үгүй гэл үү маргааш хариуг нь өгье гэсэн. Тэгээд маргааш өглөө нь эхнэрийг очтол Голомт банкны дансанд 75.000 төгрөг Ж.А гэж хүний дансанд хийгээд ир гээд тэрийг нь хийгээд иртэл 400.000 төгрөг бэлдээд олоод ир гэсэн гэсэн. Тэр тухай эхнэр яг тэр үед нь утасдаж хэлэхээр нь би өгөөд хэрэггүй биз дээ, чи өөрөө мэдээд хий дээ гэж хэлсэн. Б.Д байцаагч 400.000 төгрөгөө тусдаа 75.000 төгрөгөө хасахгүйгээр өгөөрэй гэж хэлсэн байсан. Тэрийг нь сонсохоор бүр аваад сурчихсан, сурмаг болчихсон байгаа юм. Тэгээд ажлын байрны дүгнэлтийг нь гаргаж өгөөгүй, тэгэхээр нь н.Б эгч рүү тэр талаар хэлчихсэн юм шиг байна лээ. н.Б эгч Т.Н даргад нь хэлээд Т.Н дарга нь цааш нь хэлсэн юм шиг байгаа юм. Тэгтэл Б.Д эхнэр рүү залгаад чи дарга руу хэлээд байхдаа яадаг юм бэ, ирж дүгнэлтээ ав, ирж авахдаа 3 шил архитай ирээрэй, экс юмуу гоулд гэдэг архитай ирж аваарай гэж хэлсэн гэсэн. Энэ тухай манай эхнэр уйлаад хэлэхээр нь утсыг нь авч залгаад чамд хангалттай өгчихөөд байхад чинь архи нэхээд байхдаа яадаг юм гэхэд би бол хангалттай авлаа гэж бодохгүй байна гэхээр нь би мөнгө төгрөгийн боломжгүй байна гэхэд тэгвэл тэгээд боломжгүйгээ хэлчихнэ биздээ гэсэн. Тэгэхээр нь би очоод авчихъя гэхэд би ажилтай гараад явлаа, хуульч дээрээ үлдээчихье гэхээр нь би орой хуульч дээрээс нь очиж авсан. /хх-ийн 1-181-184/ гэсэн,

Гэрч Д.Г-ийн ...БГД-ийн ЗДТГ-ын Т.Н 11 сарын сүүлээр 20-ны орчим байх над

руу утасдаад танай Б.Д байцаагч ААН-ийг дарамтлан 3 шил архи нэхсэн асуудлыг ярьж, та 2 хамт хүрч ирэх үү гэж утсаар ярьсан. Тухайн үед би дүүрэг дээр явж байсан учраас Тамгын газрын даргын өрөөнд ороход Засаг даргын орлогч н.Ц-ийн хамт орж ирээд, танай байцаагч хяналт шалгалт хийх явцдаа 3 шил архи нэхэж дарамталсан асуудал байна, иймд энэ байцаагчаа ажлаас нь хал, эсхүл өөр дүүрэгт шилжүүлэн ажиллуул гэж шаардсан. Би надад шууд халах эрх байхгүй, НМХГ-т одоо удирдах албан тушаалтнуудад хэлж, ёс зүйн хороогоор шалгуулж, дүгнэлт гарсны дараа хэрхэн шийдвэрлэхийг НМХГ-ын даргын тушаалаар баталгаажиж шийдвэрлэдэг гэдгийг хэлсэн...Материалыг хамгийн сүүлд би хянаад дугаар олгодог, материалаас харж байхад холбогдох бүх материалыг бүрдүүлсэн байна, дүгнэлт гаргахад шаардагдах бүх материалууд бүрэн байсан. Би муу санаалаад, м.кв нь дутуу юман дээр дүгнэлт гаргасан байж магадгүй гэж бодоод ахлах байцаагч Б, ахлах байцаагч н.Л нарыг авч, тухайн ААН дээр Т.Н даргатай уулзсан өдрөө очиж үзсэн юм. Очиж хараад плитагаар нь хэмжиж үзэхэд заал нь 38.5, агуулах нь 22 м кв бүгд нийлээд 60.5 м кв буюу стандартанд хангалттай хүрч байсан. 5021:2007 гэсэн стандартаар дэлгүүр, мини маркет бол 41 м кв-аас дээш байх ёстой. Би бодохдоо м.кв нь хүрэхгүй юман дээр өгчихөөд шантаажилсан асуудал гарсан юм болов уу гэж бодоод үзэхэд стандартын хэмжээнд нь хангалттай хүрч байсан. Б.Д-ийн бичсэн ажлын байрны дүгнэлт дээр заасан талбайн хэмжээг нь өсгөөд бичсэн байсан. Яг хэд бичсэн байсныг одоо санахгүй байна. ААН-ээс буюу Д.Н-ээс 400.000 төгрөг бэлнээр авсан, 75.000 төгрөг дансаар шилжүүлсэн асуудал ёс зүйн хороон дээр яригдсан юм байна лээ, ёс зүйн хороо нь гэмт хэргийн шинжтэй гэж үзэж, АТГ-т шилжүүлж шийдвэрлэсэн юм байна лээ./хх-н 1-185-191/ гэсэн,

Гэрч н.Б-ийн: ...Д.Н би ажлын байрны дүгнэлт авах гэж байгаа юм. Гэтэл үнэн хэлээд байгаа юмуу яагаад байгаа юм, мэргэжилтэн нь нэг гарын үсэг дутуу гээд байлгаад байна, олон өдөр явлаа, бүтдэггүй, уг нь бүх юмыг нь бүрдүүлээд өгсөн, ганцхан даргынх нь гарын үсэг дутуу байгаа, дарга байхгүй байна, болохгүй байна гээд уйлаад яриад байсан, яагаад уйлаад байгаа юм гэхэд н.Б эгчээ намайг битгий загнаарай, би тэр хүнд яаралтай бичиг баримтаа гаргуулах



гээд тэр хүнд мөнгө өгсөн, тэгсэн чинь нэмээд дахиад 3 шил архи нэхээд байна, надад 3 шил архины мөнгө байхгүй байна гэхээр нь би ямар хүнд өгсөн юм бэ, яагаад хүнд мөнгө өгсөн юм бэ, БГД-ийн Тамгын газарт нь хэл, ийм асуудал боллоо гээд хэл гэсэн. Тэгээд би Т.Н рүү утасдаж танай мэргэжлийн хяналтын байцаагч мөнгө авсан байна дээр нь 3 шил архи нэхсэн байна гэж хэлсэн. Би өөрөө Т.Н рүү утасдаад, дүүгээсээ сонссон зүйлээ хэлээд, ийм балай хүнд сурталтай чирэгдэлтэй ажиллаж болдог юмуу, ганц гарын үсэг дутаад байна гэнээ гэж хэлсэн, дүүд Т.Н-тэй утсаар ярьж зөвлөгөө ав гэсэн. Тэр үедээ бол Д.Н өөрөө мэдээд өгчихлөө гэж хэлсэн. Тэгээд Т.Н утсаар ярьж, юу нь болохгүй, яагаад ингээд яваад байгаа юм гээд тусалж өгөөрэй гээд Т.Н-д хэлж байсан. /хх-ийн 1-221-225/ гэсэн,

Гэрч Б.Ө-ийн ...Би стандартыг нь хуулбарлаж өгсөн, үүний дараа шаардлага хангаад өгчихвөл үүний дагуу тохижуулаад өгчихвөл шаардлага хангасан гэсэн дүгнэлт манайхаас гарах ёстой гэдгийг би хэлээд явуулсан. Стандартынхаа дагуу нилээн юм хийчихлээ гээд ирэхээр нь хүсэлтээ өгчих гээд өгүүлсэн. Хүсэлт нь Б.Д дээр цохогдоод ирэхээр нь утсаар яриад энэ компани чам дээр цохогдсон байна, чи боломжтой бол яаралтай үзээд өгөөч, болмоор юм байвал яаралтай гаргаад өгөөч, манай таньдаг хүн байгаа юм, болмооргүй юм байгаа бол бас дэмий шүү гэдгийг бас хэлсэн. Д.Н өөрөө манай бүх асуудал бусад юмнууд нь болчихсон, дүгнэлт л дутуу байна, хурдан гаргуулаад өгөөч гээд байхаар нь би Б.Д-тэй утсаар ярьсан. Нөхөр нь бас яриад байсан, танайх стандартын шаардлагад нийцсэн бол хамаагүй, би хэлээд хурдал гэж хэлж болно, хэрвээ хангаагүй юм бол хангаагүй гэдгээрээ л байна гэдгийг хэлсэн. Б.Д, М.М 2 үзэж ирээд дэмий юм байна, нөгөө стандартдаа хүрэхгүй юм байна гэж хэлсэн. Тэр 2-ыг ажлын байрны дүгнэлтийг гаргаж өгөх талаар гуйж, хүсэлт тавьсан зүйл байхгүй. Б.Д-д утсаар хэлсэн байсан, М.М-тэй тааралдаад, манай таньдаг хүн байгаа юм, гайгүй үзчихээд ирээрэй гэсэн. Тэрнээс хойш манай ажил дээр 2-3 өдөр байсан. Тэгээд юу болж байна гэхээр тийм тийм юм болохгүй л гэж хэлж байсан. Б.Д байцаагч дүгнэлт гаргахын өмнө ажил дээр тааралдаж байсан одоо гаргаж байнаа л гэж хэлсэн санагдаад байна. 3 шил архины талаар мэдэхгүй, Манай үйлчлэгч 3 шил архи гэж гуйсан нь үнэн юм шиг байна лээ. /хх-ийн

1-232-238/ гэсэн,

Гэрч Ж.Ш-ийн ...Манай охин хүнтэй суух болоод Б.Д-ээс надад туслаач, 3 шил архи олоод өгөөч, би цалин мөнгө буухаар мөнгө төгрөгийг нь өгье, надад туслаач гэж гуйсан. Тэр архийг олж ирж өгөөгүй, би ч аваагүй. Б.Д тэр үед би нэг хүнд хэлчихсэн байгаа, 11 сарын 12-нд авчирч өгнө гэж хэлсэн. Тэр хүн нь архи авчирч өгөөгүй. Б.Д-ээс нэг л удаа гуйсан, би хүнээс юм гуйж байгаагүй, мөнгө төгрөг муутай, яалт ч үгүй л болоод гуйсан. /хх-ийн 1-245-247/ гэсэн,

Гэрч Я.А-ын ...Д.Н-г ерөнхийдөө таньдаг хүүхэд, гэртээ 2 хүүхдээ хараад ажилгүй байдаг, дэлгүүр нээх гэсэн юм таньдаг хүн байна уу, туслаад өгөөч гэхээр нь би нэг таньдаг хүн байгаа Т.Н гэж хүн байгаа, өөрсдөө яриарай, би түүнд туслаадахаарай гэж хэлье гээд Т.Н-ийн утсыг өгсөн. Т.Н-тэй яриад туслаад өгөөрэй, ийм хүн байгаа шүү гээд Д.Н-ийн тухай хэлсэн. Би бодохдоо тэнд ажилладаг болохоор бас танилтай байлгүй дээ л гэж бодсон. Эхлээд Д.Н ярихаар нь би Т.Н-тэй ярьж хэлээд, за за миний утсыг өгчихгүй юу гэхээр нь буцаж Д.Н рүү залгаад утсыг нь өгсөн. /хх-ийн 11-1-2/ гэсэн,

Гэрч Ж.А-ын ...Б.Д надаас 9 сард ном авсан. 11 сард номоо зарагдсан уу яасан гэж асуухад Б.Д 9 сард таны ном зарагдсан, би таны мөнгийг өгөх завгүй яваад байсан юм, та надад дансны дугаараа өгчих гээд миний дансаар 75.000 төгрөг буюу 5 ширхэг номны мөнгө шилжүүлсэн байсан. Одоо 2 номны тооцоо дутуу байгаа. Б.Д 11 сард энэ номны талаар ярьсан, намайг ярьснаас хойш 1-2 хоногийн дараа шилжүүлсэн байсан. Нэг их тэр номны талаар олон яриагүй, нэг чиглэлийн байцаагч нар болохоор ярих юм их гардаг учраас их холбогдож ярьдаг. Яг номны тухай тэгж онцолж ярьсан талаараа санахгүй байна. Энэ номыг заавал зараадах гэсэн юм байхгүй, айхтар мөнгийг нь нэхээд шаардаад байсан зүйл байхгүй, номоо яасан бэ гэж л асууж байсан. Тэрнээс хойш 1-2 хоногийн дараа мөнгийг нь явуулсан байсан. Б.Д-г албадсан, мөнгө шаардсан зүйл байхгүй, хэрвээ албадаад байсан бол аль 9 сард шаардах байсан. Учиргүй мөнгөний хэрэгцээ гараад байна, одоо явуул гэсэн зүйл байхгүй. /хх-ийн II- 4-7/ гэсэн,

Гэрч Г.Б-ийн ...Б.Д байцаагчтай холбоотой "А" ХХК-аас гаргасан гомдол үндэслэлтэй байгаа юм, гэхдээ 400.000 төгрөг авсан өгсөн асуудал нотлох боломж байхгүй юм байна лээ. ААН-ээс ирүүлсэн хүсэлтийг

хугацаанд нь барагдуулж ажилласан юмуу олон хоног чирэгдүүлсэн үү үгүй юу гэдгийг харахад хуулийн хугацаанд нь хүсэлтийг нь шийдвэрлэсэн байсан. Шалгалтын дүнгээс үндэслээд санал нь юу гэж оруулсан бэ гэхээр авилгын шинжтэй байгаа учраас, манай ёс зүйн хорооны шийдвэрлэх асуудал биш учраас харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах нь зүйтэй юм байна гэж үзсэн. Би “А” ХХК-ны байранд биечилж очиж үзээгүй, хяналт шалгалт хийсэн тэмдэглэлийг үзсэн гаргасан дүгнэлтийг нь үзсэн. Стандартын хуудсыг авч шалгаагүй, үйлчилгээний талбай нь 40 м кв байсан гэж өөрсдөө ярьсан, дүгнэлт дээрээ 60 м кв гээд бичсэн байна лээ...Д.Н-ийн утас гэж 91xxxxxx гэсэн дугаарыг Б.Д байцаагч өгсөн, тэгтэл энэ утас нь нөхрийнх нь утас болчихоод нөхөр нь надад 91xxxxxx дугаарын утсыг мессэжээр ирүүлсэн. Хяналт шалгалтын тэмдэглэл дээр байгаа утасны дугаарыг энэ мөн үү гэж Б.Д-с асуухад тэр тэмдэглэл дээр байгаа утасны дугаарыг өөрөө миний дэргэд дарж хаячхаад наад утасны дугаар чинь биш гээд 91xxxxxx гэсэн дугаарыг өгсөн. Шалгалтын тэмдэглэл дээр байгаа утсыг дарчихсан байгаа. /х-II-9-14/ гэсэн,

Гэрч Т.Н-ийн ...Д.Н-тэй би ямар ч холбоогүй, түүнийг А.С гэж хамаатны хүнээр дамжуулж анх мэддэг болсон. А.С надтай энэ компанийн талаар утсаар ярьсан. н.Б-тэй бол Д.Н хамаатан. Б.Д-тэй ямар ч холбоо байхгүй, урд өмнө мэддэггүй...Өмнө ерөөсөө харьцаж байгаагүй. “А” ХХК-тай ямар ч холбоо байхгүй, би энэ компанийн хаана байдгийг ч мэдэхгүй. Манай БГД-т л гэж байгаа. Н.Б 2013.11.12-ны үдээс хойш над руу залгаад, манай дүү нар танай дүүргийн МХХ дээр очоод ажлын байрны дүгнэлт авах гэсэн чинь 3 шил архи нэхэж байна гэнээ. Бас мөнгө өгсөн гэсэн. Танай МХХ-ынхан чинь арай дэндүү байна гэж хэлсэн. Ярианы утга бол арай дэндүү байна, дэндчихсэн байна гэсэн утгатай зүйл ярьсан. Тэгээд л тэр мөнгө авсан асуудлыг нь мэдсэн, тэгээд би энэ тухай тэр байцаагч нь мөнгө авсан байна, өгсөн байна гээд удирдлагууддаа хэлсэн. Д.Г дарга манай ажлын коридорт явж байхтай нь таараад Б.Д байцаагчаа дуудаад ороод ир гэсэн, ирэхээр нь н.Ц дарга орж хэлээд хоёуланг нь байхад наад хүн чинь ААН-ээс архи нэхсэн байна, бас мөнгө авсан гэж байна, энэ бол төрийн албан хаагчийн ёс зүйд таарахгүй, бид энэ хүнтэй чинь цаашид хамтарч ажиллахгүй, та энэ асуудлыг судлаж

үзээд арга хэмжээ аваад, эргэж хариу мэдэгд гэсэн утгатай зүйл хэлсэн. Тэгсэн Б.Д та нарт буруу ойлголт өгсөн байна, би бол архи аваад ир гэж хэлсэн, гэхдээ би ирэхээр нь мөнгийг нь өгье гэж бодож байсан. Мөнгө би аваагүй, наад хүмүүс чинь намайг бүүр Голден парк хотхонд ажлын байр үзээд явж байхад надтай уулзах гээд миний хойноос дагаад яваад, гэрт хүргэж өгөөд, надад мөнгө өгөх гэхээр нь тэр мөнгийг нь өөдөөс нь шидээд машинаас нь үсрээд буусан гэсэн утгатай юм хэлсэн. Тэгэхээр нь би Б.Д-г гаргаж байгаад Д.Н-ийн утас руу залгаад, утсаа чанга яригч дээр нь тавьж байгаад Д.Г дарга, н.Ц дарга бид 3 зэрэг сонсоод, би өөрөө түүнтэй ярьсан. Тэгээд юу болсон бэ гээд яриулахад мөнгө өгсөн, архи авчир гэсэн гэж хэлсэн. Тэгэхээр нь би Д.Н-ээс мөнгө өгсөн юмуу гэж асуухад Д.Н ...400.000 төгрөг өгсөн...75.000 төгрөг А гэж хүний нэр дээр шилжүүлсэн /хх-ийн II-25-28/ гэсэн, тэдгээрийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн мэдүүлгүүд,

М.М-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан шалгаж, түүнд холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон Дүүргийн 2 дугаар прокурорын газрын 2014 оны 04 сарын 03-ны өдрийн 107 дугаартай тогтоол /хх-ийн IV-671/

2014 оны 01 сарын 17-ны өдрийн шинжээчийн дүгнэлт:

Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Б.Д, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч М.М нар хамтран тус ажлын байранд 2013.11.11-ний өдөр хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, шалгалтын тэмдэглэл үйлдэн, 2013.11.12-ны өдрийн 02-02-430/1178 тоот улсын байцаагчийн дүгнэлт гаргасан байна. Тус ажлын байр нь тухайн өдрийн шалгалтаар Монгол Улсад мөрдөгдөж байгаа Худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021:2007 стандартын хүнсний дэлгүүр /ангилал 3.2.4/-ийн стандартын шаардлага хангасан гэж дүгнэсэн байна. Тус “А” ХХК-ны “Б” хүнсний дэлгүүрийн ажлын байранд 2014.01.24-ний өдөр худалдагч нарыг байлцуулан Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Д.Ц, Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч Х.Ч бид хамтран шалгахад стандартын шаардлага

хангахгүй учир үндэслэлгүй байна. Хэмжилт хийхэд хэмжилтээр тус хүнсний дэлгүүрийн худалдааны танхимын дотор хананаас хэмжихэд өргөн нь 5.74 м, урт нь 6.7м, нийт 38.4 мкв талбайтай байгаа нь Худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021:2007 стандартын хүнсний мухлагийн стандарт шаардлагыг хангаж байна. Мөн стандартын биелэлт хэрхэн хангаж байгааг дүгнэхэд стандартын биелэлт 52 хувьтай байгаа нь стандартын шаардлага хангахгүй байна. “А” ХХК-ны “Б” хүнсний дэлгүүрийн ажлын байр нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа Худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021:2007 стандартын 4.6, 6.2, 6.6, 6.7, 7.3, 7.6, 8.1.2, 8.1.6, 8.2 зэрэг заалтуудын шаардлагыг бүрэн хангахгүй байна. /хх-ийн I-145-148/ гэсэн дүгнэлт болон бусад бичгийн нотлох баримтаар нотлогдон тогтоогдлоо.

Иймд Б.Д-г хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс хээл хахууль авсан гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар,

Д.Н-ийг албан тушаалтанд өөрөө хээл хахууль өгсөн гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар тус тус ял оногдуулж шийдвэрлэлээ.

Шүүхээс Б.Д, Д.Н нарт ял оногдуулахдаа анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн хэрэгтээ чин санаанаас гэмшиж байгаа болон тэдгээрийн хувийн байдлыг харгалзан оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж, хянан харгалзав.

Шүүгдэгч Б.Д-ээс хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 10330001xxxx тоот дансанд тушаасан 475.000 төгрөгийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар улсын орлого болгов.

Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй, битүүмжлэгдсэн хөрөнгө үгүй болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 286, 290, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Б.Д-г хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс хээл хахууль авсан гэмт хэрэгт гэм буруутайд,

Д.Н-ийг ан тушаалтанд хээл хахууль өгсөн гэмт хэрэгт гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Б.Д-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн

268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар төрийн албанд албан тушаал эрхлэх эрхийг 2 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жил 5 /тав/ сар хорих ялаар,

Д.Н-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар 2 /хоёр/ жил хорих ял тус тус шийтгэсүгэй.

3. Б.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар оногдуулсан 2 жил 5 сар хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар оногдуулсан 2 жил хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар жирийн дэглэмтэй, эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

4. Шүүгдэгч нар бусдад төлөх төлбөргүй, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй, битүүмжлэгдсэн хөрөнгөгүй, Д.Н цагдан хоригдоогүй, Б.Д 14 хоног цагдан хоригдсон болохыг тус тус дурдсугай.

5. Б.Д-ээс Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн газрын 10330001xxxx тоот дансанд тушаагдсан 475.000 төгрөгийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар улсын орлого болгосугай.

6. Б.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар оногдуулсан 2 жил 5 сарын хорих ялыг, мөн Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар оногдуулсан 2 жил хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4-д зааснаар тэнсэж, Б.Д-г 2 /хоёр/ жилийн хугацаагаар, Д.Н-ийг 1 /нэг/ жилийн хугацаагаар тус тус хянан харгалзаж тэдгээрт хяналт тавихыг Баянгол дүүрэг дэх цагдаагийн хэлтэст даалгасугай.

7. Б.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар оногдуулсан төрийн албанд албан тушаал эрхлэх эрхийг 2 жилээр хассан нэмэгдэл ялын хугацааг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2-т зааснаар шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолсугай.

8. Шүүхийн шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд тогтоолыг эс зөвшөөрвөл шийтгэх тогтоол гардуулснаас хойш 14 хоногийн

дотор Эрүүгийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд ялтан, өмгөөлөгч нар давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

9. Шүүхийн шийтгэх тогтоолд эрх

бүхий этгээд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч эсэргүүцэл бичвэл тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоолыг биелүүлэх хүртэл Б.Д, Д.Н нарт урьд бусдын батлан даалтад өгөхөөр авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр байлгасугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Ц.ДАЙРИЙЖАВ

**ЦАГААТГАХ ТОГТООЛ**

2014 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 07

Булган сум

**МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС**

Сум дундын 26 дугаар шүүхийн шүүгч Ц.Энхжаргал даргалж, тус шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар:

Нарийн бичгийн дарга Ц.Отгонжаргал

Улсын яллагчаар хяналтын прокурор Б.Оюунцэцэг

Өмгөөлөгч Д.Эрдэнэчимэг,

Л.Эрдэнэцэцэг нарыг оролцуулан, Ховд аймгийн прокурорын газраас Х овогт Ц.Т-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар, Г овогт Б.Б.Ш-д холбогдуулан Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн 201321000273 тоот эрүүгийн хэргийг 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч, хянан хэлэлцэв.

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, эмэгтэй, ...оны ...дүгээр сарын ...-нд ...аймгийн ...суманд төрсөн, ...настай, яс үндэс ..., ам бүл .../...хүүхдийн хамт/ ...аймгийн ...сумын ...баг ...тоотод оршин суух, Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгч ажилтай, аминдаа хувийн 3 өрөө сууцтай, Ховд аймгийн төвд 2 өрөө байр зэрэг хөрөнгөтэй, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, бие эрүүл, ухаан бүрэн, ПЮ..... дугаарын регистртэй Х овогт Ц.Т,

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...аймгийн ...суманд ...оны ...дугаар сарын ...ний өдөр төрсөн, ...настай, яс үндэс ..., ам бүл .../эцэг, эх ...ах ... дүүгийн хамт амьдрах/ ...аймгийн ...сумын ...нуур багт оршин суух, дээд боловсролтой, цэцэрлэгийн багш мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, сарын өрхийн орлогогүй, аминдаа хөрөнгөгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, бие эрүүл, ухаан бүрэн хэрэг хариуцах чадвартай ПМ..... дугаарын регистртэй Г овогт Б.Ш нар нь хээл хахууль авах, хээл хахууль өгөх гэмт хэргийг үйлдсэнд холбогджээ.

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Гэрч: Х.Б-ын ...Би ажилд орохоосоо өмнө хөдөө мал дээр байсан, 2012 оны 09 дүгээр сараас эхэлж Цэцэг сумын цэцэрлэгт

сахиулаар ажиллаж байна. Б.Ш-ын зан аашийн хувьд хэлэхэд дуу цөөтэй төлөв даруу зантай, олонтойгоо нийтэч байж чаддаг, харин Ц.Т эрхлэгчийн хувьд ч гэсэн хамт олонтойгоо хэвийн хэмжээнд харьцдаг, нэр хүндтэй тийм л хүн байгаа юм гэх мэдүүлэг /хх-ийн 19 хуудас/

Гэрч Д.Б-ын ...Би 2011 онд Цэцэг сумын Цэцэрлэгт туслах багшаар ажилд орсон, орохдоо эрхлэгч Ц.Т-ын тушаалаар орсон. Ажилд орохдоо Ц.Т-д мөнгө төгрөг өгөөгүй гэх мэдүүлэг /хх-ийн 22 хуудас/

Гэрч: Л.Э-ийн "... Би эрхлэгч Ц.Т-ын тушаалаар 2009 онд цэцэрлэгт тогоочоор ажилд орж ажиллаж байгаад 2013 оны 09 дүгээр сард туслах багш болсон. Ажилд орохдоо цэцэрлэгийн эрхлэгчид мөнгө төгрөг өгсөн асуудал байхгүй. Ц.Т эрхлэгч надаар цалингийн зээл авахуулж байгаагүй" гэх мэдүүлэг /хх-ийн 24 хуудас/

Гэрч: С.Т-ын ...Би 2006 онд цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-ын тушаалаар энэ байгууллагад анх галчаар ажилд орж байсан, тэгээд 2011 онд нярав болоод өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Цалингийн зээлийг би өөрийнхөө гэр бүлийн хэрэгцээнд шаардлага гарсан тохиолдолд авдаг. Тэрнээс цалингийн зээл аваад Ц.Т эрхлэгчид өгч байсан удаа байхгүй /хх-ийн 28 хуудас/

Гэрч Г.Г-ын... Би 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс Ц.Т эрхлэгчийн тушаалаар тус цэцэрлэгт нягтлан бодогчоор анх ажилд орсон цагаас хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна. Байгууллагын дотоод журамд зааснаар жилд нэг хүн суралцахад тэр хүний суралцах хугацааны цалинг бодож олгохоор заасан байдаг, эрхлэгч Ц.Т туслах багш Б.Ш нарын суралцах нь давхцсан учир арай олон жил ажилласан гэдэг утгаар нь Ц.Т-ын суралцах хугацааных нь цалинг олгосон, тодруулж хэлэхэд Б.Ш нь цалингүй сурсан юм. Харин амралтын мөнгөнөөс болж эрхлэгч Ц.Т, Б.Ш хоёр маргалдсан юм шиг байна лээ. Гэхдээ бол эрхлэгчийн зүгээс шийдвэр гарах юм бол Б.Ш-ын амралтын мөнгийг олгодог журмаар олгоно.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Аудитаас жил бүр санхүүгийн хяналт шалгалтууд ордог, хамгийн сүүлд Ховд

аймгийн МХГ-аас 2013 оны 04 дүгээр сард 2012 оны санхүүгийн баримтыг шалгасан гэх мэдүүлэг /хх-ийн 30 дугаар хуудас/

Гэрч С.У-ын ... 2012 оны 09 дүгээр сарын 06-наас эхэлж Цэцэг сумын Цэцэрлэгт Б.Ш гэх хүний орон тоон дээр туслах багшаар түр ажиллаж байгаад 2013 оны 01 дүгээр сард чөлөөлөгдсөн байсан хүн нь ажилдаа орсон болохоор би больсон. Б.Ш нь цэцэрлэгийн багшийн сургалтад УБ хотод эчнээ хэлбэрээр сурч байсан болохоор 2013 оны 02 дугаар сард эргээд сургалтдаа явсан тэр хооронд мөн адил би түр хугацаагаар эргээд ажилд орсон.

Миний хувьд гэр бүлийн хүн ажилгүй байдаг болохоор намайг ажлын түр орон тоо гарвал надад туслах үүднээс намайг 5 хоног ч бай 10 хоног ч бай хамаагүй ажиллуулдаг байсан, миний хувьд гэр бүлийн маань хүн ажилгүй байдаг болохоор ямар ч ажлыг голохгүй хийдэг. Тэрнээс надад хүнд өгөөд байх мөнгө ч байхгүй, орлого ч байхгүй, би цэцэрлэгт үндсэн ажилтнаар биш, түр ажилтнаар орох гэж байж яах гэж хүнд мөнгө өгөх юм бэ тийм зүйл огт байхгүй гэдгийг баттай хэлмээр байна. Би хэн нэгэн хүнд Ц.Т эрхлэгчид 2.0 сая төгрөг өгсөн тухай огт хэлж байгаагүй, хэрэв тэгж хэлсэн хүн байгаа бол худлаа ярьж байна гэх мэдүүлэг /хх-ийн хуу 34 хуудас/

Гэрч С.Б-ны ... Тэр үед миний дансанд 500 орчим мянган төгрөг байсан, тэрнээс их мөнгө байгаагүй, би жилдээ малынхаа ноос ноолуураар 800-900 орчим мянган төгрөгийн орлого олдог, үүнээсээ амьдрал ахуйдаа хэрэглээд үлдсэн мөнгийг нь банкинд хадгалуулчихдаг байсан учраас дансанд маань тэр үед 5000 орчим төгрөг байсан юм. Аяндаа дансны хуулгаар бүх зүйл гараад ирэх байлгүй дээ. Миний охин надаас 500.0 төгрөг авсан даруйдаа Ховд аймаг болон Улаанбаатар хот руу яваагүй гэх мэдүүлэг /хх-ийн 37-38 хуудас/

Гэрч: Л.Б-г дахин байцаасан тэмдэглэлд ... Миний санаж байгаагаар 2011 онд Засгийн газраас эх орны хишиг гэж 20,0 төгрөгийг иргэн бүрт олгож эхэлсэн тэгэхэд л ХААН банкинд данс нээлгэсэн юм. Тэгээд 2011 оны 02 дугаар сараас хойш хугацааны дансны хуулга гарч ирээд байгаа юм гэх мэдүүлэг/хх-ийн 40 хуудас/

Баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл /хх-ийн 73 хуудас/

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалын хуулбарууд /хх-ийн 75-82 хуудас/

Ц.Т-ын банкны дансны хуулгууд /хх-ийн 84-98 хуудас/

Л.Б-ын дансны хуулга /хх-ийн 99-102 хуудас/

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Ш мэдүүлэхдээ: Би 2010 онд Ховд Их сургуулийг төгсөж 2010 оны намар цэцэрлэгт ажиллаж байгаад 2011 оны 11 дүгээр сард сургуульд яваад 2012 оны 06 дугаар сард төгссөн. Ажиллаж байх хугацаандаа 1.0 сая төгрөг Ц.Т-д өгсөн. Мөн ээжийнхээ нэрээр Ц.Т-ын дансанд мөнгө хийсэн. Намайг ажиллаж байх хугацаанд янз бүрийн дарамт үзүүлдэг байсан. Туслах багшийн бүр орон тоонд ажилд ороод мөнгөө өгсөн. Би амралтын мөнгөө аваагүй гэх мэдүүлэг.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Ц.Т мэдүүлэхдээ: Би хахууль аваагүй. Цэцэрлэгт мэргэжлийн багш байхгүй болохоор багш н.Б-ын оронд Б.Ш-ыг түр авч ажиллуулсан. 3 багш зэрэг сургуульд суралцах болсон тул багш дутагдалтай байсан. 2010 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн тушаал гаргаж авч ажиллуулсан. Багш нар ирэхээр чөлөөлөгдөөд гарсан. Б.Ш нь янз бүрийн ажил хийдэг байсан.

2013 онд ашиг сонирхлын тухай хууль гарсантай холбогдуулан санал тавьсан, ажлаас халсан тушаал гаргаагүй. Суманд төрийн алба төрлийн алба боллоо гэдэг яриа гарсан учраас би Б.Ш-д санал тавьсан. Суралцах хугацаанд нь цалинг нь өгч байсан. Цэцэрлэгийн багш мэргэжилтэй хүн ажиллах шаардлага тавигддаг. Бид төрөл садан хүмүүс юм. 1997 онд энэ айлын бэр болсон. Миний хань ажлаа хийж байгаад өвчний улмаас нас барсан гэх мэдүүлэг зэрэг болно.

Шүүгдэгч Б.Ш нь албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн,

Шүүгдэгч Ц.Т нь албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж Ховд аймгийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлжээ.

Шүүгдэгч Б.Ш нь Ц.Т-д 1.0 сая төгрөгийн хээл хахууль өгсөн 500.000 төгрөгийг ааваасаа авч өгсөн 500.000 төгрөгийг увуулж цувуулж өгсөн гэж мэдүүлж байгаа боловч:

500.000 төгрөгийг эцэг Л.Б-ын данснаас

авч өгсөн гэх мэдүүлэг нь

Гэрч Л.Б-ын "...Тэр үед миний дансанд 500 орчим мянган төгрөг байсан, тэрнээс их мөнгө байгаагүй, би жилдээ малынхаа ноос ноолуураар 800-900 орчим мянган төгрөгийн орлого олдог, үүнээсээ амьдрал ахуйдаа хэрэглээд үлдсэн мөнгийг нь банкинд хадгалуулчихдаг байсан учраас дансанд маань тэр үед 500 орчим мянган төгрөг байсан юм. Аяндаа дансны хуулгаар бүх зүйл гараад ирэх байлгүй дээ" гэх мэдүүлэг

Гэрч: Л.Б-ыг дахин байцаасан тэмдэглэлд ...Миний санаж байгаагаар 2011 онд Засгийн газраас эх орны хишиг гэж 20,0 төгрөгийг иргэн бүрт олгож эхэлсэн, тэгэхэд л ХААН банкинд данс нээлгэсэн юм. Тэгээд 2011 оны 02 дугаар сараас хойшхи хугацааны дансны хуулга гарч ирээд байгаа юм гэх мэдүүлгээр Б.Ш нь эцэг Л.Б-аас 500.000 төгрөг авч, ажилд орохын тулд Ц.Т-д өгсөн нь нотлогдохгүй, гэрч Л.Б-ын мэдүүлгээр үгүйсгэгдэж байна.

Шүүхийн хэлэлцүүлэгт Б.Ш-ын мэдүүлсэн би байнгын ажлын орон тоонд орохдоо 500.000 төгрөгийг өгсөн юм байна, мөн ээжийнхээ нэрээр мөнгө өгсөн гэх мэдүүлэг нь гэрч Л.Б-ы ...Манай охин Б.Ш нь ааваа би ажилд орохоор боллоо хэдэн төгрөг хэрэгтэй байна гэж хэлэхээр данснаас 500.000 төгрөг аваад охиндоо өгсөн. Хэнд өгөх гэж байгаа талаараа хэлээгүй. Тэгтэл 2013 оны хавар охин маань сургалтад явж ирээд ажилдаа орж чадаагүй мөн халагдчихлаа гээд бага зэргийн асуудал тулгарсан тэгэхэд харин надад хэлэхдээ таниас авсан 500.000 төгрөгийг цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-д өгсөн гэж хэлсэн гэх мэдүүлгээр байнгын ажлын орон тоонд орохдоо 500.000 төгрөгийг өгсөн гэх мэдүүлэг нь үгүйсгэгдэж байх тул Гэрч Л.Б-ын мэдүүлгийг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой хуульд заасан журмын дагуу авагдсан мэдүүлэг гэж үнэлэв.

Харин гэрч Л.Б данснаасаа 500.000 төгрөг гаргаж өгсөн гэж мэдүүлж байгаа ч ХААН банкны дансны хуулга нь 2011 оны 2 дугаар сараас эхлэн дансны гүйлгээ хийгдсэн, мөн гэрч Л.Б-аас хууль сануулж авсан мэдүүлэгт 2011 онд Засгийн газраас эх орны хишиг гэж иргэн бүрт 20.0 төгрөг олгож эхэлсэн, тэгэхэд ХААН банкинд данс нээлгэсэн юм гэх мэдүүлэг нь Л.Б-ын дансанд эх орны хишиг гэж 20800 төгрөг сар бүр орлогоор орж байсан байдлаас дүгнэхэд гэрчийн мэдүүлэг нь хэрэгт хамааралтай мэдүүлэг болно.

2011 оны 08 дугаар сарын 03-нд 700.000 төгрөг, 2011 оны 08 дугаар сарын 04-нд 600.000 төгрөг, 2011 оны 08 дугаар сарын 26-нд 100.000 төгрөг, 2011 оны 09 дүгээр сарын 01-нд 100.000 төгрөг, 2011 оны 09 дүгээр сарын 29-нд 250000 төгрөг, 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 600.000 төгрөг, 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 1.000.000 төгрөгийн зарлагын гүйлгээ хийж байсан болох хавтаст хэрэгт авагдсан дансны хуулгаас харахад 2011 оны 08 дугаар сарын 03-ны өдөр Л.Б-ын дансанд гахайн аж ахуйн төслийн 4.400.000 төгрөгнөөс зарлагын гүйлгээ байнга хийгдсэн байгааг нь шүүгдэгч Б.Ш-ын би мөнгө өгсөн он сар өдрөө андуурсан байна. 2011 оны 10 дугаар сард 500.000 төгрөг өгсөн юм байна гэх мэдүүлэг нь үндэслэлгүй, эрхлэгч Ц.Т-д 500.000 төгрөг өгсөн нь нотлогдохгүй, дансны хуулгаар 500.000 төгрөг бэлнээр гарсан гүйлгээ байхгүй байна.

Ц.Т-ын дансанд ээжийнхээ нэрээр мөнгө шилжүүлсэн гэж мэдүүлж байгаа боловч хавтаст хэрэгт авагдсан Ц.Т-ын дансны хуулганаас үзэхэд Б.Ш-ын ээж н.О-оос 200.000 төгрөг шилжүүлсэн баримт байхгүй байгаа нь үлдэх 500.000 төгрөгийн 200.000 төгрөгийг дансаар хийсэн гэх үйлдэл нь тогтоогдохгүй байна.

Б.Ш нь тус цэцэрлэгт түр ажилчнаар ажиллаж байсан болох нь хавтаст хэрэгт авагдсан 2011 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 12 дугаартай Ховд аймгийн Цэцэг сумын хүүхдийн Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаал, мөн цалин авч байсан тухай бичилттэй нийгмийн даатгалын 073xxxxx тоот дэвтэр зэргээр нотлогдож байх тул би бүр орон тооны ажилд ороод хахууль өгсөн гэдэг мэдүүлэг нь үгүйсгэгдэж байна.

Иймд шүүгдэгч Б.Ш-д зүйлчилж ирүүлсэн Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар хахууль өгсөн үйлдэл нь нотлогдохгүй байх тул:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 82 дугаар зүйлийн 82.2-д зааснаар яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болно.

Харин эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүгдэгч Ц.Т-ын Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан нь хавтаст хэрэгт авагдсан 2010 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаартай Ховд аймгийн Цэцэг сумын хүүхдийн Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаал, 2010 оны цалингийн хүснэгтээр 132424 төгрөгийн цалинг гарын үсэг зурж авч байсан нотлох баримтаар албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх гэсэн үйлдэл тогтоогдохгүй байна.

Мөн Б.Ш нь байнгын орон тоонд ажиллаж байгаагүй, түр ажилчнаар ажилладаг байсан нь 2012 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 22 тоот тушаал, 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 19 тоот тушаал, 2011 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 17 тоот тушаал, 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 16 тоот түр ажилчин авах тухай тушаалуудаар нотлогдож байхад Ц.Т-г албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах үндэслэлгүй байна.

Харин шүүгдэгч Ц.Т нь Б.Ш-ын цалингийн зээл авахад нь 1.500.000 төгрөгийг зээлж аваад, буцаан өгсөн нь шүүгдэгч нарын шүүх хуралдаанд мэдүүлсэн мэдүүлгээр нотлогдож байна.

Шүүгдэгч Б.Ш-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад

тогтоогдохгүй, субъектив талын шинж байхгүй байх тул шүүгдэгч Б.Ш-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэлтэй гэж шүүх дүгнэв.

Шүүхэд эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй, битүүмжилсэн эд хөрөнгөгүй болохыг дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1, 248 дугаар зүйлийн 248.1.2, 283, 284, 286, 290.4, 295-299 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүгдэгч Б.Ш-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож,

Шүүгдэгч Ц.Т-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, тус тус цагаатгасугай.

2. Шүүгдэгч нарын бичиг баримт шүүхэд шилжиж ирээгүй, шүүгдэгч нар нь цагдан хоригдсон хоноггүй, гаргуулах хохирол, төлбөргүй, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн зүйлгүй болохыг дурдсугай.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 249 дүгээр зүйлийн 249.1-д зааснаар Ш.Б, Ц.Т нарт батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авсныг тус тус хүчингүй болгосугай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 299 дүгээр зүйлийн 299.3-д зааснаар цагаатгах тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд мөн хуулийн 303 дугаар зүйлийн 303.3, 304 дүгээр зүйлийн 304.1-д зааснаар тогтоолыг эс зөвшөөрвөл цагаатгагдсан этгээд, түүний өмгөөлөгч тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор аймгийн шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг мэдэгдсүгэй.

ДАРГАЛАГЧ

Ц.ЭНХЖАРГАЛ



## МАГАДЛАЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 48

Жаргалант сум

Ц.Т, Б.Ш нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн шүүх хуралдааны бүрэлдэхүүнд:

Даргалагч Ерөнхий шүүгч:

Д.Жамбалсүрэн

Шүүгчид: Н.Мөнхжаргал, Б.Дамба

Оролцогчид:

Нарийн бичгийн дарга: Д.Төгс-Эрдэнэ

Прокурор Б.Ууганбаяр

Өмгөөлөгч: Д.Эрдэнэчимэг,

Л.Эрдэнэцэцэг

Цагаатгагдсан этгээд: Ц.Т, Б.Ш

Сум дундын 26 дугаар шүүхийн шүүгч Ж.Энхжаргал даргалж, шийдвэрлэсэн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар цагаатгах тогтоолыг эс зөвшөөрч бичсэн улсын яллагчийн эсэргүүцлийг үндэслэн, Х овогт Ц.Т, Г овогт Б.Ш нарт холбогдох 201321000273 дугаартай хэргийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүх 2014 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авч, шүүгч Б.Дамбын илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, эмэгтэй, ...оны ...дүгээр сарын ...-нд ... аймгийн ...суманд төрсөн, ...настай, яс үндэс..., ам бүл .../...хүүхдийн хамт/ ...аймгийн ...сумын ...баг ...тоотод оршин суух, Ховд аймгийн Цэцэг сумын цэцэрлэгийн эрхлэгч ажилтай, аминдаа хувийн 3 өрөө сууцтай, Ховд аймгийн төвд 2 өрөө байр зэрэг хөрөнгөтэй, улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, бие эрүүл, ухаан бүрэн, ПЮ..... дугаарын регистртэй Х овогт Ц.Т,

2. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...аймгийн ...суманд ...оны ...дугаар сарын ...-ний өдөр төрсөн, ...настай, яс үндэс ..., ам бүл ... /эцэг, эх ...ах ...дүүгийн хамт амьдрах/ ...аймгийн ...сумын ...нуур багт оршин суух, дээд боловсролтой, цэцэрлэгийн багш мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, сарын өрхийн орлогогүй, аминдаа хөрөнгөгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, бие эрүүл, ухаан бүрэн хэрэг хариуцах чадвартай ПМ..... дугаарын регистртэй Г овогт Б.Ш нар нь хээл хахууль авах, хээл хахууль өгөх гэмт хэргийг үйлдсэнд холбогджээ.

Уг хэргийг анхан шатны шүүх: Шүүгдэгч Г овогт Б.Ш-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Х овогт Ц.Т-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, тус тус цагаатгаж, шүүгдэгч нарын бичиг баримт шүүхэд шилжиж ирээгүй, шүүгдэгч нар нь цагдан хоригдсон хоноггүй, гаргуулах хохирол, төлбөргүй, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн зүйлгүй болохыг дурдаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 249 дүгээр зүйлийн 249.1-д зааснаар Б.Ш, Ц.Т нарт батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авсныг тус тус хүчингүй болгож, давж заалдах эрхтэйг дурдаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхэд прокурор бичсэн эсэргүүцэлдээ: Анхан шатны шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаартай цагаатгах тогтоолыг 2014 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авч танилцаад дараах үндэслэлээр эс зөвшөөрч, улсын яллагчийн эсэргүүцэл бичиж байна. Үүнд:

Цагаатгах тогтоолд заасан үндэслэлийн талаар: Шүүгдэгч Ц.Т нь Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллахдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс, урьдчилан амлалгүйгээр тус сумын иргэн Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 2011 оны 09 дүгээр сард 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авсан нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдохгүй, хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах үндэслэлгүй, мөн Б.Ш-т прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад тогтоогдохгүй, субъектив талын шинж байна.

Иймд Ц.Т, Б.Ш нарт холбогдох эрүүгийн 201321000273 дугаартай хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгах нь хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнээд хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Ц.Т, Б.Ш нарыг цагаатгасугай гэжээ.

Улсын яллагчийн зүгээс Сум дундын 26 дугаар шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаартай "Цагаатгах тогтоол" нь хууль зүйн үндэслэлгүй, хэрэгт цугларсан бичгийн нотлох баримтуудыг шүүхээс бүрэн шинжлэн судлалгүйгээр, үндэслэлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Ц.Т, Б.Ш нарыг цагаатгасан гэж дүгнэхээр байна.

Тухайлбал: Шүүгдэгч Ц.Т нь Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллахдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс, урьдчилан амлалгүйгээр иргэн Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 2011 оны 09 дүгээр сард 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авсан, шүүгдэгч Б.Ш нь Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр түр ажилтнаар ажилд орохын тулд тус сумын цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-д 1.000.000 төгрөгийн хээл хахуулийг өөрөө өгсөн гэмт хэрэг үйлдсэн болох нь хэрэгт авагдсан:

Яллагдагч Б.Ш-ын: "...Би 2010 оны 06 дугаар сард Ховд Их сургуулийг төгссөн, тэгээд ажил олдохгүй байсан учраас Цэцэг сум руу гэрлүүгээ харьсан. Цэцэг суманд 2010 оны 10 дугаар сар хүртэл хугацаанд ямар нэгэн ажил эрхлээгүй, тэгж байгаад намар нь цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр түр ажилтнаар ажилд орсон. Тухайн үед цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т нь надаас шууд мөнгө нэхээгүй ч гэсэн ямар нэгэн байдлаар дарамт үүсгээд байсан болохоор би эхлээд ажилд оруулж өгсөнд баярлалаа гээд 500.000 төгрөг өгсөн. Нийт 1.000.000 сая төгрөгийг Ц.Т эрхлэгчид бэлнээр өгсөн. Би өмнө нь өгсөн мэдүүлэгтээ ааваас мөнгө авахдаа Ц.Т эрхлэгчид өгөх гэж байгаа гэдгээ хэлээгүй, буруу хэлсэн байна, харин сүүлд намайг ажлаас халах тухай Ц.Т захирлыг хэлэхэд би аавд бүх үнэнийг хэлсэн юм...." гэх мэдүүлэг /хавтаст хэргийн 60 дугаар хуудас/

Гэрч Л.Б-ны: "...Б.Ш нь ааваа би ажилд орохоор боллоо хэдэн төгрөг хэрэгтэй байна гэж хэлэхээр нь би өөрийнхөө "Хаан" банкны дансанд байсан хэдэн төгрөгнөөс 500.000 төгрөгийг аваад охиндоо өгсөн. Би тэр мөнгийг юунд зарцуулах гэж байгаа талаар ч асуугаагүй, охин маань ч гэсэн яах гэж байгаа талаараа надад хэлээгүй. Тэгтэл 2013 оны хавар охин маань сургалтад явж ирээд ажилдаа орж чадаагүй, халагдчихлаа гээд бага зэргийн асуудал тулгарсан, тэгэхэд харин надад хэлэхдээ танаас авсан 500.000 төгрөгийг ажилд орохын тулд цэцэрлэгийн

эрхлэгч Ц.Т-д өгсөн гэж хэлсэн. Би тэр үед л охин маань Ц.Т-д 500.000 төгрөг өгч ажилд орсон юм байна гэдгийг ойлгосон..." гэх мэдүүлэг /хавтаст хэргийн 37 дугаар хуудас/

Дахин өгсөн мэдүүлэгтээ: "...2011 оны 09 дүгээр сарын 30-нд 500.000 төгрөгийг охиндоо авч өгсөн байна. Тэр үед ямар ч байсан сарын сүүлч байсан гэдгийг бол тод санаад байгаа юм, тэгээд данснаасаа 600.000 төгрөгийг аваад 500.000 төгрөгийг нь охиндоо өгсөн. Би сая охиноосоо дахин дахин лавлаж асуухад Ц.Т-д 1.000.000 төгрөг өгсөн гээд байгаа юм. Миний хувьд бол охиндоо 500.000 төгрөгнөөс өөр мөнгө төгрөг өгөөгүй..." /хавтаст хэргийн 39 дугаар хуудас/

Л.Б-ы "ХААН" банк дахь 585903xxxx тоот дансаар 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн зарлагаар гарсан гүйлгээ /хх-100 дугаар хуудас/ зэрэг бичгийн нотлох баримтууд болон хавтаст хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудаар бүрэн тогтоогдсон байна.

Хээл хахууль авах гэмт хэрэг нь албан тушаалтан хууль бус үйл явдлаа хийж, бодит хор уршиг бий болгосон эсэхийг харгалзахгүй, хээл хахууль авснаар бүрдэл төгсдөг, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд гэм буруутай этгээд нь хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын дагуу өөрийн эрхэлж байгаа албан тушаалын эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэх ёстой үүргээ биелүүлэхээс татгалзаж, өөртөө шууд эд материалын болон материаллаг бус ямар нэг ашиг олохыг хэлнэ.

Харин объектив тал нь албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргээ гүйцэтгээгүй, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан үйлдлээр илрэх бөгөөд халдлагын зүйл нь хууль бус үйлдэл хийлгэх зорилгын үүднээс өгсөн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас болон эд хөрөнгийн шинжгүй, үнэ төлбөргүй үзүүлсэн ажил, үйлчилгээ зэрэг байна.

Субъектив тал нь хээл хахууль өгөгчид ашигтай үйлдэл, эс үйлдэхүй хийх, эсвэл түүнийг хамгаалах зорилгоор эд хөрөнгийн хууль бус ашиг олж байгаагаа ухамсарлан ойлгож, хээл хахууль авахыг хүссэн шууд санаатай хэлбэртэй байдаг гэж,

Харин хээл хахууль өгөх гэмт хэргийн объектив тал нь хээл хахууль өгч байгаа үйлдэл байх ба хахуулийн зүйл нь төгрөг, валют, алт, мөнгө, үнэт зүйлс, эд хөрөнгө

болон эд хөрөнгийн бус эрх гэх мэт зүйлс байна. Субъектив тал нь зөвхөн гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илрэх бөгөөд тухайн хахууль өгөгч нь өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулыг урьдаас мэдэж, түүнийгээ туйлд нь хүргэхийг хүсэж албан тушаалтанд хахууль өгсөн гэмт санаа, үйлдэл байна гэж тус тус тайлбарласан байна.

Хавтаст хэрэгт авагдсан Б.Ш-ын Ц.Т-д 1.000.000 сая төгрөгийн хахууль өгсөн гэж буруугаа хүлээн зөвшөөрч, удаа дараа тогтвортой өгсөн мэдүүлгүүд, мөн Ц.Т нь Б.Ш-аас хахууль аваагүй гэх өөрийн гэм буруугүй байдлаа нотлон харуулсан баримт гаргаж өгч чадаагүй байдал, мөн энэ хэрэг нь нууц, далд аргаар үйлдэгддэг, энэ төрлийн гэмт хэргийн субъект нь төрийн албаны эрх бүхий албан тушаалтан байдаг /тусгай субьекттэй/ зэрэг бодит нөхцөл байдлуудыг үнэлж үзэхэд дээрх гэмт хэрэг нь төгс үйлдэгдсэн болох нь тогтоогдож байна гэж дүгнэх хууль зүйн үндэслэлтэй юм.

Шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Ш нь Ц.Т-ын дансанд өөрийн ээж н.О-ы нэрээр 100.000 төгрөг шилжүүлсэн гэж мэдүүлсэн байхад шүүгч нь шүүгдэгч Б.Ш нь өөрийн ээж н.О-ы нэрээр 200.000 төгрөг шилжүүлсэн баримт байхгүй мөн дансаар шилжүүлсэн үйлдэл тогтоогдохгүй гэж ойлгомжгүй байдлаар тогтоолд дурджээ.

Гэтэл анхан шатны шүүх шүүгдэгч Ц.Т нь Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллахдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс, урьдчилан амлалгүйгээр тус сумын иргэн Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 2011 оны 09 дүгээр сард 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авсан хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдохгүй, хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах үндэслэлгүй, мөн Б.Ш-т прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад тогтоогдохгүй, субъектив талын шинж байхгүй байх тул хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэлтэй гэж дүгнэсэн нь ойлгомжгүй бөгөөд хууль зүйн үндэслэлгүй дүгнэлт болсон гэж үзэхээр байна.

Хоёр. Цагаатгах тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй, уг хуулийг ноцтой зөрчсөн талаар:

Сум дундын 26 дугаар шүүх нь Эрүүгийн 201321000273 дугаартай хэргийг хэрэгсэхгүй болгосон "Цагаатгах тогтоол"-ынхоо тогтоох хэсэгт шүүгдэгч Ц.Т, Б.Ш нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохоор дурдсан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн аль зүйл, хэсгийг үндэслэл болгон цагаатгаж буйгаа дурдалгүйгээр орхигдуулсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1 дэх хэсэгт заасан "шүүх хуралдаанаас хэргийг хэрэгсэхгүй болгохдоо энэ хуулийн 24.1.1-24.1.4-т заасан байдал, 208.1.2, 208.1.3-т заасан байдал, улсын яллагч энэ хуулийн 239.4.1-д заасан үндэслэлээр яллахаас татгалзсан бол" хэргийг хэрэгсэхгүй болгоно гэсэн хуулийн заалтыг зөрчсөн, цагаатгах тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан "Шүүхийн тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байна" гэсэн хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Иймд Сум дундын 26 дугаар шүүхийн цагаатгах тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй, хууль зүйн үндэслэлгүй байх тул Ц.Т, Б.Ш нарт холбогдох Эрүүгийн 201321000273 дугаартай хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Ц.Т, Б.Ш нарыг цагаатгасан Сум дундын 26 дугаар шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаартай хэргийн "Цагаатгах тогтоол"-ыг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр хэргийг дахин хэлэлцүүлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303 дугаар зүйлийн 303.1, 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон улсын яллагчийн эсэргүүцэл бичив гэжээ.

Цагаатгагдсан этгээд Ц.Т-ын өмгөөлөгч Д.Эрдэнэчимэг улсын яллагчийн эсэргүүцэлд холбогдуулан гаргасан тайлбартаа: Сум дундын 26 дугаар шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаартай цагаатгах тогтоох хууль ёсны үндэслэл бүхий гарсан гэж үзэж байна.

Шүүгдэгч Ц.Т нь Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байхдаа Б.Ш-аас 1.000.000 төгрөгийн хээл хахууль авч Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшаар ажилд авсан гэх үйлдэл нь хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдоогүй, Б.Ш нь Ц.Т-д 1.000.000 төгрөг өгсөн гэдгээ нотолж чаддаггүй, хахууль өгсөн хугацаагаа зөрүүтэй мэдүүлдэг.

Б.Ш нь Ц.Т-д 1.000.000 төгрөгийн

хахууль өгөхдөө 500.000 төгрөгийг өөрийн аав Л.Б-ы данснаас гаргуулж өгсөн гэж мэдүүлдэг, эцэг Л.Б нь өөрийнхөө данснаас 500.000 төгрөг гаргаж охин Б.Ш-т өгсөн гэдэг боловч үүнийгээ нотолж чаддаггүй.

Шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Ш нь Ц.Т-ын дансанд эх н.О-гийн нэрээр 100.000 төгрөгийг 2 удаа хийж байсан гэж мэдүүлдэг боловч энэ мэдүүлэг нь бусад нотлох баримтаар нотлогддоггүй.

Хээл хахууль авах гэмт хэргийн бүрэлдхүүний гол шинж нь албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө буюу бусдаар дамжуулан хээл хахууль авсан байдаг.

Ц.Т нь Б.Ш-аас хээл хахууль авсан гэдэг нь нотлогдоогүй.

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг зөв хэрэглэсэн.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байх хуулийн шаардлага хангасан тогтоолыг шүүх гаргасан гэж үзэж байна.

Шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.2-т заасныг үндэслэн Ц.Т, Б.Ш нарт холбогдуулсан хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан нь хууль зүйн үндэслэлтэй гэж үзэж байна.

Иймд 2014 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дугаартай улсын яллагчийн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж өгнө үү гэжээ.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон прокурор дүгнэлтдээ: Хэрэгт авагдсан нотлох баримтуудаар Ц.Т, Б.Ш нь гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдсон байхад тэдгээрт холбогдох хэргийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон. Мөн шүүх тэдгээрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хуулийн зүйл заалт баримтлаагүй нь тогтоол хууль ёсны ба үндэслэл бүхий байх хуулийн шаардлага хангаагүй байна. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж өгнө үү гэв.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон өмгөөлөгч Д.Эрдэнэчимэг гаргасан тайлбартаа: Анхан шатны шүүх Ц.Т нарт холбогдох хэрэгт үндэслэлтэй дүгнэлт хийж

шийдвэрлэсэн тул тогтоолыг хэвээр үлдээж өгнө үү гэв.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон өмгөөлөгч Л.Эрдэнэцэцэг гаргасан тайлбартаа: Хэрэгт авагдсан нотлох баримтуудаар Б.Ш-ын үйлдсэн гэмт хэрэг нь нотлогдоогүй тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж өгнө үү гэв.

#### ХЯНАВАЛ:

Анхан шатны шүүхээс Ц.Т, Б.Ш нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Ховд аймгийн прокурорын газраас Ц.Т-ыг Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллахдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс, урьдчилан амлалгүйгээр Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 2011 оны 09 дүгээр сард 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авсан, Б.Ш-ыг Ховд аймгийн Цэцэг сумын Цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр түр ажилтнаар ажилд орохын тулд тус сумын цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-д 1.000.000 сая төгрөгийн хээл хахуулийг өгсөн гэмт хэрэг үйлдсэн нь яллагдагч Б.Ш-ын мэдүүлэг, гэрч Л.Б-ы мэдүүлэг, Л.Б-ы "ХААН" банк дахь 585903xxxx тоот дансаар 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн зарлагаар гарсан гүйлгээ зэрэг нотлох баримтуудаар нотлогдсон гэж үзэн, яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна.

Гэтэл хэрэгт авагдсан дээрх нотлох баримтуудаар Ц.Т, Б.Ш нарын үйлдсэн гэмт хэрэг нотлогдсон гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байна. Учир нь:

1. Гэрч Л.Б нь өөрийн охин Б.Ш-т 2-3 жилийн өмнө 500.000 төгрөг өгсөн боловч энэ мөнгийг тухайн үед цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-д өгсөн гэдгийг мэдээгүй, харин ажлаас халагдсаны дараа Ц.Т-д өгсөн гэдгийг охин Б.Ш-аас сонссон талаар мэдүүлсэн байх тул Л.Б-ы мэдүүлэг нь дамжмал нотлох баримт болж байна.

2. Л.Б-ны "ХААН" банк дахь 585903xxxx тоот данснаас 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 600.000 төгрөгийн зарлага гарсан боловч уг мөнгийг өөрийн охин Б.Ш болон цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т нарт өгсөн болох нь нотлогдоогүй байна.

3. Б.Ш нь туслах багшийн орон тоон дээр анх түр ажилд орох үедээ Ц.Т-д 500.000 төгрөг өгөөд дараа нь цувуулж 500.000 төгрөг

өгсөн гэх боловч хэрэгт авагдсан мөрдөн байцаагчийн 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн "баримт бичигт үзлэг" хийсэн тухай тэмдэглэл, Ховд аймгийн Цэцэг сумын хүүхдийн Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаал зэргээр Б.Ш нь 2011 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр анх ажилд орсон байх бөгөөд дээрх дансны гүйлгээ нь 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр буюу Б.Ш-ыг ажилд орсноос хойш 7 сарын дараа хийгдсэн байх тул Б.Ш-ыг ажилд орохдоо аав Л.Бу-аас 500.000 төгрөг авч, Ц.Т-д өгсөн гэх мэдүүлэг нь үгүйсгэгдэж байна.

Б.Ш-ын "Ц.Т-д 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хахууль өгсөн" гэх мэдүүлэг нь хэрэгт байгаа бусад нотлох баримтуудаар батлагдаагүй тул зөвхөн яллагдагч Б.Ш-ын мэдүүлгийг үндэслэн Ц.Т-ыг Ховд аймгийн Цэцэг сумын цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байхдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс, урьдчилан амлалгүйгээр Б.Ш-ыг тус сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 2011 оны 09 дүгээр сард 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авсан гэж яллах хууль зүйн үндэслэлгүй байна.

Ц.Т нь Б.Ш-ыг туслах багшийн орон тоон дээр ажиллуулахдаа 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хахууль авсан гэдэг нь нотлогдоогүй тул Б.Ш-ыг Ховд аймгийн Цэцэг сумын цэцэрлэгт туслах багшийн орон тоон дээр түр ажилтнаар ажилд орохын тулд цэцэрлэгийн эрхлэгч Ц.Т-д 1.000.000 /нэг сая/ төгрөг өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх боломжгүй, энэ үйл баримт нь нотлох баримтаар нотлогдоогүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байна.

Иймд, прокурорын эсэргүүцлээс "Ц.Т, Б.Ш нарын үйлдсэн гэмт хэрэг нь нотлогдсон байхад шүүх үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон" гэх хэсгийг хүлээн авах боломжгүй байна.

Харин анхан шатны шүүх Ц.Т, Б.Ш нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хуулийн ямар үндэслэлээр хэрэгсэхгүй болгож байгаа нь тодорхойгүй, тогтоох

хэсэгтээ хуулийн зүйл, заалт баримтлаагүй байх тул прокурорын эсэргүүцлийн "анхан шатны шүүх Ц.Т, Б.Ш нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн аль зүйл хэсгийг үндэслэл болгон цагаатгаж буйгаа дурдаагүй, хуулийн зүйл заалт баримтлаагүй" гэх хэсгийг хүлээн авах боломжтой байх тул шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулан зөвтгөх нь зүйтэй байна гэж шүүх дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Сум дундын 26 дугаар шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.2 гэснийг 248 дугаар зүйлийн 248.1.1 гэж, тогтоолын тогтоох хэсгийн 1 дүгээр заалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан Ховд аймгийн Прокурорын газраас Ц.Т-д Эрүүгийн хуулийн 268 дүгээр зүйлийн 268.1, Б.Ш-т Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 201321000273 тоот хэргийг хэрэгсэхгүй болгож, Ц.Т, Б.Ш нарыг цагаатгасугай гэж тус тус өөрчилсүгэй.

2. Шийтгэх тогтоолын бусад зүйл заалтыг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлээс "Ц.Т, Б.Ш нарын үйлдсэн гэмт хэрэг нь нотлогдсон байхад шүүх үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон" гэх хэсгийг хэрэгсэхгүй болгосугай.

3. Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл магадлалыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор ялтан болон хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, улсын яллагч, эсхүл дээд шатны прокурор нь эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Д.ЖАМБАЛСҮРЭН  
Н.МӨНХЖАРГАЛ  
Б.ДАМБА

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 11 өдөр

Дугаар 0098

Булган сум

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 21 дүгээр шүүхийн шүүгч Б.Хэрлэн даргалж тус шүүхийн шүүх хуралдааны танхимд

Нарийн бичгийн дарга Г.Мэндбаяр

Улсын яллагч Б.Эрхэмбаатар

Шүүгдэгчийн өмгөөлөгч Ш.Цэдэн нарыг оролцуулан нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар Сэлэнгэ аймаг Мандал сум дахь сум дундын 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1, 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Ц.Б-т холбогдох 201301000046, 201301000412 дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, Улаанбаатар хотод ... оны ... дугаар сарын ...-ний өдөр төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, ойн инженер мэргэжилтэй, ам бүл..., эхнэр, ... хүүхдийн хамт амьдрах, ...аймаг ...сумын ... дүгээр баг, ...-ын ...тоотод оршин суух, энэ хэрэгт холбогдох үедээ Төв аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын харьяа Батсүмбэр сум дундын ойн ангийн дарга ажилтай байсан, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгүүлж байгаагүй, бие эрүүл, ухаан санаа бүрэн, хэрэг хариуцах чадвартай, М овогт Ц.Б /РД: ...../

Шүүгдэгч Ц.Б нь Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн даргаар ажиллаж байхдаа Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2 дахь хэсэгт заасан бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан ойн анги, иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллага мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно гэсэн хуулиар хүлээсэн үүрэг, хуульд нийцүүлэн гаргасан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн №128 тоот тушаалаар баталсан мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох, тэдгээрийг хэрэглэх, хяналт тавих журмын 5.4 дэх хэсэгт заасан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-153 тоот тушаалаар баталсан гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журмын 4.10

дахь хэсэгт заасан заалтуудыг зөрчин 5 удаагийн үйлдлээр гарал үүслийн гэрчилгээг бусдад шилжүүлэн өгч, хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс ойн санд 73.482.612 төгрөгийн хохирол учруулсан, мөн яллагдагч М.С-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй, гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийж М.Со-аар дамжуулан 400.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

#### ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

**Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Ц.Б-ын өгсөн** ...Би энэ гэмт хэрэгт 2013 оны 01 дүгээр сард холбогдсон юм. Би М.С гэдэг хүнд 2013 оны 01 дүгээр сард 2 ширхэг гарал үүслийн гэрчилгээ шилжүүлж өгсөн. Түнхэлээс ачиж тээвэрлэсэн модонд М.С энэ гарал үүслийн гэрчилгээг ашиглаж Улаанбаатар хот руу банз мод тээвэрлэсэн. Дараа нь 2013 оны 07 дугаар сард иргэн Ш.Ш надаас 3 гарал үүслийн гэрчилгээ өгөөч бид Батсүмбэрийн “Л” ХХК-аас мод авна гэж хүсэхээр нь би 3 ширхэг гарал үүслийн гэрчилгээг иргэн Ш.Ш-д өгсөн. 2013 оны 09 дүгээр сарын 10-ны үеэр эхний машин модоо “Л” ХХК-аас ачиж Улаанбаатар хот руу явсан. 2 дахь гарал үүслийн гэрчилгээг надаар бичүүлсэн боловч машин нь эвдрээд тээвэрлэж чадалгүй нэг хоногийн хугацаа нь өнгөрөөд уг гарал үүслийн бичиг хүчингүй болсон. 2013 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр намайг эзгүй байхгүй үед 3 дахь гарал үүслийн бичгээ өөрсдөө бичиж тээвэрлээд баригдсан байсан. 2013 оны 01 дүгээр сарын 08-нд би Улаанбаатар хотод 2 ажилтны хамт явж байхдаа бичиг хэрэгсэл, машины сэлбэг авах гэтэл мөнгө дутаад байхаар нь “Т” ХХК-ийн захирал С.Б-д хандаж 400.000 төгрөг зээлүүлээч гэсэн чинь хэдэн минутын дараа мөнгө явуулсан байсан. Хэнээс шилжиж ирснийг нь би ажиглаагүй. Энэ мөнгөнөөс 200.000 төгрөгөөр нь ажил албандаа юм аваад дууссан. Хийсэн хэрэгтээ гэмшиж байна. Хөнгөн ял оногдуулж өгнө үү гэх

мэдүүлэг болон талуудын шинжлэн судалсан нотлох баримт болох

**Иргэний нэхэмжлэгч О.Т-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ...Танай 2013 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10/6-2376 тоот албан бичгийн дагуу би энэ хэрэгт иргэний нэхэмжлэгч, хохирогчоор оролцож байгаа юм. Энэ хэргийн нөхцөл байдлыг судлахад Сэлэнгэ аймгийн Түнхэл сумаас хх-хх дугаартай машинаар ачигдсан модон материалд Төв аймгийн Батсүмбэр сумын гарал үүслийн гэрчилгээг ашигласан хууль зөрчсөн асуудал гаргасан байна. Яагаад гэхээр энэ хэргийн холбогдогч модыг Сэлэнгэ аймгийн Түнхэлээс худалдан авч, нийслэлийн бүс рүү тээвэрлүүлсэн М.С нь Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоны гарал үүслийн гэрчилгээг авах байтал Төв аймгийн Батсүмбэр сумын ойн албаны дарга Ц.Б гэх албан тушаалтнаас гарал үүслийн гэрчилгээг авч Батсүмбэрээс тээвэрлэж байгаа мэтээр ойлгуулахаар хууль зөрчсөн байна. Батсүмбэрийн ойн албаны дарга Ц.Б яагаад гарал олгосныг мэдэхгүй байна.... Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хууль бусаар бэлтгэгдсэн, тээвэрлэгдсэн модон материалд экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоохдоо Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 394 тоот тушаалын 1 дүгээр хавсралтанд заасан аргачлалаар, 1996 оны Байгаль орчны сайдын 230 дугаар тушаалыг тус тус үндэслээд үнэлгээг тогтоодог. Энэ хэрэг дээр хх-хх УБЭ дугаартай машинтай чиргүүлтэйгээр тээвэрлэж явсан машины модон материал нь нийт 20.5 метр куб нойтон банз байсан. 20.5 метр куб банзанд үнэлгээ хийхэд, тээвэрлэгдсэн мужлал нь 3 дугаар бүсэд орж байгаа тул 3 дугаар бүсийн шинэс модны үнэлгээ 96.000 төгрөг тул 96.000 төгрөгөөр үржүүлэхэд нийлбэр нь 1.968.000 төгрөг, үүнийг ашиглалтын гарцын дагуу зүсмэл материалд 2.9 гэсэн итгэлцүүрээр үржүүлээд нийт хохирлын хэмжээ 5.707.200 төгрөг юм. Үүнийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан байгаль орчинд учруулсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцно гэсэн заалтын дагуу бодохоор нийт хохирлын хэмжээ 17.121.600 төгрөг болж байна. Экологи, эдийн засгийн үнэлгээн дээр заагдаж үнэлэгдсэн байгаа байгаль орчинд

учруулсан хохирлыг холбогдох хүмүүсээс гаргуулмаар байна. Хэргийг хуулийн дагуу шийдэж экологид учирсан хохирлыг бүрэн барагдуулсан тохиолдолд гомдол санал гэх зүйл байхгүй. Энэ хэрэгт шүүх хуралд оролцохгүй гэх мэдүүлэг /Хх-н 55-56 дугаар хуудас/

**Гэрч Б.А-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ...2013 оны 01 дүгээр сарын 09-нд нэг удаа, 01 дүгээр сарын 25-нд нэг удаа Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгоноос М.С гэдэг эмэгтэйгийн нойтон банзнуудыг өөрийн эцгийн чиргүүлтэй зил-130 маркийн хх-хх УБЭ дугаартай автомашинаар Улаанбаатар хот руу тээвэрлэсэн. 2013 оны 01 дүгээр сарын 25-нд журамлагдаж, 22-ын товчооны журмын хашаанд орсон. М.С утсаар хаанаас мод ачих талаар хэлдэг байсан. Бид хоёр хөрөө рам дээрээс болон н.У гэдэг залуугаас рам дээрээс нь нойтон банз ачиж байсан. М.С утасдаж, гарал үүслийн бичиг өгдөг байсан.... 2013 оны 01 дүгээр сарын 09-нд та нартай тааралдсан. Тэгээд М.С эгчтэй ярьж, цагдаа таарлаа банзаа хаана буулгах вэ энэ гарал чинь Батсүмбэрийн гарал байна гэхэд М.С тиймээ, цагдаа таарах юм бол Батсүмбэрээс ачсан банз гэж хэлээрэй гэж хэлсэн. Түнхэл тосгонд ачаагаа ачаад хөдлөхөд М.С эгчийн гэрээс нэг ачигч нь бидэнд авчирч өгсөн гэх мэдүүлэг /Хх-н 77-78 дугаар хуудас/

**Гэрч Г.Б-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ....Би өөрийн эзэмшлийн хх-хх УБЭ улсын дугаартай зил-130 машинаар хувиараа хөлсний ачаа ачиж мөнгө олж амьдардаг юм. 2013 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр М.С над руу залгаад гарал үүсэлтэй бэлэн ачаа байна, ирээд ачаад өгөх үү, хөлсөнд нь 600.000 төгрөг өгнө гэхээр нь би Сэлэнгэ аймгийн Түнхэлд очоод М.С руу утсаар залгаад ирчихлээ гэхэд машиныхаа толгой дээр н.П гэдэг хүний рам дээрээс чиргүүл дээрээ Ц.Б-ийн рамнаас банз ачих гэхээр нь хэлсэн ёсоор нь ачсан. Тэгээд би ачаагаа аччихаад явлаа гэхэд нэг ачигч залууг гэр лүү явуулчих гэсэн юм. Тэгээд нэг ачигч залуу нь гүйгээд гарал үүслийн бичиг авчирч надад өгөхөөр нь би гарал үүслийг харсан чинь Төв аймгийн серитэй байхаар нь М.С руу утасдаад М.С-ээс лавшруулж энэ чинь Төв аймгийн гарал үүсэл байна ш дээ замд шалгалт таарна, болохгүй ш дээ гэхэд М.С надад Төв аймгийн нөхөрлөлүүд энд модоо зүсүүлсэн болохоор Төв аймгийн гарал үүсэл бичигдэж байгаа юм, наад гарал үүсэл чинь зүгээр гэж хэлсэн юм. Тэгэхээр нь тийм юм байлгүй гээд явсан. Тэгээд маргааш өглөө нь

Партизан дээр шалгалтын хүмүүс таараад зөрчилтэй байна шалгана гээд журамласан юм гэх мэдүүлэг /Хх-н 84 дүгээр хуудас/

**Гэрч Б.Д-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ...Батсүмбэр сумын ойн анги нь манай Байгаль орчны газрын байгууллага бөгөөд Төв аймгийн Байгаль орчны газрын харьяа Батсүмбэр сум дахь сум дундын ойн анги гэдэг юм.... Би энэ байгууллагад 2012 онд ороод Ц.Б дээр үнэт цаасны тайланг судалж үзсэн. Тэгтэл Батсүмбэрээс үнэт цаасны тооцоо ирүүлэхгүй байхаар нь Ц.Б-ээс асуухад сумтайгаа тооцоо хийчихдэг гэсэн. Тэгээд 8 сараас тооцоо ирүүлэхгүй байхаар нь суман дээр нь очиж тооцоог нь шалгая гэхэд Ц.Б өөрөө миний бүх бичиг баримтууд УМБГ дээр байгаа, би өөрөө байнга Улаанбаатар явж байгаа гэж байсан. Тэгээд сумынх нь нягтлангаас лавлахад сумтайгаа ерөөсөө тооцоо хийгээгүй байсан. Хүрч ирж, тооцоо хий гэхээр ирдэггүй юм. Сая 2013 оны 10 дугаар сарын 17-нд суман дээр нь очиж үнэт цаасны тооцоо судалгааг нь шалгасан. Илтгэх хуудас дээр үр дүнг нь дэлгэрэнгүй бичсэн байгаа үүнийг өгье гэх мэдүүлэг/Хх-н 101 дүгээр хуудас/

**Гэрч С.Б-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ...М.С нь надад болсон явдлынхаа талаар ярьсан юм. Тэрийг нь сонсож байгаад М.С-д туслах үүднээс би мэдүүлэг өгье гээд хэлчихсэн юм. Түүнээс би тэр хоёрын дунд болсон үйл явдал өгч авсан мөнгө төгрөгийн талаар огт мэдэхгүй. Би оролцоогүй. М.С-ийн хувьд аль хар бага наснаасаа зовлон үзсэн, олон дүү нараа тэжээх гэж явдаг охин байгаа юм. Тэгээд ийм байдалд орсон гэдгийг нь ярианаас нь сонсоод туслах үүднээс эгч нь тэгвэл мэдүүлэг өгчихье гээд хэлчихсэн юм. Энэ мэдүүлгээс болж цаашид гарах шалтгаан үр дагаврыг нь ухамсарлаж ойлгоогүй байсан юм. Миний хувьд нэг удаа 9 метр куб хар модон банзыг М.С-д худалдсан нь үнэн. Машин ачих үед би өөрөө байгаагүй. Миний ойлгосноор Г.Б жолооч ачсан гэх мэдүүлэг /Хх-н 110-111 дүгээр хуудас/

**Гэрч М.Со-ын мөрдөн байцаалтад өгсөн** ....Би энэ асуудлын он сарыг бол сайн санахгүй байна. Манай төрсөн эгч М.С 2013 оны эхээр нэг дансны дугаар хэлээд 400.000 төгрөг шилжүүлсэн юм. Би Ц.Б гэх хүнийг бол таньж мэдэхгүй. Энэ мөнгийг манай эгч М.С хийлгэсэн. Банкнаас авсан хуулбарыг үзлээ. Гарын үсэг бол минийх мөн байна. Би ямар ч байсан 400.000 төгрөг Ц.Б гэх хүний дансанд шилжүүлсэн байна. Би М.С эгчийн хэлснээр шилжүүлсэн гэх мэдүүлэг /Хх-н 124-125

дугаар хуудас/

**Гэрч Ш.Ш-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ....Энэ талаар хэлэхэд надад Ц.Б гарал үүслийн гэрчилгээг өгөөгүй. Хэрэв өгсөн бол би авна. Гэхдээ надад өгөөгүй. Харин С.С-д гарал үүслийн гэрчилгээ өгсөн гэдгийг би мэднэ. Яг сар өдрийг нь санахгүй байна. 2013 оны 07 дугаар сард Ц.Б нэг хотод ирчихсэн байсан. Тэгээд бид нар уулзаж ууж идэж байгаад Ц.Б-г хүргэж өгөх гээд Батсүмбэр явсан юм. Тэгээд явж байхад Ц.Б, С.С-д гарал үүслийн гэрчилгээ өгсөн юм. Тухайн үед гарал үүслийн гэрчилгээ олдохгүй, хэцүү байсан. Тэгээд С.С Ц.Б-аас гарал үүслийн гэрчилгээ авч байхыг харсан. Яг хэдийд авсныг нь мэдэхгүй. Ц.Б бид нар чинь найз нөхдийн холбоотой гэж явдаг учраас хоорондоо мөнгө төгрөгөөр өгч авалцсан зүйл байхгүй. Тухайн үедээ бүгд л инээж наргиад, идэж уугаад нөхөрлөж явсан. Тийм учраас хоорондоо туслах үүднээс зүгээр өгч авалцсан юм... Нэг гарал үүслийн гэрчилгээ нь надад байсан. Тэрийг нь Ц.Б ирэхдээ наад гарал үүсэл чинь хэрэггүй болчихсон солигдсон гэж хэлэхээр нь би нүдэн дээр нь ураад хогийн саванд хийсэн гэх мэдүүлэг /Хх-н 139-141 дүгээр хуудас/

**Гэрч С.С-ийн мөрдөн байцаалтад өгсөн** ...Энэ гарал үүслийн гэрчилгээг Батсүмбэр сумын ойн ангийн дарга байсан Ц.Б-аас өөрөөс нь авсан. Энэ гарал үүслийн гэрчилгээг авахдаа дараа нь Ц.Б-ын өөрийнх нь модыг Улаанбаатар хотод боломжийн үнээр зүсүүлж өгөх тохиролцоотойгоор авсан юм. Ямар нэгэн мөнгө төгрөгөөр худалдан аваагүй. Мөн мод зүсүүлэх үнээ тохиролцоогүй. Тухайн үед нь буюу модоо зүсүүлэх үед нь үнээ ярилцъя гэж тохироод Ц.Б-аас 2 ширхэг гарал үүслийн гэрчилгээ авсан юм. Надад өгсөн гарал үүслийн гэрчилгээ нь 0046521, 0046522 гэсэн дугаартай байсан юм. Энэ гэрчилгээг надад өгөхөд дээр нь ямар нэгэн бичиглэл хийгээгүй, байгаль орчны хяналтын улсын байцаагч гарын үсгээ зурж тамгаа дарсан, мөн Ц.Б өөрөө гарын үсгээ зураад тамга дарсан гарал үүслийн гэрчилгээг надад өгсөн юм. Тухайн үед би хожим хэрэг болж магадгүй гээд гар утсан дээрээ энэ хоёр гарал үүслийн гэрчилгээний зургийг дарж авсан нь одоо надад байдаг юм гэх мэдүүлэг /Хх-н 144 дүгээр хуудас/

**Яллагдагч М.С-ын мөрдөн байцаалтад өгсөн...** Би анх Ц.Б ахтай утсаар гарал үүслийн бичиг гуйж ярьж байхдаа 2 ширхэг хэрэгтэй байна гэж ярьж байсан юм. Тэгээд



дараа нь надаас Ц.Б ах 400.000 төгрөг боломжтой бол шилжүүлж өгөөч гэж хэлсэн. Түүнийх нь дагуу би шилжүүлсэн. Дараа нь энэ мөнгө шилжүүлснээс хойш 01 сарын 25-нд ачсан модныхоо гарал үүслийн бичгийг авсан. Тэгээд тухайн үед би дотроо бодохдоо Ц.Б ах нэг гарал үүслээ 200.000 төгрөгөөр тооцсон юм байна даа гэж бодсон юм. Түүнээс Ц.Б ахын зүгээс нэг гарал үүслийг 200.000 төгрөгөөр худалдаж байна гэж үнэ тогтоосон зүйл байхгүй... Ц.Б ахаас өгсөн данс руу нь би 400.000 төгрөгийг дүү М.Со-р шилжүүлсэн нь үнэн. Гэхдээ би авлига өгч байна гэж бодож өгөөгүй. Ц.Б ахыг миний дүү боломжтой бол энэ данс руу 400.000 төгрөг шилжүүлээд өгчөөч гэж хэлснийх нь дагуу тус болох үүднээс энэ мөнгийг өгсөн юм гэх мэдүүлэг /Хх-н 267-270 дугаар хуудас/

Ц.Б-ын ХААН банк дахь 5727xxxxx дугаартай харилцах дансанд М.Со-с 400.000 төгрөгийг шилжүүлсэн дэлгэрэнгүй хуулга /Хх-н 129 дүгээр хуудас/

Ц.Б-ын хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбарууд /Хх-н 357-360 дугаар хуудас/

Ц.Б-ын ажил байдлын тодорхойлолт /Хх-н 363 дугаар хуудас/

Ц.Б-ын иргэний үнэмлэхний лавлагаа, иргэний үнэмлэхний хуулбар /Хх-н 370, 373 дугаар хуудас/

Ц.Б нь ял шийтгэгдсэн талаар ЦЕГ-ын МСТ-ийн ял шийтгэлийн мэдээллийн санд бүртгэгдээгүй гэсэн ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /Хх-н 371 дүгээр хуудас/ зэрэг болно.

Шүүгдэгч Ц.Б нь Төв аймгийн Батсүмбэр сум дундын ойн ангийн даргаар ажиллаж байхдаа Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.2 дахь хэсэгт заасан бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан ойн анги иргэн аж ахуйн нэгж нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллага мод бэлтгэх эрхийн бичиг гарал үүслийн гэрчилгээ олгоно гэсэн хуулиар хүлээсэн үүрэг, хуульд нийцүүлэн гаргасан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн №128 тоот тушаалаар баталсан мод бэлтгэх эрхийн бичиг гарал үүслийн гэрчилгээ олгох тэдгээрийг хэрэглэх, хяналт тавих журмын 5.4 дэх хэсэгт заасан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-153 тоот тушаалаар баталсан гарал үүслийн гэрчилгээ олгох хяналт тавих журмын 4.10 дахь хэсэгт заасан

заалтуудыг зөрчин 2013 оны 01 дүгээр сараас 2013 оны 08 дугаар сар хүртэл хугацаанд 5 удаагийн үйлдлээр гарал үүслийн гэрчилгээг бусдад шилжүүлэн өгч хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс ойн санд 73.482.612 төгрөгийн хохирол учруулсан, мөн яллагдагч М.С-ын ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй, гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийж М.Со-аар дамжуулан 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 400.000 төгрөгийн хээл хахууль авсан болох нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байх тул хээл хахууль авах, албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэргүүдийг үйлдсэн гэм буруутайд тооцож, хуульд заасан ялыг оногдуулах үндэслэлтэй байна гэж дүгнэлээ.

Шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримт болох иргэний нэхэмжлэгч, гэрч нарын мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэрэг нь хуульд заасан шаардлага хангасан, хууль зөрчөөгүй байх тул энэ хэрэгт хамааралтай ач холбогдолтой нотлох баримтууд гэж үнэллээ.

Шүүгдэгч Ц.Б нь бусдын ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэх ёсгүй үйлдэл буюу олгогдох ёсгүй модон материалд гарал үүслийн бичгийг бичилт хийж олгон, бусдаар дамжуулан 400.000 төгрөг авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг, хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй хайнга хандаж бусдад 5 удаагийн үйлдлээр гарал үүслийн бичгийг хууль бусаар олгосноос 73.482.612 төгрөгийн хохирол учруулсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тус тус хангаж байх тул прокурор энэ зүйл ангиар зүйлчлэн, яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн нь тохирсон байна.

Шүүгдэгч Ц.Б-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар ял оногдуулахдаа тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хуульд заасан тодорхой хугацаагаар хасаж, хорих ял оногдуулах, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар ял оногдуулахдаа тодорхой

албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасахгүйгээр хуульд заасан хорих ялыг оногдуулах, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг баримтлан хөнгөн ялыг хүндэд нь багтааж, биечлэн эдлэх ялыг тогтоох, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн тул эдлэх ялыг нь жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэх нь зүйтэй байна.

Харин шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт зааснаар хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарах бөгөөд анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, бусдад төлөх төлбөргүй зэргийг нь ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан түүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэлгүйгээр тэнсэж, хянан харгалзах хугацаа тогтоох боломжтой байна гэж үзлээ.

Энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн зүйлгүй, шүүгдэгч нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг тус тус дурдаад

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 284, 286, 290 дүгээр зүйлийн 290.3, 294, 295, 296 дугаар зүйлийн 296.1, 297 дугаар зүйлийн 297.1, 298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүгдэгч М овогт Ц.Б-ыг албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийж бусдаар дамжуулан хээл хахууль авсан, хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс хүнд хор уршиг учруулсан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасныг баримтлан Ц.Б-ын тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасныг баримтлан тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасахгүйгээр 2 жилийн хугацаагаар хорих

ялаар тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг баримтлан Ц.Б-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 3 жилийн хорих ялд мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 2 жилийн хорих ялыг багтааж бүгд 3 жилийн /гурван жилийн/ хорих ялыг биечлэн эдлэхээр тогтоосугай.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар- зүйлийн 52.5 дахь хэсэгт заасныг баримтлан Ц.Б-т оногдуулсан 3 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

5. Энэ хэргийн улмаас эд мөрийн баримтаар хураагдан ирсэн зүйлгүй, Ц.Б нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдсугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт заасныг баримтлан Ц.Б-т оногдуулсан 3 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэлгүйгээр тэнсэж, мөн хугацаагаар хянан харгалзах, тэнсэгдсэн ялтанд хяналт тавих үүргийг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэст даалгасугай.

7. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 330 дугаар зүйлийн 330.1.3 дахь хэсэгт заасныг баримтлан шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц Ц.Б-ын тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хассан шийтгэх тогтоолыг тухайн шийдвэрийг гүйцэтгэвэл зохих шийдвэр гүйцэтгэлийн албанд явуулж, энэ тухай прокурорт мэдэгдэхийг шүүгчийн туслах Д.Батсайханд даалгасугай.

8. Шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болтол Ц.Б-т өмнө авсан бусдын батлан даалтад байлгах таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

9. Шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нар тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 06 дугаар сарын 25 өдөр

Дугаар 797

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Цогтзандан даргалж, шүүгч С.Базарханд, Д.Алтанжигүүр нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Э.Ганцэцэг,

Иргэдийн төлөөлөгч А.Нямаа, Г.Хатанбаатар, М.Өлзийхүү,

Улсыг яллагч Г.Магнайжав, Шүүгдэгч Д.Га, түүний өмгөөлөгч

Л.Түвшинцэнгэл, Л.Даваасүрэн, Шүүгдэгч У.Ба, түүний өмгөөлөгч

И.Ганчимэг,

Шүүгдэгч Т.Ба, Ж.Ур тэдгээрийн өмгөөлөгч У.Гансүх нарыг оролцуулан, тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн хуралдаанаар Дүүргийн 2 дугаар прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1, 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Ж овогт Д. Га, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн М.Баа овогт У.Ба, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Л овогт Ж.Ур, 3 овогт Т.Ба нарт холбогдох эрүүгийн 201426000025. дугаартай хэргийг 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч, хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Ховд аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга ажилтай байсан, ам бүл., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ..... тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай Ж овогт Д.Га /РД:ХК...../,

2. Монгол Улсын иргэн, .... оны ...дугаар сарын ...нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай эрэгтэй, бүрэн бус боловсролтой, жолооч мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ..дугаар хороо ..... тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж

байгаагүй, хэрэг хариуцах чадвартай Б овогт У.Ба /РД:ШД...../

3. Монгол Улсын иргэн, .... оны ...дүгээр сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, цахилгааны инженер мэргэжилтэй, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер техникийн албаны үйл ажиллагааг хариуцсан “СС” ХХК-ийн цахилгааны инженер ажилтай, ам бүл ..., эхнэр ...хүүхдийн хамт Баянгол дүүргийн .. дугаар хороо ..... тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай 3 овогт Т.Ба / РД:ЧМ...../

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Завхан аймгийн ...суманд төрсөн, ...настай эмэгтэй, дээд боловсролтой, боловсруулах үйлдвэрийн технологи инженер мэргэжилтэй, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер техникийн албаны үйл ажиллагааг хариуцсан “СС” ХХК-ийн ерөнхий инженер ажилтай, ам бүл.. нөхрийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо Чингэлтэйн .... тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай Л овогт Ж. Ур./ РД:ХЖ...../

Холбогдсон хэргийн талаар: /яллах дүгнэлтэд дурдсанаар /

1. Шүүгдэгч Д.Га нь:

-2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “О” ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий байгууллагын албан тушаалтанд нөлөөлж, санал хүргүүлэн “О” ХХК-ийн захирал Х.Б.с-г хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-с 200.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан,

-2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн 17 хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “МБ” ХХК-ийн “НМ” шөнийн цэнгээний газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй, “ИҮЭ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг дээрх шөнийн цэнгээний газар

ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулах шаардлагатай байгааг далимдуулан иргэн У.Ба-г хясан боогдуулах замаар, давтан үйлдлээр 200.000 төгрөгийн хээл хахууль авсан.

-2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Их тойруу-196 тоот гудамжны "РХ" зочид буудалд "Мо" ХХК-ийн "РХ" зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбуулан цахилгааныг нь ашиглаж байсныхаа төлөө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер, техникийн албаны үйл ажиллагааг хариуцсан "СС" ХХК-ийн ерөнхий инженер Ж.Ур-т 200,000 төгрөг, инженер Т.Ба-д 200,000 төгрөгийг тус тус эхнэр З.Ц-р дамжуулан хээл хахууль өгсөн.

2. Шүүгдэгч У.Ба нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн 17 хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд "МБ" ХХК-ийн "НМ" шөнийн цэнгээний газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй тул "ИҮЭ" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд иргэн Д.Га-д 200.000 төгрөгийн хээл хахууль өгсөн.

3. Шүүгдэгч Ж.Ур нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо Их тойруу-196 тоот гудамжны "РХ" зочид буудалд "Мо" ХХК-ийн "РХ" зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбож цахилгааныг нь ашиглуулж байсныхаа төлөө иргэн Д.Га-с 200,000 төгрөгийн хээл хахууль авсан

4. Шүүгдэгч Т.Ба 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо Их тойруу-196 тоот гудамжны "РХ" зочид буудалд "Мо" ХХК-ийн "РХ" зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбож, цахилгааныг нь ашиглуулж байсныхаа төлөө иргэн Д.Га-с 200,000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

#### ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг талуудын хүсэлтээр шинжлэн судлав. Үүнд:

1. Шүүгдэгч Д.Га шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн:

"...Би улсын яллагчийн яллах дүгнэлттэй

урьд нь танилцсан. Намайг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, мөн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар зүйлчилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Анхнаасаа энэ мэдүүлэгтээ бат зогсож байгаа. Эрх бүхий албан тушаалтанд нөлөөлсөн гээд байгааг ойлгохгүй байна. Би бүрэн эрхийнхээ хүрээнд бүх л зөвлөлийн хуралд шударгаар хэлдэг. Шударгаар ярьдаг байсан. Тухайн үед "О" гэх мэт 12 компани зөвлөлийн хурлаар орж байсан. Хөдөлмөр аюулгүй байдлын ажиллагаа явагдаад, нэгдсэн төлөвлөгөөний дагуу удирдлагын зөвлөлийн хуралдаан болж, уг хуралдаанд оролцсон.

Тэрнээс би албаар "О" ХХК-ийн асуудлыг оруулсан юм байхгүй. "О" ХХК-ийн Хан-Уул дүүрэгт баригдаж байсан барилга дээрээс мужаан М.Баа гэх хүн өндрөөс унаж нас барсан байдаг. 2012 оны А/507 тоот дүгнэлт, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 257 тоот тушаалууд гарсан. Улаанбаатар хотын хэмжээнд 2012 онд 34, 2013 онд 23 хүн нас барсан осол болсон. Үүнээс болж Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар сануулга авсан. Тухайн хурал дээр би ганцаараа тусгай зөвшөөрлийг цуцлах санал гаргаагүй; Г, Э, Эн, зэрэг хүмүүс мөн санал оруулж байсан. Зөвлөлийн хуралд 7 гишүүн оролцсоны 4 нь саналаа өгөөд тусгай зөвшөөрлийг цуцалъя гэж ярьж байсан. "О" ХХК нь Баянгол дүүргийн нутаг дэвсгэр, Модны 2-т бас ямар ч зөвшөөрөлгүй барилга барьж байсан.

Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар очиж, шаардлага тавихад та нар мэддэг юм уу гээд хэл амаар доромжилдог байсан байдаг. "Э" ХХК-ийн барилга дээрээс адилхан хүн нас барсан байхад адилхан хоёуланд нь тусгай зөвшөөрлийг цуцлах санал оруулсан. Хясан боогдуулах гэдгийг ойлгохгүй байна. "О" ХХК-ийн захирал Х.Бт нь өмнө эрүүгийн төлөөлөгчөөр ажиллаж байсан. Би Мэргэжлийн хяналтын газрын ахлах байцаагчаар ажиллаж байгаад Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар томилогдож ажилласан.

Харин Х.Бт нь өөрөө намайг чи их аятайхан ажилд томилогдсон байна. Би хайрганы үйлдвэртэй болж байгаа Баянгол дүүрэгт зуурмагны үйлдвэр олон байдаг биз дээ, хэлж, зуучилж өгөөрэй гэж хэлж байсан. Би Баянгол дүүрэгт зуурмагны 20 гаруй үйлдвэр байдаг гэж хэлээд байршлыг өгч

байсан.

2012 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш сарын дараа Х.Бт над дээр ирээд хамт өдрийн хоол идье гэж хэлсэн. Бид хамтдаа хоол идээд нэг шил архи уусан. Тэгээд миний өрөөнд очоод бичлэг хийсэн байсан. Он гаргаад манай газар салбарын яаманд шилжинэ гэж байсан болохоор шилжиж нийлэхээсээ өмнө 39-үүлээ шинэ жилээ сайхан тэмдэглэе гэж ярьсан байсан.

Би боломжгүй, амьдрал муутай, жолооч, бичиг хэргийн ажилтан, хуулийн мэргэжилтэн нарынхаа шинэ жилийн зардлыг өөрөө даана гэж хэлсэн. Улсын байцаагч нарыг 140.000 төгрөгийг гарга гэж хэлсэн. Миний өрөө хөл хөдөлгөөнтэй байсныг далимдуулаад гэмт хэрэгт өдөөн турхирсан. Х.Ба өөр холбогдох хүмүүстэй архидуулж бичлэг хийсэн байгаа гэж надад хэлэхэд нь яах гээд бичлэг хийж байгаа юм бэ гэж асуусан. Тэгээд “О” ХХК-тай холбоотой асуудлыг асуугаад өгье гээд асуухад аль хэдийн бичиг нь явсан гэж хэлсэн. Би Х.Бс танихгүй, мөнгө нэхсэн дарамталсан гэх хууль бус үйлдэл байхгүй. Тусгай зөвшөөрлөө цуцлуулахгүй гэсэн комбинац зохион байгуулсан. Тэр бичлэг дотор нь Төв аймгийн прокурор хүртэл байгаа. Намайг гэмт хэрэгт өдөөн турхирсан.

“О” ХХК-ийн асуудлын хувьд Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын даргын хувьд Нийслэлийн хэмжээнд болсон асуудлаар Зөвлөлийн гишүүд саналаа өгдөг. Сүхбаатар дүүрэг дээр 2, Баянгол дүүрэг дээр 1 барилгын үйл ажиллагааг зогсоосон. “О” ХХК нь цэвэр ариун биш. Зөвлөлийн гишүүний хувьд эрүүгийн хэрэгт татагдаж байгаад харамсаж байна. “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлыг эхнэр З.Ц ажиллуулдаг.

Энэ нь 1 гишүүнтэй хязгаарлагдмал хариуцлагатай компани байгаа юм. Би гэр бүлийн гишүүний хувьд л хэлж зааварлах зүйл байдаг. Би он гарахаас өмнө өр, авлагуудаа өгөөрэй гэж л хэлсэн. Т.Ба ах бол анхнаасаа манайд гэрээгээр ажилладаг. Энэ хүн манайхаас өөр 15 компанид гэрээгээр ажилладаг. Намайг унагах гэсэн бодлогоор нэг юм яваад байна. Ажил хийснийхээ төлөө яллагдагчаар татагдаж байна. Манай мэргэжлийн хяналтын газрын ажилтнуудаас таныг хорино шүү гэж айлгаж, дарамталж байж гэрчийн мэдүүлэг авсан байсан. Байцаалт авахдаа дандаа хөтөлсөн байцаалт авагдсан байсан. Би эрүүгийн төлөөлөгчийн ажлыг хийдэг байхдаа хөтөлж байцаадаггүй байсан. 14-

15 жил төлөөлөгчийн ажил хийгээд удирдах албан тушаалыг хийж байсан. Эхнэр З.Ц-р дамжуулж хээл хахууль өгсөн гэж хэлээд байна. Би энэ хүмүүст ширхэг зоос ч өгөөгүй. Ажил хийснийх нь төлбөрийг өгсөн. “Мо” төв нь өмнө Хятад худалдааны төв гэж бичсэн байсан, тэндээс тог авдаг ч байнгын тог тасардаг. Тиймээс Ня-г найзын хувьд гуйж 2009 оноос хойш Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тогноос холбуулсан.

Мөн 200.000 төгрөгийн хахууль Т.Ба, Ж.Ур нарт өгсөн гэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Хамгийн өндөр шаардлага хангасан газар бол “NM” клуб байсан. Энийг дарамтлаад авсан зүйл байхгүй. “ИҮЭ” ХХК нь тусгай зөвшөөрлийг эзэмшдэг байгаа. Баянгол дүүргийн хэмжээнд 8024 хоол үйлчилгээний салбар ажиллуулдаг. 40000 гаруй компани байдаг. “ИҮО” ХХК байдгийг ч мэдэхгүй шүүдээ. Намайг авлига авсан гэж хэлээд байна. Би 2 сая төгрөг зээлсэн нь үнэн. 2014 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 1 сая төгрөгийг нь өгсөн. Сүүлд 1 сая төгрөгийг нь өгсөн. Би эрсдэлээ тооцоод эрх зүйн байдлаа дордуулахгүйн тулд Баянгол дүүргийн төрийн сангийн дансанд 2 сая төгрөгийг тушаасан байгаа, намайг энэ хэргээс болж жил гаруй дарамталсан. Намайг золиослох гэж байгаад харамсалтай байна...” гэсэн мэдүүлэг

2. Шүүгдэгч У.Ба шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн;

“...Д.Га ахад 2 сая төгрөг зээлсэн. Ямар учраас зээлсэн бэ гэхлээр Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрынхантай хамт шинэ жил тэмдэглэх гэж байгаа гэхээр нь зээлсэн. Шинэ жилийг нь гардаж хийж байгаа гэхээр нь мөнгө зээлсэн. “ИҮЭ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хэрэглээгүй. Тоног төхөөрөмжтэй нь худалдаж авсан. Одоо хаагдсан, ажиллахгүй байгаа...” гэсэн мэдүүлэг

3. Шүүгдэгч Т.Ба шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн;

“...Цахилгааны инженер мэргэжлээр 40 гаруй жил ажиллаж байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцаас 5 газар цахилгаан авдаг. “Мо” ХХК-ны хувьд бол кабел нь тасардаг асуудал байдаг. З.Ц бидний хооронд ярилцан тохирсон зүйл байдаг. З.Ц-ын зүгээс манайд мэргэжлийн цахилгаанчин байхгүй, шаардлагатай үед надаар янзлуулахаар харилцан тохиролцсон байдаг. 2013 онд манайхаас авдаг тэжээл нь тасарсан. Тэр нь

мэргэжлийн ур чадвар шаардсан зүйл байдаг. Надад З.Ц 400.000 төгрөгийг өгсөн. З.Ц мөнгө өглөө хуваагаад авъя, шинэ жилийн мөнгөндөө хэрэглэе гэхэд манай инженер Ж.Ур чи өөрөө гардаж хийсэн юм чинь өөрөө 300.000 төгрөгийг аваад надад 100.000 төгрөгийг л өгчих гэж хэлсэн. 2014 оны 03 сарын 19-ний өдөр ажил дээр байж байтал миний нэрийг асуугаад хүн орж ирсэн. Надад нэг үнэмлэх үзүүлээд Авлигатай тэмцэх газар руу авч явсан.

Авлигатай тэмцэх газрын байцаагч надаас 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Д.Га-гээс 400,000 төгрөг авсан уу гэхэд нь авсан гэж хэлсэн. Би ажлынхаа хөлсийг авсан гэж хэлсэн. Цахилгаан өгснийхөө төлөө Д.Га-гээс 400,000 төгрөгийн авсан гэж байцаагч хэлсэн. Би үнэн чанартаа 2009 онд залгаж байсан гэж хэлсэн чинь хэрвээ ийм юм ярьж байгаа бол Д.Га-н байгаа газар аваачиж чадна шүү гэж хэлсэн.

Өдий насалчхаад ингэмээр байна уу, хясан боогдуулж байна гээд хэрэг хүндэрнэ гэж хэлсэн. Намайг тэндээс гаргаад явуулсны дараа эргэж дуудаад ахиж ярихдаа та гэрч биш сэжигтэн болсон гэж хэлсэн. Би энэ талаар мэдээгүй байсан учир нэг их ач холбогдол өгөөгүй.

Өмгөөлөгч аваад байх шаардлагагүй. Авсан 200.000 төгрөгөө буцааж төрийн сангийн дансанд тушаагаарай гэж нэг дансны дугаар өгсөн. Хэрэг прокурор дээр очиход прокурор өөрөө надад өмгөөлөгч авах хэрэгтэй юм байна гэж санал тавьсан. Тэгээд хэрэг прокурор дээр 2 хоног болж байхад Гансүх гэдэг өмгөөлөгчийг авсан. Авлигатай тэмцэх газрын байцаагч бол ажлын хөлс гэх юм бол хясан боогдуулсан гээд хэрэг чинь хүндэрнэ гэж хэлсэн..." гэсэн мэдүүлэг.

4. Шүүгдэгч Ж.Ур шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн;

"...Анх 2014 оны 03 дугаар сарын 19-ний өдөр нэг залуу өрөөнд орж ирээд надаас Т.Ба гэдэг хүн хаана байна гэж асуугаад Авлигатай тэмцэх газар руу Т.Ба бид 2-ыг авч очоод байцаасан. Бид хоёрыг өөр өөр өрөөнд байцаасан. Мөнгө авсан хэргийн талаар хэзээ авсан, яасан ийсэн талаар асуусан.

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 2009 онд "Мо" төвийг цахилгаанаар хангасны төлөө 400,000 төгрөгийг хүлээн авсан гэж өөрсдөө яриад өөрсдөө хариу бичээд явсан. Би Д.Га-с мөнгө аваагүй. З.Ц-с ч мөнгө аваагүй. Хийсэн ажлынхаа төлөө, мэргэжлийнхээ туслалцааг үзүүлснийхээ

төлөө өгсөн байх гэж ойлгосон.

Ба надад 200.000 төгрөгийг надад өгөхөд би гардан гүйцэтгэдэггүй юм. Чи 300.000 төгрөгийг нь ав би 100.000 төгрөгийг нь авъя гээд 100.000 төгрөгийг нь авсан. Байцаалт авахдаа тулгаад, шаардаад, тайлбар огт сонсдоггүй юм билээ. Өмгөөлөгч авах нөхцөлөөр хангаагүй, эхлээд гэрч болсон. Дараа сэжигтэн, сүүлд нь яллагдагч болсон.

Маш хүнд цохилтод орсон. Байцаагч надад нэг цэнхэр ном гаргаад үүнийг унш гэхэд би юун дээр гарын үсэг зурснаа гайхсан. Хэнд, юу хэлснээ мэдэхгүй, дарамттай байдалд орсон. Хийсэн ажлынхаа төлөө мөнгө авсан гэж ойлгож байгаа. 2009 оны асуудлыг холбогдуулж, хээл хахууль авсан гэсэн хэрэгт холбогдсоныгоо хүлээн зөвшөөрөхгүй байна. Магнайжав прокурор өмгөөлөгч аваарай гэж хэлсний дагуу өмгөөлөгч авч хууль зүйн зөвлөгөө авсан. Ингээд би хээл хахууль аваагүй гэдгээ ойлгож авсан..." гэсэн мэдүүлэг.

Эрүүгийн 201426000025 дугаартай хэргээс шинжлэн судлагдсан дараах баримтууд: Үүнд:

5. Гэрч Х.Бс мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

Д.Га компанийн үйл ажиллагааг зогсооно гэж дарамтлах, манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээг санхүүжүүл гэх зэргээр хууль бус шаардлага тавих замаар удаа дараа хээл хахууль нэхээд, улмаар өгөхгүй болохоор Барилга, хот байгуулалтын яам руу манай компанийг үндэслэлгүйгээр буруутгасан албан бичиг хүргүүлэх саналыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа-д гаргаж явуулсан байдаг юм... 2013 оны 11 дүгээр сарын 12-нд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөлийн хурлаар Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч М.Баа манай компанийг оруулсан. Уг нь уг зөвлөлийн хурлаар ямар нэг шалтгаантай аж ахуйн нэгжийг оруулдаг юм. 2013 оны 05 дугаар сард Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт барьж байсан барилгын 2 давхраас манай компанийн 1 ажилтан унаж эндсэн юм. Тухайн үед хуулийн байгууллага шалгаад, зохих шийдвэр дүгнэлт нь гарчихсан байсан. Тодруулж хэлбэл компанийн зүгээс ямар нэгэн буруу зүйл байхгүй, тухайн ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчсөнөөс болсон байсан энэхүү асуудлаар зөвлөлийн хурлаар оруулсан.

Хуралдаанд Д.Га манай компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг хэлж оруулж байсан. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа Д.Га-тэй их ойр дотно найз нөхөд гэдэг юм. Ингээд энэ хурлын дараа Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа-ын үсэг бүхий албан бичиг барилга хот байгуулалтын яаманд явуулсан байдаг. Тэр албан бичигт манай компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал бичигдсэн гэсэн. Гэтэл Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын байцаагч Б-н үйлдэж байсан дүгнэлт бус, түүний гарын үсгийг хуурамчаар зурсан шал өөр дүгнэлтийг М.Баа нь өөрийн албан бичигтээ хавсаргасан байж болзошгүй байгаа юм.

Би Мэргэжлийн хяналтын газарт 2013 оны 12 дугаар сард гомдол гаргасан. Үүний дагуу манай компанийн үйл ажиллагаанд шалгалт хийгээд, ямар нэгэн зөрчилгүй гэж дүгнэлт гаргаад Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн юм. Энэ байдлаас харахад л Д.Га, М.Баа нар нь хууль бус үйлдэл хийж байна гэж үзэж байгаа. Д.Га нь 2013 оны 12 дугаар сард манайх ах Х.Бт-с манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээг даачихаач гээд нэхсэн байдаг.

...Д.Га надаас барилгын шат гуйж байсныг би өгөөгүй, дараа нь хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженер В.Н-с хэв хашмал асууж байсан гэдэг. Ингээд хүссэн зүйлийг хангаагүй учир, мөн өөрийг нь тоосонгүй гээд манай компанийн үйл ажиллагааг зогсооно гэж дарамтлах болсон гэж үзэж байна. /1-р хавтаст 53-54х/

6. Гэрч Х.Бт-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн;

“...Би 1992, 1993 оны үед Д.Га-тэй цуг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгчөөр ажиллаж байхдаа бие биенийгээ таньдаг болсон юм... Манай төрсөн дүү Х.Бс-ны үүсгэн байгуулсан “О” ХХК нь барилга угсралтын чиглэлээр Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт барилгын ажил эхлүүлэн ажиллаж байх явцад буюу 2013 оны 11 дүгээр сарын үеэр Д.Га нь Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа байнга надруу утсаар ярин чамд барилгын шат байна уу, элс хайрга үнэ төлбөргүй өгөөч гэх зэргээр шаардаж байсан бөгөөд миний хувьд би уг шаардлагыг нь биелүүлээгүй юм.

Гэтэл Д.Га нь өөрийнхөө албаны эрх мэдлээ ашиглан манай компанийн барилга

угсралтын тусгай зөвшөөрлийг чинь хүчингүй болгуулна гэж манай компанийн хөдөлмөр хамгааллын инженер В.Н-д хэлсэн байсан юм... Тэгээд би 2013 оны 12 дугаар сарын дундуур Д.Га-н албан тасалгаанд нь очиж уулзсан юм.

Ингэж Д.Га-тэй уулзахдаа өөрийн гар утсаар бид хоёрын дунд яригдсан яриаг бичлэг хийн бэхжүүлэн авсан бөгөөд энэ бичлэгээ танай байгууллагад гаргаж өгсөн юм. Уг бичлэгт буюу Д.Га-тэй уулзахад Д.Га нь надаас доорх хууль бус шаардлагыг тавьж, хээл хахуульд 200.000 төгрөгийг авахаар шаардсан юм. Д.Га нь тухайн үедээ надаас манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээ болох гээд байна. Тийм учраас чи манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээнд зарцуулагдах 200.000 төгрөгийг надад өгчих. Хариуд нь би танай компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг цуцлуулахгүй байх талаар хөөцөлдөнө. Мөн танай компанийг ямар нэгэн асуудалд буюу манай байгууллагын зүгээс янз бүрийн дарамт учруулахгүй гэсэн зүйлийг ярьсан юм.

Тэгэхэд Д.Га нь тухайн үед миний хажууд М.Баа дарга руугаа утсаар залган нөгөө О ХХК-ийн асуудал яам руу явсан уу, яваагүй биздээ гэж хэлэхэд М.Баа дарга Д.Га-д та өөрөө явуул гээд энэ компани дээр ач холбогдол өгөөд байсан биздээ гэж хариулж байсныг нь би тэд хоорондоо утсаар ярих яриаг нь сонссон юм. Тэгээд манай компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрөл нь Барилга, хот байгуулалтын яаманд очоод түдгэлзээгүй юм. Учир нь Д.Га дарга манай компанийн Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт болсон үйлдвэрийн осол нь манай ажилтны өөрийнх нь буруугаас болж амь эрсдсэн асуудал нь эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаад тухайн ажилтны буруугаас болсон нь тогтоогдож, хэрэг хэрэгсэхгүй болсон асуудал учраас манай компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож түдгэлзүүлээгүй юм.

Миний хувьд бол Д.Га-н тавьсан хууль бус шаардлагын хүрээнд шаардсан 2.000.000 төгрөгийн хээл хахуулийг ямар нэгэн байдлаар өгөөгүй, учир нь энэ хүн надаас манай компанид хамааралгүй гэдэг нь нотлогдсон зүйлийг ашиглаж, амин хувьдаа хээл хахууль авахыг оролдсон үйлдэл гэж үзэн танай байгууллагад хандсан...” гэсэн

7. Гэрч В.Н мөрдөн байцаалтын шатанд өгсөн;

“О” ХХК-д миний бие 2011 оны 3 сараас эхлэн одоог хүртэл талбайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, хяналтын инженерээр ажиллаж байна... Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс дээр очоод н.У байцаагчтай уулзалдаж байтал Д.Га намайг хараад өрөөнд ороод ирээрэй гэсэн.

Тэгээд ороход Д.Га танай захирал М.Баа томроод надтай уулзахгүй юм танай байгууллагын бүх ажилчдыг чинь хөөж гаргаад лацдаад үйл ажиллагааг чин зогсооно шүү гэсэн... Д.Га танайд хар панер бас хэв хэлбэр байгаа биздээ, надад хэрэгтэй байна гэхээр нь би үүнийг захирал Х.Бс-с өөрөөс нь асуу, би мэдэхгүй гээд явсан.

...2013 оны 11-р сарын 12-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар дээр болдог хурал дээр Д.Га-тэй би таарсан. Манай компани Хан-Уул дүүргийн нутагт барьсан барилгын үйл ажиллагааны талаар тэр хурлаар орсон юм. Тэгэхэд би уг хуралд компаниа төлөөлөн суусан ба Д.Га ч дүүргийн хэлтсийн дарга гээд сууж байсан. Т.Ба тэр хурлын үеэр надруу өөрийн 9999xxxx дугаарын утаснаасаа танай нэгдүгээр хүний бие зүгээр биз дээ томроод ирэхгүй байна уу гэсэн мессежийг миний 8807xxxx дугаарын утас руу явуулсан. Би хариуд нь захирал өвчтэй байгаа гээд явуултал Д.Га-гээс за за загнахгүй бол болохгүй юм байнаа гэсэн хариу надад мессежээр ирүүлсэн. Ямар учиртайг нь би мэдэхгүй, одоо ч эдгээр мессежүүд нь миний гар утсан дээр байгаа. Иймд, би үүнийг хуулбарлаад, мэдүүлэгтээ хавсаргаж байна.

Тэр хурал дээр Хан-Уул дүүргийн нутагт манай компанийн барьж байсан барилгын үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ц.Бам танилцуулга хийсэн юм. Тэгэхэд Д.Га дарга “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг цуцлах саналтай байна гээд л хэлсэн. Энэ үгийг дээрх мессежүүдийг надруу явуулсны дараа хэлсэн. Уг нь Хан-Уул дүүргийн нутагт барилга барих явцад манай нэг ажилтан хөдөлмөр аюулгүй байдлын журмаа зөрчсөнөөс амь насаа алдсан асуудал гарсан юм. Үүнд нь зохих байгууллагуудаас шалгалт явуулаад, талийгаач өөрийн аюулгүй байдлаа хангаагүйгээс болсон гээд дүгнэлт, шийдвэр гарсан байдаг юм. Эрүүгийн хэрэг үүсгээд шалгасан. Тэгээд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гээд хэрэгсэхгүй болсон юм. Гэтэл үүнийг Д.Га нь мэдэхгүй байж л

шууд л тусгай зөвшөөрлийг нь цуцлах тухай саналаа хэлсэн. Ингээд тэр өдрийн хурал өндөрлөсөн. Орой нь Д.Га надруу залгаад байсан. Би утсаа аваагүй...”

8. Гэрч Ц.Б-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

Миний бие Хөдөлмөрийн аюулгүй байдлын улсын байцаагчаар 9 дэх жилдээ ажиллаж байна. Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэст ажиллаад 2 жил болж байна... 34-06-288/6, 34-06-288/6 дугаартай актуудыг миний бие гаргаж байсан. Актуудын хуулбартай танилцлаа, минийх мөн гарын үсэг нь ч мөн байна. 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн эхний актыг бол тухайн нэр бүхий аж ахуйн нэгжийн барьж буй барилга дээр осол гарж, 1 ажилчин нас барсан учраас зөрчлийг арилгуулах хүртэл барилгын үйл ажиллагааг нь түр зогсоосон. 2013 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн акт бол зөрчлийг арилгасан гэсэн тул гүйцэтгэлийн хяналт хийж түр зогсоосон актаа дуусгавар болгосон юм.

...2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн улсын байцаагчийн 34-06-288/67 дугаартай дүгнэлтийг би гаргаагүй миний гарын үсэг нь ч биш байна. Улсын байцаагчийн тэмдгийн дардас нь ч минийх биш. Миний дардасны дугаар 34-06-28 гэсэн байгаа. Энэ дүгнэлт дэх дардас болохоор 7-гоор төгссөн дугаартай дардас байна. 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр болсон Нийслэлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн 6 дугаар хуралд хэлэлцэх асуудал “О” ХХК-ийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг хэлэлцэх талаар төлөвлөгөөнд орсон байсан. Хүний амь нас үрэгдсэн осолтой холбоотой аж ахуйн нэгжүүдийг бүгд л энэ хурлаар орсон байсан.

Түүнээс ганц “О” ХХК-ийн асуудлыг оруулаагүй. 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралд миний бие орсон. Энэ хуралд танилцуулах танилцуулгыг улсын байцаагч Д.Цэ танилцуулсан. Аж ахуйн нэгж болгоноор ярьж байхад газрын дэд дарга М.Баа-гаас “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн / Өөрөөр хэлбэл, зэрэглэл бууруулах/ цуцлах санал гаргахад Баянгол дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Д.Га-с бүхэлд нь цуцал гэсэн санал хэлсэн. Тэгээд бүхэлд нь цуцлахаар шийдвэрлэсэн.

Энэ хурал дээр “О” ХХК-ийн инженер В.Н оролцсон. Тэрээр хийж гүйцэтгэж байсан ажлаа ч тайлагнаж байсан. Хурлын дараа В.Н надтай таарчхаад Д.Га дарга манай



компаниас хэв гуйгаад байсан тэрийг нь өгөөгүй болохоор зууж байна гэсэн үгийг хэлж байсан. 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын дараа нилээд хэд хоногийн дараа миний бие нэгдүгээр эмнэлэгт өвчний учир хэвтсэн юм. Тэгээд хэвтэж байтал надтай хамт ажилладаг З.Ц гээд улсын байцаагч над руу утасдаад “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Барилга, хот байгуулалтын яам руу явуулах улсын байцаагчын дүгнэлт гээд нэхээд байна. Би нэг дүгнэлт биччихлээ түүн дээр чиний гарын үсэг зураад явуулчих уу гэж байсан юм.

Тухайн үед нуруу татаад, босож чадахгүй, эмнэлэгт хэвтчихсэн байсан юм тэгээд л Д.Цэ бичсэн байх... Би уг хурал дээр “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг цуцлах санал гаргаагүй, “О” ХХК-ийн талаар би хурал дээр дарга нарын асуултад хариулсан. Тэгсэн чин Д.Га дарга байцаагч нар осол байгаа компаниудыг өмөөрч байна, ашиг сонирхлын зөрчилтэй гээд загнаад байсан. Газрын дэд дарга М.Баа хэсэгчлэн цуцлах санал гаргахад Д.Га бүхэлд нь цуцлах санал оруулж байна гээд л босож ирээд хэлж байсан. Тэгээд түүгээр нь шийдвэрлэсэн...” гэсэн мэдүүлэг /1-х хавтас 79-80/

9. Гэрч Д.Цэ мөрдөн байцаалтын шатанд өгсөн;

“...Энэ улсын байцаагчийн дүгнэлтийг миний бие үйлдсэн. Тухайн үед М.Баа байцаагч өвчтэй байсан юм. Дүгнэлтэд дурдагдсан “О” ХХК-ийн үйл ажиллагааг явуулж байсан барилгын талбай дээр осол гарч хүн эндэж байсан юм. Тэгээд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хурлаар энэ асуудал нь орж хэлэлцэгдэж байсан, зөвхөн “О” ХХК-тай холбоотой асуудал энд ороогүй, хэд хэдэн аж ахуйн нэгжийн асуудал орсон. Тэр хуралд миний бие мөн орж байсан. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт гарсан барилгын ослын талаар бид нар танилцуулга хийсэн. Тэгээд дарга нарын асуусан асуултад хариуцан шалгасан улсын байцаагч нар хариулт өгч байсан.

“О” ХХК-ийн хувьд улсын байцаагч Ц.Бам хариулт өгч байсан. Тэгээд уг хурлаар “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэрт хүрч байсан. Тэгээд л энэ хурлын шийдвэр дүүрэг дээр ирээд л шийдвэрийн хэрэгжилтийг хангах үүднээс 2013 оны 11 сарын 28-ны өдрийн улсын байцаагчын 34-06-288/67. дугаартай дүгнэлтийг гаргасан юм.

Тухайн үед надад Нийслэлийн Мэргэжлийн газрын улсын ахлах байцаагч Э амаараа тусгай зөвшөөрөл цуцлах бичигт улсын байцаагчийн дүгнэлт хавсаргадаг юм. Иймд, улсын байцаагчын дүгнэлтээ ирүүл гэсэн. Тухайн үед Ц.Бам өвчтэй байсан учир Би Ц.Бам-ийн нэрээр 34-06-288/67 дугаартай дүгнэлтийг би үйлдээд өмнөөс нь гарын үсэг зураад өгчихсэн юм, ингэхдээ Ц.Бам-тай утсаар ярьж хэлээд зөвшөөрөл авсан.

...Д.Га дарга байцаагч нар аж ахуйн нэгжүүдээ өмөөрөөд байна. Тусгай зөвшөөрлийг нь цуцал гээд л босож ирээд загнаж байсан... Миний хувьд тухайн үед Ц.Бам-ийн гаргасан үйлдвэрлэлийн ослын акт, шинжээчийн дүгнэлт зэргийг би огт мэдэхгүй байсан юм. Тэгээд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас дүгнэлт шаардаад байсан болохоор нь мэдээж хүний амь эрсдсэн осол болсон учраас барилгын норм, дүрмээс тодорхой заалт зөрчигдсэн байх гэж бодоод холбогдох дүгнэлтийг нь Ц.Бам-ийн өмнөөс нь бичээд гарын үсэг зураад явуулсан юм. Ц.Бам-ийн гаргасан акт бол тухайн үед гаргасан ослын хүрээнд бичсэн акт, харин шинжээчийн дүгнэлт бол тухайн хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн асуултын хүрээнд шинжээчийн дүгнэлтээ гаргадаг учраас заавал өмнө нь бичсэн акттай адилхан байна гэж байдаггүй юм

10. Гэрч Ц.Э-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хурал 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хуралдаад “О” ХХК-ийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргасан байдаг. Тэгээд уг компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар Барилга, хот байгуулалтын яам руу албан бичиг явуулах үүрэг нь надад байдаг учраас би уг компанид холбогдуулан бичсэн улсын байцаагчийн дүгнэлтийг шаардсан юм. Ингэж шаардахдаа би ямар нэг албан тушаалтны шийдвэрийг үндэслэж шаардсан асуудал байхгүй юм.

Тэгээд хэсэг хугацааны дараа манай Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт Ц.Бам-ийн гарын үсэгтэй улсын байцаагчийн дүгнэлт нь ирсэн учраас би дэд дарга М.Баа-ийн гарын үсэг бүхий 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02021/298 тоот албан бичгийг би төлөвлөж, дэд даргаар гарын үсэг зуруулж Барилга хот байгуулалтын яам

руу албан бичиг явуулсан юм. Миний хувьд улсын байцаагч Д.Цэ-г Ц.Бам-ын өмнөөс гарын үсэг зураад явуул гэж шаардсан зүйл байхгүй.

Гэхдээ уг албан бичигт “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг бүхэлд нь цуцлах бус тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх санал хүргүүлсэн юм. Яагаад ингэж албан бичиг болон дэд даргын зөвлөлийн хурлын шийдвэр хоёр нь зөрж байгаа нь аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгай зөвшөөрлийг улсын байцаагчийн дүгнэлтээр түдгэлзүүлэх саналыг холбогдох төрийн захиргааны байгууллагад нь хүргүүлэхээр заасан байсан. Харин тусгай зөвшөөрлийг манай байгууллага нь цуцлах тухай асуудал тусгагдаагүй байсан учраас би хуулийн дагуу уг асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд уг албан бичигт “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг хүргүүлсэн юм.

Уг албан бичгийг явуулахад надад хэн нэгэн албан тушаалтан ямар нэгэн байдлаар нөлөөлсөн асуудал байхгүй юм. Би тухайн үед дэд даргад уг албан бичигт хурлаас гарсан шийдвэр ингэж өөрчлөгдсөн талаар мэдэгдээгүй нь миний алдаа болсон байна. Ямар нэгэн байдлаар Барилга хот байгуулалтын яамнаас уг компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай асуудал албан бичиг ирээгүй байна... гэсэн мэдүүлэг

11. Гэрч М.Баа-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

Уг хуралдаан зохион байгуулагдаж уг хурлаар “О” ХХК-ийн асуудлыг авч хэлэлцсэн юм. “О” ХХК-ийн асуудлаар Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Д.Га нь нилээн голлож тус компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгуулах саналыг гаргаж шийдвэрлэж байсан юм.

Дэд даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн хурлын протокол дээр “О” ХХК-ийн барилга, угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах тухай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. Харин миний явуулсан албан бичгийг харахад тус компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх гэж албан бичиг явсан байна. Гэхдээ яагаад ингэж өөрчлөгдсөн талаар уг албан бичгийг боловсруулсан Э тодорхой тайлбар хийх байх. Га-н зүгээс над руу ямар нэгэн байдлаар “О” ХХК-ийн барилга угсралтын

үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахгүй байх талаар ямар нэгэн байдлаар утсаар болон биеэр ирж уулзаж, ярьж байгаагүй. Мөн миний яам руу явуулж байгаа албан бичиг бол эцсийн шийдвэр биш гэдгийг хэлмээр байна...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас 88-90/

12. Гэрч Я.Б-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас олгогддог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бол “МБ” ХХК-д огт олгогдож байгаагүй. Харин “ИҮЭ” ХХК-ийн нэр дээр “NM” гэсэн нэртэй бааранд бол тусгай зөвшөөрөл олгогдож байсан. Уг зөвшөөрөл нь хотын Ерөнхий менежерийн 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар хүчингүй болсон юм.

Ингээд “NM” нэртэй баарны тусгай зөвшөөрөл хүчингүй болсон учраас ямар нэгэн байдлаар уг баарыг үйл ажиллагаа явуулахгүй байхад хяналт тавих байгууллага нь дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс болон цагдаагийн газарт тус тус даалгасан байдаг. Өөр аж ахуйн нэгжид олгосон тусгай зөвшөөрлийг ашиглаж өөр аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж болохгүй. Мөн “ИҮЭ” ХХК-ийн “NM” баарны тусгай зөвшөөрөл нь 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүчингүй болсон бөгөөд уг өдрөөс хойш хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан байна. Харин мэргэжлийн хяналтын газраас уг баарны үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн талаар ямар ч албан бичиг ирж байгаагүй юм...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас, 104-105/

13. Гэрч О.О-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“Манай Мэргэжлийн хяналтын хэлтсийн байцаагч нар нь тухайн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хийх хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэсэн байдлаар хяналтаа хэрэгжүүлдэг юм. Харин миний “МБ” ХХК-д холбогдуулан гаргасан 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 27-02-442/1119 тоот дүгнэлтийн хувьд би уг аж ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийн дагуу буюу шөнийн цэнгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас авахын тулд манай байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг заавал авдаг ёстой

юм.

Ингэж шөнийн цэнгээний газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулахын тулд манай байгууллагад “МБ” ХХК-аас хандаж дүгнэлт гаргуулсан юм. Дүгнэлтийг дарга Д.Га хянаж дуусаад дүгнэлтийн ар талд гарын үсэг зуран “МБ” ХХК-д өгөх хувийг нь өөрөө аваад үлдсэн... Тэгээд удалгүй “МБ” ХХК-ийн захирал ЭЗ над дээр ирээд дүгнэлтээ авах хэрэгтэй байна гэхэд нь би ЭЗ-д манай хэлтсийн дарга дээр байгаа даргаас авчих гэж хэлсэн. Тэгээд ЭЗ нь Д.Га дарга дээр орчихоод гарч ирээд, надад манай компанийн дүгнэлтийг өгөхгүй байна. Манай хүргэнд өгнө гэж хэлээд өгөхгүй байна. Ямар хачин юм бэ гэж хэлж байсан...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас 116-117х/

14. Гэрч Б.Э мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Бо буюу У.Ба бид хоёрыг хамт явж байхад Д.Га ах эхлээд над руу, тэгээд дараа нь У.Ба руу гар утсаараа залгаад, бид хоёрыг нэг ирээд уулзаадхаач ээ гэж хэлсэн юм. Тэр үед бид хоёр цуг явж байсан болохоор Д.Га ахын ажил дээр нь очсон. Тэгэхэд У.Ба Д.Га ахын ажлын гадаа ирэнгүүтээ намайг чи түр байж байгаарай гэж хэлээд Д.Га ахын өрөө рүү нь орсон юм. Тэгээд нэг их удаагүй намайг утсаар дуудсан юм.

Тэгээд би Д.Га ахын өрөөнд нь ороход Д.Га ах надад хандан манай эхнэрийн хамт олны ёолкон дээр хамтлагаараа дуулаад өгөөч. Өмнө нь чамайг дуу дуулаад өгөөч гэхэд чи дуулж өгөөгүй биз дээ гэж хэлэхээр нь би зөвшөөрч эхнэрийнх нь “РХ” зочид буудалд болсон ёолкны арга хэмжээнд нь хамтлагаараа дуулж өгсөн юм. Ер нь бол Д.Га ах өмнө нь тэр өөрийнхөө найз нөхдийн найр наадамд очоод үнэгүй дуулаад өгөөч гэдэг байдлаар байнга над руу ярьдаг байсан бөгөөд тэр үед нь би амждаггүй байсан. Ер нь бол Д.Га ах утсаар ч тэр жирийн үедээ ч тэр их харьцаа муутай, дарамттай хүн шүү дээ. Бо буюу У.Ба нь тэр үед Д.Га ахад мөнгө төгрөг өгсөнг бол би мэдэхгүй байна. Харин Д.Га ах У.Ба руу байнга утсаар залгадаг. Ядаргаатай юм гэдэг байдлаар их л ярьдаг байсан. Гэхдээ Д.Га ахыг утсаар залгахад нь У.Ба утсыг нь огт авдаггүй байсан юм...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас 166х/

15. Гэрч С.Д мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс нь архи согтууруулах ундаагаар

үйлчилдэг диско баарны тусгай зөвшөөрөл, хүнсний эрүүл ахуйн стандарт, ажлын байрны стандарт зэрэг зүйлүүдэд хяналт тавьдаг. Харин Цагдаагийн байгууллагаас зөвхөн тухайн байгууллагын цаг хэтрүүлж ажиллаж байгаад нь хяналт тавьдаг юм.

Харин архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах талаар зохих саналыг Мэргэжлийн хяналтын байгууллага Улаанбаатар хотын Ерөнхий менежерт хүргүүлдэг юм... хуульдаа өөр аж ахуйн нэгжид олгосон тусгай зөвшөөрлийг ашиглан өөр аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж болохгүй юм... “ гэсэн мэдүүлэг /1-р хавтас 168х/

16. Гэрч Д.Т мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Миний санаж байгаагаар “Мо” ХХК-ийн захирал гэж Д.Га нь 2009 оны үед Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ня дээрээс цахилгааны холболт хийх зөвшөөрөл бүхий албан бичгээ авсан байна гэж надад Ж.Ур болон Т.Ба нар нь хэлж байсан, тэгээд эдний компанийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаантай холбох юм байна гэж хэлэхэд нь би тэр үед техникийн нөхцөл энэ тэрийг нь шалгаж үзээрэй гэж хэлж байсан. Харин тэр техникийн нөхцөл нь Ж.Ур, Т.Ба хоёр л хяналт тавьж байх ёстой юм.

Надад техникийн нөхцөл нь байдаггүй юм. Тэгээд л “Мо” ХХК-нь цахилгаанаа холбуулсан байдаг. “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудал нь холбосон цахилгаанаа байнга хэрэглэдэггүй бөгөөд эдний “РХ” зочид буудлын цахилгаан тасарсан үед л манайхаас холбосон цахилгааны эх үүсвэрийг ашигладаг учраас сар бүр цахилгааны төлбөр гардаггүй юм.

Харин “СС” ХХК-ийн ерөнхий инженер Ж.Ур, инженер У.Ба нар нь надад “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудал нь энэ сард хэчнээн хэмжээний цахилгаан хэрэглэсэн байна гэсэн тоолуурын заалтыг л оруулж ирж өгдөг бөгөөд уг зочид буудал, ажилчдын байрных нь цахилгааны гэмтэл, цахилгаан залгалт, холболт, таслалттай холбоотой бүх зүйлд энэ албан тушаалтнууд бүх хяналтыг тавьж байх ёстой байдаг...” гэсэн мэдүүлэг

17. Гэрч Л.Бө мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

Манай компани нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер техникийн албыг 2004 оны 04 дүгээр сарын

01-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд хариуцан ажиллаж байгаа юм. Манай компанийн ерөнхий инженер Ж.Ур, инженер Т.Ба нар нь цахилгааны тоолуурын заалтыг нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Санхүү, аж ахуйн албанд гарган өгдөг юм. Харин цахилгааны төлбөр хураамжийг бол манайх огт авдаггүй юм.

Манай дээрх 2 инженерийн хувьд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай цахилгааны эх үүсвэрийн 2 ДП байдаг бөгөөд үүнээс цахилгаан авдаг аж ахуйн нэгж иргэдийн цахилгааны холболт, таслалтыг хариуцах бөгөөд гаднын хэрэглэгчдийг уг цахилгаанд холбохын тулд зөвхөн нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Ня-с Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас шинээр холболт хийх тохиолдолд зөвшөөрөл авч байж холболтыг хийж өгдөг юм.

Тэгээд цахилгааны холболт хийлгэж байгаа аж ахуйн нэгж, иргэд нь зайлшгүй “УБЦС” ХК-наас техникийн нөхцөл авсан байхыг шаарддаг юм. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирлын зөвшөөрөлгүйгээр гаднын цахилгаан хэрэглэгчдийг холбох эрх бол манай 2 инженер бол байхгүй юм. Харин “Мо” ХХК буюу “РХ” зочид буудлын хувьд миний санаж байгаагаар Ня-н гарын үсэгтэй албан бичиг ирж байсан харин цахилгааны техникийн нөхцөлийг авсан эсэхийг нь би мэдэхгүй байна...” гэсэн мэдүүлэг

18. Гэрч З.Ц-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“... Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгааны асуудлыг нь “СС” ХХК-ийн ерөнхий инженер Ж. Ур, инженер Т.Ба гэсэн хүмүүс хариуцдаг юм. 2009 оны зун манай нөхөр Д.Га нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Ня-тэй 10 жилийн нэг ангийн хүүхэд гэдгээр нь очиж уулзан зочид буудлынхаа цахилгааныг тасарсан үед Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас хэрэглэж болохоор зөвшөөрлийг авсан гэсэн. Тэгээд л ерөнхий инженер Ж.Ур, инженер Т.Ба нар нь манай цахилгааныг холбож өгсөн юм.

Тэрнээс хойш манайх цахилгаан тасарсан үед Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас хэрэглээд, хэрэглэсэн цахилгааны төлбөрөө сар бүр нь хэчнээн төгрөг гарна, тэр хэмжээгээр нь төлбөрийг нь бөөгнүүлж байгаад л төлдөг юм. Тэрнээс биш, сар сард нь төлбөрийг нь төлдөггүй юм. Манай компани нь Халдварт

өвчин судлалын үндэсний төвийн дарга Ня-ын гарын үсэгтэй 2009 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн албан бичиг байдаг юм. Харин уг албан бичгийн дагуу манай компани нь “УБЦС” ХХК-аас цахилгааны техникийн нөхцлөө аваагүй байгаа юм.

Тэгээд одоо бол манай зочид буудлын Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс авсан цахилгааныг бүрэн тасалсан байгаа юм. Манайхаас Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгааны техникийн нөхцлөө авч ирж өг гэдэг байдлаар өмнө нь шаарддаг байсан.

2014 он гарснаас хойш бол ямар нэгэн байдлаар техникийн нөхцөлийг шаардаагүй байх...Он гарах гэж байсан бөгөөд Т.Ба нь манай цахилгааны ихэнх юмыг засаж, янзалж өгдөг учраас баяр болж байгаа юм чинь гээд Ж.Ур, Т.Ба хоёрт 400,000 төгрөгийг хувааж аваарай гэж хэлээд би өгсөн юм. Энэ талаар манай нөхөр Д.Га нь надад утсаар хэлж сануулж хэлсэн юм. Мөн Ж.Ур, Т.Ба хоёрт мөн шинэ мэндчилгээ энэ тэрийг өгч байсан гэсэн мэдүүлэг

19. Гэрч Ня-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Тэр өдөр Д.Га нь миний албан тасалгаанд орж ирээд манай “РХ” зочид буудал нь шинээр байгуулагдсан бөгөөд ингээд зочид авахаар цахилгаан эрчим хүч 1-2 цагийн хугацаанд тасалдаж хэвийн үйл ажиллагаа алдагдаж байна. Тийм учраас танай эмнэлгийн эрчим хүчний эх үүсвэрээс зочид буудлынхаа цахилгааныг тасарсан үед түр холбодог байх хэрэгтэй байна. Тийм учраас танайх надад Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс эрчим хүчнээс авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг “УБЦС” ХХК-д явуулж өгөөчээ.

Би танай албан бичгийг чинь хавсаргаад холбогдох цахилгааны техникийн нөхцөлөө аваад, танай эмнэлгийн цахилгаанчинтай чинь холбуулчихъя” гэж гуйж орж ирсэн. Тэгээд гараад явсан юм. Тэгээд би эмнэлгийн инженер техникийн албыг хариуцан ажилладаг “СС” ХХК-ийн ерөнхий инженер Ж.Ур, Т.Ба нарыг дуудан оруулж ирээд энэ талаар асуухад тэд нар эмнэлгийн цахилгаанаас холбоход болохгүй юм байхгүй гэсэн зүйлийг хэлсэн юм.

Тэгээд хэсэг хугацааны дараа дахиад Д.Га нь миний өрөөнд орж ирэхэд нь би “УБЦС” ХХК-нд “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлыг эмнэлгийн цахилгаан эрчим хүчтэй холбогдоход ямар нэгэн байдлаар татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг хийж

өгсөн бөгөөд уг компанид “УБЦС” ХХК-наас цахилгааны техникийн нөхцөл олгогдсон эсэхийг нь би мэдэхгүй байна.

Тэрнээс биш “Мо” ХХК-наас манай эмнэлэгт албан ёсоор бичгээр хүсэлт гаргаагүй, зөвхөн Д.Га л амаараа над дээр ирж хүсэлт гаргасан... манай Халдварт өвчин судлалын үндэсний төв бол улсын онцгой объект гэдгээрээ эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагддаг бөгөөд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер техникийн албаны бүх л үйл ажиллагааг “СС” ХХК-ийн ерөнхий инженер Ж. Ур, инженер Т.Ба нар нь бүрэн хариуцан ажилладаг юм...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас 232-234х/

20. Гэрч Б.Цн-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дэд станцын өндөр хүчдэл тал буюу 6кв нь “УБЦС” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшлийнх, нам тал буюу 0,4 кв нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эзэмшлийнх нь. Тодруулж хэлбэл, тус төвийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй гэж ойлгож болно. Энэхүү өөрийн эзэмшлийн 0,4 кв нам хүчдэлээс “Мо” ХХК-ийн зочид буудал олон ажилчдын байрны нэг талын тэжээлээр хангасан байдалтай холбогдсон байсан.

Тодруулж хэлбэл, намайг 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдөр газар дээр нь очиж шалгахад цахилгаан хэрэглэхэд бэлэн байдалтай байсан өөрөөр хэлбэл, тэр өдөр “Мо” ХХК-ийн цахилгаан аваагүй, тоног төхөөрөмжөө залгахад л цахилгаанаар тэжээгдэх бэлэн байсан. Энэ байдал нь “Мо” ХХК өмнө нь цахилгаанаар уг дэд станцаас тэжээгддэг байсныг баталж байгаа юм. Үүнийгээ “Мо” ХХК-ийн захирал З.Ц тайлбарлахдаа “манай компани Номингоос цахилгааны эх үүсвэрээ авдаг ба Т.Ба үргэлж цахилгаан тасардаг учир үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд Халдвартаас цахилгаан авсан, үүнийг цахилгаан тасрах үед л хэрэглэдэг” гэх тайлбарыг өгдөг юм.

...Халдварт өвчин судлалын үндэсний төв нь нийт 4 тоолуураар манай байгууллагатай цахилгааны төлбөр тооцоогоо хийдэг. Энэ 4 тоолуураас л цааш нь салаалаад хэд хэдэн аж ахуйн нэгжийг цахилгаанаар тэжээж байгаа юм. Энэ салаалсан тоолуурыг л Халдварын өөрийнх нь цахилгааны инженер нь үзээд төлбөр тооцоогоо авдаг юм. Дүүрэг хариуцсан борлуулалтын инженер ч үүнийг үзэж чаддаггүй. Тэрээр зөвхөн манайтай холбоотой 4 тоолуурын заалтыг л үзэж харсан

юм. ...“Мо” ХХК нь Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс цахилгаан авахдаа “Эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.3 дугаар заалтыг зөрчсөн байсан. Энэ нь цахилгаан хэрэглэгч техникийн нөхцөлийг манай байгууллагаас буюу “УБЦС” ХХК-наас авах ёстой байдаг боловч ямар ч тийм техникийн нөхцөлийг аваагүй байдаг. Мөн Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс “Мо” ХХК-ийг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс “Мо” ХХК-ийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас холболт хийхийг зөвшөөрсөн ямар нэгэн албан бичиг огт ирээгүй...” гэсэн мэдүүлэг

21. Шүүгдэгч У.Ба-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...Би өөрийн эхнэрийн эх Э-гийн үүсгэн байгуулсан “МБ” ХХК байдаг бөгөөд уг компанийн нэрээр би “ИҮЭ” ХХК-ийн Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “NM” шөнийн цэнгээний газрыг сарын 6 сая төгрөгийн түрээслэх гэрээг байгуулж 2013 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн “NM” шөнийн цэнгээний газрыг “ИҮЭ” ХХК-ийн Архи, согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг ашиглан 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулсан юм. Он гарснаас хойш одоог хүртэл шөнийн цэнгээний газар нь ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа юм.

Мэргэжлийн хяналтын зүгээс манай шөнийн цэнгээний газрыг “ИҮЭ” ХХК-ийн нэр дээр авсан тусгай зөвшөөрлийг ашиглаж байгааг намайг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас тусгай зөвшөөрөл авахаар Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэст 2013 оны 10 сард ажлын байрны дүгнэлт гаргуулахаар хүсэлт өгч материал бүрүүлж өгснөөс хойш мэдэх болсон юм.

Тэрнээс өмнө нь би Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга Д.Га нь манай шөнийн цэнгээний газарт ирж уулзахад нь би уулзан танилцаад төр өдрөө бид хоёр хамт архи ууцгаасан юм. Тэгээд тэрнээс хойш Д.Га дарга байнга надруу утсаар залгадаг байсан бөгөөд би тэр бүрт нь авч яриад байдаггүй байсан. Тэгээд 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр би Б.Э-ийн хамтаар машинтай гадуур явж байхад Д.Га ах надруу утсаар яриад, чи нэг хүрээд ирээч гэхээр нь би Б.Эр-ийн хамт очиж уулзахаар явсан тэгээд ажил дээр нь очиж уулзахдаа

би Д.Га даргад 2 сая төгрөгийг бэлнээр хээл хахуульд өгсөн юм.

Миний хувьд Д.Га дарга над руу байнга утсаар яриад байдаг болохоор мэдээж хахуулийн мөнгөө нэхэж байна гэж ойлгоод л би уг мөнгийг өгсөн юм. Миний хувьд би өөрийн үйлдсэн гэмт хэргээ ухамсарлан ойлгож байгаа бөгөөд хуулийн дагуу зохих хариуцлагаа хүлээх учраас бага ял оногдуулж өгөөч гэж хүсмээр байна...” гэсэн мэдүүлэг

Шүүгдэгч Ж.Ур-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“... Миний хувьд болон манай компанийн инженер Т.Ба бид хоёрт “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлыг ямар ч цахилгаан техникийн нөхцөлгүйгээр цахилгаан эрчим хүчээр манай Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс хангагдаж байхын тулд 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Га-н эхнэр З.Ц-р дамжуулан 400,000 төгрөгийг 200.000 төгрөгөөр хуваан хээл хахуульд өгсөн бөгөөд миний хувьд Д.Га-с 200.000 төгрөгийн хээл хахууль авсан үйлдэлдээ бүрэн гэмшиж байгаа учраас эрүүгийн хариуцлагаа бүрэн хүлээнэ... би өөрийн гэм буруугаа хүлээн зөвшөөрч Д.Га-с хээл хахуульд авсан 200.000 төгрөгийг Төрийн сангийн холбогдох дансанд тушаасан...” гэсэн мэдүүлэг

23. Шүүгдэгч Т.Ба-ы мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“Мо” ХХК-ийн “РХ” зочид буудал Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс цахилгааныг ямар нэгэн техникийн нөхцөлгүй ашиглаж байгааг нь Ж.Ур бид хоёр мэдэж байсан юм. Би 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Га-н 9999xxxx гэсэн дугаарын утас руу залгаад ярихад Д.Га надад утсаар хэлэхдээ манай эхнэр Ц дээр очоод 400.000 төгрөгийг яг одоо авчих, би одоо өөрөө эхнэртээ утсаар хэлчихье. Тэгээд наад 400,000 төгрөгнөөсөө 200.000 төгрөгийг нь Ж.Ур инженерт өгчих, харин та үлдсэнг нь авчих гэсэн юм.

Тэгээд би утсаа салгаад шууд З.Ц-н “РХ” зочид буудал дээр очсон чинь З.Ц намайг харангуутаа өө Т.Ба наашаа хүрээд ир гэж хэлээд, май энэ мөнгө гээд 400.000 төгрөгийг 20.000 төгрөгийн дэвсгэртээр 20 ширхгийг өгөөд уг мөнгөний 200.000 төгрөгийг нь Ж.Ур-т өгөөрэй гэж хэлээд өгсөн юм. Тэгэхэд нь би уг өгсөн мөнгийг нь хүлээн аваад шууд Ж.Ур-н ажил дээр өрөөнд нь оруулаад өгсөн... Д.Га-с 200,000 төгрөгийн хээл хахууль авсан үйлдлээ ухамсарлан ойлгож байгаа.

Мөн би өөрөө хээл хахуульд авсан

200.000 төгрөгийг танай байгууллагын Төрийн сангийн дансанд бэлнээр нь тушаасан байгаа гэдгийг хэлмээр байна. Мөн би Д.Га-н эхнэрийн компанийн цахилгааныг хууль бусаар холбон өгч ямар нэгэн цахилгааны техникийн нөхцөлгүйгээр ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлэн өгч, улмаар хээл хахууль авсандаа маш их харамсаж байна...” гэсэн мэдүүлэг /2-р хавтас 106х, 110х/

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2013 оны гадагш явуулсан албан бичгийн бүртгэл, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, шийдвэр зэрэг бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл. /1дүгээр хавтаст хэргийн 59-78 дугаар хуудас/

- Эд мөрийн баримтаар тооцож, хэрэгт хавсаргах тухай тогтоол: /1-р хавтас 95-97х/

- Баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл: /1-р хавтас 134х, 243х/

- Улсын байцаагчийн дүгнэлт: /2-р хавтас 63-64х/ зэргийг шинжлэн судаллаа.

Шүүгдэгчийг сэжигтэн, яллагдагчаар, хохирогч, гэрч нарыг байцаахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 144, 146, 147 дугаар зүйлд заасан хуулийн шаардлага хангасан, нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай, агуулгын хувьд зөрүүгүй, үйл баримтыг хангалттай тогтоож чадсан байх тул хууль ёсны үнэн зөв баримтууд гэж үнэлэв.

Түүнчлэн шүүгдэгч нарын хувийн байдалтай холбоотой нотлох баримтууд болох ДБ эмнэлгийн хэт авиан шинжилгээ /3-р хавтас 43-45х, 47-48х/ Цагдан хорих 461 дүгээр ангийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн тодорхойлолт, “СС” ХХК-ийн ажил байдлын тодорхойлолт /3-р хавтас 65х/, оршин суугаа хаягийн тодорхойлолт /3-р хавтас 66х/, Хан-Уул дүүргийн ...дугаар хорооны Засаг даргын тодорхойлолт /3-р хавтас 68х/, Д. Га-ын ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /3-р хавтас 69х/, У.Ба-н ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /3-р хавтас 65х/, Ж.Ур-н ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /3-р хавтас 71х/, Т.Ба-н ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /3-р хавтас 72х/, ажилд томилох тухай тушаал /3-р хавтас 75х/, Баянзүрх дүүргийн ...дугаар хорооны Засаг даргын тодорхойлолт /3-р хавтас 85х/, Д.Га-н ажил байдлын тодорхойлолт /3-р хавтас 86-87х/, оршин суугаа хаягийн тодорхойлолт /4-р хавтас 198х/, эмнэлгийн үзлэгийн хуудас, баримтын хамт /4-р хавтас 224-242х/ шинжлэн

судаллаа.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд нь энэ хэрэгт хамааралтай, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цугларсан байх тул шүүх тэдгээр баримтыг үнэн зөв хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзлээ.

Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Т.Ба, Ж.Ур нарыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Их тойруу-19 ...тоот гудамжинд "РХ" зочид буудалд "Мо" ХХК-ийн "РХ" зочид буудлын цахилгааныг ашиглуулж байсныхаа төлөө иргэн Д.Га-гээс тус бүр 200.000 төгрөгийн хээл хахууль авсан гэх үйлдэл нь тэдний үйлдэлд тохирохгүй байна гэж үзлээ. Учир нь:

Хээл хахууль авах гэмт хэргийн объектив тал нь албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргээ гүйцэтгээгүй, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авах үйлдлээр илэрдэг.

Энэ тохиолдолд шүүгдэгч Т.Ба, Ж.Ур нар нь албан тушаалын байдлаа ашиглан бусдаас хээл хахууль аваагүй болох нь:

ХӨСҮТ-ийн цахилгааны асуудлыг "СС" ХХК хариуцдаг, Ж.Ур, Т.Ба нар нь "СС" ХХК-д ерөнхий инженерээр, цахилгааны инженерээр ажилладаг бөгөөд "Мо" ХХК нь өөрийн компанийн цахилгааныг ХӨСҮТ-ийн хаалттай дэд станцтай холбуулан, 2009 оноос эхлэн хэрэглэж, хэрэглэсэн цахилгааны төлбөрийг төлдөг болох нь хавтаст хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдож байна.

"Мо" ХХК нь 2013 оны 01-06 дугаар сард цахилгаан хэрэглээгүй, 07-12 дугаар сард нийтдээ 223,443 төгрөгийн цахилгааныг хэрэглэсэн, өмнөх оны /2012 оны/ цахилгааны төлбөр 101,587 төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй, нийтдээ 426.617 төгрөгийг төлөх ёстой байсан болох нь 2-р хавтаст хэргийн 1 дүгээр талд авагдсан баримтаар тогтоогдсон ба энэхүү төлбөрийг төлөхгүйгээр тус компанийн ерөнхий инженер, цахилгааны инженер нарт 400.000 төгрөгийг "Мо" ХХК-ийн захирал З.Ц-р дамжуулан Т.Ба, Ж.Ур нарт өгсөн гэх субъектив санаа сэдэлт тогтоогдохгүй байна гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, "Мо" ХХК-ийн захирал З.Ц-ын ямар ашиг сонирхлыг хамгаалж гүйцэтгэвэл зохих ямар ажлыг гүйцэтгээгүй, эсхүл гүйцэтгэх ёсгүй ямар үйлдлийг гүйцэтгэхгүй байхыг

урьдчилан амлаж албан тушаалын байдлаа ашиглан бусдаас хээл хахууль авсан байдал эргэлзээтэй байна.

Мөн Т.Ба, Ж.Ур нар нь "Мо" ХХК-д цахилгаанчин байхгүй, уг компанийн цахилгааны эрчим хүчтэй холбоотой зарим ажил үйлчилгээг хөлс мөнгийг тохирч гүйцэтгэдэг талаар мэдүүлсэн ба энэ нь мөрдөн байцаалтын шатанд өгсөн гэрч, З.Ц-ын "...2009 оны зун манай нөхөр Д.Га нь Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Ня-тэй 10 жилийн нэг ангийн хүүхэд гэдгээр нь очиж уулзан зочид буудлынхаа цахилгааныг тасарсан үед Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас хэрэглэж болохоор зөвшөөрлийг авсан гэсэн. Тэгээд л ерөнхий инженер Ж.Ур, инженер Т.Ба нар нь манай цахилгааныг холбож өгсөн юм. Тэрнээс хойш манайх цахилгаан тасарсан үед Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цахилгаанаас хэрэглэсэн цахилгааны төлбөрөөс сар бүр нь хэчнээн төгрөг гарна тэр хэмжээгээр нь төлбөрийг нь бөөгнүүлж байгаад л төлдөг... Он гарах гэж байсан болохоор Т.Ба нь манай цахилгааны ихэнх юмыг засаж, янзалж өгдөг учраас баяр болж байгаа юм чинь гээд Ур, Т.Ба хоёрт 400.000 төгрөгийг хувааж аваарай гэж хэлээд би өгсөн юм." /1-р хавтас 229-230, 231х/ гэсэн мэдүүлэг,

Гэрч н.Ня-ын шүүхийн хэлэлцүүлэгч өгсөн:

"...Тэр өдөр Д.Га нь миний албан тасалгаанд орж ирээд манай "РХ" зочид буудал нь шинээр байгуулагдсан бөгөөд ингээд зочид авахаар цахилгаан эрчим хүч 1-2 цагийн хугацаанд тасалдаж хэвийн үйл ажиллагаа алдагдаж байна. Тийм учраас танай эмнэлгийн эрчим хүчний эх үүсвэрээс зочид буудлынхаа цахилгааныг тасарсан үед түр холбодог байх хэрэгтэй байна. Тийм учраас танайх надад Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс эрчим хүчнээс авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг "УБЦС" ХХК-д явуулж өгөөч ээ. Би танай албан бичгийг чинь хавсаргаад холбогдох цахилгааны техникийн нөхөцлөө аваад танай эмнэлгийн цахилгаанчинтай чинь холбуулчихъя" гэж гуйж орж ирсэн. Тэгээд гараад явсан юм. Тэгээд би эмнэлгийн инженер техникийн албыг хариуцан ажилладаг "СС" ХХК-ийн ерөнхий инженер Ж.Ур, Т.Ба нарыг дуудан оруулж ирээд энэ талаар асуухад тэд нар эмнэлгийн цахилгаанаас холбоход болохгүй юм байхгүй гэсэн зүйлийг хэлсэн юм. Тэгээд

хэсэг хугацааны дараа дахиад Д.Га нь миний өрөөнд орж ирэхэд нь би “УБЦС” ХК-нд “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлыг эмнэлгийн цахилгаан эрчим хүчтэй холбогдоход ямар нэгэн байдлаар татгалзах зүйлгүй гэсэн албан бичгийг хийж өгсөн...” гэсэн мэдүүлэг,

Л.Бө-ийн “...Манай компанийн цахилгааны цахилгааны инженер Т.Ба, ерөнхий инженер Ж.Ур нар нь ХӨСҮТ-ийн цахилгааны бүхий л холболт, залгалтыг бүрэн хариуцаж, түүнд хяналт тавьдаг эрх бүхий ажилтнууд юм. Дээрх 2 ажилтан инженерийн хувьд ХӨСҮТ-ийн хаалттай цахилгааны эх үүсвэрийн 2 ДП байдаг бөгөөд үүнээс цахилгаан авдаг аж ахуйн нэгж, иргэдийн цахилгааны холболт, таслалтыг хариуцах бөгөөд гадны хэрэглэгчдийг уг цахилгаанд холбохын тулд зөвхөн ХӨСҮТ-ийн захирал Ня-с ХӨСҮТ-ийн цахилгаанаас шинээр холболт хийх тохиолдолд зөвшөөрөл авч байж холболтыг нь хийж өгдөг юм. ХӨСҮТ-ийн захирлын зөвшөөрөлгүйгээр гадны цахилгаан хэрэглэгчдийг холбох эрх бол манай 2 инженерт байхгүй, энэ талаар ч манай 2 инженерийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан байгаа юм...” гэсэн мэдүүлэг

Шүүгдэгч Т.Ба шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн:

З.Ц бидний хооронд ярилцан тохирсон зүйл байдаг. З.Ц-н зүгээс манайд мэргэжлийн цахилгаанчин байхгүй, шаардлагатай үед надаар янзлуулахаар харилцан тохирсон байдаг. 2013 онд цахилгааны тэжээл нь тасарсан гэмтэл гарсан байсныг засаж өгсөн. Тэр мэргэжлийн ур чадвар шаардсан зүйл байдаг. Надад З.Ц 400.000 төгрөгийг өгсөн. Би ажлынхаа хөлсийг авсан...” гэсэн мэдүүлэг.

Шүүгдэгч Ж.Ур-ын шүүхийн хэлэлцүүлэгч өгсөн:

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Т.Ба надад гэж 200.000 төгрөг өгсөн, уг мөнгөнөөс би 100,000 төгрөгийг авч, үлдэх 100,000 төгрөгийг Т.Ба-д буцаан өгсөн, ингэхдээ миний хийсэн ажил гэж юу байхав, гол ажлыг чи хийдэг гээд буцааж өгсөн, би Д.Га-с хээл хахууль гэж мөнгө аваагүй, 100,000 төгрөгийг Т.Ба-с авсан, хээл хахууль авсан гэж үзэхгүй байна...” гэсэн мэдүүлэг болон шүүхийн хэлэлцүүлэгт гаргаж өгсөн “Мо” ХХК-ийн кассын тайлан, кассын зарлагын ордер зэрэг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны санхүүгийн баримт зэргээр тэднийг хээл хахууль авсан гэх үйлдэл няцаагдаж байна гэж шүүх үзнэ.

Өөрөөр хэлбэл, Т.Ба, Ж.Ур нар нь албан тушаалын байдлаа ашиглан бусдаас хээл хахуульд тус бүр 200,000 төгрөг авсан болох нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтууд болон шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн шүүгдэгч нарын мэдүүлгээр нотлогдож тогтоогдоогүй, нөгөө талаар 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Авлигын эсрэг хуулийн /2006 оны хуулийн/ 4 дүгээр зүйлийн 4.1.2 “Төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан”. 4.1.4 “Тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан” байх гэсэн хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд тооцогдохгүй байна.

Иймд Т.Ба, Ж.Ур нарын албан тушаалтан хээл хахууль авсан гэх хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгах хууль зүйн үндэслэлтэй байна.

Мөн дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, 269.1 дэх хэсэгт зааснаар ял сонсгож, яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүгдэгч Д.Га-н зарим үйлдэлтэй тохирохгүй байна.

Учир нь Т.Ба, Ж.Ур нарыг хээл хахууль авсан гэх үйлдлийг шүүх гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож буйтай холбоотойгоор Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-н бусдаар дамжуулан хээл хахууль өгсөн гэх хэргийг мөн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Шүүгдэгч Д.Га-г 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “О” ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий албан тушаалтанд нөлөөлж санал хүргүүлэн “О” ХХК-ийн захирал Х.Бс-г хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-аас 2.000.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан гэх үйлдэл нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдоогүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т хэрэг бүртгэгч



мөрдөн байцаагч, прокурор нь талуудын хүсэлт болон өөрийн санаачилгаар энэ хуульд заасан журмын дагуу мэдүүлэг авах дүгнэлт гаргуулахаар шинжээч томилох, үзлэг, нэгжлэг хийх болон энэ хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах, байгууллага, албан тушаалтан, иргэнээс болон гүйцэтгэх ажил эрхэлж байгаа байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримт, баримт сэлтийг гаргуулан авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар шалгалт, үзлэг хийлгүүлэхийг шаардах эрхтэй” гэж, 92.4-т “Нотлох баримтыг цуглуулахдаа иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх, зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.” гэж заасны дагуу хэрэгт хураагдаж ирүүлсэн нэг ширхэг CD болон уг CD-нд үзлэг хийсэн тэмдэглэл зэрэг нь байцаан шийтгэх ажиллагааны дагуу авагдаагүй, шүүгдэгч Д.Га нь албаны чиг үүргийн дагуу 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хуралдаанд оролцож, хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар удаа дараа зөрчил гаргасан нэр бүхий компаниудын тусгай зөвшөөрлийг цуцлуулах эсэх асуудлыг яаманд хүргүүлэх тухай санал гаргасан, улмаар 2013.12.02-ны өдрийн 02-021298 тоот албан тоотоор “О” ХХК, “Эк” ХХК-иудын барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн болох нь 1-р хавтаст хэргийн 66-75 дугаар талд авагдсан бичгийн нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Түүнчлэн хэрэгт “О” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг цуцлаагүй бөгөөд 2015.04.30-ны өдөр хүртэл хүчинтэй талаар саналыг Барилга, хот байгуулалтын яамны Барилгын Хөгжлийн Төвийн 2014.05.28-ны өдрийн 2/1831 дугаартай албан бичиг хэрэгт авагдсанаас үзэхэд шүүгдэгч Д.Га нь албан тушаалын байдлаа ашиглаж “О” ХХК-ийн захирал Х.Бс-г хясан боогдуулах замаар Х.Бт-с 2.0 сая төгрөгийн авлига авахыг завдсан гэх үйлдэл, үр дагавар хоёрын хоорондох шалтгаант холбоо тогтоогдохгүй байна. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн,

яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэсэн заалтыг баримтлан шүүгдэгч Д.Га-д холбогдох дээрх үйлдлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Шүүгдэгч Д.Га-н дээрх үйлдлийг хэрэгсэхгүй болгож буйтай холбогдуулан Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон өөрчлөн зүйчлэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Харин шүүгдэгч Д.Га нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “МБ” ХХК-ны “NM” шөнийн цэнгээний газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгааг мэдсээр байж өөрт олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийг санаатайгаар биелүүлэхгүй, өөрийн албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүйгээр У.Ба-с 2.000.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргийг үйлдсэн болох нь:

Мөн шүүгдэгч У.Ба нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “МБ” ХХК-ны “NM” шөнийн цэнгээний газрынхаа үйл ажиллагааг явуулах Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй тул “ИҮЭ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд иргэн Д.Га-д 2.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэргийг үйлдсэн болох нь:

Шүүгдэгч У.Ба-н мөрдөн байцаалтын шатанд өгсөн: “...Мэргэжлийн хяналтын зүгээс манай шөнийн цэнгээний газрыг “ИҮО” ХХК-ийн нэр дээр авсан тусгай зөвшөөрлийг ашиглаж байгааг мэдэж байсан. 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр би Б.Э-н хамтаар машинтай гадуур явж байхад Д.Га ах над руу утсаар яриад чи нэг хүрээд ирээч гэхээр нь би Э-н хамтаар очиж уулзахаар явсан тэгээд ажил дээр нь очиж уулзахдаа би Д.Га даргад 2.000.000 төгрөгийг бэлнээр хээл хахуульд өгсөн. Миний хувьд манай компани нь шөнийн цэнгээний газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулах ямар ч тусгай зөвшөөрөлгүй байсан

учраас хэвийн үйл ажиллагаа явуулахын тулд Д.Га-д 2.000.000 төгрөг өгсөн...” гэсэн мэдүүлэг /1-р хавтас 205, 211х/

Гэрч Б.Э-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн:

“...2013 оны 12 дугаар 11-ний өдөр Бо буюуТ.Ба бид хоёрыг хамт явж байхад Д.Га ах эхлээд над руу, дараа нь У.Ба руу гар утсаараа залгаад бид хоёрыг нэг ирээд уулзаач гэж хэлсэн. Тэр үед бид 2 цуг явж байсан болохоор Д.Га ахын ажил дээр нь очиж уулзсан. ..гэсэн мэдүүлэг /1-р хавтас166х/, хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтууд, шүүхийн хэлэлцүүлэгт оролцож мэдүүлэг өгсөн шүүгдэгч Д.Га, У.Ба нарын мэдүүлгээр нотлогдож тогтоогдож байх тул тэднийг энэ гэмт хэрэгт заасан гэм буруутайд тооцож, ял оногдуулах үндэслэлтэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан “хясан боогдуулах” гэж тухайн хүнд тохиолдсон аливаа шаардлага, тулгамдсан хэрэгцээ, үүссэн нөхцөл байдлыг ашиглах замаар хээл хахууль өгөх, зайлшгүй нөхцөл байдлыг зориудаар бий болгох, эсхүл хээл хахууль өгөхийг тулган шаардахыг ойлгоно. Гэтэл шүүгдэгч Д.Га-н дээрх үйлдэлд У.Ба-г хясан боогдуулсан гэх нөхцөл байдал тогтоогдохгүй байгааг тэмдэглэж байна.

Шүүгдэгч У.Ба-н өмгөөлөгчийн гаргасан хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү гэсэн хүсэлтийг шүүх хүлээн авах боломжгүй гэж үзнэ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт “...тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг ...хугацааааар хасаж... гэж заасны дагуу шүүгдэгч Д.Га-н улсын байцаагчаар / төрийн албанд/ ажиллах эрхийг тодорхой хугацаагаар хассан нэмэгдэл ял хэрэглэх нь зүйтэй.

Шүүгдэгч Д.Га нь уг хэрэгт 2014 оны 03 дугаар сарын 10-наас 2014 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хүртэл нийт 73 хоног цагдан хоригдсон байна. /3-р хавтас 36х, 41х, 5-р хавтас 49х/

Мөн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар Д.З-ын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №02 дугаартай тогтоолоор битүүмжлэгдсэн эрхийн улсын бүртгэлийн Ү-22040xxxxx-рт бүртгэгдсэн, Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Зүүн 4 зам хороолол ...дугаар гудамжны ...тоот дахь хувийн сууцыг битүүмжилсэн тогтоолыг

хүчингүй болгох нь зүйтэй.

Шүүх, шүүгдэгч Д.Га, У.Ба нарт ял шийтгэл оногдуулахдаа анх удаа Эрүүгийн хуулийн хүндэвтэр ангилалд хамаарах гэмт хэрэг үйлдсэнийг ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцов.

Шүүх шүүгдэгч Д.Га, У.Ба нар нь удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, эрүүл мэндийн болон хувийн байдал, бусдад төлөх хохирол төлбөргүй зэрэг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт заасныг хэрэглэх боломжтой гэж дүгнэв.

Энэ хэрэгт шийдвэрлэвэл зохих нэр бүхий шүүгдэгч нартай холбоотой иргэний баримт бичиг шүүхэд шилжиж ирээгүй, шүүгдэгч Д.Га, У.Ба нар нь бусдад төлөх төлбөргүй, шүүгдэгч У.Ба, цагдан хоригдсон хоноггүй болохыг тус тус дурдаж, хэргийн хамт ирүүлсэн CD 1 ширхгийг эрүүгийн хэрэгт хавсаргав.

Т.Ба, Ж.Ур нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож буйтай холбогдуулан тэдний “Голомт” банкаар дамжуулан Төрийн сангийн 9000xxxxx тоот дансанд тушаасан 400.000 төгрөгийг буцаан олгож, Т.Ба, Ж.Ур нарт авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, шүүгдэгч Д.Га-с “Улаанбаатар хотын банк”-ны 26020xxxxx тоот дансанд тушаасан 2.0 сая төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж шийдвэрлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар 246.2, 248.1.1, 248.1.2, 283, 286 дугаар зүйлийн 286.1, 290 дүгээр зүйлийн 290.3, 294, 296, 297 дугаар зүйлийн 297.1, 298 дугаар зүйлд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Т.Ба, Ж.Ур нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, Т.Ба, Ж.Ур нарыг цагаатгасугай.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн

208 дугаар зүйлийн 208.1.2, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д холбогдох хэргээс 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд "О" ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий албан тушаалтанд нөлөөлж санал хүргүүлэн "О" ХХК-ийн захирал Х.Бс-г хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-с 2.000.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан гэх хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

4. Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон өөрчлөн зүйлчилсүгэй.

5. Ж овогт Д. Га-г хээл хахууль авсан, Б овогт У.Ба-г албан тушаалтанд хээл хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцсугай.

6. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар Д.Га-г мэргэжлийн хяналтын улсын байцаагчаар ажиллах эрхийг 3 /гурав/ жилийн хугацаагаар хасаж, 3/ гурав/ жилийн хугацаагаар хорих ял,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар У.Ба-г 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Га, У.Ба нарт оногдуулсан хорих ялыг тус бүр жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

8. Д.Га 73 хоног цагдан хоригдсон, Т.Ба, Ж.Ур, У.Ба нар нь цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдсугай.

9. Ж.Ур, Т.Ба нарын "Голомт" банкны Авлигатай тэмцэх газар Төрийн сангийн 9000xxxx тоот дансанд тушаасан 400.000 төгрөгийг Ж.Ур, Т.Ба нарт буцаан олгож, шүүгдэгч Д.Га-ээс Улаанбаатар хотын банкны 26020xxxx тоот дансанд 2.000.000 төгрөг

тушаасныг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

10. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт хураагдаж ирүүлсэн 1 ширхэг CD-г хэрэгт хавсаргасугай.

11. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт зааснаар эрхийн улсын бүртгэлийн Y-22040xxxx-рт бүртгэгдсэн, Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, ...тоот дахь хувийн сууцыг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №02 дугаартай тогтоолыг хүчингүй болгосугай.

12. Энэ хэрэгт шийдвэрлэвэл зохих нэр бүхий шүүгдэгч нартай холбоотой иргэний баримт бичиг шүүхэд шилжиж ирээгүй, шүүгдэгч Д.Га, У.Ба нар нь бусдад төлөх төлбөргүй болохыг тус тус дурдсугай.

13. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар Д.Га, У.Ба нарт оногдуулсан хорих ялыг тус бүр тэнсэж шүүгдэгч Д.Га-г 2 /хоёр/ жилийн хугацаагаар, шүүгдэгч У.Ба-г 1 /нэг/ жилийн хугацаагаар хянан харгалзаж, тэнсэгдсэн ялтан нарт хяналт тавьж ажиллахыг тэдгээрийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийг харьяалах Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст даалгасугай.

14. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Га-д оногдуулсан албан тушаал эрхлэх эрх хасах нэмэгдэл ялыг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолсугай.

15. Шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч Д.Га, У.Ба нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж, Т.Ба, Ж.Ур нарт авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосугай.

16. Шийтгэх тогтоолд эрх бүхий этгээд давж заалдах гомдол гаргасан, улсын яллагч эсэргүүцэл бичсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол Д.Га, У.Ба, Т.Ба, Ж.Ур нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх, арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлэхээр тогтсугай.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Ё.ЦОГТЗАНДАН  
Д.АЛТАНЖИГҮҮР  
С.БАЗАРХАНД

## МАГАДЛАЛ

2014 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 713

Улаанбаатар хот

Д.Га, У.Ба, Т.Ба, Ж.Ур нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Ш.Бат-Эрдэнэ даргалж, шүүгч Н.Батсайхан, Ц.Оч нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

прокурор Г.Магнайжав,  
ялтан Д.Га-гийн өмгөөлөгч  
Л.Түвшинцэнгэл, Л.Даваасүрэн,  
ялтан У.Ба-ийн өмгөөлөгч И.Ганчимэг,  
нарийн бичгийн дарга П.Хулангоо нарыг оролцуулж,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Ё.Цогтзандан даргалж, шүүгч С.Базарханд, Д.Алтанжигүүр нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаар шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч прокурор Г.Магнайжавын бичсэн 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 35 дугаар улсын яллагчийн эсэргүүцлээр Д.Га, У.Ба, Т.Ба, Ж.Ур нарт холбогдох 201426000025 дугаартай хэргийг 2014 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч, шүүгч Ц.Очийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Ж овогт Д.Га, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Ховд аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга ажилтай байсан, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, /РД:ХК...../

2. Б овогт У.Ба, ....оны ...дугаар сарын ...нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай эрэгтэй, бүрэн бус боловсролтой, жолооч мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, /РД:ШД...../

3. З овогт Т.Ба, ...оны ...дүгээр сарын ...нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, цахилгааны инженер мэргэжилтэй, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер, техникийн албаны үйл ажиллагааг хариуцсан “СС” ХХК-ийн цахилгааны инженер ажилтай, ам бүл ..., эхнэр ...хүүхдийн хамт Баянгол

дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, /РД:ЧМ...../

4. Л овогт Ж.Ур, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Завхан аймгийн ...суманд төрсөн, ...настай эмэгтэй, дээд боловсролтой, боловсруулах үйлдвэрийн технологи инженер мэргэжилтэй, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер техникийн албаны үйл ажиллагааг хариуцсан “СС” ХХК-ийн ерөнхий инженер ажилтай, ам бүл..., нөхрийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо Чингэлтэйн ...тоотод оршин суух, урьд өмнө ял шийтгэл эдэлж байгаагүй, /РД:ХЖ...../

Д.Га нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “О” ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий албан тушаалтанд нөлөөлж, санал хүргүүлэн “О” ХХК-ийн захирал Х.Бс-ыг хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-аас 2.000.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан,

-2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “МБ” ХХК-ийн “НМ” шөнийн цэнгээний газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй, “ИҮЭ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг дээрх шөнийн цэнгээний газар ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулах шаардлагатай байгааг далимдуулан иргэн У.Ба-ийг хясан боогдуулах замаар, давтан үйлдлээр 2.000.000 төгрөгийн хээл хахууль авсан,

-2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Их тойруу-19 тоот гудамжны “РХ” зочид буудалд “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбуулан, цахилгаан ашиглаж байсныхаа төлөө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн инженер, техникийн албаны үйл ажиллагааг хариуцан ажилладаг “СС” ХХК-ийн ерөнхий инженер Ж.Ур-т 200.000 төгрөг,

инженер Т.Ба-д 200.000 төгрөгийг тус тус эхнэр З.Ц-аар дамжуулан хээл хахууль өгсөн,

У.Ба нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “МБ” ХХК-ийн “NM” шөнийн цэнгээний газрынхаа үйл ажиллагааг явуулах Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй тул “ИҮЭ” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд иргэн Д.Га-д 2.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Ж.Ур нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо Их тойруу-196 тоот гудамжны “РХ” зочид буудалд “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбож, цахилгааныг ашиглуулж байсныхаа төлөө иргэн Д.Га-гээс 200.000 төгрөгийн хээл хахууль авсан,

Т.Ба нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо Их тойруу-19. тоот гудамжны “РХ” зочид буудалд “Мо” ХХК-ийн “РХ” зочид буудлын цахилгааныг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хаалттай дэд станцтай холбож, цахилгааныг ашиглуулж байсныхаа төлөө иргэн Д.Га-гээс 200.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэгт тус тус холбогдон Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Д.Га-гийн үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, 269 дүгээр зүйлийн 269.1, У.Ба-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1, Ж.Ур, Т.Ба нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар тус тус зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Т.Ба, Ж.Ур нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, Т.Ба, Ж.Ур нарыг цагаатгаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын

газраас шүүгдэгч Д.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д холбогдох хэргээс 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “О” ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий албан тушаалтанд нөлөөлж санал хүргүүлэн “О” ХХК-ийн захирал Х.Бс-ыг хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-аас 2.000.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан гэх хэргийг хэрэгсэхгүй болгож, Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч Д.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон өөрчлөн зүйлчилж, Д.Га-г хээл хахууль авсан, У.Ба-ийг албан тушаалтанд хээл хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар Д.Га-г мэргэжлийн хяналтын улсын байцаагчаар ажиллах эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар У.Ба-ийг 2 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Га, У.Ба нарт оногдуулсан хорих ялыг тус бүр жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлж, Д.Га 73 хоног цагдан хоригдсон, Т.Ба, Ж.Ур, У.Ба нар нь цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдаж, Ж.Ур, Т.Ба нарын Голомт банкны Авлигатай тэмцэх газар Төрийн сангийн 90003xxxx тоот дансанд тушаасан 400.000 төгрөгийг Ж.Ур, Т.Ба нарт буцаан олгож, шүүгдэгч Д.Га-гээс Улаанбаатар хотын банкны 260200xxxx тоот дансанд 2.000.000 төгрөг тушаасныг улсын орлогод хэвээр үлдээж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт хураагдаж ирүүлсэн 1 ширхэг CD-г хэрэгт хавсаргаж, Эрүүгийн байцаан шийтгэх

хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт зааснаар эрхийн улсын бүртгэлийн Y-220401xxxx-рт бүртгэгдсэн, Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, ...тоот хувийн сууцыг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №02 дугаартай тогтоолыг хүчингүй болгож, хэрэгт шийдвэрлэвэл зохих нэр бүхий шүүгдэгч нартай холбоотой иргэний баримт бичиг шүүхэд шилжиж ирээгүй, шүүгдэгч Д.Га, У.Ба нар нь бусдад төлөх төлбөргүй болохыг тус тус дурдаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар Д.Га, У.Ба нарт оногдуулсан хорих ялыг тус бүр тэнсэж шүүгдэгч Д.Га-г 2 жилийн хугацаагаар, шүүгдэгч У.Ба-ийг 1 жилийн хугацаагаар хянан харгалзаж, тэнсэгдсэн ялтан нарт хяналт тавьж ажиллахыг тэдгээрийн оршин суугаа газрын нутаг дэвсгэрийг харьяалах Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст даалгаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Га-д ногдуулсан албан тушаал эрхлэх эрх хасах нэмэгдэл ялыг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолж, шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч Д.Га, У.Ба нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж, Т.Ба, Ж.Ур нарт авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Прокурор Г.Магнайжав бичсэн эсэргүүцэл болон тус шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ:

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх бүрэлдэхүүн шүүгдэгч Д.Га-гийн гэмт үйлдлүүдэд дүгнэлт хийж, прокурорын яллах дүгнэлт үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан зүйлчлэлийг өөрчлөхдөө “Д.Га-г 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд “О” ХХК-ийн барилга барих тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцлуулахын тулд эрх бүхий албан тушаалтанд нөлөөлж, санал хүргүүлэн “О” ХХК-ийн захирал Х.Бс-ыг хясан боогдуулах замаар иргэн Х.Бт-аас 2 сая төгрөгийн хээл хахууль авахыг завдсан” гэх үйлдлийг хэрэгсэхгүй болгож, давтан үйлдлийг үгүйсгэн, мөн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон хөнгөрүүлжээ. Шүүх зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж

шийдвэрлэх үндэслэлээ хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдоогүй, завдсан гэх үйлдэл, үр дагавар хоёрын хоорондох шалтгаант холбоо тогтоогдоогүй гэж дүгнэлт хийсэн нь үндэслэлгүй байна. Учир нь шүүх шийтгэх тогтоолдоо хэрэгт хураагдаж ирүүлсэн нэг ширхэг сиди болон уг сидинд үзлэг хийсэн тэмдэглэл нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 92.2, 92.4 дэх хэсэгт заасныг зөрчин байцаан шийтгэх ажиллагааны дагуу авагдаагүй гэж үзвэл шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх хэсэгт зааснаар нотлох чадвараа алдсан гэж дүгнэлт хийн нотлох баримтаас хасах боломжтой. Шүүгдэгч Д.Га-гийн дээрх үйлдэл сидинээс гадна гэрч Х.Бс-ы “Д.Га компанийн үйл ажиллагааг зогсооно гэж дарамтлах, манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээг санхүүжүүл” гэх зэргээр хууль бус шаардлага тавих замаар удаа дараа хээл хахууль нэхээд улмаар өгөхгүй болохоор Барилга хот, байгууллалтын яам руу манай компанийг үндэслэлгүйгээр буруутгасан албан бичиг хүргүүлэх саналыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа гаргаж явуулсан байдаг юм... 2013 оны 11 дүгээр сарын 12-нд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөлийн хурлаар Хан-Уул дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Б манай компанийг оруулсан. Уг нь уг зөвлөлийн хурлаар ямар нэгэн шалтгаантай аж ахуйн нэгжийг оруулдаг юм. 2013 оны 05 дугаар сард Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт барьж байсан барилгын 2 давхараас манай компанийн нэг ажилтан унаж эндсэн юм. Тухайн үед хуулийн байгууллага шалгаад зохих шийдвэр дүгнэлт нь гарчихсан байсан. Тодруулж хэлбэл компанийн зүгээс ямар нэгэн буруу зүйл байхгүй, тухайн ажилчин хөдөлмөр аюулгүй байдлын журам зөрчсөнөөс болсон байсан энэхүү асуудлаар зөвлөлийн хурлаар оруулсан. Хуралдаанд Д.Га манай компанийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг хэлж оруулж байсан. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа, Д.Га-тэй их ойр дотно найз нөхөд гэдэг юм. Ингээд энэ хурлын дараа Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга М.Баа-гийн гарын үсэг бүхий албан бичиг Барилга, хот байгууллалтын яаманд явуулсан байдаг. Тэр албан бичигт манай компанийн тусгай зөвшөөрлийг

хүчингүй болгох санал бичигдсэн гэсэн. Би Мэргэжлийн хяналтын газарт 2013 оны 12 дугаар сард гомдол гаргасан. Үүний дагуу манай компанийн үйл ажиллагаанд шалгалт хийгээд ямар нэгэн зөрчилгүй гэж дүгнэлт гаргаад Барилга хот байгууллалтын яаманд хүргүүлсэн юм. Д.Га нь 2013 оны 12 дугаар сард манай ах Х.Бт-аас манай байгууллагын шинэ жилийн арга хэмжээг даачихаач гээд нэхсэн байдаг. ...Д.Га надаас барилгын шатаа гуйж байсныг өгөөгүй, дараа нь хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан инженер В.Н-ээс хэв хашмал асууж байсан гэдэг. Ингээд хүссэн зүйлийг хангаагүй учир мөн өөрийг нь тоосонгүй гээд манай компанийн үйл ажиллагааг зогсооно гэж дарамтлах болсон гэж үзэж байна" гэх мэдүүлэг, мөн гэрч Х.Бт, В.Н, Ц.Б, Ц.Эн, М.Баа нарын мэдүүлгүүдээр хангалттай тогтоогдсон болно. Мөн завдсан гэх үйлдэл, үр дагавар хоёрын хооронд шалтгаан холбоо байгаа болох нь Баянгол дүүргийн мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Га нь 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хуралдаанд "О" ХХК-ийн барилга угсралтын тусгай зөвшөөрлийг тухайн компанийн барилга дээрээс хүн унаж нас барсан гэж түр зогсоох хууль журамд заасан заалтыг даван цуцлах үндэслэл байхгүй байхад дээрх үйлдлийг үндэслэн бүхэлд нь зөвшөөрлийг цуцлах санал гаргасан, аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийн тухай хуулинд тусгай зөвшөөрлийг улсын байцаагчийн дүгнэлтээр түдгэлзүүлэх саналыг холбогдох төрийн захиргааны байгууллагад нь хүргүүлэхээр заасан байдаг Т.Ба үүний дагуу холбогдох байгууллага шийдвэрлэдэг учир зөвлөлийн хуралд гаргасан санал ач холбогдолтой байна. Саналыг үндэслэн хүргүүлсэн албан бичгийн дараа тулгамдсан хэрэгцээ, үүссэн нөхцөл байдлыг ашиглах замаар хээл хахууль зайлшгүй өгөх нөхцөл байдлыг зориудаар бий болгон иргэн Х.Бт-аас 2.000.000 төгрөг өгчих, би танай тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлуулахгүй байх талаар хөөцөлдөнө гэж өөрийн өмнө гаргасан саналаа үгүйсгэх үйлдэл хийсэн болох нь гэрч Х.Бс, Х.Бт, В.Н, Ц.Б, Ц.Эн, М.Баа нарын мэдүүлэг, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2013 оны гадагш явуулсан албан бичгийн бүртгэл, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, шийдвэр зэрэг бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл зэрэг

нотлох баримтуудаар тогтоогдож шалтгаант холбоо бий болж байна. Шүүх энэхүү хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг давхар баримтлан шийдвэрлэсэн нь ойлгомжгүй байгааг дурдах нь зүйтэй. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаартай шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303 дугаар зүйлийн 303.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон эсэргүүцэл бичсэн гэв.

Ялтан Д.Га-гийн өмгөөлөгч Л.Даваасүрэн шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаар шийтгэх тогтоол хуулийн дагуу, үндэслэл бүхий гарсан. Прокурор завдсан гэх үйлдэл, үр дагавар хоёрын хооронд шалтгаант холбоо байна гэж байна. Гэтэл прокурор өөрөө шалтгаант холбоо нь юу вэ гэдгийг тогтоогоогүй. Аливаа гэмт хэрэг хохирол учирсан байхыг шаардсан байдаг. "О" ХХК-д ямар ч хохирол учраагүй. Тухайн үед Нийслэлийн Мэргэжлийн хяналтын зөвлөлийн хурлаар олон компанийн асуудлыг авч хэлэлцсэний дотор "О" ХХК-ийн барилгаас хүн унасан асуудлыг хэлэлцсэн. Үүний дагуу Д.Га нь өөрийн бүрэн эрхийн дагуу санал өгсөн. Тиймээс шалтгаант холбоо байхгүй хор уршиг учраагүй. Мөн яллах дүгнэлтэд "Хясан боогдуулсан" гэж байна. Хясан боогдуулах гэдэг нь ажил, үйл ажиллагааных нь дагуу саад учруулах замаар хясан боогдуулах үйлдлийг ойлгоно. Гэтэл ямар нэг үйлдэлд саад учруулсан асуудал байхгүй. Гэтэл нотлох баримт гэж үзэж байгаа бичлэгийг "О" ХХК-ийн төлөөлөх эрхтэй, үгүй нь тодорхойгүй Х.Бт гэх хүн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөлийн хурлаас нэг сарын дараа Д.Га дээр очиж уулзахдаа утсандаа бичлэг хийсэн байсан. Үүнийг хуулийн дагуу бүрдүүлсэн нотлох баримт гэж үзэж болохгүй. Тиймээс анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх хүсэлтэй байна гэв.

Ялтан Д.Га-гийн өмгөөлөгч Л.Түвшинцэнгэл шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын зөвлөлийн хурал 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэргийг шийдвэрлэдэг. Энэ зөвлөлийн тэргүүн нь Д.Га биш. Тухайн

үед "О" ХХК-ийн Баянгол дүүрэгт барьж байгаад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам зөрчсөн гэж үзээд 2012 оны 05 дугаар сард үйл ажиллагааг нь зогсоох шийдвэр гарсан байдаг. Мөн Хан-Уул дүүрэгт барьж байсан барилгаас хүн унаж нас барсан тул Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөлийн хуралд төлөвлөгөөний дагуу орсон. н.Б нь Эрүүгийн цагдаагийн газарт ажиллаж байсан, эрүүгийн төлөөлөгч байсан тул хуучин ажил албан тушаалаа буруу ашиглан энэ гэмт хэргийг өдөөн турхирсан. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын зөвлөлийн хурлаар ороод шийдвэр нь гарсан байхад н.Батбаяр нь Д.Га-гийн өрөөнд орж архи ууж, ярьж сууж байгаад бичлэг хийсэн байсан. Энэ бичлэгийг нотлох баримтаас хасуулах хүсэлтэй байна. Тухайн хуралд 7 хүн байсны, 4 нь "О" ХХК-ийн тусгай эрхийг цуцлах саналыг дэмжсэн байсан. Тиймээс Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх саналтай байна гэв.

Ялтан У.Ба-ийн өмгөөлөгч И.Ганчимэг шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх У.Ба-ийг хээл хахууль өгсөн гэм буруутай гэж үзсэн. Яллах дүгнэлт болон анхан шатны шүүхийн тогтоол дээр хээл хахууль өгсөн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, субъектив талыг тайлбарлахдаа зөвхөн шүүгдэгчийн мэдүүлгийг үндэслэсэн байдаг. Гэтэл хээл хахууль өгсөн, авсан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нарийн шалгах хэрэгтэй байдаг. Тулгамдсан нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага үүссэн эсэх, У.Ба-гийн хувьд хууль бус шаардлагаа хэрэгжүүлэхийн тулд Д.Га-гээс юу гуйсан, тухайн нөхцөл байдал зорилго нь хууль бус байсан эсэхийг мөрдөн байцаалтын шатанд шалгаагүй. Мөрдөн байцаалтын шатанд У.Ба өмгөөлөгчгүй олон удаа мэдүүлэг өгсөн. Анхан шатны шүүхийн хэлэцүүлэгт У.Ба "энэ асуудал нь тусгай зөвшөөрөлтэй огт хамаагүй" гэдгийг хэлсэн. Тиймээс У.Ба-гийн үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж байна. Учир нь гэрч н.Ба, н.Да нар "архи зарах тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж байгууллага өөр байгууллагад шилжүүлдэггүй" гэж хуульд байхгүй зүйлийг ярьж байхад прокурор энэ мэдүүлгийг үнэн зөв эсэхийг шалгаагүй. "ИҮО" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаад цуцлагдсанаас хойш 1 сарын дараа "ЭБА" ХХК-ийн захиралд мэдэгдэл ирсэн.

Энд хууль зөрчсөн асуудал огт байхгүй. Гэтэл "ЭБА" ХХК-тай У.Ба нь огт хамааралгүй, зөвхөн хүргэн төдий хүн. Гэтэл "ЭБА" ХХК-ийн захирал н.ЭЗ гэх хүнийг огт шалгаагүй, үнэхээр хүргэнээрээ дамжуулж хээл хахууль өгсөн үү гэдгийг огт шалгалгүй орхигдуулсан. У.Ба-гийн мэдүүлэгт "би хээл хахууль өгсөн нь үнэн" гэснийг үндэслээд ял оноосон. Гэтэл үйлдлийг нь хэрэгсэхгүй болгосон 2 хүний мэдүүлэгт ч "хэргээ хүлээн зөвшөөрч байна. Надад хөнгөн ял оноож өгнө үү" гэсэн байдаг. Өмгөөлөгчийн хувьд энэ нь мөрдөн байцаагчийн ажлын арга гэж үзэж байна. Тиймээс У.Ба-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох хүсэлтэй байна гэв.

#### ХЯНАВАЛ:

Д.Га, У.Ба, Т.Ба, Ж.Ур нарт холбогдох эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д зааснаар "...шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор..." эцэслэн хянан шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй болжээ.

Анхан шатны шүүх Т.Ба, Ж.Ур нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, тэдгээрийг цагаатган, улмаар Т.Ба, Ж.Ур нарын үйлдлийг хэрэгсэхгүй болгосонтой холбоотойгоор Д.Га-гийн бусдаар дамжуулан хээл хахууль өгсөн гэх хэргийг мөн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон өөрчлөн зүйлчилсэн нь зөв байна.

Д.Га нь 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд "МБ" ХХК-ийн "NM" шөнийн цэнгээний газрын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгааг мэдсээр байж өөрт олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийг санаатайгаар биелүүлэхгүй, өөрийн албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүйгээр У.Ба-өөс 2.000.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргийг үйлдсэн,

У.Ба нь 2013 оны 12 дугаар сарын



11-ний өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын өрөөнд "МБ" ХХК-ийн "NM" шөнийн цэнгээний газрынхаа үйл ажиллагааг явуулах Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны тусгай зөвшөөрөлгүй тул "ИҮЭ" ХХК-ийн тусгай зөвшөөрлийг ашиглан үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд иргэн Д.Га-д 2.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь:

Гэрч Б.Э-ын "...2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Бо буюу У.Ба бид хоёрыг хамт явж байхад Д.Га ах эхлээд над руу, дараа нь Бо руу гар утсаараа залгаад бид хоёрыг нэг ирээд уулзаач гэж хэлсэн. Тэр үед бид 2 цуг явж байсан болохоор Д.Га ахын ажил дээр нь очиж уулзсан..." /1-р хх-166/,

гэрч Я.Б-гийн "...Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас олгогддог согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл "МБ" ХХК-д огт олгогдож байгаагүй. Харин "ИҮЭ" ХХК-ийн нэр дээр "NM" гэсэн нэртэй бааранд бол тусгай зөвшөөрөл олгогдож байсан юм. Уг тусгай зөвшөөрөл нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар хүчингүй болгосон юм. Ингээд "NM" нэртэй баарны тусгай зөвшөөрөл хүчингүй болсон учраас ямар нэгэн байдлаар уг баарыг үйл ажиллагаа явуулахгүй байхад хяналт тавих байгууллага нь дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс болон цагдаагийн газарт тус тус даалгасан байдаг... Өөр аж ахуйн нэгжид олгосон тусгай зөвшөөрлийг ашиглаж өөр аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж болохгүй. Мөн "ИҮЭ" ХХК-ийн "NM" баарны тусгай зөвшөөрөл нь 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүчингүй болсон бөгөөд уг өдрөөс хойш хугацаанд үйл ажиллагаа явуулсан бол тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан байна... Харин мэргэжлийн хяналтын газраас уг баарны үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн талаар ямар ч албан бичиг ирж байгаагүй юм..." /1-р хх-104-105/,

гэрч О.О "...Манай мэргэжлийн хяналтын хэлтсийн байцаагч дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хийх хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гэсэн байдлаар хяналтаа хэрэгжүүлдэг юм... Харин миний "МБ" ХХК-д холбогдуулан гаргасан 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 27-02-442/1119 тоот дүгнэлтийн хувьд би уг аж

ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийн дагуу буюу шөнийн цэнгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас авахын тулд манай байгууллагын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг заавал авдаг ёстой юм. Ингэж шөнийн цэнгээний газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулахын тулд манай байгууллагад "МБ" ХХК-наас хандаж дүгнэлт гаргуулсан юм. Дүгнэлтийг дарга Д.Га хянаж дуусаад дүгнэлтийн ар талд гарын үсэг зуран "МБ" ХХК-д өгөх хувийг нь өөрөө аваад үлдсэн...Тэгээд удалгүй "МБ" ХХК-ийн захирал ЭЗ над дээр ирээд "дүгнэлтээ авах хэрэгтэй байна" гэхэд нь би ЭЗ-д "манай хэлтсийн дарга дээр байгаа даргаас авчих" гэж хэлсэн. Тэгээд ЭЗ нь Д.Га дарга дээр орчихоод гарч ирээд надад манай компанийн дүгнэлтийг өгөхгүй байна. Манай хүргэнд өгнө гэж хэлээд өгөхгүй байна. Ямар хачин юм бэ гэж хэлж байсан..." /1-р хх-116-117/ гэх мэдүүлгүүд, энэ хэргийн талаар Д.Га, У.Ба нарын үйлдсэн хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд болон хэрэгт цугларч, шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн бусад нотлох баримтуудаар нотлогдсон байна.

Мөрдөн байцаалтын шатанд шалгавал зохих нөхцөл байдлыг бүрэн шалгасан, шүүх Д.Га, У.Ба нарын үйлдсэн хэрэгт үндэслэл бүхий дүгнэлт хийж Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж шийдвэрлэсэн, хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй байна.

Улсын яллагчийн 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 35 дугаар эсэргүүцлээр, мөн давж заалдах шатны шүүх хуралдаанд гаргасан прокурорын тайлбараар анхан шатны шүүхээс Т.Ба, Ж.Ур нарын холбогдсон хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасныг, ялтан Д.Га, У.Ба нарын ялыг Эрүүгийн хуулийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4-т зааснаар тэнсэж, хянан харгалзсан талаар буруутгаж гомдол, эсэргүүцэл гаргаагүй ажээ.

Харин улсын яллагчийн эсэргүүцэлд дурдсанаар "Д.Га нь ...иргэн Х.Бт-аас 2.000.000 төгрөгийн хээл хахууль авахыг завдсан, У.Ба-ийг хясан боогдуулах замаар давтан үйлдлээр 2.000.000 төгрөгийн хээл хахууль авсан нь Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй" гэх эсэргүүцлийн хувьд анхан шатны шүүх Д.Га-гийн үйлдэлд дүгнэлт хийж,

"...Д.Га нь албаны чиг үүргийн дагуу

2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хуралдаанд оролцож, хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар удаа, дараа зөрчил гаргасан нэр бүхий компаниудын тусгай зөвшөөрлийг цуцлуулах эсэх асуудлыг яаманд хүргүүлэх тухай санал гаргасан, улмаар 213.12.02-ны өдрийн 02-0212982 тоот албан тоотоор "О" ХХК, "ЭК" ХХК-иудын барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн болох нь тогтоогдож байна.

Түүнчлэн "О" ХХК-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг цуцлаагүй бөгөөд 2015.04.30-ны өдөр хүртэл хүчинтэй талаар Барилга хөгжлийн төвийн 2014.5.28-ны өдрийн 2/1831 дугаартай албан бичиг хэрэгт авагдсанаас үзэхэд шүүгдэгч Д.Га нь албан тушаалын байдлаа ашиглаж "О" ХХК-ийн захирал Х.Бс-ыг хясан боогдуулах замаар Х.Бт-аас 2.0 сая төгрөгийн авлига авахыг завдсан гэх үйлдэл, үр дагаврын хооронд шалтгаант холбоо тогтоогдохгүй байна" гэж дүгнэн Д.Га-д холбогдох дээрх үйлдлийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй байна.

Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, улсын яллагчийн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Харин анхан шатны шүүх Эрүүгийн

хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Шүүх цагдан хоригдсон хугацааг шүүгдэгчийн ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно" гэж заасныг хэрэглээгүй нь буруу байх тул тогтоолд зохих өөрчлөлт оруулж ялтан Д.Га-гийн мөрдөн байцаалтын шатанд цагдан хоригдсон хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцохоор шийдвэрлэлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.1, 315.1.4 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 797 дугаартай шийтгэх тогтоолын 8 дахь заалтын "Д.Га 73 хоног цагдан хоригдсон..." гэснийг "Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2-т зааснаар Д.Га-гийн 2014 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 5 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл цагдан хоригдсон 72 хоногийг түүний ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож,..." гэж өөрчилж, шийтгэх тогтоолын бусад заалт, хэвээр үлдээж, прокурор Г.Магнайжавын бичсэн 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 35 дугаар улсын яллагчийн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл эрх бүхий этгээд 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Ш.БАТ-ЭРДЭНЭ  
Н.БАТСАЙХАН  
Ц.ОЧ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 35

Есөнбулаг сум

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 5 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Үйтүмэн даргалж,

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга О.Дэжидмаа

Улсын яллагч Ц.Сайнхүү

Шүүгдэгч Б.П, түүний өмгөөлөгч М.Энхзаяа

Шүүгдэгч Ч.Б түүний өмгөөлөгч Ж.Мөнхнасан нарыг оролцуулан тус шүүхийн шүүх хуралдааны танхимд нээлттэй явуулсан эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар ...аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлийн 203.1, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татах тогтоол үйлдэж ирүүлсэн Б.П, Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллагдагчаар татах тогтоол үйлдэж ирүүлсэн Ч.Б нарт холбогдох 201407000083 дураарын хэргийг 2014 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, халх, ...аймгийн ...сумын харьяат, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, ам бүл..., эхнэр ...хүүхдийн хамт ...аймгийн ...сумын ...багт оршин суух, ял шийтгэлгүй, гавьяа шагналгүй, бие эрүүл ухаан бүрэн, хэрэг хариуцах чадвартай, ДР ..... регистрийн дугаартай, Ц овогт Б.П

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, халх, ...хотын харьяат, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ ...аймгийн ...сумын хэсгийн төлөөлөгчөөр ажиллаж байсан, ам бүл..., эмээгийн хамт ...хотын ...дүүрэг, ...дугаар хороо ...хэсэг ...гудамж ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, гавьяа шагналгүй, бие эрүүл ухаан бүрэн, хэрэг хариуцах чадвартай, ДЮ..... регистрийн дугаартай Ч.Б овогт Ч.Б

Яллах дүгнэлтэд бичигдсэнээр:

Шүүгдэгч Б.П нь 2013 оны 10 дугаар сарын сүүлээр Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутаг Идрэнгийн нурууны ар худаг гэх газар ховор ан амьтан болох 1 тооны янгирыг хууль бусаар агнасан, улмаар дээрх хууль бус үйлдлээ хэрэгсэхгүй болгуулах зорилгоор

хэсгийн төлөөлөгч Ч.Б-д 5 сая төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт, шүүгдэгч Ч.Б нь Б.П гэгч нь ховор ан амьтан болох 1 тооны янгирыг хууль бусаар агнасан хэргийг хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүйгээр хэргийг шалгалгүйгээр урьдчилан амлаж 5 сая төгрөгийн хахууль авсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Шүүгдэгч Ч.Б шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: 2013 оны 12 дугаар сард Б.П гэх залуу нь янгир ямаа агнасан байж магадгүй гэх мэдээлэл аваад шалгах зорилгоор сумын байгаль хамгаалагч н.Г, сумын цагдаа Д.Ба, жолоочоор н.Т гэх залууг дагуулан эдгээр хүмүүсийн хамт Идрэнгийн нуруу луу явсан. Тэр өдөр сумын төвөөс 15 цагийн үед гараад орой 23 цагийн үед Б.П-ийн гэрт очиход эхнэр, хоёр хүүхдийнхээ хамт байсан. Тухайн үед Б.П-тэй уулзахад янгир агнасан тухайгаа өөрөө хэлсэн. Тэгээд авч явах гэтэл эхнэр нь хүнд өвчтэй, хоёр нялх хүүхэдтэй байсан тул сумын төв рүү гэр бүлээр нь аваад явъя гээд сумын төв дээр ирээд эхнэрийг нь эмнэлэгт хэвтүүлсэн. Б.П-ийн малыг харах хүн үлдээгүй, гэрийг нь хүнгүй орхиж ирсэн байсан. Тэгээд аймаг руу Б.П-г, Бт гэх залуутай аймаг дээр авчирсан. Тэгэхэд Б.П надаас миний амьдарлыг бодооч, нөхөн төлбөр төлдөг гэсэн, би тэр талаар нь сайн мэдэж байгаа, одоохондоо мөнгөний боломж муу байна гэхдээ нөхөн төлбөр төлөх мөнгийг олоод өгч байя, би хэргээ хүлээж шийдвэрлүүлнэ, эхнэр өвчтэй, хоёр хүүхэд нялх, мал харах хүн байхгүй, би өөрийн бас өөр айлын малыг малладаг эдгээр байдлыг харгалзаж үзээч гэдэг байдлаар надтай харьцсан. Тэгээд тухайн үед Б.П-ийн нөхөн төлбөрийн мөнгө гэж 4.000.000 төгрөгийг өөр дээрээ авч хадгалж байсан. Би тэр мөнгийг нь өөрөө зарцуулсан, ашигласан, тухайн мөнгийг авчихъя, ямар нэгэн ашиг сонирхлоор хувьдаа ашиглая гэсэн бодол надад огт байгаагүй. Мөнгөө өгчих тэгээд хэргийг чинь хэрэгсэхгүй

болгоод өгье гэх талаар огт яриагүй, тийм үг, үйлдэл хийгээгүй. Би өөрөө хэргийг хэрэгсэхгүй болгох эрх бүхий субъект нь биш учраас тухайн хүний амьдралын байдлыг харгалзан хэргийг хавар болохоор шийднэ гэсэн байсан. Сүүлд 5 дугаар сард Эрдэнэ сумын Сангийн далай багт Б.П-ийнх нутаглаж байхад нь очиж уулзсан, хэрэг хэтэрхий удаад байна аа хэргийг чинь хурдхан шилжүүлмээр байна, надад бас асуудалтай хэргийг удааж болохгүй гэж би хэлсэн. Тэгэхэд Б.П ямаа самнах арай болоогүй байна, та түр хүлээж байгаа ч гэсэн, би 4.000.000 төгрөг танд өгчихсөн байгаа үүн дээрээ нэмээд сумын төв ороод 1.000.000 төгрөг олж өгнө, та наад 4.000.000 төгрөгийг хадгалж байгаач гэсэн. Нөхөн төлбөрийн мөнгө хэдэн төгрөг байдгыг мэдэхгүй учраас их мөнгөтэй очоод хэргээ шийдүүлнэ гэж надад хэлсэн. Тэгээд удалгүй байж байтал Аймгийн Цагдаагийн газраас н.Бх дарга хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ирээд, хүмүүсээс байцаалт аваад би цагдаа дээр ирсэн гэх мэдүүлэг,

Шүүгдэгч Б.П шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: 2013 оны 10 дугаар сарын сүүл 11 дүгээр сарын үер Идрэнгийн нуруу хар худаг гэх газраас нэг янгир ямаа агнасан. Тэгээд байж байтал нэг сарын дараа Эрдэнэ сумын хэсгийн төлөөлөгч Ч.Б, н.Г, Д.Ба нар ирж намайг баривчилж авсан. Тухайн үед манай эхнэрийн бие муу байсан, манайх хоёр нялх хүүхэдтэй байсан. Тэгээд сумын төв дээр ирж, манай эхнэрийг эмнэлэгт хэвтүүлчхээд би аймаг руу хэсгийн төлөөлөгч Ч.Б, Л.Бт гэгч хоёр хүнтэй аймгийн төвд орж ирсэн. Аймаг дээр ирчхээд би Ч.Б-д миний ар гэрийг харсан биздээ хоёр нялх хүүхэдтэй, эхнэрийн бие муу, өвөл болох гэж байна мал харах хүн үлдсэнгүй, та уг хэргийг хойшлуулах арга байна уу гэж хэлсэн. Тэгээд нөхөн төлбөр гэж байдаг гэнэ би нөхөн төлбөрийн мөнгийг олж өгье гэж хэлээд ээжтэйгээ яриад би ховор амьтан агнасан, нөхөн төлбөр нь 4.000.000 төгрөг байдаг гэнээ та олоод өгөөч гээд ээжээс 4.000.000 төгрөг тухайн хүнд дансаар шилжүүлж авч байсан. Тэгээд Ч.Б-д нөхөн төлбөрийн мөнгө гээд 4.000.000 төгрөг өгч хадгалуулсан байсан. Тэгээд хавар 5 дугаар сарын үед ноолуур арай гараагүй байсан, тэгээд ноолуур гарахаар нь 1.000.000 төгрөгийг нөхөн төлбөрийн мөнгө гэж нэмж Ч.Б-д өгсөн байсан. Нийт 5.000.000 төгрөг нөхөн төлбөрийн мөнгө гэж өгсөн байсан. Тэгээд сая нөхөн төлбөрийнхөө мөнгийг Ч.Б-ээс

аваад нөхөн төлбөрөө төлсөн гэх мэдүүлэг,

Улсын яллагчийн хүсэлтээр: Эрдэнэ сумын Байгаль хамгаалагч н.Г-ийн тайлан /хх-7-10-рт/, гэрч Б.А-гийн мэдүүлэг /хх-21-22-рт/, гэрч Л.Бт-ийн мэдүүлэг /хх-25-26-рт/, гэрч Д.Ба-гийн мэдүүлэг /хх-27-28-рт/, гэрч Д.Н-ийн мэдүүлэг /хх-29-рт/, гэрч Ц-ийн мэдүүлэг /хх-30-31-рт/, гэрч Б.П-ийн мэдүүлэг /хх-34-рт/, гэрч А.Бр-ийн мэдүүлэг /хх-35-рт/, гэрч Д.Ат-ийн мэдүүлэг /хх-122-рт/, Хаан банкны депозит дансны дэлгэрэнгүй хуулга /хх-70-74-рт, 77-78-рт/,

Шүүгдэгч Б.П-ийн өмгөөлөгч М.Энхзаяагийн хүсэлтээр: Хохирогч, иргэний нэхэмжлэгч Г.Бс-ийн мэдүүлэг /хх-20-рт/, гэрч Б.А-гийн мэдүүлэг /хх-22-рт/, гэрч Л.Бт-ийн мэдүүлэг /хх-25-рт/, гэрч Д.Ц-ийн мэдүүлэг /хх-30-рт/, шинээр гаргаж өгсөн баримтаас эхнэр нь зүрхний өвчтэй байнга унаж татдаг өвчтэй, Эрдэнэ сумын Засаг даргын тодорхойлолт, Эд хөрөнгө битүүмжлэх тогтоол /хх-3-рт/, Эрдэнэ сумын Сангийн далай багийн Засаг даргын тодорхойлолт /хх- 50-рт/, ял шалгах хуудас /хх-53-рт/, Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт /хх-117-рт/,

Шүүгдэгч Ч.Б-ийн өмгөөлөгч Ж.Мөнхнасангийн хүсэлтээр: Гэрч С.Бч-ийн мэдүүлэг /хх-118-119-рт/, гэрч Н.С-ийн мэдүүлэг /хх-120-121-рт/, шинээр гаргаж өгсөн нотлох баримт, Ч.Б-ийн ял шалгах хуудас /хх-59-рт/, Цагдаагийн хэлтсийн тодорхойлолт /хх-130-рт/, Ч.Б-ийн бакалаврын дипломын хуулбар /хх-133-134-рт/,

Хохирогч, иргэний нэхэмжлэгчийн төлөөлөгч Г.Бс шүүхэд гаргасан хүсэлтдээ: Б.П-ээс төр экологид учирсан хохирол 5.400.000 төгрөг нэхэмжилсэн бөгөөд хохирлыг бүрэн барагдуулсан тул ямар нэгэн гомдол санал байхгүй гэх хүсэлт зэргийг шинжлэн судлав.

Шүүгдэгч Б.П нь 2013 оны 10 дугаар сарын сүүлээр ховор ан амьтан болох 1 тооны янгирыг хууль бусаар агнасан гэмт хэрэг үйлдсэн болох нь түүний үйлдсэн гэмт хэргээ хүлээн мэдүүлсэн "...Би 2013 оны 10 дугаар сарын сүүл, 11 сарын үед Идрэнгийн нурууны Ар худаг гэх газар эхнэр 2 хүүхдийн хамт мал малладаг байсан. Малдаа явахдаа өөрийн Чех калибрь маркын буугаа аваад Идрэнгийн нуруунд гартал жижиг биетэй эр янгир явж байхаар нь буудаж алаад гэртээ авчирч хоол унд хийж идээд дуусгасан..." гэх мэдүүлэг нь хавтаст хэрэгт авагдсан Эрдэнэ сумын Байгаль хамгаалагч н.Г-гийн "...Сумын

хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран янгир агнасан иргэнийг саатуулж, зохих газар нь шилжүүлсэн..." гэх тайлан /хх-7-10-рт/

Гэрч Б.А-гийн "...Манайх Идрэнгийн нурууны ар худаг гэх газар нутаглаж байсан. Нэг өдөр Б.П малдаа яваад ирэхдээ жижиг биетэй туранхай янгир үүрч ирэхээр нь асуухад малдаа явж байтал энэ янгир явж байхаар нь буугаар буудаад алчихлаа гэж хэлсэн..." гэх мэдүүлэг /хх-21-22-рт/,

Гэрч Л.Бт-ийн "...Ч.Б над дээр ирээд нэг хүн аваад аймгийн төв явах хэрэгтэй байна гээд Б.П, Ч.Б бид 3 миний хх-хх УБН улсын дугаартай автомашинаар аймаг явсан. Явахдаа Б.П-ийн гэх нэг ширхэг бууг бас аваад явсан. Аймгийн төв ороод маргааш нь миний Хаан банкны 500638хххх дансаар Б.П нь ээжээсээ 4.000.000 төгрөг аваад миний нүдэн дээр Ч.Б-д өгсөн..." гэх мэдүүлэг /хх-25-26-рт/,

Гэрч Д.Ба-гийн "Би Б.П-ээр заалгуулан Б.П-ийн хамт янгир агнасан гэх газар Идрэнгийн нуруунд Б.П-ийн хамт мотоциклоор очсон. Манай хэсгийн төлөөлөгч Ч.Б надад хэлэхдээ Эрүүгийн тасгийн дарга дэд хурандаа Д.Ат-д хэлчихлээ гэж надад хэлсэн болохоор бүртгэгдсэн байх гэж бодож байсан..." гэх мэдүүлэг /хх-27-28-рт/,

Гэрч Ч.П-ийн "...Яг хэдний өдөр байсныг сайн санахгүй байна манай хүр дүү болох Л.Бт-ийн хамтаар орой 19 цагийн орчимд ирсэн юм. Л.Бт намайг хадгалж байгаарай гээд нэг ширхэг хуучин ТО3-8 маркын бууг үлдээгээд явсан..." гэх мэдүүлэг /хх-34-рт/,

Гэрч А.Бр-ийн "... 2014 оны 01 дүгээр сард суманд ажлаар явж байгаад Ч.Б-тэй уулзсан. Манай суманд чоно элбэгшиж мал их барьж байна гээд чонон ав зохиож байсан. Тэр талаар ярьж байгаад надад буу байхгүй чамд гайгүй сайн калибрь буу байна уу гэхэд тэр надад нэг калибрь буу байгаа гэхээр нь надад түр өгчих гэхэд аймгийн төвд Ч.П ахынд байгаа тэндээс очоод авчих гэхээр нь би 3 хоногийн дараа очиж авсан..."

Гэрч Д.Ат-ийн "...2013 оны 12 дугаар сарын дундуур байх хэсгийн төлөөлөгч Ч.Б нь ангийн хэрэг илрүүлээ гэж утсаар гэж мэдэгдэхээр нь би сайн байна наад хүмүүсээ аваад аймгийн төв дээр ирээд тоо бүртгэлд оруулж шалга гэсэн..." гэх мэдүүлэг 4. /хх-122-рт/ зэрэг нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байх тул түүнд хуульд заасан хорих ял оногдуулах үндэслэлтэй байна гэж дүгнэв.

Прокуророос мөн Б.П-г Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан, Ч.Б-ийг Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан ялласан боловч хавтаст хэрэгт авагдсан гэрч Д.Ц-ийн "...Б.П нь миний утас руу залгаад ээжээ би янгир агнасан хэргээр аймгийн төв дээр ирчихсэн байна. Одоо нөхөн төлбөрийг нь хийчихвэл хэрэгсэхгүй болгоно гээд байна гэхээр нь би Н.Пэ-тэй утсаар яриад Л.Бт-ийн данс руу 4.000.000 төгрөг шилжүүлсэн гэх мэдүүлэг/хх-30-31-рт/,

Шүүгдэгч Б.П-г дахин байцаасан "... Тухайн өвөл болох гээд манай эхнэрийн бие тааруу, 2 хүүхэд нялх байсан юм тэгээд хэсгийн төлөөлөгч Ч.Б-д хандан миний ар гэрийн байдлыг харгалзан үзээд..." гэх мэдүүлэг/хх-125-126-рт/ зэргийг шинжлэн судлахад Б.П нь холбогдсон хэргээ хэрэгсэхгүй болгуулах зорилгоор дээрх мөнгийг түүнд өөрт нь хээл хахууль болгон өгч байна гэх субъектив хандлагаар биш харин нөхөн төлбөрийг нь төлж байна, төлчихвөл хэрэгсэхгүй болгох юм байна гэсэн сэтгэхүйн төөрөгдлөөр хандаж өгсөн болох нь тогтоогдож байна. Өөрөөр хэлбэл, нэг талаас хахууль өгөгчийн хүсэл зориг, нөгөө талаас хахууль авч байгаа хүсэл зориг нэгдээгүй байх тул дээрх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулж чадахгүй байна.

Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг нөхцөлт хэсэгт урьдчилан амлахгүйгээр гэж байдаг нь дээрхээс өөр агуулгатай буюу хээл хахууль өгч байгаа хүсэл зоригийг ойлгон мэдэж хүлээн авч, хээл хахууль авч байгаа хүсэл зориг хоёр нэгдсэн боловч ямар нэг амлалт бүхий хариу өгөөгүй байх явдал юм.

Харин Ч.Б-гийн үйлдэл нь төрийн албаны албан тушаалтан хууль, дүрэм, журмаар тогтоосон хэмжээ хязгаарын дотор эрх мэдлээ хэрэгжүүлэх байтал бусдын нөхөн төлбөрт өгсөн мөнгийг хувьдаа авах, хэргийг шалгахгүй байх зэргээр олгогдсон эрх хэмжээгээ илтэд хэтрүүлэн дур зоргоороо авирлах байдлаар Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйлд заасан төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэргийн шинжтэй байна. Гэвч уг гэмт хэрэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй хэрэг байх бөгөөд Ч.Б-ийн учруулсан гэх хохирол нь үлэмж хэмжээнд хүрэхгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан, мөн хуулийн 248

дугаар зүйлийн 248.1.1-д зааснаар үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэлтэй байна.

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Г.Бс шүүхэд гаргасан хүсэлдтээ: "...Б.П-ээс төр экологид учирсан хохирол 5.400.000 төгрөг нэхэмжилсэн бөгөөд хохирлыг бүрэн барагдуулсан тул ямар нэгэн гомдол санал байхгүй..." гэсэн нь хохирлыг арилгасан гэж үзэх үндэслэлтэй байна.

Шүүгдэгч Б.П нь учруулсан хохирол буюу 1 янгир ямааны экологи эдийн засгийн үнэлгээ 2.700.000 төгрөг, нөхөн төлбөр 2.700.000 төгрөгийг төлж барагдуулсан, анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн болон хувийн байдлыг харгалзан үзэж түүнд оногдуулсан хорих ялыг бичлэн эдлүүдэх шаардлагагүй гэж үзэн ялыг тэнсэж, хянан харгалзах үндэслэлтэй байна гэж үзэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1-д зааснаар Б.П гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн зэвсэг болох ТОЗ-8 маркын калибрь бууг устгаж, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц эд хөрөнгө битүүмжлэх мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгохоор тогтов.

Шүүх нотлох баримтыг үнэлэхдээ хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгт цугласан, ач холбогдолтой, эргэлзээгүй талаас нь үнэлсэн болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248.1, 282, 283, 286, 297, 298 дугаар зүйлд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 248.1.1, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар Говь-Алтай аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Б.П, Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Ч.Б нарт холбогдох үйлдлийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Шүүгдэгч Б.П-г ховор ан амьтан болох 1 тооны янгирыг агнасан гэм буруутайд

тооцсугай.

3. Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйлийн 203.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.П-г 1 жил 3 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй.

4. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.П-д оногдуулсан 1 жил 3 сарын хугацаагаар хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсүгэй.

5. Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.П-д оногдуулсан 1 жил 3 сарын хугацаагаар хорих ялыг тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзсугай.

6. Энэ хэрэгт шүүгдэгч Б.П цагдан хоригдоогүй, шүүгдэгч Ч.Б 3 хоног цагдан хоригдсон, шүүгдэгч нар төлөх төлбөргүй болохыг дурдсугай.

7. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэгт зааснаар Б.П-ийн эзэмшлийн ТОЗ-8 маркын бууг устгасугай.

8. Шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгосугай.

9. Шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл шүүгдэгч Ч.Б, Б.П нарт авсан бусдын батлан даалтад байлгах таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

10. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 304 дүгээр зүйлийн 304.1-д зааснаар шийтгэх тогтоолыг шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 5 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг мэдэгдсүгэй.

11. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 306 дугаар зүйлийн 306.1-д зааснаар давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, шүүгдэгч нарт авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ

Ц.ҮЙТҮМЭН

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүх хуралдааныг шүүгч М.Алдар даргалж,

Нарийн бичгийн дарга: Б.Батбаяр;

Улсын яллагч: Ц.Отгонноров;

Шүүгдэгчийн өмгөөлөгч: О.Сайнгэрэл /009./, П.Одонтунгаалаг /009./.

Иргэний нэхэмжлэгч: Б.А нарыг оролцуулан тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Э.Э-д холбогдох эрүүгийн 201201000476 дугаартай хэргийг 2013 оны 02 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгчийн биеийн байцаалтын талаар:

Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр ...хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Хууль зүйн дэд сайдын албан тушаалд ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт ...дүүргийн ...дүгээр хороо, ...дүгээр байрны ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар ЧР....., Х овогт Э.Э

Холбогдсон хэргийн талаар /прокурорын яллах дүгнэлтэд дурдсанаар /:

Яллагдагч Хууль зүйн дэд сайд Э.Э нь албан тушаалын байдлаа ашиглаж, 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт өөрийн [exxxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар Интерполын Нарийн бичгийн дарга нарын ерөнхий газрын цахим хуудсанд Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д хандаж "...Монгол Улсын Хууль зүйн яамны дэд сайдын хувиар энэ захидлыг бичиж байна. Монгол Улсын хоёр иргэн /Н.Эн, Б.Х/ Интерполын веб хуудасны эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн жагсаалтад байна гэсэн мэдээллийг өнөөдөр би авсан. ...Энэ хоёр хүнтэй холбоотой хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж бид үзэж байгаагаа Интерполд мэдэгдье. Эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас

энэ хоёр хүнийг авч хаяхыг албан ёсоор хүсье..." гэсэн захидлыг илгээснээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээг цуцалж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй эрүүгийн 20120100018. тоот хэргийн сэжигтэн Н.Эн, Б.Х нарыг Интерполын улаан булант зар мэдээгээр олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулахаар 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр холбогдох мэдээлэл хүргүүлснийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авч А-632./10-2012, А-634./10-2012 дугаарын улаан булант зар мэдээгээр 2012 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд хэвлэн нийтэлсэн дээрх Монголын 2 иргэнийг интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсож, тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын Шугамаар хандаж мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Шүүгдэгч Э.Э шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Улсын яллагчаас намайг Интерполд нөлөөлөх бүрэн эрхтэй, Олон улсын байгууллагад тушаал, заавар, хүсэлт явуулж үйл ажиллагааг зогсоох эрх мэдэлтэй, Монголын Интерполын үйл ажиллагаанд нөлөөлөх бүрэн эрхтэй, өөрийнхөө эрх мэдлийг ашигласан байна гэж үзэж байгаа. Анх Н.Эн-ыг хайхдаа Монголын цагдаагийн байгууллага Б.Х, Н.Эн хоёрыг хайж байна. Хамтарч гэмт хэрэг үйлдсэн хүн бол Н.Э сэтгүүлч, орчуулагч гээд явуулчихсан. Оршин суух хаяг нь тодорхойгүй. Цаад хүмүүс нь Монгол хүний нэрийг ойлгож аваад Монгол Улсын Ерөнхийлөгч байсан гэж ойлгохгүй. Дараа нь миний хувийн веб хаягаар захиа очсон. Хууль Зүйн Дэд сайд хүн байна гэж бичсэн. Дэд сайд учраас бүрэн эрхтэй гэсэн утгаар бичээгүй гэдгийг өмнө нь мөрдөн

байцаалтын шатанд мэдүүлж байсан. Тэрэнд энэ хүн Монгол Улсын Ерөнхийлөгч мөн, одоо ч гэсэн ШЁЭ-ийн тэргүүн, М намын дарга гэж захиан дээр байгаа. Тэгээд шалгалт хийсэн байгаа. Тэгээд Интерполоос миний захиаг аваад над руу хариу явуулсан. Үүнд: Э.Э гэдэг хүнээс захиа ирсэн. Хэрвээ Э.Э дэд сайд өөрөө захиа бичсэн бол сануулж хэлээрэй. Учир нь Интерполын Үндсэн хуулийн дагуу Э.Э-ийн захиаг албан ёсоор авч болохгүй. Бүх захиа Үндэсний товчоогоор дамжих ёстой гэдгийг Э.Э-д сануулаарай гэсэн. Өөрөөр хэлбэл, ОУ-ын Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга бид нар Э.Э-ийн захиаг албан ёсоор эх сурвалж болгоогүй гэдгээ хэлсэн. Танай өгсөн мэдээллээр тулгуурлан бид нар ямар нэгэн ажил хийгээгүй байна. Одоо харин та нар Э.Э-ийн захиа үнэн эсэх, захианд дурдсан Н.Э нь Монгол Улсын Ерөнхийлөгч мөн эсэх, ШЁЭ-ийн тэргүүн мөн эсэхийг хариулж өгөөч гэж явуулсан. Хавтаст хэрэгт Э.Э захиа явуулсан нь албан ёсны хэн нэгэнд нөлөөлөөд шийдвэр гаргах хэмжээний бичиг биш гэдгийг аль аль талдаа ойлгосон харилцаа байгаа. Н.Э нь Монгол Улсын Ерөнхийлөгч мөн гэдэг. Намайг захиа явуулж байхад Дээд шүүхэд хандаж цагаатгах боломж байна гэж үзэж байснаа эхнийхээ захианд бичиж байсан. ОУ-ын ямар ч байгууллага хэн нэгний гомдол, хүсэлтийг авахдаа Монгол дахь бүх үе шатаа дууссаны дараа ОУ-ын байгууллагад хандана гэдгийг би эхний захиалдаа хэлсэн. Дараа нь энэ талаар н.Т сайд дахиад захиа явуулсан. Одоо Монгол дахь бүх шат дууссан гэж захиа явуулсан. Тэгэхээр миний захиа худлаа биш байсан гэдэг нь харагдаж байгаа. Одоо ийм байдалтай болох гээд байна. Интерполын үндсэн хуульд Интерпол нь зөвхөн Интерполын бусад Үндэсний товчооны өгсөн мэдээлэл, хүсэлт шаардлагад нийцэж үйл ажиллагаа явуулна. Өөр ямар ч албан тушаалтны шаардлагад автахгүй гэдгийг Интерполын Үндсэн хуульд зааж өгсөн. Жишээ нь би Үндэсний товчоогоор дамжуулахгүйгээр Интерполд захиа явуулаад тэр үгэнд нь ороод ОУ-ын Интерпол хайхаа болсон гэх үндэслэлээр намайг буруутгаж яллаж байгаа нь нэг ёсондоо Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын хуулийн хэлтсийг Интерполынхоо дүрэм, журмыг зөрчиж, хэн хамаагүй бичсэн албан тушаалтны үгэнд та нар орчихож гэж давхар буруутгаж байна гэж би санаа зовж байгаа. Өмнө нь би хэлж

байсан. Улсын яллагчид,

Авлигатай тэмцэх газарт дахиад албан ёсоор бичье. Э.Э гэдэг Дэд сайд байна. Би тоглоогүй албан ёсоор хүсэж байна. Намайг одоо буруутгахаа боличих эсвэл тэр хүнд оногдуулж байгаа хэн аль нь ч, ямар ч хүн, ямар ч байдлаар хүсэлт гаргасан, сонинд үзэл бодлоо илэрхийлэх, захиагаар илэрхийлэх, амаар илэрхийлэх эсэх нь нөлөөлөхгүй. Учир нь хууль сахиулж байгаа бүх хүмүүс өөрсдийнхөө итгэл үнэмшил, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа. Интерпол ч мөн адил. Интерполын үйл ажиллагаа явуулах дүрэм байдаг. Дүрмийн дагуу ямар ч иргэн, байгууллагаас захидал авах нь нээлттэй. Интерполд хэн ч өөрийнхөө болон бусдын өмнөөс мэдээлэл өгөх нь нээлттэй. Бүх албан ёсны сурвалжийг Үндэсний Интерполын товчооны өгсөн мэдээлэлд тулгуурлаж үйл ажиллагаа явуулна гэсэн байгаа. Өөрөөр хэлбэл, Интерполыг Э.Э-ийн үгэнд орсон гэж давхар буруутгах гээд байгаа юм уу, эсвэл Э.Э Интерполд албан ёсоор мэдээлэл өгсөн гэж буруутгах гээд байгаа юм уу, Тэгээд дараа нь ирсэн бүх бичиг дээр наашаа явуулсан 2 бичиг байдаг. Аль аль бичигт тодорхой байдаг. Э.Э-ийн захианд үндэслэж бид нар шалгасан. Гэхдээ бид нар бүх үндэслэлээ танай Үндэсний Интерполын өгсөн мэдээлэлд тулгуурлаж, бид нар өөрсдийнхөө хийсэн хяналт, шалгалтын үндсэн дээр тулгуурлаж ирж хайх ажиллагаагаа зогсоосон гэх зүйл яриад байгаа. Тэгэхээр ямар ч байдлаар буруутгасан Монголын Үндэсний Интерполоос өгсөн баримтад үндэслэж ОУ-ын Интерпол шийдвэр гаргасан гэдгээ хоёр ч удаа албан ёсоор бичгээр мэдэгдсэн байгаа. Энэ нь намайг цагаатгах хангалттай нотлох баримт гэж бодож байгаа. Дахин сануулахад анхнаасаа л Н.Э гэдэг орчуулагч, сэтгүүлчтэй хамт гэмт хэрэг үйлдсэн гэж явуулаад тэр нь миний болон бусад хүмүүсийн явуулсан мэдээлэлд үндэслэж Монголын Улсын Ерөнхийлөгч байсан, одоо ч гэсэн УИХ-ын засаг бүрдүүлж байгаа эвслийн тэргүүнтэй холбоотой гэдэг нь ил болсон. Монголын Үндэсний Интерпол тийм гэсэн. Тэд нар өөрсдөө дахин шалгалт хийсэн. Манай дүрэмд нийцэхгүй улс төрийн үзэл давамгайлсан хэрэг байна гэж үзэж түр зуур больсон байдаг. Мөн Дээд шүүхэд давж заалдах боломж байсаар л байсан. Иймд би Дэд сайдынхаа албан тушаалынхаа эрх мэдлийг бодоод үзэхэд Үндэсний Интерполын



товчоонд нөлөөлдөг, эсвэл Авлигатай тэмцэх газарт нөлөөлдөг ямар ч эрх мэдэл байдаггүй. Надад хууль боловсруулахад саналаа оруулах л эрх мэдэл байдаг. Ийм эрх мэдлийг ашиглаж Интерполд нөлөөлнө гэж байхгүй. Интерпол өөрөө дүрэм, журмыг маш сайн баримталдаг талаар удаа дараа ирсэн бичигт байгаа. Э.Э-ийн захиаг албан ёсоор авсан гэж үзээгүй. Яагаад гэвэл үүнийг Э.Э-д тайлбарлаж өгөөрэй. Бид нар зөвхөн Үндэсний Интерполын товчоогоор дамжуулж л мэдээлэл авдаг гэдгийг Э.Э-д сануулаарай гэж Монголын Үндэсний Интерполын товчоонд албан ёсоор сануулсан. Интерпол бол таны үгэнд орохгүй. Таны хэлсэн үг албан ёсных биш шүү гэдгээ шийдвэр гаргахаасаа өмнө манайхаас мэдээлэл авахаасаа өмнө надад сануулчихсан, би ч ойлгосон. Үүнээс хойш Интерпол ямар ч шийдвэр гаргасан албан ёсны нөлөөлсөн гэх бололцоогүй байгаа. Юунд үндэслэсэн гэхээр энэ хүн Монгол Улсын Ерөнхийлөгч мөн эсэх талаар Интерполынхон явуулсан юмаа дахиж явуулсан. Үүнд шийдвэр гаргасан байна гэдгийг хэлмээр байна гэв.

Иргэний нэхэмжлэгч Б.А шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Манай байгууллагад гэм хор учраагүй. Харин шүүгдэгч Э.Э-ийн үйлдлийн улмаас Авлигатай тэмцэх газар газар Н.Эн, Б.Х нарын мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар авах боломжгүй нөхцөл байдал үүссэн учир түүнийг мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэж үзэж байгаа гэв.

Мөрдөн байцаалтын шатанд иргэний нэхэмжлэгч Б.А /3-р хх-ийн 64/, гэрч Г.Б гарын өгсөн мэдүүлгүүд /1-р хх-ийн 192-196/, Монгол Улсын Хууль зүйн яамны дэд сайд Э.Э-ээс Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга Р.Н-д явуулсан захидал /3-р хх-ийн 25/, Интерполын Нарийн бичгийн дарга нарын Ерөнхий газраас 2012.10.22-ны өдөр ирүүлсэн “Б.Х, Н.Эн нарын талаар нэмэлт мэдээлэл авах тухай” /3-р хх-ийн 23, 24/, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс Интерполын Үндэсний товчоонд 2012.11.26-ны өдөр ирүүлсэн 2012/335001 2012/334842/ албан бичиг /3-р хх-ийн 82, 83/, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс Интерполын гишүүн орнуудад 2012.12.05-ны өдрийн LA/5106.-3/5.2/YGO/DHA дугаартай

Б.Х, Н.Эн/ дугаарын улаан булант зар мэдээ цуцлагдсан тухай албан бичиг /3-р хх-ийн 80-81/, Интерполын нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс 2012.12.11-ний өдөр ирүүлсэн 2012/33500., 2012/33484. албан бичиг /3-р хх-ийн 86, 87/, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс Интерполын Үндэсний товчоонд 2014.01.16-ны өдрийн LA/5106.-8/5.2/DHA/lb тоот /3-р хх-ийн 106-108/, шүүгдэгч Э.Э-ийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгасан хуудас /1-р хх-ийн 222/ зэрэг болно.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд болон хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудыг шүүх тал бүрээс нь бүрэн, бодитой магадлан хянасны үндсэнд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Э.Э нь Хууль зүйн дэд сайдын албан тушаалын байдлаа ашиглаж, 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт өөрийн [exxxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар Интерполын Нарийн бичгийн дарга нарын ерөнхий газрын цахим хуудсанд Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д хандаж “...Монгол Улсын иргэн Н.Э, Б.Х нарыг Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж үзэж байгаа ...энэ хоёр хүнийг эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас авч хаяхыг албан ёсоор хүсье ...” гэсэн захидлыг илгээснээр Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012.12.05-ны өдөр тэдний эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээг цуцалж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй эрүүгийн 20120100018. дугаар хэргийн сэжигтэн Н.Эн, Б.Х нарыг Интерполын улаан булант зар мэдээгээр Олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулахаар 2012.09.24-ний өдөр холбогдох мэдээлэл хүргүүлснийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авч А-632./10-2012, А-634./10-2012 дугаарын улаан булант зар мэдээгээр 2012.10.09, 10-ны өдрүүдэд хэвлэн нийтэлсэн дээрх Монголын хоёр иргэнийг интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа 2013.04.18-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсож, тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэргийг

үйлдсэн гэм буруутай болох нь нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдсон гэж шүүх дүгнэв. Үүнд:

Иргэний нэхэмжлэгч Б.А мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: "...Хууль зүйн дэд сайд Э.Э нь 2012.10.17-ны өдөр Интерпол руу Авлигатай тэмцэх газраас Н.Э нарын хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан Н.Эн, Б.Х нарыг Интерполоор эрэн сурвалжлахыг болиулах тухай цахим шуудан илгээсэн. Энэ үйлдлээс болж Н.Э нарт холбогдох хэргээс Н.Эн, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийг тусгаарласан байсан хэргийг түдгэлзүүлэн, цаашид шалгах боломжгүй болгосон..." /3-р хх-ийн 64/,

гэрч Г.Б мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: "...Монгол Улс дахь Интерполын Үндэсний товчооны ажлын албанд Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс 2012.10.22-ны өдөр мэдэгдэл ирсэн. Энэ мэдэгдэлд Э.Э гэж хүнээс и-мэйл хүлээн аваад тухайн Н.Эн, Б.Х нарт холбогдох хэрэгт тавьсан хүсэлт нь Интерполын үндсэн хууль дүрэмтэй нийцсэн эсэхийг судлахаар болсон талаар дурдсан байна. Мөн нэмэлт мэдээлэл хүссэн байсан. Танай байгууллагаас нэмэлт мэдээлэлд нь хариуг ирүүлснийг Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын Хуулийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлсэн. Ингээд 2012.11.26-нд энэ хуулийн хэлтсээс нь Н.Эн, Б.Х нарт холбогдох хэрэгт тэднийг эрэн сурвалжилсан мэдээллийг устгах болсон талаар мэдэгдсэн байсан. Энэ нь Интерполын Үндсэн хуультай нийцээгүй байна гэж үзсэн байсан. Интерполын үндсэн хуульд улс төр, цэрэг, шашин, арьс өнгөний эсрэг асуудалд тус байгууллагаас оролцохыг хатуу хориглохоор заасан байдаг. Ингээд дэд сайд Э.Э-ээс ирүүлсэн захиа, мэдээлэл, мөн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээлэл зэргийг харьцуулан үзээд энэхүү эрүүгийн хэрэгт улс төрийн намууд хоорондын зөрчилдөөн үүссэн, улс төр давамгайлсан шинжтэй байна гэж дүгнээд эрэн сурвалжлах сэжигтний мэдээллийн сангаас устгахаар болсоноо дурдсан байсан. Энэхүү эрэн сурвалжлуулах хүсэлтийг манайх хүлээн авч Интерполын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг нь хянан үздэг. Тухайн үед танай байгууллагаас ирүүлсэн нэр дурдсан хоёр этгээдийг эрэн сурвалжлуулах хүсэлт, тэдний үйлдсэн гэмт хэрэг зэрэг нь улс төр давамгайлсан шинжтэй гэж харагдаагүй. Иймд бид цааш

нь уламжилж эрэн сурвалжлалт зарлуулж байсан юм. ...Хэрэв Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар, Интерполтой харьцах л бол заавал өөрийн улс дахь Интерполын Үндэсний төв товчоогоор уламжлуулах ёстой байдаг. Хувь хүн, албан тушаалтан өөрөө шууд бичиг, хүсэлт явуулах талаар Интерполын Үндсэн Хуульд зааж өгөөгүй. Харин бичиг хүсэлтийг Интерполын Үндэсний төв товчоогоор дамжуулахаар зааж өгсөн байдаг юм аа. ...Энэ эрэн сурвалжлах ажиллагааг цуцалж зогсоосон талаар Интерполын бүх гишүүн орнуудад 2012.12.05-ны өдөр Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс мэдэгдсэн байдаг. Ер нь Б.Х, Н.Эн нартай холбоотой эрэн сурвалжлах асуудлыг зогсоож мэдээллийг устгаснаар зөвхөн тэднийг эрэн сурвалжлах ажиллагаа зогсож байгаа асуудал биш бас тэдний талаар ямар нэг мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар хандаж авах мэдээлэл авах боломжгүй болж байгаа гэсэн үг юм аа..." /1-р хх-ийн 192-196 /,

Монгол Улсын Хууль зүйн яамны дэд сайд Э.Э-ээс Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга Р.Н-д явуулсан захидалд: "...Би Монгол Улсын Хууль Зүйн Яамны дэд сайдын хувиар энэхүү захидлыг бичиж байна, Миний бие өнөөдөр Монгол Улсын иргэн Н.Эн, Б.Х нар Интерполын цахим хуудасны эрэн сурвалжлагдаж буй хүмүүсийн жагсаалтад бичигдсэн тухай мэдээлэл авлаа... Төвийг сахисан байр суурь, улс төрийн сэдэл бүхий хэрэгт оролцохоос сэргийлэх нь Интерполын үндсэн хуулийн нэгээхэн хэсэг юм. Тиймээс миний зүгээс дээрх хоёр хүнд хамаарах хэрэг нь Монгол Улсын ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн сэдэлт бүхий хэрэг гэж үзэж буйгаа Интерполд мэдэгдэх хүсэлтэй байна. Одоогийн байдлаар ШЕЭ нь парламентийн цөөнх болоод байгаа билээ. Дээрх хүмүүсийг эрэн сурвалжлагдаж буй хүмүүсийн нэрсийн жагсаалтаас гаргахыг хүсэж байна..." /3-р хх-ийн 25/,

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс Интерполын Үндэсний товчоонд 2012.11.26-ны өдөр ирүүлсэн 2012/33500. 2012/33484./ дугаартай албан бичигт: "...Интерполын Үндсэн хууль болон дүрмүүд, тодруулбал улс төр, цэрэг, шашин эсвэл арьс өнгөөр гадуурхахтай холбоотой үйл

ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг тус байгууллагад хатуу хориглоно гэж заасан байдаг. Үндсэн хуулийн 3 дугаар зүйлтэй нийцэж байгаа эсэхийг бататгах үүднээс хууль зүйн шалгалт хийгдсэн. ...Дээр дурдсан хоёр хүний эсрэг явуулсан яллах ажиллагаа нь хуулийн дагуу гэдэг нь маргаантай, нэн ялангуяа энэ нь Монголын улс төрийн нэртэй намуудын хооронд маргаан үүсгэсэн гэдэг нь тус хэргийн нөхцөл байдлын талаар танай Үндэсний төв товчооноос өгсөн мэдээлэл, Монгол Улсын Хууль зүйн дэд сайдаас хүлээн авсан захиа мөн Ерөнхий нарийн бичгийн даргын газраас хийгдсэн судалгааны үр дүнд харагдаж байна, Иймд 3 дугаар зүйлд зааснаар энэхүү хэрэг нь улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтийг хуулийн асуудал хариуцсан хэлтэсээс гаргасан болно. Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээ цуцлагдаж, энэхүү хоёр хувь хүнтэй холбоотой мэдээлэл Байгууллагын мэдээллийн сангаас устгагдах болно гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Түүнчлэн Интерполын шугамаар явагдсан цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нь энэ тохиолдолд тус байгууллагын Үндсэн хууль болон дүрэмтэй нийцээгүй болох талаар бүх гишүүн улсуудад мэдэгдэх болно..." /3-р хх-ийн 82- 83/,

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтэсээс Интерполын гишүүн орнуудад 2012 оны 12 дугаар сарын 05- ны өдрийн LA/21063-3/5.2/YGO/DHA / Б.Х, Н.Эн / дугаарын улаан булант зар мэдээ цуцлагдсан тухай албан бичигт: "...Ерөнхий нарийн бичгийн даргын газраас шалгалт хийж үзээд улаан булант зар мэдээнүүдэд агуулагдаж байгаа мэдээлэл нь Интерполын Үндсэн хууль болон дүрмүүд, тодруулбал улс төр, цэрэг, шашин эсвэл арьс өнгөөр гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг тус байгууллагад хатуу хориглоно гэж заасан байдаг бөгөөд Үндсэн хуулийн 3-р зүйлтэй нийцээгүй гэсэн дүгнэлтэд хүрлээ. Энэхүү дүгнэлт нь тус хэргийн улс төр давамгайлсан шинжтэй ерөнхий нөхцөл байдалд үндэслэсэн болно. Иймд Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээ цуцлагдаж, тус байгууллагын мэдээллийн сангаас энэ хоёр хүнтэй холбоотой мэдээлэл устгагдах болсныг үүгээр мэдэгдэж байна..." /3-р хх-ийн 80, 81/,

Интерполын нарийн бичгийн даргын

газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтэсээс 2012.12.11-ний өдөр ирүүлсэн 2012/335001, 2012/334842 дугаартай албан бичигт: "... дээр дурдсан хүмүүсийг ялласан эрх зүйн үндэслэлтэй холбоотойгоор, уг хэрэг нь Монгол улсад үүссэн зөрчилдөөнөөс үүдэлтэй бөгөөд, Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн дагуу улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтийг Хуулийн асуудал эрхэлсэн хэлтэсээс гаргасан юм. Иймд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллээс үл хамааран, Монгол Улсын холбогдох яамдууд хоорондын зөрчилдөөн, тодорхой шийдэлд хүрэх хүртэл Ерөнхий нарийн бичгийн даргын газар уг хэргийг бүхэлд нь улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтэд хэвээр байна..." /3-р хх-ийн 86, 87/,

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтэсээс Интерполын Үндэсний товчоонд 2014.01.16-ны өдрийн LA/2106.-/5.2/DHA/ lb дугаартай албан бичигт: "...Б.Х, Н.Эн нарын эсрэг гаргасан Улаан булант зар мэдээнүүдтэй холбогдуулан мэдэгдэхэд, Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Монгол Улсын Хууль Зүйн сайд Э.Э-ээс ирүүлсэн дээрх мэдээнүүд нь улс төрийн сэдэлттэй, Монгол Улсын Ерөнхийлөгч асантай холбоотой гэж дурдсан захидлыг хүлээн авсны дараа Монгол Улсын Үндэсний төв товчооноос хариу болгож ирүүлсэн мэдээллийг хянаж үзээд Улаан булант мэдээнүүдийг эгүүлэн татах шийдвэр анх гаргасан юм. Гэвч нэмэлт мэдээлэл хүлээн авч дахин хянаж үзсэний эцэст Монгол Улсын Үндэсний төв товчооны хүсэлтийн дагуу Улаан булант зар мэдээнүүдийг сэргээсэн болно..." /3-р хх-ийн 106-108/ зэрэг бичгийн нотлох баримтуудаар шүүгдэгч Э.Э-ийн гэм буруутай үйлдэл нотлогдож топгоогдсон байна.

Шүүгдэгч Э.Э нь шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа "ийм захиаг иргэн хүн хэн ч байсан бичиж болно. Намайг бичсэнээс болоод Интерполоор эрэн сурвалжилж ажиллагаа зогсоогоогүй. Миний захидал албан ёсны хэн нэгэнд нөлөөлөх шийдвэр гаргах хэмжээний бичиг биш, Авлигатай тэмцэх газарт ямар нэгэн хор уршиг учраагүй" гэж мэдүүлж байгаа ч энэ нь дээр дурдагдсан нотлох баримтуудаар үгүйсгэгдсэний гадна Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болохын хувьд мөрдөн байцаалтын

ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бодитой үйлдэл хийгдсэнээр уг хэрэг төгссөнд тооцогдоно.

Хууль зүйн дэд сайд Э.Э-гийн захидлыг Интерполын Хуулийн асуудал хариуцсан хэлтэс, Ерөнхий нарийн бичгийн дарга аваад Монгол Улс дахь Интерполын Үндэсний товчоонд 2012.10.22-ны өдөр бичсэн №2012/33500., 2012/33484. дугаар бичгээр Улаан булант мэдэгдлийн тухай: "...Монгол Улсын Хууль зүйн дэд сайд Э.Э [exxxxxxx@toj.gov.mn](mailto:exxxxxxx@toj.gov.mn) гэх хүнээс ирүүлсэн захидлыг Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан. Энэхүү захидалд /хавсаргав/ Улаан мэдэгдэл нь улс төрийг идэвхжүүлж. Монгол Улсын өмнөх Ерөнхийлөгчтэй холбогдож байна..." гэх захидал ирүүлсэн ба эдгээр эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүс нь Интерполын Үндсэн хуульд зааснаар улс төрийн маргаанд холбогдолтой эсэхийг шалгахын тулд нэмэлт мэдээлэл хүссэн байдаг.

Улмаар Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс "Интерполын гишүүн орнуудад 2012.12.05-ны өдрийн LA/5106.-3/5.2/YGO/DHA дугаартай мэдэгдлээрээ Б.Х, Н.Эн нарт холбоотой улаан булант зар мэдээ цуцлагдсан тухай албан бичгийг /3-р хх-ийн 80, 81/ хүргүүлснээс гадна дахин Интерполын нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс 2012.12.11-ний өдөр ирүүлсэн 2012/33500., 2012/33484. албан бичигт "...Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээллээс үл хамааран, Монгол улсын холбогдох яамдууд хоорондын зөрчилдөөн, тодорхой шийдэлд хүрэх хүртэл Ерөнхий нарийн бичгийн даргын газар уг хэргийг бүхэлд нь улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтэд хэвээр байна..." /3-р хх-ийн 86, 87/ гэсэн хариуг Монголын улс дахь Интерполын Үндэсний товчоонд хүргүүлж, гаргасан дүгнэлтийнхээ дагуу Интерпол бүх гишүүн орнууддаа эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсээс Б.Х, Н.Эн нарыг хассанаар интерполын төвшинд эрэн сурвалжлах ажиллагаа зогссон байна.

Сэжигтэн Б.Х, Н.Эн нарыг Интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа зогссоноос болж 2012.12.05-ны өдрөөс 2013.04.18-ны өдрийг хүртэлх хугацаанд тэдний талаарх мэдээллийг олж авах нөхцөл байдал бүрэн хязгаарлагдсан байх бөгөөд харин 2012 оны 12 сард сэжигтэн Н.Эн нь ОХУ болон Сингапур улсаар дамжин өнгөрсөн талаарх

мэдээллийг Монголын Интерполын Үндэсний товчоонд уламжилснаас үзэхэд тухайн цаг хугацаанд тэдний талаарх мэдээллийг олж авах боломжтой байсныг харуулж байна.

Интерполын Үндсэн хуульд улс төр, шашин, арьс өнгөөр гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг тус байгууллагад хатуу хориглоно гэж заасан байдаг. Үүнийхээ дагуу тус хоёр хүнийг улаан булант мэдээнээс хассан боловч Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс дахин судалсны үндсэн дээр Монголын Интерполын Үндэсний товчоонд 2014.01.16-ны өдрийн LA/5106.-8/5.2/DHA/lb дугаартай албан бичгээр Б.Х, Н.Эн нарын эсрэг гаргасан Улаан булант зар мэдээнүүдтэй холбогдуулан мэдэгдэхдээ Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь "Монгол улсын Хууль Зүйн сайд Э.Э-ээс ирүүлсэн дээрх мэдээнүүд нь улс төрийн сэдэлттэй, Монгол Улсын Ерөнхийлөгч асантай холбоотой гэж дурдсан захидлыг хүлээн авсны дараа Монголын Интерполын Үндэсний төв товчооноос хариу болгож ирүүлсэн мэдээллийг хянаж үзээд Улаан булант мэдээнүүдийг эгүүлэн татах шийдвэр анх гаргасан. Гэвч нэмэлт мэдээлэл хүлээн авч дахин хянаж үзсэний эцэст Монголын Үндэсний төв товчооны хүсэлтийн дагуу Улаан булант зар мэдээнүүдийг эргэн сэргээсэн тухай /3-р хх-ийн 106-108/ мэдэгдсэн юм. Өөрөөр хэлбэл, Б.Х, Н.Эн нарт холбогдох хэрэг нь ямар нэг улс төрийн шалтгаант холбоогүйг тогтоосон эцсийн шийдвэрээ гаргаж уг хоёр хүнийг Интерполоор дахин эрэн сурвалжилж байгаагаа мэдэгджээ.

Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэлт хийж үзвэл шүүгдэгч Э.Э нь Хууль зүйн дэд сайдын албан тушаалын байдлаа ашиглаж Б.Х, Н.Эн нарыг Интерполын "Улаан булант" мэдээнээс улс төрийн шинжтэй учир хасуулахыг хүссэн захидал илгээсний улмаас Авлигатай тэмцэх газраас дээр нэр бүхий этгээдүүдийг 2012.12.05-наас 2012.04.18-ны өдрийг хүртэлх хугацаанд тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн орнуудаас олж авах боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэг буюу мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан байх тул шүүгдэгч Э.Э-д Эрүүгийн хуульд заасан хариуцлага

хүлээлгэх хууль зүйн үндэслэлтэй гэж шүүх дүгнэв.

Иймд шүүгдэгч Э.Э-г Хууль зүйн дэд сайдын албан тушаалын байдлаа ашиглан албан мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, хуульд заасан торгох ял оногдуулах нь зүйтэй.

Шүүхээс шүүгдэгч Э.Э-д ял шийтгэл оногдуулахдаа анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн байдлыг хөнгөрүүлэн авч үзлээ.

Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлд заасан хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдсонгүй.

Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн CD 1 ширхгийг хэрэгт хавсаргахаар тогтов.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 286, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүгдэгч Х овогт Э.Э-г албан тушаалын байдлаа ашиглаж мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Э.Э-г улс төрийн албан тушаал эрхлэх эрхийг 02 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140.400 төгрөгийг 60 /жар/ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.424.000 /найман сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийн торгох ялаар шийтгэсүгэй.

3. Ялтан Э.Э нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдсугай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн 2 ширхэг CD-г хэрэгт хавсаргасугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт зааснаар ялтан Э.Э нь торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болохыг түүнд мэдэгдсүгэй.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар ялтан Э.Э-д 02 жилийн хугацаагаар улс төрийн албан тушаал эрхлэх эрх хассан нэмэгдэл ял биелүүлэх хугацааг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхэлж тоолохыг тэмдэглэсүгэй.

7. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хуулийн хүчинтэй болох бөгөөд ялтан, түүний өмгөөлөгч, иргэний нэхэмжлэгч нар эс зөвшөөрвөл уг тогтоолыг гардуулснаас хойш Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд 14 хоногт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч эсэргүүцэл бичих, иргэний нэхэмжлэгч тогтоолын иргэний нэхэмжлэлтэй хэсэгт гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

8. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелүүлэх хүртэл ялтан Э.Э-д бусдын батлан даалтад өгөхөөр авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

М.АЛДАР

## МАГАДЛАЛ

2014 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 496

Улаанбаатар хот

## Э.Э-д холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч С.Соёмбо-Эрдэнэ даргалж, шүүгч Д.Гансүх, Ш.Бат-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

Прокурор: Ц.Отгонноров,

Ялтан: Э.Э,

түүний өмгөөлөгч П.Одонтунгалаг,

Нарийн бичгийн дарга: П.Учралгэрэл нарыг оролцуулж,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч М.Алдар даргалж хийсэн шүүх хуралдааны 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 408 дугаар шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан Э.Э, түүний өмгөөлөгч П.Одонтунгалаг нарын гаргасан давж заалдах гомдлуудаар Э.Э-д холбогдох эрүүгийн 2012 0100 047. дугаартай хэргийг 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч, шүүгч Ш.Бат-Эрдэнийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Х овогт Э.Э, Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр ...хотод төрсөн, ... настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Хууль зүйн дэд сайдын албан тушаалд ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт ...дүүргийн ...дүгээр хороо, ...дүгээр байрны ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар ЧР.....

Хууль зүйн дэд сайд Э.Э нь албан тушаалын байдлаа ашиглаж, 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт өөрийн [exxxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар Интерполын Нарийн бичгийн дарга нарын ерөнхий газрын цахим хуудсанд Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д хандаж "...Монгол Улсын хууль зүйн яамны дэд сайдын хувиар энэ захидлыг бичиж байна. Монгол Улсын хоёр иргэн /Б.Х, Н.Эн/ Интерполын веб хуудасны эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн жагсаалтанд байна гэсэн мэдээллийг өнөөдөр би авсан. ...Энэ хоёр хүнтэй холбоотой хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж бид үзэж байгаагаа Интерполд мэдэгдье. Эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас

энэ хоёр хүнийг авч хаяхыг албан ёсоор хүсье..." гэсэн захидлыг илгээснээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээг цуцалж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй эрүүгийн 201201000182 тоот хэргийн сэжигтэн Б.Х, Н.Эн нарыг Интерполын улаан булант зар мэдээгээр олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулахаар 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр холбогдох мэдээлэл хүргүүлснийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авч А-632./10-2012, А-634./10-2012 дугаарын улаан булант зар мэдээгээр 2012 оны 10 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд хэвлэн нийтэлсэн дээрх Монголын 2 иргэнийг интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсож, тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар хандаж мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Э.Э-д холбогдох хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж яллах дүгнэлт үйлдэн, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх: Э.Э-ыг албан тушаалын байдлаа ашиглаж мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт зааснаар Э.Э-ыг улс төрийн албан тушаал эрхлэх эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140.400 төгрөгийг 60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.424.000 төгрөгийн торгох ялаар шийтгэж, Э.Э нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн 2 ширхэг

сидиг хэрэгт хавсаргаж, Э.Э нь торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болохыг мэдэгдэж шийдвэрлэжээ.

Ялтан Э.Э давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Миний бие шийтгэх тогтоолд дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

1. Улс төрийн байр сууриа илэрхийлсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

2. Гэмт хэргийн бүрэлдэхүүн, шалтгаант холбоо тогтоогдоогүй байхад эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

3. Интерполын байгууллагын дүрэм журмын дагуу хийгдсэн хууль ёсны ажиллагаа ба шийдвэрийг мөрдөн байцаалтад саад учруулсан гэсэн дүгнэлт гаргаж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

4. Хуулийн байгууллагын (АТГ болон Интерполын Үндэсний товчоо) гаргасан алдааг улс төрийн албан хаагчид тохож хариуцлага хүлээлгэх гэж оролдсон.

Нэг. Улс төрийн байр сууриа илэрхийлсэн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тухай:

Миний бие Хууль зүйн дэд сайдын албан тушаалыг хашдаг бөгөөд, энэ нь төрийн улс төрийн албан тушаал. ...Намын Бага чуулган, Гүйцэтгэх товчооны гишүүний сонгуульт ажилтай. Үндсэн хуульд заасан өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх, төрийн болон бусад байгууллагад амаар болон бичгээр санал, гомдол, хүсэлтээ гаргах шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн жинхэнэ болон тусгай албан хаагчаас ялгаатай нь өөрийн гишүүнээр элссэн намын улс төрийн байр суурийг хамгаалах, мөрийн хөтөлбөрт туссан болон үзэл баримтлалд нийцсэн улс төрийн үйл ажиллагааг хэнээс ч үл хамааран хийх, хэрэгжүүлэх үүрэгтэй улс төрийн албан тушаалтан.

М нам нь тус намын дарга Н.Э-т холбогдуулсан эрүүгийн хэргийг улс төрийн учир шалтгаантай хэмээн дүгнэж удаа дараа мэдэгдэл гаргаж байсан ба одоо ч энэхүү байр суурь өөрчлөгдөөгүй байгаа.

Миний бие Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён РН-д бичсэн захидалдаа чухамхүү өөрийн улс төрийн албан тушаал болон, улс төрийн намынхаа байр суурийг илэрхийлсэн байдаг. Энэ нь М намын Бага чуулганы мэдэгдлийг хавсарган хүргүүлснээр нотлогдох болно.

Улс төрийн аливаа албан тушаалтны

нэгэн адил би өөрийн байр сууриа хэвлэл мэдээллээр илэрхийлэх, үг хэлэх, албан бичиг захидал илгээх зэрэг бүхий л арга хэлбэрээр илэрхийлэх эрхтэй. Би өөрийнхөө үзэл бодлыг Интерполын цахим хуудас дахь <http://www.interpol.int/Contact-INTERPOL> хаягаар илгээсэн нь миний бие бусад хэвлэл мэдээлэл, болон холбогдох хүмүүстэй биечлэн уулзахдаа илэрхийлдэг байр сууриас огтхон ч ялгаагүй юм.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд авагдсан яллах гол баримт болох гэрч Г.Б-ийн өгсөн мэдүүлэгт /хх-ийн 192-196/ "... хэрэв Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар, Интерполтой харьцах л бол заавал Интерполын Үндэсний төв товчоогоор уламжлуулах ёстой байдаг. Хувь хүн, албан тушаалтан өөрөө шууд бичиг, хүсэлт явуулах талаар интерполын Үндсэн хуульд зааж өгөөгүй.

Харин бичиг хүсэлтийг Интерполын Үндэсний төв товчоогоор дамжуулахаар зааж өгсөн байдаг юм аа..." гэж дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаагч болон улсын яллагчийн зүгээс гэрч Г.Б-ийн энэхүү мэдүүлэгт дурдсанчлан намайг хууль бус аргаар Интерполтой холбогдон өөрийн албан тушаалаа ашигласан хэмээн буруутгасныг анхан шатны шүүхээс нягтлан шалгалгүйгээр ял ногдуулсон. Интерполын Үндсэн хуульд үнэхээр хэнээс хэнд бичиг захидал явуулж болох талаар зааж өгөөгүй ба энэ нь аль ч байгууллагын дотоод дүрэм журмаар зохицуулагддаг. Интерпол нь олон нийттэй харьцдаг <http://www.interpol.int> хэмээх цахим хуудастай ба <http://www.interpol.int/Contact-INTERPOL> хэсэгт нь электрон шуудан илгээх боломжтой цонх бий. Энэхүү хэсэгт дэлхийн аль ч орны ямар ч хувь хүн, иргэн байгууллага өөрийн санал хүсэлт, гомдлыг илгээн шийдвэрлүүлэх боломжтой юм. Гэрч Г.Б нь интерпол болон бусад байгууллагын олон нийттэй харилцах арга, нээлттэй зарчмыг мэдэхгүйгээс зөвхөн Монголын Үндэсний интерполын төв товчоогоор дамжуулан улс төрийн болон хувийн байр сууриа илэрхийлэх ёстой хэмээн эндүүрчээ.

Хэрвээ Э.Э гэх хүн өөрийн албан тушаалыг ашигласан бол Хууль зүйн яамны албан бланк, тамга тэмдэгийг ашиглах, эсхүл ХЗЯ-ны харьяа байгууллага болох ЦЕГ, Үндэсний интерполын төв товчоонд албан үүрэг чиглэл өгөх, эсхүл албан айлчлалын үеэр хийгдэж буй яриа хэлэлцээрт дурдах зэргээр илрэх байсан болов уу. Миний

бие гэрч Г.Б-ийн хэлж буй албан ёсны харилцааны арга хэрэгсэл буюу Үндэсний интерполоор дамжуулан захидлаа илгээгүй, илгээхийг шаардаагүй, мөн интерполд Авлигатай тэмцэх газар болон бусад байгууллагыг мэдээллээ бэлтгэн хүргүүлэхэд нь аливаа байдлаар нөлөөлөөгүй.

Үндсэн хуулиар бүх хүнд олгогдсон эрх чөлөөгөө эдлэн, олон улсын байгууллагын дүрэм журамд нийцүүлэн, нийтээр хэрэглэдэг орчин үеийн арга хэрэгслийг ашиглан үзэл бодлоо илэрхийлсний төлөө эрүүгийн ял ногдуулсанд гомдолтой байна.

Хоёр. Гэмт хэргийн бүрэлдэхүүн, шалтгаант холбоо тогтоогдоогүй байхад эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

Миний захидал албан ёсоор хэн нэгэнд нөлөөлөх, шийдвэр гаргах хэмжээний бичиг биш, Авлигатай тэмцэх газарт ямар нэг хор уршиг учраагүй гэж мэдүүлж байгаа ч энэ нь дээр дурдсан нотлох баримтуудаар үгүйсгэгдсэний гадна Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болохын хувьд мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан бодитой үйлдэл хийгдсэнээр уг хэрэг төгссөнд тооцогдоно гэжээ. Дээр дурдсан нотлох баримт гэж шийтгэх тогтоолын 4-6 дугаар хуудаст дурдагдсан нотлох баримтуудыг үнэлсэн нь хэргийн бодит байдалтай нийцээгүй.

Анх Үндэсний товчооноос интерполд илгээсэн эрэн сурвалжилахыг хүссэн албан бичигтээ Авлигатай тэмцэх газар болон Үндэсний товчоо нь туйлын хариуцлагагүй хандсан байдаг. Б.Х, Н.Эн нартай хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээд гэсэн хэсэгт Н.Э нь сэтгүүлч мэргэжилтэй, орчуулагч хүн гэж явуулжээ. Угтаа Н.Э нь Монголын парламентад цөөнхийн суудалтай "М -Мү намын ШЕЭ"-ийн тэргүүн, Монголын нөлөө бүхий нам болох М намын дарга гэсэн мэдээллийг нууж хаалгүйгээр явуулсан бол Интерполын хуулийн хэлтсээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл илгээхийг шаардаж, мөн өөрсдөө ч зохих судалгаа хийх байсан нь дагаж мөрддөг Үндсэн хуулиас нь болон миний илгээсэн захианы мөрөөр авсан арга хэмжээнээс нь харахад тодорхой болов уу.

Миний захиаг авсны дараа Үндэсний төв товчоонд ирүүлсэн албан бичигтээ /З-р хх-ийн 25/ Э.Э нь үнэхээр энэхүү захидлыг бичсэн бол түүнд интерполын дүрэм журмын дагуу албан ёсоор харилцах бол Үндэсний

товчоогоор дамжуулан харилцах болохыг сануулна уу гэсэн байдаг. Үүнийг Интерпол нь миний захидлыг авсан цагаасаа энэ бол албан ёсоор даалгасан буюу хүссэн албан харилцаа биш гэдгийг сануулсан гэх үйлдэл буюу намайг албан тушаалаа ашиглан гэмт хэрэг үйлдээгүй гэдгийн нотолгоо гэж үзэж байна. Түүнчлэн тэрхүү албан бичигтээ энэхүү хэрэг нь улс төрийн хэрэг байж болзошгүй тул нэмэлт мэдээлэл хэрэгтэй тухай товчоогоор дамжуулан Авлигатай тэмцэх газарт өгсөн байдаг.

Харин анхнаасаа буруу, дутуу мэдээлэл бүрдүүлсэн Авлигатай тэмцэх газар нь бодит байдлыг нуух аргагүй болсон тул үнэхээр Н.Э Монгол Улсын Ерөнхийлөгч асан мөн болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Авлигатай тэмцэх газраас Үндэсний товчоогоор дамжуулан Н.Э нь ерөнхийлөгч асан хүн мөн бөгөөд анхан шатны шүүхээс ял оноосон байгаа тухай нэмэлт мэдээлэл явуулсны дараа Интерпол нь уг мэдээллийг нягтлан үзээд урд явуулсан сэтгүүлч орчуулагчаас өөр буюу улс төрийн нөлөө бүхий хүнтэй холбоотой гэдгийг нь мэдсэн учир өөрсдөө хяналт шалгалт явуулсан нь ирүүлсэн бичгүүдээс тодорхой харагддаг.

Хэрвээ Авлигатай тэмцэх газар болон Үндэсний товчооноос нэмэлт мэдээлэл нэхээгүй, эдгээр байгууллага дахин өөрчилсөн мэдээллээ явуулаагүй, Интерполын хуулийн хэлтэс өөрсдөө хяналт шалгалт хийлгүйгээр Э.Э-гийн илгээсэн захидалд үндэслэн эрэн сурвалжлах жагсаалтаас хассан бол би албан тушаалаа ашиглан нөлөөлсөн гэх үндэслэлд гомдол гаргахгүй байсан.

Нөгөө талаар Мөрдөн байцаах ажиллагаа гэдэг нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулагдан тодорхойлогддог үйл ажиллагаа юм. Интерпол нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч биш бөгөөд процесс ажиллагаанд аливаа эрх, болон үүрэггүй бөгөөд зөвхөн Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны хэлбэр билээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "...мэдээлэл авах боломжгүй байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулах..." гэсэн ойлголт үгүй байтал шүүхээс надад ял халдааж байгаа нь цаашдаа аль нэг иргэн, албан тушаалтан өөрийн үнэн зөв гэж бодсон итгэл үнэмшлээр хууль, хяналтын байгууллагад мэдээлэл, хүсэлт гаргаж захидал өргөдөл



өгсөн бол, түүний улмаас мөрдөн байцаалт зогссон, саатсан гэж үздэг буруу жишиг тогтох болов уу.

Мэдээлэл авах боломжгүй байдал үүсгэх гэдгийг чухам ямар утгаар тайлбарлаж байгааг ойлгохгүй байна. Хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаас үзэхэд Үндэсний товчооны ирүүлсэн албан бичигт үндэслэн цуцалсан, Үндэсний интерполын ирүүлсэн бичигт шинжилгээ хийж үзсэн зэргээр дурдагдсан байгаа нь Үндэсний интерполын ажилтнууд, түүнд хүсэлт илгээсэн Авлигатай тэмцэх газар болон албан тушаалтнуудын гэм бурууг надтай хамт нотолсон гэж үзэх үндэслэлтэй биш үү.

Гурав. Интерполын дүрэм журмын дагуу хийгдсэн хууль ёсны ажиллагаа ба шийдвэрийг мөрдөн байцаалтад саад учруулсан гэсэн дүгнэлт гаргаж эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн.

Анхан шатны шүүхийн шийдвэр нь агуулгын хувьд Э.Э гэх хүний хүсэлтийг хүлээн авч, зарим хүнийг эрж хайхыг зогсоосон интерполыг буруутгаж байгаа мэт болжээ. Интерпол болон Монголын хуулийн байгууллагууд бүгд өөрсдийн баримталдаг дүрэм журамтай бөгөөд хэн нэгний захидал, ятгалга, нөлөөнд автахгүй байх хуультай. Тиймээс миний захидлаас шалтгаалсан ч эс шалтгаалсан ч Интерпол өөрийн дүрэм журамд нийцүүлэн мэдээлэл цуглуулж, хяналт шалгалт явуулсан үйл ажиллагааг гэмт хэрэг гэж үзэж болохгүй гэж бодож байна.

Хэрвээ би интерполд бичсэн захидалдаа худал хуурмаг зүйл бичиж төөрөгдүүлсэн гэж үзэж байгаа бол миний бичсэн захидалд нэг ч худал хуурмаг зүйл байгаагүй гэдгийг би хаана ч хэний ч өмнө нотлож чадах ба үүнийгээ мөрдөн байцаалтын болон анхан шатны шүүхэд мэдээлсэн. Хэрвээ Авлигатай тэмцэх газар болон Үндэсний товчоо нь анхнаасаа Б.Х, Н.Эн нарыг хайх хүсэлтийг явуулахдаа эдгээр хүмүүс нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, М намын дарга бөгөөд "М-Мү намын ШЕЭ"-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой гэдгийг Интерполд мэдэгдсэн бол Интерпол тухайн хэргийг улс төрийн хэрэг мөн эсэхийг нягтлан үзэх байсан гэдэг нь лавтай. Миний захидлаас бус Интерполын өөрөө хяналт шалгалт явуулан улс төрийн шалтгаантай хэрэг гэж үзсэн бол Монголын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд буюу мөрдөн байцаалтад саад учруулсан гэж үзэж, Эрүүгийн хариуцлагад татахгүй.

Дөрөв. Хуулийн байгууллагын (АТГ болон Интерполын Үндэсний товчоо) гаргасан алдааг улс төрийн албан хаагчид тохож хариуцлага хүлээлгэх гэж оролдсон.

Энэхүү мөрдөн байцаалтад саад учруулсан гэх хэрэгт Авлигатай тэмцэх газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан ба мөн нэгэн зэрэг иргэний нэхэмжлэгчээр оролцож байгаа. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115-р зүйлд "гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй", 117 дугаар зүйлд "Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тэдэнд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг нь тайлбарлана" гэж заасан байдаг. Гэтэл иргэний нэхэмжлэгч болох Авлигатай тэмцэх газрыг төлөөлж буй Б.А шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ "...манай байгууллагад гэм хор учраагүй..." гэсэн байдаг.

Авлигатай тэмцэх газарт гэм хор учраагүй, надаас хохирол нэхэмжлээгүй байтал ямар учраас шүүх хуралдаанд хүртэл иргэний нэхэмжлэгчээр оролцож байгааг ойлгохгүй байна. Анхнаасаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тусгайлан заасан хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын харьяалал зөрчин эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн байцаалт явуулсан, өөрсдөө мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэх боломжгүй болмогц нэхэмжлэлгүйгээр иргэний нэхэмжлэгч болсон зэрэг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарчмуудыг ноцтой зөрчин гэмт хэрэгт холбогдуулахаар мөрдөн мөшгөж байгаад гомдолтой байна.

Төрийн байгууллага буюу Авлигатай тэмцэх газар нь анхнаасаа дутуу мэдээллийг интерполд өгсөн нь хэргийн талаар нягтлан шалгах шалтгаан болсон. Энэхүү хариуцлагаа өөрийн улс төрийн байр сууриа илэрхийлж интерполд мэдээлэл хүргүүлснээ надад тохож, эрүүгийн хэрэг үүсгэх замаар ажлын хариуцлагаас зайлсхийхийг оролдсон гэж үзэж байна. Энэхүү хэргийг бүхэлд нь нийгэмд аюултай гэмт хэрэг гэж үзэж байгаа бол ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой гэдгийг эхэлж хэлсэн нь би, харин албан ёсоор нотолсон нь Авлигатай тэмцэх газар учраас Авлигатай тэмцэх газрын мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргасан гэж Интерполд мэдэгдсэн учраас тэд бас гэмт хэргийг хамтран үйлдсэн байж болохгүй гэж үү.

Улс төрийн албан тушаалтны хувьд өөрийн байр сууриа илэрхийлсэн нь тодорхой байгууллагуудыг хяналт шалгалт хийхэд хүргэсэн бөгөөд хэн нэгэнд хохирол учраагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байхад хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, хэргийн бодит байдлыг илт буруугаар үнэлэн, хэт нэг талыг барьсан шийдвэр гаргасанд гомдолтой. Иймд шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Э.Э-ын өмгөөлөгч П.Одонтунгалаг давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолд гэм буруугийн талаар хийсэн дүгнэлт нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар үгүйсгэгдэж, хэргийн бодит байдалтай нийцээгүй, хэт нэг талыг барьж гаргасанд гомдолтой байна.

Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлах, тэдний эсрэг Интерполын цахим сангийн "Улаан булант" зар мэдээнд хэзээ, хэрхэн хэвлэн нийтэлсэн, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар ямар үндэслэл, баримтаар уг мэдээлэлийг цуцалсан, хэзээ хэрхэн сэргээсэн талаар дараах баримт, нотолгоонууд хэрэгт авагдсан байдаг. Үүнд:

Авлигатай тэмцэх газар, 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 06/1523 дугаарт бүртгэлтэй албан тоотоор Н.Эн, Б.Х нарыг эрүүгийн хэрэгт интерполоор эрэн сурвалжлуулахаар, 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр 06/359. дугаартай албан тоотоор Интерполын "Улаан булант" зар мэдээгээр дамжуулан олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулах хүсэлт, холбогдох мэдээлэлийг гарган, Монголын Интерполын Үндэсний товчоогоор дамжуулж, Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн байдаг.

Монголын Интерполын Үндэсний товчооноос ирүүлсэн мэдээллийг хүлээн авч Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд "Улаан булант" зар мэдээнд Б.Х, Н.Эн нарын эсрэг мэдээлэл хэвлэн нийтэлж, Интерполын гишүүн улсуудад мэдэгдэн түгээсэн байдаг.

Энэхүү "Улаан булант" зар мэдээнд Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлуулахаар Интерполын Ерөнхий нарын бичгийн даргын газарт хүргүүлсэн Авлигатай тэмцэх газрын 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 06/152. тоот албан тоот, 2012 оны 09 дүгээр

сарын 24-ний өдрийн 06/359. дугаартай албан тоотоор тус тус хүргүүлсэн мэдээлэл нь бүрэн гүйцэт, бодитой бус мэдээлэл байсан болох нь, хэргийн 1-р хавтасны 115-116 хуудсанд авагдсан нотлох баримтаар тодорхой тогтоогдож байдаг.

Тодруулбал Авлигатай тэмцэх газар, Б.Х, Н.Эн нарыг интерполоор эрэн сурвалжлахад шаардлагатай мэдээллээ Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой, Н.Эн нь Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-ын төрсөн дүү, Б.Х нь Н.Э-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж байх хугацаанд, түүний туслахаар ажиллаж байсан талаарх мэдээллийг огт өгөлгүй зөвхөн бусдын өмчийг завших үрэгдүүлэх гэмт хэрэгт хамтран оролцсон үндэслэлээр сэжигтнээр тооцогдсон, хамтран оролцогч нь А овгийн Н.Э гэсэн мэдээллийг хүргүүлсэн байдаг.

Уг мэдээлэл нь улс төрийн зүтгэлтэнтэй холбоотой талаарх мэдээлэл огт тусгагдаагүй байсан тул Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас Үндсэн хууль болон холбогдох дүрэм журамд харшлаагүй байна гэж үзэн "Улаан булант" зар мэдээнд хэвлэн нийтэлсэн байдаг.

Э.Э нь М намын "АШЁ" залуучуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, М намын гүйцэтгэх товчооны гишүүн, М-Мү намын ШЁЭ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд, М-Мү намын ШЁЭ, А Намтай байгуулсан "Хамтарсан Засгийн газар байгуулах" хэлэлцээрийн дагуу Хууль зүйн яамны дэд сайдын албан тушаалд томилогдсон, улс төрийн албан тушаалтан бөгөөд М намын гишүүн, улс төрч, хувь хүнийхээ хувьд өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлж, Б.Х, Н.Эн нарыг "Улаан булант" зар мэдээнд нийтэлсэн нь улс төрийн сэдэлттэй, Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотойгоор түүний төрсөн дүү болон туслахаар ажиллаж байсан хүний ахыг нь эрэн сурвалжилж байгаа нь Интерполын Үндсэн хуульд заасан "Улс төр, цэрэг, шашин эсхүл арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг хатуу хориглоно" гэсэн заалтыг зөрчихөөс сэргийлүүлж, эрэн сурвалжлах жагсаалтаас хасаж өгөхийг хүсэж, уг хэргийн талаар намын гишүүнийхээ хувьд зарим мэдээлэлийг өгч 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт цахим захидал бичсэн

байдаг.

Уг захидалд "Интерполын цахим хуудас дахь эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн жагсаалтанд Монгол Улсын эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргаж Б.Х, Н.Эн нар багтсан талаар олж мэдлээ, Одоо Монгол Улсад орон нутгийн сонгууль болж байгаатай холбогдуулан эрх барьж буй нам, хууль сахиулах байгууллагыг тусгайлан оролцуулж, улс төрийн зорилгоор мөрдлөг, ял тулгалт явагдаж байна. Интерполын Үндсэн хуульд төвийг сахих, улс төрийн сэдэлттэй хэрэгт оролцохыг сэргийлдэг бөгөөд Б.Х, Н.Эн нартай холбоотой хэрэг нь Монгол Улсын ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой тул улс төрийн сэдэлттэй гэж үзэж байгаагаа мэдэгдэж, эдгээр хүмүүсийг эрэн сурвалжлах жагсаалтаас хасахыг хүсэж, Н.Э-тай холбоотой хэрэг Улсын Дээд шүүхэд давж заалдах шатанд явж байгаа ба, улс төрийн сэдэлттэй яллаж байгаа бүх үндэслэлүүдийг хэрэгсэхгүй болгон, хууль ёсны шийдвэр гарна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж" Интерполоос баг илгээсэн манай улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт хийхийг уриалж байгаагаа бичсэн байдаг.

Ийнхүү Э.Э нь цахим захидлаараа, Авлигатай тэмцэх газраас Монголын Интерполын Үндэсний товчоогоор дамжуулан, Б.Х, Н.Эн нарын талаар "Улаан булант" зар мэдээнд нийтлүүлэхээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн мэдээлэлд заагдсан хэргийн тухай бодит мэдээлэлийг бичсэнийг, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын хуулийн асуудал хариуцсан хэлтсээс захидалд заагдсан мэдээлэл үндэслэлтэй эсэхийг тодруулахаар нэмэлт мэдээлэлийг Интерполын Үндэсний товчооноос ирүүлэхийг хүссэн бичиг ирүүлсэн байдаг. Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс дараах мэдээлэл ирүүлэхийг хүссэн байдаг Үүнд:

1. Б.Х, Н.Эн нар нь Монгол Улсын Засгийн газарт ажиллаж байсан эсэх,

2. Эдгээр хүмүүсийн буруутгаж байгаа хэрэг нь саяхан ялагдсан Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э хэрэгтэй холбоотой эсэх.

Төрийн албан хаагч эд хөрөнгө завших, шамшигдуулах, албан тушаалаа урвуулан ашиглах хэрэг үйлдсэн, дээрх 2 этгээд нь төрийн албан хаагчтай уг хэргийг хамтран

үйлдсэн гэж "Улаан булант" зах мэдээнд дурдсан. Дурдсан төрийн албан хаагч нь Н.Э мөн эсэхийг тодруулна уу. Мөн дээрх 2 этгээд нь Н.Э-тай ямар холбоотой талаар тайлбарыг хүсье.

3. "Ө" зочид буудал, УТ хэвлэлийн компанийн хувьчлалын талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг гурван долоо хоногийн дотор ирүүлнэ үү. Тэр хооронд тус улаан булант зар мэдээнүүдэд "хууль зүйн хянах" гэсэн сануулга нэмэх болно гэдгийг анхаарна уу.

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Авлигатай тэмцэх газраас 2012 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 06/4583 тоот албан тоотой хариу хүргүүлсэн бөгөөд уг албан тоотод:

1. Монгол Улсын хууль зүйн дэд сайд Э.Э нь уг захидлыг явуулсан болохыг өөрөө хүлээн зөвшөөрсөн бөгөөд гагцхүү хувийн үзэл бодлоо илэрхийлж, улс төрийн намын эрх ашгийн тулд бичсэн болохыг тайлбарласан.

2. Б.Х, Н.Эн нар нь Монгол Улсын засгийн газарт албан тушаал эрхэлж байгаагүй болно.

3. Б.Х, Н.Эн нар нь Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э нарт холбогдох хэрэгт хамтран оролцсон байж болзошгүй үндэслэлүүд тогтоогдсон, уг хэрэгт хамааралтай байна. Н.Эн нь Ерөнхийлөгч асан Н.Э-ын төрсөн дүү, Б.Х нь Н.Э-ын туслахаар ажиллаж байсан Б.Т-ын төрсөн ах болно.

Н.Э нь Монгол Улсын ерөнхийлөгчийн албан тушаалын байдлыг урвуулан ашиглаж, "Ө" зочид буудал Нийслэлийн өмчит газрыг татан буулгаж "ХД" ХХК-ны оролцоотой "ДӨ" ХХК-ийг байгуулж, хууль бусаар хувьчлан авсан, "УТ" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хууль бусаар авч, онц их хэмжээний хохирол учруулсан зэрэг гэмт хэргүүдэд холбогдон шалгагдсан бөгөөд уг хэргийн учир одоогоор шүүхээр ял шийтгэгдсэн байна гэсэн хариуг Интерполын Үндэсний товчоогоор дамжуулан Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтэст хүргүүлсэн байдаг.

Энэхүү хариуг хүлээн авч Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монголын Интерполын Үндэсний товчоонд албан бичиг ирүүлсэн байдаг.

Уг бичигт Интерполын Үндсэн хууль

болон дүрэмд тодруулбал "Улс төр, цэрэг, шашин эсвэл, арьс өнгөөр гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг тус байгууллагад хатуу хориглоно" гэж заасан байдаг Үндсэн хуулийн 3 дугаар зүйлтэй нийцэж байгаа эсэхийг бататгах үүднээс хууль зүйн шалгалт хийгдсэн.

Интерполын мэдээ мэдээлэл боловсруулах дүрмийн хүрээнд энэхүү хэргийн үндсэн шинжийг чанарыг тодорхойлж болох ерөнхий утгыг уг шалгалтын явцад хянан хэлэлцээд, дээрх 2 хүний эсрэг явуулсан яллах ажиллагаа, хуулийн дагуу гэдэг нь маргаантай, нэн ялангуяа энэ нь Монголын улс төрийн нэртэй намуудын хооронд маргаан үүсгэсэн гэдэг нь тус хэргийн нөхцөл байдлын талаар танай Үндэсний товчооноос өгсөн мэдээлэл, Монгол Улсын хууль зүйн дэд сайдаас авсан захиа, Ерөнхий нарийн бичгийн даргын газраас хийгдсэн судалгааны үр дүнд харагдаж байна. Иймд 3-р зүйлд зааснаар энэхүү хэрэг нь улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтийг Хуулийн асуудал харицсан хэлтсээс гаргасан.

Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтлэсэн "Улаан булант" зар мэдээ цуцлагдаж, энэхүү хоёр хүнтэй холбоотой мэдээлэл байгууллагын мэдээллийн сангаас устгагдаж, Интерполын шугамаар явагдсан цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нь энэ тохиолдолд тус байгууллагын Үндсэн хууль болон дүрэмтэй нийцээгүй болох талаар бүх гишүүн улсуудад мэдэгдэх болно гэсэн бичиг ирүүлж, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр гишүүн орнуудад мэдэгдсэн байдаг.

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Авлигатай Тэмцэх газраас Уг хэргийг Улсын Дээд шүүх хянан үзээд ногдуулсан ялыг анхан болон давж заалдах шатны шүүх оногдуулсныг 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталгаажуулсан талаарх танилцуулга, Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлуулах зар мэдээг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг Монголын Интерполын товчооноос хүлээн авч, мөн Хууль зүйн сайд Х.Т-ийн 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11/3. дугаартай албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн "Улаан булант" зар мэдээг сэргээсэн байдаг.

Э.Э-ы Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газар илгээсэн захидал нь

"Улаан булант" зар мэдээнд гарсан Б.Х, Н.Эн нар нь ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой, түүний төрсөн дүү болон туслахын ах гэсэн үнэн бодитой мэдээллийг явуулж, Монгол Улсад өрнөж буй улс төрийн болон хууль сахиулагчдын үйл ажиллагааг шүүмжлэн, улс төрийн сэдэлттэй хэрэгт оролцохоос сэргийлж уг ажиллагааг зогсоож, баг илгээж хууль сахиулагчдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийхийг уриалсан байдаг.

Э.Э-ны илгээсэн цахим захидал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16 дахь хэсэгт заасан "Монгол Улсын иргэн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэнэ" гэх заалтын хүрээнд улс төрийн албан хаагч, улс төрч хувь хүнийхээ хувьд өөрийн итгэл үнэмшил, байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн байдаг.

Үндсэн хуульд заасан иргэний баталгаатай эдлэх үндсэн эрхээ эдлэн, үзэл бодлоо илэрхийлсний төлөө Э.Э-д шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хүний эрхийг ноцтой зөрчиж, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, илт хууль бус шийдвэр гаргасан болно.

Анхан шатны шүүх Э.Э-ны захидал бичсэн үйлдэлд дүгнэлт хийхдээ Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтсийн хяналт шалгалтын хүрээнд Монголын Үндэсний Интерполын товчооноос ирүүлсэн тайлбар, үүнтэй холбогдуулан судалгаа явуулан дүгнэлт хийж гаргасан шийдвэр зэрэг нь Б.Х, Н.Эн нарын талаар гадаад улсаас мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүсч, "Улаан булант" зар мэдээ цуцлагдсантай ямар шалтгаант холбоотой эсэхэд шүүх дүгнэлт хийх шаардлагатай байсан.

Э.Э-ы захидал нь Б.Х, Н.Эн нарын талаарх мэдээлэлийг гадаад улсуудаас авах боломжгүй нөхцөл байдал үүсгээгүй, харин Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс Интерполын Үндэсний товчооноос нэмэлт материал шаардан ирүүлсэн баримт, өөрсдийн шалгалт судалгаа явуулж гаргасан дүгнэлтийг үндэслэн Б.Х, Н.Эн нарын эсрэг гаргасан Интерполын "Улаан булант" зар мэдээг цуцалсан шийдвэр гаргаснаар Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэгт дээрх 2 иргэний талаар гадаад улсаас мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүссэн болно.

Өөрөөр хэлбэл, Э.Э-ы захидлаас бус харин Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын шийдвэр нь "Улаан булант" зарыг цуцлаж, Б.Х, Н.Эн нарын талаар гадаад улсаас мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүсгэсэн болно.

Гэтэл "Улаан булант" зар мэдээ цуцлагдаж гадаад улсаас Б.Х, Н.Эн нарын талаарх мэдээлэл авах боломжгүй нөхцлийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын гаргасан шийдвэр бий болгосон байхад Э.Э-ы гэм буруутай үйлдэл гэж яллаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь үндэслэлгүй.

Э.Э цахим захидал илгээсэн нь нийгэмд аюултай үйлдэл бус бөгөөд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 245 дугаар зүйлд заасан мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулсан гэмт хэргийн бүрэлдэхүүний объект буюу мөрдөн байцаах ажиллагааны хуулиар тогтоосон журамд халдаагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт "Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй" гэж хуульчилсан бөгөөд, үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлсэн захидал нь мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах хэргийн объектод бие даан халдаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Э.Э-д холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү гэв.

Шүүх хуралдаанд оролцсон прокуророос: Давж заалдах гомдол үндэслэлгүй, Э.Э нь захидлыг Интерполд хүргүүлснээс нэмэлт мэдээлэл шаардсан, түүнийг нь хүргүүлсэн. 2012 оны 12 дугаар сарын 5-нд Интерпол нь эрэн сурвалжлах ажиллагааг зогсоож, 2013 оны 04 дүгээр сарын 18-наас эрэн сурвалжлах ажиллагааг дахин эхлүүлсэн. Энэ хугацаанд сэжигтэн Б.Х, Н.Эн нар нь Оросын холбооны улс, Сингапур улсад зорчсон тухай баримт хавтаст хэрэгт авагдсан байгаа.

Захидал илгээснээр Интерполын үйл ажиллагаа зогссон, мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдалд хүргэсэн. Э.Э-ы захидал нь Интерполын үндэсний товчоогоор дамжигдах ёстой байсан. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, энэ хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, зүйлчлэл зөв, ял шийтгэл тохирсон тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж өгнө үү гэв.

#### ХЯНАВАЛ:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 308 дугаар зүйлд зааснаар давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй болсон эсэхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу авагдсан бичгийн нотлох баримтууд болон хэрэгт хавсаргасан эд мөрийн баримтуудыг үндэслэж, зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр бус хэргийг бүхэлд нь хянав.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1 дэх хэсэгт заасан "шүүхийн тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй байна" гэсэн шаардлагыг хангажээ.

Хууль зүйн дэд сайд Э.Э нь албан тушаалын байдлаа ашиглаж, 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт өөрийн [exxxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар Интерполын Нарийн бичгийн дарга нарын ерөнхий газрын цахим хуудсанд Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д хандаж "...Монгол Улсын хууль зүйн яамны дэд сайдын хувиар энэ захидлыг бичиж байна. Монгол Улсын хоёр иргэн / Б.Х, Н.Эн / Интерполын веб хуудасны эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн жагсаалтад байна гэсэн мэдээллийг өнөөдөр би авсан"... Энэ хоёр хүнтэй холбоотой хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, ШЁЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж бид үзэж байгаагаа Интерполд мэдэгдье. Эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас энэ хоёр хүнийг авч хаяхыг албан ёсоор хүсье ..." гэсэн захидлыг илгээснээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээг цуцалж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй эрүүгийн 20120100018 тоот хэргийн сэжигтэн Б.Х, Н.Эн нарыг Интерполын улаан булант зар мэдээгээр олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулахаар 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр холбогдох мэдээлэл хүргүүлснийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авч А-632./10-2012, А-634./10-2012 дугаарын улаан булант зар мэдээгээр 2012 оны 10 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд хэвлэн нийтэлсэн дээрх Монголын 2 иргэнийг интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа

2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсож, тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын Шугамаар хандаж мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэх гэмт хэргийг үйлдсэн болох нь:

Иргэний нэхэмжлэгч Б.А-ын "...Э.Э-гийн үйлдлийн улмаас Авлигатай тэмцэх газар Б.Х, Н.Эн нарын мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар авах боломжгүй нөхцөл байдал үүссэн учир түүнийг мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэж үзэж байгаа..." /3 дугаар хх-61-64/,

Гэрч Г.Б-ийн "...Монгол Улс дахь Интерполын Үндэсний товчооны ажлын албанд Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр мэдэгдэл ирсэн. Мөн нэмэлт мэдээлэл хүссэн байсан. 2012 оны 11 дүгээр сарын 26-нд Б.Х, Н.Эн нарт холбогдох хэрэгт тэднийг эрэн сурвалжилсан мэдээллийг устгах болсон талаар мэдэгдсэн байсан. Энэ нь Интерполын Үндсэн хуультай нийцээгүй байна гэж үзсэн байсан. Интерполын үндсэн хуульд улс төр, цэрэг, шашин, арьс өнгөний эсрэг асуудалд тус байгууллагаас оролцохыг хатуу хориглохоор заасан байдаг. Ингээд дэд сайд Э.Э-аас ирүүлсэн захиа, мэдээлэл, мөн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээлэл зэргийг харьцуулан үзээд энэхүү эрүүгийн хэрэгт улс төрийн намууд хоорондын зөрчилдөөн үүссэн, улс төр давамгайлсан шинжтэй байна гэж дүгнээд эрэн сурвалжлах сэжигтний мэдээллийн сангаас устгахаар болсоноо дурдсан байсан.

Хэрэв Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар, Интерполтой харьцах л бол заавал өөрийн улс дахь Интерполын Үндэсний төв товчоогоор уламжлуулах ёстой байдаг. Хувь хүн, албан тушаалтан өөрөө шууд бичиг, хүсэлт явуулах талаар Интерполын Үндсэн Хуульд зааж өгөөгүй. Харин бичиг хүсэлтийг Интерполын Үндэсний төв товчоогоор дамжуулахаар зааж өгсөн байдаг юм аа. Энэ эрэн сурвалжлах ажиллагааг цуцалж зогсоосон талаар Интерполын бүх гишүүн орнуудад 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс мэдэгдсэн байдаг. Ер нь Б.Х, Н.Эн нартай

холбоотой эрэн сурвалжлах асуудлыг зогсоож мэдээллийг устгаснаар зөвхөн тэднийг эрэн сурвалжлах ажиллагаа зогсож байгаа асуудал биш бас тэдний талаар ямар нэг мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар хандаж авах мэдээлэл авах боломжгүй болж байгаа гэсэн үг юм..." /1 дүгээр хх-191-196, 199-200, 3 дугаар хх-68/ гэх мэдүүлгүүд,

Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д Хууль зүйн дэд сайд Э.Э-аас өөрийн [exxxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар бичсэн цахим захидал /3 дугаар хх-ийн 25/, "Улаан булант зар" мэдээ цуцлагдах болсныг мэдэгдсэн Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газрын албан бичиг /3 дугаар хх-ийн 80-81/, "Улаан булант зар" мэдээнүүдийг сэргээсэн тухай Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газрын албан бичиг /3 дугаар хх-ийн 102-108/, Интерполын үндсэн хууль /1 дүгээр хх-ийн 48-63/, Монгол Улс Интерполд элссэн тухай албан бичиг /1 дүгээр хх-ийн 26/, бичиг баримтуудад үзлэг хийсэн тухай тэмдэглэлүүд /1 дүгээр хх-ийн 101-126, 2 дугаар хх-ийн 5-33, 76-106, 107-134, 135-158/, "Интерполд захидал илгээх эрх хэмжээ дэд сайдад байдаггүй" тухай Хууль зүйн сайд Х.Т-гийн албан бичиг /1 дүгээр хх-ийн 202/ зэрэг хэрэгт цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар хангалттай тогтоогджээ.

Төрийн албан тушаалтан гэдэгт Төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулахаар хуульчилж өгчээ.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзвэл Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор /1 дүгээр хх-ийн 231-232/ Хууль зүйн дэд сайдаар Э.Э-г томилсон ба Э.Э нь Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсэгт зааснаар Төрийн улс төрийн удирдах албан тушаалтан болох нь тогтоогдсон болно.

Тухайн гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс хууль бусаар оролцож санаатайгаар саад, төвөг бэрхшээл учруулж хуулиар эрх мэдэл нь олгогдсон Мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын бие даасан байдал, хараат бус байдлыг алдагдуулсан хэлбэрээр илэрдэг.

Э.Э нь мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулсан болох нь Интерполд

явуулсан албан бичиг, тухайн албан бичгийн улмаас эрэн сурвалжлах ажиллагаа зогссон болон бусад нотлох баримтаар түүний гэм буруу тогтоогдож байна.

Гэмт хэргийг шууд санаатай хэлбэрээр үйлдсэн, энэ хэргийг үйлдэхдээ албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдсон болно.

Тэрээр Интерполд албан бичиг илгээх эрх бүхий албан тушаалтан биш болно. Хэрэгт авагдсан баримтад "Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар, Интерполтой харьцах л бол заавал өөрийн улс дахь Интерполын Үндэсний төв товчоогоор уламжлагддаг" тухай дурдагдсан ба өөрийн албан тушаалын хувьд харьяалалгүй, эрх хэмжээ, эрхлэх асуудлын хүрээнд тусгагдаагүй асуудлаар Интерполд цахим захидал илгээж албан тушаалын байдлаа ашигласан байна.

Ялтны гэм буруу, тухайн хэрэгт хамааралтай, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн дээр дурдсан хохирогч, гэрчийн мэдүүлэг, хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудаар тогтоогдсон, анхан шатны шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй, шийтгэх тогтоол хууль ёсны бөгөөд үндэслэлтэй болжээ.

Анхан шатны шүүхээс гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, нийгмийн хор аюулыг харгалзан Э.Э-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт зааснаар улс төрийн албан тушаал эрхлэх эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140.400 төгрөгийг 60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.424.000 төгрөгийн торгох ялаар шийтгэж шийдвэрлэсэн нь ялтны хувийн байдалд тохирсон байна.

Ялтан Э.Э "...Улс төрийн байр сууриа илэрхийлсэн, гэмт хэргийн бүрэлдэхүүн, шалтгаант холбоо тогтоогдоогүй, Интерполын байгууллагын дүрэм журмын дагуу хийгдсэн хууль ёсны ажиллагаа ба

шийдвэрийг мөрдөн байцаалтад саад учруулсан гэсэн дүгнэлт гаргасан, хуулийн байгууллагын гаргасан алдааг улс төрийн албан хаагчид тохож хариуцлага хүлээлгэх гэж оролдсон..." гэж давж заалдах гомдол гаргажээ.

Э.Э нь хувь хүний болон М намын бага чуулган, гүйцэтгэх товчооны гишүүний хувиар бус харин Хууль зүйн дэд сайдын албан тушаалын байдлаа ашиглаж Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар хандаж мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь дээр дурдсан иргэний нэхэмжлэгч, гэрчийн мэдүүлэг болон бусад нотлох баримтуудаар нотлогдсон, анхан шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн, хэргийн зүйлчлэл зөв, шүүхээс оногдуулсан ял шийтгэл тохирсон, түүнийг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаагүй гэж үзэх үндэслэлгүй, хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл тогтоогдохгүй байх тул ялтан Э.Э-ны "...намайг цагаатгаж өгнө үү...", түүний өмгөөлөгч П.Одонтунгалагийн "...хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж өгнө үү..." гэх давж заалдах гомдлуудыг тус тус хүлээн авах боломжгүй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 408 дугаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, ялтан Э.Э, түүний өмгөөлөгч П.Одонтунгалаг нарын гаргасан давж заалдах гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

2. Гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд нь давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧ  
Ш.БАТ-ЭРДЭНЭ

С.СОЁМБО-ЭРДЭНЭ  
Д.ГАНСҮХ,

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн С.Нямжав даргалж, шүүгч Б.Батцэрэн, Б.Цогт, Д.Ганзориг, Д.Эрдэнэбалсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр, Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор С.Алимаа, ялтны өмгөөлөгч П.Одонтунгалаг, нарийн бичгийн дарга Б.Өлзийхишиг нарыг оролцуулан, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 408 дугаар шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 496 дугаар магадлалтай, Э.Э-д холбогдох эрүүгийн хэргийг ялтны өмгөөлөгч П.Одонтунгалагийн гаргасан гомдлыг үндэслэн шүүгч Д.Ганзоригийн илтгэснээр хянан хэлэлцэв.

Х овгийн Э.Э, ...оны ...дүгээр сарын ...-нд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Хууль зүйн дэд сайдаар ажиллаж байгаа, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй /ЧР...../.

Хууль зүйн дэд сайд Э.Э нь албан тушаалын байдлаа ашиглаж, 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт өөрийн [exxxxxx@moj.gov.mn](mailto:exxxxxx@moj.gov.mn) и-мэйл хаягаар Интерполын Нарийн бичгийн дарга нарын ерөнхий газрын цахим хуудсанд Интерполын Ерөнхий Нарийн бичгийн дарга Р.Н-д хандаж "...Монгол Улсын хууль зүйн яамны дэд сайдын хувиар энэ захидлыг бичиж байна. Монгол Улсын хоёр иргэн / Б.Х, Н.Эн / Интерполын веб хуудасны эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн жагсаалтад байна гэсэн мэдээллийг өнөөдөр би авсан. Энэ хоёр хүнтэй холбоотой хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж бид үзэж байгаагаа Интерполд мэдэгдье. Эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас энэ хоёр хүнийг авч хаяхыг албан ёсоор хүсье." гэсэн захидлыг илгээснээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн

улаан булант зар мэдээг цуцалж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж буй эрүүгийн 20120100018 тоот хэргийн сэжигтэн Б.Х, Н.Эн нарыг Интерполын улаан булант зар мэдээгээр олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулахаар 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр холбогдох мэдээлэл хүргүүлснийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авч А-632./10-2012, А-634./10-2012 дугаарын улаан булант зар мэдээгээр 2012 оны 10 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд хэвлэн нийтэлсэн дээрх Монголын 2 иргэнийг Интерполоор эрэн сурвалжлах ажиллагаа 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд зогсож, тэдний талаарх мэдээллийг Интерполын гишүүн улс орнуудаас Интерполын шугамаар хандаж мэдээлэл авах боломжгүй нөхцөл байдал үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 408 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгч Х овогт Э.Э-ыг албан тушаалын байдлаа ашиглаж мөрдөн байцаалтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Э.Э-ыг улс төрийн албан тушаал эрхлэх эрхийг 02 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 140.400 төгрөгийг 60 /жар/ дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.424.000 /найман сая дөрвөн зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийн торгох ялаар шийтгэж шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 496 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, ялтан Э.Э, түүний өмгөөлөгч П.Одонтунгалаг нарын гаргасан давж заалдсан гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.



Ялтны өмгөөлөгч П.Одонтунгалаг хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо: "...Гэм буруугийн талаар хийсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар үгүйсгэгдэж, хэргийн бодит байдалтай нийцээгүй, хэт нэг талыг барьж гаргасанд гомдолтой байна.

Хэрэгт Интерполоор хийгдсэн эрэн сурвалжлах ажиллагаа эхэлсэн, цуцлагдсан, сэргээгдсэн талаар хэрэгт авагдсан нотлох баримтууд:

Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлах, тэдний эсрэг Интерполын цахим сангийн "Улаан булант" зар мэдээнд хэзээ, хэрхэн хэвлэн нийтэлсэн, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар ямар үндэслэл, баримтаар уг мэдээллийг цуцалсан, хэзээ хэрхэн сэргээсэн талаар дараах баримт, нотолгоонууд хэрэгт авагдсан байдаг. Үүнд: Н.Эн, Б.Х нарыг эрүүгийн хэрэгт интерполоор эрэн сурвалжлуулахаар 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр 06/359 дугаартай албан тоотой Интерполын "Улаан булант" зар мэдээгээр дамжуулан олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулах хүсэлт, холбогдох мэдээллийг гарган, Монголын Интерполын Үндэсний товчоогоор дамжуулж, Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн байдаг.

Монголын Интерполын Үндэсний товчооноос ирүүлсэн мэдээллийг хүлээн авч Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 10 дугаар сарын 9,10-ны өдрүүдэд "Улаан булант" зар мэдээнд Б.Х, Н.Эн нарын эсрэг мэдээлэл хэвлэн нийтэлж, Интерполын гишүүн улсуудад мэдэгдэн түгээсэн байдаг.

Энэхүү "Улаан булант" зар мэдээнд Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлуулахаар Интерполын Ерөнхий нарын бичгийн даргын газарт хүргүүлсэн Авлигатай тэмцэх газрын 2012 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 06/152 тоот албан тоот, 2012 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 06/359 дугаартай албан тоотой тус тус хүргүүлсэн мэдээлэл нь бүрэн гүйцэд, бодитой бус мэдээлэл байсан болох нь хэргийн 1-р хавтасны 115-116 дугаар хуудсанд авагдсан нотлох баримтаар тодорхой тогтоогдож байдаг.

Тодруулбал Авлигатай тэмцэх газар, Б.Х, Н.Эн нарыг интерполоор эрэн сурвалжлахад шаардлагатай мэдээллээ Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой, Н.Эн нь Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-

ын төрсөн дүү, Б.Х нь Н.Э-ыг Монгол Улсын ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж байх хугацаанд түүний туслахаар ажиллаж байсан талаарх мэдээллийг огт өгөлгүй, зөвхөн бусдын өмчийг завших үрэгдүүлэх гэмт хэрэгт хамтран оролцсон үндэслэлээр сэжигтнээр тооцогдсон, хамтран оролцогч нь А овгийн Н.Э гэсэн мэдээллийг хүргүүлсэн байдаг.

Уг мэдээлэл нь улс төрийн зүтгэлтэнтэй холбоотой талаарх мэдээлэл огт тусгагдаагүй байсан тул Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас Үндсэн хууль болон холбогдох дүрэм журамд харшлаагүй байна гэж үзэн "Улаан булант" зар мэдээнд хэвлэн нийтэлсэн байдаг.

Э.Э нь М намын "АШЁ" залуучуудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, М намын гүйцэтгэх товчооны гишүүн, М-Мү намын ШЁЭ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд, М-Мү намын ШЁЭ, А намтай байгуулсан "Хамтарсан Засгийн газар байгуулах" хэлэлцээрийн дагуу Хууль зүйн яамны дэд сайдын албан тушаалд томилогдсон, улс төрийн албан тушаалтан бөгөөд М намын гишүүн, улс төрч, хувь хүнийхээ хувьд өөрийн үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлж, Б.Х, Н.Эн нарыг "Улаан булант" зар мэдээнд нийтэлсэн нь улс төрийн сэдэлттэй, Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотойгоор түүний төрсөн дүү болон туслахаар ажиллаж байсан хүний ахыг нь эрэн сурвалжилж байгаа нь Интерполын Үндсэн хуульд заасан "Улс төр, цэрэг, шашин эсхүл арьсны өнгөөр ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг хатуу хориглоно" гэсэн заалтыг зөрчхөөс сэргийлүүлж, эрэн сурвалжлах жагсаалтаас хасаж өгөхийг хүсэж, уг хэргийн талаар намын гишүүнийхээ хувьд зарим мэдээллийг өгч 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт цахим захидал бичсэн байдаг.

Уг захидалд "Интерполын цахим хуудас дахь эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн жагсаалтад Монгол Улсын эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргаж Н.Эн, Б.Х нар багтсан талаар олж мэдлээ, одоо Монгол Улсад орон нутгийн сонгууль болж байгаатай холбогдуулан эрх барьж буй нам, хууль сахиулах байгууллагыг тусгайлан оролцуулж, улс төрийн зорилгоор мөрдлөг, ял тулгалт явагдаж байна. Интерполын Үндсэн хуульд

төвийг сахих, улс төрийн сэдэлттэй хэрэгт оролцохоос сэргийлдэг бөгөөд, Б.Х, Н.Эн нартай холбоотой хэрэг нь Монгол Улсын ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой тул, улс төрийн сэдэлттэй гэж үзэж байгаагаа мэдэгдэж, эдгээр хүмүүсийг эрэн сурвалжлах жагсаалтаас хасахыг хүсэж, Н.Э-тай холбоотой хэрэг Монгол Улсын Дээд шүүхэд давж заалдах шатанд явж байгаа ба улс төрийн сэдэлттэй яллаж байгаа бүх үндэслэлүүдийг хэрэгсэхгүй болгон, хууль ёсны шийдвэр гарна гэдэгт итгэж байгаагаа илэрхийлж, Интерполоос баг илгээж манай улсын хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд, үнэлэлт дүгнэлт хийхийг уриалж байгаагаа бичсэн байдаг.

Ийнхүү Э.Э нь цахим захидлаараа, Авлигатай тэмцэх газраас Монголын Интерполын Үндэсний товчоогоор дамжуулан, Б.Х, Н.Эн нарын талаар "Улаан булант" зар мэдээнд нийтлүүлэхээр Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газарт хүргүүлсэн мэдээлэлд заагдсан хэргийн тухай бодит мэдээлэл бичсэнийг, Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын хуулийн асуудал хариуцсан хэлтсээс захидалд заагдсан мэдээлэл үндэслэлтэй эсэхийг тодруулахаар нэмэлт мэдээллийг Интерполын Үндэсний товчооноос ирүүлэхийг хүссэн бичиг ирүүлсэн байдаг.

Н.Э нь Монгол улсын ерөнхийлөгчийн албан тушаалын байдлыг урвуулан ашиглаж, "Ө" зочид буудал Нийслэлийн өмчит газрыг татан буулгаж "ХД" ХХК-ийн оролцоотой "ДӨ" ХХК-ийг байгуулж, хууль бусаар хувьчлан авсан, "УТ" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хууль бусаар авч, онц их хэмжээний хохирол учруулсан зэрэг гэмт хэргүүдэд холбогдон шалгагдсан бөгөөд уг хэргийн учир одоогоор шүүхээр ял шийтгэгдсэн байна гэсэн хариуг Интерполын Үндэсний товчоогоор дамжуулан Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтэст хүргүүлсэн байдаг.

Энэхүү хариуг хүлээн авч Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монголын Интерполын Үндэсний товчоонд албан бичиг ирүүлсэн байдаг.

Уг бичигт Интерполын Үндсэн хууль болон дүрэмд тодруулбал "Улс төр, цэрэг, шашин эсвэл, арьс өнгөөр гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа явуулах, ямар нэг хэлбэрээр оролцохыг тус байгууллагад хатуу

хориглоно" гэж заасан байдаг Үндсэн хуулийн 3-р зүйлтэй нийцэж байгаа эсэхийг бататгах үүднээс хууль зүйн шалгалт хийгдсэн.

Интерполын мэдээ мэдээлэл боловсруулах дүрмийн хүрээнд, энэхүү хэргийн үндсэн шинжийг чанарыг тодорхойлж, болох ерөнхий утгыг уг шалгалтын явцад хянан хэлэлцээд, дээрх 2 хүний эсрэг явуулсан яллах ажиллагаа, хуулийн дагуу гэдэг нь маргаантай, нэн ялангуяа энэ нь Монголын улс төрийн нэртэй намуудын хооронд маргаан үүсгэсэн гэдэг нь тус хэргийн нөхцөл байдлын талаар танай Үндэсний товчооноос өгсөн мэдээлэл, Монгол Улсын Хууль зүйн дэд сайдаас авсан захиа, Ерөнхий нарийн бичгийн даргын газраас хийгдсэн судалгааны үр дүнд харагдаж байна. Иймд 3-р зүйлд зааснаар энэхүү хэрэг нь улс төр давамгайлсан шинжтэй гэсэн дүгнэлтийг Хуулийн асуудал хариуцсан хэлтсээс гаргасан болно. Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн "Улаан булант" зар мэдээ цуцлагдаж, энэхүү хоёр хүнтэй холбоотой мэдээлэл байгууллагын мэдээллийн сангаас устгагдаж, Интерполын шугамаар явагдсан цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаа нь энэ тохиолдолд тус байгууллагын Үндсэн хууль болон дүрэмтэй нийцээгүй болох талаар бүх гишүүн улсуудад мэдэгдэх болно гэсэн бичиг ирүүлж, 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр гишүүн орнуудад мэдэгдсэн байдаг.

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Авлигатай Тэмцэх газраас уг хэргийг Улсын Дээд шүүх хянан үзээд анхан болон давж заалдах шатны шүүх ял оногдуулсныг, 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталгаажуулсан талаарх танилцуулга, Н.Эн, Б.Х нарыг эрэн сурвалжлуулах зар мэдээг сэргээлгэхийг хүссэн хүсэлтийг Монголын Интерполын товчооноос хүлээн авч, мөн Хууль зүйн сайд Х.Т-гийн 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11/35 дугаартай албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн "Улаан булант" зар мэдээг сэргээсэн байдаг.

Э.Э-ны Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газар илгээсэн захидал нь "Улаан булант" зар мэдээнд гарсан Б.Х, Н.Эн нар нь, ерөнхийлөгч асан Н.Э-тай холбоотой, түүний төрсөн дүү болон туслахынх нь ах гэсэн үнэн бодитой мэдээллийг явуулж, Монгол Улсад өрнөж буй

улс төрийн болон, хууль сахиулагчдын үйл ажиллагааг шүүмжлэн, улс төрийн сэдэлттэй хэрэгт оролцохоос сэргийлж уг ажиллагааг зогсоож, баг илгээж хууль сахиулагчдын үйл ажиллагаанд дүгнэлт хийхийг уриалсан байдаг.

Э.Э-ны илгээсэн цахим захидал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт заасан "Монгол Улсын иргэн бүр итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ" гэх заалтын хүрээнд улс төрийн албан хаагч, улс төрч хувь хүнийхээ хувьд, өөрийн итгэл үнэмшил, байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн байдаг.

Анхан шатны шүүх Э.Э-ны захидал бичсэн үйлдэлд дүгнэлт хийхдээ, Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын Хуулийн асуудал эрхэлсэн хэлтсийн хяналт шалгалтын хүрээнд Монголын Үндэсний Интерполын товчооноос ирүүлсэн тайлбар, үүнтэй холбогдуулан судалгаа явуулан дүгнэлт хийж, гаргасан шийдвэр зэрэг нь Б.Х, Н.Эн нарын талаар, гадаад улсаас мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүсэж, Улаан булант зар мэдээ цуцлагдсантай ямар шалтгаант холбоотой эсэхэд шүүх дүгнэлт хийх шаардлагатай байсан болно. Э.Э-ны захидал нь Б.Х, Н.Эн нарын талаарх мэдээллийг гадаад улсуудаас авах боломжгүй нөхцөл байдал үүсгээгүй, харин Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын хуулийн асуудал эрхэлсэн хэлтсээс Интерполын Үндэсний товчооноос нэмэлт материал шаардан ирүүлсэн баримт, өөрсдийн шалгалт, судалгаа явуулж гаргасан дүгнэлтийг үндэслэн Б.Х, Н.Эн нарын эсрэг гаргасан Интерполын Улаан булант зар мэдээг цуцалсан шийдвэр гаргаснаар Авлигатай тэмцэх газраас мөрдөн байцаах ажиллагаа явуулж буй эрүүгийн хэрэгт дээрх 2 иргэний талаар гадаад улсаас мэдээлэл авах боломжгүй нөхцөл үүссэн болно.

Гэтэл "Улаан булант" зар мэдээ цуцлагдаж гадаад улсаас Б.Х, Н.Эн нарын талаарх мэдээлэл авах боломжгүй нөхцөлийг Интерполын Ерөнхий нарийн бичгийн газрын гаргасан шийдвэр бий болгосон байхад, Э.Э-ны гэм буруутай үйлдэл гэж яллаж, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь үндэслэлгүй юм.

Э.Э цахим захидал илгээсэн нь нийгэмд аюултай үйлдэл бус бөгөөд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 245 дугаар зүйлд заасан мөрдөн байцаах ажиллагаанд саад

учруулсан гэмт хэргийн бүрэлдэхүүний объект буюу мөрдөн байцаах ажиллагааны хуулиар тогтоосон журамд халдаагүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байна.

Харин ч эрхлэх ажил үүргийнхээ хувьд биш гагцхүү улс төрийн үзэл бодлоо илэрхийлсэн байхад албан тушаалын хүрээнд Хууль зүйн яамны бичиг хэрэг хөтлөлтөөр дамжуулаагүй, олон улсын харилцаа холбооны интернет шуудангаар захидал илгээснийг албан тушаалаа ашигласан гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм. Учир нь албан тушаалтан Интернет ашиглаж захидал бичихийг хориглосон хууль эрх зүйн хэм хэмжээ байхгүй болно. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар зүйлийн 3.3-т "Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй" гэж хуульчилсан бөгөөд, үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлсэн захидал нь мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах хэргийн объектод бие даан халдаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1-д заасан үндэслэлээр Э.Э-д холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү гэжээ.

Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор С.Алимаа хяналтын шатны шүүх хуралдаанд гаргасан саналдаа: "...Хууль зүйн яамны дэд сайд Э.Э нь дэд сайдынхаа хувьд гээд, дэд сайдынхаа эрх хэмжээнд захидлынхаа утга дээр Хууль зүйн яамны дэд сайдаас гэж толгой бичээд, Хууль зүйн яамны ажилтнуудад олгодог и-мэйл хаягаар Интерполтой харилцсан. Дэлхийн хэмжээнд эрэн сурвалжилж байсан Б.Х, Н.Эн нарыг "Улаан булан" гэсэн зар мэдээнээс хасахыг хүссэн захидлыг албан тушаалаа ашиглаж үйлдсэн. Ингэснээр 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд Б.Х, Н.Эн нарын талаарх мэдээллийг олон улсын хэмжээнд олж авах боломжгүй байдлыг бий болгосон. Хууль зүйн яамны дэд сайд Э.Э нь албан тушаалаа ашиглаж мөрдөн байцаалтад зориуд саад учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогдсон гэж үзэж байна. Хэргийн зүйлчлэл тохирсон, шүүх хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчөөгүй байх тул анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хэвээр үлдээх

саналтай байна" гэв.

#### ХЯНАВАЛ:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал нь хууль ёсны ба үндэслэлтэй байх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцжээ.

Хэргийн материалаас үзэхэд, Авлигатай тэмцэх газраас 2012 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Н.Эн, 2012 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Б.Х нар тус тус сэжигтнээр тооцогдон шалгагдаж байхдаа Монгол Улсын хилээр гарсан нь тогтоогдсон үндэслэлээр Интерполын үндэсний төв товчоогоор дамжуулан олон улсын хэмжээнд эрэн сурвалжлуулах хүсэлтийг гаргаж, Интерпол буюу Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага 2012 оны 10 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд Б.Х, Н.Эн нарын эсрэг гишүүн орнуудын нутаг дэвсгэрийн хэмжээнд эрэн сурвалжлах тухай улаан булант зар мэдээ нийтлэгдсэн байсан.

Дээрх байдлаар Б.Х, Н.Эн нарыг Интерполын хэмжээнд эрэн сурвалжлах мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байхад 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Интерполын Ерөнхий нарийн бичгийн дарга РН-д эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүсийн жагсаалтаас Б.Х, Н.Эн нарыг хасахыг хүссэн цахим захидал [exxxxxx@toj.gov.mn](mailto:exxxxxx@toj.gov.mn) гэсэн мэйл хаягаар очсон байх бөгөөд уг захидлыг "Монгол Улсын Хууль зүйн дэд сайдын хувиар" Э.Э нь илгээж, захидалдаа; "...Монгол Улсын Хууль зүйн яамны дэд сайдын хувиар энэ захидлыг бичиж байна. Монгол Улсын хоёр иргэн / Б.Х, Н.Эн / Интерполын веб хуудасны эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн жагсаалтад байна гэсэн мэдээллийг өнөөдөр би авсан. Энэ хоёр хүнтэй холбоотой хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан, ШЕЭ-ийн тэргүүн Н.Э-тай холбоотой улс төрийн шалтгаантай хэрэг гэж бид үзэж байгаагаа Интерполд мэдэгдье. Эрэн сурвалжлагдсан хүмүүсийн жагсаалтаас энэ хоёр хүнийг авч хаяхыг албан ёсоор хүсье", "улс төрийн шинж давамгайлсан" байгаа нь Интерполын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийг зөрчиж байгаа гэжээ.

Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газраас 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр дээрх захидлыг Монгол Улсын Хууль зүйн дэд сайд Э.Э бичсэн эсэх, эрэн сурвалжлагдаж байгаа Б.Х, Н.Эн нар Монгол

Улсын Засгийн газарт ажиллаж байсан эсэх, эдгээр хүмүүсийн буруутгагдаж байгаа хэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Этай холбоотой эсэх, ямар холбоотой, уг хэргийг хамтран үйлдсэн эсэх зэргийг нягталж өгөхийг хүссэн захидлыг Монгол Улсын Интерполын үндэсний товчоонд хандан ирүүлсэн байна.

Монгол Улсын Интерполын үндэсний товчоо Авлигатай тэмцэх газраас хариуг авч 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр буцаан хүргүүлсэн бөгөөд Интерполын хуулийн асуудал эрхэлсэн хэлтэс Э.Э-ы захидал болон бусад шалгалтын материалыг үндэслэн 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Б.Х, Н.Эн нарын эсрэг хэвлэн нийтэлсэн улаан булант зар мэдээг улс төрийн шинж давамгайлсан гэж үзэн цуцалж, Интерполын гишүүн 190 гаруй улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагааг зогсоосноо мэдэгджээ.

Дээрх цуцлагдсан ажиллагаа 2013 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд үргэлжлээд дахин сэргэсэн бөгөөд цуцлагдсан хугацаанд Б.Х, Н.Эн нарын талаар олон улсын хэмжээнд мэдээлэл авах, солилцох ажиллагаа бүрэн зогсож, энэ тухай Интерполын хуулийн асуудал эрхэлсэн хэлтэс Монгол Улсын Интерполын үндэсний товчоонд ирүүлсэн захидалдаа "Интерполын ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Монгол Улсын Хууль зүйн дэд сайд Э.Э-гаас ирүүлсэн дээрх мэдээнүүд нь улс төрийн сэдэлтэй, Монгол Улсын Ерөнхийлөгч асантай холбоотой гэж дурдсан захидлыг хүлээн авсны дараа танай Үндэсний төв товчооноос хариу болгож ирүүлсэн мэдээллийг хянаж үзээд "Улаан булант" зар мэдээнүүдийг эгүүлэн татах шийдвэр анх гаргасан юм. Гэвч нэмэлт мэдээлэл хүлээн авч дахин хянаж үзсэний эцэст Монгол Улсын Үндэсний төв товчооны хүсэлтийн дагуу "Улаан булант" зар мэдээнүүдийг сэргээсэн болно" гэжээ.

Э.Э нь уг захидлыг өөрийн мэйл хаягаас явуулснаа хүлээн зөвшөөрдөг бөгөөд гагцхүү иргэн хүнийхээ хувьд хүсэлт гаргаж явуулсан, уг ажиллагааг зогсоох эрх хэмжээ бүхий байгууллага нь Интерпол өөрөө, би зөвхөн хүсэлт гаргасан гэж мэдүүлдэг боловч түүний явуулсан захидалд Монгол Улсын Хууль зүйн дэд сайд буюу албан тушаалтнахаа хувиар, эрх хэмжээнийхээ хүрээнд явуулсан гэж бичигдсэнийг баталсан Англи хэлнээс Монгол хэл рүү орчуулсан хууль зүйн албан

орчуулгын баримтуудаар түүний мэдүүлэг үгүйсгэгдсэн, мөн Интерпол эрэн сурвалжлах ажиллагааг зогсоохдоо түүний хүсэлт болон бусад шалгалтын баримтуудыг үндэслэсэн байна.

Монгол Улсын Хууль зүйн яамны дэд сайд Э.Э нь хууль тогтоомж, тухайлбал Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 181 дүгээр зүйлд заасан дэд сайдын бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар Интерполтой харьцсан байх бөгөөд үүнийг Хууль зүйн яамны сайд Х.Т-ийн Интерполийн Ерөнхий нарийн бичгийн даргад илгээсэн 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн И/З дугаартай "... Миний бие Хууль зүйн яамны сайдын хувьд Монгол Улсын Засгийн газрын өмнөөс түүний бичсэн зүйл нь хууль зүйн үндэслэлгүй гэдгийг үүгээр баталж байна. Хууль зүйн яамны дэд сайд зохих зөвшөөрөлгүйгээр Интерполд и-мэйл явуулсан. Хууль болон баримтад үндэслэн Б.Х болон Н.Эн-ийн хэргийн мөрдөн байцаах ажиллагааг явуулсан ба улс төрийн ямар ч шалтгаангүй болно..." гэсэн захидал баталсан гэж үзнэ.

Дээрх нотлох баримтуудаас үзэхэд, Интерпол Б.Х, Н.Эн нарыг эрэн сурвалжлах ажиллагааг зогсооход Монгол Улсын Хууль зүйн дэд сайд Э.Э-ын албан тушаалтны хувьд бичсэн захидал шууд нөлөөлсөн бөгөөд энэ нь мөрдөн байцаалтын ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон идэвхтэй үйлдлээр илэрч, мөрдөн байцаалтын ажиллагаа тодорхой хугацаанд хэвийн явагдах боломжгүй үр дагавар бий болсон нь Эрүүгийн хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн хангасан байна.

Анхан болон давж заалдах шатны

шүүхийн шийтгэх тогтоол, магадлалуудад хэргийн үйл баримт, түүнийг нотолсон баримтуудыг тодорхой дурдсан байгааг тэмдэглэвэл зохино.

Мөрдөн байцаах болон хэрэг хянан шийдвэрлэх явцад Эрүүгийн хууль буруу хэрэглээгүй, Эрүүгийн байцаан шийтгэх хууль ноцтой зөрчөөгүй, шүүхээс Э.Э-д оногдуулсан ял хуулийн хүрээнд түүний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар болон гэм бурууд тохирсон гэж үзнэ.

Иймд Э.Э-ны өмгөөлөгч П.Одонтунгалагийн "...үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлсэн захидал нь мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах хэргийн объектод бие даан халдаагүй гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1-д заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү" гэсэн гомдлыг хэрэгсэхгүй болгож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг тус тус хэвээр үлдээх хууль зүйн үндэслэлтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-д заасныг удирдлага болгон хяналтын шатны шүүх хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 408 дугаар шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 496 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, ялтны өмгөөлөгч П.Одонтунгалагийн хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН  
ШҮҮГЧ

С.НЯМЖАВ  
Д.ГАНЗОРИГ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 1014

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Мөнхбаяр даргалж, шүүгч Х.Идэр, Ц.Цэлмэг нарын бүрэлдэхүүнтэй,

Иргэдийн төлөөлөгч: Д.Алтангэрэл

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: Б.Батцэнгэл, Түмэнчимэг

Улсын яллагч Б.Уранчимэг,

Шүүгдэгч Б.ЖА, Н.НА, Б.Ба, Г.ГҮ, М.Мө, Г.Чи, Ц.Ня, С.Пү, Г.Од, Ч.Ба, М.Бо, Б.Мя, З.Эн, Х.Бу, Ц.Ба, А.Мө, Э.Ба, М.Ца, Ч.Тэ, Б.Чу, Э.Ур, Н.Ба, Д.Ба, С.Га, Г.Ур, Б.Пү, Б.Цэ, М.Бу, Б.Бо, Н.Ою, Э.Бү, Б.Ар, Э.Ор, Э.Пү, Б.Мө, М.Би, Б.Со, Д.Чи, З.Ня, Б.Но, Б.Би, Б.Ца, Б.Бо, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Б.Мө, Б.Баа, Ж.Ду, Г.Чу, О.Уя, А.Сү, Э.Ба,

Шүүгдэгч нарын өмгөөлөгч Б.Цэрэндолгор /ҮД:038./, Ц.Батбаяр /ҮД: 100./ Ч.Наранцэцэг /ҮД:100./, Ч.Баднайнямбуу /ҮД:009./ Б.Бат-Эрдэнэ /ҮД:083./, Н.Болормаа /ҮД:020./, Т.Баярцэнгэл /ҮД:029./, Г.Даваа /ҮД:017./, Ц.Өлзийбаяр /ҮД:016./, Д.Халзан /ҮД:110./, Б.Цэнд-Аюуш /ҮД:068./, М.Хувцагаан /ҮД:048./, Г.Батбаяр /ҮД:005./, Б.Дашдорж /ҮД:074./, О.Цэрэнпунцаг /ҮД:128./, Д.Гангантөгс /ҮД:035./, Н.Баатардорж /ҮД:100./, Н.Дашдулам /ҮД:072./, Б.Мөнхтөр /ҮД:034./, Б.Занданпүрэв /ҮД:092./, Ц.Оргил /ҮД:125./, О.Батцэцэг /ҮД:028./, М.Амарнасаа /ҮД:072./, Д.Гунгаа /ҮД:033./, М.Ариунболд /ҮД:081./, М.Цэмбэлмаа /ҮД:028./ нарыг оролцуулан тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар Дүүргийн 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Б.ЖА, 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэгт зааснаар Н.НА, Б.Ба, Г.ГҮ, С.Пү, М.Мө, Г.Чи, Ц.Ня, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар С.Пү, Г.Од, Ч.Ба, М.Бо, Б.Мя, З.Эн, Х.Бу, Ц.Ба, А.Мө, Э.Ба, М.Ца, Ч.Тэ, Б.Чу, Э.Ур, Н.Ба, Д.Ба, С.Га, Г.Ур, Б.Пү, Б.Цэ, М.Бу, Б.Бо, Н.Ою, Э.Бү, Б.Ар, Э.Ор, Э.Пү, Б.Мө, М.Би, Б.Со, Д.Чи, З.Ня, Б.Но, Б.Би, Б.Ца, Б.Бо, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Б.Мө, Б.Баа, Ж.Ду, Г.Чу, О.Уя, А.Сү, 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар Э.Ба нарт холбогдуулж яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 20120100020 дугаартай хэргийг 2014 оны 04 дүгээр сарын 11-ний

өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Шүүгдэгч Х овгийн Б.ЖА: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, орчуулагч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ М сургуулийн сургалтын албаны дарга Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн эрхлэгчээр ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэрийн хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо, ...дугаар хорооллын ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:ЧК...../

2. Шүүгдэгч Д овгийн Н.НА: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, буддын гүн ухаанч мэргэжилтэй, М-ын үүрийн дарга ажилтай, ам бүл..., эцэг, эх, эгчийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:УМ...../

3. Шүүгдэгч И овгийн М.Мө: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, “Э” ХХК-д захиалга хүлээн авагч ажилтай, ам бүл ..., эхийн хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:...../

4. Шүүгдэгч У овгийн Б.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, хэрэгт холбогдох үедээ М сургуульд сурч байсан, ам бүл..., эцэг, эх, эгчийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороолол ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УХ...../

5. Шүүгдэгч Т овгийн Г.ГҮ: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, хэрэгт холбогдох үедээ М сургуульд сурч байсан, ам бүл..., эцэг, эхийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хороо

...дугаар байрны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:УШ...../

6. Шүүгдэгч А овгийн С.Пү: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Архангай аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, хэрэгт холбогдох үедээ М сургуульд сурч байсан, ам бүл..., эцэг, эх, эгчийн хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...гудамжны ...дүгээр байрны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:АЮ...../

7. Шүүгдэгч Ш овгийн Ц.Ня: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл ..., эцэг, эх, дүү, нөхөрийн нарын хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороолол, ...байрны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:УК...../

8. Шүүгдэгч Х овгийн Г.Чи: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Өмнөговь аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, олон улсын маркетингийн мэргэжилтэй, "Т" ХК-д менежер ажилтай, ам бүл..., эхийн хамт Өмнөговь аймгийн ...сум ...дугаар баг ...дугаар байрны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:КЮ...../

9. Шүүгдэгч С овгийн Э.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Сэлэнгэ аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:МД...../

10. Шүүгдэгч С овгийн Г.Од: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороолол ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УЗ...../

11. Шүүгдэгч Ш овгийн Ч.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Завхан аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй,

...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, эгч нарын хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ИЧ...../

12. Шүүгдэгч И овгийн Б.Мя: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:НЦ...../

13. Шүүгдэгч Ө овгийн Х.Бу: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Орхон аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, Худалдааны менежментийн мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Архангай аймгийн ...сум ...багт ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ФД...../

14. Шүүгдэгч: Ө овгийн Г.Ур: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Дундговь аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ЗЕ...../

15. Шүүгдэгч Б овгийн Б.Цэ: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, /РД:УК...../

16. Шүүгдэгч Ш овгийн Б.Бо: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Дархан-Уул аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, худалдааны менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, ах нарын хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ТЕ...../

17. Шүүгдэгч Э овгийн Б.Бо: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, М

сургуулийн зочид буудал, зоогийн газрын менежментийн 4 дүгээр дамжааны оюутан, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УМ...../

18. Шүүгдэгч С овгийн М.Бу: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, маркетингийн менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., аав, ээж, нөхөр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УХ...../

19. Шүүгдэгч М овгийн М.Ца: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, "З" ХХК-д зохион байгуулагч ажилтай, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хороо ..... тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УУ...../

20. Шүүгдэгч Б овгийн Э.Пү: Монгол улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Завхан аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, олон улсын худалдааны менежер мэргэжилтэй, Орхон аймаг дахь "Н" ББСБ-д эдийн засагч ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Орхон аймгийн ...сум ...баг ...дугаар хороолол ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ИЮ...../

21. Шүүгдэгч А овгийн Б.Со: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын удирдлагын менежер мэргэжилтэй, "А" каракед зөөгч ажилтай, ам бүл ..., эцэг, эх, дүү нарын хамт Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД: УМ...../

22. Шүүгдэгч Б овгийн Б.Чу: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Дорнод аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, хүүхдүүдийн хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ЖЮ...../

23. Шүүгдэгч Ч овгийн Н.Ба: Монгол

Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, "М" ХХК-д зөөгч ажилтай, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УК...../

24. Шүүгдэгч Г овгийн А.Мө: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Дорнод аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, ах, эгч, дүү нарын хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ЖЖ...../

25. Шүүгдэгч Г овгийн Ц.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын...-ний өдөр Ховд аймагт төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, Зочид буудал, зоогийн газрын менежментийн мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ТЮ...../

26. Шүүгдэгч С овгийн Э.Ор: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Өмнөговь аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, М сургуулийн 4 дүгээр дамжааны оюутан, ам бүл..., нөхрийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:КЮ...../

27. Шүүгдэгч О овгийн Б.Би: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, "С" телевизэд эвлүүлэгч, графикч ажилтай, ам бүл..., эх, дүү нарын хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УШ...../

28. Шүүгдэгч С овгийн Б.Но: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, "У" ХХК-д оператор ажилтай, ам бүл..., эцэг, эхийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УМ...../



29. Шүүгдэгч Г овгийн Э.Ур: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УХ...../

30. Шүүгдэгч Б овгийн Н.Ою: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Архангай аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, "Ш" дээд сургуульд нягтлан бодох бүртгэлийн багш ажилтай, ам бүл..., эцэг, эхийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:АЗ...../

31. Шүүгдэгч Б овгийн Б.Ца: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, нөхөр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй /РД:НН...../

32. Шүүгдэгч Б овгийн Б.Мө: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, олон улсын худалдааны менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эхийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:НХ...../

33. Шүүгдэгч Ц овгийн Д.Чи: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, М сургуулийн реклам, зар сурталчилгааны менежментийн ...дүгээр дамжааны оюутан, ам бүл..., эцэг, эхийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УП...../

34. Шүүгдэгч Б овгийн З.Ня: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Сэлэнгэ аймгийн ...сум ...багийн ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:МБ...../

35. Шүүгдэгч Б овгийн М.Ма: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УШ...../

36. Шүүгдэгч Б овгийн Б.Ан: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, ...хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ЧД...../

37. Шүүгдэгч Х овгийн Сү.Эн: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, "Г" ХХК-д худалдааны зөвлөх ажилтай, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суудаг гэх, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УМ...../

38. Шүүгдэгч Т овгийн И.До: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, эгч нарын хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УУ...../

39. Шүүгдэгч Ё овгийн Ж.Ду: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Өвөрхангай аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, худалдагч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ЙК...../

40. Шүүгдэгч Б овгийн Г.Чу: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эмээ, эх, дүү нарын хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас

авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /  
РД:УП...../

41. Шүүгдэгч Б овгийн А.Сү: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., нөхөр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УМ...../

42. Шүүгдэгч О овгийн О.Уя: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Увс аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, 23 настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, "К" ББСБ-д теллер ажилтай, ам бүл..., эх, ахын хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:ОЮ...../

43. Шүүгдэгч Б овгийн Б.Мө: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Төв аймагт төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Төв аймгийн ...сум ...дугаар баг ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:НЭ...../

44. Шүүгдэгч Б овгийн С.Га: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, М сургуулийн 4 дүгээр дамжааны оюутан, ам бүл ..., эцэг, эх, дүү нарын хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УП...../

45. Шүүгдэгч Б овгийн Б.Пү: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Сэлэнгэ аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:МВ...../

46. Шүүгдэгч Б овгийн М.Би: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УХ

...../

47. Шүүгдэгч Б овгийн М.Бо: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, "Н" ХХК-д кассын нярав ажилтай, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УП...../

48. Шүүгдэгч Б овгийн Б.Ар: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, зочид буудал, зоогийн газрын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Төв аймгийн ...сум ...дугаар баг ...гэх газар суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:НЗ...../

49. Шүүгдэгч Т овгийн Б.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:СФ...../

50. Шүүгдэгч Б овгийн Э.Бү: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, олон улсын худалдааны менежер мэргэжилтэй, "Д" ХХК-д менежер ажилтай, ам бүл..., эх, дүүгийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороолол ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УП...../

51. Шүүгдэгч: Ж овгийн Д.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:СЭ...../

52. Шүүгдэгч И овгийн Ч.Тэ: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, бизнесийн удирдлагын менежер мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эмээ, ахын хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял

шийтгэлгүй, /РД:УЗ...../

53. Шүүгдэгч Б овгийн Э.Ба: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Багануур дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:НЧ...../

54. Шүүгдэгч М овгийн З.Эн: Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эцэг, эх, дүү нарын хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагнал, ял шийтгэлгүй, /РД:УХ...../

Холбогдсон хэргийн талаар:

1. Шүүгдэгч Б.Жа нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байхдаа 2011 оны 01 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд давтан үйлдлээр, хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс "унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө" гэж албан тушаалын хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амалж тус сургуулийн оюутнуудаас бусдаар дамжуулан нийт 26.890.000 төгрөгийн буюу их хэмжээний хээл хахууль авсан,

2. Шүүгдэгч Н.НА нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч М.Мө нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Б.Ба нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Г.ГҮ нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч С.Пү нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн

сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Ц.Ня нь бусадтай бүлэглэн, давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Г.Чи нь давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

3. Шүүгдэгч С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Бо, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Э.Ур, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.Уя, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү, Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нар Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д хээл хахууль өгсөн, шүүгдэгч Э.Ба давтан үйлдлээр Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д хээл хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүгдэгч Г.Жа-аас шүүхийн хэлэлцүүлэгт болон мөрдөн байцаалтын шатанд мэдүүлсэн: Миний хувьд оюутнуудаас мөнгө төгрөг авч хичээлийн дүнг нь зассан асуудал байхгүй. Өөрөөр хэлбэл, би ямар нэгэн оюутны хичээлийн дүнг зассан асуудал байхгүй. 2011 оны хавар 04 сарын орчим манай найз С.Пү-гийн танил гэх манай сургуулийн оюутан Г.ГҮ гэх оюутан надтай уулзаад -Нэлээн хэдэн хичээл дээр унасан хичээлийн дүнгээ засаад өгөөч гэж гуйсан, би тэр үед нь болохгүй, кредитын мөнгөө төлөөд хичээлээ судлаад дүнгээ засуул гэж хэлсэн. Үүний дараа дахин Г.ГҮ надаас унасан хичээлийн дүнгээ засаад өг гэж гуйсан би тэр үед нь сүлжээгээр орж түүний дүнг харсан, гэхдээ засаж өгсөн асуудал байхгүй. Тэгээд ч удаагүй манай сургуулийн сервер эвдэрч дүнгийн мэдээлэл бүхий программ ажиллах боломжгүй болсон. 2011 оны 04 дүгээр сард Г.ГҮ надаас дахин -Манай найзуудын унасан хичээлийн дүнг засаад өгөөч гэж гуйхад -Би хараад өгье гэж хэлээд харж амжаагүй, хичээл сургууль амарсан. Тэгээд намар нь ирээд 2012 оны 09 дүгээр сард би Худалдааны Сургуулийн сургалтын албаны даргын албан тушаалаас чөлөөлөгдөж тус сургуулийнхаа Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн эрхлэгчээр томилогдсон. Г.ГҮ-гээс өөр надад хандаж

унасан хичээлийн дүн засаад гэсэн өөр хүн байхгүй. Г.ГҮ бид хоёрын хооронд оюутнуудын хичлээлийн дүн засахаар мөнгө төгрөг өгч авалцсан зүйл байхгүй. /2 хх-166/ Би бусдаас хээл хахууль аваагүй гэсэн мэдүүлэг,

Шүүгдэгч Г.ГҮ-гээс шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн: Би Монгол Улсын Их сургуулийн худалдаа үйлдвэрлэлийн сургуулийн 3 дугаар курсийн оюутан байхдаа сургуулийн клуб болон компанид ажиллаж байсан болохоор хэд хэдэн хичээл дээр муу үнэлгээ авсан. Намайг анх сургуульд орж ирэхэд дүн засаж болдог тухай яриа гардаг байсан. Би ахын найз болох Б.Жа-т та миний унасан хичээлийн дүн засаад өгөөч гэсэн хүсэлт тавихад харж өгье гэж хэлсэн. Тэгээд хэд хоногийн дараа үзэхэд миний дүн засагдсан байсан. Би хүний нөөц гэдэг хичээл дээр Б.Ба, С.Эн, Ч.Ба гуравтай цуг суудаг байхдаа унасан хичээлийн дүн засуулсан талаар хэлж өгсөн. Үүнээс хойш Б.Ба, С.Эн, Ч.Ба болон С.Пү өөрийнхөө найзын дүнг засуулья гэж хэлж байсан. Бас Ц.Ня-д хэлэхэд тэр дүнгээ засуулья гэж хэлсэн. Тэгээд дээрх хүмүүс дүнгээ засуулах хүсэлтийг надад тавьсан. Би Б.Жа ахад манай найзуудын дүнг засаад өгөөч гэсэн хүсэлтийг тавихад за байж бай би үзээд өгье гэж хэлсэн. Тухайн үед би С.Эн-гаар дамжуулан Б.Ца, Н.Ою нарын дүнийг нь өгсөн. Б.Ба-гаас Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Би нар дүнгээ засуулах гэсэн хүсэлтийг нь хүлээн авч дүнгийн хуудсыг нь дамжуулж өгсөн юм. Б.Мя, Э.Ба, Б.Чу, Э.Ур, Б.Баа нарын дүнгийн хуулбарыг Ц.Ня-гоос, С.Пү-гоос Г.Од нарын дүнгээ засуулах мөнгийг авч дамжуулж өгсөн үйлдэл хийсэн. Хүүхдүүдийн өгсөн мөнгөнөөс авч хувьдаа авсан зүйл байхгүй. Харин яллах дүгнэлтэд байгаа Э.Бү гэдэг хүүхдийг танихгүй, дүнийг нь засуулахаар мөнгийг нь дамжуулж өгөөгүй. Би мөнгө өгч дүн засуулах гэсэн нийт 18-н хүүхэд байна гэж Б.Жа-т хэлсэн. Мөнгийг Б.Жа-т хүүхдүүдийн мөнгө өгсөн дарааллаар нь 2 хувааж өгсөн. 2012 оны хавар оюутнууд шалгалтадаа орж чадахгүй болоход Б.Жа ах нь дүнийг нь засаж чадахгүй нь гэж хэлээд хүүхдүүдээс авсан мөнгийг нь буцааж өгсөн. Би үүнийг ээжтэйгээ хамт хүүхдүүдэд нь буцааж өгсөн баримтыг хавтаст хэрэгт хавсаргасан байгаа гэсэн мэдүүлэг.

Шүүгдэгч Г.Чи-гээс шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн: Би Худалдааны сургуулийн 3 дугаар курст сурж байгаад өвлийн амралт эхлэхэд манай ангийн П, З.Ня

хоёр амраад Эрдэнэт, Баруунхараа руу гэр лүүгээ явсан. П, З.Ня хоёр нь 4-6 хичээл дээр унасан байсан. Надад хичээлээ дахин судлах гэсэн юм кредитийн мөнгийг нь Б.Жа-т өгөөд хичээлээ дахин судалъя гэж хэлсэн. Дээрх хоёр миний данс руу нэг өдрийн дотор 400.000, 400.000 төгрөг шилжүүлсэн. Би мөнгийг нь аваад Б.Жа-т унасан хичээлийн кредитийн мөнгө хичээлээ манай хоёр найз дахин судлах гэж байгаа юм гэж хэлж өгсөн. Түүнээс би Б.Жа-ийг авлига авч байсныг мэдээгүй. Кредитийн мөнгө авч хүүхдийн дүн засаж байна гэж бодсон гэсэн мэдүүлэг.

Шүүгдэгч Э.Ба-оос шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн: Намайг 3 дугаар курст сурч байхад манай ангийн Ц.Ня над дээр ирээд сургуулийнхаа багш нарт бэлэг авч өгье гэж хэлсэн. Би бэлэг аваад өгвөл бид нарын дүнг сайн гаргаж өгөх байх гэж бодсон. Тэгээд Ц.Ня-гоор дамжуулж Г.ГҮ-ид мөнгө өгсөн. 2012 оны 03 дугаар сард М.Мө мөнгө өгч дүн засуулдаг талаар ярьж байсан. Гэхдээ би М.Мө-ад 620.000 төгрөг өгөөгүй. Би дүн засуулах гэж мөнгө өгөөгүй гэсэн мэдүүлэг.

Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн кримналистикийн шинжээчийн 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 221 дугаартай шинжилгээнд ирүүлсэн А4 бичгийн цаасан дээр наасан 15 хүний нэрс бүхий 7.9x12.1 хэмжээтэй тэмдэглэлийн дэвтрийн хуудас дээр хар хөх өнгийн будагч бүхий бичгийн хэрэгсэл ашиглан "НОТ2060. Э.Ба..." гэж эхлээд "...M1C1081. Г.Од" гэж дуусгасан гар бичмэл нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн Б.ЖА-ийн гэх бичгийн хэвийн загваруудтай тохирч байна гэсэн дүгнэлт /1хх 171-180/

ШУТИС-ийн мэргэжилтнүүдийн хууль санаж гаргасан дүгнэлтэд: 2012 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Худалдааны сургуулийн бүх компьютерүүд бүгд нэг гадаад IP хаягаар интернет рүү орж болон гардаг. Тэгэхээр энэ нь сургууль дотроос сервер рүү бүх компьютер нэг хаягаар хандана гэсэн үг -Мөн Худалдааны сургуулийн дотоод сүлжээн дэх бүх компьютерүүд динамикаар IP хаягаа авдаг /унтраад асах үед компьютерүүд нь аль нэг дурын сул IP хаягийг авч интернетэд ордог/

-Сургуулийн үндсэн шилэн кабелиас интернет хувиарлихдаа manage switch ашигласан бөгөөд manage switch-ийн нэмэлт тохиргоог хийж өгөөгүй байгаа нь мэдээллийн урсгалыг бүртгэх боломжгүйд хүрсэн

-Дүнгийн лог дээр зассан мэдээлэл байгаа боловч ямар кодтой хэрэглэгч зассан тухай мэдээлэл байхгүй

-Дүн зассан логийн огноонуудыг авч вэб рүү хандсан access лог дээрх огноонуудтай харьцуулж үзэхэд 202.5.199.2., 202.5.199.2. гэсэн IP хаягуудаас хандсан болохыг тогтоосон. Энэхүү хаягууд нь Худалдааны сургуулийн гадаад IP хаяг бөгөөд сургууль доторх бүх компьютер энэхүү хаягаар серверрүү ханддаг учир хэн гэдэг хүн яг аль өрөөнөөс зассан гэдгийг мэдэх боломжгүй болж арга мухардсан болно.

-Мөн session лог дээрээс тухайн үед хэн гэдэг хэрэглэгч программд байсан болохыг харж болох боловч энэ нь тухайн хэрэглэгч дүн яг зассан гэж нотлоход хангалттай бус гэж үзэж байна гэсэн дүгнэлт /2 хх 68-71/

Шинжээч Б.Н-гаас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Шинжилгээ хийлгэх тухай тогтоолын дагуу бакалаврын сургалтын албаны мэргэжилтэн Т.Б бид 2 Худалдааны сургууль дээр 6 өдөр ажиллаж оюутнуудаас асуулга авах, ярилцлага хийх, баримт шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг ашигласан. Оюутнуудын асуулга болон ярилцлагад үндэслэн Б.Ба, Г.ГҮ, М.Мө, С.Пү нар оюутнуудын дүнгээ засуулахаар өгсөн мөнгийг Б.ЖА-д дамжуулан өгч байжээ гэж үзсэн. Ажлын явцад Г.ГҮ, Б.Ба нар нэр бүхий оюутнуудын хүсэлтээр хичээлийн дүнгээ засуулахаар өгсөн мөнгийг Б.ЖА-д дамжуулан өгсөн гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Шинжилгээний ажлын явцад 2010, 2011, 2012 uniface мэдээллийн системээс дүн хэвлэгдсэн 38 оюутны дүн давхцаж буй хичээлийн жилийн дүнд анализ хийсэн. Гэхдээ тус сургуулийн сургалтын албаны мэргэжилтэн А зарим оюутны дүнгийн мэдээлэл засагдсан гэдгийг мэдээд эргүүлж байранд нь оруулсан байсан тул зарим оюутны дүн буцаж хэвэндээ орж өөрчлөгдсөн болохоор байна гэсэн мэдүүлэг /1хх 187-188/

Шинжээч Т.Б-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Хуучнаар Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль нь 2011 оны 09 дүгээр сараас Монгол Улсын Их сургуулийн салбар болж хамаарагдах болсон. Худалдааны сургуулийн оюутнуудын дүнгийн мэдээллийн программ, архив эмх цэгц, хадгалалт муутай учир дүгнэлт хийхэд хүндрэлтэй байна. н.Н бид 2 шинжилгээний явцад тус сургуулийн оюутнуудаас санал асуулга авахад оюутнууд унасан хичээлийн дүнгээ мөнгөөр засуулах асуудал

хавтгайрсан гэх мэдээлэл ирсэн. Оюутнууд өөрсдийн унасан хичээлийн дүнгээ ном журмын дагуу засуулах үедээ кредит цагийн мөнгөө төлж хичээлээ нөхөн судлаад дахин шалгалт өгөөд засуулах ёстой. Сургалтын албаны мэргэжилтэн А мөнгөөр дүнгээ засуулсан байсан зарим хүүхдийн засагдсан дүнг буцааж хуучин хэвэнд нь оруулсан учир дүгнэлт хийхэд хүндрэлтэй байлаа. Иймд оюутнууд өөрсдөө унасан хичээлийн дүнгээ мөнгөөр засуулсан гэж мэдүүлж байгаа бол түүнийг үнэн гэж үзэх ёстой. 2012 оны хичээлийн шинэ жилээс манай сургуулийн дүнгийн мэдээллийн программд хамрагдсан учир дүнг хууль бусаар засуулах боломжгүй болсон... гэсэн мэдүүлэг /1 хх 189/

Гэрч Ц.На-аас мөрдөн байцаалтад мэдүүлэн: Би 2012 оны 01 дүгээр сарын 26-ны орчмоос Худалдааны сургуулийн сургалтын албаны программыг хариуцан ажиллах үед сүлжээ нь Стар софт гэж программ зохиосон компани дээрээ засвартай байсан ба 2012 оны 01 дүгээр сарын сүүлээр засагдаж ирсэн. Намайг дээрх программыг хүлээн авахаас өмнө өдрийн ангийн оюутнуудын дүнгийн мэдээлэл рүү Сургалтын албаны дарга Б.Жа, мэргэжилтэн А, сургалт хариуцсан захирал Д, сургуулийн захирал нар нэвтэрч дүнгийн мэдээллийг өөрчлөх боломжтой байсан. Программ засагдаад ирэх үед А багш надад "Б.Жа-ийг дүнгийн программд нэвтрүүлдэггүй болгомоор байна, эрхийг хаамаар байна" гэхээр нь Б.Жа, Д нарын дүнгийн программд нэвтрэх эрхийг 1 дүгээр сарын сүүлээр хаасан. Б.Жа 2012 оны 01 дүгээр сарын сүүлээр Худалдааны сургуулийн оюутнуудын дүнгийн мэдээллийг өөрчлөх эрхтэй байсан. Мөн 2012 оны 01 дүгээр сарын 26-ныг хүртэл программ засвартай байсан учир Б.Жа нэвтрэх эрхтэй байсан. 2012 оны 01 дүгээр сарын сүүлээр программд ганц А багш нэвтрэх эрхтэй байсан, өөр хүн нэвтрэх боломжгүй байсан. Намайг программ судлах 14 хоногийн хугацаанд Б.Жа программд нэвтрэх дүнгийн мэдээлэл солих боломжтой байсан... гэсэн мэдүүлэг /1хх 214/

Гэрч Г.А-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Миний ажлын чиг үүргийн тухайд оюутнуудын дүнг нэгтгэж шалгалтад оруулах, өртэй оюутнуудад мэдэгдэл хүргүүлэх, дүнгийн мэдээллийг хянах зэрэг юм. Оюутнуудын дүнгийн мэдээллийг тухайн дүн тавьсан багш нар өөрийн кодоор программд байршуулдаг. Манай сургуульд үйлчилж байгаа журмаар хичээлдээ амжилтгүй дүн

үзүүлсэн буюу шалгалтандаа унасан оюутан кредит цагийн төлбөрөө төлөөд дахин хичээлээ үзэж дахин шалгалт өгч дүнгээ засуулдаг. Энэ тохиолдолд би админы эрхээр программд нэвтэрч ороод өмнөх дүнг арилгаж, дараагийн дүнг баталгаажуулдаг. Албан ёсоор кредит цагийн мөнгөө төлж дахин хичээлээ үзээгүй, шалгалт өгөөгүй оюутны тухайд дүнг засуулах ойлголт байхгүй. Б.Жа сургалтын албаны дарга байхдаа сургалтын программд нэвтрэх эрхтэй байсан. Б.Жа 2012 оны 04 дүгээр сарын 27-ны орой 21 цагийн орчим намайг ажлаас тараад гарч байхад сургуулийн үүдэнд таараад “А эгчээ энэ хүүхдүүд шалгалтанд орохгүй юм уу” гээд нэг хуудас оюутнуудын нэр, код бичсэн цаас өгсөн. Би ажил тарж байсан учир уг цаасыг нь авч яваад маргааш нь ажил дээрээ ирээд нөгөө Б.Жа-гийн өгсөн цаасан дээр бичсэн оюутнуудын дүнгийн байдлыг шүүж үзэхэд дандаа шалгалтын өртэй, ерөнхийдөө хоёр дээш муу дүн авсан /F/ үнэлгээтэй оюутнууд байсан. Б.Жа надад нэрс бүхий цаас өгснөөс дахин уулзаж яриагүй. Би Б.Би-ий дүнгийн мэдээлэл өөрчлөгдсөнийг улсын шалгалтад оруулах үедээ мэдсэн юм. Өмнө хэвлэж аваад хувийн хэрэгт хийсэн байсан дүнг нь программд байгаа дүнтэй нь харьцуулж үзэхэд өөрчлөгдсөн байсан. Миний санаж байгаагаар 10 гаран оюутны дүнг зассан байсан.

Манай сургуульд сурч байгаад МУИС-ийн эдийн засгийн сургууль руу шилжсэн С.Га гэж оюутан 2012 оны 03 дугаар сарын орчим надтай ирж уулзаад та миний дүнг МУИС руу буруу явуулсан байна гээд дүнгийн мэдээллийн программ дээр байгаа дүнгээс өөр дүнгийн хавтгай барьсан ирсэн. Би тэр үед яагаад чиний дүн программ дээр байгаа дүнгээс өөр байгаа юм бэ гэсэн чинь чимээгүй нүүр нь улайгаад гараад явсан. Би энэ үед дүнгийн мэдээлэл рүү Б.Жа ороод дүн засаад байгаа юм биш байгаа гэж бодоод тэр өдөрт нь сүлжээ хариуцсан мэргэжилтэн Наранбаатартай уулзаж Б.Жа-ийн админ эрхийг хаагаагүй юм биш биз гэхэд нэг их юм хэлээгүй компьютерээ хараад үлдсэн... гэсэн мэдүүлэг /1хх 216-220/

Гэрч Б.Ба-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Г.Гү надад 2011 оны намар буюу бид нар 3-р курсэд суралцаж байх үед чи дүнгээ засуулахгүй юм уу, дүн засах боломж байна гэж хэлсэн би тэр үед нь дүн засуулж болдог юм уу гэхэд болдог юмаа

найдвартай гэж хэлсэн тэгээд бид хоёрын яриа дуусаад салсан. 2011 оны өвөл манай ангийнхан дүнгээ яаж засуулах гэсэн яриа гараад надаас манай ангийн оюутан Б.Бо, Г.Ур нар Г.Гү-ийн утасны дугаарыг авсан. Манай нөгөө ангид сурдаг Б.Би надтай ирж уулзаад дүн засуулах талаар хандсан. Би тэгэхээр нь Г.Гү засна гэсэн гэдгийг хэлсэн. Б.Би надаас Г.Гү-ийн утасны дугаар авсан, Үүний дараа 1 сар орчмын дараа Б.Би-тэй сургууль дотор таараад түүнийг дагаж гараад сургуулийн гадаа байсан Г.Гү-ийн машинд хамт очсон. Бид хоёрыг очиход Г.Гү машин дотроо ганцаараа сууж байсан Б.Би бид 2 хойд суудал дээр хамт суугаад Б.Би найдвартай биз дээ хэнээр янзлуулах вэ гэхэд найдвартай гээд хэнээр дүнгийн нь янзлуулахаа хэлээгүй. Тэр үед Б.Би Г.Гү-д дугтуйтай зүйл өгсөн. Би дугтуйн доторхи зүйлийг хараагүй ба дүн засуулахад өгч байгаа мөнгө гэж ойлгосон. Сургалтын албаны Б.Жа дүн засдаг оюутнуудын амнаас сонсож байсан. Г.Гү-ийн ээж нь надруу яриад Г.Гү-д мөнгө өгсөн танай ангийн хүүхдүүдтэй уулзаж мөнгийг нь буцааж өгөх шаардлагатай байна гэж хэлсэн.

Г.Гү-д Б.Бо, Б.Би, Г.Ур, Б.Цэ нарыг нөгөө ангийн М.Мө-д М.Бо, За, Б.Пү, Д.Ба, Д.Чи, М.Бу, И.До, Б.Мө нарыг олж өгсөн. Би М.Мө нарт олж өгсөн зарим оюутнуудын мөнгөнөөс дундаас нь 50.000-100.000 төгрөг авч байсан. Дээрх М.Мө-д мөнгө өгсөн 8 хүүхдийн дүн засагдаагүй. Б.Жа өмнө жил буюу 2011 онд өөрөө сургалтын албанд ажиллаж байсан учир дүн засаж чадаж байсан, 2012 онд ажил нь өөрчлөгдсөн учир энэ жилийн 8 хүүхдийн дүнг засаж чадаагүй. Г.Гү-д өгсөн 4 оюутны Б.Цэ-ээс бусад 3 хүүхдүүдийн дүн засагдсан байсан. Сургалтын албанаас хүүхдүүдийн дүн зассан гэдэг асуудал үүссэний дараа хүүхдүүд надаас мөнгөө нэхсэн учир би М.Бо, За, Д.Чи, Б.Пү, М.Бу нарт авсан бүх мөнгөө буцааж өгсөн, харин Д.Ба-д 400.000 төгрөг, И.До-т 400.000 төгрөг тус тус өгсөн, Б.Мө-т мөнгийг нь буцаан өгч амжаагүй. Би ээж аав 2-т үнэн байдлаа хэлээд ээжээс 2.500.000 төгрөг, ааваас 1.500.000 төгрөг, эгч Мөн-ээс 500.000 төгрөг аваад хүүхдүүдийн мөнгийг буцааж өгсөн.

2011 оны 11 сарын орчим манай ангийн М.Бу-ын надад хичээлийн дүнгээ засуулахаар 700.000 төгрөг өгсөн. Би өмнө өгсөн мэдүүлгүүд дээр Х.Бу гэж хүүхдийн хичээлийн дүнгээ засуулахаар өгсөн 600.000 төгрөгийн тухай асуудлыг мартсан байна.

Х.Бу 2011 оны хавар надад 600.000 төгрөг өгснийг би тэр үед нь Г.ГҮ-д өгсөн... гэсэн мэдүүлэг /1 хх 223-224, 246/

Гэрч М.Мө-ээс мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Би нийт 17 оюутнаас 11 сая төгрөг авч дүнгийн засуулахаар өөрийн танил М гэх залуугаар дамжуулан манай сургуулийн сургалтын албаны ажилтан Б.Жа-т өгүүлсэн. М гэдэг нь Б.Жа-ийн аавынх нь лам гээд Шашны дээд сургууль төгссөн хүн байдаг. 2011 оны 09 сарын орчим М надад танай сургуулийн сургалтын албаны ажилтан Б.Жа-ийг сайн танина гэж байсан. М надад тухайн үед дүнгээ засуулах оюутнууд байгаа юу дүнг нь засуулж болно шүү дээ гэж хэлсэн. Б.Мө-гөөс 2011 оны намар буюу 09 сарын эхээр С.Пү-ийн хамт Спортын төв ордны ХААН банкны гадаа уулзаж дансаар шилжүүлүүлж авсан. Э.Ор-той хамт 2011 оны 09 сарын эхээр уулзаж бид 2 Сонор плаза руу хамт явж миний данс руу мөнгөө шилжүүлсэн. С.Га бид 2 мөн 2011 оны 09 сарын эхээр хамт явж Ахуйн үйлчилгээний ХААН банкнаас мөн миний данс руу тушаасан. Б.Со мөн 2012 оны 03 сарын орчим миний данс руу өөрөө над руу шилжүүлсэн. М.Ма 2012 оны 02 сарын орчим мөн өөрөө миний данс руу шилжүүлсэн. З.Эн 2012 оны 04 сарын дундуур надад Хүнсний 4-р дэлгүүрийн урд талд байрладаг Гейт ресторанд авчирч өгсөн. Ч.Тэ-г 2011 оны 12 сард сургуулийн гадаа өөрийн машин дотроо надад мөнгөө өгсөн. Ц.Ба-гаас 2011 оны 12 сарын орчим А.Мө-аас мөнгө авсан үед л авсан. Б.Ан-гаас 2012 оны 04 сарын дундуур Спортын төв ордны хажууд уулзаад бэлнээр авсан, мөнгө авах үед А.Сү Б.Ан-гийн хамт байсан. А.Сү үүнээс хэд хоногийн дараа энэ оны 04 сарын сүүлээр мөнгөө цувуулж өгсөн. М.Ца 2012.04 сарын сүүлээр мөнгөө дансаар цувуулж өгсөн юм байна. Б.Но 2012 оны 03 сард сургуулийн урд талын Холидэй бааранд Мандаа бид 2-ыг сууж байхад мөнгөө бэлнээр ганцаараа авчирч өгсөн. Н.Ба-ийн 2012 оны 04 сарын дундуур билүү сүүлээр Макс моллын гаднаас би өөрөө очиж авсан ба би тухайн үед ангийнхаа Э-тэй хамт очиж авсан. 2011 оны 11 сарын сүүлээр намайг Мон Алтиус дээд сургуулийн хойд талын кафед намайг хоол идээд сууж байхад Э.Ба дүнгээ засуулах 620.000 төгрөгөө авчирч өгсөн. Би дээрх оюутнуудаас хүлээн авсан мөнгөө тэр өдөрт нь М-д утасдаж хэлээд М ирээд авдаг байсан. Би Б.Мө-гөөс авсан мөнгөнөөс 100.000 төгрөг, Ч.Тэ-гийн мөнгөнөөс мөн

120.000 төгрөг, М.Би-н мөнгөнөөс 100.000 төгрөг, Н.Ба-ийн мөнгөнөөс 100.000 төгрөг, Э.Ба-ийн мөнгөнөөс 120.000 төгрөг суутган аваад үлдсэн мөнгийг М-д өгсөн. Бусад оюутнуудын мөнгийг бүрэн хүлээлгэн өгсөн.

Энэ асуудалд олон хүүхэд оролцуулахгүй гэдэг үүднээс зарим нэг хүүхдийн нэрийг хэлээгүй юм. С.Пү надад мөнгөөр дүн засуулах 5 оюутан, Б.Ба 8 оюутан олж өгсөн. Би өмнө мэдүүлэг өгөхдөө С.Пү-ийн 5 оюутнаас нэгийг нь хэлээд үлдсэн 4-ийг нь хэлээгүй, Б.Ба-ын 8 оюутанг бүгдийг хэлээгүй. Дээрх 29 оюутны бүгдийнх нь дүн засагдаагүй, цөөн хэдэн хүүхдийн дүн засагдсан, би хэдэн хүүхдийн дүн засагдсан гэдгийг хэлж мэдэхгүй байна. Би М-д мөнгийг тухай бүр нь дуудаад өгдөг байсан ба бүх мөнгийг бэлнээр хүлээлгэн өгсөн.

Б.Ба, С.Пү хоёр намайг М-гээр дамжуулан Б.Жа мөнгө өгч оюутнуудын хичээлийн дүнг засуулдаг гэдгийг мэдэж байсан, би Б.Ба С.Пү хоёртоо хамт байхдаа манай гэрт болон М-гийн гэрт оюутнуудаас авсан мөнгийг М-д өгч байхад хамт байлцаж байсан тохиолдол байгаа. Би Б.Ба С.Пү хоёрт оюутнуудаас авсан мөнгийг М-гаар дамжуулан Б.Жа өгч дүн засуулна гэдгээ хэлж байсан, энэ хоёр асуудлыг сайн мэдэж байсан. Би Б.Ба С.Пү хоёроос өөр оюутнаар дүнгээ засуулах оюутнууд олуулж байгаагүй, би энэ хоёртой харьцаж байсан... гэсэн мэдүүлэг /1 хх 226-231/

Гэрч Б.Т-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Миний хүү Г.ГҮ 2008 оноос МУИС-ийн Худалдааны сургуульд суралцаж байгаа, энэ жил сургуулиа төгсөх байсан ба хүү маань ээжээ таньд үнэнээ хэлэхгүй бол болохгүй нь, би өөрийн унасан хичээлийн дүнгээ Сургалтын албаны даргаа гуйгаад янзлуулсан байсныг манай сургуулийнхан мэдээд надаас дүнгээ янзлуулахыг гуйхаар нь би мөнгийг нь дамжуулаад өгсөн чинь энэ асуудал баригдаад мөнгө өгсөн бүх хүүхдүүд мөнгөө нэхээд байна, мөнгө өгч дүнгээ засуулсан хүүхдүүдийг шалгалтад оруулахгүй байна гэж хэлсэн. Хүүгээ ингэж хэлэхээр нь тэр оройдoo хүүгээрээ Сургалтын албаны дарга гэх Б.Жа гэж хүнийх нь байрыг заалгаад очиход тэр өдөртөө уулзаж чадаагүй, хаалгаа тайлаагүй. Маргааш нь ирээд гадаа хүлээгээд байж байтал Б.Жа гэх залуу машинтай гаднаас орж ирээд миний машины ар талд зогссон. Би учир байдлаа хэлээд уулзья гэхэд би эхнэрээ оруулж өгөөд ирье гээд тухайн үед

хамт явж байсан жирэмсэн эмэгтэйтэй хамт орцондоо орсон. Эргэж гарч ирээд надтай уулзахдаа Б.Жа би өмнө Сургалтын албаны даргаар ажиллаж байхдаа танай хүүхдээр дамжуулан хүүхдүүдээс мөнгө төгрөг авч хичээлийн дүнг засаж байсан юм, намайг манай болон энэ олон хүүхдүүдийг яах юм бэ гэхэд за би яахав яриадхая гээд өөрийн сургуулийн сургалтын албаны мэргэжилтэн А гэж хүнтэй утасныхаа чанга яригч дээр тавиад ярихад нөгөө А гэж хүн нь би чамаас мөнгө төгрөг авч хүүхдүүдийн хичээлийн дүнг засаагүй шүү гэж хэлж байсан. Б.Жа надад шалгалтанд оруулахгүй хүүхдүүдийг дахин комисс томилоод шалгалт авч болдог юм байна гээд байсан. Би хүүгээсээ хэдэн хүүхдийн хэдэн төгрөгийг багшдаа дамжуулан өгснийг тодруулахад санахгүй байна гэсэн. Би хүүгээрээ дамжуулан 17 оюутны мөнгө хүлээн авсан баримтыг танд хүргүүлсэн... гэсэн мэдүүлэг /1 хх 233/

Гэрч Э.Бү-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Манай ангийн С.Пү хүүхдүүдийн унасан хичээлийн дүнг засаж байгаа гэж сонсоод түүнтэй уулзаад ярьж байгаад 450.000 төгрөгөөр хоёр хичээлийн дүнгээ засуулахаар тохирсон. Би тухайн үед дараа нь ямар нэг асуудал гарвал яах вэ гэж асуухад, ямар ч асуудал байхгүй Сургалтын албаны Б.Жа өөрөө засна гэж байсан тул итгээд өөрийн зун ажил хийж хуримтлуулсан 450.000 төгрөгөө С.Пү-д хүлээлгэн өгсөн... гэсэн мэдүүлэг /1 хх 234/

Гэрч Э.Ур-гоос мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Манай нөгөө ангийн оюутан Ц.Ня, Б.Жа бага мөнгөөр унасан хичээлийн дүн засаж байгаа гэнэ чи дүнгээ засуулахгүй юм уу гэж асуусан. Би ямар үнээр засахыг нь асуугаад 10 хичээлийн дүнгээ 450.000 төгрөгөөр засуулахаар тохирсон. 2011 оны өвөл 3-р курсын эхний семестр дуусах гэж байхад сургуулийн 00 өрөөнд Ц.Ня-д бэлнээр хүлээлгэн өгсөн. Ц.Ня бид нараас авсан мөнгөө цааш нь Г.Гү гэж хүүхдэд өгөөд тэр нь цаашаа Б.Жа багш өгдөг гэж байсан.. гэсэн мэдүүлэг /1 хх 237/

Гэрч Э.Пү-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Г.Чи бид нар дотно найзууд учир Г.Чи надад туслана гээд миний унасан хичээлүүдийн дүнг засуулж өгүүлэх талаар Б.Жа-т хэлж өгнө гэж байсан. 2012 оны 02-03 сарын орчим 400.000 төгрөг шилжүүлсэн. Мөнгө шилжүүлснээс хойш нилээн удаж байгаад 2012 оны 04 сарын орчим миний унасан 4 хичээлийн дүн бүгд засагдсан гэсэн

мэдүүлэг /1хх 239-240/

Гэрч Э.Ба-оос мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Нөгөө ангийн М.Мө-ад мөнгө төгрөг өгч унасан хичээлүүдийн дүнгээ засуулсан гэдгийг сонссон. Би М.Мө-ад 10 гаран унасан хичээлийн асуудал байгаа гэдгээ хэлэхэд чи 620.000 төгрөг өгчих тэгвэл асуудал байхгүй шийдвэрлээд энэ жил төгсөнө, Б.Жа, А багш хоёр өөрсдөө засна гэсэн. Надад тухайн үед бэлэн мөнгө байсан учир би түүнд 620.000 төгрөгийг бэлнээр өгсөн. 2012.04.05-ны өдөр намайг сүлжээгээр орж дүнгээ харахад миний унасан 12 хичээлийн дүн засагдсан байсан. 2012.04.20-ны үед засагдсан байсан бүх хуучин хэвэндээ орж дүн зассан гэх асуудал үүссэн. Би тэгэхээр нь М.Мө-тай уулзаад А багш энэ асуудлыг илрүүлээд байна ш дээ юу болоод байгаан бэ гэхэд би тодруулна гээд дахин харьцаагүй.. гэсэн мэдүүлэг /1 хх 242/

Гэрч П.Бя-оос мөрдөн байцаалтад мэдүүлсэн: 2011.09.10-ны өдөр буюу М.Мө ахын төрсөн өдрөөр нь М.Мө ах М бид нар Өргөө кино театрын урд талын байрнуудын өмнө явж байхад М.Мө ах М-д 2 сая төгрөг өгсөн. Тэр 2 хоорондоо М.Мө ахын сургуулийн оюутнуудын хичээлийн дүнгээ засуулахаар өгсөн мөнгийг сургалтын албаны дарга Ж гэж хүнд дамжуулан өгч байна гэж ойлгосон. Тэгээд М Ж-д мөнгөө өгнө гээд 3-р хорооллын урд талын байрны гадаа машинд уулзсан бид нар зайтайхан газар зогсоод харж байсан... гэсэн мэдүүлэг /1 хх 243/

Гэрч О.Э-өөс мөрдөн байцаалтад мэдүүлсэн: 2011.09.10-ны өдөр М.Мө М-д оюутнуудын хичээлийн дүнгээ засуулахаар өгсөн 2 сая орчим төгрөгийг хүлээлгэн өгсөн. М бид нартай хамт машин дотор явж байхдаа Б.Жа-тэй уулзана гээд 3-р хорооллын орчим зогсож байсан машин руу явчхаад эргэж ирсэн. 2012.05.10-ны өдөр М.Мө бид нарыг сургуулийн урд талын билльард дотор тоглож байхад М.Мө манай сургуулийн оюутнууд гээд 2 охиноос мөнгө хүлээн авсан... гэсэн мэдүүлэг /1 хх 244/

Гэрч Н.НА-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: М.Мө надтай 3-р хорооллын орчим утсаар ярьж байгаад ирж уулзаад чи Б.Жа-ийг таньдаг юм бол ганц хоёр хүүхдийн хичээлийн дүнг засуулаад өгөөч, мөнгө төгрөгийг нь өгнө гэж хэлсэн. Би тэгэхээр нь Ж ахаас асуугаад үзье олон хүүхдийг бол чадахгүй шүү гэж хэлсэн. Тэгээд мөн энэ яриа болсноос хойш 4-5 хоногийн дараа



би Ж ахтай утсаар ярьж М.Мө-ын саналыг дамжуулахад за яахав бодъё гэсэн. Ж ах над руу 3-4 хоногийн дараа утсаар яриад ажил дээр хүрээд ир гэхээр нь би ажил дээр нь яваад очиход нөгөө гуйгаад байсан хүүхдүүдийн чинь дүнг засаж өгч болно, та өөрөө мэдээд мөнгийг нь өгөхгүй юу гэсэн, Ж ах намайг лам хүн болохоор "та" гэж дууддаг юм. Би М.Мө-аас С.Га, Э.Ор гэж хоёр хүүхдийн хичээлийн засуулах мөнгө гэж тус бүр 500.000 төгрөгийг нийт 1 сая төгрөгийг 2011.09 сарын орчим хүлээн авч Ж ахад дамжуулан өгсөн. Би Ж ахад мөнгө өгч оюутнуудын хичээлийн дүнг засуулна гэдэг нь хууль бус гэдгийг мэдэж байсан, М.Мө-ыг гуйгаад байхаар нь Ж ахад хэлж өгсөн... гэсэн мэдүүлэг /1-р хх 248/

Гэрч Б.М.Би-гээс мөрдөн байцаалтын шатанд өгсөн: Манай ангийн хүүхдүүд нөгөө ангийн М.Мө гэж оюутанд мөнгө өгч унасан хичээлүүдийн зүнгээ засуулаад байна гэсэн учир хүүхдүүдээс М.Мө-ын утсыг аваад ярихад 6-7 орчим хичээлийн дүнг засахад 700.000 төгрөг болно гэж хэлсэн. Би түүнээс гуйж байгаад 600.000 төгрөгөөр бүх унасан хичээлүүдийн дүнгээ засуулахаар тохирсон учир түүний Худалдаа хөгжлийн банкинд дахь данс руу 2012.04.14-ний өдөр 600.000 төгрөгийг шилжүүлсэн. Мөнгө шилжүүлснээс хойш миний унасан хичээлүүдийн засагдаагүй учир М.Мө-тай уулзаж яагаад дүнг засагдахгүй байгаа талаар асуухад би мэдэхгүй Б.Жа багш өөрөө засаж байгаа гэхээр нь тэр өдрөө Б.Жа-тэй манай ангийн Б.Ан, М.Ца бид нар уулзахад Ж багш өнөөдөр оройдоо дүнг чинь оруулна улсыг шалгалтандаа маргааш ирээд ороорой гэж байсан... гэсэн мэдүүлэг /2 хх 1-2/

Гэрч Б.Бо-оос мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Би Ц.Ня-д 450.000 төгрөгийг 2011 оны 09-р сарын дундуур буюу 3-р курст байхдаа өгсөн. Мөнгө өгснөөс хойш 2 сар орчмын дараа миний унасан хичээлүүдийн дүн бүрэн засагдсан байсан ба 2012 оны хавар төгсөлтийн шалгалтанд орохын өмнөхөн миний засагдсан байсан хичээлүүдийн дүнг эргүүлж буцаан унасан байдлаар нь болгож өөрчилсөн. Ц.Ня надаас мөнгө авахдаа Б.Жа, Алтанцэцэг нар өөрсдөө янзална, найдвартай гэж байсан. Ц.Ня надаас авсан 450.000 төгрөгийг Г.ГҮ-т хүлээлгэн өгсөн ба Г.ГҮ цаашаа хэнд ямар байдлаар өгснийг үзэж харсан зүйл байхгүй... гэсэн мэдүүлэг /2 хх 3/

Гэрч Б.Мя-ээс мөрдөн байцаалтад

мэдүүлсэн: Манай найз Ц.Ня 400.000 төгрөг өгвөл унасан хичээлүүдийн дүнг чинь засуулж өгч болно гэсэн учир 2011 оны хавар буюу 3-р курсын хавар 400.000 төгрөгийг сургуулийн гадаа Ц.Ня-д хүлээлгэн өгсөн. Ц.Ня Г.ГҮ хоёртой хамт Г.ГҮ-ийн ээж гэх хүнтэй хамт очиж уулзаад 400.000 төгрөгөө буцаан авсан... гэсэн мэдүүлэг /2 хх 5/

Гэрч Г.Од-гээс мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Надад хичээлийн дүнгээ засуулах хэрэгцээ шаардлага байсан учир С.Пү-тэй уулзаж ярилцахад миний унасан бүх хичээлүүдийн дүнг засахад 650.000 төгрөг хэрэгцээтэй гэж тохирсон. Би С.Пү-д төгрөгийг 2011 оны намар сургуулийн урд талын гуанзанд бэлнээр хүлээлгэн өгсөн. Би Г.ГҮ-ийн ээжтэй уулзаж 550.000 төгрөгийг хүлээн авсан... гэсэн мэдүүлэг /2 хх 6-7/

Гэрч Б.Чу-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Манай нөгөө ангийн Ц.Ня гэдэг охин хичээлийн дүнг засахад зуучилж байна гэж сонсоод тэр охины утсыг хүүхдүүдээс олж аваад уулзахад би 10 орчим унасан хичээлийн дүнг засуулна гэхэд болно 400.000 төгрөг өгөөрэй гэж хэлсэн. Надад дүнгээ засуулах шаардлага байсан учир би түүний хэлснээр 400.000 төгрөгийг сургуулийн 00 өрөөнд Ц.Ня-д хүлээлгэн өгсөн. Сургалтын албаныхан оюутнуудын унасан хичээлүүдийн дүнг мөнгөөр зассан гэх яриа гарснаас хойш Ц.Ня нөгөө ангийн гэх нэг бандийн ээжтэй хамт ирээд Ц.Ня-д өгсөн 400.000 төгрөг хүлээн авсан... гэсэн мэдүүлэг /2 хх 8-9/

Гэрч Г.Заг-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Манай эгч Б.Ба гэж хүн дүн засахад зуучилдаг хүүхдийг таньдаг гэж байсан ба Сургалтын албаны Б.Жа гэж хүн найдвартай засагдсан гэж байсан. Тэгээд би энэ талаар буюу мөнгө өгч дүнгээ засуулах талаар ээждээ хэлж 700.000 төгрөгийг Мө эгчийн дансаар хүлээн авсан. Мө эгч ээжээс ирүүлсэн 700.000 төгрөгийг цааш нь Б.Ба гэж хүүхдэд 2012 оны цагаан сарын өмнө дамжуулан өгсөн... гэсэн мэдүүлэг /2 хх 10/

Гэрч Ч.Ба-аас мөрдөн байцаалтад мэдүүлсэн: Г.ГҮ-тэй уулзаж миний унасан 3 хичээлийн дүнг засуулж болох гэж асуухад болно өөрийнхөө одоо байгаа дүнг хэвлээд төгрөгтэй өг гэж хэлсэн. Би Г.ГҮ-тэй уулзсанаас хойш удалгүй Америк явсан учир 550.000 төгрөгөө өөрөө өгч чадаагүй. Ингээд Америкт очоод найз нартайгаа буюу С.Эн, Б.Ца нартай э-мэйлээр харьцаж байхдаа ээжээс 550.000 төгрөг авч Г.ГҮ-д өгсөн гэдгийг мэдсэн. Миний хувьд тэр өдөр

300.000 төгрөг авсан. Үүний дараа 7 орчим хоногийн дараа Г.ГҮ дахин дахин яриад хаан байна гээд сургууль дээр байна гэсэн чинь сургуулийн гадаа мөн ээжийнхээ хамт ирээд машинтайгаа ирээд 250.000 төгрөг өгсөн... гэсэн мэдүүлэг /2 хх 11-12/

Гэрч Х.Бу-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: Би өөрийн ангийн Б.Ба-аас дүнгээ дээшлүүлэх сонирхолтой байгаа гэдгээ хэлэхэд болно Сургалтын албаны Б.Жа өөрөө засна найдвартай голч оноогоо дээшлүүлэх бол 600.000 төгрөг өгөөрэй гэж хэлсэн. Ингээл би Б.Ба-ын хэлсэн 600.000 төгрөгийн үнийг хүлээн зөвшөөрөөд эмээгээсээ 600.000 төгрөг аваад Б.Ба-д сургуулийн гадаа байдаг Алтанговь хоолны газрын гадаа бэлнээр хүлээлгэн өгсөн. Улсын шалгалтын урьд өдрийн орой Г.ГҮ гэж хүүхдийн ээжээс 600.000 төгрөгөө бүрэн хүлээж авсан... гэсэн мэдүүлэг /2 хх 13-14/ болон гэрч Б.Но, Д.Чи, З.Ня, М.Бо, З.Эн, М.Ма, Б.Пү, Э.М, Б.Ан, С.Га, Б.Ар, Б.Мө, И.До, Ц.Ба, А.Сү, М.Ца, Ч.Тэ, Ц.Ня, Б.Со, Н.Ба, Э.Ор, Э.Ба, Э.Ба, Д.Ө, Д.Ба, Ж.М /2-р хх-ийн 15-59, 5 хх 75/, иргэний үнэмлэхний лавлагаа /4 хх 110-153/, ял шалгасан хуудас /7 хх 155-169/, эд мөрийн баримтыг хэрэгт хавсаргах тогтоол /2хх 214/ зэрэг нотлох баримтуудыг шинжлэн судлав.

Шүүх хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэгт авагдаж шүүх хуралдаанаар шинжлэн судлагдаж, хэлэлцэгдсэн баримтуудыг үндэслэн ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Б.Жа нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байхдаа болон дараа нь 2011 оны 01 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс "унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө" гэж албан тушаалын хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амалж тус сургуулийн оюутан С.Пү, Г.ГҮ нараар зуучлуулан Г.Од-гээс 650.000 төгрөгийн, Э.Бү-аас 450.000 төгрөг, Г.ГҮ-ээр зуучлуулан Ч.Ба-аас 550.000 төгрөг, Б.Ца-аас 400.000 төгрөг, С.Эн-гаас 550.000 төгрөг, С.Пү-оос 600.000 төгрөг, Б.Ба, М.Мө, Н.НА нараар зуучлуулан М.Бо-гээс 650.000 төгрөг, Д.Ба-аас 600.000 төгрөг, Б.Пү-аас 600.000 төгрөг, М.Бу-оос 700.000 төгрөг, Д.Чи-аас 500.000 төгрөг, Б.Мө-аас 300.000 төгрөг Ж.Ду-оос 700.000 төгрөг, Ц.Ня, Г.ГҮ нараар зуучлуулан Б.Мя-ээс 400.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, Б.Чу-аас 400.000 төгрөг,

Э.Ур-оос 450.000 төгрөг, Б.Бо-оос 450.000 төгрөг, Б.Ба-ээс 450.000 төгрөг, М.Мө, Н.НА нараар зуучлуулан З.Энаас 500.000 төгрөг, Ц.Ба-гаас 500.000 төгрөг, А.Мө-аас 500.000 төгрөг, М.Ца-аас 600.000 төгрөг, Ч.Тэ-гээс 620.000 төгрөг, Н.Ба-аас 700.000 төгрөг, С.Га-аас 600.000 төгрөг, Б.Ар-оос 600.000 төгрөг, М.Би-гээс 600.000 төгрөг, Б.Со-гаас 500.000 төгрөг, Б.Но-гоос 400.000 төгрөг, М.Ма-аас 700.000 төгрөг, Б.Ан-гаас 700.000 төгрөг, Д.Уя-аас 750.000 төгрөг, Э.Ба-оос 620.000 төгрөг, А.Сү-аас 600.000 төгрөг, Б.Ба, Г.ГҮ нараар зуучлуулан Х.Бу-ээс 600.000 төгрөг, Г.Ур-гаас 600.000 төгрөг, Б.Цэ-аас 600.000 төгрөг, Б.Бо-гаас 600.000 төгрөг, Б.Би-ээс 600.000 төгрөг, Г.ГҮ нараар зуучлуулан Н.Ою-ээс 300.000 төгрөг, С.Пү, М.Мө, Н.НА нараар зуучлуулан Э.Ор-оос 600.000 төгрөг, Б.Мө-гээс 600.000 төгрөг, Г.Чу-ээс 600.000 төгрөг, Д.О-гээс 600.000 төгрөг, Г.Чи-ээр зуучлуулан Э.Пү-аас 400.000 төгрөг, З.Ня-оос 400.000 төгрөг, Б.Ба, М.Мө, Н.НА нараар зуучлуулан И.До-оос 600.000 төгрөгийн буюу нийт 48 оюутнаас 26.890.000 төгрөгийн буюу их хэмжээний хээл хахууль авсан,

Шүүгдэгч Д овгийн Н.НА нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын "унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө" гэж 2011 оны 09 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд Б.Ба, М.Мө нартай бүлэглэн М.Бо-гээс 650.000 төгрөг, Д.Ба-аас 600.000 төгрөг, Б.Пү-аас 600.000 төгрөг, М.Бу-оос 700.000 төгрөг, Д.Чи-аас 500.000 төгрөг, Б.Мө-аас 300.000 төгрөг Ж.Ду 700.000 төгрөг, М.Мө-тай бүлэглэн З.Эн-аас 500.000 төгрөг, Ц.Ба-гаас 500.000 төгрөг, А.Мө-аас 500.000 төгрөг, М.Ца-аас 600.000 төгрөг, Ч.Тэ-гээс 620.000 төгрөг, Н.Ба-аас 700.000 төгрөг, С.Га-аас 600.000 төгрөг, Б.Ар-оос 600.000 төгрөг, М.Би-гээс 600.000 төгрөг, Б.Со-гаас 500.000 төгрөг, Б.Но-гоос 400.000 төгрөг, М.Ма-аас 700.000 төгрөг, Б.Ан-гаас 700.000 төгрөг, Д.Уя-аас 750.000 төгрөг, Э.Ба-оос 620.000 төгрөг, А.Сү-аас 600.000 төгрөг, Б.Ба, М.Мө нартай бүлэглэн И.До-оос 600.000 төгрөг, С.Пү, М.Мө нартай бүлэглэн Э.Ор-оос 600.000 төгрөг, Б.Мө-гээс 600.000 төгрөг, Г.Чу-ээс 600.000 төгрөг, Д.О-гээс 600.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч М.Мө Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан

нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2011 оны 09 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд Б.Ба, Н.НА нартай бүлэглэн М.Бо-гээс 650.000 төгрөг, Д.Ба-аас 600.000 төгрөг, Б.Пү-гаас 600.000 төгрөг, М.Бу-оос 700.000 төгрөг, Д.Чи-аас 500.000 төгрөг, Б.Мө-аас 300.000 төгрөг, Ж.Ду-оос 700.000 төгрөг, Н.НА-тай бүлэглэн З.Эн-аас 500.000 төгрөг, Ц.Ба-гаас 500.000 төгрөг, А.Мө-аас 500.000 төгрөг, М.Ца-аас 600.000 төгрөг, Ч.Тэ-гээс 620.000 төгрөг, Н.Ба-аас 700.000 төгрөг, С.Га-аас 600.000 төгрөг, Б.Ар-оос 600.000 төгрөг, М.Би-гээс 600.000 төгрөг, Б.Со-гаас 500.000 төгрөг, Б.Но-гоос 400.000 төгрөг, М.Ма-аас 700.000 төгрөг, Э.Ба-аас 620.000 төгрөг, Б.Ан-гаас 700.000 төгрөг, О.Уя-аас 750.000 төгрөг, А.Сү-гаас 600.000 төгрөг, С.Пү, Н.НА нартай бүлэглэн Э.Ор-оос 600.000 төгрөг, Б.Мө-гээс 600.000 төгрөг, Г.Чу-гээс 600.000 төгрөг, Д.О-гээс 600.000 төгрөг, Б.Ба, Н.НА-нартай бүлэглэн И.До-оос 600.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Б.Ба нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2011 оны 04 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд М.Мө, Н.НА нартай бүлэглэн, М.Бо-гээс 650.000 төгрөг, Д.Ба-аас 600.000 төгрөг, Б.Пү-аас 600.000 төгрөг, М.Бу-оос 700.000 төгрөг, Д.Чи-аас 500.000 төгрөг, Б.Мө-аас 300.000 төгрөг, Ж.Ду 700.000 төгрөг, Г.ГҮ-тэй бүлэглэн Х.Бу-ээс 600.000 төгрөг, Г.У-гаас 600.000 төгрөг, Б.Цэ-аас 600.000 төгрөг, Б.Бо-гаас 600.000 төгрөг, Б.Би-ээс 600.000 төгрөг, М.Мө, Н.НА нартай бүлэглэн 2012 оны 03 дугаар сард И.До-оос 600.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч: Г.ГҮ Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2011 оны 01 дүгээр сараас 2012 оны 05 дугаар сарын хооронд Ч.Ба-аас 550.000 төгрөг, Б.Ц-аас 400.000 төгрөг, С.Эн-гаас 550.000 төгрөг, С.Пү-оос 600.000 төгрөг, С.Пү-той бүлэглэн Г.Од-гээс 650.000 төгрөг, Э.Бү-аас 450.000 төгрөг, Ц.Ня-той бүлэглэн Б.Мя-ээс 400.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, Б.Чу-аас 400.000 төгрөг, Э.У-гоос 450.000 төгрөг, Б.Бооос 450.000

төгрөг, Б.Баа-ээс 450.000 төгрөг, Э.Ба-оос 450.000 төгрөг, Б.Ба-тай бүлэглэн Х.Бу-ээс 600.000 төгрөг, Г.Ур-гаас 600.000 төгрөг, Б.Цэ-аас 600.000 төгрөг, Б.Бо-гаас 600.000 төгрөг, Б.Би-ээс 600.000 төгрөг, Н.О-ээс 300.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч С.Пү Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2011 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд Г.ГҮ-тэй бүлэглэн Г.Од-гээс 650.000 төгрөг, Э.Бү-аас 450.000 төгрөг, М.Мө, Н.НА нартай бүлэглэн Э.О-оос 600.000 төгрөг, Б.Мө-гээс 600.000 төгрөг, Г.Чу-ээс 600.000 төгрөг, Д.О-оос 600.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан, Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор Г.ГҮ-ээр зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Ц.Ня Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2011 оны 01 дүгээр сараас 09 дүгээр сарын хооронд Г.ГҮ-тэй бүлэглэн Б.Мя-ээс 400.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, Б.Чу-аас 400.000 төгрөг, Э.Ур-гоос 450.000 төгрөг, Б.Бо-оос 450.000 төгрөг, Б.Баа-ээс 450.000 төгрөг, Э.Ба-оос 450.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Г.Чи Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн оюутан нарын “унасан хичээлийн дүн засна, голч оноог ахиулж өгнө” гэж 2012 оны 01 дүгээр сард Э.Пү-аас 400.000 төгрөг, З.Ня-оос 400.000 төгрөгийг авч Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуулийн сургалтын албаны дарга Б.ЖА-д өгч, хээл хахууль өгч, авахад зуучилсан,

Шүүгдэгч Э.Ба нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор 2011 оны 04 дүгээр сард Ц.Ня,







Шүүгдэгч Б.Баа нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа 2011 оны 01 дүгээр сард “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор Ц.Ня, Г.Гү нараар зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Ж.Ду нь 2011 оны 12 дугаар сард 2011 оны 12 дугаар сард Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байсан хүү Г.З-гийн “унасан хичээлийн дүнг засуулах” зорилгоор Б.Ба, М.Мө, Н.НА нараар зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д 700.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Г.Чу нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа 2011 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор С.Пү, М.Мө, Н.НА нараар зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д 600.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч О.У нь Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор М.Мө, Н.НА нараар зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д 750.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч А.Сү Монгол Улсын Их сургуулийн Худалдааны сургуульд суралцаж байхдаа 2011 оны 05 дугаар сард “унасан хичээлийн дүнгээ засуулах” зорилгоор М.Мө, Н.НА нараар зуучлуулан тус сургуулийн сургалтын албаны даргаар ажиллаж байсан Б.ЖА-д 600.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь мөрдөн байцаалтын шатанд хэрэгт авагдаж, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Хэдийгээр шүүгдэгч Б.ЖА, Н.НА нар өөрт холбогдсон гэмт хэргийг үйлдээгүй гэж мэдүүлэх боловч тэд гэмт хэрэг үйлдсэн болох нь бусад шүүгдэгч нарын мэдүүлэг, хавтаст хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудаар хангалттай нотлогдож байна.

Прокуророос шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.Гү, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарыг давтан үйлдлээр хээл хахууль авч, өгөхөд зуучилсан Э.Ба-ийг давтан үйлдлээр хээл хахууль өгсөн гэж яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн боловч

шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.Гү, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарыг давтан биш үргэлжилсэн үйлдлээр хээл хахууль зуучилсан, шүүгдэгч Э.Ба-ийг мөн үргэлжилсэн үйлдлээр хээл хахууль өгсөн байна гэж үзээд тэдэнд прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэгт зааснаар сонсгосон ялыг мөн хуулийн 270 дугаар зүйлийн 270.1 болгож, шүүгдэгч Э.Ба-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт хэсэгт зааснаар сонсгосон ялыг мөн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэг болгож тус тус хөнгөрүүлэн зүйлчлэв.

Хэргийн бүрдэл хангагдсан, бусад шүүгдэгч нарын хувьд зүйлчлэл тохирсон байх тул шүүгдэгч Б.ЖА-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар, шүүгдэгч Э.Ба, С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Бо, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Э.Ур, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.У, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү, Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дугаар зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахаар,

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1 дахь хэсэгт заасан хэрэг нь мөн хуулийн ерөнхий ангид зааснаар хөнгөн гэмт хэрэг ба эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн байх тул шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.Гү, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарыг хээл хахууль өгч авахад зуучилсан гэм буруутайд тооцож, тэдэнд холбогдох хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, тэднийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр тус тус шийдвэрлэлээ.

Шүүгдэгч Б.Жа нь 2012 оны 05 сарын 18-ны өдөр төрсөн хүү н.Д-ийн хамт Сүхбаатар дүүргийн ...дугаар хороонд оршин суудаг ганц бие эцэг болохоо шүүхэд мэдүүлсэн ба энэ нь хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, Засаг даргын тодорхойлолт зэргээр нотлогдож байх тул түүнд оногдуулсан хорих ялыг, 9 сартай жирэмсэн шүүгдэгч З.Э.Урд оногдуулсан хорих ялыг тус тус хойшлуулж шүүгдэгч Э.Ба, С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Бо, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.У, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү,

Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нарт ногдуулсан хорих ялыг хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, тэдний хувийн байдал, гэм хор арилсан зэрэг байдлыг харгалзан тэнсэж хянан харгалзах нь зөв гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Шүүгдэгч Б.ЖА-д хээл хахуульд өгсөн М.Бо-гийн 650.000 төгрөг, З.Эн-ын 500.000, Ц.Ба-гийн 500.000 төгрөг, А.Мө-ын 500.000 төгрөг, Ч.Тэ-гийн 620.000, Н.Ба-ийн 700.000 төгрөг, Д.Ба-ы 600.000 төгрөг, С.Га-ын 600.000 төгрөг, Б.Пү-ын 600.000 төгрөг, М.Бу-ын 700.000 төгрөг, Б.Ар-ын 600.000 төгрөг, Э.Ор-ны 600.000 төгрөг, Б.Мө-гийн 600.000 төгрөг, М.Би 600.000 төгрөг, Б.Со 500.000 төгрөг, Б.Д.Чи-ны 500.000 төгрөг, Б.Но-гийн 500.000 төгрөг, М.Ма-ын 700.000 төгрөг, Б.А-ын 700.000 төгрөг, И.До-ын 600.000 төгрөг, Б.Мө-ын 300.000 төгрөг, Ж.Ду-ийн 700.000 төгрөг, Г.Чу 600.000 төгрөг, О.У-ын 750.000 төгрөг, Э.Ба-ийн 620.000 төгрөг, А.Сү-ын 600.000 төгрөг, Д.О-ийн 600.000 төгрөг нийт 16.040.000 төгрөгийг Б.ЖА-аас гаргуулан хурааж улсын орлого болгох, Б.Жа хээл хахуульд авсан мөнгөө буцааж авсан шүүгдэгч Г.Од-гээс 650.000 төгрөг, Ч.Ба-аас 550.000 төгрөг, Б.Мя-аас 400.000 төгрөг, Х.Бу-ээс 600.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, Б.Чу-аас 400.000 төгрөг, Э.Ур-аас 450.000 төгрөг, Г.Ур-гаас 600.000 төгрөг, Б.Цэ-ээс 600.000 төгрөг, Б.Бо-гаас 600.000 төгрөг, Н.О-ээс 300.000 төгрөг, Э.Бү-аас 450.000 төгрөг, Б.Би-ээс 600.000 төгрөг, Б.Ца-аас 400.000 төгрөг, Б.Бо-оос 450.000 төгрөг, С.Эн-гаас 550.000 төгрөг, Б.Баа-аас 450.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, С.Пү-ээс 600.000 төгрөг, З.Ня-аас 400.000 төгрөг, Э.Пү-ээс 400.000 төгрөг, М.Ца-аас 600.000 төгрөгийг тус тус гаргуулан хурааж улсын орлого болгохоор шийдвэрлэв.

Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн "Olimpus" гэсэн нэртэй дуу хураагч дахь бичлэгийг си ди-нд /CD/ буулган хэрэгт хавсарган, "Olimpus" нэртэй дуу хураагуурыг М.Мө-д буцаан олгох нь зүйтэй.

Хэрэгт битүүмжлэгдсэн Улсын бүртгэлийн Y-220300xxxx дугаарт бүртгэлтэй, Б.ЖА-ийн өмчлөлийн Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороололын ...тоот 3 өрөө орон сууцыг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгов.

Шүүгдэгч Б.Ар 2014 оны 08 дугаар сарын 13-наас 09 дүгээр сарын 03 ны өдрийг хүртэл 21 хоног цагдан хоригдсон ба бусад шүүгдэгч нар цагдан хоригдоогүй болохыг дурдав.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2, 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 286, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.ГҮ, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.2 дахь хэсэгт зааснаар сонсгосон ялыг мөн хуулийн 270 дугаар зүйлийн 270.1 болгож,

Шүүгдэгч Э.Ба-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дугаар зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар сонсгосон ялыг мөн хуулийн 269 дугаар зүйлийн 269.1 болгож тус тус хөнгөрүүлэн өөрчилсүгэй.

2. Шүүгдэгч Б.ЖА-ийг бусдаас их хэмжээний хээл хахууль үйлдсэн гэм буруутайд,

Шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.ГҮ, Ц.Ня, Г.Чи нарыг хээл хахууль өгч, авахад зуучилсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд,

Шүүгдэгч Э.Ба, С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Со, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Э.Ур, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.Уя, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү, Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нарыг хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Б.ЖА-ийг 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Э.Ба, С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Со, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Э.Ур, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.Уя, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү, Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нарыг 1 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь хэсэгт зааснаар Н.НА, М.Мө, Б.Ба, Г.ГҮ, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 72 дугаар зүйлийн 72.1.1 дэх хэсэгт зааснаар Н.НА, М.Мө, Б.Ба, Г.ГҮ, С.Пү, Ц.Ня, Г.Чи нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар



Б.ЖА-д оногдуулсан 5 жил 1 сарын хорих ялыг чанга дэглэмтэй хорих ангид,

Мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар Э.Ба, С.Пү, Г.Од, Ц.Ба, Б.Би, Д.Чи, Э.Пү, З.Ня, Б.Мө, С.Га, Б.Ар, Б.Баа, Д.Ба, Ч.Тэ, Б.Пү, Э.Ба, З.Эн нарт оногдуулсан 1 жил 1 сарын хугацаагаар хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид,

Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Бо, М.Бу, М.Ца, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Э.Ор, Б.Но, Э.Ур, Н.Ою, Б.Ца, Б.Мө, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.Уя, М.Би, М.Бо, Э.Бү нарт оногдуулсан 1 жил 1 сарын хугацаагаар хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ар-ын цагдан хоригдсон 21 хоногийг ял эдэлсэн хугацаанд нь оруулан тооцсугай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.3, 88.1.7 дахь хэсэгт зааснаар эд мөрийн баримтаар хураагдсан "Olimpus" гэсэн нэртэй дуу хураагч дахь бичлэгийг си ди-нд /CD/ буулган хэрэгт хавсарган, "Olimpus" нэртэй дуу хураагуурыг М.Мө-ад буцаан олгохыг шүүгчийн туслах Б.Нямжавт даалгасугай.

5. Хэрэгт Улсын бүртгэлийн Y-220300xxxx дугаартай, Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ...дугаар хорооллын ...тоот 3 өрөө Б.ЖА-ийн өмчлөлийн орон сууцыг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгосугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дугаар зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.ЖА-аас 16.040.000 төгрөг, шүүгдэгч Г.Од-гээс 650.000 төгрөг, Ч.Ба-аас 550.000 төгрөг, Б.Мя-ээс 400.000 төгрөг, Х.Бу-ээс 600.000 төгрөг, Э.Ба-аас 450.000 төгрөг, Б.Чу-аас 400.000 төгрөг, Э.Ур-аас 450.000 төгрөг, Г.Ур-гаас 600.000 төгрөг, Б.Цэ-ээс 600.000 төгрөг, Б.Бо-оос 600.000 төгрөг, Н.Ою-оос 300.000 төгрөг, Э.Бү-ээс 450.000 төгрөг, Б.Би-ээс 600.000 төгрөг, Б.Ца-аас 400.000 төгрөг, Б.Бо-оос 450.000

төгрөг, С.Эн-ээс 550.000 төгрөг, Б.Баа-аас 450.000 төгрөг, Э.Б-аас 450.000 төгрөг, С.Пү-ээс 600.000 төгрөг, З.Ня-аас 400.000 төгрөг, Э.Пү-ээс 400.000 төгрөг, М.Ца-аас 600.000 төгрөгийг тус тус гаргуулан хурааж тус тус улсын орлого болгосугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт зааснаар Б.ЖА-д ногдуулсан 5 жил 1 сарын хорих ялыг 2 жилийн хугацаагаар, Э.Ур-д оногдуулсан 1 жил 1 сарын хугацаагаар хорих ялыг 1 жилийн хугацаагаар тус тус хойшлуулж, хяналт тавихыг Сүхбаатар, Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэст даалгасугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар Э.Ба, С.Пү, Г.Од, Ч.Ба, Б.Мя, Х.Бу, Г.Ур, Б.Цэ, Б.Бо, Б.Бо, М.Бу, М.Ца, Э.Пү, Б.Со, Б.Чу, Н.Ба, А.Мө, Ц.Ба, Э.Ор, Б.Би, Б.Но, Н.Ою, Б.Ца, Б.Мө, Д.Чи, З.Ня, М.Ма, Б.Ан, С.Эн, И.До, Ж.Ду, Г.Чу, А.Сү, О.Уя, Б.Мө, С.Га, Б.Пү, М.Би, М.Бо, Б.Ар, Б.Баа, Э.Бү, Д.Ба, Ч.Тэ, Э.Ба, З.Эн нарт ногдуулсан 1 жил 1 сарын хорих ялыг тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзаж, түүнд хяналт харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэст даалгасугай.

9. Шүүгдэгч Н.НА, М.Мө, Б.Ба, Г.Гү, Ц.Ня, Г.Чи нарт авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, Б.Ар-од авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авч, бусад шүүгдэгч нарт авсан таслан сэргийлэх арга хэмжээг тогтоол хүчин төгөлдөр болтол хэвээр үргэлжлүүлсүгэй.

10. Шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд тогтоолыг шүүгдэгч нар тэдний өмгөөлөгч нар эс зөвшөөрвөл гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор мөн хугацаанд эсэргүүцэл бичих эрхтэйг тайлбарласугай.

11. Давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Б.МӨНХБАЯР  
Х.ИДЭР  
Ц.ЦЭЛМЭГ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 76

Хэрлэн сум

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 28 дугаар шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгч Ж.Болдбаатар даргалж, тус шүүхийн шүүх хуралдааны "Б" танхимд хийсэн шүүх хуралдаанд:

Нарийн бичгийн дарга: Н.Болор-Уянга,  
Улсын яллагч: Я.Сансар

Хохирогч, иргэний нэхэмжлэгч: Н.Жа  
Шинжээч: Д.Батжаргал

Шүүгдэгч нарын өмгөөлөгч:

Н.Ариунжаргал, Б.Цолмон-Эрдэнэ

Шүүгдэгч: Ч.Ч, Н.Э нар оролцов.

Хэнтий аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Н.Э, Ч.Ч нарт холбогдох 20142300003. дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 08 дугаар сарын 04-нд хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт

1. Шүүгдэгч: ...оны ...сарын ...-ны өдөр ...аймгийн ...суманд төрсөн, ...настай эрэгтэй, халх, дээд боловсролтой, нягтлан бодогч Ч.Ч, төрийн захиргааны менежер мэргэжилтэй, хэрэгт холбогдохын өмнө эрхэлсэн тодорхой ажилгүй байсан, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт ...аймгийн ...сумын төвд оршин суух, урьд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медалиар 2006 онд, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар 2011 онд, Хөдөлмөрийн хүндэт медалиар 2011 онд тус тус шагнагдсан, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан, гар бөмбөгийн спортын 1 дүгээр зэрэгтэй, аймгийн начин цолтой, ял шийтгэлгүй, Ц овгийн Н.Э РД: СА.....

2. Шүүгдэгч: ...оны ...сарын ...-ны өдөр... аймгийн ...хотод төрсөн, ...настай, халх, эрэгтэй, дээд боловсролтой, газар зохион байгуулагч инженер мэргэжилтэй, хэрэгт холбогдохын өмнө эрхэлсэн тодорхой ажилгүй байсан, ам бүл..., эхнэр ...хүүхдийн хамт ...аймгийн... хотын ...дүгээр хороо ...тоотод оршин суух, Биеийн тамир спортын улсын тэргүүний ажилтан цол тэмдгээр 2005 онд, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар 2011 онд тус тус шагнагдсан, сагсан бөмбөгийн спортын 1 дүгээр зэрэгтэй, урьд ял шийтгэлгүй, Ч.Ч РД:СФ.....

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн

талаар: (Яллах дүгнэлтэд дурдсанаар )

Шүүгдэгч Н.Э нь Хэнтий аймгийн ...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байхдаа эрх мэдлээ хэтрүүлэн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №308 дугаартай тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.1-т заасан Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч, Газрын тухай хуулийн 16.1.11-т заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож солбицлыг тогтоох, 2.2-т "Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож солбицлыг тогтоосон газрын талаар ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах" гэсэн заалтыг зөрчиж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас 23 дугаар тогтоолоор ...аймгийн ...сумын 7 дугаар баг ...хотын Ангал, Харцага ухаа, Төмөртэй өндөр гэх газруудад нөхөрлөлүүдэд бичил уурхайгаар газар эзэмшүүлэхийг зөвшөөрсөн хууль бус шийдвэр гаргасан, дээрх хууль бус шийдвэрийн дагуу шүүгдэгч Ч.Ч нь Бэрх хотын захирагчаар ажиллаж байхдаа нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулсны улмаас улсад онц их хэмжээний буюу 1.166.187.800 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүх хуралдаанд эрүүгийн 20142300003 дугаартай 2 хавтаст хэрэгт мөрдөн байцаалтын шатанд цугларсан, шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт дурдагдсан бичгийн нотлох баримтуудыг шинжлэн судлаад ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Н.Э нь ...аймгийн ...сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байхдаа Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №308 дугаартай тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2 дугаар

зүйлийн 2.1-т заасан "Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-т заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож солбицлыг тогтоох", мөн журмын 2 дугаар зүйлийн 2.2-т " Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож солбицлыг тогтоосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1,23-т заасан дүгнэлт гаргуулахаар Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах " гэсэн заалтыг зөрчиж албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн Батноров сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн №07 дугаартай хурлын шийдвэрийг дур зоргоороо өөрчлөн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн №23 дугаартай тогтоолоор ...сумын 7 дугаар баг ...хотын Ангал, Харцага ухаа, Төмөртэй өндөр гэх газруудад нийт 15 га газарт нөхөрлөлийн журмаар бичил уурхайн зориулалтаар газар эзэмшүүлэхийг зөвшөөрсөн хууль бус шийдвэр гаргасны улмаас байгаль экологид 1.166.187.800 /нэг тэрбум нэг зуун жаран зургаан сая нэг зуун наян долоон мянга найман зуу/ төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн.

Шүүгдэгч Ч.Ч нь ...аймгийн ...сумын ...дугаар баг ...тосгоны захирагчаар ажиллаж байхдаа Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №308 дугаартай тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т заасан "Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох тухай дүгнэлт гарсан тохиолдолд Сум, дүүргийн Засаг дарга нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн өргөдөл гаргасан нөхөрлөлтэй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулна" гэсэн заалтыг зөрчиж албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн Д, Е, У, Де, Ж, Х, Ө, С зэрэг нөхөрлөлүүдтэй хууль зөрчин ...аймгийн ...сумын 7 дугаар баг Бэрх тосгоны нутаг дэвсгэрт орших Ангал гэх газарт бичил уурхайгаар Ашигт малтмал олборлох гэрээ

байгуулж, эдгээр нөхөрлөлүүд шүүгдэгч Ч.Ч-ийн дээрх хууль бус шийдвэрийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулснаар байгаль экологид 1.166.187.800 /нэг тэрбум нэг зуун жаран зургаан сая нэг зуун наян долоон мянга найман зуу/ төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн болох нь доорх нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна. Үүнд:

1. Хэнтий аймгийн Батноров сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 23 тоот тогтоол /хх-ийн 35 х/

2. Хэнтий аймгийн Батноров сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012.07.03-ны өдрийн 07 дугаартай хуралдааны тэмдэглэл /хх-ийн 36-39 х/

3. Хохирогч, иргэний нэхэмжлэгч Н.Жа мөрдөн байцаалтад өгсөн: Н.Э нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.2, 3.1, 3.2, 3.3 дахь заалтуудыг зөрчсөн байна. Батноров сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ашигт малтмалын газарт хандаж дүгнэлт гаргуулахаар зөвшөөрсөн шийдвэрийг Засаг даргад гаргах байсан. Түүнийг Засаг дарга хүлээж аваад холбогдох газар уламжилж, дүгнэлт гаргасан тохиолдолд сум дүүргийн асаг дарга гэрээ байгуулах байсныг зөрчсөн байна. ...аймгийн ...сумын 7 дугаар багийн Засаг дарга Ч.Ч нь сумын Засаг даргын эрхийг эдэлж нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулан хууль зөрчсөн гэж үзэж байна. Ч.Ч, Н.Э нарын буруутай шийдвэрээс ...аймгийн ...тосгонд нөхөрлөлүүд жонш олборлосны улмаас газрын хөрсөнд 21.275.800 /хорин нэгэн сая хоёр зуун далан таван мянга найман зуу/ төгрөгийн, газрын хэвлийд 1.144.912.000 /нэг тэрбум нэг зуун дөчин дөрвөн сая есөн зуун арван хоёр мянга/ төгрөг буюу экологийн нийт хохирол 1.166.187.800 /нэг тэрбум нэг зуун жаран зургаан сая нэг зуун наян долоон мянга найман зуу/ төгрөгийн хохирол учирсан гэсэн мэдүүлэг /хх-ийн 59-60 х/

4. Гэрч Г.О-гийн мөрдөн байцаалтад өгсөн: Бичил уурхайгаар нөхөрлөлд газар эзэмшүүлэхэд тухайн орон нутагт бүртгэлтэй 5-аас доошгүй иргэн нөхөрлөл байгуулаад орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бичил уурхайгаар талбай эзэмшүүлэх талаар хүсэлт гаргана. Иргэдийн хурал хүсэлтийг хүлээн аваад тухайн газрын солбицлыг тогтоож тухайн газрыг бичил

уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай тогтоол гаргана. Уг тогтоолд орон нутгийн Засаг даргыг Ашигт малтмалын газарт хандаж талбайн дүгнэлт гаргуулах заалт оруулж өгсний дагуу Засаг дарга ашигт малтмалын газарт иргэдийн Хурлаас гаргасан солбицол бүхий талбайг бичил уурхайгаар ашиглаж болох талаар дүгнэлт гаргуулахаар Ашигт малтмалын газарт хандана. Ашигт малтмалын газар уг хүсэлтийг хүлээн аваад кадастрын зураг зүйн бүртгэлээс шүүлт хийгээд давхцалтай талбай мөн эсэхийг шалгаад давхцалтай талбай байвал бичил уурхайгаар ашиглах боломжгүй гэсэн, давхцалгүй байвал бичил уурхайгаар ашиглаж болно гэсэн аль нэг дүгнэлт гарна. Гарсан дүгнэлтийг орон нутагт явуулаад боломжгүй гэсэн дүгнэлт байвал иргэдийн хурал гаргасан тогтоолоо хүчингүй болгоод нөхөрлөлд мэдэгдэнэ. Ашиглаж болно гэсэн тохиолдолд орон нутгийн Засаг дарга тухайн нөхөрлөлтэй гэрээ байгуулна. Гэрээ байгуулсан талбайн хэмжээ 5 га газраас ихгүй байна. Иргэдийн хурлаас бичил уурхайгаар нөхөрлөлд газар эзэмшүүлэх тогтоол гаргахгүй зөвхөн солбицлыг тогтоож Засаг даргад Ашигт малтмалын газарт уламжлуулах заалт оруулна. Бусад үйл ажиллагааг Засаг дарга хариуцна. Иргэдийн хурлаас бичил уурхайгаар нөхөрлөлд газар эзэмшүүлэх тогтоолыг үндэслэн нөхөрлөлтэй гэрээ байгуулсан бол 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 308 дугаартай тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 2.1, 3.2, 3.3 дахь заалтуудтай зөрчилдөнө гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 61-62 х/

5. Гэрч Б.Б-ийн мөрдөн байцаалтад өгсөн: ...аймгийн ...багийн Засаг даргаар ажиллаж байсан Ч.Ч бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гаргуулах талаар утсаар яриагүй. Засгийн газрын 308 дугаар тогтоол "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын дагуу Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тусгай хэрэгцээнд авсан газарт ашигт малтмал олборлож болох дүгнэлт гаргуулах талаар Сумын Засаг даргад уламжилсан тогтоол гаргасны дагуу Сумын Засаг дарга Ашигт малтмалын газарт уламжлан дүгнэлт гаргасан тохиолдолд Сум дүүргийн Засаг дарга аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулах ёстой. Ашигт малтмалын газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гаргаагүй байхад Сумын

Засаг дарга нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулж үйл ажиллагаа явуулж болохгүй, журам зөрчиж байна гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 105 х/

6. Гэрч Ц.А-гийн мөрдөн байцаалтад өгсөн: 2004 оноос эхлэн ...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байна. 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр №07 дугаар хуралдаанд би нарийн бичгийн даргаар оролцсон. Энэ хурлаар.. 5 төрлийн асуудал хэлэлцсэн. 23 дугаартай тогтоолын төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Э даргын хэлсний дагуу тогтоолыг бичээд өөрт нь хянуулаад гаргасан. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өөр тогтоол гарч байсан. Сумын Засаг даргыг Ашигт малтмалын газар уламжлахыг зөвшөөрсөн тогтоол гардаг байсан. 2012.07.03-ны өдрийн 23 дугаартай тогтоол нөхөрлөлүүдэд эзэмшүүлэхээр зөвшөөрсүгэй гэсэн тогтоол гарсан талаар мэдэхгүй байна. Надад тогтоолд засвар хийх, өөрчлөлт оруулах ямар нэг эрх хэмжээ байхгүй. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу тогтоол боловсруулаад хурлын даргад хянуулаад гарын үсэг зуруулдаг гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 103 х/

7. Гэрч Д.Бм-ийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Хэнтий аймгийн Батноров сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тэргүүлэгчээр оролцсон. Бэрх хотод нөхөрлөл байгуулахаар 15 га газрыг шийдвэрлэх зэрэг 5 төрлийн асуудал хэлэлцсэн. Тухайн өдрийн хурал дээр би Бэрх хот өмнө нь 25 га газар аваад жоншны нөөцгүй гэсэн шалтгаанаар ашиглахгүй байна. Тийм болохоор уг асуудлыг Ашигт малтмалын газарт уламжилж шийдвэрлүүлсний дараа оруулж ирсэн тохиолдолд уг хүсэлтийг шийдвэрлэж болох юм байна. Нөхөрлөлийн журмаар газар эзэмшүүлэхийг Сумын Засаг даргаар дамжуулан Ашигт малтмалын газарт уламжлах тогтоол гарсан гэж ойлгосон. Сүүлд нь сонсоход бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам зөрчсөн тогтоол гарсан байсан гэсэн мэдүүлэг, /1-хх-ийн 87-88 х/

8. Гэрч Т.Ба-ийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ...аймгийн ...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тэргүүлэгчээр оролцсон ...Харин тухайн өдрийн хурал дээр ...хотод өмнө нь 25 га газар олгосон байсны 15 га газарт жоншны нөөцгүй гэсэн шалтгаанаар буцааж жоншны

нөөцтэй газарт шилжүүлж авъя гэсэн санал оруулж ирснийг миний зүгээс өмнө нь өгсөн 25 га газрыг бүрэн ашиглаагүй байж дахин асуудал оруулж байгааг зөвшөөрч дэмжихгүй гэсэн санал гаргасан. ...хот нь ...сумын 7 дугаар баг тийм болохоор нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулах эрх ...хотын Засаг даргад байхгүй. Гэрээг ...сумын Засаг дарга хийх ёстой гэсэн мэдүүлэг, /1-хх-ийн 92 х/

9. Гэрч Ч.Эр-ийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ...аймгийн ...сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд Тэргүүлэгчээр оролцсон. 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ...аймгийн ...сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдахаар болсон гэж ...суманд дуудсаны дагуу явах гэж байтал ...хотын Засаг дарга Ч.Ч нь дугтуйтай бичгийг хурлын дарга Н.Э-д өгөөрэй гэж өгсөн. Уг бичгийг хурал дээр задалж хэлэлцэхэд ...аймгийн ...сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт орших Ангал, Харцага ухаа, Төмөртэй өндөр гэх газруудыг нөхөрлөлийн журмаар эзэмшүүлж өгнө үү Засаг дарга Ч.Ч гэсэн утгатай бичиг байсан. Уг асуудлыг хурлаар хэлэлцүүлж холбогдох байгууллагад нь уламжлахыг дэмжсэний дагуу хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гарсан. Тэргүүлэгчдийн хурлаар нөхөрлөлийн газар эзэмшүүлэхийг Сумын Засаг даргаар дамжуулан Ашигт малтмалын газарт уламжлах талаар хэлэлцсэн учир Тэргүүлэгчдийн тогтоол нь нөхөрлөлийн журмаар газар эзэмшүүлэхийг сумын Засаг даргаар дамжуулан Ашигт малтмалын газарт уламжлах тухай тогтоол гаргасан байх ёстой. Тэргүүлэгчдийн хурлын тогтоол дээрх газруудад нөхөрлөлийн журмаар эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй гэсэн тогтоол гарсныг одоо сонсож байна. Тухайн үед би тогтоолтой танилцаагүй. Засаг даргаар дамжуулан Ашигт малтмалын газарт уламжлах тухай тогтоол гарсан гэж ойлгож байсан. Тэгээд Ч.Ч би Тэргүүлэгчдийн хурлын тогтоол дээр гарын үсэг зурдаггүй. Би 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг хараагүй гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 63-64 х/

10. Гэрч Р.М-ийн мөрдөн байцаалтад өгсөн: Би 2012.07.22-ны өдөр Ж нэртэй нөхөрлөл байгуулж тухайн өдрөө ...хотын Засаг даргаар ажиллаж байсан Ч.Ч-тэй жонш олборлох гэрээ байгуулаад ...хотын Ангал нэртэй газарт үйл ажиллагаа явуулаад 300 тонн жонш олборлож К.Эб-д өгсөн. 2013 оны 06 дугаар сарын эхээр Ж нөхөрлөлийг К.Эб-д

шилжүүлж өгөөд үйл ажиллагаа явуулаагүй. Ч.Ч нь миний эхнэр н.П-ийн төрсөн эгч н.Ая-ийн хүү байгаа юм гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 65-66 х/

11. Гэрч Р.К-ийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 07 дугаар сард У нэртэй нөхөрлөл байгуулаад 2012 оны 07 дугаар сарын сүүлээр ...хотын Засаг дарга Ч.Ч-тэй жонш олборлох гэрээ байгуулсан ...хотын Ангал нэртэй газраас 90 тонн жоншыг 2012 оны 07 дугаар сараас 2013 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд жонш олборлосон гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 67-68 х/

12. Гэрч Б.Г-ийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 03 дугаар сард нөхөрлөл байгуулж жонш олборлох өргөдлийг ...хотын Засаг дарга Ч.Ч-д өгсөн юм. 2012 оны 07 дугаар сард Д нэртэй нөхөрлөл байгуулж ...багийн Ангал гэх газарт жонш олборлох гэрээг байгуулсан боловч ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 69-70 х/

13. Гэрч Д.Ад-ийн мөрдөн байцаалтад өгсөн: Би 2012 оны 07 дугаар сард Ө нэртэй нөхөрлөлийг үүсгэн байгуулаад 2012 оны 07 дугаар сарын 30-ны өдөр ...хотын Засаг дарга Ч.Ч-тэй ...хотын Ангал нэртэй газарт жонш олборлох гэрээг нэг жилийн хугацаатай байгуулж жонш олборлож байна...250 тонн жонш олборлосон. Олборлосон жоншоо Ж нөхөрлөлийн ахлагч К.Эб-д тонныг нь 150.000 төгрөгөөр бодож өгдөг гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 72 х/

14. Гэрч С.Ас-ийн мөрдөн байцаалтад өгсөн: Би 2011 онд ...хотын Засаг даргын Тамгын газарт нөхөрлөлийн журмаар газар олгож өгнө үү гэсэн өргөдөл өгсөн байсны дагуу 2012 оны 07 дугаар сард ...хотын Засаг дарга Ч.Ч-тэй Ангал нэртэй газарт жонш олборлох гэрээ байгуулсан. Гэрээ байгуулахдаа Х нэртэй нөхөрлөлийг 2012 оны 07 дугаар сард үүсгэн байгуулсан. 2013 оны 10 дугаар сараас эхлэн ...аймгийн ...тосгоны нутаг дэвсгэрт байрлах Ангал хэмээх нэртэй газарт жонш олборлох үйл ажиллагаа явуулж 60 тонн жонш олборлосон гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 74 х/

15. Гэрч Т.Ха-гийн мөрдөн байцаалтад өгсөн: 2012 оны 07 дугаар сард ...хотын Засаг дарга Ч.Ч-тэй жонш олборлохыг зохион байгуулалтанд оруулж нөхөрлөл байгуулсан хүнтэй гэрээ хийнэ гэж хэлсний дагуу 2012 оны 07 дугаар сард С нэртэй нөхөрлөл байгуулж ...хотын Ангал гэх газарт жонш олборлох зорилгоор Засаг дарга Ч.Ч-

тэй 30 метр газарт жонш олборлох гэрээг байгуулсан. Гэхдээ би ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 76 х/

16. Гэрч К.Эб-ийн мөрдөн байцаалтад өгсөн: Би 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн одоог хүртэл Ж нөхөрлөлийн ахлагчаар ажиллаж байна. Өмнө нь Ж нөхөрлөлийг Р.М 2012 онд байгуулсан. 2013.06.05-ны өдрөөс хойш 300 тонн жонш олборлосон. Сумын Засаг даргатай гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа нөхөрлөлүүдээс нэг тонн жоншийг 180000 төгрөгөөр худалдан авч байсан гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 77-78 х/

17. Гэрч М.Гү-гийн мөрдөн байцаалтад өгсөн: ...аймгийн ...хотод жонш олборлох зорилгоор Де нөхөрлөлийг 2012 оны 08 дугаар сарын 01-ний өдөр үүсгэн байгуулаад ...хотын Засаг дарга Ч.Ч-тэй Ангал нэртэй газарт 30 метр хэмжээтэй газарт жонш олборлох гэрээг 1 жилийн хугацаагаар байгуулаад хөрс хуулалтын ажлыг 3 сарын хугацаанд хийж 2012 оны 11 дүгээр сараас өнөөдрийг хүртэл хугацаанд жонш олборлож байна. 2013 онд 950 тонн, 2014 онд 50 тонн жонш олборлосон. Үйл ажиллагааг явуулж байгаа. 4 нөхөрлөлөөс 1280 тонн жонш авсан гэсэн мэдүүлэг /1-хх-ийн 95-96-р х/

18. "МОН" ХХК-ийн ...аймгийн ...сумын 7 дугаар баг Бэрх тосгоны нутаг дэвсгэрт жонш олборлох үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тайлан /1-хх-ийн 109-өөс 2-хх-ийн 12 х/

19. Ашигт малтмал олборлох тухай гэрээ /2-хх-ийн 84-110 х/

20. 2012 онд олгосон Жоншны гарал үүслийн бичгийн бүртгэл /2-хх-ийн 139-142 х/

21. Шүүгдэгч Н.Э-гийн мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр өгсөн: 2012 оны 07 дугаар сард ...хотын захирагч Ч.Ч, ...сумын Засаг дарга Д.Жб нарын ...сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт орших Ангал, Харцага-Ухаа, Төмөртэй-Өндөр гэх газруудад нөхөрлөлөөр жонш олборлох зөвшөөрөл хүссэн албан тоотын дагуу сумын иргэдийн Хурлын Тэргүүлэгчид 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хуралдаж олонхийн саналаар дээрх газруудад нөхөрлөлийн журмаар эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй гэсэн тогтоол гаргасан. ...хотын захирагч Ч.Ч тогтоолыг үндэслэн нөхөрлөлүүдэд гэрээ байгуулаад жонш олборлох үйл ажиллагаа явуулсан байсан.

Бичил уурхайгаар ашигт малтмал

олборлох журмын 2.2-т Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбицлыг тогтоосон газрын талаар ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар геологи уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах гэсэн заалтыг зөрчсөн нь үнэн. Тогтоолын заалтыг хариуцлагагүй хандаж гаргасан байна. Энэ асуудал дээр гэм буруутай гэдгээ ойлгож байна гэсэн мэдүүлэг /2-хх-ийн 20-21-р х/

22. Шүүгдэгч Н.Э-гийн мөрдөн байцаалтын шатанд яллагдагчаар өгсөн: Надад сонсож буй Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйлийн 264.2-т заасан зүйл ангийг хүлээн зөвшөөрч байна. 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 23 дугаартай тогтоол дээр би журам зөрчиж гарын үсэг зурж шийдвэр гаргасан учир хүлээн зөвшөөрч байна. Энэ хэрэгт байцаалтыг өмгөөлөгчгүй өгөхөд татгалзах зүйлгүй.

2012 оны 05 дугаар сараас эхлэн ...багийн Ангал, Харцага ухаа, Төмөртэй өндөр гэх газруудыг нөхөрлөлд эзэмшүүлэх хүсэлтийг ...багийн Засаг дарга Ч.Ч, сумын Засаг дарга нар гаргахад нь ашигт малтмалын газраас дүгнэлт ирсэн тохиолдолд, мөн өмнө нь авсан 25 га газраас хэмжээний хувьд хэтрэх гээд байхаар нь шийдвэр ирсэн үед хурлаар шийднэ гээд хойшлууж байсан. Тэгтэл 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Тэргүүлэгчдийн хурлаас хэлэлцүүлэх гээд хурлын тэргүүлэгч Ч.Эр, ...хотын Засаг дарга Ч.Ч нар хүсэлт явуулсан орон нутгийн иргэдийг төлөөлж байгаагийн хувьд нөхөрлөлийн журмаар газар эзэмшүүлж өгөөч гэсний дагуу төлөвлөгөөнд оруулж хэлэлцээд Ашигт малтмалын газар уламжлах хамтын шийдвэр гаргаад хурлын тогтоол гарч би гарын үсэг зурж баталгаажуулсан. 2013 онд ...аймгийн Эдийн засгийн цагдаагийн хэлтсээс дуудаж 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдөр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 23 дугаартай тогтоолыг үзүүлэхэд алдаатай журам зөрчиж гарсан тогтоол дээр гарын үсэг зурж баталгаажуулсныг мэдсэн гэсэн мэдүүлгүүд.

23. Шүүгдэгч Ч.Ч-ийн мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр өгсөн: 2009 оноос хойш ...хотыг тойроод гар аргаар зөвшөөрөлгүй жонш олборлохоор орон нутаг бүрээс хүмүүс

ирсэн. Энэ асуудлыг таслан зогсоохоор орон нутгийн хуулийн байгууллагуудтай хамтран ажилласан боловч тодорхой үр дүнд хүрээгүй 2010 онд Бичил уурхайн журам гарч нөхөрлөлүүд байгуулагдсан. Нөхөрлөлүүд нь зөвхөн орон нутгийн иргэд байхаар журам гарсан байсан. Тэгтэл бусад орон нутгаас ирсэн иргэд зөвшөөрөлгүй газар хууль бусаар ажиллаад байхаар нь ...сумын иргэдийн Хуралд ...хотын 7 дугаар багт орших Ангал, Харцага ухаа, Төмөртэй өндөр гэх газруудыг тусгай хэрэгцээнд авахуулах талаар 2012 онд албан бичгээр хандсан. Сумын иргэдийн Тэргүүлэгчдийн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 23 дугаартай тогтоолоор Харцага ухаа, Ангал, Төмөртэй өндөр хэмээх газруудад нийт 15 га газрыг нөхөрлөлийн журмаар эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй гэсэн тогтоол гарсан. Тухайн үед Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Б.Б гэх хүнтэй утсаар ярьж ашигт малтмалын газраас дүгнэлт гаргаж байгаа юу гэж асуутал дүгнэлт гарахгүй байгаа сумын иргэдийн хурлын тогтоол гарсан бол Засаг дарга нөхөрлөлүүдтэй гэрээ байгуулж болно гэж хэлэхээр нь 9 нөхөрлөлтэй 2012 оны 07 дугаар сард гэрээ байгуулсан.

Би Ашигт малтмалын газарт уламжилж дүгнэлт гарсан үед Засаг дарга гэрээ байгуулна гэсэн журмыг мэдэж байсан. Тухайн үед ашигт малтмалын газрын мэргэжилтэн Б.Б-аас асуухад иргэдийн хурлын тогтоол гарсан бол болно гэхээр нь гэрээ байгуулсан гэсэн мэдүүлэг /2-хх-ийн 27-28 х/ зэрэг болно.

Шүүгдэгч нар нь дээрх гэмт хэргийг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдсэн байна.

Шүүгдэгч нарын үйлдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг мөн байна.

Шүүгдэгч нарын үйлдсэн гэмт хэргийн улмаас Монгол Улсын байгаль экологид 1.166.187.800 /нэг тэрбум нэг зуун нэг зуун жаран зургаан сая нэг зуун наян долоо мянга найман зуу/ төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учирсан байна.

Шүүгдэгч нарын Эрүүгийн хуульд заасан хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн болон хувийн бусад байдлуудыг нь харгалзан хорихоос өөр төрлийн ял шийтгэл ногдуулах

нь зүйтэй гэж шүүх үзэв

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 284, 286, 294-өөс 299 дүгээр зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүгдэгч Н.Э, Ч.Ч нарыг төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэн улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Э-д тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 2 /хоёр / жилийн хугацаагаар хасаж, 6 /зургаа/ сарын баривчлах ялаар, шүүгдэгч Ч.Ч-д тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 4 /дөрөв/ сарын баривчлах ялаар тус тус шийтгэсүгэй.

3. Энэхүү шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч Н.Э, Ч.Ч нарын ял эдлэх хугацааг 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн тоолсугай.

4. Шүүгдэгч нарын үйлдсэн гэмт хэргийн улмаас улсад учирсан байгаль экологийн 1.166.187.800 төгрөгийн хохирлыг тэнцүү хувааж шүүгдэгч Н.Э-с 583.093.900 /таван зуун наян гурван сая ерэн гурван мянга есөн зуу / төгрөгийг, шүүгдэгч Ч.Ч-ээс 583.093.900 / таван зуун наян гурван сая ерэн гурван мянга есөн зуу/ төгрөгийг тус тус гаргуулж Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд олгосугай.

5. Шүүгдэгч нар нь урьдчилан цагдан хоригдоогүй, тэдний бичиг баримт шүүхэд ирээгүй ба хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн зүйлгүй болохыг тус тус дурдсугай.

6. Давж заалдах гомдол гаргах болон эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд энэхүү шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхэд давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

7. Давж заалдах гомдол гаргасан буюу эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелүүлэх хүртэл шүүгдэгч Н.Э, Ч.Ч нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорьсугай.

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 096

Булган сум

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 4 дүгээр шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгч Л.Дарьсүрэн даргалж,

Нарийн бичгийн дарга: П.Отгон,

Улсын яллагч: Ц.Сувдаа,

Шүүгдэгч нарын өмгөөлөгч: Б.Банзрагч, П.Ган-Очир нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийж, Аймгийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.2-т заасныг журамлан тусгай ангийн 269 дугаар зүйлийн 269.1-д зааснаар С.М, Б.Б нарт яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн 132/2014/0084/Э/ дугаарын индекстэй, эрүүгийн 201306000456 дугаартай хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр ...аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, Уул уурхайн ашиглалтын технологийн инженер мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Улаанбаатар хот, ...дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, С.М /РД:...../,

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр ...аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, холбооны инженер мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл..., ээж, ахын хамт Улаанбаатар хот, ...дүүргийн ...дүгээр хорооны ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, Б.Б /РД:...../,

Холбогдсон хэргийн талаар:

Шүүгдэгч С.М, Б.Б нар нь 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдөр ...аймгийн ...сумыг камержуулах тендер сонгон шалгаруулалтад "А" нэрээр оролцож ялалт байгуулахын тулд Л.Б-ийн ХААН банкин дахь дансаар 18.000.000 төгрөгийг шилжүүлж эрх бүхий албан тушаалтанд хээл хахууль болгон өгөхийг завдсан гэмт хэрэгт холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судаллаа. Үүнд:

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч С.М-ын өгсөн ...2013 оны 07 дугаар сард Д.Э-тэй уулзахад тэрээр "Булган аймгийг

камержуулах тендер явагдах гэж байна, энэ тендерт танай компани оролцохгүй юм уу?" гэсэн санал тавьсан. Манай компани ийм үйл ажиллагаа явуулдаггүй учраас оролцох боломжгүй гэдгээ хэлээд харин манай найз Б.Б-ын компани энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг учраас найзтайгаа уулзаад, тендерийн талаар хэлж оролцох эсэхийг нь асууж, хэрэв оролцоно гэвэл дэмжиж туслахаа хэлсэн. Би Б.Б-тэй уулзаж энэ талаар хэлэхэд тэр зөвшөөрч би Д.Э-тэй дахин уулзсан. Д.Э-тэй "нэг танил эгчтэйгээ уулзуулъя, Булганы хүн байгаа юм та нарт туслах байх" гэж хэлсэн. Тэгээд П.Х гэх хүнтэй уулзуулсан. П.Х-тэй уулзахад өөрийгөө Булган аймгийн хүн, манай ах дүү нар Булган аймагт амьдардаг, хэрэв танай компани тендерт оролцвол ялахад тань туслана. Харин ажлынхаа хөлсөнд 18.000.000 төгрөг авна гэж хэлсэн. Би П.Х-тэй уулзсан талаараа Б.Б-д очиж хэлсэн. Бид тендерийн материалаа бүрдүүлэхдээ П.Х-ээс заавар авч бүрдүүлээд материалаа өгөхөөр Булган аймагт ирэхэд П.Х-ийн дүү гэх Л.Б тосож авч танилцсан. Дараа нь Л.Б, П.Х-ийн ажлын хөлсөндөө авна гэж анх ярьж байсан 18.000.000 төгрөгийг нэхсэн. Бид ажлаа дуусгаж байж авах ёстой гэсэн байр суурьтай байсан ч мөнгийг авахаар их шахамдуулсан, өгөхгүй бол ялуулахгүй гэж хэлж байсан тул бид нэгэнт зорьсон хэрэг тул бүтэх байлгүй гэж бодоод өдөржин энд тэндээс мөнгө хайж байгаад олж өсгөн. Гэтэл тендерийн хариу өөр гарсан тул Л.Б-ээс мөнгөө нэхэхэд хэд хэдэн хүнд хуваан өгсөн талаараа хэлээд өгөхгүй байсан. Бид мөнгөө олж авахын тул Авлигатай тэмцэх газарт өргөдөл гаргасан ч бидэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан. Бид Л.Б, П.Х нарын нэхэмжилсэн мөнгийг тендерт оролцоход хураалгадаг мөнгө гэж ойлгосон тул хээл хахууль өгч байна гэж ойлгоогүй гэв.

Шүүгдэгч Б.Б-ын өгсөн: 2013 оны 08 дугаар сарын дундуур манай найз С.М Булган аймгийг камержуулах тендер эхлэх гэж байгаа юм байна энэ талаар туслах хүмүүстэй уулзаад ирлээ энэ тендерт хамт оролцоё гээд манай ажил дээр ирсэн. Би зөвшөөрсөн. Тендерийн материалаа бүрдүүлээд өгснөөс хойш 7 хоногийн дараа С.М над руу залгаад



18.000.000 төгрөгийг бидний ажилд тусалж байгаа Л.Б нэхэж байна гэсэн. Л.Б мөнгөө нэн дариу олж өгөхийг шаардаж байсан тул бид хоёр 18.000.000 төгрөгийг хайж байгаад би 12.000.000 орчим төгрөг, С.М 6.000.000 орчим төгрөгийг олоод Л.Б-ийн нэр дээрх ХААН банкны данс руу шилжүүлсэн. Гэтэл тендерт танай компани шалгарсангүй гэж Л.Б залгаж хэлсэн. Тендерт шалгараагүй учраас Л.Б-ээс 18.000.000 төгрөгөө эргүүлэн авахаар шаардсан ч тал мөнгийг өгөхгүй байсан тул Авлигатай тэмцэх газарт өргөдөл гарсан. Бид бусдад хээл хахууль өгсөн гэж ойлгосон бол Авлигатай тэмцэх газар өргөдөл өгөхгүй л байсан. Тендерт ороход ийм хэмжээний мөнгө өгдөг л юм байх гэж ойлгосон гэв.

20130600045 дугаартай эрүүгийн хэргээс мөрдөн байцаалтын шатанд:

Л.Б-ийн ХААН банкин дахь 527026xxxx дугаартай харилцах дансанд

2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 цаг 22 минутад 502407xxxx тоот данснаас Б.Б-ээс түр зээл 6.800.000 төгрөгийн орлого хийснийг мөн өдрийн 13 цаг 31 минутад 6.800.000 төгрөгийн зарлага хийсэн, 14 цаг 55 минутад 502407xxxx тоот данснаас Б.Б-ээс 8.000.000 төгрөг, 16 цаг 52 минутад С.М-ээс 3.200.000 төгрөгийн орлого хийсэн талаарх депозит дансны дэлгэрэнгүй хуулга /хх 83 дугаар тал/,

Б.Б-ын ХААН банкин дахь 50xxxxxxx тоот данснаас 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 цаг 22 минутад 6.800.000 төгрөг, 14 цаг 55 минутад 8.000.000 төгрөгийг 52xxxxxxx дугаартай дансанд шилжүүлсэн тухай депозит дансны дэлгэрэнгүй хуулга /хх 174 дүгээр тал/,

С.М-ийн ХААН банкин дахь 50xxxxxxx тоот дансанд 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 20 минутад Л.Б-ээс 11.200.000 төгрөг, 2013 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 18 минутад 2.200.000 төгрөг, 2013 оны 12 сарын 23-ны өдөр 200.000 төгрөг тус тус шилжүүлэн өгсөн тухай депозит дансны дэлгэрэнгүй хуулга /хх 216, 219 дүгээр тал/,

Гэрч Д.Хд-ийн өгсөн: ...Ажлын нөхцөл байдлын улмаас бүх хуралд бүрэн гүйцэт оролцож чадаагүй, гэхдээ гол материал үнэлэх, шийдвэр гаргах хуралд суусан. Үнэлгээний хороо шударгаар ялагчийг тодруулсан, эхний тендер Сангийн яамнаас хүчингүй болгосон. Үндэслэл нь шалгарсан компани нь хүчингүй тусгай зөвшөөрөл

хавсаргасан, мөн Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны сертификат байхгүй гэсэн үндэслэлээр хүчингүй болсон. Д.Г, Г.Г нар ийм асуудлаар надтай холбогдож байгаагүй. Харин Л.Б нэг компанийг дэмжээд өгөөч гэж яриад байна. Үнэлгээний хорооны хурал хэзээ болох юм бэ, ямар журмаар үнэлдэг юм бэ гэж асууж байсан. Мөн "А" ХХК-ийг дэмжээд өгөөч гэж хэлж байсан. Би тийм боломж байхгүй журмын дагуу үнэлнэ гэж хэлсэн. Ингээд дараа нь Үнэлгээний хорооны хурал болоод ялагчийг шалгаруулсан. Хэзээ гэдгийг нь сайн санахгүй байна тендер шалгарсны дараа Л.Б эмчтэй тааралдахад нөгөө дэмжээд өгөөч гээд байсан компанийн хүмүүс чинь мөнгө төгрөг ирүүлээд би тэр мөнгийг буцаагаад өгсөн гэж хэлж байсан. Энэ үед би та тэгвэл цагдаад өгч шалгуулмаар юм байна даа гэж хэлж байсан. Миний хувьд Үнэлгээний хороо хуулийн дагуу ажилласан болохоор өөрсөддөө итгэлтэй байсан. Дахин энэ асуудлаар бид уулзаж яриагүй"...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 13-14 дүгээр тал/,

гэрч Ө.Н-ийн өгсөн: "2013 оны намар Үнэлгээний хороо ялагчийг шалгаруулаагүй байх үед манай ажил дээр Л.Б ирээд манай өрөөнд уулзсан. Гэхдээ надад манай хамаатны эгчийн компани энэ камержуулах тендерт оролцож байгаа юмаа. Энэ дээр туслах боломж юу байна гэж хэлсэн. Би эмч минь ийм асуудлаар оролдоод яах вэ сүүлд нь эвгүй зүйлд холбогдоно гэж хэлсэн. Харин Үнэлгээний хороо ялагчийг шалгаруулсны дараа ирж уулзахдаа эгч нь хүнд хүний мөнгө өгчихөөд балай юм болж байна. Яаж энэ мөнгөө авах вэ хаана хандах вэ гэж байсан би түүнээс ямар мөнгө хэнд хэзээ, хэрхэн өгсөн талаар асуухад тендертэй холбоотой хүний мөнгийг хүнд өгсөн гэж хэлж байсан. Үүнээс өөр тодорхой юм яриагүй би түүнд анхнаасаа хэрэггүй гэж байхад гэж хэлээд холбогдох хуулийн байгууллагад хандахыг зөвлөж байсан... Д.Г над руу хэд хэдэн удаа яриад ах нь дүүтэйгээ уулзах хэрэгтэй байна гэж хэлсэн. Би та яах гэж байгаа юм бэ гэхээр нэг хувийн ажил байна гэж хэлдэг байсан. Би уулзаагүй, харин хамгийн сүүлд нь та ямар хэргээр уулзах гэж байгаа талаар асуухад, аа харин энэ камерын тендер гэж хэлэхээр нь за Д.Г ахаа энэ талаар огт ярихгүй шүү гэж хэлээд утсаа тасалсан, түүнээс хойш надтай дахин яриагүй, уулзаагүй. Тэгсэн сүүлд сонссон чинь нас барсан гэж байсан. Бид

хоорондоо энгийн харилцаатай ямар нэгэн садан төрлийн болоод найз нөхдийн холбоо харилцаа байхгүй. Надад хэн нэгнээс хууль бус ямар нэгэн санал огт ирж байгаагүй...гэх мэдүүлэг /хх-2 дугаар хавтасны 15-16 дугаар тал/,

гэрч П.Х-ийн өгсөн: ...2013 оны 08 дугаар сарын үед байх нөгөө телекамер хариуцсан Д.Э гэх залуу над руу утсаар яриад таньд зав байна уу уулзах хэрэг байна гэсэн. Би тухайн үед Худалдаа хөгжлийн банкны урд талын кафед гадаадын хэдэн хүмүүстэй хоол идэж дуусаад тарж байсан юм. Ингээд би Д.Э-г энд хүрч ирээд уулз гэж хэлсэн. Д.Э "А" гэх компанийн залууг дагуулан ирсэн бөгөөд тэд та Булган аймгийн хүн биз дээ, Булган аймагт камер суулгах тендер зарлагдсан байна. Тэр тендерт бид орох гэсэн юм та туслаач, хамтраад ажиллах хүн байна уу гэж хэлсэн. Би эгч нь туслаад өгье, "А" компани чинь том компани юм чинь ялах байх гэж хэлсэн. Булган аймагт дүү маань байгаа тэр хүнтэй та нарыг холбож өгье гэж хэлээд бид нар салцгаасан. Үүнээс хэд хоногийн дараа өөрийн садангийн дүү Булган аймгийн Булган суманд оршин суух Л.Б-тэй ярьсан. Тэгсэн тэр дүү маань зөвшөөрөөд "бололгүй яах вэ, би энд ажил төрөл хийх үед нь туслаад өгнө өө. Наад хэд чинь том компани юм бол ялах байх" гэж хэлсэн. Би тийм бол чамд утсыг нь өгье гэж хэлээд Л.Б-д Д.Э-ийн утсыг өгсөн. Түүнээс хойш юу болсон талаар сайн мэдэхгүй би гадагшаа явах болсон тул яваад 20 гаран хоног болоод ирсэн. Ирээд Л.Б-тэй утсаар ярих далимдаа асуусан чинь ялж чадаагүй гэж хэлсэн. Би тухайн үед нь "А" гэдэг компани чинь тийм том биш юм байна ш дээ гэж хэлээд өнгөрсөн өөр асуудал болоогүй. Би зүгээр л тусалъя гэсэн. Би тухайн үед "А" гэдэг компани чинь дэлгүүрийн сүлжээтэй юм чинь хөдөөний нэг тендерийг авчих боломжтой байх гэж хэлж байсан. Мөн авах ч байх гэж бодсон. Л.Б Үнэлгээний хороонд ороогүй Л.Б чинь эрүүл мэндийн нэгдэлд эмч хийдэг, гэхдээ нийгмийн идэвхтэй, зохион байгуулах чадвар сайтай, хүнтэй их эвтэйхэн ярьдаг болохоор түүнийг туслаад өгнө гэж бодож, хооронд нь холбож өгсөн, ...миний хувьд энэ хоёрыг хооронд нь уулзуулж өгөөд мөнгө төгрөг авсан зүйл байхгүй, мөнгө төгрөг авахаар ярилцаж тохиролцсон зүйл байхгүй...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 17-18 дугаар тал/,

гэрч Д.Э-ийн өгсөн: ...П.Х эгч яг өөрөө тендер авч өгч чадна энэ тэр гэж хэлээгүй

харин туслая гэж хэлж байсан. Ер нь бол П.Х эгч бол бүрхэг байсан, харин энэ С.М, Б.Б нар мөнгө өгсөн гэж сүүлд сонссон. Яах гэж мөнгө хэнд өгсөн талаар мэдэхгүй би бол П.Х эгчтэй С.М-ийг уулзуулаад өгсөн... үүнээс хойш хэн хэнтэй нь тухтай уулзаж чадаагүй, харин зун С.М-тэй уулзахад Булганы тендер будлиад ямар ч ялагчгүй болсон, Б.Б П.Х эгчийн танил гэх хүнд нь мөнгө өгөөд алдсан гэж хэлж байсан. Хэдэн төгрөг яах гэж өгсөн талаар олигтой зүйл яриагүй би ч сонирхож асуугаагүй...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 19-20 дугаар тал/,

гэрч Л.А-ийн өгсөн: ...энэ компани яагаад шалгараагүйг мэдэхгүй байна, одоо санахгүй байхыг бодоход тийм сайн үнэлгээ авч чадаагүй л компани байна даа. Материалаа харвал сайн мэдэх байх. Үнэлгээний хорооны гишүүдэд гаднаас нөлөөлсөн ямар нэгэн нөлөөлөл байхгүй, учир нь манай Үнэлгээний хороо энэ шийдвэрийг гаргаагүй, Сангийн яамнаас дахин тендерийг зарла гэхээр нь тэдний хүсэлтийн дагуу "Т" ХХК-ийг шалгаруулсан. Үнэлгээний хорооны тавьсан шаардлагад нийцсэн 2 компаниас манайхан нэгийг нь шалгаруулсан, харин Сангийн яамнаас "Т"-ийг үндэслэлгүйгээр татгалзсан байна гэсэн хариу ирсний дагуу энэ компанийг шалгаруулсан. Надад энэ тендертэй холбоотой ямар нэгэн компанийг шалгаруулаад өгөөч гэсэн хүсэлт хэнээс ч ирж байгаагүй, би хуулийн дагуу ажилласан, манай Үнэлгээний хороо ч хуулийн дагуу ажилласан. Надад үүнээс өөр хэлж ярих зүйлгүй ...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 22-23 дугаар тал/,

гэрч Э.Нд-ийн өгсөн: ...Би 2013 оны 08 дугаар сарын сүүлээр амралтаа авсан. Энэ үед миний ажлыг хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны ажилтан Д.Г орлож байсан гэхдээ энэ хүн Үнэлгээний хорооны хурал болон бусад сонгуульт ажилд оролцоогүй учир нь энэ хүн худалдан авах ажиллагааны сертификат /А-3/ байхгүй. Д.Г нь 2013 оны 09 дүгээр сард нас барсан одоо яг хэзээ гэдгийг нь сайн санахгүй байна. Үнэлгээний хороонд намайг ажиллаж байх хугацаанд ямар нэгэн дарамт шахалт, хууль бус санал хүсэлт огт ирээгүй. Би Д.Г-той энгийн харилцаатай...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 24-25 дугаар тал/,

яллагдагчаар Л.Б-ийн өгсөн...Би тэр хүмүүст Засаг даргын Тамгын газрын Худалдан авах ажиллагааны газрыг зааж өгч

материалыг нь өгүүлсэн. ...Ингээд би Засаг даргын Тамгын газар луу орж явсан чинь Д.Г-той шатан дээр тааралдсан. Би түүнээс энэ тендерийн талаар асуусан чинь "өнөөдөр шалгаруулалт нь болох гэж байгаа ш дээ" гэж хэлсэн. ...Би "А" ХХК яасан талаар асуусан чинь тэр компани чинь шалгараагүй гэж хэлсэн. Гэхдээ энэ шийдвэр эцсийн шийдвэр биш гэж хэлсэн. ...Мөн бас нэг компанийн нэрийг хэлээд тэр компанийн хүмүүс тендерийн Үнэлгээний хорооны гишүүдэд үнийн дүнгийн 5% тэнцэх мөнгө өгөх гэж байгаа юм байна лээ гэж хэлж байсан. Тэгээд Д.Г-оос салаад нөгөө С.М луу яриад ингэж байна гэж хэлсэн чинь тэгвэл манай компани 6% -тай тэнцэх хэмжээний мөнгө өгье гэж хэл гэсэн. ...Утсаар ярьж дуусаад тамгын газраас гараад явж байсан чинь сумын халамжийн байцаагч Г.Гд-тэй тааралдаад худалдан авах ажиллагааны газар таних хүн байна уу гэж асуусан чинь би хүн танихгүй харин хүнээс асууж өгье гэж хэлсэн. Ингээд би хэнээс асуух гэж байгаа юм бэ гэсэн чинь Булган сумын газрын даамал Г.Г-ээс асууж үзье тэр энд аймгийн "А" намын нөхдүүдтэй ойр дотно байх гэж хэлсэн. Тэгээд гэртээ байж байхад Г.Гд залгаад Г.Г туслая гэнэ, эхний ээлжинд үнийн дүнгийн 3% буюу 18.000.000 төгрөг өг гэж байна гэсэн. Би тэгэхээр нь С.М луу залгаад үнийн дүнгийн 3% тэнцэх хэмжээний мөнгийг өг гэж байна яах вэ гэж асуусан. Тэгсэн дансны дугаар өг гэж хэлсэн. ...Бид нарт байгаа мөнгө нь 6.000.000 төгрөг байна үлдсэн мөнгийг нь дэлгүүрийн орлогыг аваад бөөгнүүлээд танд шилжүүлэе гэж хэлсэн. Ингээд миний Хаан банкны 52xxxxxxx дугаарын дансаар 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдөр эхний ээлжинд 6.800.000 төгрөг шилжүүлсэн байсан. ...Хаан банкнаас мөнгөө аваад Г.Гд руу яриад мөнгө нь ороод ирлээ нөгөө өгөх хүмүүст нь өг гэж хэлсэн. Г.Гд Хаан банкны үүдэнд ирэхээр нь би банкнаас авсан мөнгөө ууттай чигээр нь Г.Гд-д өгөөд нөгөө хүмүүстээ өг гэж хэлсэн. Тэгсэн Г.Гд Хаан банкны үүдэнд Г.Г-д ууттай мөнгийг өгөөд, Г.Г мөнгийг авсан, би банк дотроос хараад зогсож байсан. ...Тэгсэн Г.Гд над руу утсаар яриад Г.Г бүхэл мөнгийг авсан задгай 800.000 төгрөгийг өгсөн шүү гэж хэлсэн. Би Хантайд амраад 4 хоногийн дараа ирсэн чинь С.М над руу залгасан чинь та яасан бэ гэж хэлээд уурласан. Би энэ ажлыг сурагласан чинь өөр компани шалгарсан байна гэж сонсоод Г.Гд руу ярьсан чинь яана тийм үү би ёстой мэдээгүй ш дээ гэж хэлсэн. Би Г.Г-

ээс мөнгөө авъя гэж хэл гэсэн. Тэгсэн Г.Г үйл ажиллагаа дуусаагүй байна Үнэлгээний хорооны эхний хурал хуралдсан эхний хурал дээр дараагийн шатанд шалгарах хэдэн компанийг шалгаруулсан тэрэнд үлдсэн харин одоогийн орох шатанд ийм зүйл бүрдүүлж өг гэж хэлээд 8-н төрлийн зүйл бичүүлж Г.Гд-д өгсөн байна лээ. Уг бичгийг С.М-д утсаар хэлээд өгсөн чинь С.М манайх энэ жагсаалтад байгаа зүйлийг хийсэн гэсэн. ...Тэгээд Д.Г-той уулзахад Засаг даргын захирамж гараагүй болоогүй байна гэж хэлж байсан. Тэгээд С.М, Б.Б нарыг залгахаар би бас болоогүй байгаа тухай хэлж байсан. Тэгээд сүүлдээ бүтэхгүй болохоор нь өөрт байсан 11.200.000 төгрөгийг буцаагаад С.М-ийн данс руу шилжүүлсэн...гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 56-58 дугаар тал/,

яллагдагчаар Г.Гд-ын өгсөн...миний хувьд энэ тендерт оролцсон компанийг болон энэ хүмүүсийг огт танихгүй ямар нэгэн харилцаа холбоо байхгүй. ...Л.Б эмч 2013 онд 08 дугаар сарын эхээр байх цаг хугацааг нь нарийн сайн санахгүй байна, Худалдан авах ажиллагааны газарт таньдаг хүн байна уу би зөвлөгөө авах гэсэн юмаа гэж хэлсэн. Би надад таньдаг хүн байхгүй харин хүнээс асуугаад өгье гэж хэлсэн. Ингээд би нэг өрөөнд цуг суудаг Г.Г-д энэ тухай хэлсэн. ... Би Л.Б эмчид Г.Г-ын утасны дугаарыг өгсөн тэд хоорондоо ярьсан байх. Хэсэг хугацааны дараа байх Л.Б эмч над руу яриад завтай бол Хаан банкин дээр хүрээд ир гэж хэлсэн. Би яваад очсон чинь Л.Б эмч гартаа бор өнгийн ууттай юм барьсан байсан бөгөөд уг зүйлийг гадаа зогсоол дээр байгаа Г.Г-д гаргаад өгчих гэж хэлсэн. Би уг ууттай зүйлийг Г.Г-д гаргаад өгсөн тухайн үед Г.Г машин дотроо сууж байсан. ...Харин сул задгай байсан мөнгийг буцаагаад өгчих задгай нь хэрэггүй гэж хэлсэн. Би уг машинаас гарахад Л.Б эгч Хаан банкны үүдэн дээр намайг харж зогсож байхаар нь би ууттай сул мөнгийг авахгүй гэж байна гэж хэлээд өгсөн... гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 141-142 дугаар тал/,

яллагдагчаар Г.Г-ийн өгсөн ...Энэ хэргийн холбогдогчид болох компанийн эздийг огт танихгүй, хараагүй ямар ч холбоо харилцаа байхгүй. ....Харин өрөөний бүсгүй болох Г.Гд-д тусалж хүнтэй холбож өгсөн... Тэрнээс Г.Гд-ээс Т.М-д мөнгө дамжуулахдаа ямар нэгэн ашиг хонжоо хувийн бусад шалтгаанаар хандаагүй. Тэд нар ч надад мөнгө өгөөгүй, амлаагүй. Худалдах худалдан авах ажиллагааны хэлтэст таньдаг хүн

байхгүй. Мөн тухайн үед зарлагдсан тэр тендерт ч миний мэдэх хүн ороогүй байсан хэн, хэн орсныг ч мэдээгүй... Задгай мөнгө, боогоогүй болохоор их овортой харагдаад байсан. Тэгээд ч хүнд сагсайсан мөнгө аваачиж өгөхөөсөө төвөгшөөгөөд үлдээсэн... Надад Т.М энэ тендерт өөр нэг компани ялагчаар шалгаруулвал тендерийн үнийн дүнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгө амласан байна. Чиний яриад байгаа компани энэ компаниас илүү хувь өгч чадах уу гэж асуусан. Би Г.Г руу яриад ийм асуудал яригдаад байна танай тэр компани чинь үүнээс илүүг өгч чадах уу гэж асууж байна гэж хэлсэн. Г.Гд эргээд залгая гэж хэлсэн. Ингээд удалгүй өгье гэж байна гэж хэлсэн тэгээд тохиролцоод 6.000.000 төгрөгийг өгсөн гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны 134 дүгээр тал/,

яллагдагчаар Т.М-ийн өгсөн ...2013 оны 08 дугаар сарын 20-ны өглөө 10 цагийн үед Булган аймгийн Булган сумын газрын даамал Г.Г над руу утсаар яриад Булган аймгийн Булган сумыг камержуулах тендер зарлагдсан юм байна. Энэ тендерт манай нэг танилын компани оролцож байгаа юм байна. Энэ тендерт ялахад нь тусалж дэмжээд өгөх хүн байна уу өнөөдөр шалгаруулалт нь болох гэж байгаа талаар хэлсэн. Би нэг хүн байгаа асууя гэж хэлсэн. ...Ингээд би Д.Г-ын утсыг мэдэхгүй тул түүнтэй очиж уулзахаар ажил дээр нь очсон. Түүний ажил дээр очиход тэр гарч ирж таарсан бөгөөд энэ талаар хэлэхэд нэг компани энэ тендерт ялвал 5% тэнцэх хэмжээний мөнгө өгнө гэж байна чиний яриад байгаа компани чинь үүнээс илүүг өгч чадах уу гэж асуусан би хажууд нь байж байгаад Г.Г руу ярьсан. Г.Г хариу хэлье гээд удалгүй залгаж тэгийг гэнээ гэж хэлсэн. Д.Г энэ үед одоо урьдчилгаа талыг нь авмаар байна гэж хэлсэн. Тэгтэл Г.Г цаад хүмүүстэйгээ ярилцаад хариу хэлье гээд мөн удалгүй урьдчилгаа 3%-ийг нь өгье хаана уулзах вэ гэж Г.Г асуухаар нь би "АН"-ын гадаа уулзъя гэж хэлсэн. Ингээд би Г.Г-г ярихад уулзъя гэж хэлээд түүнээс салсан. Удалгүй Г.Г над руу залгаад Хаан банкны гаднаас мөнгөө авч байна одоо очлоо гэж хэлсэн. Би өөрийн эзэмшлийн улаан өнгийн Ниссан патрол маркийн машинтай Д.Г-г ажлаас нь аваад "АН"-ын урд талын зогсоол дээр очоод зогсож байсан чинь Г.Г өөрийн хх-хх БУА гэсэн дугаартай саарал өнгийн приус маркийн автомашинтай ирээд миний машины арын суудалд Д.Г-ын хажууд суусан.

Тэгээд Г.Г нөгөө мөнгө чинь энэ 6.000.000 төгрөг гэж хэлээд өгсөн үлдсэн мөнгийг тендерт шалгарсны дараа өгье гэж байна гэж хэлээд бор өнгийн ууттай зүйл өгсөн дотор нь мөнгө байсан эсэхийг мэдэхгүй. Тэгээд орой уулзахаар болоод салсан. Орой уулзсан эсэхийг мэдэхгүй надтай уулзаагүй. Маргааш нь Г.Г яриад нөгөө компани чинь шалгараагүй юм байна нөгөө өгсөн мөнгөө буцааж авъя гэж хүмүүс нь мөнгөө нэхээд байна гэж хэлсэн. Би ч Д.Г дээр очоод нөгөө компани чинь шалгараагүй гэж байна гэж хэлсэн. Тэгсэн Д.Г энэ бол эцсийн шийд биш харин чиний энэ компани чинь материалаа маш муу бүрдүүлсэн байна. Ядаж камер тавих тусгай зөвшөөрөлгүй юм байна ш дээ яаж ч зүтгүүлээд нэмэр алга гэж хэлсэн. Мөн тендер одоо дахин зарлагдана энэ хугацаанд энэ зүйлүүдийг бүрдүүлээд ир гэж хэлээд жижигхэн цаасан дээр бичсэн жагсаалт өгсөн. Тэр жагсаалтыг би Г.Г-д өгөөд яаралтай бүрдүүл гэж хэлсэн... Би Булганд ирээд Д.Г-той уулзаад хэлсэн чинь зүгээр ээ шалгаруулна аа гэж хэлдэг байсан. Би болохгүй нээ хүмүүс нь мөнгөө нэхээд байна гэж хэлж байгаад 2.000.000 гаран төгрөгийг аваад уг мөнгөө Г.Г-д өгсөн. Харин үлдсэн мөнгийг нь удаалгүй өгнө гэж хэлсэн. Ингээд сар гарангийн дараа Д.Г 2013 оны 09 дүгээр сарын үеэр байх Н.Т-ийн Харцага цолны мялаалгын наадамд явж байгаад нас барсан талаар мэдсэн...Тэгээд энэ мөнгийг өөрөөсөө цувуулж аргалж байгаад бүрэн төлсөн. Энэ мөнгөнөөс уг нь би ямар ч мөнгө аваагүй нөгөө авсан хүн нь нас барсан болохоор өөрөөсөө мөнгийг нь төлсөн гэх мэдүүлэг /хх 2 дугаар хавтасны, 128-129 дүгээр тал/,

2014 оны 02 сарын 14-ний өдрийн шинжээчийн дүгнэлтэд:

..."Т" ХХК-ийн ирүүлсэн тендерийн материал нь захиалагчийн тавьсан нөхцөл шаардлагыг бүрэн хангаж байгаа тул тус тендерт шалгаруулах үндэслэлтэй байна" гэх дүгнэлт /хх 2 хавтасны 30-31 дүгээр тал/, эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол /хх 2 дугаар тал/, эд хөрөнгө битүүмжлэх тухай тогтоол, тэмдэглэл /ХХ 234-236, 241-243 дугаар тал/, сэжигтэн, яллагдагчаар байцаасан тэмдэглэл /хх 2 дугаар хавтасны 44-47 дугаар тал, 50, 52-53 дугаар тал/, шүүгдэгч нарын урьд ял шийтгүүлж байгаагүй талаарх ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх 2 дугаар хавтасны 83-84 дүгээр тал/ зэрэг болно.

Дээрх нотлох баримт нь тухайн хэрэгт хамааралтай, Эрүүгийн байцаан

шийтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн, хэрэг хянан шийдвэрлэхэд хангалттай байна гэж шүүх үнэлэв.

Шүүгдэгч С.М, Б.Б нар нь 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Булган аймгийн Булган сумыг камержуулах тендер сонгон шалгаруулалтад "А" нэрээр оролцож ялалт байгуулахын тулд Л.Б-ийн ХААН банкин дахь дансаар 18.000.000 төгрөгийг шилжүүлж эрх бүхий албан тушаалтанд хээл хахууль болгон өгөхийг завдсан гэмт хэргийг үйлдсэн болох нь;

мөрдөн байцаалтын болон шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч С.М, Б.Б нарын ...Булган аймгийг камержуулах тендер материал бүрдүүлж оролцсон. ...Ажлын хөлс гэж ойлгон Л.Б-д 18.000.000 төгрөгийг түүний ХААН банкны дансаар шилжүүлсэн гэх мэдүүлэг,

Л.Б-ийн ХААН банкин дахь 52xxxxxxx дугаартай харилцах дансанд "2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 цаг 22 минутад 50xxxxxxx тоот данснаас Б.Б-ээс түр зээл 6.800.000 төгрөгийн орлого хийснийг мөн өдрийн 13 цаг 31 минутад 6.800.000 төгрөгийн зарлага хийсэн, 14 цаг 55 минутад 50xxxxxxx тоот данснаас Б.Б-ээс 8.000.000 төгрөг, 16 цаг 52 минутад С.М-ээс 3.200.000 төгрөгийн орлого хийсэн" талаарх депозит дансны дэлгэрэнгүй хуулга,

Б.Б-ийн ХААН банкин дахь 50xxxxxxx тоот данснаас 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 13 цаг 22 минутад 6.800.000 төгрөг, 14 цаг 55 минутад 8.000.000 төгрөгийг 52xxxxxxx тоот дансанд шилжүүлсэн талаарх депозит дансны дэлгэрэнгүй хуулга,

С.М-ийн ХААН банкин дахь 50xxxxxxx тоот дансанд 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 20 минутад Л.Б-ээс 11.200.000 төгрөг, 2013 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 10 цаг 18 минутад 2.200.000 төгрөг, 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 200.000 төгрөг тус тус шилжүүлсэн талаарх депозит дансны дэлгэрэнгүй хуулга,

гэрч Д.Хд-ийн "Үнэлгээний хороо шударгаар ялагчийг тодруулсан эхний тендер Сангийн яамнаас хүчингүй болгосон. ...Д.Г, Г.Г нар ийм асуудлаар надтай холбогдож байгаагүй. Харин Л.Б нэг компанийг дэмжээд өгөөч гэж яриад байсан. Би тийм боломж байхгүй журмын дагуу үнэлэнэ гэж хэлсэн. Үнэлгээний хорооны хурал болоод ялагчийг шалгаруулсны дараа Л.Б эмчтэй тааралдсан чинь нөгөө дэмжээд өгөөч гээд байсан компанийн хүмүүс чинь мөнгө төгрөг

ирүүлээд би тэр мөнгийг буцаагаад өгсөн гэж хэлж байсан"...гэх мэдүүлэг,

гэрч Ө.Н-ын "2013 оны намар Үнэлгээний хороо ялагчийг шалгаруулаагүй байх үед Л.Б надтай манай ажил дээр ирж уулзаад, манай хамаатны эгчийн компани энэ камержуулах тендерт оролцож байгаа юмаа. Энэ дээр туслах боломж юу байна гэж хэлсэн. Би эмч минь ийм асуудлаар оролдоод яах вэ сүүлд нь эвгүй зүйлд холбогдоно гэж хэлсэн" гэх мэдүүлэг,

гэрч П.Х-ийн "Надад Булган аймагт байдаг дүү байгаа, тэр хүнтэй та нарыг холбож өгье гэж хэлээд бид нар салцгаасан. Үүнээс хэд хоногийн дараа өөрийн садангийн дүү Булган аймгийн Булган суманд оршин суух Л.Б-тэй ярьсан. Тэгсэн тэр дүү маань зөвшөөрөөд бололгүй яах вэ би энд ажил төрөл хийх үед нь туслаад өгнө өө. Наад хэд чинь том компани юм бол ялах байх гэж хэлсэн. Би тийм бол чамд утсыг нь өгье гэж хэлээд Л.Б-д Д.Э-ийн утсыг өгсөн... миний хувьд энэ хоёрыг хооронд нь уулзуулж өгөөд мөнгө төгрөг авсан зүйл байхгүй"...гэх мэдүүлэг,

гэрч Д.Э-ийн "П.Х эгч яг өөрөө тендер авч өгч чадна энэ тэр гэж хэлээгүй, харин туслая гэж хэлж байсан. Ер нь бол П.Х эгч бүрхэг байсан, харин энэ С.М, Б.Б нар мөнгө өгсөн гэж сүүлд сонссон. Яах гэж мөнгө хэнд өгсөн талаар мэдэхгүй, би бол П.Х эгчтэй С.М-ийг уулзуулаад өгсөн" ...гэх мэдүүлэг,

гэрч Л.А-ын Үнэлгээний хорооны гишүүдэд гаднаас нөлөөлсөн ямар нэгэн нөлөөлөл байхгүй. Сангийн яамнаас "Т"-ийг үндэслэлгүйгээр татгалзсан байна гэсэн хариу ирсний дагуу энэ компанийг шалгаруулсан. Надад энэ тендертэй холбоотой ямар нэгэн компанийг шалгаруулаад өгөөч гэсэн хүсэлт хэнээс ч ирж байгаагүй би хуулийн дагуу ажилласан манай Үнэлгээний хороо ч хуулийн дагуу ажилласан ...гэх мэдүүлэг,

гэрч Э.Нд-ийн "Би 2013 оны 08 дугаар сарын сүүлээр амралтаа авсан. Энэ үед миний ажлыг хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны ажилтан Д.Г орлож байсан гэхдээ энэ хүн Үнэлгээний хорооны хурал болон бусад сонгуульт ажилд оролцоогүй учир нь энэ хүн худалдан авах ажиллагааны сертификат /А-3/ байхгүй. Д.Г нь 2013 оны 09 дүгээр сард нас барсан. ...Үнэлгээний хороонд намайг ажиллаж байх хугацаанд ямар нэгэн дарамт шахалт, хууль бус санал

хүсэлт огт ирээгүй"...гэх мэдүүлэг,

Л.Б нь өөрийн танил Г.Г-д 6.800.000 төгрөг өгснийг Г.Г нь 6.000.000 төгрөгийг Г.Г-д, Г.Г нь Т.М-д, Т.М нь Д.Г-д дамжуулан өгсөн гэх тэдний яллагдагчаар өгсөн мэдүүлэг,

2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн шинжээчийн дүгнэлт зэрэг хуульд заасан үндэслэл журмын дагуу бэхжүүлэгдэн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.

Иймд шүүгдэгч С.М, Б.Б нарыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгөх гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэм буруутайд тус тус тооцож, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлтэй байна гэж шүүх дүгнэлээ.

Шүүгдэгч С.М, Б.Б нарт ял шийтгэл оногдуулахдаа анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдэхээр завсныг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцон, тэдний хувийн байдлыг харгалзан оногдуулах хорих ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзлээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 60 дугаар зүйлийн 60.3-т зааснаар гэмт хэрэг үйлдэхээр завдсан үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн аль хүнд төрлийн ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна гэж заасан хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-т хорих ялын доод хэмжээ заагаагүй тул мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасан хорих ялын доод хэмжээгээр ял оногдуулах нь зүйтэй байна.

Улсын яллагч шүүгдэгч нарын хээл хахууль болгон бусдад өгөхөөр шилжүүлсэн 18.000.000 төгрөгийг гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн бусад хэрэгсэл гэж үзэж улсын орлого болгох ёстой. Үүнийг хангуулахаар хэрэгт битүүмжлэгдсэн шүүгдэгч нарын тээврийн хэрэгслийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэхээр санал оруулж байгаа боловч Улсын дээд шүүхийн 2006 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолд "тээврийн болон бусад хэрэгсэл" гэдэгт гэм буруутай этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ учруулж болох хор аюулын хэмжээг ихэсгэх, гэмт үйлдлээ түргэсгэх, олж авсан эд зүйлийг зөөж тээвэрлэх, гэмт хэргийн газраас зугтах зорилгоор хэрэглэсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүх төрлийн тээврийн хэрэгсэл, гэмт үйлдлээ хялбар

болгох, хохирогчийн эсэргүүцлийг няцаах, учирч болох саадыг арилгахын тулд ашигласан төрөл бүрийн тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай буюу түргэн хордуулах бодисууд, хориотой үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, барилга байгууламж зэргийг хамааруулж ойлгохоор байгаа тул шүүгдэгч нарын хээл хахууль болгон бусдад өгөхөөр шилжүүлсэн 18.000.000 төгрөгийг гэмт хэрэг үйлдэхдээ хэрэглэсэн бусад хэрэгсэл үзэн улсын орлого болгох хууль зүйн үндэслэлгүй байна.

Иймд шүүгдэгч С.М-ийн нэр дээр бүртгэлтэй "Хюндай старекс" маркийн хх-хх УНГ улсын дугаартай автомашин, шүүгдэгч Б.Б-ийн нэр дээр бүртгэлтэй "Тоёота марк-2" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашин, "Тоёота Алфард" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашин, "Хюндай Портер" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашиныг битүүмжилсэн 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн зүйлгүй, шүүгдэгч С.М, Б.Б нар нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдахаар шийдвэрлэв.

Эрүүгийн Байцаан Шийтгэх Хуулийн 283, 284, 286, 290 дүгээр зүйлийн 290.3, 295-299 дүгээр зүйлүүдэд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүгдэгч С.М, Б.Б нарыг бусдаар дамжуулж албан тушаалтанд хээл хахууль өгөх гэмт хэргийг үйлдэхийг завдсан гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.2, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар шүүгдэгч С.М, Б.Б нарыг тус бүр нэг жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар шүүгдэгч С.М, Б.Б нарт оногдуулсан нэг жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсүгэй.

4. Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн зүйлгүй, шүүгдэгч С.М, Б.Б нар нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдсугай.

5. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10-т зааснаар С.М-ийн нэр дээр бүртгэлтэй "Хюндай старекс" маркийн хх-хх УНГ улсын дугаартай

автомашин, Б.Б-ийн нэр дээр бүртгэлтэй "Тоёота марк-2" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашин, "Тоёота Алфард" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашин, "Хюндай Портер" маркийн хх-хх УНС улсын дугаартай автомашиныг битүүмжилсэн 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгосугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4-т зааснаар шүүгдэгч С.М, Б.Б нарт оногдуулсан нэг жилийн хорих ялыг тэнсэж, тус бүрийн хянан харгалзах хугацааг нэг жилээр тогтоож, ялтанд хяналт тавихыг Цагдаагийн байгууллагад даалгасугай.

7. Шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болтол шүүгдэгч С.М, Б.Б нарт нарт авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

8. Шийтгэх тогтоолыг шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 7 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

9. Давж заалдах гомдол гаргах буюу эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Л.ДАРЬСҮРЭН

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч М.Алдар даргалж, шүүгч С.Оюунчимэг, Б.Мөнхбаяр бүрэлдэхүүнтэй,

Улсын яллагч Ж.Н.Га

Иргэдийн төлөөлөгч: Я.Гантөмөр, Д.Алтангэрэл, Б.Оюунгэрэл;

Шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нарын өмгөөлөгч: З.Төмөрхүү;

Шүүгдэгч А.М-ын өмгөөлөгч: Ц.Алтанцол;

Шүүгдэгч Д.Н-гийн өмгөөлөгч: С.Оюун;

Хохирогч: Р.Б;

Орчуулагч: Н.Мя;

Шинжээч: Ж.Ба;

Гэрч: Ч.У, Т.Э, Р.Э, Ц.Э, Ж.Э, Г.О нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Нийслэлийн прокурорын газраас В.Х.В-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт заасан гэмт, Х.Р.П-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан хэрэгт, А.М-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан хэрэгт, Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн 201201000471 дугаартай эрүүгийн хэргийг 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалтын талаар:

1. БНХАУ-ын иргэн, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ӨМӨЗО-ны Улаан Цав Жиней хотод төрсөн, ... настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, фото зурагчин мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ “ХЛ” ХХК-ийн захирлаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар G.....,

В.Х.В /WHW/,

2. БНХАУ-ын иргэн, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ӨМӨЗО-ны Улаан Цав Жиней хотод төрсөн, .. настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, засварчин мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ “ХЛ” ХХК-д нярав, засварчнаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны ... байранд оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар G....., Х.Р.П /HRP/,

3. Монгол Улсын иргэн, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ... настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч эдийн засагч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст Татварын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., хүүхдүүдийн хамт, Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар УС....., Б овогт Д.Н,

4. Монгол Улсын иргэн, ... оны ... дугаар сарын ...-ний өдөр Дорноговь аймгийн ... суманд төрсөн, ... настай, эрэгтэй, боловсролгүй, мэргэжилгүй, хэрэгт холбогдох үедээ хувиараа хөдөлмөр эрхэлж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Дорноговь аймгийн ... сумын ... дүгээр хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, регистрийн дугаар ЕК....., А овогт А.М.

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар:

Шүүгдэгч В.Х.В нь “ХЛ” ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа Х.Р.П, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/, болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа “ХЛ” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд



зохион байгуулагчаар оролцсон,

Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Д.Н-г 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр /24/10/0961 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу “ХЛ” ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийхэд нь онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгч, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай акт бичүүлсэн, мөн “ХЛ” ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс татварын улсын байцаагч Д.Н-д албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Х.Р.П нь “ХЛ” ХХК-д нярваар ажиллаж байхдаа В.Х.В, А.М нартай хамтран, давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/, буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа “ХЛ” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон, шүүгдэгч А овогт А.М нь “ХЛ” ХХК-ийн захирал В.Х.В, нярав Х.Р.П нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/, буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа “ХЛ” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

Шүүгдэгч Б овогт Д.Н нь Баянзүрх

дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6-д заасан “Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх” гэсэн заалтыг зөрчиж ганцаараа “ХЛ” ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, Аж ахуйн нэгжийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн “ХЛ” ХХК-д Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу “татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих” гэсэн заалтуудыг зөрчиж тус компанийн их хэмжээний татвар ногдох орлогыг илрүүлсэн атлаа дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагад шилжүүлэхгүй, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай “Татварын улсын байцаагчийн акт” бичиж, захирал БНХАУ-ын иргэн В.Х.В гэгчээс 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль авсан, мөн Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг тус “ХЛ” ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргаж өгч, “ХЛ” ХХК-ийн захирал В.Х.В-аас Ч.У-ээр зуучлуулан 450000 төгрөгийн хээл хахууль авч, энэ хэргийг давтан үйлдсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Шүүгдэгч В.Х.В шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Прокурорын яллах дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Компания анх 2004 онд мотоцикл худалдан борлуулах чиглэлээр байгуулсан. 2005-2006 оны орчим Х.Р.П-ыг урьж авчирсан. Ажил их, хүн хүрэлцэхгүй байсан учир түүнийг ирүүлж хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн. Тэгээд миний төрсөн ах В.М.Ж, хүргэн ах Х.Р.П нартай хамтран ажилласан. Х.Р.П нь засварчнаар ажиллахаар ирсэн. Тэгээд Ч.У гэдэг эмэгтэйг орчуулагчаар, нягтлангаар Х.Я гэдэг хүнийг авч ажиллуулсан. Компанийн

үйл ажиллагааг В.М.Ж, Ч.У, Х.Я нар авч явдаг байсан. Намайг байхгүй хойгуур төрсөн ах маань Ч.У-тэй дотно харьцаатай болсон байсан. 2008 онд Хятад худалдааны төв дотор ажиллаж байхад хулгай орж 70 гаруй сая төгрөгөө алдсан. 2008, 2009 онд мөн удаа дараа хулгай орсон. 2011 онд Ч.У хоосон цаасан дээр тамга даруулж 35 сая төгрөгийг данснаас авсан. Ах В.М.Ж ажлаа олигтой хийхгүй байсан учраас түүнийг нутаг буцааж би ажлаа авсан. Х.Я ажлаа сайн хийгээгүйгээс болж 2010 онд татварын талаар акт, торгууль тавигдсан. Үүнээс болж Х.Я бидэнд дургүйцдэг байсан. Ер нь Ч.У, Х.Я нар биднийг их хэмжээний татвараас зайлсхийсэн гэж гүтгэсэн. Эрүүгийн хуулийн 166.2 гэсэн зүйл ангийг хүлээн зөвшөөрөхгүй.

Би Д.Н гэдэг хүнийг танихгүй. Прокурорын газарт л анх харсан. Тэр өгсөн гээд байгаа мөнгийг би өгөөгүй, ах өгсөн байж магадгүй. Мэдэх зүйл алга. Ч.У намайг гүтгэж байна. Энэ хоёр жилийн хугацаанд сэтгэл санаа, эд зүйлээр маш их хохирч байна гэв.

Шүүгдэгч Х.Р.П шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Прокурорын яллах дүгнэлтэд бичигдсэнээр би нярваар ажиллаж байгаагүй. Визний асуудлаас болж намайг хувьцаа эзэмшигч гэж бүртгүүлсэн. Би энэ компанид хувьцаа эзэмшдэггүй. Би цалин авч ажилладаг жирийн нэг ажилчин. Би баталгаат засвартай мотоциклыг л засдаг байсан. В.М.Ж-г байхгүй үед худалдагч нарын мөнгийг авдаг байсан нь үнэн. Компаниас ямар нэг ашиг авдаггүй байсан. Хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэж өгнө үү гэв.

Шүүгдэгч Д.Н шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би “ХЛ” компанийг бүх баримттай нь тулгаж шалгасан. 2008, 2009 оны материалыг Ц.Э байцаагчтай цуг шалгасан. Би хээл хахууль аваагүй. Мөрдөн байцаагч хүчээр тулгаж мэдүүлэг авсан. Хэзээ ч авлига аваагүй. Худалдагчаараа нь дамжуулж надад 150.000 төгрөг өгсөн. 1, 2, 3 сарын НӨАТ-ын тайланг гаргаагүй. Ганцхан хүн амын орлогын татварын тайланг бөглөж өгсөн. Хэргийг шударгаар шийдвэрлэж өгнө үү гэв.

Шүүгдэгч А.М шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Р.Э-ыг анх таньдаггүй байсан. Түүний эгч нь оруулсан мотоциклын 10 хувийг авдаг байсан. 7000 гаран мотоцикл болсон байх. Р.Э-ын эгч надаас мөнгө аваад түүнд өгдөг байсан. Би энэ компанийн ажилтан биш, татвараас зайлсхийх санаа байгаагүй. Зүгээр В.Х.В-ыг танина. Хэргийг үнэн зөвөөр

шийдвэрлэж өгнө үү гэв.

Хохирогч Р.Б-ийн /хх-ийн 6-н 4/, гэрч Р.Э-ын /хх-ийн 4-н 186-191/, гэрч Т.А-ын /хх-ийн 4-н 192-194/, гэрч Г.Г-ийн /хх-ийн 195/, гэрч Л.Ү-ын /хх-ийн 4-н 205/, гэрч Т.Э-ийн /хх-ийн 4-н 208-209/, гэрч Х.Х.Я-ын /хх-ийн 4-н 212-213/, гэрч Р.Б-гийн /хх-ийн 4-н 217-218/, гэрч О.З-гийн /хх-ийн 4-н 223-226/, гэрч Д.Ба-ы /хх-ийн 4-н 228-230/, гэрч Ц.Э-гийн /хх-ийн 4-н 231-232/, гэрч С.С-гийн /хх-ийн 4-н 233/, гэрч Ч.У-ийн /хх-ийн 4-н 237-243/, гэрч Б.Ня-ийн /хх-ийн 4-н 245/, гэрч Г.Ха-ийн /хх-ийн 4-н 246-247/, гэрч Г.О-ийн /хх-ийн 4-н 243-249/, гэрч Р.С-ын /хх-ийн 4-н 250/, гэрч Т.У-гийн /хх-ийн 5-н 69/, гэрч Т.Э-ы /хх-ийн 5-н 73-74/, шинжээч Ж.Ба-гийн /хх-ийн 5-н 180/ мөрдөн байцаалтын шатанд мэдүүлсэн, ШШҮХ-ийн 2013.04.25-ны 014 тоот дүгнэлт /хх-ийн 5-н 87-163/, ШШҮХ-ийн 2013.03.01-ний 046 тоот дүгнэлт /хх-ийн 5-н 170-179/, ШШҮХ-ийн 2013.03.29-ний 931 тоот дүгнэлт /хх-ийн 5-н 195-198/, ШШҮХ-ийн 2013.04.25-ны 2617 тоот дүгнэлт, Эд хөрөнгө битүүмжлэх тогтоолууд /хх-ийн 1-н 128-147/, Х.Р.П-ний урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 6-н 22/, В.Х.В-ны урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 6-н 46/, Д.Н-гийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 6-н 123/, А.М-ын урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 6-н 124/ зэрэг болно.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд болон хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудыг шүүх тал бүрээс нь бүрэн, бодитой магадлан хянасны үндсэнд ТОДОРХОЙЛОХ нь:

Прокуророос шүүгдэгч А.М-ад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч уг хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 10 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрэн тогтоогдохгүй байна. Учир нь энэ хэргийн субъект нь татвар ногдвол зохих орлого, эд хөрөнгөтэй, ажил үйлчилгээ эрхэлж байгаа этгээд байхаас гадна орлого олохоос санаатай зайлсхийх үйлдэл хэний эрх ашиг, сонирхолд нийцтэй вэ гэдэг нь энэ хэрэгт чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар шүүгдэгч А.М нь “ХЛ” ХХК буюу В.Х.Втай бүлэглэн Монгол Улсын хилээр мотоцикл, сэлбэг оруулж ирэхдээ татвараас зайлсхийх талаар хэрхэн урьдчилан тохиролцсон, үүний хөлсөнд ямар шан

харамж, орлого олж байсан нь тогтоогдоогүй бөгөөд харин “ХЛ” ХХК-ны өмнөөс хилээр мотоцикл, сэлбэгт гаалийн бүрдүүлэлт хийж өгөн, тодорхой хөлс авч байсныг хөлсөөр ажиллах гэрээний үндсэнд хийгдсэн үйлдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болох “ХЛ” ХХК-ны хувьд татварт ногдох хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээгээ нуун дарагдуулах, үндэслэлгүйгээр бусдад шилжүүлэх, тайланд тусгаагүй зэрэг нь тухайн компанийн буюу В.Х.В, Х.Р.П нарын шууд үйлдэлд хамаарч байна.

Иймд шүүгдэгч А.М-ад прокуророос Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан буюу гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгах нь зүйтэй гэж дүгнэв.

Мөн прокуророос шүүгдэгч Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэг буюу давтан хээл хахууль авсан гэмт хэрэгт, шүүгдэгч В.Х.В-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт буюу давтан хээл хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчлөх боломжтой байна. Учир нь хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн баримтуудаас үзэхэд шүүгдэгч нарын үйлдэл нь өөр цаг хугацаанд үйлдэгдсэн боловч нэг зорилго чиглэлд хүрэхийн тулд нэг төрлийн үйлдлүүдийг тасралтгүй хэрэгжүүлсэн, нэгдмэл хор уршигт хүрэхэд чиглэгдсэн, нэг үр дагаврыг бий болгосон нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 18 дугаар зүйлд заасан “давтан” шинжийг агуулаагүй байна гэж үзнэ.

Иймд шүүгдэгч Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж ирүүлснийг мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэг болгон, шүүгдэгч В.Х.В-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж ирүүлснийг мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 299.1 дэх хэсэг болгон тус

тус Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2 дахь хэсэгт заасан шүүхийн эрх хэмжээний хүрээнд хөнгөрүүлэн зүйлчлэхээр тогтов.

Шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нар нь бүлэглэн давтан үйлдлээр 2008-2011 онуудад нийт 11822 ширхэг мотоцикл, сэлбэгийг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа “ХЛ” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэргийн нотлогдсон байдлын талаар:

Шүүгдэгч Х.Р.П нь “ХЛ” ХХК-ны нярав биш засварчин байсан тул энэ хэргийн субъект биш”, шүүгдэгч В.Х.В нь “шинжээчийн дүгнэлт буруу гарсан, бид Монгол Улсад илүү татвар төлсөн, татвараас зайлсхийгээгүй” гэж мэдүүлсэн боловч тэдгээрийн гэм буруутай үйлдэл дараах нотлох баримтуудаар нотлогдсон байна. Үүнд:

гэрч Р.Баа мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “... Х.Р.П Монголд байдаг бөгөөд би зөвхөн Х.Р.П-тэй холбогдон тооцоогоо хийдэг. Худалдаа хийсэн баримтыг Х.Р.П үйлдэж өгдөг байсан. Ер нь Х.Р.П л бүгдийг мэдэж хийдэг байсан...” /4-р хх-ийн 212/,

гэрч Г.Г мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Х.Р.П нь захирлын туслах байхаа. Хамаг юмыг хийгээд л мөнгө тооцоог бүгдийг нь барьдаг байсан...” /4-р хх-ийн 195/,

гэрч И.Ба мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Х.Р.П л бүх зүйлийг нь гардан хийж, тооцоо мөнгийг нь барьдаг. Би бол дандаа л Х.Р.П-д мөнгөө өгдөг байсан...” /4-р хх-ийн 196/,

мөн “ХЛ” компанийн 10 хувийг шүүгдэгч Х.Р.П эзэмшдэг болохыг эрх бүхий байгууллагын буюу хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээнд /3-р хх-ийн 148/ тусгагдсан зэргээс үзэхэд түүнийг уг компанийн санхүү, мөнгөний асуудлыг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан байсан гэдгийг үгүйсгэх боломжгүй юм.

Тусгай мэдлэг шаардсан, эрх бүхий байгууллагын даалгаснаар, хуульд заасан үүргийн дагуу гаргасан шинжээчийн дүгнэлтийг шүүх шууд үндэслэлгүй гэж дүгнэх боломжгүй юм. Энэхүү дүгнэлтийн талаар шинжээч Ж.Ба шүүхийн хэлэлцүүлэгт гаргасан тайлбартаа: “...анхан шатны

баримтад үндэслэгдсэн. Нийт тооцоонд хилээр оруулсан мотоцикл болон сэлбэгийн тооцоо орсон байгаа. Нягтлан бодох бүртгэлийн дагуу хийгдсэн ажиллагаа...” гэх мэдүүлэг, бусад шинжээчийн удаа дараагийн дүгнэлтүүд зэргээс үзэхэд шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нарын үйлдлийн улмаас улсад 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учирсан болохыг тогтоосон дүгнэлт хууль ёсны, үндэслэлтэй гарсан гэж дүгнэв. Үүнээс гадна:

гэрч Р.Э мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ “...Би 2008 онд хамаатны ах н.Мө-ын барилгын материалыг урдаас зөөдөг байхдаа А.М-тай Замын Үүдийн хил дээр тааралдсан юм. Тэгэхэд А.М намайг “чи цэнхэр дэвтэртэй юм уу чиний нэр дээр хэдэн мотоцикл оруулаад ирмээр байна” гэж хэлээд миний нэр дээр 150 орчим мотоциклын гаалийн бүрдүүлэлтийг хийгээд надад 150.000 төгрөг өгсөн. Тэрнээс хойш А.М нь миний нэрээр мотоциклын гаалийн бүрдүүлэлтийг хийгээд оруулж ирээд 150.000-300.000 төгрөгийн хооронд мөнгө өгдөг байсан. Тэгээд тэрнээс хойш оруулсаар байгаад 7776 ширхэг мотоцикл болсон юм. А.М миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклыг Улаанбаатар хот руу явуулдаг байсан. Сүүлд 2011 оны 05 дугаар сард “чиний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклд улсын дугаар авах гэсэн чинь болохгүй байна, чи ирээд итгэмжлэл хийгээд өгөөч, ирэх очих зардлын чинь мөнгийг явуулья” гэж хэлсэн. Тэгээд 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдөр В.Х.В миний ХААН банкин дахь 537800xxxx дугаартай дансанд зардлын мөнгө болох 80.000 төгрөгийг шилжүүлсэн юм. Би Дорнод аймгаас Улаанбаатар хотод ирээд В.Х.В-тай Төмөр замын коллежийн хавьд уулзаад Авто Тээврийн газар дээр очоод нотариатаар орж итгэмжлэл хийлгэж өгсөн. Тэгэхэд нь би А.М-ын миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоцикл Улаанбаатар хотод “ХЛ” ХХК дээр ирдэг юм байна гэж мэдсэн. В.Х.В нь надтай ирж уулзахдаа ганцаараа машинтайгаа ирсэн ба тухайн үед надтай монголоор ярьж байсан. 2012 оны 8 дугаар сарын дундуур В.Х.В надтай утсаар яриад чамайг цагдаагийн байгууллагаас мотоцикл хэрхэн оруулж ирдэг талаар асуух юм бол би өөрийн нэрээр оруулж ирээд Замын-Үүд дээр хүмүүст тараагаад өгчихдөг гэж хэлээрэй гэсэн. Маргааш нь мөн А.М залгаад “В.Х.В чамтай ярьсан уу, чи хэлснээр нь хэлчээрэй”

гэсэн юм гэжээ. /4-р хх-ийн 186-191/,

мөн тэрээр шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: “...В.Х.В-тай нэг удаа ярьсан. Тэр над руу ярихдаа итгэмжлэл хийж өгөөч гэсэн. 2011 оны 6-р сард итгэмжлэл хийлгэхээр миний данс руу 80.000 төгрөг шилжүүлж хотод ирэх зардлыг өгсөн...” гэх мэдүүлэг, гэрч Ч.У мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “..”ХЛ” ХХК нь Монгол Улсын иргэн Р.Э, Т.Э нарын нэрээр болон миний нэрээр мотоцикл импортлон оруулж ирээд зардаг байсан. Эхлээд би ямар учиртай болохыг нь мэдэхгүй байсан чинь татвар төлөхөөс зайлсхийхийн тулд Монгол Улсын иргэдийн нэрээр гаалиар мэдүүлж мотоцикл оруулж ирдэг байсан юм байлаа. Би сүүлд нь энэ асуудлыг мэдсэн. Мөн өөрийн компанийн нэр дээр бага тооны мотоцикл оруулж ирэх нь татвар, цагдаа, гаалийнхны анхаарлыг татахгүй гэсэн арга байсан юм билээ. Эдгээр 156 ширхэг мотоцикл нь “ХЛ” ХХК-ийн мотоцикл бөгөөд В.Х.В нь татвар төлөхөөс зайлсхийхийн тулд миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийлгэж оруулж ирж худалдан борлуулсан мотоцикл юм. Эдгээр мотоцикл нь миний мотоцикл биш болохоор “ХЛ” ХХК-ийн захирал В.Х.В татварыг нь төлөх ёстой юм. Угаасаа В.Х.В нь Р.Э, Т.Э болон миний нэрээр татвар төлөхөөс зайлсхийхийн тулд оруулж ирж зардаг юм. Үүнийг нь мотоцикл зардаг манай худалдагч нар болон “ХЛ” ХХК-аас мотоцикл худалдан авдаг хүмүүс мэдэж байгаа болно” /4-р хх-ийн 237-243/,

гэрч Т.А мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...”ХЛ” ХХК нь БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай мотоцикл болон сэлбэг оруулж ирж зарах үйл ажиллагаа явуулдаг. Би энэ компанид 2010 оны 7 дугаар сараас 2011 оны 4 дүгээр сар хүртэл худалдагчаар ажиллаж байсан. Намайг “ХЛ” ХХК-д анх ажилд ороход тус компанийн худалдан борлуулж байсан мотоциклын ихэнх нь Р.Э гэдэг хүний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклууд байсан. Намайг ажилд орохоос өмнө Ч.У болон өөр хүний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоцикл худалддаг байсан юм шиг байсан. Баянзүрх дүүргийн Татварын хэлтсээс шалгалт орж байгаа гээд нэг эмэгтэй орж ирээд гараад явж байсан шиг санагдаж байна” /4-р хх-ийн 223-226/,

гэрч Д.Ба мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ...”ХЛ” ХХК-аас худалдан авч байсан мотоцикл дотор Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр Монгол Улсад импортоор

оруулж ирсэн мотоциклиуд байсан бөгөөд 2008 оноос би Р.Э-ын нэртэй гаалийн бичигтэй нийт 100 гаран мотоциклыг “ХЛ” ХХК-аас худалдан авч байсан юм. Миний “ХЛ” ХХК-аас худалдан авч байсан мотоциклууд нь болохоор “ХЛ” ХХК-ийн нэртэй мөн Р.Э-ын нэртэй гаалийн бичигтэй мотоциклууд байсан болно” /4-р хх-ийн 228-230/,

гэрч Г.Ха мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Хяналт шалгалтыг хийх явцад тухайн үед худалдагч менежер байсан Ч.У, худалдагч О.З энэ байгууллагын барааг өөрийн нэрээр импортолсон Р.Э-тай ярилцлага хийж “ХЛ” ХХК-ийн импортоор оруулж ирсэн бараа бүтээгдэхүүн /мотоцикл/ болохыг тогтоосон. Иргэн Р.Э-ын нэрээр “ХЛ” ХХК нь 2010 онд 3845 ширхэг мотоцикл оруулж ирэн худалдан борлуулаад нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнаагүй зөрчил байсан. Компанийн 2010 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил болох 3.818.000.000 төгрөгийн орлогыг мотоциклыг бэлнээр борлуулсан үнэ /бөөнөөр болон жижиглэнгээр/ ХААН банкны лизингээр борлуулсан үнэ, Х.Р.П-ий харилцах данс, Ч.У-ийн ярилцлага зэргийг үндэслэн тогтоосон. “ХЛ” ХХК нь 8.662.641,4 мянган төгрөгийг тайланд тусгаагүй албан татвар ногдуулж тооцоогүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөхөөс зайлсхийж нуун дарагдуулсан. Энэ нь Татварын Ерөнхий хуулийн 18 дугаар зүйл “Татвар төлөгч нь татварыг үнэн зөв тайлагнаж төлсөн байх”, Нэмэгдсэн өртгийн албан татварын 7 дугаар зүйл “Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа” Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод албан татвар ногдоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд Санхүүгийн тайлан нь үнэн, зөв бараа материал бодит тоо, мэдээнд үндэслэнэ. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэлийг хөтөлнө гэсэн заалтуудыг зөрчсөн гэжээ. /4-р хх-ийн 246, 247/,

гэрч Г.О мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...”ХЛ” ХХК нь Татварын Ерөнхий хуулийн 18 дугаар зүйл Татвар төлөгчийн үүргийг хэрэгжүүлээгүй гэж үзсэн. “ХЛ” ХХК нь миний шалгасан 2009 онд өөрийн нэрээр 166, иргэн Р.Э-ын нэрээр

1147 ширхэг мотоцикл импортоор оруулж ирсэн байсан. Тухайн жилд 109.968,4 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг тусгасан буюу 115 ширхэг мотоциклыг борлуулсан гэж тайландаа тусгасан байсан юм. Нийт 2009 онд 1198 ширхэг мотоциклын борлуулалтын орлогыг нөхөн ногдуулсан. Бидний хувьд тоо ширхгээ тогтоосны дараа дундаж үнийн судалгаа хийсэн. Мотоциклын тоо ширхгийг гаргахдаа марк тус бүрээр нь гаргасан бөгөөд кассын тайлан дээр мотоциклын борлуулсан орлогын ордерийг түүвэрлээд нийт үнийг нь нэмээд тоо ширхэгт нь хуваагаад дундаж үнийг гаргасан. Энэ компани нь өөр хүний нэрээр импортоор оруулж ирээд худалдан борлуулсан орлогыг өөрийн ажилтан Ч.У-ийн дансаар дамжуулж оруулж ирсэн байсан. Үүнээс бас дундаж үнээ гаргаж авсан юм. Мөн Ч.У, Х.Я, И.Ба зэрэг хүмүүстэй ярилцлага хийж үнийн дунджийг тогтоосон. “ХЛ” ХХК нь 2009 онд 970.137,7 мянган төгрөгийн татвар ногдох орлогоо нуун дарагдуулсан байсан. Нийт 2008-2011 онд 8.662.674,4 мянган төгрөгийн татвар ногдох орлогоо нуун дарагдуулсан гэж дүгнэлт бичсэн юм. Баянзүрх дүүргийн Татварын улсын байцаагч нар 2008-2009 онуудыг шалгасан байсан бөгөөд 2010-2011 онуудын асуудлыг шалгаагүй байсан. Тэгэхээр 1.673.960.969,29 төгрөгийн татвар ногдох орлогоос 359.028,5 мянган төгрөг нь тухайн 2 байцаагчийн шалгасан онд хамаарч байгаа юм. Тухайн онд импортолсон мотоциклыг өмнө шалгасан байцаагч нар үлдэгдэлтэйгээр авсан байсан боловч манай ажлын хэсгийнхэн үлдэгдэлгүйгээр борлуулснаар орлогыг тодорхойлсон. Шалтгаан нь тухайн жилүүдийн тооллогын бүртгэл огт байхгүй байсан” /4-р хх-ийн 243-249/,

гэрч Р.С мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Тухайн мотоциклыг импортоор оруулж ирж байгаа аж ахуйн нэгж, иргэнд гаалийн байгууллагаас бүрдүүлэлт хийхдээ 1 мотоциклын арлын дугаарыг бичээд ганцхан гаалийн мэдүүлэг өгдөг юм. Тэгээд манай газраас мотоциклынх нь техникийн паспортыг үзээд эхний дугаар авч байгаа мотоциклынх нь мэдээллээр мэдээллийн сан үүсгээд үлдсэн мотоциклын гаалийн мэдүүлгийн хуулбар дээр нь мотоциклын техникийн паспорттой тулгаж үзээд ТХБХ-12 гэсэн өөрийн хувийн тэмдэг дарж, архивын дугаар бичиж өгдөг юм. Тухайн иргэн хуулийн этгээд дараа нь мотоциклдоо

улсын дугаар авахдаа миний тэмдэг дарж өгсөн гаалийн мэдүүлгийн хуулбар болон мотоциклын техникийн паспорт, арал бичсэн гаалийн хүснэгтийн хуулбарыг авчраад улсын дугаар авдаг юм. Жишээ нь: Иргэн А 150 ширхэг мотоциклд улсын дугаар авахдаа 150 ширхэг мотоциклын гаалийн мэдүүлгийг хуулбарлаад эхний мотоцикл дээрээ авсан архивын дугаарыг бичдэг юм. Дараа нь иргэн А үлдсэн мотоциклдоо улсын дугаар авахдаа миний хувийн тэмдэг дарсан гаалийн мэдүүлгийн хуулбар болон мотоциклын техникийн паспортын хамт ирээд улсын дугаар авдаг. Мотоциклд улсын дугаар авахдаа 200-300 ширхгээр орж ирдэг болохоор ажлын ачааллаас шалтгаалан зарим үед өөрсдөөр нь даруулах тохиолдол гардаг юм. Тэгэхэд хоосон цаасан дээр дарагдсан байх гэж бодож байна. Би В.Х.В гэж хүнийг огт танихгүй бөгөөд мөнгө төгрөг авсан зүйл байхгүй. Хоосон цаасан дээр яагаад тэмдэг дарагдсан талаар хэлж мэдэхгүй байна” /4-р хх-ийн 250/,

гэрч Т.У мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Иргэн аж ахуйн нэгжүүд нэг удаа мотоцикл импортоор оруулж ирэхдээ олон тоогоор оруулж ирдэг бөгөөд гаалийн байгууллагаас нэг гаалийн мэдүүлэг олгодог. Тэгээд манай газраас улсын дугаар авах үед мотоциклын тоогоор нь гаалийн мэдүүлгийг нь хуулбарлаад эх хувийг архивын нэгж болгоод үлдсэн хувийг нь эзэмшигч нь буцааж өгдөг юм. Тэгээд дараа нь тэр мотоцикл дээрээ улсын дугаар авах болохоор миний тэмдэг дарсан гаалийн мэдүүлгийн хуулбарыг болон мотоциклын техникийн паспортыг авчирч улсын дугаар авдаг юм.

Би 2012 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр энэ ажилд томилогдсон бөгөөд намайг ажил хүлээж авснаас хойш “ХЛ” ХХК-аас мотоциклын дугаар авсан зүйл байхгүй. Би ажилд томилогдсоноосоо хойш 2012 оны 10 дугаар сард ТХБХ-13 дугаартай тэмдэгийг ахлах мэргэжилтэн н.Энхтуяагаас хүлээн авсан болно. Ямар учраас энэ хоосон цаасан дээр дарагдсан талаар би мэдэхгүй байна гэжээ. /5-р хх-ийн 69/,

2013.01.03-ны өдрийн Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 014 дугаартай шинжээчийн дүгнэлтэд: “ХЛ” ХХК нь ААНОАТ 89.897.063,56 төгрөг, НӨАТ 51.729.140,36 төгрөг төлөхөөр байна. ААНОАТ, НӨАТ-ын хуулийн дагуу татварын хувь хэмжээг тооцсон. “ХЛ” ХХК нь Монгол

Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, ААНОАТ-ын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулиудыг зөрчсөн байна /5-р хх-ийн 87-163/,

2013.03.01-ний өдрийн Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 046 дугаартай шинжээчийн дүгнэлтэд: Р.Э нь нийт 163.079.153,76 төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар, 162.079.153,76 төгрөгийн НӨАТ, Т.Э нь 6.970.034,58 төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар, 2.509.635,27 төгрөгийн Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөхөөр байна. /5-р хх-ийн 170-179/,

“ХЛ” ХХК-ийн захирал В.Х.В-аас Р.Э-ын дансанд зардлын мөнгө болгож өгсөн 80.000 төгрөг шилжүүлсэн гэх дансны хуулга /1-р хх-ийн 248/

“ХЛ” ХХК-ийн захирал В.Х.В болон тус компанийн худалдагч О.З нарт иргэн Р.Э-аас гаргаж өгсөн итгэмжлэл /3-р хх-ийн 171-173/ зэрэг нотлох баримтуудаар,

Шүүгдэгч В.Х.В нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Д.Н-д онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн, 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450000 төгрөгийн буюу нийт 1.950.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

шүүгдэгч Д.Н нь В.Х.В-аас дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсний төлөө нийт 1.950.000 төгрөгийн хээл авсан гэмт хэргийн нотлогдсон байдлын талаар:

Шүүгдэгч В.Х.В нь Д.Н-д өөрөө мөнгийг өгөөгүй, ах өгсөн байж магадгүй гэж мэдүүлдэг бөгөөд энэ мэдүүлгээс үзэхэд “ХЛ” ХХК-ны өмнөөс бусдад хээл хахууль өгсөн үйлдлээ үгүйсгээгүй байна. Нөгөө талаар түүний бусдад хээл хахууль өгснийг дамжуулж өгсөн гэрчүүд мөрдөн байцаалтын шатанд тодорхой мэдүүлдэг төдийгүй Д.Н нь хээл хахууль авсан үйлдлээ нуун дарагдуулах зорилгоор зохиомол байдлыг бий болгож “мөнгө зээлсэн” гэх баримтыг үйлдсэн болох нь шинжээчийн дүгнэлтээр нотлогдсон байна. Эдгээр нь дараах баримтад үндэслэгдэж байна. Үүнд:

гэрч Ц.Э мөрдөн байцаалтад болон шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн...2010 оны 7 дугаар сард татварын улсын байцаагч Д.Н-тэй хамт “ХЛ” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаа баримтад шалгалт хийх хуваарьтай байсан. Наадмын дараахан

ээлжийн амралтаа аваад 8 дугаар сарын сүүлчээр ажилдаа орсон. Тэр үед Д.Н надтай уулзаад “ХЛ” ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээд дуусаж байна. Миний хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилтэй танилц гээд шалгалтын гар ноорог үзүүлсэн. Зөрчил баримт зэрэгтэй нь тулгаж үзээгүй. Тэгээд надтай татварын улсын байцаагчийн акт бичээд надад үзүүлсэн. Би акт дээр гарын үсэг зурж баталгаажуулсан. Тухайн үед Д.Н байцаагчийн үйл ажиллагаанд итгээд актад гарын үсэг зурсан гэв. /4-р хх-ийн 231, 232/,

гэрч Т.Э мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...Би “ХЛ” ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгэхээр Татварын улсын байцаагч Д.Н, Ц.Э нарт 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 3 хоногийн хугацаагаар томилолт бичиж өгсөн юм. Гэхдээ үүнийг татварын улсын байцаагч нар нэг сарын хугацаанд багтаж шалгаж дуусгах үүрэгтэй байсан. Энэ хоёрын хувьд 2 сар гаруй хугацаагаар томилолтынхоо хугацааг хэтрүүлсэн байсан. Энэ компанийн хувьд татварын улсын байцаагч нарын тогтоосон актыг нооргоор уншиж танилцаж, хууль зөв хэрэглэсэн эсэхэд хяналт тавьж гарын үсэг зурсан. Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6-д заасан “Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх” гэсэн заалтын дагуу 2-3 байцаагч хийх ёстой байдаг. Би заалтын дагуу шалгалт хийх гэж байгаа байцаагч нарыг 2-оос дээш хүний бүрэлдэхүүнтэй томилолт олгодог юм. Ганцаараа хяналт шалгалт хийх ёсгүй. Татварын улсын байцаагч шалгах гэж буй аж ахуйн нэгж, компанийн удирдлага болон ажилтнаас мөнгө төгрөг, эд зүйл, зээл, тусламж авч болохгүй. Үүнийг хориглосон байдаг юм. Татварын улсын байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн удирдлагаас мөнгө төгрөг авч тайланг нь гаргаж өгч болохгүй тайлан гаргахыг хориглосон байдаг юм. /5-р хх-ийн 73, 74/,

гэрч С.С мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: “...2007 оны 9 дүгээр сарын үед Д.Н-гийн өмчлөлийн нэг өрөө байрыг “Мо” хадгаламж зээлийн хоршооны барьцаанд тавиулж 18.000.000 төгрөгийг үйлдвэрлэлийн

түүхий эд татах зорилгоор манай нөхөр У.Цэ зээлж авсан. Тухайн үед “мөнгөний хэрэгцээ байна, түүхий эд татах мөнгө хэрэгтэй байна” гээд Д.Н-тэй төрөл садангийн холбоотой болохоор байрыг нь зээлийн барьцаанд тавиулж байсан юм. “Мо” хадгаламж зээлийн хоршооны зээл болон зээлийн хүүг манай нөхөр У.Цэ 2010 оны 3 дугаар сарын 18-ны өдөр нас барах хүртлээ төлж байсан. Би бол нэг ч удаа очиж зээл болон зээлийн хүүг төлж байгаагүй. Тэрнээс хойш зээл болон зээлийн хүүг Д.Н өөрөө төлсөн байх гэж бодож байна. Надтай сар гарангийн өмнө Д.Н утсаар ярихдаа хүнээс нэг хэдэн төгрөг аваад зээлэндээ өгчихсөн чинь намайг тэр хүн нь Мөрдөн байцаах газар өгчихсөн байна чи мөнгөө төлөөч, хоёулаа уулзаж байгаад тухтай ярья гэж ярьж байсан” / 4-р хх-ийн 233/,

гэрч Ч.У мөрдөн байцаалтад болон шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: “...Намайг танай байгууллага дээр 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гэрчээр мэдүүлэг өгснөөс хойш болон өмнө нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Н над руу байн байн утсаар залгаж надаас “чи В.Х.В-аас Д.Н миний цалинг авсан гээд мэдүүлэг өгчих, тэгвэл иргэний хэрэг болно ш дээ” гэж гуйгаад дахин дахин залгаад 2-3 удаа уулзсан. Тэгээд 2012 оны 12 дугаар сарын дундуур би Д.Н-тэй уулзаад энэ бичгийг хэрэгт ямар ч ач холбогдолгүй байх гэж бодоод Д.Н-гийн “баталгаа” гэж бичсэн цаасан дээр нь гарын үсэг зурж өгсөн. Энэ цаасан дээрх гарын үсэг миний гарын үсэг мөн. Энэ бичгийг Д.Н өөрөө бичсэн бөгөөд надаар гарын үсэг зуруулсан юм. Энэ цаасны урд болон хойно бичсэн зүйл нь нэг өдөр бичигдсэн бөгөөд нэг өнгийн балаар бичсэн юм. Тэрнээс Д.Н В.Х.В-аас миний цалинг аваад надаас зээлсэн асуудал байхгүй бөгөөд надад 1500000 төгрөг өгсөн зүйл байхгүй болно. Би Д.Н-гийн гуйлтаар энэ бичгийг бичиж өгсөн юм. Үүнийг манай найз Б.Ня мэдэж байгаа болно. ...2011 оны 1 дүгээр сарын тайлангаас авахуулаад нягтлан бодогч байхгүй болсон тул В.Х.В Д.Н-г гуйгаад тайлангаа гаргуул гэж хэлсэн. Тэгээд 1, 2, 3 дугаар сарын тайлангаа Д.Н-гээр гаргуулаад нэг сарын цалин гэж 150000 төгрөг өгч байсан юм. Энэ цалин гэх мөнгийг нь би 1, 2 сарын мөнгийг нь 3 сарын мөнгийг нь худалдагч Т.А-аар хүргүүлсэн. Нийт Д.Н-д 450.000 төгрөг өгсөн гэв. /4-р хх-ийн 237-243/,

мөн тэрээр шүүхийн хэлэлцүүлэгт

мэдүүлэхдээ: "...Д.Н байцаагчийн гуйснаар баталгаа гэсэн бичгийг хийж өгсөн..." гэх мэдүүлэг,

гэрч Б.Ня мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: "...2012 оны 12 дугаар сарын дундуур манай найз Ч.У унаагүй болчхоод миний унаатай гадуур явж байсан чинь нэг эмэгтэй утсаар яриад бид хоёр уулзахаар болоод Кемпински зочид буудлын зүүн талын Орос хоолны газарт хамт уулзсан юм. Би тэр хүнийг нь өмнө нь харж байгаагүй бөгөөд тэр хоорондоо нэг бичиг бичүүлэх талаар тэр хүн гуйгаад тал бичгийн цаасан дээр нь нөгөө хүн нь мөнгө төгрөг зээлсэн гэж бичээд Ч.У-ээр гарын үсэг зуруулж байсан юм. Би тэр бичиг нь ямар учиртай бичиг болох талаар мэдээгүй бөгөөд тэр хүнийг нь Татварын газар ажилладаг талаар мэдээгүй болно" /4-р хх-ийн 245/,

2013.03.29-ний өдрийн Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 931 дугаартай шинжээчийн дүгнэлтэд: Шинжлэгдэж буй 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Баталгаа" гэсэн толгойтой "Н.Д-ийн" гэж эхлээд "Ч.У" гэж дуусгасан гар бичмэлүүд нь Д.Н-гийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна. Шинжлэгдэж буй тал цаасны арын хэсэгт "2011 оны гэж эхлээд авсан" гэж дуусгасан гар бичмэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн гэрч Ч.У-ийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна. Шинжилгээнд ирүүлсэн 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Зээлдсэн" гэсний ард, арын нүүрэнд "өгсөн" гэсэн бичиглэлийн ард тус тус зурагдсан шинжлэгдэж буй гарын үсгүүд нь сэжигтэн Д.Н-гийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай гарын үсгийн ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүдээрээ тохирч байна. Шинжилгээнд ирүүлсэн 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "зээлдүүлэгч" гэсний ард, мөн тал цаасны арын нүүрэнд "авсан" гэсэн бичиглэлийн ард зурагдсан гарын үсгүүд нь гэрч Ч.У-ийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай тохирч байна.

Шинжилгээнд ирүүлсэн "ХЛ" ХХК, "Санхүү, татварын тайлангууд 2010 он" гэсэн хаягтай цэнхэр өнгийн хавтастай материалын "Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын тайлан" гэсэн баримтын дунд хүснэгтэд,

"нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлангууд" гэсэн баримтын хүснэгтэд бичигдсэн тоон бичиглэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн сэжигтэн Д.Н-гийн гэх дэвтэр дээр бичигдсэн тоон бичиглэлүүдтэй тохирч байна" /5-р хх-ийн 195-198/,

2013.04.25-ны өдрийн Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 2617 дугаартай шинжээчийн дүгнэлтэд: Шинжилгээнд ирүүлсэн тал бичгийн цаасны нэг тал дээр бичсэн "Баталгаа Д.Н миний бие "ХЛ" ХХК-ийн орчуулагч Ч.У-ийн цалин болох 150.000 төгрөгийг захирал В.Х.В-аас авч гурван сарын хугацаатай буцаан төлөхөөр зээлж авав. Зээлдсэн Д.Н, "Зээлдүүлэгч Ч.У" гэсэн бичиглэлийн будагч бодис болон нөгөө тал дээр бичсэн "2011 оны 3-6-нд мөнгөө буцаан авав. Өгсөн, авсан "бичиглэл" Ч.У-ийн гарын үсэг нь "Д.Н-гийн гарын үсэг" гэсэн бичиглэлийн будагч бодис нь хоорондоо ижил байна гэжээ./5-р хх-ийн 209, 210/ зэрэг нотлох баримтуудаар шүүгдэгч нарын гэм буруутай үйлдлүүд хангалттай нотлогдсоны гадна шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн бичгийн бусад нотлох баримтуудаар давхар тогтоогдсон гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд нь энэ хэрэгт хамааралтай, хуульд заасан үндэслэл журмын дагуу цугларсан, хэрэг хянан шийдвэрлэхэд хангалттай гэж үзнэ.

Иймд шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нарыг бүлэглэн давтан үйлдлээр татвар төлөхөөс зайлсхийж онц их хэмжээний хохирол учруулсан, шүүгдэгч Д.Н нь бусдаас хээл хахууль авсан, шүүгдэгч В.Х.В-ыг бусдад хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож хуульд заасан хорих ял оногдуулах үндэслэлтэй байна.

Шүүхээс шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нарт ял шийтгэл оногдуулахад хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдсонгүй. Харин Д.Н нь ажилдаа хариуцлага алдсан, бусдаас шан харамж авсан байдлаа хүлээн зөвшөөрч гэмшиж байгааг хөнгөрүүлэх нөхцөл байдалд харгалзан үзэв.

Энэ хэргийн улмаас учирсан гэм хорын асуудлын хувьд шүүгдэгч В.Х.В, Х.Р.П нараас ААНОАТ-ын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвар хуулиар ногдох татвараас төлөгдөөгүй үлдсэн 344.117.647 төгрөгийг тэдний хөрөнгө оруулсан хувь хэмжээг харгалзсан В.Х.В-аас 309.705.882 төгрөгийг, Х.Р.П-ээс 34.411.764 төгрөгийг тус тус гаргуулж Баянзүрх дүүргийн



татварын хэлтэс /хохилогч Р.Б/-т олгохоор тогтов.

Шүүгдэгч Д.Н-гээс хууль бусаар олсон орлого болох 1.950.000 төгрөгийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хурааж улсын орлогод оруулах нь зүйтэй.

Хэрэгт битүүмжлэгдсэн /1-р хх-ийн 130-147/ 614 ширхэг мотоцикл, 113 ширхэг сэлбэгийг шийдвэр гүйцэтгэх үеийн зах зээлийн ханшийг тодорхойлох боломжгүй учир бүхэлд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, ялтнуудын хохиролд тооцогдох хэсгийг зохих журмын дагуу гаргуулж, үлдэх хэсгийг хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгох нь зүйтэй. Мөн “ХЛ” ХХК-ийн Хаан банкин дахь 500343xxxx дугаартай дансан дахь 22.148.847 төгрөг, шүүгдэгч Х.Р.П-ий 511404xxxx дугаартай Хаан банкин дахь дансан дахь 5.186.475 төгрөгийг тус тус эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэхээр тогтов.

“ХЛ” ХХК-ны нэр дээр бүртгэлтэй /1-р хх-ийн 128/ xxxx УБЛ, xxxx УБО улсын дугаартай Фотон форланд маркийн автомашин, xxxx УБА дугаартай Форланд, xxxx УБВ Жидонг машин, дугаар нь тодорхойгүй Максвелл машиныг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгож хууль ёсны эзэмшигч нарт, мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон УМБГ-ын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-ы /5-р хх-ийн 236/ 5.000.000 төгрөгийг, /5-р хх-ийн 221/ /Х.Р.П-ий хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-ы /5-р хх-ийн 219/ 50.000.000 төгрөгийг, Х.Р.П-гийн 57532xxxx-9,50771xxxx-8,5753xxxx-9 дугаартай Хаан банкны хадгаламжийн дэвтэр 3 ширхэг, “ХЛ” ХХК-ийн ТТБ3810, 2865378 дугаартай тэмдэг 1 ширхэг, “ХЛ” ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, “СЭБЭ” ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, Ч.У-ийг дэвтэр 1 ширхэг, складны бүртгэл 1 ширхэг, “ХЛ” ХХК-ийн 2010 оны Санхүү, Татварын тайлангууд 1 хавтас /яллагдагч Д.Н-гийн гараар бичсэн тайлан гэх/, өмгөөлөгч А.Элбэгсайханы хүсэлтэд хавсаргасан хятад хэл дээрх баримтууд 15 хавтас, цэнхэр өнгийн 2 гялгар ууттай гаалийн мэдүүлгүүд зэргийг тус тус буцаан олгох нь зүйтэй.

Харин Р.Э-ын УБ хх-хх дугаартай, ДОЗ хх-хх дугаартай тээврийн хэрэгслийн

гэрчилгээ, УБ хх-хх, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ улсын дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ 9 ширхгийг Авто тээврийн газарт шилжүүлж зохих журмын дагуу шийдвэрлэхийг үүрэг болгож, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн хууль бусаар ашиглагдаж болзошгүй мотоциклын арлын дугаар цохигч багажуудыг дагалдах хэрэгслүүдийн хамт устгахаар тогтов.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2, 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 286, 293, 294, 298 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Прокуророос шүүгдэгч А овогт А.М-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасугай.

2. Шүүгдэгч Д.Н-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн тусгай ангийн 268.1 дэх хэсэг болгон, шүүгдэгч В.Х.В /МНВ/-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийн мөн хуулийн тусгай ангийн 269.1 дэх хэсэг болгон тус тус хөнгөрүүлсэн зүйлчилсүгэй.

3. Шүүгдэгч В.Х.В /МНВ/, Х.Р.П /НРП/ нарыг бүлэглэн, давтан үйлдлээр татвараас зайлсхийж онц их хэмжээний хохирол учруулсан, Б овогт Д.Н-г хээл хахууль авсан, В.Х.В /МНВ/ хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч В.Х.В /МНВ/-аас 1.000.000 /нэг сая/ төгрөгийн эд хөрөнгө хурааж, 06 /зургаа/ жилийн хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Х.Р.П /НРП/-ээс 500.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 05 /тав/ жил 01 /нэг/ сарын хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Н-г төрийн албанд ажиллах эрхийг 02 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, 01 /нэг/ жил 06 /зургаа/ сарын хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч В.Х.В /ВНВ/-г 01 /нэг/ жил 06 /зургаа/ сарын хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч В.Х.В /ВНВ/-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 06 жилийн хорих ял дээр мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 01 жил 06 сарын хорих ялын зарим болох 06 /зургаа/ сарын хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 06 /зургаа/ жил 06 /зургаа/ сарын хугацаагаар хорих ялаар тогтоосугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В /ВНВ/, Х.Р.П /HRP/ нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, ялтан Д.Н-гийн эдлэх ялыг мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар ялтан В.Х.В /ВНВ/-ны 120 хоног, Х.Р.П /HRP/-ний 32 хоног цагдан хоригдсоныг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, ялтан Д.Н болон А.М нар нь цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдсугай.

8. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар ялтан В.Х.В /ВНВ/-аас 309.705.882 төгрөгийг, ялтан Х.Р.П /HRP/-ээс 34.411.764 төгрөгийг буюу нийт 344.117.647 төгрөгийг гаргуулж хохирогч Р.Б-д /Баянзүрх дүүргийн татварын хэлтэс/-д олгосугай.

9. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар ялтан Д.Н-гийн гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлого болох 1.950.000 төгрөгийг хурааж, улсын орлогод оруулсугай.

10. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн мотоциклын арлын дугаар цохигч

багажууд, үүнд хар хайрцган дотор 44 ширхэг хар өнгийн цохигч төмөр, 15 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, улаан хайрцган дотор 22 ширхэг хар өнгийн цохигч төмөр, хэрэглэж байсан 11 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, “бүргэд” гэсэн бичигтэй наалт 1 ширхгийг устгасугай.

11. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.2, 88.1.4, 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт битүүмжлэгдсэн 614 ширхэг мотоцикл, 113 ширхэг сэлбэгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, ялтан нарын хохиролд тооцогдох хэсгийг зохих журмын дагуу гаргуулж, үлдэх хэсгийг хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож, “ХЛ” ХХК-ийн Хаан банкин дахь 500343xxxx дугаартай дансан дахь 22.148.847 төгрөг, шүүгдэгч Х.Р.П-ий 511404xxxx дугаартай Хаан банкин дахь дансан дахь 5.186.475 төгрөгийг тус тус эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж,

“ХЛ” ХХК-ны нэр дээр бүртгэлтэй xxxx УБЛ, xxxx УБО улсын дугаартай Фотон форланд маркийн автомашин, xxxx УБА дугаартай Форланд, xxxx УБВ Жидонг машин, дугаар нь тодорхойгүй Максмелл машиныг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгож хууль ёсны эзэмшигч нарт, мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон УМБГ-ын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-ы 5.000.000 төгрөгийг, /Х.Р.П-ий хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-ы 50.000.000 төгрөгийг болон Х.Р.П-гийн 57532xxxx-9,50771xxxx-8,5753xxxx-9 дугаартай Хаан банкны хадгаламжийн дэвтэр 3 ширхэг, “ХЛ” ХХК-ийн ТТБ3810, 2865378 дугаартай тэмдэг 1 ширхэг, “ХЛ” ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, “СЭБЭ” ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, Ч.У-ийг дэвтэр 1 ширхэг, складны бүртгэл 1 ширхэг, “ХЛ” ХХК-ийн 2010 оны Санхүү, Татварын тайлангууд 1 хавтас /яллагдагч Д.Н-гийн гараар бичсэн тайлан гэх/, өмгөөлөгч А.Элбэгсайханы хүсэлтэд хавсаргасан хятад хэл дээрх баримтууд 15 хавтас, цэнхэр өнгийн 2 гялгар ууттай гаалийн мэдүүлгүүд зэргийг тус тус буцаан олгож,

Р.Э-ын УБ хх-хх дугаартай, ДОЗ хх-хх дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ, УБ хх-хх, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ улсын дугаартай тээврийн

хэрэгслийн гэрчилгээ 9 ширхгийг Авто тээврийн газарт шилжүүлж зохих журмын дагуу шийдвэрлэхийг үүрэг болгосугай.

12. Ялтан В.Х.В /WNW/, Х.Р.П /HRP/ нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тэдэнд буцаан олгосугай.

13. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд ялтан В.Х.В /WNW/, Х.Р.П /HRP/, Д.Н нарт урьд таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорьж, А.М-ад авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосугай.

14. Гомдол гаргах эрх бүхий этгээдүүд шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл уг тогтоолыг гардан авснаас хойш Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны 10 дугаар шүүхэд 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах буюу улсын яллагч эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

15. Давж заалдах гомдол гаргасан буюу улсын яллагч эсэргүүцэл бичсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, ялтан В.Х.В /WNW/, Х.Р.П /HRP/, Д.Н нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг, А.М-ад бусдын батлан даалтад байлгахаар авсан туслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

М.АЛДАР  
С.ОЮУНЧИМЭГ  
Б.МӨНХБАЯР

## МАГАДЛАЛ

2014 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 465

Улаанбаатар хот

В.Х.В, Х.Р.П, Д.Н, А.М нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Д.Мөнхтуул даргалж, шүүгч Ч.Хосбаяр, Ш.Бат-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

Прокурор Ж.Н.Га,

Ялтан В.Х.В, Х.Р.П нарын өмгөөлөгч

З.Төмөрхүү

Ялтан Х.Р.П-ий өмгөөлөгч М.Алтанцэцэг,

Ялтан Д.Н-гийн өмгөөлөгч

М.Цэрэндэжид,

Цагаатгагдсан этгээд А.М-ын өмгөөлөгч

Ц.Алтанцол,

Хохирогч Р.Б,

Нарийн бичгийн дарга Г.Цолмон нарыг оролцуулан,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч М.Алдар даргалж, шүүгч С.Оюунчимэг, Б.Мөнхбаяр нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан В.Х.В, Х.Р.П, тэдний өмгөөлөгч З.Төмөрхүү, ялтан Х.Р.П-ийн өмгөөлөгч М.Алтанцэцэг, ялтан Д.Н, түүний өмгөөлөгч С.Оюун, М.Цэрэндэжид нарын гаргасан давж заалдах гомдлуудаар В.Х.В, Х.Р.П, Д.Н, А.М нарт холбогдох эрүүгийн 201201000471 дугаартай хэргийг 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүлээн авч, шүүгч Ш.Бат-Эрдэнийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. В.Х.В, ... оны ... дугаар сарын ...-нд төрсөн, ... настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, фото зурагчин мэргэжилтэй, Монгол Улсад "ХЛ" ХХК-ийн захирал ажилтай, ам бүл ..., эхнэр, ... хүүхдийн хамт, Бүгд найрамдах Хятад улсын Өвөр Монголын өөртөө засах орны, Хөх хот, ...хороолол, ... тоотод оршин суух, РД:С.....,

2. Х.Р.П, ... оны ... дүгээр сарын ...-нд төрсөн, .. настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, засварчин мэргэжилтэй, Монгол Улсад "ХЛ" ХХК-д нярав ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт, Бүгд найрамдах Хятад улсын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хот ...байранд оршин суух, РД:С.....,

3. Д.Н, ... оны ... дугаар сарын ...-

нд төрсөн, ... настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст Татварын байцаагч ажилтай, ам бүл ..., ... хүүхдийн хамт, Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, РД:УС.....,

4. А.М, ... оны ... дугаар сарын ...-нд төрсөн, ... настай, эрэгтэй, бага боловсролтой, мэргэжилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл ..., эхнэр, хамт Дорноговь аймгийн ... сумын ... дүгээр хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, РД:ЕК.....,

- В.Х.В нь "ХЛ" ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа Х.Р.П, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851.14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд зохион байгуулагчаар оролцсон,

- Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Д.Н-г 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр /24/10/0961 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу "ХЛ" ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийхэд нь онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгч, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай акт бичүүлсэн, мөн "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс Татварын улсын байцаагч Д.Н-д албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Х.Р.П нь "ХЛ" ХХК-д нярваар ажиллаж байхдаа В.Х.В, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон, А.М нь "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В, нярав Х.Р.П нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

Д.Н нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6-д заасан "Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх" гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ХЛ" ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, Аж ахуйн нэгжийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн "ХЛ" ХХК-д Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар

зүйлийн 33.2.6-д заасны дагуу "татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих" гэсэн заалтуудыг зөрчиж тус компанийн их хэмжээний татвар ногдох орлогыг илрүүлсэн атлаа дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагад шилжүүлэхгүй, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай "Татварын улсын байцаагчийн акт" бичиж, захирал Бүгд найрамдах Хятад ард улсын иргэн В.Х.В гэгчээс 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль авсан, мөн Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг тус "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гарган өгч, "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-аас Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль авч, энэ хэргийг давтан үйлдсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Нийслэлийн прокурорын газраас В.Х.В-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт, Х.Р.П-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан хэрэгт, А.М-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан хэрэгт, Д.Н-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар тус тус зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх: Прокуророос А.М-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж, Д.Н-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн

хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268.1 дэх хэсэг болгон, В.Х.В-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269.1 дэх хэсэг болгон тус тус хөнгөрүүлэн зүйлчилж, В.Х.В, Х.Р.П нарыг бүлэглэн, давтан үйлдлээр татвараас зайлсхийж онц их хэмжээний хохирол учруулсан, Д.Н-г хээл хахууль авсан, В.Х.В хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар В.Х.В-аас 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 жилийн хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Х.Р.П-ээс 500.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар Д.Н-г төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 1 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-г 1 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 6 жилийн хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 1 жил 6 сарын хорих ялын зарим болох 6 сарын хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар тогтоож, ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, Д.Н-гийн эдлэх ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлж, В.Х.В-ы цагдан хоригдсон 120 хоног, Х.Р.П-ий 32 хоног цагдан хоригдсоныг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, Д.Н болон А.М нар цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдаж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-аас 309.705.882 төгрөгийг, Х.Р.П-ээс 34.411.764 төгрөгийг буюу нийт

344.117.647 төгрөгийг гаргуулж хохирогч Р.Б /Баянзүрх дүүргийн татварын хэлтэс/-д олгож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар Д.Н-гийн гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлого болох 1.950.000 төгрөгийг хурааж, улсын орлогод оруулж, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн мотоциклын арлын дугаар цохигч багажууд, үүнд хар хайрцган дотор 44 ширхэг хар өнгийн цохигч төмөр, 15 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, улаан хайрцган дотор 22 ширхэг хар өнгийн цохигч төмөр, хэрэглэж байсан 11 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, "бүргэд" гэсэн бичигтэй наалт 1 ширхгийг устгаж, хэрэгт битүүмжлэгдсэн 614 ширхэг мотоцикл, 113 ширхэг сэлбэгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, ялтан нарын хохиролд тооцогдох хэсгийг зохих журмын дагуу гаргуулж, үлдэх хэсгийг хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож, "ХЛ" ХХК-ийн "Хаан" банкин дахь 500343xxxx дугаартай дансан дахь 22.148.847 төгрөг, Х.Р.П-ий 511404xxxx дугаартай "Хаан" банкны дансан дахь 5.186.475 төгрөгийг тус тус эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, "ХЛ" ХХК-ны нэр дээр бүртгэлтэй xxxx УБЛ, xxxx УБО улсын дугаартай "Фотон форланд" загварын автомашин, xxxx УБА дугаартай "Форланд", xxxx УБВ улсын дугаартай "Жидонг" машин, дугаар нь тодорхойгүй "Максмелл" машиныг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгож хууль ёсны эзэмшигч нарт, мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон Улсын Мөрдөн Байцаан Газрын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-ы 5.000.000 төгрөгийг, /Х.Р.П-ийн хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-ы 50.000.000 төгрөгийг болон Х.Р.П-ийн 575324211-9, 507717427-8, 575324211-9 дугаартай "Хаан" банкны хадгаламжийн дэвтэр 3 ширхэг, "ХЛ" ХХК-ийн ТТБ3810, 2865378 дугаартай тэмдэг 1 ширхэг, "ХЛ" ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, "ХЛ" ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, "СЭБЭ" ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, Ч.У-ийг дэвтэр 1 ширхэг, складны бүртгэл 1 ширхэг, "ХЛ" ХХК-ийн 2010 оны Санхүү, Татварын тайлангууд 1 хавтас /яллагдагч Д.Н-гийн гараар бичсэн тайлан гэх/, өмгөөлөгч А.Элбэгсайханы хүсэлтэд хавсаргасан хятад хэл дээрх баримтууд 15 хавтас, цэнхэр өнгийн 2 гялгар ууттай

гаалийн мэдүүлгүүд зэргийг тус тус буцаан олгож, Р.Э-ын УБ хх-хх дугаартай, ДОЗ хх-хх дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ, УБ хх-хх, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ улсын дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ 9 ширхгийг Авто тээврийн газарт шилжүүлж зохих журмын дагуу шийдвэрлэхийг үүрэг болгож, В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000 төгрөгийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тэдэнд буцаан олгохыг тус тус дурдаж шийдвэрлэжээ.

Ялтан В.Х.В гаргасан давж заалдах гомдолдоо: Миний бие шүүх, цагдаагийн газарт шалгагдсан бөгөөд шалгалтын явц шударга бус болсон. Мөн бидний өгсөн нотлох баримтыг огтхон ч авч хэлэлцээгүй, бидний мэдэх эрх, хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн.

Түүнчлэн бидэнд туйлын шударга бусаар хандаж, Монгол Улсын татвар төлөгчийн эдлэх ёстой эрхийг маань үл тоосон. Бид Монгол Улсын татвар төлөгч учир адил тэгш эрхийг эдлэх ёстой. Шүүх хуралдаанд манай талын нотлох баримтыг огт үзээгүй бөгөөд ямарч тайлбар тавиагүй. Гол нотлох баримт, гэрчүүдийн талаар:

1. Тэдний хуваариар оруулж ирсэн мотоциклиуд бүгд баримт падаантай. Мөн шүүх хуралдаанд өөрсдөө оруулж ирсэн гэдгээ баталсан,

2. Р.Э шүүх хуралдаанд намайг танихгүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Өөрийн оруулж ирсэн бараандаа өөрөө татвар төлөх ёстой гэдгээ ч гэсэн хуралдаанд зөвшөөрсөн,

3. Ч.У өөрөө найзтайгаа хамт Хятадаас бараа оруулсан гэрээ, баримтыг зөвшөөрсөн. Мөн түүний найз Н.Га нь хуралдаанд Ч.У-ийн мотоцикл гэдгийг баталсан,

4. А.М уг бараа нь Эрээний Алдарынх, Монголчууд Эрээнд очиж бараа авдаг байсныг зөвшөөрсөн. Мөн тэрээр н.Ба, н.Бат, н.Мөц зэрэг хүмүүст гаалийн бүрдүүлэлт хийж өгсөн. Р.Э-т өгсөн татварын цэнхэр дэвтэрийн татварыг бүгдийг нь тэр төлсөн. Бүгд түүний гарын үсэгтэй баримтууд байгаа. Манай “ХЛ” компани нь тэдэнд үйлчилгээний хөлс өгч байгаагүй. Ямар ч худалдааны төлөөлөгч гэрээ, баримт байхгүй,

5. Шүүхийн шинжээчийн албанаас гаргасан хоёр хувь шинжээчийн дүгнэлтэд Р.Э, Т.Э, Ч.У нарын оруулж ирсэн мотоцикл нь манай компанитай огтхон ч хамаагүй гэж заасан,

6. Баянзүрх дүүргийн шүүх хуралдаанд манай өмгөөлөгч шинжээчийн албанд хандан тоо баримт буруу талаар лавлахад шинжээчийн албаны шинжээч ямар ч шалтгаангүйгээр үүнд тайлбар хийгээгүй. Учир нь бид эрх бүхий Аудитын байгууллагаар компанийнхаа санхүүгийн тайлан, блансад аудитын шалгалт хийлгэсэн. Шинжээчийн албаны дүгнэлтэд барааны өртөг, тээврийн зардал, төлсөн НӨТ, орлогын албан татвар зэрэг холбогдох зардлуудыг тооцоогүй. Тоо баримтууд нь бүгд худлаа. Мөн манай дүгнэлт гаргасан шинжээчид хэрэгт татагдсан. Ийм шинжээчийн дүгнэлт үнэн бодит байж чадах уу,

7. А.М нь прокурорын газарт тайлбар өгөх үед түүнээс “Та Р.Э зэрэг хүмүүсийн оруулж ирсэн мотоцикл нь “ХЛ” компанийх гэдгийг мэдэх үү” гэж асуухад тэрээр “Тодорхой мэдэхгүй байна, эдгээр мотоциклиуд нь Эрээн хотод мотоцикл зардаг Алдар гэдэг хүн түүнд өгсөн, бүгдийг нь Монгол хүмүүс Эрээнээс худалдаж авсан, яг хэнийх гэдгийг би мэдэхгүй” гэсэн. Тухайн үед прокурорын газраас Н.Гаээс “Та Монгол хүн мөн үү?” гэж асуусан. Тэгэхээр прокурорын хувьд ямар ч шударга, үнэний зарчмыг баримтлалгүйгээр хэргийн үнэн зөвийг шийднэ гэж байх уу. Үүнтэй холбоотойгоор А.М-ын үнэн үг хэлснийх нь төлөө хариуцагчийн эгнээнд багтаасан байсан.

8. Ч.У, нягтлан Х.Я нар нь намайг хоригдож байх хугацаанд Татварын газрын шалгаж байсан материалыг авч, компаниас хулгайлсан тамгаа ашиглан хуурамч гэрээ байгуулан их хэмжээний мөнгө болох 500.0 сая төгрөгийг залилан авсан.

Тэд эдгээр материалыг ашиглан Мэргэжлийн хяналтын газрын ажилтнуудтай хуйвалдан шийдвэр гаргуулж, мөн Баянзүрх дүүргийн шүүхээр шийдвэр гаргуулсан. Улмаар бид 281.0 сая төгрөгийг Ч.У-т өгүүлэхээр шийдсэн. Түүнчлэн шийдвэрийг шүүхэд шилжүүлсэн. Энэ хугацаанд би саатуулагдаж байсан тул юу ч мэдээгүй. Мөн Баянзүрх дүүргийн Цагдаагийн газраас хэрэг үүсгэж, Цагдаагийн газрын гаргасан нотлох баримтуудад тулгуурлан Ч.У, Х.Я нарыг компанийн эд хөрөнгө завшин, их хэмжээний мөнгөн дүн бүхий хуурамч гэрээ үйлдсэн хэрэгт холбогдуулан хэргийг прокурорын газарт шилжүүлсэн.

Шийтгэх тогтоол нь хэт нэг талыг баримталсан, ямар ч үндэслэлгүй бөгөөд манай талын өгсөн нотлох баримт, гэрчийн

үгийг шүүхийн шийдвэрт огт тусгаагүй, ямар ч тайлбар хийгээгүй. Шүүхийн шийдвэрт дурдсан агуулга нь хэргийн агуулгатай үл нийцэж байна. Энэхүү хэрэг нь мөрдөн байцаалтын шатнаас эхлэн прокурорын газарт хүртэл зориуд санаатайгаар гадаадын компани, гадаадын иргэнийг хэрэгт унагаах гэсэн санаатай байсан. Тэд хувийн эрх ашгийнхаа төлөө улсынхаа хууль цаазыг үл огоорон нийгмийн хэв журмыг ноцтой зөрчиж байна. Гадаадын компани, иргэдийг ингэж хавчсанаар Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Иймд хэргийг Цагдаагийн газарт буцаан, дахин мөрдөн байцаалт явуулж бидэнд Монгол Улсын татвар төлөгчийн хувьд Монгол хүнтэй адил эрхээр хандаж, хэргийн үнэн зөвийг олж өгнө үү гэжээ.

Ялтан Х.Р.П давж гаргасан заалдах гомдолдоо: Манай захирал байхгүй үед худалдагчид бараа зарсан мөнгөө надад өгдөг байсан. Захирлыг буцаж ирэхэд мөнгийн би тоо ёсоор нь захиралд өгдөг байсан. Компанийн бусад асуудлын талаар би юу ч мэдэхгүй. Хэрэв компанид татварын асуудал гарсан бол энэ нь компанийн нягтлан бодогч, захирал хариуцах ёстой зүйл бөгөөд надад огт хамааралгүй. Монголд удаан хугацаанд байрлах шаардлагатай байсан тул сар бүр нааш, цааш явах боломжгүй байсан бөгөөд энд удаан хугацаанд байхын тулд урт хугацаанд оршин суух карт авах шаардлагатай байсан. Тиймээс манай захирал компанийн хувьцааны 20 хувийг миний нэр дээр бүртгүүлсэн. Үнэн хэрэгтээ би нэг ч төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээгүй. Би зүгээр л нэг сарын цалин авч хөдөлмөр эрхэлж байгаа хүн. Энэ тухай манай захирал байцаагчид ярьсан. Бас олон хүмүүс энэ талаар мэдэж байгаа. Би удаа дараа энэ тухай мөрдөн байцаалтад болон шүүхэд мэдүүлэг өгч байсан. Энэ хувьцааны 20 хувийн асуудлаас болж би ял шийтгүүлснээ сая ойлголоо. Энэ хэргийг үнэн зөвөөр шийдэж, гэм буруугүйг минь нотолж өгнө үү гэжээ.

Ялтан В.Х.В, Х.Р.П нарын өмгөөлөгч З.Төмөрхүү давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шийтгэх тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1 дэх хэсэгт зааснаар "хууль ёсны ба үндэслэлтэй байна" гэж заасан шаардлагыг хангаж чадаагүй байна.

Үндэслэлгүй гэсэн шалтгаан нь:

"ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-г яллах болсон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч Ж.Ба-гийн 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн гаргасан 014 дугаартай Шинжээчийн дүгнэлтэд:

"ХЛ" ХХК нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 89.897.063,56 төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 51.729.140,36 төгрөг төлөхөөр байна гэжээ.

Шинжээчийн дүгнэлт дараах зүйлүүдээс шалтгаалан үндэслэлгүй тооцоологдсон байна. Үүнд:

Шинжээчийн тооцоолол 2008-2011 оны санхүүгийн тайланг хамарсан бөгөөд тооцооллоос харахад тухайн компанийн санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтуудтай нэг бүрчлэн танилцаж ажиллаагүй нэмэлт баримтууд болох мотоциклын худалдах, худалдан авах гэрээ, татан авалттай холбоотой тээврийн зардал, хадгалах, ачиж буулгах зардалтай холбоотой гэрээ хэлцэл, төлбөрийн баримтуудыг нь шаардаж шинжээчийн дүгнэлтэд хамруулаагүй байна. Үүнээс үүдэж 1 ширхэг мотоциклыг ямар үнээр худалдан авсан, түүнийг оруулж ирэхтэй холбогдон гарсан зардлууд, мөн хилээр оруулж ирэхэд төлсөн гаалийн татвараас хамааран 1 ширхэг мотоциклын өөрийн өртгийн тооцоолол зөв гараагүйгээс болж тухайн байгууллагын борлуулсан барааны өөрийн өртөг буруу гарах бөгөөд тухайн байгууллагын ашиг буюу татвар ногдох орлого зөв тодорхойлогдоогүй байна.

Мотоциклын барааны тайлан шинжээчийн дүгнэлтээс харагдахгүй байна. Шинжээч 2008-2011 оны хооронд хилээр орж ирсэн 3645 ширхэг мотоциклын тоонд тооцоог гаргасан байгаа. Гэтэл барааны тайланг гаргахдаа 2008 оны эхэнд байсан 53 ширхэг мотоциклын үлдэгдэл дээр 2008-2011 онуудын хооронд импортоор орж ирсэн 3645 мотоциклыг нэмж, 2008-2011 онуудад зарагдсан мотоциклын тоог хасаж эцсийн үлдэгдэл 1275 мотоциклын тоог гаргах байсан боловч шинжээч Ж.Ба мотоциклын барааны тайланг гаргаагүй, мөн эхний үлдэгдэл 53 ширхэг мотоциклын тоог орхигдуулсан зэргээс харахад тооцооны алдаа гаргасан нь нотлогдож байна. Бид 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн №014 тоот Шинжээчийн дүгнэлтийн хавсралт 2-т тусгагдсан барааны эцсийн үлдэгдэл хүснэгтэд тусгагдсан 1.146.052.391 төгрөгийн



дүнг 2011 оны 1 ширхэг мотоциклын дундаж үнэ 898.741 төгрөгт хувааж 1275 ширхэг мотоциклыг үлдэгдлээр үлдээсэн болохыг ойлголоо.

Шинжээч аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тооцооллыг хийхдээ:

2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн №014 тоот шинжээчийн дүгнэлтийн Хавсралт-2

Нийт орж ирсэн мотоцикл - 3645 ширхэг

Үлдэгдэл мотоцикл - 1275 ширхэг

Зарагдсан мотоцикл - 2370 ширхэг

Нийт орлого - 3.209.413,4 мян/төг

Барааны эцсийн үлдэгдэл - 1.146.052,4 мян/төг

Нийт борлуулалтын орлогыг- 2.063.361,0 мян/төг

2008-2011 онуудын хасагдах зардал - 1.164.390,4 мян/төг

Нуусан Татвар ногдох орлого- 898.970,6 мян/төг байна.

Энэхүү нуусан гэх орлого нь 2012 оны жилийн санхүүгийн тайланд 1.463.625,3 төгрөгийн орлогоор тусгагдсан тул нуусан гэж үзэх үндэслэлгүй байна.

Тодруулбал: УМБГ-аас үлдэгдэл мотоцикл болох 614 ширхгийг битүүмжилсэн бөгөөд энэхүү мотоциклиуд нь борлогдоогүй юм. Мотоциклын үлдэгдлийг шинжээчийн гаргасан үлдэгдлээс хөөж тооцвол барааны тайлан хийгдээгүйгээс үлдэгдэл барааг буруу тооцоолсноос шалтгаалан алдаатай дүгнэлт гарчээ.

Шинжээч нуусан гэх татвар ногдох орлогоос ААНОАТ-ыг 89.698 төгрөгөөр тооцож гарган 2013 онд нөхөн төлүүлсэн учраас "ХЛ" ХХК нь өнөөдрийн байдлаар Баянзүрх дүүргийн Татварын албанаас 8.300.000 төгрөгийн авлагатай байгаа бөгөөд тухайн компани нь орлого нуугаагүй болох нь нотлогдож байна.

Шинжээч дээрх татварын тооцооллыг хийхдээ зөвхөн төлөхөөр тооцсон дүнгээр татварын өрийг гаргасан бөгөөд "ХЛ" ХХК-ийн 2008-2010 онд нийт 8496.7 төгрөгийг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст ААНОАТ-аар мөнгөөр төлсөн татварыг хасаж тооцоогүй байна. Шүүхийн тогтоол нь тодорхой, ойлгомжтой бичигдсэн байх бөгөөд танилцуулан сонсгосноор хүчин төгөлдөр болно. Гэтэл шүүхээс гаргаж буй энэхүү эрх зүйн акт нь шүүхийн хэлэлцүүлэгт оролцсон гэрч, шинжээч, шүүгдэгч нарын мэдүүлэг бүрэн гүйцэт тусгагдаагүй, ойлгомжгүй байгаа нь шүүх хүний эрхийн баталгааг

хангахын тулд хэргийг бүрэн гүйцэд уншиж, гэм бурууг үнэн зөв тогтоодог гэхэд эргэлзээ төрж байна.

Ялтан Х.Р.П-ийн өмгөөлөгч М.Алтанцэцэг давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна. Үүнд:

1. Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт В.Х.В-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж ирүүлснийг мөн хуулийн тусгай ангийн 299 дүгээр зүйлийн 299.1 дэх хэсэг болгон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2 дахь хэсэгт заасан шүүхийн эрх хэмжээний хүрээнд хөнгөрүүлэн зүйлчлэхээр тогтов гэж бичсэн нь "Хээл хахууль өгөх" гэмт хэргийг "Хориглосон арга хэрэгслээр дайн хийх" гэмт хэргээр хөнгөрүүлэн зүйлчилжээ.

Мөн Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, ялтан Д.Н-гийн эдлэх ялыг мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй" гэж бичиж, ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр зааж, шүүхийн тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болно, шүүхийн шийтгэх тогтоол тодорхой, ойлгомжтой бичигдсэн байна гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 299.3, 294.2 дахь хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчсөн хууль бус тогтоол болжээ.

2. Уг хэргийг шийдвэрлэхэд үндэслэл болсон шинжээчийн дүгнэлтийг гаргахдаа мөрдөн байцаагч В.Х.В, Х.Р.П нарыг 461 дүгээр ангид хоригдож байхад нь шинжээч томилж, томилсон тогтоолыг тэдэнд цаг хугацаанд нь танилцуулж шинжээчийг татгалзан гаргах эрх, үүргийг тайлбарлан эрхийг нь эдлүүлээгүй, мөн холбогдох санхүүгийн баримт бичгүүдийг тэднээс бүрэн гүйцэд гаргуулж аваагүй нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155, 157 дугаар зүйлүүдийг ноцтой зөрчжээ.

Шинжээчийн дүгнэлтээс харахад 2008-2011 оны санхүүгийн тайланг хамарсан гэж гаргасан атлаа 2008 оны эхний үлдэгдэл болох 53 ширхэг мотоциклыг оруулж тооцоогүй нийт 3645 ширхэг мотоциклоос үлдэгдэл нь 1275 ширхэг мотоцикл гэж

гаргасан нь 2012 онд зарагдсан мотоциклыг 2011 онд зарагдсан мэтээр оруулснаас борлуулсан үнийн дүн автоматаар өссөн ба татварт төлөх мөнгөний дүн өссөн байгаа.

Мөн шинжээч дээрх татварын тооцооллыг хийхдээ зөвхөн төлөхөөр тооцсон дүнгээр татварын өрийг гаргасан бөгөөд “ХЛ” ХХК-ийн 2008 онд 62,0 мян/төгрөг, 2009 онд -1348,6 мян/төгрөг, 2010 онд 5091,7 мян/төгрөг, 2011 онд 1994,4 мян/төгрөг, нийт 8496,7 мян/төгрөг Баянзүрх дүүргийн татварын хэлтэст Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар төлсөн татварыг хасаж тооцоогүй байна.

Шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй.

### 3. Хэргийн зүйлчлэлийн талаар:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлд заасан татвар төлөхөөс санаатай зайлсхийх гэмт хэргийн субъект нь “татвар ногдвол зохих орлого, эд хөрөнгөтэй болон ажил үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа зөвхөн татвар төлөх үүрэг бүхий этгээд байдгаараа бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс ялгагдана”, объектив тал нь зөвхөн татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн идэвхтэй үйлдэл, татвараа зохих ёсоор төлөхгүй байх зэрэг эс үйлдэхүйн хэлбэртэй байж болдог.

Татварын хуулийн 13.1 дэх хэсэгт “Татвар төлөгч гэж татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд байх ба уг этгээд нь татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлнэ”.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт зааснаар гүйцэтгэсэн гэж үзэх ямарч үндэслэлгүй ба дээрх хуулиудад зааснаар Х.Р.П нь татвар төлөх үүрэг бүхий этгээд буюу эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъект биш байна.

“ХЛ” ХХК нь 2004 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байхад нь Х.Р.П нь 2005 онд Монгол Улсад ирж уг компанид засварчнаар ажиллаж байсан.

4. Эрүүгийн 201201000471 дугаартай хэрэгт гэрч Р.Баа нь /0202/ “Зарим мотоцикл хайрцагтаа моторгүй ирээд дараа нь мотор нь ирдэг байсан, ийм мотоцикл дээр Х.Р.П арлын дугаарыг цохьдог байсан”, гэрч Д.Ба нь “Х.Р.П-д худалдан авсан мотоциклынхоо мөнгийг өгдөг байсан” гэж түүнийг ямар ажил үүрэг гүйцэтгэж байсан талаар мэдүүлсэн, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан /0202/ арлын дугаартай цохидог багаж болон

өөрийнх нь мэдүүлгээс харахад Х.Р.П нь “ХЛ” ХХК-ийн мотоциклын дэлгүүрт засварчнаар ажиллаж байсан ба компанийн захирал В.Х.В, орчуулагч Ч.У, В.М.Ж нарын эзгүйд орлогын мөнгийг авч дараа нь В.М.Ж нарт өгдөг байсан, “ХЛ” ХХК-ийн дүрэм, журамд хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагын талаар огт заасан зүйл байхгүй байна.

5. Мөрдөн байцаалтын шатанд В.Х.В нь сэжигтэн, яллагдагчаар мэдүүлэг өгөхдөө “Би Х.Р.П-ийг хүн хүч хүрэлцэхгүйн улмаас Монголд авчирч засварчнаар ажиллуулж байсан”, Х.Р.П нь “Би нярваар ажиллаж байгаагүй, энэ компанид хувьцаа эзэмшдэггүй, цалин авч ажилладаг жирийн нэг ажилчин, би баталгаат засварын хугацаанд мотоциклыг засдаг, В.М.Ж-г байхгүй байхад худалдагч нарын мөнгийг авдаг байсан нь үнэн, компаниас ямар нэг ашиг авдаггүй байсан” гэж удаа дараагийнхаа мэдүүлэгт тогтвортой мэдүүлж байсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 82 дугаар зүйлийн 82.2 дахь хэсэгт зааснаар нотлох баримтын хэмжээнд үнэлэх боломжтой байна.

В.Х.В нь Х.Р.П-ийг хүн хүчний дутмагаас Монгол Улсад оруулж ирсэн ба удаан хугацаагаар оршин суух эрхтэй байлгахын тулд “ХЛ” ХХК-ны хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн ба Х.Р.П нь уг компанид хөрөнгө оруулж, хувьцаа худалдан авч, түүнийхээ ашгаас хүртэж байсан болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогдоогүй байна.

Х.Р.П нь татвар төлөх үүрэг хүлээсэн этгээд биш, Баянзүрх дүүргийн татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлээгүй “ХЛ” ХХК-ийн санхүүгийн тайланг гаргадаггүй бөгөөд шинжээчийн дүгнэлтэд тусгагдсан “ХЛ” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татварыг дутуу тайлагнасан гэх асуудалд Х.Р.П нь огт хамааралгүй байхад түүнийг онц их хэмжээний татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэргийг гардан гүйцэтгэсэн гэм буруутайд тооцож шийтгэх тогтоол гаргасан нь үндэслэлгүй байна.

Иймд ялтан Х.Р.П-ий татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэх үйлдлийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Д.Н гаргасан давж заалдах гомдолдоо:

Анхан шатны шүүхээс эцэслэн гаргасан шийдвэрт маргах зүйлгүй байна. 2012 оны 9 дүгээр сараас эхлэн мөрдөн байцаалтад шалгагдаж байгаад хоригдох хүртлээ өөрийн хийсэн хэргээ ухамсарлан, өөртөө харамсч алдаа дутагдлаа ойлгож бие сэтгэлээрээ мэдэрч туйлын их гэмшиж байна. Миний бие айлын ууган охин бөгөөд 7 өнчин дүүтэй, өрх толгойлсон 2 хүүхэд, ач, зээ нарын хамт өндөр настай 80 дөхөж яваа тахир дутуу ээжийгээ асран халамжилдаг. Уг хэрэгт шалгагдаж байх хугацаандаа төрсөн дүүгээ хорт хавдраар алдсан нь надад болон гэр бүлийхэнд минь асар их хүнд цохилт болон үлдсэн. Миний бие улсад 1985 оноос 2014 оны 2 дугаар 28-ны өдрийг хүртэл хоёргүй сэтгэлээр үнэнч шударгаар хөдөлмөрлөж, гавьяа шагналаар шагнуулж, хамт олондоо нэр хүндтэйгээр ажилласаар ирсэн.

Анхан шатны шүүхээс оногдуулсан торгууль болох 1.950.000 төгрөгийг бүрэн гүйцэт төлж барагдуулсан. Иймд миний хохирол төлсөн байдал болон ар гэрийн амьдрал ахуйн хүнд нөхцөлийг харгалзан үзэж анхан шатны шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнсэн харгалзаж хөнгөрүүлж өгнө үү гэжээ.

Ялтан Д.Н-гийн өмгөөлөгч С.Оюун гаргасан давж заалдах гомдолдоо:

Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт В.Х.В нь онц их хэмжээний татвар төлөх үйлдлээ нуун дарагдуулахын тулд Д.Н-д 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэсэн нь: В.Х.В нь өөрөө мөнгийг өгөөгүй ах өгсөн байж магадгүй, Д.Н-г хээл хахууль авсан үйлдлээ нуун дарагдуулахын тулд зохиомол байдлыг бий болгосон баримт үйлдсэн нь нотлогджээ.

В.Х.В Д.Н-д хээл хахууль өгсөн эсэх талаар шууд тогтоосон баримт хэрэгт авагдаагүй, түүнчлэн шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлгээр нотлогдон тогтоогдохгүй байхад анхан шатны шүүх хээл хахууль авсан нь тогтоогдсон гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь хэсгийг үндэслэн хэрэгсэхгүй болгох,

Д.Н-г “ХЛ” ХХК-ийн хүн амын орлогын тайлан гаргаж 450.000 төгрөгийн хээл хахууль авсан гэсний тухайд тэрээр тус компанид тайлан гаргаж өгч байсан гэх үйлдэл нь Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт “Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх

ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдлийг хийхийг ойлгоно гэснээр түүнийг албан тушаалын эрх мэдлээ урвуулан хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилготой байсан гэж үзэхээр байгаа юм. Д.Н-гийн энэхүү үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсгээр зүйлчилсэн зүйлчлэл нь хэргийн бодит байдалд нийцээгүй байх ба харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хэлбэрийн төдий агуулсан байх боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.1 дэх хэсэгт заасан хэрэг нь үлэмж хэмжээний хохирол учирсан байхыг шаардсан байна. Иймд Д.Н-гийн энэхүү үйлдлийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1 дэх хэсэгт зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Ялтан Д.Н-гийн өмгөөлөгч М.Цэрэндэжид давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Анхан шатны шүүх хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилсөнд маргахгүй. Д.Н өөрийн гаргасан алдаа дутагдал болон гэм буруутай үйлдлээ бүрэн ойлгож гэмшиж байгаа бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр шийдвэрлэсэн 1.950.000 төгрөгийг бүрэн төлж барагдуулсан.

Д.Н нь улсад 25 жил тасралтгүй ажиллаж хувь нэмрээ оруулсан, хувийн амьдралын хувьд өрх толгойлсон эмэгтэй, өндөр настай эхийгээ асардаг, хэрэгт шалгагдаж байх үедээ тэрээр өөрийн төрсөн дүүгээ хүнд өвчний улмаас алдсан, анх удаа хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлж байгаа, хохирлыг нөхөн төлсөн байдлыг харгалзан үзэж Эрүүгийн хуулийн ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг тэнсэж өгнө үү гэв.

Цагаатгагдсан этгээд А.М-ын өмгөөлөгч Ц.Алтанцол тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

А.М-ын хувьд шийтгэх тогтоол үндэслэлтэй гарсан тул хэвээр үлдээж өгнө үү гэв.

Хохирогч Р.Б тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Шийтгэх тогтоол үндэслэлтэй зөв гарсан тул хэвээр үлдээж өгнө үү гэв.

Шүүх хуралдаанд оролцсон прокуророос: Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй зөв гарсан. 2012 оны тайлангийн асуудалд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь Эрүүгийн хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэх боломжтой, хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх саналтай байна гэв.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1 дэх хэсэгт заасан "шүүхийн тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй байна" гэсэн шаардлагыг хангажээ.

#### ХЯНАВАЛ:

В.Х.В нь "ХЛ" ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа Х.Р.П, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851.14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд зохион байгуулагчаар оролцсон,

- Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн Татварын улсын байцаагч Д.Н-г 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр /24/10/0961 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу "ХЛ" ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийхэд нь онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгч, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай акт бичүүлсэн, мөн "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс Татварын улсын байцаагч Д.Н-д албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Х.Р.П нь "ХЛ" ХХК-д нярваар ажиллаж байхдаа В.Х.В, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг

/141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851.14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

Д.Н нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6-д заасан "Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх" гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ХЛ" ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, Аж ахуйн нэгжийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн "ХЛ" ХХК-д Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу "татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих" гэсэн заалтуудыг зөрчиж тус компанийн их хэмжээний татвар ногдох орлогыг илрүүлсэн атлаа дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагад шилжүүлэхгүй, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай "Татварын улсын байцаагчийн акт" бичиж, захирал Бүгд найрамдах Хятад ард улсын иргэн В.Х.В гэгчээс 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль авсан, мөн Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг тус "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гарган өгч, "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-аас Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргийг үйлдсэн болох нь:

Хохирогч Р.Б-ийн /4 дүгээр хх-182-183

дугаар тал, 6 дугаар хх-4 дүгээр тал/, гэрч Б.Ня-ийн /4 дүгээр хх-245 дугаар тал/, Ч.У-ийн /1 дүгээр хх-25-26 дугаар тал, 4 дүгээр хх-234-235, 237-238, 243-244 дүгээр тал/, Г.А-ын /4 дүгээр хх-192-194 дүгээр тал/, Х.Я-ын /1 дүгээр хх-27 дугаар тал, 4 дүгээр хх-212-213 дугаар тал/, Р.Э /4 дүгээр хх-186-187, 190-191 дүгээр тал/ нарын мэдүүлсэн мэдүүлгүүд, эд зүйлд үзлэг хийсэн тэмдэглэл /1 дүгээр хх-33-54, 57-61 дүгээр тал, 3 дугаар хх-97-98 дугаар тал, 5 дугаар хх-1 дүгээр тал/, эд хөрөнгө хураан авах тогтоол /1 дүгээр хх-127 дугаар тал/,

"...Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийн тайланд 8.662.674,4 төгрөгийг тусгаагүй, албан татвар ногдох орлогод тооцоогүй, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийн 2011 оны 12 дугаар сарын тайлангийн "худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ, импортын бараа" хэсэгт 221.769,9 мянган төгрөгийг тусган хассан зэргээр аж ахуйн нэгжийн орлого, НӨАТ ногдуулан төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн..." гэсэн 980060 тоот Татварын улсын байцаагчийн дүгнэлт /2 дугаар хх-73-75 дугаар тал/, "980060 дугаартай татварын улсын байцаагчийн дүгнэлт бүрэн үндэслэлтэй гэж үзэхээр байна, энэ дүгнэлтэд Ч.У-ийн 2011 оны оруулж ирсэн мотоцикл оруулж ирсэн гэж тоог гаргаад зөрчилд тооцоходоо 3412 ширхэг тооцооллын алдаа гаргасан байна, мөн орж ирсэн сэлбэгийн тоог гаргаагүй нийт үнийн дүнгээр тооцоог хийсэн, 2008, 2009, 2010, 2011 онд Бүгд Найрамдах Хятад Ард улсаас "ХЛ" ХХК нь өөрийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг импортоор оруулж ирсэн гэдэг нь үндэслэлтэй байна, Монгол Улсын иргэн Р.Э 7776, Т.Э 245, Ч.У 156 ширхэг, нийт 11822 ширхэг мотоцикл импортлон борлуулсныг "ХЛ" ХХК дээр оруулж тооцсон нь үндэслэлгүй байна, "ХЛ" ХХК нь импортоор оруулж ирсэн мотоцикл, сэлбэгийн тоогоо дутуу тайлагнаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас зайлсхийсэн байна, "ХЛ" ХХК нь ААНОАТ 89.897.063,56 төгрөг, НӨАТ 51.729.140,36 төгрөг төлөхөөр байна, ААНОАТ, НӨАТ-ын хуулийн дагуу татварын хувь хэмжээг тооцсон, "ХЛ" ХХК нь санхүү, татварын тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж байсан боловч импортоор оруулж ирсэн мотоцикл, сэлбэгийг дутуу тайлагнаж байсан, "ХЛ" ХХК нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Аж ахуйн нэгжийн

орлогын албан татварын хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын хуулиудыг зөрчсөн байна, Р.Э, Т.Э, Ч.У нарын оруулж ирсэн мотоцикл болон сэлбэгийн борлуулалтын орлогод хувь хүний орлогын албан татвар төлөхөөр байна..." гэсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 014 тоот шинжээчийн дүгнэлт /5 дугаар хх-87-163 дугаар тал/,

"...Р.Э-ын нэрээр 7776 ширхэг мотоцикл, Т.Э-ийн нэрээр 245 ширхэг мотоцикл, Ч.У-ийн нэрээр 156 ширхэг мотоцикл оруулж ирсэн гаалийн мэдээ байна, иймд "ХЛ" ХХК-ийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох боломжгүй, Р.Э нь нийт 163.079.153, 76 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, 162.079.153,76 төгрөгийн НӨАТ, Т.Э нь 6.970.034,58 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, 5.970.034,58 НӨАТатвар, Ч.У нь 3.509.635,27 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар, 2.509.635,27 төгрөгийн НӨАТатвар төлөхөөр байна..." гэсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 046 тоот шинжээчийн дүгнэлт /5 дугаар хх-170-179 дүгээр тал/,

"...Шинжлэгдэж буй "2-16" хүртэл дугаарласан нийт 15 ширхэг "АВТО ТЭЭВЭР", "ТХБХ-12" гэсэн бичиглэлтэй тэмдэгний дардсууд нь мэргэжилтэн Р.С-ын эзэмшиж буй дардасны загвартай тохирч байна, Шинжлэгдэж буй "1, 17-24" хүртэл дугаарласан нийт 9 ширхэг "АВТО ТЭЭВЭР", "ТХБХ-13" гэсэн бичиглэлтэй тэмдэгний дардсууд нь мэргэжилтэн Т.У-гийн эзэмшиж буй дардасны загвартай тохирч байна, Шинжлэгдэж буй 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Баталгаа" гэсэн толгойтой, "Н.Д-ийн..." гэж эхлээд "...Ч.У" гэж дуусгасан гар бичмэлүүд нь Д.Н-гийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна, Шинжлэгдэж буй тал цаасны арын хэсэгт "2011 оны ..." гэж эхлээд "...авсан..." гэж дуусгасан гар бичмэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн гэрч Ч.У-ийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна, Шинжилгээнд ирүүлсэн 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "зээлдсэн" гэсний ард, арын нүүрэнд "өгсөн" гэсэн бичиглэлийн ард тус тус зурагдсан шинжлэгдэж буй гарын үсгүүд нь сэжигтэн Д.Н-гийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай гарын үсгийн ерөнхий болон хувийн онцлог шинж

тэмдгүүдээрээ тохирч байна, Шинжилгээнд ирүүлсэн 148х209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Зээлдүүлэгч" гэсний ард, арын нүүрэнд "авсан" гэсэн бичиглэлийн ард зурагдсан гарын үсгүүд нь гэрч Ч.У-ийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай тохирч байна, Шинжилгээнд ирүүлсэн "ХЛ" ХХК "Санхүү, татварын тайлангууд 2010 он" гэсэн хаягтай цэнхэн өнгийн хавтастай материалын "Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын тайлан" гэсэн баримтын дунд хүснэгтэд, "Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлан"-гууд гэсэн баримтын хүснэгтэд бичигдсэн тоон бичиглэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн сэжигтэн Д.Н-гийн гэх дэвтэрт дээр бичигдсэн тоон бичиглэлүүдтэй тохирч байна..." гэсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 931 тоот шинжээчийн дүгнэлт /5 дугаар хх-195-198 дугаар тал/,

"...Шинжилгээнд ирүүлсэн тал бичгийн цаасны нэг тал дээр бичсэн "Баталгаа Д.Н миний бие "ХЛ" ХХК-ийн орчуулагч Ч.У-ийн цалин болох 150000 төгрөгийг захирал В.Х.В-аас авч гурван сарын хугацаатай буцаан төлөхөөр зээлж авав, Зээлдсэн Д.Н, "Зээлдүүлэгч Ч.У" гэсэн бичиглэлийн будагч бодис болон нөгөө тал дээр "2011 оны 3-6-нд мөнгөө буцаан авав. Өгсөн, авсан "бичиглэл" Ч.У-ийн гарын үсэг нь, "Д.Н-гийн гарын үсэг" гэсэн бичиглэлийн будагч бодис нь хоорондоо ижил байна..." гэсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2617 тоот шинжээчийн дүгнэлт /5 дугаар хх-209-210 дугаар тал/ зэрэг хэрэгт цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар хангалттай тогтоогдсон байна.

Хэрэгт авагдсан Татварын Улсын байцаагчийн дүгнэлт болон шинжээчийн дүгнэлтүүдээс үзэхэд "ХЛ" ХХК нь татварын тайланд нийт 485.743.851,14 төгрөгийг тусгаагүй хохирол учруулсан болох нь тогтоогдсон ба Улсын байцаагчийн дүгнэлт мөн шинжээчийн дүгнэлтүүдийг үндэслэлгүй буюу зөв болох нь эргэлзээтэй, бүрэн биш хийгдсэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Гэрч Б.Ня, Ч.У, Г.А, Х.Я, Р.Э нарын мэдүүлгүүдээс дүгнэж үзэхэд "ХЛ" ХХК-ийн нэрээр 2008-2011 онуудад Бүгд найрамдах Хятад ард улсаас 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 ширхэг мотоцикл, Т.Э-ийн нэрээр 245 ширхэг мотоцикл, Ч.У-ийн

нэрээр 156 ширхэг мотоцикл буюу нийт 11822 ширхэг мотоциклыг оруулж ирсэн болох нь тогтоогдсон, татварын тайланд тусгаагүй хохирлын дүн нь 485.743.851,14 төгрөг болох нь нотлогдсон болно.

Ялтнуудын гэм буруу тухайн хэрэгт хамааралтай, хуульд заасан үндэслэл, журмын дагуу Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй байна.

Анхан шатны шүүх шүүгдэгч Д.Н-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268.1 дэх хэсэг болгон, шүүгдэгч В.Х.В-д прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269.1 дэх хэсэг болгон тус тус хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Анхан шатны шүүх нь Д.Н, В.Х.В нарын үйлдэл нь өөр цаг хугацаанд үйлдэгдсэн боловч нэг зорилго чиглэлд хүрэхийн тулд нэг төрлийн үйлдлүүдийг тасралтгүй хэрэгжүүлсэн, нэгдмэл хор уршигт хүрэхэд чиглэгдсэн, нэг үр дагаврыг бий болгосон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 18 дугаар зүйлд заасан "давтан" шинжийг агуулаагүй байна гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2 дахь хэсэгт заасан шүүхийн эрх хэмжээний хүрээнд дүгнэснийг буруутгах үндэслэлгүй.

Анхан шатны шүүх прокуророос А.М-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйдийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүний цагаатгаж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

Хэргийн бүрдэл хангагдсан, мөрдөн байцаалтын шатанд чухал ач холбогдолтой байж болох зүйлийг бүрэн шалгасан, анхан шатны шүүх хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн дүгнэлт хийсэн, хэргийг зөв зүйлчлэн, ялтнуудын гэм буруу болон хувийн байдалд тохирсон хуульд заасан ял шийтгэл оногдуулжээ.

Хэрэгт авагдсан баримтаас дүгнэж үзвэл: В.Х.В-ы "...компанийн хоёр гишүүн нь тус бүр 20 хувь эзэмшиж хөрөнгө оруулсан санагдаад байна, энэ хоёр хүний нэг нь Х.Р.П. Х.Р.П нь засварын мэргэжилтэн болохоор мотоцикл засахаас гадна агуулах хариуцдаг байсан. Намайг байхгүй хойгуур Х.Р.П хариуцан ажилладаг байсан..." /6 дугаар хх-23-28 дугаар тал/,

Гэрч И.Ба-гийн "...Х.Р.П л бүх зүйлийг гардаж хийж, тооцоо мөнгийг нь барьдаг. Би дандаа Х.Р.П-д мөнгөө өгдөг байсан..." /4 дүгээр хх-196 дугаар тал/,

Гэрч Т.А-ын "...Х.Р.П нь мөн хөрөнгө оруулагч. Х.Р.П нь жижиг төмөр дээр арал, моторын дугаарыг цохиод нааж байхад нь харж байсан, гаалийн бичиг дээрх арал, моторын дугаар нь зарагдах мотоциклын арал, моторын дугаартай зөрөөд байдаг байсан юм..." /4 дүгээр хх-192 дугаар тал/,

Гэрч Г.Г-ийн "...би кассын баримтыг хоёр хувь үйлдэн нэг хувийг нь худалдан авагчид баталгааны хуудасны хамт, үлдэх хувийг нь Ч.У болон Х.Р.П нарт өгдөг байсан, Х.Р.П мотоциклын арал, моторын дугаарыг гаалийн мэдүүлэг дээрээс харж байгаад цохьдог байсан. Х.Р.П нь захирлын туслах байдхаа хамаг юмыг нь хийгээд л мөнгө, тооцоог бүгдийн барьдаг байсан..." /4 дүгээр хх-195 дугаар тал/

Гэрч Р.Б-гийн "...Х.Р.П нь байнга Монголд байдаг бөгөөд би зөвхөн Х.Р.П-тэй холбогдон худалдаагаа хийдэг байсан, худалдаа хийсэн баримтыг Х.Р.П үйлдэж өгдөг байсан, ер нь Х.Р.П л бүгдийг нь мэдэж хийдэг байсан..." /4 дүгээр хх-217-218 дугаар тал/ зэрэг мэдүүлгээс үзэхэд Х.Р.П нь онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон гэм буруутай болох нь тогтоогдож байна.

Дүгнэвэл: Тус компанийн нярав Х.Р.П нь дээрх тооны мотоциклиудыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад оруулж ирэхдээ Р.Э, Т.Э, Ч.У нарын нэрээр оруулан ирж, тэдэнд урамшуулал өгч, мөн мотоциклуудын борлуулалтын орлогыг хүлээж авах, бүртгэл хийх мөн мотоциклиудын арлын номерийг солих, дугаарлах ажлыг хийж гүйцэтгэж байсан зэргээр оролцож татварын орлогыг нуун дарагдуулж байсан нь гэрч Г.Г, Т.А, И.Ба, А.М, Р.Баа нарын мэдүүлгээр нотлогджээ.

В.Х.В, Х.Р.П нар бүлэглэн, давтан үйлдлээр татвараас зайлсхийж, онц их хэмжээний хохирол учруулсан, Д.Н нь

хээл хахууль авсан, В.Х.В нь хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн нь хохирогч, гэрч нарын мэдүүлгүүд, шинжээчийн дүгнэлт болон шүүхээр хэлэлцэгдсэн бусад нотлох баримтуудаар хангалттай тогтоогдсон, ял шийтгэлийг хөнгөрүүлэх, хэргийн зүйлчлэлийг өөрчлөх, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах үндэслэл тогтоогдохгүй байх тул ялтан В.Х.В-ы "...мөрдөн байцаалтад буцааж, хэргийн үнэн зөвийг олж өгнө үү..." гэх, ялтан Х.Р.П-ий "...хэргийг үнэн зөвөөр шийдэж өгнө үү..." гэх, ялтан В.Х.В, Х.Р.П-ий өмгөөлөгч З.Төмөрхүүгийн "...шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү..." гэх, ялтан Х.Р.П-ий өмгөөлөгч М.Алтанцэцэгийн "...Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү..." гэх, ялтан Д.Н-гийн "...хорих ялыг тэнсэж өгнө үү..." гэх, ялтан Д.Н-гийн өмгөөлөгч С.Оюуны "...гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү..." гэх, ялтан Д.Н-гийн өмгөөлөгч М.Цэрэндэжидийн "...хорих ялыг тэнсэж өгнө үү..." гэх гомдлуудыг тус тус хүлээн авах боломжгүй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Шийтгэх тогтоолын 8 дахь заалтад В.Х.В-аас 309.705.882 төгрөгийг, Х.Р.П-ээс 34.411.764 төгрөгийг буюу нийт 344.117.647 төгрөгийг гаргуулж хохирогч Р.Б /Баянзүрх дүүргийн татварын хэлтэст/ олгож шийдвэрлэжээ. Гэтэл шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 11, 12 дахь заалтуудаар "В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг тэдэнд буцаан олгож" шийдвэрлэж байгаа нь үндэслэлгүй байх тул В.Х.В, Х.Р.П нарт оногдуулсан эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан 65.000.000 төгрөгийг ялтнуудын хохиролд тооцуулахаар Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт: "...В.Х.В-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж ирүүлснийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн "299.1" дэх хэсэг болгон..." гэж буруу бичсэнийг тэмдэглэх нь зүйтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315

дугаар зүйлийн 315.1.1, 315.1.4 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 11 дэх заалтын:

...мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон УМБГ-ын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-ы 5.000.000 төгрөгийг, /Х.Р.П-ий хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-ы 50.000.000 төгрөгийг буцаан олгож..." гэснийг,

12 дахь заалтын: "...ялтан В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг шийтгэх тогтоод хүчин төгөлдөр болмогц тэдэнд буцаан олгосугай..." гэснийг

"...ялтан В.Х.В, Х.Р.П нарын эд

хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсүгэй..." гэж тус тус өөрчлөлт оруулж, шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалтуудыг хэвээр үлдээж, ялтан В.Х.В, Х.Р.П, тэдний өмгөөлөгч З.Төмөрхүү, ялтан Х.Р.П-ийн өмгөөлөгч М.Алтанцэцэг, ялтан Д.Н, түүний өмгөөлөгч С.Оюун, М.Цэрэндэжид нарын гаргасан давж заалдах гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

2. Гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд нь давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Д.МӨНХТУУЛ  
Ч.ХОСБАЯР  
Ш.БАТ-ЭРДЭНЭ



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

В.Х.В, Х.Р.П, Д.Н, А.М нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгч Р.Батцэрэн даргалж, шүүгч Р.Бат-Эрдэнэ, Д.Ганзориг, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн нарын бүрэлдэхүүнтэй, Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор С.Алимаа, ялтан В.Х.В-ы өмгөөлөгч З.Төмөрхүү, ялтан Х.Р.П-гийн өмгөөлөгч М.Алтанцэцэг, нарийн бичгийн дарга Б.Өлзийхишиг нарыг оролцуулан, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 465 дугаар магадлалтай, В.Х.В, Х.Р.П, Д.Н, А.М нарт холбогдох эрүүгийн хэргийг ялтнуудын өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг үндэслэн шүүгч Р.Бат-Эрдэнийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. БНХАУ-ын иргэн, ... оны ... дугаар сарын ...-нд төрсөн, ... настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, фото зурагчин мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ "ХЛ" ХХК-ийн захирлаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, ... 401 тоотод оршин суух, В.Х.В,

2. БНХАУ-ын иргэн, ... оны ... дүгээр сарын ...-нд төрсөн, ... настай, эрэгтэй, бүрэн дунд боловсролтой, засварчин мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ "ХЛ" ХХК-д нярав ажилтай байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, ... байранд оршин суух, Х.Р.П,

3. Монгол Улсын иргэн, ... оны ... дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ... настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст Татварын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл... , хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, Б овогт Д.Н,

4. Монгол Улсын иргэн, ... оны ...

дугаар сарын ...-нд Дорноговь аймгийн ... суманд төрсөн, ... настай, эрэгтэй, бага боловсролтой, мэргэжилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Дорноговь аймгийн ... сумын ... дүгээр баг, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, А овогт А.М.

В.Х.В нь "ХЛ" ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа Х.Р.П, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд зохион байгуулагчаар оролцсон,

Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Н-г 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр /24/10/0961 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу "ХЛ" ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийхэд нь онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгч, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай акт бичүүлсэн, мөн "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс татварын улсын байцаагч Д.Н-д албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Х.Р.П нь "ХЛ" ХХК-д нярваар ажиллаж байхдаа В.Х.В, А.М нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл,

3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

А.М нь "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В, нярав Х.Р.П нартай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

Д.Н нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6-д заасан "Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх" гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ХЛ" ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, Аж ахуйн нэгжийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн "ХЛ" ХХК-д Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу "татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн

хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичиж" гэсэн заалтуудыг зөрчиж тус компанийн их хэмжээний татвар ногдох орлогыг илрүүлсэн атлаа дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагад шилжүүлэхгүй, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай "Татварын улсын байцаагчийн акт" бичиж, захирал БНХАУ-ын иргэн В.Х.В гэгчээс 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль авсан, мөн Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг тус "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гарган өгч, "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-аас Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль авч, энэ хэргийг давтан үйлдсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоолоор прокуророос А.М-ад Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж, Д.Н-д прокуророос Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн 268.1 дэх хэсэг болгон, В.Х.В-д прокуророос Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийн зүйлчлэлийг мөн хуулийн 269.1 дэх хэсэг болгон тус тус хөнгөрүүлэн зүйлчилж, В.Х.В, Х.Р.П нарыг бүлэглэн, давтан үйлдлээр татвараас зайлсхийж онц их хэмжээний хохирол учруулсан, Д.Н-г хээл хахууль авсан, В.Х.В-г хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар В.Х.В-аас 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 жил хорих ялаар, Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Х.Р.П-ээс 500.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 01 сар хорих ялаар, Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар Д.Н-г төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн

хугацаагаар хасаж, 1 жил 06 сар хорих ялаар, Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-г 1 жил 06 сар хорих ялаар тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-д Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 6 жил хорих ял дээр мөн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 1 жил 06 сар хорих ялын зарим болох 6 сар хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 1.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 жил 06 сар хорих ялаар тогтоож, Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, ялтан Д.Н-гийн эдлэх ялыг мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлж, Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-гийн 120 хоног, Х.Р.П-гийн 32 хоног цагдан хоригдсоныг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, ялтан Д.Н болон А.М нар нь цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдаж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар В.Х.В-аас 309.705.882 төгрөгийг, Х.Р.П-ээс 34.411.764 төгрөгийг буюу нийт 344.117.647 төгрөгийг гаргуулж, хохирогч Р.Б /Баянзүрх дүүргийн татварын хэлтэс/-д олгож, Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар Д.Н-гийн гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлого болох 1.950.000 төгрөгийг хурааж, улсын орлогод оруулж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн мотоциклын арлын дугаар цохигч багажууд, үүнд хар хайрцган дотор 44 ширхэг хар өнгийн цохигч төмөр, 15 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, улаан хайрцган дотор 22 ширхэг хар өнгийн цохигч төмөр, хэрэглэж байсан 11 ширхэг хөнгөн цагаан нимгэн наалт, "бүргэд" гэсэн бичигтэй наалт 1 ширхгийг устгаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.2, 88.1.4, 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт битүүмжлэгдсэн 614 ширхэг мотоцикл, 113 ширхэг сэлбэгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, ялтан нарын хохиролд тооцогдох хэсгийг зохих журмын дагуу гаргуулж, үлдэх хэсгийг хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож, "ХЛ" ХХК-ийн Хаан банкин дахь 500343xxxx дугаартай

дансан дахь 22.148.847 төгрөг, Х.Р.П-ий 511404xxxx дугаартай Хаан банкны дансан дахь 5.186.475 төгрөгийг тус тус эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, "ХЛ" ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй xxxx УБЛ, xxxx УБО улсын дугаартай Фотон форланд маркийн автомашин, xxxx УБА дугаартай Форланд, xxxx УБВ Жидонг машин, дугаар нь тодорхойгүй Максвелл машиныг битүүмжилсэн тогтоолыг хүчингүй болгож хууль ёсны эзэмшигч нарт, мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон УМБГ-ын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-гийн 5.000.000 төгрөгийг, /Х.Р.П-гийн хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-гийн 50.000.000 төгрөгийг болон Х.Р.П-гийн 57532xxxx-9,50771xxxx-8,5753xxxx-9 дугаартай Хаан банкны хадгаламжийн дэвтэр 3 ширхэг, "ХЛ" ХХК-ийн ТТБ3810, 2865378 дугаартай тэмдэг 1 ширхэг, "ХЛ" ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, "СЭБЭ" ХХК-ийн санхүүгийн тэмдэг 1 ширхэг, Ч.У-ийн дэвтэр 1 ширхэг, складны бүртгэл 1 ширхэг, "ХЛ" ХХК-ийн 2010 оны Санхүү, Татварын тайлангууд 1 хавтас /яллагдагч Д.Н-гийн гараар бичсэн тайлан гэх/, өмгөөлөгч А.Элбэгсайханы хүсэлтэд хавсаргасан хятад хэл дээрх баримтууд 15 хавтас, цэнхэр өнгийн 2 гялгар ууттай гаалийн мэдүүлгүүд зэргийг тус тус буцаан олгож, Р.Э-ын УБ хх-хх дугаартай, ДОЗ хх-хх дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ, УБ хх-хх, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ, хх-хх УБ улсын дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ 9 ширхгийг Авто тээврийн газарт шилжүүлж зохих журмын дагуу шийдвэрлэхийг үүрэг болгож, В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тэдэнд буцаан олгож, шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд В.Х.В, Х.Р.П, Д.Н нарт урьд таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорьж, А.М-ад авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх В.Х.В, Х.Р.П, Д.Н, А.М нарт холбогдох хэргийг 2014 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хянан хэлэлцэж, 465 дугаар магадлалаар Дүүргийн Эрүүгийн

хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 11 дэх заалтын "...мөн эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд авагдсан Нийслэлийн Прокурорын газрын 500050xxxx тоот болон УМБГ-ын 90009xxxx тоот дансанд хадгалагдаж байгаа В.Х.В-ы 5.000.000 төгрөгийг, /Х.Р.П-ий хамт/ 10.000.000 төгрөгийг, Х.Р.П-ий 50.000.000 төгрөгийг буцаан олгож..." гэснийг, 12 дахь заалтын "...ялтан В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тэдэнд буцаан олгосугай..." гэснийг, "...ялтан В.Х.В, Х.Р.П нарын эд хөрөнгө барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнд барьцаалагдсан нийт 65.000.000 төгрөгийг эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон хохирогчийн хохиролд тооцуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсүгэй..." гэж тус тус өөрчлөлт оруулж, шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалтуудыг хэвээр үлдээж, ялтан В.Х.В, Х.Р.П, тэдний өмгөөлөгч З.Төмөрхүү, ялтан Х.Р.П-гийн өмгөөлөгч М.Алтанцэцэг, ялтан Д.Н, түүний өмгөөлөгч С.Оюун, М.Цэрэндэжид нарын гаргасан давж заалдах гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхэд ялтан Д.Н-гийн өмгөөлөгч М.Цэрэндэжид гаргасан гомдолдоо: "...Д.Н өөрийн гаргасан алдаа дутагдал болон гэм буруутай үйлдлээ бүрэн ухамсарлан ойлгож, чин санаанаасаа гэмшиж байна. Энэ ч үүднээс анхан шатны шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр шийдвэрлэсэн төлбөл зохих 1.950.000 төгрөгийг бүрэн төлж барагдуулсан. Д.Н нь татварын улсын байцаагчаар 25 жил тасралтгүй үр бүтээлтэй ажиллаж байсан. Төрийн албан хаагч ажил үүргийн хувьд алдах эрхгүй ч алдаа гаргасандаа маш их гэмшиж байгаа. Хувийн амьдралын хувьд өрх толгойлсон хоёр хүүхэдтэй эмэгтэй, өндөр настай ээжтэй, хэрэгт шалгагдаж байх үедээ тэрээр өөрийн төрсөн дүүгээ хүнд өвчний улмаас алдсан амьдралын хүнд бэрхийг туулж яваа эмэгтэй юм. Иймд Д.Н-д анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасан хүндэвтэр гэмт хэрэгт анх удаа хорих ял шийтгүүлж байгаа, түүний хувийн байдал, гэмт хэргийн улмаас учирсан

хохирлыг нөхөн төлсөн, бусдад төлөх төлбөргүй байдал зэргийг харгалзан үзэж, түүнд оногдуулсан хорих ялыг тэнсэж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд ялтан Х.Р.П-гийн өмгөөлөгч М.Алтанцэцэг гаргасан гомдол болон тус шүүх хуралдаанд хэлсэн саналдаа: "...Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт шүүгдэгч В.Х.В-ы үйлдлийг Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж ирүүлснийг мөн хуулийн 269 дүгээр зүйлийн 299.1 дэх хэсэг болгон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2 дахь хэсэгт заасан шүүхийн эрх хэмжээний хүрээнд хөнгөрүүлэн зүйлчлэхээр тогтов гэж бичсэн нь "Хээл хахууль өгөх" гэмт хэргийг "Хориглосон арга хэрэгслээр дайн хийх" гэмт хэргээр хөнгөрүүлэн зүйлчилжээ. Мөн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, ялтан Д.Н-гийн эдлэх ялыг мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй гэж бичиж, ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхээр зааж шүүхийн тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болно, шүүхийн тогтоол тодорхой, ойлгомжтой бичигдсэн байна гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 299.3, 294.2 дахь хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчсөн хууль ёсны бус тогтоол болжээ. Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн субъект нь татвар ногдвол зохих орлого, эд хөрөнгөтэй болон ажил үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа зөвхөн татвар төлөх үүрэг бүхий этгээд байдгаараа бусад ойролцоо төрлийн гэмт хэргээс ялгагдана. Объектив тал нь зөвхөн татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн идэвхтэй үйлдэл, татвараа зохих ёсоор төлөхгүй байх зэрэг эс үйлдэхүйн хэлбэртэй байж болдог. Татварын хуулийн 13.1 дэх хэсэгт "Татвар төлөгч гэж татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн хуулийн этгээд байх ба уг этгээд нь татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлнэ. Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт зааснаар гэмт хэргийн гүйцэтгэгч гэдэг нь гэмт хэргийг гардан гүйцэтгэсэн этгээдийг хэлнэ гэж тус тус заасан байна. Х.Р.П-ийг татвараас санаатай зайлсхийх гэмт хэргийг гардан

гүйцэтгэсэн гэж үзэх ямар ч үндэслэлгүй ба дээрх хуулиудад зааснаар Х.Р.П нь татвар төлөх үүрэг бүхий этгээд буюу Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъект биш байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.6-д "анхан шатны баримтын бүрдэлт, түүний үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, Компанийн тухай хуулийн 95.4-д компанийн гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна" гэж заажээ. Тэгвэл Х.Р.П нь "ХЛ" ХХК-д засварчнаар ажиллаж цалин хөлс авч байсан ба Х.Р.П нь "ХЛ" ХХК-ийн санхүүгийн тайланг гаргаж байгаагүй, "ХЛ" ХХК-ийн импортоор оруулж ирсэн мотоцикл, сэлбэгийн тоогоо дутуу тайлагнаж, ААНОАТ, НӨАТ-аас зайлсхийсэн үйлдэлд Х.Р.П огт хамаагүй тул түүний үйлдэлд объектив талын шинж байхгүй улмаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэхээр байна. Мөрдөн байцаалтын шатанд Х.Р.П нь дээрх тооны мотоциклиудыг БНХАУ-аас оруулж ирэхдээ Т.Э, Р.Э, Ч.У нарын нэрээр оруулан ирж, тэдэнд урамшуулал өгч байсан талаар хэн ч мэдүүлээгүй. Х.Р.П мотоцикл огт хилээр оруулах ажлыг хийж гүйцэтгэж байгаагүй, энэ талаарх нотлох баримт хэрэгт огт байхгүй болохыг эрхэм шүүгч нар анхаарна гэж итгэж байна. Х.Р.П нь "ХЛ" ХХК-д нярав, засварчнаар ажиллаж цалин авдаг байхдаа мотоцикл худалдсан мөнгийг авч захиралдаа тушаадаг, захирлыг байхгүйд дансанд мөнгийг нь байршуулах, баталгаат хугацаандаа эвдэрсэн мотоциклыг иргэдэд төлбөргүй засах, арлын дугаар нь давхардсан мотоциклын дугаарыг зөвтгөн цохих зэрэг ажлуудыг хийж байсан болох нь гэрчүүдийн мэдүүлгүүд болон өөрийнх нь мэдүүлгээр нотлогдсон боловч тэрээр "ХЛ" ХХК-ийн санхүүгийн тайланг нэг ч удаа гаргаж байгаагүй тул түүнийг татвараа дутуу тайлагнасан асуудалд буруутгах ямар ч үндэслэлгүй. Шинжээчийн 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн №014 дугаартай дүгнэлтэд 2008-2011 онд "ХЛ" ХХК нь 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг импортоор оруулж ирсэн гэдэг нь үндэслэлтэй байна, харин Т.Э 245 ш, Р.Э 7776 ш, Ч.У 156 ш, нийт 11822 ширхэг мотоциклыг импортлон борлуулсныг "ХЛ" ХХК дээр оруулан тооцсон нь үндэслэлгүй байна гэсээр байхад дээрх иргэдийн оруулж ирсэн мотоциклын татварыг

"ХЛ" ХХК-ийг төлөх ёстой гэж холбогдогч нарт ял оноосон нь туйлын шударга биш байна. Мөн дээрх хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт яллагдагчаар татагдсан А.М-ын мэдүүлэг болон "ХЛ" ХХК-аас 55 сая төгрөг завшин, 500 сая төгрөг залилсан гэх эрүүгийн 201201022555 дугаартай хэргийн холбогдогч тус компанийн орчуулагч байсан Ч.У, нягтлан байсан Х.Я нарын мэдүүлгээр хэргийг шийдвэрлэсэн нь үндэслэлгүй гэж үзэхээр байна. "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-ы 2012 онд БНХАУ-аас Р.Э-ын нэрээр 2690 ширхэг мотоциклыг оруулж ирж борлуулахдаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тусгахгүй, онц их хэмжээний татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэсэн асуудалд 2014 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар 2014250001204 дугаартай эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгаад прокуророос яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн бөгөөд энэ хэрэгт урьдын эрүүгийн хэрэгт шинжээчийн дүгнэлтийг үндэслэлгүй гаргасан гэж үзэхээр байгаа шинжээч Ж.Ба-г дахин томилон дүгнэлт гаргуулсан, мөрдөн байцаагч нь "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-г хорих 461 дүгээр ангид хоригдож байхад түүнд шинжээчийг татгалзан гаргах эрх, үүргийг нь тайлбарлаж өгөөгүй, шинжээчтэй уулзан шаардлагатай баримт сэлтийг нь гаргаж өгөх боломжоор хангаагүй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчин дүгнэлт гаргуулсан. Иймд "ХЛ" ХХК-ийн татвараас зайлсхийсэн гэх 201201000471 дугаартай хэргийг 2014250001204 дугаартай хэрэгтэй нь нэгтгэн дахин шинжээчийн дүгнэлт гаргуулан "ХЛ" ХХК-ийн татвараас зайлсхийсэн асуудлыг нэг мөр шийдвэрлэн хэрэв буруутай нь тогтоогдвол нэг тогтоолоор ял оногдуулан тэдний эрх зүйн байдлыг дордуулахгүй байлгах арга хэмжээ авч өгнө үү. "ХЛ" ХХК-ийн үлдэгдэл 619 ширхэг мотоцикл болон бусад сэлбэгийг мөрдөн байцаалтын шатанд 2 байранд буюу Амгалангийн ... дугаар баазын хашааны агуулах болон Баянзүрх дүүргийн ... дүгээр хорооны нутаг дэвсгэр ... байрны нэг давхрын ... хэсэгт тус тус хувааж битүүмжилсэн бөгөөд ... байрны нэг давхрын ... хэсгийн эзэн нь түрээсийн төлбөрөө нэхэж дээрх эд хөрөнгийг ... дугаар баазын агуулахад битүүмжлэн миний байрыг суллаж өгсөнгүй гэж өмгөөлөгч бидэнд уурлан бухимдаж биднээс түрээсийн төлбөрөө нэхэж загнах, доромжлох зэргээр туйлын их бухимдал үүсч

байгааг харгалзан үзээд битүүмжилсэн эд хөрөнгийг нэг байранд нь нэгтгэн нэг байрыг нь суллахыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж өгнө үү. Х.Р.П нь хэдийгээр хятад хүн ч гэлээ хүн алаагүй, хулгай, дээрэм хийгээгүй, эхнэр хүүхдээ тэжээхийн тулд Монгол Улсад хүргэн дүүгийнхээ компанид ажил хийж цалин авч байсан жирийн нэг боловсрол, мэргэжилгүй эцэг хүн билээ. Хэрэв шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх тогтоол гаргавал түүнд оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмд эдлүүлж өгөхийг хүсч байна. Гэрч Р.Баа, Д.Ба нар Х.Р.П-ийг ямар ажил үүрэг гүйцэтгэж байсан талаар мэдүүлсэн. Х.Р.П нь "ХЛ" ХХК-ийн мотоциклын дэлгүүрт компанийн захирал В.Х.В, орчуулагч Ч.У, В.М.Ж нарын эзгүйд орлогын мөнгийг авч дараа нь тэдэнд өгдөг байсан. В.Х.В нь Х.Р.П-ийг хүн хүчний дутмагаас Монгол Улсад оруулж ирсэн ба удаан хугацаагаар оршин суух эрхтэй байлгахын тулд "ХЛ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн байх боловч үнэндээ Х.Р.П нь уг компанид хөрөнгө оруулж, хувьцаа худалдан авч, түүнийхээ ашгаас хүртэж байсан болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдоогүй. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх хариуцлагыг хариуцахгүй" гэж заажээ. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх Х.Р.П-ийг "ХЛ" ХХК-ийн 20 хувийн хувьцаа эзэмшдэг байсан, мотоцикл зарсан мөнгийг худалдагч нараас хураан авдаг байсан, мотоциклын арлын дугаарыг цохьдог байсан нь гэрч И.Ба, Т.А, Г.Г, Р.Баа нарын мэдүүлгээр нотлогдож байна гэж дүгнэж, түүнд оногдуулсан ялыг хэвээр үлдээсэн нь үндэслэлгүй байна. Компанийн хувьцаа эзэмшдэг хүнийг татварын тайланд орлогоо дутуу тайлагнасан гэж татварын хэргээр ял оноох хууль зүйн үндэслэл байхгүй байна. Иймд Х.Р.П-д холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгож, түүнд авсан барьцааны 50 сая төгрөгийг буцааж олгож өгнө үү" гэв.

Хяналтын шатны шүүхэд ялтан Д.Н-гийн өмгөөлөгч С.Оюун гаргасан гомдолдоо:

"...Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт В.Х.В нь онц их хэмжээний татвар төлөх үйлдлээ нуун дарагдуулахын тулд Д.Н-д 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэсэн нь В.Х.В нь өөрөө мөнгийг өгөөгүй ах өгсөн байж магадгүй, Д.Н-г хээл хахууль авсан үйлдлээ нуун дарагдуулахын

тулд зохиомол байдлыг бий болгосон баримт үйлдсэн нь нотлогдож байна гэж шийдвэрлэсэн нь хуулийг буруу ойлгож хэрэглэсэн гэж үзэхээр байна. В.Х.В Д.Н-д хээл хахууль өгсөн эсэх талаар шууд тогтоосон баримт хэрэгт авагдаагүй, мөн шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлгээр нотлогдон тогтоогдохгүй байхад тогтоогдсон гэж дүгнэсэн, түүнчлэн Д.Н-г "ХЛ" компанийн хүн амын орлогын тайлан гаргаж 450.000 төгрөгийн хээл хахууль авсан гэсний тухайд хэргийн зүйлчлэл, хэргийн бодит байдалд нийцээгүй байна. Тэрээр тус компанид тайлан гаргаж өгч байсан гэх үйлдэл нь Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдлийг хийхийг ойлгоно гэсэн тайлбараас үзэхэд Д.Н-гийн энэхүү үйлдэл нь Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байх боловч эрүүгийн хэрэг үүсгэх хуульд заасан хугацаа дууссан байгаа юм. Шат шатны шүүх хэргийн дээрх байдлыг анхаараагүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 321 дүгээр зүйлийн 321.1.3-т зааснаар хуулийг жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж үзэх үндэслэлтэй байх тул хэргийг хянаж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд ялтан В.Х.В-ы өмгөөлөгч З.Төмөрхүү гаргасан гомдол болон тус шүүх хуралдаанд хэлсэн саналдаа: "...Шинжээчийн 014 дугаартай дүгнэлт эргэлзээтэй, "ХЛ" ХХК-ийн ААНОАТ, НӨАТ /хил гаальд төлсөн/-ыг бүрэн тооцоогүй, "ХЛ" ХХК нь Баянзүрх дүүргийн Татварын албанд ААНОАТ-ын 83 сая төгрөгийн илүү төлөлттэй, НӨАТ-ын 26 сая төгрөгийн илүү төлөлттэйг нотолсон баримт шүүхийн шатанд үнэлүүлэхээр өгсөөр байтал хэрэгт хамааралтай, ач холбогдолтой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөөгүй. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчийн дүгнэлтээр ХХОАТ төлөгч Р.Э, Т.Э, Ч.У нарын импортын барааны төлбөл зохих татварын дүнг гаргасан бөгөөд "ХЛ" ХХК-д оруулан тооцох үндэслэлгүй болохыг шинжээчийн 014 дүгнэлтэд тодорхой тусгасан байдаг. "ХЛ" ХХК нь харьяалах татварын албанд татвар ногдох орлогоо тухай бүр тайлагнаж төлдөг байсан болох нь хэрэгт

авагдсан нотлох баримтаар хангалттай нотлогдоно. Мөн Баянзүрх дүүргийн татварын албанаас гаргасан тодорхойлолтоор илүү төлөлттэй болох нь нотлогдоно. Гэрч Ч.У нь 156 ш мотоциклыг өөрийн компанийн нэрээр оруулж ирэн худалдан борлуулсан болохыг мөрдөн байцаалтын шатанд гаргаж өгсөн байхад гэрч Ч.У-ийн мэдүүлгийн эх сурвалжийг нягталж шалгасангүй.

Гэрч Т.Э нь 245 ш мотоцикл импортоор оруулж ирсэн гэх ба мэдүүлгийн эх сурвалжаа заахдаа А.М-ын хүсэлтийн дагуу цэнхэр дэвтрээ ашиглуулж байснаа мэдүүлдэг. Гэрч Р.Э-ын хувьд цэнхэр дэвтрээ А.М-ад удаан хугацаагаар ашиглуулдаг, ашиглуулсны хөлс төлбөр авдаг байсан гэдэг. Дээрх гэрч нарын мэдүүлгийг шүүхээс үнэлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2 дахь хэсгийг зөрчсөн. Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-д ял шийтгэл оногдуулсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1 гэмт хэрэг гарсан байдал, 80.1.2 уг гэмт хэргийг хэн үйлдсэн, 80.1.3 гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр гэсэн хэргийн талаар нотлогдвол зохих асуудлууд нотлогдоогүй байхад анхан шатны шүүхээс шүүгдэгч В.Х.В нь Д.Н-д өөрөө мөнгийг өгөөгүй, ах өгсөн байж магадгүй гэж мэдүүлдэг бөгөөд энэ мэдүүлгээс үзэхэд "ХЛ" ХХК-ийн өмнөөс бусдад хээл хахууль өгсөн үйлдлээ үгүйсгээгүй байна гэж дүгнэсэн нь Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэсэн зарчмыг алдагдуулж, мөн хээл хахууль өгсөн үйлдлээ үгүйсгээгүй байна гэсэн нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 290 дүгээр зүйлийн 290.2 дахь заалтуудыг ноцтой зөрчжээ. "ХЛ" ХХК-ийн борлуулаагүй байсан мотоциклыг борлуулснаар тооцооноор татварын өр өсөж гарсан. В.Х.В мөрдөн байцаалт, прокурор, шүүхэд шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа учраас дахин шинжээч томилуулах хүсэлт гаргаж байсан. Энэ хэрэгт аудитын дүгнэлт гаргуулах хүсэлт гаргасан. Үүнтэй холбоотой "ХЛ" компанитай холбоотой бүх мэдээлэл ирсэн. Ийм байхад шинжээч алдаатай дүгнэлт гаргасан. 210 сая төгрөгийн НӨАТ-ийг хасаж тооцоогүй. Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү. Хээл

хахууль Д.Н-д өгсөн гэж дүгнэдэг боловч В.Х.В нь Д.Н гэдэг хүнийг танихгүй, Д.Н ч гэсэн В.Х.В-ыг танихгүй гэдэг. Шүүх "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс өгсөн байх үндэслэлтэй гээд ял шийтгэл оногдуулсныг хууль буруу хэрэглэсэн гэж үзэж байна" гэв.

Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон прокурор дүгнэлтдээ: "...Мөрдөн байцаалтын шатанд шалгавал зохих бүх зүйлийг шалгаж тогтоосон. Шинжээч тусгай мэдлэгийн хүрээнд тогтоовол зохих зүйлийг хууль зүйн үндэслэлтэй, байцаан шийтгэх ажиллагааг зөрчихгүй хийгдвэл зохих ажиллагааг хийж дүгнэлтийг гаргасан. Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болсон. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх саналтай байна" гэв.

#### ХЯНАВАЛ:

Ялтан В.Х.В нь "ХЛ" ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа Х.Р.П-тэй хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Н-г 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр /24/10/0961 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу "ХЛ" ХХК-д төлөвлөгөөт шалгалт хийхэд нь онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд түүнд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль өгч, 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай акт бичүүлсэн, мөн "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс татварын улсын байцаагч Д.Н-гээр албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайлан гаргуулж, түүнд Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

Ялтан Х.Р.П нь "ХЛ" ХХК-д нярваар

ажиллаж байхдаа В.Х.В-тай хамтран давтан үйлдлээр 2008-2011 онуудад БНХАУ-аас өөрийн компанийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг /141.626.203,92 төгрөг/ болон Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр 7776 мотоцикл /325.158.307,52 төгрөг/, Т.Э-ийн нэрээр 245 мотоцикл /12.940.069,16 төгрөг/, Ч.У-ийн нэрээр 156 мотоцикл /6.019.270,54 төгрөг/ буюу нийт 11822 ширхэг мотоциклыг Монгол Улсад импортоор оруулж ирээд худалдан борлуулахдаа "ХЛ" ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгахгүй 485.743.851,14 төгрөгийн буюу онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэгчээр оролцсон,

Ялтан Д.Н нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст Татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6-д заасан "Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх" гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ХЛ" ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, Аж ахуйн нэгжийн орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нууж, албан татвар төлөхөөс зайлсхийсэн "ХЛ" ХХК-д Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу "татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих" гэсэн заалтуудыг зөрчиж тус компанийн их хэмжээний татвар ногдох орлогыг илрүүлсэн атлаа дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагад шилжүүлэхгүйгээр 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр №241723 дугаартай "Татварын улсын байцаагчийн акт" бичиж, захирал БНХАУ-ын иргэн В.Х.В-аас 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн хээл хахууль авсан, мөн Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг тус "ХЛ" ХХК-ийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гарган өгч, "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В-аас Ч.У-ээр зуучлуулан

450.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэг тус тус үйлдсэн болох нь гэрч, хохирогч, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт болон хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдсон талаар анхан болон давж заалдах шатны шүүх хэргийн жинхэнэ байдалд нийцсэн, үндэслэл бүхий дүгнэлт хийсэн, хэргийн зүйлчлэл зөв, шүүхээс оногдуулсан ял нь тэдний гэм буруу, тухайн гэмт хэргийн хор аюул, шинж чанарт тохирсон байна.

Хяналтын шатны шүүхэд ялтнуудын өмгөөлөгч нарын гаргасан гомдлын дагуу хэргийн нөхцөл байдлууд болон хууль хэрэглээний асуудлыг шинжлэн судалбал:

Хэдийгээр шинжээчийн 014 тоот дүгнэлтэд "...980060 дугаартай татварын улсын байцаагчийн дүгнэлт бүрэн үндэслэлтэй гэж үзэхээргүй байна. Энэ дүгнэлтэд Ч.У-ийн 2011 онд оруулж ирсэн мотоцикл, сэлбэг ороогүй, "ХЛ" ХХК 3638 ширхэг мотоцикл оруулж ирсэн гэж тоог гаргаад зөрчил тооцохдоо 3412 ширхэг гэж тооцооллын алдаа гаргасан байна. Мөн орж ирсэн сэлбэгийн тоог гаргаагүй нийт үнийн дүнгээр тооцоог хийсэн. 2008, 2009, 2010, 2011 онд Бүгд Найрамдах Хятад Ард улсаас "ХЛ" ХХК нь өөрийн нэр дээр 3645 мотоцикл, 3251 ширхэг сэлбэг импортоор оруулж ирсэн гэдэг нь үндэслэлтэй байна. Монгол Улсын иргэн Р.Э 7776, Т.Э 245, Ч.У 156 ширхэг, нийт 11822 ширхэг мотоцикл импортлон борлуулсныг "ХЛ" ХХК дээр оруулж тооцсон нь үндэслэлгүй байна. "ХЛ" ХХК нь импортоор оруулж ирсэн мотоцикл, сэлбэгийн тоогоо дутуу тайлагнаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас зайлсхийсэн байна. "ХЛ" ХХК нь ААНОАТ 89.897.063,56 төгрөг, НӨАТ 51.729.140,36 төгрөг төлөхөөр байна. ААНОАТ, НӨАТ-ын хуулийн дагуу татварын хувь хэмжээг тооцсон. "ХЛ" ХХК нь санхүү, татварын тайлангаа хуульд заасан хугацаанд гаргаж байсан боловч импортоор оруулж ирсэн мотоцикл, сэлбэгийг дутуу тайлагнаж байсан. "ХЛ" ХХК нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулиудыг зөрчсөн байна. Р.Э, Т.Э, Ч.У нарын оруулж ирсэн мотоцикл болон сэлбэгийн борлуулалтын орлогод хувь хүний орлогын албан татвар төлөхөөр байна..." /хх<sup>А</sup>-87-163 дугаар хуудас/ гэж дурдсан боловч Р.Э, Т.Э, Ч.У нарын нэрээр 8177 ширхэг мотоциклыг импортоор



оруулж ирээд худалдан борлуулж "ХЛ" ХХК нь орлогоо авдаг байсан болох нь гэрч Р.Э-ын "...Би 2008 онд хамаатны ах н.Мө-ын барилгын материалыг урдаас зөөдөг байхдаа А.М-тай Замын-Үүдийн хил дээр тааралдсан юм. Тэгэхэд А.М намайг "чи цэнхэр дэвтэртэй юм уу, чиний нэр дээр хэдэн мотоцикл оруулаад ирмээр байна" гэж хэлээд миний нэр дээр 150 орчим мотоциклын гаалийн бүрдүүлэлтийг хийгээд надад 150.000 төгрөг өгсөн. Тэрнээс хойш А.М миний нэрээр мотоциклын гаалийн бүрдүүлэлтийг хийгээд оруулж ирээд 150.000-300.000 төгрөгийн хооронд мөнгө өгдөг байсан. Тэгээд тэрнээс хойш оруулсаар байгаад 7776 ширхэг мотоцикл болсон юм. А.М миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклыг Улаанбаатар хот РУУ явуулдаг байсан. Сүүлд 2011 оны 05 дугаар сард "чиний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоциклд улсын дугаар авах гэсэн чинь болохгүй байна, чи ирээд итгэмжлэх хийгээд өгөөч, ирэх очих зардлын чинь мөнгийг явуулья" гэж хэлсэн. Тэгээд 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдөр В.Х.В миний ХААН банкин дахь 537800xxxx дугаартай дансанд зардлын мөнгө болох 80.000 төгрөг шилжүүлсэн. Би Дорнод аймгаас Улаанбаатар хотод ирээд В.Х.В-тай Төмөр замын коллежийн хавьд уулзаад Авто тээврийн газарт очоод нотариатаар итгэмжлэл хийлгэж өгсөн. Тэгэхэд нь би А.М-ын миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоцикл Улаанбаатар хотод "ХЛ" ХХК дээр ирдэг юм байна гэж мэдсэн. В.Х.В нь надтай уулзахдаа ганцаараа машинтайгаа ирсэн ба тухайн үед надтай монголоор ярьж байсан. 2012 оны 08 дугаар сарын дундуур В.Х.В надтай утсаар яриад чамайг цагдаагийн байгууллагаас мотоцикл хэрхэн оруулж ирдэг талаар асуух юм бол би өөрийн нэрээр оруулж ирээд Замын-Үүд дээр хүмүүст тараагаад өгчихдөг гэж хэлээрэй гэсэн. Маргааш нь мөн А.М залгаад В.Х.В чамтай ярьсан уу, чи хэлснээр нь хэлчхээрэй гэсэн юм" /хх-М-190-191 дүгээр хуудас/ гэсэн, гэрч Ч.У-ийн "...ХЛ" ХХК нь Монгол Улсын иргэн Р.Э, Т.Э нарын нэрээр болон миний нэрээр мотоцикл импортлон оруулж ирээд зардаг байсан. Эхлээд би ямар учиртай болохыг нь мэдэхгүй байсан чинь татвар төлөхөөс зайлсхийхийн тулд Монгол Улсын иргэдийн нэрээр гаалиар мэдүүлж мотоцикл оруулж ирдэг байсан юм билээ. Би сүүлд нь энэ асуудлыг мэдсэн. Мөн өөрийн компанийн нэр дээр бага тооны мотоцикл оруулж ирэх

нь татвар, цагдаа, гаалийнхны анхаарлыг татахгүй гэсэн арга байсан юм билээ. Эдгээр 156 ширхэг мотоцикл нь "ХЛ" ХХК-ийн мотоцикл бөгөөд В.Х.В нь татвар төлөхөөс зайлсхийхийн тулд миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийлгэж оруулж ирж худалдан борлуулсан мотоцикл юм. Эдгээр мотоцикл нь миний мотоцикл биш болохоор "ХЛ" ХХК-ийн захирал В.Х.В татварыг нь төлөх ёстой" /хх-М-243-244 дүгээр хуудас/ гэсэн, гэрч Т.А-ын "...ХЛ" ХХК нь БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай, мотоцикл болон сэлбэг оруулж ирж зарах үйл ажиллагаа явуулдаг. Би энэ компанид 2010 оны 07 дугаар сараас 2011 оны 04 дүгээр сар хүртэл худалдагчаар ажиллаж байсан. Намайг ажиллаж байх хугацаанд "ХЛ" ХХК-ийн нэрээр болон Р.Э-ын нэрээр гаалийн бүрдүүлэлт хийсэн мотоцикл худалдан борлуулдаг байсан" /хх-М-192-194 дүгээр хуудас/ гэсэн, гэрч Д.Ба-ы "...ХЛ" ХХК-аас худалдан авч байсан мотоцикл дотор Монгол Улсын иргэн Р.Э-ын нэрээр Монгол Улсад импортоор оруулж ирсэн мотоциклиуд байсан бөгөөд 2008 оноос би Р.Э-ын нэртэй гаалийн бичигтэй нийт 100 гаран мотоциклыг "ХЛ" ХХК-аас худалдан авч байсан юм. "ХЛ" ХХК-аас худалдан авч байсан мотоциклиуд нь "ХЛ" ХХК-ийн нэртэй, мөн Р.Э-ын нэртэй гаалийн бичигтэй мотоциклиуд байсан" /хх-М-230 дугаар хуудас/ гэсэн, гэрч Т.Э-ийн "...би 2007-2008 онд урагшаа БНХАУ-ын Эрээн хот орж барилгын материал зөөдөг байсан юм. Тэр үед буюу 2008 оны эхээр намайг Эрээнд явж байхад нэг Өвөр монгол залуу ирээд та дэвтэртэй юу, би таны нэр дээр мотоцикл Монгол Улс руу оруулах гэсэн юм гэж хэлсэн. Тэгээд надад тухайн үед нэг мотоциклын 30.000 төгрөг өгөөд миний дэвтрийг ашиглаж Эрээнээс Замын-Үүд хүртэл мотоцикл оруулж ирдэг байсан юм. Тэгээд сүүлдээ тэр Өвөр монгол залуу Замын-Үүдийн гааль дээр ирээд над руу утсаар яриад миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийдэг байсан. Хамгийн сүүлд 2008 оны 09 дүгээр сард 120 ширхэг мотоцикл оруулж ирээд надад 200 гаран мянган төгрөг өгсөн. Тэр Өвөр монгол залуу Замын-Үүдийн гааль дээр миний нэрээр гаалийн бүрдүүлэлт хийчхээд өөрөө мотоциклоо машинтайгаа аваад явчихдаг байсан. Хаана буулгадаг байсан талаар мэдэхгүй байна" /хх-IV-208-209 дүгээр хуудас/ гэсэн мэдүүлгүүдээр тус тус нотлогдож байна.

Ялтан В.Х.В нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

Д.Н-д онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн үйлдлээ нуун дарагдуулахын тулд 2010 оны 11 дүгээр сард 1.500.000 төгрөгийн, 2011 оны 1, 2, 3 дугаар сарын тайланг гаргуулж, Ч.У-ээр зуучлуулан 450.000 төгрөгийн буюу нийт 1.950.000 төгрөгийн хээл хахууль өгсөн,

ялтан Д.Н нь В.Х.В-аас дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсний төлөө нийт 1.950.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргийн хувьд:

В.Х.В нь Д.Н-д өөрөө мөнгийг өгөөгүй, ах өгсөн байж магадгүй гэж мэдүүлдэг бөгөөд энэ мэдүүлгээс үзэхэд "ХЛ" ХХК-ийн өмнөөс бусдад хээл хахууль өгсөн үйлдлээ үгүйсгээгүй байна. Нөгөө талаар түүний Д.Н-д хээл хахууль өгснийг гэрчүүд тодорхой мэдүүлдэг төдийгүй Д.Н нь хээл хахууль авсан үйлдлээ нуун дарагдуулах зорилгоор зохиомол байдлыг бий болгож "мөнгө зээлсэн" гэх баримтыг үйлдсэн болох нь гэрч Ц.Э-гийн "...2010 оны 07 дугаар сард татварын улсын байцаагч Д.Н-тэй хамт "ХЛ" ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаа баримтад шалгалт хийх хуваарьтай байсан. Наадмын дараахан ээлжийн амралтаа аваад 08 дугаар сарын сүүлчээр ажилдаа орсон. Тэр үед Д.Н надтай уулзаад "ХЛ" ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээд дуусаж байна. Миний хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилтэй танилц гээд шалгалтын гар ноорог үзүүлсэн. Зөрчил баримт зэргийг тулгаж үзээгүй. Тэгээд татварын улсын байцаагчийн акт бичээд надад үзүүлсэн. Би акт дээр гарын үсэг зурж баталгаажуулсан. Тухайн үед Д.Н байцаагчийн үйл ажиллагаанд итгээд актад гарын үсэг зурсан" /хх-IV-231-232 дугаар хуудас/ гэсэн, гэрч Т.Э-ы "...Би "ХЛ" ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгэхээр татварын улсын байцаагч Д.Н, Ц.Э нарт 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 3 хоногийн хугацаагаар томилолт бичиж өгсөн юм. Гэхдээ үүнийг татварын улсын байцаагч нар нэг сарын хугацаанд багтааж шалгаж дуусгах үүрэгтэй байсан. Энэ хоёрын хувьд 2 сар гаруй хугацаагаар томилолтынхоо хугацааг хэтрүүлсэн. Энэ компанийн хувьд татварын улсын байцаагч нарын тогтоосон актыг нооргоор уншиж танилцаж, хууль зөв хэрэглэсэн эсэхэд хяналт тавьж гарын үсэг зурсан. Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын

албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6-д заасан "Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх" гэсэн заалтын дагуу 2-3 байцаагч хийх ёстой байдаг. Ганцаараа хяналт шалгалт хийх ёсгүй. Татварын улсын байцаагч шалгах гэж буй аж ахуйн нэгж, компанийн удирдлага болон ажилтнаас мөнгө төгрөг, эд зүйл, зээл, тусламж авч болохгүй. Үүнийг хориглосон байдаг. Мөн өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн удирдлагаас мөнгө төгрөг авч тайланг нь гаргаж өгч болохгүй, тайлан гаргахыг хориглосон байдаг юм" /хх -V-73-74 дүгээр хуудас/ гэсэн, гэрч С.С-гийн "...2007 оны 09 дүгээр сарын үед Д.Н-гийн өмчлөлийн нэг өрөө байрыг "Мо" хадгаламж зээлийн хоршооны барьцаанд тавиулж 18.000.000 төгрөгийг үйлдвэрлэлийн түүхий эд татах зорилгоор манай нөхөр Н.Цэ зээлж авсан. Тухайн үед "мөнгөний хэрэгцээ байна, түүхий эд татах мөнгө хэрэгтэй байна" гээд Д.Н-тэй төрөл садангийн холбоотой болохоор байрыг нь зээлийн барьцаанд тавиулж байсан юм. "Мо" хадгаламж зээлийн хоршооны зээл болон зээлийн хүүг манай нөхөр Н.Цэ 2010 оны 03 дугаар сарын 18-ны өдөр нас барах хүртлээ төлж байсан. Би нэг ч удаа очиж зээл болон зээлийн хүүг төлж байгаагүй. Тэрнээс хойш зээл болон зээлийн хүүг Д.Н өөрөө төлсөн байх гэж бодож байна. Надтай сар гарангийн өмнө Д.Н утсаар ярихдаа хүнээс нэг хэдэн төгрөг аваад зээлэндээ өгчихсөн чинь намайг тэр хүн нь мөрдөн байцаах газар өгчихсөн байна, чи мөнгөө төлөөч, хоёулаа уулзаж байгаад тухтай ярья гэж ярьж байсан" /хх-IV-233 дугаар хуудас/ гэсэн, гэрч Ч.У-ийн "...Намайг танай байгууллага дээр 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гэрчээр мэдүүлэг өгснөөс хойш болон өмнө нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Д.Н над руу байн байн утсаар залгаж надаас "чи В.Х.В-аас Д.Н миний цалинг авсан гээд мэдүүлэг өгчих, тэгвэл иргэний хэрэг болно ш дээ" гэж гуйгаад дахин дахин залгаад 2-3 удаа уулзсан. Тэгээд 2012 оны 12 дугаар сарын дундуур би Д.Н-тэй уулзаад энэ бичгийг хэрэгт ямар ч ач холбогдолгүй байх гэж бодоод Д.Н-гийн "Баталгаа" гэж бичсэн цаасан дээр нь гарын үсэг зурж өгсөн. Энэ бичгийг Д.Н өөрөө бичсэн бөгөөд надаар гарын үсэг зуруулсан юм. Энэ цаасны урд болон хойно бичсэн зүйл нь нэг өдөр бичигдсэн бөгөөд

нэг өнгийн балаар бичсэн юм. Тэрнээс Д.Н В.Х.В-аас миний цалинг аваад надаас зээлсэн асуудал байхгүй бөгөөд надад 1.500.000 төгрөг өгсөн зүйл байхгүй. Би Д.Н-гийн гуйлтаар энэ бичгийг бичиж өгсөн. Үүнийг манай найз Б.Ня мэдэж байгаа. ...2011 оны 01 дүгээр сарын тайлангаас авахуулаад нягтлан бодогч байхгүй болсон тул В.Х.В Д.Н-г гуйгаад тайлангаа гаргуул гэж хэлсэн. Тэгээд 1, 2, 3 дугаар сарын тайлангаа Д.Н-гээр гаргуулаад нэг сарын цалин гэж 150.000 төгрөг өгч байсан юм. Энэ цалин гэх 1, 2 дугаар сарын мөнгийг нь би, 3 дугаар сарын мөнгийг нь худалдагч Т.А-аар хүргүүлсэн. Нийт Д.Н-д 450.000 төгрөг өгсөн" /хх-IV-237-238, 243-244 дүгээр хуудас/ гэсэн мэдүүлгүүд, "Шинжлэгдэж буй 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Баталгаа" гэсэн толгойтой, "Н.Д-ийн..." гэж эхлээд "...Ч.У" гэж дуусгасан гар бичмэлүүд нь Д.Н-гийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна. Шинжлэгдэж буй тал цаасны арын хэсэгт "2011 оны..." гэж эхлээд "...авсан" гэж дуусгасан гар бичмэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн гэрч Ч.У-ийн бичгийн хэвийн харьцангуй чөлөөт болон туршилтын загваруудтай тохирч байна. Шинжилгээнд ирүүлсэн 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Зээлдүүлэгч" гэсний ард, мөн тал цаасны арын нүүрэнд "авсан" гэсэн бичиглэлийн ард зурагдсан шинжлэгдэж буй гарын үсгүүд нь сэжигтэн Д.Н-гийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай гарын үсгийн ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүдээрээ тохирч байна. Шинжилгээнд ирүүлсэн 148x209 мм хэмжээтэй цаасны нүүрэн хэсэгт "Зээлдүүлэгч" гэсний ард, мөн тал цаасны арын нүүрэнд "авсан" гэсэн бичиглэлийн ард зурагдсан гарын үсгүүд нь гэрч Ч.У-ийн гарын үсгийн туршилтын болон харьцангуй чөлөөт загваруудтай тохирч байна. Шинжилгээнд ирүүлсэн "ХЛ" ХХК, "Санхүү, татварын тайлангууд 2010 он" гэсэн хаягтай цэнхэр өнгийн хавтастай материалын "Цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын тайлан" гэсэн баримтын дунд хүснэгтэд, "Нэмэгдсэн өртгийн албан татварын сарын тайлангууд" гэсэн баримтын хүснэгтэд бичигдсэн тоон бичиглэлүүд нь харьцуулах шинжилгээнд ирүүлсэн сэжигтэн Д.Н-гийн гэх дэвтэр дээр бичигдсэн тоон бичиглэлүүдтэй тохирч байна" /хх-195-198 дугаар хуудас/ гэсэн 2013 оны 03 дугаар сарын 29-ний

өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 931 дүгээр шинжээчийн дүгнэлт, "Шинжилгээнд ирүүлсэн тал бичгийн цаасны нэг тал дээр бичсэн "Баталгаа Д.Н миний бие "ХЛ" ХХК-ийн орчуулагч Ч.У-ийн цалин болох 150.000 төгрөгийг захирал В.Х.В-аас авч гурван сарын хугацаатай буцаан төлөхөөр зээлж авав. Зээлдсэн Д.Н, Зээлдүүлэгч Ч.У гэсэн бичиглэлийн будагч бодис болон нөгөө тал дээр бичсэн "2011 оны 3-6-нд мөнгөө буцаан авав. Өгсөн, авсан "бичиглэл" Ч.У-ийн гарын үсэг нь "Д.Н-гийн гарын үсэг" гэсэн бичиглэлийн будагч бодис нь хоорондоо ижил байна" /хх-209-210 дугаар хуудас/ гэсэн 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2617 дугаар шинжээчийн дүгнэлт зэргээр хангалттай нотлогдож байна.

Давж заалдах шатны шүүхээс нотлох баримтад тулгуурлаж ялтан Х.Р.П нь мотоциклиудыг БНХАУ-аас Монгол Улсад оруулж ирэхдээ бусдын нэрээр оруулж, уг хүмүүст урамшуулал өгч байсан, мотоциклиудыг борлуулсны орлогыг хүлээн авч байсан, арлын дугаарыг сольж, шинээр дугаарлаж бүртгэх ажлыг хийж байсан зэргээр татварын орлогыг нуун дарагдуулж байсан гэж дүгнэсэн нь үндэслэлтэй гэж үзнэ.

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй, Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй байх тул ялтнуудын өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож, шийтгэх тогтоол, түүнд өөрчлөлт оруулсан магадлалыг хэвээр үлдээх үндэслэлтэй гэж хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэрлэв.

Харин шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6 дахь заалтад В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэхийг орхигдуулсан байх тул энэ талаар зохих өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1, 350.1.2 дахь заалтыг удирдлага болгон хяналтын шатны шүүх хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 355 дугаар шийтгэх тогтоол, түүнд өөрчлөлт оруулсан Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 465 дугаар магадлалд дараах өөрчлөлт оруулсугай.

-Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6 дахь заалтын "...Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй хорих ангид, ялтан Д.Н-гийн эдлэх ялыг мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй" гэснийг "...Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан В.Х.В, Х.Р.П нарын эдлэх ялыг чанга

дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар ялтан Д.Н-гийн эдлэх ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй" гэж өөрчилж, шийтгэх тогтоол, түүнд өөрчлөлт оруулсан магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.

2. Ялтнуудын өмгөөлөгч М.Цэрэндэжид, 3.Төмөрхүү, М.Алтанцэцэг, С.Оюун нарын хяналтын гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,  
ШҮҮГЧ  
ШҮҮГЧ

Р.БАТЦЭРЭН  
Р.БАТ-ЭРДЭНЭ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 1263

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч М.Нармандах даргалж,

хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга В.Орхон хөтлөн, улсын яллагч Б.Энэрэл, шүүгдэгч Ц.Б, түүний өмгөөлөгч Н.Дэмбэрэлдагва, шүүгдэгч Д.Т, түүний өмгөөлөгч Ж.Батзоригт, шүүгдэгч Д.Ба түүний өмгөөлөгч Б.Цэрэндолгор, хохирогч Ж.Б,

шинжээч А.Ц нарыг оролцуулан тус шүүхийн шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар,

Дүүргийн 2 дугаар прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т заасан гэмт хэрэгт холбогдсон Ц.Б,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 214 дүгээр зүйлийн 214.2-т заасан гэмт хэрэгт холбогдсон Д.Т, Д.Ба нарт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 2014260002045 дугаар хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хүлээн авч, хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол улсын иргэн, ...оны ... дугаар сарын ...-ны өдөр ... хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаар ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт ...дүүргийн ... дүгээр хороо, ...тоотод оршин суух хаягтай, урьд ...дүүргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар төрийн удирдах албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жил хорих ял оногдуулсныг тэнсэж, 2 /хоёр/ жилийн хугацаагаар хянан харгалзсан, ШД..... дугаарын регистртэй, Д овогт Ц.Б

2. Монгол Улсын иргэн, ...оны ... дүгээр сарын ...-ны өдөр ...аймгийн ... суманд төрсөн,

эрэгтэй, .... настай, дээд боловсролтой, автозамын инженер мэргэжилтэй, “Т” ХХК-ийн захирал ажилтай, ам бүл ... эхнэр хүүхдүүдийн хамт ...дүүргийн ...дугаар хороо ...хотхоны ...тоотод оршин суух хаягтай, урьд ял шийтгэлгүй, ШД..... дугаарын регистртэй, О овогт Д.Т

3. Монгол Улсын иргэн, ...оны ... дугаар сарын ...-ны өдөр ... аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ... настай, дээд боловсролтой, автозамын инженер мэргэжилтэй, “Б” ХХК-ийн захирал ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт ...дүүрэг ...дугаар хороо, ...тоотод оршин суух хаягтай, урьд ял шийтгэлгүй, НЭ..... дугаарын регистртэй, Г овогт Д.Ба.

Холбогдсон гэмт хэргийн талаар /яллах дүгнэлтэд дурдсанаар /

Шүүгдэгч Ц.Б нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр 122 дугаар захирамж гарган “Т” ХХК, “Б” ХХК-уудад Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны орчмоос түгээмэл тархацтай ашигт малтмал болох уулын дайргыг ашиглуулах зөвшөөрөл олгосны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан,

Шүүгдэгч “Т” ХХК-ийн захирал Д.Т, “Б” ХХК-ийн захирал Д.Ба нар нь ашигт малтмал хайх, олборлох, ашиглах тусгай зөвшөөрөлгүй атал 2012 оны 04 дүгээр сараас 2013 оны 06 дугаар сарыг хүртэлх хугацаанд Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны орчмоос түгээмэл тархацтай ашигт малтмал болох уулын дайргыг хууль бусаар олборлож, байгаль экологид 78.284.369 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэх гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Шүүгдэгч Ц.Б шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: ...мэдүүлэг өгнө, дайрга нь түгээмэл тархацтай ашигт малтмалд орно, гэхдээ тухайн үед уг дайргыг ашиглах зөвшөөрлийг орон нутгийн Засаг дарга

шийддэг байсан, өмнө би замын ажилд дайрга олгох захирамж гаргаж байсан, орон нутгаас санал авч дайрга олгохоос биш ашигт малтмалын хэрэг эрхлэх газар шийдвэрлэхгүй, харин 2013 оны 12 дугаар сараас ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас тусгай зөвшөөрөл олгодог болсон, би дүүргийн хүн амын төлөө ажил хийсэн, өөртөө ашиг олоогүй, одоо энэ зам улсын өмч болсон, орон нутагт дайрсан замд орон нутгийн газар нь өөрсдөө олгодог юм байна лээ гэж шинжээч хэлж байна, улсад зам тавьсныхаа төлөө ингэж хариуцлага хүлээх гэж байгаадаа харамсаж байна... гэв.

Шүүгдэгч Д.Т шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: ...мэдүүлэг өгнө, манайх замын дайрга ашиглах зөвшөөрөл авсан, манай компани арван таван жил замын ажил хийж байна. Уг газарт зохих газраас нь байгаль орчин газрын үнэлгээ хийж, газрын кадастрыг нь үзсэн, бид зам барилгын ажил хийсэн болохоос уул уурхайн ажил хийгээгүй, тэр үед тусгай зөвшөөрөл авах хууль байгаагүй, замын дайрга хаанаас авах зөвшөөрлийг Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрээс гэж заасан байсан, тэр ч утгаараа дүүргийн Засаг даргын 2012 оны 04 сард захирамж гарч бид танилцсан, замын ажилд гадаадын хөндлөнгийн хяналтын байгууллага ч замын бүх ажлыг шалгасан, нөхөн сэргээлтийн хувьд замын ажлыг хүлээлгэж өгсөн ч баталгаат хугацаанд цаашид засвар нэмэлт ажил гарвал дайргыг ашиглах гэрээтэй тул энэ хугацаа дуустал төлбөрийг төлөөгүй байсан, бид зохих журмын дагуу ажлаа чанартай гүйцэтгэж улсын комисст хүлээлгэж өгсөн, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулаагүй тул зүйл ангийг хэрэгсэхгүй болгож өгнө үү... гэв.

Шүүгдэгч Д.Башүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: ...мэдүүлэг өгнө, улсад манай хийсэн ажил үнэлэгдэж байсан, бид авсан ажлаа хугацаандаа хийж гүйцэтгэсэн, бид карьерийн асуудлын талаарх бүх зөвшөөрлийг авсан, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл байсан, миний хувьд улс орондоо сайн үйл хийсэн атлаа ийм хэрэгт холбогдсондоо харамсаж байна, надад гомдолтой, дайрга ашиглах зөвшөөрлийг Засаг дарга эрх хэмжээндээ гаргасан гэж үзэж байгаа, үнэн зөв шийдвэрлэж өгнө үү... гэв.

Хохирогч Ж.Б шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: ...Нийслэлийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор Нийслэлийн ногоон бүсийг хамгаалах журам гаргасан, 2012 оноос дайрга ашиглах нөхөн төлбөрийг 200 төгрөг гэж тогтоосон, мөн уг ашигласан газарт нөхөн сэргээлт хийх ёстой, гэхдээ шүүхийн шатанд дээрх компаниуд нь нөхөн сэргээлт хийсэн тул уг төлбөрийг хасаж, байгаль орчинд учруулсан хохирлын төлбөр 42.126.169 төгрөгийг нэхэмжилж байна, дайрга нь түгээмэл ашигт малтмалд орох бөгөөд дайрга ашиглахад тусгай зөвшөөрөл авна гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4-р зүйлд заасан байгаа тухайн үед ч энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан, дараа нь 2013 онд түгээмэл тархацтай хууль батлагдсан, хэргийн материалтай танилцахад манай байгууллагаас очсон ч гэрээ байгуулж олборло гэсэн мэдэгдэл өгсөн байсан, харин манай байгууллагаас дайрга ашиглах зөвшөөрөл өгөөгүй, тухайн үед очсон байцаагч зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа юм байна гэж бодсон гэсэн, ашигт малтмалын газар тусгай зөвшөөрөл өгдөг, иргэний мэдээллээр анх очсон тул дуудлагаар очсон байна гэж үздэг, байгалийн баялгийг авсан байна, шороо ашигласан байна, улсын өмч чинь дайрга шүү дээ, зохих газраас нь зөвшөөрөл авахгүй олборлосон байна, Засаг дарга нь дайрга ашиглах зөвшөөрөл өгөхгүй... гэв.

Шинжээч А.Ц шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: ...байгаль орчинд учирсан хохирол нь 42.126.169 төгрөг, нөхөн сэргээлтийн зардал нь 36.158.200 төгрөг гэж гаргасан, нөхөн сэргээлтийн зардал нь хууль бус гэж үзсэн нөхцөлд хохиролд орж тооцдог, энэ талаар сайд нарын журам байдаг. Энэ хоёр компани тус тусдаа хохирол гаргуулна гэсэн тул дахиж дүгнэлтийг компани тус бүр дээр нь гаргасан. Тэр үед газар дээр нь очиход техникийн нөхөн сэргээлтээ хийсэн байсан тул хасаж тооцон гаргаж өгсөн чинь Авлигатай тэмцэх хэлтсийн мөрдөн байцаагч анхны үзлэгээр нь хохирлыг гаргах ёстой гэж хэлсэн. 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тушаал байгаль орчны сайдын тушаал байдаг, эдгээр хүмүүс нь шинжээчийн дүгнэлтийг үндэслэлгүй, эргэлзээтэй гэж үзээгүй, би бүх дүгнэлтийг гаргасан, би хэргийн материалыг нэг бүрчлэн танилцах шаардлагагүй, бид газар дээр нь очиж байгаль орчны үнэлгээгээ гаргасан, харин уг компани нь тусгай зөвшөөрөлтэй эсэх нь манай байгууллагад хамааралгүй... гэв.

Хохирогч Ж.Б-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын журам-ыг хавсралтаар баталсан. Хавсралт журам нь Нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон нөөц баялгийг ашиглах, эзэмших, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Тэгэхээр 2012 онд Нийслэлийн нутаг дэвсгэрт зам тавихад ашиглагдах дайрга олборлох, ашиглах харилцааг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын журам”-аар зохицуулж байсан бөгөөд 1 м куб шороонд ногдох төлбөрийн хэмжээг 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 29 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар байгалийн баялаг ашигласны төлбөрийн хэмжээг /уулын дайрга/ 1м куб шороонд 200 төгрөг байна гэж ойлгож болно. “Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын журам”-аар дүүргийн Засаг дарга нарт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах, олборлуулах эрх олгоогүй. Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны орчим нь Нийслэлийн ногоон бүсэд хамаарах газар байдаг. Энэ газар нутгаас дайрга ашиглаж, олборлоход заавал манай газраас байгалийн баялаг ашиглах зөвшөөрөл авах ёстой. Хэрэв зөвшөөрөгдсөн дайрганы карьераас шаардлагатай шороог авч байгаа тохиолдолд манай газраас зөвшөөрөл авахгүй. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтаар зам тавихад шаардагдах дайргыг ашиглах, олборлоход зайлшгүй манай газраас зохих зөвшөөрөл авч, гэрээ байгуулан дайрга ашигласны төлбөр төлж, дараа нь ашигласан газраа нөхөн сэргээх ёстой байдаг юм. Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 дугаартай захирамж гаргасан нь Байгалийн баялгийг төлбөртэй ашиглах тухай хуулийн заалтыг зөрчсөн байна. Мөн манай газраас зөвшөөрөл олгодог байтал манайд мэдэгдэлгүйгээр байгалийн баялгийг зүй зохисгүй ашиглуулсан байна, хэрэв зөвшөөрөл өгсөн бол газрыг ашиглаж, нөхөн сэргээлгэх хугацаатай гэрээ байгуулж, байгалийн баялаг ашигласны төлбөрийг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх

ёстой. “Т” ХХК, “Б” ХХК-уудын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчинд 78.284.369 төгрөгийн хохирол учирсан Д.Ба төлбөрийг дээрх 2 компаниас нэхэмжилж байна... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 28-29 дүгээр хуудас/,

Гэрч Ч.Э-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн ...Манай “А” ХК нь Энэтхэг улсын хөрөнгө оруулалттай, авто зам тавих эрх бүхий аж ахуйн нэгжүүдэд технологийн чиглэлд хяналт тавих зөвлөгөө өгөх чиглэлийн компани юм. “Т” ХХК, “Б” ХХК-иудтай хамтран ажиллах гэрээг манай компани байгуулаагүй. Захиалагч байгууллага Зам тээврийн яамтай Жаргалант тосгон чиглэлийн 17 км хатуу хучилттай авто зам тавих ажилд чанарын хяналт тавих, зөвлөгөө өгөх ажлыг хийхээр гэрээ хийж ажилласан. Уг 2 гүйцэтгэгч компани зам тавихад ашиглах уулын дайргыг хаанаас авах талаараа орон нутагтаа гэрээ хийгээд зөвшөөрлөө аваад ажлаа эхэлсэн. Манай компани уулын дайргыг хаанаас ямар зөвшөөрлөөр авч ашиглаж байгаа талаар хяналт тавих шаардлагагүй зөвхөн замын далан, суурийн ажилд ашиглах материал нь уг замын ажилд тэнцэх эсэх, замын ажил нь техникийн шаардлагын дагуу явагдаж байгаад хяналт тавьж ажилладаг... гэсэн мэдүүлэг /1-р хх-ийн 132-133 дугаар хуудас/,

Гэрч С.О-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...Манай “А” ХХК нь “Т” ХХК, “Б” ХХК-уудтай зам тавих талаар гэрээ байгуулаагүй. Зам тээвэр хот байгуулалтын яамтай гэрээ байгуулж захиалагчийг төлөөлж замын чанар технологийн байдалд хяналт тавих үүргийг хүлээсэн, замыг барихад байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн, хэрэгжилтэнд төслийн багийн зүгээс хяналт тавьж байх ёстой... гэсэн мэдүүлэг /1-р хх-ийн 140-141 дүгээр хуудас/,

Гэрч Ц.Ба-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...2013 оны 05, 06 дугаар сард манай байгууллагаас зам тавьж байгаа газруудад шалгалт хийсэн, шалгалтаар Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны Жаргалант тосгоны нутагт “Т”, “Б” ХХК-уудын үйл ажиллагаа явуулж байгаа уулын дайрга олборлож байгаа газарт очиход 2 хэсэг газар олборлолт явуулсан байсан, бид Байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлоход манай байгууллагад зохих төлбөр төлдөг, газрын нөхөн сэргээх төлөвлөгөө батлуулдаг, зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана гэхэд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамж үзүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох ашиглах асуудал нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлтэй талбайгаас зах зээлийн ханшаар нь худалдан авч хэрэглэх ёстой байтал аж ахуйн нэгж байгууллагууд мөнгөө хэмнэх зорилгоор ойролцоох уулнаас зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлоод байгаа юм. Энэ аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох эрх хэмжээ Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч, ахлах байцаагчийн зөвшөөрлөөр зогсоодог тул Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт мэдэгдэхэд мэдэж байсан бөгөөд Ц.Б даргын захирамжаар үйл ажиллагаа явуулж байгаа гэж байсан. Үйл ажиллагаа явуулж дууссаны дараа аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэлийн тайлан гаргадаг бөгөөд уг тайлан дээрээс хэдэн метр куб дайрга ашигласныг харж байгаад нэг метр куб шороонд мөнгийг тогтоон хураамжавдаг, гэтэл “Т”, “Б” ХХК-ууд одоог хүртэл нөхөн сэргээсэн газраа өгөөгүй юм. Байгалийн баялаг болох ямар ашигт малтмалыг хайгуул хийх, ашиглаж олборлох нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд уг хуулинд зөвшөөрөлтэй лицензтэй талбайгаас ашигт малтмал олборлох ашиглахаар зохицуулсан байдаг. Аж ахуйн нэгж байгууллага нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл лицензтэй байх ёстой үүнийхээ дагуу ашиглалт олборлолт явуулдаг. Эсхүл ашиглалт олборлолтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаас зах зээлийн ханшаар нь худалдан авч үйл ажиллагаандаа хэрэглэх ёстой байдаг. Дүүргийн Засаг даргын захирамжаар аж ахуйн нэгж байгууллагад ашигт малтмал олборлох ашиглуулах эрх байхгүй. “Т” ХХК-аас манай байгууллагад албан бичгээр дайрга шороо ашиглах зөвшөөрөл олгож өгнө үү гэж хандаж байсан. Үүний дагуу намайг энэ компанийн хүмүүстэй газар дээр нь очиж үзээд ир гээд “Т” ХХК-ийн ажилчин залуутай хамт зам тавих гэж байгаа газрын ойр орчмын газраар явахад энэ газраас дайрга авна гэсэн санал хэлж байсан. Тэгэхэд нь би байгалийн баялаг ашиглах гэж байгаа тохиолдолд манай байгууллагаас зөвшөөрөл авна, дайрга ашигласны төлбөр төлөх ёстой гэж хэлсэн. Тэгэхэд компанийн захирал залуу энэ зам гадаадын хөрөнгө оруулалтаар тавих гэж байгаа зам юм, гадны хөрөнгө оруулалт дээр дайрга худалдан авах

мөнгө тусгаж өгөөгүй болохоор бид дайрга худалдан авах боломжгүй гэж хэлсэн, мөн Жаргалант тосгоны байгаль хамгаалагч П.Б-д энэ компани манай байгууллагад төлбөр төлж дагалдах хуудас аваагүй тохиолдолд үйл ажиллагааг нь явуулахгүй гэж хэлсэн. Энэ компаниудын хувьд гадаадын хөрөнгө оруулалтаар зам тавьж байсан болохоор захиалагч компани нь манай байгууллагатай харьцаагүй. Би “Т” ХХК-д дайрга олборлох ямар нэгэн зөвшөөрөл өгөөгүй бөгөөд зөвшөөрөл өгдөг эрх бүхий субъект би биш. Хэрэв зөвшөөрөл зохих албан тушаалтнаас нь авсан бол би байгалийн баялаг ашиглах хуудас /үнэт цаас/ бичиж тамга даран тооцоо хийх ёстой байдаг. Гэтэл энэ компани манай байгууллага дээр дахин ирж уулзаагүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 33-36 дугаар хуудас/,

Гэрч П.Б-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...Би 2008 оноос хойш одоог хүртэл Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт СХД-ийн 21-р хорооны байгаль хамгаалагчаар ажиллаж байна. “Т” ХХК, “Б” ХХК энэ 2 компанийн хүмүүс надтай ирж уулзаад бид энэ газраас уулын дайрга олборлох гэж байгаа юм гэхэд нь ахад нь энэ талаар мэдэх зүйл байхгүй, мөнгө төгрөг төлж гэрээ байгуулдаг учиртай гэдгийг хэлсэн, үүний дараа газрын улсын байцаагч Ц.Ба зам тавих компанийн хүмүүстэй ирсэн, ирээд энэ хүмүүс манай дээр гэрээ байгуулан төлбөр мөнгөө тушаах учиртай, үүний үндсэн дээр олборлох юм шүү гэж хэлсэн, удалгүй тэр 2 компанийн улсууд Саалийн ам гэх газраас зам тавихад ашиглах дайрга олборлоод эхэлсэн. Тэр үед би манай байгууллагатай гэрээ байгуулсан, байгалийн баялагийн төлбөрөө төлсөн юм байна гэж ойлгосон. Уг нь журмаараа манай газраас байгалийн дагалдах баялаг ашиглах тухай зөвшөөрлийн бичиг авчирч тухайн газраасаа уулын дайрга ашиглах ёстой. 2014 оны 05 дугаар сард шалгалт яваад энэ 2 компани зөрчилтэй байна, зөвшөөрөлгүй байна гэсэн, тэр үед компанийн зөвшөөрөл аваагүй юм байна гэдгийг мэдсэн. “Т” ХХК, “Б” ХХК-уудын барьсан хатуу хучилттай авто замыг улсын комисс хүлээн авах үед Байгаль орчноос хүн байх шаардлагатай гээд намайг дуудаж байна гэхээр нь би өөрийнхөө хорооны нутаг дэвсгэрийг хариуцдаг, манай хорооны нутаг дэвсгэрийн зам болохоор нь байлцах ёстой юм байна гэж бодоод очиж акт дээр нь гарын үсэг зурсан, миний ажил үүргийн



хуваарьт зам хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд орох эрх үүрэг байхгүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 39-40 дүгээр хуудас/,

Гэрч М.Бя-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: “Т” ХХК-нд ерөнхий инженерээр ажилладаг, манай компани Жаргалант тосгоны хажууханд байх Саалийн ам гэх газраас уулсын дайрга зам тавихад ашигласан. Манай компани зам барилга барих тусгай зөвшөөрөлтэй. Харин ашигт малтмал болох олборлох тусгай зөвшөөрөл байхгүй. Манай захирал дайрга олборлох зөвшөөрөл хөөцөлдөж кадастрын зураг гаргаж байсан. Миний хувьд Нийслэлийн байгаль орчны газарт очиж дайрга олборлох зөвшөөрөл олгож өгнө үү гэсэн албан бичиг өгсний дагуу мэргэжилтэн Ц.Ба ирж кадастрын зураг хийлгэдэг, зохих зөвшөөрөл авдаг, мөнгө төлдөг гэж байсан. Би захирал Д.Т-д танилцуулсан... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 41-42 дугаар хуудас/,

Гэрч Л.Б-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...би “Б” ХХК-д ерөнхий инженерээр ажилладаг, манай компани тендерийн баримт бичгийн хэсэг болох Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан карьер орд газрын ойролцоох байршлаас лабораторид хөрсний дээж авч шинжилж үзээд шаардлагад нийцсэн карьеруудын байршлыг хяналтын инженер зөвлөх компанид мэдэгдэж карьер ашиглах хүсэлтээ Сонгинохайрхан дүүрэгт албан бичгээр хүргүүлсэн. Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ц.Б, газрын албаны байцаагчийн хамт зам дээр иржхүсэлт гаргасан карьеруудын байршлыг үзэж танилцаад тухайн зам барилгын ажилд карьер ашиглах захирамж гарч ажлаа эхэлсэн. Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газраас та нарын ажил буруу байна, зөвшөөрөл манай байгууллагаас аваагүй байна гэж байгаагүй. Манай компанид түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон олборлох тусгай зөвшөөрөл байхгүй. Тендерийн материалыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн 47 дугаар хуудсанд замд ашиглах шорооны 8 ордыг тогтоож өгсөн, 8 карьер бүхий газруудаас Саалийн ам гэх газарт зөвшөөрөл авч ажилласан Д.Ба байгалийн дагалдах баялаг ашигласны мөнгө төгрөг тушаагаагүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 44 дүгээр хуудас/,

Шинжээч А.Ц-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...2014 оны 05 дугаар сарын

20-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны зам дагуу байрлах ...-ын нурууны урд энгэрт байрлах 7.33 га талбайд үнэлгээний мэргэжилтэн Г.Б, “Т” ХХК, “Б” ХХК-иудын захирал, цагдаагийн алба хаагч нар хамт очиж тухайн эвдэгдсэн газарт хэмжилт хийж, судалгаа хийсэн. Тухайн газарт нийт 7.33 га газарт биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай. Үүнээс 0.37 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай байсан. Техникийн нөхөн сэргээлт гэдэг нь газрыг унаган төрхийг овоолж, эвдэж гүнзгий нүх овоолго болгосон газрыг техникээр түрж тэгшлэн унаган төрхөнд буцаан оруулахыг хэлдэг. Харин биологийн нөхөн сэргээлт гэдэг нь тэгшилсэн газраа ургамал тарьж ургамалжуулахыг хэлдэг. Байгаль орчинд үүссэн хохирлын хэмжээг тооцоходоо Байгаль орчны сайдын 2010 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу гаргадаг. Энэ аргачлал дээр бодит хохирол, боломжит хохирол гэж байдаг бөгөөд хууль бусаар олборлосон олборлолтын бодит хохирлыг бодоходоо боломжит хохирол болон нөхөн сэргээлтийн зардлын нийлбэрээр тооцно гэж заасан байдаг. Энэ аргачлалын дагуу томьёолж экологи эдийн засгийн үнэлгээг гаргасан. Нөхөн сэргээлтийн зардлын тооцоог 2010 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан А-132, 122 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу хийсэн. Экологи эдийн засгийн хохирлын үнэлгээ 42.126.169 төгрөг, нөхөн сэргээлтийн зардал 36.158.200 төгрөг болж нийт 78.284.369 төгрөг болсон. Мөрдөн байцаагчийн дахин шинжилгээ хийлгэх тогтоол гарсны дагуу 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдөр эвдэгдсэн газарт дахин очиж шалгахад Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газартай хийсэн нөхөн сэргээлтийн гэрээний дагуу өмнө хэлсэн 0.37 га газарт хийгдэх техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Харин биологийн нөхөн сэргээлт хийх гэрээ нь батлагдаагүй байсан. Техникийн нөхөн сэргээлт хийсэн зардлыг хасаж тооцсоноор экологи эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ нь 21.053.979 төгрөгийн хохирол учруулсан байсан. “Б” ХХК-ийн ажиллагаагаар эвдэрсэн нийт 0.18 га /1845м2/ талбайд учруулсан экологи эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ 21.065.397 төгрөг болсон. Нөхөн сэргээлтийн зардлын тооцоо тухайн 2

компанийн нийлбэр талбайгаар 36.158.200 төгрөг болсон. Нэмэлт шинжилгээ хийхэд Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газартай нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулж баталгаажуулсан учраас нөхөн сэргээлтийн зардлын тооцоог давхардуулахгүйн үүднээс хасаж тооцон “Т” ХХК нь 21.053.979 төгрөг, “Б” ХХК нь 21.065.397 төгрөгийн хохирлын үнэлгээ гарсан... Дээрх 2 компанийн аль нь хэдэн га газарт олборлолт ашиглалт явуулсныг нарийн тогтоох боломж байгаагүй. Учир нь газар дээр нь очиж хэмжилт хийж шалгаж үзэхэд энэ 2 компани 2-лаа техникээрээ зэрэг ороод 2-лаа зэрэг олборлолт ашиглалтын ажлаа хийсэн байсан болохоор нарийн зааглах боломжгүй юм. Тийм болохоор байгаль орчинд учруулсан экологи эдийн засгийн хохирлын бодит үнэлгээг энэ 2 компанид хувааж гаргасан байгаа... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 46-49, 47-49, 193-194 дүгээр хуудас/,

Яллагдагч Ц.Б-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...УИХ-ын гишүүн н.Т Жаргалант тосгоны ард иргэдтэй уулзах үеэр буюу 2012 оны эхээр зам тавихыг мэдсэн, 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Улсын Авто замын газарт хуралд очиход ХБНГУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж хөрөнгөөр манай дүүргийн 21-р хороо Жаргалант тосгон руу 17 км хатуу хучилттай замыг тавихаар болсон байсан. Тендерт шалгарсан 2 компанийн захирлууд зөвлөх гадаадын компанийн /Энэтхэг/ захиралтай хамт ирж уулзаад ойролцоох газраас дайрга олборлох зөвшөөрөл эрх үүргийнхээ дагуу олгож өгнө үү гэсэн хүсэлт гаргасан. Үүний дагуу 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 дугаартай /газрын албатай зөвшилцөж/ Засаг даргын захирамж гаргаж замын ажлаа эхэлсэн. Тухайн үеийн хуулиар замыг зам тавих эрхтэй компани тендерт шалгардаг байсан болохоос зам тавих эрхтэй компани хайрга дайрга олборлох тусгай зөвшөөрөл авах хууль байгаагүй. Ашигт малтмалын газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох зөвшөөрөл авахад маш их хугацаа шаардагдах ажил байсан... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 96-99 дүгээр хуудас/,

Яллагдагч Д.Т-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...Манай “Т” ХХК нь 2012 оны 01 дүгээр сард Зам тээврийн яамны захиалгаар Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны нутаг 361-ын гармаас Партизан тосгон /Жаргалант тосгон/ хүртэлх 17 км хатуу хучилттай замын тендерт

оролцож шалгарсан. Авто замын ажилд Жаргалант тосгоны Саалийн ам гэх газрын буталсан чулуу дайрга тэнцсэн. Ингээд Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Д.Б-д уг газраас замын ажилд авч ашиглах зөвшөөрлийг хүссэн. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 тоот захирамж гарч “Б” ХХК-ийн хамт замын ажлыг хийж гүйцэтгэн 2013 оны 06 дугаар сард дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Тухайн зам нь 2014 оны 12 дугаар сард баталгааны хугацаа дуусах тул энэ хугацаанд зам дээр гарсан аливаа эвдрэл гэмтлийг сэргээн засахад зориулж тухайн ашиглалт явуулсан талбайг бүрэн нөхөн сэргээгээгүй орхисон байсан. Манай компанид ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл байхгүй, зүйл ангийг зөвшөөрөхгүй байна:

1-т, 17 км зам тавих ажилд байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гарч дайрга олборлох зөвшөөрлийг заасан,

2-т, зам тавих зөвшөөрлийг Улсын Мэргэжлийн хяналтын газраас дүгнэлтээр өгсөн,

3-т, “А” ХХК техникийн иж бүрэн зөвшөөрөл олгосон,

4-т, Зам Тээврийн яамны төслийг удирдлагын нэгж нь хяналт тавьсан,

5-т, тухайн орон нутгаас зөвшөөрөл авч зөвшөөрөгдсөн газраас дайрга олборлосон,

Нийслэлийн байгаль орчны газрын мэргэжилтэн Ц.Ба эндээс авч болно гэсэн газраас дайрга олборлосон. Бид ашигт малтмалын тухай хуулийн 6.3, 7.3-т заасныг зөрчсөн байна... гэсэн мэдүүлэг /1-р хх-ийн 143-144 дүгээр хуудас, 2-р хх-ийн 101- 104 дүгээр хуудас/,

Яллагдагч Д.Ба-ын мөрдөн байцаалтын шатанд өгсөн: ...манай “Б” ХХК нь 2012 оны 01 дүгээр сард Герман улсын Сэргээн босголтын банкны санхүүжилтээр Зам тээврийн яамны захиалгаар бүс нутгийг хөгжүүлэх төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны нутаг болох 361-ын гармаас Партизан тосгон /Жаргалант тосгон/ хүртэлх 17 км хатуу хучилттай замын тендерт “Т” ХХК-тай түншлэлээр шалгарсан, орон нутгаас нь замын ажилд ашиглах элс хайргыг сонгож шинжлүүлсэн. Жаргалант тосгоны Саалийн ам гэх газрын чулуу дайрга тэнцсэн. Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Ц.Б-д үзүүлж албан бичгийг хүргүүлсэн.

Үүний үндсэн дээр түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 тоот захирамж гарсан, замын ажлыг хийж гүйцэтгэж 2014 оны 6-р сард дуусгаж улсын комисст хүлээлгэн өгсөн. Байгалийн уулын унаган төрхийг алдагдуулсан гэж 39.142.184 төгрөгийн хохирол учруулсан гэж үзээд байгаа, дайрга шорооноос авч ашигласан зүйл байхгүй. Зам тавьж байгаа компаниудад түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох, хайгуул хийх тусгай зөвшөөрөл авна гэж байдаггүй, тухайн сум орон нутгийн засаг захиргаатай зөвшилцөж замын шороо олборлодог. Засаг дарга захирамж гаргаад, зөвшөөрөл өгч байхад таны захирамж буруу байна, таны захирамж зөв гээд явах боломжгүй... гэсэн мэдүүлэг /1-р хх-ийн 146-147 дугаар хуудас, 2-р хх-ийн 106-109 дүгээр хуудас/ гэсэн мэдүүлгүүд,

2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлт / "Т" ХХК, "Б" ХХК-иудын олборлолт явуулсан гэх Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны нутаг Жаргалант тосгоны орчим хуучнаар Партизан САА. /1-р хх-ийн 4-8 дугаар хуудас/,

Байгаль орчны зөвлөх "Н" ХХК-ийн 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 117 шинжилгээг 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдөр "Н" ХХК-ийн захирал газар зүйч А.Ц, үнэлгээний мэргэжилтэн, хяналт үнэлгээний шинжээч Г.Б нар эвдэгдсэн газар дээр Garmin GPSmap 60 CSx маркын байршил тодорхойлогч, талбай хэмжигч, зургийн аппарат, хөрсний зүсэлт хийх хүрз, хэмжилт хийх шугам, уут, тэмдэглэгээ хийх индикатор бүхий цаас, тэмдэглэл зэрэг зүйлсийг ашиглан байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтооход шаардагдах хэмжилт судалгаа хийж дээж авсан болно. Энэ үнэлгээгээр "Т" ХХК, "Б" ХХК-иудын үйл ажиллагаагаар эвдэрсэн нийт 7.33 га талбайд учруулсан экологи - эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ нь 78.284.369 төгрөг болж байна гэсэн шинжээч А.Ц, мэргэжилтэн Г.Б нарын дүгнэлт /1-р хх-ийн 23 дугаар хуудас/,

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны зам дагуу газарт "Т" зам ХХК, "Б" ХХК-уудын уурхайлалтын улмаас эвдэрсэн 7.33 га талбайн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо, экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээний тайлан /1-р хх-

ийн 25-63 дугаар хуудас/,

Байгаль орчны зөвлөх "Н" ХХК-ийн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 121 шинжилгээг 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдөр "Н" ХХК-ийн захирал газар зүйч А.Ц, үнэлгээний мэргэжилтэн, хяналт үнэлгээний шинжээч БД нар эвдэгдсэн газар дээр Garmin GPSmap 60 CSx маркын байршил тодорхойлогч, талбай хэмжигч, зургийн аппарат, хөрсний зүсэлт хийх хүрз, хэмжилт хийх шугам, уут, тэмдэглэгээ хийх индикатор бүхий цаас, тэмдэглэл зэрэг зүйлсийг ашиглан байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтооход шаардагдах хэмжилт судалгаа хийж дээж авсан болно. Энэ үнэлгээгээр "Т" ХХК-ийн үйл ажиллагаагаар эвдэрсэн нийт 0.18 га /1844м2/ талбайд учруулсан экологи - эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ нь 21.053.979 төгрөг болж байна гэсэн шинжээч А.Ц, мэргэжилтэн Г.Б нарын дүгнэлт /1-р хх-ийн 66 дугаар хуудас/,

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны зам дагуу газарт "Т" ХХК-ийн уурхайлалтын улмаас эвдэрсэн 0.18 га талбайн экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээний тайлан /1-р хх-ийн 68-89 дүгээр хуудас/,

Байгаль орчны зөвлөх "Н" ХХК-ийн 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 120 шинжилгээг 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдөр "Н" ХХК-ийн захирал газар зүйч А.Ц, үнэлгээний мэргэжилтэн, хяналт үнэлгээний шинжээч Г.Б нар эвдэгдсэн газар дээр Garmin GPSmap 60 CSx маркын байршил тодорхойлогч, талбай хэмжигч, зургийн аппарат, хөрсний зүсэлт хийх хүрз, хэмжилт хийх шугам, уут, тэмдэглэгээ хийх индикатор бүхий цаас, тэмдэглэл зэрэг зүйлсийг ашиглан байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтооход шаардагдах хэмжилт судалгаа хийж дээж авсан болно. Энэ үнэлгээгээр "Б" ХХК-ийн үйл ажиллагаагаар эвдэрсэн нийт 0.18 га /1845м2/ талбайд учруулсан экологи - эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ нь 21.065.379 төгрөг болж байна. гэсэн шинжээч А.Ц, мэргэжилтэн Г.Б нарын дүгнэлт /1-р хх-ийн 90 дүгээр хуудас/,

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны зам дагуу газарт "Б" ХХК-ийн уурхайлалтын улмаас эвдэрсэн 0.18 га талбайн экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээний тайлан /1-р хх-ийн 92-113 дугаар хуудас/,

Байгаль орчны зөвлөх "Н" ХХК-ийн 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн

124 шинжилгээг 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Н” ХХК-ийн захирал газар зүйч А.Ц, үнэлгээний мэргэжилтэн, хяналт үнэлгээний шинжээч Г.Б нар эвдэгдсэн газар дээр Garmin GPSmap 60 CSx маркын байршил тодорхойлогч, талбай хэмжигч, зургийн аппарат, хөрсний зүсэлт хийх хүрз, хэмжилт хийх шугам, уут, тэмдэглэгээ хийх индикатор бүхий цаас, тэмдэглэл зэрэг зүйлсийг ашиглан байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтооход шаарддгдах хэмжилт судалгаа хийж дээж авсан болно. Энэ үнэлгээгээр “Т” зам ХХК, “Б” ХХК-иудын үйл ажиллагаагаар эвдэрсэн нийт 7.33 га талбайд учруулсан экологи - эдийн засгийн бодит хохирлын үнэлгээ нь 78.284.369 төгрөг болж байна. Тус хохирлын үнэлгээг аж ахуйн нэгж тус бүрээр нь бодвол “Т” ХХК 39.142.184.5 төгрөг “Б” ХХК 39.142.184.5 төгрөгийн экологи-эдийн засгийн бодит хохирол учруулсан гэсэн тооцоо гарч байна гэсэн шинжээч А.Ц мэргэжилтэн Г.Б нарын дүгнэлт /2-р хх-ийн 51 дүгээр хуудас/,

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн гэрчилгээ дугаар №2013/17 /“Н” ХХК/ /2-р хх-ийн 52 дугаар хуудас/,

Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны зам дагуу газарт “Т” ХХК, “Б” ХХК-иудын уурхайлалтын улмаас эвдэрсэн 7.33 га талбайн биологийн нөхөн сэргээлт үүнээс 0.37га талбайн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо, экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээний тайлан 2014 оны 07 дугаар сар /2-р хх-ийн 54-92 дугаар хуудас/,

2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Эд хөрөнгө битүүмжлэх тогтоол /Д.Ба-ын Хюндай ачааны машин хх-хх УБТ, Хюндай Старикс машин хх-хх УНӨ/ эд хөрөнгө битүүмжилсэн тэмдэглэл /1-р хх-ийн 114-119 дүгээр хуудас/,

2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Эд хөрөнгө битүүмжлэх тогтоол /Д.Т-ын Камак-551 маркийн хх-хх УББ самосмал, Дугуйт экскаватор ДЭУ-130 маркийн хх-хх/ /1-р хх-ийн 120-123 дугаар хуудас/,

Ашигт малтмалын газрын 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 6-3378 дугаар албан бичигт: “Б” ХХК-ийн эзэмшилд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүртгэгдээгүй байна, “Т” ХХК-ийн эзэмшилд байсан 1285хх тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь Кадастрийн хэлтсийн даргын 2013-03-28-ны өдрийн 133 тоот шийдвэрээр

цуцлагдсан байна. /1-р хх-ийн 122 дугаар хуудас/,

Улсын бүртгэлийн гэрчилгээ /“Т” ХХК үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл-Авто зам, замын байгууламжийг барих, засварлах 2006.01.17 улсын бүртгэлийн дугаар 901106xxxx/ /1-р хх-ийн 228 дугаар хуудас/,

Авто зам, замын байгууламжийг барих, засварлах Тусгай зөвшөөрөл дугаар №025, №14/627 “Т” ХХК /1-р хх-ийн 229-230 дугаар хуудас/,

Улсын бүртгэлийн гэрчилгээ /“Б” ХХК үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл-Зам талбайн тохижилт хийх, зам, замын байгууламжид засвар арчлалт хийх 2007.01.02 улсын бүртгэлийн дугаар 9011048xxxx /1-р хх-ийн 231 дүгээр хуудас/,

Авто зам, замын байгууламжийг барих, засварлах Тусгай зөвшөөрөл дугаар №13/48. “Б” ХХК /1-р хх-ийн 232 дугаар хуудас/,

Гэрээ /нэг талаас Зам Тээвэр, Барилга, Хот байгуулалтын Яам нөгөө талаас “Т” зам ХХК, “Б” ХХК-ийн түншлэл Партизан Жаргалант чиглэлийн авто замын ажлыг гүйцэтгэх/ /1-р хх-ийн 235 дугаар хуудас/,

2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн дугаар №02/14/13 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт /1-р хх-ийн 236-239 дүгээр хуудас/,

2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дугаар №03/16/2012 Барилга угсралтын ажлыг эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл /1-р хх-ийн 240 дүгээр хуудас/,

2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дугаар №122 Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамж Засаг дарга Б/ /1-р хх-ийн 243 дугаар хуудас/,

Сонгинохайрхан дүүргийн 2012 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт/2-р хх-ийн 3-27 дугаар хуудас/,

1998 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар №29 Байгалийн зарим баялаг ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол /2-р хх-ийн 30 дугаар хуудас/,

2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дугаар №10/40 Нийслэлийн нутаг дэвсгэрт хар шороо, дайрга, Рашаан ашиглах төлбөр тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Рашаан ашигласны төлбөрийн хэмжээ /2-р хх-ийн 31, 32 дугаар хуудас/,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга нарын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээ 2012.02.18 Улаанбаатар хот. /2-р хх-ийн 115-122 дугаар хуудас/,

2014 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн Баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл /2-р хх-ийн 137 дугаар хуудас/,

Улаанбаатар Дарханы төв замаас Партизан чиглэлийн 18 км хатуу хучилттай Авто замын барилгын ажлын байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан /2-р хх-ийн 139-146 дугаар хуудас/,

2014 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Эд зүйлийн үнэлгээ /2-р хх-ийн 147-153 дугаар хуудас/ болон хавтаст хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтууд болно.

Шүүх хуралдаанд талууд эрх тэгш байдлаар оролцоходоо:

Улсын яллагчаас: ...газар, түүний хэвлий нь улсын өмч тул түүнийг ашиглахдаа хуулийн дагуу ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авах ёстой, төлбөр төлөх ёстой, Ц.Б нь өөрт олгогдоогүй эрх мэдлийг хэтрүүлж ашигт малтмал ашиглах Засаг даргын захирамж гаргасан бөгөөд шүүгдэгч Д.Т, Д.Ба нар нь энэхүү захирамжийн дагуу хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал дайргыг олборлож улсад онц их хэмжээний хохирол учруулсан нь хэрэгт хангалттай тогтоогдсон тул шүүгдэгч нарыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй... гэж,

Шүүгдэгчийн өмгөөлөгч Н.Дэмбэрэлдагваас: ...Ц.Б нь Засаг даргын эрх мэдлээ хэтрүүлсэн, ашиг хонжоо олсон зүйл байхгүй, тухайн үед түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа тусгай зөвшөөрөл шаарддаггүй байсан, мөн хэргийн газрын үзлэгт хөндлөнгийн гэрч оролцуулаагүй, шинжээч томилсон тогтоолд нэг шинжээч гарын үсэг зураагүй, хохирогчийг иргэний нэхэмжлэгчээр тогтоогоогүй зэрэг байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн байна, Ц.Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү... гэж,

Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Батзоригтоос: ...Д.Т-ийн үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй, учир нь ашигт малтмалд дайрга орж байна уу гэдэг нь эргэлзээтэй байна. Учир нь уг хуулийн талаарх Улсын дээд шүүхийн тайлбарт зааснаар дайрга ашигт малтмалд

хамаарахгүй байна. Дайрга олборлох талаар Засаг дарга захирамж гаргасан, энэ захирамжийг дээд шатны Засаг дарга хүчингүй болгоогүй тул захирамжийг хууль бус гэж үзэх үндэслэл байхгүй, шинжээчийн дүгнэлт гарахад мөрдөн байцаагч нөлөөлсөн байх тул үндэслэлтэй эсэхэд эргэлзээ төрж байна. Иймд хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд заасан нотолбол зохих асуудлыг бүрэн шалгаагүй тул шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг баримтлан Д.Т-д холбогдох үйлдлийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү... гэж,

Шүүгдэгчийн өмгөөлөгч Г.Цэрэндолгороос: ...Д.Ба-д холбогдох хэргийн зүйлчлэлийг зөвшөөрөхгүй, Авлигатай тэмцэх газрын хэргийг таслах гэж прокурор зүтгүүлж байна, улсад зам хийснийхээ төлөө хариуцлага хүлээх нь үндэслэлгүй бөгөөд шинжээчийн дүгнэлтийг мөрдөн байцаагч дарамталж гаргасан байна. Гэмт хэргийн объектив болон субъектив талууд тогтоогдоогүй байх тул Д.Ба-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү... гэж тус тус мэтгэлцлээ.

Шүүх тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлж авсан бүх нотлох баримтыг бүх талаас нь бодит байдлаар нь хянаж үнэллээ.

Прокурорын газраас шүүгдэгч Ц.Б-г албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн түгээмэл тархацтай ашигт малтмал болох уулын дайргыг ашиглуулах зөвшөөрөл олгосны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан,

Шүүгдэгч "Т" ХХК-ийн захирал Д.Т, "Б" ХХК-ийн захирал Д.Ба нарыг түгээмэл тархацтай ашигт малтмал болох уулын дайргыг хууль бусаар олборлож, байгаль экологид 78.284.369 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан үйлдэлд тус тус ял сонсгож, яллах дүгнэлт үйлджээ.

Шүүгдэгч нар нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг болон албан тушаалын гэмт хэрэг тус тус үйлдсэний улмаас байгаль-экологид нийт 78.284.369 төгрөгийн хохирол учирсан байна.

Ашигт малтмалын тухай хууль 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Д.Ба гэмт хэрэг гарах өдөр буюу 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр уг хууль мөрдөгдөж эхэлсэн байна.

Уг ашигт малтмалын тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад орших бөгөөд энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3 дахь хэсэгт зааснаар Барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий хурдас, чулуулгийн хуримтлалыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод хамааруулна гэж заасан байх тул Жаргалант тосгоны Саалийн ам гэх газрын уулын дайрга нь түгээмэл тархацтай ашигт малтмалд хамаарч байна.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэгт “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж тус тус заасан төдийгүй, энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх хэсэгт “Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тусгай зөвшөөрөл авах, хугацааг сунгах, шилжүүлэх... үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх хэсэгт зааснаар хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих, 11.1.23 дахь хэсэгт зааснаар ...сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл... давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтооно” гэсэн чиг үүрэгтэй болохыг хуульчилжээ. Харин уг хуульд ашигт малтмалын асуудлаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь / ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэгт /харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох л эрхийг хэрэгжүүлэхээр зааснаас гадна Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн е/-д “Дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэрт нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжид

заасны дагуу санал өгөх”, мөн хуулийн 29.1.3-ийн н/ “...нутаг дэвсгэрт нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах...”, 29.1.3-ийн в/ “...орон нутгийн чанартай зам, гүүр, үер усны хамгаалалт, далан суваг барих, засварлах, тэмдэгжүүлэх ажлыг ажлыг зохион байгуулах... нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх хэсэгт заасан ...эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох”... бүрэн эрхтэй. Д.Ба энэ эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргахаар заасан байна.

Гэтэл шүүгдэгч Ц.Б нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаар ажиллаж байхдаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох эрхгүй атлаа албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 дугаар Засаг даргын захирамжаар Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Жаргалант тосгоны орчмоос түгээмэл тархацтай орд газрыг “Т” ХХК, “Б” ХХК-иудад 78062 м2 газрыг ашиглуулах зөвшөөрөл олгосны улмаас улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь:

хохирогч Ж.Б-ийн ...”Нийслэлийн ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын журам”-аар дүүргийн Засаг дарга нарт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах, олборлуулах эрх олгоогүй, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 122 дугаартай захирамж нь Байгалийн баялгийг төлбөртэй ашиглах тухай хуулийн заалтыг зөрчсөн, манай газраас зөвшөөрөл олгодог байтал манайд мэдэгдэлгүйгээр байгалийн баялгийг зүй зохисгүй ашиглуулснаас “Т” ХХК, “Б” ХХК-иудын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчинд 78.284.369 төгрөгийн хохирол учирсан ...гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 28-29/,

Гэрч Ц.Ба-ийн ...аж ахуйн нэгж байгууллага нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл лицензтэй байх ёстой үүнийхээ дагуу

ашиглалт олборлолт явуулдаг. Дүүргийн Засаг даргын захирамжаар аж ахуйн нэгж байгууллагад ашигт малтмал олборлох ашиглуулах эрх байхгүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 33-36/,

Гэрч П.Б-ийн ...2 компанийн улсууд Саалийн ам гэх газраас зам тавихад ашиглах дайрга олборлоод эхэлсэн. Уг нь журмаараа манай газраас байгалийн дагалдах баялаг ашиглах тухай зөвшөөрлийн бичиг авчирч тухайн газраасаа уулын дайрга ашиглах ёстой... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 39-40/,

Гэрч М.Бя-ийн ...манай "Т" ХХК-нь зам барилга барих тусгай зөвшөөрөлтэй харин ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл байхгүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 41-42/,

Гэрч Л.Б-ийн ...манай "Б" ХХК нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын зам барилгын ажилд карьер ашиглах захирамжийн дагуу ажлаа эхэлсэн. Манай компанид түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон олборлох тусгай зөвшөөрөл байхгүй... гэсэн мэдүүлэг/2-р хх-ийн 44/,

Шинжээч А.Ц-ийн ...Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны ...-ын нурууны урд энгэрт 7.33 га талбайд үнэлгээ хийхэд нийт 78.284.369 төгрөгийн хохирол гарсан, /2-р хх-ийн 46-49, 47-49, 193-194/, гэсэн мэдүүлгүүд,

Шүүгдэгч нарын шүүхийн хэлэлцүүлэгт болон мөрдөн байцаалтын шатанд ...тухайн орон нутаг дайрга ашиглах зөвшөөрөл олгодог байсан, дайрга ашиглахад тусгай зөвшөөрөл олгодог хууль тогтоомж байгаагүй тул Засаг даргын захирамжийг хуулийн дагуу гарсан... гэсэн хоорондоо зөрүүгүй мэдүүлгүүд болон 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дугаар №122 Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглуулах тухай Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамж /1-р хх-ийн 243/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч болон Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга нарын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээ /2-р хх-ийн 115-122/, 1998 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар №29 Байгалийн зарим баялаг ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол /2-р хх-ийн 30/, 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дугаар №10/40 Нийслэлийн нутаг дэвсгэрт хар шороо, дайрга, Рашаан ашиглах төлбөр тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Рашаан

ашигласны төлбөрийн хэмжээ /2-р хх-ийн 31, 32/ зэрэг нотлох баримтуудаар хангалттай тогтоогдож байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Шүүгдэгч "Т" ХХК-ийн захирал Д.Т, "Б" ХХК-ийн захирал Д.Ба нар нь түгээмэл тархацтай ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг зохих газраас нь аваагүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч биш атлаа 2012 оны 04 дүгээр сараас 2013 оны 06 дугаар сарыг хүртэлх хугацаанд Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны нутаг дэвсгэр Жаргалант тосгоны Саалийн ам гэх газрын 7.33 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал болох уулын дайргыг хууль бусаар ашиглаж байгаль экологид 42.126.169 төгрөгийн хохирол учруулж, улмаар ашигт малтмалын үйл ажиллагаа явуулсан талбайд хуулиар хүлээсэн 36.158.200 төгрөгийн биологийн нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлээгүйгээс улсад нийт 78.284.369 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь:

хохирогч Ж.Б-ийн ...дайрга ашиглаж, олборлоход манай газраас байгалийн баялаг ашиглах зөвшөөрөл авна, хэрэв зөвшөөрөгдсөн дайрганы карьераас шороог авч байгаа тохиолдолд манай газраас зөвшөөрөл авахгүй. Засаг дарга манайд мэдэгдэлгүйгээр байгалийн баялгийг зүй зохисгүй ашиглуулсан байна. "Т" ХХК, "Б" ХХК-иудын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчинд 78.284.369 төгрөгийн хохирол учирсан Д.Ба төлбөрийг дээрх 2 компаниас нэхэмжилж байна... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 28-29/,

Гэрч Ц.Ба-ийн ...Сонгинохайрхан дүүргийн ...дүгээр хорооны Жаргалант тосгоны нутагт "Т", "Б" ХХК-иуд уулын дайрга олборлохныг шалгалтаар илрүүлсэн, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлоход манай байгууллагад зохих төлбөр төлдөг, газрын нөхөн сэргээх төлөвлөгөө батлуулдаг, зөвшөөрөл байгаа эсэхийг шалгана гэхэд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамж үзүүлсэн, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох ашиглах асуудал нь Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулдаг, уг хуулинд зөвшөөрөлтэй лицензтэй талбайгаас ашигт малтмал олборлох ашиглахаар зохицуулсан. Аж ахуйн нэгж, байгууллага

нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл лицензтэй байх ёстой үүнийхээ дагуу ашиглалт олборлолт явуулдаг. Эсхүл ашиглалт олборлолтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаас зах зээлийн ханшаар нь худалдан авч үйл ажиллагаандаа хэрэглэх ёстой, гэтэл аж ахуйн нэгж, байгууллагууд мөнгөө хэмнэх зорилгоор ойролцоох уулнаас зөвшөөрөлгүй ашигт малтмал олборлодог, Дүүргийн Засаг даргын захирамжаар аж ахуйн нэгж байгууллагад ашигт малтмал олборлох ашиглуулах эрх байхгүй. Би “Т” ХХК-д дайрга олборлох ямар нэгэн зөвшөөрөл өгөөгүй бөгөөд зөвшөөрөл өгдөг эрх бүхий субъект би биш. Хэрэв зөвшөөрөл зохих албан тушаалтнаас нь авсан бол би байгалийн баялаг ашиглах хуудас /үнэт цаас/ бичиж тамга даран тооцоо хийх ёстой байдаг... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 33-36/,

Гэрч П.Б-ийн ...”Т” ХХК, “Б” ХХК 2 компанийн хүмүүс Саалийн ам гэх газраас зам тавихад ашиглах дайрга олборлоод эхэлсэн, би гэрээ байгуулсан, байгалийн баялаг төлбөрөө төлсөн гэж ойлгосон. Уг нь журмаараа манай газраас байгалийн дагалдах баялаг ашиглах тухай зөвшөөрлийн бичиг авчирч тухайн газраасаа уулын дайрга ашиглах ёстой... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 39-40/, гэрч М.Бя-ын ...манай “Т” ХХК-нь ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл байхгүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 41-42/,

Гэрч Л.Б-ийн ...манай “Б” ХХК нь компанид түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон олборлох тусгай зөвшөөрөл байхгүй, байгалийн дагалдах баялаг ашигласны мөнгө төгрөг тушаагаагүй... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 44/,

Шинжээч А.Ц-ийн ...Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны ...-ын нурууны урд энгэрт байрлах 7.33 га эвдэгдсэн газарт хэмжилт хийж, судалгаа хийж экологи эдийн засгийн хохиролд 42.126.169 төгрөг, нөхөн сэргээлтийн зардалд 36.158.200 төгрөг буюу нийт 78.284.369 төгрөг болсон, хэмжилт хийж шалгаж үзэхэд энэ 2 компани 2-лаа техникээрээ зэрэг ороод 2-лаа зэрэг олборлолт ашиглалтын ажлаа хийсэн байсан болохоор нарийн зааглах боломжгүй тул бодит үнэлгээг энэ 2 компанид хувааж гаргасан байгаа... гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 46-49, 47-49, 193-194/, Ашигт малтмалын газрын 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 6-3378 дугаар албан бичиг /1-р хх-ийн 122/ зэрэг бичгийн нотлох баримтуудаар

хангалттай тогтоогдож байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 214 дүгээр зүйлийн 214.2-д заасан гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Шүүх хуралдаанд шүүгдэгч нарын өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийг шүүх хүлээн авах боломжгүй байна. Учир нь:

2014 оны 05 дугаар сарын 8-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэр Жаргалант тосгоны орчим хууль бусаар дайрга олборлосон газарт буюу хэрэг учрал болсон гэх газарт үзлэг хийхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсгийг баримтлан хөндлөнгийн гэрчийг байлцуулахгүйгээр явуулсан хэдий ч энэ талаараа болон үзлэгийн явц, үр дүнг тэмдэглэлд тусгаж, гэрэл зураг авч хуулийн дагуу бэхжүүлсэн байна.

Мөн эрүүгийн хэрэгт авагдсан шинжээчийн дүгнэлтүүдийг шинжлэн судлахад дүгнэлт гаргасан шинжээч нар Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан эрх, үүрэгтэй танилцсан талаараа гарын үсэг зурсан байна.

Эрүүгийн хэрэгт 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 117 дугаар шинжээчийн дүгнэлт гарсны дараа дахин 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 121, 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 120 дугаар шинжээчийн дүгнэлтүүд гарсан байх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 165 дугаар зүйлийн 165.1 дэх хэсэгт зааснаар мөрдөн байцаагч нь дахин шинжилгээ хийлгэхдээ шинжээчийн дүгнэлт, эсхүл түүний зарим хэсэг үндэслэлгүй буюу үнэн зөв болох нь эргэлзээтэй үндэслэлээр шинжээчийг томилоогүй, харин өмнөх шинжээчийн дүгнэлтээр “Т” ХХК, “Б” ХХК-иудын үйл ажиллагаагаар эвдэрсэн нийт 7.33 га талбай болон нөхөн сэргээлтийн зардлыг аж ахуйн нэгж тус бүрээр нь зааглаж гаргуулахаар томилсон нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан дүгнэлт гаргасан шинжээчийг оролцуулахыг хориглох үндэслэл болохгүй юм.

Гэтэл шинжээч нь дахин шинжээчийн дүгнэлт гаргахдаа гэмт хэрэг үйлдэгдэх үед учирсан бодит хохирлын хэмжээг олборлолт явуулсан нийт талбайн хэмжээгээр гаргаагүйгээс мөрдөн байцаагч нэмэлт шинжилгээ хийлгэхээр томилсон нь Шүүхийн



шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт дүгнэлтийг гаргасан буюу гаргахад оролцсон шинжээчээр хийлгэж болно гэсэн зохицуулалттай нийцэж байх тул 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 124 шинжээчийн дүгнэлтийг шүүх үнэлэх боломжтой гэж үзэв.

Байгаль орчин, ногоон хөгжлийн газрын 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 1/833 дугаар албан бичигт эрүүгийн 201426000204 дугаар хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгчээр Ж.Б-г томилсоны дагуу эрүүгийн хэрэгт Ж.Б-г иргэний нэхэмжлэгч, хохирогчоор тогтоосон /1 хх-ийн 16-18/ байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9 дэх хэсэгт зааснаар хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй юм.

Шүүхийн хэлэлцүүлэг болон мөрдөн байцаалтын шатанд шүүгдэгч Ц.Б-ээс ...дайрга нь тухайн нутаг дэвсгэрийн өмч тул орон нутгийн Засаг дарга зөвшөөрөл олгодог байсан, өөртөө би ашиг олоогүй, улсад бүтээн байгуулалт хийж зам тавьсныхаа төлөө хариуцлага хүлээж байгаадаа харамсаж байна... гэж,

шүүгдэгч Д.Т-ээс ...дайрга ашиглах зөвшөөрлийг тухайн орон нутгийн Засаг даргад хүсэлт гаргаж авсан, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл йжиллагаа явуулаагүй, авсан дайрга нь зам руугаа орсон, бид хохирол учруулаагүй... гэж,

шүүгдэгч Д.Ба-аас ...дайрга ашиглах зөвшөөрлийг Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан, маш их гомдолтой байна... гэж мэдүүлж байх бөгөөд шүүгдэгч нь Үндсэн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар өөрийгөө өмгөөлөх эрхтэй төдийгүй өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн гэм буруугүйг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй тул хэрэгт цугларсан бусад нотлох баримтуудаар шүүгдэгч нарын гэм буруу нотлогдсон гэж дүгнэлээ.

Шүүгдэгч Ц.Б-ийн хувийн байдалтай холбоотой түүний урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгасан хуудас, Баянзүрх дүүргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоолийн хуулбар /1-р хх-ийн 171-207 дугаар хуудас/, иргэний үнэмлэхийн лавлагаа /1-р хх-ийн 209 дүгээр хуудас/, Баянзүрх дүүргийн ...дүгээр хорооны Засаг даргын тодорхойлолт /2-р хх-ийн 110 дугаар хуудас/, Сонгинохайрхан

дүүргийн Засаг дарга Ц.Б-ийн ажил байдлын тодорхойлолт /2-р хх-ийн 111-113 дугаар хуудас/-ыг шинжлэн судлахад тэрээр урьд: ...дүүргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар төрийн удирдах албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жил хорих ял оногдуулсныг тэнсэж, 2 /хоёр/ жилийн хугацаагаар хянан харгалзсан байх боловч шүүгдэгч нь 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө буюу 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр өөр гэмт хэрэг үйлдсэн байх тул түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэгт заасан журмыг баримтлан, оногдуулахаар шийдвэрлэв.

Шүүгдэгч Д.Т-ийн хувийн байдалтай холбоотой түүний урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгасан хуудас /1-р хх-ийн 155 дугаар хуудас/, иргэний үнэмлэхийн лавлагаа /1-р хх-ийн 156 дугаар хуудас/, Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо Засаг даргын тодорхойлолт /2-р хх-ийн 130 дугаар хуудас/,

Шүүгдэгч Д.Ба-ын хувийн байдалтай холбоотой түүний урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгасан хуудас /1-р хх-ийн 159 дүгээр хуудас/, иргэний үнэмлэхийн лавлагаа /1-р хх-ийн 161/, Улсын бүртгэлийн ерөнхий газар оршин суугаа хаягийн тодорхойлолт /2-р хх-ийн 131 дүгээр хуудас/ гэсэн бичгийн баримтуудыг тус тус шинжлэн судлахад шүүгдэгч нар нь анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн байна.

Эрүүгийн хэрэгт мөрдөн байцаагчийн 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Эд хөрөнгө битүүмжлэх тогтоолоор “Б” ХХК-ийн эзэмшлийн хх-хх УНӨ улсын дугаартай Hyundai Starex маркийн автомашин /15.000.000 төгрөгийн/, мөн хх-хх УБТ улсын дугаартай HD-270 моделийн Hyundai маркийн ачааны автомашин /45.000.000 төгрөгийн/, “Т” ХХК-ийн эзэмшлийн хх-хх УББ улсын дугаартай Камак-5511 маркийн самосмал автомашин /15.000.000 төгрөгийн/, мөн хх-хх УБ улсын дугаартай ДЭУ-130 маркийн Даевоо автомашин /40.000.000 төгрөгийн/-уудыг битүүмжилсэн /1-р хх-ийн 114-123 дугаар хуудас/ байх бөгөөд дээрх тээврийн хэрэгсэлүүд нь “Б” ХХК болон “Т” ХХК-ийн эзэмшилд байдаг болох нь тээврийн хэрэгслийн лавлагаа, тээврийн

хэрэгслийн гэрчилгээ зэргээр нотлогдож байх тул гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн уг тээврийн хэрэгслүүдийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хурааж, улсын орлогод оруулж шийдвэрлэв.

“Т” ХХК болон “Б” ХХК нь хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулснаар байгаль экологид нийт 78.284.369 төгрөгийн буюу, онц их хэмжээний хохирол учруулсан байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ өөрөө хариуцлага хүлээх зарчмыг удирдлага болгож дээрх хуулийн этгээдүүдийн захирал буюу шүүгдэгч нар нь улсад учруулсан гэм хорыг өөрөө хариуцаж арилгах үүрэгтэй тул шүүгдэгч нар хувь тэнцүү хохирлыг барагдуулах нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Шүүхийн хэлэлцүүлэгт хохирогчоос ...шүүгдэгч нар нийт 78.284.369 төгрөгийн хохирлоос нөхөн сэргээлтийн зардал 36.158.200 төгрөгийг төлж барагдуулсан тул байгаль экологийн хохирол 42.126.169 төгрөгийг нэхэмжилж байна... гэсэн хүсэлт гаргаж, хохирогч нь төлөгдсөн мөнгөөр эвдэрсэн газрыг нөхөн сэргээх боломжтой талаараа мэдүүлж байх тул байгаль экологийн хохирол 42.126.169 төгрөгийг Иргэний хуулийн 497 дүгээр зүйлийн 497.1, 497.3, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.Т, Д.Ба нараас хувь тэнцүүлэн хамтран хариуцуулж тус бүрээс 21.063.845 төгрөгийг гаргуулж Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт олгохоор шийдвэрлэв.

Шүүгдэгч Ц.Б-д ял шийтгэл оногдуулахдаа хуульд заасан хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдал байхгүй байна.

Шүүгдэгч Д.Т, Д.Ба нарт ял шийтгэл оногдуулахдаа анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлын зарим хэсгийг сайн дураараа нөхөн төлсөн, шүүгдэгч нарын хувийн байдал зэрэг ял хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг тус тус харгалзан үзэв.

Эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй, хураагдсан иргэний бичиг баримтгүй, шүүгдэгч нар цагдан хоригдоогүй болохыг тус тус дурдав.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 286, 290 дүгээр

зүйлийн 290.3, 294, 297 дугаар зүйлийн 297.1.1 -297.1.4, 298 дугаар зүйлийн 298.1.2, 298.1.4 дүгээр зүйлд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ц.Б-г төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлсний улмаас улсад онц их хэмжээний хохирол урчуулсан гэмт хэрэгт, Д.Т, Д.Ба нарыг хууль бусаар ашигт малтмал ашиглаж үйл ажиллагаа явуулсны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус гэм буруутайд тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т зааснаар Ц.Б-г тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жил хасаж, 2 /хоёр/ жил хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 214 дүгээр зүйлийн 214.2-т зааснаар Д.Т, Д.Ба нарыг 200.000 /хоёр зуун мянга/ төгрөгийн эд хөрөнгө тус тус хурааж, 2 /хоёр/ жил хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.3-д заасныг журамлан Ц.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т зааснаар оногдуулсан тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жил хасаж, 2 /хоёр/ жилийн хорих ял дээр өмнөх ... дүүргийн шүүхийн 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 63 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар төрийн удирдах албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жил хорих ял оногдуулснаас нэмэгдэл ялыг багтааж, 2 /хоёр/ жилийн хорих ялын зарим болох 1 /нэг/ жилийн хорих ялыг нэмж нэгтгэн, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жил хасаж, түүний биеллэн эдлэх хорих ялын хугацааг бүгд 3 /гурав/ жил хорих ялаар тогтоосугай.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар Ц.Б-д ногдуулсан 3 жилийн хорих ялыг, Д.Т, Д.Ба нарт оногдуулсан 2 жилийн хорих ялыг тус тус жирийн дэглэмтэй, эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

5. Ц.Б, Д.Т, Д.Ба нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөн цагдан хорьж, тэдний хорих ял эдлэх хугацааг 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн тус тус тоолсугай.

6. Иргэний хуулийн 497 дүгээр зүйлийн 497.1, 497.3, 510 дугаар зүйлийн 510.1

дэх хэсэгт зааснаар Д.Т, Д.Ба нараас хувь тэнцүүлэн тус бүр 21.063.845 төгрөгийг гаргуулж Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газарт олгосугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар мөрдөн байцаагчийн 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Эд хөрөнгө битүүмжлэх тогтоолоор битүүмжилсэн “Б” ХХК-ийн эзэмшлийн хх-хх УНӨ улсын дугаартай Hyundai Starex маркийн автомашин, мөн хх-хх УБТ улсын дугаартай HD-270 моделийн Hyundai маркийн ачааны автомашин, “Т” ХХК-ийн эзэмшлийн хх-хх УББ улсын дугаартай Камак-5511 маркийн самосмал автомашин, мөн хх-хх УБ улсын дугаартай ДЭУ-130 маркийн Даевоо автомашинуудыг тус тус хурааж, улсын орлогод оруулсугай.

8. Эрүүгийн хэрэгт хураагдсан иргэний

бичиг баримт, эд мөрийн баримтгүй, шүүгдэгч нар цагдан хоригдоогүй болохыг тус тус дурдсугай.

9. Шүүхийн шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоол гардаж авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд ялтан, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч нар давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

10. Шүүхийн шийтгэх тогтоолд эрх бүхий этгээд давж заалдах гомдол гаргасан, улсын яллагч эсэргүүцэл бичвэл угтогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелүүлэх хүртэл Ц.Б, Д.Т, Д.Ба нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

М.НАРМАНДАХ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 92

Хэрлэн сум

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 28 дугаар шүүхийн Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг тус шүүхийн шүүгч Ж.Болдбаатар даргалж тус шүүхийн "Б" танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Нарийн бичгийн дарга: А.Оюун-Эрдэнэ

Улсын яллагч: Д. Отгонтуяа

Шүүгдэгч нарын өмгөөлөгч:

Г.Бадамгэрэл, Б.Минжүүрдорж

Шүүгдэгч: Т.Н, С.Г нар оролцов.

Тус аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1, 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Т.Н, С.Г нарт холбогдох 201423000204 дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 08 дугаар сарын 25-нд хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...аймгийн ...суманд ...оны ...сарын ...-нд төрсөн, ...настай эмэгтэй, халх, дээд боловсролтой, цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багш мэргэжилтэй, ...аймгийн ...сумын ...-р ...ажилтай, ам бүл ..., ...хүүхдийн хамт ...аймгийн ...сум ...дугаар баг ...тоотод оршин суух, 1993 онд Аргазүйч багш цол, 1995 онд Боловсролын яамны Хүндэт жуух бичиг, 2012 онд БШУЯ-ны Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнагдаж байсан, урьд ял шийтгэлгүй О овогт Т.Н /РД:СЕ..... /

2. Монгол Улсын иргэн, ...аймгийн ...хотод ...оны ...сарын ...-нд төрсөн, ...настай, эмэгтэй, халх, тусгай дунд боловсролтой, тогооч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ ...суманд хувийн малаа маллаж байсан, ам бүл ..., хүүхдүүдийн хамт, ...аймгийн ...сумын ...дугаар баг... тоотод оршин суух улсаас авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгэлгүй Т овогт С.Г /РД:СЭ..... /

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар /яллах дүгнэлтэд дурдсанаар /

Шүүгдэгч Т.Н нь 2013 оны 08 дугаар сард иргэн Л.Т-г цэцэрлэгийн багшийн ажилд оруулахаар урьдчилан амлаж Л.Т-ийн хадам ээж болох С.Г-ээс 1 сая /1.000.000/ төгрөгийн хахууль авсан,

Шүүгдэгч С.Г нь иргэн Л.Т-г цэцэрлэгийн

багшийн ажилд оруулахаар 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч ажилтай Т.Н-д 1 сая /1.000.000/ төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүх хуралдаанд эрүүгийн 20142300020. дугаартай хэрэгт цугларсан болон шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт дурдагдсан нотлох баримтуудыг шинжлэн судлаад ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Т.Н нь ...аймгийн ...сумын ...дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн ажил албан тушаалаа ашиглан 2013 оны 08 дугаар сарын 20-доор шүүгдэгч С.Г-ээс 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахууль авч, түүний бэр Л.Т-г ...сумын 3 дугаар цэцэрлэгт 2013.08.31-ний өдрөөс бүлгийн багшаар түр томилсон цэцэрлэгийн эрхлэгчийн 2013.08.23-ны өдөр №29 дугаартай тушаалыг гарган авч ажиллуулсан гэмт хэргийг үйлдсэн.

Шүүгдэгч С.Г нь өөрийн бэр Л.Т-г цэцэрлэгийн эрхлэгч ажилтай шүүгдэгч Т.Н-д 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хээл хахуулийг 2013 оны 08 дугаар сарын 20-дын орчимд өгсөн гэмт хэргийг үйлдсэн болох нь доорх нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна гэж шүүх дүгнэв. Үүнд:

1. Гэрч Л.Т-ийн мөрдөн байцаалтад өгсөн...Би цэцэрлэгийн насны 3 хүүхэдтэй болохоор цэцэрлэгт орж ажил хийе гэж гэр бүлийн хүнтэйгээ ярилцаж байсан юм. Гэтэл нөхөр маань 2013 оны 08 дугаар сард ...сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Т.Н-тэй уулзаж ажил асуусан чинь цэцэрлэгийн багшийн орон тоо байгаа гэж хэлсэн байсныг хадам ээж С.Г-т хэлсэн байсан. Тэгтэл хадам ээж С.Г нь Т.Н-тэй уулзаад 1 сая төгрөг өгөөд намайг ажилд оруулсан байсан. Тухайн үед хадам ээж С.Г-г 1 сая төгрөг өгч намайг ажилд оруулсныг мэдээгүй. 2014 оны 04 дүгээр сард ажлаасаа гарлаа гэж хадам ээжтэй ярихдаа мэдсэн. Би хадам ээж С.Г-тэй дараа нь уулзаад та намайг 1 сая төгрөг өгч ажилд оруулсан талаараа тухайн үедээ яагаад хэлээгүй юм бэ гэж асуутал Т.Н хэнд ч хэлж болохгүй, хүн амьтан мэдчихнэ, та дуугүй л байгаарай гэсэн болохоор надад хэлээгүй гэсэн. 2013 оны 09 дүгээр сард цэцэрлэгийн хүүхдүүдийн аяга таваг шинэчлэх болоод, хүүхэд нэг бүрээс

5 мянган төгрөг хурааж авсан мөнгөнөөс эрхлэгч Т.Н аваад хэрэглэхсэн байна, чамайг 300 мянган төгрөг зээлээч гэж байна гээд, үйлчлэгч Д.О надад ирж хэлэхээр нь надад мөнгө байхгүй гэж хэлсэн. Түүнээс хойш 2, 3 хоногийн дараа 2013.09.25-ны өдөр эрхлэгч Т.Н Улаанбаатар хотод очсон байна чамайг 300 мянган төгрөг олоод яаралтай явуул, 2, 3 хонуулаад өгнө гэж яриад байна гээд үйлчлэгч Д.О ирж хэлэхээр нь эзэмэг, бөгжөө ломбардад 250 мянган төгрөгөөр барьцаалаад, 3 хүүхдийнхээ 20 мянган төгрөгийг аваад, 300 мянган төгрөг болгоод туслах багш н.Б-д өгсөн. Хугацаа нь болохоор нь мөнгөө авъя гэж мессеж бичээд дансны дугаараа өгсөн чинь 2014.06.30-нд миний дансанд 300 мянган төгрөг хийсэн байсан... гэсэн мэдүүлэг /хх-ийн 22-24х/

2. Гэрч Д.О-гийн мөрдөн байцаалтад өгсөн...Би 2007 оны 08 дугаар сард ...аймгийн ...сумын 3 дугаар цэцэрлэгт угаагчаар анх ажилд ороод одоог хүртэл ажиллаж байна. 2008 оны 06 дугаар сарын дунд үеэр цэцэрлэгийн эрхлэгч Т.Н хоолгүй болчихлоо, идэх ямаа олж өгөөч гэж хэлэхээр нь би хүнээс хязаалан насны ямааг 30 мянган төгрөгөөр авч өгсөн боловч одоог хүртэл өгөөгүй. Мөн би 2009 оны 05 дугаар сарын үед цалингийн зээл авахад эрхлэгч Т.Н 200 төгрөг зээлж аваад 2010 оны 01 дүгээр сард 60 мянга, 02 дугаар сард ноосон цамц 18 мянган төгрөгөөр бодож өгөөд үлдсэн 122 мянган төгрөгийг одоог хүртэл өгөөгүй. 2013 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр эрхлэгч Т.Н намайг дуудаад Б.Т-с 300 мянган төгрөг зээлээд өгөөч гэж хэлэхээр нь Б.Т-д хэлтэл Б.Т мөнгө байхгүй гэж хэлсэн. Түүнээс хойш 2 хоногийн дараа эрхлэгч Т.Н Улаанбаатар хотод ирээд байна та Б.Т-с ямар ч байсан 300 мянган төгрөг аваад яаралтай явуулаач гэж хэлэхээр нь мөнгөгүй гэсэн шүү дээ гэж хэлтэл, сургалтын мөнгө нь байгаа түүнээс та зээлээд өгөөч гээд гуйгаад байхаар нь Б.Т-д хэлтэл төлбөрийн мөнгө байхгүй, эзэмэг бөгжөө барьцаанд тавьж 300 мянган төгрөг туслах багш н.Б-д өгсөн. Ер нь Т.Н мөнгөний сонирхолтой, багш ажилчдыг хооронд нь хутган үймүүлж мөнгө төгрөг нэхэн авдаг, хүмүүсийг өөртэй нь дотно байхгүй бол хална гээд байдаг гэсэн мэдүүлэг /хх-ийн 29-30/,

3. Шүүгдэгч С.Г-ийн мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр болон яллагдагчаар өгсөн... аймагын ...сумын 3 дугаар цэцэрлэгт багшийн орон тоо байна гэж сонсоод 2013 оны 08 дугаар сарын дунд үеэр цэцэрлэгийн

эрхлэгч Т.Н-тэй уулзаж асуухад манай цэцэрлэгт багшийн орон тоо байгаа, орох гэсэн хүн байгаа гэж хэлэхээр нь би бэр Б.Т-г ажилд оруулах гэсэн юм, бага ангийн багш хийж байсан гэж хэлтэл, танай бэртэй чинь уулзаж ярина, өөрөө сонирхолтой юм уу гэхээр нь сонирхолтой, бэрийгээ уулзуулах уу гэтэл би нэг удаа бэрийг чинь харж байсан шиг санаж байна за яахав, эргээд та надтай уулзаарай гэж хэлсэн. 2, 3 хоногийн дараа Т.Н рүү утсаар ярьж асуутал өөрөө сонирхолтой бол яахав дээ, өөр нэг их давгүй авъяастай охин орох гээд байгаа гээд гар хараад байх шиг байхаар нь ажилд авчихвал эгч нь зүгээр байхгүй гэж хэлсэн чинь багш нарын цалин нэмэгдэнэ, давгүй болно шүү дээ, манай аймагт сургуулийн өмнөх насны сургалт явагдах гэж байгаа гээд зан ааш нь сайжраад Б.Т-г сургалтад суулгаарай гэхээр нь өө ямар сайн юм, би Боловсрол төвд очоод бэрийгээ бүртгүүлчихье гэж хэлтэл, та хэрэггүй ээ би цэцэрлэгээс нэрийг нь өгчихье гэж хэлсэн. Түүний дараа 2013 оны 08 дугаар сарын 25, 26-ны үед Т.Н-тэй утсаар яриад хаана байна гэж асуутал би “Жавхаа” гэдэг нэртэй үсчний газар байна гээд надад байгаа газраа зааж өгөхөөр нь би очоод хаалгаар нь шагайтал, намайг хараад гарч ирээд, мэнд ус мэдэлцээд, Т-г хэзээ явуулах уу, гэж асуутал за яахав би дууднаа гэж хэлэхээр нь 10 мянгатын дэвсгэртээр 1 боодол 1 сая төгрөгийг цүнхнээсээ гаргаад май гэж өгөөд яанаа хүн амьтан харчих вий дээ, та хэнтэй явж байгаа юм гэж асуутал барьж явсан тороо онгойлгоод хийчих, гэхээр нь торонд нь хийгээд тоолоорой гэж хэлтэл, өө яахав ээ баярлалаа гээд үсчний газартаа буцаад орчихсон... гэсэн мэдүүлгүүд /хх-ийн 34-35, 37-38х/

4. Шүүгдэгч Т.Н-ийн мөрдөн байцаалтад сэжигтнээр өгсөн...Б.Т бага ангийн багшийн мэргэжилтэй байсан. Цэцэрлэгийн багшийн мэргэжил эзэмшээгүй байсан. Бусад багшийн мэргэжлээс цэцэрлэгийн багшийн мэргэжилтэй арай ойрхон юм гэдгээр нь ажилд авсан. Би Б.Т-г ажилд оруулахын тулд 1 сая төгрөг аваагүй, боломжтой үедээ буцааж өгье гэж С.Г-д хэлж авсан. Би 2013 оны 08 дугаар сард ...аймагт н.Ж үсчинд үсээ засуулж байхдаа 1 сая төгрөг авсан. Би мөнгийг нь хийх гэж байсан чинь С.Г-ийн дансны дугаарыг нь бичиж авсан цаасаа олохгүй байхаар нь ХААН банкин дээр очоод С.Г-ийн дансыг нь хэлээд өгөөч гэж хэлтэл энэ хүний нэр дээр данс харагдахгүй байна,

хаалгасан юм шиг байна гэж хэлсэн. Би С.Г-ээс зээлсэн 1 сая төгрөгөө өнөөдрийг хүртэл буцааж өгч чадаагүй байгаа гэсэн мэдүүлэг /хх-ийн 40-42/,

5. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2013 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн №29 тоот тушаал /хх-ийн 25х/,

6. Хөдөлмөрийн гэрээ /хх-ийн 26-28х/

7. Шүүгдэгч Т.Н-ийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 55х/,

8. Шүүгдэгч С.Г-ийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 75х/

9. Шүүгдэгч С.Г-ийн шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт үйлдсэн гэмт хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд зэрэг болно.

Шүүгдэгч Т.Н нь хээл хахууль өгөгч С.Г-ийн ашиг сонирхлын үүднээс өөрийн эрхэлж байгаа ажил албан тушаалаа ашиглан өөртөө ашиг олох зорилгоор хийж гүйцэтгэх ажлынхаа өмнө түүнээс хээл хахууль авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг мөн байна.

Шүүгдэгч С.Г нь өөрийн гэр бүлийн ашиг сонирхлын үүднээс ажил хэргээ хурдан, хялбар, баталгаатай болгох хувийн явцуу зорилгоор Т.Н-д хээл хахууль өгөх санал тавьж, хээл хахууль өгсөн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг мөн байна.

Шүүгдэгч нар нь дээрх гэмт хэргүүдийг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр материаллаг ашиг хонжоо олох зорилгоор үйлджээ.

Шүүгдэгч нарын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн байдал, хувийн байдлуудыг харгалзан энэ удаад нийгмээс тусгаарлаж хорих ял оногдуулах шаардлагагүй гэж шүүх үзлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 286, 294, 295, 296, 297, 298, 299 дүгээр зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Шүүгдэгч Т.Н-ийг хээл хахууль авах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч

С.Г-г хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Т.Н-д тодорхой албан тушаал эрхлэх эрхийг нь 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 1 /нэг/ жил 6 /зургаа/ сарын хорих ял, шүүгдэгч С.Г-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жил 6 /зургаа/ сарын хорих ял тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Т.Н-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ял, шүүгдэгч С.Г-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ялыг тус тус жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

4. Шүүгдэгч нар нь энэ хэрэгт урьдчилан цагдан хоригдоогүй, тэдний иргэний бичиг баримт шүүхэд ирээгүй, энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан болон битүүмжлэгдэн ирсэн зүйлгүй болохыг тус тус дурдсугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Т.Н-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ял, шүүгдэгч С.Г-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ялыг тус тус тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзсугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт зааснаар тэнсэгдсэн ялтан Т.Н, С.Г нарт хяналт тавьж ажиллахыг ...аймгийн Цагдаагийн газарт даалгасугай.

7. Шүүгдэгч Т.Н, С.Г нар нь бусдад төлөх хохирол, төлбөргүй болохыг дурдсугай.

8. Давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд нь энэ шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхэд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг дурдсугай.

9. Давж заалдах гомдол гаргасан буюу эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелэгдэх хүртэл шүүгдэгч Т.Н, С.Г нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээсүгэй.

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгч З.Болдбаатар даргалж, шүүгч И.Ганбат, Б.Мөнхбаяр нарын бүрэлдэхүүнтэй,

Нарийн бичгийн дарга: Н.Оюунбилэг, Б.Наранцацрал,

Иргэдийн төлөөлөгч: Д.Нанжидмаа, П.Цэрэнчимэг, Л.Баянзул

Улсын яллагч: М.Гантулга, О.Гэрэл,

Шүүгдэгч Н.Хү, түүний өмгөөлөгч Д.Нямдорж, М.Баасанбат, Х.Базаррагчаа,

Шүүгдэгч М.Ху, түүний өмгөөлөгч Б.Энхзаяа, Б.Оюунбилэг, Р.Мэндсайхан,

Шүүгдэгч Д.Цэ, түүний өмгөөлөгч Д.Гансүх, М.Алтанцэцэг, Д.Цогтжаргал,

Шүүгдэгч Б.Чи, түүний өмгөөлөгч Л.Өлзийхүү, И.Отгонсүрэн, Шүүгдэгч Х.Бо, түүний өмгөөлөгч Д.Даваа,

Шүүгдэгч Ж.Сү, түүний өмгөөлөгч З.Төмөрхүү,

Шүүгдэгч М.Аб, түүний өмгөөлөгч Ц.Баасанжав,

Шүүгдэгч Б.Да, түүний өмгөөлөгч С.Дондов,

Шүүгдэгч Т.Мө, түүний өмгөөлөгч Д.Мянган, Л.Данзанноров Шүүгдэгч Б.Ат, түүний өмгөөлөгч С.Цэдэндамба,

Шүүгдэгч Д.Гэ, түүний өмгөөлөгч Ж.Энхнасан,

Хохирогчийн төлөөлөгч: А.Мэ,

Гэрч: Э.Эб, П.А, Б.Со, С.Эт, Ж.Цо нарыг оролцуулан ШШГЕГ-ын харьяа цагдан хорих 461 дүгээр ангийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Нийслэлийн прокурорын газраас Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 272 дугаар зүйлийн 272.2, 268 дугаар зүйлийн 268.2 заасан гэмт хэрэгт, М.Ху-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэрэгт, Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэрэгт, Б.Чи-ийг Эрүүгийн хуулийн тусгай

ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 270 дугаар зүйлийн 270.1-т заасан гэмт хэрэгт, Б овогт Х.Бо-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 269 дүгээр зүйлийн 269.1-т заасан гэмт хэрэгт, М.Аб-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-т заасан гэмт хэрэгт, Б.Да-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт, Т.Мө-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2-т заасан гэмт хэрэгт, Ж.Сү-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-т заасан гэмт хэрэгт, Б.Ат, Д.Гэ нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэрэгт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 20130100027. дугаартай хэргийг 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Ховд аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн захирал ажилтай, ял шийтгэлгүй /5-р хавтас х-163/, Б овогт Н.Хү /регистрийн дугаар ПЭ...../

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч ажилтай, ял шийтгэлгүй /5-р хавтас х-164/, Б овогт М.Ху /регистрийн дугаар УЕ...../

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Д.Ц /регистрийн дугаар ШГ...../,

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-нд Архангай аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл..., охины хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн мэргэжилтэн ажилтай, ял шийтгэлгүй, Т овогт Б.Чи /регистрийн дугаар ЧВ...../,

5. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч ажилтай, 2005 оны 3 дугаар сарын 11-нд Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 3-д зааснаар 2 жил хорих ялаар шийтгүүлж, уг ялыг тэнсэж 1 жилийн хугацаагаар хянан харгалзсан, Б овогт Х.Бо /регистрийн дугаар НМ ...../,

6. Монгол Улсын иргэн, 1970 оны 8 дугаар сарын 28-нд Сүхбаатар аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суудаг, Баянгол дүүргийн Татварын хэлтэст улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Я овогт Ж.Сү /регистрийн дугаар ЛБ...../,

7. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, экологич мэргэжилтэй, ам бүл ..., хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "Үндэсний Хөгжлийн Хүрээлэн"-д Хүрээлэн буй орчин бодлогын судалгааны секторын эрхлэгч ажилтай, ял шийтгэлгүй, У овогт М.Аб /регистрийн дугаар ПЭ...../

8. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газарт аудитор ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Б.Да /регистрийн дугаар ЮЮ...../,

9. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Чингэлтэй

дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суудаг, "ИТТ" ХХК-д менежер ажилтай, ял шийтгэлгүй, Г овогт Т.Мө /регистрийн дугаар СР...../,

10. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр хүүхдүүдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суудаг, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Х овогт Б.Ат /регистрийн дугаар ЦД...../,

11. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл..., нөхрийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суудаг, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Д.Гэ /регистрийн дугаар ХН...../.

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар /яллах дүгнэлтэд бичигдсэнээр /

1. Шүүгдэгч Н.Хү нь:

Чингэлтэй дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Монгол Улсын Засгийн газрын тусгай сан буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар сан"-ийн гүйцэтгэх захирлаар 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж байхдаа 2012 онд 116.000.000 төгрөгийг сургалт зохион байгуулах нэрээр "ХБ"ХХК-ийн дансаар, 21.440.000 төгрөгийг ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар, 1.454.079.500 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар, 100.000.000 төгрөгийг зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар, 2011 онд 240.000.000 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" ХХК-ийн дансаар гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан гэмт хэрэгт, мөн Н.Хү нь М.Ху, Б.Чи нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 38.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11.000.000 төгрөгийг, "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг, мөн Б.Да-ын төрсөн дүү Б.3г-ын нэрээр үүсгэн байгуулсан



"ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг тус тус авч, 1.447.671.550 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт, мөн яллагдагч Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цагаан цаасан дээр зурж үлдээснээс М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлж, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан гэмт хэрэгт,

мөн яллагдагч Н.Хү нь давтан үйлдлээр, 2011 онд ШУА-ийн Газар зүйн хүрээлэнд 76.000.000 төгрөгийн санхүүжилт бүхий Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн хөрсний бохирдолд шинжилгээ хийх ажлыг олгож уг санхүүжилтээс өөрийн үүсгэн байгуулалцсан "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөгийг, "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас 44 сая төгрөгийг нийт 53.000.000 төгрөгийн хахууль авсан гэмт хэрэгт,

2. Шүүгдэгч М.Ху нь:

"ХБ", "ОСБ", "АЖ" компаниудын гэрээг хуурамчаар үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ"ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 36.500.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.144.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 86.000.000 төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар гаргасан 429.760.000 төгрөгөөс 380.000.000 төгрөгийг,

мөн Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 771.000.000 төгрөгийг тус тус хувьдаа завшиж, улсад 1.278.644.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт,

3. Яллагдагч Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нь албан тушаалын байдлаа урвуулан, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху болон түүний найз Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар" сангаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гаргуулж, үүнээс 1.500.000.000 төгрөгийг авч хувьдаа завшсан гэмт хэрэгт,

4. Яллагдагч "Цэвэр агаар" сангийн

мэргэжилтэн Б.Чи нь "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэж "ХБ"ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг, 2011 оны 12 сарын 30-ны өдөр "ПИ"ХХК-наас буцаагдсан бэлэн мөнгө болох 21.780.000 төгрөгийг тус тус хувьдаа авч, нийт 188.280.000 төгрөг завшсан гэмт хэрэгт,

мөн яллагдагч Б.Чи нь "ХТТ" ХХК-ны захирал Т.Мө нь "Цэвэр агаар" сантай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд "Цэвэр агаар" сангийн захирал Н.Хү-д өгсөн 44.000.000 төгрөгийн хээл хахуулийг зуучилсан гэмт хэрэгт,

5. Яллагдагч "Цэвэр агаар" сангийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн захирал үүсгэн байгуулагч Х.Бо нь 2011 онд "Цэвэр агаар" сангийн нягтлан М.Ху болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сантай хуурамч гэрээг үйлдэн, байгуулж улмаар тус сангаас гаргасан 2.726.500.000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшсан гэмт хэрэгт,

мөн хуурамч бичиг баримтаар гэрээ байгуулан "Цэвэр агаар" сангаас "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө шилжүүлж авсан гэмт үйлдлээ нуун далдлах зорилгоор уг компанийг татан буулгах, татварын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрүүлэхгүй байх зорилгоор Баянгол дүүргийн татварын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт,

6. Яллагдагч М.Аб нь ШУА-ийн Газар зүйн хүрээлэнтэй түншлэлийн гэрээ хийх замаар "Цэвэр агаар" сангаас 76.000.000 төгрөгийн, мөн "Цэвэр агаар" сангаас санхүүжигдсэн гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхнүүдийг ариутгах ажлыг хийх "ИЙТ" ХХК-аас Н.Хү-ийн албан тушаалын байдлыг ашиглан мониторингын 86.400.000 төгрөгийн ажлыг, мөн "Цэвэр агаар" сантай гэрээ хийж гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур суурилуулсан ажлын үр дүнд мониторинг хийх 89.900.000 төгрөгийн ажлыг авч бусдаар хийлгүүлэн ашиг олж Н.Хү-д 9.000.000 төгрөгийн хахууль өгсөн

гэмт хэрэгт,

7. Яллагдагч Б.Да нь Үндэсний Аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудиторын албан тушаал эрхэлж байхдаа "Цэвэр агаар" сангийн 2011-2012 оны тайланд санхүүгийн Аудит хийснийхээ дараа тус сангийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэн өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн байгуулж тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч, уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт,

8. Яллагдагч "ХТТ" ХХК-ийн захирал Т.Мө нь "Цэвэр агаар" сантай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд Б.Чи-ээр дамжуулан тус сангийн захирал Н.Хү-д давтан үйлдлээр нийт 44.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт,

9. Яллагдагч Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ж.Сү нь "ШГЭБ" ХХК-ийн захирал Х.Бо-гаас 1.000.000 төгрөгийн хахуулийг түүний ашиг сонирхлын үүднээс урьдчилан амлахгүйгээр авсан гэмт хэрэгт,

10. Яллагдагч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Ат нь 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Д.Гэ-ийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт,

11. Яллагдагч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Д.Гэ нь 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Ат-гийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт тус тус холбогдоцгоожээ.

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Шүүгдэгч Н.Хү шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Энэ хэрэгт зайлшгүй тодруулах зүйлс нилээн хэд байгаа. Агаарын бохирдол бууруулах Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гарч хууль тогтоомжид өөрчлөлт орж мөн шинэ хууль батлагдсаны дагуу "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо" байгуулсан. Шаардлагатай агентлагийн дарга нараас бүрдсэн 34-35 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Үүнээс үүдээд "Цэвэр агаарын сан" 2011 онд байгуулагдсан. Бүтэц орон тооны хувьд Ерөнхий сайд баталдаг. Энэ байгууллагыг би 2 жил буюу 772 орчим хоног удирдсан. Улаанбаатар хотын захирагч "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо"-ны дэд даргаар ажилладаг. Дүүргийн дарга нар салбар хороодын даргаар ажилладаг. "Цэвэр агаарын сан"-ийн гүйцэтгэлийг үндэслэж санхүүжилтийг баталдаг. Нийт бүх дүүрэгтэй ажилладаг буюу 1 мянга гаруй ажилтантай. Түлшний ангилал салгах, түлш хүлээн авсны дараа санхүүжилт ордог. Шүүх хурал дээр би зөвхөн үнэнийг хэлнэ. Удирдах зөвлөл, Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайдаас бүрдсэн удирдах зөвлөлтэй. Удирдах зөвлөлийн дарга нар төсвийн хөрөнгийг юунд зарцуулахыг зааж өгч баталдаг. Энэ хуваарийн дагуу би санхүүжилт хийдэг. Сонгон шалгаруулалт Улаанбаатар хотод зохион байгуулагддаг. Энэ дүнг үндэслэн гэрээ байгуулж санхүүжилт хийдэг. 2011 оноос Засгийн газрын тогтоолоор энэ байгууллагыг эхнээс нь удирдаж байгууллагад хэрэгтэй бүх зүйлсийг бэлтгэсэн. Энэ ажил миний эрхэм зорилго байсан. 2011 оны 04 сард энэ ажилд томилогдсоноос хойш өөрөөсөө гадна 4 ажилтантай болсон. Нягтлан бодогч яаж авсныг яллах дүгнэлтэд зөв бичигдсэн. Засгийн газрын заавраар мэргэшсэн нягтлан бодогч ажиллуулах шаардлагатай байсан. М.Ху мэргэшсэн нягтлан бодогч байсан тул түүнийг ажилд авсан. ...Энэ хэрэг 2011 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс эхэлсэн. Нягтлан М.Ху намайг байх үед болон байхгүй үед төлбөрийн даалгаврыг ашиглаж мөнгө шилжүүлдэг байсан. Энэ хэрэг надад хамаагүй. Н.Хү захирал мэдэж байсан тул тусгайлсан данснаас мөнгө шилжүүлсэн гэж М.Ху ярьсан байдаг ч тийм боломж байхгүй. "ШГЭБ" ХХК-ийн төлбөрийн даалгавар

шалгуулахыг хүсэж байна. Болд гэдэг нэрийг нэмж бичсэн нь харагддаг. Манай байгууллагын нягтлан ажилд ороод 30 хонолгүйгээр эхний мөнгөнүүдийг гаргаж эхэлсэн. Цаг хугацааг нь харахад намайг томилолтоор явсан үед хийгдсэн гүйлгээнүүд байдаг. Нягтлан бодогч дарга хоёрын хооронд итгэлцэл явагддаг. Цалин, нийгмийн даатгал, татварт зориулж төлбөрийн даалгавар үлдээсэн. Томилолтоор явах үедээ 2-3 төлбөрийн даалгавар үлдээдэг байсан. Эдгээр нь хаана байгааг шалгуулахыг хүсэж байна. "ШГЭБ" ХХК-ийн гэрээг хуурамчаар үйлдсэн гэдэг нь Х.Бо-гийн мэдүүлгээс харагдаж байгаа. Үүнийг нотлохын тулд Хас банкны захирлыг гэрчээр оруулах гэж өмгөөлөгч маань дуудсан боловч ирсэнгүй. Хуурамчаар гэрээ үйлдсэн гэдэг нь тодорхой болох байх. Хуурамч гарын үсэг гэдэг нь криминалистикийн дүгнэлтээр тогтоогдсон. Төлбөрийн даалгавар үлдээх үедээ төлбөрийн даалгаврын доод буланд ягаан өнгийн бэхээр тусгай тэмдэглэгээ буюу 1 2 3 гэж дугаарладаг байсан. М.Ху-гийн хийсэн хуурамч төлбөрийн даалгаварт эдгээр тэмдэглэгээ байхгүй. "ШГЭБ" ХХК-д хийсэн шалгалт миний хувьд эргэлзээтэй. Үндэсний аудитын газар, улсын мэргэжлийн газруудаас нийт 300 орчим хоног шалгасан байдаг. Шалгалтын үр дүнд сэтгэл хангалуун биш байдаг. Төлбөрийн даалгаврыг хавтас хавтсаар авч явж шалгадаг байсан. Энэ үед засгийн эрх өөр намд шилжсэн тул намайг ажлаас чөлөөлөх тухай яригдсан. Шалгалтын дүнд ямар нэг байдлаар оролцоогүй. Шалгалтын эхэнд буюу төгсгөлд зохих этгээдүүдтэй нь 2 удаа уулзаж болж байгаа зүйл болон болохгүй байгаа зүйлийг хэлж танилцуулсан. Шалгалтын тайланг надад өгөөгүй. Тухайн үед шалгалтаар сайн байна, зөрчилгүй гэх дүгнэлт гаргаж өгсөн. Тухайн ондоо багтааж ажлын гүйцэтгэл хийгдээгүй ажил, томилолтын зардал илүү зарцуулсан, гадны байгууллагын зардал давсан байна гэж үзсэн. Үүнээс өөр мөнгөн хөрөнгөтэй холбоотой акт хүлээн авч байгаагүй. Цаг хугацааны хувьд өвлийн улиралд, он дамжиж хийгдэх ажил их байсан. "Цэвэр агаарын сан" байгуулагдаад 6 сар болсон байхад санхүүгийн тайланд дэндүү хайнга хандсан. Цаг хугацаа, хэргийн сэдэлт, санаа зорилго тодорхойлогдоно. Шалгалтын ажил дууссаны дараа 240 сая төгрөг "ШГД" ХХК-д шилжсэн. Энэ нь түлшний компани. "Цэвэр агаар сан" 10 компанитай гэрээ байгуулсан. Хууль ёсны

дагуу гэрээ байгуулсан байгууллагад урьдчилгаа төлбөр өгдөг. Гэрээний үүргээ биелүүлээгүй байгууллагаас урьдчилгаа төлбөрийг алдангитай нь авч байсан. Шалгалт хийсний үр дүнд "ШГД" ХХК түлшээ нийлүүлж чадаагүй тул урьдчилгаа төлбөрөө буцаан байршуулсан гэж үзэж байгаа. Энэ асуудлаар шүүх, цагдаагийн байгууллагаар шийдвэрлүүлж байсан тул урьдчилгаа төлбөр олгохоо больсон. Гэрээ байгуулдаг дарааллын хувьд аж ахуйн нэгж байгууллага эхлээд Улаанбаатар хотын захиргаагаар дараа нь "Цэвэр агаар сан"-аар гарын үсэг зурдаг. Улаанбаатар хотын захиргаа тухайн түлшийг үзэж шалгасны үндсэнд чанарыг тодорхойлж өгдөг. Нийт тэрбум төгрөгийн гэрээ байсан. Шалгалтын үетэй давхцсан тул эдгээр гэрээг хүчингүй болгосон. Түлшний нийлүүлэлт хийх боломжгүй байсан тул мэргэжлийн хяналтын дүгнэлтээр буцаан оруулсан гэж ойлгосон. Тухайн компанитай гэрээ байгуулж урьдчилгаа шилжүүлсэн ч эдгээр мөнгө буруу тийшээ явсан. Тиймээс М.Ху-гийн гэгдэх 240 сая төгрөг хаанаас "Цэвэр агаарын сан"-д орсныг дахин шалгуулах хүсэлтэй байна. Мөрдөн байцаалтын шатанд тусгайлсан сангаас орсон гэж хэлсэн. Түлш нийлүүлэх гэрээтэй холбоотой гэж үздэг. Э.Эб, н.Б, н.М нарын гарын үсэг байх ёстой боловч зөвхөн Э.Эб-ын гарын үсэг байдаг. Тиймээс Э.Эб, М.Ху нарын хооронд ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа. Түлш хүлээн авсан гэж итгүүлэх замаар хуурамч бичиг баримт бүрдүүлж удирдлагадаа итгүүлж М.Ху 2 тэрбум төгрөг авч идсэн байх. Ийм хэмжээний мөнгө авсан хүн байрны зээлээ төлөөгүй байх боломжгүй. 240 сая төгрөгийн төлбөрийн даалгавар хаанаас орж ирснийг шалгуулна гэж бодож байна. Зайлшгүй төлбөрийн өр, авлага байсан тул оны эцэст төлбөр хийгдсэн байна гэж эдийн засагч хүний хувьд бодсон. Шалгалт дууссаны дараа буюу 2012 оны 4, 5 дугаар сард "ХБ" ХХК болон "ОСБ" ХХК-ийн данс руу мөнгө орсон байдаг. Эдгээр байгууллагаар дамжуулан мөнгө гаргаж авсан гэх үйлдлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Ямар байдлаар энэ дүнг гаргасныг мэдэхгүй. Б.Чи энэ хэрэгт ямар ч хамаагүй. Хавтаст хэрэгт авагдсан баримтыг үзэхэд гэрээг М.Ху хуурамчаар хийсэн байдаг. Үүнд миний гарын үсэг байхгүй. Төлбөрийн даалгавруудыг ихэвчлэн 10 цагт хийсэн байдаг. М.Ху-д гэрээ байгуулах эрх байхгүй. "ХБ" ХХК болон

"ОСБ" ХХК нь М.Ху-гийн ах, дүү нарын компани байсныг хавтаст хэрэгтэй танилцах үед мэдсэн. Ямар шалтгаанаар зөвхөн түүний ах, дүү нарын компанийн дансаар мөнгө дамжиж байсан нь сонин. Энэ бол түүний сонирхол байсан нь харагдана. Ямар байдлаар тамга дарагдсан нь их хачирхалтай. Намайг яг хуралтай, ажилтай үед яаруу, сандруу байдлаар олон баримтад гарын үзэг зуруулдаг. Тэр үед та гарын үсэг зур би тамга даръя гэдэг байсан. Намар 9-10 сард дээврээс ус алдаж байгаа байх гэж бодож ажил дээр ирэхэд өрөө онгорхой байсан тул анхааралдаа авч хаалганы түлхүүр шинээр солиулсан. Нэг түлхүүр нь санхүүгийн хүнд байдаг байх. М.Ху өөрийн "ХБ" ХХК болон "ОСБ" ХХК-тай өөрөө гэрээ байгуулж мөнгө шилжүүлж авсан байх. 5 дахь өдөр төлбөрийн даалгавар бичүүлж авсан ч Сангийн яамны гүйлгээ хаагдсан байна гэж хэлээд дараагийн өдөр дахин бичүүлж авдаг байсан. Тиймээс эдгээр гүйлгээнүүд дахин дахин хийгдсэн байх талтай. Өөр 23 сая төгрөгийн гүйцэтгэл санхүүгийн шилжүүлэх баримтад хавсаргагдсан байх ёстой. М.Ху хуурамч бичиг баримт хавсаргах тал дээр гаршсан. Сангийн яамны төлбөрийн даалгавар 3 хоног хүчинтэй байдаг тиймээс заримдаа хүчингүй болох тал байдаг. Нягтлан хүн үнэн зөв тайлан гаргах үүрэгтэй ч М.Ху удаа дараа хуурамч тайлан гаргаж өгч байсан. М.Ху нь миний гарын үсэгтэй төлбөрийн даалгаврыг ашиглаж "ДЗТМ" ХХК-ийн дансанд 100 сая төгрөг шилжүүлсэн гэж бодож байгаа. Энэ компанитай хийсэн гэрээ манай байгууллагын гэрээний маягт биш. "ХБ" ХХК болон "ОСБ" ХХК-тай байгуулсан гэрээ ч манай байгууллагын гэрээний маягт биш. Энэ бол М.Ху-гийн хийсэн гэрээ буюу тэрээр гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг. Манай байгууллага Агаарын бохирдлыг бууруулах хороотой нэгдэж Монгол Улсын бүх радио, телевизээр зар сурталчилгаа явуулах ёстой байсан. Энэ асуудлаар "ДЗТМ" ХХК-тай холбогдохдоо гурвалсан гэрээ хийсэн. Энэ гэрээг Байгаль орчин аялал жуулчлалын яамны сурталчилгааны 30 сая төгрөгийн зардал гэж М.Ху танилцуулсан. Төсөв хэтэрсэн байсан тул холбогдох хүмүүстэй нь уулзаад 15 сая төгрөгөөр баталсан. Үүний дараа 45 сая төгрөг "ДЗТМ" ХХК-ийн данс руу шилжсэн байдаг. 15 сая төгрөгөөс өөр мөнгөний шилжүүлэг хийгээгүй, хэрэв байгаа бол үүнийг М.Ху надаас нууж гүйцэтгэсэн байх.

М.Ху төлбөрийн даалгаврыг бөөн бөөнөөр хийсэн байдаг. Б.Да М.Ху-д мөнгө өгсөн ч М.Ху надад мөнгө өгсөн зүйлгүй. Драмьн театрын үүдэнд мөнгө өгсөн гэх М.Ху-гийн мэдүүлэг гэрч нарын мэдүүлгээс өдөр шөнө шиг ялгаатай. М.Ху энэ компани руу мөнгийг шилжүүлэх үед Г.Ши гэдэг хүн харж байсан гэж мэдүүлсэн байдаг. Би тэр хүнийг хараагүй, танихгүй. Үүнийг М.Ху-тай тооцох асуудал гэж хэлснээр тооцооноос хассан. Манай нягтлангийн үйлдэл арга нь тамга тэмдэг ашигласны дараа дахин мөнгө өгнө гэж итгүүлдэг. Компанийн дансаар гаргаж авсан мөнгөө захиралд өгч байна гэж итгүүлдэг. Би өөрөө эдгээр хүмүүстэй уулзах байсан, бидний дунд худал хэлдэг байсан. "Т" ХХК 1.5 тэрбум төгрөгийн үртсэн шахмал түлш нийлүүлсэн. Захирал Ж.Цо М.Ху-д бүх мөнгө шилжүүлсэн гэх боловч би мөнгө авч байгаагүй. Тиймээс энэ компанийг шалгуулах хүсэлтэй байна. 9-12 сар хүртэл түлшний нөөц бүрдүүлэх ажил хийгддэг. Нөөцийг 100 хувь бүрдүүлэхийн тулд 100 орчим тонн түлш хэрэгтэй. Тиймээс олон байгууллага оролцуул гэдэг байсан. Мөрдөн байцаалтын шатанд "Т" ХХК-тай холбоотой нэг ч байцаалт аваагүй. Байцаалт аваагүй хирнээ яллаж болох эсэхийг би мэдэхгүй байна. Би өөрөө "Т" ХХК-тай ямар холбоотой юм бэ гэж мөрдөн байцаагчаас асууж байсан. Мөрдөн байцаалтын шатанд хэт нэг талын барьж ажиллагаа явуулсан. Нотлох баримтыг бүрдүүлэн түүнд үндэслэх ёстой. Ажил авсан байгууллагад санхүүжилт шилжүүлэх үүрэгтэй. Ажил авсны дараа бүх аж ахуйн нэгжтэй уулзсан. Манай байгууллагаас ямар нэг чирэгдэл байхгүй гэж хэлсэн. Сангийн яам яахыг бид мэдэхгүй, хурлын тэмдэглэл байх ёстой. Түлш хэрэглэдэг оргил цагт мөнгө шилжүүлсэн байдаг. Яагаад 7-9 сард шилжүүлэг хийгдээгүйг гайхаж байна. Санхүүжилтийн үнийн дүн 100 сая төгрөгөөс дээш бол би мэдэх ёстой. Тиймээс бутархай мөнгөн тоо ашиглаж мөнгө шилжүүлсэн байдаг. Санхүүжилт авахдаа бүрдүүлсэн материалыг заавал шалгуулахыг хүсэж байна. Энэ материалд М.Ху болон Х.Бо-гийн гарын үсэг байгаа байх. Нийт 10 орчим гүйлгээ байгаа. Үүнээс 3 гүйлгээ нь долоо хоногийн лхагва гаригт хийгдсэн байсан. Энэ өдөр миний машин явдаггүй өдөр. 2 гүйлгээг намайг томилолтоор явсан байхад хийсэн байдаг нь асуудалтай. Тиймээс яагаад намайг яллаж байгааг ойлгохгүй байна. Эдгээр мөнгө хаана байгааг АТГазар шалгаж

байгаа байх. Гэрч Ж.Цо-ын өгсөн мэдүүлгүүд зөрүүтэй байдаг. Дансаар орж ирсэн мөнгийг авсны дараа буцааж ямар машинтай хүнд өгөхийг М.Ху утсаар мэдэгдэж байсан гэдэг. Мөнгө шилжүүлсэн өдрийн гар утасны ярианы бичлэгийг шалгуулахыг хүсэж байна. Энэ асуудлыг тухайн үед мөрдөн байцаагчид хэлэхэд маш хүнд ажиллагаа болно гэх хариу өгсөн. Тиймээс М.Ху, Ж.Цо хоёрыг шалгуулахыг хүсэж байна. Улаанбаатарын хотын захирагчийн албаны урд машин тавьсны дараа дахин дахин орж, гарах нь хүндрэлтэй. Би машинаар бараг яваад байдаггүй. Машинаа зэрэгцүүлж тавьдаг нотариатч эмэгтэй ч үүнийг батална. Зогсоолын харуул намайг хэдэн цагт явж хэдэн цагт ирдгийг мэднэ. Ж.Цо-тай 2 удаа санамсаргүй байдлаар тааралдаж байсан. М.Ху тамга ашиглаж хүмүүсийг өөр хооронд нь ашигладаг. Түүний авсан мөнгийг цаг хугацааны хувьд графикаар гаргаж өгч болно. Намайг саатуулагдах үед АТГазар хураан авсан. Ж.Цо-ын утасны дугаар ч надад байхгүй, харин М.Ху-гийн утсанд байгаа байх. Үүнийг шалгасан байх. "Т" ХХК-ийн төлбөрийн даалгаврыг шалгахад 52 сая төгрөг шилжсэн байсан, энэ нь хэрэгт байхгүй. /хавтастай баримт улсын яллагчид өгөв/ Хулгай хийсэн хүнийг харсан хүн хамжигч болдог. Ж.Цо-ыг шалгаагүйд гайхаж байна. Түүнийг хясан боож дарамталж байгаагүй гэж тэрээр мэдүүлсэн. Түүнтэй хувийн өс хонзон байхгүй. М.Ху-гийн ах, дүү нар зочид буудал барьсан байна. Хөрөнгө оруулалт хаанаас гарсныг шалгах ёстой. Барилгын бүтээн байгуулалт болон М.Ху-гийн мөнгө авсан цаг хугацаа таарч байгаа. Түүний ах, дүү нарын бүрдүүлж өгсөн баримтыг хүчин төгөлдөр бус гэж үзэж байгаа. 1800 орчим м2 зочид буудал барьсан. Үүнд 2.7 орчим тэрбум төгрөг зарцуулсан байх магадлалтай. М.Ху-тай өс хонзон байхгүй мөн түүнийг дарамталсан зүйлгүй. Түүнийг ийм үйлдэл хийсэнд харамсаж байна. Намайг гүтгэхэд миний улс төрийн карьер хаагдсан. Үүнд гомдолтой байна. Түүний ах, дүү нарын эзэмшлийн 7-8 жип машин, 92 ширхэг брэндийн гутал, 300 сая төгрөгийн эзэмж, бөгж, барьж байгаа гар утасны хамгийн доод үнэ нь 15-45 сая төгрөг байдаг мөн түүний эдэлж хэрэглэж байгаа зүйлс нь 1 тэрбум 500 сая төгрөг болох байх. Намайг албан тушаалдаа хайнга хандсан гэдэгт тодорхой зүйл сонсох байх. Зайлшгүй гарын үсэг зурахаас өөр аргагүй байдалд

хүргэж намайг татан оруулсан. Намайг байсан ч байгаагүй ч намайг ашигладаг байсан. Нийт 600 орчим хоног М.Ху жүжигчилсэн тоглолтондоо худал мэдүүлэг өгсөн. Яавал "М"ХХК-ийн хэргийн хүмүүст хувааж ногдуулах вэ гэх аргыг М.Ху судалсан гэж би сонсож байсан." гэв.

Шүүгдэгч М.Ху шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Хийсэн хэрэгтээ чин санаанаасаа гэмшиж байна. Н.Хү-ийн мэдүүлгийг нотлох баримтаар няцаана. Д.Цэ, Б.Чи, Н.Хү нарыг гүтгээгүй. Шинжээчийн дүгнэлтээр миний мэдүүлэг батлагдсан гэж үзэж байна. "ХБ" ХХК, "ОСБ" ХХК, "АЖ", "ШГД" ХХК, "ШГЭБ" ХХК, "Т" ХХК, "ДЗТМ" ХХК-ийн нийт 11 гэрээ, 30 төлбөрийн даалгавар, 29 нэхэмжлэлд нийт 70 гарын үсэг, тамганы хаагуур нь Н.Хү өнгөрсөн бэ? Сангийн яамнаас "Цэвэр агаар" сангийн төлбөрийн хуулгыг интернэтээр харах хүсэлт явуулсны үндсэнд нууц дугаартай факс ирсэн. Үүнийг Н.Хү өөрөө хувилж өгсөн. Ингэснээр "Цэвэр агаар" сангийн орлого, зарлага хянах эрхтэй болж эдгээр орлогын хуулбарууд Н.Хү-ийн өрөөнөөс хураагдсан. "ШГЭБ" ХХК-ийн дансанд шилжсэн мөнгөний баримтын гарын үсгийг шинжлүүлмээр байна гэхэд энэ баримт Н.Хү-ийн өрөөнөөс хураагдсан. М.Ху бичигдсэн төлбөрийн даалгаварт нэг орон тоо нэмж бичсэн байсан гэх Н.Хү-ийн мэдүүлгийг үгүйсгэж байна. Төлбөрийн даалгаварт мөнгөн дүнг үсгээр бичдэг. "ХБ" ХХК, "ОСБ" ХХК-тай гэрээ хийж мөнгө шилжүүлсэн. Энэ гэрээний маягыг манай байгууллагын гэрээний загвар биш гэж Н.Хү хэлсэн. "ПИ" ХХК-тай зар сурталчилгааны гэрээ хийсэн гэрээний загвараар эдгээр гэрээнүүдийг хийсэн. Аудитын шалгалтын өмнө "хоолны мөнгө гэж их мөнгө гаргаж болохгүй байна. Тиймээс зар сурталчилгааны зардал болгоод гаргуулчих" гэж байсан. Б.Чи-ийн өгсөн гэрээний загварын дагуу хийж байсан. Б.Чи, хуульч Б.Со, М.Ху бид дөрөв "ХБ" ХХК-ийн дансанд шилжүүлсэн мөнгөөр Сингапур улсад 2 хоног амарсан. Энэ нь мөрдөн байцаалтын шатанд тогтоогдсон. Ард иргэдээс авсан нүүрсний татаасны мөнгө дутсан тул намайг тооллогод явуулсан. Дансны аргаар "ХБ" ХХК руу 50.000.000 төгрөг шилжүүл гэж хэлээд Н.Хү 30.000.000 төгрөгийг нь авсан би 15.000.000 төгрөгийг нь авсан. Намайг ганцаараа бүгдийг хийсэн гэх мэдүүлгийг үгүйсгэж байна. "ШГЭБ" компанийн дансанд 465.500.000 төгрөг шилжүүлээд буцааж "Цэвэр агаар" сангийн

дансанд авсныг Н.Хү өөрөө мэдэж байсан. Би өөрийн гарын үсэгтэй хуулгыг түүнд оруулж өгсөн. "Сонгууль болж байна мөнгө хийнэ" гэж хэлж байсан. /хх 183-189, 192-198/ Санхүүжилт олгоход эхлээд захиалагч дараа нь нийлүүлэгч, санхүүжүүлэгч байгууллага, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гарын үсэг зурж тамга дардаг боловч байгуулсан гэрээнд захиалагч болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гарын үсэг зураагүй. Тиймээс хүчин төгөлдөр бус гэрээнд тамга дарсан нь харагдаж байгаа. Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа баталгааждаг. Гэрээ хүчин төгөлдөр болоогүй байхад урьдчилгаа төлбөрийн баталгаа болгож 100.000.000 төгрөг шилжүүлсэн. Засаг дарга батлаагүй байхад Н.Хү баталсан. Хэнээр ч хамаагүй гарын үсэг зуруулдаг байсан. Хоосон тамга ч дардаг байсан. Намайг худлаа гүтгэж байна. Энэ хүний зааснаар би хийсэн. н.Баа нь Б.Чи, Н.Хү нарын ах, дүү "Цэвэр агаар" сангийн удирдах зөвлөлийн 2012 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 2 дахь хурлын /9-193хх/ тэмдэглэлээр Б.Чи-ийг үндсэн ажилтан байсан нь батлагдана. Энэ тэмдэглэлийн 5 дахь хуудсанд байгаа баримтаар батлагдана. Энэ хүнийг авч болохгүй ашиг сонирхлын зөрчилтэй гэж цаад газраас мэдэгдэхэд авсан. Б.Чи-ийг ажилд ороход Н.Хү-ийн нөлөө орсон. Төслийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчин авч ажиллуулах гэрээ байдаг. Гэрээний 3.2.2-т заасныг хуурамчаар нэмсэн. Үсгийн фонд нь ч өөр байгаа мөн 6.2.29-т заасан заалтыг ч мөн хуурамчаар нэмж оруулсан. Би өөрийн хийсэн хэргийг хамгаалах гэж оролдоогүй, Н.Хү-тэй адил үгсэн хуйвалдсан. Хүчин төгөлдөр бус гэрээ батлуулсан. Үүнийг Н.Хү өөрөө удирдаж хийсэн. 2012 оны 05 дугаар сард "АЖ" компани руу 420.000.000 төгрөг шилжүүлсэн. Б.Чи гэрээг хийж өгнө гэж хэлсэн боловч хийгээгүй. Энэ мөнгөнөөс би 80.000.000 төгрөг авсан Н.Хү 300.000.000 төгрөгийг нь авсан. "ШГД" ХХК-ийн данс руу 12 дугаар сарын 28-нд мөнгө шилжүүлсэн. Энэ мөнгөнөөс 130.000.000 төгрөгийг Н.Хү өөрөө ирнэ гэж хэлээд Б.Чи-д өгсөн. "ХБ" ХХК-ийн дансанд шилжсэн 50.000.000 төгрөгийг "Б.Чи-д мэдэгдэхгүйгээр ч 15.000.000 төгрөгийг ав. Надад 30.000.000 төгрөгийг нь өгчих, 5.000.000 төгрөгийг нь үлдээгээрэй" гэж Н.Хү хэлсэн. 117.000.000 төгрөгөөс Н.Хү 8.000.000 төгрөг, Б.Чи-д 31.500.000 төгрөг, татварт 10 хувийг үлдээсэн, надад 36.500.000 төгрөг өгсөн.

Үүнээс Б.Со-гийн Сингапур явсан 5.000.000 төгрөг надад бичигдсэн. "ДЗТМ" ХХК-руу 4 удаа мөнгө шилжүүлсэн. Үүнээс 2013 оны эхээр 30.000.000 төгрөгийн нэхэмжлэхийг 15.000.000 төгрөг болгон бичүүлсэн. 20.000.000, 45.000.000, 20.000.000 төгрөгийг удаа дараа шилжүүлсэн. Би Б.Да-т хэлсэн байгаа гэж хэлсэн, тэгээд Б.Да-аар дамжуулж 95.200.000 төгрөг Н.Хү өөрөө авсан. "ОСБ" ХХК-ийн данс руу 21.440.000 төгрөг цай, хоолны мөнгө, зар сурталчилгааны зардал гэж шилжүүлсэн. "ПИ" ХХК-ийн дансанд орсон мөнгийг Б.Чи мэднэ. Өөрөө хүлээн зөвшөөрөхгүй болохоор нь баримт үзүүлдэг. Тэр үед энэ мөнгийг Н.Хү-д өгсөн гэж хэлдэг. Манай өрөө салаа утастай, Б.Чи-ийн яриаг сонсоход хэд хэдэн компани руу мөнгө шилжүүлсэн "20 хувийг нь авчирч өг, үгүй бол гэрээг чинь цуцална" гэдэг байсан. Зөвхөн Т.Мө-ыг Б.Чи дарамталж байгаагүй. Ямар ч сонгон шалгалтгүйгээр оруулсан тэгээд хүнийг байж боломгүй байдлаар дарамталдаг. Т.Мө-ыг хясан боогдуулж 47.000.000 төгрөг авсан. 20.000-ын төгрөгийн дэвсгэртээр өгч байсан. Би утсаар ярьж байхыг нь сонссон. Хэргийг анхнаас нь үнэн байдлаар ярьж байна гэв.

Шүүгдэгч Д.Цэ шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд санхүүгийн хэлтсийн даргаар ажиллаж байсан. Яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн дагуу намайг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж "ШГЭБ" ХХК-ийг Х.Бо, М.Ху нартай үгсэн тохирч үүсгэн байгуулж уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээ үйлдэж 2.726.500.000 төгрөгийг гаргуулж, үүнээсээ 1.500.000.000 төгрөгийг хувьдаа завшсан гэсэн үндэслэлээр ялласан. Албан тушаалаа урвуулан ашиглах боломж надад байгаагүй. Яагаад гэвэл угаасаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд сан нь өөрөө удирдах зөвлөлтэй, удирдах зөвлөл нь сангаа удирддаг. Удирдах зөвлөлд би ордоггүй. Удирдах зөвлөлөөс гаргаж байгаа шийдвэрт бас нөлөөлдөггүй. Дараагийн үйлдэл бол намайг компани байгуулсан гээд байгаа юм. Би "ШГЭБ" ХХК гэж байдгийг огт мэдэхгүй. Байгуулсан хүн нь Х.Бо, түүний өөрийнх нь мэдүүлгээр нотлогдоно. Хавтаст хэрэгт байгаа нотлох баримтуудаар хангалттай нотлогдох байх. Дараагийн нэг заалт нь хуурамч гэрээ байгуулсан гэсэн. Хуурамч гэрээ байгуулсныг би огт мэдэхгүй. Гэрээнд гарын үсэг зураад тамга дарсан гэсэн.

Гэрээний талаар болон компани байгуулсныг би мэдэхгүй. 2.726.500.000 төгрөгийг гаргуулсан гэсэн байна. Надад шийдвэр гаргах ямар ч эрх зүйн үндэс байхгүй. Сангийн яам нь төрийн сан руу гүйлгээ хийхдээ тушаал, шийдвэр зэрэг бүх юмыг нь хянаж гүйлгээ хийдэг. Гүйлгээ хийхэд миний оролцоо гэж ерөөсөө байхгүй. Энэ нь төрийн сангийн гүйлгээ хийсэн мэргэжилтэн А.С-гийн мэдүүлгээр нотлогдоно. 1.500.000.000 төгрөгийг хувьдаа завшсан гэсэн. Би 1.500.000.000 төгрөгийг хувьдаа завшсан зүйл огт гаргаагүй. М.Ху, Х.Бо хоёр яагаад өөрсдийнхөө хийсэн хэргийг намайг хийсэн мэтээр мэдүүлэг өгч гүтгэж байгааг би ойлгохгүй байна. Хавтаст хэрэгтэй танилцаж байхад М.Ху-гийн мэдүүлэг хоорондоо их зөрүүтэй байдаг. Намайг 850.000.000 төгрөгийг шалгалтыг аргалах гэж авчирч өгсөн гэдэг. Би тэр их мөнгийг яаж М.Ху-гаас авсан байх уу. М.Ху намайг мөнгө аваад ир гэхээр авчраад өгөх ямар үндэслэл байдаг юм бэ. 2014 оны санхүүгийн тайланд улсын аудитын газраас Г.Дж, мэргэжлийн хяналтын газраас Б.Ат, Д.Гэ нар шалгалт хийсэн. 850.000.000 төгрөгийг шалгалтыг аргалах гээд өгсөн эсэхийг үнэнээр нь хэлээд өгнө. Дахиад 650.000.000 төгрөг авсан гэж байна. 650.000.000 төгрөгийг яаж авсан байх уу. Ямар зарцуулалт хийх үү. Би М.Ху-г 1995 оноос хойш танина. Би нефть концернд ажилладаг байсан. Тэгэхэд М.Ху Багахангай, Дарханы салбарт ажиллаж байсан. Ер нь бол М.Ху хүнд тусархуу сайн эмэгтэй гэж тухайн үедээ дүгнэж байсан. Ах, дүү нараараа баян чинээлэг, баян компанитай, алтны уурхайтай, нөхөр нь алтны уурхайтай, эгч нар нь дэлгүүр ажиллуулдаг ер нь л баян чинээлэг, мөнгөнд умбасан тийм л амьдралтай байсан. Миний амьдралыг М.Ху маш сайн мэддэг байсан. Дүү нарын маань амьдралыг бас мэддэг байсан. Яллах дүгнэлт уншиж байхад Г.Хб-ын мэдүүлэгт наадмаар манай зусланд Д.Цэ нэг найзтайгаа ирсэн гэсэн байна. Би тэдний зусланд М.Ху-тай хамт очсон. Тэр үед М.Ху анх Г.Хб-ыг харсан. Г.Хб АНУ явна гэж байсан. Лексус машин ашигтай 2 сая болно гэж бодсон. Машин зарна гэхэд 7 дугаар сарын 16-нд 16 сая төгрөг өгсөн. Машин үзсэн. Яг ижил машин авсан. Үнэ нилээн буулгаад АНУ явах тухай ярьж байгаад М.Ху-гийн виз гараагүй. Н.Эб эхнэртэй хамт явах гэж байгаад миний бие өвдсөн тул яваагүй. Н.Эб-ад мөнгөө зээлүүлсэн 170 сая төгрөг. М.Ху Оюу толгойд

газ нийлүүлэх ажил ашигтай гэсэн. Надаас мөнгө зээлж байрны гэрээ хий гэсэн. Байр авч зараад эргээд М.Ху-д өгөх боломжтой машины мөнгө хийнэ гэж бодсон. Найзын хувьд холбогдсон. Ажил хэргээр уулзаагүй. М.Ху Х.Бо-д сарын дараа "М"-ын хүмүүсийн хэргээр Д.Цэ-д тохно гэж ярьж байсан гэсэн. Намайг гүтгэнэ гэж би бодоогүй. Намайг дарга гэж хэлж байгаагүй. Би удирдан зохион байгуулж байгаагүй. М.Ху, Х.Бо нар өөрсдийн авсан мөнгийг надад тохож байгааг гайхаж байна. Анхнаасаа энэ сангаас мөнгө авах талаар тохирсон байх. Цэвэр агаар санд оруулна гэж хэлээгүй яаманд оруулна гэж сайдад хэлсэн. М.Ху надад ажил захисан байсан. Сайдад танилцуулсан 2 хүний нэгийг нь ав гэсэн. М.Ху программ сайн мэддэг байсан. М.Ху Сандаг-Очироор яриулаад санд орохоор болсон. н.Ган сайдын туслах над руу М.Ху гэж ямар хүн байна гэж ярьсан. Н.Хү даргыг таньдаггүй байсан. Ажилд оруулсны шан харамж хүсээгүй. Х.Бо-тай би үгсэн тохироогүй. Би удирдах ажлыг 16 жил хийсэн. Нэг удаа ч буруу зүйл хийж зөрчил гаргаж байгаагүй гэв.

Шүүгдэгч Б.Чи шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би дандаа гадны байгууллагуудад ажиллаж байгаад яг "Цэвэр агаар" санд үндсэн ажилтнаар 2013 оноос ажиллаж эхэлсэн. Тэрнээс өмнө би гадны хөрөнгө оруулалттай байгууллагуудад донор төсөл дээр цалингаа аваад ажиллаж байсан. Миний хувьд үгсэн тохиролцож мөнгө идэх шаардлага байхгүй. Би 2013 оны 02 сар хүртэл би Англи улсын иргэн Р.В гэдэг хүнтэй амьдарч байсан. Миний охиныг М.В гэдэг. Анх мөрдөн байцаалтад ч хүртэл хэлж байсан. Та нар намайг мөнгө авсан гээд гүтгээд байх юмаа. Миний дансны гүйлгээг аваад үзээчээ. Худалдаа хөгжлийн банкны 40403xxxx данс байгаа. Үүнийг харахад бараг наян хувь нь миний гарын үсгээр гардаг мөнгө байгаа. Би тэр мөнгийг л ашигладаг. Тэрнээс биш "Цэвэр агаар" санд гэрээ хийдэг Б.Со гээд хуульч байхад би дундуур нь орж гэрээ байгуулах хүн биш. Би гэрээ байгуулах хуулийн мэргэжилтэй ч хүн биш. Би тэр гэрээг хараа ч үгүй. Харин М.Ху-гийн яриад байгаа тэр "ПИ" ХХК-ийн зочид буудлын гэрээг харсан. М.Ху өөрөө гарын үсэг зураад тамга дарсан гэрээ байна лээ. Би тэр гэрээг хавтаст хэрэгтэй танилцаж байхдаа үзсэн. Миний нэг сул тал гэвэл би тэр мөнгийг очоод авсан. Очиж авчраад буцаагаад зарцуулах юмандаа зарцуулсан учраас

тайлан тооцоог нь хийсэн. "ОСБ" ХХК-аас 31.500.000 төгрөгийг авсан гэж мэдүүлсэн байна лээ. Би ийм мөнгө аваагүй. "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг өгсөн гэж байна. 2011 онд би "Цэвэр агаар" санд байгаагүй. ...Олон хүний мэдүүлгээр Б.Чи, М.Ху хоёр таарамж муутай хүмүүс гэж мэдүүлсэн байдаг. Надтай таарамж муутай хүн өнөөдөр зуу, зуун саяар нь надад мөнгө өгөх үү. Хэрвээ би авчихсан бол М.Ху-тай илүү найрсаг харилцаад явах байсан байх. ...М.Ху дээр бүх гэрээ хэлэлцээр байдаг, би тэр хүнээс бол ямар нэг байдлаар, төслийн ажилчид бол гэрээ хийсэн компаниудын гүйцэтгэлийг шалгадаг, тэр гүйцэтгэлийг нь шалгахын тулд гэрээнийх нь ядаж барааг нь хараад би юугаа шалгаад байна гэдгээ мэдэх ёстой шүү дээ. Би тэр гэрээнийх нь гүйцэтгэлийн бид нар юу харах вэ, юу үзэх вэ гэдгийг мэдэхгүйгээр бид юу ч хийж чадахгүй. Тэгээд гэрээний эхийг авъя гээд утасдахаар чи миний цагийг бүртгэлээ, шалгалаа, чи хэн юм, чи юу юм гэдэг. Мэдүүлгүүд дээр нь тэр 240.000.000 төгрөгийн 130.000.000 төгрөгийг авсан гэдэг. Өөрөө ч түрүүн хэлж байна. "Дүү Б.Хз-оос авч Б.Чи-ийн гэрт нь аваачиж өгсөн" гэж байна. Дүү Б.Хз нь 2013 оны 07 дугаар сарын 09-ний мэдүүлэгтээ байцаагчийн асуултад "та М.Ху-тай хэн нэгнийд хамт очиж мөнгө хүргэж өгч байсан юм биш үү" гэхэд "тийм зүйл огт байхгүй. Би банкнаас мөнгөө аваад М.Ху эгчийн гэрт нь өөрөө хүргэж өгч байсан." гэж мэдүүлсэн. М.Ху-гийн хамт аваачиж өгсөн гээд байгаа хүн нь хүртэл тэр чинь худлаа би тэр айлд очоогүй гэж байна. Н.Хү захиралд өгнө гээд мөнгө авсан гэж байна. Хоорондоо таарамжгүй хүмүүс Н.Хү захирал мөнгө аваад ир гэхээр нь мөнгө аваачиж өгчихдөг хүн чинь энийг Н.Хү захиралд өг гээд надад мөнгө өгөх ямар ч шаардлага байхгүй гэж бодож байна. Үүнийг би надад хуучин хорсож байсан хорслоосоо болоод ингэж хэлж байна гэж бодож байна. Сингапур явсан тухай ярьж байна. Сингапур явсан. Би угаасаа бие муутай, тийм болохоор эмчилгээ хийлгэх гэж гадаадын улс орнуудад байнга очдог. Гэхдээ би хэн нэгнээс мөнгө авч, хахууль авч явдаггүй. Өөрийнхөө нөхрийн мөнгөөр явж байсан. Сингапурт хоёр хонохдоо би өглөө нь гараад явдаг байсан. М.Ху, Б.Со хоёр өрөөндөө үлддэг байсан. Би өөрөө эмнэлэг явчхаад үдээс хойш л бие биенийгээ хардаг байсан. Тэр хоёр хоногт эмчилгээ хийлгэж, шинжилгээ өгөхдөө сангаас мөнгө

аваагүй. Надад мөнгө авах шаардлага ч байхгүй. "ХБ" ХХК-аас Мөнхзоригт 3.500.000 төгрөг өгсөн нэг болохоор 5.000.000 төгрөг өгсөн гэж зөрүүтэй ярьдаг. Худлаа ярьж байгаа болохоор хэлж байгаа мөнгө нь бүгд зөрүүтэй байгаа байх. М.Ху-гийн мэдүүлэгт бүх мөнгөн дүн зөрүүтэй байдаг. Би "ХТТ" ХХК-ийн сүүлд хэрэгжсэн хоёр төсөл дээр ахалж ажилласан. Хоёр хүнийг жолооч гэж оруулж ирсэн. Тэр хоёр хүнийг төслөөс цалинжуулсан. Сүүлийн хэдэн сар манай нөхөр унааны зардлыг төлсөн. Бид нар өөрсдөө хувийн машин ч байхгүй. Надад өнөөдөр том жип машин байтугай жижиг тэрэг нь ч байхгүй. ..."АЖ" компанийн гэрээг хуурамчаар үйлдсэн гэж байна. Би анх "АЖ" компанийн талаар н.Бо байцаагчийн амнаас сонссон. М.Ху тэгсэн чинь намайг гэрээг нь хийсэн гэж хэлсэн байсан. Би ямар ч гэрээ хийгээгүй. Үнэхээр гэрээ хийсэн бол ямар гэрээ, юуны гэрээ, юунд зарцуулсан талаар гарын үсэг нь хаана байна. Сангийн яам мэдээж гэрээний нэг хувийг авч үлддэг байх. Эсвэл компани дээр нь энэ гэрээ нь байдаг байх. Тэр компаниас гэрээг нь авч үзэж, үнэхээр би тэр гэрээг хийсэн бол тэр гэрээг нь шалгуулмаар байна. Ажлынхаа цагаар хуульчийнхаа хажуугаар ороод гэрээ хийж байх эдийн засагч хүн гэж ч байхгүй. Т.Мө-аас 44.000.000 төгрөг авсан гэж байна. М.Ху утсаар ярьж байхыг нь сонссон гэж байна. Өөрөө магадгүй эсвэл утсаар хүмүүстэй тэгж ярьдаг байсан байх. ...Миний биеийн байдлаас болоод ойрхон, ойрхон гадагшаа явах шаардлагатай болсон. Би Т.Мө-аас 24.000.000 төгрөгийг зээлээр 20.000.000, 4.000.000 авч баримттайгаар 24.000.000 төгрөгийг авсан гэж гарын үсэг зураад 19.000.000 төгрөгөөр 5.000.000 төгрөгөөр авсан мөнгөө буцааж өгсөн. Буцааж өгөхдөө би бас гарын үсэгтэй баримт авсан. Тэр хоёр баримт надад хэрэг болохгүй учраас Т.Мө-д өөрт нь байсан. Би мэдүүлэг өгөхдөө ч Т.Мө-д тэр баримт устгаагүй бол эх хувиараа байгаа гэж дандаа хэлж байсан. Т.Мө гаргаж өгсөн байсан. Түүнээс биш утсаар дарамтлаад чиний гэрээг цуцлуулна барина энээ тэрээ гэсэн зүйл байхгүй. Эдний гэрээ чинь 2012 оны эхээр хийгдсэн гэрээ. Би Т.Мө-аас бүр сүүлд 7-8 сард мөнгө зээлж авсан. Нэгэнт "Цэвэр агаар" санд хийгдчихсэн гэрээг би дураараа ороод цуцлаад, хүн айлгаж сүрдүүлээд, дарамтлаад байх бодол угаасаа байхгүй. Харин энэ гэрээний гүйцэтгэл дээр төслийнхөн бусад мэргэжлийн багтай



хамтарч Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн агаарын чанарын алба, нийслэлийн эрүүл мэндийн газар гэсэн газруудтай хамтарч шалгалтуудыг хийсэн. Энэ үнэхээр хүний биед хор нөлөөгүй юу, үүнийг хотод ашиглаж болох уу, аюул нь хэр юм бэ гэдгийг тал талын байгууллагуудаар шалгалт хийлгэсэн. Тэглээ гээд Т.Мө-аас нэг удаа ч болов чи намайг хоолонд оруул гэж асууж үзээгүй. Би шалгалтаар явахдаа энэ хүнийг ч авч явж байгаагүй. Би ирсэн хүмүүстэйгээ хагас, бүтэн сайнд өглөөнөөс орой хүртэл гэр хорооллын айлуудын хаалгыг нүдээд зогсдог байсан. Г.Бс ахын 2013 оны 08 дугаар сарын 16-ны мэдүүлэг дээр байж байгаа. М.Ху, Б.Чи хоорондоо маш таарамжгүй хүмүүс хуурамч гэрээ төлбөрийн баримтыг Н.Хү захиралд оруулж өгснөөс хойш энэ яриа үүссэн гэж. Н.Хү захирлыг санаандгүй гарын үсэг зурчхаар нь та юун дээр гарын үсэг зурчих ваа гэж би оруулж баримтыг нь өгч байсан. Үүнээс болж М.Ху намайг мөнгө идэхэд нь саад болох хүн гэж байнга харддаг байсан. Баримт дунд хуурамч гэрээ, төлбөрийн даалгавар авч орж гарын үсэг зуруулах гэж байгаад баригдсан гэж ярьж байсан. Тэрнээс би хараагүй гэж мэдүүлсэн байдаг. Сая ийм асуудал боллоо гэж хэлээд л би гарсан. Хэрвээ М.Ху үнэн яриад байгаа юм бол надад өгсөн гээд байгаа 130.000.000 төгрөгөөр нь би ядаж машин аваад уначих байсан. Би дөчин мянгатад амьдарч байгаа хоёр өрөө байраа томруулчих байсан. Би арван хэдэн жил тэр байрандаа амьдарч байна. Гэрээ хэлцэл хийсэн л гэж байна. М.Ху-гийн яриад байгаа гэрээ хэлэлцээрийг би хийгээгүй. Б.Чи, М.Ху хоёр маш таарамжгүй хүмүүс гэдгийг олон хүн хэлнэ, мэдүүлгээс ч уншиж болно. Яллах дүгнэлт дээр яагаад зөвхөн нэг талыг барьж ялласныг би үнэхээр гайхаж байна. Шүүх, тэр тусмаа прокурорын байгууллага тал талаас нь үзэж, үнэн зөвийг нь тогтоож байж ялынхаа дүгнэлтийг бэлддэг болов уу гэж бодож байсан. Тэгсэн чинь зүгээр М.Ху-гийн мэдүүлгээр намайг ялласан. Гэрээ хэлэлцээр хийлээ, мөнгө зарцууллаа гэж байна. Яг ямар гэрээ хэлэлцээрийг хаана хийгээд юунд зарцуулсныг би тогтоолгомоор байна. Үнэхээр би мөнгө аваагүй байж авсан мэтээр өнөөдөр энд шүүгдэгчийн суудалд суумааргүй байна. Би маш их гомдолтой байна. Ийм учраас би үнэн зөвийг нь шалгуулмаар байна. Үнэн зөвөөр нь нотолж

өгөх байх гэж итгэж байна гэв.

Шүүгдэгч Х.Бо шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би Дарханаас 2013 оны 04 дүгээр сарын 05-нд хотод шилжиж орж ирсэн. Тэгээд би 05 сарын сүүлээр М.Ху-тай уулзаад би ажилгүй байна надад ажил олж өгөөчээ гэж хэлсэн. Найз нь дэлгүүр ажиллуулдаг юм билүү, эсвэл нэг жижиг компани байгуулдаг юм билүү гэхэд М.Ху компани байгуулах чинь их зүгээр юм байна. Найз нь чамд ажил олж өгье. Манай төслийн мөнгөнөөс ажил хийгдээгүй гээд мөнгө буцаагдах учраас компанийн чинь данснаас гаргая гэсэн. Тэгээд 2011 оны 06 дугаар сард компаниа байгуулсан. Анх 2013 оны 06 дугаар сарын 30-нд 350.000.000 төгрөг манай дансанд орж ирсэн. 2011 оны 06 дугаар сараас 2011 оны 12 сар хүртэл 5 удаа нийт 2.260.000.000 төгрөгийг, 2012 оны 02 сард 1.980.000.000 төгрөгийг гаргасан. 2013 оны 04 сард 466.000.000 төгрөгийг компанийн дансаар гаргасан. 2,7 тэрбумаас 2011 оны 7 дугаар сарын 1-нд, 2011 оны 07 дугаар сарын 10-нд, 2011 оны 7 дугаар сарын 15-нд, 2011 оны 09 дүгээр сарын 16-нд 4 удаа 280.000.000, 180.000.000, 50.000.000, 158.000.000, 608.000.000 төгрөгийг хүмүүсийн данс руу шилжүүлсэн. 2013 оны 01 дүгээр сарын 03-нд орсон 456.000.000 төгрөгөөс би өөрийнхөө Хаан банкны данс руу 419.000.000 төгрөгийг шилжүүлээд тэрийгээ эргүүлээд "Цэвэр агаар" сангийн данс руу компанийн нэрээр шилжүүлсэн. 2012 оны 02 сард оруулсан 1.980.000.000 төгрөгийг тэр өдөр нь Цэвэр агаар санд буцаагаад хийсэн. Энэ мөнгийг болохоор төсвийн хэмнэлтээс орж ирсэн мөнгө гэсэн. Бусад үлдсэн 1.600.000.000 төгрөгийг бол тухайн үед мөнгө орж ирсний дараахан М.Ху чиний дансанд мөнгө орчихсон шүү гэж хэлээд авчраад өгчхөөрэй гэдэг байсан. Мөнгийг би М.Ху-гийн гэрт нь аваачиж өгдөг байсан. Д.Цэ даргынх М.Ху-гийн дээд давхарт байдаг байсан. Д.Цэ дарга энэ талаар мэдэж байгаа гэж байсан. Би дарга цэргүүд нь мэдэж байгаа юм чинь гайгүй байх гэж бодоод дансаар орж ирсэн мөнгийг нь аваачиж өгдөг байсан. 2012 оны 02 сард 60.000.000 төгрөг авсан. Би үүнийг Д.Цэ дарга зохион байгуулж байгаа гэж мэдэж байсан. Бид хэд М.Ху-гийн гэрт уулзалдаж байсан. Намайг М.Ху-гийн гэрт очиход М.Ху дээшээ мөнгөө оруулж өгдөг байсан. Би ийм хэрэг хийсэндээ харамсаж байна. Өөрийнхөө хариуцаж төлөх мөнгийг төлж барагдуулна. Ж.Сү-гийн талаар бол

Ж.Сү бид хоёр найзууд байсан. Дотуур байранд хамт амьдарч байсан. Сургууль төгссөнөөсөө хойш уулзаагүй байж байгаад 2013 оны хавар би Ж.Сү-г татварын албанд ажилд орсныг сонсоод утсаар ярьж байгаад уулзсан. Тэрнээс хойш хоёр, гурван удаа компанийнхаа талаар очихдоо Ж.Сү-тэй тааралдаж уулзаж байсан. Би компани татан буулгах гээд Баянгол дүүргийн татварын хэлтэст өргөдөл өгсөн. Энэ талаараа Ж.Сү-тэй уулзаж зөвлөгөө авсан. Ж.Сү надаас мөнгө зээлээч гэхээр нь эхлээд 500.000 дараа нь 500.000 төгрөгийг өгсөн. Би өөрөө хэрэгт татагдахаасаа илүү Ж.Сү-г энэ хэрэгт татсандаа харамсаж байна. Яагаад гэвэл Ж.Сү өрх гэр толгойлсон. Өвчтэй хүүхэдтэй. Би уг нь Ж.Сү-д тус больё гэж бодсон чинь ус болчихсон. Энэ хүнийг ийм байдалд оруулсандаа харамсаж байна. Ж.Сү-д би тус больё гэж мөнгө өгсөн болохоос биш тэрнийхээ төлөө ямар нэг хариу авах гээгүй. Шалгалтыг аргалуулъя гэж бодоогүй. Эгчийн үүднээс тусалъя гэж бодсон гэв.

Шүүгдэгч М.Аб шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...намайг Н.Хү-д авлига өгсөн гээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-ээр буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Яагаад зөвшөөрөхгүй байгаагаа тайлбарлая. Үүнийг тайлбарлахын тулд эхлээд "ЭАИ" компани хэзээ байгуулагдсан талаар тайлбар өгөх хэрэгтэй байх. "ЭАИ" компанийг анх Н.Хү ахтай хамтарч байгуулсан түүхээс нь товчхон тайлбар хэлье. Би Байгаль орчин, ногоон хөгжлийн санд өнгөрсөн арван жил судалгаа хийж байгаа хүн. Судалгаа хийснийхээ үндсэн дээр судалгааны үнэлгээний байгаль орчны нөхөн сэргээлтийн компани байгуулъя гэсэн бодолтой болсон. Тэгээд ганц хоёр санаа нэгтэй судлаач залуучууд хамтраад байгуулах гээд явж байхдаа Н.Хү ахтай уулзсан. Н.Хү ахтай би 2010 онд Засгийн газрын ордонд уулзсан байгаа. Тэгэхэд "Цэвэр агаар" сан гэж байгуулагдаагүй байсан. Н.Хү ах шадар сайдын ахлах зөвлөхийн албан тушаалд байсан. Тэгээд би Н.Хү ахтай яриад манай нутгийн ах, таньдаг ах гээд би нэг иймэрхүү компани байгуулах саналтай байна. Та бидэнтэй нэгдээч гэхэд Н.Хү ах дэмжсэн. Тэгээд энэ компанийг гурван хүн байгуулсан. Тэгээд энэ компаниа байгуулаад нэгэнт л байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм чинь ямар нэг байдлаар тендер, төсөл, судалгааны ажил хийх шаардлагатай

болсон. Энэ компанийн бүх баримт бичиг байгаа. Энэ компани бол анхнаасаа Н.Хү ахын нэрийг барьж "Цэвэр агаар" сангаас ямар нэг байдлаар мөнгө завших гэсэн зорилгоор анхнаасаа байгуулагдаагүй юм гэдгийг хэлмээр байна. Манай компани бол зөвхөн энэ гурван ажлаар үйл ажиллагаа нь хязгаарлагдахгүй. Манай компани болон "Цэвэр агаар" сантай холбоотой гурван ажил байгаа. Яллах дүгнэлтэд болохоор энэ гурван ажлыг нийт дүнгээр нь бичээд гурвууланг нь завшчихсан юм шиг ойлголтоор биччихсэн байсан. Үүнтэй санал нийлэхгүй. Үүнийгээ тайлбарлая. Ямар гурван ажил вэ гэхээр гэр хорооллын жорлон, муу усны нүхийг ариутгадаг компани үүсгэж тэрний хойноос бид хөндлөнгийн мониторинг хийж жорлон муу усны нүх рүү асгаж байгаа бодис нь үнэхээр тэрийг задалж чадаж байна уу гэдэг дээр эрдэмтдийн баг бүрдэж хөндлөнгийн мониторинг хийх ажил байсан. Хоёр дахь ажил нь бол нийт гэр хорооллын 300 айл өрхүүдэд халаагуур суурилуулсан. Тэр халаагуур нь хүний эрүүл мэндэд хортой байна уу үгүй юу гэдгийг манай компани бас хөндлөнгийн мониторинг хийж дүгнэлт гаргаж байсан. Гурав дахь ажил нь бол Нийслэлийн хөрсний бохирдолтой холбоотой ШУА-ын Газар зүйн хүрээлэнтэй хамтарч түншлэлийн баг байгуулж, түншлэлийн гэрээ хийж, тендерт орж өрсөлдөж энэ ажлыг авсан. Яг энэ ажлыг авах гээд тендерт орж өрсөлдөхөд бас МУИС-ийн газар зүйн сургууль бас хөрсний бүтцийн судалгаа хийдэг гэдгээрээ оролцож байсан. Өөрөөр хэлбэл, энэ гурван ажил гурвуулаа тусгай зөвшөөрөлтэй, мэргэжлийн аж ахуйн нэгжүүдэд тендерийг сониноор зарлаж, зарынх нь дагуу оролцож авч байсан ийм ажлууд байсан юм. ...Жишээ нь том аж ахуйн нэгжүүд тендер авахаараа өөр нэг аж ахуйн нэгжийг татаж авчирч хийлгэдэг. Бид тийм юм хийгээгүй. Бид бол өөрсдөө биечлэн эрдэмтдийн багийг компани дээрээ бүрдүүлээд, менежментийг нь өөрсдөө гаргаад, өөрсдөө бүх зохион байгуулалтыг нь хийсэн ажил. Жорлон, муу усны нүхний судалгааны ажил бол нийт Улаанбаатар хотын 500 орчим жорлонгоор бид явсан. Тусгай хувцас өмсөөд, тусгай дээж авдаг багажаар жорлонгийн гүнээс, дээрээс нь дээж авч явсан. Энд маш их зардал гарсан. Унаа, бензин, дээжийн тоног төхөөрөмжийн, тэгээд лабораторийн дээр нь бил энэ ажлуудыг хийхийн тулд зөвхөн манай компанийн чадавх, эрдэмтдийн

баг хүрэлцэхгүй байсан. Тэгээд бид ямар арга хэмжээ авсан бэ гэхээр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас мэргэжлийн шинжээч, Нийслэлийн агаарын чанарын албанаас мэргэжлийн шинжээч, ЭМЯ-ны харьяа нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс мэргэжлийн эрдэмтдийн багийг бүрдүүлээд дээр нь манай эрдэмтдийн судалгааны баг хамтраад нийтдээ хоёр удаагийн давталтаар 25-30 орчим эрдэмтдийн баг бүрдүүлж судалгааны ажлыг бүгдийг нь хийж гүйцэтгэсэн. Энэ хүмүүстэй бүгдтэй нь хөлсөөр ажиллах гэрээ хийн цалин хөлсийг нь цаг тухайд нь тавьж ингэж хийсэн ажил. Ингээд бүх тайлангаа гаргаж холбогдох төрийн байгууллагад нь өгсөн. Энэ ажлуудыг хийхэд ямар, ямар тодорхой зардал гаргаж байсныг дурдах шаардлагатай гэж бодож байна. Яагаад гэвэл миний саяны дурдсан 25-30 орчим эрдэмтдийн баг дээр нь бид Мэргэжлийн хяналтын газарт жижиг агаарын тоосжилтыг хэмждэг Тесто-340 гэдэг багажийг 30 сая төгрөгөөр авч өгч байсан. Дээр нь 500 айл, өрхөөр явахад унааны хөлс, машины зардал маш их гарсан. Дээр нь багажийн зардал гээд их зардал гарч байсан. Бид боломжийн төвшинд энэ ажлыг хийсэн. Ингээд АТГ-ын захиалгаар Баянгол дүүргийн татварын хэлтсээс манай компанид шалгалт орсон. Шалгалт ороод шалгалтаар юу гарч ирсэн бэ гэхээр бид бүх баримтууд, анхан шатны бүх баримтаа гаргаж өгсөн. Ингэж гаргаж өгөөд Баянгол дүүргийн татварын хэлтсийн 2013 оны 09 дүгээр сарын 05-ны 263963 тоот актаар манай компанид нийт 3 орчим сая төгрөгийн торгууль ногдуулж, түүний алданги гээд нийтдээ 5,1 сая төгрөгийн акт үйлдсэн. Энэ мөнгийг бол манай компани төлсөн. Энэ 5,1 сая төгрөгийн акт нь ямар акт вэ гэхээр бид 500 гаруй айл өрхийн жорлонгоос дээж авахдаа машин хөлсөлж явсан. Хөлсний мөнгөө өгөхдөө дундын суутгал болон арван хувийг улсад тушаах ёстой байсан юм байна лээ. Энийг бол тэр болгон бид тушааж чадаагүй. Тэр 5,1 сая төгрөгийн акт нь ийм учиртай. Ингээд нийт баримт Өөрөөр хэлбэл, Цэвэр агаар сантай холбоотой бүх мөнгөн дүн, бидний төсөл, судалгаагаа хийж гаргаж ирсэн мөнгөн дүнтэй яг таарч байхад би хаанаасаа Н.Хү-д 9.000.000 төгрөгийг хахууль өгөх вэ?, энэ ямар ч боломжгүй зүйл. Манай компани тодорхой хэмжээнд ашигтай ажилласан гэдгийг би нуухгүй. Хэдэн төгрөгийн ашигтай ажилласан нь санхүүгийн тайланд байгаа.

Энэ тайлан хэргийн материалд байгаа байх. Н.Хү манай компанийн хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдээ бид хувьцааны ашиг гэж өгдөг болохоос биш авлига гэж өгдөггүй. Гэхдээ би компаниа ашигтай ажиллавал хувьцааны ашиг гэж Н.Хү-д өгнө гэж боддог байсан. Гэхдээ өгөөгүй. Яагаад өгч чадаагүй гэхээр манай компани байгуулагдаад ерөөсөө гурван жил болж байсан. Яаж нэг энэ компаниа цааш нь нэр хүндтэй, авсан тендер төслөө чанартай гүйцэтгэж, дараагийн тендерээ авах уу гэж боддог. Манай энэ байгаль орчны салбар чинь ашиг гэж овоолсон их юм гардаггүй гэдгийг манай байгаль орчны салбарынхан бүгд мэднэ. Гэхдээ бид олсон ашгаа юунд зарцуулсан бэ гэхээр компанийн интернэт, вэб сайт хийлгэсэн, ажилчдын сарын цалин, тендерийн материал худалдаж авах зардал, компанид байдаг өдөр тутмын зардалд олсон ашгаа зарцуулъя гээд хувьцаа эзэмшигчидтэйгээ яриад тохирчихсон байсан. Энэ байдлаараа олсон ашгаа зарцуулсан. Н.Хү-д авлига байдлаар өгсөн мөнгө байхгүй. Анхан шатны баримтууд хоёр талаасаа бүгд тулчихсан байгаа. Шалгалт орсны дараа АТГ-т дуудагдаж очиход намайг хоёр зүйл ангиар зүйлчилсэн. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, болон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269-өөр зүйлчилсэн байсан. Анх байцаалт өгөхөд их балмагдаж байсан. Тэгээд прокурорын газрын 484 тоот тогтоолоор манай компанийн хийсэн гурван ажлыг бодит хохиролгүй гэж үзээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-ын хэрэгсэхгүй болгосон гэдгийг хэлмээр байна гэв.

Шүүгдэгч Б.Да шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би 2011-2012 онд 2 жил дараалан "Цэвэр агаар" санд аудит хийсэн. Энэ нь бол Үндэсний Аудитын газрын төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил. 2 жил дараалан хийхдээ 2 дарга солигдсон. 2011 онд 2 зөвлөмж өгсөн. 2012 онд 4 зөвлөмж өгсөн. 11 тэрбум төгрөгийг тусгай данснаасаа төрийн сан руу тат гэсэн зөвлөмж өгсөн. Мөн 62 сая төгрөгийн автомашин худалдаж авсан байсан. Санхүүгийн тайландаа тусгасан мөртлөө төрийн өмчийн хороонд гаргаагүй байсан. Энэ мэт жижиг зөрчлүүд гарсан. 2011 ондоо 11 тэрбум төгрөгийн зөрчил, 2012 ондоо 102 сая төгрөгийн түлш дутуу нийлүүлснийг татан төвлөрүүлсэн. Мөн замын зардал, томилолтын зардал хэтэрсэн

байсныг тус тус татан төвлөрүүлсэн. Яллах дүгнэлтэд бичигдсэн зүйлийн тухайд реклам, зар сурталчилгааны ажил байна гэж Н.Хү хэлсний дагуу манай компанид 100 сая төгрөгийн 4 удаагийн гүйлгээ орж ирсэн. 4 удаагийн гүйлгээг тухай бүрт нь би нягтланд нь аваачиж өгсөн. 95.2 сая төгрөгийг нягтланд аваачиж өгөөд 4.8 сая төгрөгийг татварт тушаасан. Гэтэл яллах дүгнэлтэд 5.2 сая төгрөгийг хувьдаа завшсан гээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-аар зүйлчилсэн. Мөрдөн байцаалтын явцад мэдүүлэгтээ 5.2 сая төгрөг авсан гээд хэлчихсэн. Миний хувьд бусдын эд хөрөнгийг үрэгдүүлсэн, хохироосон, завшсан зүйл байхгүй. Үүнийг хуулийн байгууллага маань үнэн зөвөөр нь тогтоож өгнө үү гэж хүсмээр байна." гэв.

Шүүгдэгч Т.Мө шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...ХТТ" компани нь Цэвэр агаар сангаас санхүүжүүлж байсан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилготой утаагүй зуух буюу Нийслэлийн захирагчийн албаны "Цэвэр агаар" сангаас зарлагдсан утаа бууруулах ажилд оролцсон. 6-7 компани тухайн үедээ оролцож байсан. МСМ, ЮГ, ДВ, Аг зэрэг компаниуд оролцсон. Мэргэжлийн байгууллагаар компанийнхаа тоног төхөөрөмжийг шалгуулаад энэ байгууллагын дүгнэлтээр ямар байгууллагыг сонгохоо шийднэ гэсэн. Сонгон шалгаруулалтын хувьд бүх зүйл хуулийн дагуу явагдсан. Ингээд сонгон шалгаруулалтын журмаар бид шалгарч бүх зүйлийг хуулийн дагуу энэ ажлыг хийхээр болсон. Эхний санхүүжилт орж ирсний дараа мөнгө төгрөгийн асуудал яригдсан зүйл байгаа. Үүнийг би өмнөх мэдүүлэгтээ ч хэлж байсан. Би энэ "Цэвэр агаар" санд ажиллаж байгаа хүмүүстэй ямар нэг садан төрлийн холбоо байхгүй. Тухайн ажлыг авахдаа хуулийн дагуу авсан. Ажлын явцад, ажлаа эхлээд явж байхдаа эхний санхүүжилтийн дараа Б.Чи надаас 20 сая төгрөг нэхсэн зүйл бий. Үүнийг би мөрдөн байцаалтын явцад хэлж байсан. Үнэхээр надад ажил аваад авлига өгөөд ашиг ольё гэсэн зүйл байгаагүй. Санхүүжилт нь орчихсон учраас надаас мөнгө асуусан асуудал бий. Би удаа дараа хойш нь тавьж надад боломж байхгүй ээ, надад ашиг гараагүй гэж хэлсэн. Тэгээд байнгын ажилтай байсан учраас, байнга зөвлөгөө авч байсан учраас надад буцааж өгөөрэй гээд мөнгө зээлүүлсэн. Нийслэлийн гэр хорооллын 500 ширхэг

зуухыг туршилтын журмаар суурилуулах, агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос явуулсан ажил байгаа. Компанийн зүгээс хийсэн ажилдаа зуун хувь итгэлтэй байсан. Яагаад гэвэл манай компани маш сайн тоног төхөөрөмжтэй, компанийн зүгээс маш сайн суурилуулсан учраас гэрээ цуцлуулах зүйл бүрдээгүй. Ажил гүйцэтгэх явцад монгол хүмүүс өвчин зовлонгоо ярина, манай хүүхэд таван настай байхдаа сахарын өвчтэй болсон гэж хэлж байсан. Өөрөө ч надад өвчнийхөө тухай яриад надад мөнгөний хэрэгцээ байна удаахгүй өгнө гээд мөнгө гуйсан. Тухайн үед надад тодорхой хэмжээний санхүүжилт орж ирсэн байсан. 9 сард охиноо аваад Солонгос улс руу эмчилгээнд явах гээд мөнгөтэй байсан. Тэгээд 9 сараас өмнө өгөөрэй гээд 24.0 сая төгрөг өгсөн. Үүнийгээ би баримт үйлдэж буцааж авсан. Мөрдөн байцаалтын шатанд яагаад энэ баримт гарч ирээгүй вэ гэхээр АТГ-аас намайг 8 дугаар сарын 7-ны өдөр байцаалт авна гэж дуудаад гэрчээр мэдүүлэг авна, та бичиг баримтаа авчирч үзүүл гэсэн. Тэгээд гэрчээр мэдүүлэг авч байснаа сүүлдээ байцаалт болж хувирсан. Дараагийн байцаалтад би асуух ёстой, чи хариулах ёстой гэдэг байр сууринаас байцаасан. Дараагийн байцаалтад энэ зээл байсан юм аа энэ асуудлыг яагаад ингэж тавиад байгаа би баримтыг нь үзүүлье гэсэн чинь тийм юм байхгүй ээ. Тэгвэл чамайг хорино гээд би хоригдсон. Хоригдох хугацаандаа тэр баримтыг гаргаж өгөх боломж байгаагүй. Над дээр хүн ирээгүй. Намайг батлан даалтад гаргаж өгөөч ээ гэсэн хүсэлтээ бичгээр тавьж байсан. Ийм л процесс болсон. 24.0 сая төгрөгийг зээлүүлээд буцааж авсан. Баримтаа мөрдөн байцаалтын шатанд өгсөн. Өмнө нь өгсөн 20.0 сая төгрөгөө буцааж авч чадаагүй. Нэлээн олон удаа нэхэж, гуйж явж байсан. Байнга эдний байгууллага дээр очих шаардлага байгаагүй. Эхний шатны ажил одоо хүртэл дуусаагүй. Улирлын чанартай учир зуны цагт зогсдог. Мөнгөө нэхэж очсоныг М.Ху эгч, Б.Со эгч хэлэх байх. Ийм л асуудал миний хувьд болсон" гэв.

Шүүгдэгч Ж.Сү шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...намайг эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлээр ялласныг хүлээн зөвшөөрөхгүй байгааг тайлбарлая. Энд байгаа хүмүүсээс Х.Бо эгчийг би танина. Анх 1988-1990 онд оюутны байранд хамт нэг өрөөнд дөрвүүлээ амьдарч байсан. Би төрсөн эгч шигээ ханддаг байсан. Надад

ч бас төрсөн дүү шигээ ханддаг байсан. 1990 онд сургууль төгсөөд нутаг нутаг руугаа яваад 23 жилийн дараа уулзсан. Анх уулзахдаа Х.Бо эгч "чамайг энд ажилладгийг мэдээд эгч нь ирлээ. Эгч нь танай энд нэг компанитай юмаа. Тэрнийхээ тайланг хоцроочихсон байна" гээд 4 дүгээр сарын 27-нд ирсэн. Би одоо яг сайн санаж байна. "Хоцроочихсон чинь миний тайланг авахгүй байна яах уу" гэсэн. Тэгээд би гарц нь ийм байдаг юм "төрийн санд эхлээд баланс аа өг, баланс гарсны дараа манайх татварын тайлан авна, төрийн сан өөрөө захиргааны хариуцлага хүлээлгэчихдэг, тэнд хариуцлага хүлээсэн тохиолдолд, манайх хариуцлага хүлээлгэхгүй" гэж хэлсэн. Тэгээд 7 хоногийн дараа "эгч нь компаниа татан буулгахаар болчихлоо чамаас очиж зөвлөгөө авъя" гэж ярьсан. Тэгээд ирэхээр нь би компанийн регистрийн дугаараар программ руу орж харахад тодорхой хэмжээний орлоготой, татвараа цаг тухайд нь төлчихсөн, татварын ямар нэг тооцоогүй цэвэрхэн компани байсан. Би "Х.Бо эгчээ таны энэ компани чинь татан буулгахад асуудалгүй компани байна шүү дээ" гэж хэлсэн. Тэгэхэд би ажилдаа ороод хоёр сар орчим болж байсан. Тэгээд 2-3 хоногийн дараа нэг цэгийн үйлчилгээн дээр Х.Бо эгчтэй таарсан. "Та энд юу хийж байгаа юм бэ" гэхэд "манай компанийг НӨАТ төлөгч бол гэж байна одоо яах вэ" гэсэн. Тэгэхээр нь "НӨАТ хариуцдаг хүн нь 11 дүгээр цонхон дээр байгаа тэнд очиж уулз" гэсэн. Тэгээд хэд хоногийн дараа над руу залгаад "би нөгөө татан буулгах баримт бичгийн жагсаалтаа очиж бичиж авахаас, чи өрөөндөө байх юм уу" гэж ярьсан. Би "өглөө 7.30-аас 5 цаг хүртэл байна. Хамгийн гол нь би 5 цагт гарч явдаг шүү" гэж хэлсэн. Тэгээд 3 цаг өнгөрч байхад над дээр ирсэн. Та тэнд байгаа материалын жагсаалтыг одоо бичээд авчих. Тэгээд би татан буулгах талаар зөвлөгөө өгсөн. Би тэр үед 2 жил гэртээ суучихсан байсан. Өвлийн гуталтай явж байсан. Дүнжингаравт явж байхад надад таарах гутал таарсан. Би өөрөө 41 размерийн гутал өмсдөг. 50 хувь хямдарчихсан байсан гэж худалдагч нь над руу залгасан. Тэгээд би Х.Бо эгч дээр халгаж халгаж очсон. Би өөрөө Х.Бо эгчээс айдаг байсан. Намайг анх очиход Х.Бо эгч 2-3 жил ажилчихсан компанийн санхүүг барьдаг. Би өөрөө орой кино үзэхдээ зөвшөөрөл авдаг байсан. Тэгээд би Х.Бо эгчээ дүүд нь ингээд мөнгөний хэрэг гарчихлаа гэсэн. Надад тэр үед гутал авах

шаардлага байсан мөн миний хүүхэд зүрхний өвчтэй ДОХ-той хүмүүсийн хэрэглээд байдаг 150.000 төгрөгийн үнэтэй тариаг сар болгон авч хийлгэдэг. Өмнөх сарын тариаг очиж авах гэсэн чинь 7 хоног тасарчихсан байсан. Тэгээд би нэг мөр авчихъя гэж бодоод "Х.Бо эгчээ дүүдээ 1.0 сая төгрөг зээлчих ээ, дүүд нь мөнгөний хэрэг гараад байна. Би удаахгүй өгнө" гээд авсан. "Өө тийм үү тэгвэл энэ мөнгийг гялс очоод дансаар чинь хийчихье" гэсэн. Тэгээд би хамт ажилладаг хүндээ хэлсэн. Би хурдан Дүнжингарав руу гутлаа авчхаад, хүүхдийнхээ тариаг аваад 5 цагт хүрээд ирнэ гээд ажлаасаа 3 өнгөрч байхад гарсан. Тэгээд би гутал, тариагаа авсан. Би Х.Бо эгчид удаахгүй мөнгийг нь өгнө гэж бодож байсан. Тэрнээс хойш Х.Бо эгчтэй уулзаагүй. Тэгж байгаад Х.Бо эгч нэг залгасан. "Эгч нь татан буугдах хүсэлтээ өгчихсөн. Одоо хүртэл таг чиг болчихлоо чи эгчдээ туслаач" гэхээр нь "дүүд нь туслах боломж байхгүй ээ, татан буулгах хүсэлт хэлтсийн дарга нараар цохилт хийгддэг юм аа. Дүү нь тусалж чадахгүй" гэдгээ хэлсэн. Тэгээд би 6 сард 1.0 сая төгрөгийг нь бэлэн болгочихоод Х.Бо эгч рүү залгахад утас нь холбогдохгүй байсан. 27-нд залгаснаа би байцаагчид үзүүлж байсан. Тэгээд байж байтал АТГ-аас намайг 7 дугаар сарын 2-нд сэжигтнээр дуудсан. Тэгээд юу болсныг тэнд очоод мэдсэн. Х.Бо эгчийг "Цэвэр агаар" санд ажилладгийг тэнд очоод байцаагчаас мэдсэн. Одоо тэр 1.0 сая төгрөг чинь байгаа биз гэхээр нь би байгаа гэсэн. Авсан мөнгөө өгье гэхэд мөрдөн байцаалтын шатанд мөнгө өгөлцөж, авалцахгүй чи Х.Бо-тай уулзаад өг гэсэн. Би төрд 23 жил ажилласан. Үүнээс 18 жил удирдах ажил хийж байсан. Би худлаа ярихгүй. Тэгээд би мөнгө зээлсэн нь үнэн авсан нь үнэн болохоор би асуудал үүсгээгүй. Тэгээд би Х.Бо эгчтэй тааралдаад мөнгийг нь өгч, өгсөн авсан гэж гарын үсэг зурсан. Ийм л юм болсон." гэв.

Шүүгдэгч Б.Ат шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би 20 гаруй жил санхүүгийн хяналт шалгалт хийж байгаа. Намайг "Цэвэр агаар" санд хяналт шалгалт хийхдээ ажилдаа хайнга хандсан гэж ялласан. 2012 оны 02 дугаар сараас 3 сар хүртэл шалгалт хийсэн. 2011 оноос хойш орлого зарлагыг нь шалгаад үзэхэд 12 компанитай холбоотой 11 тэрбум 212 сая төгрөг илэрсэн. Тэгээд бид энэ зөрчлийг нь шалгуулсан. Тэгээд бид 5 компани 1.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх шаардлагатай гэж дүгнэлт

гаргасан. Нэг компани байна гэж ойлгоод Цэвэр агаар сангаас гарсан бүх мөнгийг нэгтгэж, тооцоог хийхэд тооцоо таарч болж байсан. 1.898.000.000 төгрөгийг илрүүлсэн. Эргэн төлөгдөөгүй байсан 260 сая төгрөгийг илрүүлсэн. Маргаантай байгаа 560 сая төгрөгийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх гээд шилжүүлсэн. Улсын төсвийн хөрөнгийг шамшигдуулсан их хэмжээний мөнгийг илрүүлсэн. Өөрийн үүрэгт ажлаа сайн хийсэн гэж үзэж байна." гэв.

Шүүгдэгч Д.Гэ шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: "...Би мэргэжлийн хяналтын газар 14 жил ажиллаж байна. 2011 оны 2 дугаар сард МХЕГ-ын даргын удирдамжийн дагуу 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй шалгалт хийсэн. Төлөвлөгөөтэй шалгалт байгаагүй, тухайн үед миний бие муу байсан. Тэгээд гэрээний дагуу олгосон санхүүжилтийг манай нөгөө байцаагч үзэж байсан. Би бусад зүйлийг нь шалгаж байсан. Би шалгалтын тэмдэглэл болон тэмдэглэлийг дагаж гардаг актад миний гарын үсэг байсан болохоор би байцаалт өгөхөөс татгалзаагүй. Би албан үүрэгтээ хайнга хандсан гэх яллах дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байна. 2,2 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлсэн. Тухайн үед цэвэр агаар сангийн тусгай дансанд байсан мөнгийг бид илрүүлж, төсвийн дансанд төвлөрүүлсэн. Тухайн үед Цэвэр агаар санд хийсэн шалгалтын дүн одоо хүртэл шийдвэрлэгдээгүй байгаа. Бид шалгалтын дүнгээ удирдах байгууллагадаа тайлагнаж, шалгуулдаг. Бидний шалгалтын тэмдэглэл 3 дугаар сарын 5-нд үйлдэгдсэн. Бид шалгалтаа удирдамжид заасан хугацаанд хийсэн гэж үзэж байна. Энэ шалгалтын үр дүнг зөвшөөрч Н.Хү, нягтлан М.Ху нар гарын үсэг зурсан. Нэг актад л тайлбартай гэсэн байсан. Улсын төсвөөс авсан санхүүжилтийг бүрэн шалгаж, зөрчлийг илрүүлсэн гэж үзэж байна. Бид ажилдаа хайнга хандаагүй. Бидний гол алдаа бол "ШГЭ" ХХК болон "ШГЭБ" ХХК-ийг нэг компани гэж ойлгосон явдал байсан. Учир нь "ШГЭ" ХХК-ийн захирлыг Болд гэдэг байсан. Тэгээд захирлын нэрийг ард нь биччихсэн байна гэж бодоод шалгалтаа хийсэн. Энэ үйлдэлдээ харамсаж байна." гэв.

Хохирогчийн төлөөлөгч А.Мэ шүүх хуралдаанд: "...Мөрдөн байцаалтын явцад тогтоогдсон 5.1 тэрбум төгрөгийг Н.Хү, Б.Чи, М.Ху, Д.Цэ, Х.Бо нараас нэхэмжилж байна. Татвар төлөгдсөн мөнгийг давхар нэхэмжлэх ёстой. Хохирлыг Сангийн яам нэхэмжилж

байна гэв.

Гэрч Э.Эб мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн агаарын чанарын албаны бодлого хэрэгжилт төлөвлөлтийн хэлтсийн түлшний бодлогын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн/ "...Цэвэр агаар сан" бол Агаарын бохирдолтой холбоотой төсөл ажлуудыг санхүүжүүлэгч байгууллага юм. Энэ төсөл ажлыг Агаарын бохирдол бууруулах үндэсний хорооноосоо тогтоолоороо батлаад гаргаад өгчихдөг юм. Энэ тогтоол дээрээ ямар ямар ажлыг аль байгууллага нэгж хийх вэ гэдгийг нь заагаад өгчихдөг. Тэр дагуу л хариуцсан байгууллага нэгж тухайн ажлыг зохион байгуулна. Нийслэлийн агаарын чанарын албаны хувьд Нийслэлийн хэмжээнд бүрэн шаталттай сайжруулсан зуухны баталгаажуулалтыг манай алба хийдэг тодруулж хэлбэл. Иргэдэд тухайн зуух бүрэн хүрч ашиглагдаж байгаа эсэхэд хяналт тавьдаг, Мөн боловсруулсан түлшний үйлдвэрүүдийн / гэрээтэй/ үйл ажиллагаанд хяналт тавих хэлбэрээр ажилладаг. Мөн цахилгааны хөнгөлөлт эдлэх айл өрхийг Эрчим хүчний газарт уламжилдаг. Энэ бүх ажлыг нь бол "Цэвэр агаар сан"-гаас санхүүжүүлдэг юм. Захиалагч нь бол Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль Орчны яам зэрэг байдаг. Боловсруулсан түлш нийлүүлэх гэрээ хийхээс нь өмнө болон гэрээ хийсний дараа тухайн аж ахуйн нэгжийн боловсруулсан түлш үйлдвэрлэх үйлдвэр дээр нь очиж үзэж танилцдаг. Ганц манайх ч танилцахгүй санхүүжүүлэгч Цэвэр агаар сангаас ч очиж танилцсан. Ингээд гэрээ хийх боломжтой эсэхээ шийддэг. Энэ гэрээ сонгон шалгаруулалтаар хийгддэггүй юм. Гэрээ хийх бол гэрээний төслөө гурван тал буюу захиалагч нь манайх, санхүүжүүлэгч Цэвэр агаар сан, нийлүүлэгч ахуйн нэгж хамтран боловсруулдаг. "Цэвэр агаар сан"-гаас хуульч Б.Со гэрээ боловсруулахад оролцдог. Манай албанаас миний бие оролцдог. Ингээд гэрээний төслөө боловсруулаад холбогдох дарга нарт танилцуулаад санал авна. Саналгүй бол гэрээгээ хийдэг. Гэрээнд хамгийн эхлээд түлш нийлүүлэгч аж ахуйн нэгж гарын үсгээ зурж тамгаа дардаг. Тэгээд дараа нь захиалагч тал буюу Нийслэлийн Засаг даргын орлогч гарын үсгээ зурж тамгаа дардаг. Ингээд сүүлд нь санхүүжүүлэгч буюу "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү гарын үсэг зурж тамгаа дардаг. Гэрээ 3 хувь үйлдэгдэж тус бүр нэг

нэгээр нь авдаг юм. Гэрээний хэрэгжилтийг захиалагч, санхүүжүүлэгч 2 тал хяналт тавьж ажилладаг. Мөн манай алба нь тухайн нийлүүлсэн түлшийг иргэдэд хэрхэн хүргэх ажлыг зохион байгуулах ажлыг хариуцан ажилладаг юм. 2011 онд гурвалсан гэрээгээр нийт 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. "ШГО" ХХК, "НТ" ХК, "Т" ХХК, "ӨТ" ХХК, "ХӨ" ХХК, "ГБ" ХХК, "МТХС"сан, ХБТ ХХК, "ҮШТҮ" НӨҮГазар, "Т" ХХК, "МAM" ХХК, "ӨӨМ" ХХК зэрэг болно. Эдгээр аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ манай албанд бүгд хавтаслагдсан байгаа. 2012 онд нийт 10 аж ахуйн нэгжүүдтэй түлш нийлүүлэх гэрээг байгуулсан. Тухайлбал "Вм" ХХК, "ДАг"ХХК, "ГБ" ХХК, "ХБг" ХХК. "ҮШТҮ" НӨҮГазар, "Т" ХХК, "Т" ХХК, "МННБД" ХКК, "ШГЭ" ХХК, "МAM"ХХК зэрэг болно, 2011 онд гэрээ хийгдээгүй. Тухайн гэрээ хийсэн аж ахуйн нэгжээс Боловсруулсан түлшээ үйлдвэрээс нь хүлээн авдаг. Ингэхдээ баримт үйлддэг. Манай албанаас хүн байдаг. Зарим тохиолдолд би өөрөө хүлээн авахад оролцдог. Өвлийн улиралд Баянгол дүүргийн Боловсруулсан түлш жижиглэнгээр борлуулах цэг гэж байдаг тэдгээртэй шууд тээвэрлэлтийн аж ахуйн нэгж холбогдоод баримт үйлдээд баримтаа манайд ирүүлдэг юм. Манай алба тухайн гэрээгээр заасан үүргээсээ тэдний өдөр төчнөөн түлш нийлүүлсэн гэдгийг нь баталгаажуулдаг. "Цэвэр агаар сан"-д албан бичгээр хүргүүлдэг. Ингээд нийлүүлсэн түлшинд нь тааруулаад санхүүжилтээ "Цэвэр агаар Сан"-гаас олгодог. Хэрхэн санхүүжилтээ шилжүүлдэг талаар би хэлж мэдэхгүй. Зуны улиралд түлш үйлдвэрлэгч нараас үйлдвэрлэсэн түлшийг нь авч нөөцлөх зорилгоор, авсан түлшээ түрээсийн агуулахад хадгалдаг. Манай алба агуулах түрээслэхэд "Цэвэр агаар сан" санхүүжүүлэгчээр оролцдог. Мөн халаалтын улирал эхлэх үед боловсруулсан түлшийг жижиглэн борлуулах, тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжүүдтэй мөн гэрээ байгуулахад санхүүжүүлэгч талаас "Цэвэр агаар сан" оролцдог юм. Өөрөөр "Цэвэр агаар сан"-тай гэрээнд оролцдоггүй. "Цэвэр агаар сан" өөрөө таван ажилтантай тэднийг бүгдийг нь мэднэ. Ажил төрлийн холбоотой болохоос садан төрлийн хүн байхгүй. Улаанбаатар хотын хөрсний бохирдлын судалгаа хийх, Гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхэнд ариутгалын бодис хийх түүний мониторинг мөн гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур тавьсан үр дүнгийн мониторинг

хийх ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ хэлцлийн талаар би мэдэхгүй, манай албанд бүртгэлгүй. Нийслэлийн Засаг даргын захирагчийн албанд бохирдол Хог хаягдлын менежментийн хэлтэс гэж байдаг тэдэнтэй л хамаатай байх гэж бодож байна. Гэрээний хэрэгжилт нийлүүлэлтэд "Цэвэр агаар сан"-гаас хааяа Г.Бс ах хянадаг. Өөр хүн ирдэггүй. Түлш ачиж байгаа, буулгаж байгаа гэдгийг нь ирж хардаг.Түүнээс нэг вагон буулгахад дуустал нь байдаггүй" гэх мэдүүлэг /9 хавтас-072-073/,

Гэрч П.А-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн агаарын чанарын албанд нягтлан бодогч/ "...Би 2010.07.22-ны өдрөөс Нийслэлийн агаарын чанарын албанд нягтлан бодогчоор ажиллаж байна. "Цэвэр агаар сан" бол Манай Нийслэлийн чанарын албатай хамтран ажиллах гэрээ хэлцэлтэй эсэхийг би мэдэхгүй, Миний мэдэхийн "Цэвэр агаар сан"-гаас Нийслэлийн Засаг даргын захирамжаар хороодод ажиллаж буй хэсгийн ахлагч нарт сард 50,000 төгрөгийг халаалтын улиралд, мөн агаарын чанарын албанаас дүүргүүдэд гэрээт 2 ажилтан ажилладаг тэдгээрийн цалин хөлсийг олгодог байдлаар харилцан ажиллаж байгаа. Түүнээс манай алба ийм ажил үйлчилгээг санхүүжүүл гээд "Цэвэр агаар сан"-д өгдөггүй. Иймэрхүү ажил үйлчилгээг санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргаас л шийдвэрлэдэг байх. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху-г би нүүр тулж харж уулзаагүй, утсаар бол ярьж байсан. Манай албаны санхүүгийн тамга над дээр эсхүл няравт л байдаг. Гэр хорооллын айл өрхүүдэд боловсруулсан түлш нийлүүлэх түүний агуулах зэрэг ажлыг "Цэвэр агаар сан" санхүүжүүлдэг. Энэ ажилд нь манай албаны мэргэжилтэн Э.Эб оролцож агуулахад түлш буух, түүнийг айл өрхүүдэд тараах зэрэг ажилд нь Э.Эб л вагоноос түлш агуулахад буухад орлогод авдаг, тэгээд тараадаг. БГДүүрэгт борлуулах цэгүүдэд олгоход орлого зарлагын баримт хэрэгтэй гээд зарлага,орлогын баримтад санхүүгийн тамга даруулаад авсан юм. Э.Эб өөрөө уг баримтад бичилт хийх ёстой боловч өөрөө ажлаа дийлэхгүй л "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху-д үлдээсэн байх гэж бодож байна. "Цэвэр агаар сан" бол түлш авах хадгалах тэдгээрийг санхүүжүүлэх ажлыг хариуцдаг ба манай алба бол хүлээн авах иргэдэд тараах ажлыг нь хариуцдаг. Иймд энэ санхүүгийн тамгатай орлого зарлагын баримтыг ашиглах боломж

байхгүй. Би уг нь Э.Эб-т "ийм их хэмжээгээр өгөхгүй би өөрөө ч хянахгүй байж" гэж хэлсэн Э.Эб иргэд нэхээд байна нэг баримт авах гэж ажил дээр байнга ирэх боломжгүй өдөрт вагон бугаад түүнийг агуулах руу тээвэрлэх, тэндээсээ борлуулах цэгүүдэд тараах гээд ажилтай тийм болохоор та нэг мөсөн өгчихсөн нь дээр гэж тайлбарлаад л авсан юм. Агуулахаас борлуулах цэгт зарлагын баримт үйлдээд, агуулахад буулгахад нь орлогын баримт үйлддэг. Эдгээр тамгатай баримтуудыг би Э.Эб-т өгсөн байтал яагаад "Цэвэр агаар сан"-гийн ажлын байрнаас гарч ирж байгааг би мэдэхгүй гэх мэдүүлэг /9 хавтас 0146-0147/,

Гэрч Б.Со-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /"Цэвэр агаар сан"-д мэргэжилтэн/ "...Би "Цэвэр агаар сан"-д 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2012 оныг дуустал ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр ажлаас гарсан юм. Тэгээд 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эргэж ажилдаа орсон юм. Миний ажил үүргийн хуваарь гэхээр гэрээ, хэлцлийн эх бэлтгэх, албан бичгийн эх бэлтгэх, "Цэвэр агаар сан"-гийн зарлаж буй тендерийн Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилладаг юм. Тухайн тендерүүдийн ихэнх нь яам, агентлагууд дээр зарлагддаг бөгөөд тэдгээр байгууллагууд нь тендерүүдийн гэрээнүүд дээр захиалагч тал болж оролцоод "Цэвэр агаар сан" санхүүжүүлэгч, тендерт ялсан тал гүйцэтгэгч болж оролцдог юм. Тендер зарласан бүх материалууд тендер зарласан газар дээрээ боловсруулагдаж юм. Тэнд бэлэн болсон материалуудыг аваад хавтас хэрэг болгодог байсан. Сангийн сайдын тушаалуудаар батлагдсан тендерүүдийн жишиг баримт бичгийн дагуу гэрээний маягыг шууд ашиглаж гэрээг байгуулдаг юм. Гэрээний ерөнхий нөхцөлийг өөрчлөхийг хориглосон заалт байдаг юм. Гэрээг мэргэжилтэн Г.Бс, Б.Бат, нягтлан бодогч М.Ху нар байгуулж гүйцэтгэх захирал Н.Хү баталдаг юм. Миний хувьд гэрээний эхийг бэлтгэж өгдөг юм. Гэрээний эхийг бэлтгэхдээ тендерт ирүүлсэн үнийн санал дээрх үнийн дүн, ажил гүйцэтгэх баталгаат хугацаа, ажлын хуваарь, ажлын зураг зэргийг тусгаад гэрээний," тусгай нөхцөлийг бэлтгэж өгдөг юм. "Цэвэр агаар сан" бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан байхгүй, нарийн бичгийн дарга байхгүй өдий хүртэл ажиллаж байгаа юм. Тийм болохоор голдуу бичиг хэрэг боловсруулах явуулах, архивлаж үдэх зэрэг

ажлуудыг хийдэг юм. "Цэвэр агаарын сан" голдуу гурван талт, дөрвөн талт, таван талт гэрээнүүд байгуулдаг. Утаагүй зуухаар гэр хорооллын иргэдийг хангах ажил 2011-2012 онд хийгдсэн юм. Энэ ажилтай холбоотой бүх гэрээнүүдийг нягтлан бодогч М.Ху байгуулсан юм. Зарим тохиолдолд надаар эхийг бэлтгүүлж байгаагүй цаад байгууллагаас бэлэн гэрээний эхийг бэлтгэсэн гэрээнүүд ирүүлдэг юм. Зарим нь миний мэдээгүй өнгөрсөн гэрээнүүд хүртэл байдаг. 2011 онд байгуулсан түлшний гэрээнүүд, авто машины утаа бууруулах тоног төхөөрөмж нийлүүлэх гэх мэт гэрээг хяналт шалгалт орох хүртэл би хараагүй байсан бөгөөд энэ бүх эх гэрээнүүд бүгд нягтлан бодогч М.Ху дээр байсан юм. Миний эхийг нь бэлтгэж байсан гэрээнүүдийн хувьд гэрээтэй холбогдох бусад баримт бичгүүд, гэрээний тайлан зэрэг материалуудыг тус тус хавтаст хэрэг болгож үдэж архивлаад товъёогтой, дугаартай байгаа. Миний хувьд байгууллага дээр байгаа бүх бичиг цааснаас өөрийн эхийг бэлтгэсэн гэрээ болон албан бичгийг ширхэгчлэн зааж чадна. "Цэвэр агаарын сан" дээр яг хэн бүх гэрээнүүдийг хариуцан байгуулах вэ? Хэн нь хэрэгжилтийг дүгнэж явах вэ? гэдэг дээр тодорхой бус нөхцөл байдал байсан. Захирал Н.Хү гадаад, болон дотоодод томилолттой үед түүнийг яг орлох албан тушаалтан байхгүй. Г.Бс ахад л тэгээрэй ингээрэй гэж хэлдэг, өөрийн гарын үсэг бүхий шийдвэртэй холбоотой асуудлыг үлдээдэггүй өөрөө л хийдэг. ...Гарын үсэг бүхий төлбөрийн даалгаврын хувьд би мэдэхгүй, санхүүгийн ажилд би оролцдоггүй. Бүх гэрээ санхүү дээр буюу М.Ху дээр байдаг. Учир нь төрийн сан гүйлгээ хийхэд гэрээний эх хувийг үзэж хянадаг" гэх мэдүүлэг /9-р хавтас-06-07/,

Гэрч С.Эт-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "...2001 онд "Ан" ХХК-ийг би ганцаараа үүсгэн байгуулсан. Үүнээс өмнө "Ан" ХЭАА гэж байсан. СХД-ийн Татварт бүртгэлтэй, төмөр хийц, угсармал барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 2010 оноос эхлэн утаагүй зуух үйлдвэрлэж байна. 2011 оны хавар сар өдрийг нь санахгүй байна. Төмөр хийц үйлдвэрлэгчийн холбоо, Үндэсний үйлдвэрлэгчийн холбоо байгуулагдаад телевизээр гарах үед "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү над руу залгаад уулзах санал тавиад "Цэвэр агаар сан" байгуулагдаж байгаа, би захирал нь, танайх утаагүй зуух үйлдвэрлэдэг юм



байна. Тиймээс хамтран ажиллая" гэсэн санал гаргасан. Би дуртай зөвшөөрөөд 5000 ширхэг утаагүй зуух үйлдвэрлэх гэрээ "Цэвэр агаар сан"-тай 2011 оны 12 сард хийсэн боловч манай компанид урьдчилгаа өгөхгүй, заавал айл өрхүүдэд суулгасны хойно санхүүжилт өгнө гэсэн. Энэ гэрээгээр 725 сая төгрөгийг ажил гүйцэтгэхээр болсон. Урьдчилгаанд 300 сая төгрөг би шаардсан боловч надад өгөөгүй. 153 ширхэг зуухны төлбөртөө 18 сая төгрөг "Цэвэр агаар сан"-гаас авсан. Тэгээд л миний ажил зогссон юм учир нь би Нийслэлийн агаарын чанарын албаны дарга н.Б-ыг надаас хахууль нэхээд байгаа талаар Авлигатай тэмцэх газарт өгөөд шалгуулчихсан юм. Тэгсэн чинь Н.Хү мэдчихээд "чи хүнтэй хамтран ажиллаж чаддаггүй юм байна" гээд манай компаниас хөндийрсөн. Ингээд л "Цэвэр агаар сан"-тай холбоогүй болсон. Нийслэлийн агаарын чанарын албаны дэд даргыг шалгуулсныг мэдсэн болохоор Н.Хү-ийн хувьд надаас санхүүжилтийн хувь нэхээгүй. Анх өөрөө хамтран ажиллах санал тавьчаад хууль бус үйлдлийг таслан зогсоох гэсний төлөө хамтран ажиллахаа больсон. Н.Хү үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгж болон манай компанид урьдчилгаа өгөхгүй байж СэК ХХК-ийн охин компани МВ5-д Нийслэлийн агаарын чанарын албанаас олгосон байдаг" гэх мэдүүлэг /9-р хавтас-0161/,

Гэрч Ж.Цо мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Т ХХК-ийн захирал/ "Т" ХХК-ийг миний ах ГБ 1993 онд хоршоо нэрээр үүсгэн байгуулан гадаад худалдаа, гахайн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаад 1996 онд нас барсан. Ингээд уг хоршоог нь миний бие үргэлжлүүлэн аваад үйл ажиллагааг нь явуулж байгаа. Тэгээд 2001 онд ХХК болсон юм. Үүсгэн байгуулагч нь гээд миний нэр байгаа ганцаараа. Компани болгосноосоо хойш гахайн аж ахуйгаа л эрхэлж байсан. Өөр үйл ажиллагаа явуулж байгаагүй. БЗДүүргийн татварт харьяалагддаг болно. 2011 оны 5 билүү 6 сард Нийслэлийн Засаг даргын тамгын газрын шинэ байрны 11 дүгээр давхарт хурлын зааланд Байгаль орчны сайд Г, Нийслэлийн Засаг даргын орлогч Д.Г, Нийслэлийн ИТХ-ын дарга Б болон Цэвэр агаар сангийн захирал Н.Хү зэрэг албан тушаалтнууд оролцсон түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдийн уулзалт болсон. Миний бие 2008 оноос Сэлэнгэ аймгийн Мандал сум Түнхэл тосгонд шахмал түлш үйлдвэрлэж

байсан учир энэ хуралд ирж суусан юм. Тэр хуралд сууж байсан бүх л түлш үйлдвэрлэгч нарын үйлдвэрлэлийн байранд нь ирж үзэж танилцаад тэгээд шууд түлш үйлдвэрлэгч 10 гаран аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулна гээд тэр хурлаас шийдээд л тэр өдрөө хурал дээрээ үнэ хөлсөө тохирсон шийдвэр гаргаж байсан юм. Ингээд л миний бие "Т" ХХК-ийнхаа нэрээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон "Цэвэр агаар сан"-тай гурвалсан гэрээг байгуулсан юм. Ингээд би Улаанбаатар хотод түлш нийлүүлэх болсон юм. Миний санаж байгаагаар ингэж гэрээ хийхэд 1000 тонн түлш нийлүүлэх гэрээ хийсэн ба санхүүжилт 130 сая төгрөг байсан санагдаж байна. тэгээд дараа жил нь дахин гэрээ хийхэд түлшний үнэ нэмэгдээд 150 сая төгрөг болж байсан. Гэрээгээ харахгүй болохоор би тодорхой хэлж санахгүй байна. Санхүүжилтээ гүйцэтгэлийн дараа өгдөг байсан. Тодруулж хэлбэл би үйлдвэрлэсэн шахмал түлшээ Улаанбаатар хотод авчирч Толгойт Амгалан зэрэг газарт байрлах агуулахад нь буулгадаг. Үүнийг Нийслэлийн агаарын чанарын албаныхан хүлээн авч акт үйлддэг, тэр үйлдсэн актыг нь би аваад "Цэвэр агаар сан" дээр очиж санхүүжилтээ авдаг байсан. Энэ жилийн хувьд энэхүү ажлаа үргэлжлүүлэн хийгээд явж байгаа. 2011 онд түлшний төлбөрөөс өөр мөнгө манайд орж ирж байгаагүй. 2012 онд бол түлшний төлбөрөөс өөр хэд хэдэн гүйлгээгээр мөнгө орж ирсэн. Эхлээд би мөнгө орж ирснийг би мэдээгүй. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху намайг 2012 оны 10 сард дуудахаар нь ажлынх нь гадаа яваад очиход тэрээр гарч ирээд танай дансанд мөнгө шилжүүлчихсэн дансаа шалгаад гаргаад өгөөч гэсэн би тухайн үед дансаа шалгаагүй байсан тэр мөнгө орж ирнэ гэдгийг би мэдэхгүй. М.Ху хэлэхдээ танай компанийн нэр дээр түлш нийлүүлэх гэж байгаа юм гээд гуйсан. Тэгээд дансаа шалгатал 28-29 байх сая төгрөг орж ирсэн байсан, тэгээд би тэр мөнгийг нь гаргаад М.Ху-д ажил дээр нь хар гялгар банкны ууттай нь хүргэж өгсөн. М.Ху-гийн өрөөнд хүн байгаагүй, М.Ху надаас аваад л зөрөөд захирал Н.Хү-ийнхээ өрөөнд орж байсан. Н.Хү, М.Ху хоёрын өрөө зэрэгцээ хаалгатай байдаг юм. Тэгээд л түүнээс хойш би дахин манай компанийн дансанд мөнгө шилжүүлчихнэ гэж бодоогүй, мэдээгүй байтал дахиад М.Ху мөнгө шилжүүлчихлээ гэсэн. Миний хувьд манай компанийн дансыг ашиглаж байгаа

болохоор нөгөө талаараа манай компанид ашигтай дараа банкнаас зээл авахад гүйлгээ их байвал ач холбогдолтой гэж бодож байсан ба "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху өөрөө хэлж байгаа болохоор зөвшөөрчихсөн юм. Ингээд л иймэрхүү байдлаар хэд хэдэн удаа гүйлгээ орж ирж би бэлнээр гарган М.Ху-д хүргэн өгч байсан. Ер нь нийт 1 тэрбум орчим төгрөг ийм байдлаар гарган М.Ху авсан. Хэдний өдөр хэдэн төгрөг авч байснаа санахгүй байна. Компанийнхаа дансны хуулгыг авч харж байгаад энэ талаар тодорхой мэдүүлэг өгнө. Би өөрөө дэвтэр хөтлөж байсан тэр дэвтрээ ч харна. 10 гаран удаагийн гүйлгээ байгаа байх. Их хэмжээгээр ороод ирэхэд нь би нэг мөсөн гаргаж авч чадахгүй хэд хэдэн удаа таслан гарган авч өгч байсан байх. Миний хувьд ингэж гарган авсан мөнгийг М.Ху-д ажил дээр нь хүргэн өгч байсан. М.Ху аваад захирал Н.Хү-ийн өрөө рүү 2 удаа тортой мөнгийг аваад орж байсан. Би өөрөө бол Н.Хү-тэй нүүр тулж уулзалдаж байгаагүй. Анх тэр хурал дээр л харсан М.Ху-г ч би мөн адил танихгүй юм. Гэтэл яагаад надад итгэж тэгж хэлээд надаар зөвшөөрүүлэх болов гэдгийг мэдэхгүй. Миний хувьд нэгд компанийн үйл ажиллагаа том болгох гэж дараа нь банкнаас зээл авахад хэрэгтэй учир гүйлгээ, борлуулалт байх хэрэгтэй гэж үзсэн. Нөгөө талаараа М.Ху-г тэгж хэлэхээр итгэсэн манай нэрээр л өөрсдөө хэдэн тонн түлш олж ирж нийлүүлэх гэж байгаа юм байх гэж бодсон. Түүнээс М.Ху өөр зүйл яриагүй. Эхний 2 удаа бэлэн мөнгө гаргахад би аваагүй. Татварт борлуулалтын тайлан гаргадаг учир борлуулалтын татвар гээд 10 хувийг нь М.Ху-д хэлж байгаад авч үлдсэн. Нийт 100 орчим сая төгрөг авч үлдсэн. Энэ мөнгийг нь би татварт тушаасан. Түүнээс би өөртөө ашиг гэж аваагүй, татварт тушаах мөнгийг нь хэлж байж авч үлдсэн. М.Ху өөрөө ч тэг гэсэн юм. Тэгэхгүй бол өмнөөс нь манай компани татвар төлөх болно. Тухайн үед М.Ху надаас "танайхаас өгсөн нэхэмжлэл засвартай байна, солих гэсэн юм" гэж хэлээд нэхэж байгаад хоосон тамгатай нэхэмжлэл авсан. Манай компанийн нэрээр М.Ху-г хувиараа л түлш нийлүүлж байгаа гэж бодож байсан" /9-р хавтас-122-123/,

мөн түүний "...түрүүчийн удаа мэдүүлэг өгөхдөө жаахан зөрүүтэй өгсөн байна. М.Ху-гийн хэлснээр компанийн данснаас мөнгийг аваад М.Ху-д дандаа бэлнээр өгөөгүй юм байна. 2 удаа дансаар би мөнгийг

шилжүүлж өгч байсан. Мөн 4 удаа нь М.Ху-гийн хэлснээр мөнгийг хар өнгийн машинд аваачих өгсөн. Намайг хөдөө Замын-Үүдэд явж байхад М.Ху утасдахаар нь данснаас мөнгө аваад бэлнээр өгөх боломжгүй байсан болохоор М.Ху надад дансны дугаар өгдөг байсан. Тэр данс руу нь мөнгийг нь хийдэг байсан. Хэний данс гэдгийг нь би мэдээгүй. Эхний удаа 2012.11.30-нд 35 сая төгрөгөөс татварт өгөхийг нь авч суутгаад 32.125.000 төгрөгийг М.Ху-гийн өгсөн дансанд хийж байсан. Тэгээд маргааш нь бас 53 сая төгрөг орж ирсэн байхаар нь М.Ху-гийн хэлсэн дансанд нь тушаасан. Хар өнгийн машины хувьд тухайн үед өвлийн улирал байсан, орой харанхуй болчихсон байдаг "Цэвэр агаар сан"-гийн хойд талд Байгаль орчны яамны авто зогсоол дээр байж байдаг ямар маркийн, хэд гэсэн дугаартай машин байсныг мэдэхгүй байна, жолоочид нь өгчихөөд л явчихдаг байсан. М.Ху намайг тэр машинд мөнгийг өгчих гэхээр нь л би өгдөг байсан. 4-5 удаа л мөнгийг хүргүүлэн авч байсан. Яг хэдэн төгрөг өгснийг санахгүй байна. Жолооч нь машиндаа ганцаараа л байдаг байсан. Тухайн үед М.Ху надад тийм маркийн тийм дугаартай машин гэж хэлдэг байсан гэхдээ би одоо санахгүй байна. М.Ху өөрөө намайг гэрчлэх байх. Би тэр шилжүүлж байсан мөнгөнөөс нэг ч төгрөг өөртөө аваагүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-124/,

Гэрч Э.Ба-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /ХБХХК-д нягтлан бодогч/ "...М.Ху бол миний ээж М.Б-гийн төрсөн дүү нь байгаа юм. "ШГЭБ" ХХК-ны талаар надад мэдэх зүйл байхгүй. Миний Хаан банкинд 2008 онд нээлгэсэн 506808xxxx тоот дансанд М.Ху эгч мөнгө шилжүүлж байсан. Хаанаас хэнээс орж ирж байсныг нь би мэдэхгүй. М.Ху эгч чиний дансанд мөнгө шилжүүлчихсэн бэлнээр гаргаад аваад ирээрэй гэдэг. Тэгээд би банкин дээр очоод дансаа шалгаад орж ирсэн мөнгийг гаргаад М.Ху эгчид хүргээд өгчихдөг байсан. 2012 онд хэд хэдэн удаа хамгийн сүүлд 2013 оны 03 дугаар сард 1 удаа, 6 сард 1 удаа мөнгө орж ирсэн. Би тус бүрээр нь хэлж мэдэхгүй байна. 6 сард орсон мөнгө нь 50 сая төгрөг байсан. 2011.07.10-ны өдөр 180 сая төгрөг орж ирж байсан эсэхийг яг хэлж санахгүй байна. Ер нь ийм хэмжээний мөнгө орж ирж л байсан. М.Ху эгч өөрөө утасдаад дансанд чинь мөнгө орлоо гаргаад аваад ир гэдэг байсан. Тэгээд би М.Ху эгчийн ЧД-ийн 1 дүгээр дэлгүүрийн ард байрлах гэрт нь хүргэж өгдөг байсан.

Нийт хэдэн төгрөг өгч байсныг нь санахгүй байна. Барагцаагаар хэлбэл 3 сая орчим төгрөг надад өгсөн байхаа. Би "ХБ" ХХК-д нягтлан бодогч ажилтай, энэ компанийг 2008 оны 10 дугаар сард М.Ху эгчийн дүү миний ээжийн дүү М.Аг үүсгэн байгуулсан. М.Аг эгч захирал нь манай нөхөр К.Эр менежерээр, би нягтлан бодогчоор нь ажилладаг юм. "ХБ" ХХК нь "Цэвэр агаар сан"-тай хамтын ажиллагааны гэрээ байхгүй. Харин манай компанийн дансанд "Цэвэр агаар сан"-гаас сургалт семинарын төлбөр гээд 2012 оны 04 сараас эхлэн нийт 4 удаагийн гүйлгээгээр эхний удаад 23 сая, дараа нь дахин 23 сая, дараа нь 20 сая дараа нь 50 сая төгрөг, нийт 116 сая төгрөг орж ирснийг эгч Аг-гийн гарын үсгээр данснаас би гарган авч М.Ху эгчид хүргэж өгч байсан. Ямар учиртай мөнгө болох талаар би мэдэхгүй... "ШГД" гэх компани бол миний ээж Б-гийн эгч С-гийн хүү Б.Хз-ийн 2011 онд үүсгэн байгуулсан компани. Анх байгуулагдахад нь би үйл ажиллагаа явуулаагүй гэсэн тайланг гарган өгч байсан. Одоо ямар үйл ажиллагаа явуулдгийг би мэдэхгүй. "ХБ" ХХК-ийн тамгыг М.Ху 6-7 удаа авч байсан. М.Ху эгч компанийн тамгыг "ХБ" ХХК руу мөнгө шилжүүлэхдээ л хэрэглэдэг байх гэж бодож байна" гэх мэдүүлэг /9-р хавтасны 00017 хуудас/,

Гэрч М.Аг-гийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "ХБ" ХХК-ийн захирал / "...2007 оны 10 дугаар сарын 17-нд миний бие энэ компанийг үүсгэн байгуулсан. Энэ компанийн хөрөнгө оруулагч нь би өөрөө ганцаараа боловч ах дүү нараасаа дэмжлэг авдаг. Одоо Дархан-Уул аймагт зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа. "Цэвэр агаар сан"-тай миний "ХБ" ХХК ямар нэгэн ажил төрлийн холбоо байхгүй. Хамтран ажилладаггүй. Энэ санд миний төрсөн дүү М.Ху нягтлангаар ажилладаг. Өөр ямар нэгэн холбоо байхгүй. Энэ мөнгөний талаар би мэдэхгүй, манай нягтлан Э.Ба гээд миний төрсөн эгч Б-гийн охин ажилладаг юм. Тэр л М.Ху эгч ярьж байна компанийн дансанд ийм мөнгө орсон гэнэ бэлнээр гаргаад аваад ир гэсэн гээд надад хэлсэн тэгээд би Э.Ба-ийн хамт банк руу очоод тэр мөнгийг нь захирлын хувьд гарын үсэг зурж гаргаж өгөөд Э.Ба-т өгөөд явуулдаг. М.Ху өөрөө авдаг. Нийт 116 сая төгрөг мөн байх би тодорхой санахгүй байна. 4 удаа ингэж авч байсан. М.Ху яагаад манай компанийн дансанд шилжүүлсэн талаар би мэдэхгүй. Бэлнээр гарган авах л хэрэгтэй байсан байхаа. Түүнээс ингэж

шилжүүлсэн мөнгийг нь би авсан зарцуулсан зүйл байхгүй. Зочид буудлын барилгыг 2007 оноос компани байгуулаад л барьж эхэлсэн, суурийг нь бол эрт цутгачихсан байсан. Тэгээд 2011 оны 11 сард ашиглалтад оруулсан. Түүнээс хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Ганц М.Ху хөрөнгө оруулалт хийгээгүй, ах дүү нар маань тал талаасаа л дэмжиж бага ч гэсэн хөрөнгө оруулалт хийж энэ зочид буудлыг байгуулсан. М.Ху эгчийн хувьд зочид буудлын тавилга авахад 30 гаран сая төгрөгийн хөрөнгө оруулсан. Өөр хөрөнгө оруулалт хийсэн зүйл байхгүй" гэх мэдүүлэг /9-р хавтас -00020/,

Гэрч М.Жа-гийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /М.Ху-гийн төрсөн дүү/ "...М.Ху бол миний төрсөн эгч.Түүнд холбогдох хэргийн талаар асуувал надад мэдэх зүйл байхгүй, "ШГЭБ" ХХК-ийн талаар би дуулаагүй мэдэхгүй юм байна. Тийм болохоор ямар нэгэн харьцаа ажил төрлийн холбоо байхгүй. Надад Хаан банкинд 5207xxxx дугаартай данс байгаа. "ШГЭБ" ХХК-аас миний энэ дансанд мөнгө орж ирж байсныг би санахгүй байна. Тийм зүйл байхгүй байх. Харин эгч М.Ху над руу утасдаад миний дансны дугаарыг авч байсан. 2011 онд 9 сар юм өдрийг нь санахгүй байна. М.Ху хэлэхдээ мөнгө шилжүүлсэн эгч М.Цолмон бид хоёрыг нэг нэг машин аваад унаарай гэсэн юм. Яг хэдэн төгрөг миний дансанд шилжүүлснийг би санахгүй байна. Ингээд би төрсөн дүү М.Х-г дагуулаад машин худалдааны газруудаар машин сонирхож яваад БЗД-т байрлах Автомаркет худалдааны төвөөс 2 ширхэг Лексус 470 маркийн/ саарал өнгөтэй үйлдвэрлэсэн он 2007 он, ногоон өнгийн 470 нь 2004 оных/ 118,500,000 төгрөг худалдан авахаар тохирч мөнгийг нь би данснаасаа шилжүүлэн өгсөн болно. Одоо би 2004 онд үйлдвэрлэгдсэн ногоон өнгийн Лексус 470 маркийн машиныг хх-хх НАА улсын дугаартай эзэмшиж байгаа ба төрсөн эгч М.С 2007 онд үйлдвэрлэгдсэн саарал өнгийн Лексус-470 маркийн машиныг хх-хх УБВ улсын дугаартай эзэмшиж байгаа. Ингээд машин аваад үлдсэн мөнгийг М.Ху өөрөө авсан. Би дансаараа бэлнээр гаргаж өгсөн. Нийт хичнээн төгрөг байсныг би санахгүй байна. Үүнээс өөрөөр надад М.Ху ямар нэгэн мөнгө төгрөг өгч байгаагүй. Дүүгийнхээ амьдралд тус болоод л надад машин авч өгч байгаа гэсэн. Ийм зүйл болно гэж бодоогүй. Ямар мөнгөөр машин авч өгч байгаа талаар би асуугаагүй. Хөндлөнгөөс харахад М.Ху-

гийн амьдрал боломжийн л харагддаг. Тэгээд л авч өгч байна гэж ойлгосон. Бид эх эцгээс 8 уулаа. Аав ээж маань өнгөрчихсөн. Хамгийн том маань М.С тэгээд М.Б, М.Ц, М.Ху, М.Аг, тэгээд би, миний дүү М.Х" гэх мэдүүлэг. /9-р хавтас -00021/,

Гэрч Б.Мө мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "...Би "Цэвэр агаар сан"-д ямар нэгэн ажил, албан тушаал хашдаггүй. 2012 оны эхээр "Цэвэр агаар сан"-гаас Цэвэр агаар төсөл-2 гэдэг ажил эхэлсэн. Энэ төсөл дээр нь жолоочоор ажиллаач гэж миний найз н.Одү-ийн эгч Б.Чи санал болгосон. Ажиллахдаа би өөрийн эзэмшлийн Хьюндай Верна маркийн автомашинаар ажилласан бөгөөд гэрээ хэлцэл хийгээгүй. Тэгээд энэ төсөл дээр ажиллаж байсан Ц, Б, У, Б.Чи гэх хүмүүстэй гэр хорооллын айлуудаар явдаг байсан. Өвлийн улиралд л явдаг. Сард 412.000 төгрөг Б.Чи-эс авдаг байсан. Цалин өгч байна гэж ямар нэгэн гарын үсэг зуруулж байгаагүй. Энэ төсөл нь Дэлхийн банкнаас санхүүждэг гэж байсан. Нийт 16 сар ажиллахдаа Б.Чи-ийн ажил дээр байнга байдаг учраас Н.Хү даргын таньдаг болоод хааяа машиныг нь барьж өгдөг байсан. Тэгээд 2013.05.01-нээс төсөл дуусаад ажилгүй болсон" гэх мэдүүлэг /9 хавтас-022/,

Гэрч З.Бм мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Д.Цэ-гийн нөхөр/ "...Д.Цэ миний гэр бүлийн хүн бөгөөд бид 2002 онд албан ёсоор гэрлэлтээ бүртгүүлээд одоог хүртэл хамт амьдарч байна. 2012 онд эхнэр Д.Цэ байрны захиалга өгч байна 2-уулаа явж байр үзье гээд РЖ хотхоны загварын каталогийг үзэж байгаад 9 давхрын байрнаас 2 өрөө байр захиалахдаа хоёулангийнхаа нэрээр захиалсан. Байр нийт 290 сая төгрөгийн ханштай болсон бөгөөд тэр мөнгийг хэрхэн төлснийг нь сайн мэдэхгүй байна. Гэрээгээ харахад тодорхой болох байх. 2012 онд "ТБМ" ХХК-наас 36.000 ам доллараар Volkswagen маркийн саарал өнгөтэй, хх-хх УНБ улсын дугаартай автомашиныг манай эхнэр Д.Цэ, "Цэвэр агаар сан"-гийн ерөнхий нягтлан бодогч М.Ху бид 3 очиж төлбөр төлсөн. Тэгэхэд өмнө нь байрны төлбөр төлдөг шиг график гарган жилийн хугацаанд төлж дууссаны дараа запас түлхүүрийг нь авахаар гэрээ байгуулсан. Тухайн үед яг хэдэн төгрөг төлснийг нь би сайн мэдэхгүй байна. Гэрээн дээр би гарын үсэг зурсан. Одоо тэр машин нь манай эхнэр Д.Цэ-гийн дүү Д.Дв-ын нэр дээр байдаг." гэх мэдүүлэг /9-р хавтас-023 хуудас/,

Гэрч Г.Хб-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Д.Цэ-гийн танил/ "...Би 2005 оны 1 сараас одоог хүртэл Баянгол дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байна. Би тус хэлтсийн хяналт шалгалтын тасагт ажилладаг. Ажил үүргийн хувьд даргаас өгсөн томилолтын дагуу аж ахуйн нэгж байгууллагад татварын хяналт шалгалтын биелэлтийг шалгаж татварын улсын байцаагчийн акт дүгнэлт илтгэх хуудас үйлддэг болно. Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ-тэй садан төрөл биш. Бид 1985 онд Санхүү эдийн засгийн техникумыг хамт төгссөн оюутан цагийн найзууд болно. 2011 оны намар юм. Би Д.Цэ-гээс түүний эзэмшиж байсан Хонда CRV маркийн автомашиныг нь 7 сая төгрөгөөр худалдан авч байсан. Төлбөрийг нь тухайн үед бүрэн хийсэн. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху гэх хүнийг танихгүй. 2011 оны зун наадмаар манай зусланд Д.Цэ мөн найз Н.Эб түүний эхнэр н.Г болон өөр нэг эмэгтэй ирж байсан. Тэр хүнийг хэлж байгаа юм уу би нэрийг нь санахгүй байна. Манайх Толгойтын баруун салаанд зусланд гарчихсан байсан юм тэгээд л наадмаар ирж баяр тэмдэглээд явж байсан. Н.Эб бол банкуудын холбоонд захирал ажилтай, утас 9901xxxx. Н.Эб бид хоёр л дотно найз байгаа юм. Д.Цэ бол Н.Эб-ын эхнэртэй л найзууд байгаа юм. Тэр хамт явсан эмэгтэйн нэрийг одоо үнэхээр санахгүй байна. Идэж уугаад л дуулж байгаад л явцгаасан тэр хамт явсан эмэгтэй нь бордуу царайтай хүн байсан. Өөрөөр ямар нэгэн хүн дагуулж ирж байгаагүй. Түүнээс хойш Д.Цэ ч өөрөө ирж байгаагүй." гэх мэдүүлэг. /9-р хавтас-00024/,

Гэрч Б.Б-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Би М.Аб-ы хадам ах/ "...Манай эхнэр Г.Ц-ын дүү Г.Ба нөхөр М.Аб 2011 оны хавар надад "ЭАИ" нэртэй байгаль орчны үнэлгээ судалгаа хийх компани байгуулах гэсэн юм, та надад иргэний бүртгэлийн мэдээллээ өгөөч, хамтран эзэмшигчээр таныг бүртгүүлчихье" гэхээр нь өөрийн мэдээллээ өгсөн. Харин энэ компанийг хэзээ үүсгэн байгуулсан, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулдгийг нь мэдэхгүй.Би өмнө нь техник эдийн засгийн үйлчилгээний чиглэлээр тодорхой хэмжээний ажил хийж гүйцэтгэж байсан бөгөөд миний энэ туршлагыг цаашид ашиглаж магадгүй гэсэн үүднээс компанийн хөрөнгө оруулагчаар намайг бүртгүүлсэн.

"Цэвэр агаар сан"-тай холбоотой асуудлыг би мэдэхгүй" гэх мэдүүлэг /9 хавтас-025/,

Гэрч Д.Дв-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Д.Цэ-гийн төрсөн дүү/ "...Д.Цэ миний хамгийн том эгч юм. Байгаль орчин, ногоон, хөгжлийн яаманд хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар ажилладаг. 2012.02.09-ний өдөр Д.Цэ эгч намайг дуудаад "миний эзэмшлийн хх-хх УНР улсын дугаартай тээврийн хэрэгсэл чиний нэр дээр шилжих боллоо, чи яваад өөрийн нэр дээр бүртгүүлчих гэхээр нь би Авто тээврийн газар дээр очоод өөрийн нэр дээр бүртгүүлсэн. Киа-рио маркийн автомашин манай дүү Д.Н-ын эзэмшилд байсан бөгөөд дүү маань Солонгос улс руу явах болоод машинаа Д.Цэ эгчид өгсөн бас л миний нэр дээр бүртгүүлсэн. Тэгээд Д.Цэ эгчийн 2 тээврийн хэрэгсэл миний нэр дээр байдаг. Би хувийн байшин барьж байхдаа Д.Цэ эгчээс 3.000.000 орчим төгрөг авч байсан. Бид хоёрын хооронд өр, авлагын асуудал байхгүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-027/,

Гэрч Н.Эб-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /"Зээлийн мэдээллийн төв" ХХК-ийн захирал/ "...Д.Цэ бол миний эхнэр н.Га-ийн 10-н жилд хамт сурч байсан найз байсан ба сургуулиа төгсөөд надтай хамт Санхүүгийн техникумд хамт сурч төгссөн танилууд байгаа юм. Тэр утгаараа би 1983 оноос хойш таних болсон. Найз нөхдийн харьцаатай хүмүүс. Д.Цэ болон манай гэр бүлийн хооронд одоо өр авлага байхгүй. 2011 оны 09 сард байх Д.Цэ-гээс 170 сая төгрөг 3-н сарын хугацаатайгаар сарын 3 хувийн хүүтэй зээлж байсан. Үүнээс өөрөөр Д.Цэ-гээс мөнгө төгрөг зээлж байгаагүй. Энэ 170 сая төгрөгийг Д.Цэ хаанаас олж ирсэн юм бол мэдэхгүй, надад хэлээгүй. Бэлнээр жижигхэн чемоданд хийчихсэн авчирч өгч байсан. Д.Цэ-гийн найз М.Ху гэж эмэгтэй байдаг. Дарханд ажиллаж байгаад Улаанбаатар хотод шилжиж ирээд Д.Цэ-гийн амьдардаг байранд байр аваад гээд хэлж байсан тухайн үед би Гурван гал ...банкны салбарын захирлаар ажилладаг байсан юм тэгээд М.Ху нь байр авна гээд манай салбараас зээл авч байсан. Тухайн үед М.Ху-г "Цэвэр агаар сан"-д нягтлан бодогч гэж Д.Цэ хэлж байсан юм. Энэ асуудал нь Д.Цэ-г надад 170 сая төгрөг зээлэхээс өмнө болсон асуудал юм. Ингэж анх М.Ху-тай танилцаж байсан. Нийт 50-60 сая төгрөгийн зээл авсан байх би зээлийн дүнг тодорхой санахгүй байна. 2011 оны хавар л болсон

санагдаж байна. Үүний дараа Д.Цэ тэр М.Ху-тай, би эхнэр Г дагуулаад найз Г.Хб-ын гэрт нь очиж байсан юм. Тэгэхэд М.Ху-тай бас таарч байсан юм. Г.Хб Д.Цэ бид гурав санхүүгийн сургуулийн оюутнууд байгаа юм. Д.Цэ яагаад М.Ху-г дагуулан очсоныг би мэдэхгүй. Миний санаж байгаагаар тэр М.Ху нь Дарханд зочид буудал барьж байгаа ашиглалтад орохоор та нарыг урина гэж хэлж байсан. Өөр юм ярьж байсан талаар үнэхээр санахгүй байна. Д.Цэ бол олон жил улсад ажиллаж байгаа болохоор танил тал намайг бодвол хамаагүй илүү л юм байна лээ." гэх мэдүүлэг /9-р хавтас-028/,

Гэрч Д.До-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: / Шинжлэх Ухааны Академийн Газар зүйн хүрээлэнгийн захирал/ "...Анх 2011онд "Цэвэр агаар сан"-тай 2012 онд хийх ажил гүйцэтгэх гэрээ хийж байсан. Улаанбаатар хотын хөрсний бохирдол, эко геохимийн үнэлгээ хийх ажил юм. Анх манай хүрээлэн дээр "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб гэх залуу ирсэн юм тэрээр хэлэхдээ манайх "Цэвэр агаар сан"-гаас Улаанбаатар хотын хөрсний бохирдол, эко геохимийн үнэлгээ хийх төсөл авч байгаа, энэ төсөл дээр танайх хамтран ажиллаач манай компанийн хувьд дээж авах зэрэг техникийн ажлыг нь хийнэ танай хүрээлэн шинжилгээ судалгааны ажлыг нь хий" гэсэн санал гаргасан юм. Ингээд Аб-тай буюу "ЭАИ" ХХК-тай 2011 оны 7 сард гэрээ хийсэн. М.Аб-ас би "танайх хөрс судалгаа хийдэг юм уу" гэхэд тэрээр "үгүй бид боловсруулах ажилд нь л оролцоно танайх хийх ажлаа л хий" гэж байсан. Ингээд манайх хийх ажлынхаа төсвийг 2011 онд 27 сая төгрөг 2012 онд мөн 29 сая төгрөгөөр тооцож өгсөн. Ингээд нийт 56 сая төгрөг гээд, хийх ажлын хугацаа 2011-2012 онуудад хийхээр төлөвлөсөн учир нь бүх улирлын хөрсний дээж авах шаардлагатай байсан юм. Тэгээд М.Аб энэ төсөв дээр чинь манайх өөрийн зардлаа нэмнэ гээд 19 билүү 20 гаран сая төгрөг хэлж байсан. Нийт төсвийн 76,3 хувийг манайх аваад үлдсэн хувийг М.Аб-ынх авахаар гэрээнд тусгасан юм. Ингээд дараа нь 2011 оны 08 сард "Цэвэр агаар сан"-тай зөвлөх үйлчилгээний гэрээг хийсэн юм. Энэ гэрээг хийхэд манай хүрээлэнгийн хөрс судлалын лабораторийн эрхлэгч доктор О.Бш "Цэвэр агаар сан" дээр өөрөө очиж гэрээ хийсэн байгаа би хийсэн гэрээг нь би баталж өгч болно. Миний хувьд тус сангийн захирал Н.Хү-тэй нүүр тулж уулзаж байгаагүй байх, сайн санахгүй байна. Ингээд л ажлаа хийсэн.

“Цэвэр агаар сан”-гаас манай байгууллагын төрийн сан дахь дансанд 2011 онд 27 сая, 2012 онд 29 сая орж ирсэн. Үүнээс өөрөөр мөнгө аваагүй ба хийх ёстой ажлаа манайх хийж гүйцэтгэн “Цэвэр агаар сан”-д өгсөн. Одоо ямар нэгэн тооцоо байхгүй. Зөрүү 20 сая төгрөгийг хэн авсныг би мэдэхгүй, манай дансанд ирээгүй. М.Аб авсан юм байлгүй. Манай төсөв дээр мөнгө нэмнэ гээд байсан. Манай байгууллага хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргасан. М.Аб өөрийн хийсэн ажлын тайлан гэж гаргасан эсэхийг нь би мэдэхгүй, түүнийг ямар ажил хийснийг ч мэдэхгүй. Манай байгууллагын хувьд Улаанбаатар хотын гэр хороолол төв суурьшил хэсгийн хөрсөнд агуулагдаж байгаа хортой хүнд металлын агууламжийг тогтоох ажил юм. Үүнийг тогтоосноор агаарын бохирдол хир байгаа хэмжээг тогтооход ач холбогдолтой юм. Агаар бохир байснаар бохирдсон агаар хөрсөнд бууж хөрсийг бохирдуулдаг юм. Ингээд ургамлаар дамжин хүний биед нөлөөлдөг юм. Энэ жил “Цэвэр агаар сан” манай хүрээлэнгээр Улаанбаатар хотын хөрсний бохирдлын зураг хийлгэх гэрээг саяхан байгуулсан байсан. Нийт өртөг нь 11 сая төгрөг. Энэ мөнгө манай дансанд орж ирсэн байгаа боловч манайх зарцуулаагүй байгаа. Энэ ажлыг хийж эхлээгүй байгаа.” гэх мэдүүлэг /9 хавтас-035, 036/.

Гэрч О.Бш-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: / Шинжлэх Ухааны Академийн Газар зүйн хүрээлэнд хөрс судлал лабораторийн эрхлэгч/ "...2011 оны 6 сард байх би сар өдрийг нь сайн санахгүй байна. Захирал Д.До намайг дуудаад "Цэвэр агаар сан"-гаас хөрсний бохирдлын судалгаа хийх шаардлагатай байна, манайх хийх үү, чи тэр хүмүүстэй очоод уулзчих" гэхээр очоод хуульч Б.Со гэх хүнтэй уулзахад танайх "ЭАИ" ХХК-тай түншлэлийн гэрээ хийгээд материалаа бүрдүүлээд өгчих гэсэн. Тэгээд компанийн утсыг надад өгсөн. М.Аб гээд хүн байсан. Энэ хүнтэй холбогдоод захирал Д.До-той уулзуулаад ингээд 2011 оны 7 сарын 6-нд манай хүрээлэн тус компанитай Түншлэлийн гэрээг хийсэн юм. Гэрээгээр Улаанбаатар хотын хөрсний бохирдол экологийн үнэлгээ хийх ажил гүйцэтгэх байсан. Яагаад энэ компанитай түншлэлийн гэрээ хий гэснийг би сайн мэдэхгүй туршлагатай энэ чиглэлээр ажилладаг гэж л надад Б.Со хэлж байсан. Түүнээс манай хүрээлэнгээс энэ компанийг мэдэхгүй. Ингээд 7 сард түншлэл гэрээг хийгээд М.Аб хийсэн гэрээг аваад явсан.

Ингэхдээ манай хийх ажлынхаа төсөв зардал зэргийг тооцоод гарга танай зардал дээр манайх өөр зардлаа нэмээд өгчихнө гэж М.Аб хэлж байсан. Түүний дагуу манайх 2011 болон 2012 онуудад нийт 58 сая төгрөгийн ажил гүйцэтгэнэ гээд төсөв гаргаж өгсөн. 1 жилд 29 сая төгрөгөөр тооцоод М.Аб-д өгсөн. Ингээд 8 сар гаргаад манайхтай хийсэн түншлэлийн гэрээ нь сонгон шалгарсан гээд М.Аб хэлээд "Цэвэр агаар сан" дээр очиж Ажил гүйцэтгэх гэрээ хийсэн. Гэрээний төсөл Цэвэр агаар сан дээр бэлэн байсан нөгөө Б.Сотай уулзалдаад гэрээнд гарын үсэг зурсан. Тэгээд гэрээг аваад хүрээлэн дээр ирээд захирал Д.До-оор гэрээг батлуулан тамгыг нь даруулж буцаад Цэвэр агаар сан дээр хүргэж өгсөн. Тэгээд "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү нь гэрээг танилцаад батлаж өгөөд надад нэг хувийг нь өгсөн. Ингээд би Н.Хү гэх хүнийг харж мэдэх болсон. Өөрөөр уулзалдаж байгаагүй. Ингээд гэрээ хийснээс хойш 2012 он дуустал гэрээнд заасан ажлаа хийгээд 2013 он 4 сард тайлангаа бичиж "Цэвэр агаар сан"-д хүлээлгэн өгсөн. "Экологи Ана Инженеринг"ХХК манайхтай тайлангаа нэгтгэж өгсөн. Манай хүрээлэн гэрээнд заасан ажлаа хийсэн. Өөрийн хүч техник хэрэгсэл мэргэшсэн албан хаагчдаар"ЭАИ"ХХК-ийн хувьд ямар ажил гүйцэтгэснийг мэдэхгүй, хараагүй. Ямар ч байсан тайлан бичиж өгсөн. Тайланд бичсэн ажлаа хийсэн байх. Гэрээгээр гаргаж өгсөн төсөв 58 сая төгрөгөө манайх зарцуулсан. Гэрээний санхүүжилт нийт 76 сая төгрөг байсан. Үүнээс манай 58 сая төгрөгийг өгсөн. Үлдсэн 18 сая төгрөгийг "ЭАИ"ХХК авсан байх шууд "Цэвэр агаар сан"-гаас манай дансанд мөнгө орж шилжигдээгүй" гэх мэдүүлэг /9 хавтас-037, 038/.

Гэрч Г.Ба мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /М.Аб-ын эхнэр/ "...ЭАИ" ХХК-ийг 2011 оны 4 сард миний нөхөр М.Аб болон түүний нутгийн ах гэх Н.Хү нар үүсгэн байгуулсан ба ингэж байгуулахдаа миний эгч Г.Ц-ын нөхөр Б.Б-г хөрөнгө оруулагчаар оруулан байгуулсан байдаг юм. Б.Б нь өөрөө манай нөхөртэй мэргэжил нэгт хүн байгаа юм. Энэ компанид миний бие тушаал шийдвэр гаргуулан ажилд ажиллаж байсан зүйл байхгүй. Би өөрөө "ЧМ" ХХК-д нягтлангаар ажилладаг юм. "ЭАИ" ХХК -ийг байгуулахад манай нөхөр М.Аб одоо ажиллаж байгаа Үндэсний Хөгжлийн хүрээлэндээ ажиллаж байсан санагдаж байна. Одоо ч энэ хүрээлэндээ секторын эрхлэгчээр ажиллаж байгаа."ЭАИ" ХХК

-д 2011 оны 6 сарын сүүлчээр байх "ИЙТ" ХХК-аас 84,6 сая төгрөгийн санхүүжилт 2 удаагийн гүйлгээгээр орж ирсэн. Энэ талаар нөхөр маань надад "Гэр хорооллын жорлон муу усны нүх ариутгах төсөл байгаа юм. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах юм. Бүх ажлын төсөв тооцоог Б.Чи гаргаад түүнийгээ зарцуулсан баримтыг чамд гаргаад өгнө чи тайлан тооцоог нь гаргаад өгөөрэй" гэсэн юм. Ингэж л Б.Чи гэх хүнийг мэдэх болсон намайг сарын 500.000 төгрөгөөр цалинжуулна гэсэн. Энэ ажил нь 6-9 сарыг дуустал 4 сарын хугацаатай ажил байсан. "ИЙТ" "ЭАИ" ХХК хоёрын хооронд хийсэн гэрээ хэлцлийг мэдэхгүй, хэрхэн бие биенээ олж гэрээ хийх болсныг би мэдэхгүй. Ингэж манайд орж ирсэн 84,6 сая төгрөгөөс НИХГ-ын нийт лабораторийн төлбөрт 22 сая төгрөг шилжүүлсэн, НМХГ-ын 22 улсын байцаагч нарт цалин гэж 17,341 төгрөг гарт нь олгосон. Хувь хүний орлогын албан татварт гэж БГД-ийн татварт 1,468,000 төгрөгийг тушаасан. Нийгмийн даатгалын шимтгэлд 4,389 төгрөгийг, төслийн ажилтнуудын цалин хөлс гэж Б.Чи 5 сая орчим төгрөг авсан, гэрээгээр 2 машин хөлсөлсөн гэж 3 сая төгрөг Б.Чи авсан. М.Аб-д буюу "ЭАИ" ХХК-д 6,5 сая төгрөг өгч М.Аб ДИ гээд ТББ-д шилжүүлэн гарган авсан. Энэ явцад М.Аб үйл ажиллагааны зардалдаа 600,000 төгрөг зарцуулсан. Надад цалин хөлс гээд 2,605,000 төгрөг өгснийг би шилжүүлэн зарцуулж түрээсийн төлбөр гээд гэж авсан. Бичиг хэргийн зардалд би 360,500 төг зарцуулсан. Дотоод ажлын шатахууны зардалд 1,540,000 төгрөг зарцуулсан. Тайланд тусгасан ажлыг хийхэд түрээсийн байранд байрлаж байрны түрээсэнд 820.000 төгрөг төлсөн. Банктай холбоотой зардал /тендерийн баталгаа нотариат зэрэгт зарцуулсан/ 204,200 төгрөгийг зарцуулахаар авсан. 16,570,000 төгрөгийг Б.Чи шинжилгээ буюу бусад зардалд гэж авсан болно. Ингээд л энэ 84,6 сая төгрөг дууссан. Би өөрөө НМХГ-т шинжилгээний төлбөрт гэж 22 сая төгрөг шилжүүлсэн. Мөн ажилласан улсын байцаагч нарт цалин гэж 6-7 сая төгрөгийг гарт нь олгосон. Ингээд татварт төлөх /НДШ, ХАОАТатвар гэх зэрэгт/ 1.468.01 төгрөгийг манай дансанд үлдээсэн, Тэгээд надад олгосон цалин 2,605,000 төгрөг тэгээд дотоод ажлын зардал шатахууны зардлыг би зарцуулсан. Ингээд бусдыг нь Б.Чи бэлнээр гаргуулан авсан. Нийт 27,3 сая төгрөгийг авсан. Энэ авсан мөнгөнөөс

16,5 сая төгрөгийн зарцуулсан баримтыг Б.Чи надад өгөөгүй. Нэг удаа "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү-д гээд албан бичиг бичихэд нь л би Н.Хү-тэй холбоотой ажил байна гэж ойлгосон учир нь энэ компанийг Н.Хү-тэй хамтран байгуулсныг би мэдэж байсан. Б.Чи л бүх л зарцуулалтыг хийдэг байсан манай нөхөр бол зөвхөн гарын үсэг зурах хэмжээнд миний хувьд Б.Чи-ийн гаргаж өгсөн баримтаар татварт өгөх тайлангаа гаргадаг байсан. Түүнээс Н.Хү энэ ажилтай холбоотой ирж байсныг би мэдэхгүй хараагүй. Б.Чи авсан мөнгөөрөө тэр жорлон муу усны нүх рүү нь хэрхэн орж дээж авч явдаг байсныг би мэдэхгүй. НМХГ-ын улсын байцаагч нар ч хэрхэн ажиллаж байсныг би мэдэхгүй ямар ч байсан хамтран ажиллаж байгаа юм байна гэдгийг ойлгосон. Дараа Газар зүйн хүрээлэнтэй хамтран "ЭАИ" ХХК түншлэлийн гэрээ хийж энэ гэрээгээр манай дансанд 18 сая төгрөг "Цэвэр агаар сан"-гаас орж ирсэн. 9 сая төгрөгөөр 2 удаа орж ирсэн. Энэ гэрээгээр бол "ЭАИ" ХХК ямар нэгэн ажил үйлчилгээ явуулаагүй. 18 сая төгрөгөө бэлнээр гаргасан. 9 сая төгрөгийг Н.Хү ахад буюу хувьцаа эзэмшигчид өгсөн гэсэн. Тэгээд өөрт нь ногдох 9 сая төгрөгөөс 5 сая төгрөгийг нь ДИ ТББ-руу шилжүүлэн тэндээсээ бэлнээр гаргаж авсан. Ингээд үлдсэн 4 сая төгрөгөөр компанидаа вэб сайт хийлгэсэн Газар зүйн хүрээлэн нь ямар ажил хийсэн би мэдэхгүй. Энэ ажлыг хэрхэн олж хийх болсныг би мэдэхгүй. Үүний дараа Халаагуурын төсөл гэсэн ажил хийсэн. Гэр хороололд халаагуур тавьж туршсан юм шиг байна лээ тэгээд энэ ажлыг хийснээр иргэдэд ямраар нөлөөлж байгааг судлах ажил юм гэсэн. Энэ ажлыг нөхөр М.Аб надад хэлэхдээ Б.Чи ярьж байна ийм ажил байна танайх руу шилжүүлээд хийчих гэж байна гэхлээр нь би өмнөх төсөл шигээ багаа бүрдүүлээд татвараа төлөх юм бол манай компанид хэрэгтэй түүх бүтээхэд гэж хэлсэн юм. Ингээд л энэ ажлыг хийх болсон. Нийт санхүүжилт нь 89,6 сая төгрөгийн ажил байсан. Энэ орж ирсэн мөнгөнөөс "ИХА" ХХК-д ТЭСТО-340 багажийн үнэ гэж 30.0 сая төгрөг шилжүүлж өгсөн. НМХГ-ын улсын байцаагч нарт цалин гарт нь гэж 13.500,000 төгрөгийг Б.Чи авсан. Гэрээт ажилтны цалин хөлс гэж 7,5 сая төгрөгийг Б.Чи авсан. Компанийн дансанд үйл ажиллагааны зардал, татварт гэж тооцоод 13 сая төгрөг үлдээсэн. 2 автомашин түрээслэн ажиллуулсан гэж 3 сая төгрөг, Б.Чи өөрийн үйл ажиллагааны

зардал гэж 5,5 сая төгрөг гэж авсан байгаа. Ингэж орж ирсэн 89,6 сая төгрөгөөс би 13,952,900 төгрөг авсан. Энэ мөнгийг хувь хүний орлогын албан татварт 1,444,500 төгрөгийг, БГД-ийн татварт 540,500 төгрөгийг, Нийгмийн даатгалын шимтгэлд 3,370,500 төгрөгийг, байрны түрээсийн зардалд 2,7 сая төгрөг, шатахуун сэлбэг хэрэгслийн зардалд 1,060,000 төгрөг, банкны шимтгэл хураамж, аудитын зардалд 757,400 төгрөг гэж зарцуулсан. Ингээд би цалинд 3 сая төгрөг авсан. Багажийн мөнгө гэж шилжүүлсэн 30 сая төгрөгийг би шилжүүлсэн. Бусад зардлыг Б.Чи хэлэх ёстой.

Учир нь тэр авч зарцуулсан. Энэ санхүүжилтээс манай нөхөр ашиг аваагүй. Эдгээр ажил үйлчилгээний санхүүжилт манай компанийн дансанд 2011 оны 06 сараас эхлээд 12 сарын 15-ны хооронд хийгдэж байсан. Ажил гүйцэтгэл нь бол 2012 оны 03 сараар дууссан гэж тайлан гаргасан байдаг." гэх мэдүүлэг /9-р хавтас-061, 062/,

Гэрч Б.Хз-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "МДа" ХХК-д мэргэжилтэн/ "...М.Ху бол миний ээж М.С-гийн төрсөн дүү нь байгаа юм. Энэ хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн гэдгийг сонссон. "ШГД" ХХК-ийг 2011 оны 7 сард миний бие болон манай ах Б-гийн найз Бл бид хоёр үүсгэн байгуулсан. Үйл ажиллагаа явуулж байгаагүй Х тайлан өгөөд л явдаг одоо ч гэсэн. БГД-гийн татварт харьяалагддаг. Энэ компанийн нэрийг М.Ху эгч надад санал болгосон юм. Ямар учиртайг нь би мэдэхгүй. Би аж ахуйн нэгж байгуулах гэж байгаа Оюу толгой руу бараа нийлүүлэх санаатайгаа М.Ху эгчид хэлж байсан чинь тэгвэл би ийм нэртэй аж ахуйн нэгж байгуулаарай гэсэн юм. Тэгээд тэр нэрийг нь өгсөн. Байгуулагдсанаасаа хойш ямар ч үйл ажиллагаа явуулаагүй. Баянгол дүүргийн татварт 25,1 сая төгрөгийг 2012 онд тушааж байсан.М.Ху эгчийн ажлын газраас 251,000,000 төгрөг "ШГД" ХХК-ийн ХААН банк дахь дансанд орж ирсэн юм. Хэдний өдөр хичнээн удаагийн гүйлгээгээр орж ирсэн санахгүй байна. М.Ху эгч над руу утасдаад танай дансанд мөнгө орчихсон байгаа бэлнээр гаргаад аваад ир гэсэн юм. Үүнээс өмнө М.Ху эгчид компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ байсан ба түүн дээр банкны данс бичээтэй байдаг юм. Ингээд би банкнаас 225 сая 9-н зуу гаран мянган төгрөгийг бэлнээр гарган М.Ху-д эгчид хүргэж өгсөн. ЧД-гийн нутаг, хуучны хүнсний ...дүгээр дэлгүүрийн ард байрлах М.Ху эгчийн гэрт нь

хүргэж өгсөн. Тухайн үед ганцаараа явсан. М.Ху эгчийнд хүн байсан эсэхийг санахгүй байна. Тэгэхэд М.Ху эгч надад 2 сая төгрөгийг миний дүү өөртөө зарцуулаарай, дансанд үлдсэн мөнгийг татварт өгнө гэж хэлсэн. М.Ху эгч надаас авсан тэр мөнгөө хэрхэн юунд зарцуулсан цааш нь хэнд өгсөн талаар би мэдэхгүй. Би тэр мөнгийг данснаас аваад ганцаараа М.Ху эгчийнд оруулж өгсөн. Өөр хүнд хүргэж өгөөгүй. М.Ху эгчтэй хамт ч өөр хүнд хүргэн өгөөгүй. Н.Хү, Д.Цэ, Х.Бо, Б.Чи гэх хүмүүсийг танихгүй уулзалдаж байгаагүй, сая л зурагтаар "Цэвэр агаар сан"-тай холбоотой хэрэг гээд гарч байна лээ." гэх мэдүүлэг /9-р хавтас х-00065/,

Гэрч Б.Чу мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Н.Хү-ийн эхнэр/ "...ЭИАЭ" болон "АЭЭ" ХХК -иуд бол нөхөр Н.Хү-ийн төрсөн дүү Н.М-ийн үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжүүд. Өнгөрсөн 4 сарын сүүлчээр л манай гэрээр ирээд явахдаа орхиод явчихсан юм. Н.М-ийнх Дархан уул аймаг руу 2013 оны 4 сараас шилжээд явчихсан юм. Энэ аж ахуйн нэгжүүд нь ямар үйл ажиллагаа явуулдаг талаар би мэдэхгүй, түүнээс Н.Хү болон надтай ямар ч холбоогүй юм. Х.Б бол бидний дундах хүүхэд,бид Капитал банкинд хадгаламжийг хамтран эзэмшдэг энэ хадгаламжийн дэвтэрт би л орлого хийдэг. Одоо 12 настай сургуульд сурдаг. Н.Хү маань "Цэвэр агаар сан"-гийн захирал болохоосоо өмнө "ЛЭХ" ХХК-ийг 2000 онд үүсгэн байгуулж барилга угсралтын үйл ажиллагаа явуулж байсан. 2008 он хүртэл барилга барьж явсан. 2004 оноос л би энэ компанийг нь удирдан зохион байгуулан үйл ажиллагааг нь явуулах болсон. Учир нь Н.Хү өөрөө төрийн үйлчилгээний албанд ажилд орсон. 2006 оноос хойш Н.Хү компанийн үйл ажиллагаанд ороогүй. Манай компани БГДүүрэг 2 хороонд СБД-гийн 8 хороонд орон сууцны барилга барьж борлуулж байсан юм. "ЛЭХ" ХХК 2008 оноос хойш ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй ба өмнөх оны байрны төлбөрөөс л орлого олдог. Түүнээс өөр ашиг бол байхгүй. 2012.06.18 нд хадгаламжийн дэвтэрт хийсэн 80,000,000 төгрөг бол түрээсийн орлогоо цуглуулж байгаад бөөнд нь хийсэн юм. Одоо манай гэр бүлд БГДүүргийн 2 хороонд цэцэрлэгийн барилга, мөн хорооны нутаг дэвсгэрт барьсан 200 айлын орон сууцнаас 8 ширхэг орон сууц нь манай өөрийн нэр дээр бүртгэлтэй ба тэдгээрийгээ бусдад түрээсэлдэг. Мөн авто грашийн зогсоол 6 ширхгийг, подвалийн



талбай түрээсэлдэг. Ингээд эдгээрээс сардаа 10 гаран сая төгрөг олдог юм. Энэ бүгдийг би өөрөө л хариуцан ажилладаг. Н.Хү оролцдоггүй. Х.Т бол манай том охин. Түүний Голомт банкны дансанд 2010.03.03-нд хийсэн 38.000.000 төгрөг, 2011.07.06-нд хийсэн 30.000.000 төгрөг мөн л түрээсээ цуглуулж байгаад хийсэн орлого. Би л хийсэн мөнгө. Түрээсийг нэг дотор авдаггүй болохоор бөөгнүүлж байгаад хийчихдэг юм. Түрээсийн гэрээнүүд надад байгаа, шаардлагатай бол түрээслэж байгаа иргэдтэй уулзаж болно. Манайх зөвхөн цэцэрлэгээ сарын 5 сая төгрөгөөр түрээслэдэг юм. Манай "ЛЭХ" ХХК Нийслэлийн татварт харьяалагддаг. 2008 оноос үйл ажиллагаа явуулаагүй. 2010 онд манай компанид татварын шалгалт орж байсан. "ЭАИ" ийг байгуулахад 45 хувийн хөрөнгө оруулсан гэдгийг л мэднэ, хөрөнгө орлогын мэдүүлэгтээ бичиж байсан юм. Энэ компани нь хаана байрлаж, ямар үйл ажиллагаа явуулдгийг нь мэдэхгүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-069, 070/.

Гэрч Э.Эб мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн агаарын чанарын албаны бодлого хэрэгжилт төлөвлөлтийн хэлтсийн түлшний бодлогын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн/ "...Цэвэр агаар сан" бол Агаарын бохирдолтой холбоотой төсөл ажлуудыг санхүүжүүлэгч байгууллага юм. Энэ төсөл ажлыг Агаарын бохирдол бууруулах үндэсний хорооноосоо тогтоолоороо батлаад гаргаад өгчихдөг юм. Энэ тогтоол дээрээ ямар ямар ажлыг аль байгууллага нэгж хийх вэ гэдгийг нь заагаад өгчихдөг. Тэр дагуу л хариуцсан байгууллага нэгж тухайн ажлыг зохион байгуулна. Нийслэлийн агаарын чанарын албаны хувьд Нийслэлийн хэмжээнд бүрэн шаталттай сайжруулсан зуухны баталгаажуулалтыг манай алба хийдэг. тодруулж хэлбэл. Иргэдэд тухайн зуух бүрэн хүрч ашиглагдаж байгаа эсэхэд хяналт тавьдаг, Мөн боловсруулсан түлшний үйлдвэрүүдийн /гэрээтэй/ үйл ажиллагаанд хяналт тавих хэлбэрээр ажилладаг. Мөн цахилгааны хөнгөлөлт эдлэх айл өрхийг Эрчим хүчний газарт уламжилдаг. Энэ бүх ажлыг нь бол "Цэвэр агаар сан"-гаас санхүүжүүлдэг юм. Захиалагч нь бол Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль Орчны яам зэрэг байдаг. Боловсруулсан түлш нийлүүлэх гэрээ хийхээс нь өмнө болон гэрээ хийсний дараа тухайн аж ахуйн нэгжийн боловсруулсан түлш үйлдвэрлэх үйлдвэр

дээр нь очиж үзэж танилцдаг. Ганц манайх ч танилцахгүй санхүүжүүлэгч Цэвэр агаар сангаас ч очиж танилцсан. Ингээд гэрээ хийх боломжтой эсэхээ шийддэг. Энэ гэрээ сонгон шалгаруулалтаар хийгддэггүй юм. Гэрээ хийх бол гэрээний төслөө гурван тул буюу захиалагч манайх, санхүүжүүлэгч Цэвэр агаар сан, нийлүүлэгч ахуйн нэгж хамтран боловсруулдаг. "Цэвэр агаар сан"-гаас хуульч Б.Со гэрээ боловсруулахад оролцдог. Манай албанаас миний бие оролцдог. Ингээд гэрээний төслөө боловсруулаад холбогдох дарга нарт танилцуулаад санал авна. Саналгүй бол гэрээгээ хийдэг. Гэрээнд хамгийн эхлээд түлш нийлүүлэгч аж ахуйн нэгж гарын үсгээ зурж тамгаа дардаг. Тэгээд дараа нь захиалагч тал буюу Нийслэлийн Засаг даргын орлогч гарын үсгээ зурж тамгаа дардаг. Ингээд сүүлд нь санхүүжүүлэгч буюу "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү гарын үсэг зурж тамгаа дардаг. Гэрээ 3 хувь үйлдэгдэж тус бүр нэг нэгээр нь авдаг юм. Гэрээний хэрэгжилтийг захиалагч, санхүүжүүлэгч 2 тал хяналт тавьж ажилладаг. Мөн манай алба нь тухайн нийлүүлсэн түлш иргэдэд хэрхэн хүргэх ажлыг зохион байгуулах ажлыг хариуцан ажилладаг юм. 2011 онд гурвалсан гэрээгээр нийт 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. "ШГЭ" ХХК, "НТ" ХК, "Т" ХХК, "ӨТ" ХХК. "ХӨ", ХХК, "ГБ" ХХК, "МТХС" сан, ХБТ ХХК, "ҮШТҮ" НӨҮГазар, "Т" ХХК, "МAM" ХХК, "ӨӨМ" ХХК зэрэг болно. Эдгээр аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ манай албанд бүгд хавтаслагдсан байгаа. 2012 онд нийт 10 аж ахуйн нэгжүүдтэй түлш нийлүүлэх гэрээг байгуулсан. Тухайлбал "Вм" ХХК, "ДАг" ХХК, "ГБ" ХХК, "ХБт" ХХК. "ҮШТҮ" НӨҮГазар, "Т" ХХК, "Т" ХХК, "МННБД" ХКК, "ШГЭ" ХХК, "МAM" ХХК зэрэг болно. 2011 онд гэрээ хийгдээгүй. Тухайн гэрээ хийсэн аж ахуйн нэгжээс Боловсруулсан түлшээ үйлдвэрээс нь хүлээн авдаг. Ингэхдээ баримт үйлддэг. Манай албанаас хүн байдаг. Зарим тохиолдолд би өөрөө хүлээн авахад оролцдог. Өвлийн улиралд Баянгол дүүргийн боловсруулсан түлш жижиглэнгээр борлуулах цэг гэж байдаг тэдгээртэй шууд тээвэрлэлтийн аж ахуйн нэгж холбогдоод баримт үйлдээд баримтаа манайд ирүүлдэг юм. Манай алба тухайн гэрээгээр заасан үүргээсээ тэдний өдөр төнчөөн түлш нийлүүлсэн гэдгийг нь баталгаажуулаад "Цэвэр агаар сан"-д албан бичгээр хүргүүлдэг. Ингээд нийлүүлсэн түлшинд нь тааруулаад санхүүжилтээ

"Цэвэр агаар Сан"-гаас олгодог. Хэрхэн санхүүжилтээ шилжүүлдэг талаар би хэлж мэдэхгүй. Зуны улиралд Түлш үйлдвэрлэгч нараас үйлдвэрлэсэн түлшийг нь авч нөөцлөх зорилгоор, авсан түлшээ түрээсийн агуулахад хадгалдаг. Манай алба агуулах түрээслэхэд "Цэвэр агаар сан" санхүүжүүлэгчээр оролцдог. Мөн халаалтын улирал эхлэх үед боловсруулсан түлшийг жижиглэн борлуулах, тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжүүдтэй мөн гэрээ байгуулахад санхүүжүүлэгч талаас "Цэвэр агаар сан" оролцдог юм. Өөрөөр "Цэвэр агаар сан"-тай гэрээнд оролцдоггүй. "Цэвэр агаар сан" өөрөө 5-хан ажилтантай тэднийг бүгдийг нь мэднэ. Ажил төрлийн холбоотой болохоор түүнээс садан төрлийн хүн байхгүй. Улаанбаатар хотын хөрсний бохирдлын судалгаа хийх, Гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхэнд ариутгалын бодис хийх түүний мониторинг мөн гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур тавьсан үр дүнгийн мониторинг хийх ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ хэлцлийн талаар би мэдэхгүй, манай албанд бүртгэлгүй. Нийслэлийн Засаг даргын захирагчийн албанд бохирдол Хог хаягдлын менежментийн хэлтэс гэж байдаг тэдэнтэй л хамаатай байх гэж бодож байна. Гэрээний хэрэгжилт нийлүүлэлтэд "Цэвэр агаар сан"-гаас хааяа Г.Бс ах хянадаг. Өөр хүн ирдэггүй. Түлш ачиж байгаа, буулгаж байгаа гэдгийг нь ирж хардаг.Түүнээс нэг вагон буулгахад дуустал нь байдаггүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-072, 073/.

Гэрч М.Цч-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /МХЕГ-ын Санхүү хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын газарт санхүүгийн хяналт хэлтсийн улсын байцаагч/ "...Миний бие 2012 оны 02 сарын 1- ний өдрөөс эхлэн ажлын 21 хоногт багтаан Улсын ахлах байцаагч Б.Ат, Д.Гэ нарын хамт МХЕГазрын даргын баталсан удирдамжийн дагуу "Цэвэр агаар сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн шалгалтыг "Цэвэр агаар сан"-гийн ажлын байранд явуулсан. Энэ шалгалтын дүнг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй ба газар хэлтсийн дарга нарт л шалгах явцаа танилцуулан шалгалтын дүнг гарган "Цэвэр агаар сан"-д танилцуулж дараа нь газар хэлтсийн дарга нартаа танилцуулсан. Шалгалтаар "Цэвэр агаар сан"-д Улсын байцаагчийн 3 актаар нийт 1 тэрбум 420 сая 832 мянга 104 төгрөгийн төлбөр зөрчлийн акт тавьсан.

Шалгалтын явцад 11 тэрбум 283 сая 300 мянган төгрөгийг "Цэвэр агаар сан"-гийн дансанд буцаан төвлөрүүлсэн. Өөрөөр хэлбэл, Хас, Голомт банкинд гэрээт аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаарлан байрлуулсан байсныг "Цэвэр агаар сан"-гийн Төрийн сан дахь дансанд эргүүлэн татсан болно. Улсын байцаагчийн тавьсан 3 актаа нэг бүрчлэн яривал:

1. "Т" ХХК 50 сая төгрөгийг санхүүжилт "Цэвэр агаар сан"-гаас авсан боловч уг санхүүжилтийнхээ 26,5 сая төгрөгийн түлшээ нийлүүлсэн үлдсэнийг нийлүүлээгүй байсан тул зөрүү 23,5 сая төгрөгийн төлбөрийн актыг "Цэвэр агаар сан"-д хариуцуулсан тавьсан.

2. 2011 оны 11, 12 сар 2012 оны 1, 2 саруудад айл өрхүүдэд борлуулсан түлшний үнэ 446,7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүл гэж "Цэвэр агаар сан"-гийн захирал, нягтлан нарт акт тавьсан байгаа. учир нь БТҮТ Айл өрхүүдэд борлуулсан түлшний үнийг цуглуулан эргүүлэн "Цэвэр агаар санд 96,1 сая төгрөгийг тушаах ёстой байсан боловч тушаагаагүй байсан ба төвлөрүүлээгүй 96,1 сая төгрөгийг төвлөрүүлсэн 350,6 сая төгрөгийн хамт Улсын Орлогын дансанд тушаах ёстой гэж үзсэн. Яагаад гэвэл 2011 оны жилийн эцэс гэхэд энэ мөнгө улсын төсөвт орох ёстой гэж акт тавьсан юм.

3. "МAM" ХХК, "ШГЭ" ХХК "ШГД" ХХК-иуд нь гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 2011 онд 950,2 сая төгрөгийн ажил үүргээ биелүүлээгүй байсан учир энэ мөнгөн дүнд нь улсын төсвийн орлогод тушаа гэж акт тавьсан. Эдгээр актуудыг "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Хү нар танилцаж зөвшөөрч гарын үсгээ зурсан байгаа. "ШГД" ХХК-нд 240 сая төгрөг шилжүүлж 2011 оны 11 сараас 2012 оны 03 сар дуустал 7600 тонн хагас тонн коксжсон нүүрс нийлүүлэх гэрээтэй боловч энэ компани гэрээний үүргийн биелүүлээгүй байсан учир акт тавьсан. Гэрээг би үзсэн эсэхээ санахгүй байна баримтаа л үзэх хэрэгтэй байна. Дээрх компаниудтай холбоотой актыг "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү, М.Хү нарт танилцаад гарын үсгээ зурсан. Тэдний хэн нь ч ямар ч тайлбар гаргаагүй. Танилцуулах үед би байсан эсэхээ санахгүй байна. Эхлээд бид гурав актаа гаргаад гарын үсгээ зураад л танилцуулах ёстой. Тэднийх нийт 5 албан хаагчид ажиллаж байсан. Надад танил хүн байгаагүй. "Цэвэр агаар сан" анх 2011 оны 4 сард

байгуулагдсан байдаг. Тэгээд 2011 он дуустал 2012 оны эхний хоёр сарын санхүүгийн баримтыг авч үзэж шалгасан. 2011 онд нийт 31,5 тэрбум төгрөг төсөвт нь батлагдаад. Үүнээс гүйцэтгэлээр 27 тэрбум 973 сая 470 мянган төгрөг зарцуулагдсан. Батлагдсан төсвөөс 3 тэрбум 526 сая 500 мянган төгрөг хэмнэсэн байсан. Шалгалт хийхдээ Санхүүгийн анхан шатны баримтуудыг үзэж танилцсан. Гэрээ хийсэн бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн талтай нэг бүрчлэн биечлэн уулзаж байгаагүй. Автобус баазуудаар л явж үзсэн. Гэр хорооллын айл өрхүүдийг боловсруулсан түлшээр хангах ажилд 2011 онд 3,4 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,3 тэрбум төгрөг зарцуулсан байсан. Нэр бүхий 11 байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ хийсэн байсан гэрээг нэг бүрчлэн үзсэн. Шаардлагатай бол бидний хийсэн шалгалтын материалыг үзэж болно, манай архивт хадгалагдаж байгаа. Түлш нийлүүлэх төсвөөс дутагдал бол байхгүй харин банкинд тусгаарлан байршуулсан байсан мөнгийг буцаагаад "Цэвэр агаар сан"-гийн дансанд 2012.03 сард эргүүлэн татсан. Бидний хийсэн шалгалтаар "ШГЭ" ХХК-тай л холбоотой гэрээ байсан. "ШГЭБ" ХХК гэж дуулаагүй. Ийм нэртэй аж ахуйн нэгжтэй хийсэн гэрээ хэлцэл хараагүй. Бид "Цэвэр агаар сан"-гийн төрийн сангийн гүйлгээний дансны хуулгыг авч үзсэн. Надад бол шалгалтын явцад хэн нэг нь нөлөөлсөн зүйл огт байхгүй. Миний хувьд шинээр томилогдон ажлаа аваад удаагүй, ажил мэргэжилдээ сайн дадаагүй байдал байсныг үгүйсгэхгүй. Түлш нийлүүлэх гэрээнүүдийг би харж байсан. Харин энэ гэрээний санхүүжилт хэрхэн хийгдсэн талаарх дансны хуулга зэргийг би үзэж танилцаагүй. Манай Б.Ат, Д.Гэ нар харсан тэд олон жил ажиллаж байгаа намайг бодвол туршлагатай хүмүүс. Тэдний ажлыг би заагаад эсхүл хажуугаас нь харж оролцоод байх шаардлага байхгүй. "ЭАИ" ХХК-тай хийсэн гэрээ хэлцэл байсан. Гэр хорооллын айл өрхүүдийн жорлонгийн халдваргүйжүүлэлтийн ажлын үр дүнд мониторинг хийж дүгнэлт гаргах ажлыг хийсэн байдаг. Гэхдээ "ИЙТ" ХХК-тай гэрээтэй ажилласан байдаг. Би сайн тодорхой санахгүй байна. Бас Халаагуур суурилуулсан айл өрхүүдийн үр дүнгийн мониторингын ажлыг энэ "ЭАИ" ХХК хийсэн байдаг. Гэрээний нийт төсөв нь хэд байсныг санахгүй байна. Би тайлангуудыг нь л үзэж байсан. Гэрээ хийгдсэн байсан

санагдаж байна.Тухайн шалгалтын үед авч байсан баримтууд манай архивт байх ёстой түүнийгээ үзэж байж тодорхой хэлэх хэрэгтэй байна. Миний санаж байгаагаар "ЭАИ" ХХК -тай холбоотой өөр ажил үйлчилгээ хийлгэх гэрээ байгаагүй. Энэ аж ахуйн нэгжтэй хийсэн ажил гүйцэтгэлд ямар нэгэн дутагдал зөрчил байгаагүй. Б.Ат, Д.Гэ бид гурав ажил хуваарилан авч хийгээгүй. Шалгалтын явц л намайг хүснэгт хийлгэх, тэгээд тендерээр хийж буй ажлын гүйцэтгэлийг нэгтгэх, Авто бааз руу явах,"ЭАИ" ХХК-тай хийсэн ажлын тайланг үзэх, Хас, Өлзий зуухны тоог гаргах, "ЦТ" ХК-луу очиж Дуобус хийж байгааг үзэх, Сэлбэ голын эх дээр ногоон бүс байгуулах хашаа хамгаалалт хийх мөсөн тошин хийж байгааг очиж танилцах гээд ер нь гадуур явах ажлыг хий гэдэг байсан. "Цэвэр агаар сан"-гийн санхүүгийн гүйлгээтэй үзэж танилцаагүй, баланс харсан. Гэхдээ балансас мөнгөн дүн л хардаг юм. Нарийн задаргааг хараагүй. "Цэвэр агаар" сангийн төсвийн үзүүлж байсан." гэх мэдүүлэг /9-р хавтас х-077, 078/,

Гэрч Ч.Үр-гийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт Эрүүл мэнд, боловсрол, соёлын хэлтэст хяналтын улсын ахлах байцаагч/ "ЭАИ" ХХК гэдэг компани байдаг гэдгийг мэддэг болохоос хаана, ямар үйл ажиллагаа явуулдгийг нь мэдэхгүй. 2011 оны 11 сараас 2012 оны 03 сар хүртэлх хугацаанд "Цэвэр агаар сан"-гаас манай байгууллагад "Цэвэр агаар" төслийн хүрээнд 200 айлд шингэрүүлсэн хийн зуух тавих ажлын үр дүнг судлах ажилд улсын байцаагч томилж ирүүлнэ үү гэсэн утгатай албан бичиг ирсэн санагдаж байна. Энэ албан бичгийг манай газрын даргаас л надад цохолт хийж өгсөн учир миний бие цохолтын дагуу Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас нийт 10 гаран улсын байцаагчийн нэрийг би өгсөн. Одоо бол би тэр нэрсийг хэлж санахгүй байна. Түүнээс хойш 2 удаа "Цэвэр агаар сан"-гийн байранд очиж хуралдсан. Манай байгууллагаас миний бие очиж байсан. "Цэвэр агаар сан"-гийн Н.Хү хурлаа удирдаж байсан. Энэ хуралд Нийслэлийн агаарын чанарын албаны хүмүүс байсан мөн хийн зуух тавих компанийн хүмүүс байсан. Онцгой байдлын хүн байсан. Ингээд энэ төсөлд ажиллах албан хаагч хүн бүртэй Б.Чи гэх эмэгтэй гэрээ хийсэн. Тэр Б.Чи гэх эмэгтэй л бүх ажлыг зохион байгуулан ажиллаж байсан. Б.Чи нь "Цэвэр агаар сан"-гийн ажилтан гэж

би ойлгож байсан. Улсын байцаагч нарыг би удирдан ажиллах болсон. Хэн хэнийгээ хэдний өдөрт гэх хуваарийг би гарган ажилласан. Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын айл өрхүүдээр л явж ажилласан. Хийн зуух тавьсан айл өрхүүдийг улсын байцаагч нарт мэдэгдээд тэр айлуудаар нь улсын байцаагч нар явж айл өрхийн чийглэг байдал гадна дотно температурт хэмжилт хийх зэргээр ажилласан. Мөн гэр доторх агаарын хийн найрлага зэргийг судлаж явсан. Ингээд айл өрхийн хүмүүстэй уулзалдсан. Хийн зуух тавьснаар ямар байгаа эрүүл мэнд ахуйн байдал ам хамар хуурайших зэрэг өөрчлөлт орж байгаа эсэх гээд л. Энэ ажлыг манай улсын байцаагч нар хийхдээ хагас бүтэн сайн өдөр буюу амралтын өдрөөр хийж гүйцэтгэж байсан. Ажилласан байцаагч нар надад хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг өгөөд би түүнийг нь нэгтгээд л 2012 оны 04 сард Б.Чи-д гаргаж өгсөн. Энэ ажлыг манай байгууллагын улсын байцаагч нар ажиллахдаа ажилласан сараараа тусдаа цалин авч байсан. Миний хувьд сард 250,000 төгрөг авсан. Хамгийн сүүлд 150,000 төгрөг өгсөн. Цалин Б.Чи бэлнээр олгоод гарын үсэг зуруулдаг байсан. Манай улсын байцаагч нар цалин гэж хэд хэдэн төгрөг авсныг би хэлж мэдэхгүй. Өөр өөрсдөөс нь асуух хэрэгтэй. Миний мэдэж байгаагаар Манай байгууллагад агаарын чанарыг хэмждэг 3 ширхэг багажийг "Цэвэр агаар сан"-гаас авч өгсөн. Тэгээд манай лабораторит 2 ширхэг багажийг нь авсан байгаа нөгөө 1 багажийг нь манай байцаагч нар албан үүрэгт ажилдаа ашиглаж байгаа. Ямар үнэ ханштай багаж болох талаар би мэдэхгүй. "Цэвэр агаар сан" дээр очиж тэр гурван багажийг авчирч байсан тийм болохоор "Цэвэр агаар сан"-гаас өгсөн гэж ойлгож байна. "ЭАИ" ХХК-ийн талаар бол ажлаа хийж гүйцэтгээд тайлан бичих болоход энэ компанийн нэр гарч ирсэн юм. Бас цалин авахдаа нийгмийн даатгалын шимтгэлээ бичих хэрэгтэй гээд л Б.Чи-эс асуутал "ЭАИ" ХХК-аас төлчихсөн гээд Баянгол дүүргийн татварыг хэлтсийг хэлж байсан.Тэгээд би энэ компанийн нягтлан Г.Ба гэх эмэгтэй дээр очиж бичилт хийлгэж байсан юм. Энэ ажлаас өмнө буюу 2011 оны 7, 8, 9 саруудад юм. "Цэвэр агаар сан" гаргасан хүсэлтийн дагуу манай байгууллагаас мөн л 10 гаран улсын байцаагч айл өрхүүдийн жорлон, муу усны нүхэнд ариутгал цацсаны дараах чанарыг үзэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн л энэ ажлыг Б.Чи зохион байгуулан ажиллаж,

цалин хөлс гэж олгосон. Энэ ажилд манай байгууллага дангаараа ажилласан. Гэр хорооллын айл өрхүүдийн жорлон муу усны нүхэнд ариутгах бодис хийсний үр дүнгийн мониторингийн ажилд Н.Хү ямар ч байдлаар оролцож байгаагүй. Харин хийн зуух тавьсан айл өрхүүдийн үр дүнгийн мониторинг хийж ажлыг эхлээд 2 удаа Н.Хү хурал удирдаж байсан. Б.Чи бусад ажлыг нь зохион байгуулж, манай албан хаагч нарын хийж байгаа ажилд зарим тохиолдолд хамт яваад хяналт тавьж байсан гэдэг. Манайхаас өгсөн 7 хоногийн ажлын тайланг нэгтгээдэг байх. Б.Чи-эс өөр ямар албан тушаалтан гэдгийг хэн ч бидэнд танилцуулаагүй, бид өөрсдөө л түүнийг "Цэвэр агаар сан"-гийн мэргэжилтэн гэж ойлгож байсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-081, 082/,

Гэрч Г.Дж-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн агаарын чанарын албанд мэргэжилтэн/ "...ЭАИ" ХХК-ийн талаар би мэдэхгүй, 2011 оны 11 сард байх би сар өдрийг нь тодорхой санахгүй байна. Гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуухыг нэвтрүүлэх ажил хийгдсэн юм. Энэ ажилд манай албанаас хаягдал утааг хэмжих талаас оролцсон юм. Тухайн үед СХДүүргийн гэр хорооллын 100 айлд туршилтаар хийн зуух тавьж эхэлсэн. Энэ ажлыг "Цэвэр агаар сан"-гаас санхүүжүүлэн хийсэн ба хийн зуух суурилуулсан айлд 2 долоо хоногт нэг удаа очиж судалгааг манай албанаас авдаг байсан. Энэ ажилд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэнгээс хүмүүс, "Цэвэр агаар сан"-гаас албан тушаалтан нар оролцон ажилласан. "Цэвэр агаар сан"-гаас л зохион байгуулан ажилласан. Н.Хү захирал болон сангийн мэргэжилтэн Б.Чи нар зохион байгуулан ажилласан. "ЭАИ"ХХК хамтран ажиллаж байгааг би мэдээгүй, Энэ ажил 2012 оны 03 сар хүртэл ажилласан байх тэгээд явцын тайлангаа нэгтгээд л "Цэвэр агаар сан"-д Б.Чи-д өгсөн болно. Бас Б.Чи-ээс өөр хоёр эмэгтэй хүн явдаг байсан. "Цэвэр агаар сан"-гаас анх манай байгууллагад албан бичиг ирсэн болохоор зохион байгуулах ажлыг л хийж гүйцэтгэсэн байх гэж бодож байна. Надтай лав хамт айл өрхүүдээр явж байгаагүй, надтай хамт мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар явж байсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-083/,

Гэрч А.Оюу-ны мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Нийслэлийн агаарын чанарын албаны дүн шинжилгээ хариуцсан

мэргэжилтэн/ "...Би 2011 оны 7 сараас Нийслэлийн агаарын чанарын албанд орсон. 2011 оны 11 сард "Цэвэр агаар сан"-гаас албан бичиг ирээд манай байгууллагаас Г.Дж, н.Б бид 3-г томилон ажиллуулсан. Энэ ажилд мөн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас, Нийгмийн Эрүүл Мэндийн Хүрээлэнгээс, Онцгой байдлын газраас хүмүүс мөн хамрагдан ажиллаж байсан бүгдийг нь баг болгоод л ажиллуулсан. Хөлсөөр ажиллуулах гэрээг Б.Чи-тэй би хийж ажилласан санагдаж байна. Б.Чи бол энэ төслийг зохион байгуулан ажилласан юм. "Цэвэр агаар сан"-даа ажилладаг гэж ойлгож байгаа. "ЭАИ" ХХК ямар учиртайг би мэдэхгүй байна. Цэвэр агаар сантай л хамтран ажиллаж байгаа гэж ойлгож ажилласан. 2011 оны 11 сарын сүүлчээс 2012 оны 02 сар дуустал байх ажилласан. Ажиллахдаа амралтын өдөр буюу хагас бүтэн сайн өдрөөр СХД-гийн айл өрхүүдээр явж ажилласан. Хийн зуух тавьсан айл өрхүүдээр орж хэрхэн ашиглаж байгаа, ямар өөрчлөлттэй байгаа гээд л асуулга явуулж байсан. Тэгээд сар сардаа бид хийсэн ажлынхаа тайланг НМХГ-ын улсын ахлах байцаагч Ч.Үр-д өгч байсан. Энэ ажлыг хийснээр 500,000 төгрөг л авсан. Өөр цалин аваагүй. Сардаа 250,000 төгрөг юм уу үүнийгээ 2 хувааж авч байсан энэ цалингаас нийгмийн даатгалын шимтгэл суутган авч байсан. Цалинг Б.Чи бидэнд тараан өгч гарын үсэг зуруулдаг байсан. үүнээс өөрөөр хамтран ажиллаж байгаагүй. Б.Чи айл өрхүүдээр хамт явж байхад өөрийгөө "Цэвэр агаар сан"-гийн ажилтан гээд танилцуулаад явсан. Энэ төслийг зохион байгуулан явуулж байгаа учир сангийн ажилтан л гэж ойлгож явсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-084/,

Гэрч А.Эт-гийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: " 2011 онд би МХЕГ-н Эрүүл мэнд боловсрол шинжлэх ухааны хяналтын газарт улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан. Тэр үед манай хэлтсийн дарга Г намайг өөрийн хамт хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын хэсэгт оруулснаа хэлсэн. Тухайн үед ямар бичиг, шийдвэр ирээд ингэх болсныг би мэдээгүй. Тэгээд Нийслэлийн МХГазарт хуралтай гэхээр нь очсон чинь "ИЙТ" ХХК-ийн захирал Т болон "ЭАИ" ХХК -иас Б.Чи гээд хүмүүс байсан. Энэ хурал дээр "ИЙТ" ХХК-ийн захирал Т нь өөрийн үйлдвэрлэсэн бодисынхоо талаар танилцуулга хийсэн. Энэ хурал дуусаад л хөндлөнгийн үнэлгээ хийх гэрээг надтай байгуулсан. Хэд хэдэн

хүмүүс байсан. Бэлдсэн гэрээний хуудас гаргаад л гарын үсэг зуруулсан Үүнээс хойш Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нар айл өрхүүдээр газар дээр нь очиж шинжилгээ шалгалт хийж миний бие н.П гээд байцаагчийнхаа хамт БЗДүүргийн нутагт Амгалангийн тэнд байрлах "ИЙТ" ХХК-ийн үйлдвэрийн байрыг, үйл ажиллагааг шалгаад тайлан бичээд Б.Чи-д өгсөн. Н.Ган дарга бид хоёрт Б.Чи өөрөө ирж цалин гээд 450,000 төгрөг өгч байсан. Би өөрөө гарын үсгээ зурж авсан. Эхний хурал дээр л Б.Чи өөрийгөө "ЭАИ" ХХК-ийн ажилтан гэж танилцуулаад зохион байгуулан ажилладаг байсан" гэх мэдүүлэг /9-р хавтас-085/,

Гэрч Д.Бт-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Н.Хү-ийн танил/ "...2012 онд манай газраас "Цэвэр агаар сан"-д санхүүгийн шалгалт хийх болоод манай хэлтсээс хэд хэдэн улсын байцаагч томилогдоход намайг томилсон байсан тэгээд би Н.Хү-ийг таньдаг гээд хийх шалгалтын бүрэлдэхүүнээс татгалзаад тэгээд Нийслэлийн чанарын албыг шалгах бүрэлдэхүүнд орсон болно. Нийслэлийн Агаарын чанарын алба, "Цэвэр агаар сан"-тай ажил төрлийн байнгын холбоотой байсан учир "Цэвэр агаар сан"-гаас зарим нэг баримт материалыг авч үзэж байсан. "Цэвэр агаар сан"-гийн санхүүгийн үйл ажиллагаанд манайхаас Б.Ат, Д.Гэ, М.Цч нар шалгалт хийж байсан. Нийслэлийн агаарын чанарын алба Цэвэр агаар сан хоорондоо ажлын уялдаа холбоотой байгууллага байсан. Миний төрсөн дүү н.Ою өөртөө хэрэглэх гээд сервер компьютер авчирсан түүнийгээ зарах болоод зараад өгөөч гэхээр нь Н.Хү-ээс гуйгаад "Цэвэр агаар сан"-д 19 орчим сая төгрөгөөр өгсөн юм. Үүнийг төлбөрийг "П" ХХК-ийн нэрээр авсан байгаа. Б.Ат надад хэлэхдээ их зөрчилтэй юм байна. "ШГ"-той нэртэй компани юм уу, Зүүнхараагийн "ШГ" юм уу би мэдэхгүй, түлштэй холбоотой зөрчил байна гэж хэлж байсан. Нийслэлийн агаарын чанарын алба нь түлштэй холбоотой гэрээнд оролцдог учир би анхаарах ёстой юм байна гэж бодоод л өнгөрсөн. Нийслэлийн агаарын чанарын албанд хийсэн шалгалтаар "ШГД", ХХК "ШГЭБ" ХХК нэртэй компаниуд гарч ирээгүй. Би ийм нэртэй аж ахуйн нэгж дуулаагүй юм байна." гэх мэдүүлэг /9-р хавтас-096/,

Гэрч Ж.Ш-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /"ПИ" ХХК-д нягтлан бодогч/ "... Цэвэр агаар сан" манай компанитай хамтран

ажиллах гэрээ хэлцэл байхгүй. Харин манай компанийн зочид буудлын хурлын болон хүлээн авалтыг заалыг аж ахуйн нэгжүүд төлбөр төлөн ашигладаг юм. Цэвэр агаар сан мөн ийм зорилгоор манай хурлын болон хүлээн авалтын заалыг ашиглаад төлбөрөө төлж байсан. Санхүүгийн баримтыг харахад 2011 оны 12 сарын 28 нд манайд үйлчилгээний хөлс гэж 24,200,000 төгрөг "Цэвэр агаар сан"-гаас тушааж шилжүүлсэн байдаг. Гэтэл 2011.12.30-нд хүлээн авалтаа зогсоож, хийсэн төлбөрөө буцаан авлаа гээд Б.Чи манайд шилжүүлсэн 21,780,000 төгрөгөө бэлнээр авсан байдаг. Зөрүү мөнгө буюу 10 хувийг манайх захиалгаа цуцлан суутган авсан байна. 2012.12.17-нд 1,665,400 төгрөгийг хурлын заал, хоолны рестораны үйлчилгээнд төлсөн байна. Энэ 1,665,400 төгрөгийн урьдчилгаа нь 2012.12.04 нд 1,405,000 төгрөг манайд шилжүүлгээр орж ирсэн, үлдэгдэл мөнгө 260,400 төгрөг нь 2012.12.19-нд орж ирсэн. Энэ төлсөн төлбөртөө "Цэвэр агаар сан" манайхаас үйлчилгээ бүрэн авсан байна. 2013.01.09-нд "Цэвэр агаар сан"-гаас манай ресторан заалаар үйлчлүүлээд 2013.02.06 нд 469,000 төгрөгийг ресторан заалны төлбөрт шилжүүлгээр өгсөн байна. Өөрөөр ажил үйлчилгээ үзүүлэн төлбөр авсан зүйл байхгүй. 2011 онд Б.Чи "үйлчилгээ авахаа болилоо" гээд шилжүүлсэн мөнгөө буцаан бэлнээр манай кассаас авсан байсан" гэх мэдүүлэг /9-р хавтас-097/,

Гэрч Л.Ня мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Сангийн яамны төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтэст мэргэжилтэн/ "...2012 оны 07 сараас хойш тус албан тушаалд ажиллаж байна. Ажил үүргийн хувьд төрийн байгууллагуудаас ирж байгаа гүйлгээг хянаж компьютерт шивж өгдөг. Миний шивсэн гүйлгээг баталгаажуулах, банк хооронд дамжуулахыг өөр мэргэжилтэн хийж гүйцэтгэдэг. Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн мэргэжилтэн нарт төрийн байгууллагуудыг хуваарилан өгчихдөг. Жил болоод энэхүү хувиар өөрчлөгдөж болдог. Төрийн байгууллагуудаас гүйлгээгээ хянуулах компьютерт шивүүлэхдээ нэхэмжлэл, гэрээ, тушаал, төлбөрийн хүсэлт, материал хүлээн авсан бол акт баримт, цалингийн гүйлгээ байгаа бол цалингийн цэс товчоо зэргийг эх хувиар нь авчирч надад хянуулдаг юм тэгээд би хянаад баримт үнэн зөв бүрэн тохиолдолд гүйлгээг хүлээн авч шивдэг. Дутуу бол буцаадаг. Ямар ч

хуулбар баримтаар гүйлгээг хийдэггүй. "Цэвэр агаар сан"-гийн гүйлгээг манай мэргэжилтэн байсан А.С эгч хянаад шивдэг байсан. Тэгээд гадагшаа сургалтад 3 сарын хугацаатай явахад нь би "Цэвэр агаар сан"-гийн гүйлгээг хянаад шивдэг байсан. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху гээд хүн өөрөө ирж гүйлгээгээ хийлгэдэг байсан. Өөр хүн ирж байгаагүй. Уг нь тооцооны нягтлан нь эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь ирж гүйлгээгээ хийлгэж болдог. "ШГЭБ" ХХК-руу шилжүүлсэн 466,501 төгрөгийн гүйлгээг мөн "ХБ" ХХК -руу шилжүүлсэн хэд хэдэн гүйлгээг би хянаж дардсаа дараад гарын үсгээ зуржээ. Миний дардас болон гарын үсэг мөн байна. Ер нь 10 сая төгрөгөөс дээш гүйлгээ бол заавал гэрээ шаарддаг юм. Тухайн үед би гэрээг нь хараад, гэрээнээс нь шивж бичсэн. Худалдан авах ажиллагааны тухай хуулиар 10 сая төгрөгөөс дээш бол гэрээ байгуулна заачихсан байдаг юм." гэх мэдүүлэг /9-р хавтас-0105/,

Гэрч Ц.Бат-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Санхүүгийн аудитын газрын захирлаар ажиллаж байсан, Үндэсний Аудитын газарт Стратегийн Удирдлагын газарт менежер ажилтай./ "...Миний хувьд Д.Цэ-г таньдаг. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт өгч байхад танилцаж байсан ба тухайн үед Д.Цэ Төрийн өмчийн хороонд ажилладаг байсан юм. М.Ху-г бол одоогоос жил гаруйн өмнө манай ажлын Ю аудиторын өрөөнд танилцаж байсан. Тухайн үед М.Ху нь Ю-гийн өрөөнд сууж байсан ба Ю надад хэлэхдээ Дарханы Нефть Хангамжийн газарт бид хамт ажиллаж байсан хүмүүс гэж байсан юм. Н.Хү гэх хүнийг бол би танихгүй гэхдээ өнгөрсөн жил "Цэвэр агаар сан"-гийн аудитын дүгнэлтийг манайхаас ирж авахдаа нягтлан М.Ху-гийн хамт ирээд аваад явж байсан. Тэгэхэд л би аудитын дүгнэлтийг нь гардуулан өгч байсан юм. Тэгж л Н.Хү-ийг харсан. Түүнээс танилцаж байгаагүй. Би ажлынхаа ойролцоо Зинк гэдэг нэртэй хоолны газарт өдрийн хоолоо идээд сууж байтал Д.Цэ ороод ирсэн. Тэгээд надтай сууж хамт хооллож байтал Д.Цэ-гийн утас нь дуугараад тэгээд нэг хүн дуудсан. Удалгүй нөгөө Ю-гийн өрөөнд сууж байсан надтай танилцсан М.Ху ороод ирсэн. Д.Цэ хэлэхдээ М.Ху-гаа "Цэвэр агаар сан"-д нягтлан хийдэг гэж хэлж байсан. Ингээд бид гурвуулаа хамт хооллосон. Би эхлээд хооллож байсан учир хоолоо түрүүлж идчихээд түрүүлээд явсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-0113/,

Гэрч Ө.Мс-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн. /М.Ху-гийн хүү/ "...Төв номын сангийн эсрэг талд очиход Лексус-570 маркийн машин байсан ээж буугаад тэр машины жолоочтой уулзаад тэндээс хар өнгийн спорт цүнхтэй зүйл аваад миний машинд хийсэн тэгээд тэндээсээ ээж ажил дээрээ хүргүүлэн бууж үлдсэн ба бууж үлдэхдээ энэ цүнхийг гэртээ оруулаад тавьчих гэсэн тэр цүнхэнд юу байсныг би хэлж мэдэхгүй..." гэх мэдүүлэг /9-р хавтас-0115/,

Гэрч Н.Тг-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "...Би "ОСБ" ХХК-ийг манай аавын төрсөн дүү Ш.Т хүнтэй хамтран ажиллуулдаг. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху-г би танина. Би 2002-2004 онуудад Санхүү эдийн засгийн дээд сургуульд эчнээгээр сурч байсан ба тухайн үед л надтай Ө ах хамт сурч байсан юм тэгээд л М.Ху эгчийн нөхрийг таньдаг болохоороо М.Ху эгчийг тухайн үед таньж мэддэг болсон. Тэгээд ч бидний гэр орон Дарханд ойрхон хажуу байранд байдаг болохоороо мэнд устай явдаг хүмүүс. Түүнээс садан төрөл биш. Би өдөр сарыг нь санахгүй байна. М.Ху эгч л Дарханд тааралдаад "төрийн сангаар мөнгө дамжуулж авах гэсэн юм заавал аж ахуйн нэгжийн данс хэрэгтэй байна чамд данс байна уу" гэсэн юм. Тэгэхлээр нь л би Т-аас асуусан чинь байгаа гээд л "ОСБ" ХХК-ийн дансыг өгсөн. Тэгээд М.Ху мөнгийг нь шилжүүлчихнэ тэгээд хэлнэ гэсэн. Түүнээс хойш хэд хоногийн дараа М.Ху эгч над руу мөнгө орсон шүү гээд залгасан тэгээд дансыг шалгатал мөнгө орсон байсан. Би яг хэдэн төгрөг байсныг санахгүй байна 440 мянгатай л мөнгө орсон байсан. Ингээд би Ш.Т ахад хэлсэн Т ах ч өөрөө ирээд захирлынхаа гарын үсэгтэй баримт авчраад л надад гаргаад өгсөн. би М.Ху эгчийн өгсөн ХААН банкин дахь 510803xxxx гэсэн байх дугаарын дансанд бүгдийг нь хийсэн. М.Ху эгчийг "Цэвэр агаар сан"-д ажилладаг гэж мэдээгүй. Байгаль Орчны яаманд л ажилладаг гэсэн ойлголттой байсан. М.Ху эгч өөрөө ч тийм ийм ажил эрхэлж байгаа гээд ярьж байгаагүй. М.Ху эгч тэр мөнгөө гарган авсны дараа нилээд хэд хоногийн дараа М.Ху эгч над руу залгаад "Э.Эб-аар гэрээ өгөөд явууллаа чи нөгөө ахынхаа компанийн тамгыг дараад өгөөч" гэсэн. Тэгээд Э.Эб-ын авч ирсэн хоосон гэрээнд тамга даруулсан юм. Гэрээний загварыг би үзээгүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-0118, 0119/,

Гэрч Б.Лх-ын мөрдөн байцаалтад

мэдүүлсэн: /ЭАСЭ" ХХК-ийн захирал/ "...ХТТ" ХХК-ийг 2011 онд би өөрийн найз С.Бв-ын хамт үүсгэн байгуулсан. Тэгээд гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар болж гүйцэтгэх захирлаар Т.Мө-ыг томилсон. 2012 онд хэсэг шатахуун борлуулсан өөр үйл ажиллагаа явуулаагүй байж байгаад Т.Мө-ын олж ирсэн "Цэвэр агаар сан"-гийн төсөл дээр ажилласан. Тэгээд өөрөө л энэ ажлаа хийсэн. С.Бв бид хоёр тус тусдаа ажилтан учир "ХТТ" ХХК-ийн ажилд ороогүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-0121/,

Гэрч Ж.Бд-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Н.Хү, М.Ху нартай ажил төрлийн холбоотой/ "ШГЭ" ХХК-ийг 2004 онд би танил М, Ц.Б нарын хамт үүсгэн байгуулсан ба би 60 хувийг М 10 хувийг, Б 30 хувийг тус тус эзэмшдэг. 2008 оноос хагас коксын үйлдвэрийн суурийг Дархан уул аймгийн үйлдвэрлэлийн бүсэд барьж эхлээд 2010 онд эхний ээлж нь ашиглалтад орсон. 2011 онд шахмал түлшний үйлдвэр ашиглалтад орсон. Бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотын Агаарын чанарын албанд 2011 оноос нийлүүлэх болсон. Ингэж хамтран ажиллахдаа эхлээд 2011.05.17-нд гэрээ хийж байсан захиалагч нь Нийслэлийн Засаг даргын орлогч, санхүүжүүлэгч нь "Цэвэр агаар сан" нийлүүлэгч нь манай компани гэсэн гурвалсан гэрээг хийсэн. Энэ гэрээг жил болгон дүгнэж сунгаж одоог хүртэл ажиллаж байна. 2011.05.17-нд анх гэрээ хийхээс өмнө Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шахмал түлш үйлдвэрлэгч нартай хэд хэдэн удаа Нийслэлийн удирдлага, Цэвэр агаар сангийн удирдлага, Байгаль орчны яамны албан тушаалтан оролцон хуралддаг байсан ба тэр үеэс Н.Хү гэх хүнийг харж мэдэх болсон. Тэгээд гэрээ хийхэд уулзалдаж байсан. Манайх санхүүжилтээ авах гэж л "Цэвэр агаар сан" дээр очдог тэгэхдээ л Н.Хү-тэй уулздаг байсан. нягтлан М.Ху-г бол танихгүй. Нэг удаа л санхүүжилтээ шаардаж очиж уулзаж байсан. 2011 онд 450 сая төгрөгийн гэрээ хийж энэ мөнгөө бүрэн авч ажлаа хийсэн. 2012 онд 279 сая төгрөгийн гэрээ хийсэн. Үйлдвэрлэсэн түлшээ Улаанбаатар хотод Вагонд ачиж гурвалжингийн гүүрний орчим буулгаж Нийслэлийн агаарын чанарын албанд хүлээлгэн өгдөг. Ингээд тус албан гүйцэтгэлээ баталгаажуулаад "Цэвэр агаар сан"-гаас санхүүжилтээ авдаг. Манай компани Худалдаа Хөгжлийн банк,

Капитрон банкинд данстай, энэ дансаар түлшний санхүүжилтээ авдаг байсан. 2011 онд юм Н.Хү захирал намайг банкин дээр дуудсан. Засгийн газрын ордны зүүн талд очоод уулзахад он гараад танай урьдчилгаа санхүүжилт өгч магадгүй иймд танай компани дундын данстай байх хэрэгтэй гэсэн. Н.Хү захирал танай данс руу санхүүжилт хийвэл танайд манайхаас мэдэгдэнэ. Энэ дансанд мөнгө орвол танайх гүйлгээ хийх эрхгүй. Цэвэр агаар сан гүйлгээ хийх шийдвэрийг өгнө гэж тайлбарлаж байсан. Манайхаас гадна зуух нийлүүлж байсан 2 аж ахуйн нэгжийн удирдлага ирчихсэн тэдэнд бас ийм данс нээлгэж байсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-0149, 0150/,

Гэрч С.Бв-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Т.Мө-ын найз/ "...ХТТ ХХК-ийг анх 2011 оны 09 сард Б.Лх бид 2 худалдааны чиглэлээр үүсгэн байгуулсан. Тэгээд их сургуульд хамт сурч байсан Т.Мө "Цэвэр агаар сан"-гаас хэрэгжүүлж байгаа төслийн гүйцэтгэх ажил байна гэсэн санал тавьсан. Б.Лх бид хоёр тус тусдаа өөр аж ахуйн нэгжид ажилладаг учир Т.Мө-аар өөрөөр нь хариуцуулаад ажиллуулсан. Би өөрөө санхүүгийн мэргэжилтэй учир "ХТТ" ХХК-ийнхаа тайланг татварт гарган өгөхөөр болсон юм. "Цэвэр агаар сан"-тай гэрээ хийж айл өрхүүдэд суурилуулах ажил гэж өөрөө хэлж байсан санхүүгийн тайлан гаргахад нь өгсөн бичиг баримтыг нь үзэж танилцахад ч тийм ажил байсан. 2011, 2012, 2013 онуудад би тайлангаа Баянзүрх дүүргийн татварт гарган өгч зохих татвараа тушааж байсан. "Цэвэр агаар сан"-тай 2 удаа гэрээ хийсэн байдаг эдгээр гэрээний нийлбэр нь 725,3 сая төгрөг байдаг. Энэ мөнгөн дүнгээс айл өрхүүдэд хийн зуух, плитка суурилуулсны төлбөрөөс бага хэмжээний зардлыг /мөнгийг/ буцаан авах гэрээтэй юм байна лээ. Энэ мөнгийг нь хасахлаар 711,8 сая төгрөг болж байсан. Энэ мөнгөн дүнгээс "Цэвэр агаар сан"-гаас 569,7 сая төгрөг манай дансанд орж ирсэн. Ингээд гүйцэтгэлээр 521,1 сая төгрөг зарцуулсан байна. "ХТ" ХХК-тай хийсэн 2 гэрээгээр 45 сая төгрөг гэж тохирсон. Үүнээс манай компани 314,1 сая төгрөгийг "ХТ"-д шилжүүлэн өгөөд гүйцэтгэлийг нь хянаад 54,2 сая төгрөгийг буцаагаад манайх авсан." гэх мэдүүлэг /9-р хавтас-0152, 0153/,

Гэрч Ц.Эч-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Үндэсний Аудитын газарт Гүйцэтгэлийн аудитын газарт аудитор/ "Цэвэр агаар сан"-гийн үйл ажиллагаанд

аудит хийж байгаагүй. Миний санаж байгаагаар манай газрын аудитор Б.Да гэх залуу хийсэн гэдэг. Гүйцэтгэлийн аудитын газрын захирлын томилгоогоор хаана аудит хийхийг нь шийддэг юм. Н.Хү гэх хүнийг би танихгүй уулзалдаж байгаагүй. Харин нягтлан М.Ху гэх хүнтэй нэг удаа Д.Цэ-гээр дамжуулан хамт хооллож танилцаж байсан. Өөрөөр уулзалдаж байгаагүй юм байна. Д.Цэ-г бол би олон жилийн өмнөөс мэдэх юм. Манай ажлын байранд Төрийн өмчийн хороо байрладаг ба Д.Цэ төрийн өмчийн хороонд ажилладаг байсан юм. Тэгээд бие биенээ мэддэг болно. Одоо бол Д.Цэ Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүүгийн хэлтсийн даргаар ажилладаг. 2012 оны 04 сард байх сайн санахгүй байна. Д.Цэ намайг өдрийн хоол хамт идье гээд дуудсан. Тэгээд Зоос гоёлын байранд байрладаг Аксис гээд хоолны газарт нь яваад очтол Д.Цэ нэг эмэгтэйн хамт хоол идээд сууж байсан. Тэгээд би хамт суусан, би хоол захиалаад хамт идэнгээ Д.Цэ надад тэр хамт яваа хүүхнээ танилцуулсан. Дарханы Улсын нөөцийн газарт ажиллаж байгаад одоо "Цэвэр агаар сан"-гийн ерөнхий нягтлан бодогч ажилтай гэж танилцуулж байсан. Ажлыг нь хаана байдаг юм гэж асуухад хажуугийн Улаанбаатар банкны өндөр байшинг хэлж байсан. Д.Цэ хэлэхдээ энэ манай найз байгаа юм танайхаас аудит хийж байгаа юм. Эдний байгууллагад тэгсэн их хэмжээний дутагдал гараад байгаа юм үүнийг нь зохицуулах арга байна уу манай найзад туслаач гэсэн. М.Ху нь өөрөө нэг их юм яриагүй. Дөнгөж танилцаж байгаа болохоор. Д.Цэ л өмнөөс нь яриад байсан. Тэгэхэд нь би хүлээн авч тусалж чадахгүй юм байна. Би энэ байгууллагад нь Аудит хийгээгүй ш дээ гэдгээ хэлсэн. Д.Цэ хоол идээд гарах хүртэл л чи ямар нэгэн аргаар туслана шүү гэсээр байгаад л явцгаасан. Ийм л асуудлаар М.Ху-тай танилцаж байсан. Өөрөөр уулзалдаж байгаагүй. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас санхүүгийн шалгалт орчихсон дуусаж байгаа юм гэж хэлж байсан юм байна. Тэгээд ийм ийм хүмүүс шалгаж байгаа гээд нэр хэлэхэд, тэр нэрнээс миний таних хүн байгаагүй юм. "ШГЭБ" гээд компани гэж нэр хэлж байсныг би санахгүй байна. Ямар ч байсан тэрбумтай төгрөгийн асуудал яриад байсан. Бусдад шилжүүлчихсэн гэхдээ буцаагаад авчих юм, үүнийг чимээгүй байхад л туслаач гээд байсан. Үүнийг бол Д.Цэ л надад яриад байгаа ш дээ М.Ху бол чимээгүй



л суугаад байсан. Тэгээд тэр тэрбумтай төгрөгийн асуудал нь илэрч магадгүй гэж хэлж байсан. Хэрэв илэрчихвэл таньж мэдэх хүн байна уу гээд асуугаад байсан. Надад таних хүн байгаагүй. Д.Цэ-г тэгж хэлсэн гээд би хэн нэгнээс тэр талаар нь асууж сураглаж яваагүй." гэх мэдүүлэг /9-р хавтас-0162/,

Гэрч Б.Дэ-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Хас банкны Иргэдийн банк эрхэлсэн захирал/ "...2011 оноос эхлэн "Цэвэр агаар сан" манай Хас банктай хамтран ажиллах болсон. Манай банк шалгараад хамтран ажиллаж байсан юм. Гэр хорооллын айл өрхүүдэд олгосон утаагүй зуухыг айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр олгосон. Үнийн зөрүүг Цэвэр агаар сан болон Мянган сорилын сангийн Цэвэр агаар төслөөс тухайн бүтээгдэхүүн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд өгч байсан. Энэ үйл ажиллагаанд манай банк борлуулалтын захиалгыг нь хүлээн авах, мэдээлэл өгөх, худалдан авагчтай гэрээ байгуулах, түгээлт дээр тавих, хуучин зуух хураан авах ажиллагаанд хяналт тавих, түгээлтийн жагсаалтыг Цэвэр агаар сан болон Мянган сорилын санд өгөх зэрэг ажлыг хариуцан ажиллаж байсан. "Цэвэр агаар сан"-гийн хувьд нийлүүлэгч, Нийслэлийн агаарын чанарын алба манай банк зэрэг дөрвөлсөн гэрээг байгуулан ажиллаж байсан. "Цэвэр агаар сан"-тай ингэж ажиллаж байсан тул манай банкны зүгээс "Цэвэр агаар сан"-гийн санхүүжилтийн эх үүсвэрээ манай банкинд байршуулах саналыг тавьсан юм. Ингээд энэ дагуу "Цэвэр агаар сан"-гаас манай банкны төрлийн данс нээсэн. Дансны хуулгыг харахад "СЭК" ХХК-тай хамтран нээсэн дансанд 2011 оны 12 сарын 23-ны өдөр 4,604,000,000 төгрөг байршуулсан үүнээсээ зарлага хийж дуусгасан. Үүнээс өөрөөр орлого орж ирээгүй байна. Нөгөө дансны хуулгыг харахад нийт 9,064,136,701 төгрөг хэд хэдэн удаагийн орлогоор орж ирж байршиж байгаад зарлага гаргасан 2013 02.06 ны өдрөөр тэглэж хаасан."СЭК" ХХК-тай хамтран нээсэн дансанд 6.130.257 төгрөгийг хүүг бодсон харагдаж байгаа боловч гэрээгээр хүү бодно гээгүй. Манай программ өөрөө тохиргоотой ба манай салбарын ажилтан анх данс нээхдээ хүүг нь тэглээгүй юм байна лээ. Үүнээс болоод 2011.12.31-ний өдөр манай программ автоматаар хүү бодсон байсан. Ингээд үүнийг манайх илрүүлээд хүүг нь буцаалт хийж залруулсан юм. Түүнээс энэ 6 сая төгрөгийн хүү бэлнээр гараагүй.

500045xxxx болон 50045xxxx тоот дансуудад байршуулсан мөнгө хаанаас эх үүсвэртэйг би мэдэхгүй. Гүйлгээг нь харахаар Цэвэр агаар сан болон гүйцэтгэгч аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний дагуу гэсэн утгатай байдаг." гэх мэдүүлэг /9-р хавтас-0164, 0165/,

Гэрч Л.Гс-ийн: /Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга ажилтай/ "...Намайг 2008 оны 08 сараас 2012 оны 01 сар хүртэлх хугацаанд сайдаар ажиллаж байхад Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам гэсэн нэртэй байсан. Миний дараа Шинэ засгийн газраас Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яам болгосон. "Цэвэр агаар сан"-г 2011 онд анх байгуулсан. Өмнө нь ийм байгууллага байгаагүй. Шинээр "Цэвэр агаар сан"-гийн тухай хууль батлагдсаны дараа энэ хуулийн дагуу байгуулагдсан юм. Энэ хуулиар "Цэвэр агаар сан"-гийн удирдах зөвлөлийн дарга нь сайд байна, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална гэж заасны дагуу удирдах зөвлөл байгуулагдсан. Ингэж анх байгуулагдсанаас хойш сайдын ажлаа өгөх хүртэл миний бие "Цэвэр агаар сан"-гийн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байсан. Удирдах зөвлөл нь Яамдууд, Нийслэлийн захиргаанаас авсан саналыг үндэслэн "Цэвэр агаар сан"-гаас оруулж ирсэн төслийн дагуу төлөвлөгөө төсвийг батлаж өгдөг. Удирдах зөвлөл "Цэвэр агаар сан" төсвөө хэрхэн захиран зарцуулсан талаарх тайланг сонсдоггүй. Сангийн яаманд "Цэвэр агаар сан" тайлангаа гаргаж өгдөг. 2011 онд "Цэвэр агаар сан"-д хичнээн төгрөгийн төсөв батлагдсан талаар би тодорхой хэлж санахгүй байна. Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл Байгаль орчны яаманд байгаа. Ер нь "Цэвэр агаар сан" бол зөвхөн санхүүжүүлэгч байгууллага. Сонгон шалгаруулалт хуваарилалтыг яам, нийслэлийн захиргаа хариуцан ажилладаг болно. Түлшний чанар, нийлүүлэлтийн доголдол зэргийг Нийслэлийн захиргаа хариуцдаг юм. Сангийн захирлыг Удирдах зөвлөлийн шийдвэрээр томилдог. Н.Хү-ийг намаас санал болгоод томилсон. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч Маахар овогтой М.Ху энэ хүнийг томилоход төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцсэн зүйл байхгүй шууд сангийн захирлын тушаалаар томилогдсон. Анх М.Ху-г манай яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ төрийн албан хаагчийн анкетыг нь барьж над дээр орж ирээд танилцуулахдаа энэ их мундаг хүн, надтай хамт нефть баазад

ажиллаж байсан, надтай хэл амаа ололцоод явахад ажилд бэрхшээл учрахгүй сайн байна, та "Цэвэр агаар сан"-гийн нягтлангаар тавиад өгөөч гэж гуйсан. Тэгэхэд нь би Д.Цэ-д би "Цэвэр агаар сан"-гийн нягтланг томилдог хүн нь биш. Сангийн захирал Н.Хү өөрөө мэдээд томилох асуудал байна гэхэд Д.Цэ та Н.Хү-д хэлээд өгөөч анкетыг нь танилцаач гээд хэлээд өг, намайг хэлбэл танилцах ч үгүй байх Н.Хү дарга өөрөө танилцаад шийдээ гаргах биз гэхлээр нь би Д.Цэ-д за би Н.Хү-д хэлье гээд түүнийг гаргаад явуулсан. Тэгээд би М.Ху гэх хүний талаар Н.Хү-д хэлэхээ мартчихсан байтал хэд хоногийн дараа ЦЕГ-ын дарга асан н.С над руу залгаад М.Ху гээд хүн "Цэвэр агаар сан"-д нягтлан болох гээд материалаа бүрдүүлээд өгсөн гэнэ. Чи Н.Хү-д хэлээд өгөөч гэсэн тэгэхлээр нь би томилдог хүн нь биш, гэхдээ Н.Хү-д би дуулгая гэсэн. Ингээд би Н.Хү рүү утасдаж М.Ху гэх хүнийг манай яамны Д.Цэ бас ЦЕГ-ын дарга С нар яриад байна, чи судлахгүй юу гэхдээ чи өөрийнхөө сонгосон хүнийг авна шүү, нягтлангийн ажил хэцүү шүү гэж хэлсэн түүнээс хойш хэсэг хугацааны дараа Н.Хү-тэй тааралдахад нөгөө М.Ху-г нягтлангаар авчихсан ажилдаа гайгүй хүн байна лээ гэж хэлж байсан. Үүнээс хойш М.Ху-гийн талаар ярилцаж байгаагүй. Миний хувьд М.Ху гэх хүнтэй нэг ч удаа нүүр нүүрээ харж уулзалдаж байгаагүй болно. Д.Цэ бол би энэ яаманд сайдаар ирснээс хойш мэдэх болсон хүн. Үүнээс өмнө бол таньдаггүй байсан. Миний өмнөх сайдын үед л Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар ажиллаж байсан хүн. Би томилогдон ирээд энэ хүнийг өөрчлөөгүй. Бидний хооронд ямар нэгэн хувийн харьцаа байхгүй, өр авлага байхгүй. Садан төрлийн холбоо байхгүй. Д.Цэ М.Ху-гийн талаар ярихдаа их л мундаг хүн сайн нягтлан гээд л танилцуулаад байсан. Энэ талаар над дээр 2 ч удаа орж ирж ярьж байсан. Би Н.Хү-д хэлье л гэсэн болохоос за томилж өгнө шийдэж өгнө гэж хэлээгүй, ямар нэгэн амласан зүйл байхгүй. Н.Хү-ийн хувьд ийм асуудалд холбогдсон гэхэд итгэхгүй байна Энэ хүнийг би олон жилийн өмнөөс мэднэ, нэг намд байдаг. Энэ хүн Их хуралд 2 удаа нэрээ дэвшүүлж байсан, Н.Хү бол хувийн болон төрийн албанд ажиллаж байсан цаашид өсөх ирээдүйтэй залуу хүн." гэх мэдүүлэг /9-р хавтас-0170, 0171/.

Гэрч Д.Эд-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /НХХ ТББ-ын захирал/ "...Цэвэр агаар санаачилга 2 төслийг Европын сэргээн

босголтын сан санхүүжүүлж байсан ба төслийн ажилтан нарт энэ санхүүжилтээсээ цалинг олгодог. Төсөл дуусаад "Цэвэр агаар сан"-нд төслийн мэргэжилтнээр ажилласан нэр бүхий 5 хүнийг "Цэвэр агаар сан"-д авч үндсэн ажилтан болгох талаар ярилцаад "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү анх Б.Чи-ийг манай төсөлд аваач гэж санал, хүсэлт гаргаад оруулсан. Тэгээд төслийн баг татгалзаагүй. Б.Чи-ийг авч ажиллуулсан." гэх мэдүүлэг. /9-р хавтас-00174/.

Шинжээч Л.А-гийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн: "2011, 2012 оны "Цэвэр агаар сан"-гийн тайланг "Цэвэр агаар өөрсдөө гаргасан байсан. Энэ тайланд нь Аудитор Б.Да тайлангийн аудит хийсэн байсан. Б.Да "Цэвэр агаар сан"-гийн тайланг гаргав. "Цэвэр агаар сан" өөрсдийнх нь гаргасан тайланд аудит хийсэн гэж ойлгох болно. Аудитор Б.Да нь санхүүгийн тайлангийн аудит гаргасан. "Цэвэр агаар сан"-гийн 2011 оны үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн байдаг. Намайг шалгах хугацаанд 2012 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийгдээгүй байсан. Б.Да зөрчилгүй санал дүгнэлт өгсөн. Харин шалгалт тайланд буюу менежментийн захидалдаа тодорхой зөвлөмжүүд дурдаж өгсөн байдаг. "ШГЭБ" ХХК-ийн нэрээр 2011 онд гарсан тэрбум 260 сая төгрөгт Цэвэр агаар сан ямар нэгэн ажил үйлчилгээ ба материал аваагүй нь тодорхой байсан учир нь энэ талаарх анхан шатны баримт огт байгаагүй, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын гүйцэтгэл шалгалтаар ч энэ компани буюу "ШГЭБ" ХХК-ийн талаар нэг ч үг өгүүлбэр дурдаагүй байсан. Энэ компанийн нэрээр дээрх их хэмжээний мөнгө "Цэвэр агаар сан"-гаас гараад явчихсан ба үүний гүйцэтгэл болон санхүүгийн анхан шатны баримтууд нь шинжилгээнд ирээгүй. Харин 1.980,000,000 төгрөг "Цэвэр агаар сан"-д "ШГЭБ"ХХК-аас 2012.2 09-ний өдөр буцаан төлөлт гэж гүйлгээ байдаг, гэтэл энэ 1 тэрбум сая төгрөгийг "Цэвэр агаар сан"-ийн Хас банкин дахь тусгаарласан данснаас 2012 02.08-нд зарлагдсан байдаг. "ШГЭ" ХХК, "ШГЭБ" ХХК гэсэн 2 өөр аж ахуйн нэгж байхад нэг аж ахуйн нэгж гэж тооцоог гаргасан байгаа юм. Уг нь 2 аж ахуйн нэгжийг тус тусад нь тооцоог гаргах ёстой." гэх мэдүүлэг /9-р хавтас-0188/.

Гэрч Д.Др-ын мөрдөн байцаалтад мэдүүлсэн: /Цэвэр агаар сангийн нягтлан бодогч/ "...Би "Цэвэр агаар" сангийн нягтлан

бодогчоор 2013.08.15-ны өдрөөс хойш ажиллаж байна. Намайг анх ажилд ороход ажил хүлээлцэх ямар ч хүн байгаагүй учир нь энэ байгууллагын хэдэн хүн хэрэгт холбогдоод шалгагдаж байгаа гэж байсан. Хуучин нягтлан бодогчоос би ажил хүлээн авах боломж байгаагүй. Ажилд томилогдоод өөрөө л санхүүгийн бичиг баримтуудыг нэг бүрчлэн үзэж танилцан цэгцэлж ажиллаж байна. Ер нь тус сангийн санхүүгийн бичиг баримтууд нь эмх цэгцгүй өмнөх он саруудын санхүүгийн баримтыг үдэж хавтаслаж дугаарлаагүй жижиг мөнгөн сангийн тайлан дэлгэрэнгүйгээр байхгүй зарим баримт дутуу, жижиг мөнгөн санд нь 1802 төгрөг л байсан мөрдөн байцаалтын явцад танайхаас шаардсан бичиг баримтыг гарган өгч байсан ба өмнөх удирдлагуудтай холбоотой дутагдал ашиглалын талаар мөрдөн байцаалтын явцад тогтоогдсон хэмжээнд л мэдээлэлтэй байгаа. 2013.04.03-нд ХА компаниас 20 хувийн буцаан төлөлт гэж 394.561.471 төгрөг "Цэвэр агаар сан"-д тушаасан баримт эх хувиараа байсан ба үүнийгээ тухайн баримтад үдээгүй задгай баримтаас гарч ирсэн төрийн сангийн хуулга харагдаж байсан. Ямар учиртай буцаан төлөлт байсныг би хэлж мэдэхгүй. Миний болон манай сангийн тооцоогоор 5,7 тэрбум төгрөгийг хохирол учирсан гэсэн тооцоо гардаг юм. Тэрбум гэсэн дүнг мэдэхгүй. Энэ тооцоонд "ХТТ" ХХК болон "ЭАИ" ХХК-ийн санхүүжилтийг нэмсэн байдаг гэтэл "ЭАИ" ХХК -ийн гэрээгээр авсан ажил хийгдсэн. "ХТТ" ХХК-ийн ажил одоо ч үргэлжлэн хийгдэж байдаг. Хахуульд авсан мөнгийг улсын орлогод оруулсан байх." гэх мэдүүлэг /9-р хавтас-0190/, "Цэвэр агаар" сангийн Гүйцэтгэх захирлын тушаал /1-р хавтас х-42/, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2011 онд хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөө /1-р хавтас х-53-56/, Нэгжлэг хийсэн тэмдэглэл /1-р хавтас х-92-95/, БОНХЯам Цэвэр агаарын сангийн 2012 оны төсвийн зарлага /1-р хавтас х-103-104/, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /1-р хавтас х-105/, БОАЖЯ сайдын багцын 2011 оны нийт хөрөнгө оруулалт /1-р хавтас х-106/, Төрийн сан Орлогын дансны хуулга /1-р хавтас х-115/, БОАЖЯам "Цэвэр агаар" сан Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга, НАББҮХ-ны гишүүн Д.Б танаа Зарцуулалтын эрхийн тухай /1-р

хавтас х-131/, Өглөг авлагын байгууллагын товчоо /1-р хавтас х-133,140/, "Цэвэр агаар" сангийн 2012 оны санхүүгийн тайлангийн аудит /1-р хавтас х-170/, Аудитын гэрчилгээ /1-р хавтас х-171/, Боловсруулсан түлш худалдах, худалдан авч нөөц бүрдүүлэх, түүнийг санхүүжүүлэх тухай гэрээ "Цэвэр агаарын сан" - "ШГД" ХХК /1-р хавтас х-223-227/, "ШГД" ХХК-аас 2011.11.23- 2012.04.30 хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын нөөцийн агуулахад нийлүүлэх боловсруулсан түлшний хэмжээ, үнийн хуваарь /1-р хавтас х-228/, Хамтын ажиллагааны гэрээ "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /1-р хавтас х-230, 232, 233/, Бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл /3-р хавтас х-146/, Төлбөрийн хүсэлт №96 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ"ХХК /3-р хавтас х-154/, Нэхэмжлэх "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-155/, Ажил гүйцэтгэх гэрээ "ХБ"ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-156-157/, Төлбөрийн хүсэлт БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ОСБ" ХХК /3-р хавтас х-158/, Нэхэмжлэх "ДЗТМ" ХХК- "Цэвэр агаар" сан 3-р хавтас х-162/, Хамтран ажиллах гэрээ БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-164, 165/, Төлбөрийн хүсэлт БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-166/, Нэхэмжлэх "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-167/, Төлбөрийн хүсэлт №60 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ШГЭБ" ХХК /3-р хавтас х-170/, Төлбөрийн хүсэлт №75 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-172/, Нэхэмжлэх "ДЗТМ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас 173/, Төлбөрийн хүсэлт №168 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-174/, Хамтран ажиллах гэрээ "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо" - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-175-177/, Төлбөрийн хүсэлт №335 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-178/, Хамтран ажиллах гэрээ БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-180-181/, Төлбөрийн хүсэлт №382 БОНХЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-182/, Ажил гүйцэтгэх гэрээ "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-184-185/, Гарын үсэг "ОСБ" ХХК 3-р хавтас х-214/, Төлбөрийн хүсэлт №188 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "Аж" ХХК /3-р хавтас х-220/, Боловсруулан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах гэрээ "ЦАС" -"НЗДТГ" - "ШГЭ" ХХК (Б) /3-р хавтас х-233/, Шинжилгээ хийлгэх тухай тогтоол

/4-р хавтас х-1, 8/, Шинжээчийн дүгнэлт /4-р хавтас х-24-27, 31-32/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Шалгалтын тэмдэглэл /4-р хавтас 88-113, 132-133/, Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГЭБ" ХХК /4-р хавтас х-170/, "Т" ХХК-ийн дансны хуулга /4-р хавтас х-177/, Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс Хил хамгаалах ерөнхий газрын хилийн шалган нэвтрүүлэх хэлтэст /4-р хавтас х-175/, Лавлагааны хариу Хилийн шалган нэвтрүүлэх албаны хэлтэс /4-р хавтас х-177, 178/, Төлбөрийн хүсэлт №348 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ШГД" ХХК /4-р хавтас х-181/, Төлбөрийн хүсэлтүүд №142 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ШГЭБ" ХХК /4-р хавтас х-182-187/, Төлбөрийн хүсэлт №71 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /4-р хавтас х-192-195/, Төлбөрийн хүсэлт №88 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /4-р хавтас х-198-203/, "Цэвэр агаар" сангийн үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөө 4-р хавтас х-211-213/, "Цэвэр агаар" сангийн удирдах зөвлөлийн тогтоол /4-р хавтас х-215/, "Цэвэр агаар" сангийн 2012 оны ажиллах төлөвлөгөөний өөрчлөлт /4-р хавтас х-216/, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд Төсвийн гүйцэтгэлийн тухай /ЦАС/ /4-р хавтас х-219, 220/, Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс Улсын Ерөнхий прокурорын газрын эрүүгийн хэргийн төв архивт /Х.Бо-д тэнсэн харгалзах ял ногдуулж байсан тогтоолын хуулбарыг ирүүлэх тухай/ /5-р хавтас х-166/, Монгол Улсын төрийн албаны зөвлөл Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Э.А танаа "Тодруулга хүргүүлэх тухай" /5-р хавтас х-211/, МУ-ын БОАЖЯ ЦАС Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар "Хяналтын багт оролцуулах" /5-р хавтас х-214/, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар БОАЖЯамны "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирал Н.Хү танаа "Хариу хүргүүлэх тухай" /5-р хавтас 215, 216/, Монгол Улсын БОАЖСайдын тушаал Дүрэм, журам, хөтөлбөр, төсөв батлах тухай /5-р хавтас х-227, Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн Бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам /5-р хавтас х-242-244/, "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирлын тушаал /6-р хавтас х-16, 18, МХЕГ - Улсын байцаагчийн акт Цэвэр агаар сан

"ШГД" ХХК "Төсвийн орлого болгох тухай" /6-р хавтас х-68, 69/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - Шалгалтын тэмдэглэл "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн тухай" /6-р хавтас х-73-95/, Аудит хийгдсэн үр дүнгийн тайлан /6-р хавтас х-121/, БОАЖСайдын багцад Улсын төсвийн хөрөнгөөр 2011 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит /6-р хавтас х-134/, Монгол Улсын БОАЖЯ Үндэсний Аудитын газарт "Зөрчлийн тухай" /6-р хавтас х-144/, Монгол Улсын БОАЖСайдын тушаал "Эрх шилжүүлэх" /6-р хавтас х-147/, Монгол Улсын Үндэсний Аудитын газар, Албан шаардлага /6-р хавтас х-166, 220, 221/, Монгол Улсын Үндэсний Аудитын Газар Улсын төсвөөс 2011 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн /6-р хавтас х-168-177/, Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн Аудитын төлөвлөгөө /6-р хавтас х-180-184/, Худалдаа хөгжлийн банк "Тоотын хариу хүргүүлэх тухай" /7-р хавтас х-1, 9, 15, 16, 18-25, 32-34, 38, 39, 42-44, 49-53, 67/, Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГД" ХХК /7-р хавтас х-146/, Данс нээх өргөдлийн маягт "ШГД" ХХК /7-р хавтас х-147, 148/,

Байгууллагын харилцах данс, хугацаагүй хадгаламжийн гэрээ "ШГД" ХХК /7-р хавтас х-149/, Хуулийн этгээдийн харилцах данс нээх, хаах тухай мэдэгдэл Дугаар 0016140 "ШГД" ХХК /7-р хавтас х-152/, "ХБ" ХХК-ийн дансны хуулга /7-р хавтас 162, 163/, Бизнес үйлчилгээний төвийн дансны хуулга /7-р хавтас х-181/, Хас банк Гарын үсгийн баталгаа /7-р хавтас х-184, 185/, Хас банк Төлбөрийн баримт /7-р хавтас х-190/, Гэрч М.Соё-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-6-10, 12/, Иргэний хариуцагчаар татах тухай тогтоол /9-р хавтас х-11/, Гэрчээр Б.Чийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-15, 16/, гэрч Э.Ба-ийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-17-19/, Гэрч Б.Мө-ийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-22/, Гэрч О.Чи-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-30, 31/, Гэрч Л.Тө-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-53, 54/, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхийг ариутгах ажлын гэрээ "Цэвэр агаар" сан" - "ИЙТ" ХХК, "Цэвэр агаар" сан" - "ЭАИ" ХХК /9-р хавтас х-55-57, 58-60/, Гэрч Г.Бс-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-66-68/,

Т.Мө-ыг гэрчээр байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-89, 90, 95/, Бэлэн мөнгөний зарлагын баримт /9-р хавтас х-104/, Гэрч Г.Ши-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-107-109/, Улсын бүртгэлийн гэрчилгээ "Аж" ХХК /9-р хавтас х-110/, Гэрч Э.Ян -г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-116/, Гэрч П.Аг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-146, 147/, Гэрч А.С-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-167, 168/, Гэрч Б.Мө-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-169/, Төслийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчин авч ажиллуулах гэрээ "Цэвэр агаарын сан"- "НХХ" /9-р хавтас х-176-179/, Д.Цэ-г яллагдагчаар байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-196-199/, "Хаан" банкны Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГЭБ" ХХК /9-р хавтас х-213-215/, Худалдаа хөгжлийн банк Харилцах дансны гүйлгээний хуулга "ШГЭБ" ХХК /9-р хавтас х-216/, М.Ху-г яллагдагчаар /9-р хавтас х-225-239/, Б.Чи-ийг сэжигтнээр /10-р хавтас х-12/, Б.Чи-ийг яллагдагчаар /10-р хавтас х-16-21/, М.Аб-ыг сэжигтнээр /10-р хавтас х-25-28/, М.Аб-ыг яллагдагчаар /10-р хавтас х-30, 31/, "П" ХХК болон Д.Цэ нарын хооронд байгуулсан "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" /1-р хавтас х-193/, "ДЭХОР" ХХК болон Д.Цэ-гийн нөхөр З.Бм нарын хооронд байгуулсан "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" /1-р хавтас х-213-217/, "ДЭХОР" ХХК-д Д-аас байрны төлбөрт 200.000.000 төгрөг төлсөн баримт /1-р хавтас х-218/, "Цэвэр агаар сан" - "ДЗТМ" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ /3-р хавтас х-175-177, шинжээчийн дүгнэлтүүд /4-р хавтас х-01-085/, М.Ху-гийн оршин суугаа газрын тодорхойлолт /5-р хавтас х-157/, мөнгө шилжүүлсэн баримт /10-р хавтас х-71, 73, 171/, яллагдагч Х.Бо-гийн хэргийн материалтай танилцаад гаргасан хүсэлт /10-р хавтас х-190, 191/, яллагдагч Н.Хү-ийн мэдүүлэг /10-р хавтас х-9/, яллагдагч Б.Чи-ийн мэдүүлэг /10-р хавтас х-19, 20/,

Х.Бо-гийн дансны хуулга /7-р хавтас х-32/, / Э.Ба-ийн дансны хуулга /8-р хавтас х-15, 29, 41/, М.Жа-гийн дансны хуулга /8-р хавтас х-43/, М.Ху-гийн дансны хуулга /8-р хавтас х-84/, Б.Ө-ын дансны хуулга /8-р хавтас х-135-153/, Ө.Мс-ын дансны хуулга /8-р хавтас 154/, М.Ц-гийн дансны хуулга /8-р хавтас х-165/, М.Хүслэнгийн дансны хуулга /8-р хавтас х-177-186/, Х.Бо-гийн "Хаан" банкны дансны хуулга /8-р хавтас х-199-201/, "Хаан" банк дахь "ШГЭБ" ХХК-ийн дансны хуулга /9-р хавтас х-213/, гэрч Л.Г /сайд/-ийн мэдүүлэг /9-р хавтас х-170, 171/, Х.Бо-гийн

сэжигтнээр өгсөн мэдүүлэг /9-р хавтас 202, 203/, Х.Бо-гийн яллагдагчаар өгсөн мэдүүлэг /9-р хавтас х-211/, М.Ху-гийн сэжигтнээр өгсөн мэдүүлэг /9-р хавтас х-218-220/, Н.Хү-ийн яллагдагчаар өгсөн мэдүүлэг /10-р хавтас х-4/,

Д.Цэ-гийн ажил байдлын тодорхойлолт /12-р хавтас х-12, 13/, Цагдан хорих 461 дүгээр ангийн тодорхойлолт болон шинээр өгсөн баримт /фото зураг/,

Орон сууц хөлслөх гэрээ /2-р хавтас х-202/, Б.Чи-ийн зээлийн баримт /10-р хавтас х-247/, Б.Чи-ийн мөнгө хүлээлцсэн баримт /10-р хавтас х-248/, Т.Мө-ын Хас банкны дансны хуулга /10-р хавтас х-249/, Гадаадад томилолтоор явуулах тухай тушаал /6-р хавтас х-32-34/, БОАЖЯ-ны сайдын тушаал албан томилолт /6-р хавтас х-37/, албан томилолт /6-р хавтас х-41/, албан томилолтын тушаал /6-р хавтас х-43/, гэрч Б.Хз-ийн мэдүүлэг /9-р хавтас х-63/, гэрч Г.Ши-ын мэдүүлэг /9-р хавтас х-107/, гэрч Н.Тг-ийн мэдүүлэг /9-р хавтас х-119/,

Шүүгдэгч Х.Бо-гийн өрөөнд нэгжлэг хийсэн тэмдэглэл /1-р хавтас х-92-95, гэрээ, гэрээний хавсралт /3-р хавтас х-233-237/, татварын тооцооллын жагсаалт /4-р хавтас х-239/, Х.Бо-гийн мэдүүлэг /9-р хавтас х-210/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-221, Х.Бо-гийн хохирол төлсөн баримт /10-р хавтас х-72/, хохирлын тооцоо /10-р хавтас х-79/, "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК-тай хамтран ажиллах гэрээ /3-р хавтас х-164-177/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-234/, Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол /10-р хавтас х-101, 102, болон шинээр өгсөн ажил байдлын тодорхойлолт, Т.Мө-ы мэдүүлэг /9-р хавтас х-95/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-221, 235, 237/, яллагдагч Н.Хү-ийн мэдүүлэг /10-р хавтас 6-7/, Б.Чи-ийн мэдүүлэг /10-р хавтас х-13, 17, 19, 20/, Т.Мө-ы сэжигтнээр өгсөн мэдүүлэг /10-р хавтас х-53, 54/, Т.Мө-ын хүүхдийн эмчилгээний талаарх баримт /11-р хавтас х-10, хувийн байдлыг тодорхойлох баримтууд, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-226/, Зээл эргүүлэн төлсөн тухай баримт /12-р хавтас х-23, 37/, хариуцсан байгууллагын бүртгэлийн мэдээ /12-р хавтас х-33-36/, дипломын хуулбарууд /12-р хавтас х-38-41/, Ж.Сү-гийн охин С.Х-ны төрсний гэрчилгээний хуулбар /12-р хавтас х-42/, Ж.Сү-гийн ажил байдлын тодорхойлолт /12-р хавтас х-45, 46/, Баянзүрх дүүргийн 7-р хорооны тодорхойлолт /12-р хавтас х-44/,

Төрийн сангийн орлогын баримт /1-р хавтас х-110/, "ШГЭБ" ХХК-д 360 сая төгрөг орсон баримт 1-р хавтас х-119/, Банкны бүртгэлийн дансны хуулга /1-р хавтас х-120-122/, "ШГЭБ" ХХК-ийн дансны орлогын баримт /1-р хавтас х-115/, шинжээчийн дүгнэлт /4-р хавтас х-24-27/, "ШГЭБ" ХХК-д 1.980.000.000 төгрөг шилжүүлсэн тухай баримт /4-р хавтас х-170/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шалгалт хийсэн тэмдэглэл /4-р хавтас х-88-97/, МХЕГ-ын Улсын байцаагчийн акт /6-р хавтас х-68/, "Т" ХХК-д "Цэвэр агаар" сангаас оруулсан мөнгөний зөрүү харуулсан тухай дүгнэлт /4-р хавтас х-132/, шүүгдэгч Б.Ат-гийн ажлын байрны тодорхойлолт /5-р хавтас х-184/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан тоот /10-р хавтас х-210, 211/, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан бичиг /12-р хавтас х-8/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлогчийн албан тоот, Д.Гэ-ийн ажил байдлын тодорхойлолт болон шүүх хуралдаанд гэрч Э.Эб, П.А, Б.Со, С.Эт, Ж.Цо нарын өгсөн мэдүүлэг зэргийг тус тус шинжлэн судалсан болно. Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан дээрх нотлох баримтууд болон хэрэгт авагдсан бусад бичгийн нотлох баримтуудыг шүүх тал бүрээс нь бүрэн, бодитой магадлан хянасны үндсэнд ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч нараас:

Шүүгдэгч Н.Хү-д холбогдох хэргээс М.Ху нартай бүлэглэж "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг, мөн шүүгдэгч Б.Да-ын төрсөн дүү Б.Зг-ын нэрээр үүсгэн байгуулсан "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг тус тус авч хувьдаа завшсан гэх хэргийг хэрэгсэхгүй болгох санал гаргасныг, мөн 2011 онд ШУА-ийн Газар зүйн хүрээлэнд 76.000.000 төгрөгийн санхүүжилт бүхий Нийслэлийн гэр хорооллын айл, өрхүүдийн хөрсний бохирдолд шинжилгээ хийх ажлыг олгож, уг санхүүжилтээс өөрийн үүсгэн байгуулалцсан "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөгийн хахууль авсан гэх хэргийг, мөн 2012 онд "ХТТ" ХХК-д гэр хорооллын айл өрхүүдийг хийн плиткагаар хангах ажлыг олгож тус компанийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас төслийн ажилтан Б.Чи-ээр дамжуулан 2 удаагийн үйлдлээр нийт 44.000.000 төгрөгийн хахууль авсан гэх хэргээс 24.000.000 төгрөгийг хээл хахууль

авсан гэх хэргийг, шүүгдэгч Б.Чи-ийг Н.Хү, М.Ху нартай бүлэглэж, "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг завшсан, мөн Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглаж, онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэргийг,

шүүгдэгч Ж.Сү-гийн "ШГЭБ" ХХК-ийн захирал Х.Бо-гаас 1.000.000 төгрөгийн хахуулийг түүний ашиг сонирхлын үүднээс урьдчилан амлахгүйгээр авсан гэх хэргийг, шүүгдэгч Х.Бо-гийн хуурамч бичиг баримтаар гэрээ байгуулан "Цэвэр агаар" сангаас "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө шилжүүлэн авсан гэмт үйлдлээ нуун далдлах зорилгоор уг компанийг татан буулгах, татварын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрүүлэхгүй байх зорилгоор Баянгол дүүргийн татварын хэлтсийн Улсын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэх хэргийг,

шүүгдэгч М.Аб-ын ШУА-ийн Газар зүйн хүрээлэнтэй түншлэлийн гэрээ хийх замаар "Цэвэр агаар" сангаас 76.000.000 төгрөгийн, мөн "Цэвэр агаар" сангаас санхүүжигдсэн гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхнүүдийг ариутгах ажлыг хийх "ИЙТ" ХХК-аас Н.Хү-ийн албан тушаалын байдлыг ашиглан мониторингийн 86.400.000 төгрөгийн ажлыг, мөн "Цэвэр агаар" сантай гэрээ хийж гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур суурилуулсан ажлын үр дүнд мониторинг хийх 89.900.000 төгрөгийн ажлыг авч бусдаар хийлгүүлэн ашиг олж Н.Хү-д 9.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэх хэргүүдийг яллахаас татгалзсаныг шүүх хүлээн авч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр шийдвэрлэхээр тогтов.

Мөн шүүхийн хэлэлцүүлэгт Улсын яллагч нараас шүүгдэгч М.Ху-г ганцаараа болон Н.Хү-тэй бүлэглэн "ХБ" ХХК, "ОСБ" ХХК, "АЖ" ХХК-иудын гэрээг хуурамчаар үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 78.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 10.440.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 216.000.000 төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар гаргасан 429.760.000 төгрөгийг, "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.550

төгрөгийг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг, шүүгдэгч Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 931.938.529 төгрөгийг тус тус хувьдаа завшиж, улсад нийт 4.210.218.029 төгрөгийн хохирлыг М.Ху-гаас гаргуулахаар санал оруулсныг шүүх хүлээн авав.

Шүүгдэгч "ХТТ" ХХК-ийн захирал Т.Мө-ыг Б.Чи-ээр дамжуулан "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирал Н.Хү-д 20.000.000 сая төгрөгийн хахууль өгсөн гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дахь хэсэгт заасан гэм буруутайд тооцсоныг шүүх хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэв.

Учир нь: Шүүгдэгч Т.Мө-ын 2013.8.6-ны өдөр гэрчээр мэдүүлэг өгөхдөө 23 сая төгрөгийг Б.Чи-д өгсөн, 2013.08.21-ний өдөр мөн гэрчээр "...Б.Чи-д өгсөн дараагийн мөнгөн дүнг буруу хэлсэн байна. Эхний удаа 20 сая төгрөг өгсөн, дараа нь 4 сая төгрөг өгсөн. Ингээд нийт 24 сая төгрөг өгсөн. Өмнөх мэдүүлэгтээ би 27 сая төгрөг гэж асуухаар нь 4 сая төгрөгийг өгснөө хэлэлгүй асуусан мөнгөн дүнгээс 4 сая төгрөгийг хасаад 23 сая төгрөг өгсөн гэж зөрүүтэйгээр мэдүүлснээс гадна шүүхийн хэлэлцүүлэгт Б.Чи-д эмчилгээний зардал хэрэгтэй байна тус болооч гээд байхаар нь 20 сая төгрөгөөр, 4 сая төгрөгөөр тус тус өгсөн гэж мэдүүлж байна. Үүнээс гадна Шүүгдэгч Б.Чи эмчилгээнд хэрэглэсэн мөнгөө 2012.07.06-нд 20 сая төгрөг зээлсэн тухай баримтыг 10 дугаар хавтаст хэргийн 247 дугаар талд авагдсан байна. Мөн 2012.07.23-ны өдөр үлдэх 4 сая төгрөгийг зээлсэн болох нь мөн хавтаст хэргийн 248 дугаар талд тус тус авагдсан байх ба тус мөнгийг 2012.09.03-нд 19 сая төгрөгөөр, үлдэх 5 сая төгрөгийг хүлээн авснаа шүүгдэгч Т.Мө нь үгүйсгэхгүй байна. Иймд 20 сая төгрөгийг хээл хахуульд өгсөн гэсэн нь хавтаст хэрэгт авагдсан бичгийн бусад нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдохгүй байх тул гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Иймд дээрх Б.Чи-ийн Эрүүгийн хуулийн тусгай 270 дугаар зүйлийн 270.1-д заасан хээл хахуульд зуучилсан гэх хэргийг, мөн шүүгдэгч Н.Хү-ийн 20.000.000 төгрөгийг хээл хахуульд авсан гэх хэргийг тус тус хэрэгсэхгүй болгохоор тогтов.

Шүүх хуралдаанд судлагдсан дараах баримт сэлт, мэдээллийг хэрэгт ач холбогдол бүхий бөгөөд хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хүрэлцээтэй байна гэж үзлээ. Үүнд:

1. Шүүгдэгч Н.Хү нь:

Чингэлтэй дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Монгол Улсын Засгийн газрын тусгай сан буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар сан"-ийн гүйцэтгэх захирлаар 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж байхдаа 2012 онд 116.000.000 төгрөгийг сургалт зохион байгуулах нэрээр "ХБ" ХХК-ийн дансаар, 21.440.000 төгрөгийг ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар, 1.454.079.500 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар, 100.000.000 төгрөгийг зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар, 2011 онд 240.000.000 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" ХХК-ийн дансаар гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан гэмт хэргийг,

мөн Н.Хү нь М.Ху-тай нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 38.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11.000.000 төгрөгийг тус тус авч, нийт 49.000.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэргийг,

мөн Н.Хү нь хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирлыг учруулсан гэмт хэргийг,

мөн яллагдагч Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цагаан цаасан дээр зурж үлдээснээс М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлж, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан гэмт хэргийг,

2. Шүүгдэгч М.Ху нь:

"Цэвэр агаар" сангийн нягтлан бодогчоор 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл хугацаанд ажиллаж байхдаа "ХБ", "ОСБ", "АЖ" компаниудын гэрээг хуурамчаар

үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ"ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 78.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 10.144.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 216.000.000 төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар 429.760.000 төгрөгийг, мөн Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж хуурамч гэрээ үйлдэн байгуулж, уг "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 1.931.938.529 төгрөгийг хувьдаа завшиж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

3. Шүүгдэгч Д.Цэ нь:

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху болон Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар" сангаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гаргуулж, үүнээс 340.000.000 төгрөгийг авч хувьдаа завшиж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

4. Шүүгдэгч Б.Чи нь:

"Цэвэр агаар" сангийн мэргэжилтнээр ажиллаж байхдаа 2011 оны 12 сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-аас буцаагдсан бэлэн мөнгө болох 21.780.000 төгрөгийг хувьдаа авч завшиж, улсад их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

5. Шүүгдэгч Х.Бо нь:

"Цэвэр агаар" сангийн нярваар ажиллаж байхдаа "ШГЭБ" ХХК-ийн үүсгэн байгуулж, 2011 онд "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху болон Байгаль Орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сантай хуурамч гэрээг үйлдэн, байгуулж улмаар тус сангаас гаргасан 2.726,500,000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшиж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

6. Шүүгдэгч Б.Да нь:

Үндэсний Аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудиторовын албан тушаал эрхэлж байхдаа "Цэвэр агаар" сангийн 2011-2012 оны тайланд санхүүгийн Аудит хийснийхээ дараа тус сангийн нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэж өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн

байгуулж тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг гаргаж, үүнээс 90.000.000 төгрөгийг М.Ху авч, түүнээс татварт 10.000.000 төгрөг үлдээснээс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшиж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

7. Шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нар нь:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар сан"-гаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь дээр дурдагдсан шүүгдэгч, хохирогч, гэрч нарын мэдүүлгүүд, шинжээчийн дүгнэлтүүд, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтууд болон хавтаст хэрэгт авагдсан бичгийн бусад нотлох баримтуудаар хангалттай нотлогдож тогтоогдсон байна.

Иймд шүүгдэгч Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдсэн,

шүүгдэгч М.Ху-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдсэн,

шүүгдэгч Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2 гэмт хэргүүдийг үйлдсэн,

шүүгдэгч Б.Чи-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн,

шүүгдэгч Х.Бо-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдсэн,

шүүгдэгч Б.Да-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн,

шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, хуульд заасан хорих ял шийтгэл оногдуулах хууль зүйн үндэслэлтэй.



Шүүгдэгч Н.Хү-ийн Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан гэх хэргийн хохирлоос Түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар 1.457.079.500 төгрөгийг, зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөгийг тус тус хасаж тооцов.

Шүүгдэгч Н.Хү, М.Ху, Д.Цэ, Х.Бо нар нь хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн ял оногдуулж байгаа тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасныг журамлах нь зүйтэй байна.

Гэмт хэргийн улмаас учруулсан гэм хорын хохиролд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Хү-ээс 49.000.000 төгрөгийг, шүүгдэгч М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг, Д.Цэ-гээс 340.000.000 төгрөгийг, Х.Бо-гаас 25.500.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Чи-эс 21.780.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Да-аас 5.200.000 төгрөгийг гаргуулж Засгийн газрын тусгай сан буюу "Цэвэр агаар" санд оруулах нь зүйтэй байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасныг журамлан гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох хавтаст хэрэгт битүүмжлэгдсэн ирсэн шүүгдэгч М.Ху-гийн LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин, LEXUS RX-350 маркийн хх-хх УНА улсын дугаартай автомашин болон гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөөр худалдан авсан үнэт эдлэлүүд, шүүгдэгч Х.Бо-гийн албан өрөөнөөс хураагдсан 1.000 ам.доллар, шүүгдэгч Д.Цэ-гийн Volkswagen Tiguan маркийн хх-хх УНР улсын дугаартай автомашин зэргийг улсын орлого болгох нь зүйтэй гэж шүүх үзэв.

Хэрэгт битүүмжлэгдсэн ирсэн шүүгдэгч Н.Хү-ийн 10 орон сууц, шүүгдэгч М.Ху-гийн 2 орон сууц, шүүгдэгч Д.Цэ-гийн 3 орон сууц, шүүгдэгч Б.Чи-ийн 1 орон сууц, шүүгдэгч Х.Бо-гийн Ниссан Вингроуд маркийн автомашин, Краз маркийн чирэгч автомашиныг чиргүүлийн хамт хохиролд тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлэхээр тогтов.

Шүүгдэгч Б.Да, Б.Ат, Д.Гэ, Т.Мө, Ж.Сү, М.Аб нарын эд хөрөнгийг битүүмжилж ирүүлээгүй болно.

Хохирогч Сангийн яамны төрийн сангийн газар нь татварт төлөгдсөн гэх 248.559.500 төгрөгийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдах нь зүйтэй байна.

Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн "ШГЭБ" ХХК-ийн тамгыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хууль ёсны эзэмшигч Х.Бо-д буцаан олгох нь зүйтэй.

Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохиролд шүүгдэгч М.Ху-гаас 155.000.000 төгрөг, шүүгдэгч Х.Бо-гаас 5.000.000 төгрөгийг төлснийг төлөх хохирлоос хасаж тооцсон болно.

Шүүхээс шүүгдэгч нарт ял шийтгэл оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 56 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн улмаас бусдад хүнд хор уршиг учруулсан, учруулсан хохирлоо нөхөн төлөөгүй зэргийг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцов.

Шүүгдэгч Д.Гэ, Б.Ат нар хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн, гэмт этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, байдал зэргийг харгалзан, тэдэнд оногдуулсан хорих ялыг заавал биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж хянан харгалзах боломжтой гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Энэ хэргээс мөрдөн байцаагчийн 2011 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн тогтоолоор Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтэст мэргэжилтнээр ажиллаж байсан А.С нь бусдын нөлөөнд автсан, шан харамж, хахууль авсан эсэхийг шалгах шаардлагатай гэсэн үндэслэлээр Н.Хү нарт холбогдох хэргээс тусгаарласан болохыг тэмдэглэв.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 284, 286, 290 дүгээр зүйлийн 290.3, 294, 295, 296, 297, 298-р зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар шүүгдэгч Я овогт Ж.Сү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

У овогт М.Аб-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Г овогт Т.Мө-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт

заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Т овогт Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Б овогт Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг

Б овогт Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Б овогт Н.Хү-ийн түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар 1.457.079.500 төгрөгийг шилжүүлсэн, зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөгийг гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан,

Т овогт Б.Чи-ийг шүүгдэгч Н.Хү, М.Ху нартай бүлэглэж, "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг завшсан, мөн хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт ашиглаж, онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэргийг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

2.Шүүгдэгч Б овогт Н.Хү-ийг Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн,

Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан,

Албан тушаалтан албан үүрэгтэй хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учруулсан гэмт хэргийг үйлдсэн,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт М.Ху-г Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт Д.Цэ-г Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргийг үйлдсэн,

Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Т овогт Б.Чи-ийг Бусдын эд хөрөнгийг завшиж, их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт Х.Бо-г Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт Б.Да-ыг Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Х овогт Б.Ат, Б овогт Д.Гэ нарыг Албан тушаалтан албан үүрэгтэй хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

3. Шүүгдэгч Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 6 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3

дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэглэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Б.Да-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хорих ялаар,

Шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр тус бүр 1 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг журамлан ялтан Н.Хү-д энэ тогтоолоор оногдуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялд хөнгөн ял болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр

хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ялыг тус тус багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэглэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 6 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 1 жилийг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ялаар,

Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жил хорих ялыг багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тус тус тогтоосугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан Н.Хү, Б.Да нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Б.Ат, Д.Гэ нарын эдлэх ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Хү-ийн цагдан хоригдсон 93 хоногийг, шүүгдэгч М.Ху-гийн цагдан хоригдсон 138 хоногийг, шүүгдэгч Д.Цэ-гийн цагдан хоригдсон 149 хоногийг, шүүгдэгч Х.Бо-гийн цагдан хоригдсон 61 хоногийг, шүүгдэгч Б.Чи-ийн цагдан хоригдсон 66 хоногийг, шүүгдэгч Б.Да-ын 76 хоногийг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд нь оруулсан тооцож, шүүгдэгч Т.Мө 57 хоног, шүүгдэгч М.Аб, Ж.Сү, Б.Ат, Д.Гэ нар нь тус бүр 33 хоног цагдан хоригдсон болохыг дурдсугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хэрэгт битүүмжлэгдэн ирсэн LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин, LEXUS RX-350 маркийн хх-хх УНА улсын дугаартай автомашин болон М.Ху-гийн гэмт хэрэг үйлдэн олсон мөнгөөр худалдан авсан үнэт эдлэлүүд, 1000 ам.доллар, Волксваген Тигуан маркийн хх-хх УНР улсын дугаартай тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгосугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар Н.Хү төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хассан, Д.Цэ-гийн төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилийн хугацаагаар хассан нэмэгдэл ялын хугацааг үндсэн ялыг эдлэж дууссан үеэс эхлэн тоолсугай.

9. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн “ШГЭБ” ХХК-ийн тамгыг хууль ёсны эзэмшигч Х.Бо-д буцаан олгосугай.

10. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Хү-ээс 49.000.000 төгрөгийг, шүүгдэгч М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг, шүүгдэгч Д.Цэ-гээс 340.000.000 төгрөгийг, шүүгдэгч Х.Бо-гаас 25.500.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Чи-эс 21.780.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Да-аас 5.200.000 төгрөгийг тус тус гаргуулж "Цэвэр агаар сан"-д олгосугай.

12. Хэрэгт битүүмжлэгдсэн ирсэн шүүгдэгч Н.Хү-ийн:

- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 3 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц

- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 4 тусдаа өрөөнүүдээ зоорины давхрын орон сууцнуудын хэсгээс хохиролд тооцуулахаар,

шүүгдэгч Д.Цэ-гийн:

- Баянзүрх дүүргийн ... хороо ... тоот 3 өрөө

- Баянзүрх дүүргийн ...хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй орон сууц, 2 авто зогсоолын хамт

- Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

шүүгдэгч М.Ху-ийн:

- Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууц,

- ...сумын ...тоот 4 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар, шүүгдэгч Б.Чи-ийн:

- Сүхбаатар дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцны хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

шүүгдэгч Х.Бо-ийн:

- Ниссан Вингроуд маркийн автомашин, -Краз маркийн чирэгч автомашиныг чиргүүлийн хамт хохиролд тооцуулахаар тус тус Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсүгэй.

12. Шүүгдэгч Б.Да, Б.Ат, Д.Гэ, Т.Мө, Ж.Сү, М.Аб нараас эд хөрөнгө битүүмжилж ирүүлээгүйг дурдсугай.

13. Хохирогч Сангийн яамны Төрийн сангийн газар нь татварт төлөгдсөн гэх 248.559.500 төгрөгийг иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсугай.

14. Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохиролд шүүгдэгч М.Ху-гаас 155.000.000 төгрөгийг, шүүгдэгч Х.Бо 5.000.000 төгрөгийг төлсөн болохыг дурдсугай.

15. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн

61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт тус бүр оногдуулсан 1 жил хорих ялыг тэнсэж, хугацаагаар хянан харгалзаж, тэдгээрт хяналт тавихыг Сонгинохайрхан, Баянгол цагдаагийн хэлтэст даалгасугай.

16. Шүүгдэгч Ж.Сү, М.Аб, Т.Мө нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, шүүх хуралдааны танхимаас суллаж, шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авсугай.

17. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хуулийн хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо Б.Да, нарт урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээж,

тэдгээрийн эдлэх ялыг 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн тоолсугай.

18. Шийтгэх тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд тогтоолын хувийг гардаж авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

19. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Б.Да нарт урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг, Б.Ат, Д.Гэ нарт авсан батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

З.БОЛДБААТАР  
И.ГАНБАТ  
Б.МӨНХБАЯР

## МАГАДЛАЛ

2014 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө,  
Б.Ат, Д.Гэ нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Ш.Бат-Д.Эрдэнэ даргалж, шүүгч Т.Өсөхбаяр, Ц.Оч нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

прокурор О.Гэрэл,

хохирогчийн хууль ёсны төлөөлөгч

А.Дав

ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Д.Нямдорж,

М.Баасанбат, Г.Оюунцэцэг

ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Б.Энхзаяа,

Б.Оюунбилэг, Р.Мэндсайхан, Ц.Итгэл,

ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч Д.Гансүх,

М.Алтанцэцэг,

ялтан Б.Чи-ийн өмгөөлөгч Л.Өлзийхүү,

Г.Батбаяр, Б.Цэрэндолгор,

ялтан Х.Бо-гийн өмгөөлөгч Д.Даваа,

ялтан Б.Да-ын өмгөөлөгч

Д.Цэвээнцэрэн,

ялтан Т.Мө-ы өмгөөлөгч Б.Мянган,

ялтан Б.Ат, түүний өмгөөлөгч

С.Цэдэндамба, ялтан Д.Гэ, түүний өмгөөлөгч

Ж.Энхнасан,

нарийн бичгийн дарга Э.Энххэрлэн,

Э.Эрдэнэбулган нарыг оролцуулж,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шүүгч З.Болдбаатар даргалж, шүүгч И.Ганбат, Б.Мөнхбаяр нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч,

ялтан Н.Хү, М.Ху, Д.Цэ, Х.Бо, Б.Да,

Б.Чи, Б.Ат, Д.Гэ, ялтан Б.Да-ын өмгөөлөгч

С.Дондов, ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч

Д.Нямдорж, М.Баасанбат, Х.Базаррагчаа,

ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч Д.Гансүх,

М.Алтанцэцэг, ялтан М.Ху-гийн өмгөөлөгч

Б.Энхзаяа, Б.Оюунбилэг, Р.Мэндсайхан,

ялтан Б.Чи-ийн өмгөөлөгч Л.Өлзийхүү,

Г.Батбаяр, ялтан Б.Ат-гийн өмгөөлөгч

С.Цэдэндамба, ялтан Д.Гэ-ийн өмгөөлөгч

Ж.Энхнасан, ялтан Х.Бо-гийн өмгөөлөгч

Д.Даваа нарын гаргасан давж заалдах

гомдлуудаар Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо,

Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө, Б.Ат, Д.Гэ нарт

холбогдох 20130100027. дугаартай хэргийг

2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүлээн авч, шүүгч Ц.Очийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Б овгийн Н.Хү, ...оны ...дугаар сарын ...-нд Ховд аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Монгол Улсын Засгийн Газрын тусгай сан, Байгаль орчин, Ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар" сангийн захирал ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ПЭ...../,

2. Б овгийн М.Ху, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: УЕ...../,

3. Б овгийн Д.Цэ, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ШГ...../,

4. Т овгийн Б.Чи, ...оны ...дугаар сарын ...-нд Архангай аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл..., охины хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн мэргэжилтэн ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ЧВ...../,

5. Б овгийн Б овогт Х.Бо, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал ажилтай, 2005 оны 3 дугаар сарын 11-нд 1986 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 3-т зааснаар

2 жил хорих ялаар шийтгүүлж, уг хорих ялыг тэнсэж 1 жилийн хугацаагаар хянан харгалзсан, /регистрийн дугаар: НМ ...../,

6. Я овгийн Ж.Сү, ...оны ...дугаар сарын ...-нд Сүхбаатар аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл..., хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Баянгол дүүргийн Татварын хэлтэст Татварын улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ЛБ...../,

7. У овгийн М.Аб, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, экологич мэргэжилтэй, ам бүл ..., хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "Үндэсний Хөгжлийн Хүрээлэн"-д Хүрээлэн буй орчин бодлогын судалгааны секторын эрхлэгч, "ЭАИ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ПЭ...../,

8. Б овгийн Б.Да, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газарт аудитор ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар ИЮ...../,

9. Г овгийн Т.Мө, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "ИТТ" ХХК-д менежер, "ХТТ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар СР...../,

10. Х овгийн Б.Ат, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар ЦД...../,

11. Б овгийн Д.Гэ, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл..., нөхрийн хамт ...дүүргийн ...дугаар хороо,

...тоотод оршин суух, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар ХН...../,

Холбогдсон хэрэг /Прокурорын яллах дүгнэлтэд дурдсанаар/:

1. Шүүгдэгч Н.Хү нь:

Чингэлтэй дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Монгол Улсын Засгийн газрын тусгай сан буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар сан"-ийн гүйцэтгэх захирлаар 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж байхдаа 2012 онд 116.000.000 төгрөгийг сургалт зохион байгуулах нэрээр "ХБ" ХХК-ийн дансаар, 21.440.000 төгрөгийг ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар, 1.454.079.500 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар, 100.000.000 төгрөгийг зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар, 2011 онд 240.000.000 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" ХХК-ийн дансаар гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан гэмт хэрэгт,

Н.Хү нь М.Ху, Б.Чи нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 38.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11.000.000 төгрөгийг, "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг,

Б.Да-ын төрсөн дүү Б.Зг-ын нэрээр үүсгэн байгуулсан "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг тус тус авч, 1.447.671.550 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт,

Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цагаан цаасан дээр зурж үлдээснээс М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлж, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан гэмт хэрэгт,

Н.Хү нь давтан үйлдлээр, 2011 онд ШУА-ийн Газарзүйн хүрээлэнд 76.000.000 төгрөгийн санхүүжилт бүхий Нийслэлийн

гэр хорооллын айл өрхүүдийн хөрсний бохирдолд шинжилгээ хийх ажлыг олгож уг санхүүжилтээс өөрийн үүсгэн байгуулалцсан "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөгийг, "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас 44 сая төгрөгийг нийт 53.000.000 төгрөгийн хахууль авсан гэмт хэрэгт,

2. М.Ху нь:

"Цэвэр агаар" сангийн нягтлан бодогчоор ажиллаж байх хугацаандаа "ХБ", "ОСБ", "АЖ" компаниудын гэрээг хуурамчаар үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ"ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 36.500.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.144.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 86.000.000 төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар гаргасан 429.760.000 төгрөгөөс 380.000.000 төгрөгийг,

мөн Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 771.000.000 төгрөгийг тус тус хувьдаа завшиж, улсад 1.278.644.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт,

3. Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын байдлаар урвуулан, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху болон түүний найз Х.Бо нартай үгсэн тохиролцож, "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн, "Цэвэр агаар" сангаас уг компанийн дансаар 2.726,500,000 төгрөгийг гаргуулж, үүнээс 1.500.000.000 төгрөгийг авч хувьдаа завшсан гэмт хэрэгт,

4. Б.Чи нь "Цэвэр агаар" сангийн мэргэжилтнээр ажиллаж байхдаа "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэж "ХБ"ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг, 2011 оны 12 сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-наас буцаагдсан бэлэн мөнгө болох 21.780.000 төгрөгийг тус тус хувьдаа авч, нийт 188.280.000 төгрөг завшсан гэмт хэрэгт,

мөн "ХТТ" ХХК-ны захирал Т.Мө нь "Цэвэр агаар" сантай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд

"Цэвэр агаар" сангийн захирал Н.Хү-д өгсөн 44.000.000 төгрөгийн хээл хахуулийг зуучилсан гэмт хэрэгт,

5. Яллагдагч Б.Да нь Үндэсний Аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудиторроор ажиллаж байхдаа "Цэвэр агаар" сангийн 2011-2012 оны тайланд санхүүгийн Аудит хийснийхээ дараа тус сангийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэн өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн байгуулж тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч, уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт,

6. Яллагдагч "Цэвэр агаар" сангийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн захирал үүсгэн байгуулагч Х.Бо нь 2011 онд "Цэвэр агаар" сангийн нягтлан М.Ху болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сантай хуурамч гэрээг үйлдэн, байгуулж улмаар тус сангаас гаргасан 2.726,500,000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшсан гэмт хэрэгт,

мөн хуурамч бичиг баримтаар гэрээ байгуулан "Цэвэр агаар" сангаас "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө шилжүүлж авсан гэмт үйлдлээ нуун далдлах зорилгоор уг компанийг татан буулгах, татварын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрүүлэхгүй байх зорилгоор Баянгол дүүргийн татварын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт,

7. М.Аб нь ШУА-ийн Газар зүйн хүрээлэнтэй түншлэлийн гэрээ хийх замаар "Цэвэр агаар" сангаас 76.000.000 төгрөгийн, мөн "Цэвэр агаар" сангаас санхүүжигдсэн гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхнүүдийг ариутгах ажлыг хийх "ИЙТ" ХХК-аас Н.Хү-ийн албан тушаалын байдлыг ашиглан мониторингын 86.400.000 төгрөгийн ажлыг, мөн "Цэвэр агаар" сантай гэрээ хийж гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур суурилуулсан ажлын үр дүнд мониторинг хийх 89.900.000 төгрөгийн ажлыг авч бусдаар хийлгүүлэн ашиг олж Н.Хү-д 9.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт,

8. Т.Мө нь "ХТТ" ХХК-ийн захирал бөгөөд "Цэвэр агаар" сантай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд Б.Чи-ээр дамжуулан тус сангийн захирал Н.Хү-д



давтан үйлдлээр нийт 44.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт,

9. Ж.Сү нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа "ШГЭБ" ХХК-ийн захирал Х.Бо-гаас 1.000.000 төгрөгийн хахуулийг түүний ашиг сонирхлын үүднээс урьдчилан амлахгүйгээр авсан гэмт хэрэгт,

10. Б.Ат нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Д.Гэ-ийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэг Д.Гэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Ат-гийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Нийслэлийн Прокурорын газраас:

Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 272 дугаар зүйлийн 272.2, 268 дугаар зүйлийн 268.2 заасан гэмт хэрэгт,

М.Ху-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэрэгт,

Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэрэгт,

Б.Чи-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 270 дугаар зүйлийн 270.1-т заасан гэмт хэрэгт,

Х.Бо-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн

150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 269 дүгээр зүйлийн 269.1-т заасан гэмт хэрэгт,

М.Аб-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-т заасан гэмт хэрэгт,

Б.Да-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт,

Т.Мө-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2-т заасан гэмт хэрэгт,

Ж.Сү-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-т заасан гэмт хэрэгт,

Б.Ат, Д.Гэ нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэрэгт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар Ж.Сү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг,

М.Аб-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг,

Т.Мө-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг,

Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг,

Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг,

Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг,

Н.Хү-ийн түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар 1.457.079.500 төгрөгийг шилжүүлсэн, зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөгийг гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан үйлдлийг,

Б.Чи-ийг Н.Хү, М.Ху нартай бүлэглэж, "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000

төгрөгийг завшсан, мөн хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглаж онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэргүүдийг тус тус хэрэгсэхгүй болгож,

Н.Хү-ийг Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж онц их хэмжээний хохирол учруулсан,

бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан,

албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учруулсан гэмт хэргийг үйлдсэн,

хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

М.Ху-г Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Д.Цэ-г Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учруулсан,

бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б.Чи-ийг бусдын эд хөрөнгийг завшиж, их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Х.Бо-г бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан,

хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б.Да-ыг бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б.Ат, Д.Гэ нарыг албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож,

Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө

хураах нэмэгдэл ял хэрэглэн 8 жил хорих ял, 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр 3 жил хорих ял, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жил хорих ял, 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр хасаж, 3 жил хорих ял,

М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн 6 жил хорих ял, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 3 жил хорих ял,

Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн 8 жил хорих ял, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жил хорих ял, 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн 3 жил хорих ял,

Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн 5 жил 1 сар хорих ял,

Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн 5 жил 1 сар хорих ял, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жил хорих ял,

Б.Да-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн 5 жил 1 сар хорих ял,

Б.Ат-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр 1 жил хорих ял,

Д.Гэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр 1 жил хорих ял тус тус шийтгэж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг журамлан

ялтан Н.Хү-д энэ тогтоолоор оногдуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн 8 жилийн хугацаагаар хорих ялд хөнгөн ял болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ялыг тус тус багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 6 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 1 жилийг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ялаар,

Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил

1 сарын хугацаагаар хорих ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жил хорих ялыг багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тус тус тогтоож,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан Н.Хү, Б.Да нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар ялтан М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Б.Ат, Д.Гэ нарын эдлэх ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт зааснаар Н.Хү-ийн цагдан хоригдсон 93 хоногийг, М.Ху-гийн цагдан хоригдсон 138 хоногийг, Д.Цэ-гийн цагдан хоригдсон 149 хоногийг, Х.Бо-гийн цагдан хоригдсон 61 хоногийг, Б.Чи-ийн цагдан хоригдсон 66 хоногийг, Б.Да-ын 76 хоногийг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд нь оруулсан тооцож, Т.Мө 57 хоног, М.Аб, Ж.Сү, Б.Ат, Д.Гэ нар нь тус бүр 33 хоног цагдан хоригдсон болохыг дурдаж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хэрэгт битүүмжлэн ирүүлсэн LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин, LEXUS RX-350 маркийн хх-хх УНА улсын дугаартай автомашин болон М.Ху-гийн гэмт хэрэг үйлдэн олсон мөнгөөр худалдан авсан үнэт эдлэлүүд, шүүгдэгч Х.Бо-гийн албан өрөөнөөс хураагдсан 1.000 ам.доллар, шүүгдэгч Д.Цэ-гийн Volkswagen Tiguan маркийн хх-хх УНР улсын дугаартай автомашин зэргийг улсын орлого болгож,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар Н.Хү төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хассан, Д.Цэ-гийн төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилийн хугацаагаар хассан нэмэгдэл ялын хугацааг үндсэн ялыг эдэлж дууссан үеэс эхлэн тоолж,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн "ШГЭБ" ХХК-ийн тамгыг хууль ёсны эзэмшигч Х.Бо-д буцаан олгож,

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар Н.Хү-ээс 49.000.000 төгрөгийг, М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг, Д.Цэ-гээс 340.000.000 төгрөгийг, Х.Бо-гаас 25.500.000 төгрөгийг, Б.Чи-эс 21.780.000 төгрөгийг, Б.Да-аас 5.200.000 төгрөгийг тус тус гаргуулж "Цэвэр агаар" санд олгож,

Хэрэгт битүүмжлэгдсэн ирсэн

Н.Хү-ийн:

- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 3 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 4 тусдаа өрөөнүүдээ зоорины давхрын орон сууцнуудын хэсгээс хохиролд тооцуулахаар,

Д.Цэ-гийн:

- Баянзүрх дүүргийн ... хороо ... тоот 3 өрөө

- Баянзүрх дүүргийн ...хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй орон сууц, 2 авто зогсоолын хамт

- Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

М.Ху-ийн:

-Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууц,

- ...сумын ...тоот 4 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

Б.Чи-ийн:

- Сүхбаатар дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцны хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

Х.Богийн:

- Ниссан Вингроуд маркийн автомашин,

-Краз маркийн чирэгч автомашиныг чиргүүлийн хамт хохиролд тооцуулахаар тус тус

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, Б.Да, Б.Ат, Д.Гэ, Т.Мө, Ж.Сү, М.Аб нараас эд хөрөнгө битүүмжилж ирүүлээгүйг, хохирогч Сангийн яамны Төрийн сангийн газар нь татварт төлөгдсөн гэх 248.559.500 төгрөгийг иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг, гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохиролд М.Ху-гаас 155.000.000 төгрөгийг, Х.Бо 5.000.000 төгрөгийг төлсөн болохыг,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар ялтан Б.Ат, Д.Гэ нарт тус бүр оногдуулсан 1 жил хорих ялыг тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзаж, тэдгээрт хяналт тавихыг Сонгинохайрхан, Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэст тус тус даалгаж,

шүүгдэгч Ж.Сү, М.Аб, Т.Мө нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, шүүх хуралдааны танхимаас суллаж, Б.Ат, Д.Гэ нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авч, Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо Б.Да нарт урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээж, тэдгээрийн эдлэх ялыг 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн тоолж шийдвэрлэжээ.

Ялтан Н.Хү давж заалдах гомдолдоо:

Миний ажиллаж байсан Цэвэр агаар сан нь 2011 оны 6 дугаар сард Засгийн газрын шийдвэрээр шинэ бүтэц бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн ба уг бүрэлдэхүүнд салбар хариуцсан сайдын санал болгосон хүнийг итгэл хүлээлгэн ерөнхий нягтлан бодогчоор авч ажиллуулсан. Шинэ салбар, шинэ ажил эхлээд 1 жил болоогүй 2012 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас мөн Үндэсний аудитын газраас 72 хоног, 2013 онд тус 2 байгууллагаас 73 хоног санхүүгийн бүрэн хэмжээний шалгалтыг хийж ямар нэгэн зөрчил илрүүлээгүй нь М.Ху нягтланд итгэх итгэлийг улам өндөр болгож, Төрийн одон медалиар шагнуулах хүртэл хэмжээнд очсон байсан. Уг 2 байгууллагын удаа дараагийн шалгалтуудын актад ямар нэгэн санхүүгийн зөрчил байгаа талаар дурдаагүй байсан нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх үндэслэл болж байсан. Шалгалтын үр дүнд эргэлзэх, гомдох гомдол одоо ч миний сэтгэлд их байна. Нягтлан М.Ху нь намайг томилолтоор явах бүрт 4, 5 хүний цалин, нийгмийн даатгалын дэвтрийг

хоцроож торгуульд орох хэрэггүй гэж итгүүлэн 3 ширхэг гарын үсэгтэй цаас авч үлддэг байсан. Миний хувьд томилолтоос эргэж ирээд орхисон гарын үсэгтэй цаасаа юунд ашигласан, хаашаа, ямар дүнтэй гүйлгээ хийсэн гэхчилэн асууж нягтлаагүйдээ туйлын их харамсаж байна. Миний уг хэргийг шийдвэрлэсэн шүүхийн 211 дүгээр тогтоолын зарим хэсгийг зөвшөөрөхгүй байна. Тухайлбал:

Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар намайг "ХБ" ХХК, "ОСБ" ХХК-ийн нэрээр 37.0 сая төгрөг, 12 сая төгрөг, нийт 49.0 сая төгрөгийг завшин үрэдүүлсэн гэж үзэн ялласан. Үүнд:

Уг 2 гэрээг миний бие байгуулаагүй бөгөөд уг гэрээг эрх мэдлээ хэтрүүлэн М.Ху байгуулсан байдаг. Тус 2 компанийн гэгдэх 49 сая төгрөгийг зөвхөн М.Ху-гийн мэдүүлгээр надад тохож байгаа бөгөөд үүнд ямар ч нотлох баримт, гэрч байхгүй. Логикоор бодоход хэрэв би уг мөнгийг М.Ху-тай хамтран завших байсан бол уг гэрээг би өөрийн биеэр хийх байсан биз ээ. М.Ху төлбөрийн даалгаврыг дандаа багц багцаар бүрдүүлэн гарын үсэг зуруулж гүйлгээ хийдэг байсан бөгөөд энэ завсар дээрх компаниудын төлбөрийн даалгаврыг зуруулсан байх магадлалтай юм. Үүнийг Сангийн яамны төрийн сангийн гүйлгээний нягтлан хавтаст хэрэгт нотлон хэлсэн байдаг. Н.Хү болон миний ах дүүгийн хөрөнгө орлого болон банк санхүүгийн бүх данс гүйлгээнүүдийг Авлигатай тэмцэх газраас шалгасан бөгөөд ийм хэмжээний хөрөнгийн асуудал байхгүй байсан. Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйл анги болох хуурамчаар бичиг баримт үйлдсэн гэх зүйл ангиар ялласан бөгөөд хавтаст хэрэг болон шүүх хурал дээр миний үйлдсэн гэх ямарч хуурамч бичиг баримт, гэрээ хэлцэл байхгүй бөгөөд миний бие ямар бичиг баримт хийж энэ зүйл ангиар яллагдаж байгаагаа ойлгохгүй байна. Мөн төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан гэх бөгөөд миний хийсэн бүх төлбөрийн даалгаврын зориулалт нь Цэвэр агаар сангийн удирдах зөвлөлийн баталж өгсөн төсвийн дагуу хийгдсэн бөгөөд харин уг төсвийг хүлээн авсан байгууллага анхнаасаа хууль бусаар ашиглах гэж байсан хүмүүс уг мөнгийг зориулалтын бусаар ажилласан гэж үзэж байна. Дээр дурдсанчлан Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Үндэсний аудитын удаа дараагийн шалгалтын дүгнэлтэд миний биеийг төсвийн хөрөнгийг зориулалтын

бусаар зарцуулсан гэх ямар нэгэн дүгнэлт байхгүй. Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйл буюу албан тушаалдаа хайнга хандсан үйлдлийг нягтлан бодогч М.Ху-д итгэж гарын үсэгтэй цаас үлдээсэн нь буруу байсан гэж миний бие үзэж байна. Иймд би өөрийн биеэр давж заалдах шатны шүүх хуралд суух хүсэлтэй байгаа тул хүсэлтийг минь хүлээн авна уу гэжээ.

Ялтан М.Ху давж заалдах гомдолдоо:

Шийтгэх тогтоолыг уншиж танилцуулахад хэт нэг талыг барьсан өнгө аястай буюу надтай эсрэг ашиг сонирхолтой хүмүүст ашигтай мэдүүлэг, нотлох баримтуудыг илүү түлхүү оруулж, надад ашигтай хэргийн хэргийн үнэн бодитой байдлыг тогтооход хэрэгтэй мэдүүлэг, нотлох баримтуудыг оруулаагүй, дүгнэлт хийгээгүй байгаа нь илт харагдаж байна. Би өөрт оногдуулсан хэргийн зүйчлэл, ялын талаар ямар нэгэн гомдол саналгүй боловч бүлэглэн үйлдсэн дээрх гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг бүгдийг нь буюу 4.2 тэрбум төгрөгийг зөвхөн ганц оролцогч болох надад ямарч үндэслэлгүйгээр оногдуулсныг яагаад ч зөвшөөрөх боломжгүй бөгөөд хэлмэгдүүлэлт гэж үзэж байна. Үнэхээр ийм асар их хэмжээний мөнгийг би ганцаараа завшсан бол тэр мөнгийг би хаана, ямар хэлбэрээр байлгаж байгаа тухай нотолгоо хавтаст хэрэгт байх ёстой байх. Гэтэл ийм баримт байхгүй. Харин би өөрийн учруулсан 973.878.529 төгрөгийн хохирлыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд татварт тооцогдсон 258.312.950 төгрөг, Цэвэр агаар санд буцаан тушаасан 394.561.471 төгрөг, "Т" ХХК-ийн Цэвэр агаар санд өгсөн түлшний үнэ 75.750.000 төгрөгийг хасаад, үлдэх 3.236.339.500 төгрөгийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Түүнчлэн Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 4 дүгээр зүйлээр нийт 15 жилийн хорих ял оногдуулснаас хүндийг нь хөнгөнд нь багтааж 8 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр болж 7 жил нь хасагдсан. Мөн Д.Цэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 3 дугаар зүйлээр нийт 12 жилийн хорин ял оногдуулснаас хүндийг нь хөнгөнд нь багтааж 8 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр болж 4 жил нь хасагдсан байна. Гэтэл надад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 2 зүйлээр нийт 9 жилийн ял оногдуулснаас нэмж, нэгтгэх замаар 7 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр болж 2 жил нь хасагдсан байна. Дээр нь надад 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял

оногдуулсан бол Н.Хү, Д.Цэ нарт 10 дахин бага буюу 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулжээ. Үүнээс харахад л шүүх тэдний гэмт хэрэг үйлдсэнээ огт хүлээхгүй, гэмшихгүй байгааг дэмжиж байгаа мэт харагдаж байна. Би анхнаасаа үйлдсэн хэргийнхээ талаар чин санаанаасаа гэмшиж, мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд хэргийн талаар үнэн зөвөөр мэдүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд 1 дүгээр гарын үсэг зурах эрх бүхий этгээд болох Н.Хү, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий этгээд нягтлан болох миний бие нар л Цэвэр агаар сангийн орлого, зарлага зэргийг хянадаг байсан. Н.Хү нь зөвхөн хянаад зогсохгүй мэдээллийг нь өөрөө хуулбарлан авдаг байсны нотолгоо нь 2012 оны 04 дүгээр сар хүртэлх орлогын хуудсыг интернэтээс хуулбарласан нь нэгжлэг хийх үед хураагдсан. Ийм нотлох баримт хэрэгт авагдсан байхад хүртэл Н.Хү анхан шатны шүүх хурал дээр "... тийм бичиг явуулж байснаа санахгүй байна, төрийн сангийн хариу ирсэн байсныг мэдэхгүй байна гэх мэтээр худал мэдүүлж байсан. Энэ олон удаагийн үйлдлээр би ганцаараа хийгээд, ганцаараа хохирол учруулаад байгаа гэж үү. Хэрэв тийм бол нөгөө үнэнч шударга, ажил мэргэжилдээ сайн гэх дээрх гүйлгээ гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэгээ дарж байсан Н.Хү, харьяа яам, төрийн сангийн өндөр тушаалтны шууд хяналтууд болон Төрийн аудит, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг хөндлөнгийн хяналт шалгалтанд ядаж нэг гүйлгээ нь яагаад баригдаагүй юм бэ. Б.Да, М.Ху нар нь 95.2 сая төгрөгийг Н.Хү-д өгсөн гэж мэдүүлээд байхад төлбөрийг огт аваагүй хүнд оногдуулах нь хууль бус юм. Иймд хохирлын хэмжээг үнэн зөвөөр тогтоож өгнө үү. Мөн Улсын орлого болгохоор Лексус-570 маркийн автомашиныг хураасныг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бөгөөд уг автомашиныг 2012 онд авахдаа өөрийн өмчлөлийн Лексус-470 маркийн автомашин болон Ландкрузер-100 маркийн автомашинуудаа зарж, олсон мөнгө болох 135 сая төгрөг дээр ХААН банкнаас 80 сая төгрөгийн зээл авч худалдан авсан юм. Одоо ХААН банкинд зээлийн үлдэгдэлтэй болно. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн журмаар олсон мөнгөөр энэ автомашиныг аваагүй гэдгийг мөрдөн байцаалтын шатанд тогтоосон болно. Харин Лексус-350 маркийн автомашин болон үнэт эдлэлийг хохирлын төлбөрт тооцуулах хүсэлтэй байна. Эцэст нь

анхан шатны шүүх миний жирэмсэн байдлыг талаар болон ял хойшлуулах асуудлаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй болно. Миний бие одоо 5 сартай жирэмсэн ба 2 төрөлтийн хоорондох хугацаа 20 жил бөгөөд тонус өгөх, даралт унах, хэлбэлзэх зовиуртай байгаа ба энэ тухай нотлох баримт хэрэгт авагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх талаар өмгөөлөгчийн хүсэлтэд энэ талаар дурдагдсан байсан. Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д заасныг анхан шатны шүүх яагаар хэрэглэсэнгүй вэ. Яагаад энэ талаар дурдаагүй юм бэ. Иймд Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д заасан шаардлагыг хангаж байгаа тул надад ногдуулсан 7 жилийн хорих ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж өгнө үү. Мөн гэмт хэрэг хамтран үйлдсэн, удирдан зохион байгуулсан, үүрэг чиглэл өгсөн, үгсэн хуйвалдсан Н.Хү, Д.Цэ, Б.Чи нарт ногдох хохирлыг үнэн зөвөөр нь тогтоож өгнө үү гэжээ.

Ялтан Д.Цэ давж заалдах гомдолдоо:

Д.Цэ миний бие нь өөрт ногдсон ялыг хүлээн зөвшөөрөхгүй байгааг доорх үндэслэлээр тайлбарлая. Үүнд:

Нэг: Төрийн албан тушаалтан албаны эрх мэдлээ буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэрэг үйлдсэн гэж Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-оор ялласан. Миний бие нь 2008 оноос 2013 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар ажилласан. Би ажиллах хугацаандаа төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгэж байсан. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Цэвэр агаар сан гэсэн хоёр өөр байгууллага байдаг. Цэвэр агаар сан /ЦАС/ нь Засгийн газрын тусгай сангийн хуулийн дагуу 2011 онд байгуулагдсан Засгийн газраас томилогдсон удирдах зөвлөлтэй. Түүний бүрэлдэхүүнд зарим яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, газрын дарга гэх мэт албан тушаалтнууд байдаг бөгөөд намайг удирдах зөвлөл болон ажлын албанд хамааралгүй болохыг захирал Н.Хү шүүхийн хэлэлцүүлэг болон мэдүүлэгт дурдсан болно. Мөн миний албан тушаал цэвэр агаар сангийн үйл ажиллагаанд оролцох эрх мэдэл байхгүй, удирдах зөвлөлийн шийдвэрт нөлөөлдөггүй болохыг гэмт хэрэгт яллагдагчаар болон

гэрчээр татагдсан хүмүүсийн мэдүүлэг болон хавтаст хэрэгт байгаа бусад баримтуудаар нотлогдоно. Ийм байтал төрийн албан тушаалтан эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж ял оноосныг үндэслэлгүй гэж үзэж байна.

Хоёр: Бусдын эд хөрөнгийг завшсан гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэж Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ялласан.

Бусдын эд хөрөнгө гэж юуг хэлээд байгаа юм бэ. ЦАС-г хэлээд байгаа юм уу эсвэл "ШГЭБ" ХХК-ийг хэлээд байна уу. Аль эсвэл М.Ху-гийн надад хувиасаа зээлдүүлсэн 340.0 сая төгрөгийг хэлээд байгаа юм уу. Би бусдын эд хөрөнгийг албан тушаалаа ашиглан завшаагүй болно. Миний бие ЦАС-тай ямарч хамааралгүйгээ дээр дурдсан. Хавтаст хэрэгт байгаа баримтуудаар хангалттай нотлогдоно гэж үзэж байна. Би "ШГЭБ" ХХК гэдэг байгууллагыг огт мэдэхгүй. Үүнийг хавтаст хэрэгт авагдсан гэрчийн мэдүүлэг бусад баримтуудаас тодорхой харж болно. Миний бие нь М.Ху-г 20-иод жилийн өмнөөс танина. Гэмгүй сайн танил, найз нөхөд гэж боддог байсан. Миний ээж, аав 1992, 1995 онд нас барж олон өнчин дүү нартайгаа үлдсэн. Миний нөхөр төсвийн байгууллагад ажилладаг. Надад хурааж хуримтлуулсан хөрөнгө байхгүй. Миний амьдралыг М.Ху маш сайн мэднэ. М.Ху чи надаас мөнгө зээлж амьдрал ахуйгаа дээшлүүлэх ямар нэгэн юм хий гэдэг байсан. 2011 оны 07 дугаар сард хоёулаа машин авья, чи надаас мөнгө зээлчих дараа нь байр захиалаад арай илүү үнээр зараад төлчихнө биз гэсний дагуу М.Ху-д итгэж түүнээс 340.0 сая төгрөг зээлсэн. Гэтэл М.Ху хэлснээсээ огт өөр худал мэдүүлэг өгч намайг гэмт хэрэгтэн болголоо. М.Ху-гийн мэдүүлгийг худлаа болохыг Х.Бо-гийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн мэдүүлгээр "би бол Д.Цэ гэж хүнийг урьд нь харж байгаагүй, 2013 онд ажилд орсноосоо хойш харсан. Би тэр Д.Цэ-тэй уулзаж ярилцаж байгаагүй. М.Ху авсан мөнгөө хэрхэн зарцуулдаг талаар би хэлж мэдэхгүй байна" нотолно. Х.Бо нь 2013 оны 02 дугаар сард "Цэвэр агаар" санд нярваар ажилд орсон тухай хавтаст хэрэгт дурдсан байгаа. Х.Бо энэ ажилд орохоосоо өмнө Цэвэр агаар сангаас "ШГЭБ" ХХК-д шилжүүлсэн 2.7 тэрбум төгрөгийг өөрийн гараар аваад зарцуулсан тухайгаа хавтаст хэрэгт байгаа мэдүүлэгт тодорхой хэлсэн байгаа. Би хэнтэй ч бүлэглээгүй, хэний ч хөрөнгийг завшаагүй.

Үүнийг хавтаст хэрэгт байгаа баримтууд нотлоно гэж үзэж байна. Надад оноосон Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан ял нь үндэслэлгүй нотлох баримтгүй М.Ху-гийн худал мэдүүлгээр өгсөн байна.

Гурав: Хуурамч бичиг баримт, тамга тэмдэг хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдсэн гэж Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар ялласан.

Миний бие нь ямар хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэж ашиглаж гэмт хэрэг үйлдсэнээ ойлгохгүй байна. Би "ШГЭБ" ХХК гэдэг компани байдаг гэдгийг ч мэдэхгүй. Х.Бо гэдэг хүнийг огт танихгүй байж ямар хуурамч гэрээ хийх юм бэ. Х.Бо-гийн мэдүүлэгт "М.Ху бид хоёр гэрээ хийсэн би гэрээн дээр гарын үсэг зурж тамга тэмдэг дарсан" гэж тодорхой мэдүүлсэн байдаг. Надад оноосон дээрх ялыг үндэслэлгүй гэж үзэж байна. М.Ху-гийн бүх мэдүүлгүүд зөрүүтэй байдаг. Мөрдөн байцаалт зөвхөн М.Ху-гийн мэдүүлгийг үндэслэж намайг буруутан болгох гэснээс биш үнэн зөвийг тогтоохыг хүсээгүй гэдэг нь хавтаст хэрэгт авагдсан баримтуудаас тодорхой харагдаж байна. Мөрдөн байцаалтын үед хорих ангид, "Н.Хү нарын" хэргээр хоригдсон хүмүүсээс хамгийн олон хоногоор намайг хорьсон бөгөөд мөрдөн байцаагч н.Бо дээрх хэргийг хүлээхийг шаардаж тулгадаг байсан. Мөрдөн байцаагч н.Бо хэргийг дутуу дулимаг нэг талыг барьж шалгасан гэж үзэж байна. Энэ нь хавтаст хэрэг байгаа материал, шүүхийн хэлэлцүүлгийн явцаас илт харагдсан. Миний бие М.Ху гэдэг хүнтэй 20-иод жил ойр дотно хүний ёсоор нөхөрлөснийхөө, төрийн албан хаагч байсныхаа, хувь хүнээс мөнгө зээлснийхээ төлөө гэмт хэрэгтэн болно гэж бодохгүй байна. М.Ху, Х.Бо нар өөрсдийн хийсэн гэмт хэргийг хаацайлах, завшсан мөнгөө өөрсдөдөө үлдээж, оногдох ялыг хөнгөлөх зорилгоор намайг энэ гэмт хэрэгт оролцсон мэтээр гүтгэхээр төлөвлөж тохиролцсон байна гэж үзэж байна. Учир нь Х.Бо нь энэ төрлийн гэмт хэргийг үйлдээд Сонгинохайрхан дүүргийн шүүхээр шийтгүүлсэн тухай баримт хавтаст хэрэгт байдаг. Хавтаст хэрэгт байгаа гэрчүүдийн мэдүүлэг бусад баримтуудад анхаарлаа хандуулж намайг гэм буруугүй, гэмт хэрэг үйлдээгүй болохыг нотолж, анхан шатны шүүхээс оногдуулсан ялыг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Ялтан Б.Чи давж заалдах гомдолдоо:

Би 2012 онд Тайландад эмнэлэгт оношлуулан бөөр сав, тархины эхэн үеийн хавдартай гэсэн оношоор эмчилгээ хийлгэж эхэлсэн бөгөөд 2013 оны давтан шинжилгээгээр хавдрын эсийн тоо нэмэгдсэн тул нэмэлт эмчилгээг эхлүүлээд байсан ч хоригдож эхэлснээс хойш шаардлагатай эмчилгээг хийлгэж чадахгүй байгаагаас биеийн байдал дордож одоо хүнээр түшүүлж алхаж байгаа. Миний бие 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар тушаалаар гурвалсан гэрээний дагуу Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн Цэвэр агаар санаачилга-2 төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан төслийн мэргэжилтнээр томилогдон ажиллаж байсан ба "ПИ" ХХК-аас 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 21.780.000 төгрөг авахдаа би танилын хувьд Н.Хү-гийн гуйснаар авч, түүнд тэр өдөртөө хүлээлгэн өгсөн байдаг. Учир нь тухайн үед Цэвэр агаар санд ажилд ороогүй байсан ба Цэвэр агаар сангийн захирал Н.Хү-ийн 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03/13 дугаар түр ажиллах тухай тушаалаар тус санд ажиллаж эхэлсэн ба 2013 оны 06 дугаар сарын 28-ны өдөр баривчлах тогтоолоор баривчлагдан улмаар цагдан хоригдсон. Хэрэгт авагдсан Цэвэр агаар сангийн цалингийн баримт, гурвалсан гэрээ, гэрч Б.Со, яллагдагч М.Ху нарын мэдүүлгээр 2011 оны 12 дугаар сард тус санд мэргэжилтнээр ажиллаж байгаагүй нь тус тус нотлогдоно. Эдгээр баримтаар би тус санд би 3 сар 26 хоног л ажилласан болно. Гэтэл надад ял шийтгэл оногдуулахдаа Цэвэр агаар санд ажиллаж байх хугацаандаа 2012 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-аас буцаагдсан 21.780.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байгаа нь үндэслэлгүй юм. Цэвэр агаар сангаас 2011 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "ПИ" ХХК руу 24.000.000 төгрөг шилжүүлсэн болон үүнээс 21.780.000 төгрөг буцаан авах болсныг би 2011 оны 12 дугаар сард мэдэх ямар ч боломж байхгүй. Н.Хү нь байцаагдахаа би мэдэхгүй ингэж хэлээгүй, авч байгаагүй, би очоод аваад ир гэж хэлээгүй гэж мэдүүлдэг. Гэтэл би энэ мэдээллийг хаанаас авах вэ, мөн "ПИ" ХХК-ийн С гэдэг хүн хаа хамаагүй хүнд байгууллагын 21.780.000 төгрөгийг өгөх үү. Эндээс Н.Хү "ПИ" ХХК руу ярьж тохиролцсоноор би очиж авсан болох нь нотлогдож байна. Харин Н.Хү-д би дээрх мөнгийг хүргэж өгөхдөө гарын үсэг зуруулж аваагүй нь

буруу болсон. Мөн "ПИ" ХХК-ийн С гэдэг хүн яагаад хаа хамаагүй хүнд байгууллагын мөнгө өгөх болсныг нэг ч асуугаагүй нь энэ хэргийг бүрхэгдүүлсэн. Би М.Хү-г танихгүй. Н.Хү, М.Хү, Д.Цэ нар нь Улсыг завшиж, их хэмжээний мөнгө авч баяжих гэсэн нь хуульч биш надад ч ойлгомжтой байна. Би тэр мөнгийг аваагүй анхнаасаа Н.Хү-д өгсөн гэдгээ бүх мэдүүлэгтээ мэдүүлсэн. Дээрх мөнгийг Н.Хү захирлын шүүх хуралдаанд "зарцуулсан баримт нь байгаа" гэж хэлснийг намайг хэлсэн гэж буруу бичсэн байна. Тухайн үед би улсад ажиллаж байгаагүй. Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянаад шинээр өгч буй нотлох баримт болон хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтыг үнэлж дүгнээд надад холбогдох хэргийг цагаатгаж өгнө үү гэжээ.

Ялтан Х.Бо давж заалдах гомдолдоо:

Миний бие 2011 оны 5 дугаар сард Улаанбаатар хотод шилжин ирсэн бөгөөд энэ үед Дарханд хамт ажиллаж байсан М.Хү-тай уулзсан ба түүгээр дамжуулан тухайн үеийн Байгаль орчин аялал жуучлалын яамны харьяа СХОХ-ийн дарга Д.Цэ-тэй танилцсан, уулзсан болно. Ингээд компани байгуул дансаар нь мөнгө оруулаад гаргая гэсэн тэдний хүсэлтээр өөрийн нэр дээр компани байгуулан Д.Цэ-гийн танил байдаг Баянгол дүүргийн Татварын албанд бүртгүүлж байсан. Би Д.Цэ-г шударга хүн мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн өмнө үнэн зөвөө хэлнэ гэж бодож байсан боловч хийсэн хэргээ хүлээх нь битгий хэл намайг танихгүй гэж мэдүүлэг өгсөн байна. М.Хү, Д.Цэ 2 нь надаас илүү 1990 оноос хойш хамтдаа ажиллаж, үерхсэн дотно найзууд юм. Иймээс 2 найзууд учраа олно биз, би гуравдагч болоод яахав гэж бодоод зөвхөн М.Хү л мэднэ гэдэг мэдүүлгийг өгч байсан юм. "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011 онд 5 удаагийн үйлдлээр 2.260.000.000 төгрөг оруулан бэлнээр гаргаж авснаас, Д.Цэ-д нийт 1.503.700.000 төгрөгийг өгсөн. 2012 оны 02 дугаар сард түлшний хэмнэлт нэрээр компанийн дансанд орсон 1.980.000.000 төгрөгийг тэр өдөрт нь "Цэвэр агаар сан"-гийн дансанд шилжүүлсэн. Мөн оны 04 дүгээр сард орсон 466.000.000 төгрөгнөөс ХААН банкны хувийн дансаар дамжуулан 394.561.471 төгрөгийг "МХА" ХХК-ийн нэрээр Цэвэр агаар сангийн дансанд шилжүүлсэн. Дээрх мөнгийг дансаар оруулж гаргахдаа цаанаа эзэнтэй, ард нь компанийн татварын шалгалт, Цэвэр агаар сан дахь санхүүгийн болон аудитын хяналт шалгалтыг



аргална гэсэн Д.Цэ-гийн үгэнд итгэсэн. Үнэхээр ч 2011, 2012 оны шалгалтууд зөрчилгүй сайн гэсэн дүгнэлт гарсан гэхээр хэлсэндээ хүрдэг боломжтой хүн юм байна гэж бодож байсан. Би компанийн данснаас оруулсан нийт мөнгөнөөс 60.000.000 төгрөг авснаас 29.500.000 төгрөгийг компанийн татварын шимтгэлд төлсөн ба үлдэгдэл 30.500.000 төгрөгийг хувийн хэрэгцээнд зарж үрэгдүүлсэн. Бусдын үгэнд итгэж хууртан хууль бус үйлдэлд оролцсондоо үнэхээр харамсаж байна.

Миний бие нь 30.500.000 төгрөгөөс мөрдөн байцаалтын шатанд 5.000.000 төгрөг төлж барагдуулсан ба цаашид үлдэгдэл хохирлыг бүрэн төлж барагдуулах болно. Би дээрх хэргийг үйлдэх үедээ Цэвэр агаар санд ажилд ороогүй байсан ба 2013 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нярвын орон тоон дээр төслийн зуух олгосон айл өрхийн материалыг шалгах ажил үүргийн хуваарьтай түр ажилд орсон. Иймд би Цэвэр агаар сангийн ямар нэг хөрөнгийг захиран зарцуулах эрх мэдэл байхгүй болно. Хэргийг хэн санаачилсан болохыг анхан шатны шүүх тунгаасан гэж ойлгож байна. Давж заалдах шатны шүүх хэргийг олон талаас нь бодитойгоор тунгаан үнэн зөв шийдвэр гаргана гэдэгт итгэж байна. Миний эцэг 75 настай, ээжийн эрүүл мэнд тааруу, нэг нүд нь огт хараагүй, нөгөө нүд нь муу хардаг, мөн 2011 онд харвалт өгч байсан, байнгын асрамж халамж шаардлагатай, би өөрөө толгойн өвчтэй, мөн элэг, бөөр, ходоодны архаг үрэвсэлтэй бөгөөд одоо Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 461 дүгээр хорих ангийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна. Иймд миний ээжийн болон өөрийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж ял шийтгэлийг минь хөнгөрүүлж өгнө үү гэжээ.

Ялтан Б.Да давж заалдах гомдолдоо:

Миний бие "ДЗТМ" ХХК-ийг төлөөлж Цэвэр агаар сантай хамтран ажиллах гэрээ байгуулан компанийн дансанд 4 удаагийн гүйлгээгээр 100.0 сая төгрөг шилжиж орсноос 4.8 сая төгрөгийг татварт тушааж, тус сангийн нябо М.Ху-д 95.2 сая төгрөгийг бэлнээр гаргаж өгч байсан. Үүнийгээ ч М.Ху мөрдөн байцаалтын шатанд хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэрээ болон төлбөрийн даалгаврын зарим нь хуурамч гэдгийг анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр анх мэдсэн бөгөөд би зөвхөн гэрээн дээр тамга дарсан, харин гарын үсэг зураагүй юм. Анхны байцаалтыг

өмгөөлөгчгүй авсан ба зарим нэг ташаа, зөрүүтэй бичилтийг засуулаа гэхэд дараа засуул гэсэн. Гэтэл прокурор анхны өгсөн ташаа мэдүүлгийг үндэслэн 5.2 сая төгрөгийг намайг завшсан гэж яллах дүгнэлт бичсэнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Миний бие бусдын хөрөнгийг үрэгдүүлээгүй, нийгэмд хохирол учруулаагүй, тухайн сангийн эд хариуцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч биш юм. Миний ээж 70 гаруй настай бие муутай тул дүү бид 2 ээлжлэн асардаг. Эхнэр маань олон жилийн дараа сая жирэмсэн болсон, миний нуруу бөөр өвддөг, ходоодны шархтай. Миний бие уг хэрэгт холбогдсондоо харамсаж байгаа мөн ар гэрийн гачигдлыг харгалзан үзэж тус хэрэгт хамааралгүй болгон өгч хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Х.Базаррагчаа давж заалдах гомдолдоо:

Дээрх шийтгэх тогтоолоор шүүгдэгч Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5 сая төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хорих ялаар тус тус шийтгэж шийдвэрлэсэн нь хавтаст хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдохгүй байх төдийгүй шүүхийн дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримтууд харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авч бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заалгүйгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 319 дүгээр зүйлийг зөрчсөн байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-ын хувьд Н.Хү-ийн хувьд шүүхийн шийтгэх тогтоолд дурдсан "М.Ху-тай бүлэглэн "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116 сая төгрөгөөс 38 сая төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11 сая төгрөгийг тус тус авч, нийт 49 сая төгрөг хувьдаа завшсан үйлдэл огт хийгээгүй бөгөөд дээрх үйлдлийг хангалттай нотолсон нотлох баримт хавтаст хэрэгт авагдаагүй байна. Эд хөрөнгө завших үйлдэлд бусдын өмчлөлийн эд хөрөнгийг хууль ёсоор итгэмжлэн хариуцаж байсан этгээд хууль бусаар авч ашиглахыг

хамруулан ойлгох ёстой бөгөөд Н.Хү нь Цэвэр агаар сангийн хөрөнгөд хууль бус эзэмшил тогтоосон асуудал байхгүй. Гэтэл шүүхийн шийтгэх тогтоолоор Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ял оногдуулж шийдвэрлэхдээ шүүхийн дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримт болон Н.Хү-ийн бусдын эд хөрөнгийг завших гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг үгүйсгэсэн бусад нотлох баримтыг няцаан үгүйсгэсэн үндэслэл зэргийг тодорхойлж дүгнэлт хийгээгүй атлаа зөвхөн М.Ху-гийн мөрдөн байцаалтын явцад өгсөн өөр хоорондоо илтэд зөрүүтэй, бусад нотлох баримтуудаар худал болох нь нотлогдсон мэдүүлэгийг хөтөлбөргүй үнэн, зөв гэж дүгнэсэн нь хэргийн жинхэнэ бодит байдалтай нийцээгүй гэж үзэж байна. М.Ху-гийн "өөрийн дүү М.Аг-гийн эзэмшлийн "ХБ" ХХК-ийн Худалдаа хөгжлийн банк дахь дансаар дамжуулан 4 удаагийн үйлдлээр 116 сая төгрөг гаргуулан авснаас, 38 сая төгрөгийг Н.Хү-д өгсөн, мөн өөрийн найз Дархан-Уул аймаг дахь ХААН банкинд теллер ажилтай Н.Т-гаар дамжуулан "ОБ" ХХК-ийн нэрээр 21.440.000 төгрөгийг гаргуулан авч, 11 сая төгрөгийг мөн Н.Хү-д өгсөн" гэх мэдүүлэг л хавтаст хэрэгт авагдсан байх бөгөөд дээрх мөнгийг Н.Хү авсан болохыг нотолсон өөр ямар ч баримт хавтаст хэрэгт авагдаагүй байхад шүүх цугларсан нотлох баримтыг бүх талаас нь, бодит байдлаар нь хянаж үзээгүй, бусад нотлох баримттай харьцуулан шалгалгүй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 94 дүгээр зүйлд заасан үүргийг шүүх биелүүлээгүй болохыг харуулж байна. М.Ху-гийн Н.Хү-тэй хамтран дээрх гэмт хэргийг үйлдсэн гэж мэдүүлсэн мэдүүлэг нь хавтаст хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудаар батлагдахгүй байгаа тул уг мэдүүлэг нь Н.Хү-ийг яллах үндэслэл болохгүй төдийгүй харин ч М.Ху өөрийн арга болгож байгаа юм. Учир нь мөрдөн байцаалтын шатанд М.Ху нь "АЖ" ХХК-ийн нэрээр гаргасан 429.760.000 төгрөгнөөс 300 саяыг, "Т" ХХК-ийн нэрээр 1.454.079.550 төгрөгийг мөн Н.Хү-д өгсөн гэж мэдүүлж байсан боловч худал болох нь прокурорын хяналтын болон шүүхийн хэлэлцүүлгийн шатанд тус тус нотлогдож хэрэгсэхгүй болсон байна. Түүнчлэн шүүгдэгч Б.Чи-ийг "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116 сая төгрөгөөс 31.500.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21 440.000 төгрөгөөс 5 сая төгрөгийг тус тус авч хувьдаа завшсан гэх хэргийг

улсын яллагчийн хэрэгсэхгүй болгох талаар гаргасан саналыг шүүх үндэслэлтэй гэж үзэж хүлээн авсан атлаа адил нотлох баримтад буюу зөвхөн М.Ху-гийн мэдүүлгээр Н.Хү-ийн үйлдэл нотлогдож байна гэж ял оногдуулсан нь туйлын ойлгомжгүй байх бөгөөд шүүх энэ талаар ямар нэг дүгнэлт хийгээгүй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн хувьд мөрдөн байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "яллагдагчаар татах", 2013 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Сонсгосон ялыг өөрчлөх буюу нэмэлт оруулах" тухай тогтоолууд, прокурорын яллах дүгнэлт болон 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дугаартай шийтгэх тогтоолын алинд нь ч Н.Хү нь хэзээ, хаана, ямар нэр төрлийн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягыг хурамчаар үйлдсэн, ашигласан үйлдэл хийсэн талаар огт дурдаагүй атлаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар яллаж, улмаар ял шийтгэл оногдуулсан байдаг. Ийм учраас Н.Хү-ийн ямар үйлдэлд дээрх байдлаар ял шийтгэл оногдуулсан нь тодорхойгүй, ойлгох боломжгүй болж байгаа тул дурдсан зүйл ангитай холбоотой хууль бус ямарч үйлдэл байхгүй, тийм үйлдэл огт хийгээгүй болох нь нотлогдсон гэж үзнэ. Хэрэв Н.Хү-ийг М.Ху-гийн "ХБ" ХХК-ийн 4 удаагийн үйлдлээр 116 сая төгрөг гаргуулсан болон "ОСБ" ХХК-ийн нэрээр 21.440.000 төгрөгийг гаргасан гэрээнүүдийг хуурамчаар үйлдэхэд хамтран оролцсон гэж үзэж байгаа бол энэ нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар мөн нотлогдсон байх ёстой. Гэтэл мөрдөн байцаалтын шатанд уг гэрээнүүдийг хэн хуурамчаар үйлдсэн, хэн, хэзээ гарын үсэг зурсан болох, уг гарын үсэг нь Н.Хү-ийнх мөн эсэх талаар тодорхой ажиллагаа явуулаагүй, шүүх ерөнхий байдлаар хандаж, нотлох баримтад үндэслэлгүйгээр түүнд ял оногдуулсан байна. Түүнчлэн Н.Хү нь бусдын эд хөрөнгийг завших гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдохгүй байгаа учраас түүнийг дээрх зорилгоор хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнэх боломжгүй болох нь тодорхой. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн хувьд мөн л дээр дурдсанчлан мөрдөн байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн "яллагдагчаар татах", 2013 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Сонсгосон ялыг өөрчлөх буюу нэмэлт оруулах" тухай тогтоолуудад яллагдагч

Н.Хү нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан ямар үйлдэл хийснийг тодорхойлоогүй, энэ талаар огт дурдаагүй атлаа Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар яллагдагчаар татсан байдаг. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан гэдэг нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд Улсын дээд шүүхийн 2009 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолоор "Зориулалтын бусаар зарцуулсан" гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлгоно гэж тайлбарласан байх бөгөөд хуулийн дээрх заалтаар хориглосон 7 үйлдлийн чухам алийг нь Н.Хү зөрчиж хийсэн талаар шүүхийн шийтгэх тогтоолд тодорхой дүгнэлт хийлгүйгээр хэт ерөнхий байдлаар ханджээ. Н.Хү нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан Бусдын эд хөрөнгийг завших, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах, 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт заасан Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг тус тус үйлдсэн болох нь хангалттай нотлох баримтаар тогтоогдоогүй, анхан шатны шүүхээс түүнийг дээрх гэмт хэргүүдийг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулсныг ялтны өмгөөлөгчийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй, хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй байна гэж үзэж байна. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2012 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дугаартай шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж, Н.Хү-д ял оногдуулсан дээр дурдсан эрүүгийн хэргүүдийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Ялтан Б.Да-ын өмгөөлөгч С.Дондов давж заалдах гомдолдоо:

Б.Да нь Цэвэр Агаар Сантай зар сурталчилгааны ажил хийх зорилгоор өөрийн дүүгийн нэр дээрх аж ахуйн нэгжийн дансаар 100 сая төгрөг шилжин орж ирснээс 4,8 сая төгрөгийг татварт төлж, 95,2 сая төгрөгийг энэ удаа ажил гүйцэтгүүлэх боломжгүй боллоо гэсний дагуу тус сангийн ня-бо М.Ху-д буцаан хүлээлгэн өгсөн үйлдэлдээ Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан бусдын өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшиж, үрэгдүүлсэн гэмт хэрэгт холбогдон шүүгдэж байна. Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг завших,

үрэгдүүлэх" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг "Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан буюу үрэгдүүлсний улмаас бусдад хохирол учирсан" гэжээ. Б.Да мөрдөн байцаалтын явцад 100 сая төгрөгийг эргүүлэн өгсөн тухай задаргааг ярьж байх явцад, 5,2 сая төгрөгийг нь чи үрчихсэн юм биш үү гэж мөрдөн байцаагч тулгаж байсан гэдэг. Гэвч 5,2 сая төгрөгийг хэрхэн юунд зарцуулсан, яаж үрсэн талаар гарах зүйл байхгүй учраас тогтоох боломжгүй байсан энэ талаар ямар нэгэн баримт хэргийн материалд байхгүй байгаа юм. М.Ху мөнгийг буцаан авсан тухай үнэнээр нь мэдүүлсэн байгаа билээ. Гэтэл энэ байдлыг шүүх харгалзан үзэлгүй 5,2 сая төгрөгийг завшсан гэж гэм буруутайд тооцож ял халдааж байгаад гомдолтой байна. Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлд "Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно" гэж заасан. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах үндсэн зарчимтайгаас гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд заавал нотлогдвол зохих асуудал нь гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулж байгаа эсэхийг тогтооход чиглэсэн байна гэж заажээ. Мөн шүүх хурлын шинэчилсэн байцаалтад Б.Да мэдүүлэхдээ "Цэвэр Агаар Санд ямар нэгэн хохирол учруулаагүй, зар сурталчилгааны ажлыг энэ удаа хийхээргүй болсон гэсний дагуу мөнгийг нь тус сангийн ня-бод хүлээлгэн өгсөн" гэсэн бол М.Ху мэдүүлэхдээ "Б.Да-аас 95,2 сая төгрөгийг буцаан авсан нь үнэн" гэж мэдүүлсэн. Тэгэхээр Б.Да-ын үйлдэлд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байгаа нь дээрх мэдүүлгээс гадна дараах үндэслэлээр батлагдаж байна. Б.Да-ын хувьд дансаар шилжин орж ирсэн мөнгийг бүрнээр нь хэлцэл хийсэн этгээддээ буцааж өгсөн тул санд хохирол учирч байгаа гэдгийг мэдээгүй, мэдэх ч боломж байгаагүй. Цэвэр агаар сангийн үүрэг хүлээсэн ажилтан биш. Тухайн мөнгийг ашиглаагүй, үгүй хийгээгүй. Материаллаг ашиг олох зорилго байгаагүй. Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд зааснаар бусдын эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд энэ гэмт хэргийн субъект байна. Цэвэр Агаар Сангийн хөрөнгө нь Б.Да-ын мэдэлд түүний хамгаалалтанд байгаагүй, тус санд

ямар нэгэн албан тушаал эрхэлж байгаагүй тул ажил үүргийн хувьд итгэмжлэгдэн хариуцсан этгээд биш төдийгүй тухайн үед байгуулж байсан гэрээ нь өөрөө Цэвэр Агаар Сангийн стандарт шаардлага хангасан гэрээ байгаагүй талаар Н.Хү анхан шатны шүүх хурал дээр мэдүүлж байсан. Тухайн гэрээний загвар нь тус сангийн зарим ажилтны мөнгө завшдаг арга хэрэгсэл байсныг ч Б.Да мэдээгүй. Иймд Б.Да-ыг бусадтай бүлэглэн зохион байгуулалттайгаар бусдын хөрөнгийг завшиж, үрэгдүүлсэн гэж үзэх үндэслэл байхгүй байна. Үүнээс дүгнэхэд Б.Да бусадтай бүлэглэн итгэмжлэн хариуцуулсан хөрөнгийг завшин үрэгдүүлэх гэсэн санаа зорилго байгаагүй, мэдүүлгээс үзэхэд Б.Да нь Цэвэр агаар сангийн ажилтнууд мөнгөө хэрхэн зарцуулдаг талаар мэддэггүй байсан түүнийг мэдэх ч шаардлага байхгүй тухайгаа дурдсан байгаа. Энэ бүхнээс үзэхэд Б.Да-ын үйлдэлд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.1 208.1.2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Б.Да-т гомдол гаргаж байгааг хүлээн авна уу гэжээ.

Ялтан Д.Гэ давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Юуны өмнө албан үүрэгтээ хайнга хандсан гэх шүүхийн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзэж буйгаа тайлбарлая. Би хэрэгт холбогдох үедээ Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн албан тушаалд ажиллаж байсан бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулсан Цэвэр агаарын сан хэмээх тусгай санд шалгалт хийх бүрэлдэхүүнд Ерөнхий газрын удирдлагын шийдвэрээр орж, улсын ахлах байцаагч Б.Ат, улсын байцаагч М.Цч нарын хамт тус сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн юм. Шалгалтын удирдамжид зааснаар шалгалтыг 2012 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэг сарын дотор гүйцэтгэх ёстой байсан ч сар шинийн баяр зэрэг баяр, амралтын өдрүүдийг хасаж тооцвол хэрэг дээрээ ажлын 21 хоногт багтаан 27 тэрбум 973.5 сая төгрөгийн зарцуулалтын тооцоог шалгаж дуусгах шаардлагатай болсон. Үүнээс гадна М.Цч нь улсын байцаагчаар ажиллаад удаагүй, мэргэжлийн зохих дадлага туршлагагүй байснаар шалгалтыг үндсэндээ Б.Ат бид хоёр хариуцан хийхэд хүрсэн.

Түүнчлэн миний бие шалгалтын хугацаанд эрүүл мэнд сайнгүй байснаас шалтгаалан үе үе эмчилгээнд гадуур явах шаардлага гарч, ажлын ачааллын дийлэнхийг хамтран шалгагч маань гүйцэтгэсэн нь үнэн. Тус сангийн аппаратын зардлыг, мөн зарим аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнүүдийг ажлын хуваарийн дагуу би шалгасан бөгөөд харин гэрээний дагуу олгосон санхүүжилт, түүний гүйцэтгэлийг би үзээгүй юм. Шалгалтыг явуулахад дээр дурдсан бодитой хүндрэл, бэрхшээл байсан хэдий ч бид ажлаа хуваарилан авч, санхүүгийн хяналт шалгалт явуулах тогтсон арга барилын дагуу өдөр, шөнөгүй ажиллаж, Цэвэр агаарын сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд оршиж байсан их хэмжээний зөрчлийг илрүүлж, тэдгээрийг засуулах арга хэмжээг эрх хэмжээнийхээ хүрээнд авч, хэрэгжүүлсэн билээ. Шалгалтыг хэн, хэрхэн хийсэн, түүний үр дүнг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар яагаад хэлэлцэж шийдвэрлээгүй зэрэг шалгаж тогтоовол зохих олон асуудлыг шалгуулахаар мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж байсан прокурорт, түүнчлэн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа шүүхэд гомдол, хүсэлт удаа дараа гаргаж, шүүх хуралдааны явцад энэ тухай мэдүүлж байсан боловч прокурор, шүүхийн аль аль нь намайг албандаа үнэхээр хайнга хандсан эсэхийг нухацтай шалгаж, хянан шийдвэрлээгүй атлаа намайг гэм буруутай гэж үзсэнд гомдолтой байна. Намайг албан үүрэгтээ хайнга хандахын зэрэгцээ үүний улмаас хүнд хор уршиг учруулсан гэж шүүх дүгнэж, Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар хорих ял ногдуулах нь зүйтэй гэж үзжээ. Ийнхүү дүгнэхдээ "хүнд хор уршиг" гэдэгтээ прокурорын яллах дүгнэлтэд бичигдсэн удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2 тэрбум 726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй" гэх "хүнд хор уршиг" томъёолол"-ыг тэр хэвээр нь дурдсан байна. Гэтэл хуулиар хамгаалсан нийгмийн чухам ямар харилцаанд Д.Гэ гэгч этгээд "хүнд"-д тооцогдох бодитой ямар хор хөнөөл учруулсан болохыг прокурорын яллах дүгнэлтээс ч, шүүхийн шийтгэх тогтоолоос ч олж харж чадахгүй байна. Харин ч мэргэжлийн хяналтын улсын байцаагч бидний хийсэн шалгалтаар Цэвэр агаарын сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд оршиж байсан ихээхэн зөрчил, дутагдлыг илүүлж, "МАТ" ХХК

зэрэг таван аж ахуйн нэгжээс 1 тэрбум 420.432.100 төгрөгийг гаргуулан улсын төсвийн орлогод болон Цэвэр агаарын санд төвлөрүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, "Сэк" ХХК, "ШГЭ" ХХК зэрэг арван хоёр аж ахуйн нэгжийн 11 тэрбум 283.1 сая төгрөгийг арилжааны банкинд байршуулсан зөрчлийг илрүүлж, дээрх мөнгийг тус сангийн дансанд буцаан төвлөрүүлж, газар дээр нь зөрчлийг арилгуулсан юм. Миний бие баталсан удирдамжийн дагуу шалгалтыг явуулж, үүрэгт ажилдаа хайнга хандсан ямар нэг үйлдэл гаргаагүй, харин ч төсвийн их хэмжээний хөрөнгийг үрэгдэхээс сэргийлсэн тул хэн нэгэнд хүнд байтугай хөнгөн ч хор уршиг учруулаагүй учир дүүргийн шүүхийн надад ял ногдуулсан шийдвэрийг ямар ч үндэслэлгүй, хууль бус гэж үзэж, хилс шийтгүүлсэндээ маш их гомдолтой байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасныг баримтлан надад холбогдуулан Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэргэсэхгүй болгож, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын надад холбогдох заалтыг хүчингүй болгож өгнө үү гэв.

Ялтан Б.Ат давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Д.Гэ бид хоёр Цэвэр агаар сангийн зөвхөн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн юм. Энэ шалгалтаар Цэвэр агаар сангаас 2011 онд "Сэк" ХХК, "Мкн" ХХК, "Ан" ХХК, "ТХл" ХХК, "ЦТК", "Тк" ХХК, "БТд" ХХК, "МАт" ХХК, "ШГЭ" ХХК, "ГТт" компани, "ШГД" ХХК зэрэг 10 аж ахуйн нэгжүүдэд ажлын гүйцэтгэлгүй, ямар ч үр дүнгүй шилжүүлсэн 11,0 тэрбум, 283.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээд шалгалтын хугацаанд төлж, улсыг хохиролгүй болгох шаардлагыг тавьж, шалгаж байх хугацаандаа төлүүлж барагдуулсан юм. Мөн "МАт" ХХК, "ШГЭ" ХХК, "ШГД" ХХК, "БТҮТ" зэрэг компаниудаас хийгдээгүй ажлын санхүүжилтийн 1,0 тэрбум 420,4 сая төгрөгийг төлүүлж авахаар улсын байцаагчийн 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 04/408/23 тоот, 1047408/24 тоот, 04/408/25 тоот актуудыг тогтоосон юм. 2011 онд Цэвэр агаар сангаас "ШГЭ" ХХК-нд 2 удаа нийт 450,0 сая төгрөг, "ШГЭБ" ХХК-д 5 удаа 2260,0 сая төгрөг нийтдээ 2710,0 сая

төгрөг шилжсэнийг нэг компанид шилжсэн байна гэж ойлгон тооцоход "ШГЭ" ХХК-аас 2011 онд Цэвэр агаар санд 90.6 сая төгрөгийн шахмал түлш нийлүүлсэн байсныг хасаж тооцсон, 2012 оны 02 дугаар сарын 09-ний өдөр "ШГЭБ" ХХК-аас 1,0 тэрбум 980,0 сая төгрөгийг Цэвэр агаар сангийн дансанд төлүүлсэн, төлөгдөөгүй үлдсэн 260,0 сая төгрөгийг "ШГЭ" ХХК-аар төлүүлэхээр улсын байцаагчийн 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 04/408/24 тоот акт тогтоогоод Цэвэр агаар сангийн дарга Н.Хү, нягтлан бодогч М.Ху нарт танилцуулж гарын үсэг зуруулсан. Үлдсэн 379,4 сая төгрөгийн асуудал нь маргаантай байсан учраас 2012 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 30/1 тоот албан бичгээр нийт 540,0 сая төгрөгийг гаргуулахаар Дархан-Уул аймгийн шүүхэд нэхэмжлэл гаргуулсан. Мөн Цэвэр агаар сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай шалгалтын тэмдэглэлд тодорхой тусгагдсан байгаа. Ийнхүү энэ хоёр компанийн орлого, зарлагыг нэгтгэн тооцсон явдал нь үнэн мөн чанар нэмэгдэхүүний байрыг солиход нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүйтэй яг адилхан зүйл юм. Миний бие Цэвэр агаар сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ "ШГЭ" болон "ШГЭБ" ХХК-руу шилжүүлсэн нийт 2,0 тэрбум 710,0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн юм. Бид Цэвэр агаар сангийн зөвхөн 2011 оны үйл ажиллагааг шалгасан шүү дээ. Гэтэл Цэвэр агаар сангаас 2012 оны 04 дүгээр сарын 2-ны өдөр "ШГЭБ" ХХК-д хууль бусаар шилжүүлсэн 466,5 сая төгрөгийн асуудлыг надад шууд холбогдуулан ялын дүгнэлт үйлдэж, улмаар шүүх ял шийтгэл оногдуулж байгаад гомдолтой байна. Бидний хяналт шалгалт хийсэн ажлын үр дүнг үнэлэхгүйгээр барахгүй зарим нэг хилс үйлдэлд ч холбогдуулан прокурор болон анхан шатны шүүхээс ял шийтгэл оногдуулж байгаа явдалд туйлын ихээр гомдож байна.

Миний бие Цэвэр агаар сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхдээ "ШГЭ" болон "ШГЭБ" ХХК руу шилжүүлсэн нийт 2,0 тэрбум 710,0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн шаардлага тавьж шалгалтын хугацаанд 1,0 тэрбум 980,0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, 260,0 сая төгрөгийг холбогдох компаниар төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, маргаантай байсан 540,0 сая төгрөгийн асуудлыг Дархан-Уул аймгийн шүүхээр

шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргуулан шийдвэрлэсэн, хяналт шалгалтынхаа үйл ажиллагаанд шалгалтын удирдамжид заагдсан

Ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Д.Нямдорж давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх хуралдаан дууссанаас хойш хэвлэл мэдээллийн хэрэгслээр миний үйлчлүүлэгчийн нэр хүндийг асар их унагаасан. Мөн өнөөдрийн шүүх бүрэлдэхүүнийг тэр нөлөөлөлд битгий автаасай гэж хүсэж байна. Ялтан М.Ху болон Х.Бо нар өнөөдөр давж заалдах гомдолдоо энэ 4 тэрбум төгрөгийг цаг, минут, секундээр хаанаас, яаж авснаа бичсэн байна. Харин хэрэгт цугларсан нотлох баримтуудаар энэ асуудлууд тогтоогдсон зүйл байхгүй гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "...Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна..." гэсэнтэй үл нийцсэн. Мөн хуулийн 82 дугаар зүйлийн 82.2-т "...Яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь гагцхүү хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болно" гэсэн байна. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2-т "... Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана" гэж заасныг илтэд баримтлаагүй, орхигдуулсан. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2-т "... Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан..." гэж яллаж зохих хариуцлагыг оногдуулсан нь үндэслэлгүй гэж үзэж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12<sup>1</sup> дүгээр зүйлийн 12<sup>1.2</sup>-т заасны дагуу энэ хуулийн 12<sup>1.1</sup>-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна гэж заасан байна. Үүнд:

1.Хуулийн 12<sup>1.2.2</sup>-т "...стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад татаас олгох..."

Хуулийн 12<sup>1.2.3</sup>-т "...агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэх,

агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, ажлыг гүйцэтгэх..."

Хуулийн 12<sup>1.2.4</sup>-т "...эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх..."

Хуулийн 12<sup>1.2.5</sup>-т "...агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх..."

Хуулийн 12<sup>1.2.7</sup>-т "...агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах..." гэж хуульчилсан байх бөгөөд энэхүү зүйл нь 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж дагаж мөрдөж эхэлсэн.

Улсын Дээд шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолоор "...зориулалтын бусаар зарцуулсан..." гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлгоно гэж тайлбарласан. Гэтэл Н.Хү дээрх хуульд заасан хязгаарлалтын аль зүйлийг зөрчсөн талаар улсын яллагчийн зүгээс ч, шүүхийн зүгээс ч ямар нэгэн үндэслэл бүхий дүгнэлт хийж үүнийг дурдсан ямар нэгэн баримт байхгүй бөгөөд орхигдуулсан болно. Хэрэгт цугларсан нотлох баримтуудаас тодруулбал Н.Хү нь төсөв төлөвлөгөө болон батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг захиран зарцуулж байсан гэдэг нь нотлогдож байна. "ХБ" ХХК-ийн хувьд Н.Хү-ийн гарын үсэг зурсан гэх 4 ширхэг төлбөрийн даалгаврын гүйлгээний утга нь "...сургалтын төлбөр..." гэсэн гүйлгээний агуулгатай байна. Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12<sup>1</sup> дүгээр зүйлийн 12<sup>1.2.7</sup>-т "...агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах..." гэж заасан зүйлтэй нийцэж байна гэж үзэж байна. Ийм учраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ял шийтгэл оногдуулсныг мөн хууль зүйн үндэслэлгүй

гэж үзэж байна. Н.Хү нь 49.000.000 төгрөгийг хүлээж аваад, ашигласан гэсэн ямар баримт хэрэгт байхгүй. Тэр талаар зөвхөн ялтан М.Ху-гийн мэдүүлэг байдаг юм. Хэрэгт цугларсан гэрч нарын мэдүүлгээр энэ мөнгөн дүн зөвхөн М.Ху-гийн өмчлөлд очиж байгаа нь тодорхой харагдаж байна. Гэтэл энэ мөнгө миний үйлчлүүлэгчийн мэдэлд очсон мэтээр ойлгож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "...Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэн..." гэж заасан байгаа. Н.Хү-ийг энэ 49.000.000 төгрөгийг авсан гэх ямар нэгэн нотлох баримт хэрэгт байхгүй. М.Ху-гийн 2 мэдүүлгээр яллаж байгааг шүүх бүрэлдэхүүн анхаарч тус зүйл ангиар ял шийтгэл оногдуулсныг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсэж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн талаар гаргасан Х.Базаррагчаа өмгөөлөгчийн давж заалдах гомдолтой санал нэг байна.

Харин нэг зүйлийг нэмж хэлэхэд Н.Хү нь ямар баримт бичиг, мөн хэрхэн тамга тэмдгийг хуурамчаар ашигласан талаар нотолсон баримт байхгүй. Нотлох баримт байхгүй байхад яаж ял халдааж байгаа нь ойлгомжгүй байна. Ийм учраас анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.4 дэх хэсэгт заасныг өөрчлөлт оруулж өгнө үү. Учир нь миний үйлчлүүлэгч Н.Хү албан тушаалын байдалдаа хайнга хандсан талаар хүлээн зөвшөөрдөг. "Хамт ажилладаг этгээдэд итгэж гарын үсэгтэй цаас үлдээсэн асуудалд миний зүгээс тодорхой хэмжээнд буруутай байна. Энэ байдалдаа харамсаж байна" гэж гомдолдоо дурдсан бөгөөд энэ талаар анхан шатны шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед дурдсан. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд зохих өөрчлөлтүүдийг оруулж өгнө үү. Мөн Б.Да-аас 90.000.000 төгрөг аваад Н.Хү-д өгсөн гэж М.Ху мэдүүлж байгаа нь өөрийнхөө авсан мөнгөн дүнг багасгах гэсэн нэг арга гэж бодож байна. Үүнийг шүүх бүрэлдэхүүн

анхаарч үзэж Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсгийг үндэслэн Н.Хү-ийн ял эдлэх дэглэмийг бууруулж өгнө үү гэв.

Ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч М.Баасанбат давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Д.Нямдорж өмгөөлөгч бид 2 хамтарч давж заалдах гомдол гаргасан юм. Ингээд давхардуулахгүйгээр зарим зүйлийг дурдъя. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 10 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагыг хуульчилсан бөгөөд Н.Хү-ийн үйлдсэн гэх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 49.000.000 төгрөгийг хувьдаа авч завшсан гэх асуудал нь мөрдөн байцаалтыг шатанд бүрэн нотлогдоогүй, хэрэгт цугларсан нотлох баримтуудад завшсан гэдэг нь тогтоогдоогүй байхад ял шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй байна. Энэ завшсан гэдэг үйлдлийг М.Ху-гийн мэдүүлгийг үндэслэж ял халдаасан байгаа. 49.000.000 төгрөгийг шилжүүлсэн 2 компанийн захирлуудыг гэрчээр байцаасан ба энэ мөнгийг М.Ху-д өгсөн гэдэг. Харин М.Ху нь Н.Хү-д энэ мөнгийг өгсөн баримт байхгүй байхад анхан шатны шүүх үндэслэлгүй дүгнэлт гаргасан байна. Нэгэнт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ашигласан гэдэг нь тогтоогдохгүй байгаа учраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан хуурамч бичиг баримт, тамга ашигласан гэдэг нь үгүйсгэгдэж байна. Мөн Н.Хү-ийн Баянгол дүүрэг дэх орон сууцнуудыг битүүмжилж хувь ногдох хэсгээс хохирол төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн. Тэгэхлээр тухайн орон сууцнууд нь энэ гэмт хэрэгт ямар нэгэн хамааралгүй. Тухайн байрнууд нь "Цэвэр Агаар сан" байгуулагдахаас өмнө гэр бүлийн дундын эд хөрөнгөөр бий болсон байгаа. Үүнийг давж заалдах шатны шүүх анхаарч үзэхийг хүсэж байна. Мөн салбарын сайдын болон генерал, дарга нар санал болгож "эрхэлсэн мэргэжил, ажилдаа сайн" гэж хэлснээр ажилд авч итгэсэн учраас гадаадад томилолтоор болон байнгын хурал цуглаантай байдаг тул эзгүй байх үедээ санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах үүднээс өөрийн гарын үсгээ хоосон цаасан дээр үлдээж байсан эсэхээ Н.Хү хүлээн зөвшөөрдөг учраас анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд зохих өөрчлөлт оруулж, Н.Хү-д оногдуулсан ял шийтгэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. Мөн прокурорын

зүгээс Н.Хү-ийн ял эдлэх дэглэмийн тал дээр хэлэх саналгүй байна. Иймд Н.Хү-ийн ял эдлэх дэглэмийг бууруулж, жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэхэд татгалзах зүйлгүй юм байна гэж ойлголоо. Хэрэв М.Ху-г жирэмсэн гэдэг үндэслэлээр түүнд оногдуулсан ялыг хойшлуулах асуудал яригдвал тэрээр огт ял эдлэхгүй байх нөхцөл үүснэ. Эрүүгийн хуулиар болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар тусгайлан зохицуулагддаг журамтай. Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбар байдаг. Битүүмжилсэн эд хөрөнгийг нэг бүрчлэн зааж бүртгэсэн боловч үнэлгээг нэг бүрчлэн гаргаагүй. Үүнийг анзаарч анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж өгнө үү гэв.

Ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Р.Мэндсайхан давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Нийслэлийн прокурорын газрын 2013 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 224 тоот яллах дүгнэлтээр ялтан М.Ху-г шүүхэд шилжүүлсэн. Шүүх ийнхүү яллах дүгнэлтээр шилжүүлсэн хэргийг 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдөр хянан шийдвэрлэхдээ шүүх хуралдааны явцад тодорхойгүй үндэслэлээр "...Улсын яллагч нараас... санал оруулсныг шүүх хүлээн авав" гэсэн бөгөөд тухайн санал нь намайг давж заалдах гомдол гаргах хүртэл хугацаанд хэрэгт авагдаагүй байсан болно. Ялтан М.Ху-гийн улсад учруулсан хохирлын хэмжээг 4.210.218.029 төгрөг болгон тогтоож, яллах дүгнэлтээр шүүхэд шилжүүлсэн хохирлын хэмжээг 2.931.574.029 төгрөгөөр нэмж тогтоосон. Өөрөөр хэлбэл, шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан өөрийн хэмжээ хязгаарыг давж, хуульд байхгүй эрхийг эдэлсэн тул мөн хуулийг ноцтой зөрчсөн зөрчил юм. Шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1 дэх хэсэгт "Шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана" гэж заасан байхад М.Ху-гийн хувьд яллах дүгнэлтэд огт тусгагдаагүй нэмэлт 2.931.574.029 төгрөгийг хувьдаа завшиж, хохирол учруулсан үйлдлийг шүүх хуралдааны танхимд өөрөө мөрдөх ажиллагаа явуулж, улмаар шүүгдэгч М.Ху-г улсын яллагчтай зэрэгцэн нэмж ялласан нь алдаа болсон гэж үзэж байна. Иймд яллах дүгнэлтээр шилжүүлсэн хэргийн хэмжээнд шүүгдэгч М.Ху-гийн гэм буруу,

бусдад учруулсан хохирлын хэмжээг зөв тооцож, зохих өөрчлөлтийг шүүхийн шийтгэх тогтоолд оруулж өгнө үү.

Шүүгдэгч М.Ху-гийн хувьд гэмт хэргийн талаар анхнаасаа үнэн, зөв (бусад нотлох баримтуудаар давхар батлагддаг) тогтвортой мэдүүлж, үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшиж, гэм буруугаа хүлээсэн байдаг. М.Ху-гийн энэ байдал нь олон хамтран оролцогчтой, олон тэрбум төгрөгийн хохиролтой, олон үйлдэлтэй, ээдрээ төвөгтэй (Аудит болон мэргэжлийн хяналтын удаа дараагийн шалгалтаар илрээгүй нь үүнийг нотлоно) гэж Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.9 дэх хэсэгт "үйлдсэн хэрэгтээ чин санаанаас гэмшсэн, ...түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн" бол шүүх ял оногдуулахдаа түүнийг хөнгөрүүлэх нөхцөл байдлаар харгалзан үзэх ёстой. Гэтэл шүүх шүүгдэгч М.Ху-гийн дээр дурдсан хөнгөрүүлэх нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй эсхүл харгалзсан эсэх нь тодорхойгүй байх бөгөөд түүнээс олон гэмт хэрэг үйлдсэн хүнтэй харьцуулахад ял оногдуулахдаа илүү хүндрүүлж үзсэн гэж үзэхээр байна. Тухайлбал шүүгдэгч Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 5 зүйлээр нийт 15 жилийн хорих ял оногдуулснаас хүндийг нь хөнгөнд нь багтааж 8 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр болж 7 жил нь хасагдсан байхад шүүгдэгч М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 2 зүйлээр нийт 9 жилийн ял оногдуулснаас нэмж, нэгтгэх замаар 7 жилийн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр болж 2 жил нь хасагдсан байна. Дээр нь шүүгдэгч М.Ху-д 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан бол шүүгдэгч Н.Хү-д, Д.Цэ нарт 10 дахин бага буюу 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял тус тус оногдуулжээ. Үүнээс харахад шүүх Н.Хү, Д.Цэ нарын үйлдсэн гэмт хэргээ огт хүлээхгүй, гэмшихгүй байгаа нь хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, шүүгдэгч М.Ху-гийн хувьд хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нь харгалзаж үзээгүй, илт нэг талыг барьж, ялгамжтай хандсан нь харагдаж байна. Шүүгдэгч М.Ху нь анх удаа хүнд гэмт хэрэг үйлдсэн, одоо 6 сартай жирэмсэн эмэгтэй бөгөөд энэ тухай нотлох баримт (эмэгтэйчүүдийн эмчийн дүгнэлт, ургийн ЭХО-оор авахуулсан зураг, хорих 461-р ангийн эмнэлгийн бичиг, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай



өмгөөлөгчийн хүсэлт, шүүгдэгч М.Ху эцсийн үгэндээ ч энэ тухай дурдаж, хүсэлтээ гаргасан г.м.) хавтаст хэрэгт авагдсан юм. Түүнчлэн шүүгдэгч М.Ху-д шүүх хуралдаанд биечлэн оролцсон бөгөөд жирэмсэн гэдэг нь шүүх бүрэлдэхүүнд илт мэдэгдэхээр байсан бөгөөд өмгөөлөгчийн зүгээс түүнийг жирэмсэн тул суудлаасаа мэдүүлэг өгөхийг зөвшөөрөхийг хуралдаан даргалагчаас хүсэж, ёсоор болгож байсан юм. Шүүх Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэгт "Шүүх анх удаа ...хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй... хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно" гэсэн заалтыг хэрэглэх нөхцөл байдлыг ямар нэгэн дүгнэлт хийсэнгүй. Хэрэв шүүх Эрүүгийн хуулийн дээрх заалтыг шүүгдэгч М.Ху-д хэрэглэх боломжгүй гэж үзсэн бол энэ тухай шалтгаан, үндэслэлийг заах байсан. Шүүх анх удаа хүнд гэмт хэрэг үйлдсэн, жирэмсэн эмэгтэйд хорих ял эдлүүлэх тогтоолыг хойшлуулаагүй нь эх, хүүхдийн эрүүл мэнд болон ургийн хэвийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх байдалд хүргэж байна. Анхан шатны шүүх энэ бүгдийг анхаарч үзээгүйгээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 291 дүгээр зүйлийн 291.1 дэх хэсэгт "...шүүгдэгч... хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал, ...хорих ял эдлүүлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан бол шалтгааныг тодорхойлно" гэснийг зөрчжээ. Иймд шүүгдэгч М.Ху-д илүү хөнгөн ял оногдуулах үндэслэл байсныг анхан шатны шүүх харгалзаж үзээгүй тул түүнд ногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон биечлэн эдлэх 7 жилийн хорих ялыг багасгаж өгнө үү. Мөн М.Ху-д 7 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж өгнө үү.

Шийтгэх тогтоолын "Тогтоох" хэсгийн 7-д "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хэрэгт битүүмжлэгдэн ирсэн LEXUS -570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин... улсын орлого болгосугай" гэсэн нь хууль зөрчсөн байна. Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт "Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл... гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл... эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана" гэжээ. Гэтэл дээрх автомашиныг М.Ху-гийн гэр бүл нь түүнийг Цэвэр агаар санд ажилд орохоос өмнө худалдаж авсан байдаг. Өөрөөр хэлбэл,

энэ автомашиныг худалдаж авсан үе нь цаг хугацааны хувьд гэмт хэрэг үйлдэхээс өмнө байгаа тул "гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл" гэж үзэх боломжгүй юм. М.Ху нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэг, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдэхдээ LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашиныг ашигласан гэх нотлох баримт хавтаст хэрэгт байхгүй бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд ерөөсөө автомашин хэрэглэх ямар ч шаардлага байхгүй юм. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын "Тогтоох" хэсгийн 7-д "LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин..." гэснийг хасаж, тогтоолд өөрчлөлт оруулж өгнө үү гэв.

Ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Б.Энхзаяа давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх "улсын яллагч нарын санал"-аар шүүгдэгч Н.Хү-д холбогдох хэргээс М.Ху нартай бүлэглэж "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.45.079.500 төгрөгийг, ..."ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгийг тус тус хувьдаа авч завшсан хэргийг хэрэгсэхгүй болгохдоо Улсын яллагч хэргээс биш дээрх мөнгийг зөвхөн хувьдаа завшсаныг тогтоох боломжгүй гэж үзсэн тул яллах дүгнэлтээр оруулж ирсэн түүний төлөх төлбөрөөс хасах санал гаргасныг, шийтгэх тогтоолд дурдсан эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалт нь шүүгдэгч тухайн гэмт хэрэгт "бүхэлд нь" гэм буруугүй гэж улсын яллагчийн зүгээс үзэж яллахаас татгалзсан тохиолдол гэдгийг, энэ тохиолдолд улсын яллагч "бичгээр санал гаргах"-ыг хуульд шаарддагийг, хэрэгт цугларсан нотлох баримтуудаар дээрх мөнгийг завшсан үйлдэлд Н.Хү ямарч талаар холбоотой болохыг, дээрх гүйлгээнүүд хийсэн баримтад Н.Хү-ийн зурсан гарын үсэг зөвхөн өөрийнх нь зурсан гарын үсэг болохыг шинжээчийн дүгнэлтээр бүрэн тогтоогдсон болохыг, эдгээр гүйлгээнүүд бүгд өмнө нь хууль бусаар гараад явчихсан мөнгийг тусгаарласан данснаас "ШГЭБ" ХХК руу 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр шилжүүлсэн 1.980.000.000 төгрөгийн баримтад Н.Хү гарын үсэг зурснаас хойшхи үйлдлүүд болохыг тус тус хараагүй, үзээгүй, ойлгоогүй гэдэгт итгэхгүй байна. Дээрхтэй нэгэн адил М.Ху-гийн шүүгдэгч Б.Чи, Д.Цэ

нартай бүлэглэн үйлдсэн хэргүүдийн улмаас учирсан хохирол, тэдний "төлөх төлбөр"-ийн тухайд ч учир дутагдалтай дүгнэлт хийсэнд харамсаж байна. Энэ бүх гэмт хэргүүд нь 1 нь нөгөөгүйгээр үйлдэгдэх ямар ч боломжгүй гэдэг нь хэрэгт цугларсан нотлох баримтуудаас тодорхой харагдаж байхад анхан шатны шүүх зөвхөн "улсын яллагчийн санал"-ыг буруугаар ойлгож, түүндээ дулдуйдан, түүгээр гул барьж асуудалд хандаж байгаа нь үнэхээр хүлээн зөвшөөрч боломгүй алдаа гэж үзэж байна. Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49.2-т заасныг буруу хэрэглэн шийтгэх тогтоолын "тогтоох нь" хэсгийн 7 дахь заалтаар түүний нэлээд тооны хөрөнгийг улсын орлого болгосныг хүлээн зөвшөөрөхгүй байна. Хэрэв энэ заалт байх юм бол Шийтгэх тогтоолын 10 дахь заалтын М.Ху-гаас гаргуулахаар заасан мөнгөн дүнгээс дээрх 7 дахь заалтанд дурдсан эд хөрөнгийн үнийг хасаж тооцох ёстой. Эцэст нь М.Ху-г бусадтай бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж байгаа юм бол, энэ гэмт хэргээсээ хууль бусаар орлого олсон гэж үзэж байгаа юм бол, энэ гэмт хэргийн улмаас хохирол учирсан гэж үзэж байгаа юм бол, түүнээс хэн нь хэдэн төгрөг хувьдаа завшсан гэдгийг нарийн тогтоож чадахгүй байгаа юм бол тухайн хохирлыг "хувь тэнцүүлж" төлүүлэх хуулийн заалтыг хэрэглэх ёстой гэдгээ анхан шатны шүүх анхаарч үзээгүй, эсхүл анхаарч үзэхийг хүсэхгүй байгаад гомдолтой байна. Энэ бүх үндэслэлд тулгуурлаж Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр Шийтгэх тогтоолын "тогтоох нь" хэсгийн 7 дахь заалтыг хүчингүй болгох, 10 дахь заалтанд дурдсан М.Ху-гаар төлүүлэх төлбөрийг тус тусын оролцсон этгээдүүдээр хувь тэнцүүлэн гаргуулахаар өөрчлөх хүсэлт гаргаж байна гэв.

Ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Б.Оюунбилэг давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн нь илт хууль бус болсон гэж үзэж байгаа. Учир нь М.Ху-г энэ хэмжээний мөнгийг хувьдаа авч завшиж ашигласныг нотолж тогтоогоогүй байж түүнээс гаргуулахаар шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болсон. Улсын яллагч хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтын хүрээнд яллах дүгнэлтээ үйлдэхдээ Н.Ху-ийг

1.447.671.650 төгрөгийг хувьдаа завшсан, М.Ху-г 771.000.000 төгрөгийг хувьдаа завшсан, Д.Цэ-г 1.500.000.000 төгрөгийг хувьдаа завшсан, Б.Чи-ийг 188.280.000 төгрөгийг хувьдаа завшсан нь хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон гэж үзэж яллах дүгнэлтээ үйлдсэн. Шүүхийн хэлэлцүүлгийн явцад өөр ямар нэгэн шинэ нотлох баримт гараагүй мөн шүүх хуралдаанд оролцсон гэрч Э.Эб, П.А, Б.Со, С.Эт, Ж.Цо нар мөрдөн байцаалтын шатанд өгч байсан мэдүүлгээ тогтвортой мэдүүлж асуултанд хариулж байсан. Гэрч нарын шүүхийн хэлэлцүүлгийн явцад ямар нэгэн зүйл шинээр нотлох баримтаар гарч ирээгүй юм.

Н.Ху, Д.Цэ, Б.Чи нарт М.Ху нь дансаар гаргаж авсан мөнгийг өгсөн нь гэрч Ж.Цо, Х.Бо нарын мэдүүлгүүдээр тогтоогддог. Иймд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдож байгааг шүүх анхааран үзэж хохирлын тооцоог зөв судлан үзэж шийдвэрлэж өгнө үү. М.Ху-гийн гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөөр худалдан авсан гэж Лексус-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин. Лексус РХ-350 маркийн хх-хх УНА улсын дугаартай автомашин болон үнэт эдлэлүүд, 1000 ам.доллар, Волксваген Тигаун маркийн хх-хх УНР улсын дугаартай тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгохдоо өөрт байсан хувийн эд зүйлсэд үнэлэлт хийж ялгамжтай хандалгүйгээр улсын орлого болгосон нь хууль зүйн үндэслэлгүй болсныг шүүх анхааран үзнэ үү. Шүүх М.Ху-д ял шийтгэл оногдуулахдаа Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 55-д заасан хөнгөрүүлэн үзэх нөхцөл байдлыг хэрэглээгүй. М.Ху нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн, учруулсан хохирлын зарим хэсгийг төлсөн, жирэмсэн эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн хэрэгтээ чин санаанаасаа гэмшиж байгаа зэргийг харгалзан үзэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 63 дугаар зүйлийн 63.1-д зааснаар Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж өгнө үү. М.Ху-гийн биеийн байдал одоо 5 сартай жирэмсэн, Цагдан хорих нэгдсэн эмнэлэгт 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хэвтэн эмчлүүлж байна гэв.

Ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч Д.Гансүх давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Авлигатай тэмцэх газраас эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явуулсан 20130100027 дугаартай хавтаст хэрэгт

цуглуулан бэхжүүлсэн нотлох баримтууд, шүүх хуралдаанд шинээр гаргаж өгсөн нотлох баримтууд зэргээс шүүгдэгч Д.Цэ-д ял шийтгэл ногдуулсан Эрүүгийн хуулийн тусгай 263 дугаар зүйлийн 263.2 хэсэг, мөн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэг, 233 дугаар зүйлийн 233.2 заасан гэмт хэргүүдийн бүрэлдэхүүн шинжүүд, гэм буруугийн хэлбэрийн илрэл Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн байдал бүрэн бодитой тогтоогдоогүй байхад дээрх хуулийн зүйл хэсгээр шийтгэл оногдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Эрүүгийн хууль бусад хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Тухайлбал шүүгдэгч Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хийх ёстой ямар үйлдэл хийгээгүй, хийх ёсгүй ямар үйлдэл хийсэн нотолгоо, энэ албаны нэр хүнд нөлөөг ашигласан байдал, түүний үйлдэл эс үйлдэхүй нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн хэсэг заалтын дагуу тогтоосон нотолсон эсэх, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн үүрэг хэрхэн биелэгдсэн, тухайн байгууллагын хэвийн ажиллагаа, ашиг сонирхол, хор уршиг учирсан байдал, албаны эрх ашиг хөндөгдсөн, албаны эсрэг үйл ажиллагаа гэх мэт шинжүүдээр энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн шинж байхгүй байна. Мөн бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, онц хэмжээний хохирол учирсан гэх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 заасан гэмт хэргийг шүүгдэгч Д.Цэ энэ зүйлд субъект биш, эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд түүнтэй бүлэглэж үйлдсэн хэлбэр субьектив болон объектив талын шинжүүдийн тогтоосон нотлох баримт байхгүй, мөн үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг байгуулсан хуурамч гэрээ, баримт бичиг, тамга, тэмдэг хэвлэмэл маягт үйлдэх, ашиглаж гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулсан нь анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан оролцсон хэлбэр гэм бурууг бүрэн бодитойгоор тогтоогоогүй, Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 заасан иргэний эрхийн бүрэн чадамжтай иргэн Х.Бо 2011 оны 6 дугаар сарын 20-ны өдөр нэг гишүүнтэй

1.000.000 төгрөгийн дүрмийн сантай "ШГЭБ" ХХК байгуулсан гэдгээ Компанийн тухай хуулийн 11-17 зүйлд заасан шаардлагыг хангаж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13-17 дугаар зүйлд зааснаар улсын бүртгэлд бүртгүүлсэн байдаг нь энэ хуулийн дагуу байгуулсан компани юм. Харин энэ компанийг хууль бусаар ашиглаж мөнгө завшсан буюу компанитай холбоотой хуурамч гэрээг үйлдсэн түүнийг ашигласан гэх гэмт хэргийн үйлдэлд шүүгдэгч Д.Цэ хамааралгүй болно. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2-т "хуурамч баримт бичиг ашиглаж аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хохирол учруулах" үйлдлийг заажээ. Тэгвэл хуурамч баримт бичгийг албан тушаалтан үйлдсэн, хувь хүн үйлдсэн субьектийг зөв тодорхойлсноор Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх боломжтой байна. "ШГЭБ" ХХК нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар тус тусдаа эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж үүрэг хүлээдэг үйл ажиллагаанаасаа бий болсон үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг хуулийн этгээд юм. Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасан компани гүйцэтгэх удирдлага, мөн хуулийн 85, 93, 94, 95-д заасан хүлээх хариуцлага, хууль бус үйл ажиллагааны учирсан хохирол барагдуулах хэлбэрийг тусгагдсан байдаг. Цэвэр агаар сан нь төрийн өмчит хуулийн этгээд бөгөөд түүний ерөнхий нягтлан бодогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтын дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ажилтан, ажлын байрны чиг үүрэг тодорхойлолтод заасан ажлыг гүйцэтгэх гэрээтэй. Хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал болон хуулийн этгээдийн ажилтан тухайн ажлын байранд хууль зөрчсөн үйл ажиллагаа хийсэн нь төрийн захиргааны төв байгууллагын хэлтсийн даргын ажил албатай ямар холбоотой талаар нотолсон баримт байхгүй байна. Харин иргэн М.Ху-гаас иргэн Д.Цэ олон жил найз байсны хувьд Иргэний хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасан хэлцлийн үндсэн дээр 340.000.000 төгрөг зээлээр авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн нийгэмд аюултай үйлдэл эс үйлдэхүй болохгүй болно. Иймд Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болно. Эрүүгийн байцаан

шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг зааснаар хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, тогтооход эргэлзээ гарвал мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэсэн заалтаар "Шийтгэх тогтоол"-ын Д.Цэ-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, мөн холбогдсон хэргийг хэрэгсэхгүй болгуулах хүсэлтэйгээр гомдол гаргаж байна. Мөн Д.Цэ-гийн бусдаас хэлцэл буюу зээлсэн мөнгөөр авсан Тигуан маркийн хх-хх УНР улсын дугаартай тээврийн хэрэгсэл улсын орлого болгохоор шийдвэрлэсэн, битүүмжилсэн орон сууцны гэр бүлийн гишүүдэд ногдох хэсгийг хүчингүй болгож өгөхийг хүсье гэв.

Ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч М.Алтанцэцэг давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүхээс Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэргийг үйлдсэн хэмээн 8 жилийн хорих ял оноосон. Шүүхээс ял оноохдоо Д.Цэ-г "Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах", "Бусдын эд хөрөнгийг завшсан", "Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах" гэснийг дараах үндэслэлүүдээр хүлээн зөвшөөрөхгүй байгаа болно.

"Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан" гэх зүйлчлэлд:

Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд ажилладаг болохоос Цэвэр агаар санд ажилладаггүй, ямар ч хамааралгүй буюу тодруулбал, Цэвэр агаар сангийн удирдах зөвлөл болон ажлын албанд хамааралгүй этгээд билээ. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.1-д заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь өөрийн эрхэлж буй албан тушаалаа ашигласны үндсэн дээр бусдад хохирол учруулсан байхыг ойлгодог. Гэтэл Д.Цэ нь уг эд хөрөнгө завшсан гэх үйлдэлдээ албан тушаалын байдлаа ашиглаагүй бөгөөд Цэвэр агаар сангийн үйл ажиллагаатай Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд түүний эрхэлдэг албан тушаал нь ямар ч холбогдолгүй, үр дагавар үүсгэхгүй билээ. Цэвэр агаар сан нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай ямар ч холбоогүй бөгөөд харин Сангийн яамнаас шууд санхүүжилт авдаг, тус байгууллагатай шууд хамааралтай билээ. Энэ үйлдэлд Д.Цэ-

гээс албан тушаалын байдлаар дэмжлэг, нөлөө, туслалцаа үзүүлээгүй байхад М.Ху-гийн үйлдсэн үйлдлийг Д.Цэ-д хамруулан тохож буй нь Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Гэм буруутай этгээд үйлдсэн гэмт хэрэгтээ зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ" гэж заасныг зөрчиж, ял шийтгэлийг гэм буруугүй этгээдэд халдаан хэрэглэсэн болно.

Бусдын эд хөрөнгийг завшсан гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэж Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ялласан тухайд:

Миний үйлчлүүлэгч Д.Цэ нь М.Ху-гаас 340.0 сая төгрөгийг зээлж авсан л үйлдэл байгаа болохоос Цэвэр агаар сангийн эсхүл "ШГЭБ" ХХК-ийн мөнгийг завшин авсан үйлдэл байхгүй билээ. Харин тухайн зээлж авсан 340.0 сая төгрөг нь М.Ху-гийн Цэвэр агаар сангаас эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй авсан мөнгө байснаараа л ийнхүү миний үйлчлүүлэгч энэхүү хэрэгт холбогдоод байгаа. Д.Цэ-гийн үйлдэл нь М.Ху-тай сайн дурын үндсэн дээр гэрээний эрх зүйн харилцааг л үүсгэсэн билээ. Гол нь Д.Цэ нь "ШГЭБ" ХХК-ийг огт мэдэхгүй бөгөөд үүнийг хавтаст хэрэгт авагдсан гэрчийн мэдүүлэг бусад баримтуудаас тодорхой харж болно. Х.Бо-гийн мэдүүлгээс компанийг үүсгэн байгуулахад Д.Цэ нь оролцоогүй болохыг тодорхой харж болно. Мөн Х.Бо нь М.Ху-тай ярилцаж, тохиролцон "ШГЭБ" ХХК-даа хэрхэн мөнгө шилжүүлэн авч, зарцуулснаа үнэн зөвөөр мэдүүлсэн байдаг. Гэтэл Х.Бо, М.Ху нарын "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр Цэвэр агаар сангаас 2.726.500.000 төгрөгийг гаргасан үйлдэлд миний үйлчлүүлэгч Д.Цэ-г хамтрагч гэж үзэж буй нь үндэслэлгүй юм. Учир нь Цэвэр агаар сангийн данснаас мөнгө гаргах, "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө гаргах зэрэг үйлдлийг хийх эрх бүхий этгээд Д.Цэ биш бөгөөд тийм эрх хэмжээтэй этгээд биш. Гэтэл М.Ху, Х.Бо нарын мэдүүлгийг үндэслэн миний үйлчлүүлэгч Д.Цэ-г "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр Цэвэр агаар сангаас 2.726.500.000 төгрөгийг гаргасан гэх үйлдэлд хамтран оролцогчоор тооцсон нь үндэслэлгүй юм. Учир нь уг үйлдэлд Д.Цэ нь холбоотой гэх нотлох баримт хавтаст хэрэгт нэг ч үгүй, харин зөвхөн М.Ху, Х.Бо нарын өөрсдийнх нь өмнө өгч байсан мэдүүлгүүдтэй эрс зөрөөтэй

мэдүүлэг дээр үндэслэж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй юм. Мөн яллагдагч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар үнэн зөв мэдүүлэг өгөх үүргийг хүлээдэггүй бөгөөд мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.4-т "Яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн буруугүй болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй" гэж заасан эрхүүдийн дагуу яллагдагчийн мэдүүлэг нь шийдвэрийн шууд үндэслэл болохгүй билээ. Харин миний үйлчлүүлэгч Д.Цэ-г уг хууль бус үйлдэлд холбоотой болох талаар өөр үндэслэл бүхий нотлох баримтуудаар дэмжигдэж байж энэ гэмт хэргээр зүйлчлэх ёстой. Гэтэл хавтаст хэрэгт Д.Цэ нь уг хууль бус үйлдэлд хамааралгүй болох талаарх нотлох баримтууд байсаар байхад яллагдагчийн мэдүүлэгт үндэслэн ийнхүү ял оноосон нь буруу юм. Харин ч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ" гэж зааснаар шийдвэрлэх бүрэн боломжтой байсан.

Хуурамч бичиг баримт, тамга тэмдэг хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдсэн гэж Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар ялласан тухайд:

Д.Цэ нь ямар нэгэн хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэж, ашиглаж гэмт хэрэг үйлдээгүй бөгөөд М.Ху-гийн хуурамч тамга тэмдэг, хэвлэмэл хуудас, маягт үйлдэж, мөнгө завшсан үйлдлийг Д.Цэ-г хийсэн болгож ялыг халдаан шийдвэрлэж байна. Д.Цэ нь яг ямар хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэж, ашигласан гэх үйлдлийг нотлож, үндэслэл болгож буй нотлох баримтууд нь бүгд л М.Ху, Х.Бо нарын эрх хэмжээнд, тэдний хийсэн үйлдлийг нотолсон баримтууд л байдаг билээ.

Д.Цэ нь "ШГЭБ" ХХК гэдэг компани байдаг гэдгийг ч мэдэхгүй, Х.Бо гэдэг хүнийг огт танихгүй байж ямар хуурамч гэрээ хийх юм бэ. Яллагдагч Х.Бо-гийн мэдүүлэг "М.Ху бид хоёр гэрээ хийсэн би гэрээн дээр гарын үсэг зурж тамга тэмдэг дарсан" гэж тодорхой мэдүүлсэн байдаг. Иймд Д.Цэ-д оноосон дээрх ялыг үндэслэлгүй гэж үзэж байгаа тул хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Б.Чи-ийн өмгөөлөгч Г.Батбаяр давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд байгаа "Итгэмжлэгдэн хариуцсан этгээд" гэдгийг ААН, байгууллага, иргэдээс өөрийн өмчийг хариуцуулахаар үүрэг хүлээлгэсэн, эсхүл хууль буюу гэрээнд зааснаар бусдын өмчийг итгэмжлэн хариуцах үүрэг хүлээсэн этгээдийг ойлгоно гэж Улсын Дээд шүүхийн тайлбарт заасан байна. Ийм үүрэг хүлээсэн байдгаараа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 152 дугаар зүйлд заасан хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн, бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийн субъектээс ялгагддаг. Гэтэл Б.Чи нь 150 дугаар зүйлийн субъект биш болох нь тухайн эд зүйлсийг итгэмжлэгдэн хариуцах үүргийг хууль буюу гэрээнд зааснаар хүлээгээгүй этгээд байснаар нотлогдож байна. Хэрвээ Б.Чи-ийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай субъект гэж шүүх үзэж байгаа бол Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1 дэх хэсэгт заасан "Бусдын хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн ..эд хөрөнгийг завших" гэсэн гэмт хэргийг үйлдсэн этгээд буюу субъект байна хэмээн хуулийг зөв хэрэглэн тайлбарлаж түүнд оногдуулсан зүйлчлэлийг 152.1 болгон өөрчлөж ял оногдуулах нь зүйтэй байсан. Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1 дэх хэсэгт буй "Итгэмжлэн өгсөн эд хөрөнгө" гэдэгт өмчлөгч өөрөө эд хөрөнгөө түр хугацаагаар өгөхийг хэлнэ. Учир нь хэрэгт авагдсан баримтаар Б.Чи гэмт хэрэг үйлдэгдсэн гэх 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Цэвэр агаар санд ажилд ороогүй байсан нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйл заасан гэмт хэргийн субъект биш болохыг нотолж байна. Тэрээр бүр хойно 2 жил орчмын дараа буюу Өөрөөр хэлбэл, 2013 оны 05 сард уг санд ажилд орсон байна. Эдгээр гэмт хэргийн бүрдэл нь гэмт этгээд хохирогчийн өгсөн эд зүйлсийг завшсанаар төгсөнө. Б.Чи уг мөнгийг хувьдаа завшсан гэх үйлдэл нь тогтоогдохгүй байна. "Завших" гэдэгт гэмт этгээд бусдын итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг хууль бусаар эргэлтэнд оруулахдаа өмчлөгчид эд зүйлстэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр буюу мөнгийг өгөхгүй байгааг ойлгоно. Гэмт этгээд нь завшсан эд зүйлсийг өөрийн эзэмшилд оруулсан боловч түүнийг үрэгдүүлээгүй байдаг. Ашиглалтын энэ хэлбэр нь гэмт этгээдэд итгэмжлэгдэн олгогдсон эд зүйлс хууль ёсоор очоод хууль бус хэлбэрээр бусад

руу шилжиж, үр дүнд нь гэмт этгээд шунахайн зорилгоор тухайн эд зүйлсийг ашиглаж байдаг. Гэтэл Б.Чи-ийн завшсан гэх мөнгийг М.Ху "...би аваад хурлын ажиллагаанд зарцуулсан..." хэмээн тайлбарладаг. Үүгээр завшсан гэх үйлдэл нь үгүйсгэгдэж байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээд бусдын эд зүйлсийг өмчлөгчид тогтоосон хугацаанд нь хяналт, шалгалтын шаардлагагүйгээр буцаан өгөхгүй байх үйлдлээр завших арга нь илэрч байдаг. Завших арга энэ хугацаанд илрэхгүй байсан нь тухайн мөнгөний хууль ёсны өмчлөгч Цэвэр агаар сан болон Б.Чи-д мөнгийг итгэмжлэн өгсөн "ПИ" ХХК-ийн зүгээс итгэмжлэн хариуцуулсан гэх эд зүйлсээ ямар нэгэн байдлаар нэхэмжлэлгүй 2 жил гаран болсонтой холбоотой гэж шүүх үзэх нь хууль зүйн үндэслэлгүй, хэт өрөөсгөл дүгнэлт болно. Харин ч эсрэгээрээ, энэ нөхцөл байдал нь Б.Чи уг мөнгийг хохирогч гэх байгууллагад тэр даруйд дамжуулан өгсөн болохыг нотолж байна. Энэ гэмт хэргийн бүрэлдхүүний объект нь өмчийн бүх төрлийн Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний өмчлөх эрх байдаг. Иймээс Цэвэр агаар сангийн өмчлөх эрх энэ гэмт хэргийн объект болж байна. Объектив тал нь дээр дурдсан объектийн эрхийг гэмт этгээдийн зүгээс хууль, гэрээ, албан тушаалын байдлын үндсэн дээр олгогдсон итгэмжлэл, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглах замаар хууль бусаар авах үйлдлээр илэрдэг. Энэ нь Эрүүгийн 150 дугаар зүйлийн итгэмжлэгдэн хариуцсан этгээд гэдэг субъектын онцлогоос хамааран энэхүү объектив шинж илэрсэн байгаагаар энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн бүрддэг. Тэгвэл Б.Чи-ийн "ПИ" ХХК-аас дамжуулан тээвэрлүүлсэн эд зүйлсийг завшсан гэх гэмт хэрэгт энэхүү объектив тал байхгүй байна. Энэ нь шүүх Б.Чи-ийг буруутай гэж үзэн яллахдаа Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн гэмт хэргийн бүрэлдхүүний шинжүүд байхгүй байхад хуулийг буруу тайлбарлан түүний үйлдэлд тохироогүй зүйл ангиар шийтгэснийг харуулж байна. Мөн хохирлын хэмжээг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд зааснаар тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлана. 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 140.400 төгрөг байсан нь Б.Чи-ийн бусдад учруулсан гэх хохирол Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт зааснаар их

хэмжээний хохиролд тооцогдож байна. Энэ нь шүүх хуулийг буруу хэрэглэн хохирлын хэмжээг буруу тооцон тайлбарлаж зүйл ангийг хүндрүүлэн ялтны эрх зүйн байдлыг дордуулсан болохыг харуулж байна. Шүүх хэрвээ Б.Чи-ийг гэм буруутай нь нотлогдож байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлд заасныг үйлдсэн байна гэж үзсэн бол хохирлын хэмжээг зөв тодорхойлж 150.2 дахь хэсгээр зүйлчлэн ял оногдуулах нь зөв байсан. Шийтгэх тогтоолын 2 дахь хэсэгт "...Б.Чи-ийг их хэмжээний хохирол бусдад учруулсан гэм буруутайд тооцсугай.." хэмээн дурдсан боловч мөн тогтоолын 3 дахь хэсгээр ял оногдуулахдаа 150.3 дахь хэсгийг хэрэглэсэн байгаа нь хуулийг буруу хэрэглэсэн болохыг харуулж байна. Гэхдээ Б.Чи-ийг гэм буруугүй болохыг энд хавсаргасан бичлэгийн яриа шууд нотолж байна. Цэвэр агаар сангийн нягтлан бодох ажилтай байсан ялтан М.Ху, Н.Хү нар нь "...надад мөнгийг Б.Чи өгөөгүй." гэгцгээж байгаа боловч энэ нь нотлох баримтгүй, өгсөн мэдүүлгээ үнэн болохыг нотлох үүрэггүй, өөрийгөө хамгаалж худлаа ярих эрхтэй сэжигтэн, яллагдагч шүүгдэгч нарын нотлох баримтын шаардлага хангахгүй мэдүүлэг байхад уг мэдүүлгүүдийг нотлох баримтын хүрээнд үнэлсэн нь шүүх хэргээ сайн ойлгоогүйг харуулж байна. Б.Чи-ийг гэм буруутайг нотолсон шууд нотлох баримт хэрэгт авагдаагүй, тэрээр тухайн үед Цэвэр агаар санд ажилладаг хууль ёсны эрхтэй этгээд байгаагүй, зүйлчлэл тохироогүй зэрэг эргэлзээтэй нөхцөл байдал нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасантай тохирч байна. Мөн Б.Чи-ийг 461 дүгээр хорих ангид хоригдож байх хугацаанд түүний бусдад учруулсан гэх 21.780.000 төгрөгийн хохирлыг нэгэн сайн санаатан бүрэн төлж барагдуулсан байна. Энэ нь шүүх Б.Чи-ийг буруутай гэж үзвэл хохирол төлөгдсөн буюу нийгмийн гэм хор арилсан гэж хөнгөрүүлэн үзэн тохирсон зүйл ангиар зүйлчлэн, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг хэрэглэх боломж нээгдэж байгааг анхааран үзэх нь зүйтэй байна. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын 2, 3, 5, 10, 17, 19 хэсэгт байх Б.Чи-д холбогдох хэсгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24.1.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Б.Чи-ийн өмгөөлөгч Л.Өлзийхүү давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Б.Чи-ийг 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-аас 21.780.000 төгрөгийг бэлнээр авч хувьдаа завшсан гэж анхан шатны шүүх дүгнэсэн боловч Б.Чи нь тухайн үед Цэвэр агаар санд ажиллаж байгаагүй бөгөөд 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 17 дугаар тушаалаар "Цэвэр агаар санаачилга-2" төслийн төсөл хариуцсан мэргэжилтнээр, мөн 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн вх03/13 тоот тушаалын дагуу Цэвэр агаар санд мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан нь хавтаст хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар хангалттай нотлогдсон. Б.Чи-ийг бусдын эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завших, үрэгдүүлэх гэсэн зүйл ангиар зүйлчилж ирүүлсэн боловч Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн субъект нь Хууль, гэрээ ба албан тушаал эрхэлж байгаа байдлынх нь хувьд эд зүйл, өмч хөрөнгийг тодорхой хүрээнд итгэмжлэн олгосон, итгэмжлэгдэн хариуцах үүрэг бүхий этгээд байна. Гэтэл Б.Чи нь тухайн үед ямар нэгэн ажил албан тушаал эрхэлж байгаагүй, ямар нэгэн эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцах үүрэг хүлээсэн зүйл байхгүй байсан тул энэ гэмт хэргийн субъект биш юм. Б.Чи нь уг мөнгийг хувьдаа завшсан гэх үйлдэл тогтоогдохгүй байх бөгөөд "Завших" гэдэг нь гэмт этгээд бусдын итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг хууль бусаар эргэлтэнд оруулж өмчлөгчид нь эд зүйлстэй тэнцэх хэмжээний мөнгийг өгөхгүй байхыг ойлгоно. Гэтэл Б.Чи-ийн авсан гэх мөнгө нь Цэвэр агаар сангийн үйл ажиллагаа буюу тухайн үед "ПИ" ХХК-ийн байранд хэд хэдэн удаа хийгдсэн хурлын үйл ажиллагаанд зарцуулагдсан болохыг М.Ху мэднэ. Хэрэгт авагдсан нотлох баримт болон түүний мэдүүлгээр Б.Чи нь гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдохгүй байх тул Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 тоот шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, Б.Чи-д холбогдох үйлдлийг хэрэгсэхгүй болгуулахаар давж заалдах гомдол гаргаж байна гэв.

Ялтан Х.Бо-ийн өмгөөлөгч Д.Даваа давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Х.Бо нь: Цэвэр Агаар сангийн нярваар ажиллаж байхдаа "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн

байгуулж, 2011 онд Цэвэр Агаар сангийн нябо М.Ху болон БОНХЯ-ны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж хуурамч гэрээ үйлдэж, байгуулж Цэвэр Агаар сангаас гаргасан 2.726.500.000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа завшиж, Улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэжээ. Тэгвэл Х.Бо 2011 онд "Цэвэр Агаар сан"-д нярваар ажиллаж тухайн байгууллагын эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцаж байсан этгээд мөн үү? Х.Бо тус "Цэвэр Агаар сан"-д 2013 оны 02 дугаар сарын 10-нд нярвын ажилд орсон. Харин дээрх онц их хэмжээний хөрөнгө буюу 2.726.500.000 төгрөг 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд нябо М.Ху, хэлтсийн дарга Д.Цэ нарт албан тушаалаа ашиглаж, Х.Бо-гийн нэрээр байгуулсан "ШГЭБ" ХХК дансаар дамжин гарч, М.Ху, Д.Цэ нарт очсон. Энэ мөнгийг дансаар авч М.Ху-д хүргэн өгч байсан хүн нь Х.Бо мөн. Х.Бо-д М.Ху нь 30.500.000 төгрөгийг өгсөн нь үнэн, үрж ашигласан нь үнэн. Нэг ёсондоо М.Ху хөдөлмөр хийгээд хөлс өгсөн байх үндэслэлтэй. Нэгэнт Х.Бо нь тус "Цэвэр Агаар сан"-д ямар нэгэн ажил үүрэг гүйцэтгэж байгаагүй болохоор итгэмжлэгдэж хариуцсан этгээд болох Х.Бо-д "Цэвэр Агаар сан"-гийн эд хөрөнгө хууль ёсоор шилжээд түүнийг Х.Бо хууль бусаар М.Ху-д шилжүүлсэн байсан гэж үзэх үндэслэлгүй байна. Харин М.Ху албан тушаалаа ашиглаж, иргэн Х.Бо-гаар дамжуулж "Цэвэр Агаар сан"-гийн мөнгийг компанийн дансаар авч байсан гэсэн үг. Иймд миний бие Х.Бо-г "Цэвэр Агаар сан"-гийн хөрөнгийг итгэмжлэгдэж хариуцсан этгээд биш гэж үзнэ. М.Ху, Д.Цэ нарт ашиглагдаж байсан иргэн хүн юм. Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн талаар тайлбарлавал М.Ху мөрдөн байцаалтын шатанд болсон шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэгтээ "Д.Цэ нь "Цэвэр Агаар сан"-д байгаа мөнгийг зүгээр байлгаад хэрэггүй, юуны төлөө чамайг ажилд оруулж өглөө, найдвартай хүнээр компани байгуулуулаач гэхээр нь Х.Бо-д хэлсэн. Компани байгуулах санаачилгыг Д.Цэ гаргасан, Тус компанийг тэрээр хуурамч гэрээг Д.Цэ бид 2 тэдний гэрт очиж хийсэн" гэдэг. Х.Бо-д анхнаасаа компани байгуулья, хэн нэгэнтээ хамтарч аль нэг байгууллагын хөрөнгийг завшъя" гэсэн санаа зорилго байгаагүй. Нэгэнт Х.Бо-гийн санаа зорилгоор түүний гараар

үйлдэгдээгүй гэрээгээр гарсан мөнгийг Х.Бо дамжуулахаас бус өөрөө хуурамч бичиг баримт үйлдээгүй болно. Дээрх дурдсан нөхцөл байдлууд, хэрэгт цугларсан нотлох баримтуудыг харьцуулан дүгнэж, Х.Бо-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. Х.Бо-д М.Ху-гийн өгсөн гэх 30.500.000 төгрөгийг түүний хувиасаа өгсөн мөнгө биш болохыг Х.Бо мэдсэн болохоор түүнийг төлж барагдуулах санаачилга гаргасан. 5.000.000 төгрөгийг төлсөн. Одоо 25.500.000 төгрөгийг төлөх болно. Давж заалдах шатны шүүх тус хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэж, Х.Бо-д холбогдогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Ялтан Б.А-гийн өмгөөлөгч С.Цэдэндамба давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлд албан тушаалтнаас албан үүрэгт ажилдаа хайнга хандах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлон заахдаа 272 дугаар зүйлийн 272.1-д "Албан тушаалын хууль, тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүйгээс бага бус хэмжээний хохирол учирсан байхыг" тодорхой заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хэргийн улмаас хүнд хор хохирол учирсан бол хүндрүүлэн үзэж, ял оногдуулж байхыг" заасан байна. Тэгвэл Б.Ат хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс болж, бага бус хэмжээний ч хохирол учраагүй, мөн энэ зүйлийн 2-т заасан хүнд хор хохирол ч учраагүй нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, Б.Ат-д холбогдуулан ял шийтгэл оногдуулаад байгаа Цэвэр агаар сангийн хоёр тэрбум гаруй төгрөгийн хохирол чинь Б.Ат, Д.Гэ нарыг санхүүгийн баримтад хяналт шалгалт хийхээс өмнө бусад шүүгдэгч нараас үйлдсэн гэмт хэргийн улмаас улсад учирчихсан хохирол юм. Хэрвээ Б.Ат албан үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүйгээс болж, хүнд хор хохирол учруулчихсан бол мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс хохирол учруулсан зөрчил гэж үзээд байгаа 2.726.500.000 төгрөгийг Б.Ат, Д.Гэ нараар төлүүлэхгүй яагаад өөр бусад шүүгдэгч нараар төлүүлээд байгаа юм бэ?

Н.Хү, М.Ху, Б.Х.Бо нараас үгсэн хуйвалдаж, улсын хөрөнгийг хамтран ашигласан 2.726.500.000 төгрөгийн хүнд хор

хохирлыг Б.Ат-д холбогдуулан ял оноосон нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан заалтыг зөрчиж байна. Мөн Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг зөрчөөд зогсохгүй, Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг шууд хориглоно, гэм буруугүй хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байхад оршино гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан заалт болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтуудыг давхар зөрчлөө.

Б.Ат, Д.Гэ нар нь Цэвэр агаар сангийн зөвхөн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Энэ шалгалтаар Цэвэр агаар сангаас 2011 онд 10 аж ахуйн нэгжүүдэд ажлын гүйцэтгэлгүй, ямар ч үр дүнгүй шилжүүлсэн 11.283.051.455 төгрөгийн зөрчлийг илрүүлээд дээрх мөнгийг нэн дариуд барагдуулж, улсыг хохиролгүй болгох шаардлагыг тавьсан байна. Үүний үр дүнд Б.Ат-г шалгаж байх хугацаанд 10 аж ахуйн нэгжүүдээс 11.283.051.455 төгрөгийн зөрчлийг барагдуулсан байна. Мөн "МАТ" ХХК, "ШГЭ" ХХК, "ШГД" ХХК, "Тэн" ХХК, "БТҮТ" зэрэг компаниудаас хийгдээгүй ажлын санхүүжилтийн 1.420.432.000 төгрөгийг төлүүлэхээр улсын байцаагчийн 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 04/408/23 тоот, 04/408/24 тоот, 04/408/25 тоот актуудыг тус тус тогтоожээ. Цэвэр агаар сангаас "ШГЭ" ХХК болон "ШГЭБ" ХХК-д 2011 онд шилжсэн 2.710.000.000 төгрөгийн тооцоог гаргаад шалгаж үзэхэд "ШГЭ" ХХК-аас 2011 онд Цэвэр агаар санд 90.600.000.000 төгрөгийн шахмал түлш нийлүүлснийг хасаад үлдсэн 2.169.400.000 төгрөгийн зөрчил дутагдлыг илрүүлээд шийдвэрлэжээ. Б.Ат нь Цэвэр агаар сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгээд "ШГЭ" болон "ШГЭБ" ХХК-руу хууль бус байдлаар шилжүүлсэн 2.710.000.000 төгрөгийн зөрчлийг илрүүлж, шаардах журмаар 1.980.000.000 төгрөгийн төлбөрийг барагдуулж, 260.000.000 төгрөгийг "ШГЭ" ХХК-аар төлүүлэх акт тогтоож, маргаантай байсан 540.000.000 төгрөгийн асуудлыг Дархан-уул аймгийн шүүхээр шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргуулан шийдвэрлэчихсэн байхад, баримтын шалгалт хийгээд дууссанаас хойш Цэвэр агаар сангаас 2012 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр "ШГЭБ" ХХК-д хууль бусаар шилжүүлсэн 466.500.000 төгрөгийн асуудлыг Б.Ат-д шууд холбогдуулан шүүх ял шийтгэл



оногдуулж байгаа нь хэтэрхий бүдүүлэг байдлаар хууль зөрчлөө. 2011 онд Цэвэр агаар сангаас "ШГЭ" болон "ШГЭБ" ХХК-руу үндэслэлгүйгээр хууль зөрчин шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр илрүүлэн шалгалтын хугацаандаа шаардан барагдуулж, төлөгдөөгүй үлдсэн 260.000.000 төгрөгийг холбогдох компаниар төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, маргаантай байгаа мөнгөн хөрөнгийг шүүхэд нэхэмжлэл гаргуулан асуудлыг шийдвэрлэсэн хяналт шалгалтынхаа үйл ажиллагаа нь шалгалтын удирдамжинд заагдсан үүргээ Б.Ат бүрэн биелүүлсэн болох нь тодорхой харагдаж байна. Энэ хэргийг шийдвэрлэсэн шүүгч / шүүгчид/ зарим нэг нотлох баримтыг буруугаар ойлгожээ. Тодруулж хэлбэл: Мэргэжлийн хяналт шалгалт хийсэн хоёр байцаагчийн эсрэг утга агуулгатайгаар ойлгож хэргийг шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүхийн энэ дүгнэлтээс үзэхэд Б.Ат-г хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэх асуудлыг шинжээчийн дүгнэлтүүдээр батлагдаж байгаа мэтээр дүгнэжээ.

Энэ хэрэгт хэд хэдэн удаагийн шинжээчийн /4 удаа/ дүгнэлтүүд гаргасан бөгөөд энэ дүгнэлтүүд дотроос ганцхан 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 168 тоот дүгнэлтийн 3 дугаар асуултын хариултанд: Төрийн сангийн дансны хуулгад 2012 оны 02 дугаар сарын 09-нд Цэвэр агаар сангийн Төрийн сан дахь 90001хххх тоот дансанд "ШГЭБ" ХХК-аас гэрээний мөнгө гэж 1.980.000.000 төгрөгийн орлого орж ирсэн байна гэж дүгнэжээ. Энэ дүгнэлт нь Б.Ат-г яллах биш харин цагаатгах үндэс болж байгааг анхан шатны шүүх зөв ойлгож чадсангүй, энэ хэрэгт шинжээчийн хэд хэдэн удаагийн дүгнэлт байгаа боловч Б.Ат, Д.Гэ нарыг ялласан, үүрэгт ажлаа зохих ёсоор хийгээгүй, хариуцлагагүй хандсан талаар ямарч дүгнэлт байхгүй байгаа юм. Санхүүгийн баримтад 2011 онд Үндэсний аудитын газрын шалгалт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хийсэн шалгалт хоёр чинь тусдаа өөр асуудал шүү дээ. Гэтэл Цэвэр агаар сангийн 2011 ба 2012 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аудитын шалгалт хийгээд Цэвэр агаар сангийн 2011, 2012 онуудын санхүүгийн тайлан зөрчилгүй гэсэн дүгнэлтийг аудитор Б.Да гаргасан юм.

Мөрдөн байцаагчаас Б.Да-ын дээрх дүгнэлт үндэслэлтэй юм уу? эсвэл үндэслэлгүй юм уу? гэдгийг л

тогтоох зорилгоор шинжээч томилон 169 тоот дүгнэлт гаргуулсан юм. Гэтэл энэ дүгнэлтийн 3 дугаар асуултанд аудитор Б.Да-ын нэрийг цохон дурдаад шинжээчид тавьсан асуултын хариултан дотор "2011 онд "ШГЭБ" ХХК-д шилжүүлсэн мөнгөний талаар 2011 оны Цэвэр агаар сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын актанд дурдаагүй байна." гэж хариулсныг Цэвэр агаарын санд 2011 онд хийсэн баримтын шалгалтын талаар Б.Ат-д холбогдсон дүгнэлт байна гэж үзжээ. Үүнээс үзэхэд мөрдөн байцаагчаас Б.Да-т холбогдуулан тавьсан асуултыг анзаарахгүйгээр Б.Ат, Д.Гэ нарт холбогдуулан буруугаар ойлгосон байна. Мөн хэргийн дотор болон шийтгэх тогтоолд авагдсан ямарч гэрч Б.Ат, Д.Гэ нарын хяналт шалгалтынхаа үйл ажиллагаанд хийх ёстой ажлаа зохих ёсоор хийгээгүй, хариуцлагагүй хандсан талаар гэрчилсэн мэдүүлэг байхгүй байна.

Мөн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын газрын дарга Д.Б-ийн 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 4/3746 тоот албан бичиг болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Б-ийн 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/143 тоот албан бичгүүдээр Цэвэр агаар сангийн 2011 оны санхүүгийн баримтад хяналт шалгалт хийсэн улсын ахлах байцаагч Б.Ат, Д.Гэ нарын хийсэн хяналт шалгалтын ажлын үр дүнг тодорхой нэг бүрчлэн дурдаад Б.Ат, Д.Гэ нарыг үүргээ зохих ёсоор биелүүлсэн гэдгийг онцлон дурдсан байна.

Б.Ат, Д.Гэ нар "ШГЭБ" гэдэг нэрийг л илрүүлэн гаргаж ирээгүй боловч үнэн мөн чанар Цэвэр Агаар сангаас 2011 онд "ШГЭ" болон "ШГЭБ" ХХК-д хууль бусаар оруулсан нийт 2.710.000.000 төгрөгийг илрүүлээд эрх хэмжээнийхээ хүрээнд зохих арга хэмжээ авсан болох нь дээр дурдсан байдлаар бүрэн хэмжээгээр нотлогдон тогтоогдчихоод байгаа учир Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.2-т зааснаар анхан шатны шүүхийн 211 тоот тогтоолд өөрчлөлт оруулан улмаар мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 208 дугаар зүйлийн 208.2-т заасан зүйлүүдийг үндэслэн Б.Ат-д Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож өгөхийг Давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүнээс хүсэж байна гэв.

Ялтан Д.Гэ-ийн өмгөөлөгч Ж.Энхнасан

давж заалдах гомдол болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шүүгдэгч Д.Гэ-д холбогдох хэргийн мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа шүүх тогтоол гаргахад чухал ач холбогдолтой байж болох зарим нөхцөл байдлыг тодруулаагүй, Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай болох нь шинэчлэн судалсан нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй байхад зөвхөн яллаж шийтгэх чиглэлийг урьтал болгон түүнийг тийнхүү шийтгэснийг хууль бус гэж үзэж, Д.Гэ-д холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасныг баримтлан хэрэгсэхгүй болгуулахаар мөн хуулийн 303 дугаар зүйлийн 303.1, 304 дүгээр зүйлийн 304.1-д заасныг тус тус үндэслэн давж заалдах гомдол гаргаж байна. Хүнд хор уршиг нь Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын заавал байх шинж юм. "Хүнд хор уршиг"-т "...онц их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас хохирсон, хүнд, эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учирсан, байгаль орчны тэнцвэр алдагдсан, халдварт өвчин тархсан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зогссон зэргийг хэлнэ" гэж Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолд тайлбарлажээ. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 211 дүгээр тогтоолд "Д.Гэ нь ..."Цэвэр агаарын сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр Цэвэр агаарын сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2 тэрбум 726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй..." гэж тэмдэглэснээс үзвэл шүүх Цэвэр агаарын сангаас хууль бусаар гарсан 2 тэрбум 726.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй явдлыг шүүгдэгчийн учруулсан "хүнд хор уршиг" гэж дүгнэжээ. Гэхдээ шүүх ийнхүү дүгнэлт хийхэд хүргэсэн үндэслэл, нотолгоог тогтоолдоо тодорхойлж дурдаагүй учир тэрхүү дүгнэлтийг ойлгож, хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. "Зөрчлийг илрүүлээгүй" явдал нь эд хөрөнгийн онц их хэмжээний хохирол учруулсан, эсхүл хүний амь нас хохирсон, албан байгууллагын хэвийн үйл ажиллагаа зогссон зэрэгтэй дүйцэх

нийгмийн хор аюултай үр дагавар мөн гэж үзэхэд ихээхэн эргэлзээтэй. Улсын Дээд шүүхийн тайлбар тогтоолд дурдсанаар Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэргийн "хүнд хор уршиг"-т албан тушаалтны хайнга байдлаас үүсч бий болсон, нийгэмд аюултай, бодитой оршин буй олон янзын үр дагаврыг ойлгож болохоор байна. Өөрөөр хэлбэл, энэхүү үр дагавар нь төсөөлөл төдий бус, харин бодитой учирсан байх бөгөөд хэмжээ, чанарын хувьд нийгэмдээ ихээхэн хор аюултай шинжийг давхар агуулсан байж гэмээ нь сая эрүүгийн хариуцлагад татаж болох "хүнд хор уршиг"-т тооцогдохоор байна. Иймд бусдыг Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллаж, шийтгэхийн тулд мөрдөн байцаалт, шүүхийн шинэчилсэн байцаалтаар тэрхүү үр дагаврын бодитой болоод нийгэмд аюултай шинж (хэмжээ, чанар)-ийг нотлох баримтаар хөтөлбөргүй тогтоосон байх шаардлагатай. Гэтэл шүүгдэгч Д.Гэ-д холбогдох хэргийн материалд "...2 тэрбум 726.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй нь хүнд хор уршиг учруулсан гэж тооцогдох нөхцөл байдлыг нотолсон баримт нотолгоо огт байхгүй бөгөөд шүүхийн хэлэлцүүлгийн үед ч тэр байдал өөрчлөгдөөгүй болно. Шүүх "ШГЭБ" ХХК-ийн нэрээр Цэвэр агаарын сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2 тэрбум 726.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй гэх дүгнэлтийг хийхдээ "илрүүлээгүй зөрчил"-ийн хэмжээг үндэслэлгүй өсгөсөн байна. Үүнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шалгалт өнгөрснөөс хойшхи хугацаанд буюу 2012 оны 05 дугаар сард гарсан 450.0 сая төгрөгийн ашиглалыг Д.Гэ-ийн илрүүлээгүй гэх зөрчлийн дүнд оруулан тооцсон нь буруу байна. Мөрдөн байцаах байгууллага, прокурор, шүүх нь Цэвэр агаарын сангийн дарга, нягтлан бодогч болон нэр бүхий бусад этгээд "ШГЭБ" компанийн нэрээр Цэвэр агаарын сангаас нийт 5 удаагийн үйлдлээр 2 тэрбум 726.5 сая төгрөг ашиглан шамшигдуулж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдэх боломжийг олгосон этгээдүүд буюу хуулиар хүлээсэн албаны үүргийн хувьд Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, улсын төсвийн санхүүжүүлт, түүнд хяналт тавих зэрэг салбарын дотоодын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байсан албан тушаалтнуудыг албан үүрэгтээ хайнга хандсанаас хүнд хор уршиг учруулсан гэмт хэрэг үйлдсэний төлөө эрүүгийн хариуцлагад

таталгүй, ял завшуулж байгаа нь ойлгомжгүй. А.С-д холбогдох хэргийг тийнхүү буруу тусгаарласан, сангийн үйл ажиллагаа, төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавиагүй хариуцлага алдсан бусад албан тушаалтны хэргийн холбогдлыг мөрдөн шалгаагүй зэрэг байдал нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлийн 230.1.1-203.1.2-т заасныг баримтлан шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах бүрэн үндэслэл болох байсан ч шүүх эдгээр байдлыг хэрэгсэж үзсэнгүй.

Албан үүрэгтээ хайнга хандсан тухай:

Цэвэр агаарын сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийхдээ Цэвэр агаарын сангаас "ШГЭБ" ХХК-ийн нэр дээр үйлдсэн хуурамч гэрээгээр их хэмжээний мөнгө гарган ашиглаж байсныг илрүүлж чадаагүй нь шүүгдэгчийг албан үүрэгтээ хайнга хандсан гэж дүгнэхэд хүргэжээ. Шүүгдэгчийн албан үүрэгтээ хайнга хандсан гэм буруутай болохыг мөрдөн байцаалт болон шүүхийн шинэчилсэн байцаалтын явцад нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй гэж өмгөөлөгчийн хувьд үзэж байна. Албан үүрэгтээ хайнга /хайхрамжгүй/ хандсан гэмт хэрэгт буруутгахын тулд шүүгдэгч (мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч) Цэвэр агаарын сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхдээ хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлогдсон албаны чухам ямар үүргийг, ямар учраас биелүүлсэнгүй вэ гэдгийг заавал тогтоох шаардлагатай. Үүнээс гадна ийнхүү дагаж мөрдөөгүйн улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах боломжтойг шүүгдэгч мэдэх бүрэн бололцоотой байсныг нотлох баримтаар мөн тогтоосон байхыг шаарддаг. "Хайхрамжгүй байх, мэдэхгүй байх гэдэг нь гол төлөв салан задгай, сахилга хариуцлагагүй, хэнэггүй, анхаарал сэрэмжгүй зан авиртай шууд холбоотой байдаг" гэж Монгол Улсын Дээд шүүхийн эрхлэн гаргасан Эрүүгийн хуулийн тайлбар номын 97 дугаар талд онцолжээ. Гэтэл "Цэвэр агаарын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн улсын байцаагч нарын хувьд албан үүрэгтээ хэнэггүй, хайхрамжгүй, салан задгай хандаж байсан гэх баримт нотолгоо хэргийн материалд хангалттай авагдаагүй байхад шүүх "хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэргийг үйлдсэн" гэх дүгнэлт хийж байгаа нь үндэслэл муутай байна.

Мөрдөн байцаагч "зөрчлийг илрүүлээгүй тул салан задгай, хариуцлагагүй хандсан байж таарна" гэсэн хялбар дүгнэлтийг хийж, Д.Гэ-ийг сэжигтэн, яллагдагчаар тус бүр нэг удаа товчхон байцаахдаа хөтлөн байцаах аргыг чадамгай хэрэглэн, гэм буруутай болохыг нь өөрөөр нь хүлээн зөвшөөрүүлж, энэ тухай тэмдэглэл хөтөлж гарын үсэг зуруулсан. Шинжээч томилон ажиллуулахдаа түүнд хэдэн болхи асуудал тавьж, түүндээ урьдаас илт ойлгомжтой хариуг хүлээн авснаар Д.Гэ-ийн хувьд мөрдөн байцаалтын ажиллагааг дуусгасан болох нь хэргийн материал болон шүүгдэгчийн тайлбараас илт байна. Түүнчлэн сэжигтэн, яллагдагчийг мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчийн туслалцаа авах боломжоор үндсэндээ хангаагүй байдаг. Шүүгдэгчийг албан үүрэгтээ хайнга хандсан гэж буруутгахын тулд наад зах нь дор дурдсан асуудлыг шалгаж тодруулах шаардлагатай байсан гэж үзнэ. Үүнд:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шалгалтын удирдамж төлөвлөгөөнд тусгасан шалгах зүйлийн хүрээ, хэмжээ, улсын байцаагч нар шалгалтын ажлыг хэрхэн, яаж зохион байгуулсан, шалгалт явуулах хугацаа хангалттай байсан эсэх, шалгалтын дүнг гаргах журам, шалгасан болон шалгуулсан байгууллагаас шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодруулах, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тодорхой бүрэн эрх, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, шүүгдэгчийн ажил хэргийн болон хувийн байдлыг тогтоох зэрэг олон асуудлыг холбогдох гэрчүүдийг байцаах, шинжээчийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах, хяналт шалгалтын талаарх хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, зааврын биелэлтийг улсын байцаагч нарын үүрэг гүйцэтгэлтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийх зэргээр мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааг явуулж байж албан үүрэгтээ хайнга хандсан гэм буруутай эсэх тухай дүгнэлтийг хийх шаардлагатай байжээ.

Шүүхийн шинэчилсэн байцаалтын шатанд тодруулахаар өмгөөлөгчийн гаргаж өгсөн зарим баримт нотолгоо, шүүгдэгчийн тайлбар мэдүүлгээр Д.Гэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын групп шалгалтын бүрэлдэхүүнд багтаж 2012 оны 02 дугаар сарын 01-ээс 03 дугаар сарын 01-нийг хүртэлх ажлын 21 хоногт Цэвэр агаарын сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд Б.Ат, М.Цч нарын хамт шалгалт

хийсэн байх ба шалгалтын хийх хугацаа маш шахуу бөгөөд М.Цч нь улсын байцаагчаар томилогдоод удаагүй учир мэргэжлийн чадвар, ажлын дадлагаас шалтгаалж шалгалтын ажилд гүнзгий оролцох боломжгүй байсан нь нотлогддог. Шалгалтын дүнг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын Зөвлөлөөр хэлэлцэн дүгнэх хуралдааныг тодорхой бус шалтгаанаар хэд хэдэн удаа хойшлуулж, эцэст нь дүгнэлгүй орхисноор шалгагдсан байгууллагад зөрчил дутагдал арилгах үүрэг чиглэл бүхий зөвлөмж өгдөг практик болсон журмыг яагаад хэрэгжээгүй учрыг мөрдөн байцаалтаар мөн л шалгаж тодруулаагүй.

Д.Гэ нь шалгалтыг хийх хугацаанд эрүүл мэнд сайнгүй байснаас шалтгаалан эмчилгээнд явж, шалгалтын явцаас үе үе хөндийрөх шаардлага гарч байсан тул ажлын ачааллын хүндийг хамтран шалгагч нь "үүрсэн" гэж мэдүүлдэг ба "Цэвэр агаарын сан"-гийн аппаратын зардал, зарим аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнүүдийг ажлын хуваарийн дагуу шалгаж, гэрээний дагуу олгосон санхүүжилт, түүний гүйцэтгэлийг хамтран шалгагч нь хариуцан шалгасан тухай мэдүүлгийг бусад шүүгдэгч нотолдог ба эдгээрийг үгүйсгэх баримт нотолгоо хэргийн материалд мөн л авагдаагүй.

Түүнтэй шалгалт хамтран хийсэн улсын ахлах байцаагч Б.Ат Цэвэр агаарын сангаас гэрээний дагуу олгосон санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой материалыг хариуцан үзсэн талаарх дээрх тайлбар мэдүүлэг үнэн зөв болох нь хэрэв нотлогдвол Д.Гэ-ийг албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэг үйлдсэнд буруутгах ямар ч үндэслэлгүй болохоор байгаа юм. Энэ мэт зайлшгүй шалгаж тогтоовол зохих нөхцөл байдлуудыг шалгуулахаар хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах тухай хүсэлтийг хэрэг шийдвэрлэгдэхээс бүр урьд шүүгдэгч, түүний өмгөөлөгч Ц.Монгол нар гаргаж байсан боловч тэдгээрийн хүсэлтийг анхаарч үзэлгүй орхиж байсныг буруу гэж үзэж байна.

Дээрхээс дүгнэж үзвэл Д.Гэ-ийн албан үүрэгтээ хайнга хандаж байсан нь хангалттай нотлогдоогүй, албан үүрэгтээ хайнга хандсанаас учруулсан гэх хүнд хор уршиг нь бодитой бус, үнэн хэрэгтээ төсөөлөл төдий байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасныг баримтлан Д.Гэ-д холбогдуулан Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллах

дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэргэсэхгүй болгож өгнө үү гэв.

Ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Г.Оюунцэцэг шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 150, 233 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэрэгт буруутгаж байгаа. Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх арга нь байсан болов уу гэж харагдахаар байдаг ба бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүн биш юм. Хэргийн материалтай танилцаж байхад Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт буруутгаж байгаа хирнээ түүнтэй яг адилхан хэрэг үйлдсэн хүнийг тус зүйл ангиар яллахаас татгалзсан байдаг. Ялгаа нь Н.Хү санхүүгийн баримтад өөрийн гарын үсгийг зурснаар л буруудаж байгаа юм. Хавтаст хэрэгт авагсан нотлох баримтуудаас харахад Н.Хү-ийн мэдүүлэг нотлох баримтаар давхар нотлогддог ба үндэслэлтэй байсан. Хуурамч гэрээг хэн үйлдсэн нь тодорхой болсон. Тэр хүний субъектив санаа зорилгыг мэдүүлгээс нь харж болно. Н.Хү-ийг уг хэргийг бусадтай бүлэглэн үйлдсэн гэж буруутгах үндэслэл нь гэрээнд гарын үсэг зурсан явдал юм. Н.Хү нь ямар нэг байдлаар үндэслэлгүй хөрөнгөжөөгүй учраас Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, мөн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар түүнийг яллах нь учир дутагдалтай гэж бодож байна. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг бодитоор гаргаагүй, хэрэгт холбогдолгүй гэр бүлийн гишүүдийн өмч хөрөнгийг битүүмжилсэн байсан. Гэр бүлийн гишүүдийн өмч хөрөнгийг битүүмжлэх шаардлага байгаагүй гэж бодож байна. Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар голлон яллаж үүндээ бусад зүйл ангийг багтаасан байдаг. Хавтаст хэрэгт Н.Хү-ийн эрүүл мэндийн байдлын талаар нотлох баримтууд авагдсан байдаг. Н.Хү нь толгой тархи байнга өвддөг эрүүл мэндийн хувьд сайнгүй байгаа. Түүний эрүүл мэндийн байдлыг харж үзээд Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт зааснаар түүний ял эдлэх дэглэмийг бууруулж өгнө үү гэв.

Ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Ц.Итгэл шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

М.Ху, Д.Цэ хоёрын хэн нь хэнийгээ ажилд оруулсан нь сонирхолтой байдаг. 2011 оны 6 сард Д.Цэ-гийн гуйлтаар М.Ху

онцгой байдлын нөөцийн нярвын ажлаасаа гарч Дарханаас Улаанбаатар хотод ирсэн. Тэрээр гэмт хэрэг үйлдээд мөнгөтэй болсон уу эсвэл өмнө нь мөнгөтэй байсан уу гэдэг нь тодорхойгүй байдаг. Үүнийг мөрдөн байцаалтын шатанд шалгаж тогтоогоогүй. Өв залгамжилж авсан зүйлийг нь улсын орлогод хураасанд гомдолтой байдаг. М.Ху нь огт хувийн бизнес хийдэггүй, цалингаараа амьдардаг хүн биш юм. Ах дүү нарынх нь банкин дахь дансанд 11-730 сая хүртэлх төгрөгийн хадгаламж байдаг. М.Ху энэ ажилд орохоос өмнө хадгаламждаа 84.000.000 төгрөгийн орлого хийсэн тохиолдол байдаг. Түүнийг Дарханд байшин барьсан гэж байна. 1440 м.кв талбайтай 4 давхар байшинг 2011 онд барьж дуусгаад гэрчилгээг нь авсан байдаг. Энэ нь "Цэвэр агаар сан"-д ажилд орохоос өмнө болсон явдал юм. Бизнес хийдэг мөнгөтэй байсан гэдгийн илрэл юм. Тэрээр энэ бүхнийг мөрдөн байцаалтын шатанд үнэнээр мэдүүлсэн. М.Ху нь үйлдсэн хэрэгтээ гэмшиж байгаа ба одоо 7 сартай жирэмсэн, биеийн байдал нь хүнд байгаа гэв.

Ялтан Б.Чи-ийн өмгөөлөгч Б.Цэрэндолгор шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан хэргийн субъект нь Б.Чи биш юм. Тэрээр 21.780.000 төгрөгийг 2011 оны 12 дугаар сарын 31-нд авсан ба үүнээс хойно 2013 оны 03 дугаар сарын 01-нд "Цэвэр агаар" санд ажилд орсон. Б.Чи энэ мөнгийг Н.Хү-ийн гуйлтаар очиж авсан гэдэг нь тогтоогддог ч Н.Хү-д өгсөн гэдэг нь тогтоогддоггүй. Энэ мөнгийг өгсөн авсан асуудлаас үл хамааран уг гэмт хэргийн субъект биш юм. Учир нь уг хөрөнгийг хариуцах субъект биш юм. Хэрэв түүнийг эд хөрөнгө завшсан гэж байгаа бол түүний Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэнээр зүйлчлэх бүрэн боломжтой байсан. Иймд Б.Чи-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж өгнө үү. Б.Чи нь 14 настай охинтой. Охиныг нь харгалзан дэмжих хүн байхгүй. Түүнд ойр дотны ах дүү хамаатан садан байдаггүй. Б.Чи нь тархины хорт хавдартай. Хавдар нуруу нугасанд нь нөлөөлж одоо суга таягтай явж байгаа. Биеийн эрүүл мэндийг нь харж үзнэ үү гэв.

Б.Да нь Н.Хү, М.Ху нартай бүлэглэн өөрийн дүүгийн байгуулсан компанийн дансаар 100.000.000 төгрөг гаргуулан авч

үүнээс 5.200.000 төгрөгийг завшсан гэж ял шийтгүүлсэн. Б.Да нь уг хэргийг бусадтай бүлэглэн үйлдсэн гэдэгтэй санал нийлэхгүй байна. Б.Да-ыг Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгө завшсан гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгасан. Гэтэл уг хэрэгт түүнтэй хамтарсан гэх М.Ху-г Эрүүгийн хуулийн эдгээр зүйл заалтаар яллаагүй. Иймд уг хэргийг бүлэглэн үйлдсэн гэж үзэх боломжгүй. Б.Да мэдүүлэгтээ "М.Ху манай компани руу 4 удаагийн үйлдлээр 100.000.000 төгрөг шилжүүлсэн. Үүний дараа наад мөнгөө нааш нь явуулчих, дараа нь танай компанид ажил өгнө гэсэн. Би М.Ху-д 95.500.000 төгрөгийг өгсөн. Үлдсэн 4.800.000 төгрөгийг татварт тушаасан" гэсэн байдаг. М.Ху мэдүүлэгтээ "95.200.000 төгрөгийг Б.Да надад өгсөн. Би тэр мөнгийг аваад Н.Хү-д өгсөн" гэж мэдүүлдэг. Анхан шатны шүүх хуралдаанд үүнийгээ 4 удаагийн үйлдлээр гэж тодруулж хэлсэн. Энэ талаар М.Ху-гийн 2 удаа өгсөн мэдүүлэг байдаг. Б.Да-ын үйлдэл ял шийтгэл оногдуулах хэмжээнд хүрээгүй. Түүнд ял шийтгэх үндэс байхгүй. Улсын яллагч Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлд зааснаар яллахаас татгалзсан. Үүнийг анхан шатны шүүх хүлээн авч хэрэгсэхгүй болгосон. Иймд Б.Да-ын үйлдлийг мөн хэрэгсэхгүй болгох ёстой. Б.Да яахаараа "Цэвэр агаар"сангийн эд хөрөнгийг итгэмжлэн хариуцсан этгээд болов гэдэг тун сонин. Хууль буюу гэрээгээр харж хамгаалах захиран зарцуулах эрх бүхий этгээд уг гэмт хэргийн субъект байх ёстой. Гэтэл Б.Да нь тийм эрх бүхий субъект биш юм. Үндэсний аудитын газрын аудитор хүн тэр зүйлтэй огт хамаагүй. Тэрээр хэн нэгэнд хохирол учруулаагүй. Иймд Б.Да-т холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Ялтан Т.Мө-ны өмгөөлөгч Б.Мянган шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

М.Ху-гийн мэдүүлгээр Т.Мө-ыг гэрчээр анх байцааж эхэлсэн байдаг. Т.Мө нь М.Ху-гаас 24.000.000 төгрөг зээлж аваад эргүүлэн төлсөн нь тогтоогдсон. Т.Мө-ыг Н.Хү-д хээл хахууль өгсөн гэж мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдсэн боловч энэ үйлдлийг нь анхан шатны шүүхээс хэрэгсэхгүй болгосон нь зөв юм гэв.

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч А.Дав шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Мөрдөн байцаалтын шатанд хохирлын

хэмжээг 5 тэрбум төгрөг гэж тогтоосон ч анхан шатны шүүхээс нийт хохирлын хэмжээ 4.699.000.000 төгрөг байна гэж шийдсэн. Хэрэгт холбогдсон этгээдүүдээс хохирлыг гаргуулж өгнө үү. Сангийн сайдын хүсэлтийг хэрэгт хавсарсан байгаа. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг зөвшөөрч байгаа. Иймд шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж өгнө үү гэв.

Прокурор О.Гэрэл шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ:

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг дэмжиж байна. Давж заалдах гомдлын дийлэнх нь хохирлын хэмжээтэй холбоотой байна. Хэргийг шүүхэд шилжүүлэх үедээ хэрэгт шалгагдсан бүх хүнийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар яллах санал өгсөн. Хохирлын хэмжээг шүүх хуралдааны явцад өөрчлөх санал оруулсан. Яллах дүгнэлт үйлдэх үед "Цэвэр агаар" санд учирсан хохирол 5.111.979.000 төгрөг гэж тооцсон. Үүнээс мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгүүдэд үндэслэн, данснаас гарсан мөнгөнөөс татварт орсон 10 хувийг хасаж гаргасан. 4.454.065.529 төгрөгийн хохирол учирсан байна гэж эцсийн байдлаар тооцоог гаргасан. Татварын газраас ирүүлсэн баримтуудаас үзэхэд "ШГЭБ" ХХК нь татварт 29.500.000 төгрөг, "ШГД" ХХК 24.000.000 төгрөг, "ПИ" ХХК нь 21.400.000 төгрөгөөс буцаалт хийсний суутгал 2.420.000 төгрөг авч үлдсэн байсан. Татварт өгсөн мөнгө өөрчлөгдсөн учраас нийт татварт 60.720.000 төгрөг төлөгдсөн гэж үзсэн. Мөнгө дансаар шилжүүлснээс болж хохирлын хэмжээ өөрчлөгдсөн. "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2.726.500.000 төгрөг орсон нь тогтоогдож байсан боловч энэ мөнгөнөөс 2012 оны 04 дүгээр сарын 04-нд хийгдсэн 466.500.000 төгрөгөөс 394.561.471 төгрөг "ХА" ХХК-д тушаасан нь харагдаж байгаа. "ШГЭБ" ХХК-с 2.331.938.529 төгрөг болж өөрчлөгдсөн. "ШГЭБ" ХХК-ийн дансаар гарч үрэгдсэн мөнгө нь 2.331.938.539, "ХБ" ХХК-ийн дансаар 116.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар 21.430.000 төгрөг, "АЖ" ХХК-ийн дансаар гарсан 429.760.000 төгрөг, "Т" ХХК-ийн дансаар гарсан 1.454.779.000 төгрөг зэргийг хохиролд тооцсон. Үүнээс татваруудыг хасаж тооцоход нийт үлдэж байгаа мөнгө 4.654.558.229 төгрөг болсон. Н.Хү-д яллах дүгнэлт үйлдэх үед түүнийг 1.468.680.000 хохирол учруулсан гэж үзэж, харин М.Хү нь 979.000.539 төгрөгийн хохирол учруулсан

гэсэн тооцоо гаргасан. 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдөр улсын яллагчаас дүгнэлт хийх үед хохирлын тооцоонд өөрчлөлт оруулсан. Үүнд Н.Хү 49.000.000 төгрөг, М.Хү 4.210.218.029 төгрөг, Б.Чи 280.000.000 төгрөг, Х.Д.Цэ 340.000.000 төгрөгийг тус тус "Цэвэр агаар" сангийн мөнгөнөөс завшсан гэж үзсэн. Н.Хү-ийн үйлдсэн хэргийг Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлээр зүйлчилснийг зөвшөөрөхгүй гэж байна. Н.Хү "Цэвэр агаар" санд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. "Цэвэр агаар" сан нь төсвөөс санхүүждэг байсан ба Тусгай сангийн тухай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг байсан. Түүнийг сангийн мөнгөнд хяналт тавих эрх бүхий субъект гэж үзээд Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлд зааснаар ялласан. Төсийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан нь ойлгомжгүй байна гэж байгаа дээр тайлбар хийхэд Н.Хү нь М.Хү-д итгээд хоосон цаасан дээр гарын үсэг зурж өгдөг байсан гэж байгаа ч өөрийнх нь гарын үсгээр тэр мөнгөнүүд гарсан байдаг. Агаарын бохирдолтой холбоотой сургалт зохион байгуулагдаагүй хирнээ сургалтад мөнгө гарсан зэрэг үйлдэл гарсан байдаг. Иймд түүний хийсэн хэрэг яах аргагүй Эрүүгийн хуулийн 273 дугаар зүйлд зааснаар зүйлчлэгдэх юм. Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан үйлдлүүд нь нотлогдсон гэж үзэж байна. Б.Да-ын өмгөөлөгчийн ярьж байгаа нь буруу. Б.Да нь 100.000.000 төгрөг авч үлдээд 90.000.000 төгрөгийг буцааж өгсөн. Авч үлдсэн мөнгөнөөсөө 4.800.000 төгрөг татварт төлөөд 5.200.000 төгрөгийг нь үрсэн байсан. Б.Чи-ийн үйлдэл нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар зүйлчлэгдэхгүй гэж байна. Прокуророос түүний учруулсан хохирлыг онц их хэмжээ гэж ойлгож байсныг анхан шатны шүүх зассан байгаа. Б.Да, Б.Чи нар нь "Цэвэр агаар" сангийн албан хаагч биш, уг хэргийг бүлэглэн үйлдээгүй гэсэн гомдол гаргаж байна. Энэ хүмүүс компани байгуулан мөнгө завшихад хамтран оролцсон. Иймд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд зааснаар энэ хүмүүсийн үйлдлийг зүйлчилсэн нь зөв юм. М.Хү-д ял оногдуулсан хорих ялын шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахад татгалзах зүйлгүй гэв.

ХЯНАВАЛ:

Н.Хү, М.Хү, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө, Б.Ат, Д.Гэ нарт холбогдох эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх

хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д зааснаар "...шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор..." эцэслэн хянан шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Нэг. Н.Хү нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сан буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар сан"-гийн гүйцэтгэх захирлаар 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж байхдаа 2012 онд 116.000.000 төгрөгийг сургалт зохион байгуулах нэрээр "ХБ" ХХК-ийн дансаар, 21.440.000 төгрөгийг ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар, 1.454.079.500 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар, 100.000.000 төгрөгийг зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар, 2011 онд 240.000.000 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" ХХК-ийн дансаар гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан,

мөн М.Ху-тай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 38.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11.000.000 төгрөгийг авч нийт 49.000.000 төгрөгийг хувьдаа завшсан,

мөн "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цаасан дээр зурж үлдээснээс М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлж, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан болох нь хэрэгт авагдсан, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон, дээрх үйлдэлд нь анхан шатны шүүх гэм буруутайд тооцож ял оногдуулсан нь зөв байна.

Н.Хү-д холбогдох хэргээс "М.Ху-тай бүлэглэж "Т" ХХК-ийн дансаар гаргасан 454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг", "Б.Да-ын төрсөн дүү Б.Зг-ын нэрээр үүсгэн байгуулсан "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг авч хувьдаа завшсан" гэх үйлдлийг, "2011 онд ШУА-ийн Газарзүйн

хүрээлэнд 76.000.000 төгрөгийн санхүүжилт бүхий Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн хөрсний бохирдолд шинжилгээ хийх ажлыг олгож уг санхүүжилтээс өөрийн үүсгэн байгуулалцсан "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөгийг", "2012 онд "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас 44 сая төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргээс 24.000.000 төгрөгийг хээл хахууль авсан" гэх хэргийг прокурор яллахаас татгалзсан үндэслэлээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар, "ХТТ ХХК-ийн захирал Т.Мө-аас 20.000.000 төгрөгийн хахууль авсан" гэх хэргийг "гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй" үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй болжээ.

Харин Прокуророос Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар яллаж яллах дүгнэлт үйлдэн, улмаар анхан шатны шүүх "хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглаж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд тооцсон" нь үндэслэлгүй байна. Н.Хү-ийг ямар баримт бичиг, хэвлэмэл маягтыг хэрхэн хуурамчаар үйлдсэн талаар мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдоогүй энэ зүйлээр ялласан нь буруу байх тул шүүхийн шийтгэх тогтоолын Н.Хү-д холбогдох "Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн" хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

Мөн Н.Хү-ийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлж байгаа нөхцөл байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10-т зааснаар түүний ял эдлэх дэглэмийг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулах боломжтой гэж дүгнэв.

Хоёр. М.Ху нь "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогчоор 2011 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс ажиллаж байх хугацаандаа "ХБ", "ОСБ", "АЖ" ХХКомпаниудын гэрээг хуурамчаар үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 78.000.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 10.144.000 төгрөгийг, "ШД" ХХК-ийн дансаар

гаргасан 240.000.000 төгрөгөөс 216.000.000 төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар 429.760.000 төгрөг төгрөгийг,

мөн Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж хурамч гэрээ үйлдэн байгуулж, "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 1.931.938.529 төгрөгийг хувьдаа завшиж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн нь тогтоогдсон байна.

Анхан шатны шүүх гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 4.210.218.029 төгрөгөөр тогтоож, прокуророос гаргасан саналын дагуу энэ хохирлыг М.Ху-гаас бүрэн гаргуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна. Учир нь М.Ху-г "Т" ХХК-ийн дансаар 1.454.079.500 төгрөг гаргасан" үйлдэл, мөн "Б.Да-тай бүлэглэж түүний төрсөн дүү Б.Зг-ын нэрээр үүсгэн байгуулсан "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөг гаргуулж, үүнээс 90.000.000 төгрөгийг завшсан" үйлдэлтэй холбогдуулж яллагдагчаар татаагүй, энэ талаар огт яллаагүй байхад түүнээс уг хохирлыг шууд гаргуулж шийдвэрлэсэн нь буруу гэж үзэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д зааснаар түүний төлөх төлбөрөөс дээрх 1.544.079.500 төгрөгийг хасаж "2.511.138.529 төгрөг гаргуулах"-аар шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж шийдвэрлэлээ.

"Цэвэр агаар" сангаас 2011-2012 онд "Т" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан 1.454.079.500 төгрөг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 90.000.000 төгрөгтэй холбоотой асуудлыг тусад нь мөрдөн байцаалтаар шалгуулах нь зүйтэй гэж үзнэ.

М.Ху-гийн үйлдсэн гэмт хэрэг нотлогдон тогтоогдсон, шүүхээс түүний үйлдлийг зөв зүйлчилж, ял шийтгэл оногдуулсан байна.

М.Ху-гийн өмгөөлөгч нараас "М.Ху нь одоо жирэмсэн байгаа нөхцөл байдлыг харгалзан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж өгнө үү" гэх хүсэлтийг гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон прокуророос "М.Ху-д ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах боломжтой" гэж санал гаргасан тул хэрэгт авагдсан М.Ху-гийн эрүүл мэндийн тодорхойлолт, Хорих 461 дүгээр ангийн Эмнэлгийн эмч нарын дүгнэлт зэргийг харгалзан түүнд анхан шатны шүүхээс 7 жил хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн

63.1-д зааснаар 2 жилийн хугацаагаар хойшлуулж, энэ хугацаанд хяналт тавихыг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст хариуцуулахаар шийдвэрлэв.

Гурав. Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч М.Ху болон түүний найз Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар" сангаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гаргуулж улсад онц их хэмжээний хохирол учруулсан, улмаар үүнээс 340.000.000 төгрөгийг авч хувьдаа завшиж хохирол учруулсан болох нь тогтоогдсон. Түүний үйлдлийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар зүйлчилж ял оногдуулсан нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Анхан шатны шүүх Д.Цэ-д дээрх зүйлүүдэд зааснаар ял оногдуулж Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар 8 жил хорих ял шийтгэсэн атлаа Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар ялыг нэмж нэгтгэхдээ "Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан 7 жил хорих ял дээр" гэж буруу бичсэн байна. Иймд Д.Цэ-гийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж, түүний биечлэн эдлэх ялыг "7 жил хорих ялаар тогтоох" нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Дөрөв. Б.Чи-ийг "Цэвэр агаар" сангийн мэргэжилтнээр ажиллаж байхдаа 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-аас буцаагдсан бэлэн мөнгө болох 21.780.000 төгрөгийг хувьдаа завшиж, улсад их хэмжээний хохирол учруулсан гэж дүгнэж Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Эрүүгийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно" гэж заасан бөгөөд хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъект нь "итгэмжлэгдэн хариуцсан этгээд" буюу байгууллагаас өөрийн өмчийг хариуцуулахаар үүрэг хүлээлгэсэн, эсхүл хууль буюу гэрээнд зааснаар үүрэг хүлээсэн этгээд байдаг онцлогтой.



Б.Чи нь 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдөр уг үйлдлийг хийхэд "Цэвэр агаар" санд ажил эрхэлж байгаагүй, Өөрөөр хэлбэл, үүрэг хүлээгээгүй байжээ. Иймд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн субъект биш байх тул уг зүйлчлэлийг өөрчлөх нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Харин Б.Чи нь "Хурал семинар, хүлээн авалт зохион байгуулах" зорилгоор "Цэвэр агаар сан"-гаас "ПИ" ХХК-д шилжүүлсэн мөнгөнөөс "Хүлээн авалт цуцлаад мөнгөө буцааж татна" гэж 21.780.000 төгрөгийг бэлнээр авч завшсан буюу "Бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан" болох нь тогтоогдож байх тул түүний үйлдлийг Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.

Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн ангилалд багтах бөгөөд гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д заасан зургаан сар өнгөрсөн байх тул Б.Чи-ийг энэ зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэв.

Шүүх Б.Чи-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2, 270 дугаар зүйлийн 270.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулж шүүхэд шилжүүлсэн боловч анхан шатны шүүх хуралдаанд улсын яллагчаас "Н.Хү, М.Ху нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг хувьдаа авч завшсан, хуурамч баримт бичиг тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх ашиглаж онц их хэмжээний хохирол учруулсан" гэх хэргүүдэд яллахаас татгалзсан байх тул шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар, "Т.Мө-ны 44.000.000 төгрөгийн хээл хахуулийг Н.Хү-д зуучилсан" гэх үйлдлийг нотлогдоогүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй болжээ.

Б.Чи нь 21.780.000 төгрөгийг "Цэвэр агаар сан"-д буцаан төлсөн байх тул түүнээс гаргуулах өөр хохирол төлбөр байхгүй болохыг, түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн тул Хорих ангиас нэн даруй суллахыг энэхүү магадлалд дурдав.

Тав. Б.Да-ыг "Үндэсний Аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудиторор ажиллаж байхдаа "Цэвэр агаар" сангийн 2011-2012 оны тайланд санхүүгийн Аудит хийснийхээ дараа тус сангийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэн өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн байгуулж, тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч, уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшсан" гэж ялласны дагуу шүүх Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар гэм буруутайд тооцож ял шийтгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Б.Да нь "Цэвэр агаар" санд тодорхой үүрэг хүлээж ажиллаж байгаагүй бөгөөд "итгэмжлэгдэн хариуцсан этгээд" буюу Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъект биш байна. Мөн прокурорын яллах дүгнэлтэд "сангийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэн өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн байгуулж тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг завшсан" гэж ялласан атлаа Н.Хү, М.Ху нарт дээр үйлдэлд холбогдуулан яллах дүгнэлт үйлдээгүй, мөрдөн байцаалтын шатанд Б.Да нь 5.200.000 төгрөгийг авч хувийн хэрэгцээндээ зарцуулснаа хүлээн мэдүүлсэн зэрэг нөхцөл байдлыг харгалзан түүний үйлдлийг Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй.

Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэргийн ангилалд багтах бөгөөд гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д заасан зургаан сар өнгөрсөн байх тул Б.Да-ыг энэ зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэв.

Зургаа. Х.Бо нь "Цэвэр агаар" сангийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн захирал үүсгэн байгуулагч бөгөөд 2011 онд "Цэвэр агаар" сангийн нягтлан М.Ху болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сантай хуурамч гэрээг үйлдэн, байгуулж улмаар тус сангаас гаргасан 2.726.500.000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшсан гэм буруутай болох нь хэрэгт авагдсан, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар

тогтоогдсон бөгөөд анхан шатны шүүх түүнийг гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 Түүнд холбогдуулан шүүхэд шилжүүлсэн Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан "Баянгол дүүргийн Татварын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1.000.000 төгрөгийн хахууль өгсөн" гэх гэмт хэргийг анхан шатны шүүх хуралдаанд улсын яллагчаас яллахаас татгалзсан байх тул шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар хэрэгсэхгүй болгожээ.

Харин анхан шатны шүүх "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар" гэж шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт бичээгүй байх тул энэхүү өөрчлөлтийг оруулах нь зүйтэй.

Долоо. М.Аб-ыг "ШУА-ийн Газар зүйн хүрээлэнтэй түншлэлийн гэрээ хийх замаар "Цэвэр агаар" сангаас 76.000.000 төгрөгийн, мөн "Цэвэр агаар" сангаас санхүүжигдсэн гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхнүүдийг ариутгах ажлыг хийх "ИЙТ" ХХК-аас Н.Хү-ийн албан тушаалын байдлыг ашиглан мониторингийн 86.400.000 төгрөгийн ажлыг, мөн "Цэвэр агаар" сантай гэрээ хийж гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур суурилуулсан ажлын үр дүнд мониторинг хийх 89.900.000 төгрөгийн ажлыг авч бусдаар хийлгүүлэн ашиг олж Н.Хү-д 9.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн боловч шүүх хуралдаанд улсын яллагчаас яллахаас татгалзсан байх тул шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй байна.

Харин шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт энэ талаар дүгнэсэн атлаа тогтоолын тогтоох хэсэгт "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1" дэх заалтыг баримтлаагүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.4-т зааснаар М.Аб-ын холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаагүй байх тул энэхүү өөрчлөлтийг оруулж шийдвэрлэлээ.

Найм. Ж.Сү-г Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа "ШГЭБ" ХХК-ийн захирал Х.Бо-гаас 1.000.000 төгрөгийн хахуулийг түүний ашиг сонирхлын үүднээс урьдчилан амлахгүйгээр авсан гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1-

д зааснаар яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн боловч шүүх хуралдаанд улсын яллагчаас яллахаас татгалзсан байх тул шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй байна.

Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1" дэх заалтыг баримтлаагүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.4-т зааснаар Ж.Сү-гийн холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаагүй байх тул энэхүү өөрчлөлтийг оруулж шийдвэрлэв.

Ес. Т.Мө нь "ХТТ" ХХК-ийн захирал ажилтай бөгөөд "Цэвэр агаар" сантай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд Б.Чи-ээр дамжуулан тус сангийн захирал Н.Хү-д давтан үйлдлээр нийт 44.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт холбогдуулан Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шүлжүүлснийг "24.000.000 төгрөгийн хахууль өгсөн" гэх гэмт хэргийг улсын яллагч яллахаас татгалзсан тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар, харин "20.000.000 төгрөгийн хахуулийг Б.Чи-ээр зуучлуулан Н.Хү-д өгсөн" гэх хэргийг "гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй" үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нь зөв байна.

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт Т.Мө-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон атлаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.4-т зааснаар түүнийг цагаатгаагүй байх тул тогтоолын тогтоох хэсэгт зохих өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэв.

Арав. Б.Ат, Д.Гэ нар нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар" сангаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.260.000.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан, үүний улмаас М.Ху, Д.Цэ, Х.Бо нар нь "Цэвэр агаар сан"-гаас гэрээний мөнгө гэж 2012 оны 04 дүгээр сарын

02-ны өдөр дахин 466.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн данс руу шилжүүлэн авч завшсан болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдож тогтоогджээ.

Шүүх Б.Ат, Д.Гэ нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Б.Да, Б.Ат, Д.Гэ нарын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн байцаалтын шатанд хэрэгт авагдсан, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан гэрч Э.Эб /9- хавтас х-72-73/, П.А /9-р хавтас х-146-147/, Б.Со /9-р хавтас х-6-7/, С.Эт /9-р хавтас х-161/, Ж.Цо /9-р хавтас х-122-124/, Э.Ба /9-р хавтас х-17 хуудас/, М.Аг /9-р хавтас х-20/, М.Жа /9-р хавтас х-21/, Б.Мө /9-р хавтас х-22/, З.Бм /9-р хавтас х-23, Г.ГХб /9-р хавтас х-24/, Б.Б /9-р хавтас х-25/, Д.Дв /9-р хавтас х-27/, Н.Эб /9-р хавтас х-28/, Д.До /9-р хавтас х-35-36/, О.Бш /9-р хавтас х-37-38/, Г.Ба /9-р хавтас х-61-62/, Б.Хз /9-р хавтас х-65/, Б.Ч /9-р хавтас х-69-70/, Э.Эб /9-р хавтас х-72-73/, М.Цч /9-р хавтас х-77-78/, Ч.Үр /9-р хавтас х-81-82/, Г.Дж /9-р хавтас х-083/, А.Ою /9-р хавтас х-84/, А.Эт /9-р хавтас х-85/, Д.Б /9-р хавтас х-96/, Ж.Ш /9-р хавтас х-97/, Л.Ня /9-р хавтас х-105/, Ц.Бат /9-р хавтас х-113/, Ө.Мс /9-р хавтас х-115/, Н.Тг /9-р хавтас х-118-119/, Б.Лх /9-р хавтас х-121/, Ж.Бд /9-р хавтас х-149-150/, С.Бв /9-р хавтас х-152-153/, Ц.Эч /9-р хавтас х-162/, Б.Д /9-р хавтас х-164-165/, Л.Гс /9-р хавтас х-170-171/, Д.Эдэ /9-р хавтас х-174/, шинжээч Л.А /9-р хавтас х-188/, гэрч Д.Др /9-р хавтас х-190/ нарын мэдүүлгүүд,

хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтууд "Цэвэр агаар" сангийн Гүйцэтгэх захирлын тушаал /1-р хавтас х-42/, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2011 онд хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөө /1-р хавтас х-53-56/, Нэгжлэг хийсэн тэмдэглэл /1-р хавтас х-92-95/, БОНХЯам Цэвэр агаарын сангийн 2012 оны төсвийн зарлага /1-р хавтас х-103-104/, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2012 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /1-р хавтас х-105/, БОАЖЯ сайдын багцын 2011 оны нийт хөрөнгө оруулалт /1-р хавтас х-106/, Төрийн сан Орлогын дансны хуулга /1-р хавтас х-115/, БОАЖЯам Цэвэр агаар" сан Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга, НАББҮХ-ны гишүүн Д.Б танаа Зарцуулалтын эрхийн тухай /1-р хавтас х-131/, Өглөг авлагын байгууллагын товчоо /1-р хавтас х-133,140/, "Цэвэр агаар" сангийн

2012 оны санхүүгийн тайлангийн аудит /1-р хавтас х-170/, Аудитын гэрчилгээ /1-р хавтас х-171/, Боловсруулсан түлш худалдах, худалдан авч нөөц бүрдүүлэх Түүнийг санхүүжүүлэх тухай гэрээ "Цэвэр агаарын сан" - "ШГД" ХХК /1-р хавтас х-223-227/, "ШГД" ХХК-аас 2011.11.23- 2012.04.30 хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын нөөцийн агуулахад нийлүүлэх боловсруулсан түлшний хэмжээ, үнийн хуваарь /1-р хавтас х-228/, Хамтын ажиллагааны гэрээ "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /1-р хавтас х-230, 232, 233/, Бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл /3-р хавтас х-146/, Төлбөрийн хүсэлт №96 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-154/, Нэхэмжлэх "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-155/, Ажил гүйцэтгэх гэрээ "ХБ"ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-156-157/, Төлбөрийн хүсэлт БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ОСБ" ХХК /3-р хавтас х-158/, Нэхэмжлэх "ДЗТМ" ХХК- "Цэвэр агаар" сан 3-р хавтас х-162/, Хамтран ажиллах гэрээ БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-164, 165/, Төлбөрийн хүсэлт БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-166/, Нэхэмжлэх "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-167/, Төлбөрийн хүсэлт №60 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ШГЭБ" ХХК /3-р хавтас х-170/, Төлбөрийн хүсэлт №75 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-172/, Нэхэмжлэх "ДЗТМ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас 173/, Төлбөрийн хүсэлт №168 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-174/, Хамтран ажиллах гэрээ "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо" - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-175-177/, Төлбөрийн хүсэлт №335 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-178/, Хамтран ажиллах гэрээ БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /3-р хавтас х-180-181/, Төлбөрийн хүсэлт №382 БОНХЯам "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /3-р хавтас х-182/, Ажил гүйцэтгэх гэрээ "ХБ" ХХК - "Цэвэр агаар" сан /3-р хавтас х-184-185/, Гарын үсэг "ОСБ" ХХК 3-р хавтас х-214/, Төлбөрийн хүсэлт №188 БОАЖЯам "Цэвэр агаар" сан - "Аж" ХХК /3-р хавтас х-220/, Боловсруулан түлшний нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан түлш нийлүүлэх, түүнийг урьдчилан худалдан авах гэрээ "ЦАС" -"НЗДТГ" - "ШГЭ" ХХК (Б) /3-р хавтас х-233/, Шинжилгээ хийлгэх тухай тогтоол /4-р хавтас х-1, 8/, Шинжээчийн дүгнэлт /4-р хавтас х-24-27, 31-32/, Мэргэжлийн хяналтын

ерөнхий газар Шалгалтын тэмдэглэл /4-р хавтас 88-113, 132-133/, Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГЭБ" ХХК /4-р хавтас х-170/, "Т" ХХК-ийн дансны хуулга /4-р хавтас х-177/, Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс Хил хамгаалах ерөнхий газрын хилийн шалган нэвтрүүлэх хэлтэст /4-р хавтас х-175/, Лавлагааны хариу Хилийн шалган нэвтрүүлэх албаны хэлтэс /4-р хавтас х-177, 178/, Төлбөрийн хүсэлт №348 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ШГД" ХХК /4-р хавтас х-181/, Төлбөрийн хүсэлтүүд №142 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ШГЭБ" ХХК /4-р хавтас х-182-187/, Төлбөрийн хүсэлт №71 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ХБ" ХХК /4-р хавтас х-192-195/, Төлбөрийн хүсэлт №88 БОАЖЯ "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК /4-р хавтас х-198-203/, "Цэвэр агаар" сангийн үйл ажиллагааны төсвийн төлөвлөгөө 4-р хавтас х-211-213/, "Цэвэр агаар" сангийн удирдах зөвлөлийн тогтоол /4-р хавтас х-215/, "Цэвэр агаар" сангийн 2012 оны ажиллах төлөвлөгөөний өөрчлөлт /4-р хавтас х-216/, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд Төсвийн гүйцэтгэлийн тухай /ЦАС/ /4-р хавтас х-219, 220/, Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтэс Улсын Ерөнхий прокурорын газрын эрүүгийн хэргийн төв архивт /Х.Бо-д тэнсэн харгалзах ял оногдуулж байсан тогтоолын хуулбарыг ирүүлэх тухай/ /5-р хавтас х-166/, Монгол Улсын төрийн албаны зөвлөл Авлигатай тэмцэх газар Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаах албаны дарга, ахлах комиссар Э.А танаа "Тодруулга хүргүүлэх тухай" /5-р хавтас х-211/, МУ-ын БОАЖЯ ЦАС Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар "Хяналтын багт оролцуулах" /5-р хавтас х-214/, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар БОАЖЯамны "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирал Н.Хү танаа "Хариу хүргүүлэх тухай" /5-р хавтас 215, 216/, Монгол Улсын БОАЖСайдын тушаал Дүрэм, журам, хөтөлбөр, төсөв батлах тухай /5-р хавтас х-227, Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн Бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам /5-р хавтас х-242-244/, "Цэвэр агаар" сангийн гүйцэтгэх захирлын тушаал /6-р хавтас х-16, 18/, МХЕГ - Улсын байцаагчийн акт Цэвэр агаар сан "ШГД" ХХК "Төсвийн орлого болгох тухай" /6-р хавтас

х-68, 69/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - Шалгалтын тэмдэглэл "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн тухай" /6-р хавтас х-73-95/, Аудит хийгдсэн үр дүнгийн тайлан /6-р хавтас х-121/, БОАЖСайдын багцад Улсын төсвийн хөрөнгөөр 2011 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит /6-р хавтас х-134/, Монгол Улсын БОАЖЯ Үндэсний Аудитын газарт "Зөрчлийн тухай" /6-р хавтас х-144/, Монгол Улсын БОАЖСайдын тушаал "Эрх шилжүүлэх" /6-р хавтас х-147/, Монгол Улсын Үндэсний Аудитын газар, Албан шаардлага /6-р хавтас х-166, 220, 221/, Монгол Улсын Үндэсний Аудитын Газар Улсын төсвөөс 2011 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн /6-р хавтас х-168-177/, Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн Аудитын төлөвлөгөө /6-р хавтас х-180-184/, Худалдаа хөгжлийн банк "Тоотын хариу хүргүүлэх тухай" /7-р хавтас х-1, 9, 15, 16, 18-25, 32-34, 38, 39, 42-44, 49-53, 67/, Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГД" ХХК /7-р хавтас х-146/, Данс нээх өргөдлийн маягт "ШГД" ХХК /7-р хавтас х-147, 148/, Байгууллагын харилцах данс, хугацаагүй хадгаламжийн гэрээ "ШГД" ХХК /7-р хавтас х-149/, Хуулийн этгээдийн харилцах данс нээх, хаах тухай мэдэгдэл Дугаар 0016140 "ШГД" ХХК /7-р хавтас х-152/, "ХБ" ХХК-ийн дансны хуулга /7-р хавтас 162, 163/, Бизнес үйлчилгээний төвийн дансны хуулга /7-р хавтас х-181/, Хас банк Гарын үсгийн баталгаа /7-р хавтас х-184, 185/, Хас банк Төлбөрийн баримт /7-р хавтас х-190/, Гэрч М.Соё-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-6-10, 12/, Иргэний хариуцагчаар татах тухай тогтоол /9-р хавтас х-11/, Гэрчээр Б.Чи-ийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-15, 16/, гэрч Э.Ба-ийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-17-19/, Гэрч Б.Мө-ийг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-22/, Гэрч О.Ч Ж.Сү-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-30, 31/, Гэрч Л.Т-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-53, 54/, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхийг ариутгах ажлын гэрээ "Цэвэр агаар сан" - "ИЙТ" ХХК, "Цэвэр агаар сан" - "ЭАИ" ХХК /9-р хавтас х-55-57, 58-60/, Гэрч Г.Бс-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-66-68/, Т.Мө-ыг гэрчээр байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-89, 90, 95/, Бэлэн мөнгөний

зарлагын баримт /9-р хавтас х-104/, Гэрч Г.Ши-ыг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-107-109/, Улсын бүртгэлийн гэрчилгээ "Аж" ХХК /9-р хавтас х-110/, Гэрч Э.Я-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-116/, Гэрч П.Аг байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-146, 147/, Гэрч А.С-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-167, 168/, Гэрч Б.Мө-г байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-169/, Төслийн хүрээнд мэргэжлийн боловсон хүчин авч ажиллуулах гэрээ "Цэвэр агаарын сан"- "НХХ" /9-р хавтас х-176-179/, Д.Цэ-г яллагдагчаар байцаасан тэмдэглэл /9-р хавтас х-196-199/, "Хаан" банкны Депозит дансны дэлгэрэнгүй хуулга "ШГЭБ" ХХК /9-р хавтас х-213-215/, Худалдаа хөгжлийн банк Харилцах дансны гүйлгээний хуулга "ШГЭБ" ХХК /9-р хавтас х-216/, М.Ху-г яллагдагчаар /9-р хавтас х-225-239/, Б.Чи-ийг сэжигтнээр /10-р хавтас х-12/, Б.Чи-ийг яллагдагчаар /10-р хавтас х-16-21/, М.Аб-ыг сэжигтнээр /10-р хавтас х-25-28/, М.Аб-ыг яллагдагчаар /10-р хавтас х-30, 31/, "Пума" ХХК болон Д.Цэ нарын хооронд байгуулсан "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" /1-р хавтас х-193/, "Д" ХХК болон Д.Цэ-гийн нөхөр З.Бм нарын хооронд байгуулсан "Орон сууц захиалгаар бариулах гэрээ" /1-р хавтас х-213-217/, "Д" ХХК-д Д-аас байрны төлбөрт 200.000.000 төгрөг төлсөн баримт /1-р хавтас х-218/, "Цэвэр агаар сан" "ДЗТМ"ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ /3-р хавтас х-175-177, шинжээчийн дүгнэлтүүд /4-р хавтас х-01-085/, М.Ху-гийн оршин суугаа газрын тодорхойлолт /5-р хавтас х-157/, мөнгө шилжүүлсэн баримт /10-р хавтас х-71, 73, 171/, яллагдагч Х.Бо-гийн хэргийн материалтай танилцаад гаргасан хүсэлт /10-р хавтас х-190, 191/, яллагдагч Н.Хү-ийн мэдүүлэг /10-р хавтас х-9/, яллагдагч Б.Чи-ийн мэдүүлэг /10-р хавтас х-19, 20/, Х.Бо-гийн дансны хуулга /7-р хавтас х-32/, / Э.Ба-ийн дансны хуулга /8-р хавтас х-15, 29, 41/, М.Жа-гийн дансны хуулга /8-р хавтас х-43/, М.Ху-гийн дансны хуулга /8-р хавтас х-84/, Б.Ө-ын дансны хуулга /8-р хавтас х-135-153/, Ө.Мс-ы дансны хуулга /8-р хавтас 154/, М.Ц-гийн дансны хуулга /8-р хавтас х-165/, М.Х-гийн дансны хуулга /8-р хавтас х-177-186/, Х.Бо-гийн "Хаан" банкны дансны хуулга /8-р хавтас х-199-201/, "Хаан" банк дахь "ШГЭБ" ХХК-ийн дансны хуулга /9-р хавтас х-213/, гэрч Л.Гс /сайд/-ийн мэдүүлэг /9-р хавтас х-170, 171/, Х.Бо-гийн сэжигтнээр өгсөн мэдүүлэг /9-р хавтас 202, 203/, Х.Бо-гийн яллагдагчаар өгсөн мэдүүлэг /9-р хавтас

х-211/, М.Ху-гийн сэжигтнээр өгсөн мэдүүлэг /9-р хавтас х-218-220/, Н.Хү-ийн яллагдагчаар өгсөн мэдүүлэг /10-р хавтас х-4/, Д.Цэ-гийн ажил байдлын тодорхойлолт /12-р хавтас х-12, 13/, Цагдан хорих 461 дүгээр ангийн тодорхойлолт болон шинээр өгсөн баримт / фото зураг/, Орон сууц хөлслөх гэрээ /2-р хавтас х-202/, Б.Чи-ийн зээлийн баримт /10-р хавтас х-247/, Б.Чи-ийн мөнгө хүлээлцсэн баримт /10-р хавтас х-248/, Т.Мө-ы Хас банкны дансны хуулга /10-р хавтас х-249/, Гадаадад томилолтоор явуулах тухай тушаал /6-р хавтас х-32-34/, БОАЖЯ-ны сайдын тушаал албан томилолт /6-р хавтас х-37/, албан томилолт /6-р хавтас х-41/, албан томилолтын тушаал /6-р хавтас х-43/, гэрч Б.Хз-ийн мэдүүлэг /9-р хавтас х-63/, гэрч Г.Ши-ын мэдүүлэг /9-р хавтас х-107/, гэрч Н. Тг-ийн мэдүүлэг /9-р хавтас х-119/, шүүгдэгч Х.Бо-гийн өрөөнд нэгжлэг хийсэн тэмдэглэл /1-р хавтас х-92-95, гэрээ, гэрээний хавсралт /3-р хавтас х-233-237/, татварын тооцооллын жагсаалт /4-р хавтас х-239/, Х.Бо-гийн мэдүүлэг /9-р хавтас х-210/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-221/, Х.Бо-гийн хохирол төлсөн баримт /10-р хавтас х-72/, хохирлын тооцоо /10-р хавтас х-79/, "Цэвэр агаар" сан - "ДЗТМ" ХХК-тай хамтран ажиллах гэрээ /3-р хавтас х-164-177/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-234/, Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол /10-р хавтас х-101, 102, болон шинээр өгсөн ажил байдлын тодорхойлолт, Т.Мө-ын мэдүүлэг /9-р хавтас х-95/, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-221, 235, 237/, яллагдагч Н.Хү-ийн мэдүүлэг /10-р хавтас 6-7/, Б.Чи-ийн мэдүүлэг /10-р хавтас х-13, 17, 19, 20/, Т.Мө-ын сэжигтнээр өгсөн мэдүүлэг /10-р хавтас х-53, 54/, Т.Мө-ын хүүхдийн эмчилгээний талаарх баримт /11-р хавтас х-10/, хувийн байдлыг тодорхойлох баримтууд, М.Ху-гийн мэдүүлэг /9-р хавтас х-226/, Зээл эргүүлэн төлсөн тухай баримт /12-р хавтас х-23, 37/, хариуцсан байгууллагын бүртгэлийн мэдээ /12-р хавтас х-33-36/, дипломын хуулбарууд /12-р хавтас х-38-41/, Ж.Сү-гийн охин С.Х-ны төрсний гэрчилгээний хуулбар /12-р хавтас х-42/, Ж.Сү-гийн ажил байдлын тодорхойлолт /12-р хавтас х-45, 46/, Баянзүрх дүүргийн 7-р хорооны тодорхойлолт /12-р хавтас х-44/, Төрийн сангийн орлогын баримт /1-р хавтас х-110/, "ШГЭБ" ХХК-д 360 сая төгрөг орсон баримт /1-р хавтас х-119/, Банкны бүртгэлийн дансны хуулга /1-р хавтас х-120-122/, "ШГЭБ"

ХХК-ийн дансны орлогын баримт /1-р хавтас х-115/, шинжээчийн дүгнэлт /4-р хавтас х-24-27/, "ШГЭБ" ХХК-д 1.980.000.000 төгрөг шилжүүлсэн тухай баримт /4-р хавтас х-170/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шалгалт хийсэн тэмдэглэл /4-р хавтас х-88-97/, МХЕГ-ын Улсын байцаагчийн акт /6-р хавтас х-68/, "Т" ХХК-д "Цэвэр агаар" сангаас оруулсан мөнгөний зөрүү харуулсан тухай дүгнэлт /4-р хавтас х-132/, шүүгдэгч Б.Ат-гийн ажлын байрны тодорхойлолт /5-р хавтас х-184/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан тоот /10-р хавтас х-210, 211/, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны албан бичиг /12-р хавтас х-8/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлогчийн албан тоот, Д.Гэ-ийн "тодорхойлолт зэрэг шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон байна.

Иймд ялтан Н.Хү, түүний өмгөөлөгч Д.Нямдорж, М.Баасанбат, Х.Базаррагчаа нарын "Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 273 дугаар зүйлийн 273.2-т зааснаар ял халдаасан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

ялтан М.Ху, түүний өмгөөлөгч Б.Энхзаяа, Р.Мэндсайхан, Б.Оюунбилэг нарын гаргасан "хэт нэг талыг барьж хохирлыг М.Ху-гаар гаргуулсныг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т заасан ялыг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

ялтан Д.Цэ, түүний өмгөөлөгч Д.Гансүх, М.Алтанцэцэг нараас гаргасан "Д.Цэ энэ хэрэгт хобогдолгүй учир түүнийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ялласныг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

Б.Чи, түүний өмгөөлөгч Г.Батбаяр, Л.Өлзийхүү нарын гаргасан "Б.Чи-ийг үйлдлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

Х.Бо, түүний өмгөөлөгч Д.Даваа нарын гаргасан "Х.Бо-д Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар ял оногдуулсан хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүхээс оногдуулсан ял шийтгэлийг хөнгөрүүлж өгнө үү" гэх,

Б.Да, түүний өмгөөлөгч С.Дондов нарын гаргасан "Б.Да-т холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

Б.Ат болон түүний өмгөөлөгч С.Цэдэндамба, Д.Гэ болон түүний өмгөөлөгч Ж.Энхнасан нарын гаргасан "Б.Ат, Д.Гэ нарыг Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар гэм буруутайд тооцож ял шийтгэсэн нь үндэслэлгүй тул хэрэгсэхгүй

болгож өгнө үү" гэх давж заалдах гомдлуудыг хүлээн авах хууль зүйн үндэслэлгүй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

М.Ху, Д.Цэ, Х.Бо нарын гэмт хэрэг үйлдэж олсон зарим хөрөнгө, эд зүйлсийн Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хурааж, улсын орлого болгож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол үндэслэлтэй байна. Мөрдөн байцаалтын шатанд Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчийн 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн тогтоолоор захиран зарцуулах эрхийг нь хязгаарласан хх-хх НАА улсын дугаартай "Лексус-470" загварын, хх-хх УБВ улсын дугаартай "Лексус-470" загварын хоёр ширхэг автомашиныг "Цэвэр агаар сан"-гаас "ШГЭБ" Ххк-аар дамжуулан 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр М.Жа-гийн нэр дээр ХААН банкны 575207xxxxx тоот дансаар шилжүүлсэн 158.550.000 төгрөгөөр худалдаж авсан болох нь нотлогдсон байх тул /7 хавтас 42, гэрч М.Жа, Б.Хз нарын мэдүүлэг/ уг хоёр ширхэг автомашиныг Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хурааж улсын орлогод оруулах нь зүйтэй гэж шийдвэрлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.4 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын 2, 3 дахь заалтын "Н.Хү-ийг ...Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан", "...Шүүгдэгч Н.Хү-д ...мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй" гэж шийдвэрлэсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэрэгсэхгүй болгосугай.

2. А. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын 1 дэх заалтын "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1..." гэсний дараа "239 дүгээр зүйлийн 239.4.1" гэж, "...хэрэгсэхгүй болгосугай" гэснийг "...хэрэгсэхгүй болгож, Ж.Сү, М.Аб, Т.Мө нарыг цагаатгасугай.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2-т зааснаар Нийслэлийн Прокурорын газраас Б.Чи, Б.Да-ын нарын

үйлдлийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар зүйлчилснийг "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 152 дугаар зүйлийн 152.1" болгон өөрчлөн зүйлчилсүгэй" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж,

Б.Шийтгэх тогтоолын 2 дахь заалтын "...Т овогт Б.Чи-ийг Бусдын эд хөрөнгийг завшиж, их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд" гэснийг "Т овогт Б.Чи-ийг бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан гэм буруутайд" гэж,

"...Б овогт Б.Да-ыг Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд" гэснийг "Б овогт Б.Да-ыг Бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан гэм буруутайд" гэж,

В.Шийтгэх тогтоолын 3 дахь заалтын "...Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар" гэснийг "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн 6 жил хорих ял" гэж,

"Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т зааснаар Б.Чи-д холбогдох Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д зааснаар Б.Чи-ийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй" гэж,

"Шүүгдэгч Б.Да-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хорих ялаар" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т зааснаар Б.Да-т холбогдох Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д зааснаар Б.Да-ыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй" гэж,

Г. Шийтгэх тогтоолын 4 дэх заалтын "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн

эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ял дээр" гэснийг "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн 6 жил хорих ял дээр" гэж "...түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар" гэснийг "...биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 7 жил хорих ялаар" гэж өөрчилж,

Д. Шийтгэх тогтоолын 5 дахь заалтын "...Б.Да,...Б.Чи..." гэснийг хүчингүй болгож, "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан Н.Хү-ийн эдлэх ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид" гэснийг "Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10-т заасныг журамлан мөн зүйлийн 52.5-д зааснаар ялтан Н.Хү-ийн эдлэх ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид" гэж,

Е. Шийтгэх тогтоолын 7 дахь заалтын "...тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгосугай" гэснийг "...хх-хх НАА улсын дугаартай "Лексус-470" загварын, хх-хх УБВ улсын дугаартай "Лексус-470" загварын автомашиныг тус тус хурааж, улсын орлого болгосугай" гэж,

Ё. Шийтгэх тогтоолын 10 дахь заалтын "...М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг..." гэснийг "...М.Ху-гаас 2.511.138.529 төгрөгийг..." гэж өөрчлөлт оруулж,

Ж. Шийтгэх тогтоолын 15 дахь заалтад "Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д зааснаар М.Ху-д энэ шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар оногдуулсан 7 жил хорих оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулж, энэ хугацаанд түүнд хяналт тавих үүргийг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст хариуцуулсугай" гэж нэмэлт оруулж тус тус өөрчилсүгэй.

3. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалт, хэсгийг хэвээр үлдээж, ялтан Н.Хү, түүний өмгөөлөгч Д.Нямдорж, М.Баасанбат, Х.Базаррагчаа, ялтан М.Ху, түүний өмгөөлөгч Б.Энхзаяа, Р.Мэндсайхан, Б.Оюунбилэг, ялтан Д.Цэ, түүний өмгөөлөгч Д.Гансүх, М.Алтанцэцэг, ялтан Б.Чи, түүний өмгөөлөгч Г.Батбаяр, Л.Өлзийхүү, ялтан Х.Бо, түүний өмгөөлөгч Д.Даваа, ялтан Б.Да, түүний өмгөөлөгч С.Дондов, ялтан Б.Ат болон түүний өмгөөлөгч С.Цэдэндамба, ялтан Д.Гэ

болон түүний өмгөөлөгч Ж.Энхнасан нарын гаргасан давж заалдах гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

4. Монгол Улсын Засгийн газрын тусгай сан, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар" сангаас 2011-2012 онуудад "Т" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан гэх 1.454.079.500 төгрөг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан гэх 90.000.000 төгрөгтэй холбоотой асуудлаар тусад нь мөрдөн байцаалтаар шалгах

асуудал нээлттэй болохыг дурдсугай.

5. Энэхүү магадлал гарснаар Б.Чи, Б.Да, М.Ху нарыг нэн даруй сулласугай.

6. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл эрх бүхий этгээд 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Ш.БАТ-ЭРДЭНЭ  
Т.ӨСӨХБАЯР  
Ц.ОЧ



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо,  
Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө, Б.Ат, Д.Гэ нарт холбогдох  
эрүүгийн хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн С.Нямжав даргалж, шүүгч Б.Батцэрэн, Д.Ганзориг, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн нарын бүрэлдэхүүнтэйгээр, Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор А.Оюунгэрэл, өмгөөлөгч Г.Оюунцэцэг, С.Баасанбат, Х.Базаррагчаа, Д.Нямдорж, Ц.Итгэл, Р.Мэндсайхан, Б.Оюунбилэг, Д.Гансүх, М.Алтанцэцэг, Д.Даваа, С.Цэдэндамба, Ж.Энхнасан, нарийн бичгийн дарга Б.Өлзийхишиг нарыг оролцуулан хийж, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр магадлалтай, Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө, Б.Ат, Д.Гэ нарт холбогдох 20130100027 дүгээр эрүүгийн хэргийг ялтнууд болон тэдгээрийн өмгөөлөгч нарын гомдлыг үндэслэн, хэргийг 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч, шүүгч Д.Эрдэнэбалсүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Ховд аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Монгол Улсын Засгийн Газрын тусгай сан, Байгаль орчин, Ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар" сангийн захирал ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Н.Хү /РД: ПЭ...../;

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ....., нөхөр хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нягтлан бодогч ажилтай, ял

шийтгэлгүй, Б овогт М.Ху /РД:УЕ...../;

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Д.Цэ /РД: ШГ...../;

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-нд Архангай аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл ..., охины хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн мэргэжилтэн ажилтай, ял шийтгэлгүй, Т овогт Б.Чи /РД: ЧВ...../;

5. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл 3, нөхөр, хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, "Цэвэр агаар" сангийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал ажилтай, 2005 оны 03 дугаар сарын 11-нд 1986 оны Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлийн 3-т зааснаар 2 ажил хорих ялаар шийтгүүлж, уг хорих ялыг тэнсэж 1 жилийн хугацаагаар хянан харгалзсан, Б овогт Х.Бо /РД: НМ...../;

6. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Сүхбаатар аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Баянгол дүүргийн Татварын хэлтэст Татварын улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Я овогт Ж.Сү /РД: ЛБ...../;

7. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой,

экологич мэргэжилтэй, ам бүл ..., хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "Үндэсний Хөгжлийн Хүрээлэн"-нд Хүрээлэн буй орчин бодлогын судалгааны секторын эрхлэгч, "ЭАИ" ХХК-ийн гүйцэтгэх захирал ажилтай, ял шийтгэлгүй, У овогт М.Аб /РД: ПЭ...../;

8. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Үндэсний Аудитын газрын Санхүүгийн аудитын газарт аудитор ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Б.Да /РД: ИЮ...../;

9. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, "ИТТ" ХХК-нд менежер, "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал ажилтай, ял шийтгэлгүй, Г овогт Т.Мө /РД: СР...../;

10. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Хэнтий аймгийн ...суманд төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл 3, нөхөр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Х овогт Б.Ат /РД: ЦД...../;

11. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл 2, нөхрийн хамт ...дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газарт Санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч ажилтай, ял шийтгэлгүй, Б овогт Д.Гэ /РД: ХН...../.

Холбогдсон хэрэг /Прокурорын яллах дүгнэлтэд дурдсанаар/:

1. Н.Хү нь Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Монгол Улсын Засгийн газрын тусгай сан буюу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар сан"-гийн гүйцэтгэх захирлаар 2011 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж байхдаа 2012 онд 116.000.000 төгрөгийг сургалт зохион байгуулах

нэрээр "ХБ" ХХК-ийн дансаар, 21.440.000 төгрөгийг ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар, 1.454.079.500 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар, 100.000.000 төгрөгийг зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар, 2011 онд 240.000.000 төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" ХХК-ийн дансаар гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан гэмт хэрэгт,

Н.Хү нь М.Ху, Б.Чи нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 38.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 11.000.000 төгрөгийг, "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг, Б.Да-ын төрсөн дүү Б.Зг-ын нэрээр үүсгэн байгуулсан "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг тус тус авч, 1.447.671.550 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт,

Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цагаан цаасан дээр зурж үлдээснээс М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлж, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан гэмт хэрэгт,

Н.Хү нь давтан үйлдлээр, 2011 онд ШУА-ийн Газарзүйн хүрээлэнд 76.000.000 төгрөгийн санхүүжилт бүхий Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн хөрсний бохирдолд шинжилгээ хийх ажлыг олгож уг санхүүжилтээс өөрийн үүсгэн байгуулалцсан "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөгийг, "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас 44 сая төгрөгийг нийт 53.000.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэгт,

2. М.Ху нь "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогчоор ажиллаж байх хугацаандаа "ХБ", "ОСБ", "АЖ" ХХКомпаниудын гэрээг хуурамчаар үйлдэн, гэрээ байгуулж, уг "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 36.500.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.144.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 86.000.000

төгрөгийг, "АЖ" ХХК-ийн дансаар гаргасан 429.760.000 төгрөгөөс 380.000.000 төгрөгийг, мөн Д.Цэ, Х.Бо нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн дансаар 2011-2012 онуудад удаа дараагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг гаргаж, үүнээс 771.000.000 төгрөгийг тус тус хувьдаа завшиж, улсад 1.278.644.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт,

3. Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан, "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху болон түүний найз Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар сан"-гаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гаргуулж, үүнээс 1.500.000.000 төгрөгийг авч хувьдаа завшсан гэмт хэрэгт,

4. Б.Чи нь "Цэвэр агаар сан"-гийн мэргэжилтнээр ажиллаж байх хугацаандаа "Цэвэр агаар сан"-гийн гүйцэтгэх захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэж, "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг, 2011 оны 12 сарын 30-ны өдөр "ПИ" ХХК-наас буцаагдсан бэлэн мөнгө болох 21.780.000 төгрөгийг тус тус хувьдаа авч, нийт 188.280.000 төгрөг завшсан гэмт хэрэгт,

мөн "ХТТ" ХХК-ийн захирал Т.Мө нь "Цэвэр агаар сан"-тай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд "Цэвэр агаар сан"-гийн захирал Н.Хү-д өгсөн 44.000.000 төгрөгийн хээл хахуулийг зуучилсан гэмт хэрэгт,

5. Б.Да нь Үндэсний Аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудиторoor ажиллаж байхдаа "Цэвэр агаар сан"-гийн 2011-2012 оны тайланд санхүүгийн аудит хийснийхээ дараа тус сангийн захирал Н.Хү, нягтлан бодогч М.Ху нартай бүлэглэн өөрийн төрсөн дүү Б.Зг-ын нэрээр "ДЗТМ" ХХК-ийг үүсгэн байгуулж, тус компанийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч, уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэгт,

6. Х.Бо нь "Цэвэр агаар сан"-гийн нярав, "ШГЭБ" ХХК-ийн захирал үүсгэн байгуулагч

бөгөөд 2011 онд "Цэвэр агаар сан"-гийн нягтлан М.Ху болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэ нартай бүлэглэж "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар сан"-тай хуурамч гэрээг үйлдэн, байгуулж улмаар тус сангаас гаргасан 2.726.500.000 төгрөгөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшсан гэмт хэрэгт,

мөн хуурамч бичиг баримтаар гэрээ байгуулан "Цэвэр агаар сан"-гаас "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө шилжүүлж авсан гэмт үйлдлээ нуун далдлах зорилгоор уг компанийг татан буулгах, татварын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрүүлэхгүй байх зорилгоор Баянгол дүүргийн Татварын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт,

7. М.Аб нь ШУА-ийн Газар зүйн хүрээлэнтэй түншлэлийн гэрээ хийх замаар "Цэвэр агаар сан"-гаас 76.000.000 төгрөгийн, мөн "Цэвэр агаар сан"-гаас санхүүжигдсэн гэр хорооллын айл өрхүүдийн жорлон, муу усны нүхнүүдийг ариутгах ажлыг хийх "ИЙТ" ХХК-аас Н.Хү-ийн албан тушаалын байдлыг ашиглан мониторингийн 86.400.000 төгрөгийн ажлыг, мөн "Цэвэр агаар сан"-тай гэрээ хийж гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур суурилуулсан ажлын үр дүнд мониторинг хийх 89.900.000 төгрөгийн ажлыг авч бусдаар хийлгүүлэн ашиг олж Н.Хү-д 9.000.000 төгрөгийн хахууль өгсөн гэмт хэрэгт,

8. Т.Мө нь "ХТТ" ХХК-ийн захирал ажилтай бөгөөд "Цэвэр агаар сан"-тай Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд хийн зуух суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг хийж, улмаар уг гэрээг цуцлуулахгүйн тулд Б.Чи-ээр дамжуулан тус сангийн захирал Н.Хү-д давтан үйлдлээр нийт 44.000.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэмт хэрэгт,

9. Ж.Сү нь Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа "ШГЭБ" ХХК-ийн захирал Х.Бо-гаас 1.000.000 төгрөгийн хахуулийг түүний ашиг сонирхлын үүднээс урьдчилан амлахгүйгээр авсан гэмт хэрэгт,

10. Б.Ат нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар" сангийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын

улсын ахлах байцаагч Д.Гэ-ийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар сан"-гаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт,

11. Д.Гэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг тус газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Ат-гийн хамт хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаар сан"-гаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2.726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолоор:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар шүүгдэгч Я овогт Ж.Сү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

У овогт М.Аб-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Г овогт Т.Мө-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Т овогт Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270 дугаар зүйлийн 270.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Б овогт Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг

Б овогт Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж

ирүүлсэн хэргийг,

Б овогт Н.Хү-ийн түлш нийлүүлэх гэрээ нэрээр "Т" ХХК-ийн дансаар 1.474.079.500 төгрөгийг шилжүүлсэн, зар сурталчилгаа нэрээр "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөгийг гаргаж төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарчуулсан,

Т овогт Б.Чи-ийг шүүгдэгч Н.Хү, М.Ху нартай бүлэглэж, "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан 116.000.000 төгрөгөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан 21.440.000 төгрөгөөс 5.000.000 төгрөг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан 240.000.000 төгрөгөөс 130.000.000 төгрөгийг завшсан, мөн хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт ашиглаж, онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож.

2. Шүүгдэгч Б овогт Н.Хү-ийг Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн,

Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан,

Албан тушаалтан албан үүрэгтэй хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учруулсан гэмт хэргийг үйлдсэн,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт М.Ху-г Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт Д.Цэ-г Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргийг үйлдсэн,

Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан,

Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Т овогт Б.Чи-ийг Бусдын эд хөрөнгийг завшиж, их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Б овогт Х.Бо-г Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их

хэмжээний хохирол учруулсан,

Б овогт Б.Да-ыг Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд,

Х овогт Б.Ат, Б овогт Д.Гэ нарыг Албан тушаалтан албан үүрэгтэй хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож.

3.Шүүгдэгч Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 6 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэглэл ял хэрэглэн, 5

жил 1 сарын хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар,

Шүүгдэгч Б.Да-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хорих ялаар,

Шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр тус бүр 1 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэж,

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг журамлан ялтан Н.Хү-д энэ тогтоолоор оногдуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялд хөнгөн ял болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялыг, мөн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ялыг тус тус багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэглэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

М.Ху-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 6 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 1 жилийг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ялаар,

Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн

эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялын зарим болох 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,

Х.Бо-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 жил хорих ялыг багтааж, түүний биечлэн эдлэх хорих ялыг 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар тус тус тогтоож.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан Н.Хү, Б.Да нарын эдлэх ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Б.Ат, Д.Гэ нарын эдлэх ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлэхээр.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Хү-ийн цагдан хоригдсон 93 хоногийг, шүүгдэгч М.Ху-гийн цагдан хоригдсон 138 хоногийг, шүүгдэгч Д.Цэ-гийн цагдан хоригдсон 149 хоногийг, шүүгдэгч Х.Бо-гийн цагдан хоригдсон 61 хоногийг, шүүгдэгч Б.Чи-ийн цагдан хоригдсон 66 хоногийг, шүүгдэгч Б.Да-ын 76 хоногийг тэдгээрийн ял эдэлсэн хугацаанд нь оруулсан тооцож, шүүгдэгч Т.Мө 57 хоног, шүүгдэгч М.Аб, Ж.Сү, Б.Ат, Д.Гэ нар нь тус бүр 33 хоног цагдан хоригдсон болохыг дурдаж.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар хэрэгт

битүүмжлэгдэн ирсэн LEXUS-570 маркийн хх-хх УБУ улсын дугаартай автомашин, LEXUS RX-350 маркийн хх-хх УНА улсын дугаартай автомашин болон

М.Ху-гийн гэмт хэрэг үйлдэн олсон мөнгөөр худалдан авсан үнэт эдлэлүүд, 1000 ам.доллар, Волксваген Тигуан маркийн хх-хх УНР улсын дугаартай тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгохоор.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэгт зааснаар Н.Хү төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хассан, Д.Цэ-гийн төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилийн хугацаагаар хассан нэмэгдэл ялын хугацааг үндсэн ялыг эдлэж дууссан үеэс эхлэн тоолж.

9. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн "ШГЭБ" ХХК-ийн тамгыг хууль ёсны эзэмшигч Х.Бо-д буцаан олгохоор.

10. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Хү-ээс 49.000.000 төгрөгийг, шүүгдэгч М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг, шүүгдэгч Д.Цэ-гээс 340.000.000 төгрөгийг, шүүгдэгч Х.Бо-гаас 25.500.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Чи-эс 21.780.000 төгрөгийг, шүүгдэгч Б.Да-аас 5.200.000 төгрөгийг тус тус гаргуулж "Цэвэр агаар" санд олгохоор.

11. Хэрэгт битүүмжлэгдсэн ирсэн шүүгдэгч Н.Хү-ийн:

- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 3 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 1 өрөө орон сууц,,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 2 өрөө орон сууц,
- Баянгол дүүргийн ... хороо ... тоот 4 тусдаа өрөөнүүдээ зоорины давхрын орон сууцнуудын хэсгээс хохиролд тооцуулахаар, шүүгдэгч Д.Цэ-гийн:
- Баянзүрх дүүргийн ... хороо ... тоот 3

өрөө

- Баянзүрх дүүргийн ...хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй орон сууц, 2 авто зогсоолын хамт

- Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар,

шүүгдэгч М.Ху-ийн:

-Чингэлтэй дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууц,

- ...сумын ...тоот 4 өрөө орон сууцнуудын хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар, шүүгдэгч Б.Чи-ийн:

- Сүхбаатар дүүргийн ...хороо ...тоот 2 өрөө орон сууцны хувьд ногдох хэсгээс хохиролд тооцуулахаар, шүүгдэгч Х.Бо-ийн:

- Ниссан Вингроуд маркийн автомашин,

-Краз маркийн чирэгч автомашиныг чиргүүлийн хамт хохиролд тооцуулахаар тус тус Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж.

12. Б.Да, Б.Ат, Д.Гэ, Т.Мө, Ж.Сү, М.Аб нараас эд хөрөнгө битүүмжилж ирүүлээгүйг дурдаж,

13. Хохирогч Сангийн яамны Төрийн сангийн газар нь татварт төлөгдсөн гэх 248.559.500 төгрөгийг иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж.

14. Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохиролд шүүгдэгч М.Ху-гаас 155.000.000 төгрөгийг, шүүгдэгч Х.Бо 5.000.000 төгрөгийг төлсөн болохыг дурдаж.

15. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт тус бүр оногдуулсан 1 жил хорих ялыг тэнсэж, 1 жилийн хугацаагаар хянан харгалзаж, тэдгээрт хяналт тавихыг Сонгинохайрхан, Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэст даалгаж.

16. Шүүгдэгч Ж.Сү, М.Аб, Т.Мө нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, шүүх хуралдааны танхимаас суллаж, шүүгдэгч Б.Ат, Д.Гэ нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авахаар.

17. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хуулийн хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо Б.Да, нарт урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээж, тэдгээрийн эдлэх ялыг 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн тоолж шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх Н.Хү, М.Ху, Д.Цэ, Б.Чи, Х.Бо, Ж.Сү, М.Аб, Б.Да, Т.Мө, Б.Ат, Д.Гэ нарт холбогдох хэргийг 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хянан хэлэлцээд, 484 дүгээр магадлалаар:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын 2, 3 дахь заалтын "Н.Хү-ийг ...Хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан", "...Шүүгдэгч Н.Хү-д ...мөн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй" гэж шийдвэрлэсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэрэгсэхгүй болгож,

2.

А. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолын 1 дэх заалтын "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1." гэсний дараа "239 дүгээр зүйлийн 239.4.1" гэж, "...хэрэгсэхгүй болгосугай" гэснийг "... хэрэгсэхгүй болгож, Ж.Сү, М.Аб, Т.Мө нарыг цагаатгасугай."

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2-т зааснаар Нийслэлийн Прокурорын газраас Б.Чи, Б.Да-ын нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар зүйлчилснийг "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 152 дугаар зүйлийн 152.1" болгон өөрчлөн зүйлчилсүгэй" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж,

Б.Шийтгэх тогтоолын 2 дахь заалтын "...Т овогт Б.Чи-ийг Бусдын эд хөрөнгийг завшиж, их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд" гэснийг "Т овогт Б.Чи-ийг бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан гэм буруутайд" гэж,

"...Б овогт Б.Да-ыг Бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж, онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд" гэснийг "Б овогт Б.Да-ыг Бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан гэм буруутайд" гэж,

В.Шийтгэх тогтоолын 3 дахь заалтын "...Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн

хугацаагаар хорих ялаар" гэснийг "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн 6 жил хорих ял" гэж,

"Б.Чи-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 300.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хугацаагаар хорих ялаар" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т зааснаар Б.Чи-д холбогдох Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д зааснаар Б.Чи-ийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй" гэж,

"Шүүгдэгч Б.Да-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 500.000 төгрөгийн эд хөрөнгийг хураах нэмэгдэл ял хэрэглэн, 5 жил 1 сарын хорих ялаар" гэснийг "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т зааснаар Б.Да-т холбогдох Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д зааснаар зүйлчилсэн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д зааснаар Б.Да-ыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй" гэж,

Г. Шийтгэх тогтоолын 4 дэх заалтын "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ял дээр" гэснийг "Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн 6 жил хорих ял дээр" гэж "...түүний биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар" гэснийг "...биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 7 жил хорих ялаар" гэж өөрчилж,

Д. Шийтгэх тогтоолын 5 дахь заалтын "...Б.Да, ...Б.Чи..." гэснийг хүчингүй болгож, "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар ялтан Н.Хү-ийн эдлэх ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид" гэснийг "Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10-т заасныг журамлан мөн зүйлийн 52.5-д зааснаар ялтан Н.Хү-ийн эдлэх ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид" гэж,

Е. Шийтгэх тогтоолын 7 дахь заалтын "...тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгосугай" гэснийг "...хх-ххНАА улсын дугаартай "Лексус-470" загварын, хх-хх УБВ улсын дугаартай "Лексус-470" загварын автомашиныг тус тус хурааж, улсын орлого болгосугай" гэж,

Ё. Шийтгэх тогтоолын 10 дахь заалтын "...М.Ху-гаас 4.055.218.029 төгрөгийг..." гэснийг "...М.Ху-гаас 2.511.138.529 төгрөгийг..." гэж өөрчлөлт оруулж,

Ж. Шийтгэх тогтоолын 15 дахь заалтад "Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д зааснаар М.Ху-д энэ шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар оногдуулсан 7 жил хорих оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жилийн хугацаагаар хойшлуулж, энэ хугацаанд түүнд хяналт тавих үүргийг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст хариуцуулсугай" гэж нэмэлт оруулж тус тус өөрчилж.

3. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалт, хэсгийг хэвээр үлдээж, ялтан Н.Хү, түүний өмгөөлөгч Д.Нямдорж, М.Баасанбат, Х.Базаррагчаа, ялтан М.Ху, түүний өмгөөлөгч Б.Энхзаяа, Р.Мэндсайхан, Б.Оюунбилэг, ялтан Д.Цэ, түүний өмгөөлөгч Д.Гансүх, М.Алтанцэцэг, ялтан Б.Чи, түүний өмгөөлөгч Г.Батбаяр, Л.Өлзийхүү, ялтан Х.Бо, түүний өмгөөлөгч Д.Даваа, ялтан Б.Да, түүний өмгөөлөгч С.Дондов, ялтан Б.Ат болон түүний өмгөөлөгч С.Цэдэндамба, ялтан Д.Гэ болон түүний өмгөөлөгч Ж.Энхнасан нарын гаргасан давж заалдах гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгож.

4. Монгол Улсын Засгийн газрын тусгай сан, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны харьяа "Цэвэр агаар" сангаас 2011-2012 онуудад "Т" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан гэх 1.454.079.500 төгрөг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан гэх 90.000.000 төгрөгтэй холбоотой асуудлаар тусад нь мөрдөн байцаалтаар шалгах асуудал нээлттэй болохыг дурдаж.

5. Энэхүү магадлал гарснаар Б.Чи, Б.Да, М.Ху нарыг нэн даруй суллажээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Н.Хү-ийн гомдолд: "...Намайг шийтгэж байгаа Эрүүгийн хуулийн 273.2 гэх зүйл ангийг зөвшөөрөх ямар ч боломжгүй тул хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. Би төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан явдал огт байхгүй. Цэвэр агаар сангийн хөрөнгө холбогдох хуулиуд болон



Засгийн газрын тогтоол Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу юунд зарцуулах ёстой тэр л журам төслөөр зарцуулагдаж байсан. Нягтлан М.Ху-гийн гэрээ төлбөрийн даалгаврын хуурамч баримт зэргийг шалгалгүй итгэн гарын үсэг зурсан нь албан тушаалдаа хайнга хандсан зүйл хэмээн үзэж байна. Эрүүгийн хуулийн 150.3 гэх зүйл ангийг ямар ч нотлох баримтгүй ганцхан М.Ху-гийн худал мэдүүлгээр шийтгэж байгаад маш их гомдолтой байгаа тул хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. Албан тушаалтан албан тушаалдаа хайнга хандсан Эрүүгийн хуулийн 272.2 дахь зүйл ангийг хоёр талтай харж үзэж шүүж өгнө үү. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн агаарын чанарын албаны түлш хүлээн авсан тамга тэмдэг бүхий падаан гэрээг үндэслэн төлбөрийн даалгавар дээр түлшний төлбөр хийх зөвшөөрөл олгож гарын үсэг зурдаг. Гэтэл эдгээр байгууллагын тамга тэмдэг бүхий 72 ширхэг падаан М.Ху-гийн өрөөнөөс шалгалт нэгжлэгийн үеэр илэрч хураагдсан байдаг. Нягтландаа итгэж хөдөө гадаа явахдаа гарын үсэгтэй цаас орхидог байсандаа тун их харамсаж байна." гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн гомдолд: "...давж заалдах шатны шүүхийн магадлалаар Н.Хү-д 1 жилийн хорих ял шийтгэсэн Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлийн 233.2-т заасан хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн атлаа түүнд ногдуулсан нийт 8 жилийн хорих ялд ямар нэг хөдөлгөөн оруулж, багасгаагүй нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар зүйлд тодорхойлсон шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Мөн шийтгэх тогтоолоор Н.Хү-д Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 273 дугаар зүйлийн 273.2-т зааснаар ял оногдуулахдаа хавтаст хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдоогүй буюу шүүхийн дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримтууд өөр хоорондоо эрс зөрүүтэй байхад эдгээрийн алийг дүгнэлтийнхээ үндэслэл болгосон, бусдыг нь няцаан үгүйсгэсэн тухай үндэслэл зэргээ шийтгэх тогтоолд заалгүйгээр нотлох баримтыг шүүгдэгч нарт харилцан адилгүйгээр ялгамжтай, ойлгомжгүй байдлаар хэрэглэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 319 дүгээр зүйлийг зөрчсөн. Н.Хү-ийн бусдын эд хөрөнгийг завших,

төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг үйлдсэн болох нь хангалттай нотлох баримтаар тогтоогдоогүй байхад гэм буруутайд тооцож, ял оногдуулсан нь шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэж, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Иймд шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулж, Н.Хү-д ял оногдуулсан Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт заасан хэргүүдийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Д.Нямдорж, М.Баасанбат нарын хамтран гаргасан гомдолд: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 82-р зүйлийн 82.2-т "...Яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь гагцхүү хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болно", мөн 94-р зүйлийн 94.2-т "...Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана..." гэж заасныг илтэд баримтлаагүй болно. Мөн хуулийн 196 дугаар зүйлийн 196.1 дэх хэсэгт "...Тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байвал мөрдөн байцаагч уг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэнэ..." гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Улмаар Н.Хү, М.Ху нар нь гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдэж, гэмт хэрэгт хамтран оролцсон оролцоо огт тогтоогдоогүй байхад шүүх хэт нэг талыг барьж, хэргийнхээ талаар харилцан эсрэг сонирхолтой М.Ху-аар бусдын гэм бурууг нотлуулж, хөдлөшгүй нотлох баримт болгож ялтан Н.Хү-д ял шийтгэл оногдуулж байгаа нь Эрүүгийн байцан шийтгэх хуульд заасан үндсэн зарчим, хуульчилсан шаардлага болох бусад нотлох баримтуудаар тогтоогдсон байх гэснийг зөрчсөн.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйл заасан бусдын эд хөрөнгийг завшсан гэмт хэрэг нь гэм буруутай этгээд өөрийн эзэмшилд байгаа бусдын эд хөрөнгөөс хууль бусаар, үнэ төлбөргүйгээр өөрийн эрх мэдэлд оруулсан, мөн үрэгдүүлсний хувьд эд хөрөнгийг өөрийн эзэмшилдээ авч түүнийг худалдан борлуулах, бусдад бэлэглэх, өөртөө хэрэглэх зэргээр ашиглан шамшигдуулсан байхыг шаарддаг байтал ялтан Н.Хү-ийн хууль бус ямар үйлдэл хийж

итгэмжлэгдэн хариуцсан хөрөнгөнөөс өөрийн эрх мэдэлд болон эзэмшилдээ оруулсан, гэм буруугийн хэлбэр, сэдэлт болон ямар ашиг олох санаа зорилгоор бусдын эд хөрөнгийг завшсан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг мөрдөн байцаалтын шатанд болон шүүхийн хэлэлцүүлгээр нотолж чадаагүйгээс гадна ялтан Н.Хү-ийн буруутай ямар үйлдлийн улмаас гэм хор уу эсвэл хохирол учирсан уу гэдэг объектив талын шинжүүд бүрэн үгүйсгэгдсэн байгааг анхаарч, хор уршиг, үр дагавар хоёрын хоорондох шалтгаант холбоог тогтоогоогүй нь хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байна.

Ялтан Н.Хү-ийг зөвхөн М.Ху-гийн нэг талын мэдүүлгээр 49 000 000 төгрөгийг хүлээж аваад хувьдаа авч завшсан ашигласан гэж шийтгэл оногдуулж байгаа нь хэрэгт цугларсан ямар ч нотлох баримтуудад тогтоогдоогүй байхад Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн гэж үзэж байна. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2-т "... Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан..." гэмт хэрэгт буруутай гэж шүүхүүд хариуцлага шийтгэл оногдуулан хуулийг буруу хэрэглэсэн.

Улсын Дээд шүүхийн 2009 оны 6-р сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолоор "...зориулалтын бусаар зарцуулсан..." гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлгоно гэж тайлбарласан байх бөгөөд Н.Хү дээрх хуульд заасан хязгаарлалтын аль зүйлийг зөрчсөн талаар улсын яллагчийн зүгээс нотолгоог мэтгэлцээ болон шүүх хуралдааны хэлэлцүүлгийн явцад гаргаагүй, гэм бурууг нотлож чадаагүй байхад шүүх өөрийн "санаачилгаар" ял оногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй болсон. Иймд магадлалд өөрчлөлт оруулж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, мөн хуулийн 273 дугаар зүйлийн 273.2-т заасан гэмт хэргийн хувьд ялтан Н.Хү-ийг цагаатгаж өгнө үү." гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Н.Хү-ийн өмгөөлөгч Г.Оюунцэцэгийн гомдолд: ...анхан болон давж заалдах шатны шүүх Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 257 дугаар зүйлийн 257.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт хууль зүйн үндэслэлгүйгээр гэм буруутайд тооцож ял

шийтгэл оногдуулсан гэж үзэж байна. Шүүх Н.Хү-ийг төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаагүй, "Цэвэр агаар" сангийн хөрөнгийг холбогдох хуулийн заалт болон Засгийн газрын тогтоол, Удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу зарцуулж байсан нөхцөл байдлуудыг анхааран үзсэнгүй.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолд "зориулалтын бусаар зарцуулсан" гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7 дахь хэсэгт заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлгоно гэж заасан.

Мөн үүнээс гадна шүүх Н.Хү-ийг уг зүйл хэсгээр гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулахдаа холбогдуулж буй үйлдлийн субъектив талд бодит дүгнэлт хийж чадсангүй. Уг хэргийн субъектив талын гол шинж нь гэм буруугийн санаатай хэлбэр юм. Гэм буруутай этгээд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах үйлдлийн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас нийгэмд аюултай хор уршиг учирна гэдгийг урьдчилан мэдсэн байдаг онцлогтой. Харин Н.Хү-ийн хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтнуудын хяналтын дор Цэвэр агаар сангийн хөрөнгийг захиран зарцуулж байсан. Энэ нь Н.Хү-ийн өгсөн мэдүүлгээс гадна хэрэгт авагдсан нотлох баримтуудаар давхар батлагдаж байгаа билээ.

Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар буруутгах хууль зүйн үндэслэлүүд байхгүй гэж үзэж байна. М.Ху-гийн мэдүүлгээр миний үйлчлүүлэгчийг буруутгах боломжгүй юм. Мөрдөн байцаалтад М.Ху хуурамч бичиг баримт үйлдэж, компаниудыг тамга тэмдэг, гэрчилгээ, падаан ашиглаж байсан нь тогтоогдсон. Түүний гэрээс хуурамчаар үйлдсэн олон тооны гэрээний маягтууд олдсон, М.Ху-гийн эгч, дүү нарынхаа дансаар гарсан мөнгөнөөс тодорхой хувийг /49.000.000 төгрөг/ Н.Хү-ийг ашигласан гэж дүгнэн үзэх нотолгоо хангалтгүй.

Шүүх зөвхөн М.Ху-гийн уялдаа холбоогүй, хоорондоо зөрүүтэй, бусад нотлох баримтуудаар давхар батлагдаагүй мэдүүлгүүдээр Н.Хү-ийг буруутгаж ял шийтгэл оногдууллаа гэж үзэж байна. Мөрдөн байцаалтын шатанд Н.Хү, М.Ху болон тэдэнд хөрөнгө орлогын хамааралтай

хүмүүсийн байдал, хөрөнгийн гарал үүслийг нарийвчлан шалгасан. Н.Хү нь бусдын эд хөрөнгийг завшаагүй, бусдын хөрөнгийг өөрийн мэдэлд авч үрэгдүүлсэн, үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж үзэх нэг ч нотлох баримтууд хэрэгт байхгүй. Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт "...Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарсан бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ" гэж заасны дагуу Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт буруутгаж ял халдаах боломжгүй тул хэргийн зүйлчлэлийг нягтлан үзэж шийтгэх тогтоолд зохих өөрчлөлтийг оруулж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан М.Ху-гийн гомдолд: "...Надад ногдуулсан хохирлын нийт төлбөр болох 2.511.138.529 төгрөгөөс 1.692.260.000 төгрөгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд эдгээр мөнгийг М.Ху миний бие хувьдаа завшсан гэдэг нь нотлогдоогүй, үйлдээгүй, харин хэн авсан, тэдгээр хүмүүс мөнгийг авахад хэрхэн, яаж оролцсон нь хангалттай нотлогдсон гэж үзнэ. Б.Чи нь "Цэвэр агаарын сан"-д ямар ч хамааралгүй гэж мэдүүлдэг боловч 2011, 2012 оны гүйцэтгэх захирлын гаргаж байгаа тушаалын төсөл бэлдэх болон гэрээ, тушаалыг дугаарласан гар бичвэр нь Б.Чи-ийн үйлдэл байдаг. Мөн тушаал, гэрээг олон янзаар дахин, дахин гаргадаг, засдаг, устгадаг байсан нь 2013 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 04/13 тоот тушаал болон бусад баримтуудаар нотлогдоно. ...Х.Бо-гийн анхан болон давж заалдах шатны шүүхэд өгсөн тайлбар, гомдолд Д.Цэ-гийн мөнгө авсан тухай тодорхой гэрчилсэн байгаа тул миний үйлдээгүй хэрэгт намайг буруутгасныг залруулж өгнө үү. ...УБУ хх-хх, УБВ хх-хх, НАА хх-хх дугаартай автомашинууд нь гэмт хэргийн замаар олсон мөнгөөр аваагүй гэдгийг мөрдөн байцаалтын шатанд тогтоосон ба бусад нотлох баримтуудаар нотлогдож байгаа болно. Дээрх байдлаас дүгнэхэд Давж заалдах шатны шүүх нь Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийг буруу хэрэглэж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1, 246.2 дахь заалтыг ноцтой зөрчсөн гэж үзэж байгаа тул тогтоол,

магадлалд зохих өөрчлөлтийг оруулж, үнэн зөвөөр нь шийдэж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Р.Мэндсайханы гомдолд: "...Анхан шатны шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагааны явцад Улсын яллагч шүүгдэгч Б.Чи-ийн бусадтай буюу Н.Хү, М.Ху нартай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар гаргасан мөнгөнөөс 31.500.000 төгрөгийг, "ОСБ" ХХК-ийн дансаар гаргасан мөнгөнөөс 5.000.000 төгрөгийг, "ШГД" ХХК-ийн дансаар гаргасан мөнгөнөөс 130.000.000 төгрөгийг хувьдаа авч завшсан болох нь нотлогдоогүй тул дээрх үйлдлийг хэрэгсэхгүй болгох саналыг гаргасан юм. Гэвч улсын яллагч дээрх мөнгийг хувьдаа завшсан гэм буруутай үйлдлийг үлдсэн хоёр оролцогчийн нэг нь болох ялтан М.Ху-г хийсэн хэмээн яллах дүгнэлтэд дурдагдаагүй гэм буруутай үйлдэлд шууд буруутгасан нь хууль бус бөгөөд шүүх түүнийг хүлээн авсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчихөд хүргэсэн.

Мөн улсын яллагч ялтан Д.Цэ-гийн "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө гаргуулж, түүнээс 1.500.000.000 төгрөгийг авч, хувьдаа завшсан гэх үйлдлээс өөрийнх нь хүлээсэн 340.000.000 төгрөгийг завшсан гэм буруутай үйлдэлд нь яллаж, үлдсэн 1.160.000.000 төгрөгийн хувьдаа завшсан үйлдлийг нь хэрэгсэхгүй болгох санал гаргахгүй байж шууд ялтан М.Ху-г энэ үйлдлийг хийсэн хэмээн яллах дүгнэлтгүйгээр буруутгасан нь хууль бус бөгөөд шүүх түүнийг хүлээн авсан нь мөн л ноцтой зөрчил болжээ.

Иймд М.Ху-г яллах дүгнэлтэд огт дурдагдаагүй 1.326.500.000 төгрөгийн хохирлыг "Цэвэр агаар сан"-д учруулсан гэм буруутайд тооцсон үйлдлийг, нэр бүхий 2 компанийн өмнөөс татварт тушаасан 60.760.000 төгрөгийг хувьдаа завшсан гэм буруутайд тооцсон үйлдлийг тус тус хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь заалтыг шүүх жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн. Учир нь гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ гэдэг нь гэм буруутай этгээд буюу ялтан М.Ху нь гэмт хэрэг үйлдэх явцаа хууль бусаар олж авсан эд юмс байх ёстой. Гэтэл ялтан М.Ху гэмт хэрэг үйлдэх явцаа хууль бусаар олсон эд юмс нь "Цэвэр агаар сан"-ийн мөнгөн хөрөнгө болохоос иргэн М.Х, М.Жа, М.С нарын өмчлөлийн дээрх гурван автомашин биш юм.

Иймд автомашинуудыг хурааж, улсын орлого болгосныг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан М.Ху-гийн өмгөөлөгч Б.Оюунбилэг, Ц.Итгэл нарын хамтран гаргасан гомдолд: Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ М.Ху-гаас 2.511.138.500 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болсон гэж үзэж байгаа. Н.Хү, Д.Цэ, Б.Чи нарт М.Ху нь дансаар гаргаж авсан мөнгийг өгсөн нь гэрчүүдийн мэдүүлгээр тогтоогдсон.

Мөн Д.Цэ нь 2010.12.24-нд Орон сууц захиалах гэрээ 64.500.000 төгрөгийн үнэтэй, 2012.03.12-нд Орон сууц бариулах гэрээг байгуулж 220 сая төгрөг төлж байсан. 2012 онд "ТБМ" ХХК-аас 36.000 ам.доллараар Волксваген Тигаун маркийн машин худалдан авч их хэмжээний мөнгө захиран зарцуулж байгаагаар Д.Цэ нь Улсын яллагчийн яллах дүгнэлтэд дурдагдсан мөнгийг авч захиран зарцуулаад байгаа нь тогтоогдож байгаад шүүх дүгнэлт хийж үзсэнгүй.

М.Ху-г гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөөр худалдан авсан гэж Лексус-570 маркийн хххх УБУ улсын дугаартай автомашин, Лексус РХ 350 маркийн хххх УНА улсын дугаартай автомашин болон үнэт эдлэлүүд, 1.000 ам.доллар, Волксваген Тигаун маркийн хххх УНР улсын дутаартай тээврийн хэрэгсэл зэргийг улсын орлого болгохдоо М.Ху-гийн өөрийнх нь өмчлөлд байсан хувийн эд зүйлсэд үнэлэлт хийж ялгамжтай хандалгүйгээр улсын орлого болгосон нь хууль зүйн үндэслэлгүй болсон. Иймд хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдсон хохирлын тооцоог зөв судлан тооцож М.Ху-гаас гаргуулахаар шийдвэрлэсэн хохирлыг хасаж тооцон шийдвэрлэж мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 49-р зүйлийн 49-2-т зааснаар эд хөрөнгө хураасан байгаад дүгнэлт хийж зөв шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Д.Цэ-гийн гомдолд: "...Би Цэвэр агаар санд ямар нэгэн албан тушаал эрхэлдэггүй, миний эрхэлж байгаа албан тушаал ч ямар холбоогүй. Ийм байтал ямар ч үндэслэлгүйгээр надад Эрүүгийн хуулийн 263.2-т зааснаар албан тушаалаа урвуулан ашигласан гэж, хуурамч бичиг баримт үйлдээгүй байхад Эрүүгийн хуулийн 233.2-т зааснаар, Цэвэр агаарын сангаас ямар ч мөнгө аваагүй байхад Эрүүгийн хуулийн 150.3-т зааснаар ялласан гомдолтой байна.

Иймд дээрх зүйлүүдээр зүйлчилсэн ялыг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсье" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч М.Алтанцэцэгийн гомдолд: Эрүүгийн хуулийн 263.2-д, 150.3-д, 233.2-д заасан гэмт хэргээр Д.Цэ-г зүйлчилж, ял оногдуулсныг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд ажилладаг болохоос Цэвэр агаар сан /ЦАС/-д ажилладаггүй, тус байгууллагад ямар ч хамааралгүй буюу тодруулбал Цэвэр агаар сангийн удирдах зөвлөл болон ажлын албанд хамааралгүй этгээд билээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 263.1-д заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь өөрийн эрхэлж буй албан тушаалаа ашигласны үндсэн дээр бусдад хохирол учруулсан байхыг ойлгодог. Гэтэл Д.Цэ нь уг эд хөрөнгө завшсан гэх тулгаад буй үйлдэлд албан тушаалын байдлаа ашиглаагүй бөгөөд Цэвэр агаар сангийн үйл ажиллагаатай Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд түүний эрхэлдэг албан тушаал нь ямар ч холбогдолгүй, үр дагавар үүсгэхгүй билээ. Цэвэр агаар сан нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамтай ямар ч холбоогүй бөгөөд харин Сангийн яамнаас шууд санхүүжилт авдаг тус байгууллагатай шууд хамааралтай билээ. Энэ талаар эрх бүхий этгээдүүд болон бусад гэрч болон хавтаст хэрэгт байгаа нотлох баримтуудаар тогтоогдож байгаа билээ.

Д.Цэ-д тулгаад буй бүлэглэн бусдын эд хөрөнгийг завшсан үйлдэлд Д.Цэ нь яг ямар байдлаар дэмжлэг тусалцаа үзүүлж бүлэглэн оролцсонг шүүхээс тогтоогоогүй атлаа, Х.Бо, М.Ху нарын үйлдэлд хавсарган үзээд шууд л энэ хэрэгт бүлэглэсэн гэж тогтоогоод байна.

Д.Цэ нь ямар нэгэн хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэн, түүнийг ашиглаж гэмт хэрэг үйлдээгүй бөгөөд М.Ху-гийн хуурамч тамга тэмдэг, хэвлэмэл хуудас, маягт үйлдэж, мөнгө завшсан үйлдлийг Д.Цэ-г хийсэн болгож ялыг халдаан шийдвэрлэж байна.

Ямар ч ач тусгүй, эрх хэмжээгүй, албан тушаалын байдлаараа дэмжлэг тусалцаагүй, мөнгө угаалгах компанигүй, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны албан тушаал, ажлын байраараа хуурамч бичиг баримт бүрдүүлж өгөөгүй хүнд ял халдаасанд үндэслэлгүй юм. Иймд шийтгэх тогтоол, магадлалаас Д.Цэ-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, түүнийг цагаатгаж

өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан Д.Цэ-гийн өмгөөлөгч Д.Гансүхийн гомдолд: ...Д.Цэ-г бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэн үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд тооцсон нь мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд авагдсан нотлох баримтаар бүрэн нотлогдоогүй байхад ял шийтгэл оногдуулсан.

Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2-т заасан гэмт хэргийг үйлдсэн эсэхийг бүрэн бодитой тогтоогоогүй ба гэм буруутайд ямар ч нотлох баримтгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байхад гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулсан нь эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна.

Д.Цэ-г төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан ашигласан гэм буруутайд тооцож ял оногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй байна. Д.Цэ нь М.Ху-тай найз нөхдийн хувьд харилцан хэлцэл хийж мөнгө авсан бөгөөд тухайн мөнгийг авсан цаг хугацаа, газар орон зэрэг нөхцөл байдал түүний ажил болон албан тушаалтай ямар ч холбогдолгүй болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, шүүхийн хэлэлцүүлэгт тодорхой ба "Цэвэр агаар" сан нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтэстэй үйл ажиллагаагаараа холбогдолгүй, хамааралгүй хуулийн этгээд гэдэг нь нотлогдсон байхад эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар үзэхээр байна.

Д.Цэ-г "Цэвэр агаар сан"-гийн өрөнхий нягтлан бодогч М.Ху болон түүний найз Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг байгуулж, уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар" сангаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гаргуулж улсад онц хэмжээний хохирол учруулсан, улмаар үүнээс 340.000.000 төгрөгийг авч хувьдаа завшиж хохирол учруулсан болох нь тогтоогдсон гэжээ. Гэтэл Д.Цэ, М.Ху Х.Бо нар үгсэн тохиролцож компани байгуулсан бол тэдгээрийн хэлцлийн хэлбэр нь Иргэний хуульд заасан хуулиар тогтоосон хэлбэрийг зөрчсөн мөн Компанийн тухай хуульд ч нийцээгүйгээр амаар хэлцэл хийгдсэн бол энэ нь хууль бус хэлцэл бөгөөд хүчингүйд тооцдог бөгөөд гэмт хэрэг үйлдэхээр үгсэн тохиролцсон хэлцэл хийгдсэн гэж үзвэл

хэлцэлд оролцогч Д.Цэ-гийн гүйцэтгэсэн үүрэг, үйлдэл нь мөрдөн байцаалтын болон шүүхийн хэлэлцүүлэгт нотлох баримтаар тодорхой тогтоогдоогүй болно. Харилцан эсрэг сонирхолтой шүүгдэгч нарын мэдүүлэг нь бусад нотлох баримтаар бодитой тогтоогдоогүй байхад нэг талыг барьсан буюу мөрдөн байцаалт ч гүйцэт биш хийгдсэн ба энэ хуурамч гэрээний асуудлаар Сангийн яамны төрийн сангийн газрын мэргэжилтэнд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа болно.

Мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан 10 сая төгрөгийн хохирол төлсөн боловч үүнийг шийтгэх тогтоол, магадлалд хохирлын төлбөрөөс хасаагүй орхигдуулсан мөн М.Ху-гаас мөнгө авч худалдаж авсан Тигун загварын хх-хх УНР улсын дугаартай машиныг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн зэрэг нь хуульд нийцээгүй гэж үзэж байна. Иймд шийтгэх тогтоол болон магадлалын Д. Д.Цэ-д холбогдох эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулсныг хянуулан хэрэгсэхгүй болгуулах гомдол гаргаж байна." гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан Д.Гэ түүний өмгөөлөгч Ж.Энхнасангийн гомдолд: ...Д.Гэ-д холбогдуулсан хэргийн мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа шүүхийн тогтоол гаргахад чухал ач холбогдолтой байж болох олон нөхцөл байдлыг бүрэн тодруулаагүй, Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай болох нь шинэчлэн судалсан нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй байхад зөвхөн яллаж шийтгэхийг урьтал болгон шийтгэсэн нь илт хууль бус байхад Давж заалдах шатны шүүх ЭБШХ-ийн 317-319 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон холбогдол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлээгүйд гомдолтой байна.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 211 дүгээр тогтоолд "Д.Гэ нь ..."Цэвэр агаар сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг хийхдээ албан үүрэгтээ хайнга хандаж, хийх ёстой ажил үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс "ШГЭБ" ХХК-ийн нэрээр "Цэвэр агаарын сан"-гаас удаа дараагийн гүйлгээгээр гарсан 2 тэрбум 726.500.000 төгрөгийн зөрчлийг илрүүлэлгүй

албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэргийг үйлдсэн..." гэж прокурорын яллах дүгнэлтийн тэмдэглэх болон тогтоох хэсэгт дурсныг тэр хэвээр нь хуулбарлан авч бичжээ. Гэтэл прокурорын яллах дүгнэлтээс шүүгдэгчийн өдүүлсэн гэмт үйл явдал, учруулсан хүнд хор уршигийг ялгаж зааглах боломжгүй байгааг шүүх хуралдаанд тайлбарласан боловч шүүх анхааралдаа авсангүй. Шүүхийн шийтгэх тогтоолд "Цэвэр агаарын сан"-гаас хууль бусаар гарсан 2 тэрбум 726.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй явдлыг шүүгдэгчийн учруулсан "хүнд хор уршиг" гэж дүгнэсэн мэт. Гэхдээ ийнхүү дүгнэхэд хүргэсэн үндэслэл, нотолгоог шүүхийн тогтоолд тодорхойлж дурдаагүй.

"Зөрчлийг илрүүлээгүй" явдал нь эд хөрөнгийн онц их хэмжээний хохирол учруулсан, эсхүл хүний амь нас хохирсон, албан байгууллагын хэвийн үйл ажиллагаа зогссон зэрэгтэй дүйцэх нийгмийн хор аюултай үр дагавар мөн үү? Миний үзэж буйгаар хууль бусаар гарсан 2 тэрбум 726.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй нь яагаад ч хүнд хор уршигт тооцогдохгүй. Учир нь албандаа хайнга хандсанаас үүдэх үр дагавар нь бодитой, материаллаг шинжтэй байж гэмээ нь нийгмийн хор аюулыг өөртөө агуулдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү үр дагавар нь төсөөлөл төдий бус, харин бодитой учирсан байх бөгөөд нийгэмдээ ихээхэн хор аюултай шинжийг давхар агуулсан байх ёстой.

...Монгол Улсын төсвийн тухай хууль тогтоомжид зааснаар санхүүгийн хөрөнгийг Монгол банкинд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдаж, төсвийн өдөр тутмын гүйлгээг хийж, төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж, төлбөрийн амлалтыг шалгаж бүртгэх чиг үүрэгтэй Сангийн яамны холбогдох албан тушаалтныг хариуцлагад татсангүй. Үүнд: Сангийн яамны төрийн сангийн төлбөр тооцооны мэргэжилтэн А.С нь "ШГЭБ" компанийн нэрээр 5 удаагийн 2 тэрбум 726.5 сая төгрөгийн гүйлгээг баталгаажуулан тэмдгээ дарж, төсвийн хөрөнгийг онц их хэмжээгээр ашиглан шамшигдуулах нөхцлийг бүрдүүлсэн гол гэм буруутан байж болохоор атал түүнийг энэ хэрэгт зөвхөн нэг удаа гэрчээр байцаасан байх ба 2011 оны 11 дүгээр оарын 07-ны өдөр холбогдох 201301000439 дугаартай хэргийг нь тусгаарлаж, улмаар түдгэлзүүлсэн байна.

...Д.Гэ нь албан үүрэгтээ хайнга хандсан гэм буруутай болохыг мөрдөн байцаалт болон шүүхийн шинэчилсэн байцаалтын явцад нотлох баримтаар хангалттай нотлогдоогүй гэж үзэж байна. ...мөрдөн байцаагч, прокурор, шүүх бусдыг гэмт хэрэг үйлдсэнд буруутгаж, яллаж, шийтгэхийн тулд наад зах нь дараах нөхцөл байдлыг шалгаж тодруулах ёстой байлаа. Үүнд:

МХЕГ-ын хяналт шалгалтын удирдамж төлөвлөгөөнд тусгасан шалгах зүйлийн хүрээ, хэмжээ, улсын байцаагч нар шалгалтын ажлыг хэрхэн, яаж зохион байгуулсан, шалгалт явуулах хугацаа хангалттай байсан эсэх, шалгалтын дүнг гаргах журам, шалгасан болон шалгуулсан байгууллагаас шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодруулах,

мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тодорхой бүрэн эрх, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, тэдгээрийн хэрэгжилтийг дүгнэх,

шүүгдэгчийн ажил хэргийн болон хувийн байдлыг тогтоох,

шинжээчийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах, хяналт шалгалтын талаарх хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам зааврын биелэлтийг улсын байцаагч нарын үүрэг гүйцэтгэлтэй нь харьцуулан дүн шинжилгээ хийх зэргээр мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааг явуулж байж албан үүрэгтээ хайнга хандсан гэм буруутай эсэх тухай дүгнэлтийг хийх. Гэтэл эдгээр асуудлыг огт шалгаагүй.

Яллаж буй хэргийн талаар үндэслэл бүхий тайлбар өгөх, хэрэгт ач холбогдол бүхий бусад асуудлыг шалгуулах, өмгөөлөгчийн туслалцаа авах боломжийг мөрдөн байцаалтын шатанд бүрэн олгоогүйд гомдолтой байна.

Хэрэгт авагдсан зарим нотлох баримт, шүүхийн шинэчилсэн байцаалтын шатанд тодруулахаар өмгөөлөгчийн хамт шүүхэд гаргаж өгсөн нэмэлт бичгийн нотлох баримтаар Д.Гэ нь албан үүрэгтээ хайнга хандаж байсан бус, харин ч албан үүрэгт ажлаа зохих ёсоор гүйцэтгэж байсныг хангалттай нотлож байгаа. Иймд хэргийг хянаж өгнө үү" гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан Б.Ат-гийн өмгөөлөгч С.Цэдэндамбын гомдолд: 1. Эрүүгийн хуулийн тусгай 272-р зүйлд албан тушаалтнаас албан үүрэгт ажилдаа хайнга хандах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлон заахдаа: 272-р зүйлийн

272.1-д Албан тушаалтан хууль, тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүйгээс бага бус хэмжээний хохирол учирсан байхыг тодорхой заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт: Энэ хэргийн улмаас хүнд хор хохирол учирсан бол хүндрүүлэн үзэж, ял оногдуулж байхыг заасан байна. Тэгвэл Б.Ат хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс болж, бага бус хэмжээний ч хохирол учраагүй, мөн энэ зүйлийн 2-д заасан хүнд хор хохирол ч учраагүй. Б.Ат-д холбогдуулан ял шийтгэл оногдуулаад байгаа Цэвэр агаар сангийн хоёр тэрбум гаруй төгрөгийн хохирол нь Б.Ат, Д.Гэ нарын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийхээс өмнө бусад шүүгдэгч нараас үйлдсэн гэмт хэргийн улмаас улсад учирчихсан хохирол шүү дээ.

Хэрвээ Б.Ат албан үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүйгээс болж, хүнд хор хохирол учруулчихсан бол мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс хохирол учруулсан гэж үзээд байгаа 2,260,000,000 төгрөгийг Б.Ат, Д.Гэ нараар төлүүлэхгүй яагаад өөр бусад шүүгдэгч нараар төлүүлээд байгаа юм бэ? Үүнээс үзэхэд л өөр бусад хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн хүнд хор хохирлыг Б.Ат-д холбогдуулан 2,260,000,000 төгрөгийн зөрчлийг илрүүлээгүй гэж үзэж ял шийтгэл оногдуулж байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 8-р зүйлийн 8.2-т заасан заалтыг зөрчиж байна.

Анхан болон давж заалдах шатны шүүх шинжээчийн дүгнэлтүүдийг бас л буруугаар эсрэг ойлгож, Б.Ат-г /Д.Гэ-ийг / ял шийтгэсэн.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230-р зүйлийн 230.1.1-д хэргийг буруу тусгаарласан бол урьдчилсан мөрдөн байцаалтад буцааж хэргийг дахин шалгуулах тухай хуулийн заалтыг анхан болон давж заалдах шатны шүүх зөрчсөн байх тул шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад буцааж өгөхийг хүсье. Хэрвээ энэ хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгож мөрдөн байцаалтад буцаадаггүй юм бол Б.Ат-д холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24-р зүйлийн 24.1.1-д заасныг үндэслэн хэрэгсэхгүй болгож өгөхийг хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнээс хүсэж байна." гэжээ.

Хяналтын шатны шүүхэд гаргасан ялтан

Х.Бо-гийн өмгөөлөгч Д.Даваагийн гомдолд: "...Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъект нь итгэмжлэгдэн хариуцсан этгээд буюу байгууллагаас өөрийн өмчийг хариуцуулахаар үүрэг хүлээлгэсэн, эсхүл хууль буюу гэрээнд зааснаар үүрэг хүлээсэн байхыг тайлбарладаг. Х.Бо ямар хууль, ямар гэрээгээр ямар байгууллагын эд хөрөнгийг хариуцаж ямар үүрэг хүлээж байсан болох нь нотлох баримтаар тогтоогдохгүй байна. ...Х.Бо компани байгуулах болон хуурамч гэрээ үйлдэх санаачилгыг огт гаргаагүй бусдын ятгаас түлхээсээр мөнгө дамжуулсан байхад гэмт үйлдлүүдэд буруутгаж байгаа нь үндэслэлгүй байна. Иймд Х.Бо-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүсье" гэжээ.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор А.Оюунгэрэлийн хэлсэн саналд:

"Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа 2012 онд 116 сая төгрөгийн сургалт зохион байгуулах нэрээр "ХБ" ХХК-ийн дансаар 21.440.000 төгрөгийг, ажлын хөлс нэрээр "ОСБ" ХХК-ийн дансаар 1.545.500 төгрөг, 2011 онд 240 сая төгрөгийг түлш нийлүүлэх гэрээ нэрээр "ШГД" компанийн дансаар гаргаж төсвийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулсан буюу албан тушаалын байдалдаа хайнга хандсан, төсвийн мөнгөнд тавих хяналтыг хууль ёсоор тавиагүй, мөнгө завшсан болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогдож байна. Төсвийн мөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Н.Хү зурах эрхтэй. Гэтэл Н.Хү хоосон бланкан дээр гарын үсэг зураад нягтландаа өгдөг байсан. Ялтны өмгөөлөгч нар нь Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.2, 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсгүүдэд зааснаар яллаж байгааг үндэслэлгүй гэж байгаа боловч төсвийн мөнгийг захиран зарцуулахад хяналт тавих ёстой хүн хяналтаа тавиагүйгээс улсад хохирол учруулсан. "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогч М.Ху ажиллаж байхдаа онц их хэмжээний мөнгийг ашигласан болох нь хавтаст хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон. Мөнгийг ашиглахдаа М.Ху нь Х.Бо, Д.Цэ нартай урьдчилан бүлэглэж үйлдсэн байдаг. М.Ху гэмт хэргийг үйлдэхдээ хуурамч компани, гэрээ байгуулж, хуурамч компанийнхаа дансаар мөнгийг гаргаж ашигласан болох нь нотлогдож, тогтоогдсон. Авсан мөнгөө

аяж зарцуулсан талаар мэдүүлдэг. Д.Цэ нь М.Ху-г "Цэвэр агаар сан"-д ажилд оруулсан. Хууль бус гүйлгээ хийхийг Д.Цэ анх санаачилсан гэж М.Ху мэдүүлдэг. Д.Цэ М.Ху-гаас 340 сая төгрөгийг зээлсэн гэдэг боловч ямар үндэслэлээр зээлсэн болох нь тодорхойгүй байдаг. Иймд Х.Бо, М.Ху, Д.Цэ нар Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар яллагдах бүрэн үндэслэлтэй байна. Б.Ат, Д.Гэ нар нь "Цэвэр агаар сан"-гийн тайланд шалгалт хийхдээ хайхрамжгүй хандаж, компанийн баримтыг гүйцэт шалгаагүйгээс эдгээр хүмүүсийн хууль бус гүйлгээгээ үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлсэн. Иймд Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж ял шийтгэл оногдуулсан үндэслэлтэй байна. Эх үүсвэрийн тогтоож чадаагүй учраас хайнга хандсан. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол алдаатай байсан учраас давж заалдах шатны шүүх засаж өөрчлөн ял шийтгэлийг бодитойгоор оногдуулсан бөгөөд Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэсэн үндэслэл тогтоогдоогүй тул давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх саналтай байна" гэв.

#### ХЯНАВАЛ:

**Нэг.** Ялтан Н.Хү нь М.Ху-тай бүлэглэж "ХБ" ХХК-ийн дансаар 116.000.000 төгрөг, "ОСБ" ХХК-ийн дансаар 21.440.000 төгрөг нийт 137.440.000 төгрөгийг гарган авч завшиж үрэгдүүлсэн гэмт хэрэг үйлдсэн бөгөөд уг мөнгөнөөс 49.000.000 төгрөгийг өөрөө завшсан,

Мөн Н.Хү нь "Цэвэр агаар сан"-гийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгт ажилдаа хайнга хандаж, тус сангийн нягтлан бодогч М.Ху-д өөрийн гарын үсгийг хоосон цагаан цаасан дээр зурж үлдээснээс, М.Ху нь уг гарын үсгийг ашиглан төлбөрийн хүсэлт үйлдэж, 5 удаагийн үйлдлээр 2.726.500.000 төгрөгийг "ШГЭБ" ХХК-ийн дансанд 2011-2012 онд шилжүүлэн бусадтай бүлэглэн завшиж үрэгдүүлсэн, үүний улмаас улсад хүнд хор уршиг учруулсан болох нь хэрэгт авагдаж, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал хууль ёсны ба үндэслэл бүхий болсон бөгөөд дээрх үйлдлүүдэд нь гэм буруутайд тооцож ял оногдуулсан нь

үндэслэлтэй болжээ.

Тэрчлэн, анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалснаар, Н.Хү-ийг М.Ху-тай бүлэглэж "Т" ХХК-ийн дансаар гаргасан 1.454.079.500 төгрөгөөс 1.308.671.550 төгрөгийг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар гаргасан 100.000.000 төгрөгөөс 90.000.000 төгрөгийг хувьдаа завшсан гэх гэмт хэрэг, мөн "ЭАИ" ХХК-ийн захирал М.Аб-ас 9.000.000 төгрөг, "ХТТ" ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Мө-аас 44.000.000 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэргээс 24.000.000 төгрөгийн хээл хахууль авсан гэх хэргүүдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д заасан үндэслэлээр улсын яллагч яллахаас татгалзсаныг анхан шатны шүүх хүлээн авч, эдгээр гэмт хэргээс Н.Хү-ийн үйлдэл, холбогдлыг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн нь хууль зөрчөөгүй байна.

Мөн прокурорын яллах дүгнэлтэд "ХТТ" ХХК-ийн захирал Т.Мө-ыг давтан үйлдлээр Б.Чи-ээр дамжуулан 44.000.000 төгрөгийг Н.Хү-д хахуульд өгсөн гэх үйлдлийн талаар хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлаад Т.Мө болон Б.Чи нарын хооронд зээлийн харилцаа үүссэн талаар нотлох баримт хэрэгт авагдсан байх бөгөөд 20.000.000 төгрөгийг хээл хахуульд өгсөн, авсан, зуучилсан үйл баримт нотлох баримтаар тогтоогдоогүй, уг үйл баримтыг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна.

Харин Н.Хү-ийг "Цэвэр агаар сан"-гийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа нэр бүхий компаниудын нэрээр төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж, 1.931.519.500 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирлыг улсад учруулсан гэмт хэрэг, мөн хуурамч баримт бичиг, тамга тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэн ашиглаж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутай гэж ял шийтгэл оногдуулсан анхан шатны шүүхийн энэ дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалд нийцээгүй, үндэслэлгүй байх бөгөөд үүнээс, хуурамч баримт бичиг үйлдсэн гэх хэргийн талаар давж заалдах шатны шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийж, хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэрэгсэхгүй болгосон нь зөв болжээ.

Анхан болон давж заалдах шатны шүүх аль аль нь Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн



тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2-т зааснаар "Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутай гэж дүгнэсэн нь үндэслэл бүхий болж чадаагүй байна.

Учир нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах үйлдлийн хэлбэрийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.1.1-ээс 273.1.6 хүртэл нэг бүрчлэн тодорхойлон хуульчилж эдгээр үйлдлийн үр дүнд хохирол учирсан байхыг шаардсан байдаг. Гэтэл Н.Хү-ийн үйлдэлд дээр дурдсан хэлбэрүүд тогтоогдохгүй байх тул Н.Хү-д холбогдох "Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж онц их хэмжээний хохирол учруулсан гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2-т зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр, 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн" хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзнэ.

Мөн түүнчлэн шүүхийн шийдвэрээр төлүүлэхээр тогтоосон хохирлын хэмжээ болон уг нөхцлийг хангах зорилгоор мөрдөн байцаагчийн тогтоолоор битүүмжлэгдээд буй хөрөнгийн үнэлгээний зохистой харьцааг харгалзан үзээд ялтан Н.Хү-ийн Баянгол дүүргийн ... дүгээр хороо .... тоот 3 өрөө орон сууцыг хохиролд тооцуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, түүний өмчлөлийн бусад орон сууцыг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

**Хоёр.** Ялтан М.Ху нь "Цэвэр агаар сан"-гийн нягтлан бодогчоор ажиллаж эхэлсэн үеэс тус сангаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг санхүүжүүлэх ёстой төсвийн хөрөнгийг онц их хэмжээгээр завших гэмт хэргийг санаачлан, энэхүү гэмт хэрэгтээ бусдыг татан оролцуулж, гэмт үйлдлүүдээ хэрэгжүүлэх арга замыг сэдэж төлөвлөн, тус сантай хууль ёсны дагуу гэрээ байгуулан ажиллаж байгаа аж ахуйн нэртэй ижил төсөөтэй, андуурагдахуйц нэр бүхий аж ахуйн нэгжүүдийг зориудаар санаачлан байгуулах, мөн өөрийн ахан дүүс, танил хүмүүсийн аж ахуйн нэгж байгууллагын нэр дээр хуурамч гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийн үнийн дүнг хуурамчаар ихэсгэх, санхүүгийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлэх зэрэг санхүүгийн луйврын олон тооны арга

хэрэглэн улсын төсвийн "Цэвэр агаар сан"-гийн/ хөрөнгөнөөс онц их хэмжээний хөрөнгө ашигласан хэрэгт холбогдон шалгагдаж, шүүхээр ял шийтгэгдсэн байна.

Анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалснаар, тэрчлэн улсын яллагчийн гаргасан санал дүгнэлтийн хүрээнд, М.Ху-г ганцаар болон бусадтай бүлэглэж, "ХБ", "ОСБ", "АЖ", "ШГЭБ", "ШГД", "ДЗТМ" гэх компаниудын нэрээр хуурамч гэрээ үйлдэж, мөн хууль ёсны гэрээтэй ажиллаж байсан "Т" ХХК-ны гэрээний гүйцэтгэлийг санаатайгаар ихэсгэн, улмаар холбогдох санхүүгийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх замаар, олон удаагийн үйлдлээр нийт 4.656.968.029 төгрөгийг гарган авч завшиж, үрэгдүүлсэн бөгөөд уг хөрөнгөнөөс 4.210.218.029 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ял оногдуулсан нь зөв болжээ.

М.Ху нь дээр дурдсан хэргүүдэд хамтран оролцсон болохоо хэргийн шалгалтын эхнээс хүлээн зөвшөөрч байсан хэдий ч, өөрийн оролцоо болон хувьдаа авч завшсан гэх мөнгөний дүн, мөн бусад шүүгдэгч нарын оролцоо, тэдний авч завшсан гэх мөнгөн дүнгийн талаарх түүний мэдүүлгүүд нь мөрдөн байцаалтын явцад болон шүүхийн хэлэлцүүлэгт хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар хир зэрэг няцаагдсан байдал, тэрээр хууль бус мөнгөн гүйлгээнүүдийг гардан гүйцэтгэж мөнгийг өөрөө хүлээн авч байсан нь нотлогдсон байдал, харин бусад шүүгдэгч, тухайлбал, Н.Хү, Д.Цэ болон Б.Чи нарт дамжуулан өгсөн гэдэг нь бусад нотлох баримтаар нотлогдохгүй байгаа зэргийг дүгнэн хэлэлцээд, М.Ху-гийн гэм буруу, хариуцах төлбөрийн талаар гаргасан анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байна.

Харин давж заалдах шатны шүүх, М.Ху-гийн үйлдсэн хэргүүдээс "Т" ХХК-ийн данснаас хууль бусаар гаргасан гэх 1.454.079.500 төгрөг, "ДЗТМ" ХХК-ийн дансаар хууль бусаар гаргасан гэх 90.000.000 төгрөгийг завшсан гэх үйлдэлд түүнийг яллагдагчаар татаагүй, түүнийг энэ талаар огт яллаагүй байсан хэмээн, уг үйлдлүүдийн талаарх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нь илтэд буруу, үндэслэлгүй дүгнэлт болжээ.

Учир нь мөрдөн байцаалтын шатанд сонсгосон ялыг өөрчлөх буюу нэмэлт оруулах тухай 2013 оны 10 дугаар сарын 25-

ны өдрийн мөрдөн байцаагчийн тогтоолоор М.Ху-г Н.Хү, Б.Чи нартай үгсэн тохиролцож "Т" ХХК-ийн нэрээр 1.454.079.500 төгрөг, "ДЗТМ" ХХК-ийн нэрээр 100.000.000 төгрөг..." завшин үрэгдүүлсэн, авч ашигласан хэрэгт холбогдуулан ял сонгосон байх бөгөөд уг тогтоолтой М.Ху танилцаж гарын үсэг зурсан, мөн ял өөрчлөн сонгосон тогтоолын дагуу байцаасан байцаалтад тэрээр Эрүүгийн хуулийн 150, 233 дугаар зүйлд заасан ял сонгосныг хүлээн зөвшөөрсөн байна.

Мөрдөн байцаалтын шатанд хийгдсэн шалгалт болон прокурорын яллах дүгнэлтээр нэр бүхий 2 компанийн нэрээр онц их хэмжээний мөнгө шилжүүлэн авч завшсан үйлдлийн хувьд М.Ху гүйлгээ бүрийг өөрөө гардан гүйцэтгэж, мөнгийг хүлээн авч байсан зэрэг уг үйлдэл дэх өөрийн оролцоог үгүйсгээгүй бөгөөд гагцхүү уг мөнгөнүүдийг Н.Хү-д дамжуулан өгсөн гэх түүний мэдүүлэг хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт, мөн анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр нотлогдохгүй байгааг үндэслэн улсын яллагчийн саналыг харгалзан, М.Ху-г уг гэмт хэргийг үйлдсэн гэж үзсэн анхан шатны шүүхийн дүгнэлт нь шүүх хэргийг шүүгдэгч нэг бүрээр, хэргийг бүхэлд нь хянаж шийдвэрлэвэл зохих хуулийн шаардлагад нийцсэн гэж үзнэ.

Давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлахдаа, хэргийн талаарх дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох нотлох баримтуудыг анхааран үзэлгүй орхигдуулснаар, дээрх үйлдлүүдэд зөв дүгнэлт хийж чадаагүй, улмаар дээрх нэр бүхий 2 компанийн нэрээр хууль бусаар хөрөнгө гарган завшсан гэх хэргийг тусад нь шалгуулахаар шийдвэрлэснийг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Түүнчлэн, давж заалдах шатны шүүхээс М.Ху-д 7 жил хорих ял оногдуулсан анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д зааснаар 2 жилийн хугацаагаар хойшлуулахаар шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн зорилтод нийцээгүй бөгөөд "ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна" хэмээн шударга ёсны зарчмыг тодорхойлсон Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлийн заалтыг

зөрчсөн байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн үзэв.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах харилцааг зохицуулсан Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйл нь заавал биелэгдэх императив шинжийг агуулсан зохицуулалт биш бөгөөд жирэмсэн байгаа гэсэн үндэслэлээр М.Ху-д оногдуулсан хорих ялыг хойшлуулсан нь шударга ёс, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон ял оногдуулах нийтлэг зарчимд нийцүүлэн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй өөрчилсөн шийдвэр болжээ.

М.Ху-гийн үйлдсэн гэмт хэрэг, гэм буруу, ял шийтгэлийн талаар хийсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт, хэрэгт авагдсан нотлох баримт зэргийг шинжлэн судлаад хяналтын шатны шүүхээс хийж буй дээрх үндэслэлүүдэд тулгуурлан шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан магадлалын 2 дахь заалтын ё, ж хэсгүүд болон 4 заалт нь үндэслэлгүй байх тул хүчингүй болгох нь зүйтэй гэж үзнэ.

**Гурав.** Ялтан Д.Цэ нь М.Ху, Х.Бо нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар сан"-аас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гарган авч завшсан гэмт хэрэгт хамтран оролцож, уг мөнгөнөөс 340.000.000 төгрөгийг авч хувьдаа завшсан болох нь хэрэгт авагдсан, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болсон бөгөөд дээрх үйлдэлд нь гэм буруутайд тооцож ял ногдуулсан нь зөв болжээ.

Харин Прокуророос Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар яллаж яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн, улмаар хоёр шатны шүүх "Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учруулсан гэм буруутайд тооцсон" нь үндэслэлгүй байна.

Албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэдгийг албан тушаалын эрх мэдэл болон албан тушаалын байдлаа албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж, хийвэл зохих ажил үүргээ биелүүлэхгүй байх, эсвэл

хийх ёсгүй ажил үүрэг гүйцэтгэхийг ойлгодог.

Мөн албан тушаалын гэмт хэргийн үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хуулийн тодорхой заалт зөрчсөн байдаг төдийгүй уг этгээдийн эрхэлж байгаа албан ажлын ашиг сонирхлын эсрэг чиглэгдсэн байдаг.

Гэтэл Д.Цэ нь Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга гэх албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, хийвэл зохих ажил үүргээ биелүүлээгүй, хийх ёсгүй ажил үүрэг гүйцэтгэсэн болох нь тогтоогдохгүй байх тул Д.Цэ-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилээр хасах нэмэгдэл ял хэрэглэн, 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн" анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт хэргийн бодит байдалд нийцээгүй, үндэслэлгүй болсон гэж үзээд уг хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

**Дөрөв.** Ялтан Х.Бо нь 2011 онд М.Ху, Д.Цэ нартай үгсэн тохиролцож "ШГЭБ" ХХК-ийг үүсгэн байгуулж уг компанийн нэрээр түлш нийлүүлэх хуурамч гэрээг үйлдэн "Цэвэр агаар сан"-гаас уг компанийн дансаар 2.726.500.000 төгрөгийг гарган авч завшсан гэмт хэрэгт хамтран оролцож, уг мөнгөнөөс 30.500.000 төгрөгийг хувьдаа авч завшсан болох нь хэрэгт авагдсан, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болжээ.

Анхан шатны шүүх Х.Бо-д холбогдох хэргээс "хуурамч бичиг баримтаар гэрээ байгуулан "Цэвэр агаар сан"-гаас "ШГЭБ" ХХК-ийн дансаар мөнгө шилжүүлж авсан гэмт үйлдлээ нуун далдлах зорилгоор, уг компанийг татан буулгах, татварын хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрүүлэхгүй байх зорилгоор Баянгол дүүргийн татварын байцаагч Ж.Сү-гээс мэдээлэл авахын тулд 1 сая төгрөгийн хахууль өгсөн" гэх хэргийг прокурор яллахаас татгалзсан үндэслэлээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлтэй байна.

**Тав.** Б.Чи-ийг дангаар "ПИ" ХХК-аас буцаагдсан 21.780.000 төгрөгийг хувьдаа завшиж, улсад их хэмжээний хохирол учруулсан гэх,

мөн Б.Да-ыг бусадтай үгсэн тохирч бүлэглэн, "ДЗТМ" ХХК-ийн дансаар 100.000.000 төгрөгийг шилжүүлэн авч, уг мөнгөнөөс 5.200.000 төгрөгийг хувьдаа завшсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай гэж үзэн, Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар ял шийтгэл оногдуулсан анхан шатны шүүхийн дүгнэлт нь үндэслэл бүхий болж чадаагүй гэж дүгнээд давж заалдах шатны шүүх өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн нь зөв болжээ.

Тодруулбал, давж заалдах шатны шүүх дээрх үйлдлүүдтэй холбоо бүхий хэрэгт авагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалснаар, шүүгдэгч нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн субъект биш байна гэж дүгнээд, улмаар "Бусдын бусад зорилгоор итгэмжлэн өгсөн эд хөрөнгийг завшсан" болох нь тогтоогдсон гэж тэдний үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 152 дугаар зүйлийн 152.1-т зааснаар зүйлчилж, уг гэмт хэргүүд нь хөнгөн гэмт хэргийн ангилалд багтах тул Б.Чи, Б.Да нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэснийг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна.

Мөн түүнчлэн анхан шатны шүүх Б.Чи-д холбогдох хэргээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 233 дугаар зүйлийн 233.2, 270 дугаар зүйлийн 270.1-т заасан гэх хэргийг прокурор яллахаас татгалзсан үндэслэлээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосон нь хууль зөрчөөгүй байна.

**Зургаа.** М.Аб-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.2-т заасан, Т.Мө-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.3-т заасан, Ж.Сү-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан хэргүүдэд холбогдох нотлох баримтыг шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалснаар, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1-д заасан үндэслэлээр улсын яллагч яллахаас татгалзсаныг анхан шатны шүүх хүлээн авч, дээрх нэр бүхий хүмүүст холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зөрчөөгүй байна.

Харин анхан шатны шүүх ийнхүү шийдвэрлэхдээ шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1" дэх заалтыг баримтлаагүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.4-т

зааснаар М.Аб, Т.Мө, Ж.Сү нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаагүй орхигдуулсан байсныг давж заалдах шатны шүүх зөвтгөн дүгнэж зохих өөрчлөлтийг оруулсан нь үндэслэл бүхий болжээ.

**Долоо.** Б.Ат, Д.Гэ нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллаж яллах дүгнэлт үйлдэн, шүүх "Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учирсан гэм буруутайд тооцсон", улмаар ял шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй байна.

Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэргийн албаны үүргээ биелүүлээгүй гэдэгт өөрийн хийх ёстой ажил үүргийг цаг хугацаанд нь хийхгүй орхих, залхуурах зэрэг хайнга хандсан бусад эс үйлдэхгүйг, харин албан үүргээ зохих ёсоор нь биелүүлээгүй гэдэгт албан тушаалтанд хуулиар болон түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон үүргээ биелүүлэхдээ хагас дутуу биелүүлэх, оромдох, дүр эсгэх, чанаргүй гүйцэтгэх зэрэг хайнга хандсан эс үйлдэхгүйг тус тус хамруулан ойлгодог.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан "хүнд хор уршиг учирсан" гэдэгт бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан, амь нас хохирсон, их буюу онц их хэмжээний хохирол учирсан, албан газар, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаа тасалдсан, зогссон зэрэг ноцтой үр дагавар бий болсон байхаар ойлгодог.

Гэтэл хэрэгт авагдсан баримтуудаас харахад Б.Ат, Д.Гэ нар нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналтын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа 2012 оны 02 дугаар сард Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны "Цэвэр агаар сан"-гийн 2011 оны санхүүгийн баримтад санхүүгийн хяналт шалгалтыг хийсэнтэй холбоотойгоор ямар хүнд хор уршиг учирсан талаар ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл дурдагдаагүй байх бөгөөд анхан шатны шүүх "ШГЭБ" ХХК-ийн нэрээр М.Ху нарын авч завшсан нийт мөнгөн дүнг хийсэн гүйлгээг илрүүлээгүй хайнга хандсан гэж дүгнэсэн байхад давж заалдах шатны шүүх тус компанийн нэрээр 2011 онд шилжүүлж авсан мөнгөн дүнг илрүүлээгүйн улмаас 2012 онд 466.500.000 сая төгрөгийг шилжүүлэн завшсан гэж зөрүүтэй дүгнэсэн эдгээр дүгнэлт нь хэргийн бодит байдалд нийцээгүй,

үндэслэлгүй болсон байна.

Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандаж байгаа эс үйлдэхүй, үүнээс үүдэх үр дагавар нь тодорхой чиг үүргээ хууль, дүрэмд заасан ёсоор хэрэгжүүлээгүйн улмаас үүсэх бодит хор уршиг, хохиролтой шууд шалтгаант холбоотой байвал тухайн албан тушаалтан хариуцлага хүлээх үндэслэл үүснэ.

Гэтэл Б.Ат, Д.Гэ нар нь "Цэвэр агаар сан"-гийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх явцдаа албан үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж ажилласан, харин М.Ху нарын урьдаас төлөвлөн, гэмт хэрэг үйлдэхийн тулд зориудаар аливаа хяналт шалгалтыг төөрөлдүүлэх зорилгоор үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийг, "ШГЭ" ХХК-ийн нэртэй андууран нэг аж ахуйн нэгж хэмээн шалгалт хийсэн гэдгээ мэдүүлдэг бөгөөд хэдийгээр нэр андуурагдсан боловч бодит байдал дээр "ШГЭ" ХХК болон "ШГЭБ" ХХК-ийн нэрээр хийгдсэн гүйлгээ бүрийг хянан, эрх хэмжээний хүрээнд гүйцэтгэлээр баталгаажаагүй санхүүгийн хувьд зөрчил байгааг илрүүлэн улмаар зөрчлийг арилгуулахаар шаардлагыг шалгалтын явцад тавьж ажилласан талаараа тогтвортой мэдүүлж ирсэн байна. Тухайн үед, М.Ху нь нягтлан бодогчийн үндсэн чиг үүргийн хүрээнд "Цэвэр агаар сан"-гийн санхүүгийн үйл ажиллагааг тайлагнан шалгуулж байсан байх бөгөөд, "ШГЭБ" ХХК-ийн нэрээр түүний бусадтай авч завшсан гүйлгээнүүд шалгалтаар санхүүгийн зөрчил, дутагдал болж илрэхээр нь 1.980.000.000 төгрөг буцаан төвлөрүүлж байгаа гэх гүйлгээг зохион байгуулан хийж, төлбөрийн баримтыг шалгалт хийж байгаа Б.Ат, Д.Гэ нарт танилцуулан, тэдэнд гүйцэтгэл хийгээгүй зөрчилтэй гүйлгээний зөрчлийг арилсан хэмээн итгүүлж, улмаар дээрх байдлаар шалгалтын тайланд тусгагджээ.

Энэ нөхцөл байдлыг М.Ху болон Х.Бо нар гэрчилж мэдүүлсэн байх бөгөөд тухайн үед бодитой төөрөгдөх нөхцөл байдал бүрдүүлсэн байхад аж ахуйн нэгжийн нэрийг андуурсан хэдий боловч нэр бүхий 2 компанийн нэрээр хийгдсэн гүйлгээг хянан зохих дүгнэлт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах шаардлага, акт гаргаж ажилласан Б.Ат, Д.Гэ нарыг албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй гэж буруутгах, нөгөөтэйгүүр бусдын эд хөрөнгө завшсан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хяналт шалгалт хийсэн хүмүүсийн үйлдлээс учирсан хор уршиг гэж тодорхойлох, эсхүл урдаас сайтар

төлөвлөн зохион байгуулсан санхүүгийн луйврын шинжтэй гэмт хэрэг үйлдэгдсэн байгааг илрүүлээгүй нь гэмт хэрэг болно гэх мэтээр дүгнэх боломжгүй байна.

Дээрх байдлаас үндэслэн Б.Ат, Д.Гэ нарт холбогдох "Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандсаны улмаас хүнд хор уршиг учирсан гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар төрийн албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах нэмэгдэл ял хэрэглэхгүйгээр тус бүр 1 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн" хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

"Цэвэр агаар санг"-ийн өмч хөрөнгийг онц их хэмжээгээр завшиж үрэгдүүлсэн болон бусад гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, прокурорын яллах дүгнэлтээр шүүхэд шилжүүлсэн нэр бүхий 11 хүн тус бүрийн холбогдсон гэмт хэрэг, гэм буруу, ял шийтгэлийн талаар хийсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт, хэрэгт авагдсан нотлох баримт зэргийг шинжлэн судлаад хяналтын шатны шүүхээс хийж буй дээрх үндэслэлүүдийг нэгтгэн дүгнэж үзвэл, Н.Хү, М.Ху, Д.Цэ, Х.Бо, Б.Чи, Б.Да нарын үйлдсэн гэмт хэрэг мөрдөн байцаалтын шатанд хэрэгт авагдаж, шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон байх бөгөөд тэднийг гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй байна.

Прокурорын яллах дүгнэлтэд дурдсан болон хоёр шатны шүүхээс шүүгдэгч нарын гэм буруу, үйлдсэн хэргийн зүйлчлэлийн талаар хийсэн дүгнэлтүүд, тэдгээрт орж байгаа өөрчлөлтүүд, мөн гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон хүмүүсийн оролцоо, гүйцэтгэсэн чиг үүрэг, учруулсан хохирлын хэр хэмжээ зэрэг нь тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагад нийцсэн байх хуулийн шаардлагыг харгалзан, Н.Хү, Д.Цэ нарт оногдуулсан хорих ялыг зохих хэмжээгээр хөнгөрүүлэн өөрчлөх боломжтой гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Түүнчлэн, Н.Хү-ийн хувийн байдал, хэрэгт оролцсон оролцоо, анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлж байгаа нөхцөл байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.10-т зааснаар түүний ял эдлэх дэглэмийг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр шийтгэх тогтоолд

өөрчлөлт оруулсан давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзлээ.

Ялтан Д.Цэ мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас учруулсан хохиролд тооцуулахаар 10.000.000 төгрөг төлснийг шийтгэх тогтоол магадлалд дурдаагүй орхигдуулсан байгааг үүгээр тэмдэглэж байна.

Эдгээр дээр дурдсан үндэслэлүүдэд тулгуурлан ялтан Н.Хү, түүний өмгөөлөгч Х.Базаррагчаа, Д.Нямдорж, М.Баасанбат, Г.Оюунцэцэг нарын "Н.Хү-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар ял халдаасан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх,

ялтан М.Ху, түүний өмгөөлөгч Р.Мэндсайхан, Б.Оюунбилэг, Ц.Итгэл нарын "М.Ху-гаас хохирлыг гаргуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй тул хэрэгсэхгүй болгох, автомашинуудыг хурааж, улсын орлого болгосныг хүчингүй болгож өгнө үү" гэх,

ялтан Д.Цэ, түүний өмгөөлөгч М.Алтанцэцэг, Д.Гансүх нарын "Д.Цэ-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 233 дугаар зүйлийн 233.2-т зааснаар ял халдаасан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх

ялтан Х.Бо-гийн өмгөөлөгч Д.Даваагийн "Х.Бо-гийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ял халдаасан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү" гэх гомдлуудыг хүлээн авах хууль зүйн үндэслэлгүй байх тул хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.2-т заасныг удирдлага болгон хяналтын шатны шүүх хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 211 дүгээр шийтгэх тогтоолд:

А. Шийтгэх тогтоолын 1 дэх заалтанд "...Б овогт Н.Хү-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2-т заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг, Д.Цэ-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг, Х овогт Б.Ат-д холбогдуулан Эрүүгийн хуулийн

тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг, Д.Гэ-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, Х овогт Б.Ат, Д.Гэ нарыг цагаатгасугай." гэсэн нэмэлт оруулж,

Б.Шийтгэх тогтоолын бусад заалт дахь Х овогт Б.Ат, Д.Гэ нарт холбогдох заалтуудыг хүчингүй болгох, мөн шийтгэх тогтоолын 2, 3, 4 дэх заалтуудын "...Б овогт Н.Хү-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 273 дугаар зүйлийн 273.2 дахь хэсэгт зааснаар, Б овогт Д.Ц-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар..." гэм буруутайд тооцсон, ял шийтгэсэн заалтуудыг тус тус хүчингүй болгож,

В. Шийтгэх тогтоолын 3 дахь заалтын "...Б овогт Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 8 жилийн хугацаагаар хорих ялаар,..." гэснийг "...Б овогт Н.Хү-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэн, 7 жилийн хугацаагаар хорих ялаар..." гэж,

Г. Шийтгэх тогтоолын 4 дэх заалтын "... Н.Хү-ийн ...биечлэн эдлэх хорих

ялыг 5.000.000 төгрөг хурааж 8 жилийн хугацаагаар хорих ялаар,..." гэснийг "...Н.Хү-ийн ...биечлэн эдлэх хорих ялыг 5.000.000 төгрөг хурааж 7 жилийн хугацаагаар хорих ялаар,..." гэж,

Д. Шийтгэх тогтоолын 11 дэх заалтанд ялтан Н.Хү-ийн Баянгол дүүргийн ...дүгээр хороо ...тоот 3 өрөө орон сууцыг хохиролд тооцуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, түүний өмчлөлийн бусад орон сууцыг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгосугай" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр магадлалд:

А. Магадлалын 2 дахь заалтын 2Е, 2Ж хэсгүүд болон 4 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгосугай.

Б. Магадлалын 2 дахь заалтын 2Г хэсгийн "Д.Цэ-д... түүний биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 жилийн хугацаагаар хорих ялаар..." гэснийг Д.Цэ-д... түүний биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар..." гэж тус тус өөрчилсүгэй.

3. Шийтгэх тогтоол, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээж, ялтан болон ялтнуудын өмгөөлөгч нарын хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлуудыг хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН  
ШҮҮГЧ

С.НЯМЖАВ  
Д.ЭРДЭНЭБАЛСҮРЭН

**ЦАГААТГАХ ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 1169

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС**

Дүүргийн эрүүгийн хэргийн 1 дүгээр шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Ш.Төгсгэрэл даргалж хийсэн хуралдаанд:

Нарийн бичгийн дарга Б.Тунамал,

Улсын яллагч А.Дэлгэрмөнх,

Шүүгдэгчийн өмгөөлөгч Н.Мандах / үнэмлэх 0-654/ нарыг оролцуулав.

Тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар Дүүргийн нэгдүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн С.Д-д холбогдох 201425000113. тоот хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн аваад 2014 оны 10 сарын 06-ны өдөр яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн хэргийг хянан хэлэлцэв.

Шүүгдэгчийн биеийн байцаалт:

Монгол Улсын иргэн, ...оны ...сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, ам бүл ..., эхнэр С.М FM радиод менежер ажилтай, ...насны ...хүүхдийнхээ хамт ...дүүргийн ...хороо ...байрны ...тоотод оршин суух, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга ажилтай байсан, одоо халагдсан эрхэлсэн ажилгүй, ял шийтгэлгүй /хх 4-67/, Б овогт С.Д, регистр: УШ..... /хх 4-84/

Прокуророос үйлдэж ирүүлсэн яллах дүгнэлтээр:

Яллагдагч С.Д нь 2013 оны 03 сарын 02-ны өдөр баталсан 02-02/49 дугаартай удирдамжийн дагуу улсын байцаагч М.М-ийн “Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц сан болон тусгай сангийн 2012 оны санхүү аж ахуйн үйл ажиллагааг шалгаж” шалгалтын дүнг дэд даргын зөвлөлийн хурлаар 2013 оны 06 сарын 11-ний өдөр хэлэлцүүлж Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газарт 26.000.000 төгрөг, Засаг даргын нөөц санд 35.500.000 төгрөг нийт 61.500.000 төгрөгийн төлбөр барагдуулах актуудыг эцэслэн шийдвэрлэлгүйгээр нээлттэй орхисныг 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр дэд даргын зөвлөлийн хурал болсон мэтээр тэмдэглэл үйлдэж, Нийслэлийн Мэргэжлийн

хяналтын газрын даргын 2013 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 335 дугаар тушаалаар батлагдсан дэд даргын зөвлөлийн хурлын гишүүдийг оролцуулалгүйгээр өөрт үл хамаарах хэлтсийн улсын байцаагчийн актыг хүчингүй болгох /улсын мөнгө хууль бусаар зарцуулсан албан тушаалтнуудын шийдвэрийг хэвээр үлдээж/ шийдвэрийг бие даан гаргаж албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлсний улмаас улсад 61.500.000 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

**ТОДОРХОЙЛБОЛ:**

201425000113 тоот хэргээс

- Хохирогч А.Д-ийн мэдүүлэг /хх 4-116/
- Гэрч М.М-ийн мэдүүлэг /хх 4-7-9/
- Гэрч Г.У-ын мэдүүлэг /хх 4-157-160/
- Гэрч Т.Э-ийн мэдүүлэг /хх 4-55-56/
- Гэрч М.Н-ийн мэдүүлэг /хх 4-142-145/
- С.Д-г сэжигтнээр 2014.05.27-ны өдөр /хх 4-60-62/ яллагдагчаар 2014.05.28-ны өдөр /хх 64-66/ байцаасан тэмдэглэл зэрэг болно.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч С.Д мэдүүлэхдээ:

Би Сүхбаатар дүүргээс орж ирсэн акттай танилцсан. Сүхбаатар дүүргийн Засаг дарга болон Тамгын газраас 6 хүний нийгмийн асуудлыг шийдвэрлэж 61.500.000 төгрөгийг олгосон байсныг хууль ёсны гэж үзсэн. Тухайн үед гаргасан захирамж, тушаалд зааснаар Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд зааснаар тусламжийг олгосон байсан. 2010 оны 04 сарын 9-ний өдөр Нөөц санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг баталсан байсан. Энэ журмын 2.8-д зааснаар “мэргэжил дээшлүүлэх, давтан сургалт, нийгмийн асуудал” шийдвэрлэхэд зарцуулна гэсэн байна. Бас дотоод журмын 9.18-р зүйлд зааснаар, мөн Төрийн албаны хуулийн 27.1-д заасныг үндэслэн ажилтандаа орон байртай болоход нь дэмжлэг тусламж үзүүлсэн байгаа нь холбогдох хуулийн заалтыг зөрчөөгүй байна гэж үзсэн. Манай байцаагч М.М акт тогтоохдоо төсвийн хөрөнгөөс тусламж авсан хүмүүс 1-14

хоногийн дотор ажлаасаа халагдсан гэсэн байсан. Гэтэл энэ хүмүүс сургалтад явсан цаашид төрийн албанд ажиллахаар нөөцөд бүртгэгдсэн байсан. Манай байцаагч төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах хүнд олгох ёстой гэж үзсэн. Бас ажил албан тушаал худалдаж авсан гэснийг үндэслэлгүй гэж үзээд актыг хүчингүй болгож төлбөрөөс чөлөөлсөн. Энд эрх мэдлээ хэтрүүлсэн явдал байхгүй. Хэрэв намайг эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзвэл миний энэ шийдвэрийг хүчингүй болгох ёстой. Гэтэл миний гаргасан эрхийн акт одоо болтол хүчинтэй хэвээр байгаа. УЕПГ, МХЕГ-ын даргын хамтарсан А/33/330 тоот тушаалаар баталсан журмын 3.5-р зүйлд зааснаар улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг бүрэн хэмжээгээр болон хэсэгчилсэн хэмжээгээр Мэргэжлийн хяналтын газрын дарга буюу ерөнхий байцаагч хүчингүй болгох эрхтэй юм. Мөн ажлын хэсэг гаргаж шалгаад шийдвэрлэж болно. Гэтэл энэ миний гаргасан эрхийн актыг одоо болтол буруу эсвэл зөв гэж нотлоогүй байгаа. Ер нь хуулинд МХЕГ-ын дэд даргын хурлаар хэлэлцэнэ гэсэн заалт байхгүй. Зөвхөн шалгасан ажлынхаа шалгалтын дүнг хэлэлцдэг. Үүнийг зохицуулсан тодорхой журам байхгүй. Газрын дарга, дэд дарга актад үнэлэлт өгөхөд туслах зорилготой юм. Улсын байцаагчийн гаргасан эрхийн актыг дээд шатны албан тушаалтан хянах эрхтэй. Заавал зөвлөлөөр шийдэх шаардлагагүй. Би тухайн үедээ өөрөө шийдвэрлэх эрхтэй байсан. Миний энэ эрх ажлаас халагдсан үед дуусгавар болсон гэж үзэж байна. Би энэ эрхээ хэрэгжүүлж болох байсан. Гэхдээ өмнө нь зөвлөлийн хурлаар хэлэлцээд шийдвэрлэлгүй нээлттэй орхисон учир үргэлжлүүлж протокол үйлдэж шийдвэрлэсэн. Энэ нь миний алдаа болсон. Энд миний хувийн сонирхол байгаагүй. Мэргэжлийн хяналтын газар хууль сахиулах эрхээ хэрэгжүүлэхдээ хууль зөрчихгүй байх ёстой гэж үзэж байна. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас 2013 оны 10-р сард ирсэн бичигтэй байцаагч М.М танилцсан. Энэ бичгийг бүртгэлд авсан эсэхийг мэдэхгүй байна. Энэ асуудлыг өргөдөл гомдол шийдвэрлэх хугацаандаа шийдвэрлээгүй нь түр хаагаад дараа нь сэргээж шийдвэрлэсэн. Би энэ салбарыг хариуцаж байсан. Дүүргийн шалгалтын дүнг 2013 оны 06 дугаар сард хурлаар хэлэлцэж байсан. Сүхбаатар дүүргээс актыг хянаж үзээч гэсэн хүсэлт тавихад

судална гэж хэлсэн. 2013 оны 8-р сард бүтэц өөрчлөгдсөн. Ажил үүргийн хувиар өөрчлөгдсөн боловч өмнөх хяналтаа өөрсдөө хариуцаж шийдвэрлэж дуусга гэсэн учир шийдвэрлэсэн. Энэ үүргийг дарга М.Н өгсөн. Би тэр үед санхүүгийн ахлах байцаагчийн эрхтэй байсан. Би хурал хийгээгүй боловч хурлын тэмдэглэл үйлдэж шийдвэрлэсэн нь үнэн. Би өөрөө ахлах байцаагч учир ганцаараа бие дааж шийдвэр гаргах эрхтэй байсан. Үүнийгээ ашиглах боломжтой байсан. Ингэж шийдвэрлээгүй нь миний буруу. Би санхүүгийн ахлах байцаагчийн эрхээ 2012 оны 02-р сард авсан. Энэ эрх намайг ажлаас халагдсан үед дуусгавар болсон.

1-рт Би МХЕГ-ын дэд даргын албан тушаалд ажиллаж байсан албаны эрх мэдлээ хэтрүүлээгүй. 2-рт Би санхүүгийн ахлах байцаагч байсан. 3-рт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10-р зүйлд заасан санхүүгийн ахлах байцаагчийн эрхтэй байсан. 4-рт Улсын байцаагч М.М-ийн тавьсан актанд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас гомдол гаргасан. Энэ асуудлыг шийдвэрлэх эрх нь надад байсан. Одоо миний гаргасан шийдвэрийг хүчингүй болгоогүй хэвээр байгаа учир би эрх мэдлээ хэтрүүлээгүй гэж үзэж байна. Ийм учраас надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэсэн мэдүүлгээр,

Хохирогч А.Д мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ:

Хууль худалдан авах ажиллагааны бодлогын газрын мэргэжилтэн. Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Д 2013 оны 06 сард шалгалтын дүнг хэлэлцэж дээрх 61.500.000 төгрөгийн төлбөр барагдуулах актыг эцэслэн шийдвэрлэлгүйгээр нээлттэй орхисон боловч 2013 оны 12 сарын сүүлчээр 61.500.000 төгрөгийн актыг улсын төсөвт төлөлгүйгээр төлбөрөөс чөлөөлсөн байгаа нь хууль зөрчсөн үйлдэл гэж үзэж 61.500.000 төгрөгийг төлүүлэн улсыг хохиролгүй болгуулмаар байна. /хх 4-116/ Шүүх хурлыг намайг оролцуулалгүйгээр хийж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдээс төрд учирсан хохирлыг барагдуулж өгнө үү /хх 4-234/ гэсэн мэдүүлгээр,

Шүүгдэгч С.Д нь Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт дэд дарга ажилтай байхдаа 2013 оны 03 сарын 20-ны өдөр батлагдсан 02-02/49 дугаартай удирдамжийн дагуу улсын байцаагч М.М-ийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын нөөц сан болон тусгай



сангийн 2012 оны санхүү аж ахуйн үйл ажиллагааг шалгаж шалгалтын дүнг 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн дэд даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 26.000.000 төгрөг, Засаг даргын нөөц санд 35.500.000 төгрөг нийт 61.500.000 төгрөгийн төлбөр барагдуулах актуудыг эцэслэн шийдвэрлэлгүйгээр нээлттэй орхисон байна. Энэ актуудыг нээлттэй орхисон шалтгаан нь уг актыг хүлээн зөвшөөрөхгүй /тайлбартай/ гэж шалгалтын актан дээр шалгуулагч байгууллага бичсэн сүүлд нь гомдол гаргасан байна.

2013 оны 10 сарын 24-ний өдрийн Сүхбаатар дүүргийн 3/8500 тоот “Шалгалтын актын дүнгээс чөлөөлөх тухай” гэсэн албан бичгээр /хх 1-103/ жолооч Г.Э-д олгосон 3.000.000 төгрөг, Засаг даргын туслах Б-д олгосон 3.000.000 төгрөг, СТСХ-ийн дарга Б.Бс-д олгосон 20.000.000 төгрөг зэрэг нийт 26.000.000 төгрөгийг шалгалтын актын дүнгээс чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч М.М танаа гэж хаяглан ирүүлсэн байна.

2013 оны 10 сарын 24-ний өдрийн Сүхбаатар дүүргийн 3/8501 тоот “Шалгалтын актын дүнгээс чөлөөлөх тухай” гэсэн албан бичгээр /хх 1-104/ ЗДТГ-ын дарга Б.М-д 8.500.000 төгрөг, Засаг даргын орон тооны зөвлөх ЭЦ-д олгосон 5.000.000 төгрөг, жолооч Г.Э-д олгосон 2.000.000 төгрөг зэрэг нийт 35.500.000 төгрөгийг шалгалтын актын дүнгээс чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч М.М танаа гэж хаяглан ирүүлсэн байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд Төрийн албаны хуульд зааснаар төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, тодорхой хугацаагаар ажилласан боловч цаашид суралцаж мэдлэг боловсролоо дээшлүүлэн, өөр ажилд дэвшин одоог хүртэл ажиллаж байгаа хүмүүсийнхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон сурч боловсроход нь зориулж зохиох хэмжээний /2.000.000 төгрөгөөс 28.500.000 төгрөгийн/ мөнгөн тусламж үзүүлсэн байна. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч М.М тусламж авсан хүмүүс ажлаасаа халагдсан. Тодруулж хэлэхэд төсвийн хөрөнгөөр албан тушаал худалдаж авсан байна гэж үзээд олгосон мөнгийг

төлүүлэх тухай акт тогтоосон байна.

Энэ актыг тухайн үед Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Д нь 2012 оны 09 сарын 27-ны өдрийн Улсын ерөнхий прокурорын газар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хамтарсан А/34/303 тооттушаалаар батлагдсан журмын 3.3, 3.4 дэх хэсэгт зааснаар “газрын дарга, дэд дарга, хэлтсийн дарга нар” ахлах байцаагчийн эрхтэй байсан учир улсын байцаагчийн дээрх мөнгийг төлүүлэх тухай актыг хүчингүй болгож шийдвэрлэснийг эрх мэдлээ хэтрүүлсэн байна гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй гэж шүүх дүгнэлээ.

Хавтас хэрэгт Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Д-ийн гаргасан дээрх шийдвэр хэвээр хүчин төгөлдөр байгаа бөгөөд хэрэв энэ шийдвэрийг хууль зөрчсөн гэж үзсэн бол эрх бүхий албан тушаалтан эсвэл дээд шатны байгууллага нь хүчингүй болгосон байх шаардлагатай юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг нь өөрт нь хуулиар олгогдоогүй эрх мэдэл эдэлсэн эсвэл өөрт нь олгогдсон эрх хэмжээгээ илтэд хэтрүүлэн дур зоргоороо авирласан байх тухай ойлголт бөгөөд шүүгдэгч С.Д-ийн үйлдэлд энэ шинж байхгүй байна гэж шүүх үзэв.

Шүүхээс шүүгдэгч С.Д-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт заасан онц их хэмжээний хохирлыг шүүгдэгч С.Д-ийн буруутай үйл ажиллагаатай шууд шалтгаант холбоотой гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй байна.

Учир нь шүүгдэгч С.Д тусламж авсан хүмүүст өгсөн мөнгийг төлүүлэх тухай актыг хүчингүй болгох шийдвэр гаргасан бөгөөд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас нэр бүхий 6 хүнд 61.500.000 төгрөгийг олгосноор улсад 61.500.000 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол нь улсын байцаагч М.М акт тогтоохоос ч өмнө нь бодит байдлаар учирсан байна.

Улсын байцаагч М.М-ийн тогтоосон актыг 2013 оын 06 сарын 11-ний өдрийн Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын зөвлөлийн хурлаас эцэслэн шийдвэрлэлгүй нээлттэй орхисныг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 3/8500, 3/8501 тоот албан бичгүүдээр гаргасан гомдлыг үндэслэн шийдвэрлэснийг дэд дарга албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзэх боломжгүй байна.

Шүүгдэгч С.Д-ийн холбогдсон гэмт хэрэг шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч С.Д-ийн мэдүүлсэн мэдүүлэг, хохирогч А.Д-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн /хх 4-116/ мэдүүлэг,

Гэрч Г.У-ын мэдүүлсэн Улсын байцаагчийн үйлдэж байгаа акт, албан шаардлага дүгнэлтийг хүчингүй болгох эрх нь Улсын ахлах байцаагч, улсын ахлах байцаагчийн үйлдэж байгаа баримт бичгийг бол Улсын ерөнхий байцаагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох эрхтэй байхаар төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10-р зүйлийн 10.12.6-д зааж өгсөн байдаг гэсэн /хх 4-157-160/ мэдүүлгээр С.Д-д эрх мэдэл байсан болохыг, Гэрч Т.Э-ийн мөрдөн байцаалтад мэдүүлсэн "...Эрх зүйн хэлтэс улсын байцаагчийн актыг судалж үзсэн. Мөн Сүхбаатар дүүргийн удирдлага ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор олгосон тэтгэмж нь хуулийн хүрээнд явагдсан байна гэж үзээд дэд дарга С.Д-д эрх зүйн талаас нь зөвлөгөө өгсөн юм шиг байна лээ. Үүний дагуу 61.500.000 төгрөгийг чөлөөлсөн байсан" гэсэн /хх 4-55-56/ мэдүүлгээр С.Д-ийн гаргасан шийдвэр үндэслэлтэй болохыг, гэрч М.Н-ийн "... миний санаж байгаагаар УЕПГ, МХЕГ-ын дарга нарын хамтарсан тушаал байдаг. Тэр тушаалд улсын ахлах байцаагч, бүсийн ахлах байцаагч нь улсын байцаагчийн гаргасан захиргааны акт, шийдвэрийг хянаж уг шийдвэр, актыг бүхэлд нь эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох, хэвээр үлдээх эрхтэй байхаар зааж өгсөн байдаг. Мөн улсын ахлах байцаагч, бүсийн байцаагч нь тухайн хяналтын газрын дарга, дэд дарга, хэлтсийн дарга байна гэж заасан. ...Намайг анх ажилд ороход өргөдөл гомдол хүлээн авсан ямар ч албан тушаалтан тухайн асуудлыг өөрөө эцэслэн шийдвэрлэж дуусгах ёстой гэсэн практик тогтчихсон байсан. Шалгаж эхлээгүй тохиолдолд бусдад шилжүүлж болно" гэсэн /

хх 4-142-145/ мэдүүлгээр 2013 оны 06-р сард шийдвэрлэж чадаагүй нээлттэй орхисон асуудлаа үргэлжлүүлэн шийдвэрлэсэн болох нь нотлогдож байна.

Ийм учраас шүүх прокуророос С.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэрэгсэхгүй болгож цагаатгах хууль зүйн үндэслэлтэй байна гэж дүгнэлээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 284, 286, 293, 297, 298 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ :

1. Прокуророос С.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан хэрэгсэхгүй болгож цагаатгасугай.

2. Энэ хэрэгт хураагдсан эд мөрийн баримтгүй, шүүгдэгч С.Д-д төлөх төлбөргүй, цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдсугай.

3. Шүүгдэгч С.Д-д авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосугай.

4. Цагаатгах тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд эс зөвшөөрвөл тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах буюу улсын яллагч эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

5. Цагаатгах тогтоол нь эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 301 дүгээр зүйлийн 301.1.1-д зааснаар давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй тохиолдолд тогтоол хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Ш.ТӨГСГЭРЭЛ

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 863

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Ч.Отгонбаяр даргалж, шүүгч Б.Мөнхбаяр, Б.Мөнх-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй,

иргэдийн төлөөлөгчид: Б.Норовсүрэн, Р.Оюун,

нарийн бичгийн дарга: Б.Наранцацралт, улсын яллагч: Д.Үүлэн, Ш.Баярбилэг,

шүүгдэгч нарын өмгөөлөгчид: Ц.Нямдорж, Ч.Шаравнямбуу, Б.Баясгалан, Р.Дашням, Р.Пүрэвхам, Ж.Энхчулуун,

Хохирогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Б.А, Ч.М,

Хохирогчийн өмгөөлөгч: А.Нарантуяа нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5, 35.3 дахь хэсэг, мөн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, мөн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт Б овогт Ц.Б-т холбогдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5, мөн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг тус тус журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, мөн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт Б овогт Т.Б, С овогт Г.М нарт холбогдуулж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт Б овогт Ц.Ч-д холбогдуулж тус тус яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн 201201000182 дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 06 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

1. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, Б овогт Ц.Б, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, улс төр судлаач, эдийн засагч мэргэжилтэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж

байсан, одоо Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч ажилтай, ам бүл-..., эхнэр, хүүхдийн хамт Багахангай дүүрэг, ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, урд ял шийтгүүлж байгаагүй, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтангадас одон, Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагдсан, хэрэг хариуцах чадвартай, ЦЗ..... тоот регистртэй.

2. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, Б овогт Т.Б, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Говь-Алтай аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, улс төрч, багш мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан, ам бүл-..., эхнэрийн хамт Чингэлтэй дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Сүхбаатарын одон, Алтангадас, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдаж байсан, урд ял шийтгүүлж байгаагүй, УЕ..... тоот регистртэй.

3. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, С овогт Г.М, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Завхан аймгийн ...сумын нутагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, түүхийн багш мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн даргаар ажиллаж байсан, одоо өндөр насны тэтгэвэрт, ам бүл-..., эхнэр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтангадас одонгоор тус тус шагнагдсан, урд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, ЧК..... тоот регистртэй.

4. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, Б овогт Ц.Ч, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, эмч мэргэжилтэй, анагаах ухааны докторын зэрэгтэй, "СЗК" эмнэлгийн дарга ажилтай, ам бүл-..., ...хүүгийн хамт Баянгол дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагналгүй, урд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай,

ЧС..... тоот регистртэй.

Шүүгдэгч Ц.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлалын комиссын даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э, Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д нартай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 188 дугаар тогтоолыг гаргуулан, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 555 дугаар захирамжийг гарган 605.000.000 / зургаан зуун таван сая/ төгрөгийн үнэлгээтэй "Ө" зочид буудал НӨҮГ-ыг татан буулгаж, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой "ДӨ" ХХК байгуулах нэрийдлээр "Ө" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 453.750.000 /дөрвөн зуун тавин гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн эд хөрөнгийг, Н.Э-ын хүү Э.Бш-ын нэр дээр байгуулсан "ХД" ХХК-ийн өмчлөлд шилжүүлэн, улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компанид шилжүүлэн үрэгдүүлж, Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан.

- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж давтан үйлдлээр Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Г.М-тай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 182 тоот тогтоолоор батлагдсан Өмч хувьчлах комиссын ажиллах журмын 2.1.3-д заасан "...Хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах", 2.1.7-д заасан "...нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хянан батлах", 2.1.8-д заасан "... менежментийн болон удирдлагын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хэлэлцэж үр дүнг харгалзан хувьчлах ажлыг хэрэгжүүлэх", 2.2.5-д заасан "...хувьчлагдах аж ахуйн нэгжийн бэлтгэл ажлыг хангуулах", 3.4.3-д заасан "...Өмч хувьчлах асуудлаар комиссын гишүүдэд үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцох", 3.4.4-т заасан "... Хувьчлалтай холбоотой тодорхой асуудал

боловсруулах ...магадлан шинжилгээ хийлгэх асуудалд мэргэшсэн хүмүүсийг татан оролцуулах ..." зэрэг заалтуудыг хэрэгжүүлэхдээ СЗКЭ Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байсан төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан.

-Шүүгдэгч Т.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн өмч хувьчлах комиссын даргын албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э, иргэн Д.Ч нартай бүлэглэн УТ менежментийн баг нь Нийслэлийн өмчийн харилцааны газартай 2004 оны 05 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан "Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах гэрээ"-ний дагуу сонгон шалгаруулалтад шалгарсан багийн бизнес төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй, аудит хийгдээгүй, алдагдалтай ажиллаж, гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байхад 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссын 75 дугаар тогтоол гаргаж, 2.125.000.000 / хоёр тэрбум нэг зуун хорин таван сая / төгрөгийн үнэлгээтэй "УТ" сонин нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хууль бусаар Н.Э-ын төрсөн дүү Н.Эн-гийн "Мх" ХХК, Д.Ч нарын нэрээр хувьчилж, улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компани болгон шилжүүлэн, үрэгдүүлж Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан.

-Шүүгдэгч Г.М нь Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Нийслэлийн Засаг дарга бөгөөд өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан Ц.Б-тай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 182 тоот тогтоолоор батлагдсан Өмч

хувьчлах комиссын ажиллах журмын 2.1.3-д заасан "...Хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах", 2.1.7-д заасан "...нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хянан батлах", 2.1.8-д заасан "... менежментийн болон удирдлагын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хэлэлцэж үр дүнг харгалзан хувьчлах ажлыг хэрэгжүүлэх", 2.2.5-д заасан "...хувьчлагдах аж ахуйн нэгжийн бэлтгэл ажлыг хангуулах" зэрэг заалтыг хэрэгжүүлэхдээ "СЗКЭ" НӨҮГ-ыг 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байсан Ц.Б-ын төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗК" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан.

-Шүүгдэгч Ц.Ч нь 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай "Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх удирдлагын гэрээ" байгуулан "СЗКЭ" НӨҮГ-ыг ажиллуулж байхдаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан төрсөн ах Ц.Б, Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлах хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Г.М нартай бүлэглэн, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоолгон хувьчлан авч, завшин нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

#### ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт яллах, өмгөөлөх талаас шинжлэн судалсан болон хэрэгт цугларсан дараах нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэн судлав.

Үүнд:

Шүүгдэгч Т.Б-ийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: "Миний биед холбогдуулан нийслэлийн Прокурорын хяналтын прокурор Ш.Баярбилэг, Д.Үүлэн нар 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдөр 48 тоот яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн байна. Энэхүү яллах дүгнэлтийг миний бие хүлээн зөвшөөрөхгүй байгаа болно. Энэхүү үндэслэлүүдээ дараах байдлаар тайлбарлая. "УТ" сонин Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хууль бусаар хувьчлан авсан гэмт хэргийг нотолж буй байдал гэсэн яллах дүгнэлтийн 3.2-т бичсэн зүйлүүд нь бүхэлдээ яллах биш харин уг сонин хувьчлал хуулийн дагуу явагдсаныг нотолж байна. Тухайлбал 1998 онд батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, холбогдох мэргэжлийн байгууллагуудын хууль журмын дагуу гаргасан шийдвэрүүдийг гэмт хэргийн нотолж буй баримт болгон оруулсан байна. Тухайлбал Нийслэлийн Засаг даргын 2000 оны 280 дугаартай захирамж, ИТХ-ын 2003 оны 128, 141 дүгээр, 2005 оны 130 дугаар тогтоолууд мөн Тендерийн комиссын тайлан Нийслэлийн Өмчийн харилцааны газрын байгуулсан гэрээнүүд зэргийг дурдаж болно. Яллах дүгнэлтийн тогтоох нь хэсэгт намайг Нийслэлийн Засаг дарга бөгөөд нийслэлийн өмч хувьчлалын даргын албан тушаалаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э, иргэн Д.Ч нартай бүлэглэн гэж дүгнэжээ. Энэ тухайд ерөнхийлөгч асан Н.Э-тай бүлэглэн гэмт хэрэг үйлдээгүй бөгөөд энэ талаар ямар ч үйлдэл байхгүйг би мэдүүлэгтээ тодорхой дурдсан нь хавтаст хэрэгт байгаа болно. Хавтаст хэргүүдийн материалтай танилцаж үзэхэд намайг Ерөнхийлөгч асан Н.Э-тай бүлэглэсэн гэж дүгнэх ямар ч баримт, нотолгоо байхгүй байгааг эрхэм шүүгчид анхаарахыг хүсье. Би Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаал хашиж байсныгаа элдэв хэрэгт хардагдах үндэслэл, гэм буруутайн нотолгоо болно гэж үзэхгүй байна. Иргэн Д.Ч-ын хувьд ч би сайн танихгүй бөгөөд хувийн ямар ч харилцаа холбоо байхгүй болно. Д.Ч-тай бүлэглэсэн гэх баримт нотолгоо, нэг өгүүлбэр ч хавтаст хэргүүдэд байхгүй болохыг энд дурдъя. Яллах дүгнэлтэд ч энэ талаар дурдаагүй бөгөөд харин ч Д.Ч тухайн менежментийн багт хэрхэн орж ирсэн,

ямар үйл ажиллагаа явуулж байсан талаар тодорхой баримтууд хавтаст хэрэгт байгаатай танилцсан. Яллах дүгнэлтийн 12 дахь талд гэрч Н.Ат "Д.Ч-ыг ерөнхий эрхлэгчээр ажиллуулъя гэсэн саналыг би гаргасан. Багийн гишүүн, ахлагчаар ажиллуулах саналыг Ж.Сар дарга гаргасан болно" гэж мэдүүлсэн байна. Д.Ч-ын менежментийн багийн ахлагчаар хэрхэн ажиллах болсныг яллах дүгнэлтэд дурдсан нь Ш.У болон бусад гэрчүүдийн мэдүүлгээс тодорхой харагдаж байна. Д.Ч нь менежментийн багаа төлөөлөн "УТ" сонины хувьчлалтай холбоотой саналаа Нийслэлийн өмчийн харилцааны газарт гаргаж шийдвэрлүүлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, хүсэлтээ надад биш хариуцсан холбогдох газарт нь гаргасан гэсэн үг. Хавтаст хэрэгт байгаа баримтууд нь Д.Ч бид хоёрын хооронд ямар нэгэн холбоо харилцаа байхгүйг нотолно. Албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэсэн дүгнэлтийг зөвшөөрөхгүй байна. Энэхүү хувьчлал нь Монгол Улсын хуулиуд, холбогдох журмуудын дагуу явагдсан. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль 1998 оноос хойш гарч төрийн байгууллагуудын дэргэд хэвлэл мэдээллийн байгууллага байгуулахыг хориглосноос хойших процесс юм. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд би өөрт оногдсон эрх, үүргийн дагуу оролцсон нь хавтаст хэрэгт авагдсан материалуудаас харагдана. "УТ" сонины хувьчлалын асуудлаар миний зориуд зохион байгуулсан хууль журамд нийцээгүй үйл ажиллагаа байхгүй бөгөөд НӨХГ болон Өмч хувьчлалын комиссын эрх бүхий албан тушаалтнуудаас боловсруулж Нийслэлийн өмч хувьчлалын комиссын хуралд оруулсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэр гаргасан нь хууль журамд нийцсэн үйлдэл юм. Өөрөөр хэлбэл, НӨХК холбогдох эрх бүхий байгууллага нь хурлаар оруулж энэ асуудлыг шийдвэрлэсэн. Энэ хуралдсан үйл ажиллагаа нь хууль зөрчөөгүй болохыг нийслэлийн прокурорын хяналтын прокурор О.М-ын 2011 оны 196 дугаар тогтоол батална. Энэхүү тогтоолоор намайг сэжигтнээр тооцсон тогтоолыг хүчингүй болгосон юм. Үүний дараа 2012 оны 04 дүгээр сард АТГ-аас энэхүү 196 дугаар тогтоолыг хүчингүй болгуулахаар Нийслэлийн Прокурорын газарт хандсан боловч "...уг тогтоолыг хүчингүй болгох үндэслэлгүй байна" гэсэн хариуг нийслэлийн прокурорын орлогч Ё.С албан бичгээр хоёронтоо өгсөн нь хавтаст хэрэгт байгаа болно. Харин Үндсэн

хууль, бусад хууль зөрчиж хийсэн ХҮТ-ийн "үнэлгээ" гэгчтэй холбогдуулж сэжигтнээр сэргээн тооцсон нь хууль бус болохыг үнэлгээтэй холбогдсон хэсэгт тайлбарлана гэж бодож байна. Яллах дүгнэлтийн тогтоох нь хэсэгт "...УТ менежментийн баг нь НӨХГ-тай 2004 оны 05 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан "Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах гэрээ"-ний дагуу сонгон шалгаруулалтад шалгарсан багийн бизнес төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй, аудит хийгдээгүй, алдагдалтай ажиллаж гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байхад 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Нийслэлийн Өмч хувьчлалын комиссын 75 дугаар тогтоол гаргасан" гэж дүгнэсэн байгаа. Нийслэлийн прокурорын 2011 оны 196 дугаар тогтоол нь дээрх дурдсан 75 дугаар тогтоол хууль зөрчөөгүй болохыг тогтоосныг дахин дурдахыг хүсэж байна. Сонины барилгаа зөвшөөрөлгүй нурааснаас алдагдал хүлээн бизнес төлөвлөгөө бүрэн биелээгүй бодит шалтгаанаас болж менежментийн гэрээг дүгнэх хугацаа хоёр жилээр хэтэрч, хэвлэлийн зардал, нийгмийн даатгал, татвар, байрны түрээсийн өр зэрэг нийслэлийн төсөвт учрах их хэмжээний хохирол өдөр бүр нэмэгдэж энэхүү асуудлыг яаралтай шийдэхийг шаардаж байсан нь хавтаст хэрэгт авагдсан материалуудаас тодорхой харагдана. Гэрээнд дурдсан үүргээ биелүүлээгүй нь менежментийн багийн хангалтгүй ажилласантай холбоотой биш зөвхөн Л.С хөрөнгө оруулалт нэрээр барилгыг нь нурааж түрээсээр олдог орлогогүй болж сониныхон бүр өөрсдөө ч ажлын байр түрээслэх болсонтой холбоотой юм. Яллах дүгнэлтийн 11 дэх талд гэрч Н.Ат "... манай сонин өөрийн байртай, түүндээ түрээслэгч нар ихтэй байсан. Мөн хэвлэх үйлдвэрээ ажиллуулж орлого олдог байсан" гэж мэдүүлсэн байна. Сонины байр нурсан, алдагдалд орсон нь надтай огтхон ч холбоогүй бөгөөд энэ үед би нийслэлийн төр захиргааны байгууллагад ажиллаж байгаагүй болно.

"УТ" сонины хамт олноос 2008 оын 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Засаг даргаар ажиллаж байсан миний нэр дээр ирүүлсэн албан бичигтэй танилцаад Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Б, НӨХГ-ын дарга М.ГБ нарт судалж саналаа танилцуулах чиглэл өгсөн нотлох баримт 4 дүгээр хавтаст хэргийн 160 дугаар хуудсанд байгаа. Энэхүү албан

бичигт "...учирсан бэрхшээлийн талаар тайлбарлаж, менежментийн багийн хамт олон, ажлын тайлангаа гаргаж Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлжээ. Цаашид хэрхэх талаар шийдвэр гаргаж өгнө үү" гэсэн байна. "УТ" сонины газрыг менежментийн багт нь хувьчлах ажил миний ямар ч оролцоогүйгээр ажил хариуцсан мэргэжилтэн, албан тушаалтнууд саналаа боловсруулж НӨХК-ийн хуралд оруулсныг хавтаст хэрэгт авагдсан материалууд нотолж байна. НӨХГ-ын Өмч хувьчлалын хэлтсийн дарга Г.М, хариуцсан мэргэжилтэн Ц.О нарын гарын үсэг зурсан 3 хуудас танилцуулга хавтаст хэрэгт байгаа. Энэ танилцуулгад "... менежментийн багт нь гэрээний үнээр шууд хувьчлах саналыг оруулж байна" гэж бичсэн байгаа. Мөн хавтаст хэрэгт байгаа НӨХК-ийн хуралдааны 2008.09.08-ны өдрийн 5 тоот тэмдэглэлээс комиссын хурал дээр уг асуудлыг тал бүрээс нь нухацтай хэлэлцэж шийдвэр гаргасныг харж болно. ӨХК-ийн хуралд оруулсан мэргэжилтний санал нь яллах дүгнэлтийг 9 дүгээр талд байгаа. НӨХК-ийн 75 дугаар тогтоол гарахад миний ямар нэгэн нөлөөлөл байхгүй болохыг хэрэгт авагдсан бүх гэрч, сэжигтнүүдийн мэдүүлэг нотолж байна. Миний эсрэг ямар ч гэрч сэжигтний мэдүүлэг байхгүй байгаа. Ганцхан Г.М гэрчийн мэдүүлэг өгөхдөө "... үнэнийг хэлэхэд энэ хувьчлах шийдвэр, санал хотын дарга Т.Б-ээс гаралтай гэж би үзэж байна..." гэсэн мэдүүлэг өгсөн нь яллах дүгнэлтийн 15 дугаар талд намайг буруутгах баримт болж оржээ. Менежментийн багт нь хувьчлах нь зүйтэй гэсэн санал бичгээр боловсруулж комиссын хурлаар биечлэн хэлэлцүүлсэн хүн ийм мэдүүлэг өгсөн нь өндөр настай зүрх муутай хүн сэтгэл санаа ямар нэгэн байдлаар цочирдсоноос болсон байж магадгүй гэж бодож байна. Г.М сүүлд нь энэ мэдүүлгээ өөрчилснийг яллах дүгнэлтэд оруулаагүй байна. АТГ-ын комиссар Т.Г.М-ыг сэжигтнээр дахин байцаасан тэмдэглэлд "... надад М.Гб дарга саналаа танилцуулгаар бичээд ир гэсэн үүргийг өгсөн. Тэр үед Засаг дарга Т.Б, ИТХ-ын дарга Г.Мө нар байсан болов уу" эдгээр хүмүүс хувьчлалын талаар танилцуулга бичээд ир гэсэн үүрэг даалгаврыг надад өгөөгүй гэсэн мэдүүлгийг 8 дугаар хавтаст хэргийн 169 дугаар хуудсанд өгчээ. Намайг үүрэг өгсөн гэсэн мэдүүлэг өгөөгүй байгаа. Яллах дүгнэлтийн 9 дэх талд Өмч хувьчлалын хэлтсийн 2008.04.28-ны өдөр "УТ" НӨҮГ-ын менежментийн

багийн үйл ажиллагааны танилцуулга гэсэн материалыг 3 дугаар хавтаст хэргийн 110-112 дугаар хуудсанд нотлох баримт болгон оруулжээ. Энд уг объектыг хувьчлах А, Б, В санал тавьж байсан мэтээр оруулсан байна. Ийм албан ёсны материал байхгүй. 3 дугаар хавтаст хэргийн 109 дүгээр хуудсанд мөрдөн байцаагчийн тэмдэглэл байна. Улсын мөрдөн байцаах газрын мөрдөн байцаагч н.Буя тэмдэглэлдээ НӨХГ-ын өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Ц.О-ын 2008.04.28-ны өдөр бичиж хэлтэс, газрын дарга, ӨХК-ийн дарга нарт танилцуулж байсан "гэх" "УТ" сонин НӨҮГ-ын менежментийн багийн үйл ажиллагааны тухай танилцуулга 3 хуудас материалыг хэрэгт хавсаргахаар тогтов гэжээ.

Мөрдөн байцаагчийн тэмдэглэлд танилцуулж байсан "гэх" гэж бичсэн байна. Энэ материал холбогдох байгууллага, газар хэлтсийн албан хэрэгт бүртгэлтэй ийм материал байгаагүй. Шалгах үед хураагдсан материалд байгаагүй. Ийм зүйлийг намайг буруутгах баримт болгон оруулжээ. Мөн мөрдөн байцаагч энэ тэмдэглэлийнхээ талаар ямар ч ажиллагаа явуулсан баримт хавтаст хэрэгт байхгүй байна. НӨХГ-ын дарга М.Гб "Би сонин гаргаж байгаа л гэдгийг мэдэж байсан. Энэ сонинтой холбоотой ямар ч асуудлыг хэн ч надад танилцуулж, эсвэл үүрэг чиглэл өгч байгаагүй" гэж мэдүүлсэн байна. НӨХГ-ын даргын хувьд надад ямар ч материал, санал танилцуулж байгаагүй. Ц.О энэ хувьчлалтай холбоотой асуудлаар, ер нь өөр ямар ч асуудлаар надтай уулзаж байгаагүй болно. Ийм санал боловсруулж байсан хүн яахаараа менежментийн багт хувьчлах санал боловсруулж гарын үсэг зурж, НӨХК-т албан ёсоор танилцуулдаг юм бэ. Ядахдаа танилцуулгадаа энэхүү өөр хувилбаруудаа яагаад бичээгүй юм бэ. Уг объектыг дуудлагаар худалдъя гэсэн комиссын хурал дээр миний болон комиссын гишүүн Ц.Са нарын гаргасан саналд НӨХГ-ынхан эсэргүүцэн тайлбар хийсэн нь хурлын тэмдэглэлд байгаа. Энэхүү "...танилцуулж байсан гэх" зүйлийг яллах дүгнэлтэд оруулсан нь ямарч хамаагүй аргаар намайг гэмт хэрэгт холбогдуулах гэсэн арга ядсан арга гэж ойлгогдож байна. Энэхүү хувьчлах шийдвэр гаргахад миний зүгээс ямар нэгэн оролцоо, нөлөөлөл байгаагүй болохыг, хавтаст хэрэгт ямар ч нотолгоо байгаагүй болохыг дахин хэлье. Аудит хийгдээгүйн талаар: Тус сонины үйл ажиллагаа,

санхүүгийн байдалд удаа дараа шалгалт хийгдсэн нь хавтаст хэрэгт авагдсан байна. 2003 оноос хойш удаа дараа хийгдсэн олон шалгалтын олон хуудас материалууд 4 ба 8 дугаар хавтаст хэрэгт авагдсан байгаа, бараг хоёр хавтаст хэрэг баримт байна. Мөн хувьчлах шийдвэр гаргахын өмнөх 2008 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлан хавтаст хэрэгт байгаа. Өөрөөр хэлбэл, тус сонины санхүүгийн үйл ажиллагааны байдалд дахин аудит хийлгэх шаардлагагүй нь тодорхой байсан учраас НӨХГ-аас хувьчлах саналаа боловсруулсан байна гэж үзэх үндэстэй байна. Барилгыг нураасантай холбогдсон асуудлыг зохицуулахаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлалын комиссын дарга Ц.Б, менежментийн багийн ахлагч Ж.Сар нар үйл ажиллагааны үр дүнгийн шинэ гэрээг 2007.01.08-ны өдөр байгуулсан байна. Талууд гэрээгээ 2008.01.20-ны дотор багтаан дүгнэнэ гээд гэрээгээ дүгнээгүй байгаа нь 4 дүгээр хавтаст хэргийн 124 дүгээр талд байна. Энэ гэрээнд нийслэлийн засаг захиргааны зүгээс авсан үүрэг болох, сонины байрыг бүрэн засварлаж дуусгахад дэмжлэг үзүүлнэ, бүтээгдэхүүнийг худалдан авах хөлсийг нь цаг хугацаанд нь төлнө. Нийслэлийн ИТХ-д биелэлтийг танилцуулж байх зэрэг захиргааны зүгээс хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь менежментийн баг гэрээний үүргээ биелүүлэхэд харгалзан үзвэл зохих маш ноцтой саад бэрхшээл байсныг харуулж байна. Энэ бүхнийг шийдвэрийн төсөл боловсруулахдаа ажил хариуцаж байсан хүмүүс олон талаас нь бодож ихээхэн анхаарал хандуулсан нь дээр дурдсан нотлох баримтуудад туссан байна. "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн "хувьчлахад бэлтгэх" гэсэн 35 дугаар зүйлд аудит хийлгэх тухай ямар ч заалт байхгүй. Гол баримталж байгаа хууль. Энэ хуульд хувьчлалд бэлтгэх гэсэн заалтад аудит хийлгэ гэсэн заалт байхгүй. Ер нь энэ хуульд аудитын тухай ямар ч заалт байхгүй байна. "УТ" сонины санхүүгийн болон хөрөнгийн байдлын талаар хангалттай мэдээлэл байсныг дээр дурдсан. Аудит хийгдээгүй гэж хуульд заавал хийхээр заагаагүй үндэслэлийг яллах дүгнэлтэд оруулсныг хууль бус гэж үзэж байна. Хувьчлалыг явуулахдаа "Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 65 дугаар зүйлийн 4-д заасан зарчмуудыг баримталсан болно. 65.4 Нийгмийн салбарын өөрчлөлт шинэчлэл, хувьчлалын үйл ажиллагаанд

дараах зарчмыг баримтална. Үүнд 1.Үйл ажиллагааны чиглэл, хөрөнгийн зориулалтыг өөрчлөхгүй байх, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөөгүй болно. 2.Үйлчилгээ, үйл ажиллагааны хүрсэн төвшинг буруулахгүй байх, үйлчилгээнийхээ дагуу сониноо гаргаж үйлчилж байсан. 3.Үйлчилгээнд хамрагдах хүрээг өргөтгөх. 4.Ил тод, нээлттэй байх, үүнд ямар нэгэн юм нууцалсан зүйл байхгүй байгаа. 5.Ажиллагсад учрах эрсдэлийг бууруулах гэсэн үндсэн таван шаардлагыг үндсэндээ менежментийн баг хангасан гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хүнд байсан боловч нэг ч хүнээ халаагүй, хорин хэдэн ажилчид нь ажилласаар байсан. Нийгмийн салбарт өөрчлөл шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолд хуулийн дээрх зарчмуудыг баталгаажуулан хуульчилсан байдаг. Нийгмийн салбарын хувьчлалыг хийхдээ ашиг хөөцөлдөх биш, энэ эмзэг салбарын ажиллагсдын ажлын байрыг баталгаатай байлгах, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй байхад чиглэгдсэн тогтоол байгаа. Энэ тогтоолын гол үзэл баримтлалыг тусгасан юм. Гэрч Г.М-ын 8 дугаар хавтаст хэргийн 166 дугаар хуудсанд байгаа мэдүүлэгт "...гэрээнд заасан үндсэн үүрэг болох сониноо тасалдуулахгүй байнга гаргаж байсан, ажилчдаа ерөөсөө халж солихгүй байлгаж байсан. Гол нь сониноо таслахгүй гаргаж байсан учир багт нь хувьчилъя гэсэн санал гаргасан юм. Хамгийн гол нь би "УТ" сониноо хотдоо авч үлдэе, хотынхоо бодлого чиглэлийг нийслэлчүүдэд хүргэж байя гэсэн бодлоор багт нь хувьчилъя гэсэн санал оруулсан юм" гэсэн мэдүүлэг өгчээ. Мөн миний гэм буруугүй болох талаарх дараах нотлох баримтуудыг танилцуулж байна. Шүүгчдэд хандаж хэлэхэд энэ "УТ" сонин бол 2005 оын 6 дугаар сарын 22-ны 130 тоот тогтоолоор батлагдсан юм. Энэ нь хавтаст хэрэгт байгаа. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хувьчлах тухай тогтоол 2005.06.22-ны №130 менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах гэрээний биелэлтийг үндэслэн "УТ" сонин, UBS телевиз, "УБ радио" нийслэлийн төсөвт байгууллагуудыг хувьчилсугай. Хурлын дарга Н.Б, тэргүүлэгчид гэжээ. Ийм материал бол байгаа. Өөрөөр хэлбэл, хувьчлал хууль бусаар явуулсан гэдэг асуудал бол аль эрт 2005 онд хувьчлагдсан. Одоо юуны тухай яригддаг вэ гэхээр байр,



орлоготой холбоотой асуудал яригддаг. Үүнийг улсын яллагчид тодорхой анхаарч үзээгүй юм уу гэж бодогдож байна. 5 дугаар хавтаст хэргийн 20 дугаар хуудсанд Нийслэлийн өмчийн харилцааны газрын танилцуулга байгаа. Үүнд менежментийн багт нь хувьчилсан шалтгааныг тэмдэглээд тус баг өрөө бүрэн барагдуулаагүйгээс үүссэн өр төлбөр болох 1.5 тэрбум орчим төгрөгийг улсын төсвөөс барагдуулах асуудлыг УИХ, Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх тогтоолын төсөл танилцуулж байна гэсэн төсөл хавтаст хэрэгт байгаа юм. Товчхон ярихад Нийслэлийн өмч хувьчлалын комиссын 75 дугаар тогтоол нь хууль зөрчөөгүй болохыг дээрх баримтууд нотолно. Яллах дүгнэлтийн "... 2.125.000.000 /хоёр тэрбум нэг зуун хорин таван сая/ төгрөгийн үнэлгээтэй "УТ" сонин НӨҮГ-ыг ..." гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Яллах дүгнэлтийн 8 дугаар талд "УТ" сонин НӨҮГ-ыг хууль бусаар хувьчлан авсан гэмт хэргийг нотолж буй байдлын дээрээсээ 5 дахь хэсэгт НӨХК-ийн 2003.12.18-ны өдрийн Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай 101 тоот тогтоол 1 дүгээр хавтаст хэргийн 149 дүгээр хуудсанд байгаа. Энэ 1 дүгээр хавсралтад юу гэж заасан бэ гэхээр "УТ" НӨҮГ-ыг хаалтан дотор /хувьчлах үнэ 369.724.000 төгрөг, дэнчин 36.972.400 төгрөг/ гэжээ. Өөрөөр хэлбэл, 2003 онд 101 дүгээр тогтоолоор 369.724.000 төгрөг, дэнчин 36.972.400 төгрөг гээд үнэлсэн байгаа. Энэ нь НӨХК-ийн 2008 оны 75 дугаар тогтоолоор хувьчилсан үнийг 2003 онд тогтоосон болохыг нотолж байна. Яллах дүгнэлтийн энэхүү баримт нь намайг гэм буруутайг биш харин эсрэгээрээ Иргэдийн хурлаар тогтоосон үнээр өгснийг нотолж, гэм буруугүйг нотолж байна. Мөн "Нийслэлийн өмчөөс 2005 онд хувьчлах эд хөрөнгийн жагсаалтыг зөвшөөрөх тухай" Монгол Улсын Төрийн өмчийн хорооны 2005.04.14-ний өдрийн 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтанд "УТ" ОНӨҮГ-ыг 2005 онд менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлахаар зааж, аж ахуйн нэгжид хийсэн зах зээлийн үнэлгээний дүнг 369.724.000 төгрөг байхаар тогтоож, Төрийн өмчийн хорооны дарга З.Эн гарын үсэг зурсан материал хавтаст хэрэгт байгаа. Би дахин хэлье аж ахуйн нэгжид хийсэн зах зээлийн үнэлгээний дүнг 369.724.000 төгрөг байхаар тогтоосон. Өөрөөр хэлбэл, 2003 онд НИХ

баталсан, 2005 онд ТӨХ баталсан үнэ байгаа юм. Харин ч 2008 онд нурчихсан байсан байшинг бүтэн байсан үеийн үнэлгээгээр үнэлүүлээд, Миний бие 2013 оны 09 сарын 26-нд АТГ-ын удирдлага, Улсын ерөнхий прокурорт гаргасан хүсэлтдээ энэхүү баримтыг харгалзан үзэхийг хүсэж дээрх тогтоол, тогтоолын хавсралтыг хүргүүлсэн нь хавтаст хэрэгт авагдсан байгаа. Энд дахин онцлон хэлэхэд "УТ" сонин ОНӨҮГ-ын зах зээлийн үнэлгээг 369.724.000.00 төгрөгөөр Төрийн өмчийн хороо үнэлжээ. Нийслэлийн ӨХК-ийн 2003 оны үнэлгээ, ТӨХ-ны 2005 оны зах зээлийн үнэлгээ нь намайг яллах дүгнэлт, үндэслэл болж байгаа нь шударга ёс, хууль зүйд нийцэх үү. Тэр тусмаа 2008 онд нурсан байшинг дээр нь бүх өр төлбөрийг нь хариуцуулж үндсэндээ нэг тэрбум гаруй төгрөгөөр худалдсан явдал нь нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан биш харин нийслэлийн өмчид ашигтай үйл явдал болсон. Өмнөх шүүх хуралдаанд "ХҮТ" ХХК-ийн шинжээч "...нурсан байшинг хэрвээ үнэлбэл 130 саяас хэтрэхгүй юм байна лээ" гэж шүүх хуралдаанд мэдүүлснийг дашрамд дурдъя. Өөрөөр хэлбэл, нийслэл хотод ямар ч хохирол учраагүй, харин ч ашигтай шийдвэр байсныг дахин хэлье. "ХҮТ" ХХК "УТ" сонин 2 тэрбум 125 сая төгрөгөөр үнэлсэн нь МУ-ын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн үнэлгээ юм. Уг объектийн байрлаж байгаа газрыг үнэлж бусдад худалдахаар тооцож үнэлгээг 2,7 дахин өсгөжээ. Үүнд Нийслэлийн өмчийн харилцааны газрын хохирогч нарын төлөөлөгчид байж байна. Монгол Улсад өнөөдрийг хүртэл явагдаж ирсэн өмч хувьчлалд хэзээ ч газрыг үнэлж, худалдсан түүх байхгүй. Үндсэн хуулийн 6.2-т "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий... төрийн өмч мөн" гэж заасан. Өөрөөр хэлбэл, иргэдэд өмчлүүлсэн 0,07 га-аас бусад газар нь төрийн өмч байна гэсэн үг юм. Гэтэл төрийн өмч байх ёстой газрыг бусдад үнэлж, хувьчлан худалдсангүй гэж яллаж байгаагийн учрыг улсын яллагчаас асууж байна. Хэрэв ингэж яллаж байгаа нь хууль зүйд нийцэж байна гэж үзэж байгаа бол 1990 оноос хойш явагдсан бүх өмч хувьчлал, хувьчлагдсан объектуудын байрлаж байгаа газрыг нь үнэлж худалдаагүй, төрийн өмчийн газрыг өмчлүүлээгүй, хувьчлаагүй хэмээн үзэж бүх шийдвэр гаргагчид, хувьчилж авсан бүх хүмүүсийг яллах шаардлага гарч байна. Өмч

хувьчлалын комисс нь мэргэжлийн байгууллагын хийсэн үнэлгээнд тулгуурлан шийдвэр гаргадаг. ӨХК-ийн дарга болоод гишүүдийг заавал үнэлгээчний мэргэжилтэй байхыг шаардсан хууль байхгүй. Хэрэв "Ю-Б-П" ХХК нь "УТ" сонинг 5 тэрбумаар үнэлсэн гэхэд түүгээр л шийдвэрлэх байсан. Хараат бус үнэлгээний байгууллага үнэлсэн, Төрийн Өмчийн хорооноос үнэлсэн ийм үнэлгээнээс өөр ямар үнэлгээгээр үнэлэх гэсэн юм бэ. ӨХК-ийн гишүүдийн 100%-ийн саналаар гаргасан хамтын шийдвэрийн төлөө, зөвхөн нэг саналын эрхтэй оролцсон намайг яагаад яллаж байгаа. Хэрэв "ХҮТ" ХХК-ийн үнэлгээг зөв гэж үзэж байгаа бол 2.7 дахин багаар үнэлсэн "Ю-Б-П" ХХК, Төрийн өмчийн хороо ямар хариуцлага хүлээсэн бэ. Бид тэрийг баримтлан үнэлсэн. "ХҮТ" ХХК нь үнэлгээ хийхдээ газрын гэрчилгээ, газрын мэдээлэл байхгүй объектод зарим хэмжилтийг нүдэн багцаагаар хийсэн, "Централ тауэр"-ын газрыг хүмүүс хоорондоо өгч авалцсан сураг ажигт тулгуурласан зэрэг маш олон байж болшгүй дутагдал гаргасныг энд дурдах шаардлагагүй гэж үзэж байна. Би зөвхөн Үндсэн хууль түшиж, Үндсэн хуулиар төрийн өмчид байх газрыг худалдсан гэж намайг буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Яллах дүгнэлтийн төгсгөл хэсэгт, "УТ" НӨҮГ-ыг хууль бусаар Н.Э-ын төрсөн дүү Н.Эн-гийн "Мх" ХХК, Д.Ч нарын нэрээр хувьчилж, улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компани болгон шилжүүлэн үрэгдүүлж, нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг гардан үйлдсэн" гэжээ. "УТ" НӨҮГ-ыг Д.Ч ахлагчтай менежментийн багт хувьчилсан. Түүнээс Н. Эн-д хувьчилсан шийдвэр байхгүй. Менежментийн баг ямар бүрэлдэхүүнтэй, яаж ажиллаж байсныг нотлох баримтууд хавтаст хэрэгт хангалттай байгаа. Энэхүү яллах дүгнэлтэд менежментийн багийн гишүүдийн мэдүүлгүүдэд надтай ямар ч холбогдолгүй материал, миний нэр ч байхгүй байгаа. Энэ нь яллах дүгнэлтийн 11, 12, 13, 14 дүгээр хуудсуудад бүхэлдээ орсон байна. Менежментийн багийн гишүүдээс гадна тухайн сонин хамт олон, сэтгүүлчид ажиллаж байсан. "УТ" сонин НӨҮГ-ыг менежментийн багт нь Өөрөөр хэлбэл, тухайн хамт олонд хувьчилсан юм. НӨХК-ийн 75 дугаар тогтоол "Худалдах худалдан авах гэрээ зэрэг бүхий л баримт бичигт Н.Эн гэсэн нэр байхгүй". Ийм байхад Н.Эн-гийн

"Мх" ХХК-ийн нэрээр хувьчилж гэж яллах дүгнэлтэд илт худал дүгнэлт хийсэн байна. Энэхүү хувьчлалд албан үүргийн дагуу оролцож НӨХК-ийн 75 дугаар тогтоолд гарын үсэг зурснаас хойш "УТ" НӨҮГ-тай холбоотой ямар ч үйл ажиллагаанд миний бие оролцоогүй бөгөөд тийм эрх, үүрэг ч байхгүй болно. Тогтоол гарсан, холбогдох мэргэжлийн байгууллагууд нь гэрээгээ хийгээд өгч авалцаад төлбөр, мөнгөө хийгээд явдаг замаараа явсан байгаа. Яллах дүгнэлтийн нотлох баримтууд энэ хэрэгт намайг холбогдолгүйг нотлох, цагаатгах баримтууд болсоор байгааг дахин хэлье. Хавтаст хэрэгтэй танилцах явцад буюу 4 дүгээр хавтаст хэргийн 74 дүгээр хуудсанд "Тооцоо нийлсэн акт албан бичигт Д.Ч-аас хоёр удаагийн шилжүүлгээр 369.724.000 төгрөг шилжүүлснийг тэмдэглэсэн байна. Энэ нь надтай холбоогүй боловч хавтаст хэргээс хэний нэрээр мөнгө шилжиж орж ирсэн байгааг харсан. 4 дүгээр хавтаст хэргийн 74 дүгээр хуудсанд Д.Ч-аас хоёр удаагийн шилжүүлгээр мөнгө орж ирсэн байна лээ. Өмчлөгчийн эрх олгох тухай НӨХК-ийн 96 дугаар тогтоолоор "... Менежментийн багт хаалтан дотор /Д.Ч ахлагчтай/ өмчлөх эрхийн гэрчилгээ олгосон нь 4 дүгээр хавтаст хэргийн 77 дугаар хуудсанд байгаа. Энэ тогтоолд менежментийн багт нь гэж онцлон тэмдэглэснээс биш ямар нэгэн Н.Эн гэсэн нэр байхгүй. Яллах дүгнэлтийн 10 дахь талаас харахад Д.Ч нь "Мх" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Х-тай хувьчлах шийдвэр гарснаас 17 хоногийн дараа Зээлийн гэрээ хийсэн юм байна. Иргэд байгууллагын хооронд хийгдсэн энэ иргэний гэрээ яахаараа намайг яллах нотолгоо болж байгаа юм бэ. Ийм гэрээ хийгдсэнийг би яллах дүгнэлтээс л анх уншлаа. Хувьчлагдсан объектийн төлбөрийг хийхдээ заавал багийн ахлагчийн халааснаас гаргана гэсэн заалт ямар ч хуульд байхгүй. Зүйрлүүлж хэлбэл алан хядагчийн холбогдолтой этгээдээс зээл авсан, гэрээ хийсэн байлаа гэхэд намайг бас буруутгах юм уу. Зээл авсан, төлбөр хийсэн нь хууль зөрчсөн бол тэр гэрээ хийсэн хүмүүсийн л хариуцлагын асуудал гэдэг нь хэнд ч ойлгомжтой байхад надтай яагаад холбогдож байгааг би ойлгохгүй байна. Яллах дүгнэлтийн 17 дахь талд буй 3 шатны шүүхийн тогтоол, магадлал нь намайг яллах нотлох баримт болгон оруулж байгаа нь миний хувьд яллах нотлох баримт болж чадахгүй гэж үзэж байна. 3 шатны шүүхийн

шийдвэрүүдийг бүхэлд нь буруутгах шүүмжлэх эрх надад байхгүй бөгөөд тийм зорилго ч агуулаагүй. Зөвхөн Н.Э нартай бүлэглэн гэж миний нэрийг дурдсан талаар тайлбар хийхийг хүсэж байна. Тухайн шүүх хурлуудын явцад уг хэрэгтэй холбогдуулан миний биеийг яллагдагч, шүүгдэгчээр тогтоогоогүй байсан тул Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар "...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох..." эрхээ эдлэх боломж, шаардлага ч байхгүй байсан. Гэвч таслан шийдвэрлэх тогтоолд миний нэр эчнээгээр орсон нь миний гэм буруутайг тогтоосон мэтээр ойлгогдож шүүхээс гарах шийдвэрт нөлөөлөхгүй байх гэж найдаж байна. НӨХК-ийн 75 дугаар тогтоол гарснаас хойшхи үйлдлүүдэд надтай холбоо хамааралтай ямар ч асуудал байхгүй бөгөөд хавтаст хэрэгт ч нотолгоо, тэмдэглэл байхгүй болно. Яллах дүгнэлтэд "... улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компани болгон шилжүүлж..." гэжээ. НӨХК-ийн 75 дугаар тогтоол гарснаас хойш бараг жилийн дараа 2009.07.10-нд Н.Э, Б.Ту нар "Э" ХХК-ийг байгуулсан юм байна. Н.Э, Б.Ту, Н.Эн нар компаниа нааш цааш болгосон материалууд яллах дүгнэлтийн 16 дахь талд байна. "Э" ХХК түүний охин компанитай намайг холбон яллаж байгааг үнэхээр ойлгохгүй байна. 75 дугаар тогтоолд гарын үсэг зурсан миний үйлдэл дууссан. Үүнээс жилийн дараа Н.Э, Б.Ту нарын байгуулсан "Э" ХХК-ийг би яахаараа шилжүүлсэн болдог юм бэ. Ямар нотлох баримт байгаа юм бэ, жирийн логикын үүднээс аваад үзэхэд үнэхээр учир холбогдолгүй зүйл гэдэг нь ойлгогдоно. 2009 онд "Э" ХХК байгуулагдсан, 75 дугаар тогтоол 2008 онд гарсан. Яллах дүгнэлтэд "...онц их хэмжээний хохирол учруулсан, гэмт хэргийг гардан үйлдсэн ..." гэжээ. НӨХК-ийн хурлыг даргалж ӨХК-ийн гишүүдийн 100%-ийн саналаар шийдвэр гаргасныг л буруутгахгүй юм бол үүнээс өөр ямар ч үйлдэл надад байхгүй. Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учраагүй болно. Нийслэлийн өмчийн газрыг төлөөлж ирсэн хүмүүс энэ талаар ярих байх гэж бодож байна. "УТ" сонин НӨҮГ-ын нурсан барилга нийслэлийн өмчид хэвээр байгааг нотлох баримтууд хавтаст хэрэгт хангалттай байна. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж уг барилгын оронд яамдын нэгдсэн барилга барих шийдвэр гаргасныг бид мэдэж байгаа билээ. Дахин хэлэхэд нийслэлийн

өмчид ямар ч хохирол учраагүй болно. Яллах дүгнэлтийн бүх нотлох баримтыг зөвхөн хуулийн заалт, шударга үнэнд тулгуурлан, нотлох баримтаар үгүйсгэж байгааг шүүх бүрэлдэхүүн анхаарч надад холбогдуулж байгаа энэхүү хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгөхийг хичээнгүйлэн хүсье" гэв.

Шүүгдэгч Ц.Б-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: Намайг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э-тай бүлэглэн Нийслэлийн өмчийг хууль бусаар Иргэдийн хурлын тогтоол гаргуулан авах ажлыг зохион байгуулсан гэсэн үндэслэлээр яллаж байна. Нэгдүгээрт "НӨ" компани ямар байсан талаар яримаар байна. 2012 онд намайг шалгаж байхад анх мэргэжлийн байгууллагынхантай анх ирсэн. Тэр үед н.О гэдэг байцаагчид үүнийг хэргийн материалд оруулж өгөөч гэсэн хүсэлтээ тавьж байсан. "НӨ" хамтарсан компани байгуулах хамгийн гол шалтгаан нь нэгд, үйл ажиллагаа доголдсон, үндсэндээ сүүлийн хэдэн жил дандаа алдагдалтай ажилласан. Хоёрт, менежментийн арга, байгууллагыг удирдаж байсан удирдлагын арга барил хоцрогдож муудсан. Гуравт, үйлчилгээний цар хүрээ байхгүй болсон. Дөрөвт, өрсөлдөх чадваргүй болсон. Тавд, нийгмийн даатгал болон татварт их хэмжээний өр жил жил хуримтлагдан ирсэн. Ашигт ажиллагаа байхгүй болсон. Алдагдалтай ажиллаж ирсэн, дампуурахад бэлэн болсон. Буудлын байшингийн гадна, дотно өнгө үзэмж алдагдаж, Нийслэлийн өмчит хамтарсан компани байгуулах үндсэн шалтгаан болсон. Тэр үед үндсэндээ хажууд нь байсан хувийн зочид буудал хэдэн сая төгрөгийн ашигтай ажиллаад байхад манай хотын төвд, бүр нэгдүгээр зэрэглэлд байж байгаа энэ буудал алдагдалтай ажиллаж байгаа асуудал байсан. Надад хотын дарга болсны дараа олон хүн хэлж байсан. Ц.Б-аа чи Засаг дарга юм бол Улаанбаатар хотын төвд байгаа янхны газраа цэгцлээч, өөдтэй, өнгөтэй болгоочээ, манай хотын нэр хүндийн асуудал болоод байна гэж хэлж байсан. Би ч гэсэн сонин хэвлэлээр яг энэ талаар ярилцлага өгч байсан. Энэ ярилцлага хавтаст хэрэгт авагдсан байгаа. Хоёрдугаарт Иргэдийн хурлаас гаргасан Нийслэлийн өмчит хамтарсан компани байгуулах шийдвэр гаргахад дараах чиглэлийг сайжруулахаар зааж өгсөн. Үүнд нэгд үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ашигт

ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөр болгон хэрэгжүүлэх энэ үндсэн шаардлагыг тавьсан. НӨХГ-ын 2007 оны хөрөнгийн үнэлгээгээр компанид 469.000.000 төгрөгийг баталж өгсөн байгаа. Ийм хөрөнгийн үнэлгээ хийгдсэн байгаа. Энэ бол хамтарсан компанийн 25 хувь болж байгаа юм. Дараа нь хамтарсан компанийн 25 хувь, 75 хувийн асуудал яригдаад байна. Энэ нь үндсэндээ ойролцоогоор 1 тэрбум 800 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай байна. Өнөөдөр Нийслэл Улаанбаатар хотын “Ө” зочид буудлын 721 м2 байшинг үнэлэхэд нийтдээ 468.000.000 төгрөг, нөгөө талын хөрөнгө оруулагч нь 1.500.000.000 төгрөгийн хөрөнгө оруулж байж энэ компанийн үйл ажиллагаа сайжирна, энэ үндсэн асуудал байсан. Манайх 49:51-тай эзэмшиж болох байсан. Нийслэл тухайн үед даана ч ямар ч мөнгө байгаагүй. Өөрийгөө яая гэж байсан. Үүний дараа би бас хэдэн тоо баримт эрхэм шүүгчид, улсын яллагчид хэлнэ. Тэгээд энэ үндэслэлээр 75:25 гэсэн асуудал гарсан шүү гэдгийг хэлмээр байна. Үүний талаарх баримтыг хавтаст хэрэгт аваагүй байгаа. Ингээд үндсэндээ хийсэн хөрөнгө оруулалтууд үүн дээр байж байна. 2005 оноос алдагдалтай ажилласан график, үйл ажиллагаа үүнд байна. Үүнд бас 2006 оноос хойш алдагдалтай ажиллаж байсан баримт он оноороо авагдсан байна. Хамтарсан компани байгуулсны дараа үйл ажиллагаанд нь шинжилгээ хийж үзсэн. Үүнд өмнөхөөсөө бүгд давуу байдалтай байгаа. Сул тал гэгч нэг байхгүй. Барилгын гаднах өнгө үзэмж сайжирч хотын төвийн үзэмжинд эерэгээр нөлөөлсөн. Барилгын дотоод заслыг чанартай материалаар дээд зэргээр хийж өнөөдөр Монгол Улсын төвд дөрвөн одтой буудал болж дахин үүдээ нээсэн. Менежмент нь сайжирсан, үйл ажиллагааны хүрээ өссөн. Хуучин алдагдалтай ажиллаж байсан бол 2011 онд 138.000.000 төгрөгийн татварын дараах ашигтай ажиллаж эхэлсэн. Мөн үйлчлүүлэгчдэд тав тухтай орчныг бий болгосон, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж борлуулалтын орлого нэмэгдсэн, ажлын байр, боловсон хүчин нэмэгдсэн, алдагдалгүй болж ашигтай ажиллаж эхэлсэн. Улсад төлөх татварын хэмжээ өссөн байгаа. Энэ үндсэн зүйлүүд нь бол Нийслэлийн Өмчийн харилцааны газраас энэ газрыг өөрчилсний үр дүнд бий болсон бодит өөрчлөлтүүд юм. Үүнд ямар нэгэн сөрөг

зүйл байхгүй. 2005 оноос хойш Улаанбаатар хотын төсөв, хөрөнгө оруулалт ямар байсан юм бэ гэхээр 2005 оны Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт үндсэндээ 3.3 тэрбум байсан. 2005 онд 4.9 тэрбум болж өссөн. 2006 онд 4.8 тэрбум болсон. 2007 онд 22.6 тэрбум болсон. 2009 онд Улаанбаатар хот 19.3 тэрбумын төсөвтэй байсан. Нийслэлийн Засаг дарга бол бүх асуудлыг шийддэг хүн биш. Үүнийг мэргэжлийн байгууллага, Нийслэлийн өмчийн газар асуудлыг оруулж бүх төвшинд нь хэлэлцүүлдэг. Энд сууж байгаа хүмүүс Нийслэлийн Засаг дарга Э.Бү-ийн бүх захирамжийн төсөл, өмчтэй холбоотой асуудлуудыг оруулж ирдэг болохоос биш хотын дарга тэг гэдэг үүрэг хаана ч байхгүй. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлд Нийслэлийн Засаг даргын эрх үүргийг зааж өгсөн байдаг. Мөн хуулийн 19 дүгээр зүйлд Иргэдийн хурлын эрх үүргийг заагаад өгчихсөн байдаг. Би өнөөдөр өмчийн харилцаатай холбоотой төрийн болон орон нутгийн өмчийн талаар бодлого, хууль тогтоомж, тухайн хурлын шийдвэрийн биелэлтийг ханган зохион байгуулах үүрэгтэй. Тухайн орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах болон бусдад шилжүүлэх, шинээр олж авах, хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн талаар санал боловсруулж Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулдаг ийм л үүрэгтэй. Мөн тухайн орон нутгийн хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Иргэдийн хуралд оруулж шийдвэрлүүлэх үүрэгтэй. Энэ асуудлыг өмч хариуцсан ӨХГ тухайн асуудлыг боловсруулж оруулдаг учраас Ц.Б гэдэг хүн асуудлыг боловсруулаад оруулдаг зүйл байхгүй. Өнөөдөр хувьчлал гэдэг бол хэд хэдэн аргатай байдаг.

Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан байдаг. Үүнд менежментийн үр дүнг харгалзан хувьчлах, дуудлага худалдаа мөн уралдаан, сонгон шалгаруулах, төрийн хувьцаа болон хувь хөрөнгийг худалдах гэх мэт заалтууд хуульд тусгагдсан байгаа. Намайг буруутгаад байгаа, ял өгөөд байгаа Н.Э гэдэг хүний энэ асуудалд би үндсэндээ ямар нэгэн байдлаар харилцаа холбоо байхгүй. Монгол Улсын Ерөнхийлөгч байсны хувьд, Монгол ардын намын дарга байсны хувьд, Монгол Улсын Ерөнхий сайд байсны хувьд Нийслэлийн Засаг дарга ажил үүргээ Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулдаг үүргийн

хувьд байхаас биш хэн нэгэн хүн надад энэ чиглэлээр үүрэг даалгавар өгч би тэрийг нь биелүүлдэг тийм ч хүн би биш. Энэ бол миний өөрийн хувийн зан чанар. Тийм учраас би ӨХГ-аас бэлтгэсэн энэ асуудлыг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулсан. Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал оруулаад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэр гаргавал би хэрэгжүүлэх болохоос биш Ц.Б дураараа өмч хөрөнгө захиран зарцуулах зүйл байхгүй. Тэгээд энэ асуудалд би Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг би биелүүлсэн. Энэ шийдвэрийг би биелүүлэх үүрэгтэй. Хэрвээ энэ үүргээ биелүүлэхгүй бол би огцрох үүрэгтэй. Иргэдийн төлөөлөгчдийн хурал надад хяналт тавьдаг, намайг шалгадаг. Үнэндээ надад бүлэглэн асуудлыг хийсэн гэж байна. Өнөөдөр надад ийм асуудал хийсэн зүйл байхгүй. Сая Т.Б дарга хэлж байна. Өнөөдөр яагаад тэр 2009 онд байгуулагдсан "Э" ХХК-ийн асуудал гаргаж ирээд байгаа юм бэ. Миний үед ганцхан 555 дугаар тогтоолыг гаргахдаа 2007 оны 9 дүгээр сард Иргэдийн хуралд оруулаад 49:51-ээр компани байгуулъя гэж оруулсныг буцаасан. Буцаахдаа үүнийг хувийн хэвшлээр хийлгэ гэдэг асуудал гарсан. Тэр үед ӨХГ-ын мэргэжилтнүүд надад боловсруулж өгсөн. Үүний дагуу "ХД" гэдэг ганцхан компани ирлээ гэж байсан. Өөр ямар ч компани ирээгүй. Тэгэхээр дахиж буцаах журам байхгүй. Ирсэн л бол нэг ч байсан, хоёр ч байсан хамаагүй шалгаруулалт хийдэг. Тэгээд үүний дагуу энэ асуудлыг шалгуулсан гэдгийг хэлмээр байна. Иргэдийн хурлын тогтоол гаргуулсан гэж байна. Өнөөдөр Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан байгаа. Иргэдийн хурлын хийх ажил нь өөрөө бүрэн эрхтэй. Бүгд хууль мэддэг хүмүүс байгаа учир би энэ бүрэн эрхийг унших нь илүүц байх. Энэ хуулиар чинь энэ асуудлыг гаргуулна. Түүнд Ц.Б гэдэг хүн Засаг даргын болон хувь хүний хувьд түүнд ямар нэгэн эрх хэмжээ байхгүй. Тэнд чинь Ардчилсан нам байна, бусад намууд байна, намуудын төлөөлөл орж байж Иргэдийн хурлын тэргүүлэгчид байдаг. Тэрнээс биш Ц.Б чи ингээрэй гэсэн зүйл байхгүй. Өнөөдөр хавтаст хэргийн алинд ч Ц.Б гэдэг хүн Иргэдийн хурлын төлөөлөгчид, Тэргүүлэгчдийг өөртөө татна, өөрийнхөө эрх ашгийн төлөө энэ хуулийг гаргуулсан гэсэн ийм заалт энэ хавтаст хэргийн алинд нь ч

байхгүй байгаа. Би энэ талаар улсын яллагч нараас асуумаар байна. Үүнд нэгд Ц.Б гэдэг хүн Нийслэлийн Засаг даргын хувьд ч, ӨХК-ийн даргын хувьд ч өмч итгэмжлэн хариуцсан хүн мөн үү, биш үү, надад хэн ямар өмч гаргаж өгсөн юм бэ, тэгэхээр би "Ө" зочид буудлыг итгэмжлэн хариуцсан учраас би яллагдаад байна гэж ойлгож байна. Тэгэхээр энэ хэддүгээр хавтаст хэрэгт байгааг надад хэлж өгөөч. Хоёрт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллаж байна. Өнөөдөр Ц.Б гэдэг хүн эд хөрөнгө хариуцдаг юм уу, энэ нь хаана ямар заалтад байгаа юм бэ, үүнийг тогтоож хэлж өгөөч гэдгийг хүсэж байна. Үүнтэй холбогдуулаад "ДӨ" ХХК, Э.Бш гэдэг хүний асуудлууд тухайн үед нэг ч удаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар болон над дээр орж ирж байгаагүй. Тэр Б.Х гэдэг хүний компани ийм ийм менежментээр ингэж, ингэж сайжруулъя гэсэн хөтөлбөр оруулж ирсэн. Энэ бол хавтаст хэрэгт байгаа. Би өөрөө н.О гэдэг хүнээс анх намайг байцаах гэж байхад нь асууж байсан. Хавтаст хэрэгт миний тэр байгаа юу, тэрийг заавал оруулж өгөөрэй гэж би гуйж байсан. 2011 оны 12 дугаар сард намайг нэг удаа асуусан. Тэрэн дээр тэр компани юу хийх талаар тодорхой заагаад өгчихсөн байгаа шүү гэдгийг би өөрөө хэлж байсан. Хавтаст хэрэгт тэр компанийн тэр баримт байхгүй байна лээ. Би тухайн үед хэргийн материал алга болгочихвоо гэж байцаагчид хэлж байсан. Хоёрт Нийслэлийн Засаг дарга бөгөөд ӨХК-ийн даргаар ажиллаж байхдаа дүүтэйгээ болон Г.М нартай бүлэглэн улсын өмчийг үрэн таран хийж, дүүдээ давуу байдал олгосон гэж ярьж байна. Өнөөдөр миний ганц барьдаг зарчим бол Монгол Улсын хууль тогтоомжийг би биелүүлэх юмсан гэж бодож явдаг. Тэрнийхээ төлөө ч би цэргийн алба хааж байхдаа тангараг өргөсөн. Хувьчлалын асуудал бол надаас өмнө болсон асуудал. 2003 онд зарлагдаад 2004 онд дүгнэгдээд явсан. 3 жилийн дараа үндсэндээ 3 жилийн гэрээ байгуулсан. Энэ хүрээнд энэ асуудал орж ирэхэд Өмчийн харилцааны газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар энэ байгууллагууд маань өөрсдөө жил болгон энэ ажлыг дүгнэж зохион байгуулдаг. Энэ ажлыг хийгээд 3 жил болчихлоо, энэ асуудлыг яах вэ гээд би өмч хувьчлалын комисст оруулсан. ӨХК 9 хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Тухайн үед 6 хүн энэ хуралд орсон байдаг. Би санахгүй

байж байгаад сүүлд хэргийн материалтай танилцаж байх үедээ санасан. Энэ комисс бол өнөөдөр асуудлын шийдвэрлэдэг эрх үүрэгтэй. Тэгэхээр энэ асуудал үндсэндээ Ц.Б гэдэг хүн бол ӨХК-ийн дарга байсан. Г.М болон Ц.Ч гэдэг дүүдээ давуу эрх хэзээ ч би олгож байгаагүй, би хэлж ч байгаагүй. Энэ хавтаст хэргүүдийн алинд нь ч байхгүй. Ц.Б гэдэг хүн ӨХК-ийн Г.М гэдэг хүнд хэдэн сарын хэдний өдөр тийм үүрэг даалгавар өгөөд энэ хэргийг хэрэгжүүлчихлээ, мөн ӨХК-ийн 5 гишүүн ингэж хийчихлээ гэсэн ямар нэгэн заалт энэ дотор байхгүй. Нотлох баримт байхгүй. Би өөрөө ч ингэж хүнд үүрэг даалгавар өгдөг хүн биш. Яагаад гэвэл би өөрөө бусдаараа үнэлүүлэх ёстой. Ц.Б гэдэг хүн буруу юм хийгээд буруу юм ярьж байвал доод хүн яг тийм хэмжээний шийдвэр гаргана. Багахангай дүүрэгт ажиллаж байсан үе үеийн хүмүүсээс асуухад энэ зарчмыг хатуу барьдаг байсан гэдгийг хэлнэ. Тэгээд үүнд нийгмийн салбарыг хувьчлах 5 үндсэн зорилго байсан. Үүнд нэгд ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг барьсан. Хоёрт үйлчилгээний төвшин буурахгүй байсан. Энэ сая өнгөрсөн гурван жилд энэ “СЗК”-ийн эмнэлэг улсын төсвөөс санхүүжилт авдаг байсан. Эхний жилд 5 хувь, дараагийн жилд нь 10 хувь, тэрний дараагийн жилд нь 15 хувийн санхүүжилт авдаг байсныг байхгүй болгосон. Мөн тэнд хэвтэж эмчлүүлж байгаа хүмүүсийн тоо нэмэгдсэн. Өнөөдөр Монголд “СЗКЭ” гэдэг бол бас хүн болгоны ялангуяа настай, тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн очдог газар болсон. Түүнд хэвтэх гэж өдөр шөнөгүй оочирлодог болсон.

Тийм учраас үйлчилгээний чанар сайжирсан. Гуравт чиглэл зорилго нь өөрчлөгдөөгүй. Энэ нь эмнэлэг байсан эмнэлгээрээ л байгаа. Дөрөвт ажилчиддаа эрсдэл дагуулахгүй байх ёстой байсан. Ажилчид нэмэгдсэн болохоос биш хасагдсан зүйл байхгүй. Ажилчдын цалин нэмэгдсэн, нийгмийн хамгаалал сайжирсан. Мөн боловсон хүчнээ сургаж бэлтгэхэд гол ажлууд хийгдсэн үндэслэлээр мэргэжлийн байгууллагууд хангалттай гэж дүгнэсэн. Дээрээс нь намайг бага үнээр өгсөн гэсэн асуудал ярьж байна. Өнөөдөр би бага үнийг юу гэж тооцож байгаа вэ гэхээр энэ “ЭЭС” гэдэг хөрөнгийн үнэлгээний ХХК манай ӨХГ-тай гэрээ байгуулж энэ байшинг тухайн үед үнэлүүлсэн. Тэгэхэд энэ байшин 324.000.000 төгрөгөөр үнэлэгдэж орж ирсэн. Намайг яллах дүгнэлтэд ...доод үнийг зөрчсөн байна

гэж ялласан байсан. Би үүнийг хамгийн доод үнэ гэж ойлгож байгаа. Тийм учраас хамгийн доод талын үнээс дээш ӨХК-т 3 санал орж ирсэн байдаг. 3 санал орж ирэхэд нь ярилцаад тэр Төмөр гэдэг хүн гурав дугаар хувилбараар нь үнэлье гэж хэлсэн байдаг. Яагаад гурав дугаар хувилбараар нь үнэлье гэж байгаа юм гэхээр аль ч байгууллагад бланс гэж байдаг. Яахын тулд баланс гаргадаг юм бэ, энэ байгууллагын үндсэн хөрөнгө, бүх элэгдэл хорогдол, зардлууд, орлогыг бүгдийг нь нэмж байж баланс гаргадаг. Үүнийг бүх хүмүүс мэдэж байгаа. Тэр балансын үнэ гэдэг бол хамгийн бодитой үнэ байдаг. Мэргэжлийн байгууллагын хүмүүс ч тэгж хэлж байгаа. Хамгийн түрүүнд ямар ч байгууллагад орж баланс үзье гэдэг. Гадна, дотны ч бай, хамтарсан ч бай танай байгууллагын баланс чинь ямар юм бэ гэдгийг үздэг. Тэгээд энэ компанид энэ балансын үнээр өгсөн. Тэрнээс биш доош нь аваачиж өгөөгүй. Балансын үнээр өгсөн нэг шалтгаан бол “СЗК” гэдэг бол ахмад настан, тахир дутуу иргэдэд үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний байгууллага. Энэ нь төрийн нэг ачааг авч явж байгаа. Нөгөө талаасаа энэ эмнэлэг нийгмийн даатгалаас санхүүжилт авдаг эмнэлэг. Энэ бол бизнесийн байгууллага биш. Тийм учраас үнийн асуудалд тэр үнийг л барьсан. Өнөөдөр СЗКЭ, Тэнгис кино театр хоёулаа нийслэлийн өмч. Тэгэхэд Тэнгис кино театр өдөр болгон хүнээс мөнгө авч ашгаа нэмэгдүүлдэг, харин СЗКЭ бол нийгмийн даатгалаас нэг хүн 150 төгрөг гэсэн бол түүгээрээ л санхүүждэг байгууллага. Энэ хоёрын ялгаа зарчим үүндээ байгаа юм. Тийм учраас үүнд эрхэм шүүгч нар, улсын яллагч нар анхаарлаа хандуулана уу. Тэрнээс биш Ц.Б гэдэг хүн аваачаад 360.000.000 төгрөгөөр улсыг хохироогоод, нийслэл Улаанбаатар хот хохирсон гэж би үзэхгүй байна. Хэрвээ тэр үед хувьчлаагүй хэвэндээ байсан бол Нийслэл өнөөдөр тэр эмнэлэгт мөнгө төлж байх үүрэгтэй байх байсан. Одоо нэгдүгээр эмнэлэг, хоёрдугаар эмнэлэг, гуравдугаар эмнэлэгт улсын төсвөөс мөнгө өгдөг. Яг тэрэнтэй адилхан. Тийм учраас эмнэлгийн үйлчилгээ сайжирсан, өрөө сайжирсан, иргэд нь сайжирсан, мөн боловсон хүчин сайжирч мэргэжил дээшлүүлэх гэж гадаад явсан. Энэ эмнэлэгт монгол улсдаа цус харвалтын дараах доктор хийж ирсэн ганцхан хүн ажиллаж байна. Яагаад гэвэл энэ эмнэлэгт тахир дутуу, цус харвасан хүмүүс очдог. Үүнийг эмчлэхийн

тулд би мэргэжлээ дээшлүүлэх ёстой гэсэн үүднээс хандаж энэ үйл ажиллагаа явагдсан гэдгийг товчхон хэлмээр байна. Тэгээд дээрээс нь бүлэглэсэн гэсэн асуудал огт байхгүй. Энэ хавтаст хэргийн алинд нь ч байхгүй. Ц.Б гэдэг хүн Г.М гэдэг хүнд үүрэг өгөөгүй. Түрүүний хэлсэн ӨХК-ийн 6 гишүүний шийдвэр байсан. ӨХК-ийн шийдвэр гэдэг бол хамтын шийдвэр байдаг. Яахаараа өнөөдөр Ц.Б гэдэг хүн ганцаараа хариуцлага хүлээдэг юм бэ. Хэрвээ хүлээх гэж байгаа бол ӨХК-ийн тэр шийдвэрийг гаргасан 6 гишүүн бүгд хариуцлага хүлээх ёстой. Өнөөдөр энэ хувьчлалын асуудлаас болж Нийслэл Улаанбаатар, ӨХГ хохирсон зүйл байхгүй.

Бизнес хийдэг байгууллага байсан бол нэг ондоо, хувийн эмнэлэг шиг өвчтөнөөсөө төлбөр авдаг байсан бол ондоо байх байсан. үүнийг та нар мэргэн оюундаа бодож өгөөрэй. Ц.Ч гэдэг хүн Ц.Б-тай төрсөн ах дүүгийн харилцаа байгаа болохоос биш эмнэлэг үйлчилгээний талаар ямар нэгэн холбоо байхгүй. Ажил төрлийн хувьд оролцоод явдаг зүйл байдаггүй. Ц.Ч гэдэг хүн надад нөлөөлсөн зүйл байхгүй. Энэ хүнд миний зүгээс давуу байдал олгосон зүйл байхгүй. Тэр үед 700.000.000 гаруй төгрөгөөр ав гэвэл энэ хүн авахгүй байсан байх. Тэр үед ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль гэж байгаагүй. Хэрвээ энэ хууль тэр үед байсан бол би хэзээ ч тэр хуралд орохгүй байх байсан. Ц.Б гэдэг хүний дүү учраас энэ хүн өнөөдөр чирэгдчихээд яваад байгаа юм. Дээрээс нь ХҮТ, "ЭЭС" ХХК нь хоёулаа улсаас итгэмжлэл авчихсан. Хөрөнгийн үнэлгээ хийж болно гэсэн зөвшөөрөлтэй байгууллагууд юм. Энэ хоёр байгууллагын хэнийх нь зөв гэж үзэх юм бэ. Шийдвэрлэж чадахгүй байсан юм бол гурав дахь хөндлөнгийн баг гаргах ёстой байсан. Үнийн хувьд өртгийн аргаар, зардлын аргаар, зах зээлийн аргаар бодсон гурван үнэ байсан. Тэгвэл энэ 700.000.000 төгрөг гэж байгаа үнийг зах зээлийн аргачлалаар бодож гаргасан байдаг. Үүнийг бас шийдвэр гаргахдаа харгалзаж өгөөрэй гэж хүсмээр байна. Тэрнээс би Н.Э, Э.Бш, мөн Г.М, Ц.Ч-тай бүлэглэн ямар нэгэн шийдвэр гаргаагүй, гаргах ч үгүй. Үүнийг би итгэл дүүрэн хэлж чадна" гэв.

Шүүгдэгч Г.М-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: "Ийм хэрэгт холбогдоод шүүгдэж байгаадаа харамсалтай байна. Надад ногдуулж байгаа үйлдэлд дор дурдсан тайлбарыг хууль журмын дагуу та бүхэнд

сонордуулахыг хүсэж байна. Нэгдүгээрт намайг Ц.Б-тай бүлэглэсэн гэж үзсэн байна. Би 2004 онд тэтгэврээ тогтоолгоод биеийн эрүүл мэнд муудаж, зүрхэндээ аппарат тавиулснаар бие сайжирч тэтгэвэр 105.000 төгрөгөөр тогтоосон учраас хотын даргаас ажил өгөөч гэж гуйсан. Тэгээд би 2005-2008 оны хооронд Нийслэлийн өмчийн харилцааны газарт хөрөнгө оруулалтын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа одоогийн биднийг буруутгаад байгаа, мөрдөөгүй гээд байгаа 2005 оны журмыг өөрөө боловсруулан, хурлаар батлуулж, мөрдөн хэрэгжүүлж, өмч хувьчлалын ажлаас хотын төсөвт 10,5 тэрбум төгрөгийг гаргуулж байсан. Ийм учраас би албан тушаалын төлөө Ц.Б-тай бүлэглэх, ашиг сонирхлын ямар ч зөрчил байхгүй. Би өөрөө тэтгэвэрт гарсан, албан тушаал сонирхоод байх зүйл байхгүй. Хоёрдугаарт миний хүүхдүүд бүгд биеэ даасан амьдралтай, өмч хөрөнгө хувьдаа ашиглах талаар ямар нэгэн холбоогүй. Өмч хувьчлалын хэлтсийн дарга гэдэг бол гүйцэтгэх албан тушаалтан. Иймд миний дээр Өмч хувьчлалын газрын дэд дарга, газрын дарга, нийслэлийн Засаг даргын орлогч байна, нийслэлийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ажлын хороодын дарга гэж байдаг. Олон шатаар энэ асуудал боловсрогдож, ярилцаж, хэлэлцэгдэж байж 2006 онд "СЗК"-ийн эмнэлгийг менежментийн үр дүнгээр хувьчлах нь зүйлтэй гэсэн шийдвэр хурлаас гарсан. Энэ шийдвэрийн дагуу асуудлыг боловсруулж, өргөн барьсан. Энэ асуудлыг би өөрөө боловсруулдаг хүн нь биш. Миний дор ажилтнууд байдаг. ӨХК-ийн шийдвэр хурлаар батлагдсаны дараагаар уг хувьчлагдах объектуудыг судлах, боловсруулах, мэдээлэх үүрэг бүхий итгэмжлэсэн төлөөлөгч засаг даргын захирамжаар томилдог. Энэ итгэмжлэгдсэн төлөөлөгч маань энэ бүхнээ боловсруулаад надаар хянуулаад гарын үсэг зуруулсан. Хоёрдугаарт намайг Нийслэлийн өмч хувьчлалын ажиллах журмыг хэд хэдэн удаа зөрчсөн гэж үзсэн байна. Тухайлбал Комиссын журмын 2.1.3-ыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөтөлбөрийн дагуу судлах ажлыг эрхлэн зохион байгуулж үр дүнг тайлагнах, хянах үүргээ зөрчсөн гэж байна. Би харин энэ үүргээ сайн зохион байгуулж байсан. Үүнийг манай өмч хувьчлалын нөхдүүд болон надтай хамт ажиллаж байсан хүмүүс хохирогчоор орж ирсэн байна. Өмч хувьчлалын ажлыг

би эмхэлж орлогын төлөвлөгөөг биелүүлж, менежментийн гэрээтэй олон байгууллагууд үр дүнг шалгаж, тодруулж, заримыг нь ухрааж, ажиллаж байсан. Комиссын журмын 2.1.7-д хувьчлах үйлдвэрийн газрын хувьцаа, ногдол хувь, битүүмжилсэн болон олон нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хянан батлах гэсэн байдаг. СЗКЭ бол ашиг олдог бизнесийн байгууллага биш. Иргэдэд түүний дотор ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, асаргаа сувилгаа шаардлагатай хүмүүст үйлчилдэг үйлчилгээний байгууллага. Бид түүнд хувьчлалын үнийг тогтоохдоо УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор гаргасан шийдвэр, хуульд төсвийн ачааллыг бууруулах тухай журмын ба Үндсэн хуулийн холбогдох заалт, менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах холбогдох заалтуудыг үндэслээд энэ асуудлыг шийдвэрлэсэн. Нийслэлийн өмчийг хувьчлах журмын холбогдох заалтуудыг бид зохих ёсоор нь биелүүлсэн. Үүнд намайг буруутгаж байгаа нэг заалт бол доод үнийн талаарх асуудал юм. Өөрөөр хэлбэл, СЗКЭ-ийг хамгийн бага үнээр хувьчилж улсад 360.000.000 төгрөгийн хохирол учруулсан гэж хэлж байна. Энэ 360.000.000 төгрөгийг гаргасан дүнг би сайн ойлгоогүй. Гэхдээ бид энэ журмаараа манай ажилтнууд, мэргэжлийн хүмүүс, үнэлгээ хийдэг мэргэжлийн хүмүүс байдаг. Манай өмч хувьчлалын мэргэжлийн ажилтнууд бол үүнийг боловсруулаад надад хоёр хувилбар танилцуулсан. Нэгдүгээр хувилбар нь 1999 оны Дэд бүтцийн сайдын журмаар баталсан зардлын аргаар үнэлж гаргана. Хоёрдахь арга нь тэрнээс хөрөнгө оруулалтыг нь хасаад, элэгдэл хорогдлыг нь хасаад 360.000.000 гаруй төгрөгөөр үнэлэх үнэлгээ, гурав дахь нь хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн байсан. Тэр нь бүр 334.000.000 төгрөгөөр үнэлсэн байсан. Би ямар санал оруулсан гэхээр 334.000.000 төгрөг чинь хамгийн бага байна. Хоёр дахь хувилбар нь хөрөнгө оруулалтыг хасаад, элэгдэл хорогдлыг хасаад үзэхэд бас үнэ нь бага байна. Тийм учраас балансын үнийг нь авч үз гэж үүрэг өгсөн. Энэ санал миний хувьд санал болохоос биш би шийдвэр гаргаагүй, асуудлыг өөрөө шийдээгүй гэж хэлмээр байна. Ер нь СЗКЭ бол улсад 360.000.000 төгрөгийн хохирол учруулсан биш харин миний бодож байгаагаар 2007 онд нийслэлийн төсвөөс 170.000.000 төгрөгийн татаас авдаг байсан. Үүнийгээ 10-15 хувь бууруулаад 2012 он хүртэл энэ

татаасаа аваад хэвээрээ байсан бол харин Нийслэлийн төсвөөс 800.000.000 төгрөгийн татаас аваад нийслэлийн төсвийг улам хүндрүүлэх байсан. Тэгээд юуг харгалзан хувьчилсан гэхээр нэгдүгээрт энэ эмнэлэг бол менежментийн гэрээний үүргээ 87.2 хувиар биелүүлсэн байна. Хоёрдугаарт жил бүр төсвийн ачааллыг 10-15 хувиар бууруулсан байна. Энэ бүгдийг харгалзаад энэ үнэлгээг хийвэл яасан юм бэ гэж ажилтандаа хэлсэн. Тэгээд хурлаар манай ажилтан танилцуулдаг болохоос биш би танилцуулдаггүй. Итгэмжлэгдсэн төлөөлөгч манай ажилтанд танилцагдаад өмч хувьчлалын комиссын хурлаар яригдаад хасагдаад шийдэгдээд хариу нь гарчихсан баримтуудыг би нарийн бичгийн даргын хувьд баталгаажуулдаг, албажуулдаг үүргийнхээ дагуу тэр тогтоол, худалдах худалдан авах гэрээ байгуулсан байна. Би СЗКЭ-ийн талаар хувьчлал хийхдээ янз бүрийн шан харамж авсан, эсвэл эндээс хувьцаа эзэмшил авсан зүйл өчүүхэн ч байхгүй. Би 71 настай, улсад 50 шахан жил зүтгэсэн. Энэ хугацаанд дандаа хоёргүй сэтгэлээр зүтгэж, харин ч шударга үнэний төлөө ажиллах гэж эрмэлздэг байсан. Тэрнийхээ төлөө ч би махан зүрхээ аппаратаар солиод, инээхээс бусад өвчин тусаж явж байна. Тийм учраас мэргэн шүүгчид прокурор та бүхэн намайг анхаарч энэ хэргийг хэрэгсэхгүй болгож өгөөч гэж хүсмээр байна" гэв.

Шүүгдэгч Ц.Ч-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: "Би өөрөө Анагаах ухааны их сургуулийг онц төгссөн. Анагаах ухааны чиглэлээр доктор хамгаалсан. Энэ чиглэлээрээ эрдэм шинжилгээний ажил хийж байсан. Тэгээд 2003 онд нийтийн хэвлэлд нийгмийн салбарыг хувьчлах дэр дундаа таван эмнэлгийг хувьчлах мэдээлэл гарсан байсан. Өөрийнхөө бололцоондоо тулгуурлаад энэ хувьчлалд оролцъё гээд баг бүрдүүлж орсон. Баг бүрдүүлж оролцсон цагаасаа амжилттай оролцож эхэлсэн. Үүнээс хойш гэрээний дагуу өөрийн ажлуудыг дэс дараалан гүйцэтгэж ирсэн. Хамгийн эхний ээлжинд барилга засвар үйлчилгээний асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэсэн эхний байр суурь байсан. Өмнө нь байсан энэ эмнэлгийн үндсэн чиглэл нь хүүхдийн клиник эмнэлгийн зориулалттай, бүх зүйл нь хүүхдийн зориулалттай, хэмжээ, талбай багатай, эмчилгээ үйлчилгээ үйлчлүүлэгч үйлчлүүлэх ямар ч нөхцөл бүрдээгүй, том том заал хэлбэртэй, сантехникийн болон шалны



асуудал нь хүндрэлтэй, хана нь суулт өгсөн, цахилгааны систем нь ил, маш их гэмтэлтэй байсан. Энэ байдлыг засвар хийхээс өмнө нь болон завсар хийсний дараах байдлыг гэрэл зургаар баталгаажуулсан байгаа. Мөн видео бичлэгээр хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө бичлэг хийсэн байгаа. Энэ эмнэлэгт хөрөнгө оруулалтыг бид гүйж очоод дураараа хийчээгүй. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраар албан ёсны дүгнэлтүүдийг гаргуулаад энэ байгууллагад ямар завсар үйлчилгээ хийх ёстой вэ гэдэг Улсын хяналтын газрын дүгнэлтийг гаргуулсан. Энэ дүгнэлтэд үндэслээд энэ дүгнэлтийг Нийслэлийн харилцааны өмчийн газар, Эрүүл мэндийн газарт ийм засвар үйлчилгээг хийх юм байна, ийм хөрөнгө оруулалтыг хийх үү гэдэг албан ёсны зөвшөөрлүүдээ авч хийж байсан. Нийслэлийн өмчийн газар луу албан бичгүүдээ явуулаад хөрөнгө оруулалтаа хий гэсэн бичгийн дагуу бид хөрөнгө оруулалтын ажлуудаа хийсэн. Хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө барилгын засвар, төслүүдийг хийлгээд, зураг хөргүүдийг нь хийлгүүлээд, Өмчийн газарт хийж дууссаныхаа дараа улсын комисст хүлээлгэн өгсөн. Албан ёсны акттай. Энэ актад барилгын засварын ажлыг хийгээд дууссаны дараа улсын комисс дээрээс нь Өмчийн харилцааны газрын төлөөлөл, Эрүүл мэндийн газрын төлөөлөл, гүйцэтгэгч компани байлцаж албан ёсны гарын үсгээ зурж ажлуудаа хийж дуусгасан. Ингэж дуусгасны дараа хууль ёсоор хийсэн хөрөнгө оруулалтаа хөрөнгө оруулалтын баталгааны бичгээр баталгаажуулж авсан. Ингэж баталгаажуулж аваад хөрөнгө оруулалтыг дэс дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн. Ингээд барилга байшин СЗКЭ-ийн үйл ажиллагаа, зориулалт, эмчилгээний шинэ төрлүүдийг бий болгоход хангалтгүй байсан. Засвар үйлчилгээнүүдийг өмнөх, хойнох зургуудаар баталгаажуулсан байгаа. Хоёрдугаарт энэ эмнэлэг маань өөрөө хүүхдийн зориулалттай эмнэлэг байсан учраас тоног төхөөрөмж нь бидний бий болгох гээд байгаа эмнэлэгт тохирохгүй, тоног төхөөрөмж нь дандаа хүүхдийн зориулалттай, эвдэрсэн тавилгатай байсан. Ор нь хүртэл хүүхдийн ор байсан. Ингээд үйлчлүүлэгч тохитой үйлчлүүлэх боломж байхгүй байсан учраас бид оношилгооны тоног төхөөрөмжиндөө хөрөнгө оруулалтыг хийсэн. Хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө албан ёсны дүгнэлтээ гаргуулаад саналаа аваад хийсэн тоног төхөөрөмжөө бүгдийг

нь зургаар баталгаажуулсан байгаа. Үүний дараа хөрөнгө оруулалт хийсэн тухай барилгын хөрөнгө оруулалт хийсэн гэрчилгээ болон тоног төхөөрөмж эд хогшилдоо хөрөнгө оруулалт хийж гэрчилгээг баталгаажуулж авсан. Гуравдугаарт гол зорилго нь эмчилгээ үйлчилгээний нэр төрлүүдийг нэмсэн. СЗКЭ-т сэргээн засах эмчилгээний ямар нэгэн төрлүүд байхгүй байсан. Манай багт мэргэжлийн эмч нар байсан учраас эмчилгээний маш олон төрлүүд нэмэгдсэн. Жишээлбэл бариа засал нь толгой, хөл бариад орхидог байсан бол хүний организм бүхэл бүтэн учраас бүх биеийг барьж байж хүний биеийн цусан хангамжийг дээшлүүлж байж эмчилгээ сайжирдаг. Энэ утгаараа олон эмчилгээний төрлүүд усан эмчилгээ, шавар эмчилгээ зэрэг олон эмчилгээний төрлийг бий болгож үүний үр дүнд эмчилгээний чанар сайжирсан. Мөн түүнээс гадна хүний нөөцийг хөгжүүлэх асуудал бол хэдий байшин барилга тоног төхөөрөмж сайжирсан боловч боловсон хүчин өөрөө сайн байхгүй бол сайн үйлчилгээ үзүүлэх боломжгүй гэдэг утгаараа багийн хөрөнгө оруулалтаар сэргээн засалт, нөхөн сэргээх эмчилгээний эмч сувилагч нарыг бэлтгэсэн. Ингэж мэргэжлийн эмч сувилагчтай болсноороо манай эмчилгээ үйлчилгээний чанар сайжирсан. Дээрээс нь цаашид энэ сэргээн засах эмчилгээний мэргэжилтэн монгол улсад байдаггүй, ерөөсөө хоёр доктор саяхан бэлтгэгдэж ирсэн. Цаашид энэ эмнэлгийг хөгжүүлэх, боловсон хүчин хөгжүүлэх зорилгоор хүмүүсээ сургасан. Мөн гадаад харилцаагаа хөгжүүлэх, ажилчдынхаа мэргэжил боловсролыг дээшлүүлэх гэж Япон улсад сургасан. Сургалтынх нь зурагнууд энд байна. Япон улсад хоёр их эмч, нэг эмч, сувилагч, Хятад улсад зургаан их эмч, хоёр сэргээн засахын сувилагч нарыг бэлтгэсэн байгаа. Ингэж энэ олон үйл ажиллагааны үр дүнд манай эмнэлгийн эмчилгээний үзүүлэлтүүд эрс сайжирсан. Энэ үзүүлэлтээс та бүхэнд үзүүлье. Энэ нь графикаар гараад ирсэн байгаа. Хамгийн гол нь эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр 2005 онд 93 хувьтай хүргэсэн бол 2013 онд 98 хувьд хүргэсэн байна. Эмч ажилчдын боловсон зан харилцаа өссөн. Ор хоногийн ашиглалт хүүхдийн зориулалттай байсан учраас маш бага байсныг өсгөж чадсан. Эрэлт хэрэгцээ өссөөр байгаа. Улсын төсвөөс 2007 оноос хойш ямар ч татаас авахаа больсон. Эрүүл

мэндийн даатгалаас өөрийнхөө орлогыг авч байгаа. Зуны сувилал зэргийг өөрсдийнхөө хөрөнгө оруулалтаар байгуулсан. Эмчилгээний үзүүлэлт сайжирсан гэж үзэж аудитын байгууллага болон бусад хяналтын байгууллага үзэж хянасан учраас манайх гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн гэж үзэж хувьчлах шийдвэр гарсан байх. Одоо намайг буруутгаж байгаа асуудал бол эмнэлгийг хувьчилж авсан үнийн асуудлаар буруутгаж байгаа. Үнэ гэдэг ойлголт бол надад огт хамаагүй асуудал. Үнийн асуудалд би саналаа өгөх эрхгүй, би ийм үнээр авъя гэж саналаа өгөх эрхгүй, комиссын хуралд би оролцох эрхгүй, тэр үнэлгээг би өөрөө оруулдаггүй, хаа хамаагүй юмаар надад хэрэг үүрүүлээд яллаж байгааг ойлгохгүй байна. Би үнийн саналд би ямар ч оролцох эрхгүй. Гэрчийн мэдүүлэгт өмч хувьчлалын үнийг тогтоох үүрэг зөвхөн Өмч хувьчлалын комиссын асуудал юм гэж мэдүүлсэн байгаа. Тэгэхээр энэ комисст би өөрөө ордог ч үгүй, байдаг ч үгүй, санал өгдөг ч үгүй юм чинь үнийн асуудалтай холбоотой ямар ч асуудалд холбоогүй. Ийм учраас энэ асуудалд хаана хаана бодолцож үзэн намайг цагаатгаж өгөөч гэж хүсэж байна. Миний хувьд улс төрчийн дүүгийнхээ хувьд ял үүрэх гээд байгаа юм болов уу гэж бодож байна. Тэрнээс биш надад эд нарт хамжиж туслах ямар ч бололцоо байхгүй. Яаж хамжиж тусалсан гээд байгааг ойлгохгүй байна. Ийм үндэслэлгүй заалтаар намайг яллаад байгаад харамсаж байна. Үүнийг үнэн зөвөөр шийдэж өгөөч гэж хүсмээр байна" гэв.

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Ч.МБ-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: "...УТ" сонин НӨҮГ-ыг хууль бусаар хувьчилж учруулсан хохирол арилсан тул шүүгдэгчээс нэхэмжлэх зүйл байхгүй. Уг хөрөнгө нь Нийслэлийн өмчийн харилцааны газрын хөрөнгөнд бүртгэгдсэн байгаа" гэв.

Хохирогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.А-ийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн: "...Ө" зочид буудал НӨҮГ-ыг хууль бусаар хувьчилсан хэргийн хувьд хохирол төлөгдсөн буюу нийслэл өмчөө өөртөө авсан байгаа. "СЗК"-ийн эмнэлгийн хувьчлалын хувьд манай байгууллагын зүгээс ХҮТ ХХК-ийн гаргасан үнэлгээг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд уг үнэлгээнээс хөрөнгө оруулалт, хувьчилсан үнийг хасаж үлдэж байгаа 360.736.300 төгрөгийг нэхэмжилж байна" гэв.

Гэрч Т.Ос-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Би "Ө" НӨҮГ-ын 2 удаагийн танилцуулгыг

үзэж харлаа. Эхний Нийслэлийн Засаг дарга Ц.Б-аас НИТХТ-ийн дарга Н.Б-д 2007 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 1/1386 дугаартай "Ө" НӨҮГ-ын Ө, Д зочид буудлуудын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх, менежментийг сайжруулах талаар цаашид арга хэмжээний тухай саналуудыг өргөн барьж байна гэсэн албан бичиг болон Нийслэлийн өмчийн харилцааны газраас "Ө" НӨҮГ-ын "Ө" зочид буудлын үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөн байгуулах тухай танилцуулгыг бичээгүй. Харин Нийслэлийн Засаг дарга Ц.Б-аас, НИТХТ-ийн дарга Н.Б-д 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/1724 дугаартай "Ө" НӨҮГ-ыг татан буулгаж нийслэлийн өмчийн 25 хувийн оролцоотой "ДӨ" ХХК шинээр зохион байгуулах тухай буюу "Хөрөнгө оруулалт хийлгэж хамтарсан компани байгуулах тухай" албан бичгийн төсөл мөн "ХД" Ххк-аар хөрөнгө оруулалт хийлгэн, нийслэлийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн өмчийн харилцааны газар /М.ГБ/-т даалгасугай гэсэн төсөл зэргийг миний бие боловсруулсан. Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д 2007 онд зун байсан өрөөндөө мэргэжилтэн Ц.Су, мэргэжилтэн н.Б болон намайг дуудаж "Ө" зочид буудал НӨҮГ-ын талаарх танилцуулгыг ярилцаад бичээдэх гэсэн. Үүнийх нь дагуу би Ц.Су-гаас "Ө" зочид буудал НӨҮГ-ын талаарх материал байсныг аваад танилцуулгаа бичих гэхэд материал дутуу байсан учраас н.Б дээр очиж "Ө" зочид буудал НӨҮГ-тай холбоотой материалууд дутуу байна, таньд материал байна уу гэхэд сейфнээсээ тус газартай холбоотой 1 хавтас материал гаргаж өгөхөөр нь дотроос нь мэдээллийг аваад танилцуулгыг би бичсэн. Улмаар урд нь хариуцан ажиллаж байсан н.Б-д бичсэн танилцуулгаа уншуулахад болж байна гэхээр нь дээрх танилцуулгыг Д.Д даргад оруулж өгсөн. Үүний дагуу надаар "Ө" зочид буудал НӨҮГ-ыг татан буулгах тухай захирамжийн төсөл мөн Нийслэлийн Засаг даргын захирамж, Хамтарсан компани байгуулах төсөл, "Ө" зочид буудал НӨҮГ-ыг татан буулгах тухай комисс буюу Засаг даргын захирамжийн хавсралтын төсөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, /НӨХГ/, "ХД" ХХК-ийн хамтарсан "ДӨ" ХХК-ийн хариуцлагатай компанийн гэрээ төсөл хэлбэрээр, Нийслэлийн Засаг даргын тамгын газар /НӨХГ/, "ХД" ХХК-ийн хамтарсан

"ДӨ" ХХК-ийн хариуцлагатай компанийн дүрэм зэргийг төсөл хэлбэрээр бичиж өгсөн. Миний бичсэн дээрх төслүүдийг Д.Д дарга хүлээж аваад засвар хийгээд өгсөн. Түүнийх нь дагуу янзлаад Д.Д даргад төсөл хэлбэрээр өгсөн. Одоо надад засвар хийсэн төслүүд нь байна. Д.Д дарга компанийн дүрмийг боловсруулахад нийслэлийн 25 хувийн, хувийн өмчид 75 хувь гэж тооцож төслийг янзлаад оруулаад өг гэсэн юм. Гэхдээ өмнө нь Нийслэлд 51 хувь, хувьд 49 хувь, нийслэлд 34 хувь, хувьд 66 хувийг гэсэн хувилбарууд явж байсан. Энэ хоёр хувилбараар дүрэм, үүсгэн байгуулах гэрээ хоёрыг төсөл хэлбэрээр эхлээд боловсруулж авч байсныхаа дараа Д.Д дарга нийслэлийн 25 хувь, хувийн өмчид 75 хувь гэж тооцож төслийг оруулж ирэх үүргийг өгсөн. Өөр бусад асуудлыг мэдэхгүй байна" гэсэн мэдүүлэг /хх-73-77/.

Гэрч Ц.Су-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "...2007 оны зун Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д намайг болон мэргэжилтэн н.Б, Т.Ос нарын хамтаар өрөөндөө дуудаж "Ө зочид буудал" НӨҮГ-ын талаарх танилцуулгыг ярилцаад бичээдэх гэсэн үүрэг даалгавар өгөөгүй. Мөн надаас Т.Ос мэргэжилтэн "Ө" НӨҮГ-тай холбоотой материал аваагүй. Миний хувьд би "Ө" НӨҮГ-ыг 2007 оны 4 дүгээр сараас 2008 оны 09 дүгээр сарыг хүртэлх хугацаанд хариуцаж байсан нь үнэн. Уг нь хариуцсан мэргэжилтэн би иргэдийн хуралд өргөн барих ёстой "Ө" НӨҮГ-тай холбогдолтой танилцуулга болон бусад нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, компанийн дүрэм, гэрээ гэх мэт холбоотой материалуудыг төсөл хэлбэрээр боловсруулах ёстой юм. Гэтэл өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Т.Ос дээрх материалыг боловсруулсан байна" гэсэн мэдүүлэг /хх-14-н 204-205/.

Гэрч Ж.Э-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Төрийн өмчит үйлдвэрийн газар болох Нийслэлийн "Ө" зочид буудлыг 1995 оны 07 сарын 25 нд анх байгуулж Чингэлтэй дүүргийн 1 хороо, Худалдааны гудамж М-100 дугаар байр буюу гутлын 22 дугаар дэлгүүр байсан байрны зүүн хэсэг буюу 6 дугаар орцонд буудлын үйл ажиллагаа явуулах болсон юм. Миний бие 1999 оны 02 дугаар сараас тус "Ө" зочид буудал буюу ТӨҮГ-ын захирлаар томилогдон ажилласан. 2001 онд Зайсан дахь ТӨҮГ болох "Д" зочид буудлыг "Ө" зочид буудалтай нэгтгэж нэг байгууллага болгосон... Гэтэл дээрх 2 ТӨҮГ-ыг 2007 оны

10 сарын 17-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 188 дугаар тогтоол, мөн Нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 сарын 07-ны өдрийн 555 тоот захирамжаар "Д" болон "Ө" зочид буудлыг татан буулгаж, хамтарсан компани байгуулж байгаа нэрээр "ХД" ХХК-д ямар ч өрсөлдөгчгүйгээр сонгон шалгаруулалт тендергүйгээр шилжүүлж төрийн өмчийг тус компанид үнэгүй бэлэг болгож өгсөн. ...ТӨҮГ байхдаа үйл ажиллагаа нь жигд явагддаг. Хотын захиргаанаас ямар ч санхүүгийн дэмжлэг туслалцаа авахгүйгээр өөрөө өөрсдийгөө санхүүжүүлдэг байсан. 2006 оны жилийн эцсийн тайлангаар 500.000 төгрөгийн алдагдалтай ажилласан. Бусад онуудад нь дандаа л ашигтай ажиллаж байсан...Дээрх объектыг "ХД" гэдэг нэртэй байгуулагдаад 10 ч хоноогүй 1 сая төгрөгийн дүрмийн сантай Б.Х гэдэг залууд бөөнөөр нь ямарч өрсөлдөгчгүйгээр өгч байгаа юм бэ? Үүнийг л шалгуулах гэсэн юм. Энэ асуудлын цаана ямар эрх ашиг, хэдэн төгрөгийн хээл хахууль, төрийн өмчийн том луйвар явагдаж байгааг шалгуулах хүсэлт гаргаж байна...2007 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Засаг дарга Ц.Б нь "Ө" ТӨҮГ-ийн "Ө", "Д" зочид буудлуудын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх, менежментийг сайжруулах талаар саналаа хүргүүллээ. Хуралдаанаар шийдвэрлэнэ үү гэсэн албан бичиг явуулж байсан. Үүнийх нь хариуд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007-09-06-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор "Ө" ТӨҮГ-ын "Ө", "Д" зочид буудлуудын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл сонгон шалгаруулалт явуулж дүнг 2007 оны 10 сард багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга Ц.Б-т зөвшөөрсөн тогтоол явуулсан байсан. 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг дарга Ц.Б нь 1/1724 дугаартай албан бичгээр "Ө" зочид буудал ТӨҮГ-ыг татан буулгаж хөрөнгө оруулалт хийлгэж хамтарсан компани байгуулах тухай албан бичигт 25%-ийн төрийн өмчит, 75%-ийн өмчтэй "ДӨ" ХХК шинээр зохион байгуулах асуудлыг өргөн барьсан байна. Ингээд л хоёр хоногийн дараа буюу 2007 оны 10 сарын 17-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Тэргүүлэгчдийн 188 дугаар тогтоолоор ТӨҮГ-ыг татан буулгахыг Засаг дарга Ц.Б-т даалгасан байна. Ингээд л Ц.Б 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр ТӨҮГ-ыг татан буулгаж хамтарсан компани байгуулах 555 тоот захирамж гарсан..." гэсэн мэдүүлэг /хх-14-н 100-104/,

Гэрч Э.Бш-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Би АНУ-д сурч байхдаа Монголд "Р" гэж компанийг 1 гишүүнтэйгээр бизнесийн үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулсан. Дүрмийн сангаа санахгүй байна. Би энэ компани байгуулах саналаа тухайн үед аавын туслахаар ажиллаж байсан Б.Ту гэж хүнд хэлсэн. Тэр хүн миний нэрээр энэ компанийг байгуулсан. Би "Э" гээд аавын дүү болох Н.Эн эгчийн компанид шилжүүлсэн байгаа. Би 2007 онд "ХД" ХХК нэртэй охин компани байгуулах шийдвэр гаргасан. Тэгээд тэр компанийнхаа захирлаар аавын туслах Б.Ту-ын ах Б.Х-ийг томилсон. "ХД" ХХК-ийг үүсгэн байгуулахад би Монголд байгаагүй. Үүсгэн байгуулах бичиг баримтыг Б.Ту бүрдүүлсэн. Нийслэлийн өмчит "Ө" Зочид буудлын хувьчлалын талаар мэдэхгүй..." гэсэн мэдүүлэг /хх-14-н 139-140/,

Гэрч С.О-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Би Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр 2004-2008 онуудад ажилласан... НӨҮГ болох "Ө зочид буудал"-ын 75 хувийг "ХД" ХХК-д эзэмшүүлье гэснээс өөр ямар нэгэн сонголтгүй байсан. Сонгон шалгаруулалт явуулалгүйгээр хууль бусаар нийслэлийн өмчийг шилжүүлсэн гэж үзсэн. Яагаад заавал нийслэлийн 25% гэж оруулж ирснийг ойлгоогүй. Мөн би саналдаа "Ө", "Д" гэж хоёр объектийн нэгийг нь зараад нөгөөд нь хөрөнгө оруулах боломжтой. Заавал хувийн аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх шаардлагагүй гэдгийг хэлсэн. "ХД" ХХК-д ямар ч сонголтгүйгээр өгсөн нь хууль бус гэж үздэг...Нийслэл өмчөө аваад явах боломжтой байсан..." гэсэн мэдүүлэг /хх-14-н 141-142/,

Гэрч М.Э-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...“Ө” зочид буудал"-ыг "ХД" ХХК-тай хамтарсан компани байгуулахад өмчийн харьцаа 51:49 ч бай, 75:25 ч бай хамтарсан аж ахуйн нэгжүүдийн хувьд төсөл сонгон шалгаруулалт явуулж хэвлэл, сонинд зар өгч тодорхой шалгуур хангасан хөрөнгө оруулалт хийх тийм боломжтой шаардлагыг хангасан аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтын зарчмаар сонгох ёстой..." гэсэн мэдүүлэг /хх-15-н 61-63/,

Гэрч Г.Бж-ын мөрдөн байцаалтад

өгсөн: "...Б.Ту нь 2010 оны 02 сарын 08-ны өдөр "Э" ХХК-ийн хувьцааны 25 хувь буюу 894600 төгрөгийн үнэ бүхий 250 ширхэг хувьцааг өмчлөх эрхээ хариу төлбөргүйгээр Н.Э-т шилжүүлэхээ зөвшөөрсөн хувьцаа шилжүүлэх гэрээ, Н.Э нь 2010 оны 02 сарын 28-ны өдөр "Э" ХХК-ийн бүх хувьцааг Н.Эн-д хариу төлбөргүйгээр шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээ, Э.Бш нь 2010 оны 03 сарын 03-ны өдөр "Р" ХХК-ийн 100 хувь хувьцааг хариу төлбөргүйгээр, эргэлт буцалтгүйгээр "Э" ХХК-д шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээнүүдийг баталгаажуулах үед иргэн Н.Э, Н.Эн, Э.Бш, Б.Ту нар нотариатч дээр өөрсдийн биеэр хүрэлцэн ирээгүй. Надтай өмнө Хууль зүйн яаманд хамт ажиллаж байсан Ш.Р ирж уулзаад дээрх гэрээнүүдтэй холбоотой бичиг баримтыг бүрдүүлж ирээд батлаад өгөөч гэж хүсэлт тавьсны дагуу би баталгаажуулж өгсөн. Энэ хүмүүс ажил ихтэй болохоор өөрсдийн биеэр хүрэлцэн ирж амжихгүй гэж хэлдэг байсан. Нотариатч хүн аливаа гэрээ хэлцлийг баталгаажуулахдаа гэрээ хэлцэл хийж байгаа хүнийг өөрсдийн биеэр байлцуулах үүрэгтэй .." гэсэн мэдүүлэг /хх-15-н 55-56/,

Гэрч Ш.Р-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Би нотариатч Г.Бж-ыг танина. Бид 2 Хууль зүйн яаманд хамт ажиллаж байсан. Г.Бж нотариатч дээр очиж Н.Э даргын хамааралтай хэд хэдэн гэрээг баталгаажуулж байсан. / гэрээнүүд болон нотариатчийн дэвтэрийн хуулбарыг үзүүлэв. /Би гэрээнүүдийг харахад "Р", "Э"-ын 25 хувь, "Э" бүхэлдээ Н.Эн руу шилжсэн гэрээнүүдийн төсөл миний бэлдсэнээр байна. Уг гэрээнүүдийн текст агуулгыг би бичсэн. Гэрээ байгуулах дарааллын хувьд миний бэлтгэсэн гэрээний төслийг Б.Х аваад Н.Эн, Э.Бш, Б.Ту нараар гарын үсэг зуруулж надад өгөхөөр би Н.Э даргаар гарын үсэг зуруулж байсан. Дээрх гэрээнүүдийн аль нэг дээр Б.Х бид 2-ын дунд маргаан үүсч байсан. Би Б.Х-т энэ хүнээр яаж гарын үсэг зуруулаад байгаа юм бэ, энэ хүн чинь Монголд байгаа юмуу, итгэмжлэл байгаа юмуу гэхэд итгэмжлэл байгаа гэсэн. Би тэгэхээр нь итгэмжлэл байгаа юм бол чи өөрөө гарын үсэг зураач гэхэд итгэмжлэл байгаа өөрсдөөр нь гарын үсэг зуруулсан гэж хэлсэн. Н.Э дарга ийм гэрээ хийх хэрэгтэй байна гэсний дагуу би төслийг бэлдэж өгсөн. Цаад учир шалтгааныг би мэдэхгүй..." гэсэн мэдүүлэг /хх-14-н 135-136-137/,

Д.Д-ийн сэжигтнээр мэдүүлсэн: "...2006 оны 5 дугаар сараас өнөөдрийг хүртэл

Нийслэлийн өмчийн харилцааны орлогч даргаар ажиллаж байна..."ХД" ХХК өөрийн оруулах хэмжээг Засаг дарга Ц.Б-т тавьсан. Манайд шууд хандаагүй. "ХД" ХХК-ийг манай газраас сонгоогүй, Засаг даргаас оруулж ирсэн юм. Нийслэлийн Засаг дарга Ц.Б үүрэг өгсөн. Манай байгууллага бол Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг юм. Тэгэхлээр 2007 онд "Ө" зочид буудал НӨҮГ-ыг 51:49 хувь болгох талаар танилцуулгыг хэн боловсруулсныг мэдэхгүй. Харин Хөрөнгө оруулалт хамтарсан компани байгуулах тухай танилцуулгыг би мэргэжилтэн Т.Ос-д үүрэг өгч бичүүлж байсан. 2007 оны 555 дугаар захирамжийн төслийг харлаа. Би боловсруулсан юм байна. Захирамж, тогтоолын төслийг боловсруулах талаар зохицуулсан дүрэм, журам байхгүй. "ДӨ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд миний бие Засаг дарга Т.Б-ийн захирамжаар томилогдсон. "ХД" ХХК-аас "Ө" зочид буудал НӨҮГ-т 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Хөрөнгө оруулалтыг баталгаажуулж өгөөч ээ гэсэн хүсэлт ирүүлсэн. Үүнийх нь хөндлөнгийн экспертиз оруулахад 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна гэж гарсан...2007 оны НЗД-ын 555 тоот захирамжийг миний бие боловсруулаагүй. Харин Засаг даргын Тамгын газраас албан ёсны бланк дээр бичигдсэний дараа Тамгын газрын бичиг хэргээс авахдаа гарын үсэг зурсан байна. Харин хянаж гарын үсэг зурсан..." гэсэн мэдүүлэг /хх-16-н 89-93/.

Хохирогч Л.С-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "...2004 онд Улсын Их Хурлын гишүүн Т.Бж Д.Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэрийн барилга буюу "УТ" сонины газрын менежментийн хувьчлалд Ж.Сар ахлагчтай баг тендерт оролцон ялсан тул намайг хөрөнгө оруулахыг санал болгосны дагуу 493 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн боловч "УТ" сонин менежментийн багт оруулалгүй 2008 онд Д.Ч-ыг менежментийн багт гишүүнээр оруулж багийн ахлагчаар томилж, УТ сонины газрыг хувьчилж авч онц их хэмжээний хохирол учруулсан. Т.Бж нь "УТ" сонин менежментийн багийн гишүүдэд О.А нь Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э-ын эхнэр, О.Ц-ийн, Зам тээвэр, барилга, хот байгууллалтын яамны дэд сайд А.Гс нь Ерөнхий сайд С.Б-ын, Н.А нь шадар сайд М.Э-ын, Б.У нь ХХААХҮЯ-ны сайд Т.Бж-гийн, Б.Со нь УИХ-ийн гишүүн Ц.Да-ийн төлөөлөл гэж танилцуулсан. Тухайн үед би Т.Бж-гийн

хүсэлтээр намд нь 20 сая төгрөг тухайн үед өгсөн..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 165-182/.

Гэрч А.Гс-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Олон жил өнгөрсөн учраас он, сарыг тодорхой санахгүй байна. УТ сонины эрхлэгч Ж.Сар 2003 оны сүүлээр шиг санаж байна уулзаад Менежментийн хувьчлалын талаар хуулийн зөвлөгөө авсан юм. "УТ" сонины менежментийн хувьчлалд манай багт нэрээ оруулаад цаашид хуулийн зөвлөхөөр ажиллаад өгөөч гэсэн санал тавьсан. Миний хувьд тухайн үед өмгөөлөгчөөр ажиллаж байсан учраас өмгөөллийн гэрээ хийж ажиллаж гэсэн. Ж.Сар менежментийн багт гишүүнээр ороод цаашид хууль зүйн үйлчилгээ авъя гэсэн саналыг надад тавьсан юм. Ингээд би Ж.Сар-гийн удирдсан менежментийн багт гишүүнээр орж ажиллахаар болж менежментийн багийн гишүүний материал бүрдүүлж өгөхөөр болсон. Би өөрийн анкет болон бичиг баримтыг баталгаажуулан Ж.Сар-гийн нарийн бичигт нь өгсөн. Ж.Сар тухайн үед УТ сонины эрхлэгчээр ажиллаж байсан юм. Түүнээс хойш Ж.Сар-тай би дахин уулзаагүй учир нь Ж.Сар-гийн ахалсан менежментийн баг тус хувьчлалд ялсан эсэхийг би мэдээгүй. Түүнээс хойш Ж.Сар надтай уулзъя гэж яриагүй, уулзаагүй, би ч гэсэн түүнтэй уулзаагүй. Миний хувьд ажил төрөлдөө болоод уг асуудлыг ч гэсэн мартсан байна лээ. Өөрөөр хэлбэл, миний хувьд Ж.Сар-гийн санал болгосноор хууль зүйн үйлчилгээ үзүүлэхээр тохиролцоод л анкет бичиг баримтын хуулбараа өгч байсан түүнээс хойш юу болсныг нь мэдэхгүй байна. Тэр баг нь хувьчлалд ялсан эсэх, одоо ямар байдалтай байгаа зэргийг мэдэхгүй байна.

...Л.С нь 2006 оны намар билүү 2007 оны хавар ч билүү надтай ирж уулзаад би УТ сонины менежментийн багт хөрөнгө оруулалт хийгээд гишүүн болох гэсэн юм чи тус менежментийн багийн гишүүн нь юм байна, оруулсан хөрөнгө мөнгөө авч чадахгүй болчихлоо туслаач гэсэн утгатай зүйл ярьж надтай уулзсан. Би тус багийн гишүүнээс цаашгүй одоо надад энэ талаар мэдэж байгаа юм алга. Ж.Сар-тай уулзъя боломжтой бол туслъя гээд л өнгөрсөн. Л.С нь надад чамайг Ж.Сар гадаадад байдаг Монголд байдаггүй гэх юм ярьж байсан. Би Л.С-д тус менежментийн багийн үйл ажиллагаанд огт оролцдоггүй гэдгээ хэлсэн. Ингээд л түүнээс хойш Л.С над руу яриагүй би ч Ж.Сар-тай уулзаагүй тэгээд л өнгөрсөн.

Ач холбогдол өгч хөөцөлдөөгүй юм..." гэсэн мэдүүлэг /хх-236-238/,

Гэрч Н.Ат-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Менежментийн багийн үйл ажиллагаанд би сонины нийтлэлийн бодлогоо хариуцаж ажиллаж байсан учир төсөлд заасны дагуу ажлаа явуулсан. Санхүүгийн талаар бол би сайн мэдэхгүй байна. 2004 ондоо үйл ажиллагаа гайгүй л явж байсан, бид цалингаа цаг хугацаанд нь аваад явж байсан. Манай сонин өөрийн байртай, түүндээ түрээслэгч нар ихтэй байсан. Мөн хэвлэх үйлдвэрээ ажиллуудаг орлого олдог байсан учир үйл ажиллагаа гайгүй байсан. Би 2004 оны 7 дугаар сараас 2005 оны 4 дүгээр сарыг хүртэл аав маань өвчтэй байгаад нас барсан, дараа нь өөрөө өвдсөн зэрэг шалтгаанаар явж байгаад ажилдаа ирэхэд манай ажил хуучин байрнаасаа нүүгээд СУИС-ийн баруун талд "Хг" гэж ХХК-ийн байранд очсон байсан. Энэ хоорондох асуудлын талаар би мэдэхгүй байна, ингээд нүүснээс хойш үйл ажиллагаа доголдож эхэлсэн, хүмүүс ажлаасаа гарч эхэлсэн. Цалин хугацаандаа тавьж чадахаа байсан. Тэгээд татвар, нийгмийн даатгалын өр ширэнд орж эхэлсэн юмаа. Л.С хөрөнгө оруулагч гэж Ж.Сар-тай гэрээ байгуулсан байсан. Тэрнээс багийн гишүүнээр элсээгүй болно. Харин 2007 оны 07-р сараас 2008 оны 08-р сар хүртэл би сонины ерөнхий эрхлэгчээр ажиллаж байсан. Тэгэхэд Л.С өргөдөл гаргаад менежментийн багт гишүүнээр оръё гэж байсан. Бид гишүүнээр элсүүлэх зөвшөөрөл хүсэж Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүсэлт гаргасан боловч НӨХГ-ын дарга М.Гб-аас хариу ирсэн. Уг хариунд багт гишүүнээр элсүүлэх асуудлыг манайх дангаар шийдэхгүй. Тиймээс Нийслэлийн өмч хувьчлах комиссын хурлаар шийдэх ёстой гэсэн хариу өгсөн. Тэгээд энэ асуудал шийдэгдээгүй. Дахин энэ асуудлын талаар ч хүсэлт тавиагүй болно. Ж.Сар бол тухайн үед сонины эрхлэгчийн ажлаа өгчихсөн багийн ахлагч байсан. Д.Ч надтай уулзаад сониныг сонирхож ажил байдал явцын талаар асууж байсан. Мөн ерөнхий эрхлэгчээр ажиллах хүсэлтэй байгаагаа хэлж байсан. Би ч ерөнхий эрхлэгчийн ажлаа өгөх хүсэлтэй байгаагаа хэлж байсан. Ингээд би Ж.Сар даргатай яриад энэ хурлыг зарлаж хуралдуулаад энэ хуралд Д.Ч-ыг би урьж оролцуулсан юмаа. Намайг ерөнхий эрхлэгчийн ажлыг Д.Ч-т өгөхөд Ж.Сар дарга би энэ сонинд ажиллахгүй байгаа юм

чинь багийн ахлагчийн ажлаа өгмөөр байна гээд ажлаа өгсөн юмаа. Д.Ч-ыг ерөнхий эрхлэгчээр ажиллуулъя гэсэн саналыг би гаргасан. Багийн гишүүн, ахлагчаар ажиллуулах саналыг Ж.Сар дарга гаргасан болно.

Д.Ч захирал У бид 2-ыг дуудаад Ту компанийн хавьцаа ресторанд уулзаж хөрөнгө оруулах боломжгүй бол хувьцаагаа зараад гарвал та 2-т тус бүрт чинь 30 сая төгрөг болж байна болох уу гэсэн юм, түүнийг нь бид хоёр зөвшөөрч 30 сая төгрөг аваад компаниас гарахаар болсон юмаа. Тэгээд намайг ажлаас гарсны дараа 2010 оны 6 дугаар сарын орчим байх Д.Ч захирал над дээр ирж 30 сая төгрөг өгсөн, мөн У-гийн 30 сая төгрөгийг надад өгөөд би түүнд эмнэлэгт хэвтэж байхад нь очиж мөнгийг нь өгсөн юмаа..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 228-235/,

Гэрч Ш.У-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Д.Ч ямар замаар орж ирснийг би мэдэхгүй. Ж.Сар эрхлэгчтэй уран бүтээлийн танилууд болно. Гэхдээ Ат эрхлэгч ажлаа өгмөөр байна гээд байсан юм. Тэгээд Ж.Сар дарга Д.Ч-ыг сонины эрхлэгчээр томилъё гэсэн санал гаргаж шийдсэн юм. Энэ хурлаар шийдвэр гаргахад гишүүдийн ирц хүрэхгүй байсан. Тэгтэл Д.Ч гуай багийн гишүүн А намайг дэмжиж байгаа. Тиймээс А-гийн саналыг тэмдэглэлд оруулъя гэснээр түүнийг хуралд оролцсоноор тэмдэглэл хөтөлсөн, уг хурлын тэмдэглэлийг би хөтөлсөн. Харин С.Б, Б.Со, н.Г, н.А гэх хүмүүс нэр нь явдаг боловч үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцдоггүй байсан..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 212-219/,

Гэрч Н.Бу-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "Анх 2003 оны сүүлээр бүтцийн өөрчлөлтөөр өмч хувьчлалын хэлтэст томилогдсон юмаа, тэгэхэд энэ "УТ сонин" НӨҮГ-ын хувьчлалтай холбоотой материалыг Ц гэж мэргэжилтэнгээс хүлээн авсан юм. Намайг анх материал авахад "Нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаант шалгаруулалтын журам", "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний үлгэрчилсэн загвар" зэрэг нь НИТХТ-ийн 2003 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 141-р тогтоолоор батлагдсан байсан юм. Ингээд үүнээс хойшхи хувьчлах асуудлыг би хариуцаж ажилласан. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах этгээдийг сонгон шалгаруулах тухай зар мэдээллийг бэлтгэж хэвлэл мэдээллээр

зарлуулсан, би мэдээллийг нь бэлтгэж өгөөд тухайн үед дотоод ажил хариуцаж байсан. Би "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлах тендерийн комиссыг томилох материалыг бүрдүүлж, Нийслэлийн Засаг даргын 2004.03.04-ний өдрийн 79 дүгээр захирамжаар тендерийн комиссыг батлуулсан, би өөрөө нарийн бичгийн даргаар нь ажилласан юм. 2003 оны 11 дүгээр сард намайг дөнгөж ажил авсны дараа "УТ сонин" НӨҮГ-ын бизнес үнэлгээг хийлгүүлэх гэрээ байгуулсан, үнэлгээг "Ю-Б-П" Ххк-аар хийлгүүлсэн, энэ үнэлгээний компанийн захирал нь тухайн үед манайд мэргэжилтэн байсан Ц.Оы нөхөр Э байсан, үнэлгээг манай Ц.О өөрөө хийсэн болно, үнэлгээний тайлангийн нийт үнийг 369 сая 723 мянган 300 төгрөгөөр тогтоосон юмаа. Би энэ үнэлгээг Нийслэлийн өмч хувьчлалын хуралд оруулж танилцуулаад энэ үнээр нь менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаанд шалгаруулалт явуулахыг даалгасан тогтоол гарсан байгаа, анхны дэнчинг энэ үнийн дүнгийн 10 хувь буюу 37 сая орчим төгрөгөөр тогтоож өгсөн юмаа. Энэ баг бизнес төлөвлөгөөний биелэлтээ өгч байх ёстой, тайлан ирүүлж байсан байхаа. Г.М даргатай аудит 2007 онд орсон. Гэхдээ хувьчлахаар гэрээ байгуулсан нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад бүгдэд нь орсон шиг санаж байна. Тэгээд тэр комиссын дүгнэлтээр Улаанбаатар телевиз, радио 2-ыг 2007 онд хувьчилсан байгаа. Тэгэхээр УТ багийн гэрээний үүрэг хангалтгүй биелсэн гэж үзээд хувьчлах боломжгүй гэж шийдсэн. Тэгээд би М.Гб дарга ирээд бүтцийн өөрчлөлт хийхэд 2007 онд өмч хувьчлалын хэлтсээс гарч төлөөллийн хэлтэст очсон. Ингээд шилжихдээ УТ-ын материалыг хэнд хүлээлгэж өгсөнөө санахгүй байна, Гэхдээ надад хүлээлгэн өгсөн акт нь байгаа болохоор хараад хэлье, надад байгаа байх гэж бодож байна. Би бүтцийн өөрчлөлтөөр буцаад өмч хувьчлалын хэлтэст ирсэн юм. Надад ирэхэд "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчилж Д.Ч ахлагчтай багт өмчлөх эрх олгосон гэрчилгээ нь гарсан байсан. Ц.О тэр гэрчилгээг надад өгөхдөө энэ гэрчилгээг өгөхийн өмнө Д.Ч ахлагчтай багаар Л.С гэж хүний хөрөнгө оруулалтын тооцоо байгаа. Энэ тооцоо дууссаны дараа өгөөрэй гэж байсан. Гэрээн дээр нь төлбөрийг барагдуулна гэж заасан байсан. Над дээр материал байх хугацаанд энэ гэрээтэй холбоотой ямар ч ажил хийгдээгүй. Төлбөр тооцоо барагдаагүй болно. Гэрчилгээ НӨХГ-

ын дарга Однасан 2010 онд надаас авсан. Гэрчилгээг нь аваад ир гэхээр нь би даргын өрөөнд оруулж өгсөн болно. Нийслэлийн Т.Б дарга гэрчилгээг өг гэж хэлээгүй. Надад тэр талаар хэлж яриагүй. Дарга л гэрчилгээг нь аваад ир гээд би оруулж өгсөн болно. Өмчлөх эрхийн гэрчилгээ олгосны дараа байгууллагыг Д.Ч ахлагчтай багт би бол хүлээлгэж өгөөгүй. Ц.О хүлээлгэж өгсөн эсэхийг мэдэхгүй. Ц.О-аас өгсөн задгай материалыг би авахгүй гэдгээ дарга нарт хэлсэн. Тиймээс ч уг материалыг үзэж судлах шаардлага надад байгаагүй. Сүүлд нь би энэ задгай материалаа аваач Ц.О-д өгч архивлах шаардлагатай байна гэж хэлтсийн дарга Э, газрын дарга О болон Ц.О-д өөрт нь хэлж байсан. Ц.О болохоор чи авснаараа тайланг нь батлуулаад архивлуулчихаач гэсэн. Би хувьчлаагүй юм чинь яаж тайланг нь бичих юм бэ гэж хэлж байсан. Тэгээд би 2010 оны сүүлээр О даргад задгай материал байгаад байна яах вэ гэхэд архивт өг гэсэн. Архивт хүлээж ав гэж дарга архивч От-ыг дуудаад үүрэг өгснөөр би архивт өгсөн юмаа. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тайлан бичиж өгөөд тайланг өмч хувьчлах комиссын тогтоолоор батлагдаж тэгээд архивт орсноор өмч хувьчлалын процесс дуусах ёстой. 2007 онд аудит ороход Улаанбаатар сонин байраа буулгаад Л.С-гийн олж өгсөн түрээсийн байранд байсан..." гэсэн мэдүүлэг / хх-5-н 246-248 /,

Гэрч Ц.Да-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Тухайн үед С сонины эрхлэгч хийж байсан Ба над дээр ирж уулзсан, тэр "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлахаар тендер зарлагдаж байна. Үүнд оролцъё гэсэн саналыг надад тавьсан юмаа. Би тухайн үед сонин ашигтай юмуу гэхэд Ба ашигтай гэж хэлсэн. Би бол сонины талаар мэдлэг мэдээлэл муутай хүн учир түүний саналыг дэмжсэн. Ба бид хоёр 1998 оноос хойш танилцсан. Их гайгүй залуу байгаа юмаа. Тэгээд тендерт оролцвол яах юм гэхэд менежментийн хувьчлалаар авна гэж ярьж байсан. Тэгээд дэнчинд мөнгө төлөх хэрэгтэй гэсэн. Би тухайн үед УИХ-ын гишүүн байсан ба манай эхнэр Б.Со миний ажлыг хариуцаж ажиллаж байсан учир Б.Со-г Батэй уулзуулсан. Дэнчинд өгөх мөнгийг Б.Со авч Ба дээр очсон. Хаана яаж тушаасныг мэдэхгүй байна. Одоо яг хэдэн төгрөг өгснөө санахгүй байна, ямар ч байсан их мөнгө байгаагүй юм. Одоо сайн санахгүй байна. Тэгээд дэнчингийн мөнгө өгснөөс хойш тэр менежментийн багийн үйл ажиллагаанд

оролцоогүй..." гэсэн мэдүүлэг /хх-6-н 1-2 /,

Гэрч Б.Со-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "...2004 онд байх сайн санахгүй байна. Намайг ажил дээрээ байхад манай нөхөр Ц.Да утсаар яриад Улаанбаатар сонин дээр очоод уулз гээд хэлсэн. Яаралтай мөнгө хэрэгтэй байна, юмыг яаж мэдэх вэ? Мөнгийг нь очоод тушаачих, мөн иргэний үнэмлэхтэйгээ очоорой баримт бүрдүүлэх юм байна гэсэн. Тэгээд би хуучин хэвлэх үйлдвэр, засгийн газрын ордны зүүн талд байрлах одоо нураасан байгаа байранд очиж уулзсан. Нэг эрэгтэй хүн байсан. Тэр хүн одоо хэн гэдгийг нь одоо мэдэхгүй санахгүй байна. Тэгээд би уулзаж яаралтай баримт бүрдүүлж өг гээд тэр үедээ баримтыг бүрдүүлж өгсөн. Мөн намайг мөнгөө тушаа гээд би өөрөө банкинд тушаасан шиг санаж байна. Яг хэдэн төгрөг тушааснаа мэдэхгүй байна. Би нөхрийгөө сонин луу орох гэж байгаа юм байна л гэж ойлгосон. Тэгээд юмыг яаж мэдэхэв дэнчингийн төгрөг хэдэн төгрөг тушаачих гэхээр нь би одоо санахад 10 гаран сая төгрөг авч очсон шиг санаж байна. Яг хэдэн төгрөг тушааснаа санахгүй байна. Тэгээд хэдэн баримт бүрдүүлж, зарим баримт дээр гарын үсэг зураад явсан юм. Тэгээд сүүлд нь нээх удаагүй байхаа нөгөө асуудал нь бүтэхээ болилоо гээд дэнчинд төлсөн мөнгийг буцаан авсан болно. Багийн хуралд огт суугаагүй болно..." гэсэн мэдүүлэг /хх-6-н 26-27 /,

Гэрч Т.Бж-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Намайг Улаанбаатар хотын ерөнхий менежерээр ажиллаж байх үед улс орон даяар хэвлэлийн байгууллагууд хувьчлагдаж байх үед Улаанбаатар хотын захиргаа өөрийн дэргэд байсан хэвлэл мэдээллийн байгууллагууд болох УТ сонины газрыг менежментийн хувьчлалаар хувьчилсан. Хувьчлах үед УТ сонин ажиллаж байгаа байрны хувьд муудсан. Эдийн засгийн чадамж муудсан сониноо гаргаж чадахгүй байдалд хүрсэн байсан. Ерөнхий менежерийн хувьд хотын дэргэдэх аж ахуйн байгууллагуудыг хариуцан ажиллах үүрэгтэй байсан. Тийм учраас УТ сонины газар нь барилга нь муудсан ажиллах нөхцөл нь муудсан байсныг газар дээр нь очиж үзэж байсан. Ж.Сар ахлагчтай менежментийн багт би нэр зааж гишүүд оруулсан асуудал байхгүй. Ж.Сар л өөрөө багийн гишүүдээ бүрдүүлсэн байх. Иргэний нисэхийн дарга байсан Л жанжингийн хүүхэд Лх гуай 2004 оны зун намайг УИХ-ын гишүүн болоогүй

хотын ерөнхий менежерийн ажлыг гүйцэтгэж байхад надтай захирагчийн ажлын албаны өрөөнд уулзаад манай хүү Л.С-д эдийн засгийн боломж байгаа юм иймд УТ сонины барилгын ажилд хөрөнгө оруулагчаар ажиллах хүсэлтэй байгаа юм иймд энэ асуудлыг уламжилж өгөөч гэсэн хүсэлтийг надад тавьсан. Тэгээд би УТ сонины эрхлэгч Ж.Сар-тай Л.С-г холбож өгч уулзуулсан. УТ сонины барилгыг сэргээн засварлах ажилд хөрөнгө оруулах талаар Ж.Сар-д хэлж Л.С-тэй холбож өгсөн. Н.Лх гуайтай яг менежментийн багт оруулах талаар болон тодорхой хувь эзэмших талаар яриагүй ээ. Би 2004 оны 07 сараас хотын менежерийн ажлыг өгөөд УИХ-ын гишүүнээр сонгогдсон учраас тус менежментийн баг хэдэн жилийн хугацаатай гэрээ байгуулсан хэзээ гэрээ дүгнэж ямар шийдвэр гаргасан талаар сайн мэдэхгүй байна..." гэсэн мэдүүлэг /хх-6-н 13-20 /

Мөрдөн байцаалтад Ж.Сар-гийн сэжигтнээр өгсөн: "...2004 оны хавар УИХ-ын гишүүн Т.Бж надад хөрөнгө оруулагч Л.С-г Засгийн газрын ордонд гишүүний өрөөнд намайг дуудаж уулзуулсан. Намайг очиход Т.Бж гишүүн Л.С нар байсан. Тэгээд Л.С гэдэг хүнийг хөрөнгө оруулагчаар оруулвал зүгээр байх, энэ хүн онгоцны нислэг болон аялал жуулчлалын компанийн захирал хүн байгаа юм, энэ хүнийг хөрөнгө оруулагч болго гэсэн. Л.С надтай хэд хэдэн удаа уулзаад сонины барилгыг 3 давхар болгох барилгын зураг төсөл хийж ирсэн. Ингээд би Л.С-тэй 2004.05.07-ны өдөр менежментийн багт хөрөнгө оруулалт хийх тухай гэрээ байгуулсан. Өөрөөр хэлбэл, тус сонины газар менежментийн гэрээний үр дүнг харгалзан 2007 онд хувьчлах үед нь 40%-ийг нь эзэмших нөхцөлөөр гэрээг байгуулсан юм. Би 2007 оны 5 сард сонины эрхлэгчийн ажлаа өгөөд ажилгүй байж байгаад 2007 оны 12 сард БСШУ-ны сайдын тушаалаар Үндэсний түүхийн музейн захирлаар томилогдсон. Д.Ч надтай ирж уулзаад сонины эрхлэгчийн ажлыг авъя гэж хэлсэн. Тэгээд миний хувьд татгалзах зүйлгүй гэдгээ хэлсэн. Бүх өр зээлээ хэлсэн, өр зээл ихтэй байгаа шүү гэдгийг хэлсэн. Д.Ч сонины газрыг авч явна гэж шийдээд явсан. Ингээд сонины эрхлэгчээр 2007 оны зун томилогдсон байсан. Ингээд л 2008 оны 07 сарын 20-ны өдөр манай ажил дээр менежментийн баг хуралдаж Д.Ч-ыг менежментийн багийн ахлагчаар томилсон. Би оюуны хөрөнгө



оруулалт хийсэн учраас түүнийгээ 50 сая төгрөгөөр үнэлсэн. Д.Ч 50 сая төгрөг өгье гэсэн үүнийг би зөвшөөрөөд 50 сая төгрөг аваад менежментийн багийг гишүүнээс бүр мөсөн гарч баримт үйлдэж өгсөн. 2007 онд гэрээ дуусаж гэрээг дүгнэх ёстой байсан. Гэрээг дүгнэх эсэх, гэрээг цунгах асуудлаар би хотын дарга Ц.Б-тай удаа дараа уулзаж байсан. Ц.Б дарга намайг чи сонины ажлаа өг гэж хэлсэн. Ер нь намайг ажлаа өг гэж шахаж дарамталсан..." гэсэн мэдүүлэг /хх-8-н 121-128 /

Гэрч Ү.Хү-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...УТ сонин НӨҮГ-ын менежментийн хувьчлалд өөрийн нэрээр дангаараа тендерт оролцохоор материал худалдаж авсан боловч эцсийн шатны шалгаруулалтад мэдээллээр бүрэн хангаагүй учир оролцож чадаагүй..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 249-250/,

Гэрч Ц.Бя-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Ж.Сар захирал намайг тухайн үед тус менежментийн хувьчлалд эсрэг баг болж өрсөлдөгч багаар материал бүрдүүлээд ороод өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан. Ингээд би тухайн үед өөрийнхөө нэрээр менежментийн хувьчлалд материал бүрдүүлж оролцсон. Тухайн үед миний бүрдүүлсэн материалын дэнчингийн мөнгийг УИХ-ын гишүүн Ц.Да-ийн эхнэр Б.Со төлж байсан. Дэнчингийн мөнгө нь 36-37 сая орчим төгрөг болж байсан..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 195-200 /

Мөрдөн байцаалтад Г.М-ын гэрчээр өгсөн: "...Ж.Сар ахлагчтай УТ менежментийн баг жил бүр алдагдалтай ажиллаж байсан. Тайлангаа цаг хугацаанд нь гаргаж өгдөггүй байсан учраас жил жилдээ аудит хийж болдоггүй байсан. Улаанбаатар сонин явахаа байлаа. Энэ газрыг яах вэ? гэж дарга нарт танилцуулж байсан. Хувьчлах ажил хийгдэж байх үед НӨХГ-ын даргаар М.Гб ажиллаж байсан. Ингээд байж байтал М.Гб дарга УТ менежментийн багийн дарга Ж.Сар-г өөрчилж, Д.Ч-ыг тавихаар боллоо, дээрээс дарга нар тийм чиг өглөө гэж надад хэлсэн. Ц.О болон би менежментийн гэрээг цуцлах эсхүл гэрээг сунгах, бүр газрыг нь дуудлага худалдаагаар худалдаж тэр хөрөнгө оруулалтаар хэвлэх үйлдвэрээ барих зэрэг хувилбарууд гаргаж санал оруулж байсан. Гэтэл хотын удирдлагуудаас хувьчлах нь зүйтэй гэсэн чиг ирсэн учир хувьчлах санал оруулсан. Үнэнэийг хэлэхэд энэ хувьчлах шийдвэр санал хотын дарга Т.Б-ээс гаралтай гэж би үзэж байна ..." гэсэн мэдүүлэг /хх-6-н

5-7 /,

Гэрч Ц.О-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Би 2005 оноос 2009 оны 01 сарын 29-ний өдөр хүртэл өмч хувьчллаын хэлтэст мэргэжилтнээр ажиллаж түүнээс хойш төлөөллийн хэлтэст ахлах мэргэжилтэн, 2011 оноос Концессийн багт мэргэжилтнээр ажиллаж байна. Би УТ сонин НӨҮГ-ыг хувьчлах тухай асуудлыг хариуцаж байсан. Эхлээд энэ байгууллагыг Я.О гэж мэргэжилтэн хариуцаж байгаад би түүнээс 2007 оны 09-р сард хүлээн авсан. Энэ танилцуулгыг 2008 оны 09-р сард бичиж НӨХК-ийн хуралдаанд оруулаад Менежментийн үр дүнгийн гэрээгээр хувьчлах тогтоол 2008.09.08-ны өдөр 75 тоот тогтоол гэж гарсан юм. Энэ байгууллагатай байгуулсан гэрээний хугацаа 2007.05.07 нд дууссан байсан. Би Я.О-ээс энэ байгууллагын асуудлыг хүлээн аваад танилцаж багт нь тайлангаа ирүүл, цаашид хэрхэх талаар саналаа ирүүл гэж албан бичгээр хандаж байсан. Дарга нартаа энэ байгууллагын үйл ажиллагаанд аудит оруулъя гэсэн саналаа удаа дараа гаргаж байсан. Намайг санал оруулахаар хэлтсийн дарга Г.М түр байж бай гээд байлгаад байсан. Мөн багийн гишүүдэд өөрчлөлт оруулахаар санал ирүүлж байсан, удаа дараа ирүүлсэн. Ингээд би ер нь энэ байгууллагын гэрээг цаашид сунгах эсэх, аудитын комисс томилж дүгнэлт гаргуулах асуудлыг НӨХК-ын хуралдаанаар оруулж нэг мөрсөн шийдвэрлүүлье гэж үзээд танилцуулга материалаа бэлдээд Г.М даргад танилцуулсан юм. Тэгээд Г.М дарга НӨХК-ын даргатай хэлэлцэх асуудлаа цааш нь ярилцсан байх, тэгээд дараа нь гэрээг сунгах эсэх асуудлыг ярихгүй шууд хувьчлах санал оруулахаар боллоо гээд материалыг нь бэлд гэсэн. Тэгээд л би хувьчлах санал оруулах материал, танилцуулга бэлдэж Г.М даргад өгсөн. 2008.09.08-нд НӨХК-ийн хуралдаанд оруулсан юм. Миний бичсэн танилцуулгыг Г.М дарга өөрөө засаж янзлаад дахин бичүүлж өөрөө гарын үсэг зурсан. Ер нь менежментийн гэрээний гол агуулга нь энэ байгууллагыг өөд нь татах явдал байсан. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй байсан. Мөн энэ байгууллагын гэрээний үүргийн биелэлтэд аудитын комисс гарч хариуцсан мэргэжилтэн болох би өөрөө комиссын нарийн бичгийн даргаар орж ажиллаад, комиссын гаргасан дүгнэлтийг үндэслэн танилцуулгаа бичиж хуралд оруулах ёстой. Гэтэл аудитын комисс томилогдоогүй учир

надаар шууд танилцуулга бичүүлж улмаар комиссын хуралдаанд оруулж шийдвэрлэсэн юм. УТ менежментийн баг гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байсан..." гэсэн мэдүүлэг /хх-5-н 240-242 /,

Гэрч М.Э-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Нийслэлийн өмч хувьчлах комиссын 75 дугаар тогтоолоор Д.Ч гэдэг хүнийг менежментийн багийн ахлагчаар томилогдсон. ..." УТ" НӨҮГ-ыг хувьчлах асуудлыг тавьсны дагуу анхны үнэлгээ 369.724.000 төгрөгөөр хувьчилсан. Дээрх 75 дугаар тогтоолын дагуу 2008.09.12-ны өдөр 28 дугаартай НӨХГ, "УТ" багийн ахлагч Д.Ч нар худалдах, худалдан авах гэрээг байгуулсан бөгөөд гэрээний 3.8 дээр "УТ" НӨҮГ-ын өр төлбөрийг маргаангүйгээр 1 сарын дотор буюу 2008.10.12-ны дотор төлж барагдуулна гэж зааж өгсөн байдаг. Гэрээгээр хүлээсэн 369.724.000 төгрөгийг шилжүүлсэн.... Д.Ч-ын баг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй Өөрөөр хэлбэл, хохирлыг барагдуулаагүй... Нийслэлийн Засаг даргын 2011 оны 04 дүгээр сард дугаарыг нь мэдэхгүй байна. Захирамжаар ажлын хэсэг томилогдоод хувьчлагдсан үйл ажиллагаатай танилцаад Нийслэлийн өмч хувьчлах комисст гэрээний үүргийг биелүүлээгүй гэж үзээд 2011.05.04-ний өдрийн Нийслэлийн өмч хувьчлах комиссын 17 дугаар тогтоолоор УТ НӨҮГ хувьчлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн" гэсэн мэдүүлэг /хх-6-н 44-46 /

Гэрч Я.О мөрдөн байцаалтад өгсөн: "... Хэлтсийн дарга Г.М-ын өгсөн үүргийн дагуу тогтоолын төсөл танилцуулгыг бэлтгэсэн. Энэ сэргээн засах эмнэлэг хувьчлах гэж байгаа, энэ эмнэлэг хувьчлагдах байгууллагын жагсаалтад багтсан байгаа иймд тогтоолын төсөл бэлд танилцуулга бэлд гэсэн. Тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг нь гаргахад би уг ажилд шинээр орсон байсан яаж хийдгийг нь сайн мэдэхгүй туршлага байхгүй байсан учраас ахлах мэргэжилтэн М.Э-оос урьд нь хувьчилж байсан материал байна уу гэж асууж хувьчлагдсан нэг байгууллагын материалыг авч үзээд тэнд үл хөдлөх эд хөрөнгөд хийсэн үнэлгээг нь харж байгаад хэлтсийн дарга Г.М-д танилцуулж, түүний ингэж хий гэсэн үүргийн дагуу үнэлгээг хийсэн... Уул нь уг үл хөдлөх эд хөрөнгийг хөндлөнгийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний компаниар надаас өмнө хийлгүүлсэн үнэлгээний материал байсан тухайн материалыг авч үзээгүй, учир нь тухайн материалыг надад үзэж хар гэж

хэлээгүй. Харин миний хувьд Засаг даргаас өгсөн итгэмжлэлийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд хэлтсийн дарга Г.М-ын үнийн тооцооллыг нь хийгээд ир гэсний дагуу энэ 3-н хувилбараар тооцооллыг хийж даргад өгсөн...Надад ийм санал нэмж тусга гэж Г.М дарга миний танилцуулсан төсөл дээр гараараа бичиж өгч байсан..." гэсэн мэдүүлэг /хх-18-н 130-132/,

Гэрч М.Гб-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Намайг ажил авах клиник эмнэлгийг хувьчлахаар менежментийн гэрээгээр өгчихсөн ажиллуулж байсан. Тэгээд л өмч хувьчлалын комиссоос тухайн эмнэлгийг хувьчилсан. Энэ эмнэлгийн хувьчлалтай холбоотой асуудлын талаар би сайн мэдэхгүй. Намайг дөнгөж ажлаа авсны дараахан л энэ эмнэлгийн хувьчлал хийгдсэн байх...Өмч хувьчлалын комиссоос л үнийг тогтоож өгсөн байх, эмнэлгийн хувьчлалын үнийг хэрхэн тооцож байсан талаар надад мэдэх зүйл байхгүй. Өмч хувьчлалтай холбоотой асуудал надад танилцуулагддагүй байсан, хувьчлалын комисст би ордоггүй байсан болохоор надад хувьчлалтай холбоотой ямар нэгэн асуудал танилцуулагдаж байгаагүй..." гэсэн мэдүүлэг /хх-18-н 139/,

Гэрч Д.Га-ын мөрдөн байцаалтад өгсөн: "...Хувьчилж байсан объектийн хувьд Төрийн өмчийн хорооноос баталсан үнэлгээ тогтоолгох аргчлал, журмын дагуу 2-3 аргаар байх тухайн барилгын үнэлгээг тогтоолгон, тэр тогтоогдсон үнээр хувьчлах эсэх асуудлыг Нийслэлийн өмчийн харилцааны газраас холбогдох танилцуулга, саналаа өмч хувьчлалын комисст оруулж ирэн шийдвэрлүүлдэг нийтлэг жишигтэй л байсан. Энэ дагуу л Өмчийн харилцааны газраас хувьчлагдах үнийн саналыг оруулж ирэн, саналын дагуу хувьчлах шийдвэрийг гаргаж байсан байх гэж бодож байна..." гэсэн мэдүүлэг /хх-18-н 142/,

Шинжээч Ж.У-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "...Манай хувьд Нийслэлийн Өмчийн харилцааны газраас удирдлагын багийн хөрөнгө оруулалтыг батламжилсан бичигт үндэслэн хөрөнгө оруулалтыг нь тооцож үзэхэд 162.216.214 төгрөг болсон байна. Бид нар үнэлгээг хийхдээ газар дээр нь хөрөнгө оруулалтаар хийсэн гэх ажлуудыг үзэж танилцсан. ...428.987.700 төгрөгийн үнийг тухайн "СЗК" эмнэлгийн барилга байгууламж, түүний дагалдах хөрөнгийг үнэлсэн үнэлгээ гэж үзэж болохгүй. Энэ үнэ

нь тухайн байгууллагын 2006 оны санхүүгийн тайлан балансад тусгагдсан нийт хөрөнгийн дүн байсан. “ЭЭСЭ” ХХК нь зөвхөн Хан-Уул дүүрэгт байрлах “СЗКЭ”-гийн газар дээрх үл хөдлөх хөрөнгийг л үнэлсэн байсан. Тэд газрыг үнэлээгүй байсан. Яагаад газрыг үнэлээгүй болохыг би хэлж мэдэхгүй байна. Миний үзэж байгаагаар эзэмшил газар нь төрийн өмчийн мэдлийн газар байсан болохоор үнэлээгүй байж болох юм. Уг нь барилгын үнэлгээг хийж байгаа тохиолдолд эзэмшил газрын үнэлгээг цуг хийх л ёстой. Гэхдээ “ЭЭСЭ” ХХК-ийн хийсэн “СЗКЭ”-гийн барилгын үнэлгээ нь үндэслэлгүй, үнэлгээг багаар үнэлсэн байсан. Манай тогтоосон барилгын үнэ болох 934.955.400 төгрөг нь хөрөнгийн нийт үнэлгээнээс тухайн барилгад оруулсан хөрөнгө оруулалт болох 162.216.200 төгрөгийг хассан дүн юм. Харин “СЗК” эмнэлгийн зөвхөн барилга байгууламж, машин тоног төхөөрөмж зэрэг дагалдах хөрөнгийн үнэлгээ нь 2007 оны байдлаар /“ЭЭСЭ” ХХК-ийн үнэлсэн барилга, дагалдах эд хөрөнгийн хувьд/ 779.724.000 төгрөгийн үнэлгээтэй байгаа юм. Энэ дүн нь 2007 оны байдлаар хөрөнгийн үнэлсэн үнэлгээ болох 1.097.171.000 төгрөгийн дүнгээс “ЭЭСЭ” ХХК-ийн үнэлээгүй эзэмшил газрын болон хөрөнгө оруулалтаар хийсэн барилга, объект эд хогшлын үнэлгээг хасахаар гарч байгаа дүн юм. Хэрэв энэ үнэлгээнээс менежментийн багийн хөрөнгө оруулалтаар оруулсан 162.216.200 төгрөгийг хассан тохиолдолд “СЗК” эмнэлгийн тухайн үеийн үнэлгээ нь 617.507.800 болох юм...” гэсэн мэдүүлэг /хх-18-н 150-151/,

“ХҮТ”-ийн хөрөнгийн үнэлгээ: "...2012 оны 02 сарын 04-ний 42 дугаартай “Ө” зочид буудал” НӨҮГ-ын үнэлгээг 2007 оны 10 сарын байдлаар 605 сая төгрөг гэж үнэлсэн..." гэсэн дүгнэлт /хх-15-н 130-151/,

Үнэлгээ хийсэн шинжээч Г.Н-ийн мөрдөн байцаалтад өгсөн: "... “Ө” зочид буудал НӨҮГ-ын үнэлгээг тогтоохдоо “Д” зочид буудлын газар эзэмших эрхийн үнэлгээг нарийвчлан тооцоогүй 468 сая төгрөгөөр “Ю-Б-П” ХХК үнэлсэн байсан. 2007 оны 10 дугаар сарын байдлаар “Ө” зочид буудал НӨҮГ-ын зах заалийн үнэ 605.0 сая төгрөг болж байгаа юм" гэсэн мэдүүлэг /хх-15-н 162-164/,

Үнэлгээ хийсэн шинжээч Ж.У-гийн мөрдөн байцаалтад өгсөн: "... “Ю-Б-П” ХХК-ийн 2003-12-16-ны өдрийн байдлаар УТ сонин НӨҮГ-ын зах зээлийн бодит үнэлгээг 369.723.388 төгрөгөөр тогтоосон нь тухайн

үеийн зах зээлийн бодит үнэлгээнээс даруй 2,7 дахин бага байсан нь манай үнэлгээний явцад тогтоогдсон..." гэсэн мэдүүлэг /хх-15-н 167-168 /,

Нийслэлийн Засаг дарга М.Э-ын 2000.08.29-ний өдрийн 280 дугаартай захирамж /хх-1-н 94 /, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003.09.17-ны өдрийн 128 тоот тогтоол /хх-1-н 105-107 /, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2003.10.23-ны өдрийн 141 тоот тогтоол /хх-1-н 108-141/, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2005.06.22-ны өдрийн 130 тоот тогтоол /хх-1-н 144/, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2003.12.18-ны өдрийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай 101 тоот тогтоол /хх-1-н 149/, "УТ" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг менежментийн гэрээгээр хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах тендерийн комиссын 2004.03.04-ний өдрийн дүнгийн тайлан /хх-2-н 41-42/, Нийслэлийн өмчийн харилцааны газраас 2004.05.07-ны өдөр Ж.Сар ахлагчтай "УТ" багтай байгуулсан Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээ /хх-2-н 164-184/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2005.03.24-ний өдрийн 5-244-1793 тоот дүгнэлт /хх-3-н 94-95/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас УТ сонин газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын материал /хх-3-н 100-108/, Нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээгээр ажиллуулж байгаа багуудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн 2005.06.27-ны өдрийн аудитын тайлан /хх-55-н 67-68 /, Өмч хувьчлалын хэлтсийн 2008.04.28-ны өдөр УТ Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын менежментийн багийн үйл ажиллагааны тухай танилцуулга /хх-3-н 110-112/, Өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Ц.О-эны бичсэн танилцуулга /хх-4-н 55-57 /, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 75 тоот тогтоол Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч өмч хувьчлах комиссын дарга Т.Б, нарийн бичгийн дарга М.Гб /4хх-н 63/

Нийслэлийн өмчийн харилцааны газрыг төлөөлж, нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Нийслэлийн өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Ч.О,

итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.О нар 2008.09.12-ны өдөр "УТ" багийн ахлагч Д.Ч-тай худалдах, худалдан авах тухай 28 тоот гэрээ /хх-4-н 65-66 /, УТ НӨҮГ-ын дарга Д.Ч нь 2008 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр "Мх" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Х-тай 332.751.600 төгрөгийг 14 хоног 3.5 хувийн хүүтэй зээлсэн зээлийн гэрээ /хх-5-н 118-119/, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008.09.26-ны өдрийн 96 тоот тогтоол /хх-4-н 77/, Нийслэлийн өмч хувьчлах комиссын дарга Т.Б нь 2008.09.26-ны өдөр Д.Ч ахлагчтай УТ менежментийн баг болон бусад гишүүдэд УТ НӨҮГ-ыг 369.724.000 төгрөгөөр худалдан авсан хөрөнгийн өмчлөгчөөр бүртгэж өмчлөгийн эрхийн 33/2008 тоот олгосон гэрчилгээ /хх-4-н 76/, УТ сонины менежментийн багийг төлөөлж ахлагч Д.Ч нь "Мх" ХХК-ийг төлөөлж Б.Х-тай 2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ /хх-5-н 122 /, 2010.06.25-ны өдөр Н.А, Ж.Сар, Ш.У, Б.Со нар нь УТ менежментийн багийн гишүүнээс гарсан тухай баримтууд /хх-6-н 194-200 /, "УТ" ХХК-ийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл /хх-6-н 156-165/, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2011.05.04-ний өдрийн 17 тоот тогтоол /хх-5-н 17/, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011.06.27-ны өдрийн 97 тоот тогтоол /хх-5-н 125/, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011.06.27-ны өдрийн 91 тоот тогтоол /хх-5-н 26/, Нийслэлийн Засаг даргын 2011.08.03-ны өдрийн 589 тоот захирамж /хх-5-н 39 /, "... УТ менежментийн багийн ажиллаж байх хугацаанд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хэвлэх үйлдвэрийн барилгыг цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлтээр хөрөнгө оруулалтыг зогсоосон тул барилгад оруулсан баталгаажсан хөрөнгө оруулалт болох 493.000.000 төгрөгийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр барагдуулах...", төлбөрийн хүсэлт /хх-5-н 43 /, ХҮТ ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний: /хх-7-н 103/,

-2001.01.19-ний өдөр Э.Э, Б.Б нь 1 сая төгрөгийн дүрмийн сантайгаар "Мх" ХХК-ийг үүсгэн байгуулсан. Б.Б нь өөрийн 250 ширхэг хувьцаа эзэмших эрхээ Ц.М-д, хувь нийлүүлэгч Э.Э нь 500 ширхэг хувьцаагаа Н.Эн-д 2002.01.18-ны өдөр шилжүүлсэн. 2007.06.07-ны өдөр Ц.М, Б.Б нар нь 25 хувийн хувьцаагаа тус тус үнэ төлбөргүйгээр Н.Эн-д шилжүүлсэн талаарх баримтууд /хх-13-н 8-76 /, 2010.03.03-ны өдөр Н.Эн нь

өөрийн эзэмшиж буй "Мх" ХХК-ийн бүх хувьцааг "Э" ХХК-д хариу төлбөргүйгээр шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээ /хх-13-н 4 /,

-2009.07.10-ны өдөр "Э" ХХК-ийг бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чиглэлээр Н.Э, Б.Ту нар үүсгэн байгуулж улсын бүртгэлд бүртгүүлсэн талаарх лавлагаа, баримтууд /хх-13-н 1-3, 131-147 /, 2010.02.08-ны өдөр Б.Ту нь өөрийн эзэмшлийн хувьцааг үнэ бүхий 250 ширхэг хувьцааг өмчлөх эрхээ Н.Э-т хариу төлбөргүйгээр шилжүүлсэн талаарх баримт /хх-13-н 128-135 /, 2010.02.08-ны өдөр Н.Э нь "Э" ХХК-ийг иргэн Н.Эн-д шилжүүлсэн талаарх баримт /хх-13-н 119-122/,

-2006.11.16-ны өдөр Э.Бш нь "Р" ХХК-ийг үүсгэн байгуулж, 2010.03.03-ны өдөр "Р" ХХК-ийн 100 хувийн хувьцааг хариу төлбөргүйгээр "Э" ХХК-д шилжүүлж, охин компани болсон талаарх баримтууд /хх-13-н 77-88 /

-Э.Бш-ын үүсгэн байгуулсан "Р" ХХК нь "зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлал, гадаад худалдаа эрхлэх" үйл ажиллагааны чиглэлээр 2007.10.10-ны өдөр "ХД" ХХК-ийг үүсгэн байгуулсан талаарх лавлагаа, баримтууд /хх-13-н 94-96, 152-160 /,

"...Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Б-ыг өмч хувьчлах комиссын даргаар томилох тухай..." Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 53 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт /хх-10-н 69,82 /

"...Ц.Б-ыг Нийслэлийн Засаг даргаар томилох тухай..." Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Э-ийн 2005.10.24-ний өдрийн 136 дугаартай захирамж /хх-17-н 59 /,

"...Т.Б-ийг Нийслэлийн Засаг даргаар томилох тухай..." Монгол Улсын Ерөнхий сайд С.Б-ын 2007.12.28-ны өдрийн 116 дугаартай захирамж /хх-25-н 86/,

-Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012.08.02-ны өдрийн 326 тоот шийтгэх тогтоол /хх-16-н 172-197 /, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012.09.25-ны өдрийн 749 тоот магадлал /хх-16-н 198-246 /, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн 2012.12.07-ны өдрийн шүүх хуралдааны 775 тоот тогтоол /хх-16-н 249-250, хх-17-н 1-29 /,

Нийслэлийн Засаг дарга М.Э-ын 2003.11.10-ны өдрийн 477 тоот захирамж /18хх-н 24/

"...Нийслэлийн эрүүл мэндийн салбарын зарим байгууллагуудын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгэх гэрээлэгчийг сонгон шалгаруулах хуваарийг нэгдүгээр, удирдлагын гэрээний үүргийн биелэлтийн баталгаа, үүргээ биелүүлээгүйгээс хүлээх хариуцлага, учруулсан хохирлын нөхөн төлөх барьцаа хөрөнгийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар баталсан..." Нийслэлийн Засаг дарга М.Э-ын 2003.11.10-ны өдрийн 478 тоот захирамж /хх-18-н 26 /,

"...Нийслэлийн эрүүл мэндийн салбарын зарим байгууллагуудын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх, гэрээлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон "СЗК" эмнэлгийн тендерт Ц.Ч ахлагчтай баг шалгаруулсныг баталж, удирдлагын гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг даалгасан..." Нийслэлийн Засаг дарга М.Э-ын 2004.01.19-ний өдрийн 24 тоот захирамж /хх-18-н 27 /,

2004.02.02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн эрүүл мэндийн газраас Ц.Ч-тай 3 жилийн хугацаатай байгуулсан Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх удирдлагын гэрээ / хх-19-н 114-123 /,

Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Я.О, хэлтсийн дарга Г.М нарын бичсэн "СЗК" эмнэлгийн удирдлагын гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай танилцуулга /хх-18-н 45-48/,

"... "СЗК" эмнэлгийг үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй нөхцөлтэйгээр удирдлагын багт нь худалдах үнийг 256.771.500 төгрөгөөр тогтоох тухай..." Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч өмч хувьчлах комиссын дарга Ц.Б, Өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Г.М нарын Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007.03.26-ны өдрийн 37 тоот тогтоол /хх-18-н 51 /,

"... "СЗКЭ"-т нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын барилга байгууламжийг 256.771.500 төгрөгөөр хувьчлах үнийг тогтоож, Ц.Ч ахлагчтай багаас "СЗКЭ"-т оруулсан хөрөнгө оруулалтыг 172.216.200 төгрөгөөр тогтоосон..." Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хурлын тэмдэглэл / хх-19-н 14-18 /,

Нийслэлийн өмч харилцааны газрыг

төлөөлж Өмч хувьчлалын хэлтсийн дарга Г.М, мэргэжилтэн Я.О нэр нь Ц.Ч-тай 2007 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "СЗК" эмнэлгийг 256.771.500 төгрөгөөр худалдахаар байгуулсан худалдах худалдан авах гэрээ /хх-18-н 52-54/,

"...Иргэн Ц.Ч ахлагчтай багт нийслэлийн Хан-Уул дүүргийн ...дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "СЗК" эмнэлгийг шилжүүлэн олгож, өмчлөгчийн эрхийн гэрчилгээ олгох тухай..." Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007.04.11-ний өдрийн 47 тоот тогтоол /хх-24-н 148/,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч өмч хувьчлах комиссын дарга Ц.Б, Өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Г.М нараас олгосон 2007 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 15/2007 тоот гэрчилгээ /хх-18-н 57/,

"...2007 оны үеийн байдлаарх үнэлгээгээр "СЗК" эмнэлгийн хөрөнгө 957.916.000 төгрөг, хөрөнгө оруулалтаар барьсан объектууд 66.405.000 төгрөг, тоног төхөөрөмж, эд хогшил 36.807.100 төгрөг, бусад эргэлтийн хөрөнгө 36.043.500 төгрөг тус тус бүгд 1.097.171.600 төгрөг болно. Энэ үнээс "ЭЭСЭ" ХХК-ийн "СЗК" эмнэлгийн хөрөнгийг үнэлэхдээ оруулж тооцоогүй дээрх хөрөнгийг хасаж тооцвол...779.724.000 төгрөг болно..." гэсэн Шинжээч томилж шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу ХҮТ-өөс "СЗК" эмнэлгийн үл хөдлөх хөрөнгөд хийсэн үнэлгээ: /хх-18-н 193-233/, "...Нийслэлийн өмчийн харилцааны газрын мэргэжилтэн Я.Од хадгалагдаж байсан "СЗК"-ийн өмч хувьчлалтай холбоотой хийгдэж байсан бичиг баримтуудын төслийг хураан авч хэрэгт хавсаргасан..." эд мөрийн баримт хураан авч хадгалах тухай тогтоол/ хх-18-н 153-182/, Өмчийн харилцааны газрын даргын 2005.01.24-ний өдрийн 16 тоот тушаал /хх-24-н 215/ зэрэг болно.

Шүүхийн хэлэлцүүлгийн үед шинжлэн судласан нотлох баримт нь энэ хэрэгт хамааралтай, хуульд заасан журмаар цугларсан, хэрэг хянан шийдвэрлэхэд хангалттай байна гэж үнэлэв.

Прокуророос шүүгдэгч Ц.Б-ыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж давтан үйлдлээр Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч

хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Г.М-тай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 182 тоот тогтоолоор батлагдсан Өмч хувьчлах комиссын ажиллах журмын 2.1.3-д заасан "...Хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах", 2.1.7-д заасан "...нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хянан батлах", 2.1.8-д заасан "... менежментийн болон удирдлагын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хэлэлцэж үр дүнг харгалзан хувьчлах ажлыг хэрэгжүүлэх", 2.2.5-д заасан "...хувьчлагдах аж ахуйн нэгжийн бэлтгэл ажлыг хангуулах", 3.4.3-д заасан "...Өмч хувьчлах асуудлаар комиссын гишүүдэд үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцох", 3.4.4-т заасан "... Хувьчлалтай холбоотой тодорхой асуудал боловсруулах ...магадлан шинжилгээ хийлгэх асуудалд мэргэшсэн хүмүүсийг татан оролцуулах ..." зэрэг заалтуудыг хэрэгжүүлэхдээ "СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байсан төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

-Шүүгдэгч Г.М-ыг Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Нийслэлийн Засаг дарга бөгөөд өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан Ц.Б-тай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 182 тоот тогтоолоор батлагдсан Өмч хувьчлах комиссын ажиллах журмын 2.1.3-д заасан "...Хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах", 2.1.7-д заасан "...нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод

хязгаарыг хянан батлах", 2.1.8-д заасан "... менежментийн болон удирдлагын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хэлэлцэж үр дүнг харгалзан хувьчлах ажлыг хэрэгжүүлэх", 2.2.5-д заасан "...хувьчлагдах аж ахуйн нэгжийн бэлтгэл ажлыг хангуулах" зэрэг заалтыг хэрэгжүүлэхдээ "СЗКЭ" НӨҮГ-ыг 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байсан Ц.Б-ын төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗК" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

Шүүгдэгч Ц.Ч-ыг 2004 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай "Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх удирдлагын гэрээ" байгуулан "СЗКЭ" НӨҮГ-ыг ажиллуулж байхдаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан төрсөн ах Ц.Б, Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлах хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Г.М нартай бүлэглэн, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоолгон хувьчлан авч, завшин нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогдуулж яллах дүгнэл үйлдэж ирүүлснийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь хэсэгт "нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй байвал" хэргийг хэрэгсэхгүй болгоно гэж заасны дагуу тус тус хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Г.М, Ц.Ч нарыг цагаатгах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Нийслэлийн эрүүл мэндийн салбарын

зарим байгууллагуудын удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх, гэрээлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцсон “СЗК” эмнэлгийн тендерт Ц.Ч ахлагчтай баг шалгарсныг баталж, удирдлагын гэрээг 3 жилийн хугацаатай байгуулж, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг даалгасан Нийслэлийн Засаг дарга М.Э-ын 2004 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 24 тоот захирамжаар шүүгдэгч Ц.Ч нь уг эмнэлгийг удирдлагын гэрээгээр ажиллуулсан болох нь тогтоогджээ.

Энэ цаг хугацаанд шүүгдэгч Ц.Ч-ын төрсөн ах Ц.Б нь Нийслэлийн Засаг даргын албан тушаалд томилогдоогүй байсан нь тогтоогджээ.

Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас Ц.Ч-тай 3 жилийн хугацаатай удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх удирдлагын гэрээг дүгнэж, гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тухай танилцуулга хийгдэж, уг эмнэлгийг Ц.Ч-д хувьчлах тухай Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоол гарчээ.

Энэ үед Ц.Ч-ын төрсөн ах Ц.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд өмч хувьчлах комиссын даргаар, Г.М нь Өмч хувьчлах комиссын даргаар тус тус ажиллаж байсан нь баримтаар тогтоогдсон байна.

Тухайн үед Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдаж мөрдөгдөөгүй байсан ба Ц.Б, Г.М нар нь өөрт олгогдсон эрх, үүргийн дагуу албан үүргээ гүйцэтгэсэн байна.

Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд Ц.Б, М.Гб, Г.М, Б.Мө, Б.Т, Д.Га нарын 6 гишүүн оролцсон байх ба “СЗК” эмнэлгийн хувьчлалын талаар хэлэлцэж, үнэлгээг нь Б.Т гишүүний гаргасан саналын дагуу гишүүд санал нэгтгэйгээр шийдвэр гаргасан талаар хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байна.

Үүнийг албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл болохгүй бөгөөд Ц.Б, Г.М, Ц.Ч нарыг хэрхэн бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн талаар мөрдөн байцаалтын ажиллагаагаар нотлоогүй байна.

Түүнчлэн, Өмч хувьчлах комиссын хуралдаанаас гаргасан хамтын шийдвэрийг

Ц.Б, Г.М нар бүлэглэж, гэмт хэрэг үйлдэж гаргуулсан гэх нотлох баримт хэрэгт авагдаагүй байна.

Өмч хувьчлах комиссын хамтын шийдвэрээр шийдвэрлэсэн үнэлгээг үндэслэлгүйгээр доод үнээр хувьчилсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Түүнчлэн, “ЭЭСЭ” ХХК-ийн гаргасан хөрөнгийн үнэлгээг үндэслэлгүй талаарх шинжээчийн дүгнэлт гарсан нь хэрэгт авагджээ.

“ЭЭСЭ” ХХК, “ХҮТ” ХХК нь үнэлгээ хийх эрх бүхий байгууллагууд байх бөгөөд өмч хувьчлах үеийн гаргасан үнэлгээг үндэслэлгүй гэж үзсэн бол тухайн үнэлгээг ямар шалтгаанаар үндэслэлгүй гаргасан, уг үнэлгээг гаргахад шүүгдэгч Ц.Б, Г.М, Ц.Ч нар хэрхэн нөлөөлсөн талаар мөрдөн байцаалтаар тогтоогоогүй байна.

Мөн яллах дүгнэлтэд “ЭЭСЭ” ХХК-ийн гаргасан үнэлгээг яллах нотлох баримт болгож оруулаагүй байна.

“ЭЭСЭ” ХХК-ийн үнэлгээг хийсэн шинжээч нь тухайн үед доод үнийг тогтоолгох талаар санал ирүүлсний дагуу уг үнэлгээг хийсэн талаар мэдүүлсэн болохыг дурдах нь зүйтэй байна.

Шүүгдэгч Ц.Б-ыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан, шүүгдэгч Г.М-ыг Өмч хувьчлах комиссын нарийн бичгээр даргаар ажиллаж байсан, шүүгдэгч Ц.Ч-ыг шүүгдэгч Ц.Б-ын төрсөн дүү учраас бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн гэж нотлох баримтаар нотлогдоогүй байхад шүүх таамаглалд үндэслэн тэднийг гэмт хэрэгт буруутгах үндэслэл болохгүй гэж шүүх дүгнэв.

Мөн прокурор болон хохирогч байгууллага нь өмч хувьчлал хууль бус болсон талаар дүгнэлт болон гомдол гаргаагүй, харин доод үнээс доогуур үнээр хувьчилсан тул түүний зөрүү үнийг хохиролд гаргуулхаар шаардаж байгаа нь үндэслэлгүй гэж үзлээ.

Өмч хувьчлал нь хуулийн дагуу явагдсан гэж үзсэн нөхцөлд өмч хувьчилсан үнийг үндэслэлгүй гэж үзэх боломжгүй байна.

Шүүгдэгч Ц.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлалын комиссын даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э, Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д нартай бүлэглэн

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 188 дугаар тогтоолыг гаргуулан, Нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 555 дугаар захирамжийг гарган 605.000.000 / зургаан зуун таван сая/ төгрөгийн үнэлгээтэй "Ө" зочид буудал НӨҮГ-ыг татан буулгаж, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой "ДӨ" ХХК байгуулах нэрийдлээр "Ө" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын 453.750.000 /дөрвөн зуун тавин гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийн эд хөрөнгийг, Н.Э-ын хүү Э.Бш-ын нэр дээр байгуулсан "ХД" ХХК-ийн өмчлөлд шилжүүлэн, улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компанид шилжүүлэн үрэгдүүлж, Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан.

-Шүүгдэгч Т.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн өмч хувьчлах комиссын даргын албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э, иргэн Д.Ч нартай бүлэглэн УТ менежментийн баг нь Нийслэлийн өмчийн харилцааны газартай 2004 оны 05 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан "Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах гэрээ"-ний дагуу сонгон шалгаруулалтад шалгарсан багийн бизнес төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй, аудит хийгдээгүй, алдагдалтай ажиллаж, гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй байхад 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссын 75 дугаар тогтоол гаргаж, 2.125.000.000/ хоёр тэрбум нэг зуун хорин таван сая/ төгрөгийн үнэлгээтэй "УТ" сонин нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг хууль бусаар Н.Э-ын төрсөн дүү Н.Эн-гийн "Мх" ХХК, Д.Ч нарын нэрээр хувьчилж, улмаар уг компанийг Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компани болгон шилжүүлэн, үрэгдүүлж Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан болох нь хэрэгт цугларсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн болон хэрэгт авагдсан нотлох баримтуудаар нотлогдлоо.

Шүүгдэгч Ц.Б, Т.Б нар нь гэмт хэрэг үйлдээгүй, үйлдсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдоогүй тул тэдгээрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж өгнө үү гэсэн

өмгөөлөгч нарын болон шүүгдэгч нарын саналыг хүлээн авах боломжгүй гэж дүгнэв.

Шүүгдэгч Ц.Б, Т.Б нарыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э, Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д нартай бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн болохыг Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 326 тоот шийтгэх тогтоол, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 749 тоот магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн шүүх хуралдааны 775 тоот тогтоолоор тогтоосон байх ба эдгээр шүүхийн шийдвэрүүд хүчин төгөлдөр болсон байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт "хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлох шаардлагагүй..." гэж заасны дагуу шүүгдэгч Ц.Б, Т.Б нарын үйлдсэн хэргийн талаарх үйл баримтыг дахин нотлох шаардлагагүй гэж шүүх үзсэн болно.

Иймд шүүгдэгч Ц.Б, Т.Б нарыг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, -Төрийн өмчийг итгэмжлэн хариуцсан этгээд үрэгдүүлсний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн гэм буруутай болохыг тус тус тогтоох нь зүйтэй.

Шүүгдэгч нарын үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол буюу "УТ" сонин нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, "Ө" зочид буудал НӨҮГ-ыг хувьчилсан шийдвэрийг хүчингүй болгож, эдгээр хөрөнгө нь Нийслэлийн өмчийн харилцааны газарт буцаан олгогдсон байх тул шүүгдэгч нар нь бусад төлөх төлбөргүй гэж үзлээ.

Энэ нь шүүх хуралдаанд оролцсон хохирогч Нийслэлийн өмчийн харилцааны газрын төлөөлөгч нарын мэдүүлгүүдээр давхар тогтоогдож байна.

Шүүгдэгч нарт ял хүндрүүлэх болох хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй болно.

Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Эрүүгийн хуульд заасан... хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээдийн ...шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа эрүүгийн хэргийг тус тус хэрэгсэхгүй



болгоно" гэж заажээ.

Тухайн хэргийн шүүгдэгч гэм буруугийн асуудлаар маргавал шүүх хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан ердийн журмаар хянан хэлэлцэж, гэм буруутай эсэхийг шийдвэрлэсний дараа Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэглэх журмын дагуу шүүгдэгч нарын "албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн" хэргийг тус тус хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Мөн Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт "жараас дээш насны эрэгтэйчүүд"-ийн шүүхээс оногдуулсан ялыг хугацаа харгалзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ" гэж заажээ.

Шүүгдэгч Т.Б нь 1946 оны 6 дугаар сарын 13-ны өдөр төрсөн ба 68 настай болох нь хэрэгт авагдсан иргэний баримт бичгийн лавлагаагаар тогтоогдож байна.

Иймд шүүгдэгч Т.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулах үндсэн болон нэмэгдэл ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн дээрх заалтад хамруулан өршөөн хэлтрүүлэх үндэслэлтэй болно.

Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн ялтны эдлээгүй үлдсэн хорих ялаас гурван жилийг өршөөн хасна" гэж заасны дагуу шүүгдэгч Ц.Б-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар буюу хүнд гэмт хэрэгт нь оногдуулах хорих ялаас гурван жилийг өршөөн хасах нь зүйтэй гэж шүүх үзлээ.

Шүүгдэгч Ц.Б-т оногдуулах хорих ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлэх нь зүйтэй.

"СЗКЭ" нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр тогтоолгон хувьчлан авч, завшин нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосонтой холбогдуулан Нийслэлийн өмчийн харилцааны газрын гаргасан 360.736.300 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй

гэж үзлээ.

Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан "СЗК" эмнэлгийн хувьчлалын материал 1 хавтасыг хэрэгт хавсаргахаар шийдвэрлэлээ.

Хэрэгт мөрдөн байцаагчийн тогтоолоор битүүмжлэгдсэн шүүгдэгч Ц.Ч-ын Хан-Уул дүүргийн ...дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "СЗКЭ"-гийн 4922.5 м/кв барилга, "СЗКЭ"-гийн өмчлөлд бүртгэлтэй хх-хх улсын дугаартай Хьюндай Санта Фэ маркийн автомашин, шүүгдэгч Г.М-ын Хан-Уул дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 700 м/кв газрыг тус тус битүүмжлэлээс чөлөөлөх нь зүйтэй.

Хэрэгт битүүмжлэгдсэн шүүгдэгч Ц.Б-ын дундын өмчлөлийн Баганхангай дүүргийн ...дүгээр хороо, ...дүгээр байр, ...тоот 36 м/кв орон сууцыг эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлэхээр шийдвэрлэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.2, 283, 286, 290 дүгээр зүйлийн 290.3, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Прокуророос Ц.Б-г албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Г.М-тай бүлэглэн төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн үнэ бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөг буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн үйлдэл холбогдлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай.

2. Прокуророос Г.М-ыг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Ц.Б-тай бүлэглэн түүний төрсөн дүү Ч.Ц-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлалын комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн үнэ бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөг буюу бага үнээр тогтоон хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлж, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт, 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Г.М,

Ц.Ч нарыг тус тус цагаатгасугай.

- Шүүгдэгч Ч.Ц-ыг Г.М, Ц.Б нартай бүлэглэн Нийслэлийн өмч хувьчлалын комиссын 2007 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн үнэ бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөг буюу бага үнээр тогтоолгон хувьчлан авч, завшин, нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт тус тус холбогдуулж яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь хэсэгт зааснаар тус тус хэрэгсэхгүй болгож, Г.М, Ц.Б нарыг тус тус цагаатгасугай.

3. Шүүгдэгч Б овогт Т.Б, Б овогт Ц.Б нарыг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн,

- Төрийн өмчийг итгэмжлэн хариуцсан этгээд үрэгдүүлсний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн гэм буруутай болохыг тус тус тогтоосугай.

4. Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар Т.Б, Ц.Б нарын үйлдсэн " албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан хэргийг бүлэглэж үйлдсэн" Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар Т.Б, Ц.Б нарыг тус бүр 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

6. Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын дагуу Т.Б-д оноосон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ялыг өршөөн хэлтрүүлсүгэй.

7. Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7

дугаар сарын 9-ний өдрийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын дагуу Ц.Б-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ялын 03 жилийг өршөөн хасаж, биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 2 жил 1 сар хорих ялаар тогтоосугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Ц.Б-т оногдуулсан 2 жил 1 сар хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

9. Хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан "СЗК" эмнэлгийн хувьчлалын материал 1 хавтсыг хэрэгт хавсаргасугай.

10. Нийслэлийн өмчийн харилцааны газраас гаргасан 360.736.300 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай.

11. Шүүгдэгч Ц.Б, Т.Б нар нь бусдад төлөх төлбөргүй, Т.Б нь энэ энэ хэрэгт 11 хоног цагдан хоригдсон, Ц.Б нь цагдан хоригдоогүй болохыг тус тус дурдсугай.

12. Т.Б-эд авсан бусдын батлан өгөх, Г.М-т авсан гадагш явж болохгүй баталгаа гаргах, Ц.Ч-д авсан 20.000.000 төгрөгийн барьцааны таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгосугай.

13. Хэрэгт битүүмжлэгдсэн шүүгдэгч Ц.Ч-ын Хан-Уул дүүргийн ...дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "СЗКЭ"-гийн 4922.5 м2 барилга, тус эмнэлэгт бүртгэлтэй хх-хх улсын дугаартай "Хьюндай Санта Фэ" маркийн автомашин, Г.М-ын Хан-Уул дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 700 м2 газрыг тус тус битүүмжлэлээс чөлөөлсүгэй.

14. Хэрэгт битүүмжлэгдсэн Ц.Б-ын дундын өмчлөлийн Багахангай дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 36 м2 орон сууцыг эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсүгэй.

15. Энэ тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд шийтгэх тогтоол гардуулснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлийг Эрүүгийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд гаргах эрхтэй болохыг дурдсугай.

16. Шүүхийн шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох

бөгөөд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол

Ц.Б-т цагдан хорих, Т.Б, Г.М, Ц.Ч нарт урьд бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ тус тус авсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Ч.ОТГОНБАЯР  
Б.МӨНХБАЯР,  
Б.МӨНХ-ЭРДЭНЭ

## МАГАДЛАЛ

2014 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 907

Улаанбаатар хот

### Ц.Ч нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Л.Даваасүрэн даргалж, шүүгч Ч.Хосбаяр, М.Пүрэвсүрэн нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

прокурор Д.Үүлэн, Ш.Баярбилэг, ялтан Ц.Б-ын өмгөөлөгч Ч.Шаравнямбуу, ялтан Т.Б-ийн өмгөөлөгч Ч.Дашням, нарийн бичгийн дарга Б.Хулангоо нарыг оролцуулж,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Ч.Отгонбаяр даргалж, шүүгч Б.Мөнхбаяр, Б.Мөнх-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 863 дугаар шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан Ц.Б-ын өмгөөлөгч Ч.Шаравнямбуугийн гаргасан давж заалдах гомдлыг үндэслэн Ц.Б, Т.Б, Г.М, Ц.Ч нарт холбогдох 20120100018. дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 1-ний өдөр хүлээн авч, шүүгч М.Пүрэвсүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Монгол Улсын иргэн, Б овогт Ц.Б, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, улс төр судлаач, эдийн засагч мэргэжилтэй, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан, одоо Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч ажилтай, ам бүл-..., эхнэр, хүүхдийн хамт Багахангай дүүрэг, ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, урд ял шийтгүүлж байгаагүй, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтангадас одон, Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагдсан, ял шийтгэлгүй, /РД: ЦЗ...../

2. Монгол Улсын иргэн, Б овогт Т.Б, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Говь-Алтай аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, улс төрч, багш мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байсан, ам бүл-..., эхнэрийн хамт Чингэлтэй

дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Сүхбаатарын одон, Алтан гадас, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдаж байсан, ял шийтгэлгүй, /РД:УЕ...../

3. Монгол Улсын иргэн, С овогт Г.М, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Завхан аймгийн ...сумын нутагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, түүхийн багш мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн даргаар ажиллаж байсан, одоо өндөр насны тэтгэвэрт, ам бүл-..., эхнэр, хүүхдийн хамт Чингэлтэй дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтан гадас одонгоор тус тус шагнагдсан, ял шийтгэлгүй, /РД: ЧК...../

4. Монгол Улсын иргэн, Б овогт Ц.Ч, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, эмч мэргэжилтэй, анагаах ухааны докторын зэрэгтэй, "СЗК" эмнэлгийн дарга ажилтай, ам бүл- ...хүүгийн хамт Баянгол дүүрэг, ...дугаар хороо, ...тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагналгүй, урд ял шийтгүүлж байгаагүй, ял шийтгэлгүй, /РД: ЧС...../

Ц.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлалын комиссын даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Н.Э, Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д нартай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 188 дугаар тогтоолыг гаргуулан, үүнийг үндэслэж Нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 555 дугаар захирамжийг гарган 605.000.000 төгрөгийн үнэлгээтэй "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, сонгон шалгаруулалтгүйгээр нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой "Д Ө" ХХК байгуулах нэрийдлээр "Ө зочид буудал" НӨҮГ-ын 453.750.000 төгрөгийн

эд хөрөнгийг, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Э-ын хүү Э.Бш-ын нэр дээр байгуулсан "ХД" ХХК-ийн өмчлөлд шилжүүлэн, улмаар уг компанийг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компанид шилжүүлэн үрэгдүүлж, Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан, мөн давтан үйлдлээр Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга Г.М-тай бүлэглэн Өмч хувьчлах комиссын ажиллах журмын 2.1.3 дахь хэсэгт "Хувьчлах ажлыг эрхлэн зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах", 2.1.7 дахь хэсэгт "нийтийн дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хянан батлах", 2.1.8 дахь хэсэгт "менежментийн болон удирдлагын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг хэлэлцэж үр дүнг харгалзан хувьчлах ажлыг хэрэгжүүлэх", 2.2.5 дахь хэсэгт "хувьчлагдах аж ахуйн нэгжийн бэлтгэл ажлыг хангуулах", 3.4.3 дахь хэсэгт "Өмч хувьчлах асуудлаар комиссын гишүүдэд үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцох", 3.4.4 дэх хэсэгт "Хувьчлалтай холбоотой тодорхой асуудал боловсруулах ...магадлан шинжилгээ хийлгэх асуудалд мэргэшсэн хүмүүсийг татан оролцуулах" гэж заасныг хэрэгжүүлэхдээ "СЗКЭ" НӨҮГ-ыг 2004 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай байгуулсан "Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх" гэрээний дагуу ажиллаж байсан төрсөн дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр буюу бага үнээр хувьчлах замаар нийслэлийн өмчийг үрэгдүүлж, 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

Т.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн өмч хувьчлах комиссын даргын албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Н.Э, иргэн Д.Ч нартай бүлэглэн УТ менежментийн багийн 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан "Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах гэрээ"-ний дагуу бизнес төлөвлөгөө нь бүрэн хэрэгжээгүй, аудит хийгдээгүй, алдагдалтай ажиллах зэргээр

гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байхад Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 09 дүгээр сарын 8-ны өдөр 75 дугаар тогтоол гаргаж, 2.125.000.000 төгрөгийн үнэлгээтэй "УТ сонин" НӨҮГ-ыг хууль бусаар Ерөнхийлөгч Н.Э-ын төрсөн дүү Н.Эн-гийн "Мх" ХХК буюу иргэн Д.Ч нэрээр хувьчилж, улмаар уг компанийг Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Э-ын үүсгэн байгуулсан "Э" ХХК-ийн охин компани болгон шилжүүлэн, үрэгдүүлж Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан,

Г.М нь Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлалын хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Нийслэлийн Засаг дарга Ц.Б-тай бүлэглэн түүний дүү Ц.Ч-д давуу байдал олгож, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр тогтоон хувьчлах замаар нийслэлийн өмчийг үрэгдүүлж, 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

Ц.Ч нь 2004 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай "Удирдах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх удирдлагын гэрээ" байгуулан "СЗКЭ" НӨҮГ-ыг ажиллуулж байхдаа Нийслэлийн Засаг даргаар ажиллаж байсан төрсөн ах Ц.Б, Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмч хувьчлах хэлтсийн дарга бөгөөд өмч хувьчлах комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Г.М нартай бүлэглэн, Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн өртөг бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөгөөр хувьчлан авч, завшин нийслэлийн өмчид 360.736.300 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Нийслэлийн прокурорын газраас Ц.Б-ыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5, 35.3, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг тус тус журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдсэнээр, Т.Б, Г.М нарыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5, 19 дүгээр

зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг тус тус журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг үйлдсэнээр, Ц.Ч-ыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэнээр тус тус яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх:

Шүүгдэгч Ц.Б, Г.М, Ц.Ч нарт холбогдох "Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 37 тоот тогтоолоор 779.724.000 төгрөгийн үнэ бүхий "СЗКЭ" НӨҮГ-ыг үндэслэлгүйгээр 256.771.500 төгрөг буюу бага үнээр хувьчилж, нийслэлийн өмчийг үрэгдүүлэн 360.736.300 төгрөгийн хохирол учруулсан" гэх үйлдлийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь заалтын дагуу хэрэгсэхгүй болгон, Г.М, Ц.Ч нарыг цагаатгаж,

Т.Б, Ц.Б нарыг бусадтай бүлэглэн, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан, төрийн өмчийг үрэгдүүлсний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу Т.Б, Ц.Б нарын үйлдсэн "бусадтай бүлэглэж албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас онц их хэмжээний хохирол учруулсан" хэргийг өршөөлд хамруулан хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар Т.Б, Ц.Б нар тус бүрээс 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ял тус тус шийтгэж, Өршөөл үзүүлэх тухай 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын дагуу Т.Б-эд оноосон 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ялыг өршөөн хэлтрүүлж, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын дагуу Ц.Б-т оноосон 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 5 жил 1 сар хорих ялаас 3 жилийг өршөөн хасаж, түүний биечлэн эдлэх ялыг 5.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 2 жил 1 сар хорих ялаар тогтоож, уг

ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлж, Ц.Б, Т.Б нар нь бусдад төлөх төлбөргүй, Т.Б 11 хоног цагдан хоригдсон, Ц.Б цагдан хоригдоогүй болохыг тус тус дурдаж, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан "СЗК" эмнэлгийн хувьчлалын материал 1 хавтсыг хэрэгт хавсаргаж, Нийслэлийн өмчийн харилцааны газраас гаргасан 360.736.300 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, Т.Б-эд авсан бусдын батлан өгөх, Г.М-т авсан гадагш явж болохгүй баталгаа гаргах, Ц.Ч-д авсан 20.000.000 төгрөгийн барьцаалах таслан сэргийлэх арга хэмжээнүүдийг хүчингүй болгож, хэрэгт битүүмжлэгдсэн Ц.Ч-ын Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах "СЗК" эмнэлгийн 4922.5 м2 барилга, тус эмнэлэгт бүртгэлтэй хх-хх улсын дугаартай "Хьюндай Санта Фэ" маркийн автомашин, Г.М-ын Хан-Уул дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 700 м2 газрыг тус тус битүүмжлэлээс чөлөөлж, хэрэгт битүүмжлэгдсэн Ц.Б-ын дундын өмчлөлийн Багахангай дүүргийн ...дүгээр хороо, ...тоот ...м2 орон сууцыг эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж шийдвэрлэжээ.

Ялтан Ц.Б-ын өмгөөлөгч Ч.Шаравнямбуу давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "Миний үйлчлүүлэгч Ц.Б хувийн байдлын хувьд Монголын төр, засаг, ард түмэн, тэр дундаа Улаанбаатар хотын иргэдийн дунд танигдсан нэр хүндтэй улс төрч билээ. Түүний эхлүүлж гүйцэтгэсэн олон ажил, бүтээн байгуулалт өнөөдрийн хотын хөгжилд өнгө нэмсээр ирсэн. Улс төрчийн хувиар сонгогч олны итгэлийг дааж Багахангай дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын Их Хурлын гишүүний нэр хүндтэй албыг хашиж байсан. Ингэхдээ Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон, Алтангадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль зэрэг төрийн дээд шагналуудаар шагнагдаж явсныг дурдахад хангалттай гэж үзэж байна. Гэтэл анхан шатны шүүх Ц.Б-т ял шийтгэл оногдуулахдаа дээр дурдсан хувийн байдлыг болон тухайн гэмт хэргийн оролцоо, шинж чанарыг харгалзан үзсэнгүй. Ц.Б-т хорих ял оноохдоо Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 551 дүгээр зүйлд зааснаар хөнгөрүүлэх бүрэн боломжтой байсан ч хэрэглэлгүй эрх зүйн байдлыг дордуулсан гэж өмгөөлөгчийн

зүгээс үзэж байна.

2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э-ын улс төрийн болон албан тушаалын нөлөөний хувьд түүнтэй сөргөлдөх, үүрэг даалгаврыг биелүүлэхгүй гэх ямар ч албан тушаалтан байгаагүйг нийгэм, олон нийт бүхэлдээ мэдэж байгаа байх. Энэ нь юуг илэрхийлж байна гэхээр ерөнхийлөгч гэсэн өндөр албан тушаалын нөлөө, дарамтан дор ийм үйлдэл хийхэд хүрсэн байгаа нь илт ойлгомжтой. Нөгөө талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэгт "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний хуралдааны чөлөөт цагт хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ", мөн хуулийн мөн зүйлийн 77.1 дэх хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна", 77.4 дэх хэсэгт "Хурлын Тэргүүлэгчид хурлын чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ" гэж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь Нийслэлийн өмчийн хувьд өмчлөгч болохыг зааж өгсөн. Ц.Б-аас илүүтэй Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гаргасан албан тушаалтнуудын оролцоо илүүтэй байгаа нь хэрэгт авагдсан баримтаас тодорхой байхад тэдгээрийн алиныг нь ч улсын яллагч шүүхэд шилжүүлэлгүй прокурорын шатанд хэргийг нь нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон зөвхөн нэг талыг барьж Ц.Б-ыг яллуулахаар шүүхэд шилжүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 188 тоот тогтоол нь өмчийн захиран зарцуулахтай холбоотой хууль зүйн үр дагавар үүсгэх эрх зүйн акт бөгөөд түүний дагуу бүх асуудал шийдэгдсэн гэдгийг анхаарч үзнэ үү.

Эндээс зөвхөн Засаг даргын 555 тоот захирамж тухайн үйл явдлын бүхий л үе шатны үр дагаврыг үүсгээгүй болох нь илэрхий байна. Мөн Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн завшиж үрэгдүүлсэн гэх хохиролд тооцож буй үл хөдлөх эд хөрөнгө нь бусдын өмчлөлд огт

шилжээгүй. Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан "Энэ хуулийн тусгай ангийн хоёр буюу түүнээс дээш зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг агуулсан нэг удаагийн үйлдэл, эс үйлдэхгүйг нийлмэл гэмт хэрэгт тооцно" гэсэн байхад Ц.Б-ын үйлдлээс үүссэн гэх хохирол нь Эрүүгийн хуулийн 150, эсхүл 263 дугаар зүйлд заасан гэмт хэргийн алиных нь хохирол болох нь тодорхойгүй байна.

Миний үйлчлүүлэгч Ц.Б-ын хувьд урьд ял шийтгүүлж байгаагүй, анх удаа тохиолдлын шинжтэй нөхцөл байдалд гэмт хэрэгт холбогдсон, бусдад төлөх хохирол төлбөргүй, насны болон одоогийн биеийн байдал зэргийг харгалзан хорих ялын дэглэмийг хөнгөрүүлж өгнө үү. Тэрбээр зүрх судасны хэм алдагдах, хоолойн зүүн баруун талд хавдартай, /яаралтай хагалгаа хийлгэх/ ослын улмаас 3 нуруу хугарч хагалгаа хийлгэж одоо 5, 6 дугаар нугаламын суулттай, цусан дахь сахарын хэмжээ хэт өндөр учир /18-с дээш/ 2 дугаар эмнэлэгт байнгын эмчийн хяналтад байдаг." гэв.

Ялтан Т.Б-ийн өмгөөлөгч Ч.Дашням тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 863 дугаар шийтгэх тогтоолыг хүлээн зөвшөөрч байна. Тусгайлан гаргах саналгүй." гэв.

Шүүх хуралдаанд оролцсон прокурор Д.Үүлэн дүгнэлтдээ: "Өмгөөлөгч Ч.Шаравнямбуу давж заалдах гомдолдоо ялтан Ц.Б-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 551 дүгээр зүйлийг хэрэглэх талаар дурдаж байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 551 дүгээр зүйлд "анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэргийн хохирлыг төлж, гэм хорыг арилгасан" байхыг шаардсан. Гэтэл Ц.Б нь гэм хорыг арилгаагүй тул хохирол төлж барагдуулсан гэх үндэслэлгүй. Мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд гэм буруугаа хүлээдэггүй тул Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах боломжгүй. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийслэлийн өмчийг хувьчлах тухай журамд заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал эрх хэмжээнийхээ хүрээнд Ц.Б-т сонгон шалгаруулалт явуулах, Нийслэлийн өмчийг хувьчлах эрх олгосон байхад энэ эрх мэдлээ хэтрүүлэн хөрөнгийн баталгаагүй, үйл ажиллагаа явуулдаггүй, байгуулагдаад

10 хонож байгаа компанид төрийн өмчийг шилжүүлэн өгсөн нь тогтоогдсон. Иймээс Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 863 дугаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх саналтай байна." гэв.

#### ХЯНАВАЛ:

Ц.Б нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлалын комиссын даргаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Н.Э, нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д нартай бүлэглэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 188 дугаар тогтоолыг гаргуулан, үүнийг үндэслэж нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 555 дугаар захирамжийг гарган 605.000.000 төгрөгийн үнэлгээтэй "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, сонгон шалгаруулалтгүйгээр нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой "Д Ө" ХХК байгуулах нэрийдлээр "Ө зочид буудал" НӨҮГ-ын 453.750.000 төгрөгийн эд хөрөнгийг, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Э-ын хүү Э.Бш-ын нэр дээр байгуулсан "ХД" ХХК-ийн өмчлөлд шилжүүлэн үрэгдүүлж, Нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай болох нь:

Гэрч Т.Ос-ын "... "Ө зочид буудал" НӨҮГ-ын 2 удаагийн танилцуулгыг үзэж харлаа. Эхнийх нь Засаг дарга Ц.Б-аас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Б-д хандан "Ө зочид буудал" НӨҮГ-ын "Ө", "Д" зочид буудлуудын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан өмчийн үр өгөөжийг дээшлүүлэх, менежментийг сайжруулах талаар цаашид арга хэмжээний тухай саналуудыг өргөн барьсан 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 1/1386 дугаартай албан бичиг болон "Ө зочид буудал" НӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөн байгуулах тухай танилцуулгыг би бичээгүй. Харин нийслэлийн Засаг дарга Ц.Б-ын "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, нийслэлийн өмчийн 25 хувийн оролцоотой "Д Ө" ХХК-ийг шинээр зохион байгуулах тухай албан бичгийн төсөл, мөн "ХД" ХХК-аар хөрөнгө оруулалт хийлгэн, нийслэлийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах ажлыг зохион байгуулахыг

нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Гб/-т даалгасан захирамжийн төсөл зэргийг би боловсруулсан. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д 2007 оны зун ерөөндөө мэргэжилтэн Ц.Су, н.Б болон намайг дуудаж "Ө зочид буудал" НӨҮГ-ын талаарх танилцуулгыг бич гэсэн. Үүний дагуу би С-гаас холбогдох материалыг аваад танилцуулга бичих гэхэд материал дутуу байсан учраас Б-гээс тус газартай холбоотой 1 хавтас материал авч танилцуулгыг бичиж Д.Д даргад оруулж өгсөн. Үүний дагуу надаар "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгах, хамтарсан компани байгуулах тухай нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгах комисс буюу захирамжийн хавсралтын төсөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, /НӨХГ/, "ХД" ХХК-ийн хамтарсан "Д Ө" ХХК-ийн гэрээ төсөл хэлбэрээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НӨХГ/, "ХД" ХХК-ийн хамтарсан "Д Ө" ХХК-ийн дүрэм зэргийг төсөл хэлбэрээр бичиж өгсөн. Миний бичсэн дээрх төслүүдийг Д.Д дарга хүлээж аваад засвар хийгээд өгсөн. Түүнийх нь дагуу янзлаад буцаан өгсөн. Одоо надад засвар хийсэн төслүүд нь байна. Д.Д дарга компанийн дүрмийг боловсруулахад "нийслэлийн 25 хувь, хувийн өмчийн 75 хувь" гэж тооцож төслийг янзлаад оруулаад өг гэсэн. Гэхдээ өмнө нь нийслэлд 51 хувь, хувьд 49 хувь, нийслэлд 34 хувь, хувьд 66 хувь гэсэн хувилбарууд явж байсан. Энэ хоёр хувилбараар дүрэм, үүсгэн байгуулах гэрээ хоёрыг төсөл хэлбэрээр эхлээд боловсруулж авч байсныгаа дараа Д.Д дарга "нийслэлийн 25 хувь, хувийн өмчид 75 хувь" гэж тооцож төслийг оруулж ирэх үүргийг өгсөн. Өөр бусад асуудлыг мэдэхгүй байна ..." /15-р хх, 74-78/,

Гэрч Ж.Су-ийн "... 2007 оны зун нийслэлийн Өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д намайг болон мэргэжилтэн Бүрэнцэцэг, Т.Ос нарын хамтаар ерөөндөө дуудаж "Ө зочид буудал" НӨҮГ-ын талаарх танилцуулгыг бич гэсэн. Мөн надаас Т.Ос мэргэжилтэн "Ө зочид буудал" НӨҮГ-тай холбоотой материал аваагүй. Миний хувьд би "Ө зочид буудал" НӨҮГ-ыг 2007 оны 4 дүгээр сараас 2008 оны 09 дүгээр сар хүртэлх хугацаанд хариуцаж байсан. Уг нь хариуцсан мэргэжилтэн би учраас иргэдийн хуралд өргөн барих ёстой. "Ө зочид буудал" НӨҮГ-тай холбогдолтой танилцуулга болон бусад нийслэлийн Засаг даргын



захирамжийн төсөл, компанийн дүрэм, гэрээ гэх мэт холбоотой материалуудыг төсөл хэлбэрээр боловсруулах ёстой юм. Гэтэл өмч хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн Т.Ос дээрх материалыг боловсруулсан байна ..." /14-р хх, 204-205/,

Гэрч Ж.Э-ын "... Төрийн өмчит үйлдвэрийн газар болох "Ө зочид буудал"-ыг 1995 оны 7 дугаар сарын 25-нд анх байгуулж, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Худалдааны гудамж, М-100 дугаар байр буюу гутлын 22 дугаар дэлгүүр байсан байрны 6 дугаар орцонд буудлын үйл ажиллагаа явуулах болсон юм. Миний бие 1999 оны 2 дугаар сараас тус "Ө зочид буудал" НӨҮГ-ын захирлаар томилогдон ажилласан. 2001 онд Зайсан дахь "Д" зочид буудал"-ыг "Ө зочид буудал"-тай нэгтгэж нэг байгууллага болгосон. Гэтэл 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 188 дугаар тогтоол, мөн нийслэлийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 555 тоот захирамжаар татан буулгаж, хамтарсан компани байгуулж байгаа нэрээр "ХД" ХХК-д ямар ч өрсөлдөгчгүйгээр сонгон шалгаруулалт, тендергүйгээр шилжүүлж төрийн өмчийг тус компанид үнэгүй бэлэг болгож өгсөн. Тус зочид буудал хотоос ямар ч санхүүгийн дэмжлэг туслалцаа авахгүйгээр өөрийгөө санхүүжүүлдэг байсан. 2006 оны жилийн эцсийн тайлангаар 500.000 төгрөгийн алдагдалтай ажилласан. Бусад онуудад нь дандаа л ашигтай ажиллаж байсан. Дээрх объектыг "ХД" гэдэг нэртэй байгуулагдаад 10 ч хоноогүй, 1.000.000 төгрөгийн дүрмийн сантай Б.Х гэдэг залууд бөөнөөр нь ямар ч өрсөлдөгчгүйгээр яагаад өгч байгаа юм бэ? Энэ асуудлын цаана ямар эрх ашиг, хэдэн төгрөгийн хээл хахууль, төрийн өмчийн том луйвар явагдаж байгааг шалгуулах хүсэлт гаргаж байна ..." /14-р хх, 100-104/,

Гэрч Э.Бш-ын "... АНУ-д сурч байхдаа Монгол Улсад "Р" гэж компанийг 1 гишүүнтэйгээр бизнесийн үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулсан. Дүрмийн сангаа санахгүй байна. Би энэ компани байгуулах саналаа тухайн үед аавын туслахаар ажиллаж байсан Б.Ту гэж хүнд хэлсэн. Тэр хүн миний нэрээр энэ компанийг байгуулсан. Би "Э" гээд аавын дүү болох Н.Эн эгчийн компанид шилжүүлсэн байгаа. Би 2007 онд "ХД" нэртэй охин компани байгуулах шийдвэр гаргасан. Тэгээд тэр компанийнхаа захирлаар аавын туслах Б.Ту-ын ах Б.Х-ийг

томилсон. "ХД" ХХК-ийг үүсгэн байгуулахад би Монгол Улсад байгаагүй. Үүсгэн байгуулах бичиг баримтыг Б.Ту бүрдүүлсэн..." /14-р хх, 139-140/,

Гэрч С.О-ын "... Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчээр 2004 оноос 2008 онуудад ажилласан. "Ө зочид буудал"-ын 75 хувийг "ХД" ХХК-д эзэмшүүлэхээс өөр ямар нэгэн сонголтгүй байсан. Сонгон шалгаруулалт явуулахгүй, хууль бусаар нийслэлийн өмчийг шилжүүлсэн гэж үзсэн. Яагаад заавал нийслэлийн 25 хувь гэж оруулж ирснийг ойлгоогүй. Мөн би саналдаа "Ө", "Д" гэж хоёр объектын нэгийг нь зараад нөгөөд нь хөрөнгө оруулах боломжтой. Заавал хувийн аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх шаардлагагүй гэдгээ хэлсэн. "ХД" ХХК-д ямар ч сонголтгүйгээр өгсөн нь хууль бус гэж үздэг. Нийслэл өмчөө хадгалж үлдээд цааш нь аваад явах боломжтой байсан ..." /14-р хх, 141-142/,

Гэрч М.Э-ын "... "Ө зочид буудал"-ыг "ХД" ХХК-тай хамтарсан компани байгуулахад өмчийн харьцаа 51:49 хувь, 75:25 хувь ч бай хамтарсан аж ахуйн нэгжүүдийн хувьд төсөл сонгон шалгаруулалт явуулж хэвлэл, сонинд зар өгч тодорхой шалгуур хангасан хөрөнгө оруулалт хийх боломжтой аж ахуйн нэгжийг сонгох ёстой байсан ..." /15-р хх, 62-64/,

Гэрч Г.Бж-ын "... Б.Ту нь 2010 оны 2 дугаар сарын 8-ны өдөр "Э" ХХК-ийн хувьцааны 25 хувь буюу 894.600 төгрөгийн үнэ бүхий 250 ширхэг хувьцааг өмчлөх эрхээ хариу төлбөргүйгээр Н.Э-т шилжүүлэхээ зөвшөөрсөн хувьцаа шилжүүлэх гэрээ, Н.Э нь 2010 оны 2 дугаар сарын 28-ны өдөр "Э" ХХК-ийн бүх хувьцааг Н.Эн-д хариу төлбөргүйгээр шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээ, Э.Бш нь 2010 оны 3 дугаар сарын 3-ны өдөр "Р" ХХК-ийн хувьцааг хариу төлбөргүйгээр, эргэлт буцалтгүйгээр "Э" ХХК-д шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээнүүдийг баталгаажуулах үед иргэн Н.Э, Н.Эн, Э.Бш, Б.Ту нар нотариатч дээр өөрсдөө хүрэлцэн ирээгүй. Надтай өмнө Хууль Зүйн яаманд хамт ажиллаж байсан Ш.Р ирж уулзаад дээрх гэрээнүүдтэй холбоотой бичиг баримтыг бүрдүүлж ирээд "батлаад өгөөч" гэж хүсэлт тавьсны дагуу би баталгаажуулж өгсөн. Энэ хүмүүс ажил ихтэй болохоор өөрсдийн биеэр хүрэлцэн ирж амжихгүй гэж хэлдэг байсан..." /15-р хх-55/,

Гэрч Ш.Р-ийн "... Нотариатч Г.Бж-ыг танина. Бид Хууль Зүйн яаманд хамт ажиллаж байсан. Г.Бж нотариатч дээр

очиж Н.Э даргын хамааралтай хэд хэдэн гэрээг баталгаажуулж байсан. Гэрээнүүдийг харахад "Р", "Э" ХХК-ийн 25 хувь, "Э" ХХК бүхэлдээ Н.Эн руу шилжсэн гэрээнүүдийн төсөл миний бэлдсэнээр байна. Уг гэрээнүүдийн текст агуулгыг би бичсэн. Гэрээ байгуулах дарааллын хувьд миний бэлтгэсэн гэрээний төслийг Б.Х аваад Н.Эн, Э.Бш, Б.Ту нараар гарын үсэг зуруулж надад өгөхөөр би Н.Э даргаар гарын үсэг зуруулж байсан. Дээрх гэрээнүүдийн аль нэг дээр Б.Х бид 2-ын дунд маргаан үүсч байсан. Би Б.Х-т "энэ хүнээр яаж гарын үсэг зуруулаад байгаа юм бэ, энэ хүн чинь Монголд байгаа юм уу, итгэмжлэл байгаа юм уу" гэхэд "байгаа" гэсэн. Би тэгэхээр нь итгэмжлэл байгаа юм бол чи өөрөө гарын үсэг зураач гэхэд итгэмжлэл байгаа өөрсдөөр нь гарын үсэг зуруулсан гэж хэлсэн. Н.Э дарга ийм гэрээ хийх хэрэгтэй байна гэсний дагуу би төслийг бэлдэж өгсөн. Цаад учир шалтгааныг би мэдэхгүй ..." /14-р хх, 135-137/,

Сэжигтэн Д.Д-ийн "... 2006 оны 5 дугаар сараас өнөөдрийг хүртэл Нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч даргаар ажиллаж байна. "ХД" ХХК өөрийн оруулах хэмжээг Засаг дарга Ц.Б-т тавьсан. Манайд шууд хандаагүй. "ХД" ХХК-ийг манай газраас сонгоогүй, Засаг даргаас оруулж ирсэн юм. Нийслэлийн Засаг дарга Ц.Б үүрэг өгсөн. Манай байгууллага бол нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг. 2007 онд "Ө зочид буудал" НӨҮГ-ыг 51:49 хувь болгох талаар танилцуулгыг хэн боловсруулсныг мэдэхгүй. Харин хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулах тухай танилцуулгыг би мэргэжилтэн Т.Ос-д үүрэг өгч бичүүлж байсан. "ХД" ХХК-аас "Ө зочид буудал" НӨҮГ-т 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Хөрөнгө оруулалтыг баталгаажуулж өгөөч гэсэн хүсэлт ирүүлсэн. Үүнийх нь дагуу хөндлөнгийн экспертиз оруулахад 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна гэж гарсан..." /16-р хх, 89-93/, гэх мэдүүлгүүд,

"Ө зочид буудал" НӨҮГ-т хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан, хөрөнгийн харьцааг 51:49 болгож, үйл ажиллагааны цар хүрээг нь нэмэгдүүлэх, хувь нийлүүлэгчийн хөрөнгө оруулалтын хэмжээ 49 хувь байх ба үүнийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн дунд төсөл сонгон шалгаруулах зарчмаар сонгох тухай танилцуулгыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан

нийслэлийн Засаг дарга Ц.Б-ын 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 1/1386 тоот албан бичиг /10-р хх 224-

"Ө", "Д" зочид буудлын үйл ажиллагааг шинэчлэн сайжруулах, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл сонгон шалгаруулалт явуулан дүнг 2007 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг Засаг дарга Ц.Б-т зөвшөөрсөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 159 дүгээр тогтоол /10-р хх 223/,

Дээрх тогтоолын дагуу "Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, нийслэлийн өмчийн 25 хувийн оролцоотой "Д Ө" ХХК-ийг шинээр зохион байгуулах тухай танилцуулгыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан нийслэлийн Засаг дарга Ц.Б-ын 2007 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1/1724 тоот албан бичиг /10-р хх 199-202/,

"Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, нийслэлийн өмчийн 25 хувийн оролцоотой "Д Ө" ХХК-ийг шинээр зохион байгуулах асуудлыг нийслэлийн өмчийн харилцааны газрын орлогч дарга Д.Д хурлаар хэлэлцүүлэхдээ "ХД" ХХК-ийг судалж үзээд сонгосон хэмээн танилцуусныг бэхжүүлсэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл /10-р хх 182-185/,

Нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой хамтарсан компани байгуулахыг нийслэлийн Засаг дарга Ц.Б-т үүрэг болгосон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 188 дугаар тогтоол /10-р хх 26/,

"Ө зочид буудал" НӨҮГ-ыг татан буулгаж, нийслэлийн өмчийн 25 хувь, "ХД" ХХК-ийн 75 хувийн оролцоотой, "Д Ө" ХХК байгуулах тухай нийслэлийн Засаг дарга Ц.Б-ын 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 555 дугаар захирамж /10-р хх 24-25/, - "Д Ө" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ /11-р хх 10/,

"Ө зочид буудал" НӨҮГ-ыг өөрчлөн шинэчлэхэд төсөл сонгон шалгаруулалт явагдаагүй" гэх Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга Ц.Б-ын 2012 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/84 тоот албан бичиг /10-р хх 44/,

Шинжээч Г.Н-гийн "...Ю-Б-П" ХХК нь "Ө зочид буудал" НӨҮГ-ын үнэлгээг тогтоохдоо газрыг нарийвчлан тооцолгүй, 468.000.000

төгрөгөөр үнэлсэн байсан. 2007 оны 10 дугаар сарын байдлаар "Ө зочид буудал" НӨҮГ-ын зах зээлийн үнэ 605.000.000 төгрөг болж байгаа ..." /15-р хх, 163-165/ гэх мэдүүлгүүд

2009 оны 7 дугаар сарын 10-ны өдөр "Э" ХХК-ийг бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чиглэлээр Н.Э, Б.Ту нар үүсгэн байгуулж улсын бүртгэлд бүртгүүлсэн талаарх улсын бүртгэлийн лавлагаа, баримтууд /13-р хх, 129-146/,

2006 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Э.Бш "Р" ХХК-ийг үүсгэн байгуулж, 2010 оны 03 дугаар сарын 03-ны өдөр тус компанийн бүх хувьцааг хариу төлбөргүйгээр "Э" ХХК-д шилжүүлсэн тухай баримтууд ..." /13-р хх, 77-88/, - Э.Бш-ын үүсгэн байгуулсан "Р" ХХК нь "зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлал, гадаад худалдаа эрхлэх" үйл ажиллагааны чиглэлээр 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдөр "ХД" ХХК-ийг үүсгэн байгуулсан тухай улсын бүртгэлийн лавлагаа, баримтууд /13-р хх, 94-96, 152-160/ - 2010 оны 02 дугаар сарын 8-ны өдөр Б.Ту нь "Э" ХХК-д эзэмшдэг 250 ширхэг хувьцаагаа Н.Э-т хариу төлбөргүйгээр шилжүүлсэн тухай баримт ..." /13-р хх, 129-133/, - 2010 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Н.Э нь "Э" ХХК-ийг иргэн Н.Эн-д шилжүүлсэн тухай баримтууд ..." /13-р хх, 119-128/, - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Б-ыг өмч хувьчлах комиссын даргаар томилох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 53 дугаар тогтоол /10-р хх, 69,82/, - Ц.Б-ыг нийслэлийн Засаг даргаар томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Э-ийн 2005 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 136 дугаар захирамж /17-р хх-59/, - Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 326 дугаар шийтгэх тогтоол /16-р хх, 172-197/, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 749 дүгээр магадлал /16-р хх, 198-246/, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2012 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 775 дугаар тогтоол /16-р хх, 249-250, 17-р хх, 1-29/ зэрэг нотлох баримтуудаар,

Т.Б нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Н.Э, иргэн Д.Ч нартай бүлэглэн

УТ менежментийн багийн 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан "Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах гэрээ"-ний дагуу бизнес төлөвлөгөө нь бүрэн хэрэгжээгүй, аудит хийгдээгүй, алдагдалтай ажиллан гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байхад Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 75 дугаар тогтоол гаргаж, 2.125.000.000 төгрөгийн үнэлгээтэй "УТ сонин" НӨҮГ-ыг хууль бусаар Ерөнхийлөгч Н.Э-ын төрсөн дүү Н.Эн-гийн "Мх" ХХК буюу иргэн Д.Ч нэрээр хувьчлах замаар үрэгдүүлэн нийслэлийн өмчид онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай болох нь:

Хохирогч Л.С-ийн "...2004 онд Улсын Их Хурлын гишүүн Т.Бж Д.Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэрийн барилга буюу "УТ" сонины газрын менежментийн хувьчлалд Ж.Сар ахлагчтай баг ялсан тул намайг хөрөнгө оруулахыг санал болгосон. Үүний дагуу 493.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн боловч "УТ" сонин менежментийн багт намайг оруулалгүй 2008 онд Д.Ч-ыг гишүүнээр оруулан багийн ахлагчаар томилсноор "УТ" сонины газрыг хувьчилсан. Т.Бж нь "УТ сонин" менежментийн багийн гишүүн О.А нь Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Э-ын эхнэр О.Ц-ийн, Зам тээвэр, барилга, хот байгууллалтын яамны дэд сайд А.Гс нь Ерөнхий сайд С.Б-ын, Н.А нь шадар сайд М.Э-ын, Б.У нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд Т.Бж-гийн, Б.Со нь УИХ-ийн гишүүн Ц.Да-ийн төлөөлөл гэж танилцуулсан..." /5-р хх, 165-182/,

Гэрч А.Гс-ийн "... Олон жил өнгөрсөн учраас он, сарыг тодорхой санахгүй байна. "УТ" сонины эрхлэгч Ж.Сар 2003 оны сүүлээр менежментийн хувьчлалын талаар хуулийн зөвлөгөө авсан юм. "УТ" сонины менежментийн хувьчлалд манай багт нэрээ оруулаад цаашид хуулийн зөвлөхөөр ажиллаад өгөөч гэсэн санал тавьсан. Миний хувьд тухайн үед өмгөөлөгчөөр ажиллаж байсан учраас өмгөөллийн гэрээ хийж ажиллая гэсэн. Ингээд би Ж.Сар-гийн удирдсан менежментийн багт гишүүнээр орж ажиллахаар болж гишүүний материал бүрдүүлж өгсөн. Түүнээс хойш Ж.Сар-тай дахин уулзаагүй учир нь менежментийн баг хувьчлалдаа ялсан эсэхийг мэдээгүй..." /5-р хх, 236-238/,

Гэрч Н.Ат-гийн "... Менежментийн багийн үйл ажиллагаанд би сонины нийтлэлийн бодлого хариуцаж ажиллаж байсан учир төсөлд заасны дагуу ажлаа явуулсан. Санхүүгийн талаар бол би сайн мэдэхгүй байна. 2004 ондоо үйл ажиллагаа гайгүй л явж байсан. Бид цалингаа цаг хугацаанд нь аваад явж байсан. Манай сонин өөрийн байртай, түрээслэгчид ихтэй байсан. Би 2004 оны 7 дугаар сараас 2005 оны 4 дүгээр сар хүртэл өвдөж явж байгаад ажилдаа ирэхэд манай ажил хуучин байрнаасаа нүүгээд СУИС-ийн баруун талд "Хг" ХХК-ийн байранд орсон байсан. Энэ хоорондох асуудлын талаар би мэдэхгүй байна. Ингээд нүүснээс хойш үйл ажиллагаа доголдож хүмүүс ажлаасаа гарч эхэлсэн. Цалингаа хугацаандаа тавьж чадахгүй болсон. Тэгээд татвар, нийгмийн даатгалын өр ширэнд орж эхэлсэн. Л.С хөрөнгө оруулагч гэж Ж.Сартай гэрээ байгуулсан. Тэрнээс багийн гишүүнээр элсээгүй болно. Харин 2007 оны 7 дугаар сараас 2008 оны 8 дугаар сар хүртэл би сонины ерөнхий эрхлэгчээр ажиллаж байсан. Тэгэхэд Л.С өргөдөл гаргаад менежментийн багт гишүүнээр оръё гэсэн. Бид гишүүнээр элсүүлэх зөвшөөрөл хүсэж Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүсэлт гаргасан боловч "гишүүн элсүүлэх асуудлыг манайх дангаар шийдэхгүй, Нийслэлийн өмч хувьчлах комиссын хурлаар шийдэх ёстой" гэсэн хариу өгсөн. Тэгээд энэ асуудал шийдэгдээгүй. Ж.Сар бол тухайн үед сонины эрхлэгчийн ажлаа өгчихсөн багийн ахлагч байсан. Д.Ч надтай уулзаад сониныг сонирхож, ажил байдал явцын талаар асууж байсан. Мөн ерөнхий эрхлэгчээр ажиллах хүсэлтэй байгаагаа хэлсэн. Би ч ерөнхий эрхлэгчийн ажлаа өгөх хүсэлтэй байсан тул Ж.Сар даргатай яриад хурал зарлаж хуралдуулаад Д.Ч-ыг ерөнхий эрхлэгчээр ажиллуулах болсон. Д.Ч захирал У бид 2-той "Ту" компанийн хавьцаа ресторанд уулзаж "хөрөнгө оруулах боломжгүй бол хувьцаагаа зараад гарвал та хоёрт тус бүрт чинь 30.000.000 төгрөг өгнө" гэхээр нь бид зөвшөөрч мөнгөө аваад компаниас гарахаар болсон..." /5-р хх, 228-235/.

Гэрч Ш.У-гийн "... Д.Ч ямар замаар орж ирснийг би мэдэхгүй. Ж.Сар эрхлэгчтэй уран бүтээлийн танилууд болно. Гэхдээ Ат эрхлэгч ажлаа өгмөөр байна гээд байсан юм. Ж.Сар дарга Д.Ч-ыг сонины эрхлэгчээр томилъё гэсэн санал гаргаж шийдсэн. Энэ хурлаар шийдвэр гаргахад гишүүдийн ирц

хүрэхгүй байсан. Тэгтэл Д.Ч гуай багийн гишүүн А намайг дэмжиж байгаа. Тиймээс А-гийн саналыг тэмдэглэлд оруулъя гэснээр түүнийг хуралд оролцсоноор тэмдэглэл хөтөлсөн. Харин С.Б, Б.Со, А.Гс, А гэх хүмүүс нэр нь явдаг боловч үйл ажиллагаанд ямар нэг байдлаар оролцдоггүй байсан ..." /5-р хх, 212-219/.

Гэрч Н.Бу-ийн "... "УТ сонин" НӨҮГ-ын хувьчлалтай холбоотой материалыг Ц гэж мэргэжилтнээс хүлээн авсан. Намайг анх материал авахад Нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаант шалгаруулалтын журам, Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний үлгэрчилсэн загвар зэрэг нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор батлагдсан байсан. Ингээд үүнээс хойш хувьчлах асуудлыг би хариуцаж ажилласан. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах этгээдийг сонгон шалгаруулах тухай зар мэдээллийг бэлтгэж хэвлэл мэдээллээр зарлуулсан. Би мэдээллийг нь бэлтгэж өгөөд тухайн үед дотоод ажил хариуцаж байсан. "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлах тендерийн комиссыг томилох материалыг бүрдүүлж, нийслэлийн Засаг даргын 2004 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 79 дүгээр захирамжаар тендерийн комиссыг батлуулж, би өөрөө нарийн бичгийн даргаар нь ажилласан. 2003 оны 11 дүгээр сард "УТ сонин" НӨҮГ-ын үнэлгээг "Ю-Б-П" Ххк-аар хийлгүүлсэн. Энэ үнэлгээний компанийн захирал нь тухайн үед манайд мэргэжилтэн байсан Ц.О-ын нөхөр Э байсан. Үнэлгээний тайлангийн нийт үнийг 369.723.300 төгрөгөөр тогтоосон. Би энэ үнэлгээг нийслэлийн өмч хувьчлалын хуралд оруулж танилцуулаад, менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаанд шалгаруулалт явуулахыг даалгасан тогтоол гарсан. УТ багийн гэрээний үүрэг хангалтгүй биелсэн гэж үзээд хувьчлах боломжгүй гэж шийдсэн. М.Гб дарга ирээд бүтцийн өөрчлөлт хийхэд 2007 онд өмч хувьчлалын хэлтсээс гарч төлөөллийн хэлтэст очсон. Ингээд шилжихдээ УТ-ын материалыг хэнд хүлээлгэж өгснөө санахгүй байна. Би бүтцийн өөрчлөлтөөр буцаад өмч хувьчлалын хэлтэст ирсэн юм. Ирэхэд "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчилж Д.Ч ахлагчтай багт өмчлөх эрх олгосон гэрчилгээ нь гарсан байсан..." /5-р хх,

- Гэрч Ц.Да-ийн "... Тухайн үед "С сонин"-ны эрхлэгч хийж байсан Ба над дээр ирж уулзаад "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлахаар тендер зарлагдаж байна. Үүнд оролцье гэсэн саналыг тавьсан. Би тухайн үед сонин ашигтай юм уу гэхэд Ба ашигтай гэж хэлсэн. Би бол сонины талаар мэдлэг мэдээлэл муутай хүн учир түүний саналыг дэмжсэн. Би тухайн үед УИХ-ын гишүүн байсан болохоор эхнэр Б.Со миний ажлыг хариуцаж ажиллаж байсан. Б.Со Ба-тэй уулзаж дэнчингийн мөнгийг өгсөн. Түүнээс хойш тэр менежментийн багийн үйл ажиллагаанд оролцоогүй ..." /6-р хх, 1-2/,

- Гэрч Б.Со-гийн "... 2004 онд байх сайн санахгүй байна. Намайг ажил дээрээ байхад манай нөхөр Ц.Да утсаар яриад Улаанбаатар сонин дээр очоод уулз гэсэн. Яаралтай мөнгө хэрэгтэй байна, юмыг яаж мэдэх вэ? мөнгийг нь очоод тушаачих, мөн иргэний үнэмлэхтэйгээ очоорой баримт бүрдүүлэх юм байна гэсэн. Тэгээд би хуучин хэвлэх үйлдвэр, Засгийн газрын ордны зүүн талд байрлах одоо нураасан байгаа байранд очиж уулзсан. Яг хэдэн төгрөг тушааснаа мэдэхгүй байна. Би нөхрийгөө сонин луу орох гэж байгаа юм байна л гэж ойлгосон. Тэгээд нэг их удаагүй асуудал нь бүтэхээ болилоо гээд дэнчинд төлсөн мөнгөө буцаан авсан ..." /6-р хх, 26-27/,

- Гэрч Т.Бж-гийн "...Сар ахлагчтай багт би нэр зааж гишүүд оруулсан асуудал байхгүй. Ж.Сар багийн гишүүдээ бүрдүүлсэн байх. Иргэний нисэхийн дарга байсан Л жанжингийн хүүхэд Лх гуай 2004 оны зун намайг УИХ-ын гишүүн болоогүй хотын ерөнхий менежерийн ажлыг гүйцэтгэж байхад надтай захирагчийн ажлын албаны өрөөнд уулзаад манай хүү Л.С-д эдийн засгийн боломж байгаа. Иймд "УТ" сонины барилгын ажилд хөрөнгө оруулагчаар ажиллах асуудлыг уламжилж өгөөч гэсэн. Тэгээд би "УТ сонин"-ы эрхлэгч Ж.Сар-тай Л.С-г холбож өгч уулзуулсан..." /6-р хх, 13-20/,

Гэрч Ү.Хү-ын "... "УТ сонин" НӨҮГ-ын менежментийн хувьчлалд өөрийн нэрээр дангаараа тендерт оролцохоор материал худалдаж авсан боловч эцсийн шатны шалгаруулалтад мэдээллээр бүрэн хангаагүй учир оролцож чадаагүй ..." /5-р хх, 249-250/,

Гэрч Ц.Бя-ын "... Ж.Сар захирал намайг менежментийн хувьчлалд эсрэг баг болж материал бүрдүүлээд ороод өгөөч гэсэн хүсэлтийг тавьсан. Ингээд би тухайн үед

өөрийнхөө нэрээр менежментийн хувьчлалд материал бүрдүүлж оролцсон. Миний бүрдүүлсэн материалын дэнчингийн мөнгийг УИХ-ын гишүүн Ц.Да-ийн эхнэр Б.Со төлж байсан. Дэнчингийн мөнгө нь 36-37.000.000 орчим төгрөг болж байсан ..." /5-р хх, 195-200/,

Гэрч Г.М-ын "... Хувьчлах ажил хийгдэж байх үед НӨХГ-ын даргаар М.Гб ажиллаж байсан. М.Гб дарга "УТ" менежментийн багийн дарга Ж.Сар-г өөрчилж, Д.Ч-ыг тавихаар боллоо. Дээрээс дарга нар тийм чиг өглөө гэж надад хэлсэн. Ц.О бид хоёр "менежментийн гэрээг цуцлах эсхүл гэрээг сунгах, бүр газрыг нь дуудлага худалдаагаар худалдаж тэр хөрөнгө оруулалтаар хэвлэх үйлдвэрээ барих" зэрэг хувилбарууд гаргаж санал оруулж байсан. Гэтэл хотын удирдлагуудаас хувьчлах нь зүйтэй гэсэн чиг ирсэн учир хувьчлах санал оруулсан. Үнэнийг хэлэхэд энэ хувьчлах шийдвэр, санал хотын дарга Т.Б-ээс гаралтай гэж би үзэж байна ..." /6-р хх, 7/

Гэрч Ц.О-ы "...Би "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлах тухай асуудлыг хариуцаж байсан. УТ менежментийн багтай байгуулсан гэрээний хугацаа 2007 оны 5 дугаар сарын 7-нд дууссан. Би тус багт тайлангаа ирүүл, цаашид хэрхэх талаар саналаа ирүүл гэж албан бичгээр хандаж байсан. Дарга нартаа энэ байгууллагын үйл ажиллагаанд аудит оруулъя гэсэн саналаа удаа дараа гаргаж байсан. Намайг санал оруулахаар хэлтсийн дарга Г.М түр байж бай гээд байлгаад байсан. Мөн багийн гишүүдэд өөрчлөлт оруулахаар санал удаа дараа ирүүлсэн. Ингээд би ер нь энэ байгууллагын гэрээг цаашид сунгах эсэх, аудитын комисс томилж дүгнэлт гаргуулах асуудлыг НӨХК-ийн хуралдаанаар оруулж нэг мөсөн шийдвэрлүүлэе гэж үзээд танилцуулга, материалаа бэлдээд Г.М даргад танилцуулсан. Дараа нь гэрээг сунгах эсэх асуудлыг ярихгүй шууд хувьчлах санал оруулахаар боллоо гээд материал бэлд гэсэн. Ер нь менежментийн гэрээний гол агуулга нь энэ байгууллагыг өөд нь татах явдал байсан. Гэтэл энэ үүргээ биелүүлээгүй байхад надаар шууд танилцуулга бичүүлж улмаар комиссын хуралдаанд оруулж шийдвэрлэсэн. Улаанбаатар таймс менежментийн баг гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байсан ..." /5-р хх, 240-242/,

- Гэрч М.Э-ын "... Нийслэлийн өмч хувьчлах комиссын 75 дугаар тогтоолоор Д.Ч гэдэг хүнийг менежментийн багийн

ахлагчаар томилогдсон. "УТ сонин" НӨҮГ-ыг хувьчлах асуудлыг тавьсны дагуу анхны үнэлгээ 369.724.000 төгрөгөөр хувьчилсан. 75 дугаар тогтоолын дагуу 2008 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 28 дугаартай НӨХГ болон "УТ" багийн ахлагч Д.Ч нар худалдах, худалдан авах гэрээг байгуулсан ба гэрээний 3.8 дахь хэсэг "УТ сонин" НӨҮГ-ын өр төлбөрийг маргаангүйгээр 1 сарын дотор буюу 2008 оны 10 дугаар сарын 12-ны дотор төлж барагдуулна гэж заасан..." /6-р хх, 44-46/,

- Шинжээч Ж.У-гийн "... "Ю-Б-П" ХХК-ийн үнэлгээгээр 2003 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар "УТ сонин" НӨҮГ-ын зах зээлийн бодит үнэлгээг 369.723.388 төгрөгөөр тогтоосон нь тухайн үеийн зах зээлийн бодит үнэлгээнээс даруй 2.7 дахин бага байсан..." /15-р хх, 167-168/,

- Сэжигтэн Ж.Сар-гийн "... 2004 оны хавар УИХ-ын гишүүн Т.Бж хөрөнгө оруулагч Л.С-тэй Засгийн газрын ордонд гишүүний өрөөнд намайг дуудаж уулзуулсан. Намайг очиход Т.Бж гишүүн "Л.Сг хөрөнгө оруулагчаар оруулвал зүгээр байх, энэ хүн онгоцны нислэг болон аялал жуулчлалын компанийн захирал тул хөрөнгө оруулагч болго" гэсэн. Л.С надтай хэд хэдэн удаа уулзаад сонины барилгыг 3 давхар болгох барилгын зураг төсөл хийж ирсэн. Ингээд би Л.С-тэй 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр менежментийн багт хөрөнгө оруулалт хийх тухай гэрээ байгуулсан. Өөрөөр хэлбэл, тус сонины газар менежментийн гэрээний үр дүнг харгалзан 2007 онд хувьчлах үед 40 хувийг эзэмших нөхцөлтэй. Би 2007 оны 5 дугаар сард сонины эрхлэгчийн ажлаа өгөөд ажилгүй байж байгаад 2007 оны 12 дугаар сард БСШУ-ны сайдын тушаалаар Үндэсний түүхийн музейн захирлаар томилогдсон. Д.Ч надтай ирж уулзаад сонины эрхлэгчийн ажлыг авъя гэж хэлсэн. Тэгээд миний хувьд татгалзах зүйлгүй гэдгээ хэлсэн ба 2007 оны зун сонины эрхлэгчээр томилогдсон. Би оюуны хөрөнгө оруулалт хийсэн учраас түүнийгээ 50.000.000 төгрөгөөр үнэлж, Д.Ч-аас аваад менежментийн багийн гишүүнээс бүр мөсөн гарч баримт үйлдэж өгсөн. 2007 онд гэрээ дуусаж гэрээг дүгнэх ёстой байсан ба хотын дарга Ц.Б-тай удаа дараа уулзахад "чи сонины ажлаа өг" гэж шахаж дарамталсан ..." /8-р хх, 121-128/ гэх мэдүүлгүүд,

- "УТ сонин" НӨҮГ-ыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах шалгаруулалтад Ж.Сар ахлагчтай "УТ" баг

87,3 оноогоор ялагч болсон тухай тендерийн комиссын 2004 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн тайлан /2-р хх, 41-42/, - Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2004 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Ж.Сар ахлагчтай УТ багтай байгуулсан "Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах тухай" гэрээ /2-р хх, 164-184/,

-Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2005 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 5-244-1973 тоот дүгнэлт /3-р хх, 94-95/,

- "УТ сонин" НӨҮГ-ын 2004, 2005, 2006, 2007 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийхэд тус газрын эд засгийн үзүүлэлтүүд "УТ" менежментийн багийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсанаар хэрэгжээгүй болохыг тогтоосон Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2007 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн акт /3-р хх, 100-108/,

"УТ" менежментийн багийн үйл ажиллагаа гэрээнд зааснаар явагдаагүй, алдагдалтай ажилласан тул гэрээг цуцлах, иргэн Л.С-ийн оруулсан хөрөнгийг өр төлбөрт тусгаж, дахин тендер зарлах, эсхүл гэрээг үргэлжлүүлж өр, хөрөнгө оруулалтын нийт дүнг оруулах замаар нээлттэй тендер зарлах, гурав дахь хувилбар нь сонины газрыг хотын харьяанд хэвээр ажиллуулах талаар Өмч хувьчлалын хэлтсийн 2008 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн танилцуулга /3-р хх, 110-112/,

Нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээгээр ажиллуулж байгаа багуудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн 2005 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн аудитын тайлан /5-р хх, 67-68 /,

"УТ" менежментийн багийн бүрэлдэхүүнд Д.Ч-ыг нэмж оруулан, багийн ахлагч Ж.Сар-г чөлөөлж, Д.Ч-ыг багийн ахлагчаар томилж, "УТ сонин" НӨҮГ-ыг менежментийн багт нь гэрээнд заасан үнэ болох 369.724.000 төгрөгөөр худалдах тухай Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 75 тоот тогтоол, /4-р хх-63/,

-Нийслэлийн өмчийн харилцааны газар, "УТ" багийн ахлагч Д.Ч-тай 2008 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан худалдах-худалдан авах тухай 28 тоот гэрээ /4-р хх, 65-66/,

- "УТ сонин" НӨҮГ-ын дарга Д.Ч нь 2008

оны 09 дүгээр сарын 25-ны өдөр "Мх" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Х-тай 332.751.600 төгрөгийг 14 хоногийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй зээлсэн зээлийн гэрээ /5-р хх, 118-119/,

- "Мх" ХХК, "УТ сонин" менежментийн багийн ахлагч Д.Ч-тай 2008 оны 10 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан хөрөнгө оруулж хамтран ажиллах тухай гэрээ /5-р хх, 122/,

- Д.Ч ахлагчтай "УТ" менежментийн багт "УТ" НӨҮГ-ын өмчлөх эрхийн гэрчилгээ олгож, зохих журмын дагуу хүлээлгэж өгөхийг даалгасан Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2008 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 96 тоот тогтоол /4-р хх, 77/,

- "УТ" НӨҮГ-ыг Д.Ч ахлагчтай "УТ" менежментийн баг 369.724.000 төгрөгөөр худалдан авсан уг хөрөнгийн өмчлөгч болсныг гэрчилсэн 2008 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 33/2008 тоот өмчлөгчийн эрхийн гэрчилгээ /4-р хх, 76/,

- 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Н.А, Ж.Сар, Ш.У, Б.Со нарын "УТ" менежментийн багийн гишүүнээс гарах хүсэлтүүд /6-р хх, 194-200/,

- "УТ" ХХК-ийг 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Д.Ч, А.Гс, С.Ба, О.А нар болон "Мх" ХХК үүсгэн байгуулсан тухай улсын бүртгэлийн лавлагаа /6-р хх, 156-165/,

- "УТ сонин" НӨҮГ-ын хөрөнгийн үнэ 2008 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 2.125.000.000 төгрөг болохыг тогтоосон "ХҮТ" ХХК-ийн шинжээчийн дүгнэлт /7-р хх-103/,

- Т.Б-ийг Нийслэлийн Засаг даргаар томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайд С.Б-ын 2007 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 116 дугаар захирамж... /25-р хх-86/,

- УТ сонины газрыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 128 тоот тогтоол /1-р хх, 105-107/,

- Менежментийн үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгох уралдаан шалгаруулалтын журам, гэрээний загварыг баталсан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 141 тоот тогтоол /1-р хх, 108-142/,

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 130 тоот тогтоол /1-р хх-144/,

- Нийслэлийн өмч хувьчлах комиссын 2003 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах тендерийг зарлах тухай 101 тоот тогтоол /1-р хх-149/,

- 2001 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Э.Э, Б.Б нар нь 1.000.000 төгрөгийн дүрмийн сантай "Мх" ХХК-ийг үүсгэн байгуулж, Ц.Б нь өөрийн 250 ширхэг хувьцаагаа Ц.М-д, Э.Э нь 500 ширхэг хувьцаагаа Н.Эн-д шилжүүлж, үүний дараа 2007 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Ц.М, Б.Б нар 25 хувийн хувьцаагаа тус тус үнэ төлбөргүйгээр Н.Эн-д шилжүүлсэн баримтууд /13-р хх, 7-88/,

- 2010 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Н.Эн нь "Мх" ХХК-ийн бүх хувьцааг "Э" ХХК-д хариу төлбөргүйгээр шилжүүлсэн хувьцаа шилжүүлэх гэрээ /13-р хх -4/

- Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 326 тоот шийтгэх тогтоол /16-р хх, 172-197/, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 749 тоот магадлал /16-р хх, 198-246/, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн 2012 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн шүүх хуралдааны 775 тоот тогтоол /16-р хх, 249-250, 17-р хх, 1-29/ зэрэг болон хэрэгт цугларч шүүх хуралдаанаар шинжлэн судалсан бусад нотлох баримтуудаар нотлогдон, тогтоогджээ.

Мөрдөн байцаалтын шатанд шалгавал зохих бүхий л нөхцөл байдлыг бүрэн шалгасан, шүүх хуульд заасан журмын дагуу цугларч, шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудыг харьцуулан үнэлсний үндсэн дээр Ц.Б, Т.Б нарын гэм буруугийн талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, хэргийг зөв зүйлчлэн, тэдний хувийн байдал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон ял оногдуулсан байна.

Ялтнуудын үйлдсэн гэмт хэрэг нь 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан "Өршөөл үзүүлэх тухай" хуулийн үйлчлэлд хамаарч байгаа тул анхан шатны шүүх "албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж онц их хэмжээний хохирол учруулсан" хүндэвтэр гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож, "бусадтай бүлэглэн итгэмжлэн хариуцсан төрийн өмчийн хөрөнгийг үрэгдүүлсний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан" гэмт хэрэгт оноосон ялаас ялтан Т.Б-ийг өршөөн хэлтрүүлж, ялтан Ц.Б-т оноосон

ялын тодорхой хэсгийг өршөөн хасаж шийдвэрлэсэн нь хуульд нийцжээ.

Мөн шүүгдэгч Ц.Ч нь өөрийн төрсөн ах Ц.Б-ыг нийслэлийн Засаг даргын албан тушаалд томилогдохоос өмнө "СЗК" эмнэлгийн удирдлагыг гэрээгээр гүйцэтгэх сонгон шалгаруулалтад ялагч болж, 3 жилийн хугацаатай тус эмнэлгийн удирдлагыг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан бөгөөд гэрээг дүгнэж, үр дүнг харгалзан Ц.Ч-д хувьчлах асуудлыг нийслэлийн өмч хувьчлах комиссын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн хэргийн үйл баримт тогтоогдсон. Гэвч энэхүү хувьчлалын үйл ажиллагаанд Ц.Б, Г.М нар хэрхэн бүлэглэж, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа хортойгоор ашиглаж оролцсон болох нь нотлогдоогүй гэж үзэж холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон, Г.М, Ц.Ч нарыг цагаатгаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй, зөв байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах", 6 дахь заалтад "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг Төрийн өмчийн хорооны мэргэжил, арга зүйн удирдлага дор хувьчлах ажлыг зохион байгуулах" эрхтэй болохыг тус тус хуульчилсан.

Дээрх хуулийн зүйл, хэсэг, заалтаас үзэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах ажлыг зохион байгуулах эрх, үүргийг Засаг даргад олгожээ. Иймээс менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах, сонгон шалгаруулалт явуулж шалгарсан аж ахуйн нэгжтэй хамтарсан компани байгуулах талаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэртэй "Ө зочид буудал", "УТ сонин" НӨҮГ-уудын хувьд Засаг дарга нар итгэмжлэн хариуцсан этгээдүүд байна.

Тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Н.Э нь өөрийн бүрэн эрхэд хамааралгүй боловч албан тушаалын байдлаа урвуулан

ашиглаж хууль бус шийдвэр гаргуулан нийслэлийн өмчийг өөрийн төрсөн хүү Э.Бш-ын үүсгэн байгуулсан "ХД" ХХК, төрсөн дүү Н.Эн-гийн эзэмшдэг "Мх" ХХК-д хувьчлуулах, улмаар уг компаниудыг өөрийн үүсгэн байгуулан "Э" ХХК-д шилжүүлэх замаар завшсан гэмт хэргийг зохион байгуулсан. Ц.Б, Т.Б нар нийслэлийн Засаг дарга бөгөөд Өмч хувьчлах комиссын даргаар ажилласан тус тусын цаг хугацаандаа албан тушаалын эрх мэдлээ ашиглан хууль бус шийдвэр гаргах байдлаар "нийслэлийн өмчийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан" хэрэгт гүйцэтгэгчээр хамтран оролцсон болох нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон дээрх нотлох баримтуудаар хөдөлбөргүй нотлогдсон байх тул Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар зүйлчилсэн хэргийн зүйлчлэл тохирсон гэж үзэв.

Анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй, шийтгэх тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй байх хуулийн шаардлагад нийцсэн байна.

Ц.Б-т оногдуулсан ял түүний гэм буруу, үйлдсэн хэрэгт нь тохирсон, хүнд биш байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 551 дүгээр зүйлийг хэрэглэн ялыг доош татах үндэслэл байхгүй. Нөгөөтэйгүүр уг заалтыг шүүхэд заавал хэрэглэхийг хууль тогтоогч үүрэг болгоогүй учраас "хэрэглээгүй нь ялтны эрх зүйн байдлыг дордуулсан" явдал болохгүй тул энэ талаар гаргасан давж заалдах гомдлыг хангах боломжгүй.

Харин энэ хэргийг зохион байгуулсан ялтан Н.Э-т шүүхээс оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсэн атал гүйцэтгэгчээр оролцсон Ц.Б-т түүнээс хүнд, "чанга" дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэхээр шийдвэрлэсэн нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Ц.Б-ын гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, оролцоо, түүний нас, эрүүл мэндийн болон хувийн байдал, анх удаа гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял эдлэх дэглэмийг хөнгөрүүлэх нь зүйтэй. Энэ талаар гаргасан өмгөөлөгчийн гомдол үндэслэлтэй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.1, 315.1.4 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 07 дугаар



сарын 22-ны өдрийн 863 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 8 дахь заалтад "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Ц.Б-т оногдуулсан 02 жил 01 сар хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй" гэснийг "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасныг журамлан мөн зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Ц.Б-т оногдуулсан 2 жил 1 сар хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй" гэж өөрчилж, тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээн, ялтан Ц.Б-

ын өмгөөлөгч Ч.Шаравнямбуугийн "... Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 551 дүгээр зүйлийг хэрэглэн ялыг доош татаж өгнө үү ..." гэсэн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

2. Гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл магадлалыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Л.ДАВААСҮРЭН  
Ч.ХОСБАЯР  
М.ПҮРЭВСҮРЭН

## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 1189

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Г.Буяннэмэх даргалж, шүүгч И.Ганбат, Б.Халиун нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд хийсэн шүүх хуралдаанаар

иргэдийн төлөөлөгч П.Цэрэнчимэг, нарийн бичгийн дарга Б.Батбаяр, улсын яллагч Ж.Сандагсүрэн, шүүгдэгч Б.Эн, түүний өмгөөлөгч Ц.Монгол, шүүгдэгч Ж.А, түүний өмгөөлөгч Б.Билгүүн, хохирогч Боловсролын үнэлгээний төвийн төлөөлөгч Т.От нарыг оролцуулан,

Дүүргийн 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.3, 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн, Б.Эн, Ж.А нарт холбогдох, 20120100007. дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 18-нд хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Ховд аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, Түүх газар зүйн багш мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Боловсролын үнэлгээний төвийн захирлаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Баянгол дүүргийн ...дугаар ...тоотод оршин суудаг, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтангадас одон, ойн медалиудаар шагнагдсан, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Ц овогт Б.Эн (РД:ТЯ.....)

Шүүгдэгч Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Ховд аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Боловсролын үнэлгээний төвд ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан, ам бүл ..., нөхөр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суудаг, ойн медалиудаар шагнагдсан, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Б овогт Ж.А

(РД:ПЮ.....)

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар:

Яллах дүгнэлтэд тэмдэглэсэнээр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Боловсролын үнэлгээний төвийн даргаар ажиллаж байсан Б.Эн, нягтлан бодогч Ж.А нар нь урьдчилан үгсэн тохиролцон бүлэглэн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчиж байгууллагынхаа данснаас

"АДЭ" ХХК-ийн дансанд 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 8,0 сая төгрөг, 2011 оны 3 дугаар сарын 09-ний өдөр 5,0 сая төгрөг, 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 12,0 сая төгрөг, "Э" ХХК-ийн дансанд 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 1,0 сая төгрөг, "УМ" ХХК-ийн дансанд 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 21,0 сая төгрөг, "Г-А" ХХК-ийн дансанд 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдөр 5,0 сая төгрөгийг тус тус шилжүүлж, нийт 52 сая төгрөгийг хувийн компаниудын дансаар гаргуулан авч завшсан,

-2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг хуурамчаар үйлдэж 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр "Нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгох тухай 29 тоот тушаал гаргаж, 15 сая төгрөгийг Ж.А-ийн Голомт банкны 554849989974xxxx тоот дансанд шилжүүлэн авч завшиж Боловсролын үнэлгээний төвд нийт 67,0 сая төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед шүүгдэгч, хохирогч, бусад нотлох баримтыг шинжлэн судалж ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүх хуралдаан дээр шүүгдэгч нараас мэдүүлэхдээ:

1. Б.Эн-аас:-Манай байгууллага өмнө нь 3 жил дараалан 150,0 сая төгрөгөөр программ хийлгэсэн байсан ба тэр хувийн компанийн серверт бүх бүртгэл байсан. Бид тэндээс хэрэгтэй мэдээллээ худалдаж авдаг байсан. Боловсролын сайдын 2010 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн тушаалын дагуу 2010 онд "АДЭ" ХХК-тай 3 төрлийн программ хангамжийн талаар гэрээ хийгээд 2010 онд

12,0 сая төгрөг, 2011 онд 13,0 сая төгрөг шилжүүлээд, программ хүлээлцсэн акт үйлдэж, 2011 онд 126,0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг орлогод авч, ерөнхий журнал, мөнгөн хөрөнгийн журнал дээр бүртгэсэн байгаа. Автоматжуулсан даалгаврын төсөл гэрээний дагуу ажил үйлчилгээ хийгдсэн. Нягтлан бодогч Ж.А нь 24 жил тасралтгүй ня-богоор ажилласан, мөн Завхан аймгаас манайд нэг орон сууцны квот шилжиж ирсэн тул орон сууц авахад нь дэмжлэг үзүүлж, тушаал гаргаж, 15,0 сая төгрөгийг орон сууц авахад нь өгсөн. Лац худалдаж авахаар "УМ" ХХК-тай байгуулсан гэрээг нь би баталгаажуулсан. Хэмжил зүйн дүгнэлт, Мэргэжлийн ерөнхий газрын дүгнэлт гарч, лацыг Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өгсөн. Фитнес клубт шилжүүлсэн 1,0 сая төгрөгийг би буцаан олгосон. Би байгууллагыг хохироогоогүй, гэмт хэрэг үйлдээгүй тул гэм буруугүй болохыг тогтоож өгнө үү гэв.

2. Ж.А-ээс:-Би гэрээний дагуу программын 25,0 сая төгрөгийг шилжүүлсэн. Энэ программыг хүлээн авч, биет бус хөрөнгийн бүртгэлд авсан байгаа. Сэдвийн хайрцаг лацдах лацыг 2012 онд хэрэглэхээр БНХАУ-д захиалж хийлгүүлсэн ба мөнгийг шууд тийш нь шилжүүлэх боломжгүй байсан учир компанийн дансаар шилжүүлсэн. Лац 2012 оны 02 дугаар сарын 22-нд бэлэн болсон боловч тухайн үед эрүүгийн хэрэг үүсгэсэн тул авахгүй гээд аваагүй. Мөн удаан хугацаанд тог барьдаг хүчин чадалтай тог баригч шаардлагатай байсан тул мөн гаднаас захиалж авчруулсан. Одоо ч тэр тог баригч нь байж л байгаа.

Жилийн эцсийн тайланд өртэй гарах нь муу үзүүлэлт тул би өргүй мэт тайлан гаргасан нь миний алдаа юм. Ажлын хариуцлага алдсанаа бол хүлээн зөвшөөрнө. Харин би мөнгө авч завшаагүй. Байгууллагаас надад орон сууц авахад 15,0 сая төгрөг өгснийг байрны төлбөртөө өгсөн нь үнэн. Гэм буруугүй болохыг тогтоож өгнө үү гэв.

Шүүх хуралдаанд хохирогч Боловсролын үнэлгээний төвийн төлөөлөгч Т.От-аас мэдүүлэхдээ: -Шүүгдэгч нар нийт 52,0 сая төгрөгийг "УМ", "Ай Ди эс", "Г-А", "Э" ХХК-ийн дансаар гаргуулан авч завшсан. Хуурамч тэмдэглэл үйлдэж 15,0 сая төгрөгийг орон сууцны хөнгөлөлт нэрээр гаргаж, нийт 67,0 сая төгрөгийн хохирол учруулснаас Б.Эн 1,0 төгрөг буцааж өгсөн. Мөн лацыг 15,0 сая

төгрөгт тооцож манай байгууллага авсан. Лац, тог баригч нь Ж.А-тэй холбоотой, Б.Эн-аас программын 25,0 сая төгрөг нэхэмжилнэ. Үлдэхийг Ж.А-ээс нэхэмжилнэ гэв.

Мөрдөн байцаалтад гэрчүүдээс мэдүүлэхдээ:

Г.Бу-аас: -Би "УМ" ХХК-ийн захирал. Манай хадам ээж н.Тун-ыг Боловсролын үнэлгээний төвийн ерөнхий нягтлан бодогч Ж.А гэж хүн компанийн дансаар мөнгө гаргаж авах гэсэн гэж хэлээд гуйсан юм шиг байна лээ. Манай хадам ээж Тун намайг гуйхаар нь би өөрийн компанийн чекэн дээр гарын үсэг зураад, тамгаа дараад, өөрийн компанийн дансны дугаарыг цаасан дээр бичээд өгсөн гэжээ.

Ж.Эн-аас:-Боловсролын үнэлгээний төвийн нягтлан бодогч Ж.А намайг гуйж байгаад манай хүргэн Г.Бу-ын "УМ" ХХК-ийн дансаар 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 21.000.000 төгрөг гаргуулж авсан. Тэгээд би Г.Бу-аас компанийнх нь чекэн дээр гарын үсэг зуруулж аваад, компанийнх нь тэмдэгийг аваад Улаанбаатар хотын банкин дээр очиж Боловсролын үнэлгээний төвөөс шилжүүлсэн мөнгийг гаргаж аваад Боловсролын үнэлгээний төвийн гадаа Ж.А-т аваачиж өгсөн. Тэр үед Ж.А бэлдсэн 2 хувь гэрээ гаргаж ирээд "УМ" ХХК-ийг төлөөлж менежер У.Б гэсэн хэсэгт надаар "Б" гэж бичүүлж аваад "УМ" ХХК-ийн захирал "Г.Бу" гэсэн хэсэг дээр манай хүргэн Г.Бу-ын компанийн тэмдгийг даруулсан. Намайг тэмдэг дарж өгөхөд Г.Бу гэсэн хэсэгт ямар нэгэн гарын үсэг зурагдсан зүйл байхгүй байсан. Энэ гэрээн дээрх Г.Бу гэсэн хэсэгт зурагдсан гарын үсэг хэний гарын үсэг болох талаар би хэлж мэдэхгүй байна. Энэ гэрээний талаар манай хүргэн Г.Бу огт мэдэхгүй болно. Тухайн үед нь би ямар учиртай гэрээ юм бэ? Би гарын үсэг зурж болох юм уу? гэж асуухад янз бүрийн шалтгаан тоочоод санхүүгийн баримтад хэрэгтэй байдаг гэхээр нь би нилээн дургүйцэж байгаад Б гэж зурж өгөөд, хүргэн Г.Бу-ын компанийн тэмдгийг дарж өгсөн гэжээ.

Ц.Эр-ээс:-Эхнэр Ж.Эн 2011 оны 5 дугаар сарын 30-ны өдөр надад манай хүргэн Г.Бу-ын компанийн мөнгө хүлээн авах чекийг надад өгөөд, энэ мөнгийг очоод аваад ир гэж хэлсэн. Тэгээд би уг чекээр нь Улаанбаатар хотын банкнаас 21,0 сая төгрөгийг аваад эхнэр Ж.Эн-т авчирч өгсөн гэжээ.

Боловсролын үндэсний төвийн нярав, гэрч Б.Ня-ээс:

- "УМ" ХХК-ийн дансанд 21,0 сая төгрөг шилжүүлсэн асуудлыг мэдэхгүй. Сүүлд нь Эрүүгийн цагдаагийн газраас шалгалт орсны дараа мэдсэн. Ядахдаа лацыг нь нийлүүлэхгүй яасан юм бэ гэхэд, энэ мөнгийг компанийн дансаар гаргаж аваад захирал Б.Эн-д 16 сая төгрөгийг өгсөн, би 5 сая төгрөгийг авсан гэж байсан. "Г-А" ХХК-аас 5 сая төгрөгийн серверийг худалдаж авсан зүйл байхгүй болно. 2011 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийж дуусаад, тооллогын дүнг цэгцэлж байхад үндсэн хөрөнгийн бүртгэл дээр UPS сервер гэж байгаагүй бөгөөд хөрөнгөд тусгасан талаар баримт байгаагүй. Хурлын тэмдэглэл дээр намайг хэлснээр бичигдсэн зүйлийг би хэлээгүй, ийм хурал болоогүй болно. Хурлын тэмдэглэлийг манай бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Б.Бз хөтөлдөг. Манай байгууллагын 2011 оны 12 дугаар сард үндсэн хөрөнгийн тооллогыг Б.Сүх, Ж.А, Б.Ня, Б.Ба, Б.Бз, Ч.От нарын бүрэлдэхүүнтэй тоолоход 21.000.000 төгрөгийн 7000 ширхэг лац байхгүй байсан. Энэ тооллогын комисст нягтлан бодогч Ж.А өөрөө орж ажиллаж байсан. Тэр үед лац байхгүй гээд 2011 оны үндсэн хөрөнгийн бүртгэлд огт бүртгэгдээгүй, тухайн үед 2007 онд худалдаж авсан лацнаас 1100 ширхэг үлдэгдэлтэй байсан. Манай байгууллагын 2011 оны 04 дүгээр улирлын санхүүгийн тайланд 5.000.000 төгрөгийн үнэтэй UPS төхөөрөмж байхгүй байгаа бөгөөд үндсэн хөрөнгийн дүн дээр орлогоор нэмэгдсэн байгаа. 2012 оны 06 дугаар сард Төрийн өмчийн хорооны өмч хөрөнгийн улсын үзлэгээр 5.000.000 төгрөгийн үнэтэй UPS төхөөрөмж нь маргаантай хөрөнгийн жилийн мэдээнд бүртгэгдсэн байгаа. Маргаантай хөрөнгийн жилийн мэдээ нь тухайн үеийн тооллогоор байхгүй байгаа хөрөнгийг бүртгэдэг. "УМ" ХХК лацны үнэ гэж 21.000.000 төгрөг, "Г-А" ХХК тог баригч UPS төхөөрөмжийн үнэ 5.000.000 төгрөг нийт 26.000.000 төгрөгийг, 2011 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд нягтлан бодогч Ж.А өөрийнх нь гаргасан "Төсөвт байгууллагын 2011 оны 04 дүгээр улирлын санхүүгийн тайланд" байгууллагад орлогод авснаар тайланг гаргасан байгаа юм. Гэхдээ дээрх үнийн дүн бүхий тоног төхөөрөмж, лац нь бодит байдал дээр байгууллагад орлого гэж орж ирсэн зүйл байхгүй байгаа юм гэжээ.

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, гэрч З.Мт-аас:-Ийм хурал болоогүй. Би энэ хурлын тэмдэглэлийг анх

удаа харж байна. Ажил тарах гэж байхад нягтлан бодогч Ж.А орж ирээд, дарга энэ дээр гарын үсэг зураадах гэж байна гэхээр нь би гарын үсэг зурсан гэжээ.

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн гэрч М.Гт-аас:-Нягтлан бодогч Ж.А-т байрны хөнгөлөлт үзүүлэх талаар огт яригдаж байгаагүй. Манай дотоод журамд байрны хөнгөлөлт олгох талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй бөгөөд байгууллагын албан хаагч нарт ямар нэгэн байдлаар байрны хөнгөлөлт олгож байсан асуудал байхгүй болно гэжээ.

Боловсролын үнэлгээний төвд мэргэжилтэн, гэрч Б.Бз-гаас:- Хурал болоогүй би ийм хуралд суугаагүй учраас нягтлан бодогч Ж.А-т байрны хөнгөлөлт олгохоор хэлэлцсэн асуудлын талаар мэдэхгүй байна. Ажил үүргийн хувьд мэргэжилтэн Д.Мт хурлын тэмдэглэл хөтлөх ёсгүй гэжээ.

Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, гэрч Л.Гб-аас:

-Энэ хурлын тэмдэглэлийг уншиж танилцахад зарим зүйл нь манай байгууллагын хурал дээр яригдаж байсан зүйл байна. Гэхдээ нягтлан бодогч Ж.А-т байрны хөнгөлөлт олгох талаар яригдсан зүйл байхгүй, хурлын тэмдэглэлийн зарим зүйлийг засаад засвар оруулсан байх гэж бодож байна гэжээ.

Н.Лх-аас:-Би "АДЭ" ХХК-ийг 2008 оны эхээр байгуулсан, би 2009 оны 01 дүгээр сард Боловсролын үнэлгээний төвд мэргэжилтнээр ажилд орсон. Тэр үед Боловсролын үнэлгээний төвийн захирал Б.Эн надаас хувьдаа компанитай юу гэж асууж байсан. 2010 оны 11 дүгээр сард захирал Б.Эн дуудаад оны эцэс болоод мөнгө татагдах гээд байна, танай компанийн дансаар мөнгө гаргаж авах шаардлагатай байна чи Ж.А-тэй уулзаадах гэсэн. Тэгээд би нягтлан бодогч Ж.А-тэй уулзаад компанийнхаа дансны дугаарыг өгч байсан. Нягтлан бодогч Ж.А манай компанийн "Хаан" банкин дахь дансанд 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 12.000.000 төгрөг шилжүүлсэн байсан. Би тэр мөнгийг маргааш нь буюу 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр данснаасаа гаргаж аваад нягтлан бодогч Ж.А-т өгч байсан, ямар нэгэн байдлаар хамтран ажиллаж бараа, материал нийлүүлж байсан тохиолдол байхгүй болно. Захирал Б.Эн-ын гуйлтаар өөрийн компанийн дансыг ашиглуулж 2010 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 12.000.000 төгрөг, 2011 оны 02 дугаар

сарын 25-ны өдөр 80.000.000 төгрөг, 2011 оны 3 дугаар сарын 09-ний өдөр 5.000.000 төгрөг, нийт 25.000.000 төгрөг гаргаж өгсөн. "Г-А" ХХК-аас 5 сая төгрөгийн үнэтэй тог баригч авлаа гэж надад хүлээлгэн өгсөн зүйл байхгүй. Серверийн өрөөний тоног төхөөрөмжүүд манай нярав Л.Ня дээр бүртгэлтэй байдаг, би серверийн өрөөний эд зүйлийг хариуцдаг юм. Миний хариуцаж байгаа эд хөрөнгийн бүртгэлд 2011 онд худалдаж авсан 5,0 сая төгрөгийн үнэтэй тог баригч байхгүй гэжээ.

10. Ж.Га: -"АДЭ" ХХК нь 2009 оны эхээр байгуулагдсан, хөрөнгө оруулагчид нь Н.Лх. Н.Зор бид гурав юм. Захирал Б.Эн Н.Лх-ыг гуйгаад "АДЭ" ХХК-ийн дансаар 12.000.000 төгрөг гаргуулж авсан талаар мэдэж байна. Сүүлийн мөнгөний асуудлыг Н.Лх мэдэж байгаа. Манай компанийн хувьд ямар нэгэн байдлаар Боловсролын үнэлгээний төвд программ хийж өгөөд мөнгө төгрөг авсан зүйл байхгүй. Тухайн үед захирал Б.Эн, нягтлан бодогч Ж.А нарын гуйлтаар компанийн даснаар гаргаж өгсөн гэжээ.

11.Ч.Га-оос: -Би "Г-А" ХХК-ийг 2008 онд байгуулсан, манай компани ганц гишүүнтэй компани. Манай компани ямар нэгэн байдлаар байгуулагдсанаас хойш үйл ажиллагаа явуулсан зүйл байхгүй болно. Боловсролын үнэлгээний төвийн нягтлан бодогчоор манай эхнэр Ж.А надад сервер авна гэж хэлээд 5.000.000 төгрөг шилжүүлсэн гэж ярьж байсан. Ямар учраас манай компанийн дансанд шилжүүлснийг мэдэхгүй байна. Тухайн үед би мөнгийг нь компанийн данснаас аваад Ж.А-т өгсөн. Ж.А надад манай байгууллагаас намайг удаан жил ажилласан, шинэ байр авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хуралдаад, албан ёсоор шийдвэр гараад 15.000.000 төгрөг олгосон гэж надад хэлсэн. Энэ мөнгийг нь Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо .... тоот байрыг авахад зарцуулсан гэжээ.

М.Зо-оос: -Б.Эн 2011 оны 5 дугаар сарын 19-ний өдөр нэг сая төгрөг тушааж карт нээлгэсэн байна. Хөнгөлөлттэй карт нээлгэсэн эзэмшигч зөвхөн өөрөө үйлчлүүлнэ. Хамт өөр хүн үйлчлүүлнэ гэсэн ойлголт байхгүй гэжээ.

Төрийн сангийн газарт мэргэжилтэн, гэрч Л.Ня-гээс:-Би 2011 оны 09 дүгээр сараас 11 сар хүртэл Боловсролын яамыг хариуцаж байсан. Төсвийн байгууллагаас манай газраар дамжуулан гүйлгээ хийх тохиолдолд нэхэмжлэх, гэрээ, тендер зарласан

бол тендерийн материал, томилолтоор явах гэж байгаа бол тушаал, төсөв, гэх мэт гүйлгээ хийхэд шаардлагатай бүх материалыг хянадаг. Төсөвт байгууллагууд жил бүр төсвөө батлуулсны дараа сар сараар санхүүжилтийг гаргаж өгдөг. Тухайн байгууллага ямар гүйлгээ хийх гэж байгаа талаарх материалыг бүрдүүлээд ирсэн тохиолдолд Төрийн сангийн газраас холбогдох материалыг хянаж, тухайн гүйлгээг нь хийдэг. Төсөвт байгууллага ажил, үйлчилгээ авахаар гэрээ байгуулж ирээд Төрийн сангаар гүйлгээ хийгдэж байгаа тохиолдолд тухайн төсөвт байгууллага нь байгуулсан гэрээ болон гүйлгээ хийхээр бүрдүүлж өгч байгаа баримтыг үндэслэн гүйлгээг хийнэ. Төрийн сангийн газраас тухайн байгууллагын байгуулсан гэрээ нь хуурамч эсэхийг мэдэх боломж байхгүй. Тухайн хувийн компанийн дансыг шалгах эрх байхгүй болно. Хуурамчаар хийсэн тохиолдолд Боловсролын үнэлгээний төв өөрсдөө хариуцлага хүлээх ёстой юм. Төсөвт байгууллагын албан тушаалтанд хувийн компанийн дансаар бэлэн мөнгө гаргуулж зарцуулах эрх байхгүй болно. Зөвхөн хувийн компанитай байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх ёстой гэжээ.

ШШҮХ-ийн 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 167 тоот шинжээчийн дүгнэлтэд:

2009-2011 оны хооронд нийт 156.389.100 төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтгүйгээр данс бүртгэлд тусгасан байна. Завшиж үрэгдүүлсэн эсэхийг эдийн засгийн шинжилгээгээр тогтоох боломжгүй болно. Боловсролын үнэлгээний төвийн захирал Б.Эн, нягтлан бодогч Ж.А нар нь нийт 273.241.670 төгрөгийг хувийн компаниудын дансанд шилжүүлсэн байгаа бөгөөд үүнээс анхан шатны баримтгүйгээр 156.389.100 төгрөгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 8 дугаар зүйлийн 8.3, 9 дүгээр зүйлийн 9.1, 18 дүгээр зүйлийн 18.1 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.5, 19.1.6, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна гэжээ.

Шинжээч Д.Мө-ийг байцаасан тэмдэглэлд: -Мөрдөн байцаагчаас ирүүлсэн Боловсролын үнэлгээний төвийн үдээтэй санхүүгийн баримтад үндэслэж дүгнэлтээ гаргасан. Дүгнэлт гаргах явцад нэмэлтээр ямар нэгэн хуулбарласан сул баримт ирүүлээгүй болно гэжээ.

Шүүх дээрх баримтуудыг дүгнэж үзвэл прокурорын яллах дүгнэлтэд тэмдэглэсэнээр Б.Эн нь Боловсролын үнэлгээний төвийн даргаар ажиллаж байхдаа тус газрын нягтлан бодогч Ж.А-тэй урьдчилан үгсэн тохиролцож бүлэглэн, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчиж байгууллагынхаа данснаас

“АДЭ” ХХК-ийн дансанд 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 8,0 сая төгрөг, 2011 оны 3 дугаар сарын 09-ний өдөр 5,0 сая төгрөг, 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр 12,0 сая төгрөг, “УМ” ХХК-ийн дансанд 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 21,0 сая төгрөг тус тус шилжүүлэн авч завшсан, мөн 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг хуурамчаар үйлдэж 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгох тухай 29 тоот тушаал гаргаж, 15,0 сая төгрөгийг Ж.А-ийн Голомт банкны дансанд шилжүүлэн авч завшсан болох нь нотлогдон тогтоогдохгүй буюу дараах баримтуудаар үгүйсгэгдэж байна. Тухайлбал:

Гэрч Н.Лх нь “Энэ мөнгөтэй холбоотойгоор Боловсролын үнэлгээний төвтэй ямар нэгэн байдлаар хамтран ажиллах гэрээ байгуулж, ямар нэгэн ажил гүйцэтгэж бараа нийлүүлсэн зүйл байхгүй” гэж мэдүүлсэн боловч Даалгаврын сангийн программын гэрээг 2010 оны 10 дугаар сарын 23-нд үйлдэж, тус компанийн дансанд 2010 оны 10 дугаар сараас 2011 оны 3 дугаар сарын 09 хүртэл хугацаанд 3 удаагийн гүйлгээгээр нийт 25,0 төгрөг орсон байх ба 2011 оны 3 дугаар сарын 03-нд нэг талаас Боловсролын үнэлгээний төв, нөгөө талаас “АДЭ” ХХК-ийн төлөөлөгчид гэрээг хүлээлцэж, үндсэн даалгавар дууссанд тооцогдож, гэрээ дуусгавар болсон тухай баримтад гүйцэтгэгчийг төлөөлж, ажлыг хүлээлгэн өгсөн “АДЭ” ХХК-ийн захирал Н.Лх гарын үсэг зурсан (1-р хавтасны хх-ийн 180-182) байх бөгөөд уг баримтыг хуурамчаар үйлдсэн талаар ямар нэг дүгнэлт гарч, үгүйсгээгүй, талууд маргаагүй байна. Түүнчлэн Н.Лх нь “Манай компанийн дансанд мөнгө орсон байсныг аваад захирал Б.Эн-д бэлнээр аваачиж өгсөн” гэж мэдүүлсэн боловч энэ талаарх нотлох баримтгүй, Өөрөөр хэлбэл, гэрч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2-т зааснаар шүүгдэгч Б.Эн-д мөнгө өгсөн тухай нотлох баримтын эх сурвалжийг зааж

чадахгүй байна.

Шүүгдэгч Ж.А нь Боловсролын үнэлгээний төвийн данснаас 2011 оны 5 дугаар сарын 27-ны өдөр “УМ” ХХК-ийн дансанд сэдвийн хайрцаг лацдах лац худалдаж авахаар 21,0 сая төгрөг шилжүүлсэн байх ба 2012 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 5.000 ширхэг лацыг тухайн үеийн ханшаар 100.750 юаниар авсан болох нь төлбөрийн баримт (7-р хавтас хх-ийн 127)-аар нотлогдож байна. Стандартчилал, хэмжил зүйн газрын №УБИ000049. тоот тохирлын гэрчилгээгээр БНХАУ импортлосон 1 удаагийн хуванцар лац нь холбогдох стандарт, норматив техникийн баримт бичгийн шаардлагыг хангасан гэж үзсэн тул Боловсролын үнэлгээний төв уг лацыг нийт 15,0 сая төгрөгт үнэлж авсан байна. 2012 онд ашиглагдах лацны үнийг 2011 онд шилжүүлж, жилийн эцсийн тайланд орлогод авсан мэтээр тайлан гаргасан нь буруу боловч 2012 оны 02 дугаар сард уг лац нийлүүлэгдсэнийг мөнгө завшсан гэж үзэх боломжгүй юм. Нөгөө талаар дээрх 100.750 юань буюу 21,0 сая төгрөгөөр худалдаж авсан лацыг Боловсролын үнэлгээний төв нь 15,0 сая төгрөгөөр үнэлж орлогод авсан зөрүү 6,0 сая төгрөгийг шүүгдэгч Ж.А-ээс нөхөн гаргуулах үндэслэлгүй юм.

3. Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны дэргэдэх Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2011 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 29 тоот тушаалаар тус төвийн ерөнхий нягтлан бодогч Ж.А-т нэг удаагийн тэтгэмж болгон 15.000.000 төгрөгийг “Нэг удаагийн тэтгэмж урамшуулал” эдийн засгийн ангиллаас санхүүжүүлэхээр заасныг шүүгдэгч Б.Эн, Ж.А нар бүлэглэн дээрх хөрөнгийг завшсан гэх үндэслэлгүй юм. Уг тушаалыг гаргахдаа хуурамчаар үйлдсэн гэх 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэл болгоогүй байх бөгөөд Боловсролын үнэлгээний төвийн захирлыг нэг удаагийн тэтгэмж олгож, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсхүл төсөв хэтрүүлсэн талаар Боловсрол, соёл шинжлэх ухааны яам болон Төрийн өмчийн хороо дүгнээгүй, ямар нэг эрхийн акт гараагүй, №29 тоот тушаалыг хүчингүй болгоогүй байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр шүүгдэгч нарыг бүлэглэн байгууллагын 61,0 сая төгрөгийг завшсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Харин шүүгдэгч Б.Эн нь Боловсролын

үнэлгээний төвийн даргаар буюу төсөв захирагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, 2011 оны 5 дугаар сарын 24-ний өдөр төсвийн хөрөнгөөс 1,0 сая төгрөг гаргуулан, фитнес клубийн үйлчилгээний карт худалдан авч, хувьдаа ашигласан болох нь Боловсролын үнэлгээний төвөөс 1.000.000 төгрөг шилжүүлсэн мөнгөний баримт, хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн FG фитнесийн клубийн хөнгөлөлтийн карт, уг мөнгийг шүүгдэгчээс хохирогч байгууллагад буцааж тушаасан баримтуудаар нотлогдон тогтоогдлоо.

Шүүгдэгч Ж.А нь Боловсролын үнэлгээний төвийн нягтлан бодогчоор ажиллаж байхдаа тог баригч худалдан авах нэрээр 2011 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгууллагын данснаас 5,0 сая төгрөгийг "УМ" ХХК-д шилжүүлсэн атлаа уг эд хөрөнгийг биетээр худалдаж авалгүйгээр завшсан болох нь гэрчүүдийн мэдүүлэг, хэрэгт авагдсан мөнгө шилжүүлсэн баримт, тус газрын 2011 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, бусад бичгийн баримтуудаар нотлогдон тогтоогдлоо. Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Ж.А нь тухайн үед худалдаж авсан тог баригч одоо бэлнээр байгаа гэж тайлбарлаж байгаа боловч уг эд зүйлийг хэзээ, хэрхэн яаж авсан, одоо хаана байгааг нотолсон ямар нэг бичгийн баримт хэрэгт авагдаагүй байна.

Иймд шүүгдэгч Б.Эн-ыг төрийн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, байгууллагын өмч хөрөнгийг завшсаны улмаас бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч Ж.А-ийг байгууллагын эд хөрөнгийг завшсаны улмаас бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцох үндэслэлтэй байна.

Прокуророос шүүгдэгч нарыг урьдчилан үгсэн тохиролцож бүлэглэн, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан гэмт хэрэг үйлдсэн хэмээн яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч шүүгдэгч нар гэмт хэргийг үйлдэхдээ хэрхэн яаж бүлэглэсэн эсэх, гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн сэдэлт, санаа зорилго нь тогтоогдохгүй байна. Нөгөө талаар хохирогч байгууллагын төсвийн зарцуулалтын баримтад 2 дугаар гарын үсэг зурж байсан шүүгдэгч Ж.А нь бие даан захирамжлан зохион байгуулах үүрэг бүхий албан тушаалтан биш тул түүнийг гэмт

хэрэг үйлдэхдээ албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэх үндэслэлгүй юм.

Түүнчлэн прокуророос шүүгдэгч нарын аль алинд нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.3, 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангид заасан ял сонсгож, яллагдагчаар татсан нь ойлгомжгүй байна.

Шүүх өмнө нь хэргийг 2 удаа мөрдөн байцаалтад буцааж, хэрэгт ач холбогдолтой гэх зарим зүйлүүдийг шалгуулах нь зүйтэй гэж үзэж байсан ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасныг баримтлан хэргийг шүүгдэгч нарт ашигтайгаар, шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явуулж, Дүүргийн 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.3, 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн, Б.Эн, Ж.А нарт холбогдох хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлж, шүүгдэгч Б.Эн-ыг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.1, 263 дугаар зүйлийн 263.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч Ж.А-ийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж, хэргийг шийдвэрлэлээ.

Шүүгдэгч нар нь Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д тус тус зааснаар тэдгээрийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хэргийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэлтэй байна.

Шүүгдэгч Б.Эн нь бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн тул түүнийг төлөх төлбөргүй гэж дүгнэв. Харин шүүгдэгч Ж.А-ээс 5,0 сая төгрөг гаргуулж, хохирогч байгууллага болох Боловсролын үнэлгээний төвд олгуулахаар шийдвэрлэлээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 286, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2-т заасныг баримтлан Дүүргийн 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн

19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.3, 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Б.Эн-д холбогдох хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.1, 263 дугаар зүйлийн 263.1, шүүгдэгч Ж.А-г холбогдох хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.1 болгон тус тус хөнгөрүүлэн өөрчилсүгэй.

2. Шүүгдэгч Ц овогт Б.Эн-ыг төрийн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, байгууллагын өмч хөрөнгийг завшсаны улмаас бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд,

Шүүгдэгч Б овогт Ж.А-ийг байгууллагын эд хөрөнгийг завшсаны улмаас бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1-д тус тус зааснаар шүүгдэгч Б.Эн, Ж.А нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, тэдгээрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

4. Шүүгдэгч нар цагдан хоригдоогүй болохыг дурдсугай.

5. Шүүгдэгч Б.Эн-ын өмчлөлийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоот

орон сууц, шүүгдэгч Ж.А-ийн өмчлөлийн Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, ...тоот орон сууцыг тус тус захиран зарцуулах эрхийг хязгаарласан тухай 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн мөрдөн байцаагчийн тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

6. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн FG фитнес клубийн хөнгөлөлтийн картыг энэ хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт хавсаргаж үлдээсүгэй.

7. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар шүүгдэгч Ж.А-ээс 5.000.000 (таван сая) төгрөг гаргуулж, Боловсролын үнэлгээний төвд олгож, шүүгдэгч Б.Эн-аас бусдад төлөх төлбөргүйг дурдсугай.

8. Шүүхийн тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд гомдол, эсэргүүцэл гаргасан тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, шүүгдэгч Б.Эн, Ж.А нарт урьд авсан бусдын батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

9. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ  
ШҮҮГЧИД

Г.БУЯННЭМЭХ  
И.ГАНБАТ  
Б.ХАЛИУН



## ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 9 дүгээр шүүхийн эрүүгийн шүүх хуралдааныг ерөнхий шүүгч Э.Болормаа даргалж,

Нарийн бичгийн дарга Ц.Цэрэндулам

Улсын яллагч Т.Цэнд-Аюуш

Шүүгдэгч нарын өмгөөлөгч О.Үүрцайх, Ч.Энхбаяр

Гэрч П.О

Иргэний нэхэмжлэгч Х.З

Шүүгдэгч Д.З, Ц.Н, нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь Сум дундын Прокурорын газраас:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 214<sup>1</sup> дүгээр зүйлийн 214<sup>1.1</sup>, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1, 215 дугаар зүйлийн 215.2, 216 дугаар зүйлийн 216.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Д.З,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Ц.Н нарт холбогдох эрүүгийн 2100643 тоот хэргийг 2014 оны 10 сарын 03-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

1. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...оны ...сарын ...-ны өдөр Говь-Алтай аймгийн ...суманд төрсөн, ...настай эрэгтэй, яс үндэс халх, бүрэн бус дунд боловсролтой, жолооч мэргэжилтэй, хэрэгт татагдах үедээ эрхэлсэн тодорхой ажилгүй байсан, ам бүл ..., эхнэр, ...хүүхдийн хамт Замын-Үүд сумын ...хэсэгт оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, 1977 онд Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн б-д зааснаар 1 жилийн хорих ял авч тэнссэн, 1979 онд Эрүүгийн хуулийн 200 дугаар зүйлийн а, 169 дүгээр зүйлийн в-д зааснаар 3 жил хорих, 1982 онд Эрүүгийн хуулийн 239 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 3 жил хорих, 1984 онд Эрүүгийн хуулийн 88 дугаар зүйлийн б, 109 дүгээр зүйлийн б-д зааснаар 7 жил хорих, 1996 онд Эрүүгийн хуулийн 260 дугаар зүйлийн 2-д зааснаар 6 жил хорих

ялаар тус тус шийтгүүлж байсан, ухаан мэдрэл бүрэн, хэрэг хариуцах чадвартай, О овогт Д.З /РД: ШЕ...../

2. Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...оны ...сарын ...-нд Завхан аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, яс үндэс халх, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, хэрэгт татагдах үедээ Замын-Үүд суман дахь Гаалийн газарт гаалийн улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл..., эхнэр, ...хүүхдийн хамт Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн ...хороо, ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэл эдэлж байгаагүй, ухаан мэдрэл бүрэн, хэрэг хариуцах чадвартай, Ж... овогт Ц.Н /РД: ИЛ...../

Шүүгдэгч Д.З нь Ж.Б-тай бүлэглэн 2010 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хх-хх ДГА, хх-хх ДГА улсын дугаартай УАЗ-469 маркын автомашинуудад онцгой хортой химийн бодис болох хар тугалганы исэл 200 шуудай буюу 5 тонныг тусгай зөвшөөрөлгүйгээр Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр импортолсон,

Ж.Б-тай бүлэглэн 2010 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хх-хх ДГА, хх-хх ДГА улсын дугаартай УАЗ-469 маркын автомашинуудад химийн хортой бодис болох хар тугалганы исэл 200 шуудай буюу 5 тонныг тусгай зөвшөөрөлгүйгээр Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр импортлохдоо хяналт шалгалтанд хамруулахгүйн тулд М.Ц-аар дамжуулж гаалийн улсын байцаагч Ц.Н-ид 250 юань буюу 51.330 төгрөгийн хээль хахууль өгсөн,

Шүүгдэгч Д.З нь 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Биржийн гражийн баруун талын төв засмал зам дээр архи дан согтуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний дүрэм зөрчиж хохирогч Д.Э-ы жолоодож явсан мотоцикольтой мөргөлдөж хохирогч Д.У, Д.Э нарын биед хүнд гэмтэл учруулсан, улмаар зам тээврийн осол гаргасан газрыг санаатай орхиж зугтаасан,

Шүүгдэгч Ц.Н нь 2010 оны 06 дугаар

сарын 05-ны өдөр Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомт дээр гаалийн улсын байцаагчаар ажиллаж байхдаа албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар буюу хяналт шалгалтыг хийхгүй байхаар урьдчилан амлахгүйгээр Д.З, Ж.Б нарын УАЗ-469 маркын автомашинуудад ачигдсан химийн хортой бодис болох хар тугалганы исэл 5 тонн, дээжний уут 40.000 ширхгийг Монгол Улсын хилээр импортоор оруулахад нь хяналт шалгалт хийлгүй нэвтрүүлж, Д.З, Ж.Б нараас М.Ц-аар дамжуулан 91.064 төгрөгийн хээл хахууль авсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

#### ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

-Шүүгдэгч Д.З мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ: 2010 оны 06 сарын 05-ны өдөр би өөрийн хх-хх ДГА дугаартай УАЗ-469 маркын машинтайгаа 13 цагийн орчимд Эрээн гарсан. Хуучин зээлийн урд талбай дээр очиход манай найз Ж.Б хх-хх ДГА дугаартай УАЗ-469 маркын машинтайгаа зогсож байсан. Бид хоёрт хүн, ачаа олдохгүй зогсож байтал 15 цаг өнгөрч байх үед Ж.Б дээр нэг Өвөрмонгол хүн ирж уулзаж байсан. Тэгтэл Ж.Б 200 шуудай оохор байна гэнэ нэг шуудайг нь 15 юаниар бодож ачна гэнэ, хоёулаа ачих уу гэхлээр нь зөвшөөрсөн. Тэгээд бид хоёр нөгөө хүнээ даган барилгын зээл дээр нэг дэлгүүрийн гадаа очиход бид хоёрын машинд жижигхэн шаргал өнгийн мяндсан шуудайнуудтай оохор гэх зүйлийг 100, 100 ширхгээр хувааж ачсан. Би ачаагаа ачуулчхаад түрүүлээд дугуй засварын газар очоод сул хийтэй дугуйндаа хий нэмүүлээд зогсож байхад араас Ж.Б ирээд ачааны хөлс 1500 юань өгсөн. Тэгээд бид хоёр Замын-Үүдрүү явсан. ...Хятадын хилээс гараад миний машины дугуй хагараад зогсож байхад л Ж.Б эхнэр М.Ц-руугаа утсаар ярьж байсан. Тэгээд биднийг Монголын хилээр орж ирэхэд ХМХА-ны байцаагч импортын мэдэгдэл бичээд М.Ц-д өгчихсөн байсан бөгөөд тэр бичгийг М.Ц надад өгсөн. Харин тэр Ур гэдэг байцаагч нь бидний машиныг үзээгүй. Тэгээд гаалийн хяналтын талбай дээр ирэхэд М.Ц 2 машинд байцаагч хуваарилуулчихсан байсан. Гаалийн байцаагч Ц.Н ирж үзээд явсан. Тэгэхэд М.Ц "гаалийн байцаагчид өгөх мөнгө" гээд Ж.Б бид хоёроос тус бүр 300 юань аваад явсан.

Тэгээд дотогшоо ороод гарч ирэхдээ гаалийн татвар төлөхгүй явах шар бичгүүдийг авч ирсэн. Хилийн мэргэжлийн хяналтын албаны байцаагч болон гаалийн байцаагчид М.Ц хэдэн төгрөг өгсөн гэдгийг би мэдэхгүй. Ямар ч байсан Ж.Б бид хоёроос нийт 600 юань аваад явсан. Би шуудайтай зүйлс дээрээ 2 пресс хувцас ачсан байсан юм. Ж.Б ч гэсэн бас жаахан юм ачсан байсан. Тийм ачаатай болохоор гаалийн байцаагч их татвар нэхнэ гэж бодоод шууд байцаагчид мөнгө өгөхөөр болсон нь тэр юм. Тиймэрхүү ачаатай байхад гаалийн байцаагч нар дор хаяж 80.000 төгрөг нэхээд байдаг юм. ...Монгол Улсын хилээр орж ирэхдээ ХМХА-ны байцаагч Ур, гаалийн байцаагч Ц.Н нарт 600 юанийн авлига өгсөн нь үнэн. Түүнийг М.Ц зохицуулж зуучилсан юм гэжээ. /хх-ийн 103-104/

-2010 оны 04 сарын 15-ны өдрийн 19 цагийн орчим өөрийн найз Ж.Б-тай хамт хоёулаа хоёр шил 500 граммын Хараа архи уусан юм. Архи ууж байхад хажууд урдаас машинд сууж орж ирсэн Са гэдэг эмэгтэй байсан. Архиа ууж дууссаны дараа би Ж.Б-ын хх-хх ДГА дугаартай УАЗ-469 маркын авто машиныг нь бариад Са, Ж.Б бид 3 хамт явж урдаас хэдэн хайрцаг ачаа оруулж ирснийг эзэнд нь аваачиж өгөх гээд гэр байранд байдаг бензин клонкийн хавиар хайгаад олоогүй. Буцаад Ж.Б-ыг гэрт нь хүргэж өгөх гээд гэр байрнаас гарч ирсэн шороон замаар явж байгаад биржийн гражын харалдаа засмал зам руу орсон чинь өөдөөс мотоцикольтай гурвуулаа сундалдчихсан хүмүүс ороод ирсэн. Би харангуутаа тоормос гишгэсэн чинь өөрөө хүрч ирээд машины урд талын гупер мөргөөд унасан. Машинаас Са, Бо бид гурвуулаа буугаад босгох гэсэн чинь нэг эрэгтэй, нэг эмэгтэй хоёр нь хөл эвгүй болчихлоо гээд босож чадахгүй байсан. Нэг эмэгтэй нь зүгээр босоод зогсчихсон байсан юм. Тэгж байтал нэг машин ирэхээр нь зогсоосон чинь найз Д.Э явж байхаар нь тэр хоёрыг эмнэлэг рүү явуулсан юм. Би эмэгтэйг нь таньдаг хүн байсан нэрийг нь Д.У гэдэг юм. Д.У намайг хараад танингуутаа намайг чи явж бай чамайг баллаад хаячихлаа гэхээр нь би машинаа асаагаад яваад өгсөн юм гэжээ. /хх-ийн 107-108/

-Шүүгдэгч Д.З шүүх хуралдааны шатанд өгсөн мэдүүлэгт: Ц.Н-ид би хээл хахууль өгөөгүй. Ж.Б ачаа олоод л бид оохор гэж бодоод ачсан. Химийн хортой бодис гэж мэдээгүй. М.Ц татварын мөнгө гэхээр нь 300 юань өгсөн. М.Ц-д 50 юань өгөх ёстой байсан

300 юаниас аваарай гэж хэлсэн. Хийсэн хэрэгтээ гэмшиж байна. Хохирол төлсөн, ар гэрийн байдлыг харгалзан үзээд хөнгөн ял оногдуулж өгнө үү гэв.

-Шүүгдэгч Ц.Н-ийн мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэгт: 2010 оны 06 сарын 05-ны өдөр хилийн цогцолборт жижиг тэргэн дээр хуваарилагдан ажиллаж байсан. Ингээд ахлах байцаагчийн хувиарлалтын дагуу машиныг шалгаж байсан. Машиныг тав таваар хуваарилж байсан. Сүүлийн гурав дахь машиныг үзчихээд байж байхад сүүлийн хоёр машин хүлээж байсан. Тэр хоёр машиныг шалгаж үзэхэд шаргал өнгийн шороо байсан. Машиныг шалгахдаа Засгийн газрын тогтоолын дагуу эхлээд хилийн мэргэжлийн хяналтын алба шалгах ёстой. Ингээд хилийн мэргэжлийн хяналтын албаны бичгийг шаардахад хоёр машинд 400 кг оохор байгаа гэх зөвшөөрлийн бичгийг надад үзүүлсэн. М.Ц надад оохор байгаа юм аа гэж хэлсэн. Хилийн мэргэжлийн хяналтын албаны бичгийг үндэслэж хяналт хийх учиртай. Ингээд шалгаж үзэхэд шаргал нунтаг зүйл байсан. Шалгах үед юу юм бэ гэхэд оохор байгаа юм аа, манай хилийн мэргэжлийн хяналтын алба үзээд өгсөн бичиг нь энэ байна гэж бичгийг үзүүлсэн. Чи айх юм байхгүй. Мэргэжлийн хяналт үзсэн гэж хэлсэн. Би тэгэхээр нь газар дээр нь татвар бодож үзэхэд нэг машины 15000 төгрөг болж байсан. Ингээд 400 кг оохорын татварыг төл гэхэд М.Ц нь би хашаа байшингаа оохордох гэсэн юм аа. Гаргаад явуулчихаач гэсэн. Тэгэхээр нь би хилийн мэргэжлийн хяналтын албаны бичгийг үндэслээд шар хуудсыг бичиж өгсөн. Ингээд би заал руу орж ирээд хуваарилагдсан машинуудыг бүртгэлээс үзэхэд над дээр хуваарилсан хоёр машин бүртгэлд байхгүй байсан. Тэгэхээр нь би үзсэн хоёр машинаа бүртгэлийн дугаар дээр дарж бичсэн юм. Би өөрөө шалгасан машинаа бүртгэлд оруулахын тулд бүртгэлийг дарж засварласан юм. Мөнгө төгрөг би аваагүй гэжээ. /хх-ийн 333-336/

-Шүүгдэгч Ц.Н шүүх хуралдаан гаргасан тайлбартаа: Би татварын мөнгийг тэр дор нь тушаагаагүй нь миний буруу. Гэхдээ би М.Ц-гаас хээл хахууль гэж мөнгө төгрөг аваагүй. Татварт 40.000-50.000 төгрөг тушаа л гэж хэлсэн юм. Гэхдээ М.Ц тухайн үед яг хэдэн төгрөг өгснийг мэдэхгүй үзээгүй гэв.

-Яллагдагч Ж.Б-ын мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэгт: ...2010.04.15-ны өдөр миний эзэмшлийн хх-хх ДГА улсын дугаартай

тээврийн хэрэгслийг Д.З-оор бариулж Эрээн гарсан. Миний бие өвдөөд байсан болохоор өөрөө бариагүй юм. ...Эрээнээс орой 3-4 цагийн үед байх гарсан. Тэр үед машиныг Д.З барьж ирсэн. Д.З машиныг Эрээнээс Монгол руу орж иртэл барьсан. Монголын гааль гараад 3-ын хаалт дээр цагдаа байна гээд Н.М-ыг би утсаар дуудаж 3-ын хаалтны цаанаас машиныг бариулсан. Ингээд Д.Э-ын ачааг буулгах гэж тэднийх рүү явах замд Н.М-ыг эмнэлгийн тэнд буулгаад би өөрөө машиныг бариад цаашаа явсан. Ингээд Д.Э-ынд очоод ачааг нь буулгаж өгөөд нэг шил архи уусан байх. Би өөрөө элэгнээсээ болоод их амархан согтдог болохоор хэдэн шил архи уусан, хэзээ тэднийхээс яаж гарсан болохыг мэдэхгүй байна. Гэнэт "хөөе" гээд Са хашгирч, машин тормоз гишгэхэд сэрсэн. Тэгэхэд 3 хүн зөв талруугаа унасан байдалтай байсан. ...Тэгэхээр нь Са бид 2 Д.Э руу яриад энд ийм юм болчихлоо хурдан ирээд энэ улсуудыг эмнэлэг хүргээд өгчих гэж хэлээд Д.З бид 2 машинаа аваад явсан.

-2010 оны 06 сарын 05-ны өдөр урагшаа гараад ачаа олдохгүй Эрээнд зогссон. Тэгтэл нэг хужаа давхиж ирээд бараа байна, ачих уу гэсэн. Ямар бараа вэ гэхэд оохор гэхээр нь очиж үзье гээд дагаад шинэ барилгын захын цаана павилонд дээр очсон. Тэгэхэд шуудайтай зүйлүүд байсан. ...Тэгээд нэг шуудайг нь Улаанбаатар хүртэл 15 юаниар буюу нийт 3.000 юаниар ачихаар болсон. Энэ мөнгийг болон ачааг Д.З бид 2 хувааж авсан. ...Орой болсон байсан, хил гараад ирэнгүүт Д.З-ийн дугуй хагарсан. Тэгээд нэг хүний запас дугуйг гуйж аваад тавиад Монгол руу ирсэн. Тэгэж ирэхдээ би Д.З-ийн машиныг чирж ирсэн. Тэр үед М.Ц-руу би яриад "одоо хожигдох нь ээ Д.З бид 2 жоохон жоохон оохор ачсан байгаа. Би 40.000 төгрөг өгнө, Д.З 50.000 төгрөг өгнө тэгээд гарчихмаар байна, Улаанбаатартай нь аччихсан юм гэсэн. ...Хил дээр ирэхэд хорио цээрийн хүүхэн ирэхээр нь бид 2 хаалгаа онгойлгож өгсөн. Тэгэхэд юу юм бэ гэхээр нь оохор гэхэд чирээтэй байсан 2 тэргийг харчхаад юм ярилгүй мэдэгдлийг надад өгөөд яваад өгсөн. Тэгэхэд 1 бичиг дээр 2 машиныг бичсэн байсан. Цаашаа яваад гааль дээр очиход Ц.Н юу юм бэ гэхээр нь хашаа будах гэж байгаа юм аа, оохор гэж хэлсэн. Ц.Н харчхаад яваад өгсөн. Тэгээд М.Ц Д.З-ийн мөнгийг аваад, дандаа юань байсныг аваад цогцолбор руу Ц.Н-ийн араас орсон. Тэгээд гарч ирэхдээ гаалийн хяналт хийсэн тухай шар бичгийг аваад гарч ирсэн.

...Ц.Н-ийн өмгөөлөгч нь гээд нэг залуу надруу яриад "Номгон" буудалд хүрээд ирээч гэсэн. Тэгэхээр нь Д.З, М.Ц нарыг дагуулаад очсон. Мөнгөний асуудлыг цэгцэлмээр байна. Хэн хэнийгээ бодооч гэж байсан гэжээ. /хх-ийн 338-342/

Яллагдагч Д.Ур мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ:...Хуваарийг албаны дарга 5 хоногоор баталснаас 3 дахь хоног нь 2010 оны 06 сарын 05-ны өдөр байсан. Хил хаах дөхөж байхад манай хилийн мэргэжлийн хяналтын байцаагч М.Ц ирээд "манай нөхөр оохор ачаад ирж байгаа юм. Хил хаах гээд байна. Миний дүү импортын мэдэгдэл бичээд өгчихөөч гэсэн. Та стандартын байцаагчид хэлээрэй би машинаа үзэж байгаад бичиж өгнө. Машины дугаар нь хэд юм бэ гэж М.Ц-д хэлэхэд хх-хх ДГА, хх-хх ДГА гэж надад хэлсэн. Тэгэхээр нь мэдэгдэл дээр дээрх 2 машины дугаарыг бичээд өөртөө байлгаж байсан. Хил хааж байхад хх-хх машин нь нөгөө машинаа чирчихсэн байдалтай хяналтын талбайд ирээд зогссон. М.Ц ирээд машинууд ирчихлээ, миний дүү хурдан бичгээ өгөөч гэхээр нь одоохон гээд нэг машин үзчихээд яваад очсон. Би очоод М.Ц эгчээс стандартын байцаагч үзсэн юм уу гэхэд үзчихсэн гэсэн. Машиныг үзэхэд арынхаа суудлын араар оохор гэх шуудайтай нунтаг шар зүйлийг ачсан байсан. Жолоочоос нь асуусан. Тэгэхэд оохор байгаа юм гэсэн. Хэдэн шуудай хичнээн киллограмм юм бэ гэхэд нэг машинд 200 орчим кг байгаа гэсэн. Тэгэхээр нь импортын мэдэгдэлд 400 кг оохор гэж тэмдэглээд М.Ц байцаагчид мэдэгдлийг өгсөн. Би машиныг үзсэн, багавтар шуудайтай шаргал өнгийн нунтаг зүйлүүд байсан. Суудлын араар бараг суудлын суух хэсгийн хэмжээний, тэрнээс арай дээгүүр ч юм уу байсан. Тэгээд би 400 орчим киллограмм гэдгээр нь импортын мэдэгдлийг бичиж өгсөн гэжээ. /хх-ийн 311-313/

- Яллагдагч М.Ц мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ:...90.000 төгрөгийг өгчихье гэнэ. Явахаасаа өмнө бичээд өгчих байцаагч байна уу гэж утсаар ярилаа гэж би хэлсэн. Тэгэхэд Ц.Н тэгье, тэгье хэдэн номер юм бэ гээд гүйгээд явсан. Нэрийг болохоор нэр нь ямар хамаатай юм бэ, хэн ч гэсэн яахав гээд хуваарилалт хийдэг гаалийн байцаагч руу очих шиг болсон. Тэгээд 113 буюу жижиг машины гаалийн байцаагч дээр очиж тонгойгоод юм ярьсан. Тэгээд эргэж ирээд би өөр дээрээ хуваарилуулчихлаа, болчихлоо

гэж хэлсэн. Дараа нь энэ асуудал илэрсний дараа "хоёр хөгшинг гуйгаад, хашаагаа будах гэсэн юм гэхээр оруулсан" гээд хэлчихье гэж байсан. Уул нь миний хувьд хашаа энэ тэр гэж ч гуйгаагүй, шавдуулаагүй юм. Зүгээр л болно гэвэл тэр биз гэж санаад хэлэхэд л Ц.Н зөвшөөрсөн юм. Ингээд хил хааж байхад Ж.Б, Д.З нар нэгийгээ чирээд орж ирсэн. ...Тэр үед Ур 2 машиныг хараад "өө энэ 2 машин юм уу гээд хуурай оохор юм уу гэхэд оохор гэж хэлээд хаалгануудаа онгойлгосон. ...Тэгсэн Ур харчхаад ахаа мөн юм уу? Танд итгэлээ шүү гэж хэлээд яваад өгсөн. Мэдэгдлийг бол бүртгэлд урьдчилан бүртгэхээд машиныг үзэж байж болно, машин ирээч үү, үгүй ч үү гэж байсан. Тэгээд үзчихээд тэр хоёрт мэдэгдлийг өгсөн.

...Ц.Н намайг өрөөндөө буюу цогцолборын 2 давхарт байх ажлын өрөөндөө дуудаад надад цаас харандаа өгөөд "чи Ц.Н-д мөнгө өгөөгүй гээд биччих" гээд гуйгаад байсан. Би бүгдийг мөрдөн байцаагчид ярьж хэлсэн. Бичиг хийж өгч чадахгүй гэсэн. Сая өнгөрсөн бүтэн сайн өдөр буюу 2010 оны 09 сарын 19-ний өдөр Замын-Үүдийн "Номгон" зочид буудлын 308 тоот өрөөнд Д.З, Ж.Б бид гуравыг Ц.Н-ийн өмгөөлөгч гэх Э гэх залуу дуудсан. Тэгээд "та нар мөнгөний асуудлаа эндээс гаргаад хаячих. Тэгвэл та нарын бүгдийн чинь хэрэг хэрэгсэхгүй болчихоно. Одоо та нарыг хорих хугацаа нь өнгөрсөн. Н.Ама ч мэддэг юм биш, би прокурортой нь уузчихсан. Тэгэхгүй бол таны ажлыг чинь би түдгэлзүүлэх гээд байна. Мэдүүлгээ өөрчлүүлээд өгчих гэж н.Ама тэгсэн гэж хүртэл хэлсэн. Би яаж болдог юм бэ гэхэд мөнгөнөөс л салгаад хаячихвал авлигынхан бидэнтэй орооцолдохоо больчихно. Их л бодож 3 цаг загнана биз гээд яриад байсан. ...эхлээд өмгөөлөгч нь бид гуравтай уулзаж байхдаа Ц.Н таниас мөнгө аваагүй гээд байна гэсэн. Тэгэхээр нь би хүүе, дуудчих тэгвэл гэсэн. Тэгэхэд утсаар Ц.Н-ийг дуудахад ороод ирсэн. Тэгтэл тэр өмгөөлөгч мөнгөний талаар Ц.Н-оос асуулгүйгээр та тэр мөнгөө Ц.Н-ид өгөөгүй, энэ хоёрын өртэй хүнд өгсөн гэж хэл. Ийм ажлыг өнөө орой одоо зохион байгуул. Маргааш өглөө н.Ама хүрээд ирнэ. Өнөө орой л цэгцэлье гээд байсан. ...Ц.Н тэр үед энэ мөнгөнөөс болоод заваараад байгаа юм. Бүгдээрээ чирэлдсэн, сунжирсан заваан юм болно шүү дээ, мөнгөгүй болчихвол хэрэгсэхгүй болчихно шүү дээ гэж байсан. Дахиад сая наашаа ирж явахдаа гадаа тааралдаад хүмүүсийнхээ

мэдүүлгийг цэгцэлчих гэж хэлж байсан гэжээ. /хх-ийн 324-328/

-Яллагдагч Д.Эр мөрдөн байцаалтад мэдүүлэхдээ:...Энэ өдрийн үдээс хойш гэрээсээ гарч төврүү орохоор явсан. Тэгээд төврүү оролгүй гуталчин Амгалангийн улаан худгийн тэнд байдаг гэрээр нь орсон. ...Ам-гийнхаас дөнгөж гараад Д.У, Ц.На нартай гудамжинд тааралдахад Д.У ганц шил архи авчих гэхээр нь би дэлгүүр орж улаан шошготой Тэргүүн нэртэй архи нэгийг худалдаж аваад гурвуул цугтаа Амгалангийн дунд буцаад орсон. Тэр архинаас Ам уугаагүй, бид гуравыг хуваагаад архийг ууж дунд нь оруулах үед Ам-гийн эхнэр эмнэлгээс утасдаад бүгдээрээ тэднийхээс гарч 4 айлын хамгийн захынхад орж уусан. Архийг гурвуул хувааж уучаад би харьлаа гэхэд хойшоо харих юм бол бид 2 дөхөөд буучихъя гэж Д.У-г хэлэхээр нь сундлаад явсан. Энэ үед гадаа бүрэнхий болсон байсан. Тэр хоёрыг сундлаад Петровисийн хажуугаар гараад төв замд нийлээд чигээрээ явж байгаад Торгоны зам буудлын хажууд чигээрээ явж байхад урдаас замын хажуугаар УАЗ-469 машин ирж байсан. Тэгэхээр нь өмнөөс нь их гэрлээрээ би дохисон. УАЗ-469 машиныг дөхөөд ирэх үед нь би хурдаа багасгасан, тэр үед машин шороон замаас засмалруу гарч ирээд л засмал замруу орох үедээ өөдөөс ирээд мөргөсөн юм. Мөргөнгүүтээ машины жолооч бага зэрэг ухраад зогссон. Мотоциклын урд талын дугуй машины урд талын гуперт дэгээдэгдсэн байсан нь бага зэрэг ухрах үед салж ойчсон. ...Би гурвуул нэг шил архийг ижил тэнцүү хувааж уусан байсан болохоор мотоциклио бариад явчихаар байсан гэжээ. /хх-ийн 356-359/

-Д.Э-ын хохирогчоор өгсөн мэдүүлэгт:...2010 оны 04 сарын 15-ны өдөр би мотоциклтойгоо явж байгаад Д.У, Ц.НА нартай гэр байрны ХААН банкны тэндэх улаан худгийн тэнд тааралдаад дэлгүүрээс би "Тэргүүн" нэртэй 0.5 гр архи авч гуталчин Ам-гийн дунд ууж байгаад намайг гэрээдээ явлаа гэхэд дөхөөд бууя гээд хамтдаа би мотоциклио бариад миний ард Д.У, хамгийн ард Ц.На сууж явсан. ...Би 20-30 км/цагийн хурдтай явсан байх гадаа бүрэнхий болчихсон би хар замаас шороон замруу эргэх гээд дохио өгөөд бараг зогсох шахаж байхад өөдөөс ирсэн УАЗ-469 шууд мөргөсөн гэжээ. /хх-ийн 57-59/

-2010.06.29-ний өдөр өгсөн мэдүүлэгт:... Надад ямар нэгэн гомдол санал гээд байх

зүйл

-Хохирогч Д.У-ын мэдүүлэгт:...Би 2010 оны 04 сарын 15-ны өдөр зээ хүү болох н.Х-г 16.00 цагаас эхлэх хичээлд нь хүргэж өгчихөөд гэр байранд байдаг том хүү Бат-ын хадмынд очоод байж байтал Д.Эр 19 цаг болох гэж байхад ирээд 1 шил 500 граммын архи гаргаж ирсэн бөгөөд тэр архийг Д.Эр, Ц.На, би нэг танихгүй залуу бид 4 хувааж уусан бөгөөд би тэр архинаас нь нэг л татсан юм. Тэгэж байтал зээ хүү Х хичээлээ тараад ирсэн ба Д.Эр мотоциклтой явж байсан болохоор гэрлүүгээ дөхүүлэхээр болсон байсан юм. Зээ хүү Х найзтайгаа гэрлүүгээ явган яваад өгсөн бөгөөд Д.Эр-ын мотоцикл дээр Ц.На бид 2 сундалдсан ба Д.Эр мотоциклио бариад урд нь ард нь би, миний ард Ц.На гэсэн дарааллаар сундалдаж суугаад төв замаар хойшоо яваад биржийн гражын хажуугаар очтол өөдөөс хойноос урагшаа явж байсан УАЗ-469 маркын машин ирээд Д.Эр зөрөх гээд баруун талруугаа бага зэрэг дарсан чинь тэр машин ирээд ялимгүй хазайж ирээд бид нарыг мотоциклтой маань хамт мөргөчихсөн ба би нэг хэсэг ухаан балартаж байгаад сэрэхэд зүүн хөлийн гутал тайлагдчихсан байсан ба босох гэсэн чинь зүүн хөл нугижнаад их өвдөөд босож чадаагүй юм. Тэгээд эмнэлэгт хүргүүлсэн юм гэжээ. /хх-ийн 61-63/

-2010 оны 06 сарын 29-ний өдөр өгсөн мэдүүлэгт:...Миний биеийн байдал ерөнхийдөө гайгүй байгаа гэхдээ хугарсан хөлийн хувьд бол бүрэн гүйцэд эдгээгүй байгаа учир хөл дээрээ дангаараа босож явж чадахгүй байгаа ба суга таягтай л муухан явж байна. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байхад бид нарыг мөргөдөг машины жолооч Д.З эмчилгээний зардал гэж 430.000 төгрөг өгсөн. ...Тухайн үед осол болсны дараа би Д.З-д чамайг баллаад хаячихлаа чи явж бай гэж хэлээгүй, тухайн үед хөл маш ихээр өвдөж байсан учраас ухаан балартчихсан байсан юм. ...Надад одоо ямар нэгэн гомдол санал байхгүй байна гэжээ. /хх-ийн 63/

-Гэрч Б.Д-ын мэдүүлэгт: Би 2010 оны 06 сарын 06-ны өдөр МЧ-1-ийн 7-р зам дээр 70274. дугаартай вагонд Эрэннээс ачаа ачуулж байсан. Тэгтэл манай найз Б.До над руу 16 цагийн үед утсаар яриад ачаа ачуулж байгаа вагонд чинь зай гарах уу гарахаар бол хэдэн шуудай оохор, хайрцагтай юмнууд ачих гэсэн юм гэсэн. Тэгээд шөнө 02 цагийн үед ачаагаа ачуулж дуусахад жоохон зай гарсан ба Б.До-руу ярьж дуудахад тэр портер

машинтай ирээд жижигхэн шуудайтай оохор гэх зүйл болон өөр хэдэн хайрцагтай зүйл ачаад надад 80.000 төгрөг өгсөн. Тэгээд надад дээрх ачааг тосч авах хүний утас гээд 9910xxxx гэсэн дугаарыг өгч байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 70-71/

-Гэрч Д.П-ын мэдүүлэгт: Би 2010 оны 06 сарын 05-ны өдөр 18 цаг өнгөрч байх үед Замын-Үүдийн төв талбай дээр явж байгаад хөрш айлын Ц ахтай таарсан. Тэр өөрийнхөө хх-хх УБЯ дугаартай супер УАЗ-469 машинтайгаа зогсож байсан. Тэгээд бид 2 ойр зуурын юм яриад зогсож байхад Ж.Б ах өөрийн хх-хх ДГА УАЗ-469 машинаараа Д.З ахын хх-хх ДГА дугаартай УАЗ-469 машиныг чирээд талбай дээр орж ирээд зогссон. Би тэдний машин тэргийг засаж өгч байгаад л танилцсан. ...түүний дараа машинд нь жижигхэн шуудайтай зүйлс болон 2 ширхэг цаасан хайрцагтай ачаа үлдсэн байсан. Харин Ж.Б нь машиндаа Д.З-ын ачсан байсантай адилхан 2 ширхэг цаасан хайрцагтай зүйл ачсан байсан бөгөөд доор нь шуудайтай зүйлс байсан. ...машинтайгаа Булган плазагийн урд очсон. Ж.Б-ын машинд түүний эхнэр М.Ц гэх Хилийн мэргэжлийн хяналтын албанд ажилладаг зүс мэдэх эмэгтэй суугаад явж байсан. ...Тэнд ачсан жижигхэн цагаан саарал өнгийн шуудайтай зүйлсийг Д.З, Ж.Б 2 оохор гэж байсан бөгөөд нилээд хүнд жинтэй байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 72/

-Гэрч Д.Э-ын мэдүүлэгт: 2010 оны 04 сарын 15-ны орой 19 цаг болж байсан байх Д.З, Ж.Б бас нэг танихгүй хүүхний хамт манайд миний захисан 2 хайрцагтай хүнсний зүйлийг дөхүүлж ирсэн. Манайд ирэхдээ Д.З, Ж.Б хоёул халамцуухан байсан. Хамт явсан хүн нь юм уусан байсан эсэхийг мэдэхгүй. Машиныг Д.З барьсан явсан. Манайд миний хайрцагтай юмыг буулгачхаад өөр нэг айлд ачаа буулгана гээд явсан. ...Манайхаас гараад 1 цагийн дараа л байх Ж.Б-ын 9666xxxx дугаарын утаснаас Ж.Б, Д.З хоёр залгаад аваар хийчихлээ, эмнэлэгт хүн хүргэмээр байна, хүн нь гэмтчихлээ, хөл нь хөдлөхөө байчихлаа гэж надруу ярьсан. Би өөрийн машинтайгаа тэр хоёрын хэлсэн газар буюу Шунхлай колонкийн урд яваад очиход Ж.Б-ын машиныг осол болсон газрыг өнгөрөөгөөд замаас гаргаж тавьсан байдалтай байсан, мотоциклийг цементэн хавтан түшүүлсэн байдалтай тавьсан байсан. Мөн тэр үед энгийн хувцастай нэг өндөр залуу байсан. Тэр машин тэргийг хөдөлгөж

болохгүй гэж байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 250-251/

-Гэрч Н.Г-ийн мэдүүлэгт: ...2009 оны 10 сарын 12-ны өдөр Д.З нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад журамлагдаж, тухайн өдрөө эрүүлжүүлэгдсэн. 2009 оны 10 сарын 19-ний өдрөөс тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна гэсэн мэдүүлэг. /хх-ийн 252/

-Гэрч Ө.Б-ын мэдүүлэгт: ...Тухайн үед машины эвдрэлийг шалгахад хх-хх ДГА машины тормоз ажиллахгүй байсан. Машиныг унаад явж байсныг авчирч оройд нь журмын хашаанд хийхдээ үзэхэд тормоз ажиллагаагүй болох нь тогтоогдсон. Гэрэл, дохионууд ажиллахгүй байсан, гэхдээ зөв талын их гэрэл ажиллахгүй байсан. ...мотоциклтой мөргөлдсөн хэсгээрээ эвдрэл гэмтэлтэй байсан, буруу талын урд хаалга хонхойсон, хуучин гэмтэлтэй, түгжээ хэмхэрсэн байсан.

Мотоциклын ард талын шар гэрлэн дохио хагарсан, их гэрлийн шил хагарсан байсан, тормозыг шалгахад гар тормоз ажиллагаагүй, хөл тормоз хэвийн байсан. Өөр эвдрэл гэмтэл тогтоогдоогүй. ...Хэргийн газар дээр мотоциклын ч тэр автомашины ч тэр тормозны мөр байгаагүй, газрын гадаргуу дээр дугуй тормозлосон гэсэн мөр байгаагүй. Д.З нь тухайн үед тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй байсан. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад өмнө нь хасуулсан байсан. Дараа нь осол болсноос хойш тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь сэргээсэн. /ХХ-ийн 253-254/

-Гэрч Ц.На-ын мэдүүлэгт: 2010 оны 04 сарын 15-ны өдөр Д.У эгчийн худынх болох На гэж эгчийнд Д.У эгчтэй таарсан юм. На эгчийнхээс гарах гэхэд Д.Эр ахтай таарсан. Тэгээд эргэж На эгчийнд ороход Д.Эр ах архи задалсан. Тэр нь 0.5 литрийн шилтэй архи байсан. Тэгээд тэр архинаас бүгдээрээ хуваагаад ууцгаасан. Д.Эр ах архийг аягалж байсан. Тэгээд тэр айлаас гараад Д.У эгч бид 2 дөхүүлчихье гээд Д.Эр ах мотоциклио бариад Д.У эгч дунд нь суугаад би хамгийн ард сундалж гэр рүүгээ явцгаасан. Бид нар хар замаар чигээрээ явж байхад гэнэт тас гээд явчихсан. Тэгээд тэр үед би хойшоогоо шидэгдсэн байх. Нөгөө хоёр мотоциклтойгоо хажуулдаад ойчсон байсан. Намайг босоод харахад машины гэрэл тусч байсан. Тэгээд УАЗ-469 машинтай мөргөлдчихлөө гэж мэдсэн. Яг яаж мөргөлдсөнөө бол би анзаараагүй юм. ...Д.Эр ах жоохон уучихсан

байсан болохоор нэг их хурдтай яваагүй байх. Намайг босоод ирэхэд нөгөө 2 ойчсон байсан. Тэгээд Д.У эгчийг босгох гээд татахад хөл болохоо байчихлаа, хугарчихлаа гээд босч чадахгүй байсан. ...Тэр үед жолооч талаас нэг эрэгтэй хүн, урд талын суудлаас нэг эмэгтэй хүн, арын суудлаас нэг эрэгтэй хүн бууж ирсэн. Жолооч талаас бууж ирсэн хүн нь арай махлагдуу хүн байсан санагдаж байна. Тэр хүн Д.У эгчийг өргөж зам хажуугийн бетонон хавтан дээр суулгаж өгсөн. Тэр хүн Д.У эгчийг таниад байсан. ...Тэгээд тэр машинд явсан эгчийн хамт би мотоциклийг босгоод замаас түрж гаргаад цементэн хавтан түшүүлж тавьсан. Тэр машинд явсан эгч Д.У эгчийг таниад байсан. Ах нар "эндээ зохицчихье, одоо бэлнээр 200.000 төгрөг өгчихье" гэж байсныг би сонссон гэсэн мэдүүлэг. /хх-ийн 258-260/

-Гэрч Н.М-ын мэдүүлэгт: 2010 оны 04 сарын дундуур өдрийг нь тодорхой санахгүй байна, үдээс хойш байсан. Би Замын-Үүдийн гаалийн газрын шалган нэвтрүүлэх цогцолборын наана 3 хаалтын орчим ганцаараа явж байтал миний танил Ж.Б ах өөрийн хх-хх ДГА дугаартай бор өнгийн УАЗ-469 маркын машинаа барьж яваад надтай таарсан. Тухайн үед Ж.Б ахын машин дотор нэг эмэгтэй байсан мөн зүс таних Д.З ах байсан ба Ж.Б ах энэ хүүхний ачааг хүргэж өгөхгүй бол болохгүй ах нь архи уусан байна. Цагдаа таарвал баларна чи ахынхаа машиныг унаад хүргээд өгчих гэсэн. Тухайн үед Ж.Б ахаас архи үнэртэж байсан ба бага зэргийн согтуу байсан мөн Д.З ах халамцуу согтуу байсан. Ингээд би зөвшөөрөөд машиныг нь жолоодоод Замын-Үүдийн эмнэлгийн хойд талын цэвэр ус үйлдвэрлэдэг компанийн дэргэд иртэл Ж.Б ах намайг машинаа зогсоо би өөрөө машинаа жолоодоод явна чи буучих гэхээр нь та согтуу байна би машиныг чинь хүргээд өгье гэтэл ах нь энэ хүүхний ачааг хүргэж өгөхгүй бол болохгүй гэж хэлсэн тэгээд би машинаас нь буусан, Ж.Б ах өөрөө машинаа бариад тэр 3 яваад өгсөн гэсэн мэдүүлэг. /хх-ийн 262-263/

-Гэрч Д.П-ы мэдүүлэгт:...Хятадын хил гараад анх Ж.Б-ын машинд сууж наашаа явсан юм. Тэгээд Д.З-ын машин эвдрээд чирэх үед нь би Д.З-ын машины дугуйг хамт янзлалцаад түүний машинтай Монгол хил хүртэл явсан. ...Жижигхэн цагаан ууттай зүйл ачсан байсан. Жоохон хүнд байсан. Надад хэлэхдээ оохор байгаа юм гэж байсан.

...дотроо шар өнгийн нунтаг зүйл хийсэн шуудайтай юмнууд байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 278-279/

-Гэрч Б.До-ын мэдүүлэгт: 2010.06.05-ны орой Ж.Б ах утсаар яриад ачаа авах уу гэхээр нь очиж ачсан. Би гэрээсээ гараад Булган плазагийн тэндээс баз хүргэн болох Даваагийн хамт оохор гэх шуудайтай зүйлийг ачсан. Хөлсөнд нь Ж.Б-аас 300 юань, нөгөө хүнээс нь 200 юань, 20.000 төгрөгтэй авсан. Хэнийх нь ачааг мэдэхгүй Цэцэн хоосон зогсож байсан. Бүгд л оохор гэж байсан. ...нэг л цоорхой уут байсан, ямар нэгэн үнэр байгаагүй, биед нөлөөлсөн зүйлгүй. Хүлээн авах хүний утас, нэрийг нь Цэцэн надад хэлсэн. ...Би таны химийн бодис 4 хайрцагтай зүйлийг ачууллаа гэж хэлээгүй, харин таны 200 шуудай оохор, 4 хайрцагтай юмыг ийм вагонд ачууллаа шүү гээд дугаарыг нь өгсөн. Тэгэхэд тэр хүн "тийм миний ачаа байгаа юм" гэж хэлж байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 282-283/

-Гэрч А.Н-ийн мэдүүлэгт:...2010 оны 05 сарын 24-ний өдөр баталсан 01-127 тоот удирдамжийн дагуу 2010 оны 06 сарын 09-ний өдөр 16 цагийн орчим АБТЭМА-ийн орон нутгийн ачааны 44-р ангид 5 улсын байцаагчийн хамт шалгалт хийхэд Замын-Үүдээс ирсэн ачааны вагоноос хаяг, шошго, тэмдэглэгээгүй, химийн бодис байсныг илрүүлэн шалгасан. Тухайн үед дагалдах ямар нэгэн бичиггүй ирсэн байсан. Мөн өдрийн 17 цагийн орчим дэд захирлынх нь авчирсан баримт бичгийг шалгахад тусгай зөвшөөрлийнх нь хүчинтэй хугацаа нь мөн оны 05 сарын 04-ний өдөр дууссан байсан. Дэд захирал нь тухайн үед БОАЖЯ-нд мэдүүлсэн байгаа, холбогдох баримт бичгүүдийг маргааш авчирч үзүүлэе гэж байсан. Энэ байдлыг тухайн үед удирдлагуудад мэдэгдэж, ТВ5 телевизийг дуудаж зохих мэдээллийг өгсөн. Тухайн үед барааны эзэн нь өөрийгөө "АЭ" ХХК-ийн ерөнхий нябо гэж өөрийгөө танилцуулсан С.Б гэгч байсан. ...Нөхцөл байдлыг үндэслээд бараа бүтээгдэхүүнийг "АЭ" ХХК дээр очиж битүүмжилсэн байгаа. Надад огт мэдэгдэлгүйгээр талбайгаас барааг аваад явсан байсан. ...Тухайн үед барааг яагаад аваад явчихав гэхэд дэд захирал Сайн нь гадаа бороо орж байна, норгож болохгүй үнэтэй болохоор аваад явчихлаа гэж байсан. Хар тугалганы исэл нь өөрөө химийн онцгой хортой бодисын жагсаалтад ордог. БОАЖСайд, Гадаад

харилцааны сайдын 2009 оны 11 сарын 16-ны өдрийн 334/104 тоот хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам"-ын стандартын шаардлага хангасан хаяг шошготой байх тухай заалт, түүнчлэн тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалтууд болон тусгай зөвшөөрөл бүхий этгээд уг үйл ажиллагаа эрхлэх талаарх заалтуудыг зөрчсөн. Түүнчлэн химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд "зохих зөвшөөрөлгүйгээр химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох тухай" заалтыг зөрчсөн байсан. ...Энэ бодис өөрөө хүнд металл. Тийм учраас ачих, буулгах үед доргилтоос нурчихдаг бөгөөд энэ тохиолдолд агаарын замаар тоосонцор нь сорогдвол хүний биеэс удаан гадагшилдаг буюу хүний биед хортой бодис юм. Энэ бараанд дагалдах ёстой бичиг баримт нь тусгай зөвшөөрөл, худалдах, худалдан авах гэрээ, барааны чанарын гэрчилгээ буюу сертификатууд, хилийн боомт дээр хяналтад хамрагдсан мэдэгдэл зэрэг дагалдах ёстой гэсэн мэдүүлэг. /хх-ийн 284-286/

-Гэрч С.Н-ын мэдүүлэгт:...Хар тугалга нь байгаль дээр биш байх нь ховор бөгөөд дандаа нэгдмэл байдлаар байдаг энэ нь байгаль исэл буюу сульфит хэлбэрээр байдаг, ерөнхийдөө хатуу төлөв байдалтай, цельсийн 1729ос хэмд буцалдаг, хар тугалга нь хортой металл бөгөөд химийн шинж чанараар цацраг идэвхт бодисын эцсийн бүтээгдэхүүний үлдэгдэл бодис нийлмэл байдлаар оршино. ...байгаль орчин талаасаа хөрс усанд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд аюулын зэргээр ангилж үздэг:

1 дүгээрт нь хөрсөнд зөвшөөрөгдөх хэмжээнээс /100-500 мг/м<sup>3</sup>/ энэ хорт агууламж гэж.

2 дугаарт /500-100 грамм мг/м<sup>3</sup>/ аюултай агууламжтай гэж үздэг. Хүн малын эрүүл мэндэд нөлөөлөх амьсгалын замаар залгих, арьсанд ба нүдэнд хүрэлцэх хорддог, хордлогын шинж чанар нь ядарч сульдах, нойргүйтэх, цонхийх, хоолонд дургүй болох, дутагдалд орох, шингэн алдах, өтгөн хатах, гэдэс өвдөх, бүдүүн гэдэсрүү хатгах, цус багадах, чичрэх, бугуй ба шагай саа, тархины зовнил /хар тугалганы тархи зовнил/, бөөр өвдөх, нүд өвдөх цусны даралт ихсэх зэрэг

хүний биед хортой нөлөө үзүүлнэ. Байгаль дээр болон хөрс усанд асгарсан юм уу зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд маш удаан задардаг учир хортой бодис юм гэсэн мэдүүлэг. /хх-ийн 644-645/

-Шинжээч П.М-ий мэдүүлэгт: ...шинжилгээнд ирүүлсэн бодис нь хар тугалганы дан исэл буюу олон улсын химийн нэр томъёогоор хар тугалганы моноксид болох нь тогтоогдсон. Шинжилгээний үр дүнгээр 577.68 бүхий магадлал нь манай спектрийн буюу багажны санд байгаа спекртэй тухайн дээжнээс авсан спектр 2 адилхан байгааг харуулах буюу үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, хамгийн их магадлалтай спектр буюу хар тугалганы исэл болох нь тогтоогдсон. Энэ төрлийн бодисыг импортлохын тулд БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд улсын хилээр оруулах үед дээж авч гаалийн төв лабораториор шинжлүүлж ангиллын код тогтоолгодог. Шинжлэгдсэн дээжний тухайд 2824.10.00 ангилалд хамаарах хар тугалганы дан исэл байсан гэсэн мэдүүлэг. /хх-ийн 274-275/

-2011 оны 08 сарын 25-ны өдөр өгсөн мэдүүлэг:...Хар тугалганы исэл нь нэг төрлийн дан бодис юм. Өөрөөр хэлбэл, хар тугалга, хүчил төрөгчөөс тогтсон химийн нэгдэл юм. Найрлагад нь өөр төрлийн бодис агуулагдаагүй. Нил улаан туяаны спектрометр багажаар шинжилгээг хийсэн. Энэ багажаар NNS JIS 0117:2003 стандартын дагуу шинжилгээг хийсэн. Бодисын дээжийг калийн бромид бодистой хольж дээж буюу ялтсан шахмал бэлтгээд нил улаан туяагаар шарж, гэрлийн шингээлтийг хэмжиж авсан. Шингээлтийн спектрийн дагуу тухайн дээжийг хар тугалганы исэл болохыг тогтоосон гэсэн мэдүүлэг. /хх-ийн 646-647/

-Хэрэг учралын газарт үзлэг хийсэн тухай тэмдэглэл /хх-ийн 29/ -Хэрэг учралын газарт давтан үзлэг хийсэн тухай тэмдэглэл /хх-ийн 30/ -Хэрэг осол гарсан газар хийсэн хэмжилтийн бүдүүвч /хх-ийн 36-38/

-Тээврийн хэрэгслийн техникийн байдлыг шалгасан акт: УАЗ-31513 маркын хх-хх ДГА автомашин болон Н|125-8 маркын улсын дугааргүй мотоцикл зэрэг нь бүрэн бус тээврийн хэрэгсэл байна гэсэн акт. /хх-ийн 39-40/

-Согтуурлын зэрэг шалгасан магадлагаа: Д.З-ын согтуурлын зэрэг 1.99%-ийн согтолттой байна гэсэн магадлагаа. /хх-ийн 41-42/



-Хохирогч Д.Эр-д Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн №110 тоот дүгнэлт:

1. Д.Эр-ын биед зүүн хөлийн шилбэний зөрөөтэй ил хугарал бүхий гэмтэл учирсан байна.

2. Учирсан гэмтэл нь хатуу хүчин зүйлийн үйлчлэлээр үүсгэгдсэн болно.

3. Учирсан гэмтэл нь шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ явуулах дүрэм зааврын 2.2.1.О-д зааснаар амь насанд аюултай шинжээрээ хүнд зэргийн гэмтэл болно.

4. Цаашид эрүүл мэнд хөдөлмөрийн чадварт нөлөөлөх эсэх нь эдгэрэлтээс хамаарна гэсэн дүгнэлт. /хх-ийн 73-74/

-Д.Эрдэнэчулууны цусанд этилийн спирт илрүүлэх зорилгоор цусанд шинжилгээ хийсэн №21 тоот дүгнэлт

1. Шинжилгээнд ирүүлсэн Д.Эр-ын цус гэх шингэнд 2.5 промилли спиртийн агуулга илэрсэн байна.

2. Д.Э-ын цус гэх шингэнд илэрсэн 2.5 промилли спиртийн агуулга нь согтолтын дунд зэрэгт хамаарна гэсэн дүгнэлт. /хх-ийн 75/

-Хохирогч Д.У-д Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн №111 тоот дүгнэлт: 1. Д.У-ын биед зүүн хөлийн шилбэний зөрөөтэй ил хугарал, зөөлөн эдийн үхжил бүхий гэмтэл учирсан байна. 2. Учирсан гэмтэл нь хатуу хүчин зүйлийн үйлчлэлээр үүсгэгдсэн болно. 3. Учирсан гэмтэл нь шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ явуулах дүрэм зааврын 2.2.1.О-д зааснаар амь насанд аюултай шинжээрээ хүнд зэргийн гэмтэл болно. 4. Цаашид эрүүл мэнд хөдөлмөрийн чадварт нөлөөлөх эсэх нь эдгэрэлтээс хамаарна гэсэн дүгнэлт. /хх-ийн 76-77/

-Д.У-ы цусанд этиллийн спирт илрүүлэх зорилгоор цусанд шинжилгээ хийсэн 1 22 тоот дүгнэлт: 1. Шинжилгээнд ирүүлсэн Д.У-ын цус гэх шингэнд 0.8 промилли спиртийн агуулга илэрсэн байна. 2. Д.У-ын цус гэх шингэнд илэрсэн 0.8 промилли спиртийн агуулга нь согтолтын хөнгөн зэрэгт хамаарна гэсэн дүгнэлт. /хх-ийн 78/

-2010.04.15-ны өдрийн Зам тээврийн осол дээр тогтоосон шинжээчийн № 20 тоот дүгнэлт:

1. УАЗ-469 маркын хх-хх ДГА дугаартай автомашин жолоодож явсан Д.З нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 2.5-д заасан /Зам тээврийн осолд холбогдсон жолооч нь дор дурдсан үүрэг хүлээнэ/,

а/ тээврийн хэрэгслээ нэн даруй зогсоож, ослын дохионы гэрлээ асаах ба

ослын зогсолтын тэмдэгийг энэ дүрмийн 6.3-т заасан шаардлагын дагуу тавьж, тээврийн хэрэгсэл болон осолд холбогдол бүхий эд юмсыг байрнаас нь хөдөлгөхгүй байх.

б/ зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түргэн тусламж дуудах, хэрэв бололцоогүй бол уг хүнийг ойр байгаа эмнэлгийн байгууллагад аль тааралдсан тээврийн хэрэгслээр хүргүүлэх буюу зайлшгүй тохиолдолд өөрийн жолоодож яваа тээврийн хэрэгслээр хүргэж, эмнэлгийн ажилтанд өөрийн овог нэр, тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, гэрчилгээг үзүүлж тэмдэглүүлээд уг газартаа буцаж ирэх.

в/ зам тээврийн ослын тухай цагдаагийн байгууллага /ажилтан/-д мэдэгдэж түүнийг үзсэн хүмүүсийн овог нэр, хаягийг мэдэж аваад осолд холбогдол бүхий эд мөрийн баримтын зүйлийг хамгаалан цагдаагийн байгууллагын ажилтанг иртэл хүлээх.

2.7-д жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/ согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох.

8.2-д Эсрэг хөдөлгөөнтэй 2 эгнээгээр зорчдог замд гүйцэж түрүүлэх буюу тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгал сөрөхийг хориглоно гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Хун Лян маркын мотоцикл жолоодож явсан Д.Эр нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 2.1-д Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч дараах бичиг баримтыг биедээ авч явна,

а/ Тухайн тээврийн хэрэгсэлд тохирох МУ-ын үндэсний буюу олон улсын жолоодох эрхийн үнэмлэх, 2.5-д Зам тээврийн осолд холбогдсон жолооч дор дурдсан үүрэг хүлээнэ, түүнийг үзсэн хүмүүсийн овог нэр, хаягийг мэдэж аваад осолд холбогдол бүхий эд мөрийн баримтын зүйлийг хамгаалан цагдаагийн байгууллагын ажилтанг иртэл хүлээх.

2.7-д жолоочид дор дурдсан зүйлийг хориглоно:

а/ согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн, мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахааргүй өвчтэй буюу ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох.

21.8-д Хүн тээвэрлэхийг хориглох

тохиолдол:

а/ Тээврийн хэрэгслийн тодорхойлолтоор тогтоосон тооноос олон хүн, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлт. /хх-ийн 79-80/

-Эд зүйлд үзлэг хийсэн тухай тэмдэглэл /хх-ийн 203-210/

-Эд мөрийн баримт хураан авч хадгалах тухай тогтоол /хх-ийн 212/

-Бүртгэлийн дэвтэрт үзлэг хийсэн тухай тэмдэглэл /хх-ийн 214-216/

-Эд мөрийн баримтаар хураагдсан бодист шинжилгээ хийлгэх тухай тогтоол, шинжээчийн 0003235 тоот дүгнэлт: Шинжилгээний дүнгээр тухайн дээж нь хар тугалганы моноксид болно. БТКУС-ийн тайлбар бичгийн 28 дугаар бүлгийн зүйл 28.24-ийн тайлбарт зааснаар тухайн бодисыг хар тугалгатай болор шил, шүдэнз, будаг хатаагч хийхэд хэрэглэдэг гэсэн дүгнэлт. /хх-ийн 217-220/

-Баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл /хх-ийн 221/

-Эд мөрийн баримт хураан авч хадгалах тухай тогтоол /хх-ийн 222-223/

-Шүүхийн Шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 3222/23 тоот шинжээчийн дүгнэлт: 1.Дорноговь аймгийн Замын-Үүд дэх Гаалийн газрын архивт хадгалагдах Улсын хилээр орсон суудлын автомашины бүртгэл-ийн 113 дугаартай дэвтрийн 000026 дугаар хуудасны 333, 334 дугаарын ард байх бүртгэлүүд дэх бичиглэлийг засварласан байна. 2.Өмнө нь "хх-хх", "М,...", "хх-хх" "Э,р..." гэсэн бичиглэлүүд байна. Дээрх дарагдсан "хх-хх", "М,...", "хх-хх" "Э,р..." гэсэн бичиглэлүүдийн ерөнхий болон хувийн илрэх онцлог шинж тэмдэгүүд нь хэн бичсэн эсэхийг тогтооход хангалтгүй байх тул дүгнэлт өгөх боломжгүй байна. 3.Харин "хх-хх" ДГА, 469 Б... 6, 661", "хх-хх ГА 469 Д.3 5, 661" гэсэн бичиглэлүүд нь Х.Д-ын бичсэн гэх гар бичвэрийн албадан загваруудтай тохирч байна.

Жич: Шинжээчийн 3222/3223 тоот дүгнэлт болон шинжилгээнд ирүүлсэн объектуудыг гэрэл зургийн үзүүлэлтийн хамт бүрэн хүлээлгэн өгөв. /хх-ийн 226-241/

-Шинжээчийн 3989 тоот дүгнэлт:

1. "Улсын хилээр орсон суудлын автомашины бүртгэл"-ийн 000026 дугаартай хуудасны 334, 335 дугаар мөрөнд байх засварласан бичиглэл нь Х.Д-ын бичгийн хэвийн загвартай тохирч байна. /хх-ийн 243-246/

-Шүүгдэгч Д.3 хил нэвтрэлтийн мэдээлэл /хх-ийн 479-485/

-Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам /хх-ийн 497-499/

-Импортын химийн бодисын чанар, аюулгүй байдлыг хянаж улсын хилээр нэвтрүүлэхэд улсын мэргэжлийн хяналтын газар, гаалийн ерөнхий газар болон тэдгээрийн харьяа байгууллага, албадын байцаагчдын үйл ажиллагаанд мөрдөх заавар /хх-ийн 500-502/

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, гадаад харилцааны сайдын 2009 оны 11 сарын 16-ны өдрийн 334/104 дугаар хамтарсан тушаалын хавсралт, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам /хх-ийн 565-579/

-Мөрдөн байцаах ажиллагааг дуусгаж, хэргийн материалыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод танилцуулсан тэмдэглэл /хх-ийн 620-627/

-Шинжээчийн дүгнэлт /хх-ийн 951-953/

-Шүүхийн Шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 34 тоот шинжээчийн дүгнэлт /хх-ийн 997-999/

-Зарим яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Прокурорын 5/65, 5/16, 5/15, 5/66, 5/67 тогтоолууд /хх-ийн 1189-1194, 1197-1200/ эдгээр нотлох баримтууд нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан гэмт хэргийн нөхцөл байдлын талаар хуульд заасан үндэслэл журмын дагуу буюу нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх журмын дагуу олж авсан, тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хамааралтай гэж шүүх дүгнэсэн болно.

Шүүгдэгч Ц.Н-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.1 дэх хэсэгт зааснаар өөрчилж зүйлчлүүлэх саналыг өмгөөлөгч Ч.Энхбаяр оруулж ирж байгааг шүүх хүлээн авах боломжгүй байна. Шүүгдэгч Ц.Н нь "...хээл хахууль аваагүй татварын мөнгөө авсан" гэж шүүх хуралдаан дээр мэдүүлж байгаа боловч хэдэн төгрөгийн татварыг шүүгдэгч Д.3-д ногдуулснаа тодорхой мэдэхгүй, яг хичнээн төгрөг М.Ц-гаас авснаа мэдэхгүй, мөн татварт авсан гэх мөнгөө /хх-ийн 801/ 2012 оны 01 сарын 26-ны өдөр 91600 төгрөгийг Капитал банкинд тушаасан кассын орлогын баримт зэрэг

байдлаас үзэхэд гаалийн улсын байцаагч нь татварт төлөгдөх мөнгийг бэлнээр авч өөрөө 2 жилийн дараа уг татвараа төлж байгаа нь ойлгомжгүй байна. Шүүгдэгч Ц.Н яллагдагч М.Ц-гийн хх-ийн 324-328, Ж.Б-ын хх-ийн 338-342 дугаар хуудсан дахь мэдүүлгээр 600 юанийг өгч авалцаж байсан тухай мэдүүлдэг. Иймд шүүгдэгч Ц.Н-д Сум дундын Прокурорын газраас зүйлчилж ирүүлсэн зүйл ангиар ял ногдуулах нь зүйтэй гэж үзлээ.

1. Шүүгдэгч Д.З нь Ж.Б-тай бүлэглэн 2010 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хх-хх ДГА, хх-хх ДГА улсын дугаартай УАЗ-469 маркын автомашинуудад онцгой хортой химийн бодис болох хар тугалганы исэл 200 шуудай буюу 5 тонныг тусгай зөвшөөрөлгүйгээр ачиж Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр импортлосон,

-2010 оны 04 сарын 15-ны өдөр тус сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Биржийн гражийн баруун талын төв засмал зам дээр архи дан согтуурсан үедээ эрхийн үнэмлэхгүйгээр хх-хх ДГА улсын дугаартай УАЗ-469 маркын автомашиныг жолоодож яваад улмаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөний улмаас шүүгдэгч Д.Э-ын жолоодож явсан мотоциклтой мөргөлдөж иргэн Д.У, Д.Э нарын биед хүнд гэмтэл учруулсан, улмаар зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан,

- Шүүгдэгч Д.З нь Ж.Б-тай бүлэглэн 2010 оны 06 сарын 05-ны өдөр хх-хх ДГА, хх-хх ДГА улсын дугаартай УАЗ-469 маркын автомашинуудад онцгой хортой химийн бодис болох хар тугалганы исэл 200 шуудай буюу 5 тонныг тусгай зөвшөөрөлгүйгээр ачиж Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын хилээр импортлохдоо шүүгдэгч М.Ц-аар дамжуулж гаалийн улсын байцаагч Ц.Н-д 250 юань буюу 51.330 төгрөгийн хээль хахууль өгсөн,

Шүүгдэгч Ц.Н нь 2010 оны 06 сарын 05-ны өдөр Замын-Үүд суман дахь авто замын шалган нэвтрүүлэх боомт дээр гаалийн улсын байцаагчаар ажиллаж байхдаа албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар буюу хяналт шалгалтыг хийхгүй байхаар урьдчилан амлахгүйгээр Д.З, Ж.Б нарын УАЗ-469 маркын автомашинуудад ачигдсан химийн хортой бодис болох хар тугалганы исэл 5 тонн, дээжний уут 40.000 ширхгийг Монгол Улсын хилээр импортоор оруулахад нь

хяналт шалгалт хийлгүй нэвтрүүлж, Д.З, Ж.Б нараас М.Ц-аар дамжуулан 91.064 төгрөгийн хээль хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүгдэгч нарын мэдүүлэг, яллагдагч Ж.Б, М.Ц нарын мэдүүлэг, хохирогч Д.Э, Д.У нарын мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэг, гэрч Д.П-ы /хх-ийн 278-279/ "...Жижигхэн цагаан ууттай зүйл ачсан байсан. Жоохон хүнд байсан. Надад хэлэхдээ оохор байгаа юм гэж байсан. ...дотороо шар өнгийн нунтаг зүйл хийсэн шуудайтай юмнууд байсан", гэрч А.Н-ийн "...2010 оны 05 сарын 24-ний өдөр баталсан 01-127 тоот удирдамжийн дагуу 2010 оны 06 сарын 09-ний өдөр 16 цагийн орчим АБТЭМА-ийн орон нутгийн ачааны 44-р ангид 5 улсын байцаагчийн хамт шалгалт хийхэд Замын-Үүдээс ирсэн ачааны вагоноос хаяг, шошго, тэмдгэлгээгүй, химийн бодис байсныг илрүүлэн шалгасан. ...Нөхцөл байдлыг үндэслээд бараа бүтээгдэхүүнийг "АЭ" ХХК дээр очиж битүүмжилсэн байгаа." гэх мэдүүлэг, гэрч С.Н-ын "...Хар тугалга нь байгаль дээр биш байх нь ховор бөгөөд дандаа нэгдмэл байдлаар байдаг энэ нь байгаль исэл буюу сульфит хэлбэрээр байдаг, ерөнхийдөө хатуу төлөв байдалтай, цельсийн 1729оc хэмд буцалдаг, хар тугалга нь хортой металл бөгөөд химийн шинж чанараар цацраг идэвхт бодисын эцсийн бүтээгдэхүүний үлдэгдэл бодис нийлмэл байдлаар оршино. ...байгаль орчин талаасаа хөрс усанд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд аюулын зэргээр ангилаж үздэг" гэх мэдүүлэг, шинжээч П.М-ний "...шинжилгээнд ирүүлсэн бодис нь хар тугалганы дан исэл буюу олон улсын химийн нэр томъёогоор хар тугалганы моноксид болох нь тогтоогдсон. Шинжилгээний үр дүнгээр 577.68 бүхий магадлал нь манай спектрийн буюу багажны санд байгаа спетртэй тухайн дээжнээс авсан спектр 2 адилхан байгааг харуулах буюу үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, хамгийн их магадлалтай спектр буюу хар тугалганы исэл болох нь тогтоогдсон. Энэ төрлийн бодисыг импортлохын тулд БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд улсын хилээр оруулах үед дээж авч гаалийн төв лаборатороор шинжлүүлж ангиллын код тогтоолгодог. Шинжлэгдсэн дээжний тухайд 2824.10.00 ангилалд хамаарах хар тугалганы дан исэл байсан" гэсэн мэдүүлэг, хохирогч Д.Э-д Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн <sup>1</sup> 110 тоот дүгнэлт, хохирогч Д.У-д Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн № 111 тоот дүгнэлт, 2010.04.15-

ны өдрийн Зам тээврийн осол дээр тогтоосон шинжээчийн 1 20 тоот дүгнэлт болон хавтаст хэрэгт авагдсан бичгийн бусад баримтуудаар тогтоогдож байна гэж үзлээ.

Шүүгдэгч Д.З нь урьд нь буюу 1996 онд шийтгүүлж байсан боловч Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.3-т заасан ялгүйд тооцох хугацаа дууссан тул түүнийг анх удаа хүндэвтэр хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Сум дундын Прокурорын газраас шүүгдэгч нарт зүйлчилж ирүүлсэн хуулийн зүйл анги тохирсон байна. Ял оногдуулахдаа шүүгдэгч нар нь анх удаа хүндэвтэр хэрэг үйлдсэн, үйлдсэн хэрэгтээ гэмшсэн, хохирол төлөгдсөн зэрэг байдлыг харгалзан үзлээ.

Зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилээр импортлогдсон, эд мөрийн баримтаар хураагдсан химийн хорт бодис болох 5 тонн хар тугалганы исэлийг улсын орлого болгож, 002xxxx дугаартай хил орчмын үнэмлэх, шүүгдэгч Д.З-ын битүүмжлэгдсэн Шарп маркийн 19 инчийн өнгөт зурагт 1 ширхэг, Хитачи маркийн тоос сорогч 1 ширхэг зэргийн битүүмжлэлийн цуцалж эзэмшигч Д.З-од, шүүгдэгч Ц.Н-оос хураасан 500.000 төгрөгийг Ц.Н-ид тус тус буцаан олгож, бичлэгтэй си ди-г хэргийн хамт хадгалах нь зүйтэй байна.

Эд мөрийн баримтаар хураагдсан 5 тонн хар тугалганы исэлийн үнэлгээг хх-ийн 997-1000 дугаар хуудсан дахь Шүүхийн Шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн Шинжээчийн 034 тоот дүгнэлтийг үндэслэсэн болно. Учир нь иргэний нэхэмжлэгч, хариуцагч нараас хараат бусаар хөндлөнгийн байр суринаас уг дүгнэлтийг гаргасан гэж шүүх үзэж байна.

Иргэний нэхэмжлэгч Х.З нь хх-ийн 772 дугаар хуудсан дахь Гаалийн Ерөнхий газар Бүрдүүлэлтийн дараахь шалгалт Гаалийн улсын байцаагчийн актаар тавигдсан барааны үнэ 42.319.584 төгрөгийг иргэний хариуцагч “АЭ” ХХК-аас нэхэмжилжээ. 2011 оны 12 сарын 13-ны өдрийн 101/11 дугаартай актыг Гаалийн тухай хуулийн 290 дүгээр зүйлийн 290.2.2-т зааснаар оногдуулсан гэж акт тогтоосон гаалийн улсын байцаагч гэрч П.О мэдүүлсэн боловч Гаалийн тухай хуулийн 290 дүгээр зүйлийн 290.2.2-т зохих буруутай этгээд, аж ахуйн нэгж байгууллагыг тодорхой хэмжээний мөнгөн дүнгээр торгож, тухайн зөрчилд холбогдох барааг хураах, эсхүл үнийг гаргуулж улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан байдаг. 2011 оны 12 сарын 13-ны өдрийн 101/11 дугаартай “АЭ”

ХХК-д тавигдсан гаалийн улсын байцаагчийн актанд зөвхөн барааны үнийг компаниас гаргуулахаар тавигдсан нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллага аж ахуйн нэгжид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны арга хэмжээ авах ёстой. Гэтэл ямар нэгэн арга хэмжээ аваагүй атлаа барааны үнийг хариуцагч байгууллагаас гаргуулахаар нэхэмжилж байгаа нь буруу юм. Иймд иргэний нэхэмжлэгч болох Замын-Үүд дэх Гаалийн газар нь энэ хэргийн улмаас байгууллагад хохирол учирсан гэж үзвэл иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 284, 286, 294-298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүгдэгч О овогт Д.З-ийг бусадтай бүлэглэн химийн хорт болон аюултай бодисыг зохих зөвшөөрөлгүйгээр импортолсон, албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн, согтуугаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчсөний улмаас бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулсан, зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан,

-Шүүгдэгч Ж овогт Ц.Н-ийг хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлахгүйгээр бусдаар дамжуулан хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Шүүгдэгч Д.З-ийг Монгол Улсын Эрүүгийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 214<sup>1</sup> дүгээр зүйлийн 214<sup>1</sup>.1. дэх хэсэгт зааснаар 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ялаар,

-Эрүүгийн хуулийн 215 дугаар зүйлийн 215.2 дахь хэсэгт зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 1 /нэг/ жилийн хорих ялаар,

-Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлийн 216.2 дахь хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хорих ялаар,

-Эрүүгийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 2 /хоёр/ жилийн хорих ялаар,

Шүүгдэгч Ц.Н-ийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар гаалийн

улсын байцаагчийн албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилээр хасаж, 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ялыг жирийн дэглэмтэй тус тус эдлүүлсүгэй.

3. Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.З-д оногдуулсан хөнгөн ялыг хүнд нь багтааж биеээр эдлэх ялыг 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосугай.

4. Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.З, шүүгдэгч Ц.Н нарт оногдуулсан 2 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

5. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.4 дэх хэсэгт зааснаар эд мөрийн баримтаар хураагдсан 35.403.690 төгрөг 25 мөнгөний үнэ бүхий 5 тонн хар тугалганы исэлийг улсын орлого болгосугай.

6. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-т зааснаар хэргийн хамт ирсэн бичлэгтэй си ди-г хэрэгт хадгалж, 0021546 дугаартай Монгол, Хятадын хил орчмын нутагт зорчих үнэмлэхийг Д.З-д буцаан олгож, шүүгдэгч Д.З-ын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх шүүхэд ирээгүйг дурдсугай.

7. Шүүгдэгч Д.З-ын битүүмжилсэн эд хөрөнгө болох Шарп маркийн 19 инчийн

өнгөт зурагт 1 ширхэг, Хитачи маркийн тоос сорогч 1 ширхэг зэргийн битүүмжлэлийн цуцалж эзэмшигч Д.З-д, шүүгдэгч Ц.Н-оос хураасан 500.000 төгрөгийг Ц.Н-ид тус тус буцаан олгосугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Д.З, шүүгдэгч Ц.Н нарт оногдуулсан 2 жилийн хорих ялыг тэнсэж тус бүр 1 /нэг/ жилийн хугацаагаар хянан харгалзаж, засрал хүмүүжилд нь хяналт тавихыг Цагдаагийн байгууллагад үүрэг болгосугай.

9. Иргэний нэхэмжлэгч Замын-Үүд дэх Гаалийн газар нь өөрт учирсан хохирлоо иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдсугай.

10. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох тул хуулийн хүчин төгөлдөр болтол ялтан нарт авсан батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

11. Энэ шийтгэх тогтоолыг ялтан, хохирогч, түүний өмгөөлөгч эс зөвшөөрвөл шийтгэх тогтоолыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 2 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Э.БОЛОРМАА

